ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ

(2003-2009)

I

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ

(2003-2009)

I

ХУУЛЬ ЗҮЙ ҮНДЭСНИЙ ГЭЭЛЭН
WWW.LIBRARY.ru

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
10 жилийн ойд зориулав.

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ
/2003-2009 ОН/

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.idi.gov.mn

УЛААНБААТАР ХОТ
2012 ОН

Судалгааны баг:
Удирдсан:
Ж.Амарсанаа
Б.Чимид
Н.Мягмар
Судалгааны багийн гишүүд:
Л.Амаржаргал
П.Баяр
Б.Билэгсайхан
Д.Гантуяа
С.Должин
Г.Батчимэг
Р.Болормаа
С.Гэрэлмаа
Б.Гүнбилэг
Д.Зүмбэрлхам
Т.Жаргалсайхан
М.Мөнхбат
У.Мөнхбат
Н.Мөнхтуяа
Р.Мухийт
Б.Наранцацрал
Х.Наранцацрал
Г.Оюунболд
Ц.Одончимэг
Д.Оросоо
Б.Сансар
Ж.Соёлмаа
Б.Солонго
А.Түвшинтулга
Д.Цэнд-Аюуш
Г.Халиун
Ш.Хишигсүрэн
Б.Энх-Амгалан
Ж.Энхнасан

©Хууль зүйн үндэсний хүрээлэн

Эмхтгэсэн:	Д.Мэнджаргал
Хэвлэлийн эхийг:	Б.Цэрэнлхам
Хэвлэсэн газар:	ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр
Хэвлэлийн хуудас:	66.6
Цаасны хэмжээ:	B5
Хэвлэсэн тоо:	250 ш
Хэвлэсэн хугацаа:	2012 оны 3 дугаар сар

ISBN-978-99962-1-470-7

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт

Өмнөх үг

ЗАХИРГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР	
Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой судалгаа	8
Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа	32
УИХ-д ажлаа тайлагнадаг буюу хараат бус зарим байгууллагын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг судлах	75
ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР	
Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэлүүдээс тавих хяналт	88
Зар сурталчилгаа ба гэм хор	118
Монгол Улсын үнэт цаасны зах зээлд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц	195
Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал	294
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, КРИМИНОЛОГИЙН СЕКТОР	
Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал ба ялын тохироо	328
Шүүхийн мэтгэлцээний хэрэгжилтийн байдал	342
Хорих ялын үр нөлөө	353
Монгол Улсын Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг харьцуулан судлах нь	384
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	403
Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт хавтаст хэргийн судалгаа	450
Хүүхдийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах	473
Насанд хүрээгүй хүмүүсийг цагдан хорих байр, хорих ангийн дотоод журам боловсруулах	493
ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН СЕКТОР	
Бүгд найрамдах хятад ард улс дахь хүний эрхийн төлөв байдал	520
Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын төсөлд хийх хавсрага судалгаа/	542
Харьяатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хийх хавсарга судалгаа	586
Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын үүсэл хөгжил, хэтийн төлв	602
Шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж ба холбогдох олон улсын гэрээний зөрчилдөөний талаар судалж, шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох	700

Товчилсон үгийн жагсаалт

УДШ-Улсын дээд шүүх
ЦЕГ-Цагдаагийн ерөнхий газар
УМХГ-Улсын мэргэжлийн хяналтын газар
НЗДТГ-Нийслэлийн засаг даргын тамгын газар
ЕГ-Ерөнхий газар
ЗХТХ-Захиргааны хариуцлагын тухай хууль
ХМХ-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
БН-Бүгд найрамдах
ҮЭ-Үйлдвэрчний эвлэл
ОНРТТХ-Олон нийтийн радио телевизийн тухай хууль
ҮЦЗЗТХ-Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ОН-Орон нутаг
ИТХ-Иргэдийн төлөөлөгчдын хурал
ШШГЕГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ДХБ-Дэлхийн худалдааны байгууллага
НҮБ-Нэгдсэн үндэсний байгууллага
ГИХА-Гадаадын иргэдийн харъяатын алба
БХГ-Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТХЭГ-Газрын тосны хэрэг эрхлэх газар
СШЗ-Сонгон шалгаруулах зөвлөл
ОУЭШ-Олон Улсын эрүүгийн шүүх
ОУЭЗС-Олон Улсын эрх зүйн сектор
ИЭЗЭС-Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор
ЗХЭЗС-Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн сектор
ЭЭЗКС-Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор
ГХО - Гадаад хөрөнгө оруулалт
ТББ - Төрийн бус байгууллага
МҮЭНХ - Монголын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоо
МАОЭНХ - Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
ШӨХТГ - Шударга өрсөлдөө хэрэглэгчдийн төлөөлөгчийн газар
ХХГХ - Хүн худалдаалах гэмт хэрэг
СЗХ - Санхүүгийн зохицуулах хороо
ААХЯ - Албадан ажил хийлгэх ял
ГХУСАЗСЗ - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГШХО - Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ЭЗЧБ - Эдийн засгийн чөлөөт бүс

www.nli.gov.mn

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь анх "Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв" нэртэйгээр 2002 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба Монгол Улсын хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, үр нөлөөг судалж, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, шинээр батлагдах хууль тогтоомж болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал, дүгнэлт өгөх, хууль зүйн үргэлжилсэн сургалт явуулах, үндэсний хэмжээнд хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах, хууль тогтоомжийн тогтолцоо, хэрэгжилт уялдаа, үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэй судалж, холбогдох асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Иргэн, эдийн засгийн эрх зүй, Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, криминологи, Олон улсын эрх зүйн секторууд нь тодорхой салбар эрх зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийж ирсэн.

Энэхүү эмхтгэлээр тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний секторуудын 2003 - 2009 онд хийж гүйцэтгэсэн урьд өмнө хэвлэгдээгүй эрдэм шинжилгээний судалгааны зарим ажлуудыг эмхтгэн (хавсралтгүйгээр) гаргаж байгаа бөгөөд энэ нь эрх зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг, сонирхдог уншигчдын хүртээл болохоос гадна цаашид гүнзгийрүүлэн судлах, тухайн материалыг шинжлэх ухааны болон практик судалгааны эргэлтэд оруулах боломжийг олгож байгаагаараа ач холбогдолтой юм.

Мэргэн уншигч Та болгооно уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.gov.mn

I БҮЛЭГ

ЗАХИРГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ СУДАЛГАА

ОРШИЛ

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж онцлон заажээ.

Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль, түүнд нийцсэн эрх зүйн хэм хэмжээ нь захиргааны шийтгэл ноогдуулах гол үндэслэл мөн. Үүнийг хууль зүйн ном зохиолд захиргааны хариуцлагын хэм хэмжээний үндэс хэмээн үздэг. 1993 оныг хүртэл буюу "Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль" батлагдан гарах хүртэл Монгол Улсад захиргааны хариуцлагыг янз бүрийн хууль тогтоомж, эрх зүйн актаар захиргааны хариуцлага хүлээлгэж байсан байна.

Сүүлийн үед салбар болгон өөрийн хуулиар захиргааны шийтгэл ноогдуулах нь олширсоор байна. Үүнийг дагаад захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны хүрээ нэмэгдэн тэлэх, улмаар тэдний хууль хэрэглэх ажиллагаанд тавигдах хяналтын механизм сайжрах бус, харин ч сулрах, бас захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх тухай асуудал хуульч судлаачдын анхаарлын гадна байх хандлага ажиглагдаж байна.

Захиргааны хариуцлага гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын төрөл бөгөөд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчил гаргасан этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хуульд заасан албадлага хэрэглэх замаар зохих хэмжээгээр хязгаарлах явдал юм.

Манай эрх зүйн сурах бичиг, ном зохиолд хууль зүйн хариуцлага, түүний зарим төрөлтэй холбоо бүхий бүтээл багагүй хэвлэгдсэн нь хуульч судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар ирсэн. Энэ сэдэв хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсан чухал ач холбогдолтой хэвээр байна. Энэ нь захиргааны хариуцлагын үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Захиргааны хариуцлага нь төрийн эрх бүхий байгууллагаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын бие даасан нэг төрөл юм. Иймд юуны өмнө түүнийг хууль зүйн хариуцлагын бие даасан төрөл болохын хувьд бусадтай нь харьцуулан авч үзэх шаардлагатай юм.

Хууль зүйн бусад хариуцлагатай харьцуулан үзэхэд захиргааны хариуцлага нь дараахь нийтлэг шинжтэй. Үүнд:



- Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний төлөө хариуцлага хүлээлгэх;
- Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох;
- Иргэдийг төрийн хууль тогтоомжоо хүндэтгэн биелүүлэх үзэл бодол, итгэл үнэмшил, эрх зүйн хүмүүжилтэй болгох;
- Зөрчигдсөн эрхийг сэргээн хангах;
- Эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн албадлага хэрэглэх замаар зохих хэмжээгээр хязгаарладаг байна.

Мөн захиргааны хариуцлага нь захиргааны албадлагын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өөрийн мөн чанараараа хууль зүйн бусад хариуцлагаас ялгагдах хэд хэдэн онцлогтой байна. Үүнд:

Захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл нь бүх нийтээр дагаж биелүүлбэл зохих захиргааны журам зөрчих буюу захиргааны зөрчил гаргах явдал юм. Харин гэмт хэргийн шинж агуулсан, хор уршиг бага, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлагад татуулахаар төрийн эрх бүхий байгууллагаас шилжүүлэн ирүүлсэн тохиолдолд захиргааны шийтгэл ногдуулж болно.

1. Захиргааны эрх зүйн хэм хэмжээнд захиргааны шийтгэл ногдуулахаар хуульд урьдчилан заасан байдаг. Өөрөөр хэлбэл захиргааны зөрчлийн шинжтэй байсан ч уг зөрчилд захиргааны шийтгэл ногдуулахаар хуульд заагаагүй бол захиргааны хариуцлага хүлээлгэхгүй.

2. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн албан хаагч бүхэлдээ бус, зөвхөн хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн албан тушаалтан захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Захиргааны шийтгэлийг гол төлөв гүйцэтгэх эрх мэдлийн бараг бүх байгууллага, тэдгээрийн албан хаагч ногдуулах мэт боловч зөвхөн Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шүүгч, төрийн эрх бүхий бусад албан тушаалтан энэ эрхийг эдэлнэ. Сүүлийн үед ийм эрх бүхий албан тушаалтны хүрээ улам тэлсээр байна.

3. Захиргааны хариуцлагад татах журмыг хууль тогтоомжоор тусгайлан тогтооно. Захиргааны зөрчлийн тухай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний болон эрүүгийн хэргийн нэг адил процессын эрх зүйн хэм хэмжээний дагуу явагдана. Харин одоогийн байдлаар захиргааны процессын салангид олон хэм хэмжээ үйлчилж байна

4. Захиргааны хариуцлага хүлээлгэгч, хариуцлагад татагдагчийн хооронд эрхэлсэн ажлын хүрээнд захирах, захирагдах харилцаагүй байдаг.

5. Захиргааны зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага нь гагцхүү Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль төдийгүй, бусад хууль тогтоомж, захиргааны эрх зүйн актаар тодорхойлогдоно. Иймд захиргааны зөрчил, шийтгэл агуулсан тэрхүү хууль тогтоомжийн бусад акт нь захиргааны хариуцлагын хэм хэмжээний үндэсийг бүрдүүлнэ.

Эдгээр шинжүүдэд үндэслэн захиргааны хариуцлага гэдэг нь гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдөх захиргааны журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан захиргааны шийтгэл ногдуулах үүрэг мөн хэмээн тодорхойлж болно.

Захиргааны хариуцлагын мөн чанар болон дээр дурдсан шинжид дүн шинжилгээ хийж түүний үндэслэлийг дараах 3 хэсэгт зааглан үзэж байна. Үүнд:

1) Захиргааны хариуцлагыг тодорхойлогч хэм хэмжээ, тэдгээрийн бүхэл тогтолцоо

2) Захиргааны хариуцлагаар хамгаалагдаж буй эрх зүйн заалтыг гажуудуулсан тодорхой субъектийн үйлдэл, эс үйлдэхүй буюу бодит үндэслэл

3) Захиргааны зөрчилд шийтгэл ногдуулах тухай эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр буюу процессын үндэслэл

Сүүлийн жилүүдэд эрх зүйн зөрчилтэй тэмцэхэд захиргааны хариуцлага чухал үүрэг гүйцэтгэж, түүний ач холбогдол нь улам бүр өссөөр байна. Энэ нь захиргааны хариуцлага бүхий хууль тогтоомж ихээхэн нэмэгдсэн, мөн зах зээлийн эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт, түүний зарим удаашрал болон бусад олон хүчин зүйлтэй холбоотой юм. Тухайлбал:

1. Нарийн төвөгтэй техник хэрэгсэл, машин механизм, орчин үеийн химийн бүтээгдэхүүн, стандартын бус хүнсний зүйл олноор нэмэгдэж шинжлэх ухаан техникийн хувьсал нэвтрэх болсон нь хүрээлэн байгаа орчин, замын хөдөлгөөний болон бусад аюулгүй байдлын дэг журам шинээр тогтоох, түүнчлэн түүний сөрөг үр дагвараас хүн ам, материаллаг үнэт зүйлс, байгаль орчноо хамгаалах шаардлага хурцаар тавигдаж байна. Үүний хамгийн гол илрэл нь зам тээврийн осол, зөрчил, эмх цэгцгүй, замбараагүй хог хаягдлын бохирдлоос нийтэд учрах хор уршиг илтэд нэмэгдэж буйг дурьдаж болно.

2. Эдийн засгийн төвлөрсөн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн нөхцөлд хяналт шалгалт суларснаас өмч хөрөнгөтэй холбоотой гэмт хэрэг, захиргааны зөрчлийн тоо мэдэгдэхүйц өссөн.

3. Эдийн засгийн өөрчлөлттэй уялдан юуны өмнө нийгмийн даатгал, татвар санхүү, гааль, зээлийн харилцааг бүхэлд нь шинэчлэхдээ эрүүгийнхээс өргөн хүрээнд захиргааны шийтгэл тогтоон хамгаалахад урьтал болгосон.

4. Эрх зүйн дэг журмыг хангах, нийтийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор төрийн байгуулагын хэвийн үйл ажиллагааны нөхцөлийг бий болгохын тулд эрх бүхий байгууллагын хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй, шүүхийг хүндэтгээгүйн төлөө захиргааны хариуцлага хүлээлгэх тогтолцоо бүрдсэн.

5. Эрх зүйн зөрчилд тооцогдохгүй байсан хэрэг явдлыг захиргааны зөрчилд хамааруулах ёс зүйн шаардлага гарсан. Нэг талаас захиргааны зөрчлийн тоо буртгэл хөтлөгдөөгүйгээс зөрчил бүрд захиргааны шийтгэл

оногдуулах, нөгөө талаас эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байгаагаас захиргааны зөрчил гаргасан этгээд түүнийг үл тоож давтан үйлдэх явдал нилээд түгээмэл болж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны зөрчилд хамаарагдаж байсан үйлдэл, эс үйлдэхүй иргэний нийгэмд илүү их хохирол учруулах болсон /зам тээврийн осол гарсан газрыг орхих, албан тушаалтны нэр барих гэх мэт/. Түүнчлэн тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг Эрүүгийн хуульд тусгахдаа хууль тогтоогчийн зүгээс нийгмийн хор аюул ихтэй байх, тэдгээрт ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх замаар тэмцэх нь зайлшгүй байх, эрүүжүүлж буй үйлдэл нь түгээмэл байх, тэдгээртэй эрүүгийн эрх зүйн арга хэрэгслээр тэмцэх нь үр өгөөжтэй байх, нийгмийн хор аюул багатай үйлдэл, эс үйлдэхүйг Эрүүгийн хуулинд заахгүй байх зэргээр захиргааны эрх зүйн хэм хэмжээнд нөлөөлж байна.

I. ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХИ СТАТИСТИКИЙГ СУДЛАХ

Захиргааны шийтгэл хүлээлгэсэн этгээдийн нийт тоог /байгууллага тус бүрээр, сүүлийн 5 жилийн байдлаар, төрөл тус бүрээр нас, хүйс тус бүрээр/ авч үзвэл:

А. УЛСЫН ХЭМЖЭЭНД МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИДААС НОГДУУЛСАН ТОРГУУЛЬ ШИЙТГЭВЭРИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА









ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.hh.gov.mn

В. Цагдаагийн албан хаагчаас ногдуулах торгууль, шийтгэвэр төрөл тус бүрээр графикаар харуулбал:



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

II. ХИЧНЭЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛ НОГДУУЛЖ БАЙГАА ТАЛААРХИ СУДАЛГАА

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан 387 хууль байгаагаас Захиргааны хариуцлага ногдуулсан хэм хэмжээ бүхий зүйл, заалттай 177 хууль байна. Үүнээс 14 хуульд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж ерөнхий байдлаар заажээ. Харин 10 хуульд Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар хариуцлага хүлээлгэхээр иш татсан зохицуулалттай байна. Жишээ нь: Монгол Улсын Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 10.1-д *"Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ"*; 10.2-д *"Үндэсний гадаад паспортаа үрэгдүүлсэн, гэмтээсэн Монгол Улсын иргэнд консулын албан тушаалтан Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ"* гэж заажээ.

Захиргааны шийтгэл ногдуулахаар заасан дээрх хуулиудад шийтгэл ногдуулах субъектийн хувьд холбогдох улсын байцаагч болон шүүгч ногдуулахаар заажээ.

Захиргааны шийтгэлийн хувьд мөнгөн торгууль ногдуулах, хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, зогсоох, хүчингүй болгох шийтэл ногдуулахаар заажээ.

Мөнгөн торгууль ногдуулж буй шийтгэлийн хувьд мөнгөн торгуулийн хэмжээ нь 500 /таван зуун/ төгрөгнөөс 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хэмжээтэй байна. Энэ нь Захиргааны хариуцлагын тухай хуульд мөнгөн торгуулийн хэмжээг 500 /таван зуун/ төгрөгнөөс 1000.000 /нэг сая/ төгрөгийн хэмжээтэй заасан мөнгөн дүнгийн хэмжээтэй ижил байна.

Захиргааны хариуцлагын тухай хууль бусад хуульд заасан захиргааны шийтгэл хоорондоо давхардах, зөрчилдөх нь элбэг байна. Тухайлбал: ЗХТХ-ийн 41 дүгээр зүйл "Садар самууныг сурталчилах, өнгөний өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх" зөрчил гаргасан бол 10000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна гэсэн бол Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйл 13.2-д " садар самууныг сурталчилсан, хориглосон үйл ажиллагаа явуулсан бол садар самууныг сурталчилж олсон орлогыг хураах, гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 хүртэл төгрөгөөр торгох, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох шийтгэл ногдуулахаар заажээ. Захиргааны хариуцлагын тухай хууль дахь торгууль ногдуулсан зүйл хэсэг бусад хуульд торгууль ногдуулсан зүйл хэсэг давхардах, зөрөлдөх явдал байгаа тул цаашид нэг мөр цэгцлэх шаардлага байна.

Захиргааны шийтгэл агуулсан хууль, эрх зүйн акт тус бүрийн үйлчлэлийн талаархи судалгаа:

1992 онд батлагдан хүчин төгөлдөр болсон "Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль" нь өнөөдөр захиргааны зөрчил, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа ганц хууль бөгөөд энэхүү хууль нь эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд дорвитой өөрчлөлт оруулаагүй. 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаран удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй иржээ.

Эрх зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон зэрэг нь ард иргэдийн дунд хууль тогтоох байгууллагын ажилтнуудыг хардах, гаргасан шийдвэрийг хууль бус гэж үзэхэд хүргэж байгаа бөгөөд шинээр Захиргааны хариуцлагын тухай хуулийг батлан гаргах шаардлагыг бий болгож байгаа юм.

Захиргааны эрх зүйн шинжлэх ухааны судлах зүйл нь өөртөө төрийн удирдлагын өргөн болон явцуу утга, захиргааны эрх мэдлийн мөн чанар, тэдгээрийн харьцаа, эрх зүйн зохицуулалтын механизм, эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж, төрөл, харилцан холбоо бүхий тогтолцоо, захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцаа, захиргааны эрх зүйн субьектын эрх зүйн байдал, хүрээ хязгаар, үйл ажиллагааны хэлбэр арга, захиргааны хариуцлагын үндэслэл болон хууль ёсыг хангах үйлдэл, арга хэрэгсэл, түүнчлэн ерөнхий, мөн салбар хоорондын удирдлагын захиргааны зохион байгуулалтыг багтаадаг.

ЗХТХууль нь материаллаг хууль төдийгүй мөн нэг зэрэг процессын хуулийн шинжийг давхар агуулдаг. Учир нь ЗХТХууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчлахын зэрэгцээ уг хуулийн I бүлэгт захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны /процессын/ журмыг тогтоосон байдаг.

Захиргааны хариуцлагын хэм хэмжээ агуулсан хууль Монгол Улсад 177 байгаа бид өмнөх хэсэгт өгүүлсэн. Эдгээр бүх хуулийн үйлчлэлийн талаархи судалгааг нэг дор хийж гүйцэтгэх боломж хомс учир бид захиргааны хариуцлагын үндсийг зохицуулж буй Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилтэд судалгаа хийлээ.

Захиргааны хариуцлагын хуулийн хэрэгжилт, үр нөлөөний асуудалд нэлээдгүй бэрхшээл, давхардал үүсгэдэг хууль бол Монгол Улсын Эрүүгийн хууль мөн. Учир нь Захиргааны хариуцлагын хуульд заасан захиргааны зөрчил болон Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн хоорондын ялгаатай шинжийн асуудал өнөөдөр чухал сэдэв болоод байна.

Эрүүгийн хууль болон ЗХТХууль тогтоомжийн уялдаа холбооны нэг чухал асуудал бол гэмт хэрэг, захиргааны зөрчил нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие

биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг явдал юм.

Учир нь гэмт хэргийн нийгэмд ашуултай шинж нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 16.2-д "....Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүй учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй..." гэсэн заалт нь Эрүүгийн хууль дахь гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил тухайлбал захиргааны зөрчлийн ялгааг хуульчилсан нийтлэг хэм хэмжээ болох юм. Захиргааны хариуцлагын тухай нийтлэг /ерөнхий/ хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтыг үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгааг "...***хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол.***.." гэсэн ерөнхий үг хэллэгээр заагласан нь бий. Гэвч дээрхи хууль тогтоомжийн "...хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол..." гэсэн заалтыг судлан үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгаа бараг харагдахгүй байгаа юм.

Захиргааны хариуцлага гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын төрөл бөгөөд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчил гаргасан этгээдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хуульд заасан албадлага хэрэглэх замаар зохих хэмжээгээр хязгаарлах явдал юм.

Харин Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчихөөс хамгаалахын тулд захиргааны журам зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл хэмжээг хуульчлах замаар дээрх зорилт хэрэгжинэ.

Бидний өмнө шийтгэлийн туйлын учир холбогдлыг тодруулан зааглах асуудал чухал байна. Тухайлбал торгууль ял, торгууль оногдуулах захиргааны шийтгэл, түүнчлэн баривчлах ял, захиргааны журмаар баривчлах гэх мэт.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгаа

Монгол Улсын "Захиргааны хариуцлагын тухай хууль" нь 3 бүлэг , 56 зүйл заалттай, 1992 оны 12 сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн, 20 гаруй удаагийн нэмэлтээр уг хуулийн тавны нэгд өөрчлөлт орсон. Захиргааны хариуцлагын тухай хуулийн "соггуурах " /22-р зүйл/ гэсэн зөрчлөөс бусад нийт 44 зүйл, 86 хэсэгт торгууль оногдуулахаар заасан байгаа нь "Захиргааний торгууль оногдуулах хууль" гэмээр харагдаж байгаа юм. ЗХТХ-ийн зүйл хэсгүүдэд дүн шинжилгээ хийхэд дараахь байдлууд тогтоогдож байна. Үүнд:

1) ЗХТХ-ийн Ерөнхий ангийн заалтанд тус хуулийн зорилт хэсэгт олон улсын нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ болон, баримтлах зарчмууд ялангуяа гэм буруугүйн презумци, эрх тэгш байх зарчим, захиргааны хуулиар хамгаалагдах харилцаа, хуулийн үйлчлэх хэмжээ хязгаар, орон зай, цаг хугацаа, гадаадын иргэд, харьяалалгүй этгээд, гадаадын хуулийн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэх, мансуурсан үед хүлээлгэх захиргааны хариуцлагыг хэрхэн авч үзэх, захиргааны шийтгэлийн зорилго, төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох талаар оруулж өгөх нь зайлшгүй шаардлагатай байна.

2) ЗХТХ-ийн 39 дүгээр зүйлд "Энгийн харуул манааны дүрэм зөрчих" зөрчилд 3000 төгрөгний торгууль оногдуулахаар заасан байна. Иймэрхүү байдалд нэг бүрчлэн судалбал 5000 хүртэл төгрөгөөр торгох "ЗХТХ-ийн 24 дүгээр зүйл " Хүйтэн зэвсэг хууль бусаар биедээ авч явах" , 8000 төгрөг хүртэл торгох "замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих", мөн 10000 төгрөг хүртэл торгох ЗХТХ-ийн 41 дүгээр зүйл "Садар самууныг сурталчилах, өнгөний өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх" зөрчил гэх мэт байна. 1000 хүртэл төгрөгөөр торгох заалт бүхий заалт нь хуулийн 13,8 хувь байна. Мөн тус хуулийн 28 дугаар зүйл "Гадаадын иргэн харъяалалгүй хүн хөдөлмөр эрхлэх талаар хууль тогтоомжид заасан журам зөрчих, 42-р зүйл " Хориглосон үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, 37 дугаар зүйл "Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах", 48 дугаар зүйл "Гэрээний тухай хууль тогтоомж зөрчих" зөрчлүүдэд 10000 төгрөгөөс дээш 15000-20000 хүртэл төгрөгөөр торгохоор зааж өгсөн байна.

3) ЗХТХ-ийн нийт 38 зүйл, хэсэг нь эрүүгийн хууль тогтоомжтой давхардаж, эрх зүйн хэм хэмжээний давхардал, зөрчилдөөн бий болгож байна. Захиргааны хариуцлагын тухай хуулийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан зарим заалтыг хасах, эсвэл ялгаж ойлгох талаар хуульд тусгаж өгөх, 1993 онд гарсан УДШ-ийн "ЗХТХ-ийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" №38 тогтоол нь өнөөгийн шаардлага хангахгүй болсон учир хүчингүй болгож ахин тайлбар гаргуулах зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй байна.

4) Эрүүгийн хууль болон ЗХТХ-ийн тусгай ангид заасан заалтуудыг харьцуулан авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нилээд зөрчилтэй зүйл байсан болно. Үүнд: /дэлгэрэнгүйг дор хүснэгтээр үзүүлэв/

➢*Гэмт хэргийн бүрэлдэхүүн болон захиргааны зөрчил нь ижил төрлийн харилцааг хамгаалсан зүйл , хэсгүүд 10*

➢*Эрүүгийн хууль тогтоомжид болон захиргааны хариуцлагын тухай хуульд давхардсан байдлаар тусгагдсан зүйл хэсэг 11*

➢*Эрүүгийн хууль болон ЗХТХ-д давхардсан байдлаар орсон, материаллаг /их хэмжээний/ хор уршиг шаардсанаараа ялгаатай зүйл, хэсгүүд 7 тус тус байна.*

5)Захиргааны зөрчилтэй холбоотой хэм хэмжээ нилээдгүй олон хуулинд тусгагдсан байна. 177 хуулиас захиргааны зөрчилтэй холбоотой хэсгийг төрөлжүүлэн нэгтгэж ЗХТХ-д ямар нэг байдлаар тусгах, эсвэл зөвхөн нийтлэг хэм хэмжээ, ерөнхий анги зааж уг харилцааны эрх зүйн үндсийг тусгаж, захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг тусгаж өгөх зэрэг асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан заалтуудыг ч оруулж өгөх, хууль гаргах талаар шийдвэрлэх хэрэгтэй байгаа юм.

6) Бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, түүнчлэн шунахай зорилгоор хувьдаа ашигласан буюу бусдад ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэж зааж өгчээ. **Бага хэмжээгээр ашиглан шамшигдуулах** гэдгийг нарийн тодорхойлох, УДШ-ийн тайлбарт тодорхой оруулж өгөөгүйгээс бусдын эд зүйлийг хулгайлах, залилан мэхэлж авах, ашиглах, үрэгдүүлэх зэргийн алин болох нь ялгагдахгүй байна.

7) Эрүүгийн хэрэгтэй ижил төрлийн харилцааг хамгаалсан хэм хэмжээ Захиргааны хариуцлагын тухай хуульд байгаа нь хуулийн байгууллагын ажилтнуудын дунд хардлага бий болгох, хэргийг өөрт ашигтай байдлаар шийдэх, улмаар эрүүгийн хариуцлагаас зайлсхийж, ял завших боломжийг олгож байна. Жишээлбэл: Танхайрах зөрчил /ЗХТХ-ийн 21-р зүйл /-ийг танхайрах гэмт хэргээс/ ЭХ-ийн 181--р зүйл/ мөн Галт зэвсгийг хууль бусаар олж авах, эзэмших, хадгалах, борлуулах гэмт хэргийг / ЭХ-ийн 185-р зүйл/ энэ төрлийн захиргааны зөрчлөөс / ЗХТХ-ийн 23-р зүйл / ялгах, нэг мөр зөв ойлгож хэрэглэх талаар тайлбар гаргуулах, эсвэл зөвхөн нэг хууль тогтоомжинд тусгаж өгөх хэрэгтэй юм. "Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах" /ЗХТХ-ийн 33-р зүйл болон ЭХ-ийн 244 дүгээр зүйл/ "Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах" 260 дугаар зүйл. "Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух" гэмт хэргээс ялгагдах ямар нэг ялгаа байхгүй байгаа юм.

8) 2002 оны Эрүүгийн хуулинд танхайрсан зөрчил гаргасны дараа дахин дээрхи зөрчлийг гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан байсан хэм хэмжээ байхгүй болсон нь бэрхшээл учруулж байгаа бөгөөд эрүүгийн хууль тогтоомжинд дахин тусгаж өгөх шаардлагатай байна.

9) Огт хэрэгждэггүй, арга хэмжээ авагддаггүй Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хэм хэмжээнүүд байсаар байна. Тухайлбал "Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэх гэмтээх /ЗХТХ-ийн 38-р зүйл/. Энд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг Эрүүгийн хуулиар хамгаалсан бусдын эд хөрөнгөөс ямар шалтгааны улмаас доогуур авч үзэж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Захиргааны болон Эрүүгийн хуулийн харилцан хамаарал, зөрчлийн талаар доорхи хүснэгтээр харуулав[1]:

1.Ерөнхий ангийн хүрээнд2.

№	Захиргааны Хариуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** Энэ хуулийн зорилт нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.	**1 дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт** 1.1.Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.
2	**2 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж** Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль. энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	**2 дугаар зүйл. Эрүүгийн хууль тогтоомж** 2.1.Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ. 2.2. Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно.
3	**3 дугаар зүйл.Захиргааны зөрчил** Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил / цаашид "зөрчил" гэх/ гэж үзнэ.	**16 дугаар зүйл. Гэмт хэргийн тухай ойлголт** 16.1.Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. 16.2.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.
4	**4 дүгээр зүйл.Захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ** Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болно: 1.торгох; 2.тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох /; 3.хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах 4.баривчлах.	**46 дугаар зүйл. Ялын төрөл** 46.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна: 46.1.1. торгох; 46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 46.1.3. эд хөрөнгө хураах; 46.1.4. албадан ажил хийлгэх; 46.1.5. баривчлах; 46.1.6. хорих; 46.1.7. цаазаар авах.

[1] Энд ХЗҮТ-ийн Кримнологийн судалгааны секторооос хийсэн судалгааны дүнг ашиглав.

Эрүүгийн хууль болон ЗХТХ-ийн тусгай ангид заасан заалтуудыг харьцуулан авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нилээд зөрчилтэй зүйл байсан болно. Үүнд:

2.Гэмт хэргийн бүрэлдэхүүн болон захиргааны зөрчил заасан хэсэг нь хоорондоо зөрчилтэй зүйл, хэсгүүд

1.	МУ-ын ЗХТХ	МУ-ын ЭХ
	21 дүгээр зүйл.Танхайрах Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр, үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн бол	**181 дүгээр зүйл.Танхайрах** 181.1.Олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн бол
2.	**23 дугаар зүйл.Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах** Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодисыг хууль бусаар олж авсан, авч явсан, хадгалсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх,хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх** 185.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хийж бэлтгэсэн, хадгалсан, авч явсан, борлуулсан бол 186 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах 186.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар олж авсан бол
3.	**25[1] дүгээр зүйл. Гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, журам зөрчих** Гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, биелүүлэхээс зайлсхийсэн, гал түймрээс урьдчилан сэргийлэх зориулалттай барилгын хийц, бүтэц болон орон сууцны агааржуулах төхөөрөмжийг дур мэдэн өөрчилсөн, галын автомат дохиолол, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг санаатайгаар гэмтээсэн, тоносон, түүнчлэн шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх бодисыг зориулалтын бус газар хадгалах, ой, хээрийн түймэр тавих зэргээр гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**189 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих** 189.1.Аж ахуйн нэгж, байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг хүлээсэн этгээд галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөнөөс их хэмжээний хохирол учирсан бол **213 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих** 213.1.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан нь энэ хуулийн 84, 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол

4.	**26[1] дүгээр зүйл. Нислэгийн аюулгүй байдлыг хангах журам зөрчих** 1.Агаарын хөлгөөр тасалбаргүй зорчих, түүнчлэн нислэгийн хэвийн ажиллагааг хангах үүднээс тавьж буй агаарын хөлгийн даргын хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх зэргээр агаарын хөлгөөр зорчих журам болон олон улсын нислэгийн журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих** 224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисэж ирэх буюу Монгол Улсаас нисэж гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шалтгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол
5.	**30[2] дугаар зүйл. Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх** 3.Гэмт хэрэг, захиргааны зөрчил, гал түймэр гарсан тухай худал мэдээлэл цагдаагийн байгууллагад санаатайгаар өгсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол.	**252 дугаар зүйл. Зориуд худал мэдээлэх** 252.1.Хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж зориуд худал мэдээлсэн бол
6.	**34[1] дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих** Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчсөн бол	**235 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих** 235.1. Төрийн архивын сан хөмрөгт орсон архивын баримт бичгийг хууль бусаар худалдсан, шилжүүлсэн, дамжуулсан бол
7.	**36 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгө ашиглан шамшигдуулах** Бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол **37 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах** Бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор хувьдаа ашигласан буюу бусдад ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**145 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг хулгайлах**145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол **150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх** 150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсэн, эсхүл албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж бусдын эд хөрөнгийг авсан бол **151 дүгээр зүйл. Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших** 151.1.Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгийг завшсан бол **152 дугаар зүйл. Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших** 152.1.Бусдын хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгө, малыг завшсан буюу үрэгдүүлсэн бол
8.	**38 дугаар зүйл. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх** Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдсэн, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх** 153.1.Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол

9.	**43[1] дүгээр зүйл.Төсвийн тухай хууль тогтоомж зөрчих** Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах** 273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг: зориулалтын бусаар зарцуулсан; зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан; .нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, менгений эргэлтийг саатуулсан; зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн; төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан; улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн үгсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол
10	**52 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчих** 1.Зохих зөвшөөрөлгүйгээр эмчилгээ явуулсан, эмнэлгийн байгууллага байгуулж ажиллуулсан бол 3.Хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хорт нөлөө үзүүлэх хими, биологи, физикийн хүчин зүйл, бодисыг зохих шинжилгээгүйгээр хэрэглэсэн, худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 4. Байгалийн болон гоц халдварт өвчин гарсан хориотой бүсэд нэвтрэх, ан агнах зэргээр хорио, цээрийн дэглэм зөрчсөн, байгалийн болон гоц халдварт өвчин үүсгэгч, нян тээгч зүйлсийг хот, суурин газар зохих шинжилгээгүй оруулсан, оруулахыг завдсан бол	**197 дугаар зүйл. Хууль бусаар эмчлэх** 197.1.Эмчийн мэргэжлийн бус этгээд эмчилгээ эрхэлсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр. хүнд гэмтэл учирсан бол **200 дугаар зүйл. Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах** 200.1.Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, олгох, буртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн бол **199 дүгээр зүйл. Тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих** 199.1.Ариуни цэвэр-эрүүл ахуй, дархлаажуулалтын талаар тогтоосон болон тахалтай тэмцэх журам зөрчсөнөөс, эсхүл дархлаажуулалтаас хүндэтгэх шалтгаангүйгээр зайлсхийснээс тахал болон гоц халдварт бусад өвчин тархсан буюу тархаж болох байсан бол



3. Эрүүгийн хууль тогтоомжид болон захиргааны хариуцлагын тухай хуульд давхардсан байдлаар тусгагдсан

№	Захиргааны Хариуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1.	**28 дугаар зүйл.Гадаадын иргэн харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих** 1.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух эрхийн бичигүй, эсхүл хүчингүй болсон баримт бичиг ашиглаж буюу зохих зөвшөөрөлгүй оршин суусан бол 2. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр зорчих, түүнчлэн шилжин суурьших болон бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 8.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчиход зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн бол	**240 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих** 240.1.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад байх эрхийн баримт бичиггүй буюу хүчингүй баримт бичгээр оршин суусан, бүртгүүлэх, хаягийн бүртгэл хийлгэх, шилжин суурьших, оршин суух газраа сонгох талаар тогтоосон журам зөрчсөн, эсхүл оршин суух, түс улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх журам зөрчсөн бол
2.	**29 дүгээр зүйл.** **Улсын хилийн дэглэм, журам зөрчих** 1..Улсын хилийн дэглэм зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2.Улсын хил арчлан хамгаалах, хилийн ус болон шугам оггтлон гарсан зам, холбооны байгууламж ашиглах, хил орчмын нутагт ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3.Улсын хилийн бүс, зурваст болон хилийн гарц, боомтод тогтоосон журам зөрчсөн бол	**89 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх** 89.1.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол **90 дүгээр зүйл.** **Улсын хилийн дэглэм зөрчих** 90.1.Монгол Улсын хилийн багана, тэмдгийг санаатай устгасан, гэмтээсэн, хилийн шугамыг оггтлон гарсан ус, зам, гүүр, холбооны байгууламжийг ашиглах журам болон улсын хилийн дэглэмийг бусад хэлбэрээр ноцтой зөрчсөн бол
3.	**30 дугаар зүйл. Шүүхийг үл хүндэтгэх** 3.Шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол	**258 дугаар зүйл.** **Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх** 258.1.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол

4.	**30[1] дүгээр зүйл.** **Прокурорыг үл хүндэтгэх** **30[2] дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх** **30[3] дугаар зүйл. Хорих байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх** **30[5] дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх** **30[6] дугаар зүйл. Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх** **30[4] дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх**	**230 дугаар зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх** 230.1 . Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь буюу олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь эсэргүүцсэн бол 230.2.Энэ хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, түүнчлэн хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол **231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох** 231.1. Төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол
5.	**30[4] дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх** Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол	**258 дугаар зүйл.** **Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх** 258.2.Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн бол
6.	**33 дугаар зүйл . Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах** Төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас түр хугацаагаар битүүмжилсэн эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол	**244 дүгээр зүйл. Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах** 244.1.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас битүүмжилсэн эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол **260 дугаар зүйл. Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух** 260.1.Хуулийн байгууллагаас дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд санаатай үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн бол

7.	**34[2] дугаар зүйл. Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчих, компьютер, мэдээллийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх** Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчсөн, компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас мэдээллийг болгоомжгүйгээр өөрчлөх, устгах, хаахад хүргэсэн буюу компьютер түүний төхөөрөмжийг ашиглах боломжгүй болгон эвдсэн, түүнчлэн компьютер мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээллийг хууль бусаар хуулбарласан, мэдээллийн сүлжээгээр дамжуулж байгаа мэдээллийг замаас нь авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**226 дугаар зүйл. Компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх** 226.1.Компьютерийн программ, түүний төхөөрөмжийг санаатайгаар өөрчилсөн, эвдсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, мэдээллийн сүлжээг сүйтгэсний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол **227 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авах** 227.1.Компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа болон дамжуулж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарласан, бусад аргаар олж авсан буюу авахыг завдсан бол
8.	**41 дүгээр зүйл. Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх** Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**123 дугаар зүйл. Садар самууныг сурталчлах** 123.1 Садар самууныг сурталчилсан хэвлэл , ном зохиол , зураг , кино , дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол
9.	**44 дүгээр зүйл. Албан татварын тухай хууль тогтоомж зөрчих** Албан татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, албан татварын мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, албан татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт сэлт гаргаж өгөөгүй зэргээр албан татварын тухай хууль тогтоомж зөрчсөн бол	**167 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчих** 167.1.Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих хууль тогтоомжид заасан журмыг зөрчсөн, татварын хяналт шалгалтад саад учруулсан бол
10	**45 дугаар зүйл.** **Албан дайчилгаанаас зайлсхийх** Байгалийн гэнэтийн аюул, хүн, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, гал түймэр эсэргүүцэх, улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон хүн хүч, тээвэр, холбооны хэрэгслийн дайчилгаанаас санаатайгаар зайлсхийсэн, саад учруулсан бол	**239 дүгээр зүйл.** **Төрийн дайчилгаанаас зайлсхийх** 239.1.Байгалийн гэнэтийн аюул, хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрээс эсэргүүцэх, улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон дайчилгаанаас санаатайгаар зайлсхийсэн, саад учруулсан бол

11	**47 дугаар зүйл.** **Аюулгүй ажиллагааны журам зөрчих** 2.Тэсэрч дэлбэрэх болон радио идэвхит, түүнчлэн хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**184 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах** 184.1.Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явсан бол **190 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журам зөрчих** 190.1.Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журмыг зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл учирсан бол

4. Эрүүгийн хууль болон ЗХТХ-д давхардсан байдлаар орсон боловч хор уршиг шаардсанаараа ялгаатай зүйл, хэсгүүд

№	Захиргааны Хариуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1	**26 дугаар зүйл. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих** 1.Галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулж болох зүйлсийг төмөр зам дээр тавих, мал, ердийн хөсөг болон тээврийн хэрэгслийг төмөр зам дээгүүр гарцгүй газраар гаргах, төмөр замын хориотой бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх, мал бухий иргэд малаа хариулгагүй орхисноос төмөр замын хориг хашаанд оруулах, түүнчлэн галт тэргийг дур мэдэн зогсоох, дээвэр, гишгүүр дээр зорчих, хөдөлгөөн дунд буух, суух зэргээр төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2.Төмөр замын төхөөрөмж, хамгаалалтын тор, хаалт, галт тэрэгний болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, суудлын галт тэрэгний тоноглолыг эвдэж, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**217 дугаар зүйл. Төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих** 217.1.Төмөр зам, усан болон агаарын тээврийн байгууллагын ажилтан тухайн төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол **219 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх** 219.1.Тээврийн хэрэгслийн холбоо, дохиоллын болон бусад тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол
2	**31 дүгээр зүйл.Төрийн байгууллагын ажилтны нэр барих** Төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууран мэхлэх үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих** 267.1.Албан тушаалтан бус этгээд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр барьж үйл ажиллагаа явуулсан нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжгүй, энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний ашиг олсон, эсхүл бусдад их хэмжээний хохирол учирсан бол

Хүснэгт 3.

	Улс төрчид	Төрийн жинхэнэ албан хаагчид	Төрийн байгууллага	Бизнесийн хүрээнийхэн	Урлаг, спортын хүрээнийхэн	Бусад
СБД						
2001	4	1	0	1	1	4
2002	5	0	1	10	1	10
2003	4	2	1	3	3	5
2004	13	1	2	6	1	4
2005	3	4	0	1	6	2
Бүгд	**29**	**8**	**4**	**21**	**12**	**25**
ЧД						
2001	2	1	0	2	2	3
2002	0	0	0	2	1	3
2003	0	1	0	2	1	1
2004	5	2	1	1	1	3
2005	0	1	1	3	0	0
Бүгд	**7**	**5**	**2**	**10**	**5**	**10**
БЗД						
2002	2	0	0	0	0	0
2005	0	1	0	0	1	1
Бүгд	**2**	**1**	**0**	**0**	**1**	**1**
БГД						
2001	0	1	0	0	0	1
Бүгд	**0**	**1**	**0**	**0**	**0**	**1**
Аймгууд						
2002	Дорнод 1	0	0	0	0	0
2005	0	0	0	0	0	Дархан-Уул 1
Бүгд	**1**	**0**	**0**	**0**	**0**	**1**
Нийт	**39**	**15**	**6**	**31**	**18**	**38**

Хүүхэд зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан этгээдүүдийн эзлэх хувь хэмжээг график 3-т харуулав.

График 3



Тайлбар:
1.Улс төрчид-27%,
2.Төрийн жинхэнэ албан хаагчид-10%,
3.Төрийн байгууллага-4%,
4.Бизнесийн хүрээнийхэн-21%,
5.Урлаг, спортын хүрээнийхэн-12%,
6.Бусад-26%,

Нийт нэхэмжлэгчдээс хамгийн олон буюу 27 хувийг /39ш/ улс төрчид эзэлж байна. Энэ 27%-ийг эзэлж буй улс төрчид өөрсдийгөө анхнаасаа сэтгэлзүйн хувьд бэлтгээгүй, улс төрч болно гэдэг нь өөрийгөө сонгосон жирийн иргэдийн өмнө тэдгээр жирийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг нь хангахын тулд төрд төлөөлөн ажиллаж байгаа, тийм учраас тэдгээр жирийн иргэдийн анхаарлын төвд байнга байж иймэрхүү шүүмжлэлд өртөнө гэдгээ ухамсарлаагүйн шинж харагдаж байна.

Уг нь улс төрчид хамгийн их хувь хэмжээг эзлэхийн оронд аль болох хамгийн бага, болж өгвөл тэдний нэр иймэрхүү судалгаанд дурдагдахгүй байвал Монгол Улс дахь улс төрийн амьдрал хэр зэрэг цэвэр, шударга байгаагийн илэрхийлэл болох болов уу.

Улс төрчид нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандсан байдлыг жил жилд ямар хэмжээтэй байгааг доорхи график 4-өөр харуулав.

Улс төрчдийн нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандсан хэргийн тоо



2001 онд 6, 2002 онд 5, 2003 онд 4, 2004 онд 18, 2005 онд 3 удаа улс төрчид нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандан шийдвэрлүүлсэн иргэний хэргийн тоо ийм байгаагаас харахад ерөнхийдөө тогтмол буурах хандлагатай боловч 2004 онд гэнэт огцом өссөн байгаа нь харагдаж байна. Энэ нь 2004 оны парламентийн сонгуультай холбоотойг үгүйсгэхгүй. Удаах байранд бусад гэсэн ангилалд багтах хүмүүс орсон бөгөөд 26%-ийг /38ш/ эзэлж байна. Энэхүү ангилалд орогсодын хувьд бол нэр төрөө хамгаалуулахаар шүүхэд хандан хуулийн дагуу нэр төрөө сэргээлгэж байгаатай бол маргах шаардлагагүй юм. Гэхдээ ардчилсан нийгэм дэх чөлөөт хэвлэлийн гүйцэтгэх үүрэг, чөлөөт хэвлэлтэй байхын ач холбогдлыг манай нийгэм бүрэн гүйцэд ухамсарлаагүй байгаа юм болов уу.

Үүний дараагаар бизнесийн хүрээнийхэн 21%-ийг /31ш/ эзэлж байна. Бизнес эрхлэгчид болон бизнесийн байгууллагын хувьд нэр төр гэдэг бол маш их үнэ цэнэтэй зүйл гэдэг нь тодорхой юм. Гэхдээ үнэхээр ХМХ-ийн анхаарлыг татсан шударга бус үйлдэл хийсэн бол хэвлэлд бичигдэхээс өөр аргагүй.

Иргэний хэргийн хариуцагч

ХМХ бусдын нэр төрд халдсан хэмээн хариуцагчаар татагдсан 146 иргэний хэргээс бараг бүх тохиолдолд сонин хариуцагчаар татагдсан байна. Үүнийг хүснэгт 4, 5, 6-аас харж болно.

Хүснэгт 4.

№	Нэрс	СБД					
		2001	2002	2003	2004	2005	Нийт
1.	"Урт чихт" сонин,	1	0	0	0	0	1
2.	"Дээдсийн амьдрал" сонин,	2	1	0	0	0	3
3.	"Өнөөдөр" сонин,	2	1	1	1	0	5
4.	"Шар сонин" сонин,	2	2	0	0	0	4
5.	"Хувийн амьдрал" сонин,	1	0	0	0	0	1
6.	"Үг" сонин,	2	0	0	0	0	2
7.	"Зууны мэдээ" сонин,	1	0	2	2	0	5
8.	"Маш нууц" сонин,	0	4	1	1	0	6
9.	"Ноцтой мэдээ" сонин,	0	3	1	1	0	5
10.	"Сэрүүлэг" сонин,	0	5	2	6	3	16
11.	"Өдрийн сонин" сонин,	0	2	3	7	5	17
12.	"Цаг" сонин,	0	1	0	0	0	1
13.	"Монгол төрх" сонин,	0	1	1	0	0	2
14.	"Хүмүүс" сонин,	0	2	0	1	1	4
15.	"Сайн байна уу" сонин,	0	1	0	0	0	1
16.	"Монголын мэдээ" сонин,	0	1	0	0	0	1
17.	"Хувийн мөрдөгч" сонин,	0	1	1	1	0	3
18.	"Хувийн соёл" сонин,	0	1	0	0	0	1
19.	"Зиндаа" сонин,	0	1	0	1	3	5
20.	"Алаг хорвоо" сонин,	0	0	2	0	0	2
21.	"Үнэн" сонин,	0	0	2	2	1	5
22.	"Монголчуудын амьдрал" сонин,	0	0	2	2	2	6
23.	Сэтгүүлч Г.Уянга	0	0	0	1	0	1
24.	"Монголын нэг өдөр" сонин,	0	0	0	1	0	1
25.	"Монгол таймс" сонин,	0	0	0	1	0	1
26.	"4 дэх засаглал" сонин,	0	0	0	1	0	1
27.	"Монгол түмэн" сонин,	0	0	0	1	0	1
28.	"Тэргүүн" сонин,	0	0	0	1	1	2
29.	"Шуугиан" сонин,	0	0	0	0	1	1
	Нийт	11	27	18	31	17	104

Хүснэгт 5.

№	Нэрс	ЧД					
		2001	2002	2003	2004	2005	Нийт
1.	"Хүмүүсийн амьдрал" сонин,	2	0	0	0	0	2
2.	"Дээдсийн хүрээлэн" сонин,	3	1	1	1	1	7
3.	Сэтгүүлч О.Баясгалан	1	1	0	0	0	2
4.	"Ноёд хатагтай" сонин,	1	2	0	0	0	3
5.	"Монголын дээдсийн амьдрал" сонин,	1	0	0	0	0	1
6.	"Сэрүүлэг" сонин,	2	0	0	0	0	2
7.	"Хүмүүс" сонин,	0	1	0	0	0	1
8.	"Урт чихт" сонин,	0	1	0	0	0	1



9.	"Монголын мэдээ" сонин,	0	3	2	3	0	**8**
10.	"Үг" сонин,	0	1	0	0	0	**1**
11.	"Хувийн амьдрал" сонин,	0	1	0	0	0	**1**
12.	"Монгол таймс" сонин,	0	0	1	0	2	**3**
13.	"81-р суваг" сонин,	0	0	0	2	0	**2**
14.	Ш.Амаржаргал	0	0	0	1	0	**1**
15.	"Дээдсийн амьдрал" сонин,	0	0	0	1	0	**1**
16.	"4 дэх засаглал" сонин,	0	0	0	1	0	**1**
17.	"Ноцтой мэдээ" сонин,	0	0	0	2	1	**3**
18.	"Өнөөдөр" сонин,	0	0	0	0	1	**1**
	Нийт	**10**	**11**	**4**	**11**	**5**	**41**

Хүснэгт 6.

№	Нэрс	2001	2002	2003	2004	2005	нийт
	БГД						
1	"81-р суваг" сонин,	2	0	0	0	0	**2**
	БЗД						
2	"81-р суваг" сонин,	0	2	0	0	0	**2**
3	"Дээдсийн хүрээлэн" сонин,	0	0	0	0	2	**2**
4	"Миний Монгол" сэтгүүл,	0	0	0	0	1	**1**
	Дорнод аймаг						
5	"Шинэ Дорнод" сонин,	0	1	0	0	0	**1**
	Дархан-Уул аймаг						
6	"Лха" телевиз,	0	0	0	0	1	**1**
	Нийт	**2**	**3**	**0**	**0**	**5**	**9**

Хэрэг, маргааныг шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн байдал

Хүснэгт 7.
/иргэний хэрэг/

		2001	2002	2003	2004	2005	нийт
СБД	ялсан	1	4	1	0	0	6
	ялагдсан	**9**	**17**	**14**	**10**	**10**	**60**
	Эвлэрсэн	1	6	3	17	6	33
ЧД	ялсан	0	1	1	4	1	7
	ялагдсан	**8**	**2**	**3**	**6**	**2**	**21**
	Эвлэрсэн	2	4	0	2	2	10
БЗД	ялсан	0	0	0	0	0	0
	ялагдсан	**0**	**2**	**0**	**0**	**2**	**4**
	Эвлэрсэн	0	0	0	0	1	1
БГД	ялсан	0	0	0	0	0	0
	ялагдсан	**1**	**0**	**0**	**0**	**0**	**1**
	Эвлэрсэн	1	0	0	0	0	1
Хөдөө, орон нутаг	ялсан	0	0	0	0	1 Дархан-Уул/	1
	ялагдсан	**0**	**1 Дорнод/**	**0**	**0**	**0**	**1**
	Эвлэрсэн	0	0	0	0	0	0
Нийт		23	37	22	39	25	146

ХМХ-үүд шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны ихэнх нь буюу 59,6%-д нь өөрсдийн нийтэлж нэвтрүүлсэн мэдээ мэдээллийн үнэн зөвийг нотолж чадаагүй тул ялагдсан байна /87ш/.

Үүний эсрэг дээрх хэрэг маргаанд ХМХ ялсан тохиолдол нь дөнгөж 9,6%-тай байна /14ш/.

Нэхэмжлэгч, хариуцагч харилцан эвлэрсэн тохиолдол нь нэлээн өндөр 31,5%-тай байна /46ш/.

Эндээс харахад дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

• ХМХ-ийн хэрэгслүүд өөрсдийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ үнэн бодитой эсэхэд бага анхаардаг,

• бодитой бус мэдээлэл тараасаараа эргээд өөрсдөө хуулинд заасан хариуцлага хүлээнэ гэдгээ ухамсарладаггүй буюу хууль эрх зүйн мэдлэг дутмаг.

МУ-ын дотоодын хууль тогтоомжоор хувь хүний болон хуулийн этгээдийн нэр төрд халдсан мэдээ тараасан этгээд уг мэдээллийнхээ үнэн зөвийг өөрөө нотлох үүрэг хүлээдэг. Уг нь бол ардчилсан нийгэмд уг мэдээлэл нь өөрөө олон нийтийн эрх ашгийн төлөө, олон нийтийн эрх ашгийг зөрчигдөхөөс сэрэмжлүүлэх үндсэн зорилготой байсан бол сэтгүүлч болон ХМХ нь мэдээллийнхээ үнэн бодитойг нотлох үүрэг хүлээдэггүй, харин уг мэдээллийн эзэн буюу мэдээлэлд нэр нь дурдагдаж байгаа этгээд энэ мэдээлэл нь худал буюу үнэн байна гэдгийг нь нотлох, "би дээрх мэдээлэлд дурдагдсан хууль бус үйлдэл хийгээгүй" гэдгээ өөрөө нотлох үүрэгтэй байдаг. Энэхүү манай дотоодын хууль тогтоомжийн явцуу үзлээс болоод сэтгүүлч ХМХ нь ихэнхи тохиолдолд ялагдсан байхыг үгүйсгэхгүй.

Энэ судалгаанд хамрагдсан хэрэг маргааныг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байдлаас харахад цаашид сэтгүүлчид нь хууль эрх зүйн мэдлэгээ байнга дээшлүүлж байх, мөн өөрсдийн ажлын хариуцлагаа өндөржүүлэх, хэрвээ хийж буй ажил нь бусдын хууль ёсны эрх ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулахуйц шинжтэй байвал мэдээллийн үнэн бодитойг сайтар нягталж хэд хэдэн эх сурвалжаас баталгаажуулах зэргээр бүтээгдхүүнээ чанаржуулж, хийж буй ажлаасаа болоод хэрэг маргаанд холбогдох, эрх зүйн хариуцлага хүлээх зэргээс урдьчилан сэргийлэх боломжтой юм.

Хүснэгт 8.

№	Хаанаас тогтоосон	Доод хэмжээ	Дээд хэмжээ
1	Нэхэмжлэгчдийн нэхэмжилсэн	100 ₮	275 сая ₮
2	Шүүхийн шийдвэрээр хариуцагчаар гаргуулахаар тогтоосон мөнгөн дүн	30000 ₮	2 сая ₮



III. НУУЦ БА ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Дэлхийд нэр хүнд бүхий "19 дүгээр зүйл" байгууллагаас олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг хангахын тулд улс орон бүрийн мөрдвөл зохих зарчимуудын нэг бол мэдээллийн эрх чөлөөний үзэл баримтлалын гол цөм болох "мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх" зарчим юм гэж тодорхойлжээ.

"Мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх" зарчим ёсоор төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа бүх мэдээлэл нь олж авахад хялбар, нээлттэй байх ёстой бөгөөд зөвхөн тодорхой хязгаарлагдмал тооны нөхцөл байдалд л энэ зарчмыг хэрэглэхгүй байж болно. Мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх зарчмыг Үндсэн хуульд тусгаж албан ёсны мэдээлэл олж авах явдал бол иргэний үндсэн эрх гэдгийг тодорхойлох нь зүйтэй. Хууль, эрх зүйн хамгийн гол зорилго бол мэдээллийг дээд зэргээр нээлттэй байх явдлыг практикт хэрэгжүүлэх явдал юм.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 хэсэгт "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй." гэж заасан нь дээр дурдсан мэдээллийн эрх чөлөөний үзэл баримтлалын гол үндэс болох "мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх" зарчим нь төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуульд заасан мэдээллээс бусад бүх мэдээлэл, хүрээг хамарч үйлчилж, эл зарчмын агуулга, мөн чанар Үндсэн хуулийн энэхүү заалтад тусгагдсан гэж үзэж болно.

Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалбал зохих мэдээллээс бусад бүх мэдээлэл, тухайлбал, төрийн байгууллагын албан ёсны мэдээлэл "дээд зэргээр нээлттэй" байх бөгөөд энэхүү мэдээллийг хайх, олж авах нь Үндсэн хуулийн 16 зүйлд заасан Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх юм. Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхийг хангах үүднээс төрийн байгууллагууд мэдээллээ нээлттэй байлгах үүрэгтэй бөгөөд юуны өмнө төрийн байгууллагуудын хүрээнд нээлттэй байх соёлыг дээшлүүлэх, төрийн байгууллагын мэдээллээ нууцлах, хадгалах заншилыг халах, олон нийтийг төрхүү эрхийнх нь талаар мэдээллээр хангах явдал чухал байна. Төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзах эрхтэй ч гагцхүү төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуульд заасан хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох нууцтай холбоотой тохиолдолд татгалзах эрхээ эдлэх юм.

Дэлхийн ихэнх улсуудын Үндсэн хуулиудад мэдээллийн эрх чөлөөний институт гол төлөв хүний эрхийн хүрээнд хуульчлан баталгаажсан байдаг байна. Жишээ нь,

1."Бүх холбоо, муж, орон нутгийн засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болон бүх корпораци нууцыг нь хуулиар хамгаалаагүй тохиолдолд үйл ажиллагааныхаа явцыг ард түмэнд мэдээлж байх ёстой..." (Австри. 20/4/ дугаар зүйл)

2."Хууль, дүрэм, журмаар ямар нэгэн болзол тавиагүй тохиолдолд хүн бүр засаг захиргааны бүх бичиг баримтыг ашиглаж, хуулбарлаж болно." (Бельги. 33 дугаар зүйл)

3."Засгийн газрын байгууллагууд өөрсдийн хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхдээ Парламентын тухай хуулийн заалтуудтай уялдуулан олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг хангах ёстой." (Нидерланд. 110 дугаар зүйл)

4."Хүн бүр...чөлөөтэй мэдээлэл хийх, мэдээлэл олж авах, мэдээлүүлэх эрх эдэлнэ." (Португали. 37 дугаар зүйл)

5."Хүн бүр...нийтэд зориулсан эх сурвалжаас саадгүй мэдээлэл авах эрхтэй." (Германи. 5 дугаар зүйл)

*6.*Македоны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд мэдээллийн эрх чөлөөг бие даасан цогц байдлаар өргөн хүрээнд тусгасан байх бөгөөд*

1.Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

2.Мэдээлэл хайх, олж авах эрх чөлөө

3.Мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн нөөц, боломжтой байх эрх чөлөө

4.Мэдээллийг түгээх, тараах эрх чөлөө

5.Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээллийг өөрчлөн зөвтгөх эрх

6.Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах түүний халдашгүй байх эрх

7.Цензур хязгаарлалтыг хориглох гэх мэт (Д.Баярсайхан, Мэдээллийн эрх зүй: судлагдахуун, тогтолцоо., "Эрх зүй" сэтгүүл, 8-9/2002)

МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН НУУЦ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ХАЛДАЖ БАЙГАА ЭСЭХ

Глоб интернейшнл ТББ-аас 2006 онд хийсэн Монгол Улсын Төрийн нуущын тухай хууль ба мэдээлэл олж авах эрх сэдэвт судалгааны тайланд дурдсанаар:

Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг эрх зүйн зарчим, онол, практик, орчин үеийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Монгол Улсын Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Архивын тухай хуульд орсон зарим хуулийн нэр томъёо, ойлголт нь тодорхой тайлбар байхгүй байгаа нь зөв ойлгох, хэрэглэхэд эргэлзээтэй байна. Тухайлбал, **"нууцалбал зохих хэсэг"**, **"үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага"**, **"нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нуущлах шаардлагагүй болсон"**, **"задруулбал үндэсний аюулгүй байдалд**



хор хохирол учруулахуйц мэдээлэл", "нууцлах хугацаа дуусгавар болсон", "үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт" зэрэг болно. Эдгээр ойлголт, нэр томъёог тайлбарлах шаардлагатай юм. Төрийн нууцын тухай хуулин дахь зарим зохимжгүй утгыг боловсронгуй болгох хэрэгтэй. Тухайлбал, **Төрийн нууцыг нууцлах.** Мөн Төрийн нууцыг ил болгох гэсэн зүйлийн "**нууцлах хугацаа дуусгавар болсон**", **хуульд заасан бусад үндэслэл** гэсэн үндэслэлүүд , **яаралтай ил болгох шаардлага гарсан онцгой тохиолдолд** зэрэг нь тодорхойгүй байна.

2.Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар төрийн нууцад хамааруулж байгаа мэдээлэл нь ихэнх тохиолдолд нууцлах шаардлагатай мэдээлэл байна. Гэхдээ бас төрийн нууцад хамааруулах шаардлагагүй мэдээлэл ч бас байгаа юм. Үндэсний аюулгүй байдалд буюу төрийн нууцад хамааруулах шаардлагагүй, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй мэдээллийг төрийн нууцад хамааруулах нь мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа нэг хэлбэр мөн.

Иймд мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур үзүүлэлтийг хуульчлах хэрэгтэй юм.

3.Байгууллагын хэмжээний нууц байж болох мэдээллийг ч төрийн нууцад хамааруулсан тохиолдол байна. Иймд төрийн нууцад хамааруулах, байгууллагын нууцад хамааруулах мэдээллийн заааг ялгааг тодорхой зааж өгөх хэрэгтэй байна. Төрийн байгууллага нь төрийн нууцад хамаарахгүй олон нийтэд нээлттэй байх ёстой мэдээллийг байгууллагын нууцад хамааруулан мэдээллийн чөлөөт байдлыг хязгаарлаж болох тул төрийн байгууллагын хувьд байгууллагын нууцад хамаарахгүй эсхүл хамаарах мэдээллийн жагсаалтыг байгууллагын нууцын тухай хуулиар тусгайлан зааж өгөх хэрэгтэй юм.

4.Төрийн нууцад хамаарахгүй боловч чухал гэж үзсэн мэдээллийг нууцлах сонирхол, хандлага, төрийн байгууллагуудад хүчтэй хэвээр байгаа нь мэдээлэл олж авах эрхийг хязгаарлаж буй хамгийн гол шалтгаан юм. Энэ нь төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар тогтоосон нууцын жагсаалт, нууцад хамаарах мэдээллийн хүрээ хэт өргөн, ерөнхий байгаатай холбоотой бөгөөд төрийн албан хаагчид ямар ч мэдээллийг төрийн нууц гэж өгөхгүй байх боломжийг бүрдүүлж байгаа болно. Иймд төрийн нууцын жагсаалтыг нарийн, тодорхой болгох хэрэгтэй юм.

5.Төрийн нууцын тухай хуульд нууцад хамааруулах хүрээг таван бүлэгт ангилсан байх бөгөөд Төрийн нууцын жагсаалтын хуулинд энэхүү ангиллыг дахин давтаж, дэлгэрүүлсэн нь ач холбогдолгүй болжээ. Иймд Төрийн нууцын тухай хуульд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар ангиллыг тогтоохоор зааж, энэхүү хэсгийг хасах нь утга агуулга давхцах, хоёрдмол утга гарах явдлаас зайлсхийхэд тустай юм. Хоёр хуулийн уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.

6.Төрийн нууцын тухай хуулиар **Төрийн нууцад хамаарахгүй** мэдээ, баримт бичиг, эд зүйл, үйл ажиллагааг нэрлэн зааж өгөх нь зүйтэй. Ингэснээр төрийн нууцын өргөн хүрээлэлд аливаа мэдээг хамруулж ойлгох гэсэн эрх бүхий албан тушаалтны хууль бус ажиллагааг хязгаарлахад дөхөмтэй байна.

7. 13 нууцын төрөлд байнга гэсэн хугацаа тогтоосон нь үндэслэлгүй байна. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалтай холбоотой бичиг баримт байна. Нууцалсан зэрэглэлээр гэж нууцын зэрэглэлийг тогтоочихоод нууцлах хугацааг байнга гэсэн нь тохиромжгүй байна. Онц чухал маш нууц, маш нууц зэрэг нууцын зэрэглэлд хамаарахгүй нууц зэрэглэл бүхий мэдээллийг байнга хугацаагаар нууцалдаг явдлыг зогсоох хэрэгтэй.

8. Төрийн нууцын хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим бодит утгаараа хэрэгжихгүй байна, өөрөөр хэлбэл, төрийн нууцыг тогтооҳдоо хууль тогтоомжид нийцсэн, цаг үеэ олсон байж чадахгүй байна.

9. Төрийн нууцыг цаашид нууц хэвээр байлгах эсэх асуудлыг 5 жил тутамд хянаж, шинэчилдэг механизм тогтоох.

10. Нууцлах хугацааг багасгах, 40 жилээс их байгаа нь зохимжгүй байна.

11. Нууцлах хугацаа хэзээ дуусч байгаа нь тодорхойгүй, 1995 оны төрийн нууцын хууль, 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиас өмнөх хугацаанд нууцлагдсан төрийн нууцын хувьд ямар хууль үйлчлэх нь тодорхойгүй.

12. Жил тутмын цэргийн дайчилгааны тоо, цаазаар авах ялыг гүйцэтгэх журмыг төрийн нууцын жагсаалтаас хасах, байр зүйн зураг гэдгийг цэргийн байр зүйн зураг болгон тодотгож өгөх.

13. Төрийн нууцын хуулийн 5 дугаар зүйлд хохирол учирсны шалгуур болон олон нийтийн ашиг сонирхол давамгайлах гэсэн шалгуур алга байна. Нууцын зэрэглэлийг хохирлын хэмжээгээр шалгуур болгон онц чухал маш нууц, маш нууц, нууц гэж ангилсан боловч, эдгээр нууцыг задруулсан тохиолдолд хариуцлагын хэмжээ ижил байгаа нь буруу.

14. Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д *"Архивт байгаа хуулиар хамгаалсан төрийн болон бусад нууцад холбогдох бариmтыг үүссэн цагаас нь хойш 30 жил өнгөрсний дараа нийтэд ашиглахыг зөвшөөрнө"*, 25.8-д *"Үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах бариmтыг 50 жил, иргэдийн хувийн амьдрал, эд хөрөнгийн байдалд холбогдолтой баримт бичгийг 70 жил өнгөрсний дараа нийтэд ашиглуулна."* гэсэн заалт байна. Архивын байгууллага гэдэг бол улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, танин мэдэхүйн зорилгод ашиглах архивын баримтыг хүлээж авах, хадгалах, хамгаалах, зориулалтын дагуу ашиглуулах үүрэг бүхий байгууллага байдаг. Архивын байгууллагын үндсэн зарчим бол олон нийтэд нээлттэй байх явдал. Төрийн нууцад хамаарахгүй буюу төрийн нууцын жагсаалтаас хасагдсан баримтыг ашиглахад архивын хуулиар цаг хугацааны хувьд хязгаарлалт тогтоож байгаа нь

төр, байгууллага, хувийн нууцад хамаарахгүй мэдээллийг хайх, олж авах иргэний эрхэд нийцэхгүй байна.

Архивын тухай хуульд заасан *"үндэсний ашуулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт"* гэдгийг хэрхэн ойлгох нь ойлгомжгүй юм. Учир нь үндэсний ашуулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримтыг Төрийн нууцын тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хуульд хамаарахгүй хэрнээ *"үндэсний ашуулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт"* гэдэгт ямар баримт хамаарах нь ойлгомжгүй байна. Төрийн нууцын тухай хууль тогтоомжоор нууцлаагүй бол энэ төрлийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой бөгөөд цаг хугацааны хувьд ашиглахад хязгаарлалт тогтоож байгаа нь үндэслэл муутай байна.

15. Төрийн нууцтай холбоотой 41 хуулийг судалж үзэхэд улсын нууц, төрийн нууц гэж ялгаатай байдлаар заасныг нэг мөр болгож, төрийн нууц гэж оруулах хэрэгтэй.

16. Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын хуульд хариуцлагыг төрийн нууцыг задруулсан бол гэж заасан нь хэт ерөнхий байдалтай болжээ. Иймд нууцлалын зэрэглэлээр нь ангилж хариуцлагыг ялгавартай тогтоох хэрэгтэй гэж үзэж байна.

17. Төрийн аудитын тухай хуулийн 22.2 дугаар зүйлд "Нууц гэдгээр халхавчлан зөрчил дутагдлыг нуун дарагдуулах нь улс орны эрх ашигт харш гэж Монгол Улсын Ерөнхий аудитор үзвэл уг мэдээллийг авах эрхтэй байгууллага, албан тушаалтанд нь танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг санал болгож болно" гэсэн нь нэлээд чухал заалт болсон байна[33] гэжээ.

ГАДААД ОРНЫ ТУРШЛАГААС

Төрийн нууц болон хэвлэлийн эрх чөлөөний харилцан хамаарлын талаар бид Польш, Гүрж, Армен, ОХУ, Казахтсан улсын хууль тогтоомжийн практикийг судаллаа.

Нэг. Бүгд найрамдах Польш улсын Хэвлэлийн тухай хууль, Төрөлжсөн мэдээллийг хамгаалах тухай хууль /төрийн нууцын тухай хууль/

1997 оны Польш Улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлээр үг хэлэх эрх чөлөөг хангасан. " Хүн бүр үг хэлэх, мэдээлэл тараах, хүлээн авах эрхтэй" гэж заасан.

1984 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Хэвлэлийн тухай хууль 1984 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Dziennik Ustaw-д хэвлэгдсэн. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд Хэвлэл мэдээлэл бол иргэдийн нийгмийн амьдралын талаар

[33] Глоб интернейшнл ТББ-аас 2006 онд хийсэн Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль ба мэдээлэл олж авах эрх сэдэвт судалгааны тайлангаас.

зөв мэдээллээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх, мөн чөлөөтэй мэдээлэх эрхтэй гэж заасан

Хэвлэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн дагуу Эрх бүхий байгууллага нь Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийнхөө зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах ёстой. Үүнд улс төрийн үзэл бодол, цар хүрээ, сонин сэтгүүлийн редакцын албаны үйл ажиллагааны тоног төхөөрөмж хамаарна.

Төрийн эрх бүхий байгууллага, компаниуд өөрийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх ёстой.

Хэвлэлийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд үйлдвэрчний эвлэл, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага нь улсын эсвэл төрийн хүрээний үйл хэрэгт оролцвол мэдээлэл өгөх ёстой. Зөвхөн хуулиар хязгаарласан мэдээллийг өгөхөөс татгалзаж болно. Хэвлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд мэдээлэл өгөхөөс татгалзвал ерөнхий редакци татгалзсан бичиг хийж өгсөн байхыг шаарддаг.

Хэвлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд иргэн бүр чөлөөтэй үг хэлэх, шүүмжлэх мөн эдгээр зарчмын дагуу хэвлэлд мэдээлэх эрхтэй гэж заасан. Хуулинд зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээлэлд мэдээлэл өгсөнийхөө төлөө хэн ч ял шийтгэл болон хохирол амсах ёсгүй.

Хэвлэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар хэвлэл мэдээлэл тухайн үйл явдлыг мэдээлэхдээ бодит байдлыг харуулах ёстой төрийн эрх бүхий байгууллага болон эрх мэдэлтэн хэвлэл мэдээллийн шүүмжлэлд ямар нэгэн байдлаар саадгүйгээр хариулт өгөх ёстой ингэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлүүлсэнээс хойш нэг сараас илүүгүй хугацаанд хариу өгөх ёстой. Хэвлэл мэдээллийн шүүмжлэл няцаагдах ёсгүй.

Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхдээ гэмт хэрэг хийж болохгүй. Жишээ нь: хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэж болохгүй.

Төрийн болон бизнесийн нууц 1993 оны 4 дүгээр сарын 16-ны Шударга бус өрсөлдөөний тухай хууль, 1999 оны 1 дүгээр сарын 22-ны Төрөлжсөн мэдээллийг хамгаалах тухай хуулиар тус бүр хамгаалагдсан. Бизнесийн нууц (know-how) 1993 оны Шударга бус өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлээр хамгаалагдсан.

Үг хэлэх эрх чөлөө болон хэвлэн нийтлэх эрх чөлөөний өөр нэг хязгаарлалт бол төрийн нууц болон албан ёсны нууцыг тодорхойлсон 1999 оны Төрөлжсөн мэдээллийг хамгаалах тухай хууль юм. Энэ хууль нь 13 бүлэг 91 зүйлтэй 2 хавсралтаас бүрдэнэ. Уг хуульд төрийн нууцыг маш нууц, нууц гэж ангилдаг. Маш нууцад Бүгд Найрамдах Польш Улсын язгуур ашиг сонирхолд ноцтой аюул занал учрах, улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, халдашгүй байдал, улсын болон иргэний аюулгүй байдлын талаарх мэдээллийг оруулсан.

Нууцад тухайн улсын олон улсын байдалд аюул занал учирч болзошгүй, үндэстнийг хамгаалах эрх ашиг, улсын болон иргэний аюулгүй байдлыг хамгаалах эрх ашиг, улсын бусад чухал эрх ашиг зэрэг мэдээлэл орно.

Төрийн албаны нууц гэдэг нь төрийн нууцаас бусад нууц орно. Албан ёсны үүрэг болон гэрээний дагуу ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор олж авсан мэдээлэл, задруулбал улсын эрх ашиг, төрийн эрх ашиг эсвэл иргэн болон байгууллагын хуулиар хамгаалагдсан эрх ашигт хохирол учрахаар мэдээлэл орно.

Төрөлжсөн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1, 2 дугаар зүйлд заасан.

Төрийн албаны нууцыг маш нууц, хязгаарлагдмал нууц гэж ангилдаг. Маш нууцад улсын эрх ашиг, төрийн эрх ашиг, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг ордог бөгөөд нууцыг задруулж болохгүй.

Хязгаарлагдмал нууцад байгууллага болон хувь хүний хуулиар хамгаалагдсан эрх ашиг орно.

Төрийн нууцыг хадгалах хугацаа 50 жил байна. Төрийн албаны нууцын маш нууц ангиллын мэдээлэл нь 5 жилийн хугацаанд задруулахгүй байх ёстой. Төрийн албаны нууцын хязгаарлагдмал нууц ангиллын мэдээлэл 2 жилийн хугацаанд задруулахгүй байх ёстой.

Хоёр. Бүгд найрамдах Гүрж Улсын Хэвлэлийн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

4 дүгээр зүйл. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг урвуулан ашиглахгүй байх

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараахь зүйлийг хориглоно:

а/ Төрийн нууцыг задруулах,

12 дугаар зүйл. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох, дуусгавар болгох

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг давтан зөрчсөн буюу түүний үйл ажиллагаа нь БНГүрж Улсад материаллаг хохирол учруулахтай холбоотой бол тэдгээрийн үйл ажиллагааг зогсооно.

... Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зөвхөн шүүх бүрэн дуусгавар болгох эрхтэй.

21 дүгээр зүйл. Сэтгүүлч, түүний эрх

...Сэтгүүлч дараахь эрхийг эдэлнэ:

8/ Сэтгүүлч тухайн мэдээлэл төрийн нууц, эсхүл зөвхөн иргэн буюу тэдгээрийн хамаатан садны зөвшөөрөлтэйгээр нийтэлж болох иргэний хувийн нууцад хамаатайгаас бусад тохиолдолд дурын архивын материал, нууц фонд, тусгай фондын мэдээллийг ашиглах эрхтэй.

Бүгд найрамдах Гүрж Улсын Төрийн нууцын тухай хууль

33 дугаар зүйл. Төрийн нууц агуулсан мэдээллийг хэвлэл болон өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэхийг хязгаарлах

1.Төрийн нууц агуулсан мэдээллийг хамгаалах зорилгоор хилийн чанадад аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг илгээх, буцаан дуудахтай холбоотой мэдээллийг хэвлэл болон өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэхээр бэлдэхдээ энэ хуульд заасан шаардлагыг удирдлага болгоно.

2.Төрийн нууцыг хэвлэл болон өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулсны үр дагаварын хяналтыг Төрийн нууц хамгаалах хяналтын алба хэрэгжүүлнэ.

3.Төрийн нууцыг хэвлэл болон өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр задруулахад урьдчилсан хяналт тавихыг хориглоно.

38 дугаар зүйл. Төрийн нууцын тухай хууль зөрчсөний хариуцлага

4.Тухайн мэдээлэл нь төрийн нууц гэдгийг нь мэдээгүй, мэдэх боломжгүй этгээд төрийн нууц задруулсан бол гэмт хэрэгт тооцогдохгүй.

5.Хэрэв төрийн нууцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулсан нь Гүржийн төрийн аюулгүй байдал болон гадаад харилцаанд мэдэгдэхүйц хохирол учруулсан бол хуулиар тогтоосон хариуцлагыг хариуцлагатай редактор /тухайн дугаарыг хариуцсан/ хүлээнэ.

6.Задруулах нь нийгмийн аюулгүй байдлыг хамгаалахад ач холбогдолтой буюу өмнө нь нийтлэгдсэн төрийн нууцад хамаарах мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн нь гэмт хэрэгт тооцогдохгүй.

Гурав.
Бүгд найрамдах Армен Улсын Олон нийтийн мэдээллийн тухай хууль

9 дүгээр зүйл. Мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн хариуцлага

3. Хэрэв тухайн мэдээллийг хуулиар хориглосон аргаар олж авсан буюу хуульд зааснаар нууцад хамаарахаас бусад тохиолдолд мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд мэдээлэл түгээсний төлөө хариуцлага хүлээхгүй.

Хэрэв мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн түгээсэн мэдээлэл хуульд заасан нууцад илт хамаарах боловч энэхүү мэдээллийг түгээсэн нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бол түүнийг хариуцлагад татахгүй.



Бүгд найрамдах Армен Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль

2 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцын ойлголт

Төрийн нууц гэдэг нь цэргийн, гадаад бодлогын, эдийн засгийн, шинжлэх ухаан-техникийн, тагнуулын, сөрөг тагнуулын, шуурхай-тагнуулын үйл ажиллагааны хүрээнд хамаарах төрөөс хамгаалах, түүнийг задруулах нь БНАрмен Улсын аюулгүй байдалд хүнд хохирол учруулж болзошгүй мэдээлэл юм.

Албаны нууц гэдэг нь энэ хуулийн нэг дэх хэсэгт заасан хүрээнд хамаарах, төрөөс хамгаалагдах, түүнийг задруулах нь БНАрмен Улсын аюулгүй байдалд өөр хохирол учруулж болзошгүй мэдээлэл байна. Иймэ мэдээлэл нь төрийн·нууцын хэсгийг бүрдүүлсэн үйл баримтыг агуулах ба албаны нууц нь төрийн нууцыг задруулахгүй.

Төрийн болон албаны нууцыг агуулж буй мэдээлэл нь БНАрмен Улсын өмч гэж тооцогдох бөгөөд төр хамгаална.

27 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөний төлөөх хариуцлага

БНАрмен Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээд үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээнэ.

Дөрөв.
Бүгд найрамдах Казахстан Улсын Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

2 дугаар зүйл. Үг хэлэх, мэдээлэл авах, түгээх эрх чөлөө

3. Төрийн нууц буюу хуулиар хамгаалсан нууцыг агуулсан, алан хядах үйл ажиллагаа буюу экстризмийг дэмжсэн ухуулсан, алан хядах үйл ажиллагаатай тэмцэж байх үед түүнд хэрэглэх тактик, арга ажиллагааг илчилсэн, мансууруулах болон түүнтэй адилтгах бодис, садар самууныг уриалсан мэдээлэл түгээхийг хориглоно.

13 дугаар зүйл. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох

3. Хуульд заасан журмаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг /эфирт гарах г.м/ зогсоох, эсхүл дуусгавар болгох үндэслэл: Төрийн нууц буюу хуулиар хамгаалсан нууцыг агуулсан, алан хядах үйл ажиллагаатай тэмцэж байх үед түүнд хэрэглэх тактик, арга ажиллагааг илчилсэн, мансууруулах болон түүнтэй адилтгах бодист уриалсан, гарал үүсэл, үндэс угсаа, арьсны өнгө, шашны давамгай байдал, хүчирхийлэлд уриалан дуудсан мэдээлэл, садар самуунд уриалсан кино, видео бүтээгдэхүүнийг түгээсэн, энэ зүйлийн 3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 3-2-ыг зөрчсөн, мөн түүнчлэн энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 3-1, 15, 16 дугаар зүйлийг давтан зөрчсөн.

20 дугаар зүйл. Сэтгүүлчийн эрх

Сэтгүүлч дараахь эрхтэй:

5/ Төрийн нууцтай холбоотой мэдээлэл агуулснаас бусад баримт бичиг, материалтай танилцах.

Бүгд найрамдах Казахстан Улсын Төрийн нууцын тухай хууль

1 дүгээр зүйл. Энэ хуульд ашиглагдах үндсэн ойлголт

Төрийн нууцыг задруулах - төрийн нууцыг энэ талаар танилцаагүй байсан иргэн, хуулийн этгээдэд дурын аргаар мэдээлэх, дамжуулах, танилцуулах, ишлэх, нийтлэх, хүргэх.

29 дүгээр зүйл. БНКазУ-ын иргэн, албан тушаалтан болон гадаад улсын иргэн төрийн нууцтай танилцах

1.БНКазУ-ын иргэн, албан тушаалтан болон гадаад улсын иргэн төрийн нууцтай танилцахад:

Төрийн нууцыг агуулсан мэдээллийг задруулахгүй байх үүргийг төрийн өмнө шууд хүлээнэ.

БНКазУ-ын Төрийн нууцын тухай хууль тогтоомжоос хэрэв түүнийг зөрчвөл хариуцлага хүлээлгэхээр заасан заалттай танилцана.

37 дугаар зүйл. БНКазУ-ын Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөний хариуцлага

1.БНКазУ-ын иргэн, албан тушаалтан болон гадаад улсын иргэн Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчвөл БНКазУ-ын хуульд заасан хариуцлага хүлээнэ.

2.Энэ хуулийн хүрээнд иргэн, төрийн байгууллага, байгууллагын эрх, ашиг сонирхлыг БНКазУ-ын хууль тогтоомжид зааснаар шүүхийн журмаар хамгаална.

Тав.
ОХУ-ын Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

40 дүгээр зүйл. Мэдээлэл өгөхөөс татгалзах, хойшлуулах

Тухайн мэдээлэл зөвхөн төрийн, худалдааны болон хуулиар хамгаалсан бусад нууцыг агуулсан тохиолдолд тухайн хүссэн мэдээллийг өгөхөөс татгалзаж болно. Мэдээлэл өгөхөөс татгалзсан талаар бичгээр ирсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор редакцийн төлөөлөгчид мэдэгдэж хүргэнэ. Мэдэгдэлд:

1/Хүссэн мэдээлэл нь хуулиар хамгаалагдсан нууцыг агуулсан мэдээллээс салгах боломжгүй байгаа шалтгаан,

2/Мэдээлэл өгөхөөс татгалзсан албан тушаалтан,

3/Татгалзах тухай шийдвэрийн батлагдсан огноо.



47 дугаар зүйл. Сэтгүүлчийн эрх

Сэтгүүлч дараахь эрхтэй:

4/ Төрийн, худалдааны болон хуулиар хамгаалсан бусад нууцтай холбоотой мэдээлэл агуулснаас бусад баримт бичиг материалтай танилцах.

Оросын Холбооны Улсын Төрийн нууцын тухай хууль

21 дүгээр зүйл. Иргэн, албан тушаалтан төрийн нууцтай танилцах

Иргэн, албан тушаалтан төрийн нууцтай танилцахад:

Төрийн нууцыг агуулсан мэдээллийг задруулахгүй байх үүргийг төрийн өмнө шууд хүлээнэ.

ОХУ-ын Төрийн нууцын тухай хууль тогтоомжоос хэрэв түүнийг зөрчвөл хариуцлага хүлээлгэхээр заасан заалттай танилцана.

Бидний хийсэн эдгээр улс орнуудын хууль тогтоомжийн судалгаанаас гадна энэ талаар Глоб интернейшнл ТББ-аас 2006 онд хийсэн Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль ба мэдээлэл олж авах эрх сэдэвт судалгааны тайлан гаргасан гэдгийг өмнө дурдсан. Энэ тайлангаас зарим мэдээллийг дэлгэрэнгүй харах боломжтой.

IV. НЭР ТӨР, АЯДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНД БА ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон хэвлэлийн эрх чөлөөний харилцан хамаарлын талаар бид Гүрж, Армен, ОХУ, Казахтсан улсын хууль тогтоомжийн практикийг судаллаа.

Нэг.Бүгд найрамдах Гүрж Улсын Иргэний хууль

18 дугаар зүйл. Эд хөрөнгийн бус амины эрх

1.Нэрийг нь гутаасан буюу нэрийг зөвшөөрөлгүй ашигласнаас болж ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд түүний эрхийг зөрчсөн этгээдээс тухайн үйлдлээ зогсоох буюу татгалзахыг шаардах эрхтэй.

2. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, хувийн нууц буюу халдашгүй байдал нь зөрчигдсөн этгээд ийнхүү түүний эрхийг зөрчсөн мэдээллийн үнэн зөвийг нотолж чадахгүй бол тухайн мэдээллийг шүүхийн журмаар няцаахыг шаардах эрхтэй.

3.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон хувийн нууцад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан халдсан мэдээллийг энэхүү хэрэгслээр няцаана. Хэрэв ийм мэдээлэл нь байгууллагын баримт бичигт агуулагдаж байвал тухайн баримт бичигт өөрчлөлт орох ёстой бөгөөд энэ талаар сонирхогч этгээдэд мэдэгдэнэ.

4.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаалгасан этгээд тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хариу нийтлүүлэх эрхтэй.

5.Зураг /фото, кино, видео г.м/ нь зөвшөөрөлгүйгээр нийтлэгдсэн этгээд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан эрх эдэлнэ. Эрхэлж буй албан тушаал, шүүх, цагдаагийн шаардлага, шинжлэх ухаан, сургалт, соёлын зэрэг зорилгоор нийгмийн хүлээн зөвшөөрсөн аргаар, эсхүл шагнал авах зэрэг нийгмийн нөхцөл байдалтай холбоотойгоор зураг авахад тухайн этгээдийн зөвшөөрөл шаардлагагүй.

6.Энэ зүйлд заасан баялгийг түүнд халдаж буй этгээд гэм буруутай эсэхээс үл хамааран хамгаална. Хэрэв зөрчил нь гэм буруутай байвал гэм хорын хохирол шаардаж болно. Гэм хорын хохиролд зөрчил гаргасан этгээдийн олсон орлогыг шаардаж болно. Гэм буруутайгаар эрх зөрчсөн тохиолдолд эрх бүхий этгээд эдийн бус /сэтгэл санааны/ гэм хор шаардах эрхтэй. Сэтгэл санааны гэм хорыг эд хөрөнгийн гэм хорыг арилгаснаас үл хамааран арилгаж болно.

19 дүгээр зүйл. Нас барсны дараа амины эрхийг хамгаалах

18 дугаар зүйлд заасан эрхийг энэхүү нэр болон хувийн алдар хүндийг тээгч биш боловч тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах ёстой этгээд эдэлж болно. Тухайн этгээд нэр болон алдар хүндийг түүний тээгч нь нас барсны дараа хамгаалахыг шаардаж болно. Тухайн эд хөрөнгийн бус амины эрхийн тээгч нь нас барсны дараа түүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсаны улмаас эд хөрөнгийн нөхөн төлбөр шаардаж болохгүй.

413 дугаар зүйл. Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах

1.Зөвхөн хуульд заасан тохиолдолд ухаалаг, шударга нөхөн төлбөр шаардсан тохиолдолд эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.

2.Бие болон эрүүл мэндээр хохирсон тохиолдолд эд хөрөнгийн бус гэм хорыг арилгахыг шаардаж болно.

Бүгд найрамдах Гүрж Улсын Хэвлэлийн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

20 дугаар зүйл. Хувь хүн болон байгууллагыг гутаасан мэдээллийг няцаах, хариу нийтлүүлэх эрх

Иргэн болон байгууллага нь редакцаас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэднийг гутаасан мэдээллийг няцаахыг шаардах эрхтэй.

Няцаалт болон хариу нь тухайн сонин буюу сэтгүүл, тэдгээрийн тусгай хэвлэлийн дараагийн дугаарын ижил нүүрэнд хэвлэгдэнэ. Теле нэвтрүүлгийн хувьд шаардлага ирснээс хойш 7 хоногийн дотор нэвтрүүлнэ. Хэрэв гутаасан мэдээлэл нэг удаагийн хэвлэлд нийтлэгдсэн бол няцаалтыг өөр сонин буюу сэтгүүлд нийтлүүлж болно.

Хэрэв нийтлэгдсэн хариу нь иргэн, байгууллагын сэтгэлд хүрээгүй бол шүүхэд хандаж болно.

25 дугаар зүйл. Иргэн, байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан худал мэдээлэл тараах

Иргэн, байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан, санаатайгаар доромжилсон худал мэдээллийн хариуцлагыг төрийн, хувийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн удирдлага, редактор /ерөнхий редактор/, энэ хуулийг зөрчсөн мэдээллийг зохиогч хүлээнэ.

28 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөх тохиолдол

Дараахь тохиолдолд редактор /ерөнхий редактор/, сэтгүүлч бодит байдалд нийцээгүй мэдээлэл түгээснийхээ төлөө хариуцлага хүлээхгүй:

Хэрэв энэхүү мэдээлэл албан ёсны эх сурвалжид агуулагдсан бол, хэрэв тэдгээрийг мэдээллийн агентлаг, төрийн болон олон нийтийн байгууллагын хэвлэл мэдээллийн албанаас авсан бол,

Хэрэв эдгээр нь албан ёсны хурал, цуглаан дээр хариуцлагатай этгээдийн хэлсэн үгийг байгаагаар нь дамжуулсан бол,

Хэрэв эдгээр мэдээлэл нь зурагтын шууд нэвтрүүлэг, эсхүл энэ хуулиар редакц хийх ёсгүй бичвэр бол.

Хоёр. Бүгд найрамдах Армен Улсын Иргэний хууль

19 дүгээр зүйл. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах

1.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бодит байдалд үл нийцэх мэдээлэл тараасан этгээд тухайн мэдээллээ үнэн зөв гэдгийг нотолж чадахгүй бол иргэн өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээхийг шүүхээс шаардах эрхтэй.

Нас барсны дараа ч гэсэн иргэний нэр төр, алдар хүндийг сонирхогч этгээдийн шаардлагаар хамгаална.

2.Хэрэв иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаасан бол тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр няцаах ёстой.

Хэрэв ийм мэдээлэл байгууллагын баримт бичигт агуулагдаж байвал тухайн баримт бичгийг солих буюу өөрчлөнө.

Бусад тохиолдолд няцаах журмыг шүүх тогтооно.

3.Эрх буюу хууль ёсны ашиг сонирхол нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээллээр зөрчигдсөн иргэн тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хариу нийтлүүлэх эрхтэй.

4.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаалгасан иргэн тухайн мэдээллийг няцаалгахаас гадна тэдгээрийг түгээснээс учирсан хохирлыг шаардах эрхтэй.

5.хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл түгээсэн этгээдийг тогтоох боломжгүй бол хохирсон иргэн тухайн

мэдээлэл бодит байдалд нийцэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг шүүхээс шаардах эрхтэй.

6.Энэ зүйлд заасан журам нь хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд мөн адил хамаарна.

162 дугаар зүйл. Эдийн бус баялгийн ойлголт

1.Хуулийн дагуу иргэнийг төрснөөс нь эхэлж түүнд хамаарах амь нас, эрүүл мэнд, хувь хүний эрхэмсэг оршихуй, хувийн халдашгүй байдал, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, хувийн болон гэр бүлийн амьдралын нууц, чөлөөтэй зорчих эрх, оршин байх газраа чөлөөтэй сонгох эрх, нэртэй байх эрх, зохиогч байх эрх, эд хөрөнгийн бус амины бусад эрх болон эдийн бус баялаг нь халдашгүй бөгөөд өөр бусдад шилжихгүй. Хуульд заасан тохиолдолд нас барсан этгээдэд хамаарах эд хөрөнгийн бус амины эрх болон эдийн бус баялагийн хамгаалатыг бусад этгээд, тэр дундаа өв залгамжлагч хэрэгжүүлж болно.

2.Эдийн бус баялагийг энэ хууль, бусад хуульд заасан журмаар, түүнчлэн энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан иргэний эрхийн хамгаалалтын арга, хэрэгслийг хэрэглэх хүрээнд хамгаална.

1058 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх ерөнхий үндэслэл

1.Хувь хүн буюу иргэний эд хөрөнгөд учирсан гэм хор, түүнчлэн хуулийн этгээдийн эд хөрөнгөд учирсан гэм хорыг учруулсан этгээд бүрэн хэмжээгээр арилгана.

Хуулиар гэм хорын хохирлыг гэм хор учруулаагүй этгээдэд арилгуулах үүрэг хүлээлгэж болно.

2.Гэм хор учруулсан этгээд хэрэв түүний буруугаас болж гэм хор учраагүй гэдгийг нотолбол гэм хорыг арилгах үүргээс чөлөөлөгдөнө. Хуулиар гэм буруугүйгээр гэм хор учруулсан ч арилгахаар зааж болно.

3.Хууль ёсны үйлдлээс учирсан гэм хорыг хуульд заасан тохиолдолд арилгана.

4.Хохирогчийн хүсэлт буюу зөвшөөрлийн дагуу гэм хор учирсан бол арилгахаас татгалзаж болно.

Бүгд найрамдах Армен Улсын Олон нийтийн мэдээллийн тухай хууль

7 дугаар зүйл. Мэдээллийн хүрээнд үг хэлэх эрх чөлөөг хязгаарлах

1.Хуулиар нууцад тооцсон буюу эрүүгийн хариуцлага хүлээх үйлдэлд өдөөсөн, түүнчлэн хувийн болон гэр бүлийн халдашгүй байдлыг зөрчсөн мэдээлэл түгээхийг хориглоно.

8 дугаар зүйл. Няцаах болон хариу нийтлүүлэх эрх

1.Хэрэв мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нийтлүүлсэн үйл баримт нь бодит байдалд нийцэж буй эсэхийг нотолж чадахгүй бол тухайн мэдээлэл бодит байдалд нийцээгүйгээс эрх нь зөрчигдсөн этгээд

мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс тухайн бодит бус мэдээллийг няцаахыг шаардах эрхтэй.

2.Мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь няцаах шаардлагыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тухайн мэдээллийг няцаасан, эсхүл няцаахаас татгалзсан талаар шаардлага тавьсан этгээдэд мэдэгдэнэ.

3.Няцаалтыг тухайн мэдээллийн хэрэгслээр хийнэ. Хэрэв ингэх боломжгүй бол няцаалт хийхийг шаардаж буй этгээд хүлээн авахуйц өөр бусад аргыг ашиглана. Няцаалтыг шаардлага хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хийнэ. Хэрэв энэ хугацаанд уг хэвлэлийн дараагийн дугаарт хэвлэгдэн гарахгүй буюу нэг удаа хэвлэгдсэн бол няцаалтыг эхний хэвлэгдэх дугаарт нийтэлнэ.

Няцаалтыг "Няцаалт" гэсэн гарчигтайгаар нийтэлнэ. Няцаалтын хэмжээ, бичгийн хэлбэр, загвар нь бодит бус мэдээлэлтэй ижил байна.

4.Төрийн болон орон нутгийн байгууллагын сонгуульд нэр дэвшигчийн талаарх мэдээллийн няцаалтыг 24 цагийн дотор хийнэ. Хэрэв санал хураахад 24 цагаас бага хугацаа үлдсэн бол няцаалтыг шаардлага хүлээн авмагц хийнэ. Няцаалтыг энэ хугацаанд хийх боломжгүй бол энэ зүйлд заасан хугацааг хэрэглэнэ.

5.Хохирогч этгээд няцаалт хийлгэхээс гадна өөрийн хариуг нийтлэхийг шаардах эрхтэй.

Мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд хариуг няцаалттай хамт нийтэлж болно. Хариу нийтлэгдсэнээр няцаалт хийлгэх шаардлага хангагдсанд тооцно.

6. Хариу нийтлэлийн шаардлагад энэ зүйлд заасан няцаалтын журам нэгэн адил үйлчилнэ.

Хариу нь энэ хуульд харшилж болохгүй бөгөөд мэдээлэлд агуулагдаж буй зөвхөн бодит бус зүйлд хамааралтай байна. Хариу нь тухайн мэдээлэлд хамааралгүй зүйл буюу хариу бичигчийн шүүмжлэлийг агуулах ёсгүй. Хариуны хэмжээ мэдээллийн хэмжээнээс хэтрэхгүй байна. Хариуг үнэ төлбөргүй нийтэлнэ.

7.Няцаалт болон хариу нийтлүүлэх шаардлагаас дараахь тохиолдолд татгалзана:

1/ Нэргүй,

2/ Хуулийн дагуу хүчин төгөлдөр болсон шүүхийн актгүй зөрчилдвөл.

Няцаалттай хамт нийтлүүлэх гэж буй хариу нь энэ хуулийн 7 дугаар зүйлтэй нийцэхгүй бол түүнийг нийтлэхээс татгалзана.

8.Няцаалт болон хариу нийтлүүлэх шаардлагаас дараахь тохиолдолд татгалзаж болно:

1/Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаа хэтэрсэн,

2/Шаардлага нь нийтийн өмнө хэлсэн үг, төрийн байгууллагын албан ёсны баримт бичиг, бусад мэдээллийн хэрэгсэл буюу ямар нэгэн зохиогчийн бүтээл, анхдагч эх сурвалжаар няцаагдаагүй бол.

9.Хэрэв мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд няцаалт болон хариуг нийтлэхээс татгалзсан, эсхүл энэ хуульд заасан хугацааг зөрчсөн бол эрх нь зөрчигдсөн этгээд няцаалт болон хариу нийтлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл. Мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн хариуцлага

1.Мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн үйл ажиллагаа нь хуульд харшилбал хуульд заасан хариуцлага хүлээнэ.

2.Дараахь тохиолдолд мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хариуцлагаас чөлөөлөгдөнө:

1/Мэдээллийг агентлагаас авсан,

2/Нийтийн өмнө хэлсэн үг буюу маргагч талын болон тэдгээрийн төлөөлөгчийн хариу, эсхүл тэдгээрээс гаргасан баримт бичгээс авсан,

3/Нийтийн өмнө хэлсэн үг, төрийн байгууллагын албан ёсны баримт бичиг, бусад мэдээллийн хэрэгсэл буюу ямар нэгэн зохиогчийн бүтээлийн үгчилсэн хуулбар, түүнээс ишлэл авсан бол.

Гурав.
Бүгд найрамдах Казахстан Улсын Иргэний хууль

143 дугаар зүйл. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах

1.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бодит байдалд үл нийцэх мэдээлэл тараасан этгээд тухайн мэдээллээ үнэн зөв гэдгийг нотолж чадахгүй бол иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээхийг шүүхээс шаардах эрхтэй.

2.Хэрэв иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаасан бол тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй няцаах ёстой.

Хэрэв ийм мэдээлэл байгууллагын баримт бичигт агуулагдаж байвал тухайн баримт бичгийг солих буюу өөрчлөх бөгөөд зохих этгээдэд энэ талаар мэдээлнэ.

Бусад тохиолдолд няцаах журмыг шүүх тогтооно.

3.Эрх буюу хууль ёсны ашиг сонирхол нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээллээр зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд үнэ төлбөргүйгээр хариу нийтлүүлэх эрхтэй.

4.Хэрэв олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хариу, няцаалтыг нийтлэхээс татгалзсан, эсхүл нэг сарын хугацаанд нийтлээгүй, түүнчлэн татан буугдаж байгаа бол иргэн, хуулийн этгээдийн няцаалт буюу хариуг нийтлүүлэх тухай шаардлагыг шүүх хянан шийдвэрлэнэ.

5.Хэрэв шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй бол шүүх зөрчил гаргагчид торгууль тавина. Торгууль нь улсын төсөвт орох бөгөөд иргэний процессын хууль тогтоомжоор тогтоосон журам, хэмжээгээр ногдуулна. Торгууль төлсөн нь шүүхийн шийдвэр биелүүлэх үүргээс чөлөөлөхгүй.

6.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаалгасан иргэн, хуулийн этгээд тухайн мэдээллийг няцаалгахаас гадна тэдгээрийг түгээснээс учирсан хохирол болон сэтгэл санааны гэм хорыг шаардах эрхтэй.

7.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан

мэдээлэл түгээсэн этгээдийг тогтоох боломжгүй бол хохирсон иргэн, хуулийн этгээд тухайн мэдээлэл бодит байдалд нийцэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг шүүхээс шаардах эрхтэй.

951 дүгээр зүйл. Сэтгэл санааны гэм хорыг арилгах

1.Сэтгэл санааны гэм хор гэдэг нь эрх зүйн зөрчлийн улмаас хувь хүн, хуулийн этгээдийн эдийн бус баялгийн эрхийг хасах, багасгах, дордуулах, зөрчих (доромжлох, айлгах, дарамтлах, ичээх, бие махбодийн шаналгаа г.м), тэр дундаа сэтгэл санааны болон бие махбодийн шаналгаа юм.

2.Сэтгэл санааны гэм хорыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулагч гэм буруутай тохиолдолд арилгана.

3.Дараахь тохиолдолд сэтгэл санааны гэм хорыг гэм хор учруулагч этгээдийн гэм буруугаас үл хамааран арилгана:

1)Орчин тойрондоо ахуулдай зүйлээс иргэний амь нас, эрүүл мэндэд гэм хор учирсан,

2)Хууль бусаар иргэнийг ялласан, эрүүгийн хариуцлагад татсан, баривчилсан, гэрийн хоригт байлгасан, гадагш явахыг хориглосон, захиргааны журмаар баривчилсан, сэтгэл мэдрэлийн болон бусад эмнэлэгт албадан эмчилснээс гэм хор учирсан,

3)Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл түгээснээс гэм хор учирсан,

4)Хууль тогтоомжийн актад заасан бусад тохиолдол.

4.Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний эд хөрөнгийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйгээс учирсан сэтгэл санааны гэм хорыг арилгахгүй.

952 дугаар зүйл. Сэтгэл санааны гэм хорыг арилгах хэмжээ

1.Сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгана.

2.Сэтгэл санааны гэм хорын хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн зан байдалд учирсан дарамтын субъектив үнэлгээ, хохирогчийн зан байдал болон бие махбодийн шаналгааны түвшинг харуулах объектив баримт сэлтийг харгалзана.

3.Сэтгэл санааны гэм хорыг эд хөрөнгийн гэм хорыг арилгаснаас үл хамааран арилгана.

Бүгд найрамдах Казахстан Улсын Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

19 дүгээр зүйл. Няцаах эрх

1.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бодит байдалд үл нийцэх мэдээлэл тараасан этгээд тухайн мэдээллээ үнэн зөв гэдгийг нотолж чадахгүй бол иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээхийг шүүхээс шаардах эрхтэй.

2.Хэрэв иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаасан бол тухайн

олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй няцаах ёстой.

Хэрэв иймэрэл байгууллагын баримт бичиг агуулагдаж байвал тухайн баримт бичгийг солих буюу өөрчлөх бөгөөд зохих этгээдэд энэ талаар мэдээлнэ.

Бусад тохиолдолд няцаах журмыг шүүх тогтооно.

3.Хэрэв олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хариу, няцаалтыг нийтлэхээс татгалзсан, эсхүл нэг сарын хугацаанд нийтлээгүй, түүнчлэн татан буугдаж байгаа бол иргэн, хуулийн этгээдийн няцаалт буюу хариуг нийтлүүлэх тухай шаардлагыг шүүх хянан шийдвэрлэнэ.

4.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаалгасан иргэн, хуулийн этгээд тухайн мэдээллийг няцаалгахаас гадна тэдгээрийг түгээснээс учирсан хохирол болон сэтгэл санааны гэм хорыг шаардах эрхтэй.

25 дугаар зүйл. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчсөнөөс хариуцлага хүлээлгэх үндэслэл

1.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаасан бодит байдалд үл нийцсэн мэдээлэл түгээсэн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүхэд нөлөөлсөн бол БНКазУ-ын хууль тогтоомжийн актад заасан хариуцлага хүлээнэ.

2.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчсөний хариуцлагыг гэм буруутай төрийн байгууллага болон бусад байгууллагын албан тушаалтан, түүнчлэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, түгээгч, ерөнхий редактор /редактор/, зохиогч хүлээнэ.

2-1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, ерөнхий редактор /редактор/ Үндсэн хуулийн байгууламжийг өөрчлөх, Казахстан улсын бүрэн бүтэн байдлыг алдагдуулах талаар уриалсан, улсын аюулгүй байдалд аюул занал учруулах, дайн, гарал үүсэл, үндэс угсаа, арьсны өнгө, шашны давамгай байдал, хүчирхийлэлд уриалан дуудсан мэдээлэл, садар самуунд уриалсан нь ямар эх сурвалжаас авсныг үл харгалзан Казахстан улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

3.Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад болсон бол Казахстан улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

26 дугаар зүйл. Бодит байдалд үл нийцсэн мэдээлэл түгээсний хариуцлагаас чөлөөлөх тохиолдол

Ерөнхий редактор /редактор/, сэтгүүлч дараахь тохиолдолд бодит байдалд үл нийцсэн мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсний төлөө хариуцлага хүлээхгүй:

1/Хэрэв энэхүү мэдээлэл албан ёсны мэдэгдэл, баримт бичиг агуулагдсан бол,

2/Хэрэв тэдгээрийг зар сурталчилгааны болон мэдээллийн агентлаг

буюу төрийн байгууллагын хэвлэл мэдээллийн албанаас авсан бол,

3/Хэрэв тэдгээр нь төлөөлөх дээд байгууллагын гишүүн, төрийн байгууллага, байгууллага, албан тушаалтан, иргэний албан ёсоор хэлсэн үгний үгчилсан хуулбар бол,

4/Хэрэв тэдгээр нь шууд теле нэвтрүүлэг, эсхүл энэ хуулиар редакторлаж үл болох бичвэрт агуулагдаж байвал,

5/хэрэв тэдгээр мэдээлэл нь энэ хуулийн 18 дугаар зүйлд нийцсэн заавал гаргаж өгөх ёстой мэдээлэлд агуулагдаж байвал.

Дөрөв.
Оросын Холбооны Улсын Иргэний хууль

150 дугаар зүйл. Эдийн бус баялаг

1.Хуулийн дагуу иргэнийг төрснөөс нь эхэлж түүнд хамаарах амь нас, эрүүл мэнд, хувь хүний эрхэмсэг оршихуй, хувийн халдашгүй байдал, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, хувийн болон гэр бүлийн амьдралын нууц, чөлөөтэй зорчих эрх, оршин байх газраа чөлөөтэй сонгох эрх, нэртэй байх эрх, зохиогч байх эрх, эд хөрөнгийн бус амины бусад эрх болон эдийн бус баялаг нь халдашгүй бөгөөд өөр бүсдад шилжихгүй. Хуульд заасан тохиолдолд нас барсан этгээдэд хамаарах эд хөрөнгийн бус амины эрх болон эдийн бус баялагийн хамгаалатыг бусад этгээд, тэр дундаа өв залгамжлагч хэрэгжүүлж болно.

2.Эдийн бус баялагийг энэ хууль, бусад хуульд заасан журмаар, түүнчлэн энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хамгаалалтын арга, хэрэгслийг хэрэглэх хүрээнд хамгаална.

151 дүгээр зүйл. Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх

Хэрэв иргэний эд хөрөнгийн бус амины эрхийг, эсхүл эд хөрөнгийн бус бусад эрхийг зөрчсөн үйлдэл, бие махбодийн болон зан байдлын шаналгаа, түүнчлэн хуульд заасан бусад тохиолдлоор сэтгэл санааны гэм хор учруулсан бол шүүх зөрчил гаргагчид тухайн гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх үүрэг хүлээлгэж болно.

Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тодорхойлохдоо шүүх зөрчил гаргагчийн гэм буруугийн түвшин болон бусад нөхцөл байдлыг харгалзана. Түүнчлэн шүүх гэм хор учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодийн болон сэтгэл санааны шаналгааны түвшинг харгалзана.

152 дугаар зүйл. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах

1.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бодит байдалд үл нийцэх мэдээлэл тараасан этгээд тухайн мэдээллээ үнэн зөв гэдгийг нотолж чадахгүй бол иргэн өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээхийг шүүхээс шаардах эрхтэй.

Нас барсны дараа ч гэсэн иргэний нэр төр, алдар хүндийг сонирхогч этгээдийн шаардлагаар хамгаална.

2.Хэрэв иргэн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гутаасан бол тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр няцаах ёстой.

Хэрэв ийм мэдээлэл байгууллагын баримт бичигт агуулагдаж байвал тухайн баримт бичгийг солих буюу өөрчлөнө.

Бусад тохиолдолд няцаах журмыг шүүх тогтооно.

3.Эрх буюу хууль ёсны ашиг сонирхол нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээллээр зөрчигдсөн иргэн тухайн олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хариу нийтлүүлэх эрхтэй.

4.Хэрэв шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй бол шүүх зөрчил гаргагчид торгууль тавина. Торгууль нь улсын төсөвт орох бөгөөд процессын хууль тогтоомжоор тогтоосон журам, хэмжээгээр ногдуулна. Торгууль төлсөн нь шүүхийн шийдвэр биелүүлэх үүргээс чөлөөлөхгүй.

5.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаалгасан иргэн тухайн мэдээллийг няцаалгахаас гадна тэдгээрийг түгээснээс учирсан хохирол болон сэтгэл санааны гэм хорыг шаардах эрхтэй.

6.Хэрэв нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл түгээсэн этгээдийг тогтоох боломжгүй бол хохирсон иргэн, хуулийн этгээд тухайн мэдээлэл бодит байдалд нийцэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг шүүхээс шаардах эрхтэй.

7.Энэ зүйлд заасан журам нь хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд мөн адил хамаарна.

1099 дүгээр зүйл. Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх ерөнхий зүйл

1. Иргэнд учирсан сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх үндэслэл, хэмжээг энэ хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар тодорхойлно.

2. Эд хөрөнгийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйгээс учирсан сэтгэл санааны гэм хорыг хуульд заасан тохиолдолд нөхөн төлнө.

3. Сэтгэл санааны гэм хорыг эд хөрөнгийн гэм хорыг нөхөн төлснөөс үл хамааран нөхөн төлнө.

1100 дугаар зүйл. Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх үндэслэл

*3. Дараахь тохиолдолд сэтгэл санааны гэм хорыг гэм хор учруулагч этгээдийн гэм бурууг*аас үл хамааран арилгана:

1)Орчин тойрондоо аюултай зүйлээс иргэний амь нас, эрүүл мэндэд гэм хор учирсан,

2)Хууль бусаар иргэнийг ялласан, эрүүгийн хариуцлагад татсан, баривчилсан, гадагш явахыг хориглосон, захиргааны журмаар баривчилсан, засан хүмүүжүүлэх ажил хийлгэснээс гэм хор учирсан,

3)Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл түгээснээс гэм хор учирсан,

4)Хууль тогтоомжийн актад заасан бусад тохиолдол.

1101 дүгээр зүйл. Сэтгэл санааны гэм хорыг арилгах хэмжээ, арга

1.Сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгана.

2.Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг шүүхээс тодорхойлохдоо хохирогчид учирсан сэтгэл санаа болон бие махбодийн шаналгааны шинж, түүнчлэн гэм хорыг арилгах үндэслэл нь гэм хор учруулагч гэм бурууtай бол түүний гэм бруугийн түвшинг харгалзана. Гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үед ухаалаг байдал болон шударга байдлын шаардлагыг харгалзан үзэх ёстой.

Бие махбодийн болон сэтгэл санааны шаналгааны шинжийг шүүхээс үнэлэхдээ сэтгэл санааны гэм хорыг учирсан нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг харгалзана.

ОХУ-ын Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

25 дугаар зүйл. Олон нийтэд мэдээлэл түгээх журам

...Редакц, хэвлэл буюу түгээгч нь зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрхийг зөрчсөн, хуульд заасан болон бусад тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн түгээх үйл ажиллагааг шүүхийн шийдвэрээр дуусгавар болгож болно.

43 дугаар зүйл. Няцаах эрх

Иргэн, байгууллага нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төр, алдар хүндээ гутаалгасан бодит байдалд үл нийцсэн мэдээллийг няцаахыг редакцаас шаардах эрхтэй. Хэрэв тухайн иргэн өөрөө няцаахыг шаардах боломжгүй бол түүний хууль ёсны төлөөлөгч энэ эрхийг эдэлнэ. Хэрэв олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакц түгээсэн мэдээллээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол тухайн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр няцаах үүрэгтэй.

Хэрэв иргэн, байгууллага няцаалтын бичвэрийг өгсөн бол энэ хуульд нийцсэнээр тухайн бичвэрийг нийтэлнэ. Няцаах үүрэг бүхий радио, зурагтын редакц иргэн, байгууллагын төлөөлөгчид өөрсдийн бичвэр болон бичлэгийг унших, үзэх боломж олгоно.

44 дүгээр зүйл. Няцаалт хийх журам

Няцаалтад ямар мэдээлэл бодит байдалд нийцээгүй, тухайн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэзээ, яаж түгээсэн талаарх мэдээллийг заах ёстой. Няцаалт нь бодит бус мэдээлэл гарсан тэр байрлалд, ижил загварын үсгээр "Няцаалт" гэсэн гарчигтайгаар гарах ёстой. Радио болон зурагтын хувьд няцаалт нь хоногийн тэр цагт, тухайн нэвтрүүлгээр гарна. Няцаалтын хэмжээ нь няцаагдаж буй материалаас 2 дахин их байж болохгүй. Няцаалт нь зөвхөн нэг стандарт хуудаснаас бага байх ёстой гэж шаардаж болохгүй. Радио болон зурагтаар нэвтрүүлэх няцаалт нь нэвтрүүлэгч стандарт хуудастай бичвэрийг уншихад шаардагдахаас бага эфирийн цагтай байх ёсгүй.

Няцаалтыг дараахь байдлаар гаргана:

1/7 хоногт 1-ээс доошгүй удаа гардаг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд няцаалт буюу түүний бичвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор,

2/Бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд бэлдэж, төлөвлөж буй дугаарт.

Няцаалт болон түүний бичвэрийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор сонирхогч иргэн, байгууллагад бичгийн хэлбэрээр тухайн хугацаанд няцаалт нийтэлсэн, эсхүл түүнээс татгалзсан үндэслэлийг мэдэгдэнэ.

45 дугаар зүйл. Няцаалт хийхээс татгалзах үндэслэл

Хэрэв тухайн няцаалтын шаардлага, эсхүл түүний бичвэр дараахь зүйлийг агуулж байвал няцаахаас татгалзана.

1/Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг урвуулан ашиглаж байгаа бол,

2/Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт харшилбал,

3/Нэргүй бол.

Няцаалт хийхээс дараахь тохиолдолд татгалзаж болно:

1/Тухайн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр няцаагдчихсан мэдээлэл бол,

2/Тухайн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр няцаагдах ёстой байсан мэдээлэл түгээгдснээс хойш 1 жил өнгөрсний дараа редакцид няцаах шаардлага, эсхүл түүний бичвэр ирсэн бол.

Няцаахаас татгалзсан, эсхүл энэ хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол тухайн мэдээллийг түгээснээс хойш 1 жилийн дотор ОХУ-ын иргэний болон иргэний процессын хууль тогтоомжийн дагуу шүүхэд хандана.

46 дугаар зүйл. Хариу нийтлүүлэх эрх

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр бодит байдалд нийцээгүй, эсхүл иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн мэдээлэл түгээсэн бол хохирсон иргэн, байгууллага тухайн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хариу нийтлүүлэх эрхтэй.

Хариу нийтлэх болон нийтлэхээс татгалзах тохиолдолд энэ хуулийн 43-45 дугаар зүйлд заасан журам үйлчилнэ.

Хариунд хариу нийтлүүлэхэд дараагийн дугаараас өмнө нийтлэхгүй. Энэ журам редакцийн тайлбарт хамаарахгүй.

48 дугаар зүйл. Аккредитац

...Хэрэв сэтгүүлч буюу редакци аккредитацын журам зөрчсөн, эсхүл байгууллагын аккредитацтай сэтгүүлчийн нэр төр, алдар хүндийг гутаасан бодит байдалд үл нийцсэн мэдээлэл түгээсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол сэтгүүлчийн аккредитацийг хүчингүй болгож болно.



49 дүгээр зүйл. Сэтгүүлчийн үүрэг

Сэтгүүлч дараахь үүрэгтэй:

10/ …Сэтгүүлч өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй. Төрөөс сэтгүүлчийг нийгмийн үүргээ гүйцэтгэж байгаа этгээд болохын нь хувьд түүний мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй нь холбоотойгоор нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг нь хамгаалах баталгаа гаргана.

51 дүгээр зүйл. Сэтгүүлчийн эрхийг урвуулан ашиглахгүй байх

…Сэтгүүлч эрхээ иргэн буюу тодорхой бүлэг иргэний нас, хүйс, арьсны өнгө буюу үндэс угсаа, хэл, шашин, мэргэжил, оршин байгаа газар, ажил мэргэжил, түүнчлэн улс төрийн итгэл үнэмшилтэй нь холбоотойгоор гутаах зорилгоор мэдээлэл түгээхэд ашиглахыг хориглоно.

57 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөх

Редакц, ерөнхий редактор, сэтгүүлч дараахь тохиолдолд иргэн, байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан бодит байдалд үл нийцсэн мэдээлэл түгээсэн, эсхүл иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон сэтгүүлчийн эрхийг урвуулан ашигласны төлөө хариуцлага хүлээхгүй:

1/Энэхүү мэдээллийг зайлшгүй өгөх ёстой мэдэгдлээс авсан,

2/Тэдгээрийг мэдээллийн агентлагаас авсан,

3/Тэдгээр нь мэдээлэл хүссэн хариунд, эсхүл төрийн байгууллага, байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын олон нийтийн хэвлэл мэдээллийн албаны материалд агуулагдаж байгаа,

4/Тэдгээр нь төлөөлөгчдийн байгууллага, олон нийтийн байгууллагын хурал, зөвлөлгөөнд оролцогчийн хэлсэн үг, түүнчлэн төрийн байгууллага, байгууллага, олон нийтийн байгууллагын албан тушаалтны албан ёсоор хэлсэн үгний үгчилсэн хуулбар бол,

5/Хэрэв тэдгээр нь шууд теле нэвтрүүлэг, энэ хуулиар редакторлаж үл болох бичвэрт агуулагдаж байгаа бол,

6/Хэрэв тэдгээр нь ОХУ-ын Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль тогтоомжийг зөрчсөний учир хариуцлага хүлээж болох өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, материалын үг, үгчилсэн хуулбар бол.

Хэрэв тухайн үгчилсэн хуулбар нь сурталчилгааны материал нийтлэх ОХУ-ын сонгууль болон ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй бол сонгуулийн үед, ард нийтийн санал асуулгын үед өөр бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн сурталчилгааны материал, тэр дундаа энэ хуулийн 24 дүгээр зүйлийн үйлчлэлд хамаарах мэдээллийн үгчилсэн хуулбар нь сэтгүүлч, ерөнхий редактор, редакц, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

62 дугаар зүйл. Сэтгэл санааны гэм хорыг арилгах

Иргэний нэр төр, алдар хүндийг бодит байдалд үл нийцсэн мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээснээр түүнд сэтгэл санааны гэм хор учруулсан, эсхүл эд хөрөнгийн бус өөр гэм хор учруулсан бол түүнийг шүүхийн шийдвэрээр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнчлэн гэм буруутай албан тушаалтан болон иргэн шүүхээс тодорхойлсон хэмжээгээр арилгана.

V. ХЭВЛЭЛИЙН КОНСУЛТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хууль зүйн үндэсний төвийн хамтарсан судалгаанд Хэвлэлийн консулыг та ямар байгууллага бәйгаасай гэж бодож байна? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 54 нь хувь нь ёс зүйтэй сэтгүүл зүй хөгжүүлэх үндсэн механизм болох учиртай гэж, 46 хувь нь сэтгүүлчдийг хамгаалсан бие даасан бүтэц бүхий байгууллага байх ёстой гэсэн хариулт өгснөөс харахад ёс зүйтэй сэтгүүл зүйг монголд хөгжүүлэх үндсэн хөшүүрэг болсон сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах бие даасан бүтэц бүх хараат бусаар ажилладаг бәйгууллага байгуулах, түүний эрх зүйн үндсийг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажуулж өгөх шаардлагатай гэдгийг харж болохоор байна.

Шведийн хэвлэлийн омбудсман хэрхэн ажилладаг вэ?

Шведийн хэвлэлийн өөрийн зохицуулалтын систем нь хууль, дүрэм журамд тулгуурладаггүй байна. Хэвлэлийн өөрийн зохицуулалтын газар нь Шведийн сонины хэвлэн нийтлэгчдийн холбоо, Сэтгүүлийн хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн сэтгүүлчдийн холбоо, Үндэсний хэвлэлийн клуб зэрэг хэвлэлийн дөрвөн байгууллагаас бүрэн санхүүждэг, сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм. Эдгээр дөрвөн байгууллага Шведийн хэвлэл мэдээллийн байгууллага, радио болон телевизийн ёс зүйн кодыг боловсруулах үүрэг хүлээдэг.

Шведийн Хэвлэлийн консул нь 1916 онд байгуулагдсан бөгөөд дэлхийн ийм төрлийн шүүх байгууллагын хамгийн эртнийх нь аж. Хэвлэлийн консул нь тус байгууллагыг даргалдаг шүүгч мөн дээр дурдсан хэвлэлийн дөрвөн байгууллага тус бүрээс нэг төлөөлөгч, сонины бизнес болон хэвлэлийн байгууллагатай ямар нэг холбоо сулбээгүй олон нийтийн гурван хүний төлөөлөгчөөс бүрддэг байна.

Хэвлэлийн Омбудсманы алба 1969 онд байгуулагдсан. Үндэсний хэвлэлийн клубын дарга, Шведийн хуульчдын холбооны дарга, Парламентын Омбудсманы дарга нараас бүрдсэн тусгай хороо Хэвлэлийн Омбудсманыг томилдог байна.

Хэвлэлийн Омбудсманы алба байгуулагдахаас өмнө сэтгүүл зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Хэвлэлийн консул шийдэж байсан. Өнөө үед өргөдөл, гомдлыг эхлээд Хэвлэлийн Омбудсман авч үзээд, өргөдөл гаргаж



байгаа хувь хүн, хүмүүстэй тохиролцдог байна. Хэвлэлийн Омбудсман нь өөрийн санаачлагаар аливаа хэргийг авч үзэх эрхтэй.

Сонинд нийтэлсэн материал сэтгүүл зүйн ёс зүйг зөрчсөн гэж үзсэн нийгмийн гишүүн хэн боловч Хэвлэлийн Омбудсманд гомдол гаргах эрхтэй. Гэхдээ сонинд нийтлэгдсэн мэдээ материалд холбогдсон хүн гомдлын дагуу тухайн сонинг албан ёсоор шүүмжлэхийг зөвшөөрч байгаагаа бичгээр өгнө.

Өргөдөл гомдол хүлээж авсны дараа Хэвлэлийн Омбудсман хэвлэлээр залруулга хийх эсвэл шүүмжлэлд өртсөн хүний тайлбарыг сонинд тавих эсэхээ шийдэх үүрэгтэй. Хэвлэлийн омбудсман энэ зорилгоор сонинтой холбоо барьж болно. Маргааныг энэ аргаар зохицуулж чадаагүй мөн сэтгүүл зүйн дүрэм журмыг зөрчсөн гэж сэжиглэж байгаа бол Хэвлэлийн Омбудсман байцаалт явуулж болох юм. Үүний дараа Хэвлэлийн Омбудсман сонины хариуцлагатай редакторыг гомдол гаргагчийн бүрүүтгаж байгаа асуултад хариулт өгөхийг шаардах хэрэгтэй. Гомдол гаргасан хүнд сонины хариултанд тайлбар хийх боломж олгоно. Гомдол гаргагч дүрмийн дагуу сонинд нийтлэл гарснаас хойш гурван сарын дотор өргөдөл гаргана.

Байцаалт авч дууссан тохиолдолд Хэвлэлийн Омбудсманд шийдвэр гаргах хоёр хувилбар байна.

1. Тухайн хэргээс үүдэн сонинг албан ёсоор шүүмжлэх шаардлагагүй.

2. Цуглуулсан баримт нь Хэвлэлийн Консул шийдвэр гаргах хэмжээнд ач холбогдолтой.

Хэрэв Хэвлэлийн Омбудсман гомдлыг хэрэгсэхгүй гэж үзвэл гомдол гаргагч шууд Хэвлэлийн Консулд давж заалдаж болно. Хэвлэлийн консул болон Хэвлэлийн Омбудсман өргөдөл, гомдлыг авч хэлэлцсэний дараа гомдол гаргагч шүүх байгууллагад хандахад ямар ч саад тотгор байхгүй.

Хэвлэлийн Омбудсманд гомдол гаргахад үнэ төлбөргүй. Хэвлэлийн Омбудсман хэвлэлийн ёс зүйн асуудлаар олон нийтийн тавьсан асуултанд хариулдаг.

Сайн сэтгүүл зүйн дүрэм журмыг зөрчсөн сонин Хэвлэлийн Консулын бичгээр гаргасан шийдвэрийг нийтэлнэ. Энэ сонин захиргааны арга хэмжээний торгууль төлөх ёстой.

Өнгөрсөн жилүүдэд жил тутам 350-400 гомдол бүртгэж авсан байна. Гомдлын дийлэнх нь хувийн нууцад халдсан, гэмт хэргийн асуудалтай холбоотой байгаа юм. Хэвлэлийн Омбудсманы хүсэлтээр мөн түүний хэрэгсэхгүй гэж үзсэн хэргээр гомдол гаргагч давж заалдсанаар нийт гомдлын 30 орчим хувийг Хэвлэлийн Консул авч үзсэн байна. Гаргасан гомдол үндэслэлгүй мөн гомдол гаргагчийн тайлбар, залруулгыг сонинд нийтэлсэн зэрэг олон шалтгааны улмаас нийт гомдлын 70 орчим хувийг хэрэгсэхгүй болгожээ. Нийт гомдлын 10-15 хувьд Хэвлэлийн Консулын шийдвэрээр сонинг албан ёсоор шүүмжилсэн байна.

Хоёр. Хэвлэл мэдээллийн орчин

Одоогоос 240 жилийн өмнө үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ хуульчлан тогтоосон улс оронд бусдад үзүүлэх, харуулах туршлага байх нь гарцаагүй юм байна. Ард түмний сонгосон төрийн үйл ажиллагааг олон нийтэд бодит байдлаар нь хүргэхийн тулд энэ талаарх мэдээлэл, баримтыг цуглуулах нь (тодорхой цөөн тооны мэдээллээс бусад нь) сэтгүүлчдэд нээлттэй байж чаддаг явдал нь "баялаг" юм .

Засгийн газрын Ерөнхий сайдад ирсэн захидлыг жирийн иргэн хэн ч үзэх эрх олгогдсон нь төр өөрөө "олон түмнийх" гэдгийг шууд нотолно.

Мөн сэтгүүлчид нь өөрийн эрх ашиг сонирхолыг эвлэлдэн нэгдсэн байгууллагаараа дамжуулан бүрэн баталгаажуулж байгаа нь бодит зүйл. Сэтгүүлчдийн холбоо нь аливаа хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, ажил олгогчтой харьцаж гишүүдийнхээ цалин хөлс, урамшуулал, ажиллах нөхцөл, хараат бус байх боломжийг болон хэрэв эрхийг нь зөрчвөл яаж шийдвэрлэхийг ч гэрээ байгуулах замаар тохиролцож байгаа нь "зөв сэтгүүл зүй" хөгжих, хамгийн гол нь сэтгүүлчдийн өмнө тавигдаг гол зарчим болох олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээллийг түгээх бололцоо бүрддэг юм байна.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

УИХ-Д АЖЛАА ТАЙЛАГНАДАГ БУЮУ ХАРААТ БУС ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫГ СУДЛАХ

УИХ-Д АЖЛАА ТАЙЛАГНАДАГ БУЮУ ХАРААТ БУС ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ЭРХ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагын хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээний актуудад хийсэн эрх зүйн дүн шинжилгээний шалгуур үзүүлэлт

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад хийх эрх зүйн дүн шинжилгээний шалгуур үзүүлэлтийг онолын ойлголт болон ЗГ-ын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлагдсан "МУ-ын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж, бүртгэх журам"-ын дагуу дараах байдлаар тодорхойлов:

1.Тухайн байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд батласан байх

2.Захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр нь ямар нэртэй болох /тогтоол, тушаал, дүрэм, журам, захирамж, зарлиг, заавар, зөвлөмж, төлөвлөгөө гм./

3.Хэм хэмжээний акт нь Үндсэн хуулийн үзэл санаа болон үндсэн эрх, түүнчлэн бусад хуультай нийцэж буй эсэх

4.Тухайн шийдвэр нь гадагш чиглэгдсэн эсэх /иргэний эрхийг хөндсөн эсэх/

5.Тухайн шийдвэр нь тодорхой бус тооны этгээдэд буюу нийтэд чиглэгдсэн эсэх

6.Тухайн шийдвэр нь байнгын үйлчлэлтэй эсэх /нэг удаагийн бус/

7.Тухайн шийдвэр нь эрх зүйн зохицуулалт буюу эрх зүйн үр дагаварыг бий болгож буй эсэх

8.Тухайн хэм хэмжээний акт нь холбогдох хуулийг хуулбарлан давхардуулсан, эсвэл агуулгыг нь өөрчилсөн, эсвэл хуулийг орлосон шинжтэй эсэх

9.Тухайн шийдвэрийн үндэслэх хэсэгт үндэслэл болгож буй хуулийн заалтыг дурьдсан эсэх

10.Тухайн шийдвэр нь албан хэрэг хөтлөлтийн шаардлагыг хангаж буй эсэх /огноо, шийдвэр гаргасан этгээдийн нэр, гарын үсэг, тэмдэг, зөв бичих дүрэм гм/

11.Хэм хэмжээний акт гаргах журмыг хангасан эсэх (Тухайлбал хэд хэдэн субъект хамтарч гаргах, эсвэл бусад этгээдийн санал, зөвшөөрлийг авах шаардлагатай хэм хэмжээний актыг зохих ёсоор гаргасан эсэх, акт нь хэлбэрийн хувьд шаардлага хангаж буй эсэх, актыг зохих ёсоор нийтэлсэн эсэх гм)-ийг тус тус шалгана.

12.Шийдвэр нь урьд гарсан шийдвэрийг хүчингүйд тооцож байгаа, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол хүчингүйд тооцож байгаа болон нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа шийдвэрийг батлан гаргасан байгууллага, албан тушаалтны болон шийдвэрийн нэр, огноо, дугаарыг тодорхой заасан эсэх.

УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагын хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээний актуудад хийсэн эрх зүйн дүн шинжилгээ

Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн газар, Монгол банкнаас батлан мөрдүүлсэн актуудыг судалж шинжилгээ хийв.

Судалгааны дүнг байгууллага тус бүрээр үзүүлбэл:

I. Санхүүгийн зохицуулах хороо дангаар болон бусад байгууллагатай хамтран нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ батлуулсан нийт 69 шийдвэр гаргажээ. Үүнээс:

- Тушаал гаргахдаа хуулийн тодорхой заалт үндэслээгүй шийдвэр-69
- Засгийн газрын тогтоолд үндэслэсэн шийдвэр – 0
- Тушаалд ямар нэгэн эрх зүйн актыг огт үндэслээгүй шийдвэр байхгүй
- Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт үндэслэсэн шийдвэр - 0
- БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, шийдвэрт үндэслэсэн шийдвэр -0
- Тухайн шийдвэр нь үндэслэл болгосон хуулийн заалтад нийцсэн-69
- Хуулийн тодорхой зүйл, заалт дурьдсан боловч тэрхүү заалт нь өөрчлөгдсөн, эсхүл хүчингүй болсон буюу тодорхой бус /хуулийн нэрийг ерөнхий заасан/ - 0
- Бусад хуультай зөрчилдсөн шийдвэр байхгүй
- Үндэслэл болгосон хууль байхгүйн улмаас тодорхойлох боломж байхгүй
- Захиргааны дотоод журмын шинжтэй /дотогш чиглэсэн/ шийдвэр-37
- Тухайн салбарт чиглэсэн шийдвэр -37
- Гадагш чиглэсэн шийдвэр -12
- Нийтэд чиглэсэн шийдвэр-12
- Гадагш, тухайн салбарт чиглэсэн шийдвэр -20
- Шийдвэрийн хамтарч гаргах шаардлага хангаагүй байхгүй
- Хэм хэмжээний актын нэрийн хувьд: Журам 46, Заавар 15, Үйлчилгээний хөлс 3, Аргачлал 4, Загвар 3, Маягт 11, Жагсаалт1, Дүрмийн сангийн хэмжээ 1, Түр журам 1, Даатгалын хэлбэр-1, Зөвлөмж 1, Тодорхойлолт 1, Шалгуур үзүүлэлт 3, Мэдээлэл 1 байна.

II. Төрийн албаны зөвлөл дангаараа болон бусад байгууллагатай хамтран гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан нийт 22 шийдвэрийг судлав.Үүнд:

- Тушаалдаа хуулийн тодорхой үндэслэл заасан шийдвэр – 20
- Тушаалдаа хууль болон эрх зүйн аль нэг актыг огт үндэслэл болгож заагаагүй шийдвэр - 2
- Засгийн газрын тогтоолд үндэслэсэн шийдвэр байхгүй
- УИХ-ын тогтоолд үндэслэсэн шийдвэр байхгүй
- Шийдвэрт нь хуулийн үндэслэл дурьдсан боловч үндэслэл болгосон тухайн зүйл, заалт оновчгүй /тухайлбал эрх олгосон заалт биш/, өөрчлөгдсөн /хууль нь шинэчлэгдсэний улмаас/ шийдвэр байхгүй.
- "Хууль хэрэгжүүлэх зорилгоор" гэж хэт ерөнхий байдлаар үндэслэлдээ дурьдсан шийдвэр байхгүй
- Захиргааны дотоод журмын шинжтэй /дотогш чиглэсэн/ шийдвэр- 11
- Шууд бус гадагш чиглэсэн /тодорхой эрх зүйн зохицуулалт агуулаагүй боловч иргэн, хуулийн этгээдэд дагаж мөрдүүлэхээр заасан шийдвэрүүд, тухайлбал зарим төрлийн загвар, маягт гм./ шинжтэй шийдвэр – 6
- Гадагш нийтэд чиглэсэн шийдвэр - 5
- Үндсэн хууль, бусад хуультай зөрчилдсөн шийдвэр байхгүй.
- Хугацааны хувьд байнгын үйлчлэлтэй шийдвэр - 22
- Хамтарч гаргах шийдвэрийн шаардлага хангаагүй шийдвэр байхгүй
- Албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаагүй – 0
- Хэм хэмжээний актын нэрийн хувьд: Журам 23, Зөвлөмж 1, Загвар 4, Заавар 3, Бүрэлдэхүүн 1, Дүрэм 2, Норм 1 байна.

III. Үндэсний аудитын газар дангаараа болон бусад байгууллагатай хамтран гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан нийт 10 тушаалыг судлав. Үүнд:

- Тушаал гаргахдаа хуулийн тодорхой заалт үндэслэн гаргасан шийдвэр - 7
- Хуулийн үндэслэл заагаагүй шийдвэр -3
- Гадагш чиглэсэн акт – 2
- Нийтэд чиглэгдсэн акт -2
- Тухайн салбарт гадагш чиглэсэн акт -8
- Захиргааны дотоод журмын шинжтэй /дотогш чиглэсэн/ шийдвэр- 8
- Тухайн шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хуулийн заалт нь шийдвэрийн агуулгатай нийцсэн - 8
- Тухайн шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хуулийн заалт нь шийвэрийн агуулгатай үл нийцсэн шийдвэр байхгүй
- Үндсэн хууль, бусад хуультай зөрчилдсөн шийдвэр -0
- Хугацааны хувьд байнгын үйлчлэлтэй шийдвэр - 10
- Хэм хэмжээний актын нэрийн хувьд Дүрэм 1, Журам 7, Стандарт 1, Зөвлөмж 1 байна.

IV. Үндэсний статистикийн газар дангаар болон бусад байгууллагатай хамтран гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан нийт 13 тушаалыг судлав. Үүнд:

- Тушаал гаргахдаа хуулийн тодорхой заалт үндэслэсэн шийдвэр-12
- Эрүүл мэндийн сайдын Зөвлөлийн шийдвэрт үндэслэсэн шийдвэр-1
- Гадагш чиглэсэн акт- 11
- Захиргааны дотоод журмын шинжтэй /дотогш чиглэсэн/ шийдвэр- 2
- Нийтэд чиглэсэн шийдвэр- 11
- Тухайн салбарт чиглэсэн шийдвэр -2
- Хугацааны хувьд байнгын үйлчлэлтэй шийдвэр -13
- Эрх зүйн үр дагавар үүсгэсэн шийдвэр - 11
- Эрх зүйн үр дагавар үүсгээгүй шийдвэр - 2
- Тухайн шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хуулийн зүйл заалт нь шийдвэрийн агуулгатай нийцсэн -12
- Үндсэн хууль, бусад хуультай зөрчилдсөн шийдвэр байхгүй
- Хуулийн үндэслэлгүй акт байхгүй.
- Хамтарч гаргах, эсхүл санал, зөвшөөрлийг авах шаардлагыг биелүүлээгүй акт байхгүй.
- Хэм хэмжээний актын нэрийн хувьд: Журам 2, Маягт 3, Ангилал 3, Заавар 1, Түвшин тогтоох 2, Аргачлал 6 байна.

V. Монгол банк дангаар болон бусад байгууллагатай хамтран нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан нийт 57 шийдвэр гаргажээ. Үүнээс:

- Тушаал гаргахдаа хуулийн тодорхой заалт үндэслэсэн шийдвэр -35
- Тушаал гаргахдаа Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл гэх мэтээр хэт ерөнхий байдлаар үндэслэсэн шийдвэр-10
- "Хууль хэрэгжүүлэх зорилгоор" гэж хэт ерөнхий байдлаар үндэслэлдээ дурьдсан шийдвэр -6
- Хуулиар Санхүүгийн зохицуулах хороонд эрх олгосон байхад Монгол банк гаргасан шийдвэр -2
- Төв банк (Монгол банк)-ны тухай хууль, Банкны тухай хуулийн холбогдох заалт гэж үндэслэсэн шийдвэр -1
- Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэсэн шийдвэр -1
- Зөвлөлийн хурлын протоколд үндэслэсэн шийдвэр -1
- Хуулийн буруу зүйл, заалт үндэслэсэн шийдвэр -1
- Үндсэн хууль, бусад хуультай зөрчилдсөн шийдвэр байхгүй
- Тухайн шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хуулийн зүйл, заалт нь шийдвэрийн агуулгатай нийцсэн -53
- Тухайн шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хуулийн зүйл, заалт нь шийдвэрийн агуулгатай үл нийцсэн -4
- Хуулийн буруу зүйл, заалт үндэслэж гаргасан тухайн шийдвэр нь тухайн хуулийн зүйл, заалттай зөрчилдсөн шийдвэр -1
- Хуулиар эрх олгоогүй байхад эрхээ хэтрүүлэн гаргасан шийдвэр -2
- Тухайн шийдвэрийн үндэслэл болгосон хуулийн зүйл, заалт хүчингүй



болсон тул шинэчлэх шаардлагатай шийдвэр -1

- Захиргааны дотоод журмын шинжтэй /дотогш чиглэсэн/ шийдвэр- 15
- Тухайн салбарт чиглэсэн шийдвэр -15
- Эрх зүйн үр дагавар үүсгэхгүй шийдвэр -15
- Гадагш чиглэсэн шийдвэр -17
- Нийтэд чиглэсэн шийдвэр-17
- Гадагш, тухайн салбарт чиглэсэн шийдвэр -26
- Эрх зүйн үр дагавар үүсгэсэн шийдвэр -43
- Хугацааны хувьд байнгын үйлчлэлтэй шийдвэр -57
- Шийдвэрийн хамтарч гаргах шаардлага хангаагүй байхгүй
- Хэм хэмжээний актын нэрийн хувьд: Журам 49, Төлөвлөгөө 1, Тайлан 7, Гэрээ 9, Мэдээ 1, Загвар 3, Удирдамж 1, Түр журам 1, Аргачлал 7, Маягт 7, Заавар 4, Жагсаалт 3, Зөвлөмж 2, Өргөдөл 2, Мэдэгдэл 1, Код 1, Баланс 1, Шимтгэл 2 байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ДҮГНЭЛТ:

Хэм хэмжээний актыг агуулгаар нь нэгтгэж үзвэл:

Тус байгууллагуудаас гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актуудын нийтлэг алдаа нь хуулийн тодорхой заалтыг үндэслэл болгоогүй, хэт ерөнхий байдлаар томъёолсон, хуулиас бусад эрх зүйн акт, баримт бичгийг үндэслэл болгосон хуулийн зүйл, хэсэг нь өөрчлөгдсөн, хүчингүй болсон, хуулиар эрх олгогдоогүй субъект баталсан зэрэг болно. Зарим актын зорилго буюу зохицуулах хүрээ тодорхой бус хэт ерөнхий, түүнчлэн захиргааны байгууллагын дотоод үйл ажиллагааны журмын шинжтэй шийдвэр нилээд байна. Дээрхи байгууллагуудын нийтээр дагаж мөрдөх шийдвэрт дүн шинжилгээ хийж байх явцад дараах зүйл ажиглагдлаа.

Нэр томъёоны хувьд: УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэр нь голчлон тухайн салбарын асуудлаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжоор тодорхойлсон харилцааг нарийвчлах эсхүл тухайн байгууллага, түүний харьяа салбарын үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтыг цэгцлэн сайжруулахад чиглэсэн, "дүрэм", "журам", "заавар", "загвар", "аргачлал", "маягт", "үлгэрчилсэн журам" гэх мэт нэртэй байна.

Дээрх шийдвэрүүд нь хэдийгээр өөр өөр нэртэй боловч зохицуулсан харилцаа, хамаарсан асуудлын хүрээний үүрвь төдийлөн ялгарахгүй байгаа нь нэг талаас хэм хэмжээний актын талаарх эрх зүйн зохицуулалт нь хангалтгүй байгаа, нөгөө талаас захиргааны актыг боловсруулж, батлах улмаар мөрдлөг болгож буй байгууллага, албан тушаалтанд энэ талаар нэг мөр ойлголт, мэдлэг, нэгдсэн арга ажиллагаа илт үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан актын нилээд хэсэг нь зөвхөн тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаа, ажилтанд шууд хамаарсан, гадагшаа буюу нийт /иргэд/-д төдийлөн чиглээгүй, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гэж үзэх үндэсгүй байна. / судалгааны хавсралтаас үзэх/.

УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын эрх бүхий этгээдэд хуулиар эрх олгосон зүйл заалтын ихэнхи нь дотогш чиглэсэн, өөрөөр хэлбэл захиргааны дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт зэргийг зохицуулсан дотоод журмын шинжтэй акт байхаар байна. Тухайлбал: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.4-т зааснаар Үнэт цаасны хороонд брокер, дилерүүдийн мэргэжил, мэргэшлийн түвшин тогтоох болон аттестатчилах журам, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 12.5-т зааснаар Монголбанкинд эрдэнэсийн сангийн бүртгэл, хадгалалт, хяналтын журам, Статистикийн тухай хуулийн 15.1.4-т зааснаар Үндэсний статистикийн хорооны даргад тус хорооны зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах эрхийг тус тус олгосон байна



Судалсан нийт актын дийлэнх хувь нь хууль тогтоомжийн ямар зүйл, заалтыг үндэслэл болгож буйг дурьдаагүй, эсхүл үндэслэл болгосон заалт нь /эрх олгосон зохицуулалт биш/ оновчгүй байгаагаас үзвэл нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан актын хуулийн үндэслэлийг тодорхой зааж хэвшээгүй байна.

Баталж мөрдүүлэхээр төрийн захиргааны төв байгууллагад хуулиар даалгасан шийдвэрийг баталж гаргаагүй, түүнчлэн шийдвэр гаргахад тухайн үед үндэслэл болгосон хууль нь бүхэлдээ хүчингүй болсон, эсхүл түүнд хэсэгчлэн нэмэлт, өөрчлөлт орж, хуулийн зохицуулалт хэлбэр, агуулгын хувьд өөрчлөгдсөн байхад зарим байгууллага нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг шинээр боловсруулж гаргах, хуучныг нь хүчингүй болсонд тооцох, эсхүл шинэчилж өөрчлөх зэргээр хуульд нийцүүлэх арга хэмжээг нэн даруй авахгүй байна.

Хуулийн тодорхой заалтад бус, харин зөвлөлийн хурлын тэмдэглэл, протокол зэрэгт үндэслэсэн шийдвэр нилээд байна.

Шийдвэрийн үндэслэлийг хэт ерөнхий тодорхойлох. Тухайлбал "... хууль хэрэгжүүлэх зорилгоор" гэх мэт.

Үндэслэл болгосон хуулийн заалт өөрчлөгдсөн байтал холбогдох шийдвэрт шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхгүй байх.

Хуульд шаардлагатай хэм хэмжээний актыг гаргахыг үүрэг болгосон байхад зохицуулагдах ёстой харилцаа зохицуулалтгүй байна.

Дээрх байдалд дүгнэлт хийн үзвэл хэм хэмжээний актын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход дараах асуудлыг анхаарах шаардлагатай:

- Хэм хэмжээний акт гаргах эрх олгосон хуулийн заалт тодорхой бус. Эрх олгосон хуулийн заалт хэт ерөнхий учраас зохицуулалтын агуулга, хамрах хүрээ, хэрэгжүүлэх субъект тодорхойгүй акт гаргах боломжтой. Тухайлбал "хууль хэрэгжүүлэхээр холбогдох дүрэм, журам гаргах эрхтэй" гэсэн заалт нь эрх бүхий албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч асуудлаар хэм хэмжээний акт гаргах эрхтэй хэмээн ойлгож болохгүй.
- Хэм хэмжээний актын ойлголт тодорхой бус, нэгдмэл байдалд хүрээгүй байна. Хэм хэмжээний актыг бусад эрх зүйн актаас ялгах шалгуур тодорхой бус байгаагаас улсын бүртгэлд бүртгэх ёстой эрх зүйн акт зохицуулалт хяналтын гадуур хоцрох, шаардлагагүй актыг бүртгэх явдал гарсаар байна.
- Хэм хэмжээний акт зөрчил ихтэй байна. Хэм хэмжээний актыг боловсруулах, батлах, бүртгүүлэх үйл ажиллагааг үе шатаар нь нарийвчлан зохицуулаагүй, түүнд тавих эрх зүйн шаардлага тодорхой бус, эрх ашиг чь хөндөгдсөн субъектын санал бодлыг тусгаагүйгээс зөрчил гарах магадлал ихсэж байна.
- Хэм хэмжээний актын зохицуулах чадавхи муу байна. Хэм хэмжээний актын хэрэгжилтийг хянаж, тогтсон хугацаанд давтамжтайгаар

нэмэлт, өөрчлөлт хийх зохицуулалт байхгүй учир нийгмийн харилцааны хөгжлөөс хоцорч хүнд суртлын эх үүсвэр болж байна. Мөн шаардлагатай хэм хэмжээний акт гарахгүй байгаагаас эрх зүйн зохицуулалт дутагдаж албан тушаалтанд дураараа шийдвэр гаргах боломж бүрдэж байна.

УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллага буюу хараат бус зарим байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг хянах, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх асуудлын хувьд:

Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлсан журмын 5.6-д "Улсын нэгдсэн бүртгэлийг нэг мөр эрхлэн хөтлөх, нийтэд мэдээлэл, лавлагаа өгч байх зорилгоор Үнэт цаасны хороо, Үндэсний статистикийн газар, Монгол банк, Үндэсний аудитын газар зэрэг Улсын Их Хурлаас байгуулдаг төрийн байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авах бөгөөд уг шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж байна гэж үзвэл тухайн байгууллагад зөвлөмж бичиж хүргүүлнэ." гэж заажээ. Эндээс харахад шууд бүртгүүлж хянуулах үүрэг тус журамд заагаагүй учир УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллага нийтээр дагаж мөрдөх шийдвэрээ хянуулан хууль зүйн үндэслэлийг тогтоолгож нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй дутагдалтай байна.

Жишээ нь зарим тушаал нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан байх бөгөөд эдгээрийг ХЗДХЯ-д бүртгүүлээгүй байв. Тухайлбал: Үндэсний статистикийн газрын дарга, Сангийн сайдтай хамтран гаргасан "Мэдээллээр төлбөртэй үйлчилгээ явуулах, статистикийн эмхтгэл, бюллетень, танилцуулга, бусад баримт бичиг хэвлэн нийтлэх үйл ажиллагааны журам", 1998 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 31 дүгээр тушаалаар батлсан, Дангаараа гаргасан "Статистикийн мэдээлэл, тоо материалыг хэвлэмэл болон электрон хэлбэрээр төлбөртэй үйлчилгээ явуулах журам" 2001 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлсан (хавсралтаас үзэх) нь хэм хэмжээ тогтоосон, нийтийн эрх ашгийг тодорхой хэмжээгээр хөндсөн, шууд бусаар гадагш чиглэсэн шинжтэй байна. Гэтэл нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан, заавал биелүүлж байх шинжтэй эдгээр шийдвэрийг улсын бүртгэлд бүртгэх, хянах, хэвлэн нийтлэх, суртчилах талаар зохицуулалт байхгүй байна.

Практикт байгаа алдаанаас харахад жишээ нь Харилцаа холбооны зохицуулах хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан гэж үзсэн журмыг бүртгүүлэхээр ХЗДХЯ-д 2004 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 1/98 тоот албан бичгээр хандсан боловч яамнаас тус хорооны журмыг хянан үзэж бүртгэх эрх ХЗДХЯ-д олгогдоогүй буюу Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор "хамаарах субьект биш " гэж үзээд татгалзсан хариу өгчээ.

Нөгөө талаас ХЗДХЯ-ны холбогдох мэргэжилтэнгүүд Санхүүгийн



зохицуулах хороо л ганцхан нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрээ хянуулахаар ирүүлдэг бусад байгууллага ирүүлдэггүй гэж ярилцлага авч байх явцад хэлж байсан.

Эндээс авч үзвэл Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан журамд үл хамаарах нэрээр нилээд байгууллага нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан журам батлан мөрдүүлж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл эдгээр тушаалыг ХЗДХЯ-д хянаж бүртгүүлэн хууль зүйн үндэслэл, батлан гаргаж буй субъектийн эрх хэмжээний асуудал зэргийг шалгаж хянахгүйгээр, хууль зүйн техникийн хувьд алдаатай, тушаалд хуулийн тодорхой үндэслэл дурьдаагүй, ерөнхий заалт үндэслэн батлан гаргаж, мөрдөж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Иймээс цаашид ЗГ-ын 8 дугаар тогтоолд үл хамрагдаж буй эдгээр байгууллагын шийдвэрийг хянан үзэж зөвлөмж, дүгнэлт хүргүүлдэг байх, улсын нэгдсэн санд бүртгүүлэн иргэдэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зүй ёсны шаардлага байгаа нь харагдаж байна.

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах, батлах, нийтлэх, нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үе шатны хувьд:

УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагын холбогдох мэргэжилтнээс ярилцлага авсан.

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулахад ямар зарчим, стандарт баримтладаг вэ? гэсэн асуултанд Монгол Улсын хууль, олон улсын гэрээ, олон улсын стандарт, гадаад орнуудын туршлага, ХЗДХЯ-наас батлан гаргасан стандарт, зааврыг баримтлан ажилладаг гэж хариулжээ. Өөрийн байгууллагад хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гэсэн оновчтой хариултыг хэн нь ч хэлээгүй бөгөөд нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулахад баримтлах зарчмын талаархи ойлголт муу байна.

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг ямар албан тушаалтан боловсруулдаг талаар тодруулахад тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хуулийн хэлтсийн мэргэжилтэн эсвэл хуулийн зөвлөх боловсруулдаг гэсэн. Хуулийн хэлтсийн мэргэжилтнүүд боловсруулах болон хянах процесст их оролцдог нь ярилцлагын явцад харагдсан.

Боловсруулах шатанд иргэд. иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хэрхэн хангаж байна гэсэн асуултанд тухайн харилцааны оролцох байгууллага, аж ахуйн нэгжүүдээс шаардлагатай үед санал авдаг зарим тохиолдолд санал авдаггүй гэж хариулсанаас харахад олон нийтийн оролцоог сайн хангадаггүй нь харагдаж байна. Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулахад хамгийн их санал авдаг нэгж нь тухайн байгууллагын газар хэлтсүүд, харьяа агентлаг, газрууд байна. Иргэд, олон нийтийн оролцоо тун бага байна.

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулахаас эхлээд аль шатанд хүндрэл тохиолдож байна гэсэн асуултанд боловсруулах, олон нийтээс санал авах, нийтэд мэдээлэх, хэрэгжүүлэх шатанд хүндрэл гардаг

гэж хариулсан байна. Эндээс харахад нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах нэгдсэн зарчим, стандарт, ойлголт байхгүй, байгууллага түс бүр өөр өөрийн гэсэн арга барилаар боловсруулдаг нэгдсэн ойлголт байхгүй байна. УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг улсын нэгдсэн буртгэлд буртгүүлэх, нийтэд мэдээлэл механизм нь тодорхой бус нэгдсэн журмаар зохицуулсан журам байхгүй байна. Танай байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг ямар үндэслэлээр бүртгэхээс татгалзаж байна гэсэн асуултанд ЗГ-ын харьяа байгууллага биш гэсэн үндэслэлээр татгалздаг гэж хариулсан байна. Санхүүгийн зохицуулах хороо л ганцхан ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр материалаа ирүүлдэг бөгөөд ХЗДХЯ бүртгэж авдаг байна.

Танай байгууллагаас гаргасан бүртгэлгүй нийтээр дагаж мөрдөх шийдвэр практикт үйлчилж байна, энэ юутай холбоотой вэ? гэсэн асуултанд Байгууллагуудын хоорондох харилцан уялдаа холбоо муу, бүртгэдэг, хяналт тавьдаг механизм байхгүй учир гэж хариулсанаас үзэхэд УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллага нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг ерөөсөө бүртгүүлдэггүй бөгөөд тэр шийдвэр нь нийтэд болон тухайн салбарт үйлчилдэг байна.

Танай байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар болон цаашид сайжруулах арга замын талаар саналаа хэлнэ үү гэсэн асуултанд олон нийтэд сурталчилах ажиллагааг хүртээмжтэй зохин байгуулах, журам дүрэм батлахаас өмнө судалгаа хийх хэрэгтэй энэ журам хэрэгтэй эсэхийг шийдэх, боловсруулах шатыг боловсронгуй болгох гэсэн саналыг хэлсэн байна.

Чанарын судалгааны аргаар авсан дүнгээс харвал:

- *хэм хэмжээний актыг боловсруулах үе шатанд хэрэгжүүлэгч байгууллага болон иргэд, хувийн хэвшлийнхний санаа бодлыг тэр болгон авч чаддагүй.*
- *боловсруулах үе шатанд иргэд, олон нийт, хувийн хэвшлийнхнийг оролцуулах, хамтран ажиллах хэлбэрийг тодорхойлоогүй, журамд тодорхой үе шат болгон зохицуулаагүй;*
- *хэм хэмжээний актыг бүртгэх эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоогоогүй, эсхүл тусгайлан эрх олгоогүй гэсэн үндэслэлээр буцаадаг. Энэ нь эрх бүхий байгууллага журмыг хэт явцууруулан хэрэглэдэгтэй холбоотой гэж үзсэн;*
- *хариуцлагын тогтолцоо байхгүй;*
- *шийдвэрийг олон нийтэд хүргэх сурталчилах байдал хангалтгүй;*

Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг гаргах үе шатны зохицуулалт, практикийн нэгдсэн дүгнэлт:

- Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, нийтлэх үе шат үндсэндээ зохицуулагдаагүй.
- Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах зарчим тодорхойгүй.

- Хэм хэмжээний актыг боловсруулах болон түүнд нэмэлт, өөрчлөлт хийхэд сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй;
- Хэм хэмжээний актыг хянах ажиллагаа учир дутагдалтай, зохицуулалт муу;
- Хянуулж, буртгүүлээгүй актыг дагаж мөрдөх боломжтой, мөрдүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо байхгүй;
- Хянаж бүртгэх үүрэг бүхий байгууллага /ХЗДХЯ/ ЗГ-ын 2003.1.15-ны 8 дугаар тогтоолоор батлагдсан журмын заалтыг явцуурууллан хэрэглэдэг;
- Хэм хэмжээний актыг хэвлэн нийтлэх, олон нийтэд сурталчилахад уг шийдвэрийг баталсан байгууллага хангалтгүй ажилладаг;
- Хэм хэмжээний актыг бүртгэх, хянах, нийтийн хүртээл болгоход мэдээллийн хэрэгсэл, технологийн шинэ боломжийг ашиглахгүй байна;
- Олон нийтэд түгээх арга зам нь хязгаарлагдмал, хариуцсан албан тушаалтан байхгүй;
- Журмын зарим заалт тодорхой бус тул хэм хэмжээний актын бүртгэл хяналтаас гадуур байх боломжтой;
- Бүртгүүлэх субъект хязгаарлагдмал байна.

Санал:

1.Хэм хэмжээний актыг батлах үйл ажиллагааны бүх үе шатыг нарийвчлан зохицуулах; /олон нийтийн оролцоог хангах/

2.Хэм хэмжээний актыг олон нийтэд хүргэх арга замыг боловсронгуй болгох, үүнтэй холбоотой хөрөнгийг болон хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх;

3.Журам зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг ойлгомжтой болгох;

Хянаж, бүртгэх нэгж байгуулах саналын хувьд:

Саналын хувилбарх 1: УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг хянах ажлыг УИХ-ын тамгын газрын дэргэд нэгж байгуулан бүтэц орон тоо, санхүүгийн асуудлыг шийдэн хариуцуулах нь зүйтэй гэсэн саналтай байна. УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэр ямар ч хяналтгүй, нэгдсэн зохион байгуулалтгүй, нэгдсэн бүртгэлгүй үйлчилж байна. Мөн тус байгууллагаас гаргах нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, нийтэд мэдээлэх асуудлыг зохицуулсан журам шинээр батлах шаардлагатай.

Саналын хувилбар 2: УИХ-аас байгууллагддаг төрийн байгууллага / тухайлбал: Үндэсний Статистикийн газар, Монгол банк, Үндэсний Аудитын газар гм./-аас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг ЗГ-ын 2003.1.15-

ны №8 тогтоолд заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, уг шийдвэр нь хууль тогтоомжид зөрчилдөж байна гэж үзвэл тухайн байгууллагад зөвлөмж бичиж хүргүүлнэ /ЗГ-ын 8 тогтоолын 5.6./. Үүнээс үзвэл УИХ-аас байгууллагддаг төрийн байгууллагаас гаргаж буй хэм хэмжээний акт тодорхой хэмжээнд хянагдах үндэслэлтэй байна тиймээс ЗГ-ын 2003.1.15 №8 тогтоолоор батлагдсан журамд УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг хянах бүртгэх асуудлыг цогцоор нь оруулж ХЗДХЯ хариуцах.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСНИЙ ХУРЭЭЛЭН
www.mn.gov.mn

II БҮЛЭГ

ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДЭЭС ТАВИХ ХЯНАЛТ

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд Үйлдвэрчний эвлэлүүдээс тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь судалгааны ажлыг хийхдээ дараах зорилгыг удирдлага болгон ажиллаа.

Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллагын оролцоо, хяналтыг хэрхэн бүрдүүлэх, улмаар энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөх зэрэгт дүн шинжилгээ хийж, олон нийтийн байгууллагын оролцоог хууль хэрэгжүүлэхэд нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлон санал, дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлэхэд оршино.

Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн зорилтыг дэвшүүлэв: Үүнд:

- Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллагын оролцооны ач холбогдол, өнөөгийн төлөвийг статистикийн болон баримт бичгийн шинжилгээний аргаар судлах;
- Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллагын оролцоо хуулийн хэрэгжилтийн талаарх харьцуулсан судалгаа хийж дүгнэлт хийх;
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад олон нийтийн байгууллагын оролцоо, хяналт ямар байх талаар санал гаргах;

Судалгааны ажлын хүрээнд Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагатай хамтран ажилласан болно.

Судалгааг үндсэн 3 үе шатаар гүйцэтгэлээ: Үүнд:

I. МҮЭХ-ны үйл ажиллагаатай танилцаж, холбогдох мэргэжлийн хүмүүстэй ярилцан, тэднээс санал асуулга авах;

II: МАОЭНХ-ны мэргэжилтнүүдтэй ярилцаж, тэдний саналыг авах;

III. Энэ чиглэлээр Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан зарим нэг конвенцууд холбогдох хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаар хэрэгжилтийг авч үзлээ.

I. Судалгааны ажлын хүрээнд Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоонд 2007 онд зөвлөгөө өгсөн байдалд /хөдөлмөрийн харилцаатай холбоотойг нь түүвэрлэн авсан болно/ анализ хийж, санал асуулгын хуудсаар судалгаа авсан болно.

Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн нэгдсэн Холбооны ажилтан мэргэжилтэн нарын дунд хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээл, хэрэгжилтийг тодруулах үүднээс явуулсан санал



асуулгын байдлыг авч үзвэл энэхүү санал асуулгад нийт 42 хүн оролцсон бөгөөд тэдний асуултанд хариулсан байдлыг тоймлон үзвэл:

1.Хуульд утга агуулга нь ойлгомжгүй хэм хэмжээ байгаа эсэх гэсэн асуултад:

- Бараг байхгүй –56.3 хувь;
- Байхгүй- 43 хувь;
- 10 дугаар бүлэг буюу хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх шаардлага тавих, хариу өгөх нь их хугацаа шаарддаг, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг, хугацаа шат дамжлагыг багасгах-0.8 хувь;
- 111.5 дахь заалтын "... уг шалтгаанаар ажилд авахаас татгалзахыг хориглоно" гэсэн заалт-0,1 хувь;
- 46 дугаар зүйл үндсэндээ ойлгомжгүй, хэрэгжилт нь ч сул байдаг -0,3 хувь;
- 120 дугаар зүйлд салбарын болон үндэсний хэмжээний ажил хаялтыг зохион байгуулах хэм хэмжээг тодорхой заагаагүй гэж 0,1 хувь нь хариулжээ.

2. Хөдөлмөрийн хуулийн зарим нэг нэр томъёо ойлгомжгүй байгаа эсэхийг тодруулахад:

- 129.2 буюу ажлаас буруу халсан, өөр ажилд шилжүүлсэн тухай шүүхэд гомдол гаргах хугацааг 60 хоног болгох;
- Амьдрал дээр ажилтны төлөөлөгч нь хуулийн этгээд байж чадахгүй тул зөвхөн "Үйлдвэрчний эвлэл" байхаар оруулах гэж хариулсан.

3. Утга агуулгын хувьд хоорондоо зөрчилтэйн улмаас нэг мөр хэрэглэх боломжгүй байгаа хэм хэмжээ байгаа эсэх гэсэн асуултад хариулсан байдлыг авч үзвэл:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-тэй 55.2 нь зөрчилддөг;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл. Тус зүйлд ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байхаар заасан атал бас биеэр эдлүүлэхгүй байж болох шинжтэй заалт бий. Ажил олгогч түүнийг буруугаар ашиглаж ажилтныг хохироох явдал цөөнгүй байна;
- "Хамтын хэлэлцээр"-ээр, "Хамтын гэрээ"-гээр зохицуулах асуудлууд давхардаж байна. Жишээ нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.1-д "Хамтын гэрээгээр цалин норм, норматив тогтооно" гэсэн байхад мөн 19.1.2-т салбарын хэлэлцээрээр цалин нормыг тогтооно гэсэн байгаа;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2, 141.1.3 дах хэсэгт "нас" гэж нэмж оруулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д "...хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд заавал бичгээр мэдэгдэх" талаар нэмж оруулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 10 дугаар бүлэгт "улсын, салбарын, нутаг дэвсгэрийн, хамтын хэлэлцээрээс үүдэн гарсан хөдөлмөрийн хамтын маргааныг хэрхэн зохицуулах, хүлээх хариуцлагын талаар" нэмэлт заалтуудыг оруулах зэргээр хариулсан байна.

4. Хөдөлмөрийн тухай хуулийн 42.2-т "бөөнөөр халах үед ажил

олгогч нь ажлаас халагдсаны тэтгэмжийг ажилтаны төлөөлөгчтэй хийсэн хэлэлцээрээр тохирч тогтооно" гэж заасан. Бөөнөөр халах гэдгийг доод хязгаарыг хэд гэж үзэж байна вэ? мөн энэ тохиолдолд тэтгэмжийг ямар хэмжээгээр тогтоож байна вэ? гэсэн нээлттэй асуултад:

- 5 буюу түүнээс дээш, сарын дундаж цалингаар;
- Үүнийг ер нь тоогоор бус аж ахуйн нэгж байгууллага татан буугдсан үед гэж ойлгодог, хамтын гэрээнд заагаагүй бол 1 сарын цалингийн хэмжээгээр;
- Хэд гэж хуульд заагаагүй, гэхдээ энэ тоо 10-аас доошгүй байх нь зөв, халагдахын өмнө авч байсан цалингаар;
- Ихэвчлэн 3 ажилтан гэж үздэг, ажиллах хугацаандаа авч байсан цалин хөлсний хэмжээгээр;
- Хязгаар тогтоох шаардлагагүй, нэг сарын дундаж цалингаар;
- Энэ заалтыг тайлбарлах шаардлагатай энэ заалт их маргаантай байдаг, ялангуяа оёдлын үйлдвэрт энэ чиглэлийн маргаан их гардаг, энэ тохиолдолд тэтгэмж өгөх нь ховор байдаг;
- Ихэвчлэн 3 гэдэг ч байгууллагын ажилтны тооноос хамаардаг, хамтын гэрээнд заасны дагуу тэтгэмж олгох нь зөв;
- Хоёр ба түүнээс дээш ажилтныг халахыг, мөн халагдаж буй ажилтны сарын дундаж цалингаар гэх зэргээр хариулжээ.

5. Ер нь хөдөлмөрийн хамтын маргаанд зуучлагч оролцуулах тохиолдол Монгол Улсад хэр байдгийг судлах зорилгоор энэ чиглэлийн асуулт тавихад:

- Байдаг гэж 7,14 хувь;
- Байдаггүй гэж дийлэнхи олонхи буюу 88,26 хувь нь хариулжээ. Энд нэг хүн зуучлагч нь олон шат дамжлага, хүнд суртлын нэг тул хэрэгжих боломж муу байдаг гэсэн тайлбарыг хийжээ;
- Цөөн тохиолдолд байдаг, гэхдээ энэ нь тийм үр дүнтэй байдаггүй гэж 4.6 хувь нь хариулжээ.

6. Хөдөлмөрийн хамтын маргааныг хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлэх явдал хэр байдгийг тодруулан үзвэл:

- Байдаг гэж 2,38 хувь;
- Байдаггүй гэж 11,90 хувь;
- Цөөн тохиолдолд байдаг гэж 4,76 хувь нь хариулж;
- 80,96 хувь нь энэ асуултанд хариулаагүй байна.

7.Өнөөдөр хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг Хөдөлмөрийн маргаан таслах комисс болон шүүх гэсэн хоёр шатаар шийдвэрлэж байна. Хамтын маргааны хувьд ч мөн адил зуучлагч болон хөдөлмөрийн арбитр гэсэн хоёр шат дамжин шийдвэрлэдэг. Иймд хөдөлмөрийн арбитрт зөвхөн хамтын маргааныг шийдвэрлэх бус ганцаарчилсан маргааныг шийдвэрлэх бүрэн эрх олгох нь хэр үр дүнтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад:

- Хөдөлмөрийн арбитрт ийм эрх олгох нь үр дүнтэй, гэхдээ түүний гаргасан шийдвэр эцсийнх бөгөөд заавал биелэгддэг байх ёстой гэж 9,52 хувь;
- Хөдөлмөрийн маргаан таслах комисс байх хэрэгтэй, Учир нь түүний гаргасан шийдвэрийг давж заалдах боломжтой байдаг учраас талууд эрх ашгаа илүү өргөн хүрээнд хамгаалуулах боломж бүрдэх талтай



гэж 7,14 хувь нь хариулж 83,34 хувь нь хариулаагүй байна.

Санал асуулгын байдлаас үзвэл манай Хөдөлмөрийн тухай хуульд амьдрал дээр бараг хэрэгждэггүй, тунхагийн шинжтэй зүйл заалт нэлээд байгааг харуулж байна. Жишээ нь, хөдөлмөрийн хамтын маргаанд зуучлагч оролцуулах болон хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлнэ гэсэн заалт, мөн Хөдөлмөрийн маргаан таслах комисс үйлдвэр аж ахуйн нэгжид бараг байдаггүй зэргээс харагдаж байна.

Мөн Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны дэргэдэх Судалгааны төвөөс явуулсан "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай" Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 155 дугаар конвенцийн хэрэгжилтийг тандсан судалгаанд хот, хөдөөгийн 525 хүнийг хамруулан явуулсан судалгааны явцыг харвал:

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба байдаггүй 46,3 хувь;
- Үйлдвэрлэлийн ослыг судалж бүртгэдэг орон тооны бус байнгын комисс ажилладаггүй 47,9 хувь;
- Үйлдвэрчний эвлэл хөдөлмөр, хамгааллын итгэмжлэгдсэн төлөөлөгч байдаггүй 37,9 хувь;
- Хөдөлмөр хамгааллын сургалтын танхимгүй 76,2 хувь;
- Хууль тогтоомжийн тухай сургалт сурталчилгаа явагддаггүй 60,4 хувь;
- Хор саармагжуулах бодис, хүнсээр хангадаггүй 41,5 хувь;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцлийг судлан арилгах арга хэмжээ авдаггүй гэж 66,2 хувь нь хариулжээ.

Эндээс дүгнэж үзвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар бүлэг 92, 95 дугаар зүйл туйлын хангалтгүй, түүнд тавих хяналт сул, Үйлдвэрчний эвлэлийн итгэмжлэгдсэн төлөөлөгч муу ажилладагийг нотолж байгаа тэдийгүй хөлсний хөдөлмөр эрхлэгчид жилээс жилд нэмэгдсээр байна.

ОУХБ-ын 87, 98 дугаар конвенцийн хэрэгжилтийн талаар МҮЭХ-ны Эрдэм шинжилгээ сургалтын төвөөс танадсан судалгаа явуулсан бөгөөд үүнийг багцлан үзвэл:[34]

Судалгааны бүтэц, бүрэлдэхүүний хувьд: нийт 500 гаруй иргэн хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдагсдын 10.5 хувь нь 16-25 насны, 27.3 хувь нь 26-35 насны, 34.2 хувь нь 36-45 насны, 21 хувь нь 46-55 насны, 7 хувь нь 55-аас дээш насны иргэд байсан.

Боловсролын хувьд: 52.5 хувь нь дээд, 24.8 хувь нь тусгай дунд, 14.6 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь бүрэн бус дунд, 0.8 хувь нь бага боловсролтой иргэд байлаа.

Ажил эрхлэлтийн салбараар нь үзвэл:

[34] МҮЭХ-ний дэргэдэх Шинжилгээ сургалтын төв. "Хөдөлмөрийн хүний эрхийг хүндэтгэе", дугуй ширээний ярилцлагын материалаас 2004 он, Уб.

№	Ажил эрхлэлтийн салбар	Хувь
1.	Уул уурхай, эрчим хүч	5.3
2.	Барилга	1.3
3.	Тээвэр холбоо, нефть	5.4
4.	Эрүүл мэнд	9.5
5.	Хувийн хэвшил	20.1
6.	Авто зам	-
7.	Худалдаа үйлчилгээ	7.5
8.	ХАА, хүнс, байгаль орчин	16
9.	Төмөр зам	8
10.	Боловсрол шинжлэх ухаан	16.9
11.	Төр олон нийт, соёл урлаг	10

ОУХБ-ын 87 дугаар конвенцийн хэрэгжилтийн талаар

ҮЭ-д чөлөөтэй, сайн дураараа нэгдэх буюу ҮЭ байгуулахад ажилтнуудад ямар саад бэрхшээл байна вэ?		
1.	Хууль зүйн зохицуулалт, баталгаа хангалтгүй	30.2%
2.	Хууль эрх зүйн орчин бүрдсэн ч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй	48.5%
3.	Ажил олгогчоос таагүй хандлаг	12.0%
4.	Бусад хүчин зүйл	9.3%

Дээрхи асуултад хариулсан байдлаас үзэхэд оролцогчдын ихэнхи нь хууль эрх зүйн орчин бүрдсэн ч тэдгээрийн хэрэгжилт тааруу гэж хариулсан нь аливаа хуулийн хэрэгжилт хангалтгүй байдгийг гэрчилж байна.

ҮЭ байгуулахдаа ХЗДХЯ-д бүртгүүлдэг нь ҮЭ-ийг чөлөөтэй, сайн дурын үндсэн дээр байгуулахад саад болдог уу?

1.Тийм –32.8%;

2.Үгүй –35.0;

3.Мэдэхгүй-32.2 хувь нь хариулсан байна.

Судалгаанд хамрагдагсдын багагүй хувь нь тийм гэж хариулснаас үзэхэд энэхүү бүртгэлийн тогтолцоог дахин нягталж үзэх шаардлагатай байна. Мэдэхгүй гэж хариулсан хариултаас харвал ҮЭ-ийн талаархи мэдлэг сул, ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилт мөн хэмжээнд доогуур байгааг харуулж байна.

Үйлдвэр аж ахуйн нэгжид явуулсан судалгааны байдлаас үзэхэд дараахь нийтлэг дутагдлууд ажиглагдаж байна:

- Хөдөлмөрийн гэрээг бараг 100 хувь байгуулдаг ч нэг загвараар хэлбэрдэх байдлаар байгуулдаг;
- Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хангалтгүй;
- Хамтын гэрээ байгуулж зохих журмын дагуу бүртгүүлдэг ч хэрэгжилтийг нь нарийн дүгнэдэггүй, дүгнэх журамгүй, хамтын гэрээгээр зохицуулбал зохих харилцааг бүрэн тусгаж чадаагүй;
- Ажилчдыг өдрийн нормоо биелүүлээгүй гэдэг шалтгаанаар илүү цагаар, шөнийн цагаар ажиллуулдаг, нэмэгдэл хөлсийг зарим үед олгодоггүй, нэмэгдэл хөлсийг бодохдоо хуульд заасан хэмжээгээр

бус 0,5 хувиар боддог, ачаалал ихтэй үед ажилчдыг дараалан шөнийн цагаар хонуулж ажиллуулдаг;

- Хуучин арьс ширний үйлдвэрийн нэгдлийн байранд үйл ажиллагаа явуулж буй МСХ ХХК-ний агааржуулалтын систем ажилладаггүй, ажлын байр нь хэтэрхий бүгчим, чийгшилт багатай, тоосжилт ихтэйгээс ажилчдын хөдөлмөрийн чадварт муугаар нөлөөлдөг;
- Хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулсан хэдий ч хэлбэрийн төдий, шийдвэрлэсэн асуудал байхгүй;
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нийт ажилчдад олгоогүй, жагсаалт байхгүй, эдэлгээний хугацааг тогтоон мөрдүүлээгүй байна.

Иймд дараах зөвлөмжийг өгч байна:

- Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд нэгжийн үнэлгээг хэт доогуур тогтоодог журмыг өөрчлөх;
- Шөнийн болон илүү цагаар ажиллаж байгааг зохих байгууллагууд шалгах;
- Ажилтан ажил олгогчийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулах.

"Хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох нь" үндэсний бага хуралд оролцогчдоос "Хөдөлмөр хамгааллын хууль тогтоомжийн зохицуулалтад Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны" талаархи санал авахад:

1.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага байх зайлшгүй шаардлага;

2.Бүх байгууллагад Үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах;

3.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага хаана ч хангалтгүй ажиллаж байна;

4.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь захиргааны нөлөөнд оршиж байна;

5.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь мэдээлэл сурталчилгаа муу;

6.Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагаа хуулийг боловсронгуй болгох;

7.Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бус байна;

8.Ажилд орсон хүнээс санал авалгүй шууд Үйлдвэрчний эвлэлийн татвар авдаг;

9.Хувийн хэвшилд Үйлдвэрчний эвлэлий үйл ажиллагааг нэвтрүүлэх;

10. Ажиллаж байх хугацаанд нь татвар авчихаад тэтгэвэрт гарахаар нь хаядагаа болих;

11. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын татварыг бууруулах;

12.Цөөн хүмүүс Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын талаар ойлголттой байна;

13. Гадаадын ажил олгогчид хуулийн заалтуудыг байнга зөрчиж үүнд тавих Үйлдвэрчний эвлэлийн хяналт муу;

14. Монголын Үйлдвэрчний эвлэлүүд төрийн ажилтныг хамгаалдаггүй;

15. Үйлдвэрчний эвлэлүүд нь орон тооны бус даргатай учир бусад дээд

байгууллагад санал тавьж чаддаггүй;

16.Үйлдвэрчний эвлэл цэвэр ажилтнуудын эрх ашгийг хангаж ажиллах;

17.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага улс оронд өргөн хүрээтэй ажиллах, хөдөлмөрийн бүхий л үйл ажиллагаанд тэргүүлэх;

18.Үйлдвэрчний эвлэлийн гишүүдэд олгох шагнал урамшуулал хангалтгүй;

19.Цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар Үйлдвэрчний эвлэлийн байгууллага анхаарах;

20.Гишүүддээ үйлчлэх асуудал туйлын хангалтгүй;

21.Үйлдвэрчний эвлэлийн хяналтыг сайжруулах, бие даасан хараат бус байх;

22.Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох;

23.Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, тэтгэвэр авагчдын эрх ашиг хохирсон тохиолдолд бүх нийтийн шинж бүхий ажиллагаа явуулах;

24.Гишүүдийн давуу талыг мэдүүлэх, сургалт явуулах;

25.Үйлдвэрчний эвлэлийн байгууллага татвар авах, хамтын гэрээ байгуулахаас өөр зүйл хийхгүй байна;

Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн нэгдсэн Холбооноос иргэд, байгууллагад зөвлөгөө өгөх чиглэлээр ажилладаг./Энэ талын материалыг ард хавсаргав.[35]/

Товчлон дүгнэвэл: Монгол Улсад хөдөлмөрийн харилцаанд гэрээ хэлэлцээ хийх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь судалгааны явцаас харагдаж байна. Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн нэгдсэн Холбооноос явуулсан судалгааны явцаас харвал зарим үйлдвэр аж ахуйн нэгж компанид Үйлдвэрчний Эвлэл ажиллаж байгаа боловч хамтын гэрээ хэлэлцээрээ байгуулдаггүй, байгуулсан ч тэр хэлбэрийн төдийн өөрөөр хэлбэл, өөрийн үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй буюу ажилчдын гол асуудал болсон цалин хөлсний асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж чаддаггүй. эсхүл хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа, хамтын гэрээг дүгнэх нэгдсэн журам байхгүй байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн өнөөдөр хөдөлмөрийн харилцаанд буюу хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхах явдал газар авсаар байна. Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хууль /Арвандөрөвдүгээр зүйл/, Хөдөлмөрийн хууль /7.2, 7.4, 141.1.3/, Төрийн албаны тухай хууль /4.2.4/, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль /5.1.3, 14.1, 14.1.8, 5.1.3, 17.1.12,/, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль /10 дугаар зүйл/-д ялгаварлан гадуурхаж болохгүй талаар заасан ч энэ нь бодит амьдрал дээр бараг хэрэгжихгүй байна. Өнөөдөр аж ахуйн нэгж байгууллага иргэнийг ажилд авахдаа ажил үүрэгтэй нь холбоогүй шалгууруудыг тавьж байгаа нь цөөнгүй байна. Хамгийн энгийнээр авч үзвэл өдөр тутмын сонин хэвлэлд өгсөн зарын байдлаас үзэхэд ажлын байрны талаархи зар мэдээнд иргэдийг хувийн байдлаар нь илт ялгаварласан, эсхүл аль нэгэнд нь хууль бусаар илт давуу байдал олгосон шинж бүхий шаардлага тавих нь түгээмэл

[35] Хавсралтаар.

энгийн зүйл болжээ. Тухайлбал, банкны харилцагчийн зөвлөх гэсэн сул орон тоон дээр ажилтан авах тухай зард "168-аас дээш өндертэй, гадаад имидж сайн, 38 хүртэлх насны "хүнийг авахаар зарласан бөгөөд иймэрхэлбэрийн зарыг өнөөдрийн бүхий л хэвлэлийн нүүрнээс харж болно. /тус мэдээллийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссийн илтгэлээс ишлэв./

Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрчний эвлэлийн байгууллага төгс утгаараа үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа нь хамтын гэрээ хэрэгждэггүй, ажилчдын эрх ашиг хохирч эцэстээ шүүх хяналтын байгууллагад тэдний хандах явдал жилээс жилд нэмэгдэж байгаа зэргээс харагдаж байна.

Хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийн хэрхэн зохицуулж байгаа нь анхаарал татсан юм. Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасны дагуу ажил олгогч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийг богиносгож энэ тухай хөдөлмөрийн гэрээнд тусгах ёстой байдаг. Хэрхэн богиносгох талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа. Гэсэн хэдий ч заасан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах нөхцлүүдэд энэ асуудал ороогүй байна.

Мөн өрхийн эмнэлгийн үйлчлэгч, жолооч, манаач гэх мэтийн мэргэжилтэй ажилчдыг гэрээт ажилтан гээд тухайн байгууллага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалинжуулж байна.

Энд тэмдэглэх гэсэн гол зүйл бол гэрээт ажилтан гэдэгт хэнийг оруулах, тэдний авч буй цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болох эсэх, тэдэнд хамтын гэрээний заалт хамаарах эсэх талаар нэгдсэн ойлголт хэрэгтэй байна. Гэрээт ажилтан гэдэгт Иргэний эрхийн хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа хүмүүсийг оруулж байгаа бөгөөд эдгээр хүмүүст хамтын гэрээ, хөдөлмөрийн тухай хуульд заасан хөнгөлөлт, урамшууллын эрх зүйн зохицуулалт хэрэгжихгүй байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралт эдлэх боломжгүй байдал үүсдэг байна. Иймд гэрээт ажилтан дээрхи эрхийн зохицуулалт нэгэн адил хамаарахаар зохицуулалт хийх нь зөв болов уу. Мөн сэхээний тасгийн сувилагчийн ажлын нөхцөл хэвийн бус нөхцөлд, харин асрагчийнх хэвийн гэж явагддаг.

ДОХ, арьс, хавдарын кабинетууд ажлын байрны аль нөхцөлд хамаарах вэ? гэсэн асуултуудад хууль зүйн хувьд үндэслэлтэй хариулт өгөхөд хэцүү байна. Учир нь эдгээр асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад журмаар нарийн зохицуулаагүй байгаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-тэй 55.2 дах хэсэгтэй зөрчилддөг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл; Тус зүйлд ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байхаар заасан атал бас биеэр эдлүүлэхгүй байж болох шинжтэй заалт байгаа. Ажил олгогч түүнийг буруугаар ашиглаж ажилтныг хохироох явдал цөөнгүй байна.

"Хамтын хэлэлцээр"-ээр, "Хамтын гэрээ"-гээр зохицуулах асуудлууд давхардаж байна. Жишээ нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.1-д "хамтын

гэрээгээр цалин норм, норматив тогтооно" гэсэн байхад мөн 19.1.2-т "салбарын хэлэлцээрээр цалин нормыг тогтооно" гэжээ.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2, 141.1.3 дах хэсэгт "нас" гэж нэмж оруулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д "...хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд заавал бичгээр мэдэгдэх" талаар нэмж оруулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 10 дугаар бүлэгт "улсын, салбарын, нутаг дэвсгэрийн, хамтын хэлэлцээрээс үүдэн гарсан хөдөлмөрийн хамтын маргааныг хэрхэн зохицуулах, хүлээх хариуцлагын талаар" нэмэлт заалтуудыг оруулах шаардлагатай байна.

Ярилцлагын аргаар хийсэн ажлын дүн:

Тус байгууллагын хөдөлмөрийн харилцааны албаны мэргэжилтэнүүдтэй уулзаж ярилцсан. Үүнийг багцлан авч үзвэл:

- Хөдөлмөрийн тухай хууль нь ажил олгогчид төдийлөн нийцээгүй, социалист хэв шинжийн хууль гэж үзэж байна. Энэ хууль нь томоохон үйлдвэрлэгч, үйлдвэрийн газар, Төрийн өмчит үйлдвэрийн газар, төсвийн байгууллагуудад үйлчилдэг. Хувиараа эрхлэх аж ахуй, хоршоо, малчдад үйлчилдэггүй. Ер нь өнөөдөр малчдын хөдөлмөрийн харилцаа зохицуулагдахгүй байгаа. Тухайлбал, амьдрал дээр малчид бусдыг ажиллуулах явдал их байгаа ч энд бий болсон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан заалт Хөдөлмөрийн тухай хуульд байхгүй байна.
- Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооноос ажил олгогч нарт зориулж сургалт явуулдаг.

Ер нь ажил олгогчид хуулийн нарийн зохицуулалтад дургүй байдаг. Энэ нь ч нэг талаас аргагүй юм. Учир нь тэдний үйл ажиллагааны бүхий л хүрээг зохицуулах нь нэг талаас төр бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хэтэрхий их оролцож байгаагийн илрэл болдог. Иймэрүү нарийвчлан зохицуулсанаар тэдний хувьд хуулиас гадуурхи буюу өөрөөр хэлбэл хууль зөрчих явдал ихэсдэг.

- Мэргэжлийн хяналт жижиг дунд үйлдвэр аж ахуйн нэгжээс хол байдаг. Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтын хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна. Өнөөдөр хяналтыг зөвхөн татвар төлдөг хэдэн аж ахуйн нэгж дээр хийх төдийгөөр л хязгаарлаж байна.
- Төрийн албаны тухай хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.Төрийн аливаа /бүх/ албан хаагч ээлжийн амралтын зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуулиас хардаг. Үүнийг тусгайлсан хуульд нь оруулж өгөх нь чухал.

Мөн төрийн албан хаагчдад илүү цагийн мөнгө олгодохгүй байна.

Баримт бичгийн аргаар хийсэн судалгааны ажлын дүн:

Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооноос Хөдөлмөрийн тухай хуульд зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулах санал дэвшүүллээ. Тухайлбал, энэ ажлын хүрээнд;

- Хөдөлмөрийн тухай хуулийн 49.5-д ажилтан өөрийн буруугаас



хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй бол гүйцэтгэсэн ажилд нь тохирсон хөлс өгч, ажил олгогчид учруулсан хохирлыг барагдуулна гэж шинээр найруулан нэмэх;

- 61.2 дах хэсэгт Мал аж ахуй газар тариалангийн салбарт ажиллагсдын цалин хөлсний 1/3 доошгүй хувьд нь захиалсан буюу тохиролцсон бөөний үнээр бүтээгдэхүүн олгож болно гэж нэмэх;
- 79.8 дах хэсэгт Ажилласан хугацааг тооцох журмыг ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагатай зөвшилцсөнөөр Засгийн газар тогтооно гэж нэмэх;
- 109.6 дах 109.1-109.3 дах зааснаас бусад тохиолдолд хуульд зааснаас доош насны хүүхдийг хөдөлмөрлүүлэхийг хориглоно гэж нэмэх;
- 141.1.18 дах Хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс эхлэн иргэнийг ажилд авсан тушаал гаргаагүй, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээгээгүй, зохих бичилтийг хийж баталгаажуулаагүй, эсхүл эдгээрт саад учруулсан холбогдох бууруулай этгээдийг 30000-60000 төгрөгөөр торгох;
- 23.2.1-д Энэ хуулийн 24.1-д заасан ажилтантай харилцан тохиролцсон хугацаагаар;
- 23.2.2-т Хугацаатай гэрээг гурван жилээс хэтрэхгүйгээр гэдгийг хасах;

Мөн тус байгууллагаас энэхүү судалгааны ажилтай уялдуулан Хөдөлмөрийн тухай хуулийг боловсронгуй болгох зарим санал гаргаж байна.

1.Хөдөлмөрийн тухай хуулийг нийгмийн түншүүд, иргэний нийгмийн өргөн төлөөллийн оролцоотойгоор хянан үзэж үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлт оруулах. Үүнд:

- Албан бус эдийн засагт хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөрийн хуульд хамруулахын тулд "ажилтан", "ажил олгогч", "ажилтны төлөөлөгч", "ажил олгогчийн төлөөлөгч", "хеделмөрийн ганцаарчилсан маргаан", "хөдөлмөрийн хамтын маргаан" зэрэг тодорхойлолтыг өргөтгөх;
- Албадан болон заавал хийлгэх хөдөлмөрийн судалгааг албан бус эдийн засгийг хамруулан хийх, ийм хөдөлмөрийг арилгах арга хэмжээ авах;
- Албан бус эдийн засаг дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлж нэн даруй хориглох;
- Ялгаварлан гадуурхах зарим төрөл, хэлбэрийг (тухайлбал, насаар, үйлдвэрчний эвлэлийн гишүүн гэдгээр, биеийн өндөр, нам, царай зүсээр) тусгах;
- Албан бус эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэгчдийн төлөөлөгчид хамтын хэлэлцээнд оролцох болон хэлэлцэх асуудлыг хязгаарлахгүй байх;
- Албан бус эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн ганцаарчилсан болон хамтын маргааныг зохицуулах хөндлөнгийн арбитрын гурван талт тогтолцоо бий болгох;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг оролцуулан цалин хөлсний бүтэц,

зохицуулалт, хэлбэр гэх зэрэг асуудлыг хамтын гэрээ, хэлэлцээрээр бүрэн зохицуулах бололцоо бүрдүүлэх;

- Засгийн газар, ажил олгогчид, ажилтнуудын болон албан бус эдийн засагт хөдөлмөр эрхлэгчдийн төлөөлөгчдөөс бүрдэх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох асуудал эрхэлсэн Үндэсний комисс байгуулах;
- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн Үндэсний хорооны бүрэлдэхүүнд албан бус эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэгчдийн төлөөллийг оролцуулах;
- Хөдөлмөрийн хяналтын тухай бүлгийг өргөтгөж хөдөлмөрийн улсын хяналтыг хувь хүний хөдөлмөрийн эрх, эрх чөлөөний баталгаа байхын зэрэгцээ урьдчилан сэргийлэх, зөвлөх үүрэг, хариуцлага хүлээдэг, олон нийтийн өргөн оролцоо, нийгмийн түншлэлийн зарчимд тулгуурласан, бие даасан бүтэц болгож өөрчлөх.

2.Ажил, үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон гэрээний төрлүүдийг цөөрүүлэх чиглэлээр Иргэний хуульд өөрчлөлт оруулах.

3.Хөдөлмөрийн тухай хууль албан хэвшилд илүүтэй баримжаалагдсан байгааг харгалзан зарим салбар хууль шинээр гаргах, тухайлбал, гар аргаар ашигт малтмал олборлох тухай, хөдөлмөрийн хяналтын тухай, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хууль зэргийг батлан гаргах.

Товчлон дүгнэвэл: Холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах явцад Хөдөлмөрийн тухай хууль нь томоохон үйлдвэрлэгч, үйлдвэрийн газар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төсвийн байгууллагуудад үйлчилдэг. Хувираа эрхлэх аж ахуй, Хоршоо, малчдад үйлчилдэггүй. Мөн малчдын хөдөлмөрийн харилцаа зохицуулагдахгүй байгаа. Тухайлбал, малчид бусдыг ажиллуулах явдал их байгаа ч энд бий болсон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан заалт Хөдөлмөрийн тухай хуульд байхгүй байна гэдгийг дурьдаж байлаа.

Хяналт шалгалтын хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна. Өнөөдөр хяналтыг зөвхөн татвар төлдөг хэдэн аж ахуйн нэгж дээр хийх төдийгөөр л хязгаарлаж байна гэж мэргэжилтнүүдийн үзэж байгаа нь бас л анхаарвал зохих асуудлын нэг байна.

Аж ахуйн нэгж байгууллагын практикт ажил олгогч нар эрх зүйн мэдлэг дутмаг байдгаас болж ажилтныг хөдөлмөрийн гэрээгүй ажиллуулах, эд хөрөнгийн хохирлыг арилгах баталгаа болгон ажилтнуудаас мөнгө, эд зүйл барьцаалан авах зэрэг зөрчил гаргах явдал цөөнгүй байна. Иймд цаашид ажилтныг ямар тохиолдолд иргэний эрх зүйн гэрээгээр, ямар тохиолдолд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах вэ гэдэгт нэгдсэн ойлголт бий болгон сурталчлах, хөдөлмөрийн сахилгыг ноцтой зөрчих гэсэн ойлголтыг тодорхой болгох шаардлагатай байна. Учир нь энэ үндэслэлээр ажилтан ажил олгогч нарын дунд маргаан гарах явдал их байгаа ба энэ нь шүүхээр шийдэгдсэн хэргийн дийлэнхи хувь буюу 33,6 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Хөдөлмөрийн тухай хуульд хийсэн шинжилгээ:

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгааг хийх явцад түүнд онолын үүднээс шинжилгээ хийн үзэхэд дараах асуудлууд илэрч байна:

- Хөдөлмөрийн тухай хуулийн нэр томъёо гэсэн 3 дугаар зүйлд цалин хөлс, олговор гэсэн нэр томъёонуудын тайлбарыг оруулах хэрэгтэй. Учир нь тус хуулийн 47.1-д цалин хөлс нь үндсэн цалин нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ гэж заасан ба уг нэр томъёоны нарийн тайлбарыг оруулж өгөөгүй байна.
- Төсвийн байгууллагад ажиллагсдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой нэг хүндрэлтэй асуудал бол бага тушаалын ажилчдыг гэрээт ажилтан болгосон явдал юм. Иймд төсвийн байгууллагын бага албан тушаалын ажилчдыг гэрээт ажилчин болгох тухай Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох нь зүйтэй. Учир нь гэрээт ажилчдын цалин хөлс хэтэрхий бага байдаг, гэрээний хугацаа дуусахад ажлаас халагдах магадлал өндөр, нийгмийн баталгаа алдагдсан, оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг нь төрийн сангаас хийхгүй болсон зэрэг сөрөг үр дагавар бий болсоор байна. Засгийн газрын дээрхи шийдвэр нь байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээ заавал байгуулах тухай хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг зөрчсөн бөгөөд иймэ шийдвэр гаргаснаараа иргэдийг ажлын байр, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхсан, төрийн албан хаагчдыг ялгаварласан шийдвэр болсон гэж үзэж болохоор байна.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2.1-д "байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүй", байгуулна гэж заасан мөртөө 23.2.2-т "23.2.1-д заасан хөдөлмөрийн гэрээг талууд харилцан тохиролцсоноор хугацаатай" байгуулна гэж заасан байгаа. Гэтэл эдгээр заалт нь үг зүйн талаасаа зөрчилтэй байна. Иймд 23.2-т "энэ хуулийн 23.2.1-д заасан хөдөлмөрийн гэрээг талууд харилцан тохиролцсоноор хугацаатай байгуулж болно гэж заах нь зөв.
- Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 1-д Ажил олгогч буюу түүний эрх олгосон албан тушаалтан иргэнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй. Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж заасан. Гэтэл төрийн байгууллагын албан хаагчид хөдөлмөрийн гэрээнээс гадна үр дүнгийн гэрээ гэж байгуулдаг.
- Хуулийн 26-р зүйлд хэд хэдэн ажил үүргийг зэрэг гүйцэтгэх үед хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ байгуулж ажиллаж болно гэж заасан. Иймд үр дүнгийн гэрээ, нь бие даасан гэрээний төрөлд багтах боломжтой тул ийм гэрээг давхар байгуулж болох эсэх талаар нарийн зохицуулах хэрэгтэй юм. Мөн зэрэгцсэн гэрээг хөдөлмөрийн гэрээнээс тусад нь байгуулж болох талаар Улсын Дээд Шүүхийн тайлбар хийх хэрэгтэй. Хөдөлмөрийн тухай хуулийн 26.2-т энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд ажилтан хэд хэдэн ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ байгуулан ажиллаж болно гэж заасан. Хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээний талаар нэгдсэн ойлголтыг онолын

түвшинд бий болгох нь чухал байна. Өөрөөр хэлбэл, зэрэгцсэн гэрээг хөдөлмөрийн гэрээнээс тусад нь байгуулсан тохиолдолд энэ нь бие даасан гэрээ болох эсэх, зэрэгцсэн гэрээний нөхцлийг хөдөлмөрийн гэрээний нэг нөхцөл болгон байгуулж болох эсэх талаар нэгдсэн ойлголт хэрэгтэй байна.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1-д заасан үндсэн цалин гэдэгт юуг тооцох талаар Улсын Дээд Шүүхийн тайлбар хэрэгтэй байна. Практикт үндсэн цалинг суурь цалин гэж нэрлээд үүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тодорхойлж байна. Тэгээд нэмэгдэл урамшууллаа суурь гэж нэрлэсэн цалин дээрээ нэмээд үндсэн цалингаа гаргаж байна. Иймд үндсэн цалин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэсэн ойлголтуудыг ялгаж тодорхойлох нь чухал байна. Өөрөөр хэлбэл үндсэн цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хязгаарлагдах эсэхийг тогтоох нь зүйтэй.

Судалгаанаас үзэхэд үйлдвэр, аж ахуй нэгжид тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газрууд янз бүрийн нэмэгдэл олгож байна. Жишээ нь: ур чадварын, удаан жилийн, ирцийн, ур дүнгийн, чанарын, ажил хавсран гүйцэтгэсэний, шөнийн, илүү цагийн гэх мэт. Харин хөнгөлөлтүүд нь хоол унааны, түлээ нүүрсний, сувилалын гэх мэт. Үнэндээ энэ олон хөнгөлөлт, нэмэгдэл нь ажил олгогчид ашиггүй баймаар. Гэтэл бодит байдал дээр эдгээр нь дор дороо өөр өөрийн гэсэн үүрэг гүйцэтгэж байна. Хэрвээ цалин үнэлгээгээ нэмэгдүүлэх гээд тэмцвэл үнэлгээгээ нэмэхгүй хэрнээ хоол унаа гэх мэт хөнгөлөлтүүдээ нэмдэг. Үүний учир нь цалин нэмбэл илүү цагийн хөлс, ажилласан жилийн нэмэгдэлийг нэмэх шаардлагатай болдог. Ер нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалин хөлс гэдгийг үндсэн цалин гэж өөрчлөх нь үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын асуудлыг цэгцлэх талтай. Иймд эдгээрийг нэг тийш нь цэгцлэх нь зөв болов уу

- Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1-д долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна гэж заасан. Гэтэл энэ зохицуулалтанд илүү цагаар дээд хязгаарыг буюу ажилтан долоо хоногт хэдэн цагаар илүү ажиллаж болохыг заагаагүй байна.

Дийлэнхи тохиолдолд Оёдлын үйлдвэрүүдэд ажилтан сард 80 цагаар илүү ажиллаж байгаа нь шалгалтаар тогтоогдсон байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2-т хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол хуульд зааснаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно гэж заасан. Үүнээс үзвэл илүү цаг санаачлахыг нэг талаасаа хориглосон байхад нөгөө талаасаа илүү цагийн хөлс өгөхийг хуулиар тогтоосон нь зохих хөлсийг нь өгвөл илүү цагаар ажиллахыг зөвшөөрсөн шинжтэй байна. Илүү цагийн хөлсийг хуулинд 1.5 буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгохоор заасан. Байгууллагууд ч хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээндээ ингэж тусгасан байдаг. Гэвч бодит байдал дээр илүү цагийн хөлсийг 0.5 хувиар л бодож олгож байна. Гэтэл их багадаа гол учир байгаа бус харин илүү цагийн хөлс өгч байгаа гэдэгтээ л учир нь оршиж байна. Нэгэнт л илүү цагийн хөлс өгсөн болохоор ажилтныг хэдэн цаг ажиллуулах

нь ажил олгогчийн эрхийн асуудал болж байна. Иймд хуулиар энэ асуудалд зарим нэг хязгаарлалт тогтоох нь зүйтэй.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1, 99.2-д заасан заалтыг тус хуулийн 141.1.7-д хавсарган тусгах. Учир нь 99-р зүйлд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангаагүй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох хаах талаар заасан заалт нэг талаасаа хариуцлагын шинжийг агуулж байна.
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.1, 97.12-т заасан. Түүнээс дээш удаа гэдэгт албан ёсны тайлбар хийх нь зөв. Хуульд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлсон байдаг. Иймд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиас нь хамаарч нөхөн төлбөрийг хэдэн удаа олгох тал дээр тайлбар хийх шаардлагатай.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1 дэх заалтанд тайлбар хийх хэрэгтэй. Тайлбар хийх шаардлагыг тодорхойлохын өмнө нэгэн жишээг авч үзэх нь илүү дөхөмтэй болов уу.

СБД-ийн шүүхээр 2005 оны 5 дугаар сарын 9-нд шийдвэрлэгдсэн нэгэн хэргийг авч үзвэл: Нэхэмжлэгч нэхэмжлэлийн үндэслэлдээ хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацаанд ажил тасалж ноцтой зөрчил гаргасан гэсэн үндэслэлээр ажлаас халсан тушаал гаргасан нь үндэслэлгүй гэжээ. Харин хариуцагч тал нэхэмжлэгч хүүхэд асрах чөлөө авах тухай хүсэлтээ бичгээр гаргаж тушаал гаргуулан авааг үл ажил тасалсан ноцтой зөрчил гаргасан гэж үзэн ажлаас халсан гэж мэдэгдсэн. Нэхэмжлэгч 2001-08-31-нд Интер банкинд ня-бо-гоор ажиллаж байгаад 2004-01-06-ны өдрөөс ээлжийн амралт, дараа нь үргэлжлүүлэн жирэмсэний амралтаа авч 2004-03-28-нд төрж хүүхэдтэй болсон. Ажил олгогч 2004-01-05-ны өдөр нэхэмжлэгчид ээлжийн амралт олгох тухай тушаал гаргасан бөгөөд харин жирэмсэний болон амаржсаны дараах амралт, хүүхэд асрах чөлөө олгох талаар тушаал гаргаагүй байна. Хариуцагч нэхэмжлэгчийг хөдөлмөрийн дотоод журам зөрчин хүүхэд асрах чөлөө авах талаар бичгээр хүсэлт гаргаагүй тул хөдөлмөрийн гэрээгээ ноцтой зөрчсөн гэж үзэн ажлаас халсан гэж тайлбарласан. Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.4, 100.1, болон 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно. Иймд шүүх Хөдөлмөрийн тухай хуулийн 128.1.2-т заасны дагуу нэхэмжлэгчийг ажилд нь эргүүлэн тогтоох тухай шийдвэр гаргасан. Үүнээс үзэхэд нэг талаас хариуцагчийн тайлбар хууль зүйн үндэстэй байна. Учир нь Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д "..... өөрөө хүсвэл....." гэж заасан нь ажилтан байгууллагад хүсэлтээ гаргаж байж чөлөө авна гэсэн утгыг илэрхийлж байна.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 116.1 дэх хэсгийн эвлэрүүлж зохицуулна гэдгийг хэрхэн ойлгох талаар тайлбар хийх шаардлагатай. Мөн 117 дугаар зүйлд заасан зуучлагч гэдэгт ямар шаардлага тавигдах талаар хуульд тусгах. 118 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн хамтын

маргааныг зуучлагчийн оролцоотой хэлэлцээд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд тухайн шатны засаг дарга ажлын гурван өдөрт багтаан хөдөлмөрийн хамтын маргааныг хэлэлцэх хөдөлмөрийн арбитрыг байгуулж арбитрчдыг томилно гэсэн заалтын тухайн шатны засаг дарга гэдэгт аль шатны засаг дарга хамаарахыг тодруулах, цаашлаад хөдөлмөрийн арбитрчдыг засаг дарга бус маргааны талууд өөрсдөө сонгох боломжтой болгох нь зүйтэй. Учир нь арбитрын гол онцлог нь талууд өөрсдөө арбитрчаа сонгож, маргаанаа шийдвэрлүүлдэг. Яг өнөөдрийн хөдөлмөрийн арбитрыг үзвэл арбитр гэхээс илүүтэй Хөдөлмөрийн маргаан таслах комисстой төстэй шинжтэй байна. Түүнчлэн нэгэнт л арбитраар хамтын маргааныг шийдвэрлэх бол зуучлагч гэсэн дамжлагыг хасах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагч бус харин арбитраар шийдвэрлүүлэхээр тусгах нь зүйтэй.

- Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 132.3 дахь хэсэг буюу туршилт, тохируулгын явцад гарсан зайлшгүй хохирлыг ажилтнаар төлүүлж болохгүй гэсэн заалтын зайлшгүй хохирол гэдэгт юуг тооцох талаар тайлбар хийх нь зүйтэй.
- Хөдөлмөрийн тухай хуулийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх нь чухал байна. Учир нь одоогийн Хөдөлмөрийн тухай хуульд заасан торгуулийн хэмжээ нь 5000-250000 төгрөг хүртэл байгаа бөгөөд энэ нь хариуцлага гэсэн утгаараа хэрэгжиж чадахгүй байна. Торгуулийн хэмжээ харьцангуй бага байгаа учраас зөрчлийг давтан үйлдэх өөрөөр хэлбэл хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг удаа дараа давтан гаргах явдал байсаар байна. Зөвхөн торгуулийн хэмжээг нэмээд зогсохгүй сануулж торгосоор байтал удаа дараа зөрчил гаргаж буй этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах хариуцлага ногдуулбал үр дүнтэй юм.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнийг насаар ялгаварлахыг хориглоно гэж заах.
- Сүүлийн үед хөдөлмөрийн харилцааны хүрээнд албадлагын шинжтэй хөдөлмөрийн хэлбэрүүд газар авч байна. Тухайлбал, ажил олгогч ажилтныг хуульд зааснаас гадуур үндэслэлээр мөн тулган шахаж /тулган шахаж гэдгийг хэрэв илүү цагаар ажиллахгүй бол ажлаас хална гэх мэтээр сүрдүүлэх гэдгээр ойлговол илүү дөхөм болов уу/ илүү цагаар амралтын өдрөөр ажиллуулах, ийнхүү ажиллуулсаны хөлсийг хуульд заасан хэмжээгээр олгохгүй байх явдал их байна. Энэ нь ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтай үйлдвэр аж ахуйн нэгжид ихээхэн гарч байна. Жишээ нь, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах оёдлын АТМ компани нь захиалгаа хугацаанд нь дуусгах зорилгоор маш олон удаа илүү цагаар ажиллуулсан. Өнгөрсөн 3 дугаар сард 3 шөнө хонуулж ажиллуулчихаад нөхөн амраагүй зэрэг зөрчил нь хөдөлмөрийн харилцаанд албадлагын шинжтэй хөдөлмөр



байсаар байгааг харуулж байна.[36]

Мөн түүнчлэн ажилтанд олон давхар янз бүрийн ажлыг нэгтгэн өгч бүгдийг гүйцэтгүүлсэн атлаа цалин хөлсийг бүрэн олгохгүй зэрэг албадлагын шинжтэй хөдөлмөр байна.

- Хөдөлмөрийн норм, нормативийг үндэслэл муутай, нэг талын санаачилгаар хэт өндөр, үнэлгээг хэт бага тогтоож, буйгаас болж ажилчид хохирох явдал байна. Хөдөлмөрийн үнэлгээ нормативд нэгдсэн хяналт бодлого үгүйлэгдэж байна. Хөдөлмөрийн тухай хуулийг зөрчсөн дотоод журам боловсруулж мөрдөх явдал байсаар байна. АОСС ХХК дотоод журамдаа "ажиллавал зохих өдрийн цаг нь 2 долоо хоногт 88 цаг байхаар заасан" нь Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1, 70.2 дугаар зүйлийг зөрчиж байна. Түүнээс гадна малчдын хөдөлмөрийн харилцааг одоогийн Хөдөлмөрийн тухай хуулиар бараг зохицуулаагүй гэж үзэж болохоор байна.
- Иргэний хуулийн 369 дүгээр зүйлд Иргэн нь иргэн, хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж болно. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл журмыг хуулиар тогтооно. Хуульд өөрөөр заагаагүй бол хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн ерөнхий үндэслэлийг хэрэглэнэ гэж заасан. Үүнээс үзвэл хөдөлмөрлөх харилцааг дан ганц Хөдөлмөрийн тухай хуулиар бус Иргэний хуулиар давхар зохицуулсан нь энэ харилцаа ямар их ач холбогдолтой болохыг харуулж байна. Иргэний хуулийн дээрхи зохицуулалтаас үзэхэд хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийг гол удирдлага болгох нь харагдаж байна. Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль хоёрын хооронд ямар зөрүүтэй асуудал байгааг авч үзвэл:

1 Хөдөлмөрийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эрхийн хязгаарлагдмал чадамжтай буюу бүрэн чадамжгүй этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг уг ажилтан ажил үүргээ гүйцэтгэхгүй болсон өдрөөс хүчин төгөлдөр бус гэж үзнэ хэмээн заасан. Гэтэл Иргэний хуульд 56 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт эрх зүйн чадамжгүй этгээдтэй хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцохоор заасан. Үүнийг тодорхойлох болсоны гол учир нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ шууд хүчин төгөлдөр бусад тооцогддоггүй юм бэ гэсэн асуудал гарч байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дээрхи заалтууд хоорондоо зөрчилдөж байна гэж үзэж болохоор байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт мэдэгдлийг хүлээн авсан хариуцагч урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгож тухайн ажилтныг урьдах ажилд нь эгүүлэн тогтоосноор шийдвэр биелэгдсэнд тооцно гэсэн заалтад ямар нэгэн баталгаа алга байна.

[36] Уг эх сурвалжийг нийслэлийн хүний эрхийн сэлбар зөвлөлийн Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад хүний эрх, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан тухай тайлангаас ишлэв.

Өөрөөр хэлбэл, ажил олгогч ажилтныг мэдэгдлийн дагуу ажилд эргүүлэн тогтоосон ч маргааш нь түүнийг ажлаас халах тохиолдол байдаг байна. Энэ нь Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэлбэрийн төдий шинжийг агуулж байгаа юм. Энэ тохиолдолд яах ёстой вэ? гэсэн асуулт гарч байдаг. Хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6 дахь хэсэгт тайлбар хийх хэрэгтэй. Хөдөлмөрийн тухай хуульд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тохиолдлуудыг заасан. Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай шүүхийн шийдвэр гартал төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй тохиолдол их байна. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түр /төлбөрийн чадвартай болтол нь/ түдгэлзүүлдэг. Ингээд л хариуцлагын механизм сул байдаг нь харагдаж байна. Мөн эд хөрөнгийн хариуцлагын хувьд өөрийн нэр дээр бие даасан эд хөрөнгөгүй этгээдийн хувьд ихээхэн хүндрэлтэй байдаг. Жишээ нь, орон сууцны хувьд тухайн орон сууц хамтын эзэмшлийн үед эд хөрөнгийн хариуцлагын хохирлыг нөхөн төлөх болоход бусдынх нь эрх ашиг хөндөгддөг. Түүгээр зогсохгүй байр эзэмших гэрчилгээн дээр төлбөр төлөгчийн нэр байхгүй бол төлбөр төлүүлэх асуудал ихээхэн хүндрэлтэй байдаг нь харагдлаа.

Хөдөлмөрийн маргаан таслах комиссийн талаархи эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг дүгнэн үзвэл:

Хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэх маргааныг тухайн байгууллагад Хөдөлмөрийн маргаан таслах комисс байхгүйн улмаас 2007 онд шүүхээр хянан шийдвэрлүүлсэн тохиолдол шийдвэрлэсэн нийт хэргийн 8,04 хувийг эзэлж байна. Иймээс Хөдөлмөрийн маргаан таслах комисс, Хөдөлмөрийн арбитрыг ажиллуулж, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх нь чухал юм. Ингэснээр нэг талаас шүүхийн ачаалал буурах, нөгөө талаас маргалдагч талуудын хувьд ч ашигтай юм. Наад зах нь маргаанаа шийдвэрлүүлэх гээд цаг алдах нь багасах талтай.

Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Нэгдсэн Холбооноос хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой явуулж буй үйл ажиллагааг авч үзвэл:

Хедөлмөрийн харилцаанд гэрээ хэлэлцээ хийх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь судалгааны явцаас харагдаж байна. Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Нэгдсэн Холбооноос явуулсан судалгааны явцаас харвал зарим үйлдвэр аж ахуйн нэгж компанид Үйлдвэрчний Эвлэл ажиллаж байгаа боловч хамтын гэрээ хэлэлцээрээ байгуулдаггүй, байгуулсан ч тэр нь хэлбэрийн төдий өөрөөр хэлбэл, өөрийн үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй буюу ажилчдын гол асуудал болсон цалин хөлсний асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж чаддаггүй, эсхүл хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа, хамтын гэрээг дүгнэх нэгдсэн журам байхгүй байгаа нь харагдлаа.

Өнөөдөр үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрчний эвлэлийн байгууллага төгс утгаараа үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа нь нөгөө л хамтын гэрээ хэрэгждэггүй, ажилчдын эрх ашиг хохирч эцэстээ шүүх

хяналтын байгууллагад тэдний хандах явдал жилээс жилд нэмэгдэж байгаа зэргээс харагдаж байна.

Хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийг хэрхэн зохицуулж байгаа нь анхаарал татсан юм. Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасны дагуу ажил олгогч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажлын цагийн богиносгож тухайн ажилтны хөдөлмөрийн гэрээнд тусгах ёстой байдаг. Хэрхэн богиносгох талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа. Хөдөлмөрийн гэрээнд тусгах ёстой хэдий ч мөн л Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах нөхцлүүдэд энэ асуудал ороогүй байна.

Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Хөдөлмөрийн тухай хэрэгжилтийн төлөв байдлын талаар өгсөн дүгнэлтийг авч үзвэл:

Аж ахуйн нэгж байгууллагын практикт ажил олгогч нар эрх зүйн мэдлэг дутмаг байдгаас болж ажилтныг хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр ажиллуулах, эд хөрөнгийн хохирлыг арилгах баталгаа болгон ажилтнуудаас мөнгө, эд зүйл барьцаалан авах зэрэг зөрчил гаргах явдал цөөнгүй байна. Иймд цаашид ажилтныг ямар тохиолдолд иргэний эрх зүйн гэрээгээр, ямар тохиолдолд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах вэ гэдэгт нэгдсэн ойлголт бий болгон сурталчлах, хөдөлмөрийн сахилгыг ноцтой зөрчих гэсэн сйлголтыг тодорхой болгох шаардлагатай байна. Үүнээс нь энэ үндэслэлээр ажилтан ажил олгогчийн дунд маргаан гарах явдал их байгаа ба энэ нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн дийлэнхи хувь буюу 33,6 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 39.1 дэх заалттай холбоотой маргаан гарах нь цөөнгүй байдаг ба энэ асуудлыг зохицуулсан эрхийн зохицуулалт алга байна. Өөрөөр хэлбэл, ажил олгогч гэрээг цуцлах тухай өргөдлийг ажилтанд өгөөд 30 хоног дуусаагүй байхад ажилтан өргөдөл өгсөн гэдгээр шалтаглан ажлаа орхих, захиргаа ажилтантай тохиролцоогүй бол гэрээг цуцалж, ажилтныг ажлаас чөлөөлөх тухай гаргасан шийдвэр нь хууль зөрчсөн болдог. Иймд ажилтан хөдөлмөрийн сахилга зөрчсөн, захиргаа бусдыг хууль бусаар ажлаас халсан буруутайд тооцогддог тул энэ талын маргааныг хэрхэн шийдвэрлэх нь эрх зүйн зохицуулалтгүй байна.

III. *ҮЭ-ийн эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ, конвенц ба үндэсний хууль тогтоомж, тэдгээрийн уялдаа*[37]

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажилтан, ажил олгогчдын эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах болон хамтын гэрээ хэлэлцээр хийх эрх чөлөөг олон улсын эрх зүйгээр хамгаалан баталгаажуулсан байдаг. ХҮТТ-ийн 20 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 22 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар зүйлд эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхийн талаар тодорхой тусгагдсан.

Хөдөлмөрийн салбарт хүний үндсэн эрхийг хамгаалахад олон улсын хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан гэрээ, конвенцууд

[37] Харьцуулсан судалгааг хавсралтаар үзүүлэв.

чухал үүрэгтэй байна. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын гэрээ хэлэлцээр хийх эрх чөлөөг ОУХБ-ын дараахь гэрээ конвенцоор баталгаажуулжээ.

- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар конвенц;
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай 1949 оны 98 дугаар конвенц;
- Үйлдвэрийн газарт ажиллагчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 135 дугаар конвенц;
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 151 дүгээр конвенц;
- Хамтын хэлэлцээрийн тухай 1981 оны 163 дугаар конвенц;
- Мөн дээрхи гэрээ конвенцийн заалттай холбоотой дараахь зөвлөмжийг гаргасан:
- Хамтын хэлэлцээрийн тухай 1951 оны 91 дүгээр зөвлөмж;
- Үйлдвэрийн газарт ажиллагчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 143 дугаар зөвлөмж;
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 159 дүгээр зөвлөмж;
- Хамтын хэлэлцээний тухай 1981 оны 163 дугаар зөвлөмж.

Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/ болон Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль /1991он/, Төрийн бус байгууллагын тухай хууль /1997он/, Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/, Иргэний хууль /2002 он/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003 он/ болон бусад холбогдох хууль тогтоомжоор ажилтан, ажил олгогчийн үүсгэл санаачилгын байгууллагыг байгуулах болон үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн. Тухайлбал, Үндсэн Хуулиар иргэний нийгмийн болон өөрийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс байгууллага байгуулах эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан. Мөн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлд: "Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүй өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй. Төрийн бус байгууллага байгуулах иргэдийн эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглоно. Төрийн бус байгууллагад албадан оруулахыг хориглоно" гэж заасан байна. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: "Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр ҮЭ-д чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. ҮЭ-д гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй" гэжээ. Хууль тогтоомжоор хөдөлмөрийн харилцаанд оролцогчид эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхээ ҮЭ, ТББ байгуулах замаар эдлэх боломжийг баталгаажуулж өгсөн. Өнөөгийн практикт ихэвчлэн ажил олгогчдын хувьд

ТББ байгуулах, ажилтны хувьд ҮЭ байгуулах замаар эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамгаалах үйл ажиллагаа явуулж байна. Ажилтан, ажил олгогчийн эвлэлдэн нэгдэх эрхийн хүрээнд дараахь асуудал анхаарал татаж байна. Үүнд:

- Төрийн зарим албан хаагчдын ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрх;
- Төрийн байгууллагад удирах албан тушаалтны эвлэлдэн нэгдэх эрх;
- ҮЭ байгуулах, гишүүнээр элсэх боломжгүй субьектын асуудал.

ОУХБ-ын 87 дугаар конвенц нь тухайн улсад ажиллаж буй гадаадын харьяат ажилтан, ажил олгогчийн хувьд ч хамаарах юм. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д: "Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмын дагуу төрийн бус байгууллага байгуулах буюу төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж болно" гэж заасан.

Түүнчлэн МАОЭНХ-ны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1-д: "тус байгууллагын дүрмийг хүлээн зөвшөөрсөн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажил олгогч, хөрөнгө оруулагчид гишүүнээр элсэж болох"-ыг заажээ. *87 дугаар конвенцийн хүрээнд баталгаажсан ҮЭ-ийн байгууллагын үндсэн эрхийн нэг бол үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохоос хамгаалагдах эрх юм. Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд энэ эрхийг баталгаажуулж, хамгаалах үр дүнтэй механизм, хариуцлагын тогтолцоо бий болгох үүргийг конвенцид оролцогч улсууд хүлээсэн. ҮЭ-ийн эрхийн тухай хуульд заасан ҮЭ-үүдийг захиргааны журмаар тараах, үйл ажилгааг нь зогсоох, мөшгин хавчих зэргээр үйл ажиллагаанд нь саад учруулах болон байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан ҮЭ-ийн сонгуульт ажил гүйцэтгэхийг хориглосон, мөн ҮЭ-ийн өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах заалт нь ҮЭ-ийн үйл ажиллагаанд ажил олгогч хөндлөнгөөс оролцохоос хамгаалах зорилготой юм. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан төрөөс хараат бус байх зарчим ч дээрхи эрхтэй нягт уялдаатай билээ. Байгууллагын энэхүү эрхэд халдсан этгээдэд хариуцлага оногдуулах тухай заалт Хөдөлмөрийн тухай хуульд бий. Мөн уг хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.10-д хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах, санал зөрүүтэй асуудлаараа талууд санал солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хөндлөнгөөс оролцсон иргэн, албан тушаалтанд Байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох хэлбэр нь энэ зүйлд заасан тохиолдлоос хавьгүй олон төрөл хэлбэртэй байж болох юм. Тэрчлэн байгууллагын яланхуяа, ҮЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ажил олгогчийн зүгээс хөндлөнгөөс оролцох тохиолдол практикт нэлээдгүй байдаг боловч байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос хамгаалагдах эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлагын тогтолцоо хангалттай биш байна.*

Эвлэлдэн нэгдэхийн эсрэг алагчлах үйлдлээс хамгаалуулах эрх хангагдахад ҮЭ-ийн сонгуульт ажилтны хувьд эрхээ эдлэх нэмэлт баталгааг үндэсний хууль тогтоомжоор тогтоосон байх нь чухал. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд болон Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д хэдийгээр ийнхүү ҮЭ-ийн сонгуульт ажилтны эрхээ эдлэх баталгааг зааж өгсөн боловч энэхүү эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага тодорхой бус байна.

Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх ба ҮЭ-ийн байгууллага байгуулах эрхийн хэрэгжилт[38]

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр ҮЭ-д чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.

- Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй;
- ҮЭ-ийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхийн үндсийг тодорхойлон заасан байдаг. МҮЭХ-ны 2004 оны бүтэн жилийн мэдээгээр МҮЭ-ийн нийт 184118 гишүүн байгаагаас аймгуудад 103619 гишүүн, салбар холбоодын дүнгээр 80499 гишүүн байна.

1990 онд МҮЭ-ийн гишүүдийн тоо 624800 байсан бол 15 жилийн дараа буюу 2004 онд 184118 болж 3.4 дахин багассан нь дараахь үндсэн шалтгаантай:

- Өмнөх тогтолцооны үед ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрх сайн дурын гэх боловч хэрэг дээрээ ажилтан, албан хаагч бүр ҮЭ-ийн гишүүн байх ёстой гэж тэднийг бүртгэн батлах олгож байсан.
- Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж дангаар ноёрхож байсан улсын үйлдвэрийн газруудыг эрчимтэй хувьчилж, тэнд ажиллаж байсан ихэнхи ажиллагсад ажилгүй болж тэд аяндаа ҮЭ-ийн гишүүн биш болсон. Тэрчлэн үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудыг хувьчилж авсан ихэнхи ажил олгогч өөрт ҮЭ-ийн байгууллага байхыг хүсээгүй буюу тэдгээрийн үйл ажиллагааг дэмжээгүйгээс ҮЭ-ийн байгууллага тарсан.
- Шинээр үүсэн байгуулагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэхийн ач холбогдлыг ойлгож, эрхээ хэрэгжүүлэх талаар санаачилга гаргадаггүй.

Судалгаанд хамрагдсан 1085 хүний 19,2 хувь нь буюу арван хүн тутмын хоёр нь ҮЭ-д элсэх хүсэлтэй гэж хариулсан, энэ бол бага тоо биш юм.

ҮЭ-д элсэх хүсэлтэй болон хүсэлгүй байгаа хүмүүсээс ҮЭ-д элсэхэд хэн саад болдгийг сонирхон судлахад тухайн хүн өөрөө санаа тавьдаггүй,

[38] ХЭҮК. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2006 он.

ажил олгогч эзэд буюу дарга, захирал болон удирдлагаас шалтгаалж ҮЭ-д элсэхийг төдийлөн шамддаггүй гэжээ. Зарим албан байгууллага, хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар ҮЭ байхгүй тул гишүүнээр элсэх боломжгүй гэж цөөн тооны хариулагч үзсэн байна.

Үүнээс гадна МҮЭОХ-ноос ҮЭ-ийн гишүүдийн бүртгэлийг шинэчлэн нэрчилсэн бүртгэлийн сан байгуулах замаар ҮЭ-ийн гишүүнчлэлийг МҮЭ-үүдийн нийтлэг дүрмийг хүлээн зөвшөөрч татвараа төлсөн гишүүдээр тооцох, гишүүдийн тооны давхардлыг арилгах, гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилах зэргээр мэдээллийн багтаамжийг өргөжүүлэх, боловсронгуй болгох, арга хэмжээнүүдийг авч байгаа нь ҮЭ-ийн гишүүдийн тоонд нөлөөлсөн байна /МҮЭХ-ноос 2000-2004 онд хийсэн ажлын тайлан, 2004 он, номны 1 дүгээр тал/.

МҮЭ-ийн нийт гишүүд 2004 оны байдлаар 184118 байхад Үндэсний статистикийн газрын 2004 оны бүтэн жилийн тайлан мэдээгээр улсын хэмжээнд 950.5 мянган ажилтан байна. Үүнээс үзэхэд МҮЭ-ийн нэг гишүүнд ҮЭ-ийн гишүүн бус 5 ажилтан ногдож байна.

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх замаар хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо эрхээ хамгаалуулах явдал нэн чухал бөгөөд хөдөлмөрийн энэхүү харилцаанд хөдөлмөрлөх болон түүнтэй холбоотой бусад эрхээ ажилтнууд хамгаалуулах гол баталгааны нэг бол ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ сайн дураараа зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх явдал юм.

Одоо төрийн захиргааны төв, орон нутгийн ихэнхи байгууллагын дэргэд ялангуяа, төрийн захиргааны төв байгууллага болон яам, агентлагуудын дэргэд ҮЭ-ийн байгууллага үндсэндээ байхгүй байна.

Төрийн үйлчилгээний байгууллагуудын дэргэд ҮЭ-ийн байгууллагууд ажиллаж байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сургууль, эмнэлэг, цэцэрлэг, соёл урлагийн байгууллагуудын дэргэд ҮЭ-ийн хороо, бүлгүүд бий.

Хэвийн сайн ажиллаж байгаа ҮЭ-ийн байгууллага цөөнгүй байна. Төр, засгийн үйлчилгээний авто баазын дэргэдэх ҮЭ-ийн хороо нь баазын нийт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийг хангах талаар хамтын гэрээнд тодорхой асуудлыг тусган ажил олгогчтой хамтран мууг үйлладаг нь шалгалт судалгааны үед ажиглагдсан. Тэрчлэн нийслэлийн СХД-ийн 10 жилийн 42 дугаар дунд сургууль, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 жилийн сургуулийн дэргэдэх ҮЭ-ийн хороо сургуулийн захиргаанаас багш, ажилчдын цалин хөлс, нэмэгдлийг бүрэн олгохгүй хохироосныг зохих тэмцэл хийж шаардлага тавьж байсны дүнд хохирлыг арилгуулж хамтын гэрээний заалтыг биелүүлэхийн төлөө анхаарч ажилладаг байна. Ажиллагсад ҮЭ-ийн гишүүдийнхээ хөдөлмөрлөхтэй холбоотой эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын төлөө уйгагүй тэмцдэг санаачлагатай ажилладаг, хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж, ажил олгогчдод санал шаардлага тавьж хамтран үр бүтээлтэй ажилладаг ҮЭ-ийн байгууллага, сонгуультнууд цөөнгүй байна.

Төв, орон нутгийн ҮЭ-ийн анхан шатны 188 байгууллагын сонгуультнаас асуулга авахад 23 байгууллага буюу 11.7 хувь нь ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагаанд ажил олгогч болон зарим байгууллага хөндлөнгөөс оролцож элдэв дарамт шахалт үзүүлдэг гэж хариулжээ. Мөн санал асуулгад хамрагдсан 1085 хүний 44 хүн буюу 4.1 хувь нь ҮЭ-ийн байгууллагаас ажиллагчдын эрх ашгийг хамгаалахад байгууллагын захиргаа буюу ажил олгогч эздээс бэрхшээл учруулдаг гэж хариулсан ба үүнийгээ дараахи байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Байгууллагын захиргаанаас ажилтнуудын тавьсан асуудлыг хүлээж авдаггүй бөгөөд санал бодлыг ойлгодоггүй, ажилтнуудын дунд буруу суртал хийлээ гэж зэмлэх буюу ажлаас хална гэж дарамталж, эсхүл дотоод журамтай нийцэхгүй гэдэг.
- Хамтын гэрээ байгуулахад саад хийдэг, ялангуяа хувийн хэвшлийн байгууллагад эл байдал их байдаг, дарамт үзүүлдэг, илүү цаг ажиллсаны хөлс олгодоггүй.
- Амралт, сувилалд явуулдаггүй, тусламж дэмжлэг, хөнгөлөлт үзүүлдэггүй хэмээн тус тус үзсэн байна.

Мөн түүнчлэн ажил олгогч нь ажиллагсдыг ҮЭ-д элссэн, ҮЭ-ийн байгууллага байгуулсан, түүний үйл ажиллагаанд оролцсон, захиргааны үйл ажиллагааг шүүмжилсэн гэдэг үндэслэлээр ажлаас халсан, сахилгын шийтгэл оногдуулах явдал цөөнгүй байна.

ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн 6.5-д "....Үйлдвэрийн газар, байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажлыг хэвсран гүйцэтгэж болохгүй." гэж заасан. Зарим аж ахуйн нэгж байгууллагад дэд захирал, менежер, боловсон хүчин зэрэг удирдах албан тушаалтан, ҮЭ-ийн хорооны дарга, сонгуультны ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь ажилтнуудын эрх ашгийг хамгаалахаасаа илүү ажил олгогчийн эрх ашгийг илүүд үзэх хандлага багагүй байна.

Мөн хуулийн 6.4-т "Үйлдвэрчний эвлэл, түүний сонгуульт ажилтныг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл, боломлоогоор хангах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтанд хамтын гэрээ нийт ажилтны нэг адил хамаарна." гэж заасан. МҮЭХ-ны Эрдэм шинжилгээ, сургалтын төвөөс 1085 иргэдийн дунд санал асуулга явуулсан бөгөөд ҮЭ болон түүний сонгуульт ажилтны ажиллах нөхцөлөөр хангасан гэж 593 иргэн буюу 54.7 хувь үзсэн бол 432 иргэн буюу 39.8 хувь нь хангаагүй, 60 иргэн буюу 5.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Ажил олгогч болох аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, захирал, эздүүд эрх ашгаа хамгаалах, үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлийг хамтран тодорхойлж ажиллахын тулд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж байгууллага байгуулах эрхийг ОУХБ-ын 87, 98 дугаар конвенц, МУ-ын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулдаг

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 87 дугаар конвенцийн 5 дугаар зүйлд: "ажилчид ажил олгогчийн байгууллага нь эвсэл холбоо болон ийм төрлийн бусад байгууллага байгуулах, тэдгээрт нэгдэх эрхтэй" гэж заасан.

МАОЭНХ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн эзэд, захирлуудын санаачилгаар байгуулагдсан, гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус, төрийн бус хувийн хэвшлийн ажил олгогчдыг төлөөлсөн үндэсний хэмжээний ажил олгогчдын байгууллага юм.

Уг холбоо нь нийслэл болон 21 аймагт бүгд 22 салбартай, нийтдээ 7900 гаруй гишүүн байгууллагатай, аймаг бүрт байгаа ажил олгогч эздийн холбоо нь мөн биеэ даан эвлэлдэн нэгдсэн гишүүнчлэлтэй байдаг.

Монгол Улсад албан бус эдийн засгийн салбар бодитой оршин тогтнож байгаа билээ. Албан бус салбарт ажиллагсадын эрх, ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилготой ҮЭ байхгүй, харин сүүлийн үед зарим төрийн бус байгууллага үүсч бий болж байна. Монголын хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбоо, Хувийн таксины үйлчилгээ эрхлэгчдийн холбоо, Ардын аж ахуйтны холбоо, Жижиг бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх төв, ганзагын наймаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллагсдын эрх ашгийг хамгаалах тэгш эрх нийгэмлэг зэрэг ТББ байгууллагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр ТББ нь хэв шинжийн хувьд гишүүддээ үйлчилдэг ТББ-ын хэлбэртэй бөгөөд ихэнхийх нь үйл ажиллагаа тогтвортой бус, үр дүн нь хязгаарлагдмал, санхүүгийн эх үүсвэргүйгээс олон улсын төсөл, хөтөлбөрөөс хараат байдалтай байна.

ХЭҮК-ийн хийсэн судалгааны хүрээнд албан болон албан бус салбарын 1085 иргэдээс авсан санал асуулгаар нийт оролцогчдын 66.3 хувь нь эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж, ҮЭ-ээс өөр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага байгуулах нь зүйтэй гэж үзжээ.

Албан бус салбарт ажиллагсдыг төлөөлсөн байгууллага төлөвшиж үйл ажиллагаа нь тогтворжиж чадаагүйгээс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд байгууллагддаг хамтын хэлэлцээрт тэдгээр хүмүүсийн эрх, нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн асуудлууд төдийлөн тусгагдахгүй байна. Гэхдээ ҮЭ-ийн холбоод энэ ажлыг албан бус салбарынхныг төлөөлөн гүйцэтгэж байна. Тухайлбал, Нийгмийн зөвшлийг хангах 2002-2003 оны улсын хэлэлцээрийн 16-р зүйлд "МУ-ын Засгийн газар, эзэд, хоршоологчдын болон ҮЭ-үүдийн улсын хэмжээний байгууллагууд албан бус хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сүлжээг 2003 онд бий болгоно" гэсэн заалт оруулсан ба цаашид албан бус эдийн засгийн салбарт ажиллагсад өөрсдийн бие даасан ҮЭ байгуулж, одоо үйл ажиллагаа явуулж буй ҮЭ-үүдтэй хамтарсан төлөөлөгч томилох замаар эсхүл ҮЭ-ийн холбоодод гишүүн байгууллагаар элсэж, улмаар тэдгээр холбоодын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох үндсэн дээр зохих түвшний хамтын хэлэлцээрт оролцох боломжтой болно.

Хамтын гэрээний хэрэгжилтийн талаар:

Хөдөлмөрийн тухай хуульд "хамтын гэрээ гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог" хэлнэ гэж заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагын түвшинд хамтын гэрээ байгуулан хэрэгжүүлж байна. Харин хамтын хэлэлцээр нь байгууллж буй түвшин, хугацаа, хэлбэр, оролцогч талууд, зохицуулж буй асуудал зэргээрээ хамтын гэрээнээс ялгагдах ба Хөдөлмөрийн тухай хуульд "хамтын хэлэлцээр гэж иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамтран хамгаалах зорилгоор улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, салбар, мэргэжлийн хүрээнд ажил олгогч, ажилтны төлөөлөгчид, төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан тохиролцоог" хэлнэ гэж заасан.

ОУХБ-ын 98 дугаар конвенц болон Хөдөлмөрийн хууль тогтоомжийн заалтуудыг үндэслэн аж ахуйн нэгж байгууллагууд ҮЭ-ийн хороод хамтын гэрээ хэлэлцээр байгуулж биелэлтийн явцыг хянаж дүгнэж байгаа. Зарим ажил олгогч захиргаа хамтын гэрээ байгуулах талаар ажилтны төлөөлөгч болон ҮЭ-ийн хорооноос тавьсан санал, мэдэгдлээс татгалзах, зайлсхийх, байгуулсан хамтын гэрээг хэрэгжүүлэхгүй байх зэрэг зөрчил гарсаар байна. Жишээ нь шалгалтад хамрагдсан ҮЭ-ийн хороотой 202 аж ахуйн нэгж байгууллагаас 45 нь буюу 22.3 хувь нь хамтын гэрээ байгуулаагүй байна. Байгууллагын захиргаа, ажил олгогчийн зүгээс хамтын гэрээ байгуулахаас татгалзаг, зайлсхийдэг гол үндэслэл нь хамтын гэрээгээр ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө шаарддаг явдал байна.

Хамтын гэрээгээр ямар харилцааг зохицуулж болохыг Хөдөлмөрийн тухай хуулийн 18-р зүйлд тодорхой заасан. Гэхдээ зарим аж ахуйн нэгж байгууллага энэ заалтыг хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байгаа нь сайшаалтай юм. Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 тоот тушаалд "хамтын гэрээ хэлэлцээрийг төрийн захиргааны байгууллагаас бүртгэх, биелэлтэд нь хяналт тавих журам"-д зааснаар ажил олгогч нь өөрийн оршин байгаа сум дүүргийн ЗДТГ-т хамтын гэрээг түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй. Гэтэл хамтын гэрээг уг журмын дагуу бүртгүүлэх, түүнд тавих хяналт нь сул байгаа нь ийнхүү бүртгүүлж хуулийн хүчин төгөлдөр болоогүй хамтын гэрээ цөөнгүй байгааг гэрчилнэ.

Судалгааны ажлаас дэвшүүлсэн санал

"Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд Үйлдвэрчний эвлэлүүдээс тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь" сэдэвт судалгааны ажлын эцэст дараахь санал зөвлөмжийг дэвшүүлж байна:



Хөдөлмөрийн тухай хуульд:

1.Хөдөлмөрийн тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэсэн хэсэгт "аж үйлдвэрийн салбар" гэсэн нэр томъёог тусгах буюу аж үйлдвэрийн салбар гэдэгт юуг оруулах талаар Улсын дээд шүүхээс тайлбар хийх;

2.Ажил олгогч нар өөрийн аж үйлдвэртээ ажиллуулж байгаа 18 насанд хүрээгүй бүх хүний болон тэдгээрийн төрсөн огноог тусгасан бүртгэл хөтөлж буй эсэхэд тавих хяналт, шалгалт болон энэ талаар Хөдөлмөрийн тухай хууль, бусад тушаал зааварт тусгаж байх талаар хуульд тусгах. Аж үйлдвэрийн салбарт 15 наснаас доош насны хүүхэд авч ажиллуулж байгаа ажил олгогч нарт тооцох хариуцлагын механизмыг чангатгах, улмаар Хөдөлмөрийн тухай хуульд энэ тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлон заах;

3.Аж үйлдвэрийн салбарт 15 наснаас доош насны хүн ажиллуулсны улмаас насанд хүрээгүй ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин зэрэгт өртсөн тохиолдолд тэдгээрт нөхөн төлбөрийг нэн даруй олгож байх талаар байгууллага бүр хамтын гэрээ, болон хөдөлмөрийн гэрээндээ тусгах, насанд хүрээгүй ажилтны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх тал дээр тусгайлсан журам гаргах, тэдгээрийг холбогдох байгууллага бүр нь хэрэгжүүлэх, эсрэг тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох;

4.Илүү цагийн хөдөлмөрийн хөлсийг цаг тухайд нь өгч байх, хэрэв ингээгүй тохиолдолд ажил олгогчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;

5.Халдварт өвчний голомтод ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудад ажилласан хугацаанд нь цалингийн нэмэгдэл буюу онцгой нөхцлийн нэмэгдэл олгож байх;

6.Байгалийн гамшиг, халдварт өвчний голомт зэрэгт ажиллаж байгаа ажилтанд онцгой нэмэгдэл олгож байхаар хуульчлах;

7.Хөдөлмөрийн норм, нормативыг үндэслэлтэй гаргаж байх, энэ талаар нэгдсэн журам гаргаж мөрдүүлэх;

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "насаар ялгаварлан гадуурхах, хязгаарлах, давуу байдал тогтоох" гэж нэмэх; Мөн "үгүйсгэн гадуурхах" гэж нэмэх;

8.Хуулийн 7.2-т заасан ажилтан гэдгийг "ажилд орох гэж буй иргэн" гэж өөрчлөх;

9.Хөдөлмөрийн тухай хуулийн 141.1.3-т заасан хариуцлагын хэмжээг нэмэх;

10.Хүүхдийг илүү цагаар ажиллуулахыг хориглох талаар Хөдөлмөрийн тухай хуульд тусгах;

11.Ажил олгогчид хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа зөвхөн нэг хэлбэрийн загвар өгөөд ажилтнаар гарын үсэг зуруулж байгаа өнөөгийн практикийг өөрчлөн гэрээг хоёр тал харилцан тохиролцож байгуулах, ажил олгогчийн

зүгээс хөдөлмөрийн гэрээний зарим нөхцлийг тулган хүлээлгэхгүй байх;

12.Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1-д заасан үндсэн цалин гэдэгт юуг тооцох талаар Улсын Дээд Шүүхийн тайлбар хийх; Өөрөөр хэлбэл үндсэн цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хязгаарлагдах эсэхийг тогтоох:

13.Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1-д долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна гэж заасан. Гэтэл энэ зохицуулалтанд илүү цагаар дээд хязгаарыг буюу ажилтан долоо хоногт хэдэн цагаар илүү ажиллаж болохыг заагаагүй байна. Иймд илүү цагаар ажиллуулах хязгаарыг тогтоох, илүү цагийн хөлсийг тухайн үед нь тооцох, эсхүл биеэр нөхөн амруулах асуудлыг хуульчлах;

14.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.1, 97.12-т заасан. Түүнээс дээш удаа гэдэгт албан ёсны тайлбар хийх; Хуульд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлсон байдаг. Иймд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиас нь хамаарч нөхөн төлбөрийг хэдэн удаа олгох тал дээр тайлбар хийх; Мөн хуулийн 106.1 дэх заалтанд тайлбар хийх;

15.Хөдөлмөрийн тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх;

16.Хамтын гэрээ, хэлэлцээрийг зөрчсөн бууруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;

17.Хамтын гэрээг бүх байгууллага байгуулах асуудлыг хуульчлах.

<u>ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль:</u>

1.ҮЭ-ийн гишүүд үйл ажиллагаагаа нийтэд сурталчлах;

2.ҮЭ-ийн байгууллага нь гишүүдийнхээ зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоолгохоор шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийн заалтыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;

3.ҮЭ-ийн байгууллагаас гишүүддээ үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, цар хүрээг өргежүүлэх;

4.ҮЭ-үүд хувийн хэвшилд ажиллаж байгаа ажилтнуудын эрх ашгийг хамгаалахад идэвхитэй оролцох;

5.ҮЭ-ийн ажилтан нь Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихдаа улсын байцаагчийн эрхийг холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр эдлэх боломжийг бүрдүүлэх;

Хуулийн заалт	Оруулах санал	Үндэслэл
4 дүгээр зүйлийн 2 дах хэсэг	"Энэ нь эцсийн шийдвэр болно" гэсэн өгүүлбэрийг хасаж өөрчлөх	Шүүхийн шийдвэр эцсийн байна гэдэг нь маргагч талуудын давж заалдах, гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт тул өөрчлөх
4 дүгээр зүйлийн 3 дах хэсэг	-"Үйлдвэрчний эвлэлийн сайн дураараа тарах" гэснийг "Үйлдвэрчний эвлэл сайн дураараа тарах" гэж өөрчлөх; -"10 хоногийн дотор" гэснийг "30 хоногийн дотор мэдэгдэнэ" гэж өөрчлөх.	- Утга бүрхэг; -Төрийн бус байгууллагын хуулийн дагуу.
5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	- Улс төрийн намууд болон Засгийн газрын хараа хяналтгүйгээр улс төрийн асуудал, нийгмийн яриа хэлэлцээнд оролцох гэсэн нэмэлт оруулах; -Засгийн газраас ОУХБ-ын конвенциудад нэгдэн орсон, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг амьдралд хэрэгжүүлэхийг шаардах	- Үйлдвэрчний эвлэлүүдийн бие даасан чөлөөт байдлыг хангах; -ОУХБ-ын конвенци, зөвлөмжүүдийг амьдралд хэрэгжүүлэх.
5 дугаар зүйлийн 2 дах хэсэг	"Тухайн байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороо захиргаа, эзэдтэй тохиролцсоны дагуу хамтарсан төлөөлөгч томилон хамтын гэрээ байгуулна" гэж өөрчлөх	**"Нэг үйлдвэр-Нэг Үйлдвэрчний эвлэл"** гэдэг олон улсын Үйлдвэрчний эвлэлийн хэмжээнд хэрэглэдэг зарчмыг жишиг болгон хэрэгжүүлэх; Өмнөх заалт нь 1 аж ахуйн нэгж, байгууллагад 2 ба түүнээс дээш анхан шатны Үйлдвэрчний эвлэлийг хүлээн зөвшөөрсөн байсныг өөрчлөх. Олон анхан шатны Үйлдвэрчний эвлэлийн хороо байх нь үйл ажиллагааны зөрчилдөөнийг үүсгэдэг.
	Хатын гэрээнд дор дурьдсан 4 зарчмыг заавал тодорхойлсон байвал зохино: 1.Аливаа хүн ажилд ормогц Үйлдвэрчний эвлэлийн гишүүнд тооцогдох ба гишүүн бус боловч хамтын гэрээний үр ашгийг хүртдэг хүмүүс Үйлдвэрчний эвлэлд төлбөр төлөх; 2.гишүүдийн татварыг цалингаас шууд суутгах; 3.Ажлаас халах, цомхотгол хийх тохиолдлд Үйлдвэрчний эвлэлтэй заавал зөвшилдөж, тохиролцож байх; 4.Албан ёсоор баталгаажсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгохыг хориглох.	- Хамтын гэрээгээр үзүүлж буй хангалт, түүний үр шимийг гишүүн, гишүүн бус бүх хүмүүс адилхан хүртэж байгаа тохиололд хүн бүр татвар төлөх нь шударга ардчилсан зарчимд нийцэх болно.

6 дугаар зүйлийн 2 дах хэсэг	Хөдөлмөрийн хамтын харилцаанд ганцаарчилсан харилцааг сергүүлэн тавихыг хориглоно гэсэн нэмэлт оруулах.	"Байнгын ажлын байранд" хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглосон "Хөдөлмөрийн тухай хуулъ"-ийн нэмэлтийг үндэслэх
7 дугаар зүйл	-Үйлдвэрчний эвлэл нь олон улсын болон дотоодын ямар нэгэн санхүүгийн эх үүсвэрээс хараат бус байна; - Гишүүдийн татварыг шууд суутгах тогтолцоогоор бүрдүүлнэ; -Гадаад, дотоодын хандивийн хөрөнгийг зөвхөн боловсрол, сургалт зэрэг тодорхой үйл ажиллагаанд зарцуулна.	Авилга, хээл, хахууль, гаргах боломжийг хаах
9 дүгээр зүйл	Хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох. Тухайлбал: "Хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 мянган төгрөгөөр шүүгч торгоно" гэсэн заалтыг нэмж оруулах	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль тогтоомжийн зөрчил туушгай буурахгүй байгаа.
	Хуульд байгаа "захиргаа", "эзэд" гэсэн ойлголтыг " ажил олгогч" гэсэн нэгдмэл ойлголтоор өөрчлөх	"Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 3.1.1-д "ажил олгогч" гэж тодорхойлсон байгаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:

1.Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага бүрийг байгууллагын онцлогийг харуулсан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа, гарын авлагатай болгож хуулиар баталгаажуулах;

2.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг тогтоох асуудлыг тодорхой зааж өгөх;

3.Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг тодорхой гаргаж өвчлөгсдөд үзүүлэх эмнэлгийн тусламжийн үйлчилгээг нарийн тусгах;

4.Улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөр хамгаллын нийтлэг заавар, журам, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, хянаж батлах журмыг Засгийн газар баталдаг байх;

5.Ажил олгогч үйлдвэрлэлийн ослыг дахин гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч байх үүргийг хуульчлах;

6. Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1, 99.2-д заасан заалтыг тус хуулийн 141.1.7-д хавсарган тусгах. Үчир нь 99 дүгээр зүйлд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг хангаагүй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох хаах талаар заасан заалт нэг талаасаа хариуцлагын шинжийг агуулж байна;

7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.1, 97.12-т заасан. Түүнээс дээш удаа гэдэгт албан ёсны тайлбар хийх нь

зөв. Хуульд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар нь нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлсон байдаг. Иймд хөдөлмөрийн чадвар алдалтын хувиас нь хамаарч нөхөн төлбөрийг хэдэн удаа олгох тал дээр тайлбар хийх шаардлагатай;

8. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тухай бие даасан хуультай болох.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэх зорилгоор зээл туслалцаа авахад тавьж байгаа олон төрлийн шалгуур болзлыг өөрчлөх, цөөлөх;

2. Ажилгүй ажилтныг ажилд зуучилж оруулсан төрийн бус байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зуучилсан хүний тооноос хамааруулан санхүүжүүлэх;

3. Хуулийн 20.5-д "Үндэсний зөвлөлийн орлогч даргыг ҮЭ болон ажил олгогчдын төлөөлөгчдөөс тодорхой хугацаатай ээлжлэн сонгох" гэж нэмэлт оруулах;

4. Хуулийн 22.2-ыг "Ажилтан мэргэжлийн ур чадварын хувьд ажилдаа тэнцэхгүй болсон бол хөдөлмөр эрхлэлтийн албанд 2 сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэж холбогдох сургалтад хамруулна" гэж өөрчлөх;

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон дотоодын төслийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн нэг тогтолцоонд оруулах.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
www.nli.gov.mn

__oOo___

ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОР

1.1. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Зар сурталчилгааны харилцаан дахь үндсэн оролцогчид нь зар сурталчилгаа захиалагч, зар сурталчилгааг хүлээн авагч, түгээгч гэсэн үндсэн гурван субъект байдаг. Үүнээс:

Зар сурталчилгаа захиалагчид нь өөрсдийн ажил үйлчилгээ, бүтээгдэхүүний боломжит хэрэглэгчид болох зар сурталчилгаа хүлээн авагчдад хамгийн үр өгөөжтэй арга хэлбэрээр хүргэхийг эрхэм зорилгоо болгодог бол зар сурталчилгаа хүлээн авагчид буюу хэрэглэгчид тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээс өөрт хэрэгтэй мэдээллийг олж авах зорилготой байх бөгөөд түүнийхээ төлбөрийг тухайн зар сурталчилгааг хүлээн авснаараа төлдөг. Харин хэвлэл мэдээллийн байгууллага энэ 2 талын хүсэл зоригийг тэнцвэржүүлэх замаар өөрийн орлогын эх үүсвэрийг бий болгох зорилготой.

Гэтэл хэвлэл мэдээллийн байгууллага тэрхүү тэнцвэрт байдлыг бий болгож чадаагүйн улмаас зах зээлд илүүдэл эсвэл дутагдал үүсэх, эсвэл нийгэмд зүй бус, гаж хиймэл хэрэгцээг үүсгэх, зуршил бий болгох зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог. Тиймээс зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, эдийн засгийн болон үндэсний соёл, зан заншил, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй гэх мэт нийгмийн хүчин зүйлүүдэд нөлөөлдөг учраас зар сурталчилгааны агуулга, хэлбэр, хугацаа, хэрэглэгчдийн төрлөөр хязгаарлалт, хориг тогтоох замаар төрөөс зохицуулалт хийх нь зайлшгүй юм.

Зар сурталчилгааны үндсэн мөн чанар нь тухайн сурталчилж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэснээр хэрэглэгч сэтгэл санаа, бие мах бодь, эрүүл мэнд, нийгэмд эзлэх байр суурь, таашаал, сэтгэл ханамж одоогийнхоос илүү нэмэгдэнэ гэсэн мэдээллийг агуулж байдаг оршино. Тиймээс архи, тамхи, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом гэх мэт зүйлийн хэрэглээ ихэссэн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хэвийн амьдрах зуршилд аюул учруулж болохуйц бүтээгдэхүүний төрөлд хориг тавихаас гадна өөрийн хэрэгцээ шаардлагыг бүрэн ухамсарлан ойлгох, аливаа асуудлыг бүрэн гүйцэд үнэлж цэгнэх чадварт суралцаагүй байгаа хүүхдэд зориулсан зар сурталчилгаанд хяналт тавих зарим төрлийн хориг тогтоодог.

Мөн улсынхаа эдийн засагт дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад улсад бүтээсэн зар сурталчилгаанд хориг тавих эсвэл хязгаарлалт тогтоох туршлага байдаг байна. Жишээ нь, Европын ихэнх оронд гадаадад бүтээсэн зар сурталчилгааг явуулахыг хориглодог бол Австралид телевизээр явуулж байгаа нийт зар сурталчилгааны 20 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг хийжээ[39].

Хууль бус зар сурталчилгаа нь гэмт хэргийн үндсэн шалтгаан болж чадахгүй ч хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх сэдэл болох, гэмт зан үйл төлөвших, гэмт хэргийн орчин бүрэлдэх, гэмт үйл ажиллагаа зохион байгуулалтад орох,

[39]Regulation of television advertising, Simon P. Anderson, 2005.

үйлдлээ хялбарчлах, өөрсдийгөө нуун далдлах, иргэд олон нийтийг гэмт зан үйлийн тодорхой загварт өртөмтгий болгоход шууд бусаар нөлөөлдөг байна.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Зорилго:

Зар сурталчилгааны эрх зүйн орчин, зараас үүдэлтэй гэм хорын шалтгаант холбоог шүүхийн практикаас судлан тогтоож, судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хэлэлцүүлэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх.

Зорилт:

- Зар сурталчилгааны талаар хууль тогтоомжийн зохицуулалтыг судалж, эргэлзээтэй, зөрчилтэй, давхардсан, тодорхой бус заалтыг олж тогтоох буюу цаашид залруулах, зөв тайлбарлах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал дүгнэлт бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх;
- Зар сурталчилгаанаас учирсан гэм хорын маргааныг шүүхээр шийдвэрлэж байгаа практикийг судалж, шалтгаант холбоо болон гэм хорыг арилгаж байгаа байдалд шинжилгээ хийх;
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж гарган хуулийн хэрэгжилтийг хангадаг байгууллагуудад хүргүүлэх.

Судалгааны хугацаа:

2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдөр.

Судалгааны хамрах хүрээ

Хүн амын суурьшил, нягтрал ихтэй гэж үзэн Улаанбаатар хот, Дорнод аймгийн Чойбалсан хот, Орхон аймаг Эрдэнэт хот, Дорноговь аймгийн Замын-Үүд сумыг сонгон авч төрийн багуулага, зар сурталчилгааны харилцаанд оролцогч субъектууд болон иргэдийн дунд судалгаа хийлээ.

Нийслэлд:

Судалгааны хүрээнд нийслэлд зар сурталчилгаа бүтээгч, түгээгч гэсэн субъектуудтэй биечлэн уулзаж, энэ хүрээнд гурван удаагийн уулзалт зохион байгууллаа. Зохион байгуулсан уулзалт, судалгаанд оролцогсдыг дараах байдлаар авч үзэв.

- Төрийн байгууллага, албан тушаалтан:
  Нийт 15 байгууллагын 19 албан тушаалтан үүнээс шүүх эрх мэдлийн байгууллагаас 5, төрийн бус байгууллагаас 5, төрийн захиргааны байгууллагаас 9 албан тушаалтан оролцлоо.
- Иргэд, ажахуйн нэгж, байгууллага:

Судалгааны ажлын хүрээнд зар сурталчилгаа бүтээгч 7, түгээгч 7, нийт 12 аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж ярилцав.

Дорнод аймагт:

Тус аймаг нь хойд хэсгээрээ Оросын Холбооны Улсын Чита мужтай, урд талаараа БНХАУ-ын Алтан-Эмээл, Манжуур хоттой хиллэдэг, 80 орчим мянган хүн амтай, хүн амын суурьшил их, орон нутгийн 3 телевиз, 2 сонин, 2 богино долгионы радио станцтай бөгөөд бусад аймагтай харьцуулахад зар сурталчилгаа ихээхэн хэмжээгээр цацагддаг байна.

- Төрийн байгууллага, албан тушаалтан:

Дорнод аймгийн шүүхийн ерөнхий шүүгч, Хэрлэн сумын сум дундын ерөнхий шүүгч, аймгийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, Цагдаагийн газрын дэд дарга, хүүхдийн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, Татнуулын газрын дарга, Хилийн цэргийн шалган нэвтрүүлэх 0132 дугаар ангийн захирагч, Аймгийн прокурор, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурор, ЗДТГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий менежер, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, ЗДТГ-ын Үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл, харилцаа холбооны улсын хяналтын байцаагч нарын 16 албан тушаалтантай уулзаж ярилцав.

- Иргэд, аж ахуйн нэгж:

D1 телевизийн менежер, "Кайф" фм 100.9-ийн найруулагч, Хэрлэн телевизийн сэтгүүлч, Талын монгол ФМ 107.5 радиогын найруулагч, "Шинэ суваг" телевизийн сэтгүүлч нар. Мөн 103 иргэнээс анкетын болон ярилцлагын аргаар судалгаа авав.

Орхон аймагт:

- Төрийн байгууллага, албан тушаалтан:

Татнуулын газрын дарга, сум дундын ерөнхий шүүгч, аймгийн прокурорын орлогч, Цагдаагийн газрын хэрэг бүртгэх албаны дарга, эрүүгийн төлөөлөгч, олон нийттэй харилцах албаны байцаагч, ЗДТГ-ын өмгөөлөгч, Хуулийн хэлтсийн ажилтан, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан нартай уулзаж нийт 6 төрийн байгууллагын 10 албан тушаалтнаас ярилцлагын аргаар судалгаа авлаа.

- Иргэд, аж ахуйн нэгж:

Эрдэнэт хотод орон нутгийн 5 телевиз, зар сурталчилгааны төрлийн 2 сонин байдаг ба 100 гаруй иргэнээс анкетын, ярилцлагын аргаар судалгаа авсан.

Дорноговь аймагт:

- Төрийн байгууллага, албан тушаалтан:

Сум дундын II шүүхийн ерөнхий шүүгч, сумын ахлах прокурор, Цагдаагийн газрын дарга, эрүүгийн төлөөлөгч, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн дэд дарга, Татнуулын хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, хуулийн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Замын-Үүд боомтын Хилийн мэргэжлийн хяналтын газрын дарга нийт 7 байгууллагын 10 албан тушаалтантай уулзаж ярилцав.



- Иргэд, аж ахуйн нэгж:

Замын-Үүд радио Фм 107.5-ийн ерөнхий найруулагч, "Чөлөөт бүс" кабелийн телевиз болон ФМ 106.5-ын сэтгүүлч нартай уулзаж ярилцсан.

Мөн 100 иргэнээс анкетын асуулга авч 3 иргэнээс ярилцлагын аргаар судалгаа авав. Энэхүү судалгааг хийхдээ хууль тогтоомжийн хувьд Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хамруулснаас гадна 2006-2008 онд нийслэлийн хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн 27497 иргэний хэргийг уншиж судалсаны 111 хэргийг тэмдэглэн авч судалгаанд ашиглав.

Хэвлэл мэдээллийн хувьд улсын хэмжээнд хамгийн олон хувиар хэвлэгдэж хамгийн олон хүнд хүрдэг учраас "Шуурхай зар", "Зар мэдээ", "Үнэгүй зар" сониныг судалгааны объект болгож авлаа. Мөн өнөө үед айл бүр телевизтэй, үүрэн телефоны операторуудаас тусгай дугаар руу мессеж бичээд зар шууд нийтэлдэг /ТВ чат/ зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр зарим телевизээр нэвтрүүлдэг чатыг сонгон авч түүврийн болон туршилтын аргаар судалгаа хийсэн.

Судалгаа явуулахад баримталсан зарчим:

Судалгааг бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлах, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

Судалгааны арга:

•Баримт бичгийн судалгааны арга:

➢Зар сурталчилгааны харилцааг зохицуулж буй хууль-41, Дээд шүүхийн тогтоол-5, нийтээр дагаж мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас гаргасан 1 дэд актыг уншиж судлав.

•Анкетын судалгаа:

➢Нийт 293 хүнээс анкетын аргаар судалгаа авлаа.

•Уулзалт, ярилцлагын арга:

➢Судалгааны хүрээнд Шүүх, Прокурор, Цагдаа, Тагнуул, Хилийн цэрэг, Мэргэжлийн хяналтын газар, Засаг даргын Тамгын газар гэх мэт нийт 39 төрийн байгууллагын 48 албан тушаалтан, Телевиз, Радиогийн 19 байгууллагын 19 ажилтантай уулзаж ярилцлагын аргаар судалгаа хийсэн.

- Түүврийн арга:

➢Судалгааны хүрээнд нийт өдөр тутмын 12 сонин, 18 телевиз, 5 радио, 5 интернэт сайтаас зар сурталчилгааны хууль тогтоомжийг зөрчсөн байж болох тохиолдлуудыг түүвэрлэн судлав.

- Туршилт, тандалтын арга:

➢Хууль бус зар сурталчилгааны өнөөгийн нөхцөл байдлыг судлах зорилгоор зарим тохиолдолд ТВ чат руу мессеж бичих, сонинд зар өгөх зэргээр судалгаанд биечлэн туршилт хийсэн болно.

1.3. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улс чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэнээр хүн бүр чөлөөтэй аж ахуй эрхлэн явуулах боломжтой болж зар сурталчилгааны харилцаа хөгжсөн. Үүнийг зар сурталчилгаа болон бусад мэдээллийг хүлээн авах боломж бололцоо үлэмж нэмэгдсэн тэр хэрээр зар сурталчилгааны төрөл олширсон зэргээс харж болно. Жишээ нь: 2008 онд "Максима" Мониторингийн төвийн хийсэн судалгаанаас үзэхэд телевизийн нийт сурталчилгааны 75 хувийг эм, хүнс, банк, санхүү, дэлгүүр, худалдаа, холбоо харилцаа, ахуйн цэвэрлэгээний сурталчилгаа эзэлдэг гэсэн дүгнэлт гарчээ.

Мөн түүнчлэн түгээх хэлбэр нь өдөр ирэх тусам боловсронгуй, хялбар болж байгаа нь мэдээллийн технологийн хөгжилтэй холбоотой гэж үзэж болох ч нөгөө талаар сөрөг үр дагавартай байгаа нь анхаарал татах зүйлийн нэг юм. Зар сурталчилгааг хууль бус талаас нь зөвхөн архи, тамхийг сурталчилах төдийхнөөр ойлгох нь учир дутагдалтай бөгөөд нийгмийн амьдралын хөгжлийг дагаад хууль бус зар сурталчилгааг өргөн хүрээнд ойлгох шаардлагатай.

Зар сурталчилгааны эрх зүйн орчны талаарх байгууллага, иргэдийн мэдлэг муу байгаагаас хууль бус зар сурталчилгааг түгээх, бүтээх үйл ажиллагаа нь хяналтгүй байгаа төдийгүй хуулийн хэрэгжилт, хариуцлагын үр нөлөө сул байгаа нь аливаа гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөл болжээ. Энэ нь хууль тогтоомжийн сурталчилгаа бага, энэ талаар хийсэн нэг сэдэвт судалгаа байхгүй зэргээс шалтгаалж байна гэж үзэх үндэстэй. Өөрөөр хэлбэл, хуулиар хориглосон зар тэр дундаа ТВ чат зэрэг нь хэдийгээр шинэ болович зохицуулж болох харилцаа бөгөөд энэ талаар хийсэн дорвитой ажил /хуулийг сурталчлах, хамтын ажиллагаа гэх мэт/ байхгүй байгаа нь нийгэмд "зохицуулалтгүй", "хяналтгүй" гэх хандлагыг үүсгэсэн нь тодорхой. Мөн "Зарын бодит үнэнийг зарлуулсан байгууллага хувь хүн бүрэн хариуцна" гэсэн Зар сурталчилгааны тухай хууль болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчсөн "гэрээний нөхцөл" хуулиас илүү хүчин чадалтай үйлчилдэг "гаж" үзэгдэл газар авчээ. Энэхүү тодорхой нөхцөл байдал нь зар сурталчилгааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сурталчлах, хууль бус зар сурталчилгааг хамтын ажиллагааны үндсэн дээр таслан зогсоох хэрэгцээг бий болгосон.

Мэдээллийн технологи хурдтай хөгжихийн хэрээр хууль бус зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын /ОӨГ/ хүч, боломжийн хувьд тэрхүү хурдцыг гүйцэхгүй байгааг дараахь тоо баримтаас харж болно. 1999 оны байдлаар Хууль зүй дотоод хэргийн яаманд 1130 мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байснаас 190 орчим нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан бол энэ тоо 2008 оны эхний улиралд 398-д хүрч даруй 2 дахин өссөн байна. Тухайлбал, 1999 онд өдөр тутмын таван сонин гарч байсан бол 2008 онд энэ тоо 12 болж, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 5 телевиз 18 болсон. Түүнчлэн орон даяар нэвтрүүлгээ цацдаг телевизийн тоо 1 байсан бол 6 болж, нийслэлийн богино долгионы радио 7-гоос 20



болтлоо өсчээ. Гэтэл хуулийн дагуу хяналт тавих эрх бүхий байгууллагын байцаагчийн орон тоо цөөн байгаа нь хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Иргэдээс авсан санал асуулгад судалгаанд оролцогчдын 61.43 хувь нь зар сурталчилгааны үнэн бодитой байх гэсэн шаардлага хангадаггүй гэсэн бол зар сурталчилгаанд тавигдаж байгаа хяналтад сэтгэл дундуур байдаг гэж 70 гаруй хувь нь хариулсан байна. Мөн зар сурталчилгаа бүтээгчидтэй уулзаж ярилцахад ихэнх нь хууль бус зар сурталчилгааг далд хэлбэрээр хийлгэх захиалга нэлээд ирдэг гээд Оюуны өмчийн газрын хяналтын үр нөлөө муу гэж дүгнэв.

ХОЁР. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЭРХ

Зар сурталчилгаатай холбоотой нийгмийн харилцааг зохицуулах, хяналт тавих үүднээс Улсын Их Хурлаас "Зар сурталчилгааны тухай" бие даасан хуулийг 2002 онд батлан гаргасан байна. Иймхүү тухайн хуулийг батлан гаргахаас өмнө зар сурталчилгаа, түүнтэй холбогдсон харилцааг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай /1991 он/, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай /2000 он/, Архидан согтуурахтай тэмцэх тухай /2000 он/, Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай /1993 он/, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай /1995/, Садар самуун явдалтай тэмцэх тухай /1998 он/ хуулийн холбогдох зүйл заалтуудаар зохицуулдаг байв. Эдгээр хуулийн хэсэг бусад заалт нь ерөнхий шинжтэй, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих нэгдсэн тогтолцоо, субъект байгаагүй учир дутагдалтай байсан нь тодорхой.

Зар сурталчилгааны тухай хууль нь 6 бүлэг 29 зүйлтэй бөгөөд хуулийн зорилт буюу хуулиар зохицуулах харилцааг "Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахаар заасан байна"[40].

Түүнээс гадна зар сурталчилгааны эрх зүйн орчныг бүрдүүлэгч Монгол Улсын Эрүүгийн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хууль, Ойн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль гэх мэт олон хуульд зар сурталчилгааны тухай зүйл, заалтыг тусгасан байна.

Энэ бүлэгт Зар сурталчилгааны тухай хуулийн хамгийн ихээр зөрчигдөж байгаа зүйл заалтуудыг жишээ, тайлбарын хамт авч үзэхээс гадна Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо, давхардал хийдэлд дүн шинжилгээ хийж, гадаадын зарим орны зохицуулалтын талаар товч авч үзэв.

[40] "Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр" сэтгүүл, 2008, 5 дахь тал.

2.1.ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХАРИЛЦААН ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, НЭР ТОМЪЁОНЫ АСУУДАЛ

Зар сурталчилгааны харилцааны эрх зүйн зохицуулалт дахь нэр томъёо нэг мөр болоогүй, зөрүүтэй, салаа утгыг илэрхийлсэн дутагдалтай тал байна. Эдгээрээс хамгийн чухал нь буюу тухайн харилцааны зохицуулалтын үндсэн зүйл болсон зар сурталчилгааны хувьд **"зар", "зар мэдээ", "зарлал", "зар сурталчилгаа", "сурталчилгаа", "реклам"** гэх мэт олон нэр томъёо байгаа бөгөөд эдгээрийг хууль бүрт өөр өөрөөр хэрэглэсэн байна. Үүнд, **"сурталчилгаа"** гэсэн нэр томъёо орсон 32 хууль, **"Зар"** гэсэн үг орсон 5 хууль, **"Зар мэдээ"** гэсэн нэр томъёо орсон 2 хууль, **"зарлал"** гэсэн заалт орсон 1 хууль, **"Реклам"** гэсэн нэр томъёо хэрэглэсэн 1 хууль, "**зар сурталчилгаа**" гэсэн нэр томъёо хэрэглэсэн 6 хууль байна[41].

Жишээ нь:

- Иргэний хуулийн 197.14-д Хууль буюу **зард** өөрөөр заагаагүй бол нээлттэй дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч тэдгээрийг явуулахаас татгалзах эрхтэй.
- Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэлзүйнорчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, **сурталчилгаа явуулах**" талаар заасан байна.
- Компанийн тухай хуулийн 58.2-д "... Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцааг худалдан авах сачалыг хувь нийлүүлэгчдийн хурлын **зар мэдээг** хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ".
- Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4.2.5-д "Танхим нь **реклам, сурталчилгааны** үйлчилгээ үзүүлэх, уран сайхны зарлал, чимэглэлийн эхийг бэлтгэх, хийлгэх";
- Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т **"Зар сурталчилгаа** гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг ойлгоно".

Иймхүү өөр өөр нэршил бүхий боловч бүгд Зар сурталчилгааны тухай хуулийн үйлчлэлд багтан ойлгогдож тэдгээрийн төлөө зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч бүгд хариуцлага хүлээхээр харагдаж байна. Гэтэл хувь хүний зарыг их хэмжээгээр авч төрөлжүүлэн ангилж нийтэлдэг "Зар мэдээ", "Шуурхай зар" сонин, зарын нэгдсэн сайтууд өөрийн хүлээн авч байгаа хэдэн мянган зарын үнэн, бодит байдлыг няхтлан шалгаж, тэдгээрийн төлөө хариуцлага хүлээх бодит боломжгүй юм.

[41]Зар сурталчилгааны тухай хууль. УБ., 2002.

Зарим нэр томъёог хэл зүйн талаас нь харвал "Зар- ***олонд зарлан нийтлэх үг буюу мэдээ***[42]", "сурталчилгаа- ***сурталчлах, сурталдахын нэр үг байн байн сургаж ятгах, ухуулах, сэнхрүүлэх***[43]" гэсэн утгыг тус тус илэрхийлэх аж.

Харин **"Зар сурталчилгаа"** гэсэн нэр томъёог Зар сурталчилгааны тухай хуульд "иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг" ойлгоно гэж тайлбарлан оруулсан байна. Тэгэхээр зар сурталчилгаанд эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилго бүхий зар, зарлал, мэдээлэл, сурталчилгаа бүгд хамрагдахаар байна. Өөрөөр хэлбэл, маркетинг, олон нийттэй харилцах ажлын хүрээнд хийж байгаа бүх мэдээллийг хамруулж ойлгох боломжтой юм.

Мөн Улсын Дээд шүүхээс "Зар сурталчилгаа" гэсэн нэр томъёог дараахь байдлаар тайлбарласан байна. Үүнд:

1."Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай" дээд шүүхийн тогтоолын 4 дүгээр зүйлд "Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан "Согтууруулах ундаа худалдах, борлуулах, хэрэглэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглоно" гэснийг бүх төрлийн сонин, сэтгүүл, радио, телевизээр болон зураг ухуулах хуудсаар энэ хуульд нэр заагдсан согтууруулах ундааг худалдан авах, хэрэглэхийг уриалсан, ухуулсан зар сурталчилгаа, рекламыг хамааруулан ойлгоно."

2.Банкны болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалт, хэсгийг тайлбарлах тухай" дээд шүүхийн тогтоолын 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3-т заасан **"өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх"** гэдэгт хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон журмын дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, түүний дотор хадгаламж, зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамруулан ойлгоно." 3.Мөн зүйлийн 12.1.2-т заасан **"өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх"** гэдэг нь хууль тогтоомжийн дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан үйл ажиллагааны талаар буюу байгууллагынхаа орлого, санхүүгийн байдал, зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг ойлгоно.

[42] Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" УБ 1966 он 267 дахь тал.
[43] Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" УБ 1966 он 491 дахь тал.

3.Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Банкны тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" дээд шүүхийн тогтоолын 2 дугаар зүйлд "Банкны тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарлахдаа ... Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын "**өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх**" гэдгийг хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон журмын дагуу гаргавал зохих тайлан, тэнцэл болон бусад мэдээ, түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа, түүний дотор хадгаламж, зээлийн хүү, зээлийн чанартай холбогдсон асуудлаар буруу ташаа сурталчилгаа, мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамруулан ойлгоно гэжээ.

4.Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Мөн зүйл, хэсэгт заасан "...хэвлэл мэдээллийн хэрэгсэл..." гэдгийг Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар ойлгоно" гэжээ. Мөн Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Мөн зүйл, хэсэгт заасан "**...нийтэд тараах...**" гэж Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллийг олон нийтэд түгээхийг хэлнэ" гэж тус тодорхойлсон байна."

Нэр томъёотой холбоотойгоор Англи улсын жишээг харахад зар сурталчилгааны харилцааг зохицуулагч актуудын нэг болох "Зар сурталчилгаа, худалдааны идэвхжүүлэлт, шууд маркетингийн тухай Британийн код" нь сонин, сэтгүүл бусад хэвлэмэл материал дээрхи зар, интернэтийн зайг ашигласан зар сурталчилгаа, олон нийтийн газар байрлуулсан хөдөлгөөнт зураг, хэрэглэгчийн хувийн мэдээллийг агуулсан маркетингийн мэдээлэл, худалдааны идэвхижүүлэлт, зар сурталчилгааны идэвхижүүлэлтэд хамаарна гэж заажээ[44]. Үүнээс харахад бид үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зар сурталчилгаа гэж юуг хэлэх, үүнийг худалдааны идэвхижүүлэлт. түүний бусад арга, маркетинг, олон нийтийн харилцаа зэргээс хэрхэн ялгах гэх мэт өдөөс өдөрт хөгжиж байгаа бизнесийн шинэ тутам бий болж байгаа бараа, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаатай уялдуулан тодорхойлох хэрэгтэй байна.

Иймд судалгааны баг нэр томъёоны талаар өөрсдийн саналыг доорх байдлаар боловсруулласа.

✓ **"Зар", "зарлал", "зар мэдээ"** гэдэгт /цаашид **зарлал** гэх/ аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой болон холбоогүй төрөлжүүлэн ангилсан, үгэн буюу бичмэл бүх хэлбэрээр түгээж буй мэдээллийг ойлгож болох юм. Үүнд ажилд авах, худалдах, худалдан авах, орон сууц зарах, хөлслүүлэх, тусламж хүссэн, тусламж үзүүлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг гэх мэт

[44] Зар сурталчилгаа, худалдааны идэвхжүүлэлт, шууд маркетингийн тухай Британийн код.



багтана. Эдгээр томъёолол хоорондын нарийн ялгаа, хэлбэр, зорилгыг тусгайлан гаргаж ирэх, тусад нь зохицуулах нь эрх зүйн үр дагаврын хувьд онцын ач холбогдол байхгүй байна.

✓ **"Зар сурталчилгаа", "сурталчилгаа", "реклам"** гэдэгт /цаашид **зар сурталчилгаа** гэх/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйлажиллагаа/цаашид "бүтээгдэхүүн[45]" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг ойлгох боломжтой. Гэхдээ энд маркетингийн идэвхижүүлэлтийн бүх үйл ажиллагааг хамруулж байгаа гэж ойлгох нь зохистой гэж үзэж байна. Нэр томъёонуудыг шинж чанар, агуулга, эрх зүйн үр дагаваар нь ийнхүү 2 бүлэгт ангилан авч үзэх нь нэгэнт хэрэглэгдэж заншсан үг хэллэгийг хасах эсвэл, шинээр нэршил гаргаж ирснээс илүү үр дүнтэй юм. Дээрх 2 бүлэг нэр томъёоны шинж тэмдгийг нарийвчлан хүснэгтлэн харуулъя. Үүнд:

№	"Зар", "зарлал", "зар мэдээ" Буюу **Зарлал**	"Зар сурталчилгаа", "сурталчилгаа", "реклам" буюу **Зар сурталчилгаа**
1.	Төрөлжүүлэн ангилсан /олон нийтэд чиглэсэн арилжааны бус нийгмийн шинжтэй мэдээ, мэдэгдэл, мэдээлэл сонордуулгын хувьд заавал төрөлжсөн байх шаардлагагүй/ байна.	Заавал төрөлжүүлэн ангилсан байх шаардлагагүй.
2.	Үгэн буюу бичмэл хэлбэртэй байх.	Дуу, дүрс, үйл хөдлөлийг ашигласан байх.
3.	Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой, болон холбоогүй байж болно.	Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой /үүнд олон нийтэд чиглэсэн арилжааны бус нийгмийн шинжтэй, сонгуулийн зар сурталчилгаанд хамаарахгүй/.
4.	Бүх хэлбэрээр түгээж болно.	
5.	*Илт хууль бус байх* тохиолдолд **түгээгч хариуцлага хүлээнэ.**	
6.	*Хууль бусад тооцож болох* тохиолдолд **түгээгч хариуцлага хүлээхгүй.**	*Хууль бусад тооцож болох* тохиолдолд **түгээгч /зөвхөн Телевиз, радио/ хариуцлага хүлээнэ.**

Дээрх хүснэгтийн 5, 6 дуугаар эгнээнд *илт хууль бус зар сурталчилгаа*, *хууль бусад тооцож болох зар сурталчилгаа* гэсэн ангилал орж ирсэн байгаа. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулвал:

Илт хууль бус	**Хууль бусад тооцож болох**
Тусгай зөвшөөрөл авааГүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;	Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа;

[45]Английн зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын хувьд "бүтээгдэхүүн" гэдэгт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, саная /idea/, шалтгаан нөхцөл, боломж, шагнал урамшуулал, бэлэг гэх мэтийг хамруулж ойлгоно гэсэн байдаг. /The British Code of Advertising, Sales Promotion and Direct Marketing/.

Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах;	Хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах;
Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;	Тарифын бус хязгаарлалт тогтоосон бараанг сурталчлах;
Айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;	Хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх төслийг үнэлгээ хийлгэхээс өмнө, эсхүл үнэлгээ хийгдсэн боловч төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бол уг төслийг сурталчлах;
Монгол Улсын болон бусад улс орны төрийн тусгай бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах үйлчилгээ, үйл ажиллагаа, эрх олгох баримт бичгийг хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлэх, олгохоор сурталчлах /виз гаргах, диплом олгох, иргэний бүртгэлийн бичиг баримт гаргах, тэдгээрийг худалдах, худалдан авах гэх мэт/;	Зар сурталчилгааны тухай хуульд заасан бусад түгээхийг хориглосон зар сурталчилгаа;
Хуулиар сурталчлахыг хориглосон бэраа, ажил, үйлчилгээг сурталчлах /үүнд Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйл хамаарахгүй/;	
Тухайн эм, эмчилгээ, амин дэм, биологийн нэмэлт бүтээгдэхүүний үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;	

Дээрх нэр томъёоны тодсрхойлолт, үндсэн шинжийн ангилал бий болгосноор дараах дүгнэлт гарч байна. Үүнд:

❖ *Илт хууль бус* **зарлал** /"Зар", "зарлал", "зар мэдээ"/, **зар сурталчилгаа** /"Зар сурталчилгаа", "сурталчилгаа", "реклам"/ түгээсэн бол түгээгч нь хэн байхаас /телевиз, радио, сонин, сэтгүүл, веб сайт, зураг хуудас, самбар гэх мэт олон нийтэд түгээж болох бүх хэлбэр/ үл шалтгаалан хариуцлага хүлээнэ.

❖ *Хууль бусад тооцож болох* **зарлал**ын хувьд цацагдаж байгаа хэлбэр, зорилго, шинж чанараас нь үл хамааран түгээгч хариуцлага хүлээхгүй. Өөрөөр хэлбэл, эдгээрийн бодит үүнийг зарлуулсан байгууллага, хувь хүн хариуцна.

❖ Харин *Хууль бусад тооцож болох* **зар сурталчилгаа**ны хувьд түгээгч /зөвхөн Телевиз, радио/ хариуцлага хүлээнэ.

2.2. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА ХОЛБОО, ЗӨРЧИЛ, ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ

Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг судлахын тулд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Иргэн, эдийн засгийн эрх зүйн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хооронд уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлалыг удирдлага болгон хийсэн бөгөөд хууль-41, зар сурталчилгааны харилцааг зохицуулсан хуулийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тогтоол -5, нийтээр дагаж мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн акт -1-ийг харьцуулан давхардал, зөрчил, хийдлийг тогтоов.

Д/д	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/
1.	Тус хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын нутаг дэвсгэрт явагдах аливаа зар сурталчилгаанд энэ хуулийг хэрэглэнэ" хэмээн заасан.	Харин 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хууль улс төр, шашин, сүм хийдийн сурталчилгаа түүнчлэн худалдаа арилжаа, аж ахуйн үйл ажиллагаатай холбоогүй мэдээ, мэдээлэл **зарлалд** хамаарахгүй".
Дүгнэлт: "**аливаа**" гэдэг үгийн утгыг тайлбар толь'-иос харахад "хамаг, бүгд" гэсэн утгыг илэрхийлж байгаа бөгөөд энэ утгаар авч үзвэл Зар сурталчилгааны хууль нь дээр дурдсан улс төр, шашин, сүм хийдийн сурталчилгаа, худалдаа арилжаа, аж ахуйн үйл ажиллагаанд холбоогүй зар сурталчилгаанд хамаарахаар байгаа тул зөрчилдөж байна.		
2.	ЗСТХ-ийн 2.2-т "Энэ хууль улс төр, шашин, сүм хийдийн сурталчилгаа, түүнчлэн худалдаа арилжаа, аж ахуйн үйл ажиллагаагүй холбоогүй мэдээ, мэдээлэл зарлагд хамаарахгүй" гэснээс харахад энэ хууль... зарлалд хамаарахгүй гэж ойлгогдохоор байна.	
	Санал: 2.2-ыг Энэ хуулийн зохицуулалт бизнес, аж ахуйн үйл ажиллагаатай холбоогүй мэдээ, мэдээлэл зар сурталчилгаанд хамаарахгүй гэж өөрчлөх саналтай байна.	
3.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**
	5.1.Зар сурталчилгаа нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, энэ хуулийн 21.1, 21.2-т заасан журмыг зөрчсөн, бусдын бүтээгдэхүүнийг муугаар өөрийн бүтээгдэхүүнийг давуутай гэж харьцуулан сурталчилсан, түүнчлэн энэ хуулийн 7.2.1, 7.2.3-т заасан үйлдэл хийсэн бол иргэн, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.	7.2.2-т бусдыч нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа;
Бичвэрийн хувьд ижил өгүүлбэр оруулсан байгаа тул 7.2.2-т заасныг хасах саналтай байна.		

4.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль /2000.05.12/**
	24.3-т зааснаар: "Оюуны өмчийн улсын хяналтын алба нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	13 дугаар зүйлд: Хянан зохицуулах албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдана гэжээ.
Гэвч Төрийн хяналт шалгалтын тухай хууль нь 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд 4 бүлэг, 16 зүйлтэй байна. Арга чилалын 7.2.7-д зааснаар ишлэл алдаатай байна.		
5.	**Архидан соогтуурахтай тэмцэх тухай хууль /2000.01.28/**	
	9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт худалдан борлуулах талаар үйл ажиллагаа явуулахыг сурталчлах гэсэн байна.	

ЗСТХ-ийн 3.1.1-д "зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг хэлнэ хэмээн зааснаас үзэхэд АСТТХ-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "соогтууруулах үндаа" гэсний хойно "зар" гэж нэмэх.

Жич: Ихэнх хуульд "сурталчлах" гэсэн үгийг олон нийтэд таниулах, болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилготой мэт ойлгогдохоор хуульчилсан байна.

6.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Банкны тухай хууль /1996.09.03/**
	17.1-дБанкны үйлажиллагааны зар сурталчилгаа нь тухайн банкны төлбөрийн чадварын болон банкны хуулиар заагдсан бусад үзүүлэлтүүдэд үндэслэсэн, үнэн зөв байна. Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаанд мөнгөн хадгаламжийн гэрээний гол нөхцөлүүдийн талаар заавал мэдээлнэ.	7 дугаар зүйлд "Банкнаас хийх зар сурталчилгаа нь тухайн үеийн үйл ажиллагааг үнэн зөв тусгасан, хууль тогтоомжид нийцсэн байна".
Дүгнэлт: Бичвэрийн болон агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан тул Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийг хуулиас хасах саналтай байна. Санал: Зар сурталчилгааны тухай хуулиас ишлэл хийх шаардлагатай байна.		
7.	**Барааны тэмдэг, үзэр зүйн заалтын тухай хууль /2003.05.02/**	
	20.1.4, 24.1.3-т зар сурталчилгааны талаар тусгагдсан байна. Гэвч 24.1.3-т "Тухайн бараатай холбоотой үйл ажиллагаанд хэрэглэгдэх албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол үзэр зүйн заалтыг ашигласан гэж үзнэ" .	
Дүгнэлт: "сурталчилгаа" гэдэг үгийг урьдчилан сэргийлэх болон сэрэмжлүүлж сурталчлах гэсэн утгаар хэрэглээгүй гэж үзэж байна. Санал: "интернэт, сурталчилгаанд" гэсэн хоёр үгийн дунд "зар" гэж нэмэх.		
8.	**Даатгалын тухай хууль /2004.04.30/**	**Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль /2004.04.30/**
	54 дүгээр зүйл. Салбар, төлөөлөгчийн газар нээх 54 дүгээр зүйлд: Даатгалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах"-ыг хориглох талаар тусгасан.	13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: ...3.2.1-д мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах" талаар тусгасан.

Дүгнэлт: "даатгалын", "даатгалын мэргэжлийн оролцогчийн" гэх субъектээр ялгаатай ба бусад үгийг нь хуулбарласан тул энэ харилцааг илүү өргөн хүрээгээр зохицуулсан, суурь хууль гэдгээр нь Даатгалын тухай хуулийн заалтыг үлдээж, нөгөөг нь хасах саналтай байна.

Мөн дээрх заалтууд "сурталчилгааг" хийхдээ хэрэглэгчдийн анхаарлыг татах зорилготой мэт харагдаж байна. /зар сурталчилгаа/.

9.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /ОНРТТХ/ /2005.01.27/**
9.1	7 дугаар зүйлд **хууль бус зар сурталчилгаа** гэдэгт зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд сурталчилгааг хамааруулахаар заагаад тус бүрийг тодорхойлжээ.	Тус хуулийн 13 дугаар зүйлийн 1-д Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно гэсэн байдаг.

Дүгнэлт: Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд далд сурталчилгаа, арилжааны зар сурталчилгааг явуулахыг хязгаарлаад харин зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн зар сурталчилгааг нэвтрүүлж болохоор байна. Иймд энэ хоёр зөрчилдөж байна.

Санал: Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр хууль бус болон арилжааны чанартай зар сурталчилгааг нэвтрүүлэхийг хориглоно гэж" өөрчлөн найруулах саналтай байна.

9.2.	ЗСТХ-ийн 11.2-т: "Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно"	13.2-т: ... 13.2.1-д "Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлнэ гэсэн.

Энэ өгүүлбэр давхардсан ба ОНРТТХ-ийн 13 дугаар зүйлийн 1-д Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно гэсэнтэй зөрчилдөж байгаа тул энэ хэсгийг бүхэлд нь хасах.

9.3	ЗСТХ-ийн 11.3-т: "Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно."	ОНРТТХ-ийн 13.2.2-т "Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх".

Үүнтэй адилхан хувьд давхардсан заалт оруулсан бөгөөд ОНРТТХ-ийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэсэнтэй зөрчилдөж байгаа тул энэ хэсгийг хасах саналтай байна. Хэрэв ОНРТТХ-д энэ нь арилжааны зорилгоүй сурталчилгаа бол "зар" гэдэг үгийг хасч, "сурталчилгаа" гэдэг үгийг оруулах.

9.4.	ЗСТХ-ийн 11.4-т "Сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 5 минутаас илүүгүй хугацаанд 30 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлж болно."	ОНРТТХ-ийн 13.2.3-т "Сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлнэ" гэжээ.

Хугацааг өөрөөр зааснаас бусдаар ижил байна. ОНРТТХ-ийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэсэн байдаг. Зөрчилдөж байгаа тул хасах саналтай байна.

9.5.	ЗСТХ-ийн 11.5-д "үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа түгээхийг хориглоно."	ОНРТТХ-ийн 13 2.5-д "20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх."

Утга ижил бөгөөд ОНРТТХ-ийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэсэнтэй зөрчилдөж байгаа тул үүнийг хасах шаардлагатай гэж үзэж байна.

9.6.	ЗСТХ-ийн 6 дугаар зүйлд зар сурталчилгаанд тавих ерөнхий шаардлагын талаар тусгасан.	ОНРТТХ-ийн 13.2-т "Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараах тусгай шаардлага тавина" гэсэн. /тусгай шаардлагуудын талаар доор дурдах болно. /

13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэсэн байдаг. Зөрчилдөж буй учир ОНРТТХ-ийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах шаардлагатай байна.

9.7.		ОНРТТХ-ийн 13.3-т Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна гэжээ.

13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэсэн түл энэ заалтыг хасах.

9.8		17 дугаар зүйлийн 1-д: "Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ" 17.1.1. радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс; 17.1.2. зар сурталчилгаанаас олсон орлого; ***/Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсаггүй/***

ОНРТТХ-ийн 17.1.2-д заасан заалт нь ЗСТХ-тайгаа зөрчилдөж байна. МУ-ын ерөнхийлөгч хориг тавьсан ч үүнийг хууль тогтоох байгууллага хүлээн авсаггүй байна. ОНРТТХ-д "Олон нийтийн радио, телевизээр зар сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэнтэй зөрчилдсөн.

10.	**Зар сурталчилгааны тухай хууль**	**Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль**
	7 дугаар зүйлийн 2 1-д "Дараах зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно" *7.2.1.өөрийн барааг бусдынхтай **ижилсэн** сурталчилсан:*	10.1.3-т Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд "өөрийн бараг бусдын бараатай **ижилтгэн** сурталчлах" өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хориглонс.

Дүгнэлт: Ижил утга санаог агуулж байгаа ч, "ижилтгэн, ижилсэн" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.
Санал: ШБӨХТХ-ийн 10.1.3-т Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2.1 гэж ишлэл авах.

10.1	ЗСТХ-ийн 19.3-т Ивээн тэтгэгч зар сурталчилгаа түгээгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.	ШБӨХЗТХ-ийн 10.1.4-т "ивээн тэтгэгч этгээд ивээн тэтгүүлж байгаа этгээдээс өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаа явуулахыг шаардах"-ыг хориглохоор заажээ.

Дүгнэлт: 1 утга санааг илэрхийлсэн тул ШБӨХЗТХ-ийн 10.1.4-т ЗСТХ-иас ишлэл авах шаардлагатай байна.		
10.2	ЗСТХ-ийн 24.3-т Оюуны өмчийн улсын хяналтын алба нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.	ШБӨХЗТХ-ийн 13.1-т Хянан зохицуулах албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг болон бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдана.
Дүгнэлт: Гэтэл энэ хууль нь /ТХШТХ/ 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд 4 бүлэг 16 зүйлтэй тул 21, 23 дугаар зүйл гэж байхгүй байна. Санал: ТХШТХ-ийн 11 дүгээр зүйлд улсын байцаагчийн эрхийн талаар тусгасан байна. Дээрх 2-ыг ТХШТХ-ийн 11 дүгээр зүйл болгон өөрчлөх хэрэгтэй байна.		
11.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /1998.05.07/** /хуулийн нэрийг 2006.01.05-ны өдөр өөрчилсөн./
	13.4.1-д улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг сурталчлах;	17.3-т Эмийн сурталчилгаанд дараахь зүйлийг хориглоно: 17.3.1. эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг импортлох, борлуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
Дүгнэлт: нэг утга санааг хоёр хуульд давхцуулан хуульчилсан байгаа тул ЭЭХТХ-ийн 17.3.1-д ЗСТХ-ийн ишлэлийг оруулах шаардлагатай байна.		
11.1	*13.1 Олон нийтийн мэдээлэх хэрэгслээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно.*	17.3-т Эмийн сурталчилгаанд дараахь зүйлийг хориглоно: 17.3.2-т жороор олгохоор заагдсан эмийг борлуулах зорилгоор сурталчлах;
Олон нийтийн мэдээлэх хэрэгсэлд Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз ч багтах тул МҮОНРТ-ээс бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно гэж заах.		
11.2	13.2-т "Жорооролгох мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, эмчилгээний зориулалт бүхий мансууруудах бодис, ургамал, түүнчлэн тусгай мэдлэг, мэргэжил шаардагдах эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан мэдээлэх хэрэгслээр сурталчилна."	17.3.3. "мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах"
... эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан мэдээлэх хэрэгслээр сурталчилна гэжээ. ЗСТХ-ийн 3.1.5-д "мэдээлэх хэрэгсэл" гэдгийг "телевиз, радио холбооны шугам сүлжээ, компьютерын /компьютерийн –Р.Б/ сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг" ойлгохоор тодорхойлсон байна. Монгол Улсад Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан мэдээллийн хэрэгсэлд сэтгүүл, сонин байж болох ч телевизийн суваг, радио байхгүй билээ. Харин радио, телевизээр эрүүл мэндийн нэвтрүүлэг хааяа явуулдаг. Үүнийг эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудаас гадна өөр бусад ч үздэг.		

12.	Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/	Эрүүгийн хууль /2002.01.03/
	7.2.3.хангалттай тодорхой мэдээллийг орхигдуулан, эсхүл мэдлэг,туршлагадутмаг буюу итгэмтгий байдлыг нь ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан бол зүй бус зар сурталчилгаанд тооцно.	**169 дүгээр зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх** 169.1.Үйлдвэрлэл,үйлчилгээ,худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
Дүгнэлт: Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлд Зар сурталчилгааны тухай хуулийн 7.2.3-т зааснаар гэж ишлэх шаардлагатай байна. Энэ нь давхардсан байна.		
13.	**Зар сурталчилгааны тухай хууль /2002.05.30/**	**Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2002.12.12/**
	17 дугаар зүйлд: 17.2.Хөрөнгө оруулалтын сан, банк, санхүү, даатгалын болон бусдын мөнгөн хөрөнгийг ашиглах, захиран зарцуулахтай холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа, түүнчлэн үнэт цаасны зар сурталчилгааг бүтээх, тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах, түгээхэд дараахь зүйлийг хориглоно:	26.10-т Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тухай танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэх, зардлыг тооцох, зар сурталчилгаа явуулах, Сангийн хувьцааны үнэлгээ, хадгаламж, бүртгэл, санхүүгийн хяналт болон тэдгээрийг тайлагнах журмыг Хороо тогтооно.
ҮЦЗЗТХ-ийн 26.10-т зааснаар Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмыг олж авсан боловч зар сурталчилгаа явуулах хэсэг нь хүчингүй болсон байлаа.		
Д/д	**НИТХ-ын Тэргүүлэгчдийн Журам шинэчлэн батлах тухай 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 145 дугаар тогтоол**	
1.	1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна реклам мэдээллийн байгууламж байрлуулах үед төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, **иргэдтэй үүсэх** харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.	
Дүгнэлт: Зар сурталчилгааны тухай хуульд "гадна реклам мэдээллийн байгууламж" гэсэн нэр томъёо байдаггүй. ... иргэдтэй үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино гэдэг нь ойлгомжгүй байна.		
2.	2.3 дахь хэсгийн доод хэсэгт "Гадна рекламын байгууламжийн загварууд"	
гэж бичсэний дараа " : " тавьсан байгаа нь ютай холбогдох нь мэдэгдэхгүй байна.		
3.	энэхүү байгууламжийн хэмжээ нь 3м*6м, 4м*9м байх буюу барилга байгууламжийн гадаргууны талбайгаас хамаарч, янз бүр байх боломжтой.	
Энд заасан хэмжээ нь хамгийн бага хэмжээ эсэх нь мэдэгдэхгүй, тодорхой бус байна.		
4.	2.6-д Түр болон байнгын хашаа, хаалт, хашлаган дээрх байгууламж: Барилга барих, бүтээн байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явагдах хугацаанд уг барилга байгууламжийн талаарх товч мэдээллийг агуулсан байгууламж юм. Хэмжээ нь 3м*5м байх бөгөөд баригдаж буй барилгын график рекламд хамаарахгүй.	

"Реклам" гэсэн нэр томъёо Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулиас өөр хуульд ороогүй байдаг. Нэр томъёог солих.	
5.	2.11. Байгууллагын туг, далбаа: Энэ нь нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол болон газар доогуурх гарц дахь авто замын байгууламжид байрлуулсан байгууламж юм гэжээ.
Байгууллагын туг, далбаа нь байгууламж байна гэдэг нь ойлгомжгүй байна.	

Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл:

1.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон **далд** зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэжээ. Гэтэл Зар сурталчилгааны тухай хуульд **хууль бус зар сурталчилгаа** гэдэгт зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд сурталчилгааг хамааруулахаар заагаад тус бүрийг тодорхойлжээ. Тэгэхээр Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар далд сурталчилгаа, арилжааны зар сурталчилгааг явуулахыг хязгаарласан мөртлөө зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн зар сурталчилгааг нэвтрүүлж болохоор мэт харагдаж байна.

2.Мөн Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хуулийн ишлэл авсан хэсэг алдаатай байна. Жишээ нь, Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт "Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:" гэсэн ч Төрийн хяналт шалгалтын хууль (шинэчлэн найруулсан) 16 зүйлтэй байна.

3.Хийдлийн хувьд интернэт буюу цахим хэлбэрээр явуулж болох зар сурталчилгааны зохицуулалт дутмаг байгаа учраас энэ салбарт нарийвчилсан зохицуулалт хийх нь зүйтэй юм.

4.Зар сурталчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2-т "Нутгийн өөрөө удирдах байгууллага замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албатай тохиролцсоны үндсэн дээр тээврийн хэрэгслээр зар сурталчилгаа түгээхэд тавих аюулгүй ажиллагааны болон стандартын шаардлагыг тогтоож болно" гэсэн боловч нийслэлийн захирагчийн ажлын албанаас энэ асуудлыг эрх зүйн акт гараагүй байна. Мөн тус хуулийн 24.3.3-т зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд баримтлах зөвлөмж, гэрээний үлгэрчилсэн загварыг батална гэсэн ч ийм үлгэрчилсэн дүрэм, журам одоогоор байхгүй байна.

2.3. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА НИЙТЛЭГ БАЙДАЛ, ЗҮЙЛ, ЗААЛТ

Судалгаанаас харахад Зар сурталчилгааны тухай хуулийн дараах зүйл заалтууд ихээр зөрчигдөж байна гэж үзлээ. Үүнд:

Зар сурталчилгааны тухай хуулийн зүйл заалт	Тайлбар
6.5.1.Тусгай зөвшөөрөл авааг үй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;	Гадаадад ажиллах хүч зуучлах үйл ажиллагаа нь Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл шаардагддаг ба хэрэв зар сурталчилгаа явуулах тохиолдолд тусгай зөвшөөрлийн дугаарыг нийтлэх ёстой. Гэвч ингэж нийтэлдэггүй. Жишээ нь: *Турк улсад яаралтай ажилд зуучилж байна. Цалин өндөр. Утас: 9907XXXX (Зар мэдээ сонин. 2009.07.17-21)*
6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх,худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах;	"Нарантуул" худалдааны төв дотор байрлах радио, станцаар "бууны сум зарна" гэсэн зар явдаг.
6.5.4. Хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах;	Үр зулбуулах эм, тураах эм нь чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамрагдах ёстой байтал тийнхүү хамруулалгүйгээр худалдаалах зарыг "Зар мэдээ", "Шуурхай зар" болон телевиз, радиогоор нэвтрүүлдэг. Жишээ нь. Миозин тураах эм, арьс цайрах өвчинд хэрэглэх тос гэх мэт.
6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд урууд татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй богино долгионы радио "Өндөр, царайлаг охид шөнийн 02.00 цагаас хойш утасдана уу", *"18-22 насны хөөрхөн охидтой сексдэх найз залуучууд хүлээж байна", "Удшийг зугаатай өнгөрүүлэх охидыг урьж байна", "Баасан ахын шөнө гэртээ харих гээд байгаа юм биш биз дээ, охидуудаа, тэгвэл онигоо болно шүү"* гэсэн зар түгээж буй нь хууль бус үйлдэл болж байна. Мөн нэгэн эмээ ТВ чатын тусламжтайгаар хүүгээ хашраах гэснээр хүүгийн амь эрсдсэн золгүй явдал гарч Баянзүрх дүүргийн шүүхээр энэ хэрэг шийдвэрлэгдсэн.
9.3.Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.	Жишээ нь: 2009 оны 4 дүгээр сараас эхлэн хотын гудамж, замын хажуу талд "Буруу эргэлт" уран сайхны киноны сурталчилгааны самбар тавигдаж эхэлсэн бөгөөд тус самбарт буцаж эргэхийг хориглосон замын тэмдэглэгээг ашигласан нь эндүүрэгдэхүйц байлаа.

11.1. Уран сайхны болон баримтат кино, радио жүжгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлийг авсан байна.	Зар сурталчилгаа түгээгч зарим байгууллагын ажилтнаас ярилцлагын болон анкетын аргаар судалгаа авахад уг заалтыг хэрэгжих боломж муу гэж байсан. Харин С1 телевиз монголын эрт үеийн уран сайхны киноудыг ихэвчлэн гаргадаг учраас зохиолч эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлийг авдаг гэж байсан. Энэ заалт хэрэгжихгүй байгаа гол шалтгаан нь манай улсын санхүүгийн чадавхитай холбоотой гэж хариулж байлаа. Учир нь зохиогчийн эрхийг ном журмын дагуу авах болохоор маш өндөр үнэ хөлс нэхдэг гэв.
11.3. Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	Энэ заалт бол бараг өдөр бүр бидний үздэг 19, 21 цагт гардаг тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа болон "Бизнес мэдээ" нэртэй зар сурталчилгаа гаргах гэх байдлаар зөрчигддөг. Зар сурталчилгаа түгээгч зарим байгууллагууд "Бизнес мэдээ" бол зар сурталчилгаа биш гэж тайлбарладаг боловч Зар сурталчилгааны тухай хуулийн 3.1.1-д заасан шинжийг бүрэн агуулж байгаа тул судлаачдын зүгээс "Бизнес мэдээ"-г зар сурталчилгааны шинжийг агуулж байна.
11.5. Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.	UBS телевизээр гарч байсан "Эхнэрийн урхи" олон ангит киноны үргэлжлэх хугацаа нь 45 минут байсан боловч 15 минут кино, 15 минут зар сурталчилгаа гардаг байв.
13.3. Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.	"TV shop" болон бусад телевиз сонингоор тухайн эмийн сайн тал, өвчнийг бүрэн эдгээх чадалтай гэж зарладгаас бус эмийн сөрөг нөлөөг дурьдах, хэрэглэх заавартай танилцаарай гэж сануулж байгаа тохиолдол цөөн байна. /үе мөчний эм г.м./
13.4.3.тухайн эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдлах зорилгоор сурталчлах;	Зар сурталчилгааны тухай хуулийн энэ заалт байнга зөрчигдөж байдаг. Эмийн сурталчилгаа Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.3-т заасан шиг эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдлах зорилготой биш ч гэсэн тухайн эмийн гаж үйлчлэлийг огт дурьддаггүй. Энэ нь хэрэглэгч үнэн бодитой мэдээлэл авах, тухайн бүтээгдэхүүний шинж чанарын талаар төөрөгдөлд орохгүй байх гэх мэт зар сурталчилгааны үндсэн шинжүүдийг зөрчиж байна.
13.4.4.тухайн эмийн үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;	Өвлийн улирал эхлэхтэй зэрэгцээд ханиадны эм, зуны улиралд харшлын эсрэг үйлчилгээтэй эмний сурталчилгаа ихээр цацагддаг. Зар сурталчилгааны эхний хэсэгт зовиуртай хүний байдлыг харуулаад тухайн эмийг хэрэглэсний дараа шууд эрүүлжсэн хүний төрхийг харуулдаг. Энэ нь эмийн үйлчилгээний талаар урьдчилан баталгаа гаргаж байгаа нэг хэлбэр мөн.

13.7.Эмнэлгийн байгууллагын талаархи зар сурталчилгаа нь зөвхөн байршил, үйлчилгээний чиглэл, эмчийн нэр хаягаар хязгаарлагдана. 13.8.Эмнэлгийн үйлчилгээний талаар магтсан, үйлчлүүлэхийг уриалсан сурталчилгаа явуулахыг хориглоно.	Сүүлийн жилүүдэд хувийн эмнэлэг, сувиллын газар ихээр нээгдэж байгаатай холбогдуулан энэ чиглэлийн сурталчилгаа мэдэгдэхүйц нэмэгдсэн. Ийнхүү зар сурталчилгаа явуулахдаа хуулийн энэхүү хязгаарлалтаас хэтэрч эмчилгээний үр дүнгээр баталгаа өгөх, заавал ирээрэй гэх мэтээр ятгах зөрчлийг гаргаж байна. Жишээ нь: "Очирваань", "Сэтгэшгүй" эмнэлгийн зар сурталчилгааг энд дурьдаж болох юм.
14.1.Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.	2007 оны 12 дугаар сараас 2009 оны 2 дугаар сарын хооронд WCS-ийн оюутны судалгааны баг зэрлэг амьтны бүтээгдэхүүнтэй холбоотой зарыг ихэвчлэн "Шуурхай зар", "Зар мэдээ" сонингоор цацагддаг болохыг тогтоосон байна. Эдгээр сонин дээрээс олон төрлийн зэрлэг амьтны бүтээгдэхүүний зарыг олжээ[2].
16.1.4. хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглах	Улаанбаатар хотын гудамжинд байгаа рекламны жижиг самбар дээр Mamy Poko живхний рекламанд тоглосон жаахан жаал гар буу барьсан байх жишээтэй.

Хуулийн дээрх заалтууд хамгийн ихээр зөрчигдөж байгаагаас гадна Зар сурталчилгааны тухай хуулиар захиалагч, түгээгч, бүтээгчдийн эрх, үүргийг зөв тусгаж чадаагүй байна. Юуны өмнө субъектуудын хүлээсэн үүргийг системчлэн харуулбал:

Захиалагчийн үүрэг	Бүтээгчийн үүрэг	Түгээгчийн үүрэг
-Ивээн тэтгэгч зар сурталчилгаа түгээгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх-ийг хориглоно -Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны хувьд зар сурталчилгаа захиалагч нь өөрийгөө, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлуулахдаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу түүний зохих ёсоор баталгаажсан хуулбарыг үзүүлэх үүрэгтэй.	-Зар сурталчилгаа бүтээгч нь зар сурталчилгаа захиалагчаас өгсөн захиалга, даалгавар нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. -Энэ хуулийн 22.1-д заасны дагуу урьдчилан мэдээлсэн боловч зар сурталчилгаа захиалагч өөрийн захиалга, даалгаврыг өөрчлөөгүй тохиолдолд зар сурталчилгаа бүтээгч зар сурталчилгаа бэлтгэхээс татгалзах үүрэгтэй.	-Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлөө төлбөр авахыг хориглоно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mi.gov.mn

	-Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах ***эрхтэй.*** -Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь энэ хуулийн 21.2 -т заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримт үзүүлэхийг шаардах ***эрхтэй.*** -Энэ хуулийн 21.1 -д заасны дагуу шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг захиалагчаас шаардах эрхтэй.
-Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална. -Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах нотлох баримт, тайлбар, видео болон аудио бичлэг, бусад мэдээллийг зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчээс шаардан авах эрхтэй. -Зар сурталчилгаанд хувь хүн, түүний нэр, алдар хүнд, амьдрал ахуй, эд хөрөнгө, ураг бүтээлийг үзүүлэх, дүрслэх, хэлсэн үгнээс нь ишлэл татах болон бусад хэлбэрээр ашиглахдаа тухайн хүн, эсхүл өв залгамжлагч, эрх залгамжлагчийн зөвшөөрлийг урьдчилан авна. -Нийтэд танил, нэр хүнд бүхий хуулийн этгээдийн нэр, бэлгэдэл, бүтээгдэхүүн, барааны тэмдэг, нэрийн товчлолыг зар сурталчилгаанд ашиглахад энэ хуулийн 23.1-дэх хэсгийн заалт нэгэн адил хамаарна.	

Зар сурталчилгааны эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг хуульд тусгахдаа бүтээгч, түгээгчийн эрх, үүргийг хольж, солин алдаатай зохицуулалт оруулсан гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, та дээрхи хүснэгтэд бүтээгч, түгээгчийн нийтлэг эрхийг багцалсан хүснэгтээс доогуур нь зурж тодруулсан ***эрхтэй*** гэх үгийг эрхтэй биш үүрэгтэй гэж оруулах нь зүйтэй юм..Аливаа хуулиар олгогдсон эрхийг тухайн этгээд эдлэх болон эдлэхгүй байх эрхтэй. Өөрөөр хэлбэл, эрхээ эдлээгүйн төлөө хариуцлага хүлээдэггүй. Харин хуулиар ногдуулсан үүргээ хэрэгжүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг. Гэтэл дээрх заалтуудын хувьд үүрэгтэй биш харин эрхтэй гэж тодорхойлсноор зар сурталчилгаа бүтээгч түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримт болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардахгүй байж болно. Тийнхүү шаардаагүйнхээ төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй. Харин шаардсан тохиолдолд тухайн баримтыг захиалагч гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцлах эсэх нь мөн л эрхийн асуудал. Тэгэхээр дээрх заалтуудын “эрхтэй” гэдэг үгийг “үүрэгтэй” гэж өөрчилснөөр, хариуцлагыг тодорхой болгох ач холбогдолтой гэж үзэж байна.

Нийтлэг байдлаар зөрчигдөж байгаа хуулийн зүйл заалтуудыг олж тогтоох ажлын хүрээнд “Шуурхай зар”, “Зар мэдээ”, “Үнэгүй зар” сонин болон телевизийн зарим “Чат”-ын хүрээнд судалгаа хийсэн бөгөөд холбогдох мэдээллийг дор харуулав.

"Шуурхай зар", "Зар мэдээ" сонин 7 хоногт 2 удаа /даваа, пүрэв гараг/, 1 удаагийн хэвлэлтээр 8000 ширхэг, 7 хоногт тус бүрдээ 16000, нийт 32000 ширхэг, "Үнэгүй зар" сонин 7 хоногт 1 удаа 9000 ширхэг хэвлэгдэн гарч нэг бүрийн үнэ 800 төгрөгөөр түгээлт хийж, сонин борлуулах цэгүүдэд борлуулалт 97 хувьтай гүйцэтгэгддэг байна. /Ойролцоогоор 28 сая төгрөгийн борлуулалт хийдэг тооцоо гарч байна/

Энэ нөхцөл байдлаас үзэхэд иргэд өөрт хэрэгцээтэй мэдээлэл, сурталчилгааг дээрх сонингуудаас авдаг, нөгөө талаар энэ төрлийн бизнес эрхлэгчид багагүй ашиг олдог болох нь харагдана.

"Зар мэдээ", "Шуурхай зар", "Үнэгүй зар" сонинд гарч буй зар сурталчилгааны мэдээллийн агуулга дараах төрөлтэй. Үүнд: *Ажилд урьж байна, Ажил хайж байна, Төрөл бүрийн бараа, Барилга үйлчилгээ, Барилгын материал, Виз аялал жуулчлал, Мөнгө зээл санхүү, Тоног төхөөрөмж, Барилгын материал, Сургалт дамжаа, Гадаад хэл сургалт, Эмчилгээ гоо сайхан, Ажлын байрны түрээс, Ажлын байрны худалдаа, орон сууц түрээслэх /гадаад болон дотоодын иргэнд, мөн хажуу өрөө/, Орон сууц худалдаа, хашаа байшингийн худалдаа, Авто машины худалдаа, газар, танилцья гэсэн төрелтэй байна.* Судалгааны ажлын хүрээнд *Ажилд урьж байна, Виз аялал жуулчлал* гэсэн хэсгүүдийг онцлон авч үзсэн болно.

"Ажилд урьж байна" гэсэн зарын талаар

Энэ төрлийн зар сонины нийт талбайн 8 хувийг эзэлж байгаа ба ажлын зарууд 50 орчим хувь нь хэт ерөнхий ойлгомжгүй байдлаар зарлагдсан байгаа нь Зар сурталчилгааны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад тусгасан "Хангалттай тодорхой мэдээллийг орхигдуулан, эсхүл мэдлэг, туршлага дутмаг буюу итгэмтгий байдлыг нь ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал: *Нас, хүйс, мэргэжил харгалзахгүй ямар ч хүнийг өндөр цалинтай ажилд авна. Амьдралаа өөрчлөхийг хүссэн хүн байвал бидэнд хандана уу?*

Утас: 9811хххх

Яаралтай ажилд авна. 30-40 хүнийг Утас: 9979хххх

"Зар мэдээ" сонин 2009.06.23

Мөн царай зүс, биеийн өндрийн хэмжээгээр нь шаардлага тавих, биеэ үнэлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй шинжтэй зарууд гарсаар байна.

18-23 насны охид, бүсгүйчүүдийг массажны газарт ажилд авна. Тэгш биетэй зөв царайтай байх, цалин 600 мянгаас дээш. Айх хэрэггүй. Утас 9594хххх

20-25 насны бүсгүйчүүдийг бүтэн жилээр гэрээ хийж массажистаар сургаж ажилд авна. Оюутан биш. Унаа, хоол, байр үнэгүй. Утас: 9518хххх

" Шуурхай зар" сонин. 2009.07.24

Энэ зарын дагуу холбогдож дээрх ажлын саналын талаар тодруулахад ирээд уулз, ярилцлагад орно. Массажист хийхгүй өөр ажил ч байгаа гэх зэргээр хариулт өгч байсан ба "байраар хангана" гэдэг нь биеэ үнэлэхийг зохион байгуулах магадлалтай гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Түүнчлэн "Зар мэдээ" сонинд[46] "20-25 насны эмэгтэйчүүдийг Япон, Солонгост өндөр цалинтай ажилд яаралтай зуучилна". Урьдчилгаа авахгүй" гэсэн зарыг нийтлүүлсэн бөгөөд ийнхүү нийтлүүлэхэд ямар нэгэн шалгуур тавьдаггүй, хуулийн дагуу тавигддаг тусгай зөвшөөрлийг ч лавлаж асуугаагүй. Зар нийтлэгдсэний дараа нийт 36 дугаараас 38 эмэгтэй холбогдсон бөгөөд ширээний үйлчлэгч хийх тухай хэлэхэд хоёр хүнээс бусад нь зөвшөөрсөн бөгөөд татгалзсан хүн нь "Хүн худалдаалах гэмт хэрэг биш биз" гэж асуулаа. Ер нь сонинд нийтлэгдэж олон нийтэд хүрч байгаа ажлын заруудад хүнийг зүс царай, нуруу, биеийн галбир хэмжээгээр нь шаардлага тавьж ажилд авах асуудал нь тийм ч зүй ёсны хэрэг биш гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

Виз аялал жуулчлал гэсэн зарын талаар:

Монгол Улсаас гадаадын орнуудад виз гаргахтай холбоотой зарлал сонины нийт талбайн 6.7 хувийг эзэлж байна. Энэтхэг, Турк, Япон, АНУ, Англи, Канад, Солонгос, Шенгений улсуудад сургах болон ажил хийх иргэдэд виз гаргана гэсэн зарууд дийлэнх хувийг эзэлж байна. Түүнчлэн виз хүсэх, виз гаргах талаар тогтоосон журмыг зөрчиж виз гаргах олон зар нийтлэгдсэн байна. Манай улсын иргэд гадаадын оронд ажиллах, суралцах нь элбэг болж үүнтэй холбоотойгоор гэмт этгээдүүд виз гаргаж, гадаадад хүргэж өгнө хэмээн хууран мэхэлж охид, эмэгтэйчүүд, хүүхдийг хил давуулан худалдах иргэдийн өмч хөрөнгийг залилан мэхлэх явдлууд гарсаар байна. Үүний шалтгаан нь амар хялбар аргаар гадаад оронд гарах, сурах, мөнгө олох сонирхолтой холбоотой бөгөөд дээрх байдлаар хохирсон тохиолдол бүр зарын дагуу гэмт этгээдүүдтэй холбогдсон байдаг.

Зарыг үтга агуулгаар нь авч үзвэл:

- Гадаад оронд ажиллуулна гэсэн зарууд;
- Ажиллах хүч гаргах;
- Гадаад хүнтэй гэр бүл болгох;
- Виз гаргаж хил гаргаж өгнө;
- Виз гаргуулж хил гаргуулна. Очоод тооцоог хийнэ;
- Гадаад улсад зорчих визтэй паспорт зарна;
- Гадаадад суралцуулах зэрэг зарлалууд ихээр нийтлэгдсэн байдаг.

Гадаад улсад ажиллах хүч болон сургалтын журмаар иргэдэд виз гаргана, хүргэж өгнө, зуулчилна гэсэн зарын дотор Бүгд Найрамдах Турк улс руу гаргана гэсэн зар зонхилж байна. Турк улс хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг, хүн худалдаалах зэрэг гэмт хэргүүдээр дэлхийд дээгүүрт ордог орон бөгөөд манай улсын иргэд сүүлийн үед Турк улсыг ихээр сонирхон зорчих болсон.

[46] "Зар мэдээ" сонин 2009.8.28 №63 (1238) дугаар 10 дахь тал, зарын дугаар: 358.

Турк улсад яаралтай ажилд зуучилж байна. Цалин өндөр. Утас: 9907хххх

"Зар мэдээ" сонин. 2009.07.17-21

Судалгаанд сонгон авсан сонингуудад виз гаргана гэсэн зарууд тодорхой хувийг эзэлж байна. Тухайлбал:

Солонгос улсын виз ярилцлагад оруулалгүй гаргана. Хил гарахад зуучилна. Утас:8819хххх

АНУ-руу найдвартай гаргана. Хүргэж өгч болно. Утас:8816хххх.

Мөн манай иргэдийн зүгээс гадаад гаргуулах талаар багагүй зар өгч болзол тавьж байгаа нь зар өгөгч өөрөө хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж болзошгүйг харуулж байна.

30 настай эмэгтэй 4 настай хүүгийн хамт солонгос гаргуулна. Тооцоог хил даваад хийнэ. Утас: 9916хххх

"Зар мэдээ" сонин 2009.07.24

Гадаад улсад гарах боломжтой баримт бичиг, гадаад паспорт худалдах зарууд мөн нийтлэгдэж байна.

2015 онд хугацаа нь дуусах урьд нь нэг ч гарч байгаагүй АНУ-ын 10 жилийн визтэй гадаад паспорт яаралтай хямд зарна. Жич настайвтар эрэгтэй хүнийх. Утас: 9918хххх

"Шуурхай зар" сонин. 2009.07.07

Дээрх байдлаас харахад иргэдийн гадаад улсад гарч ажил хийх эрэлт их байгаа нь харагдаж байгаа бөгөөд энэ нь хүн худалдаалах гэмт хэрэг болон бусад гэмт хэрэг үйлдэгдэх нөхцлийг бүрдүүлж байна. Визтэй гадаад паспорт зарах зар нь хуурамч бичиг баримтаар хүнийг хил давуулах боломжийг олгож байгаагаараа сөрөг үр дагавартай юм. Түүнчлэн энэ "үйлчилгээг" аж ахуйн үйл ажиллагаагаар эрхэлдэггүй бөгөөд Монгол Улсад тухайн орны хэргийг хамааран суудаг төрийн байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудал учир зарын ийм төрөл байж огт болохгүй гэж үзэж байна.

Сонинд гарсан зар сурталчилгаа нь ихээхэн онцлогтой бөгөөд тухайн нийтлүүлсэн зар нь цаг хугацааны хувьд маш өргөн хүрээтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл, зарыг сонинд нийтэлснээс хойш тухайн зарын идэвхитэй үргэлжлэх хугацаа урт байна гэсэн үг. Энэ нь зар түгээх бусад хэлбэрээсээ илүү үр дагаварыг үүсгэж байдаг.

ТВ чат

Судалгааны явцад арилжааны телевизүүдийн нэвтрүүлэгт эзлэх хувь, гарч буй мэдээллүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр нийслэл хотод ТВ8 телевизийн, Эрдэнэт хотод D10 ТВ чатыг сонгож авсан болно. Судлаачдын биечлэн очиж судалсан орон нутгийн хувьд ТВ чат байдаг боловч хууль зөрчсөн зар сурталчилгаа байдаггүй гэж хэлэхэд болно. Харин анхаарал

татах нэг зүйл бол илгээсэн мэдээллийг техникийн хувьд эфирт гарахаас өмнө хянах техникийн боломжгүй асуудал юм. ТВ8 телевиз нь өдөрт дунджаар 7 цаг орчим ТВ чат гаргадаг бөгөөд өдрийн нэвтрүүлгийн / өмнөх өдрийн нэвтрүүлгийн давталт/ дараа 4 цаг орчим, тухайн өдрийн нэвтрүүлгийн төгсгөлд шөнийн 03.00 цаг хүртэл 3 цаг орчим гардаг байна. ТВ чатаар төрөл бүрийн зар цацагддаг бөгөөд ямар нэгэн шалгуур тавьдаггүй ба туршилтын аргаар биеэ үнэлэхийг болон, гадаадад өндөр цалинтай ажилд зуучлахыг санал болгосон зар илгээв.

Эрдэнэт хотод явуулсан "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх 2 залуу байна. Call me" гэсэн мессежийг гаргах боломжгүй тухай сануулж утасны дугаар бүтэн гарч, бичгэн текст гаралгүй эфирт гарсан боловч дугаарын дагуу харилцах хүсэлтэй 3 эмэгтэй холбогдлоо. Харин Улаанбаатар хотод 2009 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 14.25 цагт "20-25 насны охидыг Япон, Солонгост өндөр цалинтай ажилд зуучилна" гэсэн зарыг ТВ8 телевизийн чат руу явуулахад шууд эфирт гарсан бөгөөд уг зарын дагуу долоон дугаараас давхардсан тоогоор 10 удаа дуудлага ирсэн байна. Мөн 2009.7.9-ний өдрийн шөнийн 01 цагт ТВ8, DESOFT ТВ чат руу "Нөхөртэй эмэгтэйтэй танилцана" гэсэн зарыг илгээхэд 38 эмэгтэй холбогдлоо.

Дээрх туршилтын судалгаанаас харахад ТВ чатаар "үйлчлүүлэгчдийн" насны байдлыг зөвхөн өсвөр насныхан гэж авч үзэх боломжгүй, өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэйг харуулж байна.

2.4. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХАРИЛЦААН ДАХЬ ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ

Зар сурталчилгааны хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ үр өгөөжгүй байгаа тухай судлаачид болон иргэд, албан тушаалтнууд ярилцлага болон судалгааны явцад санал бодлоо илэрхийлсэн.

Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд хууль зөрчигч иргэнийг 10.000-50.000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25.000-60.000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50.000-250.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулахаар заасан байна.

Энэ нь хууль дахин зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчил гаргагчийг цээрлүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаагаас гадна оногдуулж байгаа торгуулийн хэмжээ тухайн зөрчлийг гаргаснаас олсон орлогын хэмжээний харьцаа алдагдсан учраас хууль зөрчигчид эдийн засгийн хувьд илт ашигтай байгаа юм. Эрх зүй ба эдийн засгийн онолын үүднээс хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээ, хууль зөрчсөнөөс олох орлогын хэмжээнээс илүү байх нь хариуцлагын үр нөлөөг баталгаажуулах буюу эрх зүйн харилцааны оролцогч хуулийг биелүүлэх эдийн засгийн гол хөшүүрэг болдог байна.

Судалгааны явцад зохион байгуулсан уулзалт ярилцлагад оролцсон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд "хууль бус зар сурталчилгааг захиалагч сногдуулж болох торгуулийн төлбөрийг зар сурталчилгаагаа

түгээх гэрээ байгуулахдаа урьдчилан өгдөг" гэж ярьж байлаа. Үүнээс хууль зөрчигчид хүлээлгэж байгаа торгуулийн хэмжээ нь хууль зөрчсөнөөс олох ашгаас хамаагүй бага байгаа нь илт байна. Иимд бид бусад улс оронд хариуцлагын ямар үр нөлөөтэй арга хэрэглэдэг талаар судлан үзсэнээс Англи улсын туршлага дэвшилттэй бөгөөд үр өгөөжтэй байх тул дэлгэрүүлэн судалж судалгааны тайландаа тусгахаар шийдлээ. Англид зар сурталчилгаа захиалагч, түгээгчид ногдуулах хариуцлагын төрөл, хэлбэр ялгамжтай байхаар зохицуулсан байх ба субъектын үйл ажиллагааны онцлогт тохирсон, өндөр үр нөлөөтэй байх тал дээр түлхүү анхаарсан байна. Үүнд:

Хууль зөрчсөн зар сурталчилгаа захиалагчид:

- Зар сурталчилгаа захиалагчид тухайн зар сурталчилгаагаа өөрчлөх эсвэл явуулахыг зогсоохыг шаардах;
- *Сөрөг сурталчилгаа буюу зөрчлийн талаар шийдвэр гаргасан байгууллагын тухайн шийдвэрийг нийтлэх /Сөрөг сурталчилгаа нь ихэнх зар сурталчилгаа захиалагчдад сөрөг нөлөөтэй байхын зэрэгцээ олон нийтийг сэрэмжлүүлэх ач холбогдолтой /;*
- *Хууль бус зар сурталчилгааны талаар түгээгчдээд сэрэмжлүүлэг өгөх /зөрчил гаргасан субъектын зар сурталчилгааг цацах, нийтлэх үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг сануулах бөгөөд ингэхдээ сэрэмжлүүлэгт зөрчил гаргагчийн нэр, хаяг, утас, электрон шуудангийн хаяг, зөрчлийн талаар тодорхой мэдээлэл, шаардлагатай бол зураг бусад дүрсийг хавсаргасан байна/;*
- *Олгосон худалдааны давуу эрх, хүлээн зөвшөөрөх баримт бичгийг түр хугацаагаар түтгэлзүүлэх, хүчингүй болгох;*
- *Нийтлэхээс өмнө шаардлага хангаж байгааг шалгах буюу байнгын зөрчил гаргадаг этгээдийн бүх эсвэл зарим зар сурталчилгааг нийтлэхээс өмнө заавал эрх бүхий байгууллагаар хянуулж, шаардлага хангасан тохиолдолд нийтэлж байх шийдвэр гаргах;*
- *Хуулийн албадлага хэрэглэх /дээрх арга хэмжээнүүдийг авсан ч зөрчлөө арилгахгүй байгаа тохиолдолд хуулийн дагуу Шударга өрсөлдөөний газарт тухайн зөрчил гаргагчийг шилжүүлнэ. Тийнхүү шилжүүлснээр Шударга өрсөлдөөний төлөө газар хуулийн дагуу арга хэмжээ авах эрх эдэлнэ. Энэ тохиолдолд зөрчил гаргагч зөрчлөө засаагүй хэвээр байгаа тохиолдолд шүүхэд шилжүүлэх бөгөөд тэрхүү зөрчилд шүүх зохих ялыг оногдуулна/.*

Зар сурталчилгаа түгээгчид хүлээлгэх хариуцлага[47]:

- Түгээгчээс тодорхой хөтөлбөр болон зар сурталчилгааг явуулахгүй байхыг шаардах;
- Түгээгчийг тодорхой төрлийн зар сурталчилгаанууд, зар сурталчилгааны аргыг ашиглахгүй байхыг шаардах;
- Залруулга /бодитой биш зар сурталчилгааг зассан, зөв болгосон/ хийх эсвэл шийдвэрийн талаар мэдээлэхийг үүрэг болгох;

[47]The British Code of Advertising, Sales Promotion and Direct Marketing

- Санхүүгийн хариуцлага оногдуулах, эвсэл тусгай зөвшөөрлийн хугацааг багасгах;
- Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хураан авах.

Эдгээр хариуцлагын төрлүүдийг судлан үзэж, манай улсын эдийн засаг, эрх зүйн хөгжил, соёлын түвшин, уламжлалд нийцүүлэн зохих байдлаар өөрчлөн үндэсний хууль тогтоомжид суулгах боломжтой юм.

2.5. ГАДААДЫН ЗАРИМ ОРОН ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ихэнх улс телевизийн зар сурталчилгаанд хориг тавьдаг[48]. Хориг нь зар сурталчилгаа явуулах хугацаа, агуулгын хувьд хязгаарлалт тавихаас гадна хүүхдэд чиглэсэн зар сурталчилгаа, гадаадад бүтээгдсэн зар сурталчилгаа зэргийг хамарч болдог байна. Мөн түүнчлэн зар сурталчилгаа нь телевизийн хөтөлбөрөөс дуу чимээгээр илүү байх, эсвэл хөтөлбөрийн гаралт буюу цацалт зар сурталчилгаанаас муу байхыг хориглох, зар сурталчилгаа нь хөтөлбөрөөс ялгагдахуйц, зар сурталчилгаа гэж ойлгогдохуйц байх шаардлагатай байдаг байна. Хөгжингүй ихэнх оронд зар сурталчилгаанд хориг, хязгаарлалт тавих зохицуулалт нийтлэг байна[49].

Европын орнуудад зар сурталчилгааг зохицуулсан байдал

Европын Холбооны Зөвлөлөөс 1989 онд Хилийн хязгаарлалтгүй телевизийн /ХХТ/ удирдамжийг батлан гаргасан. ХХТ удирдамж нь аль нэг гишүүн улсаас цацагдаж байгаа мэдээг бусад гишүүн улсын иргэд үзэх, сонсох боломжийг хангах, Европын холбооны зар сурталчилгааны стандартын уялдааг хангах зорилготой[50]. Тухайн удирдамжаар нэг цагт дунджаар 9 минут, дээд хэмжээ нь 12 минутаас хэтрэхгүй хугацаагаар зар сурталчилгаа явуулах эрхийг олгосон байдаг боловч Франц гэх мэт зарим оронд бүр хатуу буюу нэг цагт дунджаар 6 минут, хамгийн дээд хугацаа нь 12 минут байхаар зохицуулсан байна. Харин Англи улсад олон нийтийн телевизээр зар сурталчилгаа явуулахыг хориглосон. Кабелийн телевизүүдийн зар сурталчилгааг мөн Европын Холбооны хууль тогтоомжоор зохицуулж өгсөн байдаг.

Зар сурталчилгаа завсарлагааны үеэр явуулах ёстой бөгөөд зар сурталчилгаа хоорондын хугацаа хамгийн багадаа 20 минут байна. Гэхдээ шашны гаралтай болон ээзэн хананы оролцуулсан ёслолын ажиллагаа, хөтөлбөр, парламентын мэдээлэл, боловсрол болон хүүхдэд зориулсан хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа явуулахыг хориглодог. Мөн улс төрийн шинжтэй, тамхи, мөрийтэй тоглоом, хувийн мөрдөн байцаах байгууллага, зэвсэг, порно, жороор хэрэглэх эм, спиртийн нөлөө бүхий бүтээгдэхүүнүүдийн зар сурталчилгаа явуулахыг хориглосон байдаг.

[48] Television Advertising Standards Code
[49] Regulation of television advertising, Simon P. Anderson, 2005.
[50] Regulation of television advertising, Simon P. Anderson, 2005.

Мөн шашин, хандив, танилцуулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, архи, санхүү, мөрийтэй тоглоом, эм зэрэгтэй холбоотой мэдээлэлд тодорхой хязгаарлалтуудыг тогтоосон. Далд болон харьцуулсан зар сурталчилгаанд хориг тавьсан байдаг. Зар сурталчилгааны дууны хэмжээ нь тухайн хөтөлбөрийн дууны хэмжээнээс чанга байж болохгүй[51].

Англи улс

Англи улсад зар сурталчилгааны холбоотой үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий Зар сурталчилгааны хэрэг эрхлэх газар /1962 онд байгуулагдсан/, Зар сурталчилгааны хороо /1961 онд байгуулагдсан/ гэсэн хоёр байгууллага ажилладаг. Тус хоёр байгууллага нь зар сурталчилгааг байрлуулсны төлбөрөөс 0,1 хувийн харин нэвтрүүлсний төлбөрөөс 0,2 хувийн татаас авч санхүүжилтээ бий болгодог. Ийм замаар санхүүжилтээ бий болгох нь зар сурталчилгаа явуулж байгаа байгууллагуудаас бие даасан байдлаар оршин тогтнохын зэрэгцээ тэдэнд хяналт тавих боломжийг олгодог. Зар сурталчилгааны хороо нь хэвлэл мэдээллийн байгууллага, зар сурталчилгаа захиалагчдын төлөөлөл бүхий томоохон худалдааны ассоциацаас бүрдэнэ□.

Зар сурталчилгааны хороо салбар бүрт тохирсон зар сурталчилгааны стандарт бүхий үйл ажиллагааны кодыг боловсруулан хэвлэж гаргадаг бол Зар сурталчилгааны хэрэг эрхлэх газар тэдгээр кодын зөрчилтэй холбоотой гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байна. Энэ хоёр байгууллагаас гадна Шударга худалдааны төлөө газар нь интернетийн зар сурталчилгааг зохицуулсан 1988 оны хуулийн биелэлтийг хангах үйл ажиллагаа явуулна.

Зар сурталчилгааны хорооны батлан гаргасан код нь зайлшгүй дагаж мөрдөх шинжгүй байдаг. Гэсэн хэдий ч Зар сурталчилгааны хороо тэдгээр кодыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх эдийн засгийн үр дүнтэй хариуцлагыг хүлээлгэж чаддаг. Зар сурталчилгаа захиалагчид, маркетингийн байгууллагууд, зар сурталчилгааны компаниуд тус хорооны батлан гаргасан кодыг биелүүлэх үүрэг хүлээнэ. Телевиз, радиод зориулсан нэвтрүүлгийн болон хэвлэл, самбар, интернэт зэрэгт зориулсан нэвтрүүлгийн бус гэсэн үндсэн 2 төрлийн код үйлчилдэг. Нэвтрүүлгийн бус чиглэлээр Зар сурталчилгаа, худалдаа, маркетингийн тухай Британийн код, нэвтрүүлгийн чиглэлээр Телевизийн зар сурталчилгааны стандартын код, Радиогийн зар сурталчилгааны стандартын код тус тус хүчин төгөлдөр үйлчилж байна.

Зар сурталчилгаа, худалдаа, маркетингийн тухай Британий кодын дагуу аливаа зар сурталчилгаа нь хууль ёсны, тохиромжтой, үнэн, бодитой байхыг шаарддаг. Зар сурталчилгааг бэлдэхдээ хэрэглэгчийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарласан, Шударга өрсөлдөөний зарчмуудыг баримталсан байна. Энэхүү нэвтрүүлгийн бус зар сурталчилгаанд зориулсан код нэвтрүүлгийн зар сурталчилгаа эсвэл гадаадад цацагдах зориулалтаар хийгдэж байгаа зар сурталчилгаанд хамаарахгүй.

[51] http://www.mediaknowall.com/Advertising/adstandards.html.

Гоо сайхан, эрүүл мэнд, тамхи, архи, амин дэм, хөдөлмөр, бизнес, санхүүгийн үйлчилгээ, хүүхдийн бүтээгдэхүүн, шуудангийн захиалга болон бусад салбарын үйл ажиллагаанд хамаарна[52]. Телевизийн зар сурталчилгааны стандартын код, Радиогийн зар сурталчилгааны стандартын код телевиз, радиогоор сурталчилгаа нь явагдах бүх бүтээгдэхүүнд хамаарах боловч хүүхдэд зориулсан зар сурталчилгаа болон санхүүгийн үйлчилгээ, эм, эмнэлэг, мэс засалтай холбоотой зар сурталчилгааг нарийвчлан зохицуулсан байдаг. Ерөнхий шаардлага нь бүх зар сурталчилгаа хууль ёсны, тохиромжтой, үнэн, бодитой байна. Эдгээр кодын хүрээнд хууль бус, хүлээн зөвшөөрөгдөөгүй бараа бүтээгдэхүүнийг сурталчлахыг мөн хориглодог. Үүнд мөрийтэй тоглоом, хувийн мөрдөгчийн үйлчилгээ, гэрлэлтийн бүюу танилцуулах үйлчилгээ, тамхи, архи, мансууруулах бодис, архины үнэр дарагч буюу архины хэмжээг тогтоох шалгалтын үеэр тухайн хэмжээг бууруулах үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнийг сурталчлах нь тус тус хамрагдана[53].

Зар сурталчилгааны хэрэг эрхлэх газар нь гомдол хүлээн авч хянан шалгах үүрэг бүхий байгууллага. Эхний ээлжинд тус газар нь тухайн зөрчил бүхий зар сурталчилгааг стандартад нийцсэн байдлаар өөрчлөх эсвэл зар сурталчилгаа явуулахаа зогсоохыг шаардана. Хэрвээ зар сурталчилгаа явуулсан этгээд тухайн шаардлагыг биелүүлээгүй бол Хэрэг эрхлэх газар тэрхүү байгууллагын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авахаар шийдвэр гаргах эрхтэй. Тухайн зөрчил бүхий үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байвал тухайн зар сурталчилгааг дахин цацахгүй байлгах хэмжээний зах зээлийн хатуу шаҳалтад оруулдаг байна. Хэрэг эрхлэх газраас гаргасан зөрчлийн талаарх шийдвэрийг шүүхээс хянаж болно.

Зар сурталчилгааны хорооноос гаргасан кодын зэрэгцээ интернэтийн зар сурталчилгааг зохицуулсан 1988 онд баталсан "Хуурамч зар сурталчилгааны хяналтын тогтоол" байдаг. Тухайн тогтоолын хүрээнд Шударга өрсөлдөөний төлөө газар сонин, сэтгүүл, кино, интернэт, зураг хуудас, танилцуулга, шуудан, үзүүлэн, самбар болон автобус, такси, онгоц гэх мэт тээврийн хэрэгсэлд байрлуулсан зар сурталчилгаанд хууль хэрэгжүүлэх ажиллагаагаа зохион байгуулдаг. Шударга өрсөлдөөний төлөө газар хуурамч болон хууль бус бусад зар сурталчилгаатай холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг. Гэхдээ ийнхүү хүлээн авч шийдвэрлэхдээ гомдлыг сонгох зарчмаар ажилладаг. Жишээ нь, тухайн гомдлыг өөр ямар нэгэн байгууллага харъяаллын дагуу хүлээн авааг үй, авсан ч гол зүйлийг нь шийдвэрлэж чадаагүй гэх мэт зар сурталчилгааны чухал асуудлыг хөндсөн маргааныг хүлээн авч шийдвэрлэнэ. Хотын гудамж, талбайд байрлуулах зар сурталчилгааны самбарын асуудлыг хот төлөвлөлтийн байгууллага хариуцна. Тухайн төлөвлөлтийн байгууллагын зөвшөөрөлгүй самбар байрлуулсан бол ноцтой зөрчил гэж үзэн зөрчил тус бүрт 2500 паундын торгууль ногдуулдаг байна[54].

[52] Regulation of television advertising, Simon P. Anderson, 2005.

[53] http://www.asa.org.uk/asa/.

[54] http://en.wikipedia.org/wiki/Advertising_regulation.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын "Зар сурталчилгааны тухай" Холбооны хууль нь шинээр 2006 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Төрийн Думаар нь батлагдаж өмнө нь үйлчилж байсан 1995 оны 7 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан хууль нь хүчингүй болсон байна. Энэ нь манай улстай харьцуулбал "Зар сурталчилгааны тухай" хуулиа харьцангуй сүүлд шинэчилж баталсан гэсэн үг юм. Уг хууль нь 6 бүлэг 40 зүйлтэй. Оросын Холбооны Улсын Зар сурталчилгааны тухай хуулийг Монгол Улсын Зар сурталчилгааны хуультай харьцуулбал:

ОХУ-ын Зар сурталчилгааны тухай хууль (2006.02.22)	**Манай улсын Зар сурталчилгааны тухай хууль (2002.05.30)**
1-р зүйл. Хуулийн зорилго Шударга өрсөлдөөний зарчмыг үндэслэн бараа ажил үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх, ОХУ-ын эдийн засгийн нэгдмэл байдлыг бэхжүүлэх, хэрэглэгчдийн үнэн зөв мэдээлэл авах эрхийг хангах, ОХУ-ын зар сурталчилгааны хуулийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх болон зүй зохисгүй зар сурталчилгааг таслан зогсооход тус хуулийн зорилго оршино.	**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
3.1 Зар сурталчилгаа- тодорхой бус этгээдэд чиглэсэн зах зээлийн эрэлтийн сонирхлыг бий болгох буюу дэмжих, сурталчилгааны объектод анхаарлыг татах зорилгоор аливаа арга, хэлбэр, хэрэгсэл ашиглаж түгээсэн мэдээлэл;	3.1.1."зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;
33 дугаар зүйл. Зар сурталчилгаан дахь төрийн хяналтыг хэрэгжүүлэх монополийн эсрэг байгууллагын бүрэн эрх 1. Монополийн эсрэг байгууллага нь өөрийн бүхэн эрхийн хүрээнд ОХУ-ын зар сурталчилгааны тухай хууль тогтоомжид төрийн хяналтыг хэрэгжүүлнэ...	**24 дүгээр зүйл. Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт** 24.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг оюуны өмчийн улсын хяналтын алба хэрэгжүүлнэ.

Дээрхээс дүгнэн үзэхэд ОХУ-ын хууль нь илүү нарийвчилсан зохицуулалттай, хяналт тавих эрх бүхий субъектээрээ манай улсын хуулиас ялгаатай байна. Мөн зар сурталчилгааны харилцааг төрөлжүүлэн зохицуулсан байдлаас үзвэл 26 дугаар зүйлд "Байлдааны зориулалттай бүтээгдэхүүн болон бууны зар сурталчилгааг" тусгайлан авч үзсэн нь сонирхол татаж байна. Манай улсын Зар сурталчилгааны тухай хуульд галт зэвсэг гэж шууд заагаагүй боловч энэ нь тусгай зөршөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа учир зөвшөөрөлтэй тохиолдолд зар сурталчилгаа явуулж

болдог байна. Өөр анхаарал татах асуудал нь ОХУ-ын Зар сурталчилгааны тухай хуульд "Байгаль орчны зар сурталчилгаа" гэсэн бие даасан бүлэг байхгүй байна. Харин зар сурталчилгааг оферт талаас нь хуульд тусгаж түүний хүчинтэй хугацааг тодорхойлж өгсөн байна. Хяналтын тогтолцооны хувьд зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид болон бусад этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах, ёс зүйн дүрэм боловсруулж түүний хэрэгжилтийг дагаж мөрдүүлэх, хяналт тавих зорилгоор ассоциаци, холбоо, нэгдэл, арилжааны бус түншлэл хэлбэрээр сайн дурын байгууллагуудыг байгуулж болдог байна. Ингэхдээ зар сурталчилгааны харилцаанд тухайн байгууллагуудын эдлэх эрхийг дараагийн бүлэгт нь тусгаж өгсөн бөгөөд төрөөс зар сурталчилгаанд хяналт тавих байгууллагатай харилцах, орон нутгийн удирдах байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг тус тус тусгасан байна. Мөн зар сурталчилгааны харилцаанд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, холбооны болон төрийн байгууллагын тогтоосон хэм хэмжээний актын талаарх гомдлыг арбитрын шүүхэд гаргахаар хуульчилжээ.

Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналтыг улсын хэмжээнд Монополийн эсрэг байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд төрийн байгууламж, засаг захиргааны нэгжээс хамааран /холбооны улс/ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ч зарим талаар хяналт тавьдаг байна. Жишээ нь: ОХУ-ын зар сурталчилгааны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, холбооны гүйцэтгэх эрх мэдлийн болон ОХУ-ын гүйцэтгэх эрх мэдлийн субъект байгууллагын гаргасан хэм хэмжээ тогтоогоогүй акт нь зар сурталчилгааны хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл хэсэгчлэн болон бүхэлд нь хүчин төгөлдөр бусад тооцуулахаар арбитрын шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"[55] гэж заажээ.

Хууль тогтоомж зөрчигдөд хариуцлага хүлээлгэхдээ тусгайлан зааж өгчээ. Уг хуулийн 38 дугаар зүйлд зарим субъектыг хариуцлага хүлээхгүй байхаар зааж өгсөн нь онцлог байна. Жишээ нь: 38 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт " Зар сурталчилгаа захиалагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2-8 дахь хэсэг, 6-9 дүгээр зүйл... тус тус заасан шаардлагыг зөрсөн гэж хариуцлага хүлээхгүй" гэж хуульчилжээ. Түүнчлэн зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн бол Холбооны хууль тогтоомжийн дагуу өөр төрлийн хариуцлага ногдуулж болохоор байна.

Харин анхаарал татаж байгаа асуудал бол торгуулийн хэмжээ бөгөөд уг хуульд зааснаар хувь хүн, хуулийн этгээд зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн бол Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээх бол зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчдэд захиргааны зөрчлийн тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэдэг. Торгуульд төлсөн мөнгөн дүнгийн 40 хувь нь холбооны төсөвт орж, 60 хувь нь тухайн хууль зөрчсөн хувираа аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдийг бүртгэсэн Холбооны Улсын субъектын төсөвт ордог байна.

[55] www.advesti.ru.

ГУРАВ. ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Зар сурталчилгааны тухай хуулийн 5 дугаар бүлгийн зохицуулалтаар зар сурталчилгаанд тавих хяналтыг:

- Төрийн;
- олон нийтийн;
- хамтын гэж ерөнхийлөн 3 ангилж болох юм (хүснэгт 3-с харна уу).

Эдгээр 3 хэлбэрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны уялдаа холбоо, үр нөлөөний талаар тус тусад нь үзье.

3.1 ТӨРИЙН ХЯНАЛТ

Зар сурталчилгааны тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйлд зааснаас үзвэл төрийн хяналтыг хамрах хүрээгээр нь:

- Улсын;
- Орон нутгийн;
- Салбарын гэж хуваасан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг **Оюуны өмчийн улсын хяналтын алба**, орон нутгийн хэмжээнд **Засаг дарга**, түүний томилсон байцаагч, салбарын хяналтыг эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчлал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг чиглэлийн **мэргэжлийн хяналтын алба**, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зар сурталчилгааны хувьд тухайн **тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага** өөрийн чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй байна.

Улсын хэмжээний хяналтыг Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга, 2 байцаагчийн хамт нийт 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлж байна. 2.5 сая хүн амтай, зөвхөн нийслэлийн хэмжээнд 18 телевиз, 4 кабелийн телевиз, өдөр тутмын 12 сонин, ... самбар, 42001[56] интернэтийн хэрэглэгч, олон тооны хэвлэх үйлдвэр, 4 үүрэн холбооны операторын 1 763 178[57] үйлчлүүлэгчийн хүрээнд 2 байцаагч хяналтыг хэрэгжүүлж байгаа нь зар сурталчилгааны хуулийн биелэлт улсын хэмжээнд ямар түвшинд байгаагийн тод илрэл болно. Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтэс Зар сурталчилгааны тухай хуулийн биелэлтийг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд:

- зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчигдсөн эсэхийг тогтоож, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- хууль бус зар сурталчилгаанаас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулах бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

[56] http://www.ictpa.gov.mn/?p=129&lang=mn.
[57] http://www.ictpa.gov.mn/?p=129&lang=mn.

- өөрийн санаачилгаар, эсхүл бусад этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, шаардлага, мэдээллийг судалсны үндсэн дээр зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээх ажилд шалгалт хийх;
- тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зар сурталчилгаанд хяналт тавих орон нутгийн байгууллага, албан тушаалтныг арга зүйн удирдлагаар хангаж;
- зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд баримтлах зөвлөмж, гэрээний үлгэрчилсэн загварыг батлах;
- зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагад тавих;
- зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах;
- тухайн зар сурталчилгаа хуульд заасан шаардлагыг зөрчсөн эсэхийг тогтоох, түүнийг бүтээх, түгээхийг түдгэлзүүлэх, зөрчлийг арилгахыг шаардах;
- хуульд заасан бусад бүрэн эрх.

Зар сурталчилгааны тухай хууль батлагдсан үеэс буюу 2002 оноос эхлэн 2008 он хүртэл Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтэс нийт 1574 удаа хяналт шалгалт хийж 132 550 000 төгрөгийн торгууль ногдуулсан байна. Мөн 6 жилийн хугацаанд 17 удаа сургалт, семинар зохион байгуулжээ.

Иймхүү Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн 6 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг тоон үзүүлэлтээр үзүүлбэл[58]:

Хүснэгт-1: Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн хийсэн хяналт, шалгалт тоон үзүүлэлт (2002-2008)



Энэхүү мэдээллээс харахад Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын

[58] Оюуны өмчийн газраас авсан мэдээллээр.

хэлтэс 2002 онд жилдээ 10 хэрэгт хяналт шалгалт хийж байснаа 2004 оноос огцом өсч 2006 онд хамгийн их буюу 537 хэрэгт хяналт шалгалт хийсэн байх ба энэ үзүүлэлт 2008 он хүртэл эрчимтэй буурч 60 болсон байна. Иргэдийн өргөдөл гомдлын дагуу 6 жилийн хугацаанд 9 хэрэгт л хяналт шалгалт хийсэн нь энэ талаарх иргэдийн идэвх санаачлага, мэдлэг муу байгаа нь харагдаж байна. Нийт хяналт шалгалтын ихэнхийг буюу 928 хэргийг төлөвлөгөөт графикийн дагуу хянан шалгасан байна.

Хүснэгт-2: Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсээс ногдуулсан торгуулийн хэмжээ (2002-2008)



Дээрх хүснэгтээс харахад 2006 онд хамгийн их буюу нийт 56.5 сая төгрөгийн торгуулийг хууль зөрчсөн этгээдэд ногдуулж байсан бол энэ тоо 2008 онд 8.9 сая болтлоо буурсан үзүүлэлт харагдаж байна. Иймхүү тоон үзүүлэлт буурсны шалтгаан Оюуны өмчийн газрын мэргэжилтэн "Азийн чоно" компани техникийн спиртээр архи үйлдвэрлэж олон хүн хордуулсантай холбсотойгоор тайлбарлаж байлаа.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас авсан мэдээллээр тэд зар сурталчилгаатай холбоотой гурван хэрэгт хяналт шалгалт хийж, зохих арга хэмжээг авсан байна. Эдгээр зөрчлүүдэд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэг "Өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах", 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэг "өөрийн болон өрсөлдөгчийн үйлдвэрийн газар, түүний байршил, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх" гэсэн 2 заалт нийтлэг байдлаар зөрчигджээ.

Судалгааны багаас үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг томоохон компаниудын мэдээлэл сурталчилгаа, маркетинг, борлуулалт эрхэлсэн ажилтнуудаас анкетийн асуулга авсан. Уг асуулгаар "Зар сурталчилгаа зах зээлд шударга бусаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэгч нэг хүчин зүйл гэдэгтэй та санал нийлж байна уу?" гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 63.3% нь "огт санал нийлэхгүй байна" гэж хариулснаас

харахад одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Зар сурталчилгааны тухай хууль шударга бус өрсөлдөөнийг гаргахгүй байхад чиглэсэн зохицуулалтыг тодорхой түвшинд тусгасан нь харагдаж байна. Мөн энэ нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хуулийн хэрэгжилтийг хангах үүргээ муугүй биелүүлдэгтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт-3: Зар сурталчилгааны төрийн хяналтын тогтолцоо


Зар сурталчилгаанд тавигдах хяналт
Төрөөс тавих хяналт
Хамтын хяналт
Олон нийтийн хяналт
Онцгой өөрчлөн уялсан хяналтын арга
Засаг дарга, түүний томилсон этгээд
• Мэргэжлийн хяналтын арга
• Мэдээллийн байгууллага
• Тусгай зөвшөөрөл олгосон байгууллагууд
ӨӨГ-ын ХА + төрийн хяналтыг хэрэгжүүлэх бусад байгууллагууд
Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагууд
✓ Ажлаасүйл ээгч
✓ Байгууллага
✓ Хувь хүн
Төрийн бус байгууллага
-Хяналт, шалгалт хийх
-Арга зүйн удирдлагаар хангах
-Үлгэрчилсэн загвар бэлтгэх
-Тусгай зөвшөөрөлтэй нүцшээ, түдгэлзүүлэх саналыг тавих
-Шүүхэд нэхэмжлэл гаргах
-Хууль зөрчигдсөн нь тогтоогдсон бол зөрчлийг арилгуулах, сэргийлэх, хохирлыг барагдуулах, хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргах
-Хэрэв зөрчлийг арилгаагүй бол шүүхэд нэхэмжлэл гаргах
-Хэрэв зөрчил нь гэмт хэрэгт хамаарах бол эрх бүхий байгууллагад мэдээлэх
-Зөрчлийг арилгуулах, сэргийлэх, хохирлыг барагдуулах, хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргах

Орон нутаг дахь төрийн хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Тухайн орон нутгийн хэмжээнд мэдээлэл тараадаг мэдээлэх хэрэгслээр түгээсэн зар сурталчилгаанд аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний томилсон байцаагч хяналт тавина" гэж заажээ. Иймхүү хяналт тавих бүрэн эрх бүхий этгээд дараах эрхийг эдэлж үүрэг хүлээнэ:

- зар сурталчилгааг хуульд заасан шаардлагад нийцүүлэхийг шаардах;
- зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;
- илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- хууль тогтоомж зөрчсөн зар сурталчилгааг түгээхийг зогсоох;
- зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчигчид хуулийн дагуу хариуцлага ногдуулах;
- хуульд заасан бусад эрх, үүрэг.

Хэдий ийм боловч орон нутагт хийсэн судалгаагаар хуулийн энэ заалт огт хэрэгжихгүй байгаа буюу орон нутаг дахь төрийн хяналт байхгүй байна гэж хэлж болохоор байна.

Улаанбаатар хотод:

"Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг тусгасан хуулийн хэрэгжилт 2005-2009 он" тайланд "Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт "**Нийтийн эзэмшлийн** газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох нийтлэг журмыг тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллага тогтооно" гэж заасан байдаг боловч Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоолоор батлагдсан журамд **Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт** гэж өргөн цар хүрээг хамруулан заасан байдаг нь зөрчилдөж байгааг харуулж байна. Ингэснээр хувийн орон сууц, барилга байгууламж, хувийн эзэмшлийн газар дээр зөвшөөрөлгүй гадна реклам, мэдээллийн байгууламж байрлуулах нөхцөлийг бүрдүүлж байна". "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлаж байгаа гадна реклам мэдээллийн байгууламжийг хариуцсан 1 мэргэжилтэн байгаа нь хаанаа ч хүрэхгүй байна" гэж хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл хэсэгт дурьдсан байна.

Үүнээс харахад хуульд заасан хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ганцхан мэргэжилтэн ажилладаг нь Улаанбаатар хотын хэмжээнд хүрэлцээ муутай байдаг нь нотлогдож байна. Судалгааны хугацаанд судалгааны баг Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хангах чиг үүрэг бүхий Нийслийн Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны Реклам, зар сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнтэй хэд хэд удаагаж, ярилцлагын аргаар судалгаа авсан.



Орон нутагт хийсэн судалгаа:

Бид 2009 оны 6 дугаар сарын 17-ноос 7 дугаар сарын 3-ны хооронд Дорнод, Орхон аймаг, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллаж тухайн орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Зар сурталчилгааны тухай хуулийн хяналт, түүний үр нөлөөнд ярилцлагын аргаар, хууль бус зар сурталчилгаанд тандалт болон анкетын аргаар судалгаа хийсэн болно.

Судалгааны хүрээнд аймаг бүрийн Засаг даргын Тамгын газар, Шүүх, Прокурор, Тагнуул, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын алба, Хил хамгаалах газар, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцсан болно. Ийнхүү хийсэн судалгааны үр дүнд тогтоогдсон нөхцөл байдлыг аймаг бүрээр авч үзвэл.

Дорнод аймагт:

Дорнод аймгийн Хэрлэн суманд 2009 оны 6 дугаар сарын 18-20-ний өдөр ажиллав.

Дорнод аймгийн шүүхийн ерөнхий шүүгч, Хэрлэн сумын сум дундын шүүхийн ерөнхий шүүгч, аймгийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, Цагдаагийн газрын дэд дарга, тус газрын хүүхдийн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, Тагнуулын газрын дарга, Хилийн цэргийн шалган нэвтрүүлэх 0132 дугаар ангийн захирагч, Аймгийн прокурор, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурор, ЗДТГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий менежер, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, ЗДТГ-ын Үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл, харилцаа холбооны улсын хяналтын байцаагч, D1 телевизийн менежер, Кайф ФМ 100.9-ийн найруулагч, "Хэрлэн" телевизийн сэтгүүлч, "Талын монгол" ФМ 107.5-ын найруулагч, "Шинэ суваг" телевизийн сэтгүүлч нартай уулзаж ярилцлагын аргаар судалгаа авсан. Мөн 100 иргэнээс анкетын асуулга авч 3 иргэнээс ярилцлагын аргаар судалгаа авав. Тус аймаг нь хойд хэсгээрээ Оросын Холбооны Улсын Чита мужтай, урд талаараа БНХАУ-ын Алтан-Эмээл, Манжуур хоттой хиллэдэг, 80 орчим мянган хүн амтай, хүн амын суурьшил их, орон нутгийн 3 телевиз, 2 сонин, 2 богино долгионы радио станцтай бөгөөд бусад аймагтай харьцуулахад зар сурталчилгаа ихээхэн хэмжээгээр цацагддаг байна. Гэвч тус аймгийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцахад зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хариуцдаг албан тушаалтан байхгүй бөгөөд энэ талаар ямар нэгэн дүрэм журам аймгийн хэмжээнд гаргаж байгаагүй, Тамгын газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас зар сурталчилгааны талаар ямар нэгэн гомдол, хүсэлт ирүүлж байгаагүй байна.

Орхон аймагт:

Судалгааны ажлын хүрээнд 6 байгууллагын 10 албан тушаалтнаас ярилцлагын аргаар, 100 гаруй иргэдээс анкетын, ярилцлагын аргаар судалгаа авлаа. Үүнд: Тагнуулын газрын дарга, сум дундын ерөнхий шүүгч, аймгийн прокурорын орлогч, Цагдаагийн газрын хэрэг бүртгэх албаны

дарга, эрүүгийн төлөөлөгч, олон нийттэй харилцах албаны байцаагч, ЗДТГ-ын өмгөөлөгч, Хуулийн хэлтсийн ажилтан, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан нартай уулзаж ярилцлаа. Эрдэнэт хотод орон нутгийн 5 телевиз, зар сурталчилгааны төрлийн 2 сонин байдаг боловч Орхон аймаг нь нийслэл хоттой ойрхон байдаг, TB9, TB5, UBS телевиз орон нутагт гардаг болсон, мэдээллийн технологийн харилцаа өндөр хөгжсөн, зар сурталчилгааны ЛХА телевиз нь зар нэвтрүүлэх цагийн хязгаарлалт байдаггүй /7 төрлийн урсдаг зар байнга явж байдаг/, "Зар мэдээ", "Шуурхай зар" сонин цаг алдалгүй шуурхай ирдэг онцлогтой байна.

Түс аймгийн хэмжээнд зар сурталчилгааны хяналтыг ЗДТГ-ын Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн хариуцдаг байна. Тэрээр ярихдаа *"ЗСТХ-ийг зөрчсөн зөрчилд нэг удаа 150 000 төгрөгийн торгууль ногдуулсан /соглууруулах ундааны хууль бус сурталчилгаа явуулаад байсан/ Улиралд 2-3 зөрчил илэрдэг. Хотын хаана аль хэсэгт байрлуулах вэ? гэдгийг байрлуулсан самбар дээр юу байрлуулах вэ? гэдгийг хотын захирагчийн алба хариуцдаг. Соглууруулах ундааны зүйл байвал Мэргэжлийн хяналтын газар албан бичиг явуулаад арга хэмжээ авдаг. Манай аймагт "Лха" телевиз, "Номин" телевизтэй холбоотой иргэдээс ирсэн мэдээллийн дагуу телевизүүдэд албан бичиг явуулж байсан. /энэ телевизүүд шөнийн цагаар порно кино гаргаад хажуугаар нь ТВ чат нэвтрүүлэгд байсан/. Удирдах байгууллагаас бодлогоор зохицуулдаггүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөггүй, энэ ажлыг хариуцаж хийлээ гээд ямар ч урамшуулал байхгүй, цалин ч байхгүй харин жилийн эцэст ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ биелүүлээгүй гээд хариуцлага хүлээх болдог. Энэ чиглэлээр дагнан хариуцдаг орон тооны мэргэжилтэнтэй болох нь үр дүнтэй. Манай аймагт соглууруулах ундаа олгох журам байдаг. Нэг удаа журмыг зөрчих юм бол үйл ажиллагааг нь хүчингүй болгонс. Манайд үйл ажиллагаагаа явуулдаг том сүлжээ дэлгүүрүүд торгуулийг нь төлөөд /80 000 төгрөг/ хууль зөрчдөг. Реклам, зар сурталчилгаа нь хууль зөрчиж байгаа тухай иргэдийн мэдээллээр ажилладаг. Зарим тохиолдолд цаг гаргаад ТВ чат үзэдэг. Мөн гадуур явж рекламны самбаруудыг үзнэ гэх мэтээр цаг их ордог боловч энэ ажлыг хийлээ гээд цалин дээр ямар ч урамшуулал байдаггүй. Илэрсэн зөрчлийн дагуу бид албан бичиг явуулаад албан бичгийн дагуу арга хэмжээ аваагүй тохиолдолд үйл ажиллагааг нь хаах хүртэл арга хэмжээ авдаг"* гэлээ.

Орхон аймгийн хувьд Дорнод болон Замын-Үүдтэй харьцуулахад зар сурталчилгааны тухай хуулийн биелэлтийг хариуцсан нэг албан тушаалтантай, тэр нь өөрийн нөөц бололцооны хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдгаараа дэвшилттэй байгаа юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд:

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 2009 оны 7 дугаар сарын 1-3-ны өдөр ажилласан. Ийнхүү ажиллахдаа сум дундын II шүүхийн ерөнхий шүүгч, сумын ахлах прокурор, Цагдаагийн газрын дарга хурандаа, эрүүгийн

төлөөлөгч, Хилийн цэргийн 108 дугаар ангийн дэд дарга, Тагнуулын хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, хуулийн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч, Замын-Үүд боомтын Хилийн мэргэжлийн хяналтын газрын дарга, Замын-Үүд радио ФМ 107.5. Ерөнхий найруулагч, Чөлөөт бүс кабелийн телевиз болон ФМ 106.5-ын сэтгүүлч нартай уулзаж ярилцсан. Мөн 100 иргэнээс анкетын асуулга авч 3 иргэнээс ярилцлагын аргаар судалгаа авав.

Тус сум нь албан ёсны бүртгэлээр нийт 12 мянга орчим суурьшмал хүн амтай боловч өдөрт дунджаар 3 мянган хүн дамжин өнгөрдөг онцлогтой. Сумын иргэд ихэвчлэн Хятад улсын Эрээн хот руу гарч наймаа хийх, тэнд ажиллах гэх мэтээр суурин байж хэвлэл мэдээллээр цацагдаж байгаа зар сурталчилгааг хүлээж авах нь бага байдаг нь ажиглагдлаа. Сумын хэмжээнд нийт 2 телевиз, 2 богино долгионы радио станцтай, 1 сонинтой. Телевизийн нэвтрүүлэг цацагдаж байхад доогуур нь туузан зар нэвтэрдэг ба тэдгээр нь ихэвчлэн алдсан гээсэн, худалдана, худалдаж авна, банкны үйлчилгээ, нийтийн хоолны газрын сурталчилгаа гэх мэт төрөлд хамаарч байлаа.

Сумын хэмжээнд Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан байхгүй байна гэж үзэхээр байна. Учир нь сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь "хуулийн 1 мэргэжилтэн хариуцан ажилладаг" гэх боловч тухайн албан тушаалтантай уулзахад тэрээр "миний ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй, ийм төрлийн үйл ажиллагаа явуулж байгаагүй" гэж байлаа. Мөн сумын хэмжээнд гудамж, талбайд байрлуулах самбар, зар сурталчилгааны зураг хуудсыг хэрхэн байрлуулах, ямар стандарт, шаардлагыг хангасан байх, хөлс төлбөрийн талаар ямар нэгэн зохицуулалт хийгдээгүй байна. ЗДТГ-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн сумын хэмжээнд тухайн асуудлыг зохицуулсан журам боловсруулах төсөл боловсруулсаныгаа танилцуулж байлаа. Сумын хэмжээнд хууль бус зар сурталчилгаа явж байсан болон түүний улмаас ЗДТГ-аас ямар нэгэн арга хэмжээ авч байсан тохиолдол гарч байгаагүй гэх ба энэ талаар иргэдээс ч хүсэлт, гомдол гарч байгаагүй байна. Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хуулийг боловсронгуй болгох талаар ямар нэгэн саналыг уулзсан хүмүүс хэлэхгүй байлаа. Учир нь Зар сурталчилгааны тухай хуулийн талаар мэдлэг таараагүй, үүний улмаас хуулийн зохицуулалтын талаар ойлголт дутмаг байна.

Дээрх мэдээллээс харахад Орхон аймгаас бусад 2 аймагт зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан байхгүйн улмаас тухайн салбар ямар ч хяналтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Салбарын хяналт

Зар сурталчилгааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг "Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай

зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй", 24 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт ".... Эдгээр хяналтын алба, байгууллага нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагад шуурхай ирүүлэх үүрэгтэй" гэж тус тус заажээ. Хэдийгээр хуульд ийнхүү салбарын хяналт хэрэгжих үндсийг тавсан боловч энэ нь бодит байдал дээр хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байна. Жишээ нь МХЕГ-ын байцаагчид ярилцлагын үеэр "Зар сурталчилгааны тухай хуульд зааснаар Оюуны өмчийн газар хяналтыг тавих ёстой, бидний ажлын чиг үүрэгт зар сурталчилгаанд хяналт тавих эрх үүрэг байхгүй" гэж байлаа. Харин НМХГ-аас 2008 онд эмийн зар сурталчилгааны байдалд шалгалт хийсэн байна. Уг шалгалтанд хамрагдсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр "Для нос", "Терафлю", "Пиковит", "Неуробекс", "Геритамин, "Септолете" зэрэг эмийг сурталчилж байгаа ба тус байгууллагууд нь эм, эмийн зүйлс бусад эрүүл мэндийн бүтээгдэхүүний улсын бүртгэлийн гэрчилгээ, чанарыг нотолсон баримт, хүнсний болон хүний эмийн салбар зөвлөлийн комиссын протокол зэргийг үндэслээгүй сурталчилсан, сурталчилж буй бүтээгдэхүүний дагалдах бичиг баримтыг баримтжуулж хадгалаагүй, хяналт тавьдаггүй зэрэг зөрчил нийтлэг байсан байна. Мөн Монголчуудын амьдрал, Сэрүүлэг, Зар мэдээ, Шуурхай зар, Хүмүүс, Хүмүүсийн амьдрал сонины газрууд, Ай ТВ, ТВ-9, С-1, 25 дугаар суваг телевиз, 103.6 FM радио зэрэг байгууллагад бүтээгдэхүүний талаар урьдчилсан баталгаа гаргасан, мэдлэг, туршлага дутмаг, итгэмтгий байдлыг ашигласан, иргэдийг төөрөгдөлд оруулсан сурталчилгааг, "Шуурхай зар", "Зар мэдээ" сонингуудад жороор олгох болон эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заагдсан үр зулбуулах эмийг борлуулах зорилгоор тус тус сурталчилсан, радио телевизээр явуулж байгаа зар сурталчилгааны хугацаа, цагийн хэмнэл нь алдагдалтай, сургалтын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур хүнсний болон хоол, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааг түгээж байгаа зөрчлүүд нийтлэг байна. НМХГ-т зар сурталчилгаатай холбоотой гомдол, хүсэлт ирдэг эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэдэг талаар мэдээлэл авах зорилгоор биечлэн уулзах, албан бичиг явуулах зэргээр холбогдсон боловч энэ талаар ямар нэгэн мэдээлэл өгсөнгүй. Харин иргэдээс авсан анкетийн асуулгаар Зар сурталчилгаанаас үүдэн хохирч байгаа иргэд хаана хандахаа мэддэг эсэхийг судлахаар Зар сурталчилгаанаас үүдэн хохирсон бол хаана хандаж байсан бэ? гэсэн асуултад доорх байдлаар хариулсан байна. Үүнд:

№	Хаана хандсан	Тоо	Хувь
1	Бүтээгдэхүүн худалдан авсан газартаа очин хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардсан	15	39.47
2	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг		-
3	Мэргэжлийн хяналтын газарт	3	7.89

4	Оюуны өмчийн улсын хяналтын албанд		-
5	Шүүхэд		-
6	Бусад		-
7	Ямар нэгэн газарт хандаагүй	20	52.63
8	Хариулаагүй		-

Үүнээс дүгнэхэд зар сурталчилгааны улмаас өөрт нь хохирол учирсан гэж үзсэн иргэдийн ердөө 8 хүрэхгүй хувь нь МХГ-т хандаж байсан байна.

3.2.ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ

Зар сурталчилгааны тухай хуулийн **25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт** "Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн болон түүнтэй холбоотой мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт эрх бүхий байгууллагад тавих, шаардлагатай бол мэдээлэх хэрэгслээр нийтийг сэрэмжлүүлж болно", түс зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ:

- хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах;
- тухайн зар сурталчилгаа хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж буй эсэх талаар зөвлөмж гаргах;
- зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид зар сурталчилгаатай холбогдох санал тавих, зөвлөмж өгөх.
- Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно" гэж тус тус заажээ.

Хуулийн энэхүү зохицуулалтаас харахад зөвхөн төрийн бус байгууллага шүүхэд хэрэглэгчийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж болохоор байна.

Олон нийтийн энэ хяналт хэр хэрэгжиж байгааг Оюуны өмчийн газрын тайлан болон судалгааны багийн шүүхийн архивт сууж түүврийн аргаар хийсэн судалгаанаас харж болохоор байна. Судалгааны баг 2009 оны 7 дугаар сарын 20-28-ны өдөр Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн архивт сууж Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх, Налайх дүүргийн 2006-2008 оны шүүхийн шийдвэртэй танилцсан бөгөөд зар сурталчилгаатай холбоотой байж болох хэргийн тоон үзүүлэлтийг дор хүснэгтэд харуулав.

Хүснэгт-4: **Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх, Налайх дүүргийн 2006-2008 оны шүүхийн шийдвэрт хийсэн судалгааны үзүүлэлт**

Нийт уншсан хэргийн тоо: **27 497**		
Үүнээс зар сурталчилгаатай холбоотой хэргийн тоо: **111**		
Харилцааны төрлөөр	Зар сурталчилгааны тухай хуулийг баримтлан шийдвэрлэсэн	3
	Виз гаргаж өгөх	45
	Худалдах, худалдан авах	23
	Зээл	5
	Түрээс	18
	Ажил гүйцэтгэх	3
	Хөдөлмөр	2
	Бусад	12

(Шүүхийн архивт суусан тэмдэглэлийг хавсралт хоёроос үзнэ үү.)

Хүснэгтээс харахад Зар сурталчилгааны тухай хуулийг баримтлан 3 хэргийг л нийслэлийн хэмжээнд шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээр гурван хэргийн нэхэмжлэгчээр "Иргэдийн Альянс" төрийн бус байгууллага, хариуцагчаар ТВ9, ТВ5, UBS оролцож хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байв.

Иргэний нэхэмжлэлдээ мэдээллийг авсан арга нь зар сурталчилгаа байсан гэж тэмдэглэгдсэн нийт 111 хэрэг байснаас "виз гаргаж өгнө" гэсэн зар хамгийн олон буюу 45 нэхэмжлэлд дурьдагдсан байсан бол "худалдах, худалдан авах" тухай зар 23 нэхэмжлэлд дурьдагдсан байлаа. Нэхэмжлэгч зар сурталчилгааг ямар эх сурвалжаас авснаа нэхэмжлэлдээ тодорхой тусгаагүй байсан болно.

Энэхүү үзүүлэлтийг Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн 2006-2008 онд хийсэн хяналт шалгалтын тоотой харьцуулахад 935 харьцах нь 3 гэсэн дүнтэй гарч байна. Өөрөөр хэлбэл, шүүхэд нэхэмжлэл гаргаж болох 935 (зөвхөн хяналтад өртөгдсөн зөрчил) зөрчлөөс зөвхөн 3 тохиолдолд л олон нийтийн хяналт хэрэгжиж чадсан байна. Мөн Оюуны өмчийн газрын "Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилт" тайлангаас харахад 2002-2008 оны хугацаанд 1574 удаа хийсэн хяналт шалгалтын 9 нь л өргөдөл, гомдлын үндсэн дээр хийгджээ.

Судалгааны багийн гишүүд Нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн (НХЭАХН) дарга, ажилтнуудтай уулзаж ярилцлагын болон баримт бичгийн аргаар судалгаа хийсэн юм. Судалгааны явцад НХЭАХН-ийнхэн зар сурталчилгаа үнэн бодитой байх хуулийн шаардлагыг хангахгүй байна, зар сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллагын талаар гомдол ирж байгаагүй гэж байв. Тус байгууллагад ирсэн 180 гомдолтой уншиж танилцахад нийт 8 гомдолд зар сурталчилгааны дагуу очиж үйлчилгээ, бүтээгдэхүүн авсан гэж дурьдсан байлаа. Эдгээр гомдлын дагуу НХЭАХН тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулсан байгууллагатай холбогдон торгох, бүтээгдэхүүнийг солих, буцаах, үйлчилгээний төлбөрийг буцаах гэх мэт арга хэмжээ авсан байна. Гэсэн хэдий боловч тухайн зар сурталчилгааг түгээсэн, бүтээсэн байгууллагатай хариуцлага тооцох,

хууль бус зар сурталчилгаа явуулсан гэсэн үндэслэлээр төрийн эрх бүхий байгууллагад хандсан тохиолдол байхгүй байна.

Үүнээс дүгнэхэд зар сурталчилгаа нь хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон хэрэглэх сэдлийг бий болгодог мөртлөө тэрхүү сонголтыг хийх болсон хүлээгдсэн үр дүнг бий болгодоггүй буюу үнэн бодитой биш зарын улмаас иргэд хохирсоор байгаа нь харагдаж байна. Харин иргэдэд Зар сурталчилгааны тухай хуулийн талаарх мэдээлэл өгөх, буруутай этгээдийг зөв олж тогтоон хуульд заасан хариуцлага хүлээлгүүлэхээр зохих байгууллагад хандуулдаг болгоход чиглэсэн шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нийслэл болон гурван аймгийн хэмжээнд авсан анкетын асуулгаас харахад зар сурталчилгааны улмаас хохирсон үедээ иргэд ихэвчлэн зохих байгууллагад ханддаггүй, цөөхөн хувь нь мэргэжлийн хяналтын газар хандаж байсан байна. Өөрөөр хэлбэл, хяналт тавих гол субъект болох Оюуны өмчийн газарт хандаж байсан тохиолдол судалгаанд хамрагдсан иргэдийн дунд гарч байгаагүй байна. Харин зар сурталчилгаанд тавигдаж байгаа хяналт хэр байгаа талаар иргэдээс асуухад доорх байдлаар хариулжээ.

Зар сурталчилгаанд тавих хяналт таны бодлоор хэр байна гэж үзэж байна вэ?



Иргэдээс авсан санал асуулгын дэлгэрэнгүйг хавсралт гурваас үзнэ үү.

3.3 ХАМТЫН ХЯНАЛТ

Зар сурталчилгааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Оюуны өмчийн улсын хяналтын алба энэ хуулийн 24.6, 25 дугаар зүйлд заасан этгээдтэй харилцан мэдээлэл солилцох, шаардлагатай хяналт, шалгалт, судалгаа хамтран явуулах зэргээр ажиллаж болно" гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтэс төрийн хяналтыг хэрэгжүүлэгч дээр дурьдсан байгууллагууд болон олон

нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч хүвь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагатай хяналтыг хамтран хэрэгжүүлж болохоор тусгасан байна.

Оюуны өмчийн газраас өгсөн мэдээллээр хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа өнгөрсөн 7 жилийн хугацаанд зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтийн асуудлаар Зар сурталчилгааны тухай хууль батлагдан гарсан жил буюу 2002 онд Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Монгол Улсын байгаль орчны яам, 21 аймгийн Засаг даргад хуулийн шинэ зохицуулалтын талаар мэдэгдэж, холбогдох мэдээлэл авах санал явуулж байжээ. Мөн 2006-2008 оны хооронд хуулийн нэмэлт, өөрчлөлтөд санал өгөх чиглэлээр 3-4 байгууллагатай харилцаж байсан байна. Үүнээс өөрөөр хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор салбарын хяналт тавих эрх бүхий этгээд болон олон нийтийн байгууллагатай хамтарч ажиллан тодорхой үр дүнд хүрсэн мэдээлэл байхгүй байна[59].

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

59 *Оюуны өмчийн газрын зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааны чиглэлээр хийсэн ажлын талаархи мэдээлэл, Оюуны өмчийн газар, 2009 он.*



ДӨРӨВ. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОРЫН АСУУДАЛ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ХОХИРЛЫН АСУУДАЛ

Зар сурталчилгаа ба гэм хор, хохирлын сэдвийн хүрээнд асуудлыг иргэн, эрүүгийн эрх зүйд хэрхэн шийдвэрлэж болох, ямар асуудал тулгараад байгаа болон түүнийг хэрхэн сайжруулах талаар авч үзэх нь асуудлыг тал бүрээс нь бүрэн авч үзэх зарчимд нийцэж байгаа тул судалгааны баг хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжид хийсэн судалгаа болон түүврийн аргаар хийсэн судалгааг энэ бүлэгт тусгасан болно.

4.1.ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОРЫН АСУУДАЛ

Иргэний эрх зүйн үндсэн зарчмуудын нэг нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим байдаг. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш байдлаар оролцож байгаа хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага аль нь боловч бусдын хууль болон гэрээ зөрчиж учруулсан гэм хор, хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй байна. Иргэний хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт зааснаар **мэдээлэл** нь иргэний эрх зүйн харилцааны объект байж болох ба Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа / цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн **мэдээллийг**" ойлгох тухай заажээ.

Нэгэнт зар сурталчилгаа гэдэг нь мэдээлэл юм бол иргэний эрх зүйн харилцааны объект болох бөгөөд тухайн харилцаанд оролцогч захиалагч, бүтээгч, түгээгч, зар сурталчилгааг хүлээн авагч хэн боловч иргэний эрх зүйн харилцааны субъект мөн. Иймд зар сурталчилгааны эрх зүйн харилцааг Зар сурталчилгааны тухай хуулийн нарийвчилсан зохицуулалтаар зохицуулахаас гадна энэ нь иргэний эрх зүйн харилцааны суурь зарчим, ерөнхий зохицуулалтын хүрээнд хамаарах ёстой байна.

Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.4 дэх хэсэгт "Тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэлд гэрээ байгуулах санал болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах дуудлага гэнэ" гэжээ. Нэгэнт зар сурталчилгаа гэдэг нь олон нийтэд чиглэсэн өөрөөр хэлбэл тодорхой бус этээгдүүдэд чиглэсэн мэдээлэл байдаг тул түүнийг гэрээ байгуулах санал гаргах дуудлага гэж үзэх үндэстэй байна. Иймд тухайн зар сурталчилгааны захиалагч гэрээ байгуулах саналын дуудлага гаргаж байгаа бөгөөд тухайн зарыг хүлээн авсан этгээд гэрээ байгуулах санал гаргах эсэхээ шийдэх юм.

Гэм хор гэдэг нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон

эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, гэмтээсэн, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэрэг ордог[60]. Иргэний хуулийн дагуу гэм хор учруулсан нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл[61] болох ба иргэний харилцаанд оролцогчид учруулсан хохирлыг арилгуулах замаар харилцаанд оролцогчийн эрхийг хамгаалдаг[62]. Мөн түүнчлэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.3 дахь хэсэгт "Гэм хор учруулахад **хэд хэдэн этгээд оролцсон** бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэж заасан.

Үүнээс харахад үндэслэлтэй гэж үзвэл зар сурталчилгааг захиалагч, бүтээгч, түгээгчийг зар сурталчилгаанаас үүдэлтэй гэм хорыг учруулахад хамтран оролцсон гэж үзэж нэгэн адил хариуцлага хүлээлгэж болохоор байна. Иймд иргэд болон иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага, өмгөөлөгчид гэм хор учирсан тодорхой хэрэг дээр зөвхөн захиалагч буюу худалдагч, үйлчилгээ үзүүлэгчийг биш тэрхүү бүтээгдэхүүн үйлчилгээний зар сурталчилгааг үнэн бодит бус бүтээсэн түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллага, зар сурталчилгаа бүтээгч хуулийн этгээдүүдийг хамтран хариуцлагад татах нь зөвхөн тухайн иргэний эрхийг хамгаалахаас гадна хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хэвлэл мэдээллийн байгууллага, бизнесийн бусад байгууллагын ниймийн хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой байна.

Зар сурталчилгаанаас үүсэх гэм хорын тогтооход хялбар эсэх болон гэм хор учирсан субъектээр нь доорх байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

- Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор;
- Тогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор;

Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор гэдэгт доорх зүйлсийг ойлгох үндэстэй. Үүнд:

- Эрүүл мэндээрээ хохирох (АӨСҮТ-ийн эмч ажилтнуудтай уулзахад арьсны өвчнийг эмчилдэг "Б" гэх эмч, тураах тос, гоо сайхны бүтээгдэхүүн мэтээс хүмүүс хордох, харшлах тохиолдол элбэг байгаа гм);
- Эд хөрөнгө нь устсан, гэмтсэн (Хөргөгч дуудлагаар засна гэсэн зарын дагуу хөргөгчөө засуулсан боловч бүр эвдэлсэн /ХЭАХН/);
- Сэтгэл ханамжгүй байдал үүссэн ("Түшиг" их дэлгүүрээс Estee Lauder-ийн мөнгө, алтны хольцтой бүтээгдэхүүнийг үрчлээг 14 хоногийн дотор арилгана гэж рекламдсаны дагуу худалдан авч хэрэглэсэн боловч тухайн үр дүн гарахгүй байгаа /ХЭАХН/);
- Бизнесийн нэр хүндээ алдах;

[60]Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй /тусгай анги/, УБ., 1997., 48 дахь тал.
[61] Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг.
[62]Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4 дэх хэсэг.

- Олох байсан ашиг, орлогоо алдах (ШӨХТГ-аас ШБӨХТХ-ын 101.1, 10.1.2 зөрчсөн дүгнэлтүүд);
- Бусад.

Тогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор гэдэгт доорх гэм хорыг хамруулж үзэх боломжтой. Үүнд:

- Буруу, ташаа мэдээлэл цацах замаар төөрөгдөл бий болгох (Хадгаламж зээлийн хоршоо);
- Нийгэмд муу зуршил бий болгох (архи, тамхи, садар самууны зар сурталчилгаа);
- Буруу үлгэр, жишээ үзүүлэх замаар буруу сэдэл төрүүлэх, хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх (буу барьсан хүүхэд, эзэмшихээ даашинзыг хайчлах);
- Бусад.

Ийнхүү гэм хорыг субъект, хамрах хүрээ, онцлог шинжээр нь ангилж авч үзэх нь гэм хорыг зөв үнэлэх, түүн дээрээ үндэслэн нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлтэй гаргах, хууль хэрэгжүүлэх бусад тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байна.

Зар сурталчилгаанаас үүдэн гэм хор учирч байгаа эсэхийг тогтоохоор Арьсны өвчин судлалын үндэсний төвд очиж, эмч, үйлчлүүлэгчдээс ярилцлагын болон баримтын аргаар /АӨСТ-с гаргадаг "Арьс судлал" сэтгүүл/ судалгаа хийв.

Хүн амын дунд эм, хоол, химийн бодис хэрэглэснээс хордлого харшлын дерматит /Цочроогч хүчин зүйл нь хоол боловсруулах зам, судсаар, арьсан доор, булчинд мөн амьсгалын замаар орсноос арьсан дээр хурц үрэвсэл явагдахыг хордлого харшлын дерматит гэнэ/ үүссэн эмчлүүлэгсдийн тоо жил ирэх бүр нэмэгдэн улсын хэмжээнд 2004 онд 151 өвчлөл бүртгэгдэж байсан бол, 2005 оны байдлаар 190 болж, 20 хувиар ихэссэн байна.Мөн 2004 онд хордлого харшлын дерматит өвчлөлийн шалтгааныг 2005 оныхтой харьцуулахад эмийн зохисгүй хэрэглээ хэвээр байна. Харин хоол хүнсэндээ анхаарч баталгаагүй бүтээгдэхүүн хэрэглэхээс татгалзах болсон шалтгаан тодорхойгүй үзүүлэлт өссөн нь хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой[63].

Дээрхи дүн мэдээнээс үзвэл: сүүлийн үед эм болон үсний будаг, барилгын материал, хүнсний бүтээгдэхүүнээс хүмүүс их хордож байгаа болович эмч болон үйлчлүүлэгчид тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэх болсон сэдлийг хаанаас авсанд ач холбогдол өгдөггүй учир үйлчлүүлэгч бүрийг гадуур зарласан зар сурталчилгаанд итгээд эрүүл мэнд, гоо сайхнаараа хохирсон гэж дүгнэх боломжгүй. Гэвч эм болон гоо сайхны бүтээгдэхүүний хувьд иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж олон нийтэд танил болсон бүтээгдэхүүнийг сонгох магадлал өндөр байдаг байна.

Энэ нь "Максима мониторинг" ХХК-с гаргасан телевизээр хамгийн их хэмжээгээр сурталчилдаг бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гоо сайхны бараа, эмийн бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн хамгийн их зар

[63] 2005 онд арьсны өвчин судлалын төвд хордлого харшлын дерматит өвчны улмаас эмчлүүлсэн байдалд хийсэн судалгаа Бу.Оюун /АӨСТ/.

сурталчилгаа явагддаг гэсэн шалгууруар эхний 10-т багтсан байгаагаар батлагдаж байна. Мөн эмч ажилтнуудтай уулзаж байхад арьсны өвчнийг эмчилдэг Бадангаа гэх эмч, тураах тос, гоо сайхны бүтээгдэхүүн гэх мэтээс хүмүүс хордох, харшлах тохиолдол элбэг байгаа гэж байсан нь дээрхи дүн мэдээг батлах үндэстэй гэж үзэж байна. Үүнээс гадна УМХГ-аас 2008 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр 9 төрлийн зөрчил илэрсэн нь судлаачдын дээрх дүгнэлтийг баталж байна.

Мөн судалгааны багийн гишүүд НХЭАХН-ийн дарга, ажилтнуудтай уулзаж ярилцлагын болон баримт бичгийн аргаар судалгаа хийсэн юм. Тус байгууллагад ирсэн 180 гомдолтой уншиж танилцахад нийт 8 гомдолд зар сурталчилгааны дагуу очиж үйлчилгээ, бүтээгдэхүүн авсан гэж дурьдсан байлаа. Тэдгээр гомдлын утгыг товч дурьдвал:

1. Лавлахаас компьютер засна гэсэн зарын дагуу холбогдож компьютерээ засуулсан боловч сэтгэл ханамжгүй байсан;

2. Лавлахаас дуудлагаар үйлчилдэг залууг дуудан үйлчилгээ хийлгээд хохирсон;

3. 2008 оны 6 дугаар сард С-1 телевизээр гарсан нэвтрүүлгийн дагуу Nathersaure бүтээгдэхүүнийг авч хэрэглээд хохирсон. Зард тухайн бүтээгдэхүүнийг авч хэрэглэвэл 3 сард батга арилна, 6 сарын дотор батга сорвигүй болно гэж байсан бөгөөд нийт 600 000 төгрөгийн бүтээгдэхүүн авч хэрэглэсэн боловч үр дүнгээ үзүүлээгүй;

4. "Хурд" авто сэлбэгийн их дэлгүүр 4 сарын баталгаат худалдаа зарласан боловч хугацаандаа согогтой бүтээгдэхүүнээ буцаахгүй байна;

5. "Танайд очъё" ХХК-ийн тараасан сурталчилгааны дагуу утасдаж хөргөгчөө засуулсан боловч хохирсон. Компани хариуцлага хүлээхгүй гэсэн;

6. Тухайн моторыг маш сайн гэж рекламдсаны дагуу авсан боловч шаардлага хангахгүй байна;

7. "Түшиг" их дэлгүүрээс Estee Lauder-ийн мөнгө, алтны хольцтой бүтээгдэхүүнийг үрчлээг 14 хоногийн дотор арилгана гэж рекламдсаны дагуу худалдан авч хэрэглэсэн боловч тухайн үр дүн гарахгүй байгаа тул учирсан хохирлоо арилгуулмаар байна;

8. Хөргөгч дуудлагаар засна гэсэн зарын дагуу хөргөгчөө засуулсан боловч бүр эвдэлсэн. Гомдол барагдуулахгүй утсаа салгаад алга болсон тухайн үйлчилгээнийхээ зарыг дахин телевизээр явуулаад байсан.

Эдгээр гомдлын дагуу НХЭАХН тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулсан байгууллагатай холбогдон торгох, бүтээгдэхүүнийг солих, буцаах, үйлчилгээний төлбөрийг буцаах гэх мэт арга хэмжээ авсан боловч тухайн зар сурталчилгааг түгээсэн, бүтээсэн байгууллагатай хариуцлага тооцох, хууль бус зар сурталчилгаа явуулсан гэсэн үндэслэлээр төрийн эрх бүхий байгууллагад хандсан тохиолдол байхгүй байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас авсан мэдээллээр тэд зар сурталчилгаатай холбоотой дараах гурван тохиодлолд хяналт шалгалт хийж, зохих арга хэмжээг авсан байна. Үүнд:

1.2006 онд Нийгмийн даатгалын Ерөнхий газар, ХААН банк хамтран

Баянзүрх дүүргийн 1, 2, 3, 4, 7 дугаар хорооны иргэдэд буруу мэдээлэл өгч хэвлэмэл хуудас тараан төөрөгдүүлсэн асуудлыг шалгаж "ХААН банк" Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10.1.1, 10.1.2 дахь заалтыг зөрчсөн болохыг тогтоож 250 000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан.

2.2006 онд томоохон шоу, урлагийн тоглолт нь сурталчилгаатайгаа нийцэж буй эсэхийг тогтоох чиглэлээр шалгахад дуучид хоолойтой бичлэг хэрэглэх бүюу амьдаар дуулна гэж зарласан тоглолтууд нь бичлэг фонограмтай явагдаж байсан зөрчил нь Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөнийг тогтоож, холбогдох арга хэмжээг авч байсан.

3.2009 оны 1 дүгээр сард "Номин холдинг" ХХК-ийн "Өргөн хэрэглээний бараа хямдарлаа, үйлдвэрийн үнээр зарна" гэсэн агуулга бүхий сурталчилгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн 7.2.3, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10.1.1, 10.1.2, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байх тул зөрчлийг дахин гаргахгүй байхыг мэдэгдэж, 250 мянган төгрөгөөр торгох арга хэмжээ авсан.

Мөн НМХГ-аас 2008 онд эмийн зар сурталчилгааны байдалд шалгалт хийсэн байх бөгөөд тухайн шалгалтын дүнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шалгалтад хамрагдсан бүх хэвлэл мэдээллийн байгууллага эм, эмийн зүйлс бусад эрүүл мэндийн бүтээгдэхүүний зар сурталчилгааг захиалагч байгууллагын тусгай зөвшөөрөл, сурталчилж буй бүтээгдэхүүний улсын бүртгэлийн гэрчилгээ, чанарыг нотолсон баримт, хүнсний болон хүний эмийн салбар зөвлөлийн комиссын протокол зэргийг үндэслэзгүй сурталчилсан.
- Ай ТВ, SBN телевизээс бусад байгууллага нь сурталчилж буй бүтээгдэхүүний дагалдах бичиг баримтыг баримтжуулж хадгалаагүй, хяналт тавьдаггүй.
- Монголчуудын амьдрал, Сэрүүлэг, Зар мэдээ, Шуурхай зар, Хүмүүс, Хүмүүсийн амьдрал сонины газар, Ай ТВ, ТВ-9, С-1, 25 дугаар суваг телевиз, 103.6 FM радио зэрэг байгууллага бүтээгдэхүүний үйлчлэлийн талаар урьдчилан баталгаа гаргасан, мэдлэг, туршлага дутмаг, итгэмтгий байдлыг ашигласан, иргэдийг төөрөгдөлд оруулсан сурталчилгааг түгээсэн.
- Шуурхай зар, Зар мэдээ сонинд жороор олгох болон эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заагдсан үр зулбуулах эмийг борлуулах зорилгоор сурталчилсан.
- ТВ-8, 25 дугаар суваг телевизээр "Очирваань эмнэлэг" жороор олгохоор заагдсан уламжлалт эмийг борлуулах зорилгоор сурталчилсан.
- Ай ТВ, С-1 мэргэжлийн боловсон хүчин дутмаг, нэвтрүүлэгч, хөтлөгч нарын харилцааны соёл, үг хэллэг, хүнд хүрч буй мэдээ, мэдээлэл иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангахгүй.
- ТВ-8, Ийгл, Ай ТВ, ТМ телевизүүдийн зар сурталчилгааны хугацаа,

цагийн хэмнэл нь алдагдалтай, сургалтын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур хүнсний болон хоол, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааг түгээдэг.

Иргэдээс авсан анкетын асуулгаар "Таны бодлоор ямар төрлийн зар сурталчилгаа хүмүүст илүү их хохирол учруулж байна вэ?" гэсэн асуултад доорх байдлаар харицлсан байна. Үүнд:

№	Нэр төрөл	Тоо	Хувь
1	Хүнсний бүтээгдэхүүн	61	20.82
2	Эм, гоо сайхны бүтээгдэхүүн	135	46.08
3	Хүсний нэмэлт бүтээгдэхүүн	30	10.24
4	Ажил, үйлчилгээтэй холбогдолтой зар	34	11.60
5	Бусад	13	4.44
6	Хариулаагүй	20	6.83

Үүнээс дүгнэхэд зар сурталчилгаа нь хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон хэрэглэх сэдлийг бий болгодог мөртлөө тэрхүү сонголтыг хийх болсон хүлээгдсэн үр дүнг бий болгодоггүй буюу үнэн бодитой биш зарын улмаас иргэд хохирсоор байгаа нь харагдаж байна. Харин иргэдэд Зар сурталчилгааны тухай хуулийн талаарх мэдээлэл өгөх, буруутай этгээдийг зөв олж тогтоон хуульд заасан хариуцлага хүлээлгүүлэхээр зохих байгууллагад хандуулдаг болгоход чиглэсэн шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Судалгааны баг 2009 оны 7 дугаар сарын 20-28-ны өдөр Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн архивт сууж 7 дүүргийн 2006-2008 онд шүүхээр шийдвэрлэсэн практикийг судлахдаа нийт 24497 хавтаст хэрэг уншсанаас Зар сурталчилгааны тухай хуультай шууд холбоотой 3 хэргийг шийдвэрлэсэн талаар урьд дурьдсан. Эдгээр хэргийг тус бүрээр нь авч үзвэл: /Тайланд шийдвэрийг хавсаргасан болно./

Хэрэг 1:

Огноо	2007.11.12
Хэргийн дугаар	1282
Шүүх	Баянгол дүүргийн шүүх
Нэхэмжлэгч	Монголын үндэсний сүлжээ төв (Иргэдийн Альянс төв) ТББ
Нэхэмжлэлийн утга	Улаанбаатар телевиз нь олон нийтэд зориулсан нэвтрүүлгийнхээ дундуур соггуурулах ундааг ил болон далд хэлбэрээр байнга сурталчлан Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байна. Иймд тус телевизээр явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох, Улаанбаатар телевиз болон түүний холбогдох албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж өгнө үү гэжээ.
Хариуцагч	"Улаанбаатар телевиз" ХХК"-ийн Ерөнхий захирал Л.Балхжав

Хариуцагчийн хариу тайлбар	Бид хууль зөрчсөн үйлдэлдээ дүгнэлт хийн Зар сурталчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Оюуны өмчийн газрын улсын байцаагчийн тавьсан 1 750 000 төгрөгийн торгох захиргааны шийтгэлийг биелүүлж, зохих хариуцлагыг хүлээсэн болно.
Шийдвэрлэсэн байдал	Хэргийг шүүх хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж хариуцагч хуульд заасан хариуцлагыг ногдуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталсан шүүгчийн захирамж гаргажээ.

Хэрэг 2:

Огноо	2008.2.14
Хэргийн дугаар	142
Шүүх	Сонгинохайрхан дүүргийн шүүх
Нэхэмжлэгч	Монголын үндэсний сүлжээ төв (Иргэдийн Альянс төв) ТББ
Нэхэмжлэлийн утга	ТВ5 телевиз нь олон нийтэд зориулсан нэвтрүүлгийнхээ дундуур соггуурруулах ундааг ил болон далд хэлбэрээр байнга сурталчлан Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байна. Иймд тус телевизээр явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох, албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж өгнө үү гэжээ.
Хариуцагч	ТВ5 телевизийн Ерөнхий захирал Н. Базаррагчаа
Хариуцагчийн хариу тайлбар	Цаашид иймд далд зар сурталчилгааг нэвтрүүлэхгүй байхад онцгой анхаарал тавих болно. Мөн хуульд заасан арга хэмжээг авахад тэтгалзах зүйлгүй гэв.
Шийдвэрлэсэн байдал	Соггуурруулах ундааны ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоохыг хариуцагчид даалгаж 200 000 төгрөгөөр торгосон.

Хэрэг 3:

Огноо	2008.01.15
Хэргийн дугаар	92
Шүүх	Сүхбаатар дүүргийн шүүх
Нэхэмжлэгч	Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийг төлөөлж Монголын үндэсний сүлжээ төв (Иргэдийн Альянс төв) ТББ
Нэхэмжлэлийн утга	ТВ9 телевиз нь олон нийтэд зориулсан нэвтрүүлгийнхээ дундуур соггуурруулах ундааг ил болон далд хэлбэрээр байнга сурталчлан Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байна. Иймд тус телевизээр явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох, албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж өгнө үү гэжээ.
Хариуцагч	ТВ9 телевиз
Хариуцагчийн хариу тайлбар	Бид цаашид иймд далд зар сурталчилгааг нэвтрүүлэхгүй гэсэн тул нэхэмжлэлийн эхний шаардлага хангагдсан. Нэхэмжлэлийн 2 дахь шаардлагын хувьд тухайн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас хариуцлага хүлээлгэж, торгууль ногдуулж байсан болно.
Шийдвэрлэсэн байдал	Соггуурруулах ундааны ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоохыг хариуцагчид даалгасан. Хууль зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулах тухай шаардлагад үүсгэсэн иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосугай гэжээ.

Дээрх гурван хэргийн хувьд Зар сурталчилгааны тухай хуульд заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалан буруутай этгээдийг шүүхэд хариуцагчаар дуудсан нь дэвшилттэй байгаа хэдий ч иргэний эрх зүй талаасаа зар сурталчилгааны гэм хорыг тогтооход анхаарах олон асуудал байна. Үүнд:

Нэхэмжлэгчийн хувьд:

Зар сурталчилгааны тухай хуульд олон нийтийн хяналтыг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хэрэгжүүлж болохоор заасан байдаг. Ийнхүү заахдаа төрийн бус байгууллагад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн боловч энэ эрхийг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд дурдаагүй. Гэсэн хэдий ч үндэслэлтэй гэж үзвэл хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж шүүхэд нэхэмжлэл гаргаж болох эрх нь иргэний хуулийн дагуу нээлттэй байгаа юм. Дээрхи гурван хэргээс харахад бүх хэрэгт төрийн бус байгууллага нэхэмжлэгчээр оролцсон байна.

Хариуцагчийн хувьд:

Дээрх гурван хэрэгт нэхэмжлэгч зар сурталчилгаа түгээгчдийг хариуцагчаар татсан байдаг. Нэг зар сурталчилгааг хүлээн авагчид хүргэх явцад захиалагч, бүтээгч, түгээгч гэсэн 3 субъект оролцдог. Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно" гэж заасан учраас гурван субъект гүрвуулаа буруутайд тооцогдох боломжтой буюу гурвууланг нь хариуцагч байхаар нэхэмжлэл гаргах боломжтой. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд тодийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэж заасан байдаг.

Нэхэмжлэлийн шаардлагын хувьд:

Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно" мөн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ:

-хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах" гэж заажээ.

Дээрх гурван хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлага гаргахдаа нийтлэгээр а/ явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох, б/ албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулах гэсэн 2 шаардлагыг тавьсан байна. Энэ тохиолдолд тухайн зар сурталчилгааны улмаас учирсан шууд гэм хорыг тооцон гаргах, шалтгаант холбоог тогтоох нь



хүндрэлтэй учраас мөнгөн хэлбэрээр гэм хорыг арилгах талаар нэхэмжлэх нь хүндрэлтэй байж болох юм. Гэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хязгаарласан заалт Иргэний хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хуульд байхгүй учраас тухайн төрийн бус байгууллага тэрхүү зар сурталчилгааны эсрэг (жишээ нь архины хэрэглээг багасгах, хор уршгийг тайлбарласан) зар сурталчилгаа явуулахад гарах зардлыг нэхэмжилж болох юм.

4.2.ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОРЫН АСУУДАЛ

Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль бус зар сурталчилгааг эрүүгийн гэмт хэрэгт тооцох тусгайлсан зүйл, анги байхгүй. Харин дараах үйлдлүүдийг сурталчилсан тохиолдолд нийгэмд аюултай гэж тооцон гэмт хэрэгт тооцож болохоор тусгайлан заажээ. Үүнд: **Садар самууныг сурталчлах/123/, Шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах /144/, Терроризмыг сурталчлах /178/ Дайныг сурталчлах, уриалах /298/** зэргийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Мөн зарим төрлийн хэргийн обьектив талын шинжид сурталчилсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож болохоор байна. Тухайлбал: Эрүүгийн хуулийн **86 дугаар зүйлд**[64] "Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны үзэл номлолоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх зорилгоор **ухуулга, сурталчилгаа явуулсан...** бол" **156**[2] **дугаар зүйлд** "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аймшигч нь үг тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн, **өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийсэн..."**[65], **169 дүгээр зүйлд** "Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан... бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, **хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний** улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ. 2007 оноос 2009 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн Садар самууныг сурталчлах/123/, Шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах /144/, Терроризмыг сурталчлах /178/ Дайныг сурталчилах, уриалах /298/ гэмт хэрэг цагдаагийн байгуулагад нэг ч бүртгэгдээгүй байна[66].

[64] Эрүүгийн хуулийн 84 дүгээр зүйл "Үндэсний эв нэгдлийг бусниулах".

[65] Эрүүгийн хууль 156 дугаар зүйл "Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих".

[66] Улсын хэмжээнд бүртгэгдсэн 2007-2009 оны эхний 7 сард бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ 2009.8.5 ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төв.

4.2.1.1.ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүн худалдаалах гэмт хэргээс /ХХГХ/ урьдчилан сэргийлэхэд зар сурталчилгааны эрх зүйн орчин чухал үүрэгтэй. Учир нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх урьдач нөхцөл нь зар сурталчилгаа болдог байна. Өөрөөр хэлбэл, зар сурталчилгааны хяналтгүй байдлыг давуу талаа болгон гэмт хэргийн хохирогчид болон гэмт үйлдэлдээ ашиглах бичиг баримтыг зарын дагуу олж авдаг нь тогтоогджээ. Үүнд нэг жишээг татвал:

2004-2007 онд шийдвэрлэгдсэн нийт 17 ХХГХ-ийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож графикт үзүүлсэн байна[67]. Мөн дээрх хэргүүд үйлдэгдэхэд нөлөөлсөн зар сурталчилгааг түгээсэн байгууллагуудыг ямар нэгэн байдлаар хэрэгт хамааруулан шалгаагүй, хариуцлага хүлээлгээгүй. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШХ-ийн 80 дугаар зүйл 80.1.6-д заасан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нотлох хүрээнд хууль бус зар сурталчилгааг түгээсэн байгуулагад хариуцлага тооцдог болох нь чухал ач холбогдолтой болно. ХХГХ-ээс зар сурталчилгаа талаас нь урьдчилан сэргийлэх талаар Садар самуун явдалтай тэмцэх тухай, Зар сурталчилгааны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Эрүүгийн хууль хэрэглэлтэй тодорхой заалт байгаа боловч хэрэгжилт нь тэр болгон үр нөлөөгүй байна /2007 оноос 2009 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл "Садар самууныг сурталчлах" гэмт хэрэг цагдаагийн байгуулагад нэг ч бүртгэгдээгүй байна[68]/.

Судалгааны хамрах хүрээнээс шалтгаалан урьдчилан сэргийлэх явдлыг нийслэлд болон судалгаа хийсэн орон нутаг гэж хуваасан болно.

Нийслэлд

Нийслэлийн хэмжээнд хууль бус зар сурталчилгаа түгээх явдал нь хамгийн түгээмэл бөгөөд ингэхдээ ТВ чат, зар мэдээллийн сонинг ашиглаж байна. ХХГХ-ийн гаралтын байдлыг авч үзэхэд нийслэл хотод үйлдэгддэг бөгөөд үүнд зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын болон аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл олгодог байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах зэрэг ажиллагаа огт хийгддэггүй нь нөлөөлдөг ажээ. ХЗҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектороос 2009 оны 8 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан "Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт уулзалтад оролцогсдын ярьж буйгаар хууль бус зар сурталчилгааны эсрэг тодорхой арга хэмжээ авдаг боловч үр дүн муутай байдагт бүгд санал нэгтэй байсан юм. Мөн шүүгч нартай хийсэн уулзалтад оролцсон нэгэн шүүгч хэлэхдээ: "ТВ чатаар хүүгээ захиалга өгч алуулсан гэх хэрэг буюу "чатын эмээгийн" хэрэг гэж нэрлээд байгаа хэрэг дээр прокурор хяналт тавихдаа чатаар тэр зарыг нэвтрүүлсэн телевизийг хариуцлагад татах ёстой байсан.

[67]ХЗҮХ-ийн ЭЭЗКС-ын эрдэм шинжилгээний ажилтнуудын хийсэн судалгаа 2009 он.

[68] Улсын хэмжээнд 2007-2009 оны эхний 7 сард бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ 2009.8.5 ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төв.

Тэгсэн бол бусад мэдээллийн хэрэгсэл тодорхой хэмжээгээр сургамж болох байсан байх гэж бодож байна."[69] гэж ярилцлагын судалгаанд хариулав.

Орон нутагт

Дээр дурьдсанчлан судалгаанд хамрагдсан орон нутгийн хэмжээнд хууль бус зар сурталчилгаа бага байгааг хэлэхийн сацуу Эрдэнэт хотод туршилтын аргаар хийсэн судалгааг дурдахыг хүсэж байна. Зар сурталчилгаанд тавих хяналт хэдийгээр харьцангуй сайн байгаа гэж хэлж болох боловч авч буй зарим арга хэмжээ, нийслэлд бэлтгэгдэн түгээгдэж буй мэдээллээс /зарын сонин, орон даяар цацагдаж байгаа арилжааны телевизүүд/ шалтгаалан тэр болгон үр дүнд хүрэхгүй байна. ТВ чатаар дамжуулж биеэ үнэлэх явдал нарийссан, өөрөөр хэлбэл, садар самуунд уруу татсан үг хэллэгтэй бичмэл зарыг ТВ чатаар нэвтрүүлэхдээ текстийг дардаг боловч дугаарыг нь гаргаж байгаа нь учир дутагдалтай. Текстийг дарах нь "Санхүүгийн тусламж өгнө, авна" гэх мэт зүй бус зар болох сэдэл төрүүлж дугаар руу нь залгаж уулздаг нь туршилтын явцад тогтоогдсон.

4. 2.1.2.ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХЭД ЗАР СУРТАЛЧИЛГАА НӨЛӨӨЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгааны явц, судалгаанд оролцсон байдлыг харахад ХХГХ хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй зар сурталчилгааны гол цөм нь "нийслэл Улаанбаатар"-т байна гэж дүгнэж болохоор байна. Мэдээ, мэдээлэл хурдацтай тархахын хэрээр хууль бус зар сурталчилгаа ч тэр хэрээр тархана. Үүнд нэг жишээ татахад орон нутагт амьдарч байгаа иргэдийн сэтгэхүйд нийслэлд ажлын байрны эрэлт их байдаг гэсэн бодлыг тэндээс бэлтгэн хүргэж байгаа "*аливаа мэдээлэл*" маш хүчтэй нөлөөлжээ.

Энэ явдалд орон нутгийн захиргааны байгууллага хяналт тавих боломжгүй байгаа юм. ХХГХ үйлдэхэд нөлөөлж болох зар сурталчилгаа болон бусад сөрөг мэдээлэл дараах хэлбэрээр нийгэмд хүрч байна.

- Зар мэдээлийн сониноор;
- Телевизийн эфирээр /ТВ чат/;
- Интернэт ашиглаж;
- Түсгай дугаарын утас.

Дээрх хэлбэрүүдээс хамгийн өргөн хүрээтэй нь зарлал мэдээллийн сонин, телевизийн хэрэгсэл гэж үзэж болно. Энэ нь дараах энгийн үндэслэлээр тайлбарлагдана.

1. Өнөө цагт нийслэлд айл болгон телевизортой. Монгол Улс даяар цацаж буй суваг болгоныг ихэнх өрх үзэж байгаа. Судалгаа явуулах хугацаа оюутан сурагчдын зуны амралтын цаг таарсан нь онцлог байсан бөгөөд, хичээлийн шинэ жил эхлээд ТВ чатаар "үйлчлүүлэгчдийн" тоо эрс өсөх нь мэдээж юм. Олон эцэг, эхийг хэцүү байдалд оруулж байгаа зүйл бол ТВ

[69] 2009.8.21-нд ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-оос зохион байгуулсан "Зар сурталчилгаа ба гэм хор" сэдэвт уулзалт ярилцлагын тэмдэглэл.

чат. Үүнд холбогдох боломжоор хангагдсан ямар ч насны хүүхэд эцэг эх нь ч төсөөлж байгаагүй бэлгийн харьцааны ил задгай, бүдүүлэг, садар самуун явдал харуулсан үгсийг олж үзэхээр болсон байна. Үүнээс үзэхэд ТВ "чат" нь садар самууныг сурталчилж байгаа нэгэн эх сурвалж болж байгааг хэлэхийн сацуу өөрөө тухайн телевизийн санхүүгийн боломжоо зузаатгах нэг гол суваг нь болж байна гэдгийг бидний хийсэн судалгаанаас гадна НХХЯ-ны судалгаа харуулж байна[70].

Түүн дотроос ТВ8 телевизийн ТВ чатыг жишээ болгон авч үзвэл: ТВ8-телевизийн "чат" нь уг сувгийн бүх мэдээллийн 38.4%-ийг эзэлж байгаа ба нэвтрүүлэг нь өдөр бүр гардаг. Өдөр, орой гэсэн байдлаар хоногт дунджаар 8 цаг орчим гардаг байна.

Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон өнөө үед төр засагтаа, ард иргэддээ хандсан, цаашлаад юу хүссэнээ илэрхийлсэн, уриалсан, шаардсан, бүр сексийн хамтрагч хайсан, ивээн тэтгэхээ амласан, биеэ үнэлэхээ ичгүүр сонжуургүй илэрхийлсэн олон арван санал хүсэлт телевизийн сувгууд, ТВ "чат" хэмээх нэвтрүүлгээр цацагдах болсон. Гэтэл заримдаа манай залуучуудад үзэл бодлоо хэтэрхий чөлөөтэй илэрхийлэх боломжийг ЧАТ нэвтрүүлгүүд олгож байна.[71]

2. "Зар мэдээ" сонинд өгсөн "20-25 насны охидыг Япон, Солонгост өндөр цалинтай ажилд яаралтай зуучилна"[72] гэсэн зарын идэвхитэй үргэлжлэх хугацаа нь ТВ зарыг бодвол харьцангуй удаан, ойролцоогоор 5 хоног буюу дараагийн зар гарах хүртэл үргэлжилдэг байна. Үүнтэй зэрэгцэн гадаадад гэр бүлээр нь зуучлах, виз гаргах, визтэй гадаад паспорт зарах гэх мэт хууль бус заруудын үйлчлэх хугацаа ч уртсаж байгаа нь ойлгомжтой юм. Дээрх сонинд өгсөн зарын дагуу нийт 36 дугаараас 38 эмэгтэй холбогдсон бөгөөд зөвхөн 3 хүн л ХХГХ биш биз гэж асуусан бол 2 хүн очоод биеэ үнэлэхийг шууд хүлээн зөвшөөрсөн.

[70] Хүүхдийн хүмүүжилд үзүүлэх хэвлэл мэдээлийн сөрөг нөлөөлөлд хийх судалгааны тайлан НХХЯ. НҮБ-ын Хүүхдийн сан Улаанбаатар хот 2008 он 18 дахь тал.
[71] Дурдсан судалгаа 17 дахь тал.
[72] "Зар мэдээ" сонин 2009.8.28 №63(1238) дугаар 10 дахь тал. Зарын дугаар 358.



ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

5.1. ДҮГНЭЛТ

Судалгаанаас харахад хууль бус зар сурталчилгаа нь нийслэлд хамгийн их байна. Энэ нь нийслэл дэх хэт төвлөрөл, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа муу байгаагаас зар сурталчилгаанд тавих хяналт сул, телевиз, сонин, хэвлэл гэх мэт нийслэлд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагад тавих зар сурталчилгааны хяналт муу байснаас эдгээр нь орон даяар цацагдах боломжийг бүрдүүлж байна. Жишээ нь, Орхон аймаг /Эрдэнэт хотод/ зар сурталчилгаанд тавих хяналт Дорнод, Дорноговь аймагтай харьцуулахад сайн байгаа боловч тэдний хяналтын хүрээ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар хязгаарлагдаж байгаа учраас нийслэлд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын хууль бус зар сурталчилгаа хяналтгүй цацагдаж байна. ЗСТХ-д хууль бус зар сурталчилгаа бүтээх, түгээх, захиалахыг хориглосон байдаг. Хуулийн энэ хориглосон хэм хэмжээг "Зар сурталчилгааны үнэн бодит байдлыг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн хариуцна" гэсэн хэм хаанаас зохиосон нь мэдэгдэхгүй үгээр "дардаг" аж. Үүнийг орон нутагт өргөн ашигладаг байна.

"Зар сурталчилгаа ба гэм хор" сэдвийн хүрээнд хийсэн судалгаанаас харахад зар сурталчилгааны эрх зүйн орчинг цаашид боловсронгуй болгох шаардлага байгааг дараах үндэслэлүүдээр нотолж болох юм:

- Зар сурталчилгааны хууль дотроо болон бусад хуультай давхардсан, зөрчилдсөн, хийдэлтэй;
- зар сурталчилгааны нэр томъёо хуулиудад өөр өөрөөр тусгагдсан;
- хууль зөрчигчид хүлээлгэж байгаа хариуцлага нь хууль зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, буруутай этгээдийг цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй, хангалтгүй;
- зар сурталчилгааны хяналт хангалттай биш, хяналт тавих албан тушаалтны тоо бага, байгууллага хоорондын уялдаа холбоо муу;
- иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын мэдлэг, идэвхи сул гэх мэт. Хэдий ийм боловч зар сурталчилгааны тухай хууль зохицуулах шаардлагатай харилцаагаа хамруулж чадсан, харилцаанд оролцогчдыг зөв ангилан эрх, үүргийг нь ялгамжтай тогтоосон зэрэг сайн талууд харагдаж байна. Үүний зэрэгцээгээр хууль хэрэгжүүлэх явцад цагдаагийн байгууллага ТВ чаттай эрчимтэй тэмцсэний дүнд бодитой ахиц гарсан, зарим нэг төрийн бус байгууллагаас хэрэглэгчийн нэрийн өмнөөс буруутай этгээдийг шүүхэд өгөх замаар олон нийтийн хяналтыг тодорхой түвшинд хэрэгжүүлсэн сайн талууд байна.

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан судалгааны багийн санал, зөвлөмжийг дараагийн хэсэгт тусгав.

5.2. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны явцад тогтоогдсон байдлыг үндэслэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, хуулийн биелэлтийг хангах арга хэмжээ гэсэн 2 дэд хэсгээр санал зөвлөмжийг бичлээ.

САНАЛ
Хууль тогтоомжийн хүрээнд:

Зар сурталчилгааны тухай хуульд:

21 дүгээр зүйл. Зар сурталчилгаанд хамаарах мэдээллийг шаардах

21.1.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримтыг зар сурталчилгаа захиалагчаас шаардах ***эрхтэй***.

21.3.Зар сурталчилгаа бүтээгч, түгээгч нь энэ хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан баримт үзүүлэхийг шаардах ***эрхтэй***.

21.6.Энэ хуулийн 21.1-д заасны дагуу шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг захиалагчаас шаардах ***эрхтэй***

Үндэслэл: Зар сурталчилгааны эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг хуульд тусгахдаа бүтээгч, түгээгчийн эрх, үүргийг хольж, солин алдаатай зохицуулалт оруулсан байна. Хуулийн дээрх заалтуудад ***эрхтэй*** *биш* ***үүрэгтэй*** *гэж оруулах нь илүү зохимжтой байсан гэж судлаачид үзэж байна. Аливаа хуулиар олгогдсон эрхийг тухайн этгээд эдлэх болон эдлэхгүй байх эрхтэй. Өөрөөр хэлбэл эрхээ эдлээгүйн төлөө хариуцлага хүлээдэггүй. Харин хуулиар ногдуулсан үүрэгээ гүйцэтгээгүйн төлөө хариуцлага хүлээдэг. Гэтэл дээрх заалтуудын хувьд үүрэгтэй биш харин эрхтэй гэж тодорхойлсноор зар сурталчилгаа бүтээгч, түгээгч тухайн зар сурталчилгаа үнэн зөв болохыг нотлох баримт болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ буюу зохих ёсоор баталгаажсан бариматыг зар сурталчилгаа захиалагчаас шаардахгүй байж болно. Тийнхүү шаардаагүйнхээ төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй. Харин шаардсан тохиолдолд тухайн баримтыг захиалагч гаргаж өгөөгүй бол зар сурталчилгаа бүтээгч, түгээгч холбогдох гэрээг цуцлах эсэх нь мөн л эрхийн асуудал. Тэгэхээр дээрх заалтуудын эрхтэй гэдэг үгийг үүрэгтэй гэж сольсноор хуулийн хэрэгжилт илүү сайжрах, хариуцлагыг тодорхой болгох ач холбогдолтой байна.*

22 дугаар зүйл. Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж болох нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэх

22.1.Зар сурталчилгаа бүтээгч, ***түгээгч нь*** зар сурталчилгаа захиалагчаас өгсөн захиалга, даалгавар нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчиж байгааг түүнд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасны дагуу урьдчилан мэдээлсэн боловч зар сурталчилгаа захиалагч өөрийн захиалга, даалгаврыг өөрчлөөгүй тохиолдолд зар сурталчилгаа бүтээгч, ***түгээгч нь*** зар сурталчилгаа бэлтгэх, ***түгээхээс*** татгалзах үүрэгтэй.

Үндэслэл: ЗСТХ-ийн уг заалтыг өөрчлөлт ороогүй байдлаар нь хэрэглэвэл зар сурталчилгаа захиалагч нь өөрөө зар сурталчилгаагаа бүтээчихвэл түгээгч нь урьдчилан сануулах үүрэг хүлээхгүй шууд түгээж болохоор байна. Мөн ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ын 2009 оны 6 дугаар сарын 28-нд зохион байгуулсан зар сурталчилгаа бүтээгчидтэй хийсэн уулзалтад оролцсон зар сурталчилгаа бүтээгч /Рекламны ассоциацийн захирал асан/: "Реклам бүтээх нь тийм ч хортой зүйл биш. Харин түгээгээд нийтэд мэдээлэл болж очих нь хамгийн чухал байдаг. Хичнээн бүтээсэн ч түгээхгүй бол үр дагавар үүсэхгүй. Тэгээд ч энгийн бичгэн зар нийтлүүлэхэд бүтээх гэсэн ойлголт байхгүй"[73] гэсэн байна.

24 дүгээр зүйл. Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт

24.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг ~~олуны өмчийн улсын хяналтын алба~~ хэрэгжүүлнэ. Судалгааны баг төрөөс зар сурталчилгаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг худалдаа, аж үйлдвэрийн салбарын төрийн захиргааны байгууллагын бүтцэд оруулан хуульчлах нь зүйтэй. Учир нь зар сурталчилгаа нь дийлэнхдээ худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр явагддагаас гадна энэ чиглэлийн төрийн байгууллага хяналтыг илүү бодитой, өргөн хүрээг хамарсан байдлаар хийх боломжтой гэж үзлээ.

24.3.4.зар сурталчилгааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 14 хүртэлх хоногоор түдгэлзүүлэх~~, эсхүл цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагад тавих~~;

Үндэслэл: ЗСТХ-иар Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч хяналт тавина гэж заасан учраас хяналтаа бүрэн тавих хэрэгтэй. Уг хуулийн хариуцлагын хамгийн дээд хэмжээ болох үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах саналыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагад тавих гэсэн заалт хууль батлагдсанаас хойш биелж байгаагүй. Жишээ нь: "Хүн худалдаалах гэмт хэрэгт зар сурталчилгаа нөлөөлж буй байдал" сэдэвт ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ээс зохион байгуулсан уулзалт, ярилцлагад /2009.8.26/ оролцсон ОӨГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга "Санкц нь торгуулийн арга хэмжээ, давтвал үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх саналыг гаргана гэсэн заалт байдаг. ХХЗХороо тусгай зөвшөөрөл олгодог. Бид 2009.2.16-ны өдөр ХХЗХороонд албан тоот явуулсан. 9 телевизийн үйл ажиллагааг цуцлах санал тавихад 6 сар болоход хариу ирээгүй л байна."[74] *гэжээ. Энэ мэт байдлууд нь хууль хэрэгждэггүй, үр нөлөөгүй байдлуудыг бий болгож байгаа ба нэмж* ***өөрчилсөн хувилбар*** *нь хариуцлагын арга хэмжээг үр нөлөөтэй болгоно.*

[73] ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан "Зар сурталчилгаа бүтээгч" уулзалт ярилцлагын тэмдэглэл, 2009.6.28.

[74] ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан "Хүн худалдаалах гэмт хэрэгт зар сурталчилгаа нөлөөлж буй байдал" сэдэвт уулзалт, ярилцлагын тэмдэглэл, 2009.8.26.

24.4.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч нь ~~Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас гадна~~ дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

Үндэслэл: Төрийн хяналт шалгалтын тухай хууль[75] нь анх 1995 оны 3 дугаар сарын 27-ны өдөр анх батлагдахдаа 7 бүлэг 27 зүйлтэй УИХ-аар батлагдсан байдаг. Харин 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсон бөгөөд шинээр батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай[76] хууль нь 4 бүлэг 16 зүйлтэй батлагдсан байна. Тийм учраас одоогийн уг хуульд 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг гэсэн зүйл заалт байхгүй.

29 дүгээр зүйл. Захиргааны хариуцлага

29.1.2.энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, ~~6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл,~~ 9.3 дахь хэсэг, ~~10-14, 14[1]~~, 16, ~~17 дугаар зүйл,~~ 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

Үндэслэл: Дээр дурдсан хасахаар санал болгож байгаа заалтууд нь хууль бус зар сурталчилгааг захиалах, бүтээх, түгээх харилцааг зохицуулж байгаа учир тусад нь авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Хуулийн хариуцлага буюу торгууль оногдуулахдаа харилцааны энэ хэсгийн онцлогийг харгалзан ялгамжтай зохицуулах шаардлагатай гэж судалгааны баг үзлээ. Жишээ нь, Сонинд өгсөн хууль бус зартай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ зөвхөн 250000 төгрөгөөр торгоод өнгөрөх бус зарыг хэдэн төгрөгөөр нийтэлсэн, сонин хэдэн хувь хэвлэгдсэн зэргийг харгалзан торгуулийн хэмжээг тогтоох нь хууль бус зар сурталчилгааг түгээхээс урьдчилан сэргийлэхэд томоохон хүчин зүйл болно.

29.1.3. энэ хуулийн 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 14[1], 17 дугаар зүйлд заасныг зөрчсөн бол тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хураах, гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

Үндэслэл: ЗСТХ нь 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан ба 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өөрчлөлт оржээ. Инхүү өөрчлөлт оруулахдаа хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага бүлэг дэх торгуулын хэмжээг огт "хөндөөгүй" байна. ЗСТХ батлагдахад Засгийн газрын 2000 оны 108 дугаар тогтоолд нэг цагийн хөдөлмөрийн хөлсний хэмжээ 146 төгрөг 45 мөнгө байжээ. Үүнийг ажлын 8 цагт үржүүлбэл өдөрт 1171 төг 60 мөнгө болно. Нэг сард дунджаар ажлын 21 өдөр байдаг гэж тооцвол сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 24603 төгрөг 60 мөнгө байхаар байна. Энэ нь одоогийн мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний

[75] Төрийн мэдээлэл, 1995 он, №4.
[76] Төрийн мэдээлэл, 2003 он,

доод хэмжээ болох 108000 төгрөгтэй харьцуулбал 4,3 дахин бага юм. Эдийн засгийн өсөлт бууралт, мөнгөний ханш, инфляци зэргийг харгалзахгүйгээр торгуулийг ингэж тодорхой тогтоох нь буруу юм. Харин судлаачдын зүгээс санал болгож байгаа "үйл ажиллагаанаас олсон орлого" гэдэг үг нь эдийн засгийн өсөлттэй тохирно. Өөрөөр хэлбэл, зар сурталчилгааны үнэ тариф өсвөл хууль бус зар сурталчилгааны торгуулийн хэмжээ дагаж өснө. Жишээ нь: ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн 2009 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Зар сурталчилгаа түгээгч"-тэй хийсэн уулзалт ярилцлага дээр нэгэн телевизийн Бизнес төлөөлөлт, Маркетингийн албаны дарга: "Архи согтууруулах ундаа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд рекламыг нь гаргахгүй гэхээр торгуулийг нь өгнө гэдэг. Мөн MCS компани нь олон охин компанитай. Тэдний нэг болох "Спирт бал бурам" компанийх нь архийг сурталчлахгүй гэхээр бусад охин компаниудынхаа зар сурталчилгааг бидэнд өгөлгүй зогсоочихдог. Тийм учраас 250 000 төгрөгний торгууль хэт бага байна. Чангатгах хэрэгтэй."[77] гэсэн бол 2009 оны 5 дугаар сарын 14-нд зохион байгуулсан их, дээд сургуулийн багш судлаачидтай хийсэн уулзалт дээр МУИС-ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш Д.Энхзул "Зар сурталчилгааны эрх зүйн орчин тухайн харилцаанаас бодит хөөгжлийг гүйцэхгүй байна. Олон жилийн өмнө баталсан хуулийн 250 000 төгрөгийн торгууль оногдуулах тухай заалт одоо ямар ч нөлөөгүй болсон. Тиймээс тухайн байгууллагын тодорхой хугацааны орлогын тодорхой хувиар оногдуулах гэх мэт заалтыг оруулах хэрэгтэй."[78] гэжээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд:

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл

15.7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

15.7.7 ***гадаад улсын ерөнхий боловсролын сургууль, их сургууль, дээд сургууль, коллеж, хэлний курс, мэргэжлийн курст зуучлан суралцуулах;***

Үндэслэл: Сүүлийн үед гадаадад явж суралцах сонирхолтой хүний тоо эрс нэмэгдэж. Зар мэдээллийн сонинд ч энэ төрлийн зарын эзлэх хувь өсөөр байна. Суралцахын хажуугаар ажиллах боломжтой гэсэн нь анхаарал татаж байна. Иймхүү суралцуулах нь тодорхой гэрээний үндсэн дээр хийгдэх нь мэдээж. Үүнийг мөн л бүртгэлжүүлэх шаардлагатай байна.

15.9. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

15.9.2. Гэр бүл зуучлалын үйлчилгээ эрхлэх;

Үндэслэл: Судалгаагаар тогтоогдсон зүйлийн нэг нь гэр бүл зуучлалын үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар зохицуулсан хэм

[77]ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан "Зар сурталчилгаа түгээгч" сэдэвт уулзалт, ярилцлагын тэмдэглэл 2009.5.21.

[78]ХЗҮХ-ийн ИЭЗЭЗС-ийн зохион байгуулсан "Зар сурталчилгаа ба гэм хор " сэдэвт уулзалт, ярилцлагын тэмдэглэл 2009.5.14.

хэмжээ одоогоор байхгүй байна. Гэр бүл зуучлал болон танилцуулах үйл ажиллагааг хариуцсан төрийн ямар нэг байгууллага байдаггүй бөгөөд иргэд хувийн шугамаар, танил талаараа энэ "ажиллагаа" явуулдаг байна. Мөн "Гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучилна. Гадаадын иргэнтэй гэр бүл болно" гэсэн зар нь хувь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал учир шууд хориглох боломжгүй юм. Харин түүнд нь хяналт тавьж бүртгэлжүүлэх нь энэ төрлийн зар сурталчилгааг хяналттай болгоно. Гэхдээ үүнийг Иргэний гэр бүлийн бүртгэлээс ялгаж үзэх хэрэгтэй. Гэр бүл бол нийгмийн анхан шатны нэж бөгөөд харьцангуй удаан тогтвортой үргэлжлэх харилцаа байдаг. Үүнийг ХХГХ-т ашиглаж байгаа нь ажиглагддаг. Одоогоор яг энэ зараас болж шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна. Цаашид гарч болохыг үгүйсгэхгүй юм. Гэр бүлийн асуудал нь нийгмийн хамгаллын салбарт хамаардаг учир тухайн чиглэлийн яамны хариуцах асуудлын хүрээнд багтаах нь зүйтэй. Одоо мөрдөгдөж буй "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай"[79] хуульд нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвшөөрөл олгодог нэг харилцаа /үйл ажиллагаа/ байна.

Гэр бүлийн тухай хууль:

5 дугаар зүйл.Гэр бүлийн эрхийг хамгаалах

5.3 төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гэр бүл зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

Үндэслэл: Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах саналтай холбогдуулан гэр бүлийн харилцааг тусгайлан зохицуулсан хууль "Гэр бүлийн тухай"[80] хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна. Иңгэж өөрчлөлт оруулах нь тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний уялдаа холбоог сайжруулах ач холбогдолтой юм.

Бусад:

- Гадаадад бүтээгдсэн зар сурталчилгаанд тодорхой хязгаарлалт тогтоох;
- Телевиз, радиогийн зар сурталчилгааны хугацаанд тухайн өдрийн нийт нэвтрүүлгийн тодорхой хувиас илүүгүй байна гэсэн хязгаарлалт тогтоох;
- Тухайн төрлийн зар сурталчилгаатай холбоотой зөрчил илэрсэн болон шүүхэд нэхэмжлэл гарсан тохиолдолд бүтээгч, түгээгч, захиалагчдыг хамтран хариуцагчаар оруулах;
- Тодорхой төрлийн зар сурталчилгаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг албан ёсоор баталж мөрдүүлэх.

ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагуудын хүрээнд

Зар сурталчилгааны харилцаанд хяналт тавих үүрэг бүхий төрийн

[79] Төрийн мэдээлэл, 2001 он, №6.

[80] Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл, 1999 он, №30.

байгууллагууд нь харилцан мэдээлэл солилцох, хуулиар олгогдсон эрхийн хүрээнд арга хэмжээг авч хэвших нь хамтын ажиллагааны эхлэл болох юм. Үүнд: аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон байгууллагууд тусгай зөвшөөрлийн тухай иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэх, улмаар зар сурталчилгаа түгээдэг аж ахуйн нэгжид хүргүүлэх зэрэг ажлыг хийж болно. Жишээ нь: НХХЯ-аас гадаадад ажиллах хүч илгээх чиглэлээр хичнээн аж ахуйн нэгж зөвшөөрөл авсан. Одоо ямар аж ахуйн нэгж хичнээн ажиллах хүч гаргах гэж байгаа зэргийг хэвлэл мэдээллийн байгууллагад тогтмол өгөх нь хууль бусаар /тусгай зөвшөөрөлгүй/ гадаадад ажилд зуучлах, ХХГХ-т өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгэн хэлбэр болно. Хэрвээ гэмт хэрэг гарахад хууль бус зар сурталчилгаа нөлөөлсөн бол ЭБШХ-ийн 80 дугаар зүйл, 190 дүгээр зүйлд тус тус заасан хэм хэмжээг баримтлан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокуророос тодорхой арга хэмжээ авдаг болох нь чухал ач холбогдолтой болно. Учир нь ийм төрлийн арга хэмжээг авч, шийдвэрлэж байсан тохиолдол байдаггүй байна. Мөн хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулах, хууль бус зар сурталчилгааг "өргөн хүрээнд" ойлгуулах шаардлагатай байна.

Төрийн бус байгууллага, иргэдийн хүвьд:

Судалгааны явцад ажиглагдсан зүйл нь Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох бусад хуулийн хүрээнд ХХГХ гэж юу болох, хэрхэн зүйлчлэх шийдвэрлэх зэргээр хууль хяналтын байгууллагуудын ажилтнуудад сургалт сурталчилгаа явуулж байгаа нь сайшаалтай боловч нөгөө талаар учир дутагдалтай байна. Учир нь ХХГХ үйлдэгдсэний дараа хэрэгжүүлэх алхмын тухай ойлголт өгч байгаа болохоос бус хууль бус зар сурталчилгаа ХХГХ үйлдэгдэхэд хэрхэн нөлөөлж байгаа, түүнд хэрхэн хандах ёстой талаас нь сурталчлах, иргэдийн дунд сургалт явуулах нь илүү үр дүнтэй болно. ХХГХ-ээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай иргэдийн дунд сургалт сурталчилгаа явуулах

Бусад

Судалгааны явцад тогтоогдсон авч хэрэгжүүлэх шаардлагтай арга хэмжээг дурдвал:

- "Зар сурталчилгаа" гэсэн ойлголтыг нэг мөр ойлгох үүднээс УДШ-ээс тайлбар гаргуулах;
- "Зар сурталчилгааны бодит үнэнийг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн хариуцна" гэдэг нь хууль бус гэдгийг нийтэд мэдээлэх;
- ТВ чатаар явуулах зүйлийн шалгуурыг хууль тогтоомжийн дагуу хяналт тавих байгууллагууд хамтарсан зөвлөмж хэлбэрээр гаргах;
- Холбогдох байгууллагуудтай хамтран зар сурталчилгаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг зөвлөмж маягаар боловсруулах;
- Судалгааны үр дүнгээр сургалт зохион байгуулах.

Судалгааны явцад зохион байгуулсан 5 удаагийн хурлын оролцогчдоос бичиж үлдээсэн санал, зөвлөмжүүдийг хавсралт 4-өөс үзнэ үү.

ХАВСРАЛТ-1

Нэр томъёо ба хуулиудын жагсаалт

Хуулиудад өөр өөр нэр томъёо хэрэглэсэн байна. Эдгээрийг хууль тус бүрээр харуулбал:

"Сурталчилгаа" гэсэн нэр томъёо орсон дараах хуулийн зүйл заалт байна:

1.Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;
2.Ард нийтийн санал, асуулгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг;
3.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн $13^2.6.1$;
4.Ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын тухай хууль;
5.Ариун цэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.2, 17.1, 17.1.5;
6.Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4.5, 4.5.1, 14.1, 14.1.4;
7.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17.1, 24.1, 24.1.14, 27.1, 27.1.10;
8.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3, 19.3.1;
9.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10.1, 10.1.3;
10.Давс иоджуулах иод дутлаас сэргийлэх тухай хуулийн 5.1, 5.1.3;
11.Донорын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т зааснаар Бусдын эрүүл мэндийг;
12.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2, 21.2.3;
13.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх , урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1, 5.1.4;
14.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11.1, 11.5;
15.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйл;
16.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14.3, 14.3.7, 14.8, 35.1, 35.4, 37, 52 дугаар зүйл;
17.Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1;
18.Мөнгө угаах болон террозимтой тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйл;
19.Ой хээрийг түүмрээс хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйл;
20.Ойн тухай хуулийн 15, 21 дүгээр зүйл;
21.Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн 3, 11, 20, 21, 24, 27, 30, 44 дүгээр зүйл;
22.Сонгуулийн төв байгууллагын тухай 11, 14 дүгээр зүйл;
23.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйл;
24.Терроризмтой тэмцэх тухай хуулийн 4, 7, 8 дугаар зүйл;
25.Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 7 дугаар зүйл;



26.Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл;

27.Улс төрийн намын тухай хуулийн 4.2, 7.3, 16.2.5, 23 дугаар зүйл;

28.Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 6.1.2, 13.6, 13.6.8, 14.2.2;

29.Хүний дархлал хомсдлын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдлоос сэргийлэх тухай хуулийн 6.1, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;

30.Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;

31.Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;

32.Шүүхийн тухай хуулийн 44.1.1, 44.1.3.

"Зар" гэсэн нэр томъёо орсон дараах хуулийн зүйл, заалт байна;

1.Иргэний хуулийн 197 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.2.1;

2.Компанийн тухай хуулийн 39, 58, 66, дугаар зүйл;

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17.1;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36.2,38, 39, 40, 47, 48, 49, 52 дугаар зүйл /зар, мэдээ цуглаа байгаа юм./;

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйл.

"Зар мэдээ" гэсэн нэр томъёо орсон дараах хууль;

1.Компанийн тухай хуулийн 58, 66 дугаар зүйл;

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36.2,38, 39, 40, 47, 48, 49, 52 дугаар зүйл.

"Реклам" гэсэн нэр томъёо орсон дараах хууль байна;

1.Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 4 дүгээр зүйл.

"Зарлал" гэсэн нэр томъёо орсон дараах хууль;

2.Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.

"Зар сурталчилгаа" гэсэн нэр томъёо орсон дараах хууль байна;

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйл;

2.Банкны тухай хууль /1996.09.03/ 7 дугаар зүйл;

3.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль /2003.05.02/ 20.1.4, 24.1.3-т;

4.Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005.01.27/ 13.1, 13.2.2, 13.2.3, 13.2.5, 13.3, 17.1.1, 17.1.2;

5.Эрүүгийн хууль /2002.01.03/ 169 дүгээр зүйл;

6.Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2002.12.12/ 26.10.

Шүүхийн архиваас хийсэн тэмдэглэл

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
1.	2007.12.24 №8	Г.Ганчимэг	Б.Бумзаяа	1879 $ хариуцагчаас гаргуулах	Нэхэмжлэлийг хэсэгчлэн хангасан.	2005 оны 11 сард "Шуурхай зар" сонины зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай уулзсан.
2.	2008.1.21 №134	Э.Эрдэнэцогт	Х.Цэрэнжаа	8 424 000 төгрөгийг хариуцагчаас гаргуулах	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	Нэхэмжлэгч хариуцагчтай зарын дагуу уулзсан.
3.	2008.3.31 №426	Б.Ганзориг	Г.Баясгалан /Золхайрхан Стелла ХХК-ний ерөнхий захирал/	1500$ хариуцагчаас гаргуулах	ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1, 289 дүгээр зүйлийн 289.2.5 дахь хэсгийг баримтлан "Золхайрхан Стелла" ХХК-иас 9 491 156 төгрөг гаргуулахыг хүссэн Марүко Жү ХХК-ны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.	2007.8.31-нд "Шуурхай зар" сониноос "Караоке, ажлын байрны зориулалтаар ажлын байр түрээслүүлнэ" гэсэн зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон.
4.	2008.4.23 №470	Д.Онолт	Л.Баясгалан	100 000 төгрөг нэхэмжилсэн.	Эвлэрсэн.	Зар сонинд зарласан зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон
5.	2008.5.21 №573	Ц.Дуламсүрэн	Ц.Цэцэгмаа	70 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	520 000 төгрөг гаргуулж Ц.Дуламсүрэнд өгсөн.	Сонины зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон.
6.	2008.6.6 №646	Л.Дончинсүрэн	Сайн сайхны төлөө ТББ	2 200 ам доллар хариуцагчаас гаргуулахаар нэхэмжилсэн.	410.1 сайн сайхны төлөө нийгэмлэгээс 2 563 000 төгрөг гаргуулах	Гэрээгээр Солонгост ажилчин гаргаж байна гэсэн зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон.
7.	2008.6.12 №664	Б.Баярмаа	П.Оюун	7 429 500 хариуцагчаас гаргуулах	2 652 000 төгрөгийг 2008.6.18-ны дотор төлөхөөр тохиролцож эвлэрсэн.	Солонгосын виз найдвартай гаргаж өгнө гэсэн зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон.
8.	2008.12.10 №1360	М.Базаррагчаа	"Хүлэг зууч" ХХК	Нийт 2.065.295 төгрөгийг Хүлэг зууч ХХК-с гаргуулах	"Хүлэг зууч" ХХК-с 2.065 295 төгрөг гаргуулж М.Базаррагчаад олгосугай. ИХ 56.1.1, 56.5	М.Базаррагчаа 2008.2.14-нд зарын дагуу "Хүлэг зууч" ХХК-аар Чехийн виз гаргуулахаар бүртгүүлсэн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН www.nli.gov.mn

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
9.	2006.3.22 №291	Д.Оюунтуяа	А.Амаржаргал	Түрээсэнд төлсөн 2 200$-ийг хариуцагчаас нэхэмжилсэн.	ИХ-ийн 56.1.8-д зааснаг үндэслэн ХТБус хэлцэл болсон. 56.5-д зааснаар талууд уг хэлцлээр шилжүүлэн авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх.	А.Амаржаргалын сонинд өгсөн зарын дагуу Д.Оюунтуяа Билсс кафег түрээсэлсэн.
10.	2006.5.18 №487	П.Батбаяр	"Эрдэм" боловсролын төв	54 000 төгрөг хариуцагчаас гаргуулахаар нэхэмжилсэн.	"Эрдэм" боловсролын төвөөс 45 600 төгрөг гаргуулах	Нэхэмжлэгч "Зар мэдээ" сонины зарын дагуу "Эрдэм" сургалтын төвд ня-бо бүртгэл, компьютерийн чиглэлээр 1 сар суралцахаар болсон.
11.	2006.6.7 №572	П.Эрдэнэсай хан	П.Нямлхагва	1 300 000 төгрөг хариуцагчаас гаргуулах	ИХ-ийн 281 ИХШХШТХ-ийн 75-р зүйл, 123.2	Зар мэдээ сонинд өгсөн зарын дагуу хүүгүй мөнгө зээлдүүлж хажуу өрөөнд нь суухаар болсон
12.	2008.1.15 №92	Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийг төлөөлж Үндэсний сүлжээ ТББ	TV-9 телевиз	Архи согтууруулах ундааны ил болон далд сурталчилгааг таслан зогсоох, хууль зөрчсөн байгууллага албан тушаалтанд хариуцлага ногдуулах тухай	ИХ-ийн9.4.2-рнэхэмжлэлийн шаардлагыг хангах, хоёр дахь шаардлага болох хууль зөрчсөн байгууллага албан тушаалтанд хариуцлага тооцох гэснийг ИХШХШТХ-ийн 117.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосон. ЗСТХ-ийн 24 дүгээр зүйлийн 1, 29.1 ИХ 9.4.2, ЗСТХ-ийн 6.5.8 / энэ төрлийн зар явуулахгүй байхыг TV-9-д үүрэг болгосон.	TY-9 нь 2007.10.2-с 10 сарын 31, 11 сарын 1-11сарын 5-ны өдрүүдийн хооронд MCS компаний Tiger, Алтанговь АПУ-ийн UFC группын Хархираа архи зэрэг согтууруулах ундааг давтамжтайгаар сурталчилсан.
13.	2008.8.20 №628	Капитрон банк	Чингис хаан ОУ-ын нисэх буудал	ИНЕГ 2007.7.30-ны өдөр Капитрон банкны 3 талт рекламны байгууламжийг дур мэдэн татан буулгасан. 21.397.020 төгрөгийг нэхэмжилсэн.	Талууд эвлэрсэн.	Капитрон банк УБ хотын ерөнхий менежерийн 2005.12.27 №162 дугаар тушаалаар Чингис хаан нисэх буудлын замын уулзвар тойрогт байрлах 5*12 хэмжээтэй 3 талт рекламын байгууламж байрлуулах зөвшөөрөл авсан байсан.

www.mpu.edu.mn

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
14.	2008.11.13 №1107	С.Байгалмаа	Н.Хандсүрэн	Гэрээ хүчингүй болгож 2.300 000 төгрөгийг хариуцагчаас гаргуулах	ИХШХШТХ-ийн 74, 75 дугаар зүйлийг удирдлага болгон хэрэгсэхгүй болгосон.	"Шуурхай зар" сонины 2008.4.4-ний дугаарт 10 жил тасралттүй үйл ажиллагаа явуулсан, өөрийн гэсэн зах зээлтэй үйлдвэрийн тоног төхөөрөмж болон нэрийн хамт яаралтай зарна гэсэн зарын дагуу СХД-т байрлах "Өв-Эрдэнэ" ХХК дээр очиж Хандсүрэнтэй зээлээр худалдах худалдан авах гэрээ, хамтран ажиллах гэрээ байгуулсан.
15.	2006.8.10 №845	Л.Батаа	Б.Алтан	4000$ хариуцагчаас гаргуулах	2000$ өгөхөөр болсон.	"Зар мэдээ" сонинд Солонгос уруу найдвартай виз гаргана гэж зар өгсний дагуу нэхэмжлэгч хариуцагчтай уулзсан.
16.	2008.9.2. №1028	Л.Ганбаатар		Эрэн сурвалжлуулах тухай	ИХШХШТХ-ийн 155.4-т зааснаар Б.Батмөнхийг эрэн сурвалжлах	Савхан гоймон үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт худалдахаар зар сонинд зар өгсний дагуу нэхэмжлэгч холбогдсон.
17.	2006.3.29 №322	М.Гантөмөр	С.Цэвэгдорж	Хариуцагчаас 10 800$ гаргуулах	ИХ-ийн 492.1 дэх хэсэгт зааснаар Б.Цэрэндоржоос 7300$ буюу 8 964 400 төгрөгийг гаргуулах	2005 оны 2 дугаар сард Солонгос улсад гэрээгээр ажиллуулна гэсэн зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбогдсон.
18.	2006.5.20 №496	Х.Оюунаа	С.Энхтуяа	1200 $ хариуцагчаас гаргуулах	ИХ 218.1 ИХ 497.1 ИХ-ийн 510.1-д зааснаар Энхтуяагаас 1200$ гаргуулж Оюунаад өгөх	2006 оны 1 сард "Зар мэдээ" сонин дээр Солонгосын виз гаргаж өгнө гэсний дагуу хариуцагчтай холбогдсон.
19.	№ 16 2006.12.26	Н.Мөнхбаатар	Т.Баттулга	Нэхэмжлэгч хариуцагчаас 4 100 000 төгрөгийн зээл чөлөөлж өгснөө нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.	Хариуцагч нэхэмжлэгчтэй зарын дагуу танилцсан.
20.	№ 76 2007.01.15	С.Мягмармаа	Х.Нямсүрэн	Зээлийн төлбөр гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн.	Сониноос байр хөлслүүлэх зарын дагуу нэхэмжлэгч хариуцагчтай холбоо барьсан.

www.nli.gov.mn

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Харицагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
21.	№ 132 2007.01.30	Д.Цэрэндулам	Г.Сүлд	Зээлийн алданги нь 246 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн	"Зар мэдээ" сониноос 2 сая төгрөг зээлж үнэгүй байранд суулгана гэсэн зарын дагуу холбогдсон.
22.	№ 192 2007.02.12	Г.Оюунчимэг	Л.Өлзийжаргал	634 681 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"Зар мэдээ" сониноос "цайны газар түрээслэнэ" гэсэн зарын дагуу холбогдсон.
23.	№ 227 2007.02.22	Р.Даваажаргал	Б.Бумзаяа	2 645 300 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн	Сонинооос "Солонгос явуулна" гэсэн зарын дагуу нэхэмжлэгч харицагчтай холбоо барьсан.
24.	№ 275 2007.03.13	Т.Батцоож	Г.Сольсүрэн	Догодоолтой хөрөнгө худалдсан эд луп хорирлоо нөхөн төлүүлэх тухай	Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	"Зар мэдээ" сонины машин зарах тухай зарын дагуу нэхэмжлэгч харицагчтай холбоо барьсан.
25.	№ 280 А 2007.11.28	Ц.Ганчимэг Ц.Гантуяа	Ч.Төмөрбат Р.Отгонбаяр	9 504 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	"байрны захиалга авч байна" гэсэн зарын дагуу бариулын компанитай харицагч холбогдож нэхэмжлэгч, бариулын компани хөөрөн дүнд зуучилсан.
26.	№ 551	О.Хоролпүрэв	Х.Гантөмөр	Зээлийн үлийн дүн болох 1 500 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	Нэхэмжлэгч харицагчтай "Зар мэдээ" сонинд "менгө зээлж үнэгүй өрөөнд суулгана" гэсэн зарын дагуу холбогдсон.
27.	№ 576 2007.05.18	И.Мөнхцэцэг	Б.Бумзаяа	1 500 доллартөгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"Зар мэдээ" сониноос "виз гаргаж өгнө" гэсэн зарын дагуу холбогдсон.
28.	№ 817 2007.07.07	Ц.Сарууптуяа	Д.Дашням	487 660 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"Бэйжарна" гэсэн зарын дагуу нэхэмжлэгч харицагчтай холбоо барьсан.
29.	№ 906 2007.07.25	Н.Отгонцэцэг	Е.Энхтуяа	4100 доллар гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.	Нэхэмжлэгч харицагчтай "Яонн явуулна" гэсэн зарын дагуу холбоо барьсан.
30.	№ 916 2007.07.27	Р.Ганбат		Даваахүүг зрэн сурвалжлуулах тухай	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"Шуурхай зар" сонинд "Зочид буудлын сауны түрээслүүлнэ" гэсэн зарын дагуу холбогдсон.

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Харуцагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
31.	№ 941 2007.08.03	Б.Ганболд	А.Шийтэр	Орон сууцны үнэ болгон төлсөн 26 180 500 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн.	"Шуурхай зар" сонины "Байр хөлсөөнө" гэсэн зарын дагуу холбоо барьсан.
32.	№ 995 2007.08.21	Ц.Ариунаа	Б.Дашпэл	3 445 400 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн.	"Менге ээзлэх хажуу өрөөндөө" сууглана гэсэн зарын дагуу холбогдсон.
33.	№ 1064 2007.09.12	Т.Баттогоо	Г.Баяраа	300 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлээс татгалзаныг батлагдсан.	"Байр түрээслэнэ" гэсэн зарын дагуу холбогдсон.
34.	№ 1119 2007.09.28	А.Лхагвасүрэн	Ч.Буяндэлгэр	өөрт учирсан хохирол болох 1 600 долларгаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн	"Шуурхай зар" сонинд гарсан "Израйль улсын хил нэвтрэх батлагаат урилга зуучилна" гэсэн зарын дагуу нэхэмжлэгч харуцагчтай холбогдсон.
35.	№ 1196 2007.10.19	Б.Бямбасүрэн	"Роял смайл" ХХК	өөрт учирсан хохирол болох 2580 доллар гаргуулах	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.	"Европын орнуудаар аялуулна" гэсэн ТВ зарын дагуу нэхэмжлэгч харуцагчтай холбогдсон.
36.	№ 1198 2008.11.05	З.Золбаатар	Д.Юмжав	4 035 000 төгрөг гаргуулах	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн	"Зар мэдээ" сонинд "кафе, буудал" түрээслүүлнэ" гэсэн зарын дагуу холбогдсон.
37.	№ 1289 2008.11.28	Л.Ганцацаг Т.Амгаланбаатар	Д.Цэвэлмаа	Ойлголцлын зөрүүгээс болж 26 сая төгрөгийн үнэтэй хашаа байшингаа 2.6 сая төгрөөр зарсан тул худалдах худалдан авах гэрээг хүчингүйд тооцуулах тухай	Нэхэмжлэлийг хэрэгсэргүй болгож шийдвэрлэсэн	"Шуурхай зар" сонинд "хашаа байшин 2.6 сая төгрөөр зарна" гэсэн зарын дагуу харуцагч нэхэмжлэгчтэй холбогдсон.
38.	№ 518 2007.05.14	Л.Батцацаг	"Пигасус интернэйшнэл спешиалист" ХХҮ	1 607 700 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийг буцаж нь хангаж шийдвэрлэсэн	"Австралидажиллуулна" гэсэн зарын дагуу нэхэмжлэгч харуцагчтай холбогдсон.
39.	№ 566 2007.05.23	Б.Сэрэлэн	Ц.Эрдэнэцацаг	Худалдах, худалдан авах гэрээг хүчингүй болгуулах тухай	Нэхэмжлэлийг буцаж нь хангаж шийдвэрлэсэн	"хашаа байшин зарна" гэсэн сонины зарын дагуу нэхэмжлэгч харуцагчтай холбогдсон
40.	№ 1120 2006.11.23	Б.Менхжаргал Н.Анхмаа		Гэрээлтийг хүчингүйд тооцуулах тухай	Нэхэмжлэлийг буцаж нь хангаж шийдвэрлэсэн	"АНУ-ын виз гаргана" гэсэн зарын дагуу очиж танихгүй хүнтэй гэрээлтээ бүртгүүлсэн.

№	Хэргийн №	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
41.	№ 1199 2006.12.14	Г.Бямбасүрэн	Б.Ганзориг	Хохирол 1 484 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.	"Зар мэдээ" сониноос авсан зарын дагуу ажил гүйцэтгүүлсэн.
42.	№ 81 2006.02.06	Н.Ариунтунгалаг		Хариуцагчийг эрэн сурвалжлуулах тухай	Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн	"Солонгосын виз гаргана" гэсэн зарын дагуу холбоо барьсан.
43.	№ 216 2006.03.23	Я.Бямбацэрэн	Д.Жаргалсүрэн	1 704 950 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"Сөүлийн дээд сургуулийн хэлний бэлтгэлд 1 жил суралцуулна" гэсэн зарын дагуу хариуцагчтай холбогдсон.
44.	№ 1003 2007.12.05	Ч.Банзрагч Д. Алтантуяа нар	Монголын эмэгтэйчүүдийн тогтвортой хөгжлийн сан	Виз гаргаагүй тул төлбөр гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.	"Солонгост уран нугаралтын хүүхдүүд явуулна" гэсэн зарын дагуу холбогдсон.
45.	№ 732 2006.12.18	Д.Пүрэвдорж		Эрэн сурвалжлуулах тухай	Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.	"Гахайн фирм зарна" гэсэн зарын дагуу Д.Баттулгатай холбогдож урьдчилгаа мөнгө төлсөн.
46.	№ 414 2006.07.17	Т.Бурмаа	"Хар морьт табак" ХХК	1 000 000 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн	Нэхэмжлэгч хариуцагчийн зөвшилцлийг баталсан	Ажилд авна гэсэн зарын дагуу хариуцагч байгууллагатай холбогдсон.
47.	№ 878 2007.09.10	Т.Цолмон Б.Түмэнжаргал		Эрэн сурвалжлуулах тухай	Нэхэмжлэлээс татгалзсаныг баталсан	"АНУ-д гэрээгээр явуулна" гэсэн зарын дагуу Б.Цэдэнтэй холбогдсон.
48.	№ 300 2007.03.13	Ж.Мөнхцэцэг Д.Хишигжаргал	Д.Ганцэцэг	2 200 доллар гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.	"Солонгос улсад явуулна" гэсэн зарын дагуу холбогдсон.
49.	№ 450 2007.04.20	Д.Саранцэцэг Д.Шинэбаяр	Ж.Буяндэлгэр Н.Болормаа	Хохирлоо нэхэмжилсэн.	Зохигчдын эвлэрлийг баталсан.	"Зар мэдээ" сонинд "Солонгост гэрээгээр ажиллуулна" гэсэн зарын дагуу хариуцагчтай холбогдсон.
50.	№ 985 2006.09.28	Г.Батдэмбэрэл Д.Даваасүрэн	Ш.Даваасүрэн	1 300 доллар гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"АНУ-д цагаачлуулна" гэсэн зарын дагуу хариуцагчтай холбогдож мөнгө төлсөн.
51.	№ 49 2007.01.08	Б.Цагаанчулуун	Л.Осормаа	236 304 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.	"байр зарна" гэсэн зарын дагуу хариуцагчтай холбогдож худалдах, худалдан авах гэрээ байгуулсан.

Иргэдээс авсан санал асуулгын дүн

1. Судалгаанд хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн байдал

№	Та ямар ажил эрхэлдэг вэ?	Тоо	Хувь
1	Хувиараа бизнес эрхэлдэг	65	22.2
2	Төрийн байгууллагад ажилладаг	45	15.4
3	Хувийн байгууллагад ажилладаг	47	16.1
4	Ажилгүй	46	15.7
5	Оюутан	64	21.8
6	Бусад	10	3.4
7	Хариулаагүй	16	5.4

2. Судалгаанд хамрагдсан иргэдийг боловсролын байдлаар нь ангилж үзвэл

№	Таны боловсрол	Тоо	Хувь
1	Дээд	104	35.49
2	Бүрэн дунд	143	48.81
3	Бүрэн бус дунд	20	6.83
4	Бага	3	1.02
5	Хариулаагүй	23	7.85

3. Та бүтээгдэхүүн худалдан авахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байгааг худалдан авахыг илүүд үздэг үү?

№		Тоо	Хувь
1	Тийм, өөр бүтээгдэхүүн авах гэхээр сурталчилдаггүй тул сайн биш байх гэж боддог	48	16.38
2	Хэрэгцээ хангаж байвал заавал сурталчилгаа хэрэггүй байх гэж боддог	127	43.34
3	Сурталчлагүй ч нэг удаа хэрэглэж үзээд таалагдвал дахин хэрэглэдэг	115	39.25
4	Хариулаагүй	3	1.02

4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа зар сурталчилгааны хэдэн хувь нь үнэн бодитой гэж та үздэг вэ?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	100% нь үнэн	5	1.71
2	75% нь үнэн	65	22.18

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

3	50% нь үнэн	180	61.43
4	25% нь үнэн	40	13.65
5	0% нь үнэн	3	1.02
6	Хариулаагүй	293	100

5. Таны бодлоор ямар төрлийн зар сурталчилгаа хүмүүст илүү их хохирол учруулж байна вэ?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Хүнсний бүтээгдэхүүн	61	20.82
2	Эм, гоо сайхны бүтээгдэхүүн	135	46.08
3	Хүсний нэмэлт бүтээгдэхүүн	30	10.24
4	Ажил, үйлчилгээтэй холбогдолтой зар	34	11.60
5	Бусад	13	4.44
6	**Хариулаагүй**	20	6.83

6. Зар сурталчилгаагаар мэдээлэл авч байгаа бараа бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглээд танд ямар нэгэн хохирол учирч байсан уу?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Тийм	38	12.97
2	Үгүй	144	49.15
3	Санахгүй байна	102	34.81
4	**Хариулаагүй**	9	3.07

7. Зар сурталчилгаанаас үүдэн хохирч байгаа иргэд хаана хандахаа мэддэг эсэхийг судлахаар Зар сурталчилгаанаас үүдэн хохирсон бол хаана хандаж байсан бэ?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Бүтээгдэхүүн худалдан авсан газартаа очин хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардсан	15	39.47
2	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгт		-
3	Мэргэжлийн хяналтын газарт	3	7.89
4	Оюуны өмчийн улсын хяналтын албанд		-
5	Шүүхэд		-
6	Бусад		-
7	Ямар нэгэн газарт хандаагүй	20	52.63
8	Хариулаагүй		-

www.nli.gov.mn

8. Та хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж байгаа зар сурталчилгааг хуульд хэр нийцэж байна гэж үздэг вэ?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Бүрэн нийцсэн	17	5.80
2	Зарим талаар нийцсэн	229	78.16
3	Огт нийцэхгүй байна	41	13.99
4	Хариулаагүй	6	2.05

9. Зар сурталчилгаа нь хүмүүст хэр хэрэг болж байгааг судлах зорилгоор Зар сурталчилгаа нь таны бараа худалдан авах болон ажил үйлчилгээ сонгоход нөлөөлдөг үү?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Нөлөөлдөг	57	19.45
2	Нөлөөлдөггүй	32	10.92
3	Заримдаа нөлөөлдөг	160	54.61
4	Огт нөлөөлдөггүй	30	10.24
5	Хариулаагүй	14	4.78

10. Зар сурталчилгаанд тавих хяналт таны бодлоор хэр байна гэж үзэж байна вэ?

№	Өгөгдөл	Тоо	Хувь
1	Хангалттай	9	3.07
2	Зарим талаар хангалттай	87	29.69
3	Хангалтгүй	94	32.08
4	Маш хангалтгүй	20	6.83
5	Ямар байгууллага хяналт тавьдгийг мэдэхгүй	77	26.28
6	Хариулаагүй	6	2.05

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

ХАВСРАЛТ -4

Судалгааны явцад зохион байгуулсан уулзалт ярилцлагад оролцогчдын санал, зөвлөмжүүд

- Нийгмийн шинж чанартай, сэрэмжлүүлэг сурталчилгааг тухайн чиглэлийн төрийн захиргааны байгууллага нь улиралд 1 удаа, жилд 4 удаа гэх мэтчилэн олон нийтийн телевизээр гаргаж байх нь илүү үр дүнтэй байхаар байна. Энэ талын ажлыг телевизээр сурталчлах ажлыг хөнгөлөлттэй үнээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.
- Бүх зар сурталчилгааг тодорхой цаг хугацаатай байлгах. Кино болон бусад нэвтрүүлгийн дундуур нэг зүйлийн сурталчилгааг хэт олон гаргаж байгааг зогсоох, /Ариун цэврийн хэрэгсэл, памперс, шампунь гэх мэт/ Далд сурталчилгааны цаана хууль бус ялангуяа /хүний наймаа, биеэ үнэлэх, садар самуунд уруу татсан/ утга агуулга бүхий зар сурталчилгаа байгааг анхаарч үзэх. Хүүхдийн өөрийн гэсэн нэр төрийг дээдлэх. /Айдас хүйдэс, хүний наймааны объект болгох гэх мэт/
- Хөндлөнгийн хяналтыг чангатгах, хууль эрх зүйн орчинг сайжруулах, Зар сурталчилгааны тухай хуулийн 6.5.5-ийн заалтыг шалгаж үзсэний үндсэн дээр зар сурталчилгаа явуулах.
- Хуулийн биелэлтийг чангатгаж, хариуцах төлбөрийг өндөрсгөхийг тусгах, Төрийн зарим зөвшөөрлийн функцыг төрийн бус байгууллагад шилжүүлэх, бүх төрлийн рекламын ажил үйлчилгээнд стандартыг бий болгож, түүний биелэлтийг хянадаг болгох, PR буюу олон нийтийн харилцааны хууль бий болгох буюу бусад орны туршлагыг судлах,
- Реклам түгээгчдийн бас нэг хууль биелүүлэх гарц нь босго үнэ бий болгох буюу үнээ зэрэг нэмэх байж болох юм биш үү, Рекламны тухай хуулийг сайн сурталчлах,
- Реклам бүтээгч үйлдвэрлэгчид нь: телевиз, сонин сэтгүүл, радио зэрэг нь өөр анги ухагдахуунтай учир тусдаа нэмэлт заалт байх /хууль/
- Далд рекламыг хянахдаа хянах мэргэжлийн улсын байгууллага байх шаардлагатай. /УБ хот ЗАА-ны хот нийтийн ААХ/
- Хотын ИТХ-аас гаргасан реклам сурталчилгааны холбогдолтой журмыг судалж рекламны журам байршлын хоорондын зайг зөв тодорхойлдог болгох
- Рекламны далд сурталчилгааг захиалагчтай онцгойлон хариуцлага тооцож байх нь оновчтой.
- Зар сурталчилгааны тухай хуульд нэр томъёоны тодруулга хийвэл зохимжтой. Зар сурталчилгаа түгээгчид тавигдах шаардлагыг өндөрсгөх,
- Зар сурталчилгааны хариуцлагыг тухайн хуулийн онцлог нөхцөл байдалд зориулан тусгах хэрэгтэй. Хүүхэдтэй холбоотой зарыг ялгамжтай байдлаар хуульд томъёолох, Эмийн зар сурталчилгаатай тэмцэх үүнтэй холбоотой зар сурталчилгааны зохицуулалт оруулах, Зар сурталчилгааны агентлагийг төрөлжүүлэх шаардлагатай байна.

- Хүүхэдтэй холбоотой зар сурталчилгааг тодруулах шаардлагатай, хүүхэд тоглуулах оролцуулах, хүүхдэд нөлөөлөх нөлөөллийг харгалзах, хариуцлага нийт рекламны зардлын 50 хувиар торгох, 6-2 жил хорих ял /Францын Эрүүгийн хуульд энэ ял байдаг/ Хяналтыг шударга бус өрсөлдөөний газар өгөх нь зөв.
- Энэ хуулийн зарим ойлголт нэр томъёог оновчтой болгох, Хуулийн сурталчилгааг хүмүүст өргөнөөр хүргэх, Рекламны агентлаг албадын бүтцийг мэргэжлийн хүмүүсээр хангах ажиллуулах, үйл ажиллагааны зөвшөөрөл өгөхдөө энэ талыг чухалчлан авч үзэх
- Зар сурталчилгааны хуулийн заалтыг маш тодорхой оновчтой шинэчлэх шаардлагатай. Зар сурталчилгааны бодит үнэнийг зарлуулсан хувь хүн байгууллага бүрэн хариуцдаггүй зарласан байгууллага хамт хариуцах ёстой.
- "Зар", "сурталчилгаа" гэсэн хоёр ойлголт нь бодитойгоор явгдаж байгаа боловч авч буй арга хэмжээ хариуцлага нь тодорхойгүй байна. Сурталчилгааны агуулга нь мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг гэх мэт олон талт арга хэмжээгээр нийтэд цацаж байна. Аливаа бараа үйлчилгээний ашигтай болон сөрөг үр дагаврыг нийтэд үнэн зөв нээлттэй мэдээлэх шаардлагатай. Гарах үр дагавар хариуцлагын хэрэгслийг тодорхой, үнэлэмжийг нь нэмэгдүүлэх хэрэгтэй. ТВ чатын үйл ажиллагаа зогсоох, хязгаартай болгох. Зар сурталчилгааны хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй.
- Сурталчилгааны нэг хэлбэр нь реклам гэдгийг үзэх. Эм, архи, тамхины рекламны хажууд түүний сөрөг үр дагаврыг заавал хамт сурталчлах.
- Захиалагч, бүтээгч, түгээгчдийн хүлээх үүргийг тодорхой болгох,
- Хариуцлагын үр нөлөөг тодорхой болгохын тулд зар сурталчилгааг захиалагч байгууллагын жилийн орлогыг тодорхой хувь, эсхүл хэвлэл мэдээллийн байгууллагын тухайн зар сурталчилгаанаас олсон орлогыг тодорхой хэмжээгээр 10 дахин гэх мэтээр ихэсгэж торгох. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын чиг үүргийн хүрээнд зар сурталчилгаа хянах нэгжийг бий болгох.
- Дарс гэх мэтийг сурталчлахыг зөвшөөрвөл сөрөг үр дагаврыг нь үзүүлсэн зар сурталчилгааг бэлтгэхийг бизнес эрхлэгчид болон хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг болгох.
- Зар сурталчилгаа явуулж байгаа этгээдүүдэд эрх олгосон байгууллага маш өндөр хяналт тавих
- Зар оферт юм байна. Харин сурталчилгаа нь саналын дуудлага. Зар сурталчилгаа гэсэн ойлголтыг салгаж тодорхойлох нь зүйтэй. Зар сурталчилгаа бүтээгч гэдгийг илүү тодорхой зааж өгөх. Зар сурталчилгаа түгээгч нь бүтээгч байх боломжтой гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага бол зөвхөн түгээгч мэт ойлгогддог.

__oOo__

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗЭХ ЗЭЭЛД ДАГАЖ МӨРДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ /ЗӨРЧИЛ, ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, УЯЛДАА ХОЛБОО

Бидний үзэж судалснаар одоогоор үнэт цаасны зах зээлтэй холбоотой харилцааг зохицуулсан 27 орчим хууль, 24 орчим нийтээр дагаж мөрдүүлэх акт байгаа бөгөөд тэдгээрийг ангилан авч үзвэл:

1.Тус харилцааны эрх зүйн үндэслэлийг тогтоосон хууль буюу Үндсэн хууль, Иргэний хууль;

2.Гол хууль буюу нарийвчлан зохицуулсан хууль нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;

3.Бусад хуульд Компанийн тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль гэх мэт байна; /Үүнийг хавсралтаас харж болно./

4.Хуулиас бусад эрх зүйн акт. УИХ, Засгийн газар, Үнэт цаасны хороо /хуучин нэрээр/, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан эрх зүйн акт.

1.1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, ИРГЭНИЙ ХУУЛЬ БА ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална."; 5 дугаар зүйлийн 3-т "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно."; 5 дугаар зүйлийн 4-т "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна."; 16 дугаар зүйлийн 3-т Монгол Улсын иргэн "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно." хэмээн зааснаар эдийн засгийн харилцааны гол зарчмыг тогтоосон байна. Эндээс зарим зүйлийг тодруулбал:

- Хувийн, нийтийн өмчийг **нийгмээрээ** хүлээн зөвшөөрсөн нь иргэний болон дундын, төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн өмчийн хэлбэрээр, мөн нийтийн болон хувийн өмчийн холимог хэлбэрээр илрэх юм.
- Өмч болон өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах үүрэгтэй бөгөөд энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах ба харин хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хоригложээ.
- Төрөөс эдийн засгийг зохицуулах гэсэн үндсэн санаануудын хүрээнд үнэт цаасны харилцааг бусад хууль тогтоомжоор баяжуулан, нарийвчлан зохицуулах ёстой.

Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлал, зарчим Монгол Улсын Иргэний хууль тусгалаа олсон байдаг ч үнэт цаастай холбоотой зохицуулалтын хувьд тус хуульд хэрхэн биелэлээ олсныг энд дурдахгүй орхиж болохгүй юм. Нөгөө талаар шүүгч нартай хийсэн уулзалт ярилцлага, хавтаст хэрэгт хийсэн судалгаагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг бус Иргэний хууль, эсхүл Компанийн тухай хуулийг голдуу хэрэглэж, хэрэг маргааныг шийддэг болох нь ажиглагдсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд анализ хийж үзвэл тухайн харилцааг зохицуулсан нарийвчилсан хэм хэмжээ бараг байхгүй, ерөнхий хэм хэмжээ ихтэй тул хэрэг маргааныг шийдвэрлэхэд шууд үндэслэл болгоод шийдэх боломжгүй байгаа юм. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах талаар зохицуулсан 2, 3 зүйлийг эс тооцвол ихэнх хэм хэмжээ нь **материаллаг** гэхээсээ илүү **процессын шинжтэй** байгаа нь энэ хуулийн хэрэгжилтийг Иргэний хуулийн зохицуулалттай уялдаатай авч үзэх шаардлагатай болж байна.

2002 оны Иргэний хуулийн ерөнхий ангийн 49.1, 91.2.2, 98.1, 107, 113, 123.2.3, 155.2, 167.2, 237.1 дэх хэсэг, тусгай ангийн 274.4, 413.3, 413.4 дэх хэсэг, Дөчиндолдугаар бүлгийн 467-475 дугаар зүйлд үнэт цаастай холбоотой харилцааг шууд тусгайлан зохицуулсан байна. Эдгээрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай харьцуулан үзвэл:

Нэгдүгээрт. Хуулийн зөрчил, давхардал, ойлгомжгүй зохицуулалтын хүрээнд:

- Монгол Улсын Иргэний хуулиар үнэт цаасны талаархи ерөнхий ойлголтыг агуулга, шинжээр нь тодорхойлоогүй бөгөөд 2 шалгуураар л ангилсан байдаг. Хэрэгжих хэлбэрээр нь буюу биет ба биет бус (ИХ-467.1., 467.2 дахь хэсэг), эрх шилжүүлж буй байдлаар нь буюу мэдүүлгийн, зөвшөөрлийн, нэрийн үнэт цаас (ИХ-107, 113, 467.5, 468, 474, 475 дугаар зүйлд) байхаар тусгасан нь үнэт цаасны зах зээлийн харилцааг явцуу болгосон талтай. Онолын хувьд үүнээс гадна олон шалгуураар ангилдаг ба ерөнхий ойлголтыг хуулиар тодорхойлоогүйгээс практикт түүнийг **зөвхөн** "**хувьцаа**" мэтээр явцуу ойлгох, нэр томъёоны хувьд будилах, цаашлаад хэрэг маргааныг шийдвэрлэхэд хуулийг буруу тайлбарлаж хэрэглэх, хууль хоорондсөрчилдөх, тодорхой бус байдал бий болох шалтгаан үүсч байна. Мөн үнэт цаасыг **хэлбэрээр** ангилахыг Иргэний хуулийн 467.1. дэх хэсэгт үнэт цаас нь биет болон биет бус **төрөлтэй** байна гэж, харин эрх шилжүүлж буй байдлаар нь ангилахыг Иргэний хуулийн 467.5 дахь хэсэгт үнэт цаас нь нэрийн, мэдүүлгийн, зөвшөөрлийн гэсэн хэлбэртэй байна хэмээн тус тус алдаатай томъёолжээ.

- Иргэний хуулийн 467.6. дахь хэсэгт "Тодорхой этгээдээс зарим хэлбэрийн үнэт цаасыг гаргахыг хуулиар хориглож болно" гэжээ. Энэ нэг талаас тодорхой бус зохицуулалт болсон, нөгөө талаас үүнтэй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.1. дэх заалт зөрчилдсөн шинжтэй болсон. Учир нь энэ заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлэн зарим баримтыг үнэт цаас гэж тодорхойлж болохоор байгаа. Мөн Иргэний хуулийн 467.2. дахь хэсэгт биет болон биет

бус үнэт цаасыг тодорхойлсонтой Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.2. дахь заалт нь давхардсан ба харин 3.1.3. дахь заалт нь өөрөөр томъёологдсоныг харж болно.

- Иргэний хуулийн үнэт цаасны зах зээлийн харилцаатай холбоотой зарим зүйл, заалт нь ойлгомжгүй, шүүхийн практикт хэрэглэхэд хүндрэлтэй байна. Жишээ нь, шүүгч нартай хийсэн ярилцлагын явцад үнэт цаас нь нэрийн, мэдүүлгийн, зөвшөөрлийн гэсэн хэлбэртэй байна гэж заасан боловч тэдгээрийн тодорхойлолт байхгүй, ялгагдах шинжүүд нь ойлгомжгүй, зүйлүүдийн нэр, агуулга нь хоорондоо зөрчилтэй байдаг, хэрэглэхэд хүндрэлтэй байна гэжээ. Иргэний хуулийн 471.1.-д "Үнэт цаас эзэмшигчийн өмнө үүргээ гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэгч санаатайгаар, эсхүл илт хайхрамжгүй хандаж үнэт цаас эзэмшигчийн шударга бус эзэмшигч болохыг нотолж чадаагүйгээс бусад тохиолдолд хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөнө." гэсэн нь Иргэний хуулийн 90, 93, 95, 469.1 дэх заалттай холбоотойгоор ойлгомжгүй байгааг өмгөөлөгч, их, дээд сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаар дурдагдсан. Үүнээс гадна хуульд хийсэн контент анализаар Иргэний хуульд бас нэр томъёоны хувьд ойлгомжгүй зүйлүүд байна. Тухайлбал: 91.2.2-т заасан ".. мэдүүлгийн үнэт цаасnaас бусад эд хөрөнгө нь" гэсэн томъёоллоос мэдүүлгийн үнэт цаасыг **эд хөрөнгө** гэж ойлгохоор байгаа бөгөөд эдийн бус хөрөнгөд хамаарах ойлголт хэмээн мэргэжлийн ном зохиолд ч, Иргэний хуулийн 84.5 дахь хэсэгт ч тайлбарласантай зөрчилдөж байдаг. Мөн хуулийн 155.2 дахь хэсэгт "..бусдад шилжүүлж болох үнэт цаас..", 469.2-т ".. үнэт цаастай холбоотой аливаа шаардлага..", 469.4-т "..шууд тавьж болох шаардлага..", 469.5-т "Шууд тавьж үл болох татгалзал..", 470.1-т "..хамтын хариуцлага хүлээнэ." Иргэний хуулийн 469.1-т "Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасыг эзэмших эрхийг санаатай, илт хайхрамжгүй зөрэг хууль бус бусад замаар олж авсан бол түүнийг шударга бус эзэмшигч гэж үзнэ.", 469.2.-т "Үнэт цаас гаргагч нь үнэт цаастай холбоотой **аливаа шаардлагыг** үнэт цаас эзэмшигчид гаргаж болно.", 467.8-д "Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна." гэж зааснаас үзвэл юуны түрүүнд ойлгомжгүй томъёолсон төдийгүй, шууд утгаараа хөрөнгө оруулагч-эзэмшигч-өмчлөгчийн **эрхийг хамгаалах бус**, харин үнэт цаас гаргагч болох хөрөнгө босгож байгаа этгээдийн эрхийг илүү хамгаалсан шинжтэй зохицуулалт болсон байна.

Хоёрдугаарт. Зохицуулалтгүй буюу хийдэлтэй байдлыг авч үзвэл:

- Иргэний хуулийн 113.4, 475.2-т зааснаар нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлахаар байгаа бол харин Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зорилтоос харвал уг асуудлыг тухайн хуулиар зохицуулахаар заасан хэдий ч мөн чанартаа зохицуулалтгүй буюу Иргэний хуулийн ерөнхий ангийн 113 дугаар зүйлд заасан хэм хэмжээ л үйлчилж байна. Үүнээс гадна Иргэний хуулийн 274.4.-т "Төрийн өмчлөлийн мөнгө, үнэт цаасаар арилжаа хийх журмыг хуулиар тогтоох"-оор заасан ч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56

дугаар зүйлийг эс тооцвол энэ харилцаа хуулиар "бүрэн" зохицуулагдаагүй байна. Мөн Иргэний хуулийн 49.3-т "Талуудын худалдааны нууцыг агуулсан, тэдний зөвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлно" гэжээ. Энд мэдээллийн төрөл биш, ямар тохиолдолд мэдээлэх, мэдээлэхгүй байх тэр нөхцөлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тодорхойлоогүй байна.

- Иргэний хуулийн 107 дугаар зүйлд үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг сэргээх байгууллагын талаар заажээ. Харин зөрчигдсөн эрхийг хэрхэн, яаж, ямар журмаар сэргээх талаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмыг судлахад тэрхүү асуудал зохицуулалтгүй үлджээ. Энэ мэт үнэт цаас өмчлөгч буюу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэм хэмжээ Үнэт цаасны тухай хууль, холбогдох журамд харьцангуй бага тусгагдсан нь үнэт цаасны зах зээлийн харилцааны эрх зүйн зохицуулалт өнөөдөр Монгол Улсад төдийлөн сайн бүрдээгүй гэж үзэж болохоор байна.

1.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Энэ хэсэгт Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтын онцлог, агуулга, өөрийнх нь дотоод хэм хэмжээнд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ тус хуультай бусад хууль зөрчилдөж, давхардаж байгаа эсэх, хийдэлгүй эсэхийг тодорхойлох аргачлалаар судалсан юм.

1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааг халж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц эхэлж, үүний дагуу Иргэний хууль болон Өмч хувьчлалын тухай хуулиар төрийн өмчийг хувьд шилжүүлэх анхны алхамуудыг хэрэгжүүлснээр "хувьцаа", "хөрөнгө оруулалтын эрхийн бичиг", "үнэт цаас"-ны талаархи ойлголт эрх зүйн шинжлэх ухаанд шинээр орж ирсэн. Хэдийгээр үүнээс өмнө үнэт цаасны зарим хэлбэрүүд байсан ч агуулга, мөн чанараараа зах зээлийн эдийн засгийн харилцааны онцлог, зарчим, үзэл баримтлалтай нийцэхгүй байсан нь тодорхой.

1992 онд Үндсэн хууль батлагдахад нийгмийн харилцааг зохицуулах шинэ хууль тогтоомжийг гаргах, ялангуяа эдийн засгийн харилцааг зохицуулсан хуулиудыг яаралтай боловсруулж, хууль тогтоох байгууллагаар батлуулах шаардлага зүй ёсоор тавигдсан.

Үүний үр дүнд 1994 онд Иргэний хуулийг батлан гаргасан ба олон улсын байгууллагуудаас нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, **төслийн санхүүжилттэй холбоотойгоор зарим хуулийг гаргах шаардлага, болзлыг** эрх бүхий байгууллагад тавьдаг байсан нь нөлөөлж, 1994 онд "Үнэт цаасны тухай хуулийг" хууль тогтоох байгууллагаас баталснаар үнэт цаасны зах зээлийн харилцааны анхны бие даасан эрх зүйн зохицуулалт бүрэлдсэн байна. Улмаар 1998 онд батлагдсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Хууль тогтоомжийг 2001 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд зааснаар

эдийн засгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2002 онд тус тус шинэчлэн найруулж мөрдүүлсэн. Гэвч "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн хувийн хэрэгт түүнийг шинэчлэн найруулах шалтгааныг тэмдэглэснээр бол үнэт цаасны зах зээлийн харилцаанд гарсан бодит шаардлага, хэрэгцээнээс гадна мөн л санхүүгийн салбарын 2 дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **Азийн хөгжлийн банкнаас олгох зээлийн гэрээний нэг гол нөхцөл нь** Үнэт цаасны тухай хуулийг батлуулсан байх явдал байжээ. Эндээс харахад **бодит шаардлагаар** хууль гаргасан буюу шинэчлэн найруулсан гэхээсээ илүү **"бусдын шаардлага"-аар "болзол"-оор шахуу баталсан** гэж хэлж болмоор санагдана.

2002 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг боловсруулахдаа үзэл баримтлалын хувьд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн байгууллагын шинэ төрлүүдийг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлийг барьснаараа 1994 оны Үнэт цаасны тухай хуулиас дэвшилттэй байсан боловч зохицуулалтыг нарийн болгож чадаагүй. Тухайлбал, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг тодорхойлсон байдаг ч түүний чиг үүрэг, үйл ажиллагаа, бусдаас ялгагдах онцлог, хариуцлага зэргийг тусгаагүй, ерөнхий зохицуулалттай болсон.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль бүтцийн хувьд өмнөх хуулиасаа ялгаатай[61] ба харин агуулга талаас нь авч үзвэл үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, этгээдийн бүрэлдэхүүн, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт тавьсан байдаг боловч бодит байдал дээр 1994 оны Үнэт цаасны тухай хуулиасаа дэвшилттэй өөрчлөлт орсон, тэдгээр нь нэн хэрэгцээтэй байсан эсэх нь эргэлзээтэй байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд дараахь хэд хэдэн асуудал анхаарал татахуйц байна:

1.Уг хуулиар үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаархи мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилтыг агуулсан. Судалгаагаар хуулийн зохицуулалт зорилтоо хангаж чадахгүй байгаа нь ажиглагдсан. Учир нь зорилт нь нэлээд өргөн хүрээнд, **процессын нарийвчилсан зохицуулалтыг** шаардахаар байгаа. Гэтэл тэрхүү "үүргээ" Санхүүгийн зохицуулах хорооноос журмаар зохицуулах байдлаар шилжүүлсэн ба шилжүүлэг нь эмх цэгцгүй болжээ. Нөгөө талаар хуулиар ч, холбогдох журмаар ч тэр өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй, мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааны зохицуулалт хязгаарлагдмал байгаа нь тавьсан зорилтдоо хүрээгүйг илтгэнэ.

[61] Хавсралтаас харна уу.

2.Хуулиас түүвэрлэн үзвэл давхардсан тоогоор нийт **23** зүйл, заалтад тодорхой асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос журамлан тогтоож зохицуулахаар тусгасан байх бөгөөд энэ нь уг хууль харилцааг зорилтынхоо хүрээнд "бүрэн" зохицуулах хэмжээнд биш, давхардсан, Санхүүгийн зохицуулах хорооноос зарим асуудлыг үзэмжээр шийдэх боломжийг бүрдүүлсэн шинжтэй болгожээ. /Журмаар зохицуулахтай холбоотой хэм хэмжээний түүврийг хавсралтаас үзнэ үү./

3.Үүнээс гадна Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.2., 19.2.3.-т үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны болон хадгаламжийн, гишүүний болон суудлын хураамж, **бусад холбогдох** үйлчилгээний хураамжийг **тогтоож мөрдөх**, хууль тогтоомжийн хүрээнд СЗХ-ны зөвшөөрснөөр өөрийн үйл ажиллагаанд баримтлах **журам, заавар** гарган мөрдүүлэхээр заасан нь энэ салбарын харилцаанд оролцогчдод нэлээд хүндрэл, дарамт үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн актын тоо, хоорондын уялдаа, **байнгын хөдөлгөөнтэй байдалтай**-хамааралтайгаар тайлбарлагдана.

4.Үнэт цаасны талаархи мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх нь нэлээд том зорилт болохын хувьд өргөн хүрээнд, асуудлыг тодорхой зохицуулах ёстой. Өөрөөр хэлбэл, энд мэдээллийг хүргэх этгээдийг өргөн хүрээнд буюу үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудаас гадна хяналт тавих эрх бүхий байгууллагын зүгээс ямар мэдээллийг хэрхэн яаж, ямар хугацаанд хүргэх, түгээх асуудлыг нарийвчлан зохицуулж, хооронд нь ялгаж, хэмжээ хязгаартайгаар тогтоох явдал чухал. Энэхүү харилцаа нь өөрөө мэдээлэлд тулгуурлаж явдаг онцлогтой тул түүний түргэн шуурхай, хүртээмжтэй байдалд онцгой анхаарч **хуулиар нарийвчлан тогтоож** өгөх нь зүйтэй болов уу. Үүнийг зориуд онцолж буй нь нэг талаас хуулийн зорилтыг одоогийн зохицуулалт хангаж чадахгүй байгаа, нөгөө талаас иргэдээс авсан судалгаа, ярилцлагын судалгаагаар мэдээллийн хүртээмж дутмаг, "мэдээллийн хомсдол", ялгаварлал их, агуулга, чанар муу байгаа зэрэг үр дүн гарч байна. /Уулзалт, ярилцлагын протокол, энэхүү тайлангийн V хэсгээс харна уу./

5.Энэ хуулийн өмнөх Үнэт цаасны тухай хуулиас ялгагдах гол онцлогийн нэг нь хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол /"эрх ашиг" гэж хуульд томъёолсон байгаа/-ыг хамгаалах асуудал юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн Гуравдугаар бүлэг "хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах"-д чиглэгдсэн боловч бодит байдалд хөрөнгө оруулагч, ялангуяа "бага" хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол илүү хөндөгдөж, ногдол ашгаа авч чадахгүй байх, хувь нийлүүлэгчдийн хуралд болон шийдвэр гаргахад оролцох боломжгүй байх, мэдээлэл хязгаарлагдмал зэрэг асуудлыг тэр бүр зохицуулж чадахгүй байгаа нь хуулийн хэрэгжилт, үр нөлөөтэй шууд холбоотой.

6.Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь Иргэний хууль, Компанийн тухай хуультай уялдаа холбоотой байхаар заасан ба өөрийн зохицуулалтын

онцлог /үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулсан ерөнхий хэм хэмжээ бүхий/ шинжээсээ татгалзаж, голдуу компани, хувьцаатай холбоотой асуудлыг түлхүү оруулсныг харж болно. Үнэт цаасны талаархи тусгай харилцааг зохицуулсан хуулийг Компанийн тухай хуультай хольж хутгаж болохгүй юм. Үүгээрээ хуулийн хувьд "тусгай" байх, ойлголтын хувьд "нийтлэг" байх асуудлыг цаашдаа зайлшгүй анхаарах хэрэгтэй.

7.Хууль нь бүтэц, найруулга, нэр томъёо, агуулгын хувьд ойлгомжтой, тодорхой байх ёстой. Энэ нь түүнийг хэрэгжүүлэгч байгууллага, хэрэглэх шүүх, тэрхүү харилцаанд оролцогч бусад этгээдэд нэн хэрэгцээтэй зүйл байдаг. Жишээ нь, тус хууль 5 бүлэгтэй бөгөөд 4 дүгээр бүлэг нь 2 байх жишээтэй. Арилжаа, гүйлгээ, худалдан авагч, көрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигч гэж өөрөөр томъёологдсоныг хуулиар тодорхойлоогүй, ялгаатай бол хэн ямар эрх, үүрэгтэй оролцохыг зааглаагүй. Мөн хуулийн 7.4.9., 10.1.1., 11, 12, 14, 15, 17, 20.2., 21.5., 21.6., 38 дугаар зүйлийн агуулга ойлгомжгүй, зүйлийн нэр, зүйлийн агуулгатайгаа уялдаагүй, хууль зүйн техник болон томъёоллын хувьд алдаатай, тодорхой бус, зарим зохицуулалт нь орхигдсон ч гэж болохоор байна.

8.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 13, 16 дугаар зүйлд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага /шууд бус утгаараа ажилтан/-д зарим үйл ажиллагааг хориглосон чухал зохицуулалт оруулсан. Гэвч үүний хэрэгжилтийг хангах боломжгүй буюу зөрчсөн тохиолдолд хэрхэх тухай хариуцлагын асуудлыг тус хуульд оғт тусгаагүй нь учир дутагдалтай болжээ. Харин энэ хуульд заасан хориглосон бусад хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр 38 дугаар зүйлд зохицуулсан нь хууль тогтоогчийн алдаа гэлтэй.

9.Сүүлийн хэдэн жил тус улсад ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд гадаад орны үнэт цаасны зах зээлд өөрийн үнэт цаасаа арилжаалах нь ихэсч байна. Энэ байдал цашдаа өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ талын харилцааг зохицуулсан хэм хэмжээг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, татварын асуудал, ирээдүйд үүсч болох үр дагавраас урьдчилан сэргийлэх, хяналт тавих асуудал, хариуцлагын асуудал гэх мэт. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд "Үнэт цаас гаргагч гадаад орны зах зээлд өөрийн үнэт цаасаа арилжаалж болох"-ыг л хуульчилснаас биш энэхүү боломжийг баталгаажуулсан зохицуулалт /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 83 дугаар тогтоолыг эс тооцвол/ байхгүй байгаа нь хангалтгүй, зохицуулалт шаардлагатайг харуулна.

10.Судалгааны явцад иргэд, хуульч /шүүгч, өмгөөлөгч/, багш, судлаач, хувьцаат компанийн ажилтан, хувьцаа эзэмшигчдтэй уулзаж ярилцахад хөндөгдсөн нийтлэг асуудал нь нэмжхувьцаа гаргах /"хувьцаагүнэгүйдүүлэх"/, компанийн удирдлага буюу "их" хувьцаа эзэмшигчдийн зүгээс "бага" хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах, хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах зэрэг байсан. Хэдийгээр дээрх зарим асуудлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулсан байдаг ч эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай, хэрэгцээтэйг харуулж байна.

1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БА КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ, БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ

Үнэт цаасны зах зээлийн харилцаанд мөрдөгдөх, ач холбогдол бүхий хуулийн нэг нь Компанийн тухай хууль юм. Шүүхийн практикт ч. сурвалжлагын аргаар болон анкетын аргаар хийсэн судалгаагаар ч энэ байдал нотлогдож байсан. Зонхилон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох буюу компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, хувь нийлүүлэгчдийн хурал хийх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, мэдээлэл өгөх, хувьцааны хяналтын багцыг худалдан авах, эдгээртэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх зэрэг асуудал нэлээд анхаарал татсан юм.

Тиймээс бид дээрх асуудлын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулийг хооронд нь харьцуулах замаар хэм хэмжээний уялдаа холбоо, зөрчил, давхардал зэргийг тодорхойлохын зэрэгцээ амьдрал дээр гарч буй хүндрэлтэй асуудлуудын гол шалтгааныг тогтоохыг хичээсэн бөгөөд харьцуулалт /Үүнийг хавсралтаас харна уу./-аар дараахь асуудлууд тодорхойлогдсон:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь компаниас гаргадаг үнэт цаас /хувьцаа, өрийн бичиг, опцион гэх мэт/ төдийгүй зах зээлд ашиглагдаж болох бүхий л үнэт цаас /тухайлбал, Засгийн газрын бонд, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргах үнэт цаас гэх мэт/, тэдгээрийг гаргах болон худалдан авах, зуучлах, арилжих үйл ажиллагаа, тухайн харилцаанд оролцох, хяналт тавих субъектүүдийн эрх, үүрэг, хариуцлагын талаар **гол** зохицуулалтыг агуулсан өргөн хүрээтэй хууль байх ёстой. Гэтэл хууль энэ шинжийг хадгалаагүй, ихэнх зохицуулалт нь зөвхөн нээлттэй компанийн хувьцаа, түүнтэй холбоотой асуудлыг тусгасан, тэдгээр нь Компанийн тухай хуулийн нарийвчилсан зохицуулалттай давхардсан байх бөгөөд үүгээрээ үнэт цаасны нийтлэг шинжтэй харилцааг зохицуулах чадваргүй гэж үзэхээр байна. Нөгөө талаас нь авч үзвэл Компанийн тухай хууль компанийн үнэт цаастай холбоотой харилцааг илүү нарийвчлан зохицуулжээ.

- Юуны түрүүнд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах асуудлаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай харьцуулбал Компанийн тухай хууль давамгай зохицуулалттай ба энэ нь хувьцаа эзэмшигчийн эрхийг тодорхойлсон явдал юм. Харин Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаас худалдан авагч /хөрөнгө оруулагч/-ийн үүргийг тодорхойлсноос биш эрхийн талаар тусгайлан авч үзээгүй нь салбарын хуулийн хувьд учир дутагдалтай болжээ.

- Судалгаагаар, ялангуяа уулзалт, ярилцлагаар хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол амьдрал дээр их зөрчигдөж байгаа дүр зурагтай байсан. Тухайлбал, ногдол ашиг хуваарилах, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох, санал өгөх, шийдвэр гаргахад оролцох, компанийг өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийг бүртгэх зэрэг асуудлыг дурдаж болно.

Гэхдээ эдгээр асуудлыг Компанийн тухай хуулиар зохицуулсан байх бөгөөд энэ тохиолдолд тухайн харилцаанд оролцогч субъект хуулийг уншиж судлаагүй, өөрсдийн эрх, хууль ёсныхоо ашиг сонирхлыг хамгаалах талаар идэвхтэй тэмцдэггүй, хуулиар тодорхойлсон боломжуудыг ашигладаггүй, эрх зүйн мэдлэг дутмаг, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж, ягштал биелүүлдэггүй, энэ салбар дахь мэдээлэл хомс, хүртээмж муу зэрэг **субъектив хүчин зүйлээс** үүдэн дээрх асуудлууд гардаг нь хэрэгжилтэд сөрөг үнэлгээ өгөхөд хүргэж байна.

- Гэхдээ дээрх 2 хуулийн харьцуулалтаас зарим зөрчилтэй, хийдэлтэй, давхардсан шинжтэй зохицуулалт, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болохоор зохицуулалт цөөнгүй байна. Эдгээрийг хавсралтаас харж болно.

1.4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БА НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ АКТ

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Санхүүгийн зохицуулах хороо зарим нийтээр дагаж мөрдөх акт /дүрэм, журам гэх мэт/ гаргахаар байгаа. Онолын талаасаа нийгмийн бүх харилцааг хуулиар бүрэн зохицуулах боломжгүй учраас зарим тохиолдолд хууль тогтоох байгууллагаас бусад субъектэд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрхээ шилжүүлж, ингэхдээ хүрээ хязгаарыг нь тухайн үндэслэл болгож буй хуулиар тогтоож өгдөг.

Өнөөдөр практикт нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг боловсруулах, батлах, бүртгэх процедураас гадна үнэлж, дүгнэх буюу нийтээр дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээ мөн эсэхийг нь тогтоодог стандарт, журам Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолыг эс тооцвол байхгүй байна. Энэхүү тогтоолоор батлагдсан журмаар УИХ-аас байгуулагддаг субъектүүдийн гаргасан нийтээр дагаж мөрдөх актын хувьд үйлчлэхгүй ба энэ тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан акт хуулийн дагуу гарч буй эсэх, бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан, хэм хэмжээ тогтоосон эсэхийг тогтоох, хүчингүй болгох, тэдгээрт хяналт тавих функц дутагдаж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

- Үнэт цаас нь өөртөө хувьцааг агуулж байдгийн хувьд түүний харилцааг зохицуулсан хууль нь ерөнхий байхаас биш хувьцааны талаар тусгайлсан зохицуулалт агуулах ёсгүй гэж үзэж байна.

- Тухайн харилцааг зохицуулах хууль нь материаллаг хэм хэмжээгээ агуулсан байх ёстой байтал Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь илүү процессын шинжтэй хууль болсноороо үр нөлөө бага байна.

- Үнэт цаасны зах зээлтэй холбоотой харилцааг хууль тотгоомжоор биш, бусад эрх зүйн актаар зохицуулж байна гэж дүгнэж болохоор байна.

- Үнэт цаасны зах зээлд иргэд, байгууллагын оролцоо муу байгаа нь тэдний энэ талын мэдлэг хангалтгүй, мэдээллийн тогтолцоо бүрэлдээгүйтэй холбон үзэж болох юм.

- Хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах талаар үнэт цаас гаргагчид, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхой болгон хэрэгжилтийг хангуулахтай холбоотой зохицуулах байгууллагын эрх хэмжээг тодорхой болгох шаардлагатай байна.

- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай. Энэ талын зохицуулалт маш дутмаг байгааг судалгааны үр дүн харуулж байгаа.

- 2002 оны Иргэний хуулийн үнэт цаасны зах зээлийн харилцаанд холбогдох зохицуулалт нь ойлгомжгүй, тодорхой бус байгаа учраас ойлгомжтой болгох үүднээс тайлбар гаргах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

- Үнэт цаас гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, мэдээллийн тогтолцооны зохицуулалтыг илүү боловсронгуй болгох /нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагыг өндөржүүлэх; нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны танилцуулгад тусгах зүйлсийг дэлгэрэнгүй болгох; хорооноос үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл олгох болон татгалзах нөхцөлийг тодорхой болгох; нийтэд ил тод болгох мэдээллийг дэлгэрэнгүй жагсаан гаргах/.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХАМААРАГДАЖ БУЙ СУБЪЕКТУУДЫН ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

Монгол Улс 1990 оноос социалист эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцыг хурдасган улсын өмчийг хувьд шилжүүлэх /хувьчлах/ харилцааг 1991 онд БНМАУ-ын Бага Хурлаас батлан гаргасан "Өмч хувьчлах тухай" Монгол Улсын хуулиар зохицуулсан байдаг. Уг хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг /цаашид "эрхийн бичиг" гэх/-ийг энэхүү хууль хүчин төгөлдөр болсон едөр болон түүнээс өмнө төрсөн Монгол Улсын иргэн нэг удаа авах эрхтэй" гэж заасныг үндэслэн БНМАУ-ын иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосон. Иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосон нь төрийн өмчийн тодорхой хэсгийг иргэдэд ижил хэмжээгээр өмчлөх эрх олгож, иргэдийг хувийн өмчтэй болгож зах зээлийн тогтолцоог хөгжүүлж, өмч хувьчлах үндсэн аргыг ашигласан. "Өмч хувьчлах тухай" хуулийн үзэл баримтлалд "Хувьчлагдах үйлдвэр, аж ахуйн газруудын үйлдвэрлэлийн фонд, үр ашиг, техник технологийн түвшинг харгалзан нийт хөрөнгийг үнэлж **хувьцааг бирж** дээр гаргах бөгөөд БНМАУ-ын иргэд нь хөрөнгө оруулалтын эрхийн бичгээрээ хувьчлагдаж байгаа аль ч үйлдвэр, аж ахуйн

газрын **хувьцааг биржээр дамжуулан** авах эрхтэй гэж үзнэ" гэсний хүрээнд иргэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээрээ хувьчлагдах үйлдвэр, аж ахуйн газрын хувьцааг биржээр дамжуулан авах эрхийг бүрдүүлэн Монгол Улсад анх удаа хөрөнгийн биржийн үйл ажиллагааны үндсийг тавьсан бөгөөд "Монголын **Хөрөнгийн биржийн** түр дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөрөнгийн биржийг байгуулан Үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн байгууллагын суурийг бий болгож байсан. Мөн өмч хувьчлалтай холбогдуулан иргэдийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээрээ Хөрөнгийн биржээс хувьцаа авахад нь зуучлах, зөвлөгөө өгөх үүрэг бүхий **брокерын нүүсүүдийг** байгуулсан байна.

Өмч хувьчлалын дараагаар үнэт цаасны зах зээлийн хууль зүйн үндсийг бий болгох үүднээс 1994 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УИХ "Үнэт цаасны тухай" Монгол Улсын хуулийг батлан гаргажээ.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн төгтолцоонд шилжих шилжилтийн үед үнэт цаасны зах зээлд шинэ шинэ харилцаа бий болж байгаа болон 1999 онд Компанийн тухай хууль, 2002 онд Иргэний хууль шинээр батлагдсан зэрэг олон үйл явцын нөлөөллөөс шалтгаалан 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр УИХ 1994 оны "Үнэт цаасны тухай" хуулийг хүчингүй болгон "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийг шинээр батлан гаргасан. Уг хуульд үнэт цаасны зах зээлд оролцогч субъектуудыг тодорхойлж, тус зах зээлд оролцогчдын эрх, үүргийг зохицуулсныг судалгааны тайланд дахин дэлгэрэнгүй авч үзнэ.

УИХ-аас 2002 онд батлан гаргасан "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль /цаашид "ҮЦЗЗТХ" гэх/-ийн 1 дүгээр зүйл болох Хуулийн зорилт болон Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд гарчигтай тус хуулийн 18 дугаар зүйлээс үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд хэнийг хамааруулж болохыг тогтоовол. Үүнд:

1.Хөрөнгө оруулагч;

2.Үнэт цаас гаргагч;

3. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага гэсэн үндсэн гурван субъект байна.

Нөгөө талаар үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн субъектуудыг төрийн болон хувийн сектор гэж 2 ангилж болно. Үнэт цаасны зах зээлд төрийн оролцоо зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Төр үнэт цаасны зах зээлд зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх чиг үүрэгтэй оролцдог нь нийтлэг жишиг юм.

2.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

2.1.1. Хөрөнгө оруулагчийн эрх зүйн зохицуулалт өнөөгийн байдал

"Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах,

худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаархи мэдээллийг **хөрөнгө оруулагчид** хүргэх, **хөрөнгө оруулагчийн** эрх ашгийг хамгаалах, ...-тай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан бөгөөд **хөрөнгө оруулагч** нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн субъект болохыг тогтоосон. Уг хуульд хөрөнгө оруулагчийг тодорхойлоогүй дутагдалтай боловч хөрөнгө оруулагч гэдэгт үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, арилжих зэрэг ажиллагаанд хөрөнгө оруулан оролцож буй хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагыг хамруулан ойлгож болох юм.

ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар бүлэг нь Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах гэсэн гарчигтай бөгөөд уг бүлэг нь 5 зүйл /ҮЦЗЗТХ-ийн 13-17 дугаар зүйл/-ийг агуулж байна. ҮЦЗЗТХ-ийн эдгээр зүйл нь дараахь харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- 13 дугаар зүйл нь: Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад үнэт цаасны зах зээл дээр тавигдах хязгаарлалт,
- 14 дүгээр зүйл нь: Хөрөнгө оруулагчид үнэт цаасны гүйлгээтэй холбогдох мэдээлэл хүргэх,
- 15 дугаар зүйл нь: Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаархи хорооны шийдвэр,
- 16 дугаар зүйл нь: Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад хориглох үйл ажиллагаа,
- 17 дугаар зүйл нь: Дотоод мэдээллийн нууцыг хадгалахыг тус тус зохицуулсан байна.

Нөгөө талаас ҮЦЗЗТХ-ийн 12 дугаар зүйл нь үнэт цаас худалдан авагчийн үүргийг зохицуулсан бөгөөд үнэт цаас худалдан авагч нь нэг талаараа үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагч юм. Мөн аливаа нэг хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшиж байгаагаараа үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагч юм.

ҮЦЗЗТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэг байна. Мөн зүйлийн 12.2 болон 12.3-т компанийн хяналтын багцыг худалдан авсан этгээд Компанийн тухай хуульд заасан шаардлагыг биелүүлэх ба ҮЦЗЗТХ-ийн 12.1-т заасан этгээдийн хувьцаа таван хувиар нэмэгдсэн тохиолдол бүрт Хороонд энэ тухайгаа мэдэгдэхээр зохицуулсан бөгөөд 12.4-т Хороо компанийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувь болон хяналтын багцыг худалдан авснаа бүртгүүлэх тухай журмыг батлан гаргахаар хуульчилсан байна.

1999 оны Компанийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 35-46 дугаар зүйл, 2003 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12-17, 19-30, 34 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22, 24 дүгээр зүйлд тус тус хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах үндсэн эрх зүйн зохицуулалт хийгдсэн байна.



Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах үүднээс Компанийн тухай хуулиар компанийн энгийн болон давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг тодорхой заасан бөгөөд хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрх, хувьцааны хөрвөх үнэт цаас, үнэт цаас гаргах, хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг тогтоох, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийн асуудлыг журамлаж өгсөн. Мөн тус хуулиар компани өөрийн үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авах, хувьцааны хяналтын багцыг худалдан авахыг зохицуулсан нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нэг томоохон алхам болсон.

Нөгөө талаас төлөөлөн удирдах зөвлөлийг өмнө нь ердийн аргаар сонгодог байсан бол 1999 оны Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтын дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг санал хураах **кумулятив аргаар** сонгохоор шинэлэг зохицуулалт орсон. ТУЗ-ийн гишүүн нь компанийн хувь нийлүүлэгч биш байж болохыг зохицуулсан нь хувьцаа эзэмшигч тэр дундаа "бага" хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болсон.

Хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах асуудал бол үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийн үндсэн чиг үүргийн нэг нь юм. Иймд уг хууль тогтоомжийн тодорхой нэг хэсэг хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын хэмжээг их, бага гэж ялгалгүй хамгаалах чиг үүрэгтэй. Үнэхээр үнэт цаасны зах зээлд бага хэмжээний хөрөнгө оруулагч буюу "бага" хувьцаа эзэмшигчийг хамгаалах асуудал нилээд чухал байр суурь эзэлдэг.

Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт дараахь асуудлыг голчлон тусгасан байхыг шаарддаг. Үүнд:

- Мэдээллийн ил тод байдал;
- Компанийн удирдлага;
- Үнэт цаастай холбоотой гүйлгээ, төлбөр тооцоо хадгаламжийн найдвартай байдал;
- Зуучлагчийн найдвартай байдал;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчдын шуурхай үйлчлэх байдал;
- Итгэлцлийн зарчмыг хангах /Үнэт цаасны зах зээлд оролцогчдын шударга байх байдал/;
- Эрдслээс хамгаалах цогц тогтолцоо;
- Хөрөнгө оруулагчийн хариуцлагатай байх гэх мэт.

Үнэхээр үнэт цаасны зах зээлд мэдээлэл бол хамгийн том давуу тал юм. ҮЦЗЗТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй" гэж заасан бөгөөд СЗХ-ны 2007 оны 206 дугаар тогтоолоор "Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам"-ыг баталсан байна.

Уг журмын 2 дугаар зүйлийн 2.2-т "Мэдээллийн санд дор дурдсан иргэн, хуулийн этгээд мэдээлэл ирүүлнэ":

2.1.1.үнэт цаасны арилжаа эрхэлж буй байгууллага;

2.1.2.үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;

2.1.3.брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;

2.1.4.андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;

2.1.5.үнэт цаас гаргагч;

2.1.6.хууль тогтоомж, дүрэм журамд заасан бол холбогдох иргэн, хуулийн этгээд гэж заасан бөгөөд эдгээр этгээд уг журмыг холбогдох заалтад заасан мэдээллийг тодорхой хугацаанд СЗХ-нд ирүүлэх үүрэгтэй. Харин журмын 4 дүгээр зүйлд "**Мэдээллийн сан дахь мэдээллийг ашиглах, мэдээллийг олон нийтэд мэдээлэх"** асуудлыг зохицуулсан боловч энэхүү зохицуулалт нь **хангалтай бус байна**. Учир нь журмын 4.1-т "Мэдээллийн сан дахь мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн нээлттэй байдлыг бий болгох, олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, эрдэм, шинжилгээ, судалгаа хийх боломжийг бүрдүүлэх, зохицуулах байгууллагын хяналтын чиг үүргийг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ашиглана" гэж заасан боловч өнөөгийн үнэт цаасны зах зээлд тус заалт нь зорилгодоо хүрч, амьдралд хэрэгжиж чадаагүй юм. Мөн тус журмын 4.4-т "Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад нийтэд тогтмол мэдээлэхээр зааснаас бусад хуулиар нийтэд мэдээлэхийг хориглоогүй бөгөөд уг мэдээллийг гаргахад тодорхой шүүлт, судалгаа, харьцуулалт, дүгнэлт болон шинжилгээ шаардлагатай тухайлсан мэдээллийг төлбөртэй нийтийн хүртээл болгоно. Төлбөрийн хэмжээг Хорооны Ажлын албаны даргын тушаалаар тогтооно" гэж заасан бөгөөд мэдээллийн сан дахь зарим мэдээллийг төлбөртэй гаргана гэж зохицуулсан нь хөрөнгө оруулагчдад тэр дундаа бага хэмжээний хөрөнгө оруулагчийн эрх ашигт төдийлөн нийцэхгүй зохицуулалт юм. Тэр бүр бага хэмжээний хөрөнгө оруулагч буюу "бага" хувьцаа эзэмшигч цаг зав, тодорхой хэмжээний мөнгө төгрөг зарцуулан мэдээлэл олж авахаар хөөцөлддөггүй бөгөөд журмын уг зохицуулалт нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын шударга байдлыг хангаж чадах эсэх нь эргэлзээтэй юм.

ҮЦЗЗТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т үнэт цаас гаргагч холбогдох мэдээллийг хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй гэсэн боловч тухайн үүргийг хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус байгаа билээ.

Иймд дээрх хууль журмын зохицуулалтыг дараахь байдлаар боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

- Үнэт цаастай холбоотой мэдээллийг хөрөнгө оруулагчдад нэгэн зэрэг хүргэх боломжийг бүрдүүлэх;
- Холбогдох мэдээллийг тодорхой цаг хугацаанд мэдээлдэг байдал хэвшсэн байх;
- Аливаа нэг хэсэг этгээдэд мэдээллийг урьдчилан мэдээлэх асуудлыг хориглосон байх;
- Мэдээллийн утга, агуулга тодорхой, бодитой байх;
- Мэдээлэх хэрэгсэл, аргыг нарийвчлан журамлах;
- Мэдээлэл өгөөгүй, нуун дарагдуулсан, эсхүл буруу мэдээлэл өгсөн байх тохиолдолд холбогдох этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох.

Үнэт цаасны зах зээлд их хэмжээний хөрөнгө оруулагч буюу тодохой хувь, хяналтын багц болон түүнээс дээш хувьцаа эзэмшигч нь хувьцааг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн хүнээ оруулах аргаар мэдээлэлд ойр байдаг тул мэдээллийн ил тод байдлыг боловсронгуй болгох зохицуулалт нь "бага" хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байх зохицуулалт байх шаардлага тавигддаг.

2.1.2. Хөрөнгө оруулагчийн өнөөгийн төлөв байдал

"Өмч хувьчлалын тухай" хуулийг хэрэгжүүлж эхэлснээр 1995 оны байдлаар дотоодын үйлдвэрлэлийн 50 гаруй хувь, худалдаа, үйлчилгээний газрууд үндсэндээ, мал сүргийн 90 гаруй хувь нь хувийн өмчлөлд шилжсэн ба өмч хувьчлалын явцад нийт 1,9 сая гаруй хүнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгож, 17,4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгө хувьчлагдан, 1,1 сая гаруй иргэд хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа эзэмшигч болсон[82]. Харин янз бүрийн шалтгаанаар 113 мянган хүн хөрөнгө оруулалтын эрхийн бичиг авалгүй үлдсэн тухай УИХ-ийн 1995 оны 11 дүгээр тогтоолд тэмдэглэсэн байдаг. Мөн өмч хувьчлалын ажлын үр дүнд 1995 оны байдлаар 466 хувьцаат компани, 1297 бүрэн бус хариуцлагатай компани, 1907 хоршоо, 850 хувираа эрхлэх аж ахуй бий болсон байна гэжээ.

Өмч хувьчлалаар 1,9 сая хүнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг өгсөн бөгөөд үүний дагуу манайд үнэт цаасны анхдагч зах зээл үүсч улмаар сүүлийн жилүүдэд үнэт цаасны хоёрдогч зах зээл сонгодог утгаараа хөгжиж байна. Өнөөгийн байдлаар 370 гаруй мянган хувьцаа эзэмшигч[83] байгаа бөгөөд түүнээс 220 мянга орчим хувьцаа эзэмшигч өөрийн тооцооны дансаа нээлгээгүй байна.

Хувьцааны төвлөрлийн судалгаа
/2008 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар/

Д/д	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь
1	1-10 ширхэг хувьцаатай	70792	18,9
2	11-50 ширхэг хувьцаатай	120008	32,1
3	51-100 ширхэг хувьцаатай	71317	19,1
4	101-1000 ширхэг хувьцаатай	107480	28,7
5	1001-5000 ширхэг хувьцаатай	2504	0,67
6	5001-10000 ширхэг хувьцаатай	417	0,11
7	10000-50000 ширхэг хувьцаатай	900	0,24
8	50001-100000 ширхэг хувьцаатай	221	0,06
9	100001-ээс дээш ширхэг хувьцаатай	307	0,08
Хувьцаа эзэмшигчдийн тоо		**374.126**	**100,0**

[82]Судалгааны багийн гишүүдээс СЗХ-ны дэд дарга Д.Дүгэржав, СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Бум-Эрдэнэ нартай хийсэн уулзалт ярилцлага.
[83]Д.Дүгэржав. "Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн төлөвшил, тулгамдсан асуудал", "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2008 оны №4 (23) дугаар, 26 дахь тал.

	Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараа хэрхэн зарцуулсан бэ?					Total
Нас	Хариул-аагүй	Тухайн үед ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулсан.	Эцэг, эх маань зарцуулсан	Тухайн үед бусдад бэлэн мөнгөөр худалдсан	Тасалбар-уудыг хэрхэн зарцуулсанаа мэдэхгүй байна	
18-25	17	11	132	14	83	257
26-35	9	16	229	35	67	356
36-45	26	45	68	60	56	255
46-60	29	56	13	66	40	204
61-ээс дээш	7	5	1	9	6	28
Total	88	133	443	184	252	1100

Анхдагч зах зээлийн үүссэнээс хойш иргэдийн үнэт цаасны зах зээлд оролцох оролцоо харьцангуй багассан ба бага хувьцаа эзэмшигч нийт хувьцаа эзэмшигчдийн 98 гаруй хувь байна.

Судалгааны хүрээнд хот, орон нутгийн нийт 1100 иргэдээс санал асуулгын судалгаа авсан ба санал асуулгад оролцсон иргэдээс "Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараа хэрхэн зарцуулсан бэ?" гэсэн асуултад дараахь байдлаар хариулсан. Үүнд:

Санал асуулгын дүнгээс үзэхэд судалгаанд оролцсон "443" хүн "тухайн үед эцэг, эх нь зарцуулсан" гэсэн байхад "252" оролцогч "хэрхэн зарцуулснаа мэдэхгүй байна", "184" оролцогч "бэлэн мөнгөөр худалдсан" гэж хариулсан байна. Үүнээс дүгнэж үзэхэд тухайн үед буюу анхдагч үнэт цаасны зах зээлд оролцсон иргэдийн үнэт цаасны үр ашгийг төдийлөн ухамсарлаж чадаагүй байсан бөгөөд үүний дагуу үнэт цаасаар цөөнх хэсэг бүлэг хөрөнгөжих боломжийг бий болгосон гэж үзэж байна.

Мөн **"Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараараа өөртөө болон гэр бүлдээ ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж бодож байна уу?"** гэсэн асуултад дараахь байдлаар хариулт өгсөн.

	Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараараа өөртөө болон гэр бүлдээ ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж бодож байна уу?					
Нас	Хариул-аагүй	Тийм. Учир нь би одоо болтол ноогдол ашиг авч чадаж байна.	Тийм. Тухайн үедээ ашигтай байсан.	Үгүй	Мэдэх-гүй	
18-25	10	11	38	78	120	257
26-35	5	11	59	201	80	356

36-45	6	11	48	173	17	255
46-60	8	10	46	127	13	204
61-ээс дээш	0	0	5	21	2	28
	29	43	196	600	232	1100

Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараараа өөртөө болон гэр бүлдээ ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж бодож байна уу гэсэн асуултад нийт 1100 оролцогчоос "600" оролцогч "үгүй", "232" оролцогч "мэдэхгүй" гэж хариулсан байхад "196" оролцогч тухайн үедээ ашигтай байсан гэсэн. Үүнээс үзэт цаасны анхдагч зах зээлийг бий болгоход иргэдийн үзэт цаасны мэдлэгийн түвшин муу, нөгөөтэйгүүр өмч хувьчлалыг урьдчилан тооцоолсон "бэлтгэл"-гүйгээр хийснийг сөрөг үр дагавар гэж дүгнэвэл судлаачдын олонхи нь дэмжих байх.

Дээрх асуултад хариулсан иргэдийн боловсролын байдлаар нь асуултад хариулсан байдлыг нь хүснэгтлэвэл:

	Та өөрийн хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбараараа өөртөө болон гэр бүлдээ ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж бодож байна уу?					Total
Боловсрол	Хариул-аагүй	Тийм. Учир нь би одоо болтол ноогдол ашиг авч чадаж байна.	Тийм. Тухайн үедээ ашигтай байсан.	Үгүй	Мэдэхгүй	
Хариулаагүй	0	0	0	1	0	1
Дээд	11	26	111	372	140	660
Тусгай дунд, коллеж	3	7	24	74	19	127
Бүрэн дунд	12	7	44	111	62	236
Бүрэн бус дунд	2	2	13	34	10	61
Бага	1	1	2	6	0	10
Боловсролгүй	0	0	2	2	1	5
Нийт	29	43	196	600	232	1100

Судалгааны баг орон нутагт иргэдтэй уулзалт ярилцлага хийж байхад үзэт цаасны талаархи ерөнхий ойлголт[84] байдаг боловч түүний мөн чанар тэр тусмаа компанийн хувьцаа эзэмших ямар үр ашигтай, хэрхэн компанийн хувьцаа эзэмших, өмнө нь эзэмшиж байсан хувьцаагаа хэрхэн зарцуулсан талаар мэдээлэл хомс бөгөөд нөгөөд талаас орон нутгаас хөрөнгө оруулалт

[84] Дийлэнхдээ үзэт цаасыг "цэнхэр", "ягаан" тасалбараар л төсөөлж ойлгож байгаа нь түгээмэл байв.

татах, орон нутгийн иргэдийг үнэт цаасны зах зээлд оруулцуулах ажил нэлээд сул байгаа нь ажиглагдсан.

2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

"Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь .....үнэт цаас гаргагч болон .... холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан бөгөөд үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн субъект болохыг тогтоосон. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаас гаргагчийг тодорхойлоогүй боловч ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйл нь Үнэт цаас гаргагч гэсэн гарчигтай. Уг зүйлийн хүрээнд Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд /ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1/, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга /ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2/ үнэт цаас гаргагч болно.

Харин ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "үнэт цаас" гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, ..." гэсэн зохицуулалтаас үзэхэд Засгийн газар, бусад эрх бүхий этгээд, компани, хөрөнгө оруулалтын сан үнэт цаас гаргагч болно.

2.2.1. КОМПАНИ

ҮЦЗЗТХ-ийн дээрх хоёр заалтаас үзэхэд үнэт цаас гаргагч нь тодорхой бус байгаа бөгөөд эдгээр хоёр заалтад нэр томъёоны зөрчилтэй байдал байна. Өөрөөр хэлбэл, ҮЦЗЗТХ-д үнэт цаас гаргагчийн талаархи зохицуулалт нь нэр томъёоны хувьд зөрчилтэй байгааг нэг мөр болгох шаардлагатай байна.

Үнэхээр ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-т үнэт цаас гаргагч нь **Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд** Компанийн тухай хууль болон ҮЦЗЗТХ-ийн дагуу үнэт цаас гаргахаар ойлгогдож байхад ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т **компани** үнэт цаас гаргагч байхаар ойлгогдож байна. Ашгийн төлөө үйл явуулж байгаа хуулийн этгээд нь компани гэсэн ойлголтоос өргөн утгатай ойлголт билээ. Учир нь Монгол Улсын Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр зохион байгуулна гэж заасан бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээд гэдэг нь компаниас гадна нөхөрлөлийг агуулж байгаагаараа өргөн утгатай юм.

Хэдийгээр тус хуулийн "... Компанийн тухай хууль болон энэ хуулийн дагуу үнэт цаас гаргаж болно" гэсэн хязгаарлалтаас үзэхэд ҮЦЗЗТХ-д компанийн үнэт цаас гаргах зохицуулалтыг нарийвчлан зохицуулаагүй боловч "Компанийн тухай" хуулийн компанийн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргах, бүртгэх журам зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг. КТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.3-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол **хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр**

хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно." гэж зохицуулсан нь хувьцаа болон бусад үнэт цаасыг зөвхөн хувьцаат компани гаргах эрхтэй болохыг заасан.

Гэтэл нөгөө талаас хязгаарлагдмал хувьцаат компани хувьцаа эзэмшигчийн тоогоо нэмэгдэхийн хэрээр хувьцаагаа үнэт цаас болгон Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д хадгалуулах сонирхол байдаг боловч энэ талаархи эрх зүйн орчин бүрдээгүй тул ХХК нь хувьцаа гарган хадгалуулах боломжгүй байна.

Компанийн хувьд тоон үзүүлэлтээр:

ХЗДХЯ-аас 2007 онд санаачлан хэрэгжүүлсэн "Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ"-ний тайлангийн 115 дахь тал болон хавсралт /2.14/-д Үндэсний татварын ерөнхий газар /цаашид "ҮТЕГ" гэх/-аас 2007 онд тус судалгааны хүрээнд авсан мэдээллээр Монгол Улсад бүртгэлтэй компанийн тоо:

Д/д	Он	Хувьцаат компанийн тоо	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо	Нийт компанийн тоо
1	2002	394	17228	17622
2	2003	399	21563	21962
3	2004	404	26135	26539
4	2005	406	31525	31931
5	2006	413	37420	37833
6	2007 /эхний хагас жил/	417	41659	42076

Монголын Хөрөнгийн бирж /цаашид "МХБ" гэх/-ийн цахим хуудас /http://www.mse.mn/index.php/-д тус биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо 2008 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 201 байна[85].

Энэхүү байдлаас дүгнэхэд Үндэсний татварын ерөнхий газар болон Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын тоо зөрүүтэй байна. МХБ-ийн Мэдээллийн албан мэргэжилтэн 1995 онд Монгол Улсад хувьцаат компани 470 орчим, байсан болон одоогоор 386 хувьцаат компани байгаа гэж байсан[86]. Үүний 12 нь компани нь шинээр бий болсон компаниуд юм.

ҮТЕГ болон МХБ-д бүртгэлтэй байгаа хувьцаат компаниудын тоон зөрүүтэй байгаа үндсэн шалтгаан нь ҮТЕГ бүртгэлтэй ихэнхи ХК нь үйл ажиллагаа явуулдагүй байхад МХБ-д бүртгэлтэй байгаа ХК-ууд нь үнэт цаасны зах зээлд өөрсдийнхөө боломжийн хирээр оролцон үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд юм.

[85]Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудас /http://www.mse.mn/index.php/-д бүртгэлтэй хувьцаат компанийн тоо болон нэрийг хавсралт ... –аас харна уу.

[86]Судалгааны багийн гишүүд 2008 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах ажлын хүрээнд Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай танилцах уулзалт ярилцлагын тэмдэглэлээс.

Судалгааны баг аймаг дахь Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчөөр дамжуулан Орхон, Булган, Дархан-Уул аймагт нийт 9 ХК-ийн үйл ажиллагаатай танилцан, тухайн орон нутаг дахь ХК-ийн удирдлага болон эрх бүхий албан тушаалтантай нэг биечлэн уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

Орон нутагт судалгааны багийнхны хийсэн уулзалт ярилцлагаар орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХК-иудтай холбоотой дараахь хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд тулгарч байсан. Үүнд:

- ХК-иудын ихэнхи нь үйл ажиллагаа явуулдаггүй, үйл ажиллагаа явуулж буй ХК нь ашиг олдоггүй учир ногдол ашиг хуваарилдаггүй.
- Орон нутаг дахь ХК нь хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлахад ирц хангалтгүй байдаг.
- Орон нутаг дахь ХК-ийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн байдаг.
- Бага хувьцаа эзэмшигч нь тооны хувьд хэт их, хувьцааны тархалт их өргөн байдаг тул зарим үед нэг хувьцаа эзэмшигчийн төлөө ихээхэн зардал гаргах асуудал гардаг.

Иймд орон нутаг дахь ХК-ийн хувьд үйл ажиллагааг нь жигдлэх, тэдгээрийг үнэт цаасны хоёрдогч зах зээлд оролцох эрх зүйн орчинг боловсронгуй болгож, орон нутгийн иргэдийн өөрийн орон нутаг дахь ХК-ийн үнэт цаас эзэмших, түүний үр өгөөжийг ойлгуулах зэрэг олон талт арга хэмжээг авах, холбогдох зохицуулалтыг нэн тэргүүн хийх шаардлагатай байна.

2.2.2. ЗАСГИЙН ГАЗАР

ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "үнэт цаас" гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/,..." гэж заасны хүрээнд Засгийн газар нь үнэт цаасны зах зээлд өрийн бичиг /бонд/ гаргаж оролцдог субъект юм.

Засгийн газар үнэт цаас гарган хөрөнгө босгох арга нь нэлээд өргөн хэрэглэгддэг бөгөөд судалгааны хүрээнд Засгийн газрын үнэт цаас гаргах болон холбогдох бусад асуудлыг судлахыг зориогүй бөгөөд тус асуудал нь үнэт цаасны хоёрдогч зах зээлд уг утгаараа хамаарал багатай юм. Учир нь Засгийн газрын гаргасан үнэт цаас болох бонд нь хамгийн баталгаатай эргэн хүүгийн хамт төлөгддөг учир эрсдэлгүй үнэт цаасны төрөл бөгөөд тус асуудлыг Үнэт цаасны хууль тогтоомжоос бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг болно.

2.2.3. БУСАД ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД /АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА/

ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "үнэт цаас" гэж Засгийн газар болон **бусад эрх бүхий этгээдээс** гаргасан өрийн бичиг /бонд/,..." гэж заасан бөгөөд тус заалтын дагуу Засгийн газраас гадна үнэт цаас гаргах эрх бүхий этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогч субъект байхаар зохицуулсан боловч бусад **эрх бүхий этгээд** гэдэг нэр томъёо нь өөрөө маш тодорхой бус нэр томъёо юм. Харин ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2-

т "Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, аймаг, нийслэлийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр нийтэд санал болгон үнэт цаас гаргаж болно." гэснийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус хуулийн 3.1.1-т заасан бусад эрх бүхий этгээд болно.

Өөрөөр хэлбэл, ҮЦЗЗТХ-ийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр аймаг, нийслэлийн Засаг дарга нь өрийн бичиг /бонд/ гарган үнэт цаасны зах зээлд оролцдог нэгэн субъект юм.

Өнөөгийн байдлаар аймаг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас гаргасан тохиолдол тэмдэглэгдээгүй бөгөөд үүний үндсэн шалтгаан нь юуны өмнө аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрсдөө Үнэт цаасны хуулиар олгосон боломжоо ашигладаггүй байх, нөгөө талаас аймаг, нийслэлийн төсвийг улсаас санхүүжүүлээд, төсөвтэй холбоотой бүх асуудлыг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиар зохицуулдаг. Иймд аймаг, нийслэлийн засаг дарга Үнэт цаасны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Учир нь хууль хоорондын уялдаа холбоо муу байна. Орон нутгийн удирдлагыг төсөл хэрэгжүүлэхийн тул Үнэт цаас гарган хөрөнгө босгох боломжийг илүү боловсронгуй болгож, холбогдох эрх зүйн орчинг нь бүрдүүлэх шаардлагатай байна.

2.2.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т ""үнэт цаас" гэж ... хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, ..." гэж заасны дагуу хөрөнгө оруулалтын сан нь хувьцаа гарган үнэт цаасны зах зээлд оролцогч субъект болно. Хөрөнгө оруулалтын санг үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын хувьд авч үзнэ.

Судалгааны хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа гэгдэх хувьцаа өнөөдөр Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаггүй гэсэн мэдээлэл байна. Үүнийг Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа, хүн хүч, Үнэт цаасны хууль тогтоомжийн зохицуулалт хангалтгүй бөгөөд тухайн мэргэжлийн байгууллагын талаархи иргэд, аж ахуйн нэгжийн ойлголт дутмаг байгаатай холбон үзэж байна.

2.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

"Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд .... үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагчаас гадна мэргэжлийн байгууллагуудын оролцоо тус зах зээлийн үндсэн чигийг бүрдүүлдэг.

Үнэхээр үнэт цаасны зах зээл нь мэргэжлийн байгууллагын оролцоогүйгээр өөрийн онцлогийг харуулж чадахгүй юм.

Үнэт цаасны зах зээл нь хөрөнгө оруулагч үнэт цаас гаргагч нарыг хооронд зуучлагч, төрөөс тухайн зах зээлийн харилцааг зохицуулсан зохицуулагч, үнэт цаасны эрэлт, нийлүүлэлтийн уулзвар болсон зохион

байгууллалттай зах зээл /хөрөнгийн бирж/ зэрэг байгууллагууд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн байгууллагын чиг үүрэгтэйгээр оролцдог.

ҮЦЗЗТХ-ийн холбогдох заалтууд болон тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах Хөрөнгийн бирж, Дилерүүдийн арилжааны төв, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага, хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани байна" гэж заасснаас үзэхэд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд ямар ямар байгууллагууд хамаарахыг дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Хөрөнгийн бирж;
- Дилерүүдийн арилжааны төв;
- Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага;
- Үнэт цаасны хадгаламжийн байгууллага;
- Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага;
- Хөрөнгө оруулалтын сан;
- *Брокерийн компани;*
- *Дилерийн компани;*
- *Андеррайтерийн компани;*
- *Хөрөнгө оруулалтын менежментийн компани;*
- *Хөрөнгө оруулалтын зөвлөх компани.*

Нөгөө талаас үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн зохицуулагч байгууллага нь Санхүүгийн Зохицуулах Хороо юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалт, уг хуулийн тавдугаар бүлэг байх ёстой боловч хуульд орсон техникийн шинж бүхий алдаа болсон Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага гарчигтай давтагдсан дөрөвдүгээр бүлэг болон СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хууль нь СЗХ-ны үнэт цаасны зах зээлд оролцох хууль зүйн үндсийг бүрдүүлж байна.

2.3.1. ХӨРӨНГИЙН БИРЖ

Монгол Улс анх ардчилсан нийгэмд шилжин нийгмийн өмчийг бүх нийтэд тэгш хэмжээгээр хуваарилах үүднээс өмч хувьчлалыг хэрэгжүүлэх зорилгоор иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосон. Үүний хүрээнд Монгол Улсад анх удаа хөрөнгийн биржийн үйл ажиллагааны үндсийг тавьсан бөгөөд "Монголын **Хөрөнгийн биржийн** түр дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөрөнгийн биржийг байгуулан Үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн байгууллагын суурийг бий болгосон.

Улс орнуудад хөрөнгийн биржийн үүсгэн байгуулалтыг хууль зүйн үндэслэлээр нь үндсэн хоёр төрөлд хувааж үздэг.



1-рт Төрийн өмчийн бирж

Ихэвчлэн аливаа нэг хууль тогтоомжоор хөрөнгийн биржийг үүсгэн байгуулдаг бөгөөд биржийн удирдлагыг тодорхой дүрмийн хүрээнд хэрэгжүүлдэг. Эх газрын европын улсууд энэ төрлийн хөрөнгийн биржтэй байдаг.

2-рт Тусгай бирж

Тусгай биржийг тухайн биржийн гишүүд хувьцаат компанийн статустайгаар байгуулдаг. Бирж нь ашгийн төлөө бус бөгөөд үндсэндээ мэргэжлийн байгууллагын шинжтэй юм. Англи-Саксоны эрх зүйн системтэй улсуудын хөрөнгийн бирж нь энэ төрлийнх юм. Гэвч Засгийн газар нь сүүлд нь гаргасан тогтоол зэрэг эрх зүйн актаар биржид албан ёсны гэсэн тодотгол олгодог.

Нөгөө талаас холимог шинжтэй бирж байдаг. Энэ төрлийн бирж нь нэг талаасаа төрийн бирж шиг боловч нөгөө талаасаа тусгай биржийн статустай байдаг. Тухайлбал, Италийн хөрөнгийн бирж холимог шинжтэй юм. Италийн хөрөнгийн бирж хуулиар үүсгэн байгуулагдсан хирнээ удирдлагын хувьд худалдааны танхимдаа харьяалагдах хэлбэрээр мэргэжлийн байгууллагын шинжийг агуулдаг байна.

"Монголын **Хөрөнгийн биржийн** түр дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тогтоолыг 1995 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 170 дугаар тогтоолоор хүчингүй болгон тус тогтоолоор **"Монголын Хөрөнгийн бирж"**-ийг эхний шатанд төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээд байхаар өөрчлөн зохион байгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын 1995 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан Монголын хөрөнгийн биржийн түр дүрэмд "Монголын хөрөнгийн бирж нь /цаашид "бирж" гэх/ дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын үнэт цаасыг худалдан арилжих, түүнтэй холбоотой үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж мөн ба биржийн дүрмийн санг эхний шатанд Засгийн газар дангаараа бүрдүүлэх бөгөөд энэ үндсэн дээр тус бирж төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн журмаар ажиллана" гэж заасан.

Үүнээс үзэхэд 1991 онд байгуулагдсан Хөрөнгийн бирж нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн субъект бөгөөд төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээд байхаар зохицуулсан байна.

2002 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Хөрөнгийн биржийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх тухай Засгийн газрын 2003 оны 72 дугаар тогтоолоор **Хөрөнгийн биржийг** төрийн өмчит үнэт цаасны арилжаа болон хуульд заасан бусад үйл ажиллагаа эрхлэх **"Хөрөнгийн бирж"** компани, мөн харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий **"Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв"** компани болгон бүтцэд зохих өөрчлөлт оруулж, өөрчлөн зохион байгуулсан.

ҮЦЗЗТХ-ийн 22 дугаар зүйл нь Хөрөнгийн биржтэй холбоотой хуулийн суурь зохицуулалт юм. ҮЦЗЗТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжаа эрхлэн явуулах болон хуулиар хориглоогүй бусад ажил, үйлчилгээ үзүүлдэг компани байна" гэж заасны дагуу Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 72 тоот тогтоолоор Монголын Хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжаа болон хуулиар хориглоогүй бусад ажил, үйлчилгээ эрхлэх төрийн өмчит хувьцаат компанийн статустай юм.

Төрийн өмчийн хороо нь 2003 оны 299 дүгээр тогтоолоор МХБ-ийн дүрмийг баталж, 2003 оны 9 сарын 18-ны өдрийн 598 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, компани нь нэг бүрийн нэрлэсэн үнэ нь 100 /нэг зуун/ төгрөгөөр үнэлэгдсэн 18 677 088 /арван найман сая зургаан зуун далан долоон мянга наян найман/ ширхэг энгийн хувьцааныг бүрдэх 1 867 708 800 /нэг тэрбум найман зуун жаран долоон сая долоон зуун найман мянга найман зуун/ төгрөгийн эзэмшигчийн өмчтэй байхаар тогтоосон байна"[87].

ҮЦЗЗТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2.1-т "Хорооноос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 5-аас доошгүй гишүүнтэй байна. ..." гэж заасны дагуу МХБ-ийн гишүүн нь брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани байна. Гэтэл зарим улс орны хуульд Биржийн гишүүн нь хувь хүн байж болохоор зохицуулсан байдаг. Тухайлбал, БНТУ-ын Засгийн газрын 1983 оны Хөрөнгийн биржүүдийн тухай хууль адил хүчинтэй 91 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Үнэт цаастай холбоотой ажиллагааг биржид хийх зөвшөөрлийг Хөрөнгийн зах зээлийн хорооноос авсан хувь **хүн болон хуулийн этгээдүүдийг биржийн гишүүд** гэнэ" гэж заасан бөгөөд уг заалтын дагуу Хөрөнгийн биржийн гишүүн нь хувь хүн байж болно. БНТУ-ын Засгийн газрын 1983 оны Хөрөнгийн биржүүдийн тухай хууль адил хүчинтэй 91 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн дагуу Хөрөнгийн биржүүд гишүүдээс бүрдсэн ерөнхий хуралтай байх ба тус ерөнхий хурал нь биржийн шийдвэр гаргах дээд байгууллага бөгөөд ерөнхий хурлын шийдвэрийг Хөрөнгийн зах зээлийн хорооны зөвшөөрөл эсхүл энэхүү зөвшөөрөл нь хожимдсон тохиолдолд ерөнхий хурлын шийдвэрийг Хөрөнгийн зах зээлийн хороонд өргөн барьсан өдрөөс 30 хоногт хүчин төгөлдөр болно гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд БНТУ-ын хувьд Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд нь гишүүд шууд оролцох эрх зүйн үндсийг бий болгожээ.

Харин манай ҮЦЗЗТХ-ийн 21, 22 дугаар зүйлд үнэт цаасны зах зээлд оролцогч брокер, дилерийн компаниуд Хөрөнгийн биржийн гишүүн байх боловч эдгээр нь биржийн гишүүний хувьд зөвхөн үнэт цаасны арилжаанд оролцох л боломжийг бүрдүүлсэн. Гэтэл нөгөө талаас Хөрөнгийн биржийн гишүүн болох брокер, дилерийн компаниуд Хөрөнгийн биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй. Хөрөнгийн

[87] Судалгааны багийн гишүүд 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах ажлын хүрээнд "Би Ди Сек" ХК-ийн удирдлагуудтай хийсэн уулзалт ярилцлагын тэмдэглэлээс.

биржийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг Хөрөнгийн биржийн ТУЗ-өөс гаргадаг бөгөөд уг ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь Төрийн өмчийн хорооноос томилсон төрийн байгууллагын албан хаагчид байдаг. Эдгээр ТУЗ-ийн гишүүд нь тэр бүр үнэт цаасны зах зээлийн талаар нарийн мэргэшээгүй тул Хөрөнгийн биржтэй холбоотой шийдвэр нь зарим тохиолдолд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын эрх ашигт нийцэхгүй тохиолдол байна. Үүнээс үзэхэд Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс түүний удирдах дээд байгууллагад гишүүдийн оролцох эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судлах шаардлагатай байна.

Мөн нөгөө талаас ҮЦЗЗТХ-ийн 21, 22 дугаар зүйлд Хөрөнгийн бирж нь заавал төрийн өмчийн компани байхыг заагаагүй билээ. Иймд ҮЦЗЗТХ-ийн 22 дугаар зүйлд заасан 1,0 тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгө бүхий хувь нийлүүлсэн хувь хүн, хуулийн этгээд СЗХ-ноос тусгай зөвшөөрөл аван Хөрөнгийн бирж бүхий компани байгуулах эрх зүйн үндэстэй юм. Өнөөгийн байдлаар үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани нь төрийн өмчийн Монголын Хөрөнгийн бирж хувьцаат компани юм.

Монголын Хөрөнгийн биржийг олон талаас нь шүүмжилдэг бөгөөд эдгээрийн нэг нь төрийн өмчит ХК учир гишүүддээ үйлчилдэггүй, үйлчилгээний хураамж, үнэт цаасны арилжаатай холбоотой бусад асуудлыг Удирдах зөвлөл буюу гишүүдийн оролцоогүй, төрийн албан хаагч нар шийддэг зэрэг сул талтай гэж үздэг. Мөн Хөрөнгийн биржийн эрх зүйн орчин хангалтгүй байна гэж үздэг. Учир нь Хөрөнгийн бирж харьцангуй бие даасан байдлаар үнэт цаасны арилжааг эрхлэн явуулах ёстой байтал зарим тохиолдолд бие даасан байдал нь алдагдах талтай байдаг. Учир нь төрийн албан хаагчид төрийн өмчийг хамгаалах талтай шийдвэр гаргадаг. Энэ нь гишүүд болон ХК, хөрөнгө оруулагчдад сөрөг нөлөөтэй байх талтайн дээр ашиг сонирхлын зөрчил гарч болохыг үгүйсгэхгүй.

2.3.2. ДИЛЕРҮҮДИЙН АРИЛЖААНЫ ТӨВ

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "**Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь** нийтэд санал болгон гаргасан **үнэт цаасыг бүртгэх, арилжихтай холбогдсон үйл ажиллагаа эрхэлдэг компани** бөгөөд **Хөрөнгийн бирж, Дилерүүдийн арилжааны төв**ийн хэлбэрээр зохион байгуулагдана", мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Үнэт цаасны дилерүүдийн арилжааны төв /цаашид "**Дилерүүдийн арилжааны төв**" гэх/ нь үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас бүрдсэн гишүүнчлэлтэй, үнэт цаасны арилжаа эрхлэх чиг үүрэг бүхий компани байна" гэж заасан бөгөөд үүнээс үзэхэд Дилерийн арилжааны төв нь дилерийн компаниудын гишүүнчлэлээс бүрдсэн, компанийн хэлбэрээр байгуулагдсан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага байна. Дилерүүдийн арилжааны төв нь хуулийн*

дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх чиг үүрэгтэй байна. ҮЦЗЗТХ-ийн 23 дугаар зүйлд Дилерүүдийн арилжааны төвийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нь 500.0 сая төгрөгөөс, гишүүдийн тоо 5-аас доошгүй байхаар заасан байдаг. Дилерүүдийн арилжааны төвийн чиг үүрэг нь Хөрөнгийн биржийн чиг үүрэгтэй нэгэн адил байхаар ҮЦЗЗТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.8-т тодорхой заасан байдаг.

Өнөөдөр манайд Дилерүүдийн арилжааны төв гэх байгууллага үүсгэн байгуулагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, ҮЦЗЗТХ-ийн 23 дугаар зүйлд заасан Дилерүүдийн арилжааны төв гэсэн нэр бүхий компани нь албан ёсоор зохих журмын дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулаагүй болно. Үүний шалтгааныг дараахь хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлаж болох үндэслэлтэй. Үүнд:

1. ҮЦЗЗТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2-т " Хорооноос Хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, Дилерүүдийн арилжааны төвд тусгай зөвшөөрөл олгохдоо тус бүр нэг байгууллага байхаар, эсхүл хавсран гүйцэтгэхээр зохицуулж болно" гэж заасны дагуу СЗХ дилерийн компаниудын үнэт цаасны зах зээлд оролцохыг Хөрөнгийн биржээр дамжуулж болохоор зохицуулсан.

2. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авах боломжтой байгаа нь Хөрөнгийн биржид брокерын үйл ажиллагаа зонхилж, дилерийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжийг хаасан гэж үзэж байна.

*3. ҮЦЗЗТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Брокер, дилерийн компани нь **үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүн байна**" гэж заасан хирнээ тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1.-т " Хорооноос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 5-аас доошгүй гишүүнтэй байна. **Нэг гишүүн нь** Хөрөнгийн биржийн болон Дилерүүдийн арилжааны төвийн **аль нэгнийх нь гишүүн байна**" гэж заасан өөр хоорондоо зөрчилтэй байна гэж үзэж байна.*

Өнөөг хүртэл Диллерийн арилжааны төв байгуулагдаагүй бөгөөд үүний хамгийн гол үндсэн шалтгааныг Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж дахь Дилерүүдийн арилжааны төвийн зохицуулалт хангалтгүй, брокер, дилерийн компаниуд тусдаа үйл ажиллагаа явуулдаггүйтэй холбон үзэж байна.

2.3.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ БОЛОН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГА

*ҮЦЗЗТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Хорооноос Хөрөнгийн бирж, **үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага**, Дилерүүдийн арилжааны төвд тусгай зөвшөөрөл олгохдоо тус бүр нэг байгууллага байхаар, эсхүл **хавсран гүйцэтгэхээр зохиц улж болно** гэж заасны дагуу үнэт цаасны зах зээлд үнэт цаасны төлбөр тооцоо,*

хадгаламжийг өнөөдөр Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төв ХХК хариуцан хэрэгжүүлж байна. Тус ХХК нь 100 хувь төрийн өмчит ХХК бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны хяналтад ажилладаг. ҮЦТТХТ ХХК нь ХК-иудтай Үнэт цаас хадгаламжийн болон үнэт цаастай холбогдох төлбөр гүйцэтгэх гэрээний үндсэн дээр үнэт цаас хадгалж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэдэг байна.

Судалгааны хүрээнд ҮЦТТХТ өвийн мэргэжилтнүүдтэй уулзалт хийсэн бөгөөд уг төвийн эрх зүйн орчин хангалтай бус байгаа талаар дурдсан. Тухайлбал, хадгаламжийн, төлбөр тооцоо хийсэн хураамжийг СЗХ-ныхон дур мэдэн зохицуулдаг нь эргээд хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдэд сөрөг нөлөөтэй байдаг зэрэг асуудлыг хөндсөн.

Мөн биржээс гадуур эсхүл зөвшөөрөлгүй хийгдсэн үнэт цаастай холбоотой хэлцлийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгодог. Уг үнэт цаас хэд хэдэн этгээд дамжсан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх нь тодорхой бус бөгөөд хэд хэд дамжсан үнэт цаасыг хамгийн сүүлчийн эзэмшигчийн нэр дээрээс шилжүүлэх тохиолдолд тухайн этгээд хохирох зэрэг нэлээд томоохон асуудал байдаг бөгөөд эдгээрийн зохицуулалт нь хангалтгүй байна.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани үнэт цаас хадгалуулах сонирхол байдаг ч түүнийг ҮЦТТХТөв нь хадгалах эрх зүйн орчин бүрдээгүй. Мөн 1990-ээд оноос үүссэн анхдагч зах зээл дэх хувьцаа эзэмшигчдийн өв залгамжлалын харилцаанд тодорхойгүй асуудал үүсдэг байна.

2.3.4. ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА

*Үнэт цаасын зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд "**"Үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага"** /цаашид "Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага" гэх/ нь үнэт цаасны зах зээлд даатгалын болон тэтгэврийн сангаас тусгай зориулалтаар төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хэсгээр, Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Төлбөр тооцооны болон Хадгаламжийн байгууллагатай хийсэн гэрээний үндсэн дээр үнэт цаас худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг компани байна" гэж тодорхойлсон бөгөөд өнөөг хүртэл уг байгууллага байгуулагдан үйл ажиллагаа явуулаагүй байна.*

*Хамтын хөрөнгө оруулалтын байгууллагыг хуулиар зохицуулсан боловч өнөөгийн байдлаар манай улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлд **тусгайлан төвлөрүүлэн оруулсан хөрөнгө байхгүй** бөгөөд энэ нь өөрөө нэлээд эрсдэлтэй асуудал юм. Мөн хуульд хамтын хөрөнгө оруулалтын байгууллага нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн компаниар дамжуулан оролцох эсхүл өөрөө шууд оролцохоор зохицуулсан байна.*

Цаашид хамтын хөрөнгө оруулалтын байгууллагыг байгуулан иргэд болон хамтын төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны зах зээлд

оруулах боломжийг судлан, эрх зүйн орчинг нь нарийвчлан тодруулж, хөрөнгө оруулагчдын эрсдлийг тодорхой хэмжээнд хамгаалах эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

2.3.5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд "хөрөнгө оруулалтын сан /цаашид "Сан" гэх/ нь хувь нийлүүлэгчээс төвлөрүүлсэн хөрөнгөөр Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Төлбөр тооцооны болон Хадгаламжийн байгууллагатай хийсэн гэрээний үндсэн дээр үнэт цаас худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг компани байна" гэж тодорхойлсон бөгөөд өнөөг хүртэл манайд хөрөнгө оруулалтын сангийн талаархи мэдээлэл байхгүй байна. Хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг төвлөрүүлэн үнэт цаасны зах зээлд эргэлтэд оруулах зорилготой хөрөнгө оруулалтын сан өнөөг хүртэл байхгүй байгаагийн үндсэн шалтгааныг тодруулах шаардлагатай байна. Судалгааны явцад өнөөг хүртэл хөрөнгө оруулалтын сан байгуулагдаагүйн үндсэн шалтгааныг нэгдүгээрт: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зарим институтийг нийгмийн амьдралд уялдуулан хэрэгжүүлж чадаагүй бөгөөд энэ асуудал нь олон талтай юм.

Мөн хувь нийлүүлэгчдэд хөрөнгөө хамтран эрсдэл багатайгаар үнэт цаасны зах зээлд оруулах боломжийг олгох тал дээр холбогдох мэргэжлийн байгууллагууд хангалттай ажиллаж чадаагүй.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн хөгжил бүрэн гүйцэд төлөвшөөгүй байгаа бөгөөд нөгөө талаас анхдагч зах зээл дэх хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, тэдгээрийн хувьцаа, холбогдох хувьцаат компанийн үйл ажиллагаа жигд бус зэрэг олон асуудал шийдэгдээгүй байгаа нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг дахин төвлөрүүлэх сонирхол хаа хаанаа байхгүй бололтой гэж үзэж байна.

Цаашид үнэт цаасны анхдагч зах зээл дэх хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, хувьцаа зэрэг олон асуудлыг цэгцлэхийн тулд зохицуулах хорооноос хугацаатай арга хэмжээ зохион байгуулж, хувьцаа эзэмшигч нь тодорхойгүй байгаа хувьцааг нийлүүлэн хөрөнгө оруулалтын сан бий болгох боломжтой бөгөөд энэ мэтээр хуулийн институтийг амьдралд хэрэгжүүлэх боломжийг цаашид судлах шаардлагатай байна.

2.3.6. БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИ

"Монголын **Хөрөнгийн биржийн** түр дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөрөнгийн биржийг байгуулан Үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн байгууллагын суурийг бий болгож байсан. Мөн өмч хувьчлалтай холбогдуулан иргэдийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээрээ Хөрөнгийн биржээс хувьцаа авахад нь зуучлах, зөвлөгөө өгөх үүрэг бүхий **брокерийн пүүсүүдийг** байгуулсан.



Брокер гэдгийг олон улсын хүрээнд тааваар, валютын бирж дээр зуучлагчийн үүрэг гүйцэтгэж буй фирм болон бусад этгээд хэмээн ойлгодог. Брокер нь үйлчлүүлэгчийн даалгавраар үнэт цаас, бараа, даатгалыг гэрээг худалдах худалдан авах үйл ажиллагаа явуулна.

Дилер гэдэг бол валют, үнэт цаас, үнэт метал зэргийг дамжуулан худалдах үйл ажиллагааг эрхэлж буй бие хүн, хуулийн этгээд байна.

Монгол Улсад 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд брокер, диллер зах зээл дээр ямар үйл ажиллагаа явуулах талаар дараахь байдлаар заасан:

*3.1.10. **"брокерийн үйл ажиллагаа"** гэж үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг;*

*3.1.11. **"дилерийн үйл ажиллагаа"** гэж үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг;*

Хуульд зааснаар брокерийн ажиллагааны гол онцлог нь зуучлалын үндсэн дээр зах зээл дээр үнэт цаасыг арилжих үйл ажиллагаа явуулах явдал байна. Өөрөөр хэлбэл захиалагчийн даалгавраар түүний хүсэл зоригийн үндсэн дээр брокер үйл ажиллагаа явуулна гэсэн үг. Брокер үйл ажиллагааныхаа ашгийг зуучлалын хөлсийн журмаар хүртэнэ.

Харин дилер бол өөрөө ашиг олох зорилгоор хэн нэгний үнэт цаасыг зуучлан борлуулах бус өөрөө худалдан авч түүнийгээ зах зээлд борлуулах үйл ажиллагаа явуулна.

Мөн брокер, дилерийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан "**Брокер, дилерийн үйл ажиллагааны журам**"-аар давхар зохицуулж байна.

Үнэт цаасны зах зээлд дээрх хоёр субьект нь мэргэжлийн байгууллага хэлбэрээр оролцох боломжтой.

Эдгээр нь үнэт цаасны зах зээлд оролцохдоо дараахь чиг үүргээтэй:

- Үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу гаргаж тогтоосон хугацаанд Хороонд хүргэх;
- Бүртгэлийн, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны болон хадгаламжийн, гишүүний болон суудлын хураамж, бусад холбогдох үйлчилгээний хураамжийг тогтоож мөрдөх;
- Хууль тогтоомжийн хүрээнд Хорооны зөвшөөрснөөр өөрийн үйл ажиллагаанд баримтлах журам, заавар гарган мөрдөх;
- Өөрийн гишүүн болон үнэт цаас гаргагч, бусад оролцогч этгээд хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Хороонд хүргэх, тухай бүр олон нийтэд мэдээлэх;
- Хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргэх, жилийн эцсийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтэлж,

хөрөнгө оруулагчид мэдээлэх;

- *Дотоод мэдээлэл эзэмшигчийн бүртгэл хөтөлж, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;*
- *Үнэт цаастай холбогдсон үнэн зөв мэдээллийг сонирхогч этгээдэд шуурхай өгөх;*
- *Үнэт цаасны арилжаа, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон гүйлгээг шударга, ил тод, шуурхай хийж гүйцэтгэх;*
- *Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, Хороонд оруулах;*
- *Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн нийтлэг эрх ашгийг хамгаалах;*
- *Болзошгүй эрсдлээс хамгаалах сантай байх. Сангийн эх үүсвэр нь хувь нийлүүлэгчийн хөрөнгө болон үйл ажиллагааны ашиг байна.*
- *Энэ хуулийн 19.1-д заасан этгээд нь даатгуулах замаар эрсдлээс хамгаалах арга хэмжээ авч болно.*

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын үнэт цаасны зах зээлд хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг буюу нийт хөрөнгийн зах зээлийн 60-70 хувийг дангаар эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа **гэж үздэг** "Би Ди Сек" ХХК-ийн удирдлагуудтай уулзалт хийсэн болно. Энэ уулзалтаас харахад үнэт цаасны зах зээлд оролцогч брокер, дилерийн компаниудын өмнө тулгарч байгаа гол асуудалд:

1. Үнэт цаас эзэмшигчдийн үнэт цаасны үр нөлөөний талаархи мэдлэг тааруу, ногдол ашиг авдаг гэсэн ерөнхий ойлголтой байдаг.

2. Брокер, дилерийн компаниудын үйл ажиллагаа нь ил тод бус, ийм төрлийн компаниуд үнэт цаас эзэмшигчдийн талаархи мэдээллийг хаанаас авах нь тодорхой бус байдаг.

3. Шүүх, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагаас брокер дилерийн компаниас явуулсан арилжаа, хэлцэл зэргийг буцаах явдал их байдаг нь ийм компанид үнэт цаас эзэмшигчид итгэх явдал сул болсон.

Улмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан брокер, дилерийн компаниудын хэрэгжүүлэх чиг үүргээс огт хэрэгждэггүй заалтууд цөөнгүй байгаа нь судалгааны явцад харагдлаа. Үүнд:

- Өөрийн гишүүн болон үнэт цаас гаргагч, бусад оролцогч этгээд хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Хороонд хүргэх, тухай бүр олон нийтэд мэдээлэх чиг үүрэг – яг өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд хууль тогтоомжийн чухам ямар заалтыг зөрчиж байгаа талаархи мэдээллээ Хороонд бүрэн хүргэдэггүй, энэ талаар олон нийтэд мэдээлэх тэрхүү чиг үүрэг нь үндсэндээ орхигдсон.
- *Дотоод мэдээлэл эзэмшигчийн бүртгэл хөтөлж, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэг – брокер, дилерийн компаниуд дотоод мэдээлэл эзэмшигчийн бүртгэлийг тэр бүр тодорхой үнэн зөв хөтөлдөггүй, хяналт тавих чиг үүрэг нь мөн л хэрэгждэггүй байна.*

- *Үнэт цаастай холбогдсон үнэн зөв мэдээллийг сонирхогч этгээдэд шуурхай өгөх – жирийн иргэд төдийгүй үнэт цаас эзэмшигч нар ч үнэт цаастай холбоотой мэдээллээр тэр бүр хангагдаж чадахгүй байна. Улмаар тэд брокер, дилерийн компаниудыг хадгаламж зээлийн хоршоотой адил мэтээр үзэх явдал цөөнгүй байдаг бөгөөд үүний улмаас ч ийм төрлийн компаниуд зах зээлд төдийлөн тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.*
- *Үнэт цаасны арилжаа, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдсон гүйлгээг шударга, ил тод, шуурхай хийж гүйцэтгэх – энэ үүргийн хувьд шударга, ил тод гэдгийг хэрхэн ойлгох нь эргэлзээтэй байна.*
- *Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг боловсронгүй болгох асуудлаар санал боловсруулж, Хороонд оруулах-энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг брокер, дилерийн компаниуд байхгүй гэж хэлж болно.*
- *Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн нийтлэг эрх ашгийг хамгаалах – сүүлийн үед брокер, дилерийн компаниудтай холбоотой өргөдөл, гомдол ихэссэн бөгөөд энэ нь тэд үнэт цаас гаргагчийн нийтлэг эрх ашгийг хамгаалах тал дээр ихээхэн сул байж гагцхүү ашиг олох субьект болж хувирсан.*
- *Болзошгүй эрсдлээс хамгаалах сантай байх. Сангийн эх үүсвэр нь хувь нийлүүлэгчийн хөрөнгө болон үйл ажиллагааны ашиг байна – энэхүү эрсдлийн сан брокер, дилерийн компаниудад байгаа эсэх нь эргэлзээтэй байна.*

Монголын Хөрөнгийн биржийн гишүүдийн бүртгэлээс харахад өдгөө Монгол Улсад брокер, дилерийн үйл ажиллагааг хавсран эрхэлж байгаа нийт 39 компани байна.[83] *Эдгээр компаниас өнөөдөр зах зээлд хамгийн идэвхитэй буюу брокер дилерийн үйл ажиллагааны 70 гаруй хувийг дангаар явуулж байгаа компани нь "Би Ди Сек" ХХК байна*[84]*. Дээрх 39 компаниас андеррайтерийн үйл ажиллагааг давхар эрхэлдэг 13 компани байна.*

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа брокер, дилерийн компаниудын санхүүгийн үзүүлэлт, танилцуулгыг хавсралтаар хүснэгтээр үзүүлэв. Брокер, дилерийн компаниудын нийтлэг гаргаж буй зөрчил нь бусдын хувьцааг зөвшөөрөлгүй авч борлуулдаг явдал юм. Жишээ нь, "Мөнхөд" хэмээх брокер, дилерийн компанитай холбоотой үнэт цаас эзэмшигчийн 134 өргөдөл ирсэн бөгөөд бүх өргөдлийн гол агуулга нь хувьцааг зөвшөөрөлгүй зарсан, хувьцааг эргүүлэн байршуулж мөнгөө авах гэсэн утгатай байлаа. Үүнээс нэг зүйл ажиглагдаж байгаа нь зөвхөн нэг компани дээр ижил агуулгатай ийм олон өргөдөл ирсэн нь ийм төрлийн компанид тавих хяналт хичнээн сул байгааг харуулж байна. Улмаар ийм зөрчил гарсан нь өнгөц дүгнэвэл брокерийн буруутай үйл ажиллагаа мэт боловч өнөөдөр манайд хуульдаа брокер дилерийн үйл ажиллагааг нэг мэтээр тодорхойлсноос дилер ийм хууль бус үйл ажиллагааг ашиглах боломжтой байгаа юм. Өөрөөр хэлбэл, Үнэт цаасны зах зээлийн тухай

[83] М.А.Баскакова. "Толковый юридический словарь бизнесмена" М., 1994, стр 58, 116.
[84] Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. 2002 он. 19.1.2 дахь хэсэг.

хуулийн 3.1.10, 3.1.11 дэх хэсэгт брокер дилер нь хоёр өөр үйл ажиллагаа явуулахаар томьёолсон ч энэ хуульд мөн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50.0 сая төгрөгөөс доошгүй байна. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ гэж заасан. Яг энэ заалтаас харвал брокер, дилерийн үйл ажиллагааг эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь уг үйл ажиллагааг хавсран эрхэлж байгаа бус мэт харагдаж байгаа юм.

Брокер бол цэвэр төлөөллийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг гэж үзэж болно. Харин дилерийн харилцаанд төлөөлөл харьцангуй бага. Иргэний хуулийн 62.1 дэх хэсэгт "Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно", 62.3 дахь хэсэгт "Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ" гэж заасан. Үнэт цаас эзэмшигч брокертой харилцана гэдэг бол түүгээр төлөөлүүлэн хөрөнгийн зах зээлд орж байна гэсэн үг. Үнэт цаас эзэмшигчийн брокертой байгуулсан зуучлалын гэрээ нь брокер, үнэт цаас эзэмшигч хооронд төлөөллийн харилцаа биш болж буйг илтгэж байгаа билээ. Иргэний хуулийн 63.2 дахь хэсэгт "Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно" гэж заасан. Өнөөдөр хуулийн энэ зүйл, заалт төлөөлүүлэгчид биш харин дилерт үүсээд байна. ***Брокер дилерийн компанийн үйл ажиллагааны зааг ялгаа тодорхой бус байгаагаас брокероор дамжуулан дилер ашиг олж байгаа юм.*** *Өөрөөр хэлбэл, дилер хөрөнгийн зах зээлд өөрийн хөрөнгөөр оролцох бус харин брокероор дамжуулан оролцох явдал цөөнгүй байна. Энд дилерийн төлөөлөгч нь брокер мэтээр харагдаж байгаа юм. Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаанд гарсан зөрчлөөс үзэхэд дийлэнхи нь брокерийн хууль бус үйл ажиллагаанаас гарсан буюу бусдын үнэт цаасыг зөвшөөрөлгүйгээр хөрөнгийн зах зээлд арилжсан зөрчил байгаа. Зөрчлийг шийдвэрлэсэн байдал нь дилерээс тусгаар байдлаар авч үзсэн байгаа. Гэтэл энэ зөрчлийн улмаас бий болсон тэрхүү хөрөнгийг дилер ашиглах, хөрөнгийн зах зээлд дилер өөрөө бие даан оролцох бус брокероор дамжуулан оролцох явдал бага бус байна.*

Брокерийн хууль зөрчсөн үйл ажиллагааг Иргэний хуулийн 68.1 дэх хэсгийн зохицуулалтаар зохицуулж байгаа. Өөрөөр хэлбэл, брокерийн бусад этгээдтэй хийсэн хэлцлийг төлөөлүүлэгч зөвшөөрөхгүй бол хүчин төгөлдөр бусад тооцож байгаа. Гэтэл үүний дүнд бий болсон үр шимийг нь хүртсэн дилерт ямар хариуцлага яаж тооцох вэ?

Мөн брокерийн харилцаанд Иргэний хуулийн 65 дугаар зүйлд заасан төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх гэсэн асуудал орхигдсон байна.

Бусдын хувьцааг зөвшөөрөлгүй зарна гэдэг бусдын өмчийг, өмчийн эрхийг зөрчиж байна гэсэн үг. Гэтэл ийм үйлдлийг удаа дараа гаргасан

байхад үйл ажиллагааг нь хэвээр явуулж байгаа нь хэтэрхий учир дутагдалтай юм. Үнэндээ брокер дилерийн компани гэдэг бол үнэт цаасны зах зээл дээрхи банк гэж ойлгож болох юм. Яг үүнээс харвал брокер, дилерийн компани Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан үүргээ огт биелүүлдэггүй гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, харилцагчийн дэлгэрэнгүй бүртгэл нь хангалттүй, харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг зөвхөн тэдний захиалга, зөвшөөрлөөр арилжаанд оруулах чиг үүргээ хангалттүй хэрэгжүүлдэг буюу хуулийн энэ заалтыг эсрэгээр нь хэрэгжүүлэх явдал цөөнгүй гардаг. Жишээ нь, харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг тэдний **захиалгагүй, зөвшөөрөлгүйгээр** арилжаанд оруулдаг болоод байна. Мөн үнэт цаасыг худалдах, худалдан авахдаа харилцагчийн захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлэх; захиалгыг биелүүлэх явцад харилцагч болон брокер, дилер, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай харилцагчид нэн даруй мэдэгдэх гэсэн чиг үүрэг өнөөдөр бол тунхаг шинжтэй байна.

Хуульд мөн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50.0 сая төгрөгөөс доошгүй байна. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ гэж заасан.

Гэтэл брокер, дилерийн үйл ажиллагаа нь хоёр өөр төрлийн ажиллагаа. Дээрээс нь андеррайтерийн үйл ажиллагаа нь мөн өөр төрлийнх байдаг. Хуульд зааснаар бол ийм төрлийн компанийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 50 сая төгрөг байхаар байна. Энэ нь зөвхөн брокерийн үйл ажиллагаа явуулах компанийн дүрмийн сангийн хөрөнгийн доод хэмжээ юу, эсхүл брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагааг хавсран явуулах компанийн дүрмийн сангийн доод хэмжээ юу?

Хуульд "Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ" гэж заасан ч энэ заалтын "...хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ" *гэдгийг хэрхэн ойлгох нь хэн хэрхэн тайлбарлахаас хамааралтай болжээ.*

Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт "Хороо брокер, дилерүүдийн мэргэжил, мэргэшлийн түвшин тогтоох болон аттестатчилах журам батлан мөрдүүлнэ" гэж заасан. Өнөөдөр энэ журам үйлчилж байгаа ч хэрэгжилт байхгүй байна. Өөрөөр хэлбэл брокер, дилерүүдийн мэргэшлийн түвшинг хэрхэн тогтоож байгаа нь ил тод бус байгаагаас энэ төрлийн ажиллагаа зах зээлд идэвхитэй бус, үнэт

цаас эзэмшигч нарын дунд нэр хүнд нь доогуур байгаа талаар мэдээлэл тодорхой бус байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд брокер, дилерийн компанийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авах талаар нэг ч заалт байхгүй байна. Зөвхөн нэг компани ижил зөрчлийг 134 удаа гаргасан байхад яагаад үйл ажиллагаагаа хэвээр явуулж байна вэ? Өөрөөр хэлбэл тэдэнтэй тооцох хариуцлагын тогтолцоо байхгүй байна.

2.3.7. АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.12.-т "андеррайтерийн үйл ажиллагаа" гэж үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу гаргаж буй үнэт цаасны тухай танилцуулга бэлтгэх, шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасыг бүгдийг буюу түүний тодорхой хэсгийг худалдан авах, худалдах, эсхүл үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг нь нийтэд санал болгон арилжих ажиллагаа юм гэжээ.

Андеррайтерын үйл ажиллагаа нь брокер дилерийн үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээтэй нь харагдаж байна. Хуулийн 28 дугаар зүйлд энэ төрлийн компанийн талаар заажээ. "Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 200.0 сая төгрөг, үүнээс мөнгөн болон түүнтэй борлогдох эргэлтийн хөрөнгө нь 100.0 сая төгрөгөөс доошгүй байна. Андеррайтерийн компани нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна үнэт цаас гаргаж нийтэд санал болгох тухай танилцуулгад тусгасан болон түүнд хавсаргасан баримт, мэдээллийн үнэн зөв эсэхийг хянаж, мэдээлэл буруу байсныг илрүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцах үүрэгтэй."

Өнөөдөр манай улсад андеррайтерын үйл ажиллагааг дагнан эрхэлдэг компани байхгүй байна. Брокер, дилерийн компаниуд энэ үйл ажиллагааг хавсран эрхэлж байна. Хавсран эрхэлж байгаа 15 компани байна.

Эдгээр 15 компаниас андеррайтерын үйл ажиллагааг төдийлөн идэвхтэй явуулахгүй байна. Ийм үйл ажиллагаа явуулахад доод тал нь 300 сая төгрөгтэй байх шаардлагатай байна. Гэтэл хавсран эрхэлж байгаа компанийн хувьд энэ хөрөнгийг хэрхэн тооцох вэ? Өөрөөр хэлбэл, брокер дилерийн компанийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 50 сая төгрөг байхаар хуульд заасан. Ийм компани хавсран эрхлэх бол 50 сая төгрөг дээр +200 сая +100 сая төгрөг байх уу? Эсхүл 50 сая+250 сая төгрөг байх уу? гэдэг нь тодорхой бус байна.

Улмаар андеррайтерын зөвшөөрлийг дан ганц хөрөнгийн хэмжээг харгалзаж бус мэргэшлийн түвшин, зах зээл дэх тухайн компанийн нэр хүнд зэргийг харгалзаж олгох нь зүйтэй юм.

2.3.8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Үнэт цаасны хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид "Хөрөнгө оруулалтын менежментийн компани" гэх/ нь таваас дээшгүй Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сантай гэрээ байгуулан хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг компани байна" гэж тодорхойлсон бөгөөд өнөөг хүртэл Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байхгүй бөгөөд энэхүү байдал нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үнэт цаасны зах зээлд хуулиар зуучлах үүрэг бүхий хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон сан байгуулагдан үйл ажиллагаа явуулаагүйтэй шууд холбоотой юм. Нөгөө талаас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т "Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үнэт цаасны зах зээлд энэ хуульд зааснаас өөр төрлийн ажил, үйлчилгээ эрхлэх, Сангийн хөрөнгийг ашиглан менежментийн гэрээнд заасан үйлчилгээний хураамж, шимтгэлээс бусад орлого олохыг хориглоно" гэж заасан бөгөөд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл өнөөдрийн манай үнэт цаасны зах зээлд хангалттай байгаа төлөв байдал харагдаж байна. Нөгөө талаас хөрөнгө оруулалтын менежментийн компанийн орлого нэлээд хязгаарлагдмал зохицуулалтай бөгөөд тус компани нь хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон санг үнэт цаасны зах зээлд оролцоход нь зуучлах үүрэгтэй байна.

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийг хөгжүүлэх асуудлыг нарийвчлан судалж эрх зүйн орчинг нь илүү боловсронгуй болгох шаардлага үнэт цаасны хоёрдогч зах зээлийн хөгжилд гарах байх гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх зүйн орчинг эргэн харж хуульд байгаа хэрэгждэггүй заалтыг хэрэгжүүлэх боломжийг судлан хөгжүүлэх шаардлагатай байна.

2.3.9. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т "Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани /цаашид "Хөрөнгө оруулалтын компани" гэх/ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас нийтийн хүртээл болгохоор заасан мэдээллийг цуглуулж, судалгаа, дүгнэлт хийх, хөрөнгө оруулагчид зөвлөлгөө өгөх үйл ажиллагаа эрхэлнэ" гэж заасан бөгөөд үүнээс үзэхэд хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн талаар зөвлөгөө өгөх, захиалгаар судалгаа хийж дүн шинжилгээ өгөх зэрэг ажлыг төлбөртэйгөөр хийж гүйцэтгэх үйл ажиллагааг эрхлэх эрхтэй байна.

Одоогийн байдлаар Хөрөнгө оруулалтын зөвлөх 3 компани Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлөө авч үйл ажиллагаа эрхэлж байна.

2.3.10. ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА БУЮУ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Өмнө нь Үнэт цаасны хороо нэртэйгээр үйл ажиллагаа явуулж 2005 оноос Санхүүгийн зохицуулах хороо нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд анхаарах хэд хэдэн зүйл байна хэмээн үзлээ. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "...санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах...зарчмыг удирдлага болгоно" гэж заасан. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал гэдгийг хэрхэн ойлгох, энэ байдлыг тус хороо дангаар хангаж чадах эсэх нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл энэ нь дан ганц Хорооны үйл ажиллагаанаас хамаарах зүйл биш.

Хуулийн 9 дүгээр зүйлд Хороо ажлаа тайлагнах талаар заасан. Хороо ажлаа тайлагнахдаа зөвхөн хуулийн хэрэгжилт, түүнчлэн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар УИХ-д тайлагнана гэж заасан. Гэтэл энэ байгууллагын нэг гол үүрэг нь хуулийг хэрэгжүүлэх төдийгүй түүнд хяналт тавих явдал билээ. Энэ талаар УИХ-д тайлагнахгүй байхаар хуульд заасан байна.

Хуулийн 10 дугаар зүйлд заасан санамж бичиг нь эрх зүйн акт мөн эсэх, түүний хэрэгжилтийг хэрхэн тооцох талаар хуульд заагаагүй байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь хэсэгт хорооны санхүүжилтын эх үүсвэрийг заахдаа "хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого" гэжээ. Ямар үйл ажиллагааг ямар төлбөртэйгээр явуулаад яаж олсон орлогыг энд тооцох вэ гэдэг нь тодорхой бус байна. Санхүүгийн зохицуулах хороо бол төрийн байгууллага. Төрийн байгууллага хоёр хэлбэрээр санхүүжих боломжтой байдаг:

1.улсын төсвөөс;

2.төвлөрүүлсэн зохицуулалтын дагуу олсон үйлчилгээний хөлс.

Гэтэл санхүүгийн зохицуулах хороо энэхүү хоёр эх үүсвэрээс гадна мөн ашгийн төлөө арилжааны үйл ажиллагаа явуулж өөрийгөө санхүүжүүлэх боломжтой мэт харагдаж байна.

Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг ойлгомжгүй байна. Энд "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүн бол Хороо тухайн нэгдэлд багтах аль ч этгээдийн, эсхүл уг нэгдлийн санхүүгийн тайланг шаардаж болно" гэжээ. "...компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүн бол..." гэдгийг хэрхэн ойлгох вэ? Компанийн нэгдэл гэж юу болох, Хороо чухам ямар нэгдлийн тайланг шалгах гэж байгаа нь тодорхой бус байна. Улмаар хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг зөрчилдөж байна. 28 дугаар зүйлийн 28.2-т "Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг УИХ батална" гэсэн бол 31 дүгээр зүйлийн 31.1-т "Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг энэ хуулийн 28.2-т заасан журмаар тогтооно" гэж заасан байна.



Мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заажээ. Чухам хэн ямар зөрчил гаргасан тохиолдолд ямар төрлийн хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байна. Аль ч байгууллагын хувьд хараат бус, бие даасан байдал чухал байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны хараат бус бие даасан байдал хэрхэн хангагдсан бэ?

СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус хорооны бие даасан хараат бус байдлыг дараахь байдлаар заасан:

- Бие даасан;
- Ил тод байх;
- Бусдын нөлөөнд үл автах;
- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- Нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

Гэтэл эдгээр зарчим хэрхэн хэрэгжиж байгаа нь эргэлзээтэй байна. Тус хороо бие даасан хараат бус, ил тод, бусдын нөлөөнд үл автах анхдагч нөхцөл нь түүний өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэрээс нь хамаардаг. Хуульд тус байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрийг:

- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс;
- Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого гэж заажээ.

Эдгээр эх үүсвэрээс тус хороог шууд буюу ямар нэг дамжлага дамжихгүйгээр санхүүжүүлэх эх үүсвэр нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого байгаа юм. Үүнээс үзвэл хороо ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж өөрийгөө санхүүжүүлж болохоор байна. Гэтэл ямар хуульд зааснаар ямар үйл ажиллагаанаас хэдий хэмжээний орлого олох, тэр нь хорооны санхүүжилтийн хэдэн хувийг эзлэх нь тодорхой бус байгаа. Өөрөөр хэлбэл, хуулийн энэ заалт хэрэгжих нөхцөл бүрдээгүй.

Нөгөө эх үүсвэр болох тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс хороонд шууд төвлөрдөггүй. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу энэ төрлийн орлого нь улсын төсөвт төвлөрч дараа нь хуваарилалтын зарчмаар Хороонд очиж байгаа нь түүний бие даасан байдлыг хангаж чадахгүй байна. Учир нь Хороо нэгэнт бие даасан байх зарчимтай бол үйл ажиллагааны хувьд ч тэр, санхүүжилтийн хувьд хэнээс ч хараат бус байх ёстой. Энэ байдлаас харвал хуульд заасан улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс нь томьёоллын хувьд хуульд хоёр өөрөөр тодорхойлогдсон ч агуулгын хувьд ялгаагүй болж байна.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зарчим нь бусад нөлөөнд үл автах гэсэн зарчимтай нэн холбоотой байна. Санхүүгийн

зах зээлийн тогтвортой байдлыг хангахын тулд Хорооны үйл ажиллагаа мэргэжлийн, бусдын нөлөөнд автах нөхцлийг бүрдүүлээгүй байх ёстой. Өнөөдөр манай улсад санхүүгийн зах зээл тогтвортой байж чадахгүй байна. Энэ нь юунаас хамааралтай вэ?

Юуны өмнө үүнийг Хороонд хамааран ажиллаж байгаа ажилтнуудтай холбох нь зүйтэй. Гэтэл хөдөө орон нутагт төлөөлөгч гэсэн этгээд ажилладаг, энэ нь санхүүгийн чиглэлээр тэр бүр мэргэшиж чадаагүй, бие даасан бус, орон нутгийн тамгын газрын ажилтан хавсран гүйцэтгэх зэргээр орон нутагт санхүүгийн зах зээлд орж байгаа хуулийн этгээдүүдийн тайлан авах төдий үйл ажиллагаа явуулж байна.

Үүнээс үзвэл хөдөө орон нутагт санхүүгийн зах зээл төлөвших тогтворжих бололцоо тэр бүр харагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, Хорооны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зарчим улс орныг бүрэн хамарч үйлчилж чадахгүй байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Манай улсад 1990 оноос эхлэн үнэт цаасны зах зээлийн үндэс тавигдсан гэж үзэх үндэстэй. 1991 онд БНМАУ-ын Бага Хурлаас Өмч хувьчлах тухай хууль батлан гаргаж хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг /цаашид "эрхийн бичиг" гэх/-ийг энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдөр болон түүнээс өмнө төрсөн Монгол Улсын иргэн нэг удаа авах эрхтэй" гэж заасныг үндэслэн БНМАУ-ын иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосон байдаг. Иргэн бүрт хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгосон нь төрийн өмчийн тодорхой хэсгийг иргэдэд ижил хэмжээгээр өмчлөх эрх олгож, иргэдийг хувийн өмчтэй болгож зах зээлийн тогтолцоог хөгжүүлж, өмч хувьчлах үндсэн аргыг ашиглажээ.

Өмч хувьчлалын дараагаар үнэт цаасны зах зээлийн хууль зүйн үндсийг бий болгох үүднээс 1994 оны 10 дугаар сарын 13-ны өдөр УИХ "Үнэт цаасны тухай" Монгол Улсын хуулийг батлан гаргаж улмаар "Үнэт цаасны тухай" хуулийг хүчингүй болгон үнэт цаасны зах зээлийн харилцааг "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулиар зохицуулахаар шинээр батлан гаргасан. Уг хуульд үнэт цаасны зах зээлд оролцогч субъектуудыг тодорхойлж, тус зах зээлд оролцогчдын эрх, үүргийг зохицуулсан байна. Хэдийгээр үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн хэдий ч түүний хэрэгжилт аль ч шатанд тааруу, үнэт цаасны талаархи иргэдийн ойлголт, мэдлэг сул, үүний улмаас эрх зөрчигдөх нь их, зөрчигдсөн эрхээ хамгаалах нь бага байна.

Одоо үйлчилж байгаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг судлах явцад зарим нэг анхаарах зүйл байна гэж үзлээ. Үнэт цаасны зах зээлд мэдээлэл бол хамгийн чухал зүйл. ҮЦЗЗТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй" гэж заасан бөгөөд СЗХ-ны 2007

оны 206 дугаар тогтоолоор "Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам"-ыг баталсан. Уг журмын 2 дугаар зүйлийн 2.2-т " Мэдээллийн санд дор дурдсан иргэн, хуулийн этгээд мэдээлэл ирүүлнэ":

2.1.1. үнэт цаасны арилжаа эрхэлж буй байгууллага;

2.1.2. үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй

байгууллага;

2.1.3. брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;

2.1.4. андеррайтерийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага;

2.1.5. үнэт цаас гаргагч;

2.1.6. хууль тогтоомж, дүрэм журамд заасан бол холбогдох иргэн, хуулийн этгээд гэж заасан бөгөөд эдгээр этгээд тодорхой уг журмыг холбогдох заалтад заасан мэдээллийг тодорхой хугацаанд СЗХ-нд ирүүлэх үүрэгтэй. Харин журмын 4 дүгээр зүйлд "**Мэдээллийн сан дахь мэдээллийг ашиглах, мэдээллийг олон нийтэд мэдээллэх"** асуудлыг нэг бүрчлэн зохицуулсан боловч энэхүү зохицуулалт нь **хангалтай бус байна**. Учир нь журмын 4.1-т "Мэдээллийн сан дахь мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн нээлттэй байдлыг бий болгох, олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, эрдэм, шинжилгээ, судалгаа хийх боломжийг бүрдүүлэх, зохицуулах байгууллагын хяналтын чиг үүргийг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ашиглана" гэж заасан боловч өнөөгийн үнэт цаасны зах зээлд тус заалт нь зорилгодоо хүрч, амьдралд хэрэгжиж чадахгүй байна.

ҮЦЗЗТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т үнэт цаас гаргагч холбогдох мэдээллийг хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй гэсэн боловч тухайн үүргийг хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус байгаа билээ.

Иймд дээрх хууль журмын зохицуулалтыг дараахь байдлаар боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

- Үнэт цаастай холбоотой мэдээллийг хөрөнгө оруулагчдад нэгэн зэрэг хүргэх боломжийг бүрдүүлэх;
- Холбогдох мэдээллийг тодорхой цаг хугацаанд мэдээлдэг байдал хэвшсэн байх;
- Аливаа нэг хэсэгт этгээдэд мэдээллийг урьдчилан мэдээлэх асуудлыг хориглосон байх;
- Мэдээллийн утга, агуулга тодорхой, бодитой байх;
- Мэдээлэх хэрэгсэл, аргыг нарийвчилан журамлах.

"Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь .....үнэт цаас гаргагч болон .... холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан бөгөөд үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн субъект болохыг тогтоосон. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаас гаргагчийг тодорхойлоогүй боловч ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйл нь Үнэт цаас гаргагч гэсэн гарчигтай. Уг

зүйлийн хүрээнд Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд /ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1/, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга /ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2/ үнэт цаас гаргагч болж байна. Гэтэл үнэт цаас гаргагчийн эрх зүйн орчин тодийлөн сайн бүрдэж чадаагүй байна.

ҮЦЗЗТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-т үнэт цаас гаргагч нь **Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд** Компанийн тухай хууль болон ҮЦЗЗТХ-ийн дагуу үнэт цаас гаргахаар ойлгогдож байхад ҮЦЗЗТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т **компани** үнэт цаас гаргагч байхаар ойлгогдож байна. Ашгийн төлөө үйл явуулж байгаа хуулийн этгээд нь компани гэсэн ойлголтоос өргөн утгатай ойлголт билээ. Учир нь Монгол Улсын Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр зохион байгуулна гэж заасан бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээд гэдэг нь компаниас гадна нөхөрлөлийг агуулж байгаагаараа өргөн утгатай юм.

Хэдийгээр тус хуульд "... Компанийн тухай хууль болон энэ хуулийн дагуу үнэт цаас гаргаж болно" гэсэн хязгаарлалтаас үзэхэд ҮЦЗЗТХ-д компанийн үнэт цаас гаргах зохицуулалтыг нарийвчлан зохицуулаагүй боловч "Компанийн тухай" хуулийн компанийн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргах, бүртгэх журам зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг. Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол **хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно**." гэж зохицуулсан нь хувьцаа болон бусад үнэт цаасыг зөвхөн хувьцаат компани гаргах эрхтэй болохыг заасан.

Гэтэл нөгөө талаас хязгаарлагдмал хариуцлагатай компани хувьцаа эзэмшигчийн тоогоо нэмэгдэхийн хэрээр хувьцаагаа үнэт цаас болгон Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д хадгалуулах сонирхол байдаг боловч энэ талаархи эрх зүйн орчин бүрдээгүй тул ХХК нь хувьцаа гарган хадгалуулах боломжгүй байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50.0 сая төгрөгөөс доошгүй байна. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ гэж заасан.

Гэтэл брокер, дилерийн үйл ажиллагаа нь хоёр өөр төрлийн ажиллагаа. Дээрээс нь андеррайтерийн үйл ажиллагаа нь мөн өөр төрлийнх байдаг. Хуульд зааснаар бол ийм төрлийн компанийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 50 сая төгрөг байхаар байна. Энэ нь зөвхөн брокерийн үйл ажиллагаа явуулах компанийн дүрмийн сангийн хөрөнгийн доод хэмжээ юу, эсхүл брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагааг хавсран явуулах компанийн дүрмийн сангийн доод хэмжээ юу?

Хуульд "Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ" гэж заасан ч энэ заалтын "...хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ" *гэдгийг хэрхэн ойлгох нь маргаан үүсэх талаар дурдсан.*

ҮЦЗЗТХ-ийн 21, 22 дугаар зүйлд үнэт цаасны зах зээлд оролцогч брокер, дилерийн компаниуд Хөрөнгийн биржийн гишүүн байх боловч эдгээр нь биржийн гишүүний хувьд зөвхөн үнэт цаасны арилжаанд оролцох л боломжийг бүрдүүлсэн. Гэтэл нөгөө талаас Хөрөнгийн биржийн гишүүн болох брокер, дилерийн компаниуд Хөрөнгийн биржийн Төлөөлөн Удирдах зөвлөлд оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг Хөрөнгийн биржийн ТУЗ-өөс гаргадаг бөгөөд уг ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь Төрийн өмчийн хорооноос томилсон төрийн байгууллагын албан хаагчид байдаг. Эдгээр ТУЗ-ийн гишүүд нь тэр бүр үнэт цаасны зах зээлийн талаар нарийн мэргэшээгүй тул Хөрөнгийн биржтэй холбоотой шийдвэр нь зарим тохиолдолд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын эрх ашигт нийцэхгүй тохиолдол байна. Үүнээс үзэхэд Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс түүний удирдах дээд байгууллагад гишүүдийн оролцох эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Андеррайтерын үйл ажиллагаа нь брокер дилерийн үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээтэй нь харагдаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28 дугаар зүйлд андеррайтерийн команийн талаар заажээ. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 200.0 сая төгрөг, үүнээс мөнгөн болон түргэн борлогдох эргэлтийн хөрөнгө нь 100.0 сая төгрөгөөс доошгүй байна. Андеррайтерийн компани нь энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээс гадна үнэт цаас гаргаж нийтэд санал болгох тухай танилцуулгад тусгасан болон түүнд хавсаргасан баримт, мэдээллийн үнэн зөв эсэхийг хянаж, мэдээлэл буруу байсныг илрүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцах үүрэгтэй.

Өнөөдөр манай улсад андеррайтерын үйл ажиллагааг дагнан эрхэлдэг компани байхгүй байна. Брокер, дилерийн компаниуд энэ үйл ажиллагааг хавсран эрхэлж байна. Хавсран эрхэлж байгаа 15 компани байна. Ийм үйл ажиллагаа явуулахад доод тал нь 300 сая төгрөгтэй байх шаардлагатай байна. гэтэл хавсран эрхэлж байгаа компанийн хувьд энэ хөрөнгийг хэрхэн тооцох вэ? Өөрөөр хэлбэл, брокер дилерийн компанийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 50 сая төгрөг байхаар хуульд заасан. Ийм компани хавсран эрхлэх бол 50 сая төгрөг дээр +200 сая +100 сая төгрөг байх уу? Эсхүл 50 сая+250 сая төгрөг байх уу? гэдэг нь тодорхой бус байна.

Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: "Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ. Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй." гэж заасан. Үүнээс үзвэл компанид хувь нийлүүлсэн аливаа хөрөнгө нь хувьцаанд хуваагдах хуулийн шаардлага тавигдаж байна. Гэтэл Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн зарим нэг компанийн дүрмийг үзэхэд компанийн хөрөнгөө хувьцаанд хуваагаагүй, хувьцааны нэрлэсэн үнийг заагаагүй байна. Энэ нь хуулийн дээрхи шаардлагыг зөрчиж байгаа юм. Өөрөөр хэлбэл компанид оруулсан хөрөнгийг хувьцаанд хуваагаагүй байдлаар дүрэмдээ тусгаж түүнийг улсын бүртгэлд бүртгэсэн нь Компанийн тухай хуулийн "Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох" гэдэг заалтыг хэрэгжих боломжгүй болгож байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг хувьцаанд хуваагаагүй, нэгж хувьцааны үнийг нарийвчлан заагаагүй байх нь наад зах нь ногдол ашиг авахад маргаан үүсгэх талтай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК БУЮУ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭЖ БУЙ БАЙДАЛ

Судалгааны баг шүүхийн практикийг судлах ажлыг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

- ✓ Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн судалгаа хийж, хавтаст хэрэгтэй танилцах;
- ✓ Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн шийдвэрт анализ хийх;
- ✓ Шүүгч, өмгөөлөгч, их, дээд сургуулийн багш нартай уулзалт ярилцлага хийх.

Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс Үнэт цаастай /120 хэрэг/, Компанийн тухай хуулийн үнэт цаастай /37 хэрэг/, Гэр бүлийн дундын эд хөрөнгийн ногдол хувь, үнэт цаастай холбоотой /14 хэрэг/ шийдвэрлэсэн хэргийн статистик тоо авахад улсын хэмжээнд /аймаг, дүүрэг тус бүрээр/ нийт 171 хэрэг бүртгэлтэй гэсэн тоо өгсөн боловч энэ нь бодит байдалтай нийцэхгүй байх тохиолдол гарсан. Тухайлбал, Дархан-Уул аймагт судалгааны багийн гишүүд очиж ажиллахад статистик тоо баримтад үнэт цаас, хувьцаатай холбоотой шийдвэрлэсэн хэрэг байхгүй гэж ирүүлсэн боловч тус аймгийн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичиг нартай уулзалт, ярилцлага хийх явцад нэг хэрэг шийдвэрлэсэн байсан.

Статистик тоон мэдээлэлд Гэр бүлийн дундын эд хөрөнгийн ногдол хувь, үнэт цаастай холбоотой 14 хэрэг шийдвэрлэсэн гэсэн тоо өгсөн боловч тухайн шүүхэд очиж хавтас хэрэгтэй нь танилцаж үед зарим хэрэг нь гэр бүлийн бусад төрлийн маргаан болох нь харагдсан. Энэ нь тухайн судалгааг гаргаж өгч буй шүүхийн ажилтан судалгааны хүрээнд холбогдох байгууллага руу явуулсан албан тооттой сайн танилцдаггүй нь харагдаж байна. Судалгааны багийн гишүүд Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн сууж нийт 49 хавтаст хэрэг, Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн 61 шийдвэр /захирамж, шийдвэр, магадлал, тогтоол/-ийг тус тус уншиж танилцлаа.

Улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийг 21 аймаг, 9 дүүргээр нэгтгэн он тус бүрээр харуулбал:

/Улсын хэмжээнд/

№	Он	Үнэт цаастай холбоотой шийдвэрлэсэн маргааны тоо
1	1993	7
2	1994	1
3	1995	5
4	1996	4

5	1997	14
6	1998	72
7	1999	8
8	2000	3
9	2001	9
10	2002	3
11	2003	13
12	2004	4
13	2005	4
14	2006	6
15	2007	15
16	2008	3
Нийт		**171**

•Судалгааны багийн гишүүдийн Нийслэлийн шүүхийн архив, Захиргааны хэргийн шүүх, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн шүүхэд биечлэн сууж танилцсан нийт 49[90] хавтаст хэргийг маргааны төрлөөр нь ангилбал:

- Хувьцаа болон хувьцааны үнэ гаргуулах хэрэг -12;
- Хувьцаа өмчлөх болон эзэмших эрхтэй холбоотой -12;
- Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах хэрэг -11;
- Хувь нийлүүлэгчдийн хуралтай холбоотой -8;
- Ногдол ашиг гаргуулах хэрэг -7;
- Хувьцаа эргүүлэн гаргуулах хэрэг -1;
- Нэмэлт хувьцаа гаргасантай холбоотой -1 хэрэг байна.

49 хавтаст хэргээс хэргийг хэрэгсэхгүй болгосон 3, зохигчид хоорондоо эвлэрсэн 3, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн 2 хэрэг байна.

Хувьцаатай холбоотой маргааныг шийдвэрлэхэд удирдлага болгосон хуулийг тоон байдлаар үзүүлбэл:

- Иргэний хууль -24
- Нөхөрлөл, Компанийн тухай -8
- Компанийн тухай -6
- Үнэт цаасны тухай -4
- Үнэт цаасны зах зээлийн тухай -2
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай -2
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль -1
- Хөдөлмөрийн тухай хууль -1
- Өмч хувьчлах тухай -1
- Хуулийн нэр заагаагүй -3 байна.

Хувьцаатай холбоотой маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ Иргэний хуулийг голдуу удирдлага болгодог нь харагдаж байна. Мөн шүүгч нартай уулзалт, ярилцлага хийх үед ч Иргэний хуулийг голдуу хэрэглэн тухайн маргааныг шийдвэрлэдэг болохыг хэлж байсан.

Үүнтэй холбоотойгоор Иргэний хуулийн 107, 113 дугаар зүйлийн 113.4-

[90]Үншсан хэргийн дэлгэрэнгүй мэдээлэл болон зарим шийдвэрийн хуулбарыг Хавсралт 2-оос үзнэ үү.

д зааснаар зөрчигдсөн эрхийг сэргээхэд, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэхэд нарийвчилсан зохицуулалттай хуулийг барьж шийдвэрлэхээр байгаа боловч уг асуудлаар оновчтой, тодорхой зохицуулсан хэм хэмжээ байдаггүйгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэглэхэд хүндрэл учирдаг гэжээ.

Улсын дээд шүүх, Сэлэнгэ, Ховд, Увс аймгийн шүүхээс ирүүлсэн 61[D] шийдвэрийн 1 нь тогтоол, 4 нь магадлал, 14 нь шийдвэр, 42 нь захирамж байна.

Шийдвэрийг тус бүрт ангилан авч үзвэл:

Тогтоол-1: Хан-Уул дүүргийн шүүхээр 2005 онд, Нийслэлийн шүүхээр 2005 онд, Улсын дээд шүүхээр 2006 онд шийдвэрлэсэн 15.592.000 төгрөг гаргуулахыг хүссэн хэрэг.

Тогтоолд хамтран ажиллахаар тохиролцсон нэг боловч анхан шатны шүүхийн шүүхийн шийдвэрт Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 467.2, 467.2 ... дэх хэсгүүдэд заасныг баримтлан ... гаргуулахаар шийдвэрлэсэн ба давж заалдах шатны шүүхийн магадлалд 467 дугаар зүйлийг 476 дугаар зүйл хэмээн өөрчилж бусад заалтыг хэвээр үлдээснийг Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг тогтоох хэсгийг өөрчлөн шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлагад хамтран ажиллахдаа хувьцаагаар хөрөнгө оруулахаар заагаагүй байхад шүүх Иргэний хуулийн Үнэт цаас, түүний төрөл, хэлбэр гэсэн 467 дугаар зүйлийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэхээр байна.

Магадлал-4: 3 хэрэгт хувьцааг худалдах, худалдан авах гэрээг, 1 хэрэг нь худалдах, худалдан авах гэрээ нь агуулгаараа хууль зөрчсөн тул хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцож хэргийг шийдвэрлэсэн байна.

Шийдвэр-14: Шийдвэрийг аймгаар ялгавал, Ховд аймаг 8, Сэлэнгэ аймаг 5, Дархан-Уул аймаг 1 байна. Хэргийн төрлөөр нь ангилбал, хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулахтай холбоотой 8 /Сэлэнгэ, Ховд аймаг/, хувьцааны өмчлөгч, эзэмшигч болохыг тогтоолгохтой холбоотой 3 /Сэлэнгэ, Дархан-Уул аймаг/, ногдол ашигтай холбоотой 2 /Сэлэнгэ, Ховд аймаг/, хувь нийлүүлэгчдийн хуралтай холбоотой 1 /Ховд аймаг/ маргаан байна.

Захирамж-42. Үүнээс:

- зохигчид хувьцааны үнэ гаргуулах нэхэмжлэлд эвлэрсэн хэрэг 1 / Сэлэнгэ аймаг/;
- "А" ХХК-ийн нийт хувьцааны 30 хувь буюу 16,691 ширхэг хувьцааны эзэмшигчээр тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийг гурван /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.2 дахь заалтыг зөрчсөн гэх мэт/ үндэслэлээр хангаж шийдэрлэх боломжгүй хэмээн хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг 1 /Сэлэнгэ аймаг/;
- Ногдол хувь гаргуулах болон хувьцаагаа эргүүлэн авах нэхэмжлэл гаргасан ба хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн 19 хэрэг /Сэлэнгэ, Ховд аймаг/;

- Ногдол хувь гаргуулах, ·худалдсан хувьцааг буцаан авах, хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, зөвшөөрөлгүй зарсан хувьцааг гаргуулах зэрэг нэхэмжлэлээс нэхэмжлэгч татгалзсан 21 хэрэг / Сэлэнгэ, Ховд аймаг/;

19 тогтоол, магадлал, шийдвэрийн 7-д Иргэний хуулийн Үнэт цаас, түүний төрөл, хэлбэр гэсэн 467 дугаар зүйл, Нөхөрлөл, Компанийн тухай, Нотариатын тухай, Компанийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг, ямар хууль хэрэглэснийг огт заагаагүй байна. Бусад шийдвэрийн тогтоох хэсэгт Иргэний хуулийн 111, 106, 101, 48, 44, 43 дугаар зүйлүүдийг хэрэглэсэн байна.

Судалгааны явцад /ялангуяа хөдөө орон нутагт/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг өдөр тутам хэрэглэдэгүй учраас тухайн маргааныг шийдвэрлэхэд гарч буй хүндрэлийн талаар мэдээлэл хомс байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 27.1-д "Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх компани/цаашид"Брокер, дилерийн компани" гэх/-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50.0 сая төгрөгөөс доошгүй байна. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг хавсран эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд энэ хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээгээр нэмэгдэнэ" гэж заасан. Сүүлийн үед брокер, дилерийн буруутай үйл ажиллагаанаас болж иргэд, хуулийн этгээдэд хохирол учирч байгаа нь нэмэгдэж байна. Хуулийн уг заалтыг харвал тусдаа үйл ажиллагаа явуулсан ч, цогц үйлчилгээ үзүүлсэн ч гэсэн 50.0 сая төгрөгөөс доошгүй хөрөнгөтэй байхаар байгаа боловч үнэт цаасны зах зээлд хувьцааны үнэ байнга өсөж, буурч байдаг нэг талаас эрсдэлтэй, нөгөө талаас азтай үйлдлийг тухайн брокер, дилерийн байгууллагын дүрмийн сан 50.0 сая төгрөг байгаа нь өөрсдийн буруутай үйл ажиллагааны хохирлыг нөхөн төлөх чадваргүй болгож байна. Тиймээс хөрөнгийн зах зээлд үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс арилжаа хийдгийн хувьд дүрмийн нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

2.Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хүртээмжтэй хамгаалах талаар нарийн зохицуулалт байх шаардлагатай байна. Учир нь компанид хөрөнгө оруулах шаардлагатай гэсэн үндэслэлээр бүх гишүүдийн хурлаар нэмэлт хувьцаа гарган жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг багцлах, жижигрүүлэх нөхцөл бий болж байна.

3.Судлагаагаар зарим шүүгч нар үнэт цаасны тухай ойлголт хомс байгааг дурдаад эдийн засгийн томоохон хөшүүрэг болох энэ салбарын талаар нэлээд сайн мэдээлэлтэй болгох шаардалагтай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОЛОН УЛСЫН ЗАРЧИМ, СТАНДАРТ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

4.1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, СТАНДАРТ

Дэлхийн худалдааны байгууллагын баримт бичиг

Дэлхийн худалдааны байгууллагыг (ДХБ) үүсгэн байгуулах хэлэлцээрт "гишүүн бүр дотоодын хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон баримт бичиг болон захиргааны журмыг ДХБ-ын хэлэлцээрүүдийн дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэх арга хэмжээг авна"[91]. Аливаа улс ДХБ –д элсэн ороxдоо багц хэлэлцээрт нэгдэх шаардлагатай байдаг ба тэдгээрийн нэг нь Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр[92] (General agreement on trade in services – GATS- ГАТС) юм. ГАТС-ийн 2 дугаар зүйлийн 1-д ДХБ-ын гишүүн улс болгон үйлчилгээ үзүүлэгч гадаадын компанид болон үйлчилгээнд нь Ерөнхий хэлцээрийн гишүүн бусад улсад үзүүлж буй дэглэмээс дутахааргүй таатай дэглэм үзүүлэх үүрэг хүлээнэ.

Тухайн хэлэлцээрийн Хавсралт 1-д санхүүгийн зах зээл дэх ажиллагааны зэрэгцээ мөн тусгай зөвшөөрөл авах дараахь үйл ажиллагааг хамааруулна:

- брокер, дилерийн үйл ажиллагаа, түсгайлан биржийн болон биржээс гадуур зах зээл дэх үйл ажиллагаа;
- актив хөрөнгөөр итгэмжилээр захирах үйл ажиллагаа;
- хамтын хөрөнгө оруулалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаа;
- хадгалагчийн үйл ажиллагаа, тэр дундаа төлбөр тооцоо эрхлэх хадгалагчийн үйл ажиллагаа;
- зах зээлийн төрөл бүрийн клирингийн үйл ажиллагаа гэх мэт.

ДХБ-ын баримт бичгийн дагуу гадаадын хуулийн болон хувь этгээдийн эрх зүйн чадамжийг түүнд гадаад улсад олгогдсон лиценз болон бусад эрх тогтоосон баримтад үндэслэн хүлээн зөвшөөрөх (recognition) асуудлыг тусгасан.

Ерөнхий хэлэлцээрийн VII зүйлийн дагуу ДХБ-ын аливаа гишүүн улс түүний хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл, эсхүл бусад мэргэжлийн шалгуурыг шаардах үйлчилгээг үзүүлэх гэж буй гадаадын компани болон хувь этгээдийн гуравдагч улс (ДХБ-ын гишүүн улс) –д олгогдсон боловсрол, ажлын туршлага, тусгай зөвшөөрөл, аттестатчилалыг мөн тухайн улсын мэргэжлийн шаардлагын нийцэж буйг бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эрхтэй байна. Энэ хүлээн зөвшөөрөх асуудлыг аливаа улс нь өөрийн улсын хуулийн болон хувь этгээдийн үйлчилгээг тухайн улсад нэвтрүүлэх боломжийг хангах сонирхолтой ДХБ-ын гишүүн улстай хийсэн тусгай хэлэлцээр, тохиролцолд үндэслэн хэрэгжүүлж болно. Ийм

[91] Шийдвэрийн хуулбарыг Хавсралт 3-оос үзнэ үү.
[92] Тухайн компанийн нэрийг өөрчилсөн.

хэлэлцээрийн дагуу дээрх хүлээн зөвшөөрөх асуудлыг хэрэгжүүлэхдээ гишүүн улс үндэсний зах зээлдээ хэлэлцэн тохирогч нөгөө улсын хуулийн болон хувь этгээдэд үл ялгаварлан гадуурхах, үндэсний дэглэм олгох үүрэг хүлээдэг.

Мөн VII зүйлд гишүүн улс нь Ерөнхий хэлэлцээр түүний хувьд хүчин төгөлдөр болсоноос хойш 12 сарын хугацаанд багтаан Үйлчилгээ үзүүлэх асуудлаархи зөвлөл (Council for Trade in Services)-д хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөхийг хангахаар авсан арга хэмжээг болон тухайн арга хэмжээг авах үндэслэлийн талаар мэдэгдэх үүрэгтэй. *5 дугаар зүйлд аливаа гишүүн улс боломжтой бүх тохиолдолд үйлчилгээ үзүүлэх ажиллагааны талаархи дотоодын зохицуулалтад олон улсын стандарт, шалгуурыг харгалзах ёстой.*

Хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад тооцвол зохих гишүүн улсын үүрэгт гадаадын компанийг үйлчилгээний зах зээлд нэвтрүүлэхэд зарим хязгаарлалт тавихыг хориглосон үүрэг ерөнхий хэлэлцээрийн 16 дугаар зүйлд заасан байна. Үүнд:

- Холбогдох үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд болон хамтарсан үйлдвэрийн хэлбэрт хамаарах хязгаарлалтыг тавих;
- гадаадын хөрөнгийг хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд дээд хувь эзлэх хэлбэрээр оролцоог хязгаарлах, эсхүл хувь болон хамтын хөрөнгө оруулалтын хэмжээг хязгаарлах;
- тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын орон тоог бүрдүүлэх хувь этгээдийн тооны хувьд дээд болон доод хэмжээнд хязгаарлах;
- тодорхой нэг төрлийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн тоог квот тогтоох, эсхүл монопол тогтоох, эсхүл тийм үйлчилгээ эрхлэх тодорхой бүлэг этгээдэд онцгой нөхцөл олгох бусад хэлбэрээр хязгаарлах.

Үнэт цаасны олон улсын комиссийн баримт бичиг

Үнэт цаасны олон улсын комисс (International organization of Securities Commissions - IOSCO) нь хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үр өгөөжтэй, нээлттэй зах зээлийг бий болгох асуудлаар сонирхлыг нэгтгэж, харилцан мэдээлэл, туршлага солилцох зорилгоор дэлхийн 109 гаруй улсыг нэгтгэсэн 170 гаруй гишүүнтэй[93] олон улсын байгууллага юм. Энэ байгууллагын гишүүнээр тухайн улсын үнэт цаасны комисс, эсхүл үнэт цаасны зах зээлийг зохицуулах гүйцэтгэх эрх мэдлийн бусад байгууллага байдаг. Гишүүн нь мөн бүс нутгийн хорооны гишүүн байдаг. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь энэ байгууллагын гишүүн байгууллага бөгөөд Ази- Номхон далайн бүс нутгийн хороонд багтдаг.

[93] Төрийн мэдээллийн тусгай дугаар VIII. 2007 он.1832-1866 дахь тал.

Уг байгууллагын үндсэн барим бичгийн нэг бол "Үнэт цаасны зах зээлийн зорилго ба зарчим" юм. Энэ баримт бичиг нь үнэт цаасны зах зээлийн 30 зарчмыг агуулах бөгөөд эдгээр зарчмыг нэвтрүүлэх нь үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчдыг хамгаалах, шударга, үр дүнтэй, нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг хангах, эрсдэлийг багасгахад чиглэгдсэн эрх зүйн суурийг бэхжүүлэх практик ач холбогдолтой. Энэ баримт бичгийн Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт дараахь зорилгыг хангаж байх ёстой байна:

- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалалт;
- Зах зээлийн шударга, үр дүнтэй, ил тод байх байдлыг хангах;
- Тогтолцооны эрсдлийг бууруулах.

Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийг зохицуулах хууль тогтоомжид тусгах шалгуур болох дээрх 30 зарчмыг нийт 8 төрөлд багцлан дурдвал:

А. Зохицуулагчтай холбогдсон зарчим

1.Зохицуулагчийн хариуцлага нь тодорхой байх, бодитойгоор заагдсан байх;

2.Зохицуулагч нь эрх мэдэл, үйл ажиллагаагаа биелүүлэхийн тулд биеэ даасан байх, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.Зохицуулагч өөрт олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлж, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах эрх мэдэл, нөөц ур чадвартай байх;

4.Зохицуулагч нь тодорхой бөгөөд тогтвортой зохицуулалтын үйл явцыг жишиг болгох;

5.Зохицуулагчийн албан хаагчид /нууц/ итгэлцлийн холбогдох стандартуудыг мэргэжлийн өндөр түвшинд стандартыг мөрддөг байх;

В. Өөрийгөө зохицуулах байгууллагын зарчим

6.Зах зээлийн тохиромжтой хэмжээ болон иж бүрдлийн хэмжээнд өөрийн өрсөлдөгч хүрээнд шууд хянах үүргийг хэрэгжүүлдэг өөрөө зохицуулагч байгууллагуудыг зохицуулагч нь зөв зохистой байдлаар ашиглах;

7.Өөрөө зохицуулах байгууллагууд нь зохицуулагчийг хянаж байх субъект болох ба эрх мэдлээ хэрэгжүүлэх болон өөрт оногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ шударга ёс болон итгэлцлийн стандартыг бариmтлах;.

С. Үнэт цаасны зохицуулалт дахь албадлага

8.Зохицуулагч нь хяналт, шалгалт явуулах, мөрдөн байцаах, нуцаар мөрдөх эрх мэдэлтэй байх;

9.Зохицуулагч нь албадлагыг хэрэгжүүлэх;

10.Зохицуулалтын систем нь хяналт шалгалт явуулах, мөрдөн байцаах, нуцаар мөрдөх үйл ажиллагааг ур ашигтай, өгөөжтэй байдлаар ашиглах, мөн холбогдох хөтөлбөрүүдийг ур өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэх;

D. Зохицуулалт дахь хамтран ажиллах зарчим

11.Зохицуулагч гадаад, дотоодын харилцагч нартай нийтийн болон нийтийн бус мэдээлэлтэй адил хуваалцах эрх мэдэлтэй байх;

12.Зохицуулагчид гадаад, дотоодын харилцагчтай нийтийн болон нийтийн бус мэдээллийг хамтран хэзээ болон яаж ашиглах талаар мэдээлэл солилцох механизмыг бий болгох;

13.Зохицуулалтын систем гадаадын зохицуулагчдад өөрсдийнх нь эрх мэдэл, чиг үүргийг нь хязгаарласан талаар асуудал тавихад дэмжлэг туслалцаагаар хангах боломжийг олгох;

E. Үнэт цаас гаргагчдын зарчим

14.Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргах үндэслэл болох санхүүгийн үр дүн, бусад мэдээллийг цаг тухайд нь бүрэн, үнэн зөв мэдээлэх;

15.Компанийн үнэт цаасны хувьцаа эзэмшигчидтэй өөр хооронд нь ялгаваргүйгээр шударга, тэгш байдлаар харьцах;

16.Нягтлан бодох болон аудитын стандарт нь олон улсын шаардлагад нийцсэн байх ба өндөр чанартай байх;

F. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцооны зарчим

17.Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоог ажиллуулах, зах зээлд оруулах хүсэлтэй этгээдэд зориулж тавигдах шаардлагатай стандартыг зохицуулалтын систем бий болгох;

18.Зохицуулагч систем нь хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо болон үйлчлүүлэгчдийн эд хөрөнгийг хамгаалах болон тусгаарлахад шаардагдах хууль зүйн маягт, түүний бүтцийн талаархи дүрэм журмаар хангах;

19. "E"-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо нь тодорхой нэг хөрөнгө оруулагчид хэр зохистой болох мөн түхайн зохицуулалт түүний ашиг сонирхлыг үнэлэн дүгнэхэд шаардагдах мэдээллийг хангасан байх зохицуулалтыг бий болгох;

20.Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоонд нэгжийн төлбөр, үнэ болон эд хөрөнгийн үнэлгээг хийх тохиромжтой үндэс суурийг тусгахыг зохицуулалтаар бататгах;

G. Зах зээлд зохицуулагчийн зарчим

21.Зохицуулалт нь хөрөнгийн зах зээлийн хөндлөнгийн зуучлагч оролцох наад захын стандартыг хангасан байх;

22.Зуучлагчид учирч болох аливаа эрсдлийг тусгасан анхдагч болон одоо байгаа эд хөрөнгө мөн бусад шаардлагыг тавих;

23.Үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, эрсдлийн зохистой менежментийг бататгах болонтэдгээртэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүйг дотоод журам болон үйл ажиллагааны стандартыг зах зээлийн зуучлагчид дагаж мөрдөнө.

24.Системийн эрсдлийг бууруулахад хөрөнгө оруулагчдыг хамгийн бага эрсдэлд оруулахад зуучлагчдын зах зээл шударга зарчмаар үйл ажиллагаа явуулах;

Н. Хоёрдогч зах зээлийн зарчим

25.Үнэт цаасны зах зээлийн солилцоог багтаасан арилжааны системийг бий болгох асуудал нь зохицуулалтын эрх хэмжээ, хяналтын зүйл байх;

26.Арилжааны нэгдсэн байдлыг хангах зорилгоор арилжаа солилцооны системийг зохицуулагч байнга хангаж байх бөгөөд ийнхүү хангах үйл ажиллагаа нь зах зээлийн олон янзын шаардлагыг тэнцвэрт байдалд нөлөөлөх шударга тэгш байдлын дүрэм журмаар тогтоогдох;

27.Арилжааны ил тод, нээлттэй байдлыг дэмжих;

28.Зохицуулалт нь худалдаа арилжааны аливаа шударга бус практик, хууран мэхлэх үйл ажиллагааг олж илрүүлэх, түүнийг хориглоход чиглэгдэх;

29.Зохицуулалт нь зах зээлийн замбараагүйдэлд хүргэх, тохиролцоноо үл биелүүлэх, их хэмжээгээр эрсдэлд орохоос сэргийлэх зүй зохистой менежментийн баталгааг гаргахад чиглэгдэх;

30.Үнэт цаасыг шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлж тодорхой болсон систем нь зохицуулагчийн хяналтад байх бөгөөд үр өгөөжтэй, шударга, ашигтай байхаар тогтоож өгснөөр системийн аливаа эрсдлийг бууруулах.

Дэлхийн хөрөнгийн биржийн холбоо (FIBV)[94]

Дэлхийн хөрөнгийн биржийн холбоо нь дэлхийн үнэт цаасны зах зээлийг хамарсан хамгийн том нийгэмлэгийн нэг юм. Энэ холбоо нь өнөөдрийн байдлаар 60 орчим гишүүн биржтэй бөгөөд эдгээр хөрөнгийн бирж нь дэлхийн биржийн хэлцлийн 97 хувийг хийдэг. Эдгээр бирж нь үнэт цаасны арилжааг явуулахаас гадна бусад төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон улсын түвшинд явуулдаг. Энэ байгууллагын гишүүнээр биржээс гадна банк, компани, засгийн газрын агентлаг, төрийн бус байгууллага байж болдог онцлогтой. Энэ холбооны үндсэн зорилго нь хөрөнгийн биржийн нэгдмэл бодлого бий болгох, эрх зүйн зохицуулалтыг ижилсүүлэх, боловсронгуй болгох, стандарт бий болгох, бирж, үнэт цаасны хороо хоорондын хамтын ажиллагааг дэмжих, шинээр үүсч буй болон жижиг хөрөнгийн биржүүдэд туслалцаа, зөвлөгөө өгөхөд оршино. Холбоонд дэлхийн нэр хүнд бүхий биржүүд гишүүнчлэлтэй байдаг боловч ямар ч улсын бирж энэ холбоонд нэгдэх бодлого барин хөгжиж байдаг. Өөрөөр хэлбэл энэ холбоонд нэгдэн ороход тавигддаг шаардлага нь өнөөдөр аливаа биржийн баримтлах стандарт болжээ.

Энэ стандартад 13 багц шалгуур үзүүлэлт багтдаг. Тухайлбал,

1.Байгууллага үйл ажиллагаа: зохицуулах хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг байх; мэргэшлийн байгууллага оролцдог байх, тэдгээрт тавигдах шаардлага, хариуцлага тодорхой байх, бүтцийн өндөр зохион байгуулалттай байх, зохих дүрэм, журам тодорхой

[94] http://www.iosco.org/lists/display_members.cfm?memID=1&orderBy=none.

байх, программ хангамж, мэдээллийн сүлжээний системтэй байх, санхүүгийн эх үүсвэр оновчтой байх;

2.Үнэт цаасны арилжаанд оролцдог байх: арилжаанд оролцох тэгш байдлыг хангах, арилжаанд оролцох байгууллагын хөрөнгийн дээд хэмжээг тогтоож өгөх, арилжаанд баримтлах бусад журам, хариуцлагыг тогтоосон байх;

3.Бүртгэл ба мэдээлэл: хуулийн дагуу, түргэн, шуурхай, шударга явуулах, дотоодын болон гадаадын бүртгүүлэгчид тэгш нөхцөл олгогдож байх, хөрөнгө оруулагчдад мэдээлэл бүрэн, шуурхай хүрч байх;

4.Арилжаа: хууль тогтоомжийн хүрээнд явагдах, гэрээнд үндэслэх, мэдээлэл, тайлагналт зохих зарчмин дагуу явагдаж байх, нэр хүнд, нууцыг баримтлан мэдээлэл нээлттэй байх, гадаадын этгээдийн оролцоог дэмжиж байх, хоёр улсын эрх зүйн зохицуулалтын давхардалгүй байх;

5.Хэлцэл: хэлцэл нь олон улсын стандарт G-30, ISSA нарт нийцэж байх;

6.Техникийн хангамж: Аливаа бирж IT системээр хангагдсан байхаас гадна нөөц программ хангамжтай, өндөр түвшний хамгаалалттай байх;

7.Эрсдэл: эрсдэл тооцох, түүнээс шуурхай гарах механизмтай байх;

8.Маргаан шийдвэрлэх: тодорхой маргаан шийдвэрлэх механизмтай байх;

9.Хяналт, шалгалт: дотоод хяналт, шалгалтын уян механизмтай байх;

10.Хөрөнгө оруулагчийг хамгаалах: хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалсан тогтолцоотой байх, хохирлыг арилгах механизмтай байх;

11.Бизнесийн удирдлага: энэ шаардлага нь IOSCO-ийн гаргасан зарчим бөгөөд OECD-ийн компанийн удирдлагын гол зарчмуудыг тооцсон байх;

12.Худалдаа: худалдаа хөрөнгө оруулагчийн эрхийг хангасан байх, тодорхой хяналт дор явагдаж байх, мэдээлэл нээлттэй байх;

13. Гадаад хөрөнгө оруулалт: үндэсний дэглэм, эсхүл нэн таатай нөхцөл үзүүлэх дэглэм олгодог байх, гадаадын үнэт цаасыг хуулиар хязгаарласнаас бусдыг нь арилждаг байх.

4.2. ГАДААД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Үнэт цаасны зах зээл Англо-саксон, Эх газрын гэх үндсэн хоёр загвар дээр хөгжиж иржээ. Харин сүүлийн үед зарим улс нь энэ хоёр загварын конвергенци хэлбэрээр хөгжүүлэн хэрэглэж иржээ. Энэ загваруудыг тус бүрт нь авч үзвэл дараах онцлогтой байна:

4.2.1. Үнэт цаасны зах зээлийн загвар

А. Үнэт цаасны зах зээлийн англо-саксоны загварын онцлог:

1. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр

- үндсэн эх үүсвэр нь хөрөнгийн бирж

2. Хөрөнгийн биржийн хэрэгсэл

- үнэт цаасны зах зээлийн үндсэн хэрэгсэл нь хувьцаа, өрийн хэрэгсэл нь хөрөнгийн зах зээлээс хамааралтай болж эхэлсэн (ДНБ-ий 60-90% нь



хувьцаа. бусад тогтоогдсон бус орлоготой үнэт цаасны үнээс бүрдэнэ[95])

3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч

- арилжааны банкыг үнэт цаасны зах зээлээс тусгаарлах бодлого хэрэгжиж ирсэн (1933 оны Үнэт цаасны тухай хууль (Securities Act) 1982 оны нэмэлт өөрчлөлтийн хамт)

- эх газрын загвартай улсынхтай харьцуулбал санхүүгийн байгууллага илүү мэргэшсэн. Энд төрөлжсөн банкны (хөрөнгө оруулалтын банк, өөрөөр хэлбэл брокер-дилерийн компани) үзэл баримтлал дэлгэрсэн

4. өмчийн бүтэц

- хувь хөрөнгө оруулагч болон тэдгээрийг төлөөлсөн хөрөнгө оруулагчийн хамтарсан хэлбэрийн өмчийн хувь илүү

- төрийн болон том компани, банкны өмч бага, улсын эдийн засгийг зохицуулах төрийн оролцоо бага

- хувьцаат хөрөнгөд хяналтын багцын гүйцэтгэх үүрэг бага, хувьцаат хөрөнгийн өмчид бутархай байдал өндөр байдал ажиглагдсан

5. зах зээлийн нээлттэй чанар

- нээлттэй байдал илүү, хөрөнгийн, валютын хөдөлгөөний хязгаарлалт бага, гадаадын үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, санхүүгийн зуучлагчийн хүртээмж илүү нээлттэй. Иймд либералчлагдсан зах зээлд шударга үйл ажиллагаа болон эрсдэлийг багасгах үүднээс төрийн хяналтыг чангатгадаг байна.

6. Үнэт цаасны зах зээл

- Үнэт цаасны зах зээл олон нийтийн болж, илүүгээр хөрвөх чадвартай болж байгаа бөгөөд илүү олон улсын шинжтэй болсоор байна.

Дээрх загвар нь АНУ, Англи, Канад, Австрали зэрэг улсад давамгайлдаг.

Б. Үнэт цаасны зах зээлийн эх газрын загварын онцлог:

1. хөрөнгө оруулалтын эх үүсвэр

- хөрөнгө оруулалт нь хувьцаагаар биш өрийн бусад хэрэгсэлээр хэрэгждэг

2. Хөрөнгийн биржийн хэрэгсэл

- зах зээлийн үндсэн хэрэгсэл нь өрийн шинжтэй (банкны зээл, облигац), хувьцааны зах зээл хоёрдогч ач холбогдолтой

3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч

- хувьцаат хөрөнгөт салбарт томоохон хөрөнгө оруулагчаар банк байдаг. Үйлдвэр, бусад санхүүгийн бус компанийн хувьцаа эзэмшигчээр банк байдаг. Иймд хувьцааны ихэнхи нь банкны мэдэлд, эсүл тэдгээрийн нэгдсэн группд хамааралтай байдаг.

- улсын санхүүгийн активд арилжааны банк өндөр хувь эзэлдэг. Банк нь өөрийн сонгодог чиг үүргээсээ (депозит, төлбөр тооцоо) гадна үнэт цаасны зах зээлд мэргэжлийн байгууллагтын хувиар оролцдог (зарим тохиолдолд үнэт цаасаар дагнасан тусгай салбар нэгж, охин байгууллага байгуулдаг).

[95] Пелих С.А., Рачковская О.С. Две концепции развития фондового рынка//Финансы, М., 1999, №10, С.30.

- хамтын хөрөнгө оруулалт бага үүрэг гүйцэтгэдэг

4. өмчийн бүтэц

- хувь хөрөнгө оруулагч болон тэдгээрийг төлөөлсөн хөрөнгө оруулагчийн хамтарсан хэлбэрийн өмчийн хувь бага

- төрийн болон том компани, банкны өмч их,

- хувьцаат хөрөнгөд хяналтын багцын гүйцэтгэх үүрэг их.

Дээрх загвар нь Герман, Австри, Япон зэрэг улсад давамгайлдаг.

В. Үнэт цаасны зах зээлийн загварыг хослуулсан конвергенци:

Эдийн засгийн хөгжилтэй улс орнуудад дээрхи загваруудын зааг арилж байгаа бөгөөд санхүүгийн зах зээлийн байгууллага давхцах хандлагатай байна. Тухайлбал, АНУ, ХБНГУ гэх зэрэг улсад эдгээр загварыг хослуулсан хэлбэрээр хэрэглэж байна. 90-ээд оноос ХБНГУ хувьцааны зах зээлээ өргөтгөх бодлого хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд хамтарсан компанийг санхүүжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн мэргэжлийн байгууллага болох банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, ашиг сонирхолыг зөрчлөөс сэргийлэх, эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах зэрэг асуудалд анхаарлаа хандуулж иржээ. Мөн үнэт цаасны зах зээлийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомжоо Европын холбооны Тогтоол, Удирдамжид уялдуулсан бөгөөд англо-саксоны загвараас мэдээлэл түгээх зарчим, үнийн үндэслэлгүй хэлбэлзлийг урьдчилан тооцох зэрэг бусад худалдаа арилжааг шударга явуулах зарчмыг харгалзаж шинэчилсэн байна. АНУ-ын хөрөнгө оруулагчийг татах, АНУ-ын зах зээлд гарах үүднээс зах зээлээ өргөжүүлэх үүднээс Америкийн үнэт цаасны зах зээлийг эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх бодлого хийгдэж байна.

Харин Америкийн хувьд арилжааны банкны үнэт цаасны зах зээл дэх оролцоо нэмэгдэж санхүүгийн нэгдлүүдийг байгуулж үнэт цаасаар арилжиж буй фирмийг тэдгээрийн охин компани болгох хандлагатай байна. Францын хувьд 1945 оноос банкийг хөрөнгө оруулалтын болон арилжааны гэж хуваасан байсан бол 1984 оноос буцаагаад нийлүүлсэн байна. 1993 оны хуулиар Японы арилжааны компаниуд үнэт цаасны зах зээлд оролцох мэргэжлийн байгууллага болох охин компанийг үүсгэн байгуулах эрхтэй болсон.

Европын орнуудад санхүүгийн зах зээлээ нэгтгэх, хууль тогтоомжоо уялдуулах хандлага нэмэгдсээр байна. Мөн арилжааны банк, хөрөнгө оруулалтын банк, банк-брокер, даатгалын компани зэрэг байгууллагад ногдох санхүүгийн үйлчилгээний хуваарилалтын зааг бүдгэрч байгаа бөгөөд банкны шинэ төрөл болох санхүүгийн үйлчилгээ үзүүлэх компанийг үүсгэн байгуулж байна. Санхүүгийн интеграцчилал нь зах зээлийг хил хязгааргүй болгож байгаа бөгөөд үүнийг дагаад эрх зүйн зохицуулалтыг ижилсүүлэх шаардлагыг бий болгож зах зээлийн байгууллагуудыг ойртуулж өгсөн. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн байгууламж, зохион байгуулалтын түвшинд дараахь өөрчлөлтүүд[96] орж байна:

[96]Миркин Я. Рынок ценных бумаг России: воздействие фундаментальных факторов, прогноз

1.Санхүүгийн байгууллагыг нэгтгэж хөрөнгийг төвлөрүүлэх замаар санхүүгийн байгууллагыг өргөжүүлэх хандлагатай.

2.Банкны чиг үүргийг өргөжүүлэх (банк үнэт цаасны компани, даатгалын компанийн чиг үүргийг хэрэгжүүлэх байдлаар) хандлагатай.

3.Банкны загвартай зах зээл нь зарим улсад банк бус санхүүгийн байгууллагад нээлттэй болсон. Түүнээс гадна банк нь хөрөнгийн зах зээлд нэвтэрч эхэлсэн (Франц, Испани).

4.Хөрөнгийн биржүүдийн төвлөрөх процесс явагдаж байгаа. Олон улсын түвшинд нэгдэж байна.

5.Зохицуулах байгууллагын чиг үүргийг нэг байгууллагад төвлөрүүлэх хандлагатай.

6.Улсын зүгээс хувьцааны зах зээлийг онцгой анхаарч, дэмжиж хөгжүүлэх бодлого барьж байна. Учир нь хөгжсөн хувьцааны зах зээл нь улсын эдийн засгийг хөгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг болдог.

4.2.2. ГАДААД УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Зохицуулах байгууллага

Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, журам нь төрийн зүгээс тодорхойлогдож зохицуулагдаж байх ёстой. Төрийн зохицуулалтын гол зорилго нь үнэт цаасны зах зээлийн тогтвортой, найдвартай байдлыг хангах, өөрийн улсын нөхцөл байдлыг тооцон эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх үндэсний оновчтой загварыг тодорхойлон боловсруулахад оршино.

Дэлхийн улсуудын практикт үнэт цааны зах зээлийг зохицуулах гурван гурван үндсэн загвартай:

1.засгийн газрын байгууллагын хяналтаар (Ирланд, Голланд, Португали);

2.санхүү-банкны байгууллагын хяналтаар (ХБНГУ, Бельги, Дани);

3.тусгай чиг үүргийн байгууллагаар (АНУ, Англи, Франц, Итали, Испани).

Орчин цагт дэлхийн санхүүгийн зэх зээлийн тогтолцоонд төрийн зохицуулах, хяналтын олон шатлалтай байгууллагуудын чиг үүргийг нэгтгэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд энэ илүү үр дүнтэй нь нотлогдож байна. Ийнхүү зохицуулалтыг нэгтгэхийн гол хүчин зүйлс нь санхүүгийн зах зээлийн оролцогчийн чиг үүрэг өргөжиж нэг, хоёр чиглэлээр явцуурахаа больжээ. Энэ нь ялангуяа жижиг, эдийн засаг нь хангалттай хөгжөөгүй улсад онцгой тохиромжтой. Олон талт санхүүгийн байгууллага нь хөрөнгө оруулагч нарт багц үйлчилгээг үзүүлэх замаар хэн хэндээ ашигтай үйл ажиллагаа явуулах боломжтой. Мэдээж үүнийг дагаад зохих чиглэлийн төрийн хяналт, зохицуулалт, өөрөөр хэлбэл мега-зохицуулагч байгуулах хэрэгцээ, шаардлага бий болжээ.

и политика развития. М.: Альпина Паблишер, 2002., с.624.

Өнөөдрийн байдлаар санхүүгийн нэгдсэн зохицуулах байгууллага нь Европын хувьд Швед (1991), Дани (1998), Норвеги (1998), Исланд (1999), Люксембург (1999, гэхдээ даатгалаас бусад нь), Эстони (2001)-д банкны байгууллагад хяналт тавих, үнэт цаас, даатгалын зах зээлийг зохицуулж байгаа бол Азид 1997-1998 оны хөрөнгийн зах зээлийн хямралын дараа (1998 - Япон, БНСУ) байгуулж эхэлжээ. Казахстанд 2001 онд Үнэт цаасны үндэсний комиссийг татан буулгаж чиг үүргийг нь Төв банкинд шилжүүлж, улмаар 2004 онд Санхүүгийн зах зээл дэх хяналт, зохицуулалтын агентлагийг байгуулсан байна. ОХУ-ын хувьд 2004 онд Үнэт цаасны үндэсний комиссийг татан буулгаж, Санхүүгийн зах зээлийг зохицуулах холбооны албыг байгуулжээ.

АНУ:

АНУ-ын үнэт цаасны зах зээлийг хянах болон зохицуулах чиг үүрэг бүхий гол байгууллага бол АНУ-ын Үнэт цаасны болон Биржийн Комисс (Securities and Exchange Commission, SEC) юм. Комиссийг эдийн засгийн хямралын үед хөрөнгө оруулагчдын хөрөнгийн биржид итгэх итгэл алдагдаж байсан байдалд хариу арга хэмжээ болгон 1934 онд Ерөнхийлөгч Делано Рузвельт (Franklin Delano Roosevelt)-ийн дэргэд байгуулсан байна. Комиссийн тэргүүлэгчээр Джозеф Кеннеди (Joseph Kennedy) болж байжээ.

SEC-ийн чиг үүрэг ба эрх хэмжээ: Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах болон үнэт цаасны зах зээлийн цогц бүтэн байдлыг хангахад чиглэгдсэн үндсэн үүрэгтэй. Комисс нь зах зээлийн үндсэн оролцогч этгээдүүд болох хөрөнгийн бирж, брокер, дилер, хөрөнгө оруулалтын талаархи зөвлөх болон хамтын сан зэргийн үйл ажиллагааг хянадаг. АНУ-ын үнэт цаасны зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомж нь бүх хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулах гэж буй объектын талаар мэдээллийн хүртээмжтэй байхыг хангахад чиглэгдсэн байдаг. Тиймээс SEC-ийн үндсэн үүргийн нэг бол компаниудын зүгээс үнэн зөв, бодитой бөгөөд цаг хугацаанд нь өөрийн явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл гаргуулж байхыг хангах явдал юм. SEC нь жилдээ үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн 400-500 байгууллага, хувь хүнд хариуцлага тооцдог байна. Эдгээр зөрчилд трейдинг инсайдер (олон нийтэд хаалттай мэдээлэлд үндэслэн үнэт цаасны арилжаанаас ашиг олох замаар итгэмжлэлийн харилцааг эвдэх); зах зээлээр тоглох (зөвхөн тодорхой хувийн ашиг сонирхолд ашигтай байдлаар зах зээлийн хөдөлгөөнийг өөрчлөх, чиглүүлэх); няггтлан бодох бүртгэлийн зөрчил (санхүүгийн тайлангаас бодит мэдээллийг хасах бөгөөд гуйвуулах); үнэт цаасны тухай болон тэдгээрийг гаргаж буй компанийн талаар мэдээллийг худал, төөрөлдүүлэх байдлаар гаргаж өгөх явдал зонхилж байна.

Дээрх тохиолдолд SEC нь торгох хэмжээг тогтоох, хууль бусаар олсон орлогыг хураах, хувь хүн болон хуулийн этгээдэд үнэт цаастай холбоотой хууль бус ажиллагааг явуулахыг хориглох зэрэг эрх хэмжээтэй.

SEC-ийн бүтэц.

SEC-ийн удирдлага 5 гишүүдээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Сенатын санал болгосноор Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатайгаар томилно. Тэгэхдээ жил болгоны 6 дугаар сарын 5-ны өдөр зөвхөн нэг гишүүний хугацаа дуусахаар тохируулсан байдаг. SEC-ийн бие даасан байдлыг хангах үүднээс эдгээр гишүүдийн 3-аас дээш нь нэг намд харьяалагдахыг хориглодог. Ерөнхийлөгч нь эдгээр гишүүдээс нэгийг нь Тэргүүлэгчээр томилдог. Комисс нь байнгын бөгөөд хуралдаанаараа үнэт цаасны талаар хууль тогтоомжийг авч хэлэлцэх бөгөөд хүчин төгөлдөр буй дүрэм, журамд өөрчлөлт оруулах, зах зээлийн шинэчлэлтэй холбоотойгоор шинээр гаргах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. АНУ-ын стандартаар SEC нь холбооны жижиг агентлаг бөгөөд 3100 орчим орон тоотой, дөрвөн үндсэн хэлтсээс бүрддэг:

- корпоратив (арилжааны) санхүүгийн,
- зах зээлийн зохицуулалтын,
- хөрөнгө оруулалтын менежментийн,
- хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэс.

Корпоратив санхүүгийн хэлтэс (Division of Corporation Finance) нь мэдээллийг хянах үүрэгтэй. Тухайлбал, бүртгүүлэх тухай өргөдөл, жилийн болон улирлын тайлан, хувьцаа эзэмшигчдийн жилийн хурлын өмнө хувьцаа эзэмшигчдээс тараах итгэмжит саналын талаархи материал. Мөн үнэт цаасны тухай хууль болон түүний нэмэлт, өөрчлөлтөд тайлбар хийнэ. Нягтлан бодох бүртгэлийн хэлтэстэй хамт холбогдох байгууллагын үйл ажиллагааг ажиглан нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогыг нэвртүүлдэг. Тухайлбал, Нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс (Financial Accounting Standards Board, FASB) гаргадаг олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт (Generally Accepted Accounting Principles, GAAP).

Зах зээлийн зохицуулалтын хэлтэс (Division of Market Regulation) нь зах зээлийн үр дүнтэй болон зохион байгуулалтай, шударга явагдах үйл ажиллагааны жишгийг тогтоож, дэмжиж ажилладаг. Энэ чиг үүргийг зах зээлийн томоохон оролцогч болох брокер, дилерийн пүүс, Үнэт цаасны дилерүүдийн үндэсний нийгэмлэг (National Association of Securities Dealers, NASD), Орон нутгийн үнэт цаасны журам боловсруулах зөвлөл (Municipal Securities Rule Making Board, MSRB), мөн Depository Trust and Clearing Corporation, DTCC, National Securities Clearing Corporation, NSCC зэрэг клиринг агентлаг, үнэт цаасны талаархи мэдээллийг боловсруулан түгээдэг агент болон байгууллагын үйл ажиллагааг зохицуулах замаар хэрэгжүүлдэг. Зах зээлийн зохицуулалтын хэлтэс нь Үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах корпорац (Securities Investor Protection Corporation, SIPC)-ийн үйл ажиллагааг мөн хянадаг ба SIPC нь үнэт цаас даатгах болон корпорацийн гишүүн пүүсүүдийн дансанд буй үйлчлүүлэгчдийн бусад хэрэгсэлийг дампуурлаас даатгадаг хувийн хэвшлийн, ашгийн бус байна. SIPC нь зах зээлд унах, эсхүл залилангаас үүсэх алдагдлаас даатгадаггүй.

Хөрөнгө оруулалтын менежментийн (Division of Investment Management)

нь нийт 15 трлн. $-ийн хэмжээний хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог хянаж, зохицуулалт хийдэг байна. Мөн тухайлбал, Хөрөнгө оруулагч компани, хамтын сан, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцдаг.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэс (Division of Enforcement) нь үнэт цаасны тухай хуулийн зөрчлийг шалгах ба шаардлагатай тохиолдолд авах сахилгын арга хэмжээний талаар, эсхүл асуудлыг холбооны шүүх, эсхүл захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх талаар Үнэт цаас болон Биржийн комисст зөвлөмж гаргадаг; SEC –ийн нэрийн өмнөөс зөрчил гаргагчтай асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцээр хийдэг. Дээр дурдсанаар SEC нь зөвхөн иргэний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагын эрх хэмжээтэй.

SEC нь мөн 18 удирдах газартай бөгөөд эдгээрээс хамгийн нэр хүнд бүхий нь тохирлын хяналт, шалгалтын удирдах газар (Office of Compliance Inspections and Examinations, OCIE). OCIE нь хөрөнгийн зах зээлд оролцогчдыг байнга хянаж, шалгаж байдаг. OCIE-аас явуулж буй судалгаанд үндэслэн SEC нь үнэт цаасны тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж буйг хянаж, зөрчлийг илрүүлж байдаг. SEC нь OCIE-аас өгсөн мэдээлэлд үндэслэн эмитентод олгогдсон зөвшөөрлийг дахин харах, өөрчлөх, засах шаардлагатай байгааг илэрхийлсэн мэдэгдэх захидал илгээдэг (deficiency letters). OCIE нь ноцтой зөрчилийн талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэлтэст мэдэгдэх бөгөөд тухайн хэлтэс нь зөрчлийг арилгах арга хэмжээг авдаг.

Мужийн зохицуулах байгууллага.

АНУ-ын муж болгон үнэт цаасны өөрийн зохицуулах албатай. Эдгээр байгууллагын ажилтнууд мужийн хууль тогтоомжийн зөрчлийг шалгадаг.

1934 оны Securities Exchange Act нь үнэт цаасны нийтэд арилжих асуудлыг зохицуулсан. Энэ хуулийн дагуу Үнэт цаасны болон биржийн комисс (U.S. Securities and Exchange Commission, SEC) байгуулагдсан бөгөөд энэ нь АНУ-ын хөрөнгийн зах зээлийн үндсэн механизм юм.

Англи:

Үнэт цаасны зах зээл нь өмнө нь төрийн байгууллагаар биш, харин Лондонгийн хөрөнгийн биржээр зохицуулагддаг байсан байна. 1980 оноос Их Британи нь хөрөнгийн зах зээлийн өргөн хүрээний шинэтгэлийг хийсэн. 1988 онд Санхүүгийн үйлчилгээний тухай хууль[97] баталж үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг системчилж өгсөн. Энэ хуулиар үнэт цаасны зах зээлийг зохицуулах Үнэт цаасны болон хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулжээ. Эрх зүйн байдлын хувьд хуулиар Сангийн яамд харьяалагдах боловч төрийн байгууллага биш, харин үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий төрийн бус байгууллага. Мөн чанарынхаа хувьд хуулиар эрх хэмжээ нь тогтоогдсон өөрөө удирдах байгууллага юм. Энэ байгууллага нь санхүүгийн зуучлагчдад

[97] Дёринг Ханс-Ульрих. Универсальный банк – банк будущего. Финансовая стратегия на рубеже века: Пер. с нем.-М.:Междунар.отношения, 1999. с. 384.



тусгай зөвшөөрөл олгох эрх хэмжээтэй хэдий ч энэ чиг үүргээ бусад өөрөө удирдах байгууллагад шилжүүлсэн байна. Санхүүгийн салбарын шинэ шинэтгэлийн хүрээнд 1997 онд энэ салбар дахь бүх зохицуулах байгууллагыг Үнэт цаасны болон хөрөнгө оруулалтын зөвлөлийн үндсэн дээр нэгтгэж Санхүүгийн үйлчилгээний зөвлөл байгуулжээ. Энэ байгууллагад бусад төрийн байгууллага болон өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг шилжүүлжээ. Дарга болон удирдах зөвлөлийн гишүүдийг Сангийн сайд томилно. Санхүүгийн үйлчилгээний зөвлөлд Англиин төв банк, бусад санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани, даатгалын компани, тэтгэврийн сан, хадгаламж, клирингийн зэрэг байгууллагын хяналтын үүргийг шилжүүлжээ[98]. Энэ байгууллагын санхүүжилт нь хяналтанд байгаа байгууллага болох мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үйлчилгээний төлбөрөөс (тухайлбал, хөрөнгийн биржийн эргэлт зэрэг) болон Зөвлөлөөс үзүүлж буй бусад үйлчилгээний төлбөрөөс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл РРР зарчмын хэрэгжилт үүнээс харагдаж байна.

Санхүүгийн салбарын зохицуулах байгууллагыг нэгтгэх хандлага англиас гадна гадаад олон улсад ажиглагдаж байна. Эхний ээлжинд скандинавын орнуудад энэ процесс явагдсан бол хожим нь Япон, Солонгос, Унгар, Латви зэрэг улсад явагджээ.

Франц Улс:

Хөрөнгийн зах зээл дэх зохицуулалт Францийн хувьд Эдийн засаг, сангийн яамны харъяа олон шатлал бүхий байгууллагаас бүрддэг. Энэ зохицуулалтын үндсэн, гол байгууллага нь Биржийн арилжааны комисс (1967 онд байгуулагдсан) юм. Энэ комиссийн гол үүрэгт хөрнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах, мэдээллийн нээлттэй байх стандартыг хангах, хөрөнгө оруулалттай компаниудад тусгай зөвшөөрөл олгох, инсайдерийн арилжаанд хяналт тавих, мөн түүнчлэн хөрөнгө оруулагч нараас ирсэн гомдлыг хянах зэрэг багтана.

Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй. Эдгээр гишүүд Үндэсний Ассамблей, Сенат, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Төв банк зэргээс томилсон этгээд, бусад өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

Дараагийн байгууллага нь Санхүүгийн зах зээлийн зөвлөл юм. Энэ байгууллага нь үнэт цаасны компанийн болон биржийн үйл ажиллагааг хянах, Эдийн засаг, сангийн яамнаас батлах хөрөнгийн биржийн үйл ажиллагааг зохицуулах журам, дүрмийн төслийг боловсруулах чиг үүргэтэй. Энэхүү Зөвлөл Эдийн засаг, сангийн яамнаас томилох 16 гишүүдээс бүрдэнэ.

Францын биржүүдийн нийгэмлэг болох EURONEXT Paris (2000 он хүртэл Парижийн бирж) нь санхүүгийн төрөлжсөн байгууллага бөгөөд зах зээл дэх өдөр тутмын ажиллагааг хариуцна.

Францын санхүүгийн тогтолцоог яг энэ загварт хамаарна гэж үзэх нь хүндрэлтэй. Францын төрийн зохицуулалт, үүрэг өндөр. Францын эдийн

98http://www.pwc.com/Extweb/industry.nsf/docid/9EC5D5DDD1C5FDB085256DF6000EF523.

засгийн шинэтгэлийн үр дүнд герман загвараас англисаксон загвар луу шилжсэн гэж үзэх үндэслэлтэй.

ХБНГУ

Германд хөрөнгийн зах зээлийг олон төрлийн байгууллага зохицуулдаг. 1994 онд холбооны байгууллага болох Үнэт цаасны комиссийг байгуулсан. Комисс нь эмитентоос мэдээлэл цуглуулах, зах зээлийг хянах ба хууль тогтоомж, бусад журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг. Германы Үндсэн хуулийн онцлогоос (муж-газрын асуудал онцгой байр суурь эзэлдэг) хамааран холбооны байгууллагаас гадна Мужийн статс-комиссарын газрын төлөөлөгч мөн байна. ХБНГУ-д арилжааны банк нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн мэргэжлийн байгууллага байна. Иймд үнэт цаасны зах зээлийг зохицуулах чиг үүрэгт банкны хяналт ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Банкны холбооны хяналт шалгалтын танхим нь банкны болон үнэт цаасны компаниудад хөрөнгийн босгын хэмжээг баримталж буй байдал, балансын бүтэц гэх зэрэг үйл ажиллагаанд хяналт тавина.

Сүүлийн жилүүдэд германы үнэт цаасны зах зээл америкийн адил илүү нээлттэй болж байгаа нь нэг талаасаа эргээд америкийн үнэт цаасыг татах зорилготой юм.

Япон:

1948 онд Үнэт цаас болон биржийн комисс байгуулагдсан ба энэ байгууллага нь америкийн загвартай төстэй юм. 1951 онд энэ байгууллагын чиг үүргийг хялбаршуулж эрх хэмжээг нь Сангийн яамд шилжүүлж яамны харъяанд зөвлөлдөх байгууллага болох Үнэт цаас болон биржийн зөвлөл байгуулжээ. Энэ байгууллага нь энэ салбарын хууль тогтоомжийг боловсронгүй болгох чиглэлээр санал, зөвлөмжийг боловсруулах чиг үүрэгтэй байв. Харин 1990-1991 оны хөрөнгийн биржийн хямралын дараа инсайдер мэдээллийг хууль бусаар ашигласан, үнийг үндэслэлгүйгээр хэлбэлзүүлж зөрчил гарч байсан гэх үндэслэлээр Сангийн яамны дэргэд эргээд Үнэт цаас болон биржийн комисс байгуулсан бөгөөд энэ байгууллага нь зах зээлийн төлөв байдлыг ажиглах ба хянах үрэгтэй байв.

1998 онд санхүүгийн тогтолцооны шинэтгэлээр санхүүгийн зах зээл бүрэн либералчлагдаж хамтарсан хөрөнгийн хэрэгслээр арилжих эрхийг санхүүгийн холдингуудад олгосон. Үнэт цаасны компаниудад санхүүгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах, бүртгэх, ашиглах үйлчилгээ явуулах болон брокерын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байна. Үүний зэрэгцээ Ерөнхий сайдын дэргэд Санхүүгийн хяналтын агентлагийг байгуулсан. Энэ байгууллага нь улсын хэмжээнд бүх санхүүгийн тогтолцоог хянах байгууллага юм. Сангийн яам нь зөвхөн санхүүгийн бодлогыг тодорхойлох, валютын болон олон улсын санхүүгийн харилцааг чиглүүлэх үүрэгтэй.

ОХУ:

ОХУ-ын үнэт цаасны эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж нь ОХУ-ын Иргэний хууль, үүнээс гадна 1996 оны Үнэт цаасны зах зээлийн тухай холбооны хууль, 1995 оны Хувьцаат нийгэмлэгийн тухай холбооны



хууль юм. Тодорхой төрлийн үнэт цаасны эргэлтийг зохицуулсан хэм хэмжээ бусад төрлийн эрх зүйн актад тусгагдсан байдаг байна. Ерөнхийлөгчийн, Засгийн газрын болон бусад холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын актаар хуулийн зохицуулалтыг тодорхой болгож өгдөг бол Санхүүгийн зах зээлийн холбооны албаэрх хэмжээнийхээ хүрээнд холбогдох зохицуулалтыг гаргадаг.

Зохицуулах төрийн байгууллага нь Санхүүгийн зах зээлийн холбооны албабайна. Энэ албань 2004 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 314 дүгээр "Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо ба бүтцийн тухай" Ерөнхийлөгчийн зарлигаар өмнө нь байсан Үнэт цаасны холбооны комиссын чиг үүргийг уламжлан авч байгуулагдсан байна. Уг байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааны журам, зохион байгуулалтын асуудлыг 2004 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн Санхүүгийн зах зээлийн холбооны албаны асуудал (Вопросы федеральной службы по финансовым рынкам) Засгийн газрын тогтоол, мөн Засгийн газрын тогтоолоор 2004 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Санхүүгийн зах зээлийн холбооны албаны журмаар зохицуулсан байна.

Энэ байгууллага нь үнэт цаасыг гаргах, эргэлтэд оруулахыг зохицуулах; улсын бүртгэлийг хэрэгжүүлэх; үнэт цаас гаргач, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон Өөрийгөө зохицуулах байгууллага, хөрөнгө оруулалтын сан гэх зэрэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн практикийг нэгтгэх, боловсронгуй болгох санал боловсруулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах; хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны зах зээлд мэдээллийг хангах гэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн зах зээлийн холбооны албаны дарга, түүний орлогчийг Засгийн газар томилно. Зохион байгуулалтын хувьд дараахи статусын хувьд тэгш 10 албаны бүтэцтэй:

- Санхүүгийн зах зээлд дэх зохицуулалтыг хөгжүүлэх газар
- Хамтын хөрөнгө оруулалтыг зохицуулах, хянах газар
- Санхүүгийн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах газар
- Үнэт цаасны газар
- Үнэт цаасны зах зээлд тавигдах хяналтын арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх газар
- Хуулийн хэлтэс
- Бичиг хэрэг, архивыг хариуцах алба
- Эдийн засаг, санхүү болон няггтлан бодох бүртгэлийн хэлтэс
- Захиргаа-техникийн хангалтын алба
- Санхүүгийн зах зээлийн мэдээлэл, мониторингийн алба

Мөн бүтцэд нь бие даасан гурван нэгж багтана:

- Төрийн алба, хүний нөөцийн хэлтэс
- Нэгдүгээр хэлтэс
- Мобилизацийн бэлтгэлийн алба

Санхүүгийн зах зээлийн холбооны алба нь өөрийн үйл ажиллагаагаа шууд болон орон нутгийн байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлнэ. Холбооны улсын хэмжээнд 14 орон нутгийн салбартай.

Бүгд найрамдах Турк улс

Хөрөнгийн зах зээлийн хороо 1981 онд 2499 дугаар Хөрөнгийн зах зээлийн хуулиар байгуулагдсан. Бүрэн эрхээ өөрийн хариуцлагаар, хараат бусаар хэрэгжүүлэх, захиргаа болон санхүүгийн бие даасан зохицуулагч нийтийн байгууллага юм. Харъяалдаг сайд нь Ерөнхий сайдын үүрэг болгосон Төрийн сайд /Шадар сайд/ юм. Төв нь Анкарад байх бөгөөд Станбулд төлөөлөгчийн газартай байна. Хорооны үндсэн чиг үүрэг:

- Хөрөнгийн зах зээлийн итгэл нээлттэй, шийдвэртэй ажиллахыг,
- Хадгаламж эзэмшигчдийн өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах явдлыг хангах юм.

Хороо Засгийн газраас томилсон долоон гишүүнээс бүрдэнэ. Тэдний:

- Хоёрыг нь холбогдох сайдын нэр дэвшүүлсэн 4 хүнээс,
- Нэгийг нь Сангийн сайдын нэр дэвшүүлсэн 2 хүнээс,
- Нэгийг нь Үйлдвэр, Худалдааны сайдын нэр дэвшүүлсэн 2 хүнээс,
- Нэгийг нь Банкны зохицуулах болон хянах байгууллагын нэр дэвшүүлсэн 2 хүнээс,
- Нэгийг нь Туркийн Хөрөнгийн зах зээлийн зуучлагч байгууллагуудын нийгэмлэгээс нэр дэвшүүлсэн 2 хүнээс,
- Нэгийг нь Туркийн Танхимууд болон Биржийн нийгэмлэгийн нэр дэвшүүлсэн 2 хүнээс томилон.

Засгийн газар нэр дэвшигчдийн нэгийг даргаар томилно. Хорооны даргын саналаар гишүүдийн дундаас нэгийг нь дэд даргаар сонгоно. Хорооны дарга, гишүүд төрийн болон хувийн өөр ямар нэг үүрэгт ажил хавсарч болохгүй бөгөөд үүрэгт хугацаа 6 жил байна. Хугацаа нь дууссан гишүүн дахин томилогдох боломжтой. Даргаа бусад гишүүдийн гуравны нэгийг хоёр жилд нэг шинэчилнэ.

Хөрөнгийн зах зээлийн хороо, хорооны дарга, гишүүд болон хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц бүхий хорооны удирдлага дахь бүтцээс бүрдэнэ. Хорооны ажиллагаа даргын харьяан дахь даргын туслахын харьяанд ажиллах албадууд гүйцэтгэнэ. Албадууд:

- Хянан шалгах газар
- Компанийн санхүүгийн газар,
- Зуучлах үйл ажиллагааны газар,
- Компанийн хөрөнгө оруулагчдын газар,
- Судалгааны газар,
- Нягтлан бодох стандартын газар,
- Зах зээлийг хянах болон зохицуулах газар,
- Эрх зүйн газар,
- Мэдлэг, Статистик болон мэдээллийн газар,
- Захиргаа болон санхүүгийн газраас бүрдэнэ.

Албадууд хэлтсийн дарга, даргын туслах, мэргэжилтнүүд, хэлтсийн даргын бүтэц дэх үйлчилгээний нэгж болон албан хаагчдаас бүрдэнэ. Хороо

санхүүгийн бие даасан байна. Хорооны бүх зардлыг тусгай сангаас гаргана. Үнэт цаас гаргагчид (компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалтын компани) энэхүү санд гаргасан үнэт цаасны мянганы хоёртой тэнцэх хэмжээний төлбөр төлнө. Сангийн орлого хорооны зардалд хүрэхгүй тохиолдолд нээлттэй, төсвөөс авах тусламжаар үлдэгдлийг хаана.

Үнэт цаасны зах зээлд оролцдог зарим арилжааны банкны онцлог:

Арилжааны банк нь өөрийн олон талт чиг үүрэгтэй санхүүгийн байгууллагын хувьд үнэт цаасны зах зээлийн оролцогч байдаг. Гэхдээ улс болгонд арилжааны банкны үнэт цаасны зах зээлд эзлэх байр суурь янз бүр байдаг байна. Өнгөрсөн зууны 50-иад оны дундаас арилжааны банк үнэт цаасны зах зээлд шууд болон шууд бусаар нэвтэрч оролцож эхэлжээ. Зарим улс (АНУ, Япон, Канад)-ад арилжааны банкны санхүүгийн зах зээл оролцох эрхийг нь хязгаарласан байдаг боловч эдгээр нь трастын үйл ажиллагааны хэлбэрээр болон брокерийн пүүсээр дамжуулан, эсхүл хөрөнгө оруулалтын компани, банкыг санхүүжүүлэх хэлбэрээр шууд бус байдлаар оролцдог байна. Үнэт цаастай холбоотой ажиллагаанд идэвхтэй байдлаар германы арилжааны банк оролцдог. Үнэт цаастай холбоотой өргөн хүрээний ажиллагаанд оролцох боломжийг нь хуулиар зохицуулсан байдаг байна. Тухайлбал, эмитентийн чиг үүргийг (облигац гаргах) хэрэгжүүлж болохоос гадна зуучлагч, хөрөнгө оруулагчаар оролцож болдог байна.

Ихэнхи улсад арилжааны банк нь өөрийн ашгаа үнэт цаастай холбоотой болон хөрөнгө оруулалтын ажиллагаанаас олох орлогоос бүрдүүлэх хандлагатай байна. Арилжааны банкны үнэт цаасны зах зээлд оролцох хандлага нэмэгдсэнээр арилжааны банкаар толгойлуулсан банк, санхүүгийн том том группүүд байгуулагдах нөхцөл болжээ. Эдгээр санхүүгийн групп нь өөртөө хөрөнгө оруулалтын сан, брокерын пүүс, трастын компани, зөвлөх үйлчилгээ үзүүлэх пүүс, компаниудыг төвлөрүүлсэн бүтэцтэй байдаг.

Арилжааны банк өөрийн охин санхүүгийн компани байгуулж, мөн брокерын пүүсийн үйл ажиллагаанд шууд оролцох замаар хөрөнгийн зах зээлд байр суурыа олж байна. Үнэт цаасны зах зээлийн хил дамнаж хөгжиж байгаа нь мөн арилжааны банкинд илүү ашигтай гадаадын хувьцаа, облигацын эргэлтэнд оролцож (мөн ханшны зөрүү дээр тоглох замаар) үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлж байна. Ийм байгууллагын ихэнхи нь олон улсын түвшинд нэртэй байхаас гадна гадаадын банк, санхүүгийн байгууллагатай нягт холбоотой байдаг. Ихэнхи улсад арилжааны банкны шинэ төрлийн үйл ажиллагааны чиглэл бол санхүүгийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Энэ үйлчилгээгээ тодорхой санхүүгийн активд хөрөнгө оруулах үйлчлүүлэгчийн сонирхолд үзүүлдэг. Ийм туслалцааг банкны дотоод мэдээллийн тогтолцоонд тулгуурлан актив хөрөнгийн ашиг, эрсдэлийн харилцан хамааралд үнэлгээ хийх, ашгийн динамик үзүүлэлтийг харгалзан үнэт цаасны багц (portfolio) бүрдүүлэх, худалдан авах тооцоо боловсруулах зэргээр хийнэ.

Хөрөнгийн биржийн зарим онцлог:

Зарим улсад (Англи, АНУ) хөрөнгийн бирж нь хувьцаат нийгэмлэг

хэлбэртэй хувийн компани байдаг. Ийм бирж нь бие даасан байдалтай биржийн арилжааг явуулдаг. Бирж дээрхи бүх хэлцэл хууль тогтоомжийн дагуу явагдахаас гадна тухайн зохицуулалтыг зөрчсөнөөр тодорхой эрх зүйн хариуцлагыг үүрдэг.

Зарим улсад (Австри, Швейцар, Швед) бирж нь хувьцаат нийгэмлэг хэлбэртэй боловч холимог байдлаар, тухайлбал, 50% хувьцаа нь улсын мэдэлд байх хэлбэрээр байгууллагддаг. Ийм биржийг сонгуульт байгууллага удирдана. Гэхдээ биржийн комиссар нь биржийн үйл ажиллагааг хянахаас гадна албан ёсоор биржийн ханшийг бүртгэдэг.

Харин нэг хэсэг улсад (Казахстан, Киргиз, ОХУ) бирж нь ашгийн бус байгууллага байдаг. Ийм байгууллагын гол зорилго нь үнэт цаасны хэвийн эргэлтэд шаардлагатай нөхцөлийг хангах, зах зээлийн үнийг нь тодорхойлох, зохих мэдээллийг түгээх, мэргэжлийн оролцогчдын мэргэжлийн өндөр түвшинг тогтоож байх үүрэгтэй.

Мэргэжлийн байгууллага нь зохих тусгай зөвшөөрөлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулна. Ихэнхи улсад гурван төрлийн тусгай зөвшөөрөл мэргэжлийн байгууллагад олгогддог байна.

- Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл,
- бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл,
- хөрөнгийн биржийн тусгай зөвшөөрөл.

Ийм байдлаар тусгай зөвшөөрлийг тусгаарлан хуульчилж буй нь аливаа зөрчлийн асуудлаас урьчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагааг холин, давхардуулан хэрэгжүүлэхийг хязгаарласан байдаг байна. Өөрөөр хэлбэл бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг бүсад мэргэжлийн үйл ажиллагаатай хавсарган явуулж болохгүй.

Хөрөнгийн биржийн гишүүний статус улс болгонд харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал, АНУ, Англид хөрөнгийн биржийн гишүүд нь зөвхөн хувь этгээд, Итали, Геман, ОХУ, Казахстанд хувь болон хуулийн этгээд байдаг байна. Хөрөнгийн бирж үнэт цаасны холбоотой бирж дэх ажиллагааг явуулах журмыг тогтохоос гадна үнэт цаасыг арилжаанд гаргах (листинг), арилжаанаас гаргах (делистинг) журмыг, хэлцэлийг бүртгэх, хангах журмыг тогтоодог. Зарим улсад листингд эзлэх байр суурь нь татварын хөнгөлөлтийн үндэслэл болдог байна.

Өөрийгөө зохицуулах байгууллага:

Үнэт цаасны зах зээлд өөрөө удирдах байгууллага өндөр ач холбогдолтой. Өөрийгөө зохицуулах байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ашгийн төлөө бус сайн дурын байгууллага юм. Өөрийгөө зохицуулах байгууллагын эрх зүйн зохион байгууллагын хэлбэр нь бүх л улсад холбоо, нийгэмлэг хэлбэртэй байдаг.

Энэ байгууллага нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах оролцогчдын сайн дурын үндсэн дээр байгуулагддаг ба тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний биелэлтийг хангах, үнэт цаас эзэмшигч болон тухайн холбооны гишүүн



этгээдийн бусад үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах, Үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас үүрэг болгосны дагуу үнэт цаастай холбоотой ажиллагааг явуулах мэргэжлийн журам, стандартыг тогтоох, түүнийхээ хэрэгжилтийг хянах чиг үүрэгтэй.

Энэ байгууллага нь гол төлөв Үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас олгох зөвшөөрлөөр байгуулагдаж энэ байгууллагадаа тайлагнах үүрэгтэй байдаг байна. Олсон орлогоо гишүүддээ хуваарилахгүйгээр зөвхөн өөрийн дүрмийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа зарцуулна. Өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс зарим улсад эдгээр холбоо нь хөндлөнгийн арбитрын үүрэг гүйцэтгэх нэгжтэй байдаг байна. Харин ийм байгууллагын гишүүдийн гэрээнд арбитрийн тухай зохицуулалт байхгүй бол арбитрын байгууллагад эрхээ хамгаалуулахаар хандаж болдог байна.

Өөрийгөө зохицуулах байгууллага нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчийн итгэлийг татах хүчин зүйлсийн нэг болдог. Өөрийгөө зохицуулах байгууллага хөгжсөн улсад (АНУ; Англи, Герман, Франц) аливаа асуудлын гарц, шийдлийг мэргэжлийн зүгээс гаргадаг. Харин үнэт цаасны зах зээлийг зөвхөн төр хянадаг улсад ихэнх тохиолдолд асуудлыг шийдэхдээ үр дүн, өгөөж багатай, эсхүл хожимдуулж шийдвэр гаргадаг. Өөрийгөө зохицуулах байгууллага нь зөвшилцөлд үндэслэн шийдвэрээ гаргадаг. Мөн хариуцлагын хувьд төрийн санкцаас Өөрийгөө зохицуулах байгууллагын авах арга хэмжээ нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, бойкот үзүүлэх замаар (харьцаагаа хязгаарлах замаар) зөрчил гаргагчийг дампууралд хүргэж болно.

Хариуцлагын тогтолцоо:

АНУ-ын хувьд Үнэт цаасны болон биржийн комисс нь хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авдаг ба мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, эсхүл тухайн хуулийн этгээдэд, мөн үнэт цаас гаргагчдад торгууль тавих эрхтэй.

АНУ-ын хууль тогтоомжоор Комисс нь 500 мянган долларын торгууль тавих эрхтэй. Үүнээс гадна үнийг хууль бусаар өсгөж, бууруулсан бол хувь этгээдэд 1 сая доллар, эсхүл 10 хүртэл жил хорих ял, хуулийн этгээдэд 2,5 сая долларын тогтох ялаар шийтгэдэг байна. Харин дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд хувь этгээдэд 5-100 мянган доллар, хуулийн этгээдэд 50-500 мянган долларын торгууль тавьдаг байна. Мөн мэргэжлийн байгууллага дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд Комисс нь тухайн мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдлын хэмжээг гурав нугалсан хэмжээний торгууль тавих эрхтэй. Энэ тохиолдолд хяналт тавьж байсан этгээдийг торгож бас болно. Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих хэргийн хөөн хэлэлцэх хугацаа иргэний хэргээс их буюу 5 жил байдаг байна.

Дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журам зөрчсөнийг илрүүлэхэд мэдээллээр тусалсан этгээдэд Комисс нь торгуулийн 10% хүртэл хэмжээний шагнал, урамшуулал олгох эрх хэмжээтэй. Торгуулийн санкцаас гадна Комисс нь холбогдох этгээдийн бусад үйл ажиллагааг нь хязгаарлах арга хэмжээ авах боломжтой. Мөн Комисс нь тухайн байгууллагыг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах тухай шүүхэд хүсэлт гарган шийдвэрлүүлэх боломжтой.

Европын зохицуулалт нь мөн хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг шийтгэх үр дүнтэй зохицуулалттай. Захиргааны хариуцлагаас торгууль нь өргөн хэрэглэгддэг. Тухайлбал, Англид дотоод мэдээллийг ашиглан арилжаа эрхлэх журмыг зөрчих тохиолдолд 7 хүртэл жилээр хорих, эсхүл торгох шийтгэлийг ногдуулж болдог байна. Мөн энэ хоёрыг нэгтгэсэн байдлаар ч хариуцлага хүлээлгэж болдог байна. Дотоод мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдал болох хэмжээг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч болно.

Франц улсад энэ төрлийн хэрэгт 2 сараас 2 жил хүртэл, эсхүл (болон) 6000 – 10 сая франк буюу дотоод мэдээллийг ашиглан олж авсан орлого, эсхүл тухайн мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлсэн учирч болох байсан алдагдлын хэмжээг арав нугалсан хэмжээний торгууль тавина.

Дүгнэлт

Өөрийгөө зохицуулах байгууллагын үнэт цаасны зах зээлд үзүүлэх эерэг нөлөөнөөс гадна сөрөг нөлөөг харгалзан үзэх ёстой.

Тухайлбал, тодорхой хүрээ (холбоо)- гээр хязгаарласан монополи тогтоох боломжтой ба эрх мэдэл, нөлөөлөл хуваах нөхцөл бүрддэг. Хэдий мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах журам, стандарт гаргах боловч түүнийгээ хэрэгжүүлэх эрх зүйн хөшүүрэггүй байдаг. Мөн ийм байгууллагад гишүүнээр сайн дурын үндсэн дээр нэгддэг боловч хэн хэзээч нэг ийм байгууллагаас гарч өөр байгууллагад орох эрхтэй байдаг. Энэ тохиолдолд хяналт, зохицуулалтаас дүрвэж сул, ёс зүйн хувьд чөлөөтэйд орох магадлалтай. Эдгээр байгууллага нь зиндаархаж, чиглэл зааж хаалттай клуб болох боломжтой. Иймд манай улсын хувьд дэвшилттэй улсын практикийг даган Өөрийгөө зохицуулах байгууллагыг хөгжүүлэх шаарлагатай боловч дээрхи сул талыг нь тооцон хандах (тоон хязгаар тавих, г.м.) нь зохимжтой.

Үнэт цаасны зах зээл хөгжсөн зарим улсын практикт шинжилгээ хийж листингд эзлэх байр сууриар нь татварын хөнгөлөлтийн үндэслэл болдог тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай байна. Энэ нь үнэт цаасны зах зээлийн үр нөлөөгөөр эдийн засгийг хөгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг болох листингд баталгаатай байр суурь эзлэх, хөрөнгө оруулагчийн итгэл, сонирхолыг нэмэгдүүлж буй компанид үзүүлэх урамшуулын тогтолцоо болно.

Гадаад улсын практик, олон улсын стандартыг баримтлан Үнэт цаасны

зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход баримтлах үндсэн чиглэл:

- үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг иргэний эрх зүйд үндэслэн боловсронгуй болгох
- хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхолыг хамгаалах, зах зээл дээрхи хууль бус үйл ажиллагааг хориглох, үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогч байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, захиргааны болон эрүүгийн эрх зүйн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох
- үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх үүднээс нөхөн олговрын олон хувилбар, хэлбэрийг нэмэгдүүлэх,
- Мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох
- Удирдлагын зохистой хэлбэрийг хөгжүүлэх,
- Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн шаардлагыг шалгах улсын хяналтыг боловсронгуй болгох, мэргэжлийн үйл ажиллагаанд өндөр мэргэшил, хөрөнгийн баталгаа, шударга, нээлттэй байх стандартын асуудлаар тусгай зөвшөөрлийн шаардлагыг нэмэгдүүлэх,
- Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах тэгш нөхцөл, чөлөөт өрсөлдөөнийг хөгжүүлэх
- Бие даасан олон нийтийн хяналтыг тогтолцоог хөгжүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд оролцуулах нөхцөл, орчныг бүрдүүлэх
- Монголын үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах нөхцөл, орчныг бүрдүүлэх
- Компанийн удирдлага /манайд "Компанийн засаглал" гэж томъёолсон байгаа/-ын олон улсын стандартыг үнэт цаасны зах зээлд оролцох компаниудад нэвтрүүлэх,

ТАВДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУРТАЛЧИЛГАА БА ИРГЭДИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН БАЙДАЛ

5.1. СУДАЛГАА ЯВУУЛСАН БАЙДАЛ

Иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдал, энэ талаар тэдэнд хүрч буй хууль тогтоомжийн сурталчилгааны төлөв, үр өгөөжийг судлан тогтоохын тулд нийслэл, орон нутгийн хэмжээнд ихээхэн өргөн хүрээг хамруулан судаллаа.

Иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдал, хууль тогтоомжийн сурталчилгаа явуулж буй байдал, үр өгөөжийн талаар иргэдээс авах санал асуулгад зориулан 13 асуулт бүхий санал асуулгын хуудас боловсруулж, уг асуулгын хуудсаар 1100 иргэнээс санал асуулга авч, саналыг төрөлжүүлэн авч үзсэн болно.

Иргэдийн үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл ямар түвшинд байгаа, түүнчлэн үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл олж авахад учирч буй бэрхшээл нь иргэдийн нас, боловсрол болон нийслэл, хөдөө орон нутагт амьдарч буй байдлаас хамаарч буй эсэхэд дүгнэлт хийх зорилгоор санал асуулгын судалгааг нийслэл, хөдөө орон нутгаас адил тоогоор авсан болно.

Санал асуулгын судалгааны үр дүнгийн магадлалыг тандах, судалгааны бодитой байдлыг хангах зорилгоор Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад биечлэн очиж, зохих иргэд, албан тушаалтнаас ярилцлагын аргаар судалгаа авлаа.

Санал асуулгын болон ярилцлагын аргаар хийсэн судалгаанд иргэн, төр захиргааны байгууллагын албаң хаагч, шүүгч, өмгөөлөгч гэх мэтчилэн давхардсан тоогоор 1208 хүн оролцож санал өгчээ.

Мөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг уншиж судалж байх явцад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн байдлыг судалж үзсэн болно.

5.2. ИРГЭДИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН БАЙДАЛ

5.2.1.Хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбарыг хэрхэн зарцуулсан

Санал асуулгын судалгаанд оролцогчдын "хувьчлалын цэнхэр болон ягаан тасалбарыг хэрхэн зарцуулсан" байдлыг судалж үзэхэд судалгаанд хариулт өгсөн 1012 иргэний 13.1% нь тухайн үед ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулсан, 43.7% нь өөрөө зарцуулаагүй буюу эцэг, эх нь зарцуулсан, 18.1% нь бусдад бэлэн мөнгөөр худалдсан, 24.9% нь таслбарыг хэрхэн зарцуулснаа мэдэхгүй байна гэж хариулжээ. Харин асуулгад хариулсан орологчдыг насны ангиллаар нь авч үзвэл 35-аас доош насны иргэдийн 83.3% нь цэнхэр болон ягаан тасалбарыг өөрөө

зарцуулаагүй, эсвэл хэрхэн зарцуулснаа мэдэхгүй гэх хариултыг өгчээ. Харин 36-аас дээш насны иргэдийн 21.7% нь цэнхэр болон ягаан тасалбараа ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулж, 27.7% нь бусдад бэлэн мөнгөөр худалджээ[99].

Харин судалгаанд оролцогчдын амьдарч буй нутаг дэвсгэрийн харъяаллаар авч үзэхэд нийслэл, орон нутаг гэх үзүүлэлтийн хувьд төдийлөн ялгаа байгаагүй боловч хөдөө орон нутгийн иргэд хувьчлалын тасалбараа ажиллаж байсан байгууллагадаа хөрөнгө оруулах замаар зарцуулсан нь нийслэлд амьдарч буй иргэдтэй харьцуулахад 46.1%-аар илүү, тухайн үед бэлэн мөнгөөр худалдсан нь 44.8%-аар илүү байлаа[100]. Энэхүү дүн нь хөдөө орон нутгийн иргэд хувьчлалын тасалбарыг хэрхэн зарцуулах аргаа мэдэхгүй байснаас гадна тэднийг ажиллуулж байсан байгууллагын удирдлага болоод бусад этгээдүүд энэ байдлыг туйлын овжин ашиглаж, иргэдийн үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцох эрхийг зөрчиж байсан гэх дүгнэлтэд хүргэж байна.

Үүнээс харахад иргэд үнэт цаасыг хэрхэн зарцуулах арга замаа мэдэхгүй, энэ талаархи мэдээ, мэдээлэл хомс байснаас хувьцааг хөрөнгө оруулалт хэлбэрээр бусдад өгсөн бөгөөд үүнээс ногдол ашиг аваагүй, мөн хувьцааг хэрхэн зарцуулснаа буюу яаснаа мэдэхгүй байсан юм. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны талаархи мэдээ мэдээлэл хомс байсан нь хувьчлалын тасалбарын зарцуулалтад сөргөөр нөлөөлжээ.

Хувьчлалын цэнхэр, ягаан тасалбарын зарцуулалтын талаархи санал асуулгын дүнг магадлах зорилгоор иргэдтэй биечлэн уулзаж ярилцахад:

- цэнхэр, ягаан тасалбар гар дээр нь байхгүй, брокерийн компанид л байдаг байх, яасныг мэдэхгүй байна;
- хэзээ ч ямар нэг ногдол ашиг авч байгаагүй, үүнийг мэдэж хөөцөлдөө ч үгүй, аль нэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж үзээгүй, хурал болох тухай хэн нэгэн мэдэгдэж байгаагүй;
- цэнхэр, ягаан тасалбар байгаа, тэр одоо хэрэггүй болсон биз дээ, хувьчлалын тасалбарыг иргэд бидэнд хуваарилж байх тэр үеэр л зарж борлуулах ёстой байсан тэгж чадаагүй;
- зарим хувьцаагаа үнэтэй борлуулж, үнэд хүрэх магадлалтай гэж үзэж хэдэн ширхэг хувьцаа авсан байсан юм. Түүнийгээ зарах санаатай очтол орон нутгийн брокерийн компани надаас асуулгүйгээр борлуулчихсан байсан, тэгээд та зөвшөөрч, гарын үсэг зурсан учраас манайх ажлаа л хийсэн гэж мэлзээд өнгөрсөн. Түүнээс хойш хувьцаагүй болсон гэж бодоод тэр тухай сонирхохоо больсон;
- Үнэт цаасны арилжаа явагддаг эсэх талаар мэдэхгүй, арилжааны зар хүргэгддэггүй, арилжаа хаана явагддаг нь ч тодорхойгүй гэх мэтчилэн ярьж байлаа.

Мөн санал асуулгын судалгаанд оролцсон иргэдийн хувьчлалын

[99]Хавсралт зураг 1-ийг харна уу.
[100]Хавсралт зураг 2-ыг харна уу.

цэнхэр болон ягаан таслбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулсан эсэхийг судлахад 23.7% нь хариулаагүй буюу мэдэхгүй гэсэн бол 17.8% нь тухайн үедээ ашигтай байсан гэж, 3.9% нь одоо хүртэл ногдол ашиг авч байгаа тул ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэж хариулжээ. Гэтэл асуулгад хариулагчдийн 54.5% нь ашигтай хөрөнгө оруулалт хийгээгүй гэж хариулснаас[101] үзэхэд иргэд хувьчлалын тасалбараа ашигтайгаар зарцуулж чадаагүй байна гэх дүгнэлтэд хүрлээ.

Иргэдийн хувьчлалын тасалбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэх үнэлгээ тэдний нас, боловсрол, амьдарч буй нутаг дэвсгэрийн харъяаллаар төдийлөн ялгаатай бус байсан боловч орон нутгийн иргэдийн хувьчлалын тасалбараар өөртөө ашигтай хөрөнгө оруулсан гэх үнэлгээ нийслэлийн иргэдийн үнэлгээнээс 59.2%-аар, тухай үедээ ашигтай байсан гэх үнэлгээ 70.4%-аар илүү байлаа[102]. Энэ нь орон нутгийн иргэд хувьчлалын тасалбарааралаа нийслэлийн иргэдээс ашигтай хөрөнгө оруулалт хийсэн гэх дүгнэлтэд хүргэсэн юм.

5.2.2. Үнэт цаас гэж юу вэ?

Иргэдийн үнэт цаасны талаархи ойлголт ямар түвшинд байгааг санал асуулгын аргаар судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 44.2% нь энэхүү асуулгад хариулаагүй, харин 55.8% нь дор дурдсанаар хариулжээ. Судалгаанд оролцогчдын:

- 40 нь буюу 0.3% нь үнэт цаасыг арилжааны зүйл буюу ашигтай зүйл гэж;
- 114 нь буюу 10.3% нь буюу мөнгө, өмч хөрөнгө буюу өмч хөрөнгийн нэг хэлбэр гэж;
- 22 нь буюу 2% нь энгийн л цаас буюу залилан мэхлэх арга гэж;
- 112 нь буюу 10.1% нь хөрөнгийн баталгаа гэж;
- 38 нь буюу 3.4% нь Засгийн газар, аж ахуйн нэгж болон эрх бүхий байгууллагаас гаргадаг бичиг гэж;
- 82 нь буюу 7.4% нь хувьцаа эзэмшигчийн эрхийн гэрчилгээ, хувьцаа гэж;
- 56 нь буюу 5.09% нь ноогдол ашиг авах бизнесийн нэг төрөл гэж;
- 11 нь буюу 1% нь биет бус хөрөнгө гэж ойлгодог бол 138 нь буюу 12.5% нь мэдээлэл байхгүйгээс мэдэхгүй гэж хариулжээ[103].

Судалгааны энэхүү дүнгээс дүгнэж үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн 56.7% нь үнэт цаасны талаар тодорхой ойлголтгүй буюу мэдлэггүй /асуулгад хариулаагүй оролцогчийг үнэт цаасны талаар тодорхой ойлголтгүй байна гэж үзэхэд/, 12.1% нь үнэт цаасны талаар буруу ойлголттой байлаа.

[101] Хавсралт зураг 3-ыг харна уу.
[102] Хавсралт зураг 4-ийг харна уу.
[103] Хавсралт зураг 5-ыг харна уу.

5.2.3. Одоо эзэмшиж буй үнэт цаас

Иргэдээс одоо ямар үнэт цаас эзэмшиж байгааг нь санал асуулгын аргаар асууж судлахад судалгаанд оролцогчдын 35% нь хариулаагүй, 21.8% нь ямар нэг үнэт цаас эзэмшдэггүй гэж хариулсан бол үнэт цаас эзэмшдэг хэмээн хариулсан оролцогчид дараахь нэр төрлийн үнэт цаасыг дор дурдсан хувиар эзэмшдэг гэж хариулсан юм. Судалгаанд оролцогчид /давхардсан тоогоор/-ын:

- 14.8% нь хувьцаа;
- 5.7% нь эрх бүхий байгууллагаас олгодог гэрчилгээ;
- 1.3% нь Засгийн газрын бонд;
- 2.4% нь өрийн бичиг;
- 0.4% нь вексель;
- 3.7% нь чек;
- 0.2% нь опцион;
- 3% нь банкны сертипикат;
- 13.7% нь бусад төрлийн үнэт цаас эзэмшдэг гэж хариулжээ[104].

Үнэт цаас эзэмшиж буй оролцогчдыг насны байдлаар харьцуулж үзэхэд үнэт цаасны төрлөөс шалтгаалан харилцан адилгүй байлаа.

5.2.4. Иргэдийн хамгийн сайн мэдэх үнэт цаас

Судалгаанд оролцсон иргэдээс ямар үнэт цаасыг хамгийн сайн мэдэхийг асуулгын аргаар судлахад давхардсан тоогоор 53.1% нь хувьцаат компанийн хувьцааг, 25.6% нь Засгийн газрын бондыг, 9.5% нь өрийн бичгийг, 6% нь векселийг, 26.1% нь чекийг, 4.2% нь опционыг, 12.2% нь банкны сертификатыг, 6.3% нь бусад үнэт цаасыг сайн мэднэ гэжээ[105].

Судалгаанд оролцогчдыг насны байдлаар харьцуулж үзэхэд 18-45 насныхан илүү олон төрлийн үнэт цаасыг мэддэг ажээ.

Үнэт цаасны талаар иргэд хэрхэн ойлгодог талаар ярилцаж үзэхэд үнэт цаасыг цэнхэр, ягаан тасалбар, хувьцаа гэхээс өөрөөр нэрлэж мэдэхгүй байлаа.

5.3. ҮНЭТ ЦААСНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУРТАЛЧИЛГАА

5.3.1.Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг хаанаас олж авдаг болох

Санал асуулгын судалгаанд оролцсон иргэдээс үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг ямар эх сурвалжаас олж мэддэгийг асуухад судалгаанд оролцогчид давхардсан тоогоор дараахь байдлаар хариулт өгсөн юм. Үүнд:

- Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг теливизээр олж авдаг гэж 53.2% нь;

[104]Хавсралт зураг 6-г харна уу.
[105]Хавсралт зураг 7-г харна уу.

- Сонин хэвлэлээс олж авдаг гэж 23.9% нь;
- Хөрөнгийн биржээс гаргадаг сэтгүүлээс олж авдаг гэж 5.8% нь;
- Хувь хүнээс мэдээлэл олж авдаг гэж 8.7% нь;
- Интернетээс мэдээлэл авдаг гэж 13.9% нь хариулсан байна.

Харин судалгаанд оролцогчдын 24.6% нь үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл олж авч чаддаггүй гэж хариулсан бол 3.4% нь асуулгад огт хариулаагүй байна[106].

5.3.2. Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа

Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт ямар түвшинд байгаа талаар санал асуулгын судалгаанд оролцсон иргэдээс асуухад 2.4% нь хариулаагүй бол 80.3% нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт хангалтгүй, 14.8% нь дунд зэрэг, 2.4% нь хангалттай сайн гэж дүгнэсэн байна.

Судалгаанд оролцогчдын дүгнэсэнээс харахад орон нутагт үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа маш хангалтгүй байдаг нь харагдаж байлаа.

Судалгаанд оролцогчид үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа хангалтгүй байгаа шалтгааныг тогтоох зорилго бүхий асуулт тавихад судалгаанд оролцогчдын:

- 45% нь мэдээлэл байхгүй, сурталчилгаа хангалтгүй гэж;
- 5.7% нь төрийн бодлого хангалтгүй гэж;
- 2.5% нь үнэт цаас ач холбогдолгүй тул хэрэглээ бага, зах зээл байхгүй гэж;
- 6% нь мэргэжлийн байгууллага байхгүй, Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хангалтгүй гэж;
- 1.6% нь үнэт цаасны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчний нөөц байхгүй гэж;
- 0.8% нь хариуцлага байхгүйгээс гэж;
- 0.09% нь орон нутгийн хөгжил, иргэдийн ухамсар хангалтгүйгээс гэж;
- 8.7% нь хууль тогтоомжийн сурталчилгаа хангалтгүй байгаа шалтгааныг мэдэхгүй гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын 36.2% нь ямар нэг хариулт өгөөгүй байна[107].

Иргэдээс ярилцлагын аргаар судалгаа авахад иргэд төдийгүй төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид ч үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэлгүй, үнэт цаасны эрх зүйн харилцаанд оролцдоггүй болох нь тогтоогдож байлаа.

Мөн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд хууль тогтоомж сурталчлах ажил хийдэг ч ихэвчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон нийгмийн халамжийн чиглэлийн хууль тогтоомжийн

[106] Хавсралт зураг 8-ыг харна уу.
[107] Хавсралт зураг 9-ийг харна уу.



сурталчилгаа хийдэг, үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажил хийдэггүй байна.

Хөдөө орон нутагт буюу Дархан-Уул, Орхон аймаг дахь Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчид үнэт цаасны талаар мэдээлэл өгөх, үнэт цаасны тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн телевизээр ярилцлага нэвтрүүлэг хийхээс гадна нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, иргэдэд мэдээлэл хүргэжээ. Гэвч тус аймгуудын иргэдийн үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэл мөн л хомс байлаа.

Санал асуулгын аргаар судалгааг авахдаа судалгаанд оролцогчийн нас, боловсролын байдлыг үзүүлэлт болгон дүгнэхэд хувьчлалын тасалбарыг зарцуулсан байдал, үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэл, түүнийг олж авч буй байдал насны ангилал болоод боловсролын түвшингээр төдийлөн ялгаатай байсангүй. Өөрөөр хэлбэл, иргэд массаараа үнэт цаасны талаар мэдлэг, мэдээлэл муутай, үнэт цаасны талаархи мэдээлэл хомс, сурталчилгаа муу гэх дүгнэлтэд судлаачдыг хүргэсэн юм.

5.4. ДҮГНЭЛТ

Социологийн судалгаанд хамрагдагсдын 68.6% нь хувьчлалын тасалбараа хэрхэн зарцуулснаа мэдэхгүй, эсвэл зөв зарцуулаагүй, 56.7% нь үнэт цаасны талаар тодорхой ойлголтгүй буюу мэдлэггүй, 12.1% нь үнэт цаасны талаар буруу ойлголттой, 45.2% нь л үнэт цаас эзэмшиж байгаа, давхардсан тоогоор 53.1% нь хувьцаат компанийн хувьцааг, үлдэх 46.9% нь үнэт цаасны бусад төрлийг маш бага хувиар мэддэг, 80.3% нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа орон нутагт хангалтгүй гэж дүгнэснээс харахад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийн түвшин маш муу, үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаа маш хангалтгүй байна.

Иргэд нас, боловсролоос хамаарахгүйгээр буюу нийт массаараа үнэт цаасны талаархи мэдлэг, мэдээлэлгүйгээс хувьцаа эзэмшигчийн хөрөнгө үхмэл байгаа, үүний улмаас иргэд хөрөнгийн зах зээлд итгэх итгэлгүй, Монгол Улсад хөрөнгийн зах зээл зогсонги байдалтай байна.

Судалгааны явцад иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг эерэгээр үнэлэн сайшаах зүйл ажиглагдсангүй. Иймхүү иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэг хомс, муу байгаа нь үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилгаатай шууд холбоотой тул үнэт цаасны хууль тогтоомжийг иргэдэд таниулан сурталчилах ажлыг сайжруулж, улмаар иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Үнэт цаасны хууль тогтоомжийн сурталчилах ажлыг сайжруулж, иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

1.Үнэт цаасны талаархи мэдээ, мэдээллийг нийтэд хүртээлтэй бөгөөд үр өгөөжтэй хэлбэрээр түгээх шаардлагатай. Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 53.2% нь үнэт цаасны талаархи

мэдээ, мэдээллийг телевизээс олж авдаг байх тул телевизээр цуврал нэвтрүүлэг явуулах болон өөр бусад хэлбэрээр үнэт цаасны талаархи мэдээ, мэдээлэл нэвтрүүлж, хууль тогтоомжийг сурталчилах;

2.Хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг иргэдийн үнэт цаасны талаархи эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчлахад чиглүүлэх, уялдуулах;

3.Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын суртгалтын төлөвлөгөөнд үнэт цаасны хууль тогтоомжийн талаар сэдэв оруулж, үнэт цаасны талаархи мэдлэг олгож, мэдээлэл өгөх;

4.Бүх төрлийн хэвлэл, мэдээлэлд үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчилах, иргэдэд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох зорилго бүхий булан, нэвтрүүлэг бий болгох;

5.Хөрөнгийн биржээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4-т заасны дагуу явуулах үйл ажиллагааны хүрээнд иргэд, харилцагчдыг мэдээллээр хангахаас гадна үнэт цаасны талаархи мэдлэг олгох чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааж, Хөрөнгийн бирж энэхүү чиг үүргийн хүрээнд тодорхой ажлыг төлөвлөн ажилладаг тогтолцоог бий болгох, Хөрөнгийн биржийн энэхүү үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороонооос хяналт тавих чиг үүргийг хүлээлгэх;

6.Хөрөнгийн биржээс үнэт цаасны арилжаа явуулах журам, арилжаа явагдах цаг хугацаа, бирж дээр арилжихаар зөвшөөрөгдсөн үнэт цаасны жагсаалт, арилжааны үр дүн гэх мэдээллийг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр шуурхай мэдээлж байх тогтолцоог боловсронгуй болгох;

7.Ерөнхий боловсролын болон Их дээд сургуулийн сургалтын хөтөлберт үнэт цаасны талаар мэдлэг олгох хичээлийг зохих төлөвлөгөөний дагуу оруулахаар тусгах;

8.Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг илүү нээлттэй болгож, иргэдэд чиглүүлэх;

9.Санхүүгийн зохицуулах хороонд Хувьцаат компаниас хувь нийлүүлэгчдийн хурал хийж буй байдал, ногдол ашиг тарааж буй байдал, хувь нийлүүлэгчдийн эрх ашиг зөрчигдөж буй эсэхэд хяналт тавьж, зохих арга хэмжээ авах бүрэн эрх олгох.

МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд хийх мониторингийн хүрээнд Дархан-Уул, Орхон-Уул, Булган аймагт биечилэн судалгаа хийж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээлэл ямар байгааг судалсан. Мөн андеррайтер, дилер, брокерынн үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага болон Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчтэй, шүүгч, өмгөөлөгч, их дээд сургуулийн багш, судлаач нарыг хамруулан уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа.

Үүний хүрээнд:

Нэг. Аймаг, сумын өөрөө удирдах болон төрийн захиргааны эрх бүхий албан тушаалтан, ажилтан нийт-15;

Хоёр. Хувьцаат компаний удирдлага-4; нягтлан бодогч-3;

Гурав. Улсын Дээд шүүх, аймаг, нийслэл, сум, дүүргийн шүүхийн шүүгч-30; нарийн бичгийн дарга, туслах-29;

Дөрөв. Орон нутаг дахь СЗХ-ны төлөөлөгч-2;

Тав. Их, дээд сургуульд үнэт цаасны эрх зүй, бизнесийн эрх зүйн хичээл заадаг багш-5; өмгөөлөгч-6;

Зургаа. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын дарга, мэргэжилтэн-6 хүнтэй тус тус уулзсан.

Нэг. 1.1. Аймаг, сумын өөрөө удирдах болон төрийн захиргааны эрх бүхий албан тушаалтан

Үнэт цаасны талаар мэдээлэл хомс, иргэд болон төрийн албан хаагчид мэдлэг муу. Үнэт цаасны хууль тогтоомжийг сурталчлах ажил хийгээгүй. Хуулийн сурталчилгаа хийдэг ч иргэд сургалтад идэвхтэй оролцдоггүй. Үнэт цаасны талаархи гомдол, маргаан гарч байгаагүй. Хууль тогтоомжийн хэрэгжилт ямар байгааг хэлж мэдэхгүй. ҮЦТХ-ийг уншиж байгаагүй. Үнэт цаасны тухай хуулийг сонсож байсан мэдлэгээ бататгаагүй. Үнэт цаас, хувьцаа, брокерын пүүсийн талаар юу байдгийг хүмүүс мэддэггүй. Сурталчилгааны ажил шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн талаар бусад аймгийг бодвол мэдээлэл сайтай. Иргэдийн мэдээлэл авах боломж сайн. Эрдэнэтэд хууль зүйн мэдээ сонин гардаг, хууль тогтоомжийн сурталчилгаа, сургалтын талаар бусад байгууллагтай хамтарч ажилладаг. Радиод цаг авч, Эрх зүйн мэдээ сонин гаргадаг, үнэгүй. ТВ-тэй хамтарч ажилладаг.

- Брокерын пүүс байснаа цэнхэр ягаан тасалбарыг аваад алга болсон
- Гурилын үйлдвэр хувьцааны ногдол ашиг тарааж байсан. Сүүлийн 3 жил большсон. Нэг хэсэг хотоос хүмүүс ирж худалдан авч байсан. Тасалбараа “Сор” үслэг эдлэлийн ХК-д өгсөн. Одоо хаана байгааг мэдэхгүй.
- Цэнхэр, ягаан тасалбартай холбоотой гомдол ирж байгаагүй. Гомдол санал ирж байгаагүй.
- 7 хоногийн 1 өдөрт сургалт зохиодог. ҮЦ-ны хэлбэрийг багасгасан

талаар мэдээлэл хийж байсан

- Тасалбарыг брокерын пүүсээр дамжуулан нэлээд хэдэн ХК-д өгч байсан. ХК-д дампуурсан, нь татан буугдсан. ХХК болсноор яасан нь мэдэгдээгүй. ХК-статистик гаргадаг.
- Хуучин брокерийн пүүс хаана байгаа вэ, хэн гэдэг хүн одоо ажиллаж байгаа вэ?

1.2. Аймаг, сумын өөрөө удирдах байгууллагын зарим ажилтан:

Иргэдэд ном гарын авлага тараах, сурталчлах, таниулах, ойлгуулах шаардлагатай. Ийм зүйл дутагдаж байна. Иргэдэд мэдээ, мэдээлэл хомс, үнэт цаасны талаар ойлголт муутай. Тодорхой чиглэлээр дагнан хууль тогтоомжийг сурталчлах ажил хийдэггүй. Үнэт цаасны талаар мэдлэг муу. Хуулийг сурталчлаад, ойлгуулаад байвал хүмүүс энэ чиглэлийн мэдлэгтэй болно. Ингэснээр хууль хэрэгжинэ. Хууль гардаг ч иргэдэд хүрдэггүй. Олон нийтэд шууд хүргэх асуудал чухал байна. Иргэд өөрсөддөө хэрэгтэй хуулийг сайн мэддэг, бүр асууж ирдэг. Мэдэж байх ёстой хуулийн талаар мэдээлэлгүй байхаас гадна асуудаг ч үгүй.

Үнэт цаас, хувьцаа, цэнхэр, ягаан тасалбартай холбоотой гомдол хүсэлт ирж байгаагүй. Цэнхэр ягаан тасалбарын учрыг олоогүй, яаснаа мэддэггүй. Ач холбогдлыг мэдрээгүй, үр дүнгүй өнгөрсөн. Тасалбарууд хаана хэнд байгааг мэдэхгүй.

- Торгууль, шийтгэвэрийг үнэт цаас гэж ойлгож байна.
- Хувьцаа нь хэтэрхий тааруу байна.
- Хувьцаа эзэшигчдийн саналыг авч байх механизм бий болгох.
- Жижиг хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийг хамгаалах, ногдол ашиг хэрхэн авах талаар асуудал. Жижиг хувьцаа эзэмшигч нар цөөхөн
- Үнэт цаасны асуудлаар хандсан тохиолдол байхгүй.

Хоёр. ХК-ын удирдлага, нягтлан бодогч

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг тодорхой мэдэхгүй, уншиж. гүйлгэж харж байсан. Ойлголт, мэдээлэл муу, хүмүүс хөөцөлддөггүй, үнэгүй хувьчилсан болохоор ач холбогдол өгдөггүй. Иргэд байгууллага өөрсдөө шаарддаггүй. Цэнхэр эрхийн бичиг хүн бүрт тараасан. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаат сурталчилах, дунд сургуулийн хөтөлбөрт үнэт цаасны тухай хичээлийг оруулж өгөх. ХК-ны удирдлага ч энэ талаархи ойлголт муу байна. Цэнхэр, ягаан тасалбар гэж мэдэхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийдэг. 1, 2 сарын өмнө мэдээлдэг, өдөр тутмын сонин, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарыг цацдаг.

Хувьцаа эзэмшигч нар мэдсэн ч хуралд ирдэггүй. Хурал хэзээ болох, ногдол ашиг хуваарилах тухай л асуудаг. Хурлын гол асуудал ногдол ашиг хуваарилах, тараах талаар ярьдаг.

Хувьцаа эзэмшигч нар өөрсдөө идэвхгүй байдаг. Хурал зарлаад ирдэггүй. Дараа нь гомдол маргаан гаргаад явдаг. Энэ нь мэдээлэлтэй холбоотой.

Ногдол ашиг тараагаагүй шалтгаан нь ашиггүй ажиллаж байгаатай

холбоотой. Хүмүүс асууж ирдэггүй.

ХК-ны хөгжил, дэвшил, үйл ажиллагааны талаар санал хүсэлт хэлдэггүй. ХК сайн явахад хувьцаа эзэмшигч нар бүгд ирдэг. Муу явахад хэн ч тусалдаггүй /2 удаа гарсан/.

Үнэт цаасны компани, хөрөнгийн бирж байдаг байсан.

Гэхдээ дампуурсан байх, одоо мэдэхгүй.

Хувьцааны 10 гаруй хувийг эзэмшдэг 7-8 хүн байдаг. Бага нь 140-өөс дээш их хувийг эзэмшдэг нь шийдвэр гаргахад нөлөөлдөг.

Бага хувьцаа эзэмшигчид мэдлэг мэдээлэл байдаггүй болохоор ногдол ашиг хэрхэн яаж авах процетурын тухай л асуудаг. Хувьцаа гэж мэддэггүй. Тараагдсан байдаг.

Хувьцааг шударга, шударга бусаар олж авсанг мэдэх боломжгүй, хүндрэлтэй.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл байдаггүй, тоог мэдэхгүй. Хөрөнгийн биржид ямар ч бүртгэл байдаггүй. Хувьцаа эзэмшигч мөртлөө бүртгэлгүй байдаг, энэ талаар их асууж ирдэг.

Үнэт цаасны харилцаагаар мэргэшсэн ажилтан манайд ХК-д байхгүй. Хувьцаа тархай байсныг багцалж авсан.

1999 онд нэлээд асуудалтай байсан. ХК болон хувьцаа эзэмшигчдийн хооронд бараг маргаан гараагүй.

ХК ХХК болоход бага хувьцаа эзэмшигч нар хохирох боломжтой.

Бага хувьцаа эзэмшигч нар асуудал шийдэхэд хувьцаагаа багцлах, задлах нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигч нарын хурал хийхэд зэрэг

Компаний дүрэмд ногдол ашиг хуваарилах талаар заалт байхгүй.

Өмчлөгчийн эрхийг, хувь оролцоог баталгаажуулсан үнэт цаасны хэлбэр гэж ойлгож байна.

Гурав. Сэлэнгэ, Ховд, Увс аймгаас ирүүлсэн Үнэт цаасны эрх зүйн маргаантай холбоотой шүүхийн 61 шийвдэртэй уншиж танилцахад:

Сэлэнгэ аймаас 26 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс:

- ногдол хувийг эргүүлэн авах-9
- ногдол хувийг зохих хүмүүсийн нэр дээр эргүүлэн шилжүүлэх -4
- ногдол хувь эзэмших эрхээ эргүүлэн авах-1
- 405 мянган төгрөг гаргуулахыг хүссэн-1
- үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болохыг тогтоох-2
- хүүхдийн тэтгэлэгт тогтоолгож, хашаа байшингаа өөрийн өмчлөлд авахыг хүссэн-2
- эзэмшигчийг тогтоох-1
- хувьцаагаа буцаан авах хэлцлүүдийг хүчингүй болгох-1
- эд хөрөнгийн маргаан шийдвэрлүүлэхийг хүссэн-1
- хувьцаанд ногдох хөрөнгө гаргуулахыг хүссэн-1

- хувьцааны эзэмшигч тогтоох-2
- хувьцааны үнэ гаргуулах -1.

Увс, Ховд аймагт нийт 35 маргаан шүүхээр шийдвэрлэгдсэнээс:

- Худалдсан хувьцааг буцааж авах /олгож өгөх/ хүссэн-10
- Хувьцааны 4 ш тасалбар гаргаж өгөхийг хүссэн-1
- Хувьцаагаа өөртөө эргүүлж олгож өгөхийг хүссэн-2
- Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах-5
- Ногдол хувь гаргуулах-3
- Хувьцаа гаргуулах-8
- Хувьцааны зөрүү авах-1
- Хувьцааны үнэ гаргуулах-1
- Хувьцаа эзэмших эрхийг сэргээх-1
- Хувьцаа эзэмшигч тогтоох-1
- Хэлцлийг хүчин төгөлдөрт тооцуулах-1
- Хувьцааны үнийн зөрүү-1 байна.

Дөрөв. Орон нутаг дахь СЗХ-ны төлөөлөгч

Орхон-Уул, Дархан-Уул аймгийн Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөгчид ҮЦЗЗТХ-ийг сурталчлах ажлын хүрээнд үнэт цаасны зах зээлийн талаар ТВ шууд ярилцлага хийх, Нээлттэй хаалганы өдөр сурталчилгаа хийдэг.

Хорооноос хүмүүс ирж семинар хийж, жилд нэг удаа сургалт зохион байгуулдаг, тэрэнд нь хамрагддаг байна.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд улирал бүр компаниудын санхүүгийн тайлан авдаг. Тайланг шалгаад нэгтгэл хийгээд Хороонд өгдөг, эргээд Хороо зааварчилгаа, зөвлөлгөө өгдөг.

Хороонд голдуу цэнхэр, ягаан тасалбартай холбоотой, хаана байгаа нь мэдэгдэхгүй, ногдол ашиг өгөөгүй, зөвшөөрөлгүй зарсан, хувьцаа эзэмшигч ХК-ны хооронд маргаан байсан ба маргаантай асуудал гарвал СЗХ руу хүргүүлдэг. Орон нутаг дахь Хорооны төлөөлөгч дамжуулагчийн үүрэгтэй.

ХК болон мэргэжлийн байгууллагатай харилцдаг. Хяналт тавихад хүнд, мэдээлэл ил тод биш, үйл ажиллагаа нь идэвхгүй байх, бага хувьцаа эзэмшигч нарын эрх ашиг хохирдог явдал байна. Нэг, хоёр хүн л ихэнх хувьцааг худалдаад авсан байдаг.

Тав. Их, дээд сургуульд үнэт цаас, бизнесийн эрх зүйн хичээл заадаг багш, өмгөөлөгч.

- хувьцааг шударгаар олж авсан эзэмшигчийн эрхийг хэрхэн хангаж байгаа шүүхийн практик.
- хүчин төгөлдөр бусад тооцоход хоёрдогч, гуравдагч этгээдийн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үү гэдэг асуудал.
- ҮЦЗЗТ хуулийг сайжруулах, чанаржуулах хэрэгтэй.
- Иргэд бүгд хуульч биш учраас цөөн хуульд нарийн тусгах хэрэгтэй.



- Хуульд олон журмаар зохицуулах асуудал байх хэрэггүй, хуулиас дээгүүр өөрсдийн эрх ашигт нийцсэн журам гаргах асуудал нэмэгдэх болно. Журмууд нь хуультай зөрчилдсөн, давхардсан асуудлыг үүсгэж байна. СЗХ-ноос олон журам гаргах хэрэггүй, хуулийн боловсруулалт дутагдалтай учраас олон журам байна. Хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг нарийн тусгаж өгөх хэрэгтэй
- Хариуцлагын асуудлыг нарийн тодорхой тусгаж өгөх. Энэ зах зээл хөгжихгүй байгаа нь хариуцлагын асуудалтай холбоотой.
- Бага хувьцаа эзэмшигчдийн асуудлыг Япон улсын хуульд нарийн тусгасан байдаг. Олон хүнд бага багаар эзэмшүүлэх зарчим баримталдаг
- Хувьцааг худалдах бэлэглэх асуудал маш нарийн зохицуулалт шаарддаг.
- Манай ҮЦТХ бүртгэлийн асуудлыг нарийн тусгасан дутагдалтай.
- Хуульд ногдал ашгийг заавал өгдөг байхаар тусгах хэрэгтэй.
- Гол үнэт цаас хувьцаа, бонд 2-ыг удирдаж чадвал дамжуулан худалдах гэрээ опцион зэрэг дагадлах үнэт цаасны асуудал их гарахгүй.
- Эдийн засгийн асуудал тул үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хэрэгтэй
- Бүртгэлийн хариуцлагын асуудал байх хэрэгтэй
- Компаний дүрмийн санг нэмэх хэрэгтэй, 10 сая төгрөг хариуцлага бүрэн хүлээх баталгаа болж чадахгүй байна.
- Төвлөрсөн хөрөнгөгүй хирнээ арилжаа хийж байгаа нь өөрөө луйвар.
- Судалгааны үр дүнд гарах ном онолын суурь ойлголттой ном байх хэрэгтэй.
- Хариуцлагын асуудал дээр нэмж ёс суртахууны асуудал тусгах хэрэгтэй
- Япон, Германы хуулийг үзэх.
- энгийн хувьцаанд хувьд ногдол ашиг заавал авдаг байх хэрэгтэй
- иргэдийн хувьцаанд мэдлэг бага байгаа учир сургалт явуулах
- давуу эрхийн хувьцааг хуваарилсан тохиолдолд 2 дахин ногдол ашиг авдаг байх.
- Бага хувьцаа эзэмшигчдийн эрхийг хуульд тодорхой зааж өгөх хэрэгтэй. ТУЗ-д орох механизмийг хуульд тусгаж өгөх.
- Мэргэжлийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хохирол учруулсан бол тухайн ашгийг нэмж төлөх, шүүх шийдвэрээ буруу гаргасан бол төр хариуцдаг болгох
- Утсаар ярьж зөвшөөрөл авч хувьцааг зарж байна. Энийг хязгаарлах хэрэгтэй
- Хувьцаанд ханш унаж байна гэж хувьцааг нь заруулсан тохиолдол бий
- Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хэрхэн хүрэх асуудал өөрөө учир дутагдалтай
- үнэт цаасыг мэйлээр худалдан авч болох уу? шүүх мэйлээр хийсэн гэрээ хэлцлийг нотлох баримт гэж үзэх үү

Зургаа. *6.1. СЗХ –ны дарга, мэргэжилтэн*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэх. Дэд бүтцийн хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг ОХУ-ын жишгийг баримтлан боловсруулах. Хувьцаа эзэмшигчдийн тухайд эрүүгийн хариуцлага, иргэний маргааны хөөн хэлэлцэх хугацаа (эдийн бус баялаг), торгуулийн арга хэмжээг нэмэх /ЭХ болон ЗХТХ-д/. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тусгай зохицуулалттай болгох. Гадаадад үнэт цаас гаргах тухай заалтыг хэрэгжүүлэхийн тулд хадгаламжийн бичиг гаргаж байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах. Хуулийн зарим нэр томьёо, зохицуулалтыг хэрхэн хуульчлах, сайжруулах. Хуулийн зохицуулалтыг нарийн болгох. ЭХ-ийн 158-ийг энэ харилцаанд оролцогч сайн мэддэг хүмүүс зөрчдөг тул 108.000 төгрөгөөс дээш бол гэмт хэрэг гэж тооцдоггүй байх. Мөн мэргэжлийн ёс зүй зөрчсөн тохиолдолд ямар сахилга хариуцлага хүлээлгэх талаар нарийн тусгах. Хуулиар зохицуулаагүй асуудлыг журмаар зохицуулах. Дансаа нээлгэх хэрэгтэй байна. Данс нээлгээгүй, ногдал ашиг хуваарилж, байршуулаад тодорхой хугацаанд мөнгөө аваагүй үхмэл байлгаснаас хөрөнгө оруулалтын дансны суурь төвьбал зүгээр. СЗХ-ны бүтэц, зохионы байгуулалтыг харж үзэх хэрэгтэй байна. Санхүүгийн тодорхой салбарыг хариуцдаг хирнээ санхүүжилтийн хувьд бага байх шиг.

6.2. Андеррайтер, диллер, брокерийн үйл ажиллагаа эрхэлдэг "Би-Ди-Сек" ХК

Компаний засаглалын ил тод байдал чухал /тайлан, баланс, мэдээлэл тараах/. Мэдээллийг хэрхэн, яаж олж авах, хаанаас авах уу гэдэг нь тодорхойгүй байдаг. Хувьцаа эзэмшигч зориод мэдээлэл авахад яаж авах, Компаний тайланг хүн болгон олж авч чаддаггүй энэ асуудлыг СЗХ зохицуулах ёстой. Хотод үйл ажиллагаа явуулдаг. хөдөө орон нутагт мэдээлэл хүрдэггүй.

Ихэнх хэргүүд СЗХ-нд бүртгэлтэй байдаг тэр асуудлууд шийдвэрлэгдэхгүй байна. Хүний хувьцааг зөвшөөрөлгүй зардаг, энэ асуудлыг шүүхээр шийдвэрлүүлбэл зүгээр. Практикт СЗХ, шүүхээс арилжаа, хэлцэл буцаах асуудал их байдаг. Хэлцэл буцах нь ҮЦЗЗ-ийн хамгийн эмзэг асуудал.

- Татвар, татварын бодлого, хувьцааны ханшны зөрүү татваргүй байснаа татвартай болсон, улс 10 хувийн татвар авдаг, СЗХ бас татвар авдаг.
- Хувьцаа эзэмшигчдийн үүрэг гэж байна уу?
- ХК, ХХК болох асуудлыг анхаарч судлах.
- Хувьцааг багцлаад нийтийн дуудлага худалдаагаар худалдах. СЗХ-ноос тогтоосон үнээр худалдах.
- СЗХ-ны эрх, үүргийг нэмэх, тодорхой эрхлэх үйл ажиллагааг нь хязгаарлах
- Гадаад хүмүүс үнэт цаас гаргах асуудлыг нухацтай авч үзэх

Хөрөнгийн биржийн төлбөр тооцооны журмууд нь ТУЗ-ийн хурлаар их өөрчлөгддөг энийг зохицуулах. Биржийн индекс 60 хувь унасан байхад

төрөөс арга хэмжээ авдаггүй.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй брокер, дилерийн компаниудыг зохицуулах хэрэгтэй. Брокер, дилерийн компаниуд ХБ-ийн ТУЗ-д төлөөлөлтэй байх. Биржийн удирдлага үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа, оролцоо ихээхэн шаардлагатай.

6.3. Брокерийн пүүсийн ажилтан

Хөрөнгийн зах зээлд итгэхгүй байдал ажиглагддаг. Мөнгөтэй хүмүүс их байдаг ч итгэдэггүй.

Хөрөнгийн ЗЗ хөгжиж байж улс хөгжинө. 2001 оноос зогсонги байдалд орчихсон байсан. Сүүлийн үед нэлээд хүмүүс идэвхжиж байна.

Хурлаа жил болгон хийнэ, ногдол ашиг тараана гэсэн хуулийн заалт хэрэгжихгүй байна.

Хувьцаа эзэмшигчийн эрх их, бага гэхгүй адил хамгаалагдах ёстой

ХК-ны мэдээлэл байхгүй. Хувьцаа эзэмшигчийн хөрөнгө үхмэл байна.

Хувьцаа нэг хүнд төвлөрөөд ирэхлээр ногдол ашиг хуваарилах зэрэг дээр бусдын эрх ашиг нь хөндөгддөг.

Нийт масс мэдээлэл сайтай байвал ХЗЗ хөгжих боломжтой.

ОН-ийн захиргааны байгууллагатай яаж ажиллдаг нь мэдэгддэггүй юу ч хийдэггүй

Татвар, НД, СЗХ-ны Төлөөлөгчтэй хамтарч ажилладаг.

Төрийн албан хаагч, иргэн гэхгүй нийгмээрээ л идэвхгүй байна

Бэлэн мөнгөөр хувьцаа худалдах явдал байна.

Брокерын пүүсийн хувьд худалдан авах үйл ажиллагаа явуулдаггүй.

Хууль сурталчилах ажил жилд нэг удаа Нээлттэй хаалганы өдөр гэж явагддаг. Хууль тогтоомжийг иргэдэд мэдээлснээр сул мөнгийг ЗЗ-д оруулах хэрэгтэй. Хууль нь болж байгаа ч хэрэгжихгүй байна. Хэрэгжүүлэх арга, механизм нь болохгүй байна.

2,3 брокерийн пүүстэй холбоотой маргаан байсныг СЗХ, ҮЦХ тухайн үед нь шийдсэн.

Манай брокерын пүүс үйл ажиллагаа сайн явуулъя гэж бодож байгаа. Ирээдүйтэй ажил.

ХК ХХК болж байгаа нь хариуцлагаас зугтаж буй явдал буруу юм. ХК болох хөшүүргийг бий болгох зүйлүүдийг ХЗ-н орчин бий болгох асуудлыг судлах.

Орхон-Уул аймаг

1.Аймгийн ЗДТГ-ын Хуулийн хэлтсийн ажилтан П.Баянаа

2.СЗХ-ны төлөөлөгч Пүрэвдаавуу

3.АИТХ-ын дотоод ажил хариуцсан ажилтан М.Батсайхантай

4.АЗДТГ-ын НБЗХ-ийн ЭМ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн

5.Эрдэнэт хивс ХК-ний ерөнхий нябо Наранцэцэг

6.Эрдэнэт хүнс ХК-ний захирал А.Ганбат

7.Сумын ИТХ-ын дарга С.Жаргалсайхан
8.Сумын ЗДТГ-ын дотоод ажил, баг хариуцсан ажилтан Батбаяр
9.Баянбулаг багийн ЗД Дагвадорж
10.Баянбулаг сумын хэсгийн ахлагч Батдэлгэр

Булган аймаг

1.АЗДТГ-ын ХЗ-н хэлтсийн дарга Хишигдаваа
2.ИТХ-ийн нарийн бичгийн дарга Дагвадаш
3.Булган сумын Засаг даргын орлогч Д.Баасан сүрэн
4."Булган брокер"-ийн пүүсийн гэх Н.Уламбаяр
5.**Булган аймгийн шүүх 7 шүүгч, 5 туслах, НБД**
6.**"Гурил тэжээл Булган" ХК-ний нябо Сандуйжав**

Дархан аймаг

1.СЗХ-ны төлөөлөгч Тогтохбаяр
2.АЗДТГ-ын ХЗ-н хэлтсийн дарга
3.АЗДТГ-ын дарга Бааст
4.ИТХ-ын дарга
5.Хууль зүйн хэлтсийн ажилтан Алтанчимэг
6.Сумын ЗДТГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн О.Хүрэлчулуун
7.Сумын ИТХ-ын НБД
8."Мах экспо" ХК гүйцэтгэх захирал
9."Дархан зочид буудал" ХК гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн ерөнхий нябо Гүндэв
10. "Дархан хүнс" ХК-ний гүйцэтгэх захирал Түнгалаг
11."Сэдөт" ХК, "Монгол алт" ХК нябо Мягмарцэцэг
12.Хөрөнгийн бирж ОН-тэй харилцах албаны ажилтан
13.Үнэт цаасны ТТХТТ-ийн менежер
14. **Шүүх 7 шүүгч, 10 туслах, НБД**

Журмын талаархи зохицуулалт

№	Зүйл, заалт	Агуулга	Тайлбар
1.	3.1.2.	"биет үнэт цаас" гэж тогтоосон журмын дагуу биет байдлаар **хэвлэсэн** үнэт цаасыг	Хэн гаргах нь тодорхой бус.
2.	3.1.13	"нийтэд санал болгох" гэж үнэт цаас гаргагчаас үнэт цаасны арилжаа эрхлэх байгуулагаар дамжуулан Хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-иас дээш тооны этгээдэд санал болгож худалдахаа **мэдэгдэхийг**	СЗХ-
3.	3.1.14	"тендер санал гаргах" гэж тогтоосон журмын дагуу нээлттэй хувьцаат компанийн энгийн хувьцаааны хяналтын багц буюу түүнээс дээш хувийг дангараараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд худалдан авах саналаа нийтэд зарлахыг	Хаанаас тогтоосон журам вэ?
4.	3.1.15	"дотоод мэдээлэл" гэж үнэт цаасны ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох, Хорооноос **дотоод мэдээлэл** гэж тогтоосон нийтэд тараагдаагүй мэдээллийг	СЗХ ямар шалгуураар дотоод мэдээлэл гэж тогтоох вэ?
5.	7.1	Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар гаргахдаа тогтоосон журмын дагуу Хороонд **бүртгүүлнэ**. Үнэт цаасыг хаалттай худалдахаар гаргахад энэ журам хамаарахгүй.	СЗХ-ҮЦ бүртгүүлэх журам
6.	7.3	Үнэт цаас гаргагч үнэт цаасаа бүртгүүлэхдээ өргөдөл, .. , Хорооноос тогтоосон **бусад баримт бичгийг** Хороонд ирүүлнэ.	СЗХ-ҮЦ бүртгүүлэх журам
7.	8.1	Хороо нь үнэт цаас гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх тухай журам тогтооно.	СЗХ-ҮЦ гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх журам
8.	10.1.2	Үнэт цаас гаргагч үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх нийтлэг үүрэгтэй.	СЗХ-ҮЦ гаргагч ҮЦ-ны гүйлгээний талаархи мэдээ, тайлан гаргах аргачлал, маягт СЗХ-оос хугацаа тогтооно.
9.	10.1.4	Үнэт цаас гаргагч Хорооноос тогтоосон журмын дагуу тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх нийтлэг үүрэгтэй.	СЗХ-тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх журам
10.	10.2	Үнэт цаасны зах зээлийн үнэ, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээлэл, түүнийг олон нийтэд хүргэх журмыг Хороо тогтооно.	СЗХ-ҮЦ-ны зах зээлийн талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх журам
11.	11.1	Тендер саналыг энэ хууль болон түүнд нийцүүлэн Хорооноос тогтоосон журмын дагуу гаргана.	СЗХ-тендер санал гаргах журам (3.1.14-т заасантай адил, давхардаж буй)

12.	12.4	Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувь болон хяналтын багцыг худалдан авснаа бүртгүүлэх тухай журмыг Хороо тогтооно.	СЗХ-худалдан авснаа бүртгүүлэх журам
13.	17.1	Энэ хуулийн 3.1.15-д заасан дотоод мэдээллийг эзэмшигчид үнэт цаас гаргаж байгаа компанийн удирдлага болон эрхэлж байгаа ажил, албан тушаалын дагуу үнэт цаас гаргагчийн талаар нийтэд тараагдаагүй мэдээлэл эзэмшигч, түүнчлэн Хорооноос дотоод мэдээлэл эзэмшигчээр тогтоосон этгээд хамаарна.	СЗХ-дотоод мэдээлэл эзэмшигч тогтоох
14.	17.3	Хороо нь дотоод мэдээлэл болон дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагааны талаар журам тогтоон мөрдүүлнэ.	СЗХ-дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагааны талаар журам. Харин "дотоод мэдээлэл" гэдэг нь 3.1.15-тай давхцана.
15.	19.2.1	Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага үнэт цаасны гүйлгээний талаархи мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу гаргаж тогтоосон хугацаанд Хороонд хүргэх нийлэг чиг үүрэгтэй.	СЗХ-ҮЦ-ны зах зээлд оролцогч МБ нь ҮЦ-ны гүйлгээний талаархи мэдээ, тайлан гаргах аргачлал, маягт СЗХ-ооос хугацаа тогтооно.
16.	26.6	Сан нь тогтоосон журмын дагуу нийтэд санал болгон гаргах үнэт цаасны тухай танилцуулгыг Хороонд ирүүлнэ.	СЗХ-(Сан) нийтэд санал болгон гаргах
17.	26.8	Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон Сан нь сангийн цэвэр хөрөнгө, нэгж хувьцааны үнэлгээ, үйлчилгээний хураамжийн хэмжээ, төлбөр тооцооны журам, сангийн итгэмжлэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон сангийн гаргасан үнэт цаасны 5-аас дээш хувийг эзэмшигчийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар Хорооноос тогтоосон журмын дагуу сангийн хувьцаа эзэмшигчид хагас жил тутам мэдээлэл хүргэх үүрэгтэй.	СЗХ-сангийн хувьцаа эзэмшигчид хагас жил тутам мэдээлэл хүргэх журам
18.	26.10	Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тухай танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэх, зардлыг тооцох, зар сурталчилгаа явуулах, Сангийн хувьцааны үнэлгээ, хадгаламж, бүртгэл, санхүүгийн хяналт болон тэдгээрийг тайлагнах журмыг Хороо тогтооно.	СЗХ-танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэх, -зардлыг тооцох, -Зар сурталчилгаа явуулах, -сангийн хувьцааны үнэлгээ, хадгаламж, бүртгэл, санхүүгийн хяналт, тайлагнах журам

19.	27.4	Хороо брокер, дилерүүдийн мэргэжил, мэргэшлийн түвшин тогтоох болон аттестатчилах журам батлан мөрдүүлнэ.	СЗХ-түвшин тогтоох, аттестатчилах журам
20.	34.1.3	Хороо эрх хэмжээнийхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж мөрдүүлнэ.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2-той давхцана.
21.	34.1.10	Хороо үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан, мэдээ, түүний тайлбар тодруулгад зайлшгүй тусгагдах үзүүлэлт, тайлан, мэдээний маягт хэрэглэх талаар журам тогтоож мөрдүүлнэ.	СЗХ-тайлан, мэдээний маягт хэрэглэх талаар журам
22.	34.1.16	Хороо олон нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, тогтоосон журмын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид мэргэжлийн зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.	СЗХ-ҮЦ-ны зах зээлд оролцогчид мэргэжлийн зөвлөлгөө өгөх журам
23.	37.4.1	Улсын байцаагч нь хяналт шалгалт хийх эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчин хувиас гаргасан зардлыг Хорооны төсвөөс тогтоосон журмын дагуу нөхөн олгоно.	

19.2.2, 19.2.3 дахь заалтын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд журам тогтоохоор байна.

Хөрөнгийн бирж 22.3.5, 22.5 (үг нь хэн гаргах нь тодорхой бус байгаа)-д зааснаар мөн л журам гаргах нь. Дилерүүдийн арилжааны төв 23.7, 23.8 (22.3.5)-д зааснаар журам гаргана.

Үншиж танилцсан хавтаст хэргийг тэмдэглэсэн тэмдэглэл

№	Х №№	Шийдвэр-лэсэн шүүгч	Нэхэмжлэгч	Харилцагч	Нэхэмжлэлийн товч утга	Ямар төрлийн үнэт цаас болох	Шийдвэрлэсэн байдал	Тайлбар
Сүхбаатар дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1992 оны хэрэг- 1								
1	155	1992.1.29	Иргэн	Иргэн	29 ширхэг хувьцааны үнэ гаргуулах	Ягаан тасалбар	1. ИХ-ийн 337-дугаар зүйлд зааснаар хувьцааны үнийг олгох	1992.2.11
Сүхбаатар дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1997 оны хэрэг-1								
2	58-128	1997.1.8	Иргэн	"М" компани	30 ширхэг хувьцаанд оногдох ашгийг гаргуулах /480,000/	Ягаан тасалбар	1. НКТХ 75, 91 хэрэгсэхгүй болгох	1997.3.5 М-154 1. АШШ-д буцаасан Ш-58А НКТХ 75, 91 хэрэгсэхгүй болгох 1997.12.8 М-1034 АШШШ-ийг хүчингүй болгож дахин хянуулахаар буцаах Ш-128 1. Хэрэгсэхгүй болгох

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Сүхбаатар дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1998 оны хэрэг-2									
3	141		Иргэн	Иргэн	Хувьцаа эргүүлэн өгүүлэх, ногдол ашиг нөхөн төлүүлэх.	699 ширхэг ягаан тасалбар		Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.	1. Гомдлыг хангаагүй.
4	441	1998.3.16	Иргэн	Иргэн	Хэлцэл хүчингүй болгуулах тухай /65%-хамт олон, 20%-ХК, 10%-иргэд/			1998.5.22 1. ИХ 202.1, НКТХ 65.4 2. Хуудэр ХК-ийн хувьцааг ИХ 44.1.3, НКТХ 95.3, 95.4 Алмаз ХК, Тун нарын хувьцаа худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох	1998.7.15 М-562 1. Гомдлыг хэрэгсэхгүй болгох 1998.8.24 Т-3/3404 1. Үндэслэл тогтоогдохгүй байна. УДШЕШ-3/4683 1. Үндэслэл тогтоогдохгүй байна.
Сонгинохайрхан дүүргийн шүүхээр 1995 онд шийдвэрлэсэн хэрэг-1									
5	811	1995.10.17	Иргэн	"ХТ" ББХК-ийн захирал Ж	Хувь нийлүүлэгчийн хөрөнгөөс өөрт оногдох хувь, ашгийн зөрүүг гаргуулах	Яагаан тасалбараар авсан		1995.12.15 1 Талууд зөвлөрсөн.	
Баянзүрх дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1997 оны хэрэг-2									
6	1011	1997.3.19	Иргэн	А брокерын пүүс	14 захиалагүй зарагдсан хувьцаа үнэ гаргуулах			1. ИХ 231, 232 нэхэмжлэхгүй орлох	М-765 1.АШШ-д буцаах Ш-1011А 1. И 396.1 14 хувьцаг гаргуулж нэхэмжлэгчид олгох М-219 1. АШШ-д 14 хувьцаг 14 хувьцааны үнэ гэж өөрчлөлт оруулах

7	1081	1997.6.18	Иргэн	"ХМ" компани	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчингүйд тооцуулах		1997.7.14 1. НКТХ 44-д хурал хүчин төгөлдөр	М 1.Талууд эвлэрсэн.
Чингэлтэй дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1995 оны хэрэг-1								
8	586		Иргэн	ББХК-ийн захирал С	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах		1. Талууд эвлэрсэн.	
Чингэлтэй дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2001 оны хэрэг-2								
9	134	2000.9.8 Д.Банзрагч П.сарантуяа Д.Наранцэцэг	Иргэд	ШШГА	34360 ширхэг хувьцаа эзэмших эрхийг сэргээх		2001.1.24 1. ИХ 85.5.7, ШШГТХ 25.1-д зааснаар иргэдийн эрхийг сэргээх	
10	680	2001.5.6 Ш- Н.Мөнхбаяр М-О.Гэрэл Д.Цэвээнцэцэг Б.Ундрах	"ТУ" ХХК	"ОИ" ХХК /Үнэт цаасны арилжааны үйл ажиллагааны /	30347 хувьцаа гаргуулах		2001.7.19 1. ИХ 154.5, 172.1, 369-д заасанаар 221.734.800 төгрөг "ТУ" ХХК-д олгох	М-706 1. АШШШ-ийг өөрчилсөн.
Чингэлтэй дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2005 оны хэрэг-2								
11	4	2004.8.9 Ш-Ц.Цагаанцоож М-О.Гэрэл Ц.Ичинхорлоо Б.Ундрах Т-Ц.Амарсайхан А.Доржготов Б.Доржготов Д.Тунгалаг	"М" ХК-48% "ММ" ХХК-41.2% "ШИ" ХХК-9% "ХБУ" ХХК-8.5% "МИ" ХХК-41.3%	Банк "ТИ" ХХК /2-догч ХЧ/	Хэлцэл хүчингүй болгож, хувьцаа өмчлөх эрх сэргээлгэх		2004.12.20 1. ИХ /1994/ 181.1.5, /2002/ 156.1.1, 159.1, 164.1, **ҮЦЗЗТХ** 25.1-д өмчлөх эрхийг сэргээх, Банк, "М" ХК-ийн гэрээг ХТБ-д тооцох, "ТИ" ХХК, "М" ХК-ийн хөрөнгийн биржээр арилжаалсан 69273 ширхэг хувьцааг гаргуулах	М-2005.2.16 1. АШШШ-ийн нэг дэх заалтын хүчингүй болгож, ИХ /1994/ 181.15, 368.6 хөрөнгийн биржийн арилжааг ХТБ-д тооцож, "ТИ" ХХК, "М" ХК-ийн хөрөнгийн биржээр арилжаалсан хувьцааны үнийн 169273 төгрөгийг хэрэгсэхгүй болгох Т-2005.6.30 1. ДЗШМ-ыг хүчингүй болгох 2. АШШШ-ийг хэвээр үлдээх

Хуулъ зүйн индэсний хүрээлэн www.mn.gov.mn

12	648	2005.4.19 Ш-С.Буд Ц.ЦагаанцоожМ-Т.Гариймаа Ц.Ичинхорлоо Л.Бямбаа Т-О.Зандраа Л.Атарцэцэг Ц.Амарсайхан А.Доржготов Д.Тунгалаг	Иргэн	Банк	Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахыг хойшлуулах		2005.6.28 1. КТХ 39.1 хэрэгсэхгүй болгох	М-417 2005.8.17 1. АШШШ-ийг хэвээр Т-2005.11.3 1. АШШШ, ДЗШМ-ыг хэвээр
Чингэлтэй дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2008 оны хэрэг-4								
13	107	2007.12.3 Ч.Алтанчимэг	Иргэн	Брокер, дилерийн "ТУБ" ХХК	"ШГ" ХК-ийн 18944 ширхэг хувьцааг зарсан хэлцлийг ХТБ-д тооцуулах	Хувьцаа	2008.2.1 1. ИХ 56.1.1, 56.1.8 хэлцлийг ХТБ-д тооцох	
14	490	Ш-Э.Ариунаа Ц.Алтанцэцэг С.Буд М-Ц.Өрнөндэлгэр П.Золзаяа М.Нарантуяа Ш-Ж.Цэнгэл	Иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгч	Иргэн	"ТТ" ХК-ийн 120 ширхэг хувьцааг зөвшөрөлгүй зарсан тул өмчлөх эрхийг сэргээлгэх	Хувьцаа	2008.5.29 1. ИХ 497.1, 511.1 хариуцагчаас 1505151 төгрөг гаргуулж, 3010301 төгрөгийг хэрэгсэхгүй болгох 2. ИХ 56.1.1 "ТТ" ХК-ийн арилжсан хэлцлийг ХТБ-д тооцуулж, 920 ширхэг хувьцаа гаргулах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох	2008.8.1 М-456 1. АШШ-д буцаах Ш-490А 1. 920 ширхэг хувьцааг сэргээж, 2003-2006 оны ногдол ашиг 4515452 төгрөгийн татгалзлыг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

15	795	Ариунаа	Иргэн	"ДС" ББСБ	3000 ширхэг хувьцаа эзэмшигч болохыг тогтоолгох		2008.3.18 1. ИХ 9.4.1, 90.1 "ДС" ББСБ-ын 3000 ширхэг хувьцааг өчмлөх эрхийг Иргэн хэлцлийн үндсэн дээр шилжүүлэн авсан, шударга эзэмшигч болохыг тогтоосугай.
16	846	Аиунаа	Иргэд /3/	"Т" ХК-ийн ТУЗ-ын дарга Б	"Т"- ХК-ийн 1996 онд гаргасан 689610 ширхэг нэмэлт хувьцааны төлбөр 68760997 төгрөгийг гаргуулах, ЧДШ-ийн 2004 оны 159 дугаартай иргэний хэргийг сэргээж хамтад нь шийдвэрлэх		2008.9.2 1. 1994 ИХ 5.5.7, 43, 44, НКТХ 44.1, 44.4, **ҮЦТХ** 65.1.5, 68.3 "Т" ХК-ийн ТУЗ-ын дарга Б-д холбогдох Л компанийн эзэлийн үлдэгдэл 68760997 төгрөгийг 1993 онд төлсөн гэж хуурамч бичиг баримт бүрдүүлэн 1996 онд 687610 ширхэг нэмэлт хувьцаа гаргасан нь хууль зөрчсөн тул хувьцааны төлбөрийг хүчин төгөлдөр бусад тооцож, нэмж гаргасан 687610 хувьцааг хүчингүй болгуулах, ЧДШ-ийн 2004 оны 159 ИХ-ийг сэргээн хамтатгна шийвэрлэж, Б, Б, Д нарын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох 2. 2002 ИХ 9.4.1, ИХШХШТХ 3.1, 65.1.5 бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд "Т" ХК-ийн Б, Б, Д нар 1996 онд нэмж гаргасан 687610 ширхэг хувьцааг хүчингүй болгох нэхэмжлэл гаргах эрхгүй, нэмэлт хувьцааны төлбөр 68760997 төгрөгийг хууль бусад тооцуулах нэхэмжлэл гаргах эрхгүйг тогтоолгох шаардлагыг хэрэгсэхгүй болгох
Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1992 оны хэрэг-1							
17	843	1992.7.3	Иргэн	"Б" ББКХ	Хувьцааны мөнгө гаргуулах /гэнэт халагдсаны тэтгэмж/		1992.8.28 1. ХТЛ 21 гэнэт халагдсаны тэтгэмж олгох 2. Өмч хувьчлалын тухай хуулийн 10-"Б" ББХК-аас 9312 төгрөг гаргуулах
Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1994 оны хэрэг-1							
18	203		Иргэн	"МНБ" ББ хоршооны дарга Ч	Хувьчлах үед оруулсан хөрөнгө болон ногдол ашгаас авах	Ягаан тасалбар	1. Анх 18.6.8 хангаж шийдвэрлэсэн.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mn.gov.mn

Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1996 оны хэрэг-1								
19	110		Иргэн	Иргэн	Хурал хүчингүй болгуулах	"УБ" ХХК-ийн хувьцаа	1. ААНХ 26.12 хангаж шийдвэрлэсэн.	
Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1998 оны хэрэг-1								
20	253	1998.1.13 Ш-Т.Туяа М- Ц.Сайнбаяр Т.Гариймаа Ц.Амарсайхан	Иргэд	"ММ" ХК	Ногдол ашиг гаргуулах		1998.3.24 1. НКТХ 90-д зааснаар "ММ" ХК-иас 1995 оны ногдол ашиг 557327 төгрөгийг Г-д, Б-д 107895, 1996 оны ногдол ашиг С-д 564787, 1078950, Б-д 166352, Ц-д 369121 төгрөг олгох	М-1998.5.11 1. АШШШ-ийг хэвээр
Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2000оны хэрэг-1								
21	1161	Ш-З.Минжирмаа Б.Болормаа Д.Энхтуяа	Иргэн	Иргэн	Хувьцааны өмчлөх эрхийг сэргээлгэх		2000.10.10 1. ИХ 43.1.1, 43.1.5,45.1, ҮЦТХ 6-4-10 хувьцааг буцаан олгож, өмчлөх эрхийг сэргээх	Т-5 2001.1.10 1. Хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэх
Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2001 оны хэрэг-3								
22	17	ш-Н.Нарантуяа м- Л.Бямбаа Ц.Ичинхорлоо Л.Атарцэцэг	Иргэн /"ХХ" ХК/	Иргэн /"М" ХК"/	Хувьцаа эзэмших эрх тогтоолгох		2001.12.26 1. КТХ-ийн 33.1-д "М" Хк эзэмших эрхтэй	М-113 1. хүчингүй болгож, буцаах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlifgov.mn

23	518	Т-Л.Бямбаа Х.Сонинбаяр О.Гэрэл	Иргэд /3/	Иргэн	Хувьцаа эзэмших эрхийг сэргээх		2000.10.10 1. ИХ 43.1.1, 43.1.5, 45.1, 87, УЦТХ 6.4.10 өмчлөх эрхийг сэргээх	Т-5 2001.1.10 1. ААШШ-д буцаах Ш-518 2001.4.25 1. ИХ 43.1.1, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрийг биржийн арилжааныбусхэлцлээр худалдсан батламжийг ХТБ хэлцэлд тооцох 2. ИХ 45.1 М-522 2001.6.15 1. 518 дугаар шийдвэрийг болгож, ААШШШ-д буцаах Ш/тогтоол-40 2002.3.15 1. Хэргийг хэрэгсэхгүй болгох
24	1178	2001.8.10	Иргэн	"ТМ" ХХК захирал Х	8 хувьцааны үнэ гаргуулах / хувьцаагаа барьцаалж 56,000/			2001.10.25 1. КТХ 28.1, 30.1.1 хэрэгсэхгүй	
				Баянгол дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 2002.оны хэрэг-2					
25	190	2002.2.20	Иргэн	Иргэн	Хувьцаа өмчлөх эрхийг сэргээлгэх тухай			2003.2.11 1. КТХ-ийн 33., ИХ-ийн 87 /1/	
26	1047	2002.2.8 С.Оюунчимэг Д.Энхцацаг Л.Оюун	Иргэн	"ЕБ" ХХК	Хувьцаа эзэмших эрхийг сэргээх			2002.7.15 1. КТХ 33.1 0.52 хувьцаа эзэмшдэг болохыг тогтоох	

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Баянгол дүүргийн шүхэзр шийдвэрлэсэн 2003 оны хэрэг-2									
27	74	2002.10.31 Захиражк Д.Дэлгэрцэцэг	Иргэн	"ЕБ" ХХК	0.52%-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг сэргээх		2003.1.10 1.КТХ-иар 5724000 төгрөгөд авлэрсэн.		
28	1422	2003.10.1	Иргэн	ХХК	Өмчлөгчийн эвсвөөрөлгүй хувьцаат О-д худалдсан нэрээр 185000 төгрөг ашигласан, ногдол ашиг гаргуулах			2003.11.4 1. **УЦТХ-ийн** 12.4, 15.2, ИХ-378.1	
Напайх дүүргийн шүхэзр шийдвэрлэсэн 1999 оны хэрэг-1									
29	131	1998.6.11	Иргэн	Хувьцаат компанийн захирал иргэн	Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ногдол ашиг гаргуулах	Цэнхэр, ягаан тасалбар	1999.5.19 1. ИХ 81.1.1 эрхийн бичгийн хураамжийн төлбөр 800 төгрөг гаргуулах 2. ИХ 176.1 1994 (4080/, 1996 /7600/ оны 11680 ногло ашиг гаргуулах	/1992-1994, 1996 онд онгодл ашиг тараасан гэх/	
Хан-Уул дүүргийн шүхэзр шийдвэрлэсэн 1996 оны хэрэг-2									
30	47	1996.2.9 Ш-Б.Энхтуяа О.Зандраа Д.Байгалмаа	"М" ХК-ийн нэр бүхий гишүүдийг төлөөлөн Иргэн	Иргэн	Хурлыг хүчин төгөлдөр бусад тооцуулах		1998.2.9 1.НКТХ 43.1, **44.**1 хэрэгсэхгүй болгох	М-154 1996.3.13 1. АШШШ хэвээр Т-118 1996.5.3 1. АШШШ, ДЗШШМ хүчингүй, бүх гишүүдийн хурал хүчингүй	

31	854	1996.12.2	Иргэн	Иргэн	Хурлыг хүчин төгөлдөр бусад тооцуулах		1996.12.2 1. НКТХ 43.3, 44.1 хэрэгсэхгүй болгох	М-154 1997.2.21 1. АШШШ хүчингүй, хурал хүчинтэй Т-118 1997.5.23 1. ДЗШШМ хүчингүй, АШШШ хэвээр
Хан-Уул дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1998 оны хэрэг-1								
32	719		ХХК	Иргэд /2/	Хурал хүчингүй болгуулах	Компанийн хувьцаа	Хэрэгсэхгүй болгсон.	
Хан-Уул дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн 1999 оны хэрэг-1								
33	1029	1999.9.13 Ш-Батбаяр М-Л.Бямбаа О.Гэрэл Ц.Тогоохүү	Иргэн	Иргэн	Хувьцаа гаргуулах		1999.11.19 1. ИХ 43.1, 154.5, НКТХ 9.1 30 ширхэг хувьцааг буцаан олгох	М-25 2000.1.7 1. АШШШ хэзвэр УДШИТ-д-3/620 2000.2.22 1. Гомдлыг хангахгүй орхих
Нийслэлийн шүүхээр шийдвэрлэсэн 1999 оны хэрэг-1								
34	341		Иргэн	Иргэн	Хувьцаа гаргуулах		1999.6.23 1. ИХ 43.1.1 оногдох хэсэг хүчин төгөлдөр бус	М-135 1999.7.3 1. АШШШ хүчингүй Т-407 1999.12.15 1. АШШШ, ДЗШШМ хүчингүй, дахин шийдвэрлүүлэх
Нийслэлийн шүүхээр шийдвэрлэсэн 2000 оны хэрэг-1								
35	28		Иргэн	Иргэн	Хувьцаа гаргуулах		2000.5.18 1. ИХ 181.18.3, 229.1,3 хэрэгсэхгүй болгох	М-39 2000.6.30 1. ИХ 83.1, 154.5 гэж өөрчлөлт орсон Т-5 2001.1.3 1. АШШШ, ДЗШШМ хүчингүй, дахин шийдвэрлүүлэх

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mi.gov.mn

	Нийслэлийн шүхэр шийдвэрлэсэн 2001 оны хэрэг-1							
36	3	1999.5.17 Ш-Ц.Амарсайхан М-Д.Тунгалаг Б.Цогнам Ж.Дашдорж Ш-Б.Ундрах О.Занд раа Л.Атарцацэг М-Д.Тунгалаг П.Цэцгээ Т-Ч.Ганбат Д.Данзандорж Ш-Б.Ундрах Х.Сонинбаяр О.Гэрэл	Иргэн	Иргэн	31959 хувьцаа гаргуулах		1. Их 43.1.1 31959 ХТБ-д тооцох 2. ИХ 45.1, 396.1 Б, Б нараас 31959 ширхэг хувьцааг гаргуулж нэхэмжлэгчид олгох	М-135 1999.7.3 1. АШШШ-ийн хүчингүй болон, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох Т-407 1999.12.15 1. М-135, Ш-341-ийг хүчингүй болгох, буцаах Ш-28 2000.5.18 1. ИХ 181.18.3, 229.1, 229.3 хэрэгсэхгүй болгох М-39 2000.6.30 1. ИХ 83.1, 154.5 өөрчлөх Т-5 2001.1.3 1. Ш-28, М-39 хүчингүй болгох, буцаах Ш-3 2001.3.29 1. ИХ 43.1.1 ХТБ-д тооцох 2. ИХ 45.1, 396.1 Б, Б нараас 31959 хувьцааг гаргуулах М-7 2001.5.21 1. 1999.2.4-ний өдрийн барьцаат хэлэлийн гэрээг бүхэлд нь ХТБ-д тооцох гэж, 2 Б, Б нараас 27039 ширхэг хувьцаа гаргуулах гэж тус өөрчлөх

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.lll.gov.mn

Булган аймгийн шүүхээр 1997 онд шийдвэрлэсэн хэрэг-1								
37	513	Ш.Загдаа Б.Бямбахорлоо С.Цэрэндулам	Иргэн	Иргэд	Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах	Хувьцааг бүх гишүүдийн хурлаас зөвшөөрөл авалгүйгээр худалдаж авсан	1. ИХ-ийн 43.1, 44.2-д худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох	
1992-1999 он хүртэл шийдвэрлэсэн хэрэг-9								
38	1142 /1992/		Л.Балжням	"Зам тех" ББХК	27 ширхэг ягаан тасалбарын үнэ 27000 төгрөг гаргуулах тухай	Бага хувьчлалын тасалбар	ААНХ-ийн 30 дугаар зүйлийн 2, 6-ийн 4-т зааснаар 12000 төгрөг, 15 ширхэг бага хувьчлалын тасалбарыг гаргуулахаар шийдвэрлэсэн.	Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.
39	574 /1999/		"Монгео" ХК	-"Аргай" брокерийн пүүс -"Есөн эрдэнэ" брокерийн пүүс -"Даланзадгад" брокерийн пүүс	Брокерийн пүүстэй байгуулсан хэлцэл /захиалгын гэрээ/-ийг хүчингүйд тооцуулж, хууль бусаар арилжаалагдсан хувьцааг өөрийн эзэмшилд шилжүүлэх	Хувьцаа	Зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	
40	708 /1993/		Н.Дамбадаржаа	Д.Болд	1 ширхэг хувьцааг хариуцагчид өгөөд үнийг авч чадахгүй байгаа тул хувьцааг гаргуулах	Их хувьчлалын тасалбар	Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.	501648 тоот 1 ширхэг их хувьчлалын тасалбараар "Тэрэлж" ХК-ны 63 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 140 төгрөгөөр тооцож авсан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ilaw.mn

41	1503 /1999/	"Машин механизм" ХК-ны ТҮЗ-ын дарга	"Машин механизм" ХК-ны захирал	"Машин механизм" ХК-ны гишүүдийн 1997.12.27-ны өдрийн хурлын ТҮЗ сонгосон шийдвэр хүчингүй болохыг тогтоолгох			Нөхөрлөл, компаниийн тухай хуулийн 42.2.5, 44.4-т зааснаар "Машин механизм" ХК-ны 1997.12.27-ны өдрийн бүх гишүүдийн хурлаас ТҮЗ сонгосон шийдвэр, 1998.11.7-ны өдрийн бүх гишүүдийн хурлаас ТҮЗ сонгосон шийдвэрийг хүчингүйд тооцож шийдвэрлэсэн.	3 шатны шүүх
42	1374 /1999/	М.Баярраа	Г.Дашзэвэг	2948 ш хувьцаг өөрийн нэр дээр болгуулах	Бага хувьчлалын тасалбар		Харилцагчийн эвшээрлийг батлаж хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.	
43	464 /1997/	Р.Энхмаа	Н.Цэнд-Аюуш	70 ш хувьцааны мөнгийг зээлдүүлсэнийг хөрөнгийн биржийн одоогийн ханшаар тооцож гаргуулах	Бага хувьчлалын тасалбар		Иргэний хуулийн 229 дүгээр зүйлд зааснаар хувьцаагаа худалдах үеийн ханшаар тооцон төлүүлэхээр шийдвэрлэсэн.	Хувьцаа нь мөнгө зээлдүүлэх үед 4000 төгрөг байсан ба нэхэмжлэл гаргах үед 11000 төгрөг болсон байна.

44	714 /1998/		Т.Мягмар	Б.Амарзаяа	Биржийн арилжааны бус хэлцлээр худалдах журмын дагуу А-5-5 маягтаар хэлцэл хийсэн атал давхар худалдсан тул сүүлчийн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах	Хувьцаа	**Үнэт цаасны тухай** хуулийн 9, 26 дугаар зүйлд зааснаар 1200 ш хувьцааг 400:800-аар хувааж шийдвэрлэсэн /анхан шатны шүүх/	Давж заалдах шатны шүүх сүүлчийн хэлцлийг хүчингүйд тооцож, 1200 ш хувьцааг биржийн бус хэлцлээр авсан этгээдэд олгохоор шийдвэрлэсэн.
45	724 /1996/		ХИД 1-ийн хувьцаа эзэмшигч Ч.Эрдэнэчулуун	Монголын Хөрөнгийн Бирж	МХБ-ийн "Төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцоо хийх журам"-ыг баримтлан 54822 ш 1 багц хувьцааг "Ундарга" ББХК-д шилжүүлэх арилжааны бус үйлдэл хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах	Хувьцаа	Иргэний хуулийн 131.2-ыг зөрчсөн гэж дүгнээд мөн хуулийн 43.1-д зааснаар хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцон шийдвэрлэсэн.	
46	703 /1999/		И.Цэрэндолгор И.Намчин	-Үнэт цаасны хороо; -"Хаш орд" ХК; -ТӨХ /3-дагч этгээд/	-ҮЦХ-ны 49 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцуулах; -"Хаш орд" ХК-ны 1998.6.30-ны өдрийн ТУЗ-ын 7 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах.	Хувьцаа	-ҮЦХ-ны тогтоолыг хүчингүй болгуулах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгож; -"Хаш орд" ХК-ны ТУЗ-ын тогтоолыг хүчингүй болгож, хувьцааны асуудлыг ТУЗ-д шилжүүлэхийг даалган шийдвэрлэсэн.	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mi.gov.mn

Захиргааны хэргийн шүүхээр 1997 онд шийдвэрлэсэн хэрэг-3								
47	297	2007.8.13	Иргэн	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөл	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2007.5.24-ний 72-р өдрийн тогтоол, 2007.5.23-ний 1 дугээр дүгнэлтийг хүчингүй болгуулах			2007.11.21 1. УЦЗЗТХ 27.3.2, ЗХХШТХ 3.1.4, 4.2, 34.1.1 хэрэгсэхгүй болгох
48	128	Д.Дамдиндорж	Иргэн	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөл	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2008.3.11-ний өдрийн 1-р тогтоолыг хүчингүй болгуулах	"ТТ" ХК 1069 ширхэг хувьцаа		2008.5.8 1. СЗХЗЗБТХ 28.2 тогтоолыг хүчингүй болгох
49	177		Иргэн	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөл	СЗХ-ны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2008.3.10-ны 1-р тогтоолыг хүчингүй болгуулах болгуулах			2008.6.30 1. СЗХЗЗБТХ 28.2 тогтоолыг хүчингүй болгох

—oOo—

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАЖ БАЙГАА БАЙДАЛ

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОР

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СУДАЛГААНЫ АРГА, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгаа зорилго нь Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэлтэй хэргийг захиргааны болон иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэж байгаа практикийг судалж, холбогдох хууль тогтоомжийн үр нөлөөг эрдэм шинжилгээний үүднээс тодорхойлж, шүүхийн практикт үр нөлөө үзүүлэхүйц санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Уг зорилгын хүрээнд дараах **зорилт**уудыг дэвшүүлэн судалгааг явууллаа. Үүнд:

- Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорын хэмжээг тогтоох, нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтыг судалж, холбогдох хуулийн эргэлзээтэй, зөрчилтэй, давхардсан, тодорхой бус заалтуудыг олж тогтоох, сайжруулах, нэг мөр ойлголтод хүрэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх
- Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорын хэмжээг тогтоож байгаа практикт дүн шинжилгээ хийж, давуу болон сул талыг тодорхойлж, цаашид боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах

Судалгааг 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Судалгааг дараах зарчмыг баримтлан хийж гүйцэтгэв.

- Судалгааг бие даасан байдлаар шинжлэх ухааны арга зүйг баримтлан явуулах
- Судалгааг хийхдээ судалгааны объектийг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэн судлах
- Судалгааны үр дүнг зөвхөн тогтоогдсон баримтад үндэслэн бодитой гаргах

Нийслэлийн дүүргүүдийн шүүхээр 2007, 2008 онд иргэний журмаар шийдвэрлэгдсэн 89 хэрэг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхээр 2006 оноос 2009 оны 2 дугаар улирал хүртэлх хугацаанд шийдвэрлэгдсэн 99 хэрэг, нийт 188 шүүхийн шийдвэрийг уншин судалж, дүн шинжилгээ хийв.

1.2.СУДАЛГААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Эрх зүйт төрийн үйл ажиллагааны нэг эхлэл болсон "Хууль дээдлэх" зарчим нь нэгэнтэйгүүр засаг төрийн байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах суурь баталгаа болдог. Өөрөөр хэлбэл, засаг төрөөс иргэдтэй харилцаж эцсийн дүнд хуульд заасан үндэслэлийн дагуу шийдвэр гаргаж үр дүнг хариуцна. Гэтэл зарим тохиолдолд төрийн албан хаагч, албан тушаалтан мэдлэг чадвар дутсанаас болон бусад нөхцөл шалтгааны улмаас хууль бус үйлдэл хийж бусдад гэм хор учруулдаг. Түүний шалтгаан, үр дагавар, арга зам олон янз. Энэ сэдвээр 2007 онд судалгаа хийсэн боловч тал бүрээс нь түүнийг лавшруулан судлах шаардлага байсаар байна. Өнөөг хүртэл төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учирсан эдийн бус /сэтгэл санааны/ хохирлыг бүрэн гүйцэд, бодитой тодорхойлох, нөхөн төлөх арга, аргачлалтай холбоотой зарим харилцаа эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь уг шаардлага буйг харуулж байна.

Эрх зүйн аливаа сөрөг үзэгдлийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох нь тухайн асуудлыг зөв оношлож, гарцыг олж, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох зорилготой билээ.

1.3.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

Төрийн албан тушаалтны бусдад учруулсан гэм хорыг эрх зүйн зорилтын үр дагавар гэж үзвэл уг ойлголтыг төрийн алба, албан тушаалтны тухай ойлголтоос ургуулан авч үзэх ёстой билээ.

"Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ" гэж Монгол Улсын ТАТХ[108]-ийн 3 дугаар зүйлд тодорхойлжээ. Төрийн алба нь нийгмийн амьдралын бүх хүрээнд төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд албан хаагчаас албан тушаалын бүрэн эрхээ хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийнхээ дагуу хэрэгжүүлэх хөдөлмөрийн үйл ажиллагааны бие даасан онцгой төрөл бөгөөд хэлбэрийн хувьд улсын хуулийн дагуу байгуулагдсан засаг төрийн бие бүрэлдэхүүн, албан хаагчдын байгууллагуудын нийлбэр цогц юм.

Төрийн албан хаагчийг төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний алба гэж ангилна. Тэдгээр албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, зохих нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг **төрийн албан хаагч**/ Монгол Улсын төрийн албаны тухай хууль, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/ гэдэг.

[108] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

Хүснэгт 1. Төрийн албан хаагчийн ангилал.

Төрийн улс төрийн албан хаагчид	Төрийн захиргааны албан хаагчид	Төрийн тусгай албан хаагчид	Төрийн үйлчилгээний албан тушаалд
Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогдож, уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажилладаг, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны албан хаагчийг ;	Төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэшлийн үндсэн дээр байнга хэрэгжүүлдэг албан хаагчийг;	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчийг;	Төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахаар хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг албан хаагчийг хамаарууллаг байна.
	ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ		

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т "Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрх эрх чөлөөг баталгаатай эдлэх"-ээр хуульчилсан. Эрх зүйт төр, иргэний ардчилсан нийгэм бол хүнээ дээдлэн, иргэн нь хуулиар хориглоогүй зүйлийг хийж болох чөлөөт байдалтай, харин төр, түүний байгууллага, албан тушаалтан нь хуульд заасан эрх хэмжээ, журмын дотор ажиллах хязгаарлагдмал байдалтай байх тийм ёс зарчимд оршино гэсэн үг[109]. Угаас төр /нийтийн засаглалыг хэрэгжүүлэгч байгууллага/, түүний чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн албан хаагчийн онцлог нь хувь хүнээс харьцангуй давуу эрх эдэлж, нийтлэг эрх ашгийн төлөө төрийн албадлага хэрэглэх бүрэн эрхтэй байдаг тул эрх зүйн харилцааны онцлог субъект болдог.

Төр болон төрийн албан хаагчдад түүний буруутай үйлдэл, эс үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зохицуулалт эх газрын эрх зүйн тогтолцоонд бий болоод тийм ч урт удаан хугацаа өнгөрөөгүй байна. Өөрөөр хэлбэл, эрт үеэс л "төр", "хаан", "язгууртан" нар ямагт тусгай имунитетийн эрх эдэлж, хариуцлагаас "мултарсаар" ирснийг 19 дүгээр зуун хүртэлх эх газрын эрх зүйн хөгжлийн түүх бэлхнээ харуулах билээ.

Эх газрын эрх зүйн систем бүхий Европын улсууд 19 дүгээр зууныг хүртэл хувь хүнд учруулсан гэм хорынх нь төлөө төрийг хариуцлагад татдаггүй байсан. Учир нь Ромын эрх зүйд хувь хүнийг төрөөс хамгаалах үзэл баримтлал байдаггүй байв[110]. Өөрөөр хэлбэл, Ромын эрх зүйд гэм буруугийн төлөө хариуцлага хүлээх нь зөвхөн хувийн эрх зүйн субъектэд л хамаатай ойлголт байжээ. Бусдад хохирол учруулсан захиргааны актынхаа төлөө нөхөн төлбөр төлөхийг хүлээн зөвшөөрснөөр төрийн албан

[109] Б.Чимид, "Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл", УБ., 2004 он, 18 дахь тал.

[110] Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), 27 дахь талаас H.Street, Governmental Liability: A Comparative Study, 13 дахь талыг дам ишлэв.

хаагчид хариуцлага хүлээлгэх зарчим нийтийн эрх зүйд аажмаар хөгжиж эхэлсэн[111] байна. Өнөөдрийн байдлаар ихэнх улс оронд төр хариуцаж болох буруутай үйлдэл /эс үйлдэхүй, орч/-ийн улмаас өөрт учирсан бие махбодь, эдийн болон эдийн бус аливаа гэм хорыг нөхөн төлүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрсөн байна[112].

Нэгэнтээ нэвтэлж боломгүй мэт ойлгогдож байсан, төрийн буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхэд саад болж байсан засаглалын имунитетийн ойлголт хэдийгээр бүрэн арилаагүй ч гэсэн мэдэгдэхүйц багасч байна. Францад *actes de gouvernemento*, Англид *acts of state*, Америкт *political questions* имунитетээ хадгалж үлдсэн[113]. Аль ч улсад төрийн албан хаагч аливаа хариуцлагаас имунитетээр халхавчлагдахаа нэгэнт больжээ[114].

Дээр дурьдсанчлан төр, түүний албан хаагч нь хувийн эрх зүйн бусад субъектээс онцлог учир түүний хууль бус, буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад учруулж болох хохирол ч бас онцлог байх талтай. Хэдийгээр хохирол[115] гэдэг ойлголт хуулийн дагуу болон хууль зөрчсөн ямар ч үйлдлийн хувьд бий болж болох эдийн болон эдийн бус бүх сөрөг үр дагавар хэмээн ойлгогдох талаасаа эрх зүйн бусад субъектийн бусдад учруулах хохиролтой төстэй хэдий ч бас **илгаатай** байна. Үүнд:

1.Нийтийн эрх зүйн субъектийн хууль бус үйлдэл[116] нь тухайн зөрчлийн улмаас хохирол хүлээсэн этгээдээс гадна төрийн өөрийнх нь эрх ашигт ч бас нөлөөлж байдаг.

Зураг 1. Хохирлын үр дагаварын чиглэл.



[111] Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), 27 дахь талаас L. Trotabas, "Liability in Damages under French Administrative Law"(1930) 12 J.Comp.L. 44,49 дэх талыг дам ишлэв.

[112]Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), 27 дахь тал

[113]Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), 30 дахь тал

[114]Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), 32 дахь тал

[115] "Хохирол", "гэм хор" гэх хоёр ойлголтын аль нь өргөн хүрээтэй ойлголт болох, нарийн зааг ялгаа нь юу болох талаар монголын хуульчид, эрдэмтэн судлаачид нэгдсэн ойлголтод хүрээгүй тул энэхүү судалгааны ажлын хүрээнд дээрхи ойлголтуудыг хольж хэрэглэсэн болно.

[116] Хууль бус үйлдэл гэдэгт нийтийн эрх зүйн субъектийн бусдад хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэхүй, түүний гаргасан акт, бусад шийдвэр гэх мэт шүүхэд хариуцагчаар татагдах үндэслэл болох аливаа нөхцөл байдлыг хамруулан авч үзсэн болно. /судалгааны баг/

Өөрөөр хэлбэл, ТАтХ-ийн 4.2.7-д "хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах" мөн Иргэний хуулийн 498.2-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана" гэж заасны дагуу төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа учруулсан хохирлыг төрөөс хариуцан барагдуулдаг. Энэ утгаараа төр ч бас хохирдог.

2. Төрийн байгууллага, албан тушаалтнаас учруулж болох гэм хорын бас нэг онцлог нь ихэвчлэн Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг зөрчсөн шинжтэй байдагт оршино. Өөрөөр хэлбэл, жирийн иргэний аливаа хууль бус үйлдлийн хүрээнд Үндсэн хууль зөрчигдсөн тухай асуудал яригддаггүй. Харин төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн хүрээнд /ихэвчлэн олон нийтийг хамарсан эсвэл удаан хугацаагаар үргэлжилсэн хүний эрхийг зөрчсөн үйлдэл/ Үндсэн хууль зөрчигдсөн тухай ойлголт бий болдог. Жишээ нь, 1937 оны их хэлмэгдүүлэлт, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 5 хүний амь нас эрсдсэн явдал. Энэ тохиолдолд төр, түүний албан хаагч иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчсөнд тооцогдох бөгөөд албан ёсоор уучлалт хүсэх, нөхөн төлбөр олгох зэрэг арга хэмжээ авдаг байна.

Зураг 2. Субъектуудын хууль бус үйлдлээр зөрчигдөх эрх зүйн актын ялгаа.



3.Судалгааны явцад боловсруулсан мэдээллээс харахад дараах нийтлэг төрлийн маргаанд төрийн байгууллага, албан хаагч хариуцагчаар татагдсан байна[117].

[117] Судалгааны баг 2007, 2008, 2009 оны захиргааны хэрэг болон 2007, 2008 оны иргэний хэрэгтэй уншиж танилцан нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн зарим хэргийн түүвэрлэн авч, түүнд дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 2. Иргэний хэргийн шүүхээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хэргийн төрөл.



Хүснэгт 3. Захиргааны хэргийн шүүхээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хэргийн төрөл.



"Хохирол" гэдгийг академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" бүтээлдээ "... нэг этгээдийн хууль зөрчсөн үйлдлээр нөгөөд учруулсан мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэх хохирол. Үүнд хэн нэгэн этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнийг сэргээн тогтооход гаргах ёстой зардал, тэрчлэн түүний эд хөрөнгийг алга болгосон ба гэмтээсэн бодит зардал, олох ёстой байсан орлого" гэж тодорхойлжээ.

Судалгааны сэдвийн хүрээнд шүүхийн шийдвэрийг уншиж судлан дүгнэлт хийхэд авбал зохих цалин хөлсөө аваагүй, нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад гэрээгээр тохирсон төлбөр, хөлсөө авч чадаагүй, нэр төр, алдар хүндэд учруулсан гэм хорын болон хилс хэрэгт хэлмэгдсэний нөхөн төлбөрөөс өөрөөр хохирлоо нэхэмжилж, түүнийг нь шүүхээс хангасан тохиолдол бараг байхгүй байна. Гэтэл захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн дийлэнх нь зөрчигдсөн эрх сэргээх шинжтэй байгааг дараах хүснэгтээс харж болно[118].

[118] Зөрчигдсөн эрх сэргээх гэдэгт эрх зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрийг хүчингүйд тооцуулах эсвэл эрхийг гэрчилсэн бичиг баримт, үйл явдлыг хүчинтэйд тооцуулах тухай

Хүснэгт 4. Захиргааны хэргийн шүүхээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн нийт хэрэг дэх нэхэмжлэлийн шаардлагын төрөл



Харин нэхэмжлэгчид эрхээ зөрчигдөхөөс өмнөх байдалд сэргээн тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагадаа эдийн болон эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр илэрхийлээгүй байна.

1.4 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ /МУ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ/

1.4.1. Төрийн байгууллага, албан тушаалтан хариуцлага хүлээх үндэслэл, харьцуулсан судалгаа

Өмнөх бүлэгт бид төрийн байгууллага, албан тушаалтны учруулсан гэм хорын онцлог шинжийг илэрхийлсэн бол энэ бүлэгт тэрхүү гэм хорыг арилгах арга, хэлбэр буюу хууль зүйн хамгаалалтыг авч үзэх болно.

Юуны өмнө төрийн байгууллага, албан тушаалтны гэм хор учруулсан үйлдлийн цар хүрээ, хохирогчдын тоо, үргэлжилсэн хугацааг анхааран үзэх хэрэгтэй. Эдгээрээс шалтгаалан учирсан гэм хорын төрөл хэмжээ, ялгаатай байх ба түүнийг дагаад гэм хорыг арилгах арга, хэлбэр ялгаатай байж болно.

Монголын Улсын хууль тогтоомжийн хувьд гэм хорыг арилгах хариуцлагын үндэслэл нь зөрчлийн бүрэлдэхүүн байх бөгөөд энэ нь дараах элементээс бүрдэнэ. Үүнд:

нэхэмжлэлийг ойлгож байна.

- Хохирогч түүнд учирсан хохирол
- Гэм буруутай этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/
- Уг үйлдлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн байх /гэм хорын объект/
- Учирсан хохирол, гэм буруу хоёр хоорондоо шалтгаант холбоотой байх

УДШ-ийн 1997 оны 473 дугаар тогтоолд "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь гэм хор учруулагчийн хууль зөрчсөн үйлдэл /эс үйлдэхүй/, түүнээс учирсан гэм хор /хохирол/, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулсан этгээдийн гэм буруу тогтоогдсон үед үүснэ" гэжээ.

Бусад орны хууль зүйн практикийн хувьд Англи, Германы жишээг авч үзлээ.

Английн зөрчлийн эрх зүйн зарчмууд нь хувь хүн, төрийн эрх бүхий этгээд хоёрт тэгш үйлчилдэг. Төрийн байгууллага, эрх бүхий этгээд өөрт олгогдсон эрхээ хууль бус аргаар хэрэгжүүлсэн зөрчил үүнд хамаардаггүй. Англиийн Лордын танхим зөрчлийн 3 үндсэн элементийг тодорхойлсон байна. Үүнд: 1) хариуцагч нь заавал төрийн албан хаагч байх; 2) маргаантай үйлдэл нь төрийн албан хаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх; 3)тухайн төрийн албан хаагч нэхэмжлэгчийг хохироох зорилготой, эсвэл нэхэмжлэгчид гэм хор учирч болохыг мэдэж байсан[119] хэмээн авч үзжээ.

Германы Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ санаатай болон болгоомжгүй байдлаар зөрчсөн бол тэрхүү үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг учруулсан албан хаагч хариуцан арилгах үүрэгтэй".

Мөн хуулийн 34 дүгээр зүйлд "хэрэв аливаа этгээд өөрт нь олгогдсон төрийн /нийтийн- орч/ албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ зөрчсөн бол түүний хариуцлагыг төр эсвэл түүнийг ажиллуулж байгаа байгууллага зарчмын хувьд хариуцна" гэж заасан байдаг.

Германы Иргэний хуулийн 839 дүгээр зүйлийг 34 дүгээр зүйлтэй хамтатган хэрэглэх нь дараах хүрээгээр хязгаарлагдана. Үүнд:

- Тухайн зөрчил нь заавал төрийн албан хаагчийн үйлдлийн үр дүн байх;
- Тухайн маргаантай үйлдэл нь албан хаагчийн өөрт нь олгогдсон албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх;
- Учирсан гэх гэм хор нь зөрчигдсөн хэм хэмжээгээр хамгаалагдсан хүрээнд байх;
- Тухайн зөрчил нь санаатай болон болгоомжгүй байдлаар үйлдэгдсэн байх;[120].

[119]Walter Van Gervan, Jeremy Lever, Pierre Larouche, National, Supranational, International Tort law, pp.358

[120]Дурдсан бүтээл, 351 дэх тал

Төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Монгол, Англи, Германы эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан байдлаар хүснэгтлэн үзүүлбэл:

Хүснэгт 5. Хариуцлага хүлээлгэх үндэслэлийн талаарх харьцуулалт

№	Англи	Герман	Монгол
1.	Хариуцагч нь заавал төрийн албан хаагч байх.	Тухайн зөрчил нь заавал төрийн албан хаагчийн үйлдлийн үр дүн байх	Хохирогчид хохирол учирсан байх
2.	Маргаантай үйлдэл нь төрийн албан хаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх	Тухайн маргаантай үйлдэл нь албан хаагчийн өөрт нь олгогдсон албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой байх	Гэм хор учруулсан этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/ учирсан гэм хорын хооронд шалтгаант холбоо байх
3.	Тухайн төрийн албан хаагч нь нэхэмжлэгчийг хохироох зорилготой эсвэл нэхэмжлэгчид гэм хор учирч болохыг мэдсэн байх	Учирсан гэх гэм хор нь зөрчигдсөн хэм хэмжээгээр хамгаалагдсан хүрээнд байх	Гэм хор учруулсан этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байх
4.		Тухайн зөрчил нь санаатай боолтмжгүй байдлаар үйлдэгдсэн байх	Гэм буруутай байх.

1.4.2 Хохирлыг арилгах арга, хэлбэр, хэмжээг тогтоох нь

Эрх зүйн шинжлэх ухаанд олон онол байдгаас сүүлийн үед түгээмэл хэрэглэгдэж байгаа нь "Хууль ба эдийн засгийн онол" юм. Энэхүү онолоор бол хууль, эдийн засгийн хувьд заавал үр өгөөжтэй байхыг шаарддаг[121]. Яг энэ үндэслэлээр 2004 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш эмнэлгийн ажилтны алдаанаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн дээд хэмжээг 250 000 ам доллар гэж тогтоосон хууль санаачлан батлуулж[122] байжээ. Өөрөөр хэлбэл, эмнэлэг, эмнэлгийн ажилтны санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас бие махбодь, амь насаараа хохирсон хүмүүст учирсан гэм хорыг арилгахад шүүхээс шийдвэрлэж байгаа нөхөн төлөлтийн хэмжээ хэт өндөр байсан учраас АНУ-ын даатгалын салбар эрсдэлд орж доголдож байна хэмээн тэрээр үзсэн байна.

Учирсан гэм хорын төрлөөс шалтгаалан түүнийг үнэлэх аргачлал нь өөр өөр байдаг. Эдийн бодит хохирлыг нотлох баримтын хүрээнд үнэлэх нь мэдээж юм. Харин энэ хэсэгт чухалчлан авч үзэх нэг зүйл бол эдийн бус гэм хорыг үнэлэн тогтоох тухай асуудал. Энэ нь судалгааны нэг дэд сэдвийн хүрээнд бүрэн шийдэгдэх, судлагдах асуудал биш тул ул суурьтай судалгаа, удаан хугацааны хөдөлмөр шаардсан ажил тул судалгааны баг товчхон авч үзсэн болно.

[121] Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), pp.17

[122]Neglecting the neglected: The impact of non-economic damage caps on Meritoriuos Nursing Home Lawsuit. Michal L. Rustad, Thomas F. Lambert, p-2, 2007

Иргэний хэргийн шүүхээс нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн холбогдох шийдвэрүүдийг шүүж үзэхэд дараах үр дүн харагдаж байна.

Хүснэгт 6. Нэхэмжлэлийн шаардлагад дурьдсан гэм хорын төрөл



Мөн захиргааны болон иргэний хэргийн шүүхээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хэргүүдийн нэхэмжлэлийн шаардлагуудад дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 7. Иргэний хэргийн нэхэмжлэгчид хохирлоо дараах байдлаар тодорхойлсон байна.



Хүснэгт 8. Захиргааны хэргийн нэхэмжлэгчид хохирлоо тодорхойлсон байдал.



Дээрх байдлаас харахад захиргааны хэргийн шүүхтэй харьцуулахад иргэний хэргийн шүүхэд хандахдаа иргэд сэтгэл санааны гэм хорыг нэхэмжилсэн тохиолдол нь элбэг байх боловч нийт шийдвэрийн тоотой харьцуулахад энэ нь харьцангуй бага тоо юм. Үзүүлэлт ийм гарах нэг шалтгаан нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө" гэж заасантай холбоотой байж болох юм. Уг нь Үндсэн хуулиар иргэн хэн нэгний хууль бус үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлоо арилгуулах эрхтэй байдаг. Үндсэн хуулийн энэ ерөнхий заалтын агуулгад эдийн бус хохирлын ойлголт хамаарагдаж байгаа нь тодорхой.

Эдийн бус хохирлыг үнэлэх асуудал зөвхөн Монгол Улсын хувьд ч бус дэлхийн бусад улс орны эрх зүйд тулгарч буй бэрхшээл мөн ч олон оронд эдийн бус хохирлыг тухайн хэрэг маргаанд нь тохирсон хэмжээгээр үнэлэн арилгаж байна.

Хохирлыг арилгах хэмжээ, төрлийг тогтоохдоо дараах үндсэн үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд:

- Бодит хохирлын хэмжээ; /шаардлагатай бол шинжээч томилон ажиллуулах/
- Тухайн хохирол бий болоход нөлөөлсөн хохирогчийн гэм буруу;
- Зөрчил гаргагчийн үйлдлийн цар хүрээ, далайц, сэдэл;
- Зөрчил гаргагчийн санхүүгийн чадавхи;
- Даатгалд хамрагдсан байдал;
- Бусад.

1.4.3. Хохирлыг арилгах арга буюу хууль зүйн хамгаалалтын хэрэглүүр

Эрх зүйн бүл, улс орон бүр нийтлэг болон үндэсний соёл, уламжлалаас улбаатай онцлог олон аргыг гэм хорыг арилгах арга буюу хууль зүйн хамгаалалтын хэрэглүүр болгон ашигладаг. Үндсэн зорилго нь учирсан

хохирлыг арилгахаас гадна зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах, залхаан цээрлүүлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд оршдог байна. Дараах төрлийн хууль зүйн хамгаалалтын хэрэглүүрийг төрийн байгууллага албан тушаалтнаас учруулсан гэм хорыг арилгахад ашиглаж байна. Үүнд:

1.Тунхаглалын шинжтэй шийдвэр гаргах:

Эрх, статус, бусад хууль зүйн харилцааг цаашид сэргээх, нөхөн төлөгдөхөөс нь үл шалтгаалан тунхаглах бүрэн эрх шүүхэд байдаг. Тунхагийн шинжтэй шийдвэр нь албадлагын наад захын хэлбэр бөгөөд ихэнхдээ тодорхойгүй хууль зүйн харилцааг шийдвэрлэхэд ашигладаг. Энэ нь тодорхой үйлдэл, үйл ажиллагааг хууль бус болохыг тогтоох төдий бөгөөд түүнээс учирсан гэм хорыг арилгах асуудлыг албан тушаалтнуудад хариуцуулан үлдээдэг. Тийм ч учраас энэ нь аливаа хохирол учрахаас өмнө, учрах нь тодорхой болсон тохиолдолд тухайн шийдвэрийг гаргаж урьдчилан сэргийлэх хэрэглүүр болгож ашигладаг байна[123].

2.Нөхөн төлбөр:

Төр ихэвчлэн нийтлэг байдлаар гэм хороос үүдэлтэй учирсан хохирол /халааснаас гарсан мөнгө" гэсэн хэлц үгээр тодорхойлсон. орч/ болон ирээдүйд бий болох шууд болон шууд бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлж байна. Мөн нэлээд олон улсад төр бие махбодид учирсан гэм хороос үүдэлтэй өвчин, шаналлыг "эдийн бус гэм хор" гэсэн нэрийн дор мөнгөн хэлбэрээр нөхөн төлдөг. Харин зарим улсад үүнийг бодит бус гэж үзэн ёс суртахууны нөхөн төлбөрийг ашигладаг.

Нөхөн төлж болох хохиролд дараах үндсэн элементүүдийг ихэнх эрх зүйн бүлд ашиглаж байна.

a.Эмнэлэгийн тусламжийн төлбөр, болон асаргаа сувилгаа, зайлшгүй шаардлагатай тахир дутуугийн тоног төхөөрөмж, хангамжтай холбоотой зардал

b.Өнгөрсөн болон ирээдүйд олох ёстой байсан боловч олоогүй орлого, ашиг, түүнийг олох боломж

c.Алдагдсан ашгийг оруулан устсан болон гэмтсэн эд хөрөнгө

d.Эрүүл мэндэд учирсан гэм хор, өвчин, шаналал

e.Оршуулгын зардал

f.Хүртэж чадахгүй болсон, нас барсан болон гэмтсэн, бэртсэн хүнд үзүүлэх ёстой үйлчилгээ /халамж/

g.Зарим оронд уламжлал, заншлаасаа шалтгаалан бусад нэмэгдэл хохирлыг мөн нөхөн төлдөг[124].

Өвчин, шаналлыг ангилах, үнэлэх нь нөхөн төлөлтийн хувьд хамгийн хүнд бэрхшээл байгаа бөгөөд улс бүрт өөр өөр байна.

3.Торгуулийн буюу үлгэрчилсэн төлбөр:

Энэ нь нэрнээсээ тодорхой буюу нэхэмжлэгчид учирсан, нотлогдсон бодит хохирлоос үл шалтгаалан залхаан цээрлүүлэх, яллах шинжтэй төлбөр байдаг[125].

[123] Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), pp.34
[124]Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), pp.36
[125]Dinah Shelton, Remedies in international human rights law (2nd edition), pp.41

4.Мөнгөн хэлбэрийн бус хууль зүйн хамгаалалтын хэрэглүүр:

Олон орны эрх зүйн тогтолцоонд гэм буруутай этгээдийг учруулсан хохирлыг нь арилгуулахаар ямар нэгэн үйлдэл хийхийг эвсэл зөрчигдөхөөс өмнөх байдалд нөхөн сэргээхийг даалгадаг. Зарим азийн оронд буруутай үйлдлээ хүлээн зөвшөөрч уулчлалт хүсэх нь тухайн төрлийн буруутай үйлдлийг дахин давтахгүй байх баталгаа болдог[126]. Мөн хохирогчийн сэтгэл ханамжийг бий болгох, дахин тухайн төрлийн зөрчил гаргахгүй байх баталгааг бий болгох зэргийг энэ хэсэгт багтааж болно.

5.Habeas corpus /Баривчлагдах хуулийн үндэстэй эсэхийг шийдвэрлэх тухай шүүгчийн захирамж/ ба *amparo:*

- *Habeas corpus* нь хувь хүнийг хууль бус баривчилгаа, үндэслэлгүйгээр хорих ял эдлүүлэхээс хамгаалдаг.

- *Amparo* нь *Habeas corpus*-ээс өргөн хүрээтэй ойлголт бөгөөд хувь хүн үндсэн хуулиар олгогдсон аливаа эрхээ зөрчсөн гэж үзвэл төрөөс учирсан хохирлоо арилгуулахаар шүүхэд хандах эрхийг баталгаажуулдаг[127].

6.Өмгөөллийн зардал, төлбөр:

Хуулиар олгосон эрх нь зөрчигдсөн боловч хохирол учраагүй байна гэж үзвэл номинал /нэр төдий.орч/ төлбөрийг, харин гэм хор учруулснаас болон буруутай үйлдлийн улмаас учирсан шууд болон шууд бус хохирлыг арилгах зорилгоор нөхөн төлбөрийг гаргуулах асуудлыг шүүх шийдвэрлэдэг. Хариуцагчийн үйлдэл нь буруутай үйл ажиллагааны дараа нөхцөл байдлыг хүндрүүлсэн, нэхэмжлэгчийн хууль ёсны эрхийг бүдүүлэгээр үл хүндэтгэсэн бол үлгэрчилсэн төлбөрийг гаргуулдаг. Торгуулийн төлбөр нь хариуцагчийн жигшүүртэй үйлдлийг залхаан цээрлүүлэх зорилготой байдаг[128]. Дэлхийн улс орнуудад өргөн хүрээнд хэрэглэдэг дээрхи аргуудыг Монголын хуулиар олгосон боломжтой харьцуулан үзье.

Хүснэгт 9. Хууль зүйн хамгаалалтын хэрэглүүрийн харьцуулалт.

№	Дэлхийн улс орнуудад өргөн ашиглагддаг хууль зүйн хамгаалалтын хэрэглүүр	Монголын хуульд тусгагдсан байдал
1.	Тунхаглалын шинжтэй шийдвэр гаргах	Байхгүй
2.	Нөхөн төлбөр	Өвчин шаналлыг үнэлээгүй
3.	Торгуулийн буюу үлгэрчилсэн төлбөр	Иргэний болон захиргааны шүүхэд энэ эрх байхгүй.
4.	Мөнгөн хэлбэрийн бус хууль зүйн хамгаалалтын хэрэглүүр	Үйлдлийг хууль бусад тооцох, зөрчигдсөн эрхийг сэргээх, устсан, хүчингүй болсон баримт бичгийг хүчинтэйд тооцох гэх мэт
5.	*Habeas corpus /Баривчлагдах хуулийн үндэстэй эсэхийг шийдвэрлэх тухай шүүгчийн захирамж/* ба *amparo*	Байгаа
6.	Өмгөөллийн зардал, төлбөр	Хориглосон хуулийн заалт байхгүй боловч практик дээр тэр бүр хэрэгждэггүй

[126]Мөн тэнд, 43 дахь тал
[127]Мөн тэнд,.47 дахь тал
[128] Мөн тэнд, 49 дэх тал

1.4.4 Төр хариуцагчаар татагдсан байдал, үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-д "хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах" мөн Иргэний хуулийн 498.2-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана" гэж заасан тухай дээр дурьдсан. Энэ нь төр хариуцлага хүлээх хуулийн зүйн үндэслэлийн нэг болно.

Мөн төрийн алдаатай бодлого, хүмүүнлэгийн эсрэг онц ноцтой зэвсэглэсэн болон бусад хэлбэрийн үйлдэл, урт хугацааны хэлмэгдүүлэлт зэрэг Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийг зөрчсөн үйлдлүүдийн хувьд төр шууд хариуцагч болж учирсан хохирлыг арилгах үүрэг хүлээдэг.

Судалгаанаас харахад дараах төрлийн төрийн байгууллагууд шүүхэд нэхэмжлэгчээр татагджээ.

Хүснэгт 10. Иргэний хэргийн шүүхэд хамгийн олон удаа хариуцагчаар татагдсан байгууллага



Сургуулийн өмнөх боловсролын /Цэцэрлэг/ байгууллага ихэвчлэн ажлаас үндэслэлгүй халсан тухай, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар ажил гүйцэтгэх гэрээ, төлбөр тооцоо дутуу хийсэнтэй холбоотой, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ихэвчлэн эрх үүргээ буруу, хэтрүүлэн хэрэгжүүлсэн тухай маргаанд тус тус хариуцагчаар оролцжээ.

www.nli.gov.mn

Хүснэгт 11. Захиргааны хэргийн шүүхэд хамгийн олон удаа хариуцагчаар татагдсан байгууллага



Харин захиргааны хэрэг маргааны хувьд Онцгой байдлын ерөнхий газар ихэвчлэн ажлаас үндэслэлгүй халсан тухай маргаан, Татварын хэлтэс татвар үндэслэлгүй, буруу оногдуулсантай холбоотой маргаанд, Засаг даргын Тамгын газар ихэвчлэн газрын харилцаатай холбоотой маргаанд, Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор тус тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар оролцжээ.

1.4.5 Төрийн албан хаагч хариуцагчаар татагдсан байдал, онолын үндэслэл

Иргэний хэргийн шүүхэд ажлаас үндэслэлгүй халсан, бусдын нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан, бусад байдлаар эрх хэмжээгээ хэтрүүлсэн, албаны үүргээ буруу, дутуу хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор төрийн албан хаагч хариуцагчаар татагдсан байна.

Хүснэгт 12. Иргэний эрх зүйн маргаанд төрийн албан хаагч хариуцагчаар оролцсон хэргийн төрөл



Харин Захиргааны хэргийн шүүхэд төрийн албан хаагч ажлаас үндэслэлгүй халагдсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой болон бусад байдлаар бүрэн эрхээ хэтрүүлэн эсвэл буруу, дутуу хэрэгжүүлсэнтэй холбоотой маргааны улмаас шүүхэд хариуцагчаар татагдсан байна.

Хүснэгт 13. Захиргааны эрх зүйн маргаанд албан хаагч хариуцагчаар оролцсон хэргийн төрөл



Албан тушаалын хувьд удирдах ажилтан, Засаг дарга, улсын байцаагчид хэрэг маргааны хариуцагч болох нь элбэг байна.

Хүснэгт 14. Хэргийн хариуцагчаар оролцсон албан тушаалын төрөл



ХОЁР. ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

2.1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА ХОЛБОО, ЗӨРЧИЛ, ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх эрхийг хуульчилсан. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь хэлэлцэн тохиролцсон гэрээ, хэлцлийг ямар нэг байдлаар зөрчсөнтэй холбоогүйгээр үүсэх бөгөөд гэм хор учруулагчийн хууль зөрчсөн үйлдэл (эс үйлдэхүй), түүнээс учирсан гэм хор (хохирол), тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулсан этгээдийн гэм буруу тогтоогдсон үед үүснэ.

Энэ талаар академич С.Нарангэрэл "Гэм хор гэж иргэний эрх зүйд субьектив эрх буюу баялгийг багасгах, устгахыг хэлнэ. Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт **хохирол** гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэм хор буюу хохирол гэсэн хоёр үг нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хор гэдэгт үнэлгээний хэлбэр бүхий эрх зүйн зөрчлийн материаллаг /эдийн засгийн/ үр дагаврыг ойлгоно. Эд хөрөнгийн гэм хорын материаллаг үнэлгээг "хохирол" гэж нэрлэнэ. Эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны гэм хор гэж бусад этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан зан суртахууны ба бие махбодийн зүдгүүр шаналал"[129] гэж тодорхойлсон байдаг.

Харин судлаач Д.Наранчимэг "Гэм хор нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл мөн. Гэм хор нь субъектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг" гээд гэм хорыг материаллаг ба материаллаг бус гэж ангилсан байна. Материаллаг гэм хор гэдэгт бодит хохирол алдагдал, олох байсан орлого, зардал ордог бол материаллаг бус /ёс суртахууны/ гэм хор гэдэг нь амь нас хохирсон, эрүүл мэндийг сарниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах[130] зэрэг орно гэж тодорхойлжээ.

Мөн доктор Т.Мөнхжаргал "Хохирол бол хариуцлага хүлээлгэх нэг нөхцөл мөн. Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид хохирол эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус шинжтэй болохыг заасан. Мөн тэр нь эрх зөрчигчийн ямар нэг үйлдлээр үүсч, ямар нэг хэлбэрээр илрэх байдлыг ойлгоно. Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал буюу гэмтэл, үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид орох байсан орлогыг хохиролд тооцно[131] гэж эд хөрөнгийн хохирлыг тодорхойлсон.

[129] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2007 он

[130] Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. УБ.,1999 он

[131] Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй. УБ., 1997 он

Үүнээс үзвэл "гэм хор", "хохирол" гэдэг нь үг зүйн талаасаа ялгаатай утга санааг илэрхийлэх ч гэм хор = хохирол гэж ойлгож болохоор байна. Өнөөдөр практикт эдгээр нэр томьёонд юуг хамааруулан авч үзэх талаар тайлбар хараахан гараагүй байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан гэм хорыг арилгаж байгаа талаар зохицуулсан эрх зүйн актын хүрээнд дээрх нэр томьёог хослуулан хэрэглэж байгаа нь хуулийг нэг мөр ойлгоход хүндрэлтэй болгожээ. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 412 хуулиас[132] "**гэм хор**" гэсэн нэр томъёог хэрэглэсэн 31 хууль байгаагаас төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учруулсан гэм хорын хариуцлагын талаар оруулсан заалттай 3 хууль байна. Үүнд:

1.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Иргэний бүртгэлийн ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх хохирсон бол учирсан **гэм хорыг** хууль т(эдийн гэм хор эдийн бус гэм хор

2.Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад **гэм хор** учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд бүюу төр хариуцан арилгана.

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг холбогдох бүртгэх байгууллага хариуцан арилгана гэж тус тус заасан байна.

Гэм хор гэдэг нь үг зүйн үүднээс **"гэм"** гэдэг нь: ёс зүйгээс ангид хийсэн үйл явдал, түүний уршиг, нөлөө[133]; **"хор"** гэдэг нь гэм, хөнөөл, аюул, зовлон[134]; **"хохирол"** гэдэг нь алдаа, алдагдал, хөнөөл, сүйтгэл[135] гэж монгол хэлний зүйд тайлбарласан. "Гэм хор" гэдэг нь эрх зүйн зөрчил буюу гэмтэй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүсэх сөрөг үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн харилцаанд оролцогч субъект болох иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө, амь бие, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэгт гэм буруугүйгээр болон гэм буруугийн санаатай ба болгоомжгүй хэлбэрээр учруулсан хохирол[136] гэж ойлгож болно. Харин судалгааны сэдвийн хүрээнд "**хохирол**" гэсэн нэр томъёо хэрэглэсэн 151 хуулиас төрийн байгууллага албан тушаалтны хууль бус үйлдлээс учруулсан хохирлын талаар заасан нь 18 байна. Үг зүйн үүднээс ялгаатай нь харагдаж байгаа боловч хуульд хэрэглэж буй агуулгаараа утгын ялгаагүйгээр тусгасан нь ажиглагдлаа. Жишээ нь:

[132] www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

[133] Шинжлэх Ухааны Академи. Хэл зохиолын хүрээлэн. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. УБ., 2008 он. 580 дахь тал

[134]Мөн бүтээл. 2562 дахь тал

[135] Мөн бүтээл. 2582 дахь тал

[136] Б.Улаанбаатар, "Иргэний эрх зүйн тайлбар толь", УБ., 2005 он. 27 дахь тал

1.Авлигын эсрэг хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-т Авлигатай тэмцэх газрын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна. 32 дугаар зүйлийн 32.5-д Авлигатай тэмцэх газрын албан хаагч эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, даалгаврыг ёсчлон биелүүлснээс үүссэн хохирол, сөрөг үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

2.Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т Авто замын ашиглалтын нөхцөл хангагдаагүйгээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хохирол учирсан болохыг хууль, хяналтын байгууллага тогтоосон бол тухайн авто замын арчлалт, хамгаалалт хариуцсан авто замын байгууллага уг хохирлыг хариуцан төлнө.

3.Орон сууц хувьчлах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т Орон сууц хувьчлахтай холбогдуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол түүнд учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнө гэж тус тус заасан байгаагаас харахад гэм хор болон хохирол гэсэн нэр томьёо нь адил утгыг илэрхийлж байна гэх үндэстэй.

Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид "Хуулийг чанаржуулах, гол юмаа цөөн хуулиар зохицуулах учиртай юм. Энэ талаар хууль хичнээн олширвол төрийн байгууллага эмгэг өвчтэй сул дорой байгааг харуулж буй хэрэг гэж Ф.Вольтер /Франсуа/ хэлжээ" хэмээн бүтээлдээ дурдсан байна. Мөн тэрээр "Цаашид хуулиудаа эргэн харж цөөрүүлэх, чанаржуулах чигийг баримтлах нь чухал"[137] гэснээс харахад хуулийн уялдаа, давхардал, хийдлийг олж тогтоох шаардлага байгааг харуулж байгаа юм.

Уг судалгааны хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлалыг ашиглан хийлээ.

Дархлаажуулалтын тухай хууль /2000.04.20/ 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг болон Донорын тухай хуулийн /2000.01.28/ 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Иргэний эрүүл мэндэд учруулсан гэм хорын хохирлыг Иргэний хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу гэм буруутай этгээд нөхөн төлнө" хэмээн давхардуулан заасан байна. Мөн энд "гэм хорын хохирол" гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь гэм хор нь өргөн утгатай, хохирол нь гэм хорын бүрдэл хэсэг мэт ойлгогдохоор болжээ. Судалгааны явцад "гэм хор" гэсэн хуулийн заалт 3, "хохирол гэсэн нэр томъёогоор 18, нийт 21 хуульд дүн шинжилгээ хийснээс 6 хуульд адил агуулгатай, 9-д нь давхардсан заалт орсон байна.

Улсын дээд шүүх Гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаарх Иргэний хуулийн зарим, зүйл, заалтыг тайлбарлах тухай 1997 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 473 дугаар, Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор,

[137]Чимид Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал, Нийтлэг асуудал. Нэгдүгээр дэвтэр, УБ., 2004 он, 147 дахь тал

шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 45 дугаар; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийн зарим, зүйл, хэсгийг тайлбарлах тухай 60 дугаар, Хөдөлмөрийн тухай хуулийн заримзүйл, заалтыг тайлбарлах тухай 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 33 дугаар тогтоол, Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим, зүйл, заалтыг тайлбарлах тухай 2006 оны 5 дугаар сарын 2-ны 27 дугаартай тогтоолыг тус тус /тайлбар/ гаргасан байна.

2.2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНААС ИРГЭНД УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАЖ БУЙ ПРАКТИК /ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ/

Харьцуулан судлахдаа төрийн байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан гэм хорыг арилгаж буй практикийг эх газрын эрх зүйн бүлд харъяалагдах зарим улсын холбогдох хууль тогтоомжийг судлан үзэв.

Харьцуулалсан судалгааны обьектод Иргэний хууль болон бусад холбогдох хуулиуд хамаарна. Судалгааны хүрээнд ХБНГУ, ОХУ зэрэг улсын хуулийг эх сурвалж болгож задлан шинжилгээ хийж, үүнээс гадна социалист эрх зүйн бүлийн хувьд БНХАУ-ын Иргэний хуулийг авч үзлээ.

ОХУ-ын Иргэний хууль /1998 он/

1069 дүгээр зүйл. Хохирол учруулсан төрийн байгууллага болон өөрөө удирдах байгууллага мөн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх

Төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, эдгээр байгууллагад алба хашиж буй албан хаагчдын буруутай, хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ээс болж иргэд болон хуулийн этгээдэд хохирол учруулсан үүнийг нөхөн төлөх үүрэгтэй. Хохирлыг ОХУ-ын сан, ОХУ-ын дагавар улсуудын сан болон орон нутгийн боловсролын сангаас олгоно.

1070 дугаар зүйл. Хэрэг буртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн байгууллагаас учруулсан хохиролд хариуцлага хүлээлгэх тухай.

1.Хууль бусаар яллах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хорих аргаар таслан шийтгэх арга хэмжээ авах, захиргааны баривчилгаа хийж захиргааны хариуцлага хүлээлгэсний улмаас иргэнд учирсан хохирол, мөн хууль бусаар хуулийн этгээдэд үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, түр зогсоох захиргааны арга хэмжээ маягаар захиргааны хариуцлагыг хүлээлгэхээс үүдсэн хохирлыг ОХУ-ын сангаас нөхөн барагдуулах ба хуульд заагдсан тохиолдолд хэрэг буртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн албан тушаалтнуудын буруутай эсэхээс үл хамааран ОХУ-ын дагавар улсуудын сан болон орон нутгийн боловсролын сангаас бүрэн хэмжээгээр нөхөн барагдуулна.

2.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас үүдэн иргэн болон хуулийн этгээдэд уг зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан үр дагаварт нөлөөлөхгүй /үр дагаваргүй/ хохирол учирвал уг хуулийн 1069 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хохирлыг нөхөн төлнө. Хэрвээ хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр шүүгчдийн буруутай нь тогтоогдвол шүүн таслах ажиллагааны үед гарсан хохирлыг нөхөн төлнө.

1071 дүгээр зүйл. Сангийн өмнөөс хохирлыг нөхөн барагдуулах байгууллага, этгээд

Уг хуулийн дагуу болон бусад хуулийн дагуу учруулсан нийт хохирлыг ОХУ-ын сан, ОХУ-ын дагавар улсуудын сан, орон нутгийн боловсролын сангаас нөхөн барагдуулж байгаа үед уг хуулийн 123 дугаар зүйлийн 3-т заасны дагуу энэ үүрэг нь өөр ямар нэгэн байгууллага, хуулийн этгээд болон иргэнд оногдоогүй тохиолдолд сангийн нэрийн өмнөөс санхүүгийн байгууллагууд хариуцна.

ХБНГУ-ын Иргэний хууль. /1896 он/

832 дугаар зүйл. Хохирол нөхөн төлөх үүрэг.

1)Бусдын амь нас, бие эрхтэн, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө болон бусад эрхэд санаатай болон болгоомжгүй байдлаар эрх зүйг зөрчин хохирол учруулсан бол түүнээс учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

2)Бусдын хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчсөн этгээдэд дээр дурьдсан үүрэг мөн адил үүснэ. Хуулийн агуулгын дагуу гэм буруугүйгээр ч түүнийг зөрчсөн байж болох ч хохирол нөхөн төлөх үүрэг нь гагцхүү гэм буруутай үед л үүснэ.

БНХАУ-ын Төрөөс төлөх тухай хууль /1995 он/

Тус хууль нь БНХАУ-ын Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн хурлын 8 дугаар хугацааны байнгын хорооны 7 дугаар хурлаар 1994 онд батлагдаж 1995 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилсэн.Энэ хууль нь 6 бүлэгтэй.

1 дүгээр бүлэг нь Нийтлэг үндэслэл

2 дугаар бүлэг нь Захиргааны байгууллага, албан тушаалтнаас олгох төлбөр. Үүнд:

1.Хохирлыг төлж барагдуулах хэмжээ, хязгаар

2.Хохирол барагдуулах шаардлага гаргах эрх бүхий субъект, хохирол барагдуулах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан

3.Хохирол барагдуулах журам

3 дугаар бүлэг. Эрүүгийн хэргийн хохирол барагдуулах

1.Хохирлыг төлж барагдуулах хэмжээ, хязгаар

2.Хохирол барагдуулах шаардлага гаргах эрх бүхий субъект, хохирол барагдуулах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан

3.Хохирол барагдуулах журам

4 дүгээр бүлэг. Хохирол барагдуулах арга, хэлбэр, хэмжээ тогтоох стандарт

5 дугаар бүлэг. Бусад тогтоол

6 дугаар бүлэг. Дагалдах дүрэм гэсэн бүтэцтэй.

3 дугаар бүлэг. 15 дугаар зүйл. Эрүүл мэнд, амь насанд хохирол учруулах

Мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний албан тушаалтнаас дор дурьдсан үүрэг гүйцэтгэх явцад өөрт учруулсан гэм хорыг арилгуулах эрхтэй. Үүнд:

1.Гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг бүрэн тогтоогоогүй, нотлох баримтыг дутуу бүрдүүлж цагдан хорьсон.

2.Гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг бүрэн тогтоогоогүй, нотлох баримтыг дутуу бүрдүүлж баривчилсан.

3. Шүүхийн шийдвэрт хяналт тавих журмын дагуу ялаа эдлээд дууссаны дараа гэм бурууг нь тогтоогдож цагаатгагдсан этгээд.

4.Эрүү шүүлт тулгах, зодох, хууран мэхлэх байдал гаргаж мэдүүлэг авч хүний биед гэмтэл учруулсан, улмаар амь насыг нь хохироосон.

5.Галт зэвсэг, тусгай хэрэгслийг хууль бусаар хэрэглэж хүний биед гэмтэл учруулсан, улмаар амь насыг нь хохироосон.

16 дугаар зүйл. Эд хөрөнгийн хохирол учруулах

Мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний албан тушаалтнаас дор дурьдсан үүрэг гүйцэтгэх явцдаа иргэнд учруулсан эд хөрөнгийн гэм хорыг арилгуулах эрхтэй. Үүнд:

1.Хууль бусаар эд хөрөнгийг битүүмжилсэн, захиран зарцуулах эрхийг хязгаарласан, хураан авсан.

2.Торгох, эд хөрөнгө хураах ял шийтгүүлээд цагаатгагдсан этгээд.

17 дугаар зүйл. Дараах нөхцөл байдалд төр хариуцлага хүлээхгүй.

1)Хохирогч өөрөө зориуд шууд санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэн цагдан хоригдсон болон баривчлагдсан.

2)Эрүүгийн хуулийн 14, 15 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй хүн хоригдсон.

3)Эрүүгийн заргын хуулийн 11 дүгээр зүйлд заасан эрүүгийн хариуцлагад татагдаж болохгүй этгээд цагдан хоригдсон, баривчлагдсан.

4)Дээрхи байгууллага, албан тушаалтны албан үүрэгтэй нь холбоогүйгээр хохирол учирсан бол.

5)Хохирогч өөрийн биедээ санаатай гэмтэл учруулсан.

6)Бусад байдал.

19-р зүйл. Хохирол барагдуулах үүрэг бүхий байгууллага

1)Мөрдөн байцаах, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

2)Үндэслэлгүйгээр цагдан хоригдсон цагдан хорих тухай шийдвэр гаргасан байгууллага

3)Үндэслэлгүйгээр баривчлах шийдвэр гаргасан байгууллага.

4) Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас ял эдлээд цагаатгагдсан бол шүүх

5)Давж заалдах шүүхээр тухайн хэрэгт цагаатгагдсан бол 1 дүгээр шатны шүүхийн байгууллага.

20 дугаар зүйл. Хохирол барагдуулах журам.

1)Хохирогч нь дээрхи байгууллагад хохирсон тухай гомдлоо гаргана.

2) Тухайн байгууллага нь уг гомдлыг хүлээн аваад 2 сарын дотор хохирлыг барагдуулна. Хэрэв барагдуулаагүй тохиолдолд шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны байгууллагад гомдол гаргана.

3)Дээд шатны байгууллага 2 сарын дотор шийдвэр гаргах ёстой ба хохирогч шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бол шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны байгууллагатай шатлал тэнцүү шүүхэд гомдол гаргана.

4)Шүүх нь 3-7 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хохирол барагдуулах комиссыг байгуулна. Тус комисс нь олонхийн саналаар шийдвэрээ гаргах бөгөөд уг шийдвэр эцсийнх байна.

26 дугаар зүйл. Төлбөр барагдуулах жишиг

Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан бол өмнөх жилийн хөдөлмөрийн хөлсийг тэгшитгэсэн дундаж хэмжээгээр тогтооно.

ГУРАВ. ИРГЭН, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ ДЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ АСУУДАЛ

3.1. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ АСУУДАЛ

Гэм хороос үүсэх үүргийн нэг төрөл нь байгууллага, албан тушаалтнаас бусдад учруулсан гэм хорыг арилгах үүрэг юм. Энэхүү үүргийг Иргэний хуулийн 498 дугаар зүйлээр зохицуулахаар хуульчилсан бөгөөд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэг бүхий байгууллагыг доорхи хэлбэрээр тусгажээ. Үүнд:

1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа **ажил олгогч** хүлээнэ.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа **хуулийн этгээд** буюу **төр** хариуцан арилгана.

3.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм буруутай үйлдлийн улмаас бусдад учруулсан гэм хорыг **төр** хариуцан арилгана.

Үүнээс үзэхэд гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээдийг:

- Хөдөлмөрийн гэрээгээр бусдыг ажиллуулж байгаа ажил олгогч эзэд
- Төрийн албан хаагчийг ажиллуулж байгаа хуулийн этгээд
- Төр гэж ангилан үзэж болно.



Харин гэм хор учруулж болох субъектэд:

1.Хөдөлмөрийн гэрээ, контрактаар албан тушаалын эрх мэдлийн үүргээ гүйцэтгэж буй түр албан хаагч

2.Төрийн захиргааны албан хаагч

3.Төрийн тусгай албан хаагч /Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч г.м/ нар орно.

Иргэний хуулийн 498.1-д заасан байгууллагад төрийн байгууллагаас бусад байгууллагыг ч хамруулан авч үзэж болох юм. Жишээ нь хэдийгээр талууд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр тодорхой үйл ажиллагааг явуулж байгаа ч зөрчлийн улмаас үүрэг үүсч болохыг үгүйсгэхгүй. Тухайлбал сургуулийн өлгүүрийн ажилтан оюутны гадуур хувцсыг харж хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс бусдад гэм хор учруулбал тухайн гэм хорыг уг ажилтан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр арилгах үүрэг үүсэхгүй бөгөөд харин эхний ээлжинд сургуулийн захиргаа уг гэм хорыг Иргэний хуулийн гэм хор учруулсны улмаас үүсэх үүргийн дагуу арилгана[138]. Энэ нь тухайн төрийн үйлчилгээний албан хаагчийг ажиллуулж байгаа ажил олгогч хариуцлагыг хүлээж байгаа нэг хэлбэр юм. Мөн Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн учруулсан гэм хорыг арилгах журмыг хуульчилсан байна. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 4-т төрийн тусгай албан тушаалтнаас бусдад учруулсан гэм хорыг арилгах тусгай үйлдлийг хуульчилсан бөгөөд энэ нь захиргааны удирдлагын актаар бусдад учруулсан гэм хорыг арилгах үйлдлээс ялгаатай[139].

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана" гэж заасны дагуу төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа учруулсан хохирлыг эхний ээлжинд төрөөс хариуцан барагдуулдаг бол уг хуулийн 498.5-д хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагч өөрийн ***шууд санаатай*** буюу ***илтэд болгоомжгүй*** үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй гэж заасан байгаа нь төрийн албан хаагчийг өөрийн хийсэн үйлдлийн улмаас үүсэх хариуцлагыг төр хариуцна гэсэн нэрийн дор албан тушаалаа урвуулах, эрх мэдлээ хэтрүүлэх гэх мэт зохисгүй үйлдэл хийхээс сэргийлж байгаа заалт юм. Иймээс **Төрийн албан хаагчийн хариуцлагыг:**

-төрийн албан хаагчийн хариуцлага /төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэж байхдаа өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан/

-Төрийн хариуцлага /төр нь өөрийн албан хаагчийн буруутай ажиллагааны үр дагаврыг шууд хүлээж хохирлыг нь хариуцах/ гэж ангилж болохоор байна.

[138] Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй. УБ., 2005. 6 дахь тал.

[139] Дурдсан бүтээл. УБ., 2005. 9 дэх тал.

Иргэний эрх зүй дэх гэм хорыг арилгах тухайд:

Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд нь сэргээх үүрэгтэй ба тухайн хүний зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг нөхөн төлж болно.

Харин хүний амь нас, бие эрхтэн, өвчин зовиур, шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй[140].

Хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээгээр ямар нэг албан байгууллагад ажиллаж байсан ажилтан байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас эрүүл мэнд нь хохирсон буюу хөдөлмөрийн чадвар нь буурсан тохиолдолд гэм буруутай этгээд хохирогчид сар тутам мөнгө /тэжээн тэтгэхтэй холбогдсон тэтгэлэг/ төлөх замаар гэм хорыг арилгах үүрэгтэй. Энэ тохиолдолд сар тутам мөнгө авахааргүй хүндэтгэн үзэх шалтгаан байвал хохирогч нэг удаагийн нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй байна. Мөн Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 4-т зааснаар тухайн хэргийн улмаас хохирсон этгээд эмнэлэгт эмчлүүлэх болон эмчилгээ хийлгэх тохиолдолд эмнэлгийн зайлшгүй зардлыг урьдчилан төлүүлэхээр гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээдээс шаардах эрхтэй байгаа нь хохирогчийн эрхийг хамгаалж байгаа нэг хэлбэр юм.

Гэм хорыг арилгах хэмжээ: Гэм хороос үүссэн хохирол нь учруулсан хохирлын хэмжээгээр төлөгдөх бөгөөд түүнийг багасгах буюу ихэсгэх тохиолдлыг зөвхөн хуулиар тогтоож өгнө[141]. Өөрөөр хэлбэл өөрийн үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан этгээд хууль тухайн гэм хорыг арилгах үүргийг зааж өгсөн тохиолдолд л гэм буруутай этгээдэд учруулсан хохирлоо арилгах үүрэг үүсэх бөгөөд гэрээний үндсэн дээр эдгээр үүргийг ямар нэгэн байдлаар өөрчилж болохгүй.

Гэм хорыг арилгах хариуцлагын үндэслэл болсон зөрчлийн бүрэлдэхүүн нь:

- Хохирогчид хохирол учирсан байх;
- Гэм хор учруулсан этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байх
- Гэм хор учруулсан этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/ учирсан гэм хорын хооронд шалтгаант холбоо байх;
- Гэм буруу байх зэргээс бүрдэнэ.

Ийм учраас Монгол Улсын Дээд шүүхийн 1997 оны 473 дугаар тогтоолд "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь гэм хор учруулагчийн хууль зөрчсөн үйлдэл /эс үйлдэхүй/, түүнээс учирсан гэм хор /хохирол/, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулсан этгээдийн гэм буруу тогтоогдсон үед үүснэ" гэжээ. Гэм хор учруулсан этгээд нь дээрхи хохирлыг ямар хэлбэрээр учруулснаас үл хамааран дараах аргаар арилгах үүрэгтэй. Гэм хор учруулсны улмаас үүсэх хариуцлагыг хүлээж буй этгээд нь хохирлыг гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр төрөл,

[140] Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 1997он. №15

[141] Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй. УБ., 2005. 9 дэх тал.

чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу бусад хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй[142].

Эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг тодорхойлохдоо: Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-т зааснаар хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал, гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-т зааснаар гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд нь сэргээх үүрэг үүснэ. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно, мөн Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар гэм хор учруулахаас өмнөх байдалд нь сэргээхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээгээр тогтооно.

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэм буруутай этгээд эд хөрөнгийн хохирол учирсан эсэхээс үл хамааран мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах эдийн бус гэм хорын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2-т зааснаар мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаад учирсан үр дагавар зэргийг харгалзан тодорхойлно.

Иргэний хуулийн 497.3-д зааснаар гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцна. Хамтран оролцогчдод дараах этгээдүүдийг хамруулан ойлгоно. Үүнд:

- Шууд гэм хор учруулсан этгээд
- Уруу татсан этгээд
- Дэмжин тусалсан этгээд
- Гэм хор учруулсны үр дүнг ашигласан этгээд орно.

3.2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрхтэй", 19 дүгээр зүйлийн 1-т "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заажээ. Энэ нь бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас учирсан аливаа гэм хорыг нөхөн төлүүлж арилгуулах эрхтэй гэсэн суурь зохицуулалт юм.

Сэдвийн хүрээнд захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах асуудлыг авч үзсэн болно. Зарим тохиолдолд захиргаа өөрт олгогдсон эрхийн хүрээнд

[142]Дурдсан бүтээл. 10 дахь тал

бусдад гэм хор учруулж байдаг. Жишээ нь, бусдын өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор улсын хэрэгцээнд, нийтлэг ашиг сонирхлын үүднээс хураан авах. Захиргаа, түүн дотор гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаа нь эрх зүйт төрийн зарчим буюу хууль дээдлэх зарчимд үндэслэгддэг хэдий ч зарим тохиолдолд хуулиар олгосон эрхийн хүрээнд засагласан шийдвэр гаргаж байдаг. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүй нь захирах захирагдах харилцаан дээр үндэслэгддэг.[143] Гэвч энэ нь нэг талын хүсэл зоригийг төгс илэрхийлнэ гэж үзэж болохгүй. Учир нь "хууль шүүхийн өмнө эрх тэгш байх" эрх зүйт зарчмын хүрээнд захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, үйл ажиллагааг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн журмаар хязгаарлаж байдаг. 2004 онд Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянах боломжийг нэг алхмаар урагшлуулсан юм. Захиргааны байгууллага. тэр дундаа төрийн байгууллагын хууль бус үйлдлээс дараах хоёр субъектэд гэм хор учирч байна гэж үзэж болохоор байна.

- **Захиргааны үйл ажиллагаа, шийдвэр чиглэгдсэн этгээд**
- **Захиргааны байгууллага /Төрийн эрх ашиг/**

Захиргааны үйл ажиллагаа, шийдвэр чиглэгдсэн этгээд

Хуулийн дагуу эрх олгогдсон /тусгай зөвшөөрөл олгох. цуцлах, торгууль шийтгэл оногдуулах, дүрэм, журам гаргах, хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох г.м/ албан тушаалтны эрх зүйн үр дагавар үүсгэсэн үйл ажиллагаа, шийдвэр нь тодорхой этгээдийн /хувь хүн, хуулийн этгээд, тодорхой салбар/ хууль ёсны ашиг сонирхолд харшилж байна гэж үзвэл урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн журмаар хамгаалж болно. Захиргааны байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг тогтоох, нөхөн төлүүлэх шийдвэр гаргах ажиллагааг захиргааны хэргийн шүүх болон иргэний хэргийн шүүхийн журмаар шийдвэрлэж болно.[144] Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2006-2009 онд шийдвэрлэсэн хэргүүдийн ерөнхий байдлыг харвал төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан хохирлын төрлийг хөдөлмөрийн харилцаатай холбоотой хэрэг маргаан дийлэнх хэсгийг эзэлж байна. Нэхэмжлэлийг дараах 2 үндсэн шаардлагад хуваж болохоор байна. Үүнд:

- ажилд эгүүлэн тогтоолгох /зөрчигдсөн эрхээ сэргээлгэх буюу эдийн бус гэм хор/

- ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгохыг даалгах /олох ёстой байсан орлого буюу эдийн гэм хор/

хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэсэн хууль тогтоомжийн хувьд Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн зохицуулалтыг хэрэглэсэн байна. Эдгээр тохиолдол нь хэдийгээр учирсан гэм хорыг арилгаж байгаа боловч гэм буруутай этгээдэд хариуцлага оногдуулж байгаа бус, төрийн эрх ашгийг[145] хохироож байна гэж үзэж болохоор байна.

[143] П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2004 он. 28 дахь тал.

[144] Дурдсан бүтээл, 180 дахь тал

[145] Төрийн эрх ашиг гэдэгт "хууль дээдлэх" зарчим, түүнд нийцсэн төрийн үйл ажиллагаа,

Захиргааны байгууллага

Хамтын шийдвэр гаргахаас бусад тохиолдолд төрийн албан тушаалтан нь бие даан шийдвэр гаргадаг. Хэдийгээр ЗХХШтХ-ийн 4 дүгээр зүйл 4.1.1-4.1.16-д захиргааны хэргийн шүүхэд хариуцагч байх байгууллагуудыг жагсаалтын /тоочих/ зарчмаар зааж өгсөн боловч 4.1-д түүнийг төлөөлж шийдвэр гаргаж байгаа албан тушаалтан гэж тухайлан заасан нь хариуцлага хүлээлгэх субъектийг туйлын тодорхой болгосон гэж үзэж болохоор байна. ИХ, ТАтХ-д гэм хорыг арилгах арга замыг тодорхой хэмжээгээр зааж өгсөн. Өөрөөрхэлбэл, төрийналбантушаалтныхуульбусүйлдэлүйлажиллагаанаас учирсан гэм хорыг эхлээд тухайн байгууллага буюу төр нөхөн төлж, дараа нь тухайн этгээдээс байгууллага нь нэхэмжлэх эрхтэйгээр зохицуулжээ. Харин ЗХХШтХ-ийн 70 дугаар зүйл, 70.4-т "Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажилллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ." гэж заасан нь гэм хорыг тодорхой хэмжээгээр нөхөн төлүүлэх, нэхэмжлэгчийн хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх ачааллыг багасгаж байгаа сайн талтай боловч хариуцлага хүлээлгэх этгээдийг тодорхой зааж өгөөгүй байгаа нь дутагдалтай юм. 2006-2009 оны 2 дугаар улирал хүртэлх хугацаанд Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн, судалгааны хүрээнд сонгож авсан хэргүүдээс харахад захиргааны хэрэг дэх иргэний нэхэмжлэлийг /ажилгүй байсан хугацааны цалин хөлс/ хангахдаа тухайн байгууллагын данснаас гаргуулж байгаа нь дурдсан хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэл буйг харуулж байна. "Хууль дээдлэх" нь төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим.

Тухайн жилийн Төсвийн тухай хуульд "хууль бус үйлдлийн улмаас бусдад учруулсан гэм хорын нөхөн төлбөрт" гэж мөнгө төсөвлөхгүй нь ойлгомжтой юм. Өмнө нь дурьдсанчлан ИХ-ийн зохицуулалтаар гэм буруутай этгээдээс байгууллагад учруулсан хохирлыг шаардах эрхтэй боловч чухам хэн гэдэг нь тодорхой бус байгаагаас биелэгддэггүй гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага нь удирлагын босоо тогтолцоо буюу удирдах, удирдуулах харилцаагаар үйл ажиллагаагаа явуулж байдаггай холбоотойгоор байгууллагын "удирдлагын" шийдвэр, үйл ажиллагаанаас байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал бараг байхгүй гэж хэлэхэд болно. Захиргааны эрх зүй дэх гэм хорыг арилгах асуудлыг шийдвэрлэхдээ дээрх 2 асуудлыг хамтад нь шийдвэрлэх нь гэм хорыг бүрэн арилгаж байна гэж үзэж болох юм. Нөгөө талаас нийтийн эрх зүйд захиргааны эрх зүй багтаж, захиргааны эрх зүйн субъект нь төрийн буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд байдаг. ҮХ-ийн 38 дугаар зүйлд зааснаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд нь төрийн хууль биелүүлэх үүрэгтэй тул хууль бус шийдвэр үйл ажиллагааны улмаас бусдад гэм хор учруулсан гэм буруутай этгээдээс хохирлыг заавал гаргуулдаг байхаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж судалгааны баг үзэж байна.

төсвийн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулах гэсэн ойлголтыг авч үзсэн болно.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

4.1.ДҮГНЭЛТ

Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас бусдад учирч байгаа гэм хорыг арилгах талаах зарим ахиц ажиглагдаж байна. Тухайлбал, ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгох, өмчлөх эрхийн гэрчилгээ олгохыг даалгах зэрэг. Гэвч гүйцэтгэл хангалтгүй, зарим нэг учир дутагдалтай хандлага байсаар байна. Хэдийгээр шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт "байгууллага өөрт учирсан хохирлоо гэм буруутай этгээдээс жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж" байгаа боловч тухайн байгууллага захиргааны болон иргэний журмаар өөрт учирсан хохирлоо гэм буруутай этгээдээс нэхэмжилсэн тохиолдол одоогоор алга байна. Шүүхээс гадуур, өөр байдлаар байгууллагыг хохиролгүй болгодог байж болох юм. Мөн гэм хор учруулж байгаа албан тушаалтан нь ихэнх тохиолдолд тухайн байгууллагын удирдлага байдаг учир төрийн эрх ашиг хөндөгдөхөд хүрдэг ба үүнийг авч үздэггүй байна. Энэ нь захиргаа буюу төрийн байгууллага, албан тушаалтныг хариуцлагажуулахгүй байгаа нэг шалтгаан болох юм. Түүнчлэн захиргааны хэргийг шийдвэрлэхдээ хохирлыг тогтоож, нотлох нь бас чухал асуудал. Энэ талаар ЗХХШтХ-ийн 70 дугаар зүйлийн 70.4-т "Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ." гэж заасан байна. Захиргаа нь нэг талын хүсэл зоригийг илэрхийлсэн захирамжилсан шийдвэр гаргадаг учраас хэрэв уул шийдвэр нь хууль бус гэдгийг шүүх тогтоосон тохиолдолд түүнээс учирсан хохирлын талаарх маргааныг нэгэн зэрэг шийдвэрлэх нь зөрчигдсөн эрхийг цаг хугацаа алдалгүй сэргээх, шүүх байгууллагын ачааллыг багасгах зэрэг сайн талтай гэж үздэг.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг буюу ЭБША-ны явцад шүүх эрх мэдлийн хүрээн дэх албан тушаалтнуудын иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлж иргэнийг хохиролгүй болгож байгаа давуу талтай боловч төрөөс хохирлыг нөхөн төлөхөөр зохицуулсан нь иргэнд учруулсан хохирлыг чухам хэн хариуцан төлөх нь тодорхойгүй, иргэнд өөрийн шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирол учруулж буй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх буюу тэдний хариуцлагыг өндөржүүлэх боломжгүй болгож байна. Өмнөх дэглэмийн үед байсан практикийг судалж үзвэл 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн /одоо хүчингүй болсон/ "БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай" хуулийн 4 дүгээр зүйлд "...Харин шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын гэм буруутай албан тушаалтанд БНМАУ-ын хууль тогтоомжид зааснаар эрүүгийн, сахилгын, эд материалын болон бусад хариуцлага хүлээлгэнэ. Хэрэв уг ажиллагаа нь гэмт хэрэг болох нь зохих журмаар тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар бүрэн төлүүлнэ. Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн



ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг холбогдох санхүүгийн болон бусад байгууллага БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмаар шүүхэд гаргана...” гэж заасан нь төр үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнуудад хариуцлага тооцох заалт байжээ. Гэтэл энэ зохицуулалтыг 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд тусгаагүй орхигдуулсан нь учир дутагдалтай болжээ.

“Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай 2006 оны оны 10 дугаар сарын 30-ны өдрийн УДШ-ийн 45 дугаар тогтоолд “хуулийн 397 дугаар зүйлийн 397.1-д заасан “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдөл” гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт зохицуулагдсан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” хэмээн тайлбарласан байна. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааныг 133 дугаар зүйлд заасан боловч үүнд энэ төрлийн маргааны талаар зохицуулаагүй байна.

БНХАУ-ын Иргэний хуульд гэм хорын асуудлыг хуульчлаагүй бөгөөд 1995 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “БНХАУ-ын төрөөс төлөх хууль” нэртэй бие даасан хууль батлан гаргажээ. Энэхүү хуулиар төрийн захиргааны болон тусгай байгууллагуудаас иргэнд учруулсан эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн хариуцлагыг төр шууд хариуцан арилгахаар хуульчилжээ. Тус хуулийн зохицуулалт, тэр дундаа хохирлыг арилгах, нөхөн төлөх журмын асуудлыг нилээд боловсронгуй хуульчилсан байна. Мөн хохирол барагдуулах асуудлыг шүүхээс өмнөх шатанд тухайн гэм буруутай байгууллага бүрэн хариуцах ба шүүхээс хохирлыг барагдуулах тусгай комисс байгуулагддаг бөгөөд түүний шийдвэр эцсийн байхаар хуульчилжээ. Харин ОХУ-ын хувьд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокуророос иргэд хуулийн этгээдэд учруулсан хохирлыг ОХУ-ын сангаас нөхөн барагдуулах ба хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн албан тушаалтнуудын буруутай эсэхээс үл хамааран ОХУ-ын дагавар улсуудын сан болон орон нутгийн боловсролын сангаас бүрэн хэмжээгээр нөхөн барагдуулна. Материаллаг бус гэм хорыг жишиг болгон тус сангаас гаргуулна. Санд бүрдэх хөрөнгийг сангийн яам хариуцан бүрдүүлдэг. Гэм хор учруулсан этгээдийн гэм буруутай нь тогтоогдвол тухайн этгээд өөрөө төлөх бөгөөд дээр нь шүүхээс хянан шийдвэрлэх явцад гарсан зардлыг давхар төлөхөөр хуульчилжээ.

Дээрх хуулиудыг харьцуулж судалсанаас дүгнэхэд төрийн захиргааны байгууллагын албан тушаалтан болон шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгож, буруутай этгээдэд хариуцлага тооцох, төрд учирсан хохирлыг нөхөн

төлүүлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иргэний эрх зүй дэх төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгах асуудлын тухайд Төрийн албан хаагчийн хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг иргэн, хуулийн этгээд арилгуулах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т иргэн, "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх" эрхтэй хэмээн тусгалаа олсон байна. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498-ийн 2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана" гэсэн нь төрийн албан хаагчийн ажил үүргээ хэвийн явуулах, өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэнээс ч хараат бусаар бие даан үйл ажиллагаагаа явуулах нэгэн баталгаа болж байгаа төдийгүй, энэ нь ажил үүргээ гүйцэтгэх мэргэжлийн мэдлэг илэрхий дутмаг болон тухайн хуулийн заалтын дор эрх мэдлээ хэтрүүлэх гэх мэт буруутай үйл ажиллагаа хийхгүй байх зохицуулалтыг Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагч өөрийн **шууд санаатай** буюу **илтэд болгоомжгүй** үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй гэж заасан байна.

4.2 САНАЛ

Хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн албаны тухай хууль

13 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг

13.1.11. хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад хохирол учруулсан болох нь тогтоогдвол нөхөн төлөх; /заалт нэмэх/

13.1.12. хууль тогтоомжид заасан бусад үүрэг. /дугаарыг өөрчлөх/

Үндэслэл

1. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа салбар бүрийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байгаа боловч хариуцлага хүлээлгэх үндэслэлийн хэм хэмжээг нийт төрийн албан хаагчдад хамаатуулан энэ хуульд тусгах нь илүү үр дүнтэй байна. ТАТХ-ийн 4 дүгээр зүйл. 4.2.7.-д *"хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах."* гэж зарчим болгож зааж өгсөн хэдий ч энэ нь төрийн албан хаагчийн хууль бус үйлдэлтэй холбоогүй юм. Өөрөөр хэлбэл хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ийн сэдэл нь санаатай байдаг бол хууль тогтоомжийн хүрээнд гаргасан алдаа нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй байж болно.

2. Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан гэм хорын асуудлыг шийдвэрлэсэн



боловч үр дүн хангалтгүй зөрчилтэй асуудал байсаар байна. Тухайн албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас учирсан гэм хорыг байгууллагын хөрөнгөөс төлүүлдэг боловч түүнийгээ гэм буруутай этгээдээс нэхэмжлэхгүй өнгөрөх нь нэлээд байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтын тодорхойгүйгээс ихээхэн шалтгаалдаг гэсэн дүгнэлт гарч байна. Иргэний хуулийн гэм хорын зохицуулалт нь хэрэглэх боломжгүй зэрэг нь энэ доголдлын нэг шалтгаан мөн гэж судалгааны баг үзсэн болно. Өөрөөр хэлбэл, хууль зүйн хариуцлагын механизм, хэрэглүүр нь тухайн гэм буруутай этгээдэд шууд нөлөөлөхгүй байна гэж хэлж болно.

Хууль санаачлах эрхийн хүрээнд

ОХУ-ын хууль зүйн практикаас үзвэл гэм хорыг цаг тухайд нь арилгахад Хохирол барагдуулах сан байгуулах нь тустай юм. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1.Төрийн албаны зарчим болох "захирах, захирагдах ёс" нь төрийн байгууллагын санхүү эрхэлсэн ажилтан, удирдлагаасаа хохирол нэхэмжлэх ИХ-д заасан боломжийг хязгаарлаж байгаа юм. Иймээс учраас тухайн байгууллага бус хөндлөнгийн гуравдагч этгээд буюу сан нэхэмжлэх нь илүү үр дүнтэй.

2.Энэ сан ажилласнаар төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учрах гэм хорыг арилгахад бодит үр дүн гарна. Өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагаа хариуцлагажина.

3.Төрөөс хохирол барагдуулах харилцаанд оролцох төрийг төлөөлсөн субъект тодорхой болно.

Нөгөө талаас хэт нэг талыг барих нь өрөөсгөл болно. Гэм хорыг арилгах, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхдээ гэм буруутай нь шүүхээр эцэслэн тогтоогдсон тохиолдолд нөхөн төлүүлдэг байх зэрэг зохицуулалтыг хамтад нь авч үзэх хэрэгтэй.

Мөн гэм буруу нь шүүхээр тогтоогдсон боловч өршөөл, уучлалд хамрагдсан эсэхээс үл хамааран эдийн хохирлыг нөхөн төлдөг байхаар тусгах нь зохимжтой. Сангийн санхүүгийн эх үүсвэрийн тухайд 2007 оны 9 дүгээр сарын 12-нд БЗД-ийн шүүхээр иргэн С.Чулуунбаатарын нэхэмжлэлтэй шийдвэрлэгдсэн хэргээс жишээлэн Засгийн газрын нөөц хөрөнгөөс бүрдүүлж болох юм. Учир нь төрийг төлөөлөн харилцаанд орж буй субъект нь ихэвчлэн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага байдаг.

Бусад саналын хүрээнд

Шийдвэр гаргадаг албан тушаалтнуудад хяналт тавих санхүүгийн хяналт шалгалтын асуудлыг тодорхой болгох хэрэгтэй нь харагдаж байна. Энэ нь дараах хувилбартай байж болох юм. Үүнд:

Жилийн эцэст санхүүгийн шалгалт хийж зориулалтын бусаар буюу хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас нөхөн төлбөрт олгосон мөнгийг гэм буруутай этгээдээр нь буцаан төлүүлэх акт тавьдаг байх. Энэ талаар "Төрийн аудитын тухай хууль"-д тодорхой тусгаж өгөх

Дээд шатны захиргаа, хэрэв байхгүй бол Прокурорын байгууллагын төлөөлөгч учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргадаг байх

Монгол Улсын хуулиар гэм хорыг арилгах тодорхой аргуудыг хуульчилсан боловч дэлхийн бусад улс орны ашиглаж хэвшсэн үр дүнтэй зарим аргыг шинээр хуулийн зохицуулалтад оруулж болох юм. Жишээ нь: олон нийтийн мэдээллийн хэрэгслээр уучлалт гуйхыг даалгах, тухайн төрлийн зөрчил дахин гаргахгүй байх талаар баталгаа гаргах гэх мэт.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.gov.mn

III БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, КРИМИНОЛОГИЙН СЕКТОР

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ БА ЯЛЫН ТОХИРОО

НЭГ. УДИРТГАЛ

1.1.Судалгааны үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж буй эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль. Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх. хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, ардчиллыг гүнзгийрүүлэх зорилгоор 2001 онд Эрүүгийн хуулийг баталсан бөгөөд уг хуулийг мөрдөж эхэлсэнээс хойш даруй 3 жил гаруй хугацаа өнгөрч байна.

Энэхүү хуулийг хэрэглэх явцад зарим хэм хэмжээг эргэж харах, өөрчлөх боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд эдгээрийг хэрхэн шийдвэрлэх нь эрүүгийн эрх зүйн өнөөгийн тулгамдсан асуудал болжээ. Энэхүү асуудалд ял шийтгэлийн тохирооны асуудал нэлээд байр суурийг эзэлж байгаа юм.

Өнөөдөр "шүүх гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хэр хэмжээнд тохироогүй ял оногдуулж байна, хүнд гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтнууд болон хөрөнгө мөнгөтэй хүмүүс болон нийгмийн доод түвшний хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал. тэдэнд шүүхээс оногдуулж буй ялын харьцаа харьцангуй байна, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаж байна..." гэх мэт мэдээ. мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж, энэ асуудал нийгмийн сэтгэл зүйг эзэмджээ

Энэ байдал нь шүүхээс ял оногдуулж буй бодлоготой холбоотой юу, аль эсвэл хуулийн зохицуулалттай холбоотой юу гэдгийг судлан дүгнэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэхүү шаардлага нь судалгаа хийх үндэслэл болсон юм.

"Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал ба ялын тохироо"–ны байдлыг 2005 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд судаллаа.

Судалгааны календарчилсан төлөвлөгөөний дагуу судалгааг явуулсан болно.

1.2. Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь Эрүүгийн хуульд дахь гэмт хэргийн ангилал ба ялын уялдаа холбоо, тохирооны байдалд дүгнэлт хийх, түүнийг сайжруулах арга замыг боловсруулан санал, зөвлөмж боловсруулах явдал байв.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажиллалаа. Үүнд:

- Эрүүгийн хуульд сонгох санкцгүй зүйл анги байгаа эсэхийг судлах;
- Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл анги бүрт хичнээн төрлийн ял

оногдуулж болохоор зохицуулсан байдаг */тухайлбал, хичнээн зүйл ангид ААХЯ-ыг оногдуулахаар заасан гэх мэтээр ялын төрөл бүрээр гаргах/;*

- Гэмт хэргийн бүрэлдэхүүнд */хөнгөрүүлэх, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн/* оногдуулахаар заасан ялыг харьцуулах. Тухайлбал, Нэг зүйлийн ангийн 1, 2, 3 дахь хэсгийн ялын харьцааг судлах;
- Сонгож хэрэглэх ялуудын хоорондын харьцааг түүвэрлэн судлах;
- Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхээс оногдуулж буй ялыг өөрчилж байгаа үндэслэл, ял хүндэдсэн шалтгаанаар тогтоолыг хүчингүй болгож буй үндэслэлийг, мөн нэг төрлийн гэмт хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх бүрэлдэхүүнээр үйлдсэн тохиолдолд шүүхээс оногдуулж буй ялын харьцааг судлах;
- Ял оногдуулахад ялын тохирооны улмаас гарч буй бэрхшээлийг судлах;
- Санал, зөвлөмж боловсруулах.

1.3. Судалгаа явуулсан арга, хэлбэр

Судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага авах, санал асуух, сурвалжлах, түүхчлэх зэрэг аргаар судалгааг явуулав.

Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал ба ялын тохирооны талаар авах санал асуулгад зориулан 6 асуулт бүхий санал асуулгын хуудас боловсруулж, 57 шүүгч, 49 прокурор, 26 өмгөөлөгчөөс санал асуулгын аргаар судалгаа авч, саналыг нэгтгэн төрөлжүүлж авч үзлээ.

Санал асуулгын судалгааны үр дүнгийн магадлалыг тандах, зарим асуудлыг тодруулах, илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авах, шүүхээс оногдуулж буй ялын харьцаа өөрчлөгдсөний шалтгааныг тогтоох зорилгоор Сэлэнгэ, Дундговь, Булган аймгийн хуульчидтай зохион байгуулалттайгаар, Улаанбаатар хотод зарим хуульчидтай ганцаарчлан ярилцлага хийж, ялын тохирооны байдал, ял тохирохгүй байгаа шалтгаан, үндэслэлийн талаар судлав.

Нийслэлийн шүүхээс "ял хөнгөдсөн" үндэслэлээр анхан шатны шүүхээс оногдуулсан ялыг өөрчилсөн, "ял хүндэдсэн" үндэслэлээр анхан шатны шүүхийн тогтоолыг хэрэгсэхгүй болгосон үндэслэл, мөн гэмт хэргийн хүндрүүлэх болон хөнгөрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулж буй ялын харьцааг судлах зорилгоор 2003-2004 оны магадлалыг уншиж судаллаа.

ХОЁР. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

2.1. Эрүүгийн хууль дахь ялын байдал, түүний тохироо

Эх сурвалжийн буюу хууль тогтоомжийн судалгааны хүрээнд дараах зүйлийг судлан дүгнэлээ.

№	Ялын төрөл	Тухайн ялыг оногдуулахаар заасан зүйл, хэсгийн тоо
1	Торгох ял	181
2	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах	24 /үндсэн ял/ 26 /нэмэгдэл ял/
3	Эд хөрөнгө хураах	13/ үндсэн ял/, 3 /нэмэгдэл ял/
4	Албадан ажил хийлгэх ял	52
5	Баривчлах	171
6	Хорих	311
7	Цаазаар авах ял	6

Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал ялын тохирооны байдлыг авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нэлээд зөрчилтэй зүйл байсан болно. Үүнд:

1.Эрүүгийн хуулийн тусгай ангийн ихэнх зүйл хэсэгт хорих, баривчлах /хүнд төрлийн ял/, торгох ял /хөнгөн төрлийн ял/-ын аль нэгийг сонгож оногдуулахаар заасан.

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1		Зарим зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын сонголт харьцангуй байдлаар буюу хуульд заасан ялын хүнд төрөл болох хорих, ял, эсвэл ялын хамгийн хөнгөн төрөл болох торгох ялыг сонгон хэрэглэх боломжтой. Энэ тохиолдолд шүүх гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзахаасаа илүүтэйгээр, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадварыг харгалзан ял оногдуулж байна. Энэ нь нийгмийн сэтгэл зүйд хууль, шүүх баян, ядуу хүнд ялгамжтай хандаж байна гэсэн хардлагыг төрүүлдэг. Эрүүгийн хуульд хорих, торгох санкцтай 33 зүйл анги байдаг байна[1].
2		Хуульд баривчлах, торгох ялыг сонгон ял оногдуулах нэлээд зүйл анги байна. Баривчлах ял нь биеэр эдэлдэг ял тул торгох ялаас хүнд тусдаг. Гэтэл мөн л дээрхийн адил гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадвараас хамааралтай ял болдог. Эрүүгийн хуульд баривчлах, торгох санкцтай 77 зүйл анги байдаг байна[2].

2. Гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг ялгаж хуульчлаагүй

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	187 дугаар зүйл	187.2-т үндсэн бүрэлдэхүүнийг зааж, түүнд хүнд ял оногдуулахаар, 187.1-т хүндрүүлэх бүрэлдэхүүнийг зааж, хөнгөн ял оногдуулахаар заасан.

2	213 дугаар зүйл	213.2-т болгоомжгүй үйлдсэн буюу үндсэн бүрэлдэхүүнийг, 213.1-т санаатай үйлдсэн буюу хүндрүүлэх бүрэлдэхүүнийг заасан.
3	303 дугаар зүйл	Хөлсний цэрэг ашиглах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн буюу 303.3-т хөлсний цэрэг зэвсэгт мөргөлдөөн, дайны үйл ажиллагаанд оролцсон гэх дээрх гэмт хэрэгт хамааралгүй гэмт хэргийг зааж хуульчилсан.

3. Гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулах ялын хэмжээ ижил

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	107 дугаар зүйл	107.1, 107.2-ын ААХЯ-ын хэмжээ тэнцүү байдлаар хуульчлагдсан.
2	124 дүгээр зүйл	124.1, 124.2-ын торгох ялын дээд хэмжээ ижил хуульчлагдсан[4] нь хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хөнгөн ял оногдуулах боломжийг бий болгож байна.
3	129 дүгээр зүйл	129.1, 129.2-ын ААХЯ-ын хэмжээ тэнцүү байдлаар хуульчлагдсан.
4	230 дугаар зүйл	Энэ зүйл дэх үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний ялын хэмжээ ижил, эсвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт оногдуулах ял үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт оногдуулах ялаас хөнгөн тусах боломжтойгоор хуульчлагдсан. 230.2, 230.3-ын баривчлах ялын хугацаа ижил[6]. 230.1, 230.4-ийн ААХЯ-ын доод хэмжээ тэнцүү ба 230.4-ийн ААХЯ-ын доод хэмжээ 230.2, 230.3-ынхаас бага, 230.2-ын ААХЯ-ын хэмжээ 230.3-ынхаас илүү[7].
5	237 дугаар зүйл	237.1, 237.2-ын ААХЯ-ын хэмжээ тэнцүү байдлаар хуульчлагдсан.

4. Зарим зүйлд заасан ялыг тохируулж оногдуулах боломжгүй

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	132.1, 241.1, 243.1	Зөвхөн торгох санкцтай тул ялыг тохируулан оногдуулах боломжгүй.
2	278.1, 281.1, 284.1, 285.1, 287.1, 288.1, 289.1	Зөвхөн баривчлах санкцтай тул Эрүүгийн хуулийн 51.3-т заасан этгээд эдгээр гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд ял оногдуулах боломжгүй.
3	103.1, 107.1, 114.1, 117.1, 129.1,	Эдгээр зүйл ангид заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ААХЯ, баривчлах ялыг сонгож хэрэглэнэ. Гэтэл эдгээр гэмт хэргийг жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх болон ганц бие эцэг үйлдсэн бол тэдэнд ЭХ-ийн 50.4, 51.3-т заасны дагуу ял оногдуулах боломжгүй.

4		Хуулийн зарим зүйл анги заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох, баривчлах, ААХЯ-ын аль нэгийг сонгон хэрэглэх боломжийг хуулиар олгосон. Гэтэл энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн төлбөрийн чадваргүй этгээдүүд үйлддэг бөгөөд уг этгээд нь жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх болон ганц бие эцэг байвал зайлшгүй торгох ял оногдуулах болдог ба уг ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд тохирдоггүй[9].

5. Хуулийн заалтууд өөр хоорондоо нийцэхгүй

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	50.3; 58.3 дугаар зүйл	ААХЯ-ын хэмжээ 100-500 цагийг баривчлах ялаар солиход баривчлах ялын доод хэмжээнд хүрэхгүй байна. Тухайлбал, 100-500 цагийн ажил хийхийн оронд уг ялаас зайлсхийж, 4-20 хоног баривчлах ял эдлэх нь ялтанд ашигтайгаар тусаж болох юм. Энэ нь ААХЯ-ын үр нөлөөг бууруулах, уг ялыг хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсгэж байна.
2	57 дугаар зүйл 58 дугаар зүйл	57 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахад ялыг хамгийн хүнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээний дотор тогтооно. 58 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахдаа тухайн төрлийн ялын энэ хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тогтооно. Жишээлбэл, 91.2-т заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 57-оор ял оногдуулахад 25 жилийн ял оногдуулах боломжтой. Харин 58-аар ял оногдуулахад 15 жил /хорих ялын үндсэн хугацаа/ -ийн ял оногдуулах боломжтой. Гэтэл хувийн байдал нь хөнгөн этгээдэд оногдуулах ял хүнд, хувийн байдал хүнд этгээдэд оногдуулах ял хөнгөн тусч байгаа.

6. Бусад хуулийн хэм хэмжээтэй нийцэхгүй

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	47.3 дугаар зүйл	47.3 дугаар зүйлд "торгох ялыг баривчлах, ... хорих ялаар сольж болно" гэж заасан атал ШШГТХ-ийн 93 дугаар зүйлд "торгох ялыг хорих ялаар сольж болно" гэж заасан нь алдаатай болжээ. Өөрөөр хэлбэл, ШШГТХ-д баривчлах ялаар солих тухай заалт байхгүй байна. Мөн торгох ялыг баривчлах ялаар солино гэсэн боловч баривчлах ялын хугацааг зааж өгөөгүй.

2	50 дугаар зүйлийн 50.4	Энэ хэсэгт ААХЯ оногдуулж болохгүй этгээдүүдийг заасан ба үүнд насанд хүрээгүй этгээдийг заагаагүй байна. ААХЯ-ыг 16 насанд хүрээгүй этгээдэд оногдуулах нь хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон Хөдөлмөрийн хуулийн 109.1 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалттай зөрчилдөж байна.
3		ЭБШХ-ийн 332.1.2 дугаар зүйлд ААХЯ, баривчлах, хорих ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тухай заасан боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангид энэ талаарх зохицуулалтыг хийж өгөөгүй байна.

7.Хэрэглэхэд бэрхшээлтэй

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	47.3 дугаар зүйл	Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх баривчлах ялаар сольж болно гэж заасан боловч баривчлах ялын хугацааг заагаагүй.
2	50.1 дүгээр зүйл	ААХЯ-ыг ямар хугацааны дотор эдэлж дуусгах тухай заалт байхгүй, хугацааг нээлттэй орхисон нь энэ ялыг завших, үр нөлөөг нь бууруулахад хүргэж болзошгүй байна.
3	60 дугаар зүйлийн 60.2 60 дугаар зүйлийн 60.3	Бэлтгэсэн, завдсан үйлдэлд оногдуулах ялын хэмжээг тогтоохдоо тухайн ялын дээд, доод хэмжээний алинаас тооцох нь тодорхой биш тул бэлтгэсэн, завдсан үйлдэлд зарим тохиолдолд төгссөн гэмт хэрэгт оногдуулах ялаас хүнд ял оногдуулах явдал практикт гардаг.
4	69 дүгээр зүйлийн 69.2	Энэ зүйлд заасан "насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага" байхгүй тул уг байгууллагад явуулах арга хэмжээ авах боломжгүй байдаг. Насанд хүрээгүй этгээдийг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах хугацааны дээд, доод хэмжээг хуулиар тогтоож өгөөгүй нь учир дутагдалтай.
5	69 дүгээр зүйлийн 69.3	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй этгээд засарч хүмүүжихгүй байвал уг арга хэмжээг хүндрүүлж "насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах" арга хэмжээ авч болох ба энэ хүндрүүлсэн арга хэмжээг 16-18 насны этгээдэд авч болохгүй, харин түүнээс доош насны этгээдэд авч болохоор заасан нь тохиромжгүй.

8. Техникийн алдаатай

№	Хуулийн зүйл хэсэг	Тайлбар
1	143 дугаар зүйлийн 143.1 257 дугаар зүйлийн 257.1	"...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин *хуртэл* нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох..." гэх үг шаардлагагүй.
2	222 дугаар зүйлийн 222.1 242 дугаар зүйлийн 242.1	Монгол хэлний зүйд нэг утга бүхий үгийг "буюу" холбоосоор холбодог. Гэтэл уг зүйлүүдэд "... торгох буюу ... баривчлах", "... албадан ажил хийлгэх буюу .... баривчлах ..." гэж заасан нь алдаатай болжээ.
3	246 дугаар зүйлийн 246.2	"... бол нэгээс 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэсэн ба Эрүүгийн хуулийн 52.2-т хорих ялын үндсэн хугацаа "1-15 жил хүртэл байна" хэмээн заасан тул уг зүйл дэх хорих ялын доод хэмжээг "1-ээс" хэмээн тогтоох шаардлагагүй юм.

2.2. Шүүхээс ял оногдуулсан байдал

Шүүхээс оногдуулсан ялын харьцааг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл:

2002 он. Тус онд Монгол Улсын шүүх 13007 хүнд ял шийтгэл оногдуулсанаас 9577 буюу 73.6%-д нь хорих ял, 3412 буюу 26.2%-д нь хорихоос өөр төрлийн ял оногдуулжээ[146].

Хорих ял оногдуулсан байдлыг авч үзвэл:	*Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан байдлыг авч үзвэл:*
▪47.5%-д нь хорих ялыг биечлэн эдлүүлсэн; ▪41.9%-д нь оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан; ▪8.2%-д нь хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан; ▪2.4%-д нь өршөөл үзүүлжээ.	▪86.3%-д торгох ял; ▪10.9%-д баривчлах ял; ▪1.6%-д нь засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял; ▪1.2%-д нь албдан ажил хийлгэх ял оногдуулжээ.

[146] Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны статистик мэдээ. Монгол Улсын дээд шүүх. Жилийн тайлан. 2002 он

2003 он. Энэ онд шүүхээс нийт 9029 хүнд ял шийтгэл оногдуулсаны 6561 буюу 72.6%-д нь хорих ял, 2468 буюу 27.3%-д нь хорихоос өөр төрлийн ял оногдуулжээ[147].

Хорих ял оногдуулсан байдлыг авч үзвэл:	*Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан байдлыг авч үзвэл:*
▪43.8%-д нь хорих ялыг биечлэн эдлүүлсэн; ▪42.6%-д нь оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан; ▪13.4%-д нь хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан; ▪0.2%-д нь өршөөл үзүүлжээ.	▪ 61%-д баривчлах ял; ▪ 27.6%-д торгох ял; ▪ 11.1%-д албадан ажил хийлгэх ял; ▪ 0.3%-д бусад ял оногдуулжээ.

2004 он. Энэ онд шүүхээс нийт 9473 хүнд ял шийтгэл оногдуулсаны 6686 буюу 70.5%-д нь хорих ял, 2787 буюу 29.4%-д нь хорихоос өөр төрлийн ял оногдуулжээ[148].

Хорих ял оногдуулсан байдлыг авч үзвэл:	*Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан байдлыг авч үзвэл:*
▪43.8%-д нь хорих ялыг биечлэн эдлүүлсэн; ▪43.2%-д нь оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан; ▪12.8%-д нь хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан; ▪0.2%-д нь өршөөл үзүүлжээ.	▪ 57.1%-д баривчлах ял; ▪ 21.1%-д торгох ял; ▪ 14.2%-д албадан ажил хийлгэх ял; ▪ 4.6%-д бусад ял оногдуулжээ.

Сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхээс оногдуулж буй ялыг харьцуулж үзвэл хорих ялын хувь буурч, хорихоос өөр төрлийн ялын хувь өсөх хандлагатай болжээ. Үүнийг зураглан үзүүлбэл:



[147] Монгол Улсын дээд шүүхийн 2003 оны статистик мэдээ. Монгол Улсын дээд шүүх. Жилийн тайлан. 2003 он

[148] Монгол Улсын дээд шүүхийн 2004 оны статистик мэдээ. Монгол Улсын дээд шүүх. Жилийн тайлан. 2004 он

2003 онд *хорих ялын* биечлэн эдлүүлэлтийн хувь 2002 оныхоос 4.8%-аар буурсан байх ба энэ нь Эрүүгийн хуулиар ялын шинэ төрөл нэмэгдэж баривчлах ялыг хэрэгжүүлэх болсонтой холбоотой гэж үзэж байна. Үүнийг зураглан үзүүлбэл:



Хорихоос өөр төрлийн ялын харьцаанд нэлээд өөрчлөлт оржээ. 2003-2004 онд торгох ял урьд оныхоос дунджаар 3.5 дахин буурч, баривчлах ял дунджаар 5.4 дахин өсчээ. Үүнийг зураглан үзүүлбэл:



2003-2004 онд нийт ял шийтгүүлэгсдийн дунджаар 48% нь хорих ялыг биечлэн эдлэх болон баривчлах ялаар шийтгэгдсэн байна.

2003-2004 оны хорих ялын биечлэн эдлүүлэлт, баривчлах ялын хувийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл[149]:

№	Гэмт хэргийн төрөл	2003 он	2004 он
1	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг	*100%*	*88.7%*
2	Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг	*50.4%*	*47.9%*
3	Танхайрах гэмт хэрэг	*37.9%*	*33.7%*
4	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	*33.4%*	*31.0%*

[149]УДШ-ийн эрүүгийн шүүн таслах ажлын статистик мэдээ. Монгол Улсын дээд шүүх. Жилийн тайлан. 2003; 2004 он

Давж заалдах шатны шүүхийн анхан шатны шүүхээс оногдуулсан ялыг хөнгөрүүлэх болон ял хүндрүүлэхээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгож буй үндэслэлийг нийслэлийн шүүхийн 2004 оны магадлалыг уншиж судалсан болно.

Нийслэлийн шүүх давж заалдах шатны журмаар 705 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэснээс 44 буюу 6.2 хувийг нь ял хөнгөдсөн, эсвэл хүндэдсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг өөрчилж, хүчингүй болгон шийдвэрлэжээ. Үүний 8 буюу 1.13%-ийг нь ял хөнгөдсөн гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон бол үлдсэн 98.8%-ийг ял хүндэдсэн гэсэн үндэслэлээр ялыг хөнгөрүүлэн өөрчилсөн байна. Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг үндэслэн анхан шатны шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнсэх, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах болон ялын төрөл, хэмжээг хөнгөрүүлжээ.

Харин "анхан шатны шүүх ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд бодитой дүгнэлт хийгээгүй, ял нь шүүгдэгчийн гэм буруу, хувийн байдал, хэргийн нөхцөл байдалд тохироогүй гэсэн" дүгнэлт хийж, ялыг хүндрүүлүүлэхээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

2.3. Ялын тохирооны талаарх хуульчдын санал

Шүүхээс оногдуулж буй ялын харьцаа өөрчлөгдсөн /хорих ялын биечлэн эдлүүлэлтийн болон торгох ялын хувь буурсан, баривчлах ялын хувь өссөн/-ий шалтгааныг тогтоох зорилгоор санал асуулгын болон ярилцлагын аргаар шүүгч, прокурор, өмгөөлөгч нараас судалгаа авав.

Санал асуулгад оролцогчдын 2.4% нь Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулахаар заасан ял тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд нийцдэг, 85.3% нь зарим нь нийцдэг, 12.1% нь ерөнхийдөө нийцдэггүй гэсэн байр суурьтай байдаг ажээ.

Оролцогчдын 63.4% нь ял зарим нь хэт хөнгөдөөд, зарим нь хэт хүндэддэг гэж, 36.5% нь ял хэт хүндэддэг гэж хариулсан байна.

*Хуульд заасан <u>ял хэт хөнгөддөг</u> гэж үзвэл ямар хүмүүст илүү хөнгөн тусдаг*ийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 31.7% нь хөрөнгө мөнгөтэй хүнд;
- 29.2% нь албан тушаалтанд;
- 21.9% нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүнд;
- 19.5% нь насанд хүрээгүй хүнд;
- 14.6% нь гэмт хэрэг үйлдэхээр завдсан хүнд;
- 12.1% нь давтан гэмт хэрэг үйлдсэн хүнд ял хөнгөн тусдаг гэж үзжээ.

Ял <u>гэмт хэргийн ямар төрөлд илүү хөнгөн тусдагийг</u> судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 19.5% нь албан тушаалын гэмт хэрэгт;

- 12.1% нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт;
- 12.1% нь хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт;
- 9.7% нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ял хөнгөн тусдаг гэж үзжээ.

*Хуульд заасан ял хэт хүндэддэг гэж үзвэл ямар хүмүүст илүү хүнд тусдаг*ийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 51.2% нь давтан гэмт хэрэг үйлдсэн хүнд;
- 46.3% нь ядуу хүнд;
- 41.4% нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүнд;
- 41.4% нь насанд хүрээгүй хүнд;
- 34.1% нь ажилгүй хүнд;
- 26.8% нь гэмт хэрэг үйлдэхээр завдсан хүнд;
- 24.3% нь дундаж амьдралтай хүнд;
- 21.9% нь гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнд ял хүнд тусдаг гэж үздэг ажээ.

Ял гэмт хэргийн ямар төрөлд илүү хүнд тусдагийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 73.1% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт;
- 51.2% нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт;
- 46.3% нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт;
- 29.2% нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт;
- 9.7% нь хүний эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт ял хүнд тусдаг гэж үзжээ.

Дээрх дүнгээс хөрөнгө мөнгөтэй хүн, албан тушаалтан, мөн албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял хэт хөнгөн тусдаг гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үзсэн бол давтан гэмт хэрэг үйлдсэн хүн, хөрөнгө мөнгөгүй ядуу хүн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн, насанд хүрээгүй хүн, гэмт хэрэг үйлдэхээр завдсан, мөн хамтран үйлдсэн хүнд, түүнчлэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ял хүнд тусдаг гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь үзсэнийг анхааран дүгнэх нь зүйтэй байлаа.

Ял оногдуулахад бэрхшээл учирдаг эсэх, учирдаг бол ямар бэрхшээл учирдаг талаар санал асуулгын, ярилцлагын, ажиглалтын болон хэрэг уншин судлах аргаар судалсан болно. Уг судалгаагаар ял оногдуулахад дараах бэрхшээл учирдаг болох нь харагдсан юм. Үүнд:

№	Хуулийн зүйл хэсэг	Хуульчдын тайлбар
1		Өнөөдрийн Эрүүгийн хуульд шүүхээс ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээг харгалзан ялын төрөл, хэмжээг тогтоох боломж маш муу, шүүгч шүүн таслах ажиллагааны ур чадвар гаргах шаардлагагүй болсон. Төрөөс шүүгчид ял шийтгэлийг ялгамжтай оногдуулах эрх зүйн боломжийг бий болгож өгөх шаардлагатай.
2	47.2 дугаар зүйл	Судалгаанд хамрагдсан хуульчдын зүгээс торгох ялын хэмжээ хэт өндөр, дундажаас дээш амьжиргааны түвшинд нийцэхүйц ял учир уг ялыг оногдуулахад маш хүндрэлтэй байдаг гэсэн олонтаа гаргаж байлаа. Практикт торгох ялаар шийтгүүлсэн хүмүүс уг ялаас зайлсхийж, баривчлах, бага хэмжээний хорих ялаар шийтгүүлэх сонирхолтой байдаг нь ял завших нөхцөл болж байна. Мөн Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд заасан хугацааг өнгөртөл бага хэмжээний төлөлт хийж, уг хугацааг өнгөрмөгц ялаас чөлөөлүүлэх арга замыг хэрэглэж байна.
3	61 дүгээр зүйлийн 61.1	"Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн" гэдгийг урьд нь хүндэвтэрээс бусад ангиллын гэмт хэрэгт ял шийтгүүлсэнийг тооцохгүй байхаар ойлгох боломжтой. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд урьд нь хүнд гэмт хэрэг үйлдэж торгох ялаар шийтгүүлсний дараа хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн гэх мэт тохиолдолд уг ялыг тэнсэж болохоор ойлгогддог.
4	63 дугаар зүйлийн 63.1	"Анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн" гэдгийг анх удаа гэмт хэрэг үйлдсэн нь хүндэвтэр, хүнд гэмт хэрэг байх уу, эсвэл урьд нь хөнгөн гэмт хэрэг үйлдсэн боловч одоо ял шийтгүүлж буй хэрэг нь хүндэвтэр, хүнд ангиллын гэмт хэрэг байх уу гэдэг нь эргэлзээтэй ойлгогддог.
5	63 дугаар зүйлийн 63.1	Энэ зүйлд хохирлоо төлөөгүй байсан ч ялыг хойшлуулж болохоор зохицуулсан. Гэтэл тэнсэн хянан харгалзахад заавал хохирлоо төлсөн байхыг шаардаж байгаа. Эдгээр зүйлийн зохицуулалт агуулгын хувьд ойролцоо боловч өөр өөр шаардлага тавигддаг.
6	96 дугаар зүйл	Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас бусдад хүнд гэмтэл учруулсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлд зааснаар ял оногдуулж байгаа нь тухайн хэргийн нөхцөл байдалтай тохирохгүй байна.

7	175 дугаар зүйл гэх мэт[10]	Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг хүндрүүлж өмгөөлөх шаардлага практикт гардаг. Тухайлбал, 175.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ХХДХ-г 100-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3-аас дээш 6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял оногдуулах тул өмгөөлөгч нар уг этгээдийн үйлдлийг бүлэглэн, давтан үйлдсэн гэх мэтээр хүндрүүлэн өмгөөлж, хорих ял шийтгүүлж, уг ялыг тэнсэн хянан харгалзуулах сонирхолтой. Иймбайдал практикт маш их тохиолддог.
8	263-273 дугаар зүйл	Албан тушаалын болон банкны хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн хохирлын доод хэмжээг өндөр тогтоосноор албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял хөнгөрсөн. Албан тушаалтан хэдэн арван сая төгрөг ашигласан байсан ч 5 жилийн хугацаагаар хорихоос дээш хүнд ял байхгүй.
9	47 дугаар зүйл	Торгох ялыг хорих ялаар солиход уг хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах тухай заалт байхгүй. Иймзаалт байх хэрэгтэй.
10	147 дугаар зүйлийн 147.2	Бүлэглэн дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял маш хүнд тусдаг.
11	145 дугаар зүйлийн 145.4	Урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд бусдын бага хэмжээний зүйлийг хулгайлсан тохиолдолд хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй адил ял оногдуулдаг. Энэ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирдоггүй.
12	215 дугаар зүйлийн 215.3	Жолооч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөнөөс өөрийн гэр бүлийнх нь хүмүүсийн амь нас хохирсон тохиолдолд оногдуулах ял шийтгэл хүнд тусдаг.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцсон хуульчдын 97.4 % нь Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулахаар заасан ял тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд төдийлөн нийцдэггүй гэж үзсэнээс харахад шүүхээс гэм буруутай этгээдэд ял оногдуулахад нэлээд бэрхшээл тулгардаг гэж дүгнэхэд хүргэлээ.

Судалгаанд оролцсон хуульчид ял оногдуулах ажиллагаа хэт автоматжлагдсан учраас шүүгч эрүүгийн шүүн таслах ажиллагааны ур чадвар гаргах шаардлагагүй болсон, төрөөс шүүгчид ял шийтгэлийг ялгамжтай оногдуулах эрх зүйн боломжийг бий болгож өгөх шаардлагатай гэсэн байр суурьтай байсан бөгөөд энэ нь ял оногдуулахад учирч буй бэрхшээлийн дотор тодорхой хувийг эзэлж байсан юм.

Судалгааны явцад ял оногдуулахад хэд хэдэн төрлийн бэрхшээлтэй асуудал тулгардаг болох нь харагдсан бөгөөд үүнийг бүлэглэн авч үзвэл:

1.Хууль зүйн зохицуулалт;

2.Хуульчдын хуулийн заалтыг ойлгож хэрэглэх чадвар;

3.Ял эдлүүлэх ажиллагааны дутагдалтай байдал;

4.Ял оногдуулах талаарх ойлголт нэг мөр тогтоогүй байдал байв.

Шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцүүлж, шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ, хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан ял оногдуулах хуульд заасан зарчмыг баримтлах ёстой. Гэтэл хуулийн зарим зохицуулалтаас шалтгаалан уг зарчим бүрэн утгаараа хэрэгжихгүй байгаад дүгнэлт хийн арга хэмжээ авах нь зүйтэй юм. Иймээс дээрх бэрхшээлийг арилгаж, ял шийтгэлийн тохиромжтой байдлыг хангах зорилгоор дараах чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- *Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:* Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тодорхой саналыг боловсруулах.
- *Хуулийн заалт /ял оногдуулах, эдлүүлэхтэй холбоотой заалт/-ыг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс авах арга хэмжээ:*

№	Хуулийн зүйл	Тайлбар	Санал
1	69 дүгээр зүйлийн 69.2	Энэ зүйлд заасан "насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага" байхгүй тул уг байгууллагад явуулах арга хэмжээ авах боломжгүй байдаг.	"Насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага"-ыг байгуулах талаарх саналыг зохих байгууллагад уламжлах.

Сургалтын явцад анхаарах зүйлс:

№	Хуулийн зүйл	Тайлбар	Санал
	61 дүгээр зүйлийн 61.1	"Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн" гэдгийг урьд нь хүндэвтэрээс бусад ангиллын гэмт хэрэгт ял шийтгүүлсэнийг тооцохгүй байхаар ойлгох боломжтой. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд урьд нь хүнд гэмт хэрэг үйлдэж торгох ялаар шийтгүүлсний дараа хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн гэх мэт тохиолдолд уг ялыг тэнсэж болохоор ойлгогддог.	Энэ асуудлыг нэг мөр болгох зорилгоор ХЗҮТ, ШЭМШХ-ийн сургалтын хөтөлбөрт энэ сэдвийг оруулах нь зүйтэй.
	63 дугаар зүйлийн 63.1	"Анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн" гэдгийг анх удаа гэмт хэрэг үйлдсэн нь хүндэвтэр, хүнд гэмт хэрэг байх уу, эсвэл урьд нь хөнгөн гэмт хэрэг үйлдсэн боловч одоо ял шийтгүүлж буй хэрэг нь хүндэвтэр, хүнд ангиллын гэмт хэрэг байх уу гэдэг нь эргэлзээтэй ойлгогддог.	

ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Нэг. Нийтлэг зүйл

1993 онд батлагдан хүчин төгөлдөр болсон Шүүхийн тухай хуульд шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмаар явуулахыг хуульчлан тогтоосноос хойшхи хугацаанд мэтгэлцээний журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар шат дараатай сургалтуудыг шүүгч, прокурор, өмгөөлөгч нарын дунд зохион байгуулж ирлээ.

Байцаан шүүдэг хуучин тогтолцооноос мэтгэлцэх зарчмаар шүүн таслах ажиллагааг явуулах шинэ тогтолцоонд шилжиж байгаа энэ үйл явц практикт ямар байдалтай байгаа, тэдгээрийн ололттой ба дутагдалтай талууд юунд байгааг олж тогтоон цаашид энэ талаар авах арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох зорилгоор ШЭМШХ ба ХЗҮТ хамтран энэхүү судалгааг явуулсан болно.

Судалгааг 2004 оны 4 дүгээр сараас мөн оны 8 дугаар сарыг дуустал Нийслэлийн 7 дүүрэг, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Сүхбаатар аймгуудыг хамруулан явуулж нийт 48 шүүх хуралдааныг биечлэн ажиглаж, 350 хүнээс санал асуулга авч, мөн тэдгээрийн нилээдтэй нь ярилцлага хийх хэлбэрээр явууллаа. Ингэхдээ судалгааны үр дүнг бодитой болгох үүднээс хот, хөдөөгийн шүүх хуралдаан болон шүүн таслах ажиллагаанд оролцогчдын төлөөлөл тооны хувьд аль болох ойролцоо байлгах бодлогыг баримталсан болно. Тухайлбал, ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны 28 нь нийслэлийн, 20 нь аймгуудын байгаа ба санал асуулгын судалгаанд оролцогчдын талаас арай илүү хувь нь нийслэлийн, бусад нь аймгуудын хүмүүс байна. Мөн санал асуулгын судалгаанд 87 шүүгч, 82 прокурор, 83 өмгөөлөгч, 98 иргэдийн төлөөлөгч болон бусад хүмүүс оролцсон нь тооны хувьд ойролцоо байгаа юм.

Тус судалгаанд оролцогчдын 64 нь эрүүгийн, 23 нь иргэний шүүн таслах ажиллагааны төрлөөр асуулгад хариулсан бөгөөд судалгааны явцад ажиглалт хийсэн шүүх хуралдааны 40 нь эрүүгийн, 8 нь иргэний хэргийнх байсан.

Хоёр. Мэтгэлцээний хэрэгжилтийн байдал

Шүүн таслах ажиллагааны практик дахь мэтгэлцээний төлөвшил

Судалгаанд оролцогчдын 49% нь шүүх хуралдаанд мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан, 37.4% нь чадаагүй, 48.5% нь мэтгэлцээний хэрэгжилт бүрэн бус байна гэж үзжээ. Харин оролцогчдын асуулгад хариулсан байдлыг ангиллаар нь авч үзвэл мэтгэлцээн хэрэгжиж чадсан гэж хамгийн өндөр хувиар үзсэн оролцогчид



шүүгчид байсан бол мэтгэлцээн хэрэгжиж чадаагүй гэж судалгаанд хамрагдсан прокурорын 39%, өмгөөлөгчийн 42.1% нь, мэтгэлцээний хэрэгжилт бүрэн бус байна гэж прокурорын 50%, өмгөөлөгчийн 50.6% нь дүгнэсэн байна.

Энэ нь хуулийн дагуу мэтгэлцээнийг хэрэгжүүлэгч болох шүүгчид мэтгэлцээн хэрэгжиж чадсан гэж дүгнэж байхад мэтгэлцэгч талуудын энэ талаархи дүгнэлт тэдгээрээс өөр байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 85% нь мэтгэлцээн шүүн таслах ажиллагааны практикт хэвшил болж чадаагүй буюу учир дутагдалтай гэсэн байр суурьтай байсан юм.

Шүүх хуралдааны явцад хийсэн дүнгээс харахад ч гэсэн нийслэл болон хөдөө орон нутгийн шүүхүүдэд шүүхийн мэтгэлцээний төлөвшил жигд бус байсан болно.

Мэтгэлцээн хэрэгжихгүй байгаа буюу мэтгэлцээн бүрэн бус хэрэгжиж байгаа шалтгааны талаар судалгаанд оролцогчид харилцан адилгүй дүгнэлт хийсэн байх бөгөөд судалгаанд орол.огчдын 41.4% нь мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудыг мэтгэлцээнд оролцогчид нэг мөр ойлгож чадахгүй байгаа, 21.1% нь шүүх хуралдаан даргалагч талуудад мэтгэлцэх боломж олгодоггүй, 40.2% нь мэтгэлцээнд оролцогчдын мэтгэлцэх ур чадвар дутагдаж байгаа, 19.7% нь хуулийн зарим заалтыг шүүхийн практикт хэрэглэхэд бодитой бэрхшээл учирч байгаа гэж дүгнэжээ. Энэхүү асуулгад хариулсан оролцогчдын дийлэнх нь мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудыг мэтгэлцэгч талууд нэг мөр ойлгож чадахгүй байгаа бөгөөд тэдний мэтгэлцэх ур чадвар дутаж байна гэж, харин мэтгэлцээний талууд буюу прокурор, өмгөөлөгчийн дийлэнх хувь нь шүүх хуралдаан даргалагч талуудад мэтгэлцэх боломж олгодоггүй гэж үзжээ. Үүнээс үзэхэд мэтгэлцээний талаарх хуулийн заалтуудын хэрэгжилт жигд бус буюу дутагдалтай байгаа нь хуулийн заалтуудын хэм хэмжээний хийдлээс бус ихэнхдээ шүүгч нар болон талуудын мэдлэг, ур чадвар, хувийн санаачилгаас шалтгаалж байна.

Энэхүү судалгаагаар мэтгэлцээнийг хэрэгжүүлэгч болох шүүгч, эсхүл мэтгэлцээний талуудын хэнээс шалтгаалан мэтгэлцээн хэрэгжихгүй буюу бүрэн бус хэрэгжиж байгааг нарийвчлан судалснаа дээрх хэсгүүдэд тусгалаа. Шүүгчид мэтгэлцээний зарчим, журмыг хэрхэн ханган байгааг авч үзвэл:

Судалгааны нийт оролцогчдын 41.4% нь, түүний дотроос шүүгчдийн 57.4% нь шүүх хуралдааны явцад шүүгч мэтгэлцэгч талуудын аль нэг рүү хэлбийлгүйгээр төвийг сахисан байр сууриа ихэнх тохиолдолд баримталж чаддаг гэсэн бол судалгаанд оролцогчдын 21.6% нь шүүгч цөөн тохиолдолд төвийг сахисан байр суурь баримталдаг, эсхүл баримталж чаддаггүй гэжээ. Шүүхийн практикаас ажиглахад шүүгчид төвийг сахисан байр сууриа баримтлахгүй байх нь ховор, ихэнх тохиолдолд шүүгч шүүх хуралдааныг даргалах чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж байсан ба шүүхийн хэлэлцүүлгийн шатанд асуулт асуух нь нийтлэг биш, шаардлагатай зарим асуултыг асууж байсан юм.

Судалгаанд оролцогчдын 19.4% нь шүүгч төвийг сахисан байр сууринаас хандаж чадахгүй, мэтгэлцэгч аль нэг тал руу хэлбийж, тал өгч байгаа байдал

харуулдаг гэж, 31.1% нь шүүх хуралдааны явцад байцаалтын санаачилгыг өөртөө авч явуулдаг гэж, 22.5% нь талуудын мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй, илт тоомсоргүй ханддаг гэж, 33.7% нь мэтгэлцээний үр дүнг шийдвэртээ харгалзахгүй, зөвхөн хавтаст хэргийг уншиж танилцсан байдалдаа үндэслэн шийдвэр гаргадагаас мэтгэлцээний зарчим, журам зөрчигддөг гэж үзжээ.

Ажиглан судлах явцад шүүгч хавтаст хэргийг уншсан төсөөлөл болон мэтгэлцээний үр дүнг харьцуулан шийдвэр гаргах ёстой атлаа зарим тохиолдолд шүүх хуралдааны явцад мэтгэлцээнд анхаарлаа хандуулахгүй өөр бусад юм уншиж, зарим оролцогчийн ярьж буй зүйлийг таслан зогсоох, аль нэг талд ашигтай асуулт асуух зэрэг байдал арилаагүй байгаа нь харагдсан юм.

Шүүгчдийн хувьд шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг ухуулан ойлгуулах нь шүүхийн мэтгэлцээний хэрэгжилтийг хангаж буй нэг чухал үзүүлэлт юм гэдэг нь судалгааны явцад ажиглагдсан. Зарим шүүгчид оролцогчдын эрх үүргийг тайлбарлах биш зөвхөн танилцуулдаг бол зарим нь хохирогчид гомдолтой, гомдолгүй гэхийн учир холбогдол, үр дагаварыг болон шүүгдэгч эцсийн үгэндээ юу багтааж хэлэх талаар маш ойлгомжтой, тодорхой тайлбарлаж өгч байсан болно.

Сонгинохайрхан дүүргийн шүүх шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг гардаж авсан буюу танилцуулсаныг тэмдэглэх хуудас хэрэгт хийж, цаг тухай бүрт нь мэдэгдсэн тухай баримтыг хэвлэн хэрэглэж байгаа нь талууд дээд шатны шүүх хуралдаанд өөр өөрийн байр суурийг илэрхийлж, мэтгэлцэх боломжийг ханган өгч байгаа нь нийтлэг хэрэглүүштэй туршлага гэж үзэж байна.

Шүүхийн мэтгэлцээний зарчим, журмыг хангаж буйг үнэлэх үзүүлэлтийн нэг хэсэг нь шүүх хуралдааны танхимыг аль болох мэтгэлцэхэд боломжтой, зохистой хэлбэрээр зохион байгуулах явдал юм. Судалгаанд хамрагдсан шүүхүүдийн олонх нь энэ шаардлагыг хангадагүй байна. Мэтгэлцээний талууд тэгш байр сууринаас мэтгэлцэхийн тулд тэдний шүүх хуралдааны танхим дахь байрлал мөн адил хэмжээнд байх, мэтгэлцэх чиг үүргийнхээ дагуу ялгаран байрлах шаардлагатай атал оролцогчдыг замбараагүй хольж байрлуулсан нь мэтгэлцээн жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг хязгаарладаг байна. Шүүх хуралдааны явцад ажиглаж байхад яллах, өмгөөлөх талын ард хохирогч, гэрч нар байрласнаас яллагч, өмгөөлөгч эргэж харан асуулт асуух зэрэг зохимжгүй байдал үүсч байв. Ийнхүү замбараагүй байрласнаас хэн хаана сууж байгаа нь мэдэгдэхгүй, энгийн иргэдийн хувьд тэдний үйл ажиллагаа ил тод, ойлгомжтой байх эсэх нь эргэлзээтэй байна. Баганууд дүүргийн шүүх шүүх хуралдааны танхим дахь ширээ бүр дээр оролцогчийн шүүх хуралдаанд оролцох байрлалыг тодорхойлох хаяг тавьсан нь дэмжүүштэй байсан бөгөөд бусад шүүхүүдэд энэ туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Шүүх хуралдааны танхимын дээрх зохион байгуулалтаас гадна шүүхүүдийн ачаалал их байгаатай холбоотойгоор шүүх хуралдааны танхим

хүрэлцэхгүй /хурлын цаг давхардсанаас/ -гээс иргэний хэргийг ихэвчлэн шүүгчийн өрөө тасалгаанд явуулдаг ба энэ тохиолдолд мэтгэлцээн жинхэнэ утгаараа хэрэгжих нөхцөл боломж хязгаарлагдаж байгаа гэдэг нь ойлгомжтой юм.

Мэтгэлцээний талууд мэтгэлцээний зарчим, журмыг хэрхэн хангаж байгааг авч үзвэл:

Судалгаанд оролцогчдын 40% нь яллах, өмгөөлөх талуудын тал хувь нь л шүүх хуралдааны явцад байцаалт явуулах, нотлох баримтыг шинжлэх, шүүмжлэлийн үг хэлэх зэрэг ажиллагааг мэтгэлцэх ур чадварын түвшинд явуулж чаддаг гэж, 26% нь цөөн тохиолдолд чаддаг гэж үзжээ. Харин энэ асуулгын ихэнх хувийг талуудын тал хувь нь мэтгэлцээнийг мэтгэлцэх ур чадварын түвшинд явуулж чаддаг гэсэн үнэлгээ эзэлж байгаа бөгөөд шүүгчдийн 36 нь буюу 41.3%, прокурорын 33 буюу 40.2%, өмгөөлөгчдийн 36 буюу 43.3%, иргэдийн төлөөлөгчдийн 19 буюу 50% нь талуудын мэтгэлцэх ур чадварын түвшинг ийнхүү үнэлсэн юм. Харин бусад оролцогчдын ихэнхи буюу 26.6% нь талууд цөөн тохиолдолд л мэтгэлцээнийг мэтгэлцэх ур чадварын түвшинд явуулдаг гэж дүгнэжээ. Ингээд талуудын мэтгэлцээний зарчим, журмыг баримталж буй байдал, баримтлахгүй байгаа шалтгааны талаар тодруулан авч үзье.

1. Мэтгэлцээний зарчим журмыг яллагч баримталдаггүй тохиолдолд энэ нь ихэвчлэн ямар хэлбэрээр илэрдэг вэ? гэсэн асуултанд шүүгч, прокурор, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч бусад субьект доорх байдлаар хариулсан.

- Яллагчийн яллах дүгнэлт, ялын шүүмжлэл нь үндэслэл сайтай, үнэмшилтэй болж чаддаггүй гэдэг хувилбар дээр шүүгч нар 22, прокурорууд 11, өмгөөлөгч 21, иргэдийн төлөөлөгч нар 17, бусад субьект 22 санал тус тус ирүүлсэн. Энэ саналаас шүүгч болон мэтгэлцээний эсрэг тал болох өмгөөлөгч нар прокурорын шүүмжлэл, яллах дүгнэлтэд ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа нь харагдаж байна. Харин прокурорууд өөрсдөө энэ тал дээр тодийлөн анхаарал хандуулаагүй, ерөнхийдөө өөрсдийгөө өмгөөлөх хандлагатай хариулт өгсөн. Харин энэ байдлыг шүүх хуралдааны явцаас ажиглахад санал асуулгад дурдагдсаны адил үндэслэл муутай, товч байгаа байдал харагдсан. Тухайлбал, гэм буруутай, зүйл анги тохирсон, ял оногдуулах үндэслэлтэй байна гэх мэт жижүүрийн хэдэн үгээр шүүмжлэл явуулж байв.
- Яллагч байцаалтыг мэтгэлцээний арга хэлбэрээр явуулж чаддаггүй гэдэг хувилбарт шүүгч нар 36, прокурорууд 30, өмгөөлөгч 23, иргэдийн төлөөлөгч нар 9, бусад субьект 11 санал тус тус ирүүлсэн. Энэ асуултад прокурорууд ч өөрсөддөө шүүмжлэлтэй хандсан. Шүүх хуралдааны явцаас харахад та хохирлоо төлсөн үү, гэм буруугаа ойлгож байна уу, өөр үйлдсэн хэрэг байна уу гэх мэт нэг загвартай асуулт асуухаас биш хэргийн талаар эрх зүйн үндэслэлтэй, цэвэр яллагаа нотлоход чиглэгдсэн оновчтой асуултууд асуух тохиолдол тун цөөн ажиглагдаж байлаа.

- Яллагч эсэргүүцсэн санал гаргах боломжийг ашигладаггүй гэдэг хувилбарт шүүгч нар 19, прокурорууд 11, өмгөөлөгч 8, иргэдийн төлөөлөгч нар 4, бусад субьект 4 санал тус тус ирүүлсэн. Шүүх хуралдаанаас судалгаа хийж байхад өмгөөлөгч нар зүйл ангийг өөрчлөх, үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгох санал гаргаж байхад прокурор ямар нэг санал дүгнэлт хэлэхгүй сууж байх тохиолдол гарч байсан. Мөн асуултын шинж чанар хууль зөрчсөн шинжтэй байхад ч анхаарахгүй байх явдал элбэг тохиолдож байсан юм.
- Яллагч нотлох баримтыг шинжлэхдээ ур чадвар дутагддаг гэсэн хувилбарт шүүгч нар 19, прокурорууд 14, өмгөөлөгч 22, иргэдийн төлөөлөгч нар 10, бусад субьект 13 санал тус тус ирүүлсэн. Нотлох баримт шинжлэх ажиллагаа шүүх хуралдаан дээр мөрдөн байцаалтанд цугларсан баримтуудыг уншиж сонсгох байдлаар явагддаг. Прокурорууд гол төлөв шүүгдэгчийн ялтай эсэхийг шалгах хуудас, шинжээчийн дүгнэлт, хохирогч оролцоогүй тохиолдолд хохирогчийн мэдүүлэг, цөөн тохиолдолд гэрчийн мэдүүлгийг яллах талын нотлох баримт болгон судалснаар яллах талын нотлох бармтыг шинжлэн судлах ажиллагаа хязгаарлагддаг. Зарим тохиолдолд судлах нотлох баримт байхгүй гэх, эсхүл дээр дурдсан баримтын аль нэгийг судлах гэх мэт байдлаар нотлох баримтыг шинжлэхэд оролцож байсан нь прокуроруудын нотлох баримт шинжлэх ур чадвар тодийлөн сайн бус байгааг баталж байлаа.
- Яллагч шүүхэд болон мэтгэлцэгч талдаа хүндэтгэлтэй хандах ёс зүйн шаардлага хангадаггүй гэсэн хувилбарт шүүгч нар 9, прокурорууд 9, өмгөөлөгч 20, иргэдийн төлөөлөгч нар 4, бусад субьект 10 санал тус тус ирүүлсэн. Гэхдээ энэ байдал нь шүүх хуралдаанд сууж ажиглалт хийх явцад тодийлөн ажиглагдсангүй. Талууд шүүх хуралдааны дэгийг барих сахилга бат тогтсон, даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад танхимд өөрийн дураар ярих, дайрч давшлах, бие биенээ үл хүндэтгэх байдал гаргах асуудал тохиолдсонгүй.

2. Мэтгэлцээний зарчим журмыг өмгөөлөгч баримталдаггүй тохиолдолд энэ нь ихэвчлэн ямар хэлбэрээр илэрдэг вэ гэсэн асуултад судалгааны оролцогчид хэрхэн хариулсан байдлыг авч үзье.

- Өмгөөлөгчийн өмгөөллийн үг буюу шүүмжлэл нь үндэслэл сайтай, үнэмшилтэй болж чаддагүй гэсэн хувилбарт шүүгч нар 25, прокурорууд 21, өмгөөлөгч 16, иргэдийн төлөөлөгч нар 10, бусад субьект 22 санал тус тус ирүүлсэн. Шүүгч болон мэтгэлцээний нөгөө тал болсон прокурорууд нилээд шүүмжлэлтэй хандсан байгааг тэдний хариултаас харж болно. Энэ байдал нь шүүх хуралдааны ажиглалтын явцад доорхи байдлаар илэрч байлаа. Тухайлбал, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан үзнэ үү, ядуу юм, өвчтэй юм, хөгшин эцэг эхийг нь харж хандах хүнгүй юм, нялх хүүхэдтэй юм гэх мэт тодийлөн ач холбогдол багатай саналуудыг шүүмжлэлийн шатанд тавьж харин хууль зүйн хувьд ямар дүгнэлт өгч байгаа, зүйл анги таарч байгаа эсэх зэрэг дээр оновчтой тодорхой санал хэлэхгүй "хуульд заасан хөнгөн

ял оногдуулж өгнө үү" гэх байдлаар аргацаасан шинжтэй өмгөөлөл явуулж байсан өмгөөлөгч нар олон таарч байлаа. Цаг хугацаагаа барихгүй, шүүгч нар болон бусад оролцогч нарын цагийг барж хоцорч ирснээр шүүгч нартаа зэмлүүлэх ийм байдлаар нэгэнт үнэлэмж нь буурсан өмгөөлөгчийн үгийг шүүгч нар үл тоох байдал ч мэр сэр тохиолдож байсан.

- Өмгөөлөгч байцаалтыг мэтгэлцээний арга хэлбэрээр явуулж чаддагүй гэдэг хувилбарт шүүгч нар 22, прокурорууд 29, өмгөөлөгч 22, иргэдийн төлөөлөгч нар 9, бусад субьект 12 санал тус тус ирүүлсэн. Шүүх хуралдааны явцад зарим өмгөөлөгчийн хувьд өөрт ашигтай асуулт тавьж мэдүүлэг авах чадвар үнэхээр хангалтгүй байсан. Тухайлбал, та өөрийн үйлдэлдээ ямар үнэлэлт өгч байна, хохирлоо төлсөн үү, хохирогчоосоо уучлал гуйсан уу, өөр үйлдсэн хэрэг байна уу, үйлдлээсээ зөвшөөрөхгүй гэж байгаа үйлдэл байна уу гэх мэт зарим талаар яллагчийн асуух асуултыг ч асууж байсан. Энэ нь бүх өмгөөлөгч нарт хамаарахгүй боловч судалгааны явцад өмгөөлөл хийж таарсан хүмүүсийн олонх нь ийм байдалтай байсан гэдгийг тэмдэглэж байна.
- Өмгөөлөгч эсэргүүцсэн санал гаргах боломжийг ашигладаггүй гэдэг хувилбарт шүүгч нар 27, прокурорууд 16, өмгөөлөгч 20, иргэдийн төлөөлөгч нар 11, бусад субьект 11 санал тус тус ирүүлсэн. Шүүгч нар ийнхүү шүүмжлэлтэй хандаж байгаа нь үндэслэлтэй гэж үзэхээр байгаа юм. Учир нь зарим тохиолдолд талууд бие биенийхээ гаргасан саналыг илт үгүйсгэж санал гаргаж байхад анх санал гаргасан тал нь тайлбар хийхгүй, ямар нэг саналгүй гэх зэргээр илт идэвхгүй байдал гаргаж шүүгч дундуур нь орж та яагаад санал хэлэхгүй гээд байгаа юм бэ таны саналыг огт зөвшөөрөхгүй огт өөр үндэслэл, зүйл анги яриж байхад та яагаад тайлбар хэлдэггүй юм бэ гэх зэргээр шаардаж байж тайлбар хэлүүлэх тохиолдол, мөн илт хөнгөн зүйл ангиар зүйлчлэх боломжтой хэрэг дээр тэр гарцыг олж харагүй зүйл анги дээр прокурортой санал нэг байна гээд сууж байдаг өмгөөлөгч ч байна. Харин прокурор нь зүйл ангийг хөнгөрүүлж зүйлчилж шийдвэрлэхэд татгалзах зүйлгүй гэж 2-р шүүмжлэл дээрээ өмгөөлөгчийн хэлэх ёстой үгийг хэлж өөрийнхөө алдааг засаж байх жишээтэй.
- Өмгөөлөгч нотлох баримтыг шинжлэхдээ ур чадвар нь дутагддаг гэдэг хувилбарт шүүгч нар 26, прокурорууд 15, өмгөөлөгч 10, иргэдийн төлөөлөгч нар 2, бусад субъект 10 санал тус тус ирүүлсэн. Үүнийг нь өмгөөлөгч нарыг чадваргүй гэж буруутгах үндэслэл гэж үзэх нь өрөөсгөл болно. Тухайлбал, нотлох баримтыг анхнаасаа яллах талаа бариад бүрдүүлчихдэг. Хавтаст хэрэгт цагаатгах талын баримт ховор байдаг нь тэдэнд бодитой эрхшээл учруулдаг байна. Ялангуяа шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч ажиллаагүй хэрэгт ийм байдал илүү ажиглагдаж байлаа. Ингэхээр хэрэв хохирлоо төлсөн тохиолдолд энэ баримтыг, бие нь муу өвчтэй тохиолдолд эмнэлгийн бичгийг, ял эдэлж байгаагүй бол ял шалгах хуудсыг, ажилтай тохиолдолд хамт олны сайн хүн гэсэн тодорхойлолт, нэн ядуу төлбөрийн чадваргүй тохиолдолд

хорооны засаг даргын энэ тухай тодорхойлолт гэх мэт тоймтой хэдэн баримтыг л шинжлэн судлахад хүрдэг. Гэхдээ энэ байдлаас өмгөөлөгч нар гарц олж өмгөөллөө чанартай явуулахад тэдэнээс одоогийнхоос илүү ур чадвар шаардагдаж байгаа нь харагдлаа.

- Өмгөөлөгч шүүхэд болон мэтгэлцэгч талдаа хүндэтгэлтэй хандах ёс зүйн шаардлага хангадаггүй гэсэн хувилбарт шүүгч нар 9, прокурорууд 19, өмгөөлөгч 17, иргэдийн төлөөлөгч нар 6, бусад субьект 8 санал тус тус ирүүлсэн. Энэ байдал нь шүүх хуралдаанд ажиглалт хийх явцад төдийлөн ажиглагдсангүй. Харин ярилцлагын явцад шүүх хуралдааны үеэр өмгөөлөгч зүй бус авирладаг тохиолдол цөөнгүй гардаг гэсэн шүүмжлэл гарч байсан болно.

Иргэдийн төлөөлөгчийн саналыг шүүх хуралдаанд оролцогчдод танилцуулдаг эсэх гэсэн асуултад судалгаанд оролцогчид хэрхэн хариулсан байдлыг авч үзье.

Танилцуулдаггүй гэсэн хувилбарт шүүгч нар 30, прокурорууд 30, өмгөөлөгч 40, иргэдийн төлөөлөгч нар 11, бусад субьект 22 санал тус тус ирүүлсэн.

Танилцуулдаг гэсэн хувилбарт шүүгч нар 57, прокурорууд 52, өмгөөлөгч 43, иргэдийн төлөөлөгч нар 27, бусад субьект 38 санал тус тус ирүүлсэн. Гэвч шүүх хуралдаанд ажиглагчаар оролцож байхад энэ байдал эсрэгээр байсан бөгөөд ихэнх тохиолдолд шүүгдэгч эцсийн үг хэлсний дараа иргэдийн төлөөлөгч саналаа бичгээр өгснөөр шүүх хуралдаан завсарлаж байлаа.

Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ямар байр суурьтай оролцох нь зүйтэй гэж үздэг вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчид хэрхэн хариулсан байдлыг авч үзье.

Одоогийн байгаа энэ байр сууриа цаашид баримтлах /одоо хуулиудад тусгагдаад байгаа тогтолцоо/ гэсэн хувилбарт шүүгч нар 70, прокурорууд 48, өмгөөлөгч 27, иргэдийн төлөөлөгч нар 8, бусад субьект 21 санал тус тус ирүүлсэн.

Шүүгчтэй хамтран шийдвэр гаргадаг болох /Германы тогтолцоо/ гэсэн хувилбарт шүүгч нар 6, прокурорууд 16, өмгөөлөгч 31, иргэдийн төлөөлөгч нар 25, бусад субьект 18 санал тус тус ирүүлсэн. Дээрх хариултуудаас харахад шүүгч нар иргэдийн төлөөлөгч ямар нэг үүрэг рольгүй одоогийн тогтолцоог нилээд таатай хүлээн авч байгаа бөгөөд харин иргэдийн төлөөлөгч нар одоогийн байгаа энэ тогтолцооноос залхсан эрх мэдэл, үүрэг рольгүй байгаа энэ байдлаа өөрчлөх, шүүгч нартай адил эрх хэмжээтэй хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлдөг болох сонирхолтой байгаа нь харагдаж байна.

Тангарагтны шүүхийн хэлбэрээр гэм буруугийн талаар бие даан шийдвэр гаргадаг болох /Англи, Америкийн тогтолцоо/ гэсэн хувилбарт шүүгч нар 11, прокурорууд 18, өмгөөлөгч 25, иргэдийн төлөөлөгч нар 5, бусад субьект 21 санал тус тус ирүүлсэн.

Энэ хувилбарыг өмгөөлөгч нар бусад оролцогчдоосоо илүү их дэмжиж байгаа нь тангарагтан гэдэг энгийн иргэдийг итгэн үнэмшүүлж өөрт ашигтай шийдвэр гаргуулахад илүү дөхөмтэй гэж үздэгтэй холбоотой байж болох юм.

Гурав. Дүгнэлт

Социологийн судалгаанд хамрагдагсдын 83.1% нь байцаан шүүдэг тогтолцооноос мэтгэлцүүлэн шүүдэг тогтолцоонд шилжсэн явдлыг зөв гэж үзсэн ба 73.7% нь эрүүгийн, 17.7% нь иргэний хэргийг шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцээний хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар асуулгад хариулснаас 14% нь шүүх хуралдаанд мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан гэж дүгнэсэн байхад 48.5% нь бүрэн бус төлөвшсөн, 37.4% нь төлөвшиж чадаагүй гэж дүгнэснээс харахад шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцээний хэрэгжилтийн түвшин төдийлөн шаардлага хангахгүй байна.

Судалгааны явцад шүүхийн мэтгэлцээний хэрэгжилтэд тодорхой ахиц гарсан боловч дутагдалтай зүйл нилээд байгаа нь ажиглагдсан бөгөөд энэхүү ахицтай болон дутагдалтай талыг авч үзье.

Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцээний хэрэгжилтэд гарсан ахицтай талууд:

1.Шүүгч шүүх хуралдааны явцад нотлох баримт шинжлэх, байцаалт явуулах гэх мэт бүх ажиллагааг өөрийн санаачилгаар хэрэгжүүлдэг байсан тогтолцоог өөрчилж, талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд давамгай байдалтай оролцох явдал үндсэндээ хэвшил болж байгаа;

2.Мэтгэлцээний талууд болох өмгөөлөгч, прокурорууд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх эрмэлзлэлтэй, зарим өмгөөлөгч, прокурор мэтгэлцэх ур чадварыг боломжийн түвшинд эзэмшсэн байдал харагдаж байна;

3.Хэдийгээр нийтлэг биш боловч зарим шүүхүүд мэтгэлцээн явуулах тохиромжтой байдлаар шүүх хуралдааны танхимыг зохион байгуулахыг оролдож байна;

4.Шүүгч нарын хувьд төвийг сахисан байр сууринаас шүүх хуралдааныг удирдан явуулах чадвар нь илт сайжирсан байна.

Дутагдалтай талууд:

1.Шүүх хуралдааны танхимын байрлал ихэнхи тохиолдолд мэтгэлцэх боломжийг хангахуйц хэмжээнд зохион байгуулаагүй, оролцогчдыг замбараагүй хольж байрлуулах;

2.Шүүх бүрэлдэхүүн бүрдээгүй байхад хуралдааныг эхлэх;

3.Шүүх хуралдаан даргалагч хуралдаанд оролцогчдын эрхийг ойлгогдохуйц хэмжээнд тайлбарлаж өгөхгүй байх;

4.Шүүх хуралдаан даргалагч ирц танилцуулж хуралдааныг журам

зөрчих, ирцийг танилцуулалгүйгээр хуралдаан явуулах, бүрэлдэхүүнийг танилцуулахгүй, татгалзан гаргах эрхийг хангахгүй /асуулгүй/ орхигдуулах;

5.Шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөр хэрэг унших гэх мэтээр талуудын мэтгэлцээнд илт тоомжиргүй хандах;

6.Шүүх хуралдаан даргалагч тулгасан, хөтөлсөн асуулт асуух, мэдүүлэг өгч буй этгээд хэргийн талаар ярьж байхад дундуур нь асуулт тавих /энэ нь ЭБШХ-ийн 144.5 дугаар зүйлийн байцаагдаж байгаа этгээд хэргийн талаар ярьж дууссаны дараа тодруулахаар асуулт тавьж болно гэсэн заалтыг зөрчиж байна/;

7.Эрүүгийн шүүх хуралдааны явцад шүүгдэгч шүүх болон яллах талын асуултад босож, өмгөөлөх талын асуултад сууж хариулж байгаа байдал хэвшил болон тогтсон нь ажиглагдаж байсан ба ЭБШХ-д яллах тал асуулт асуухад болон шүүмжлэл явуулахад босох, суух тухай заалт байхгүй харин ЭБШХ-ийн 251.2 дугаар зүйлд шүүх хуралдаанд оролцогчид шүүхэд хандан мэдүүлэг өгөх, үг хэлэхдээ суудлаасаа босно гэж заасан байна. Ийнхүү мэтгэлцэх явцад босох явдал нь талуудын адил эрхтэйгээр мэтгэлцэх зарчмыг зөрчиж, яллах талд давуу эрх олгож буй сэтгэгдэл төрүүлж байв;

8.Шүүх хуралдааны шүүмжлэлийн шатанд талуудын эсэргүүцсэн санал гаргах боломжийг тоон үзүүлэлтээр хязгаарласан нь талуудын мэтгэлцэх боломжийг хязгаарлаж буй нэг хэлбэр болж байна /ЭБШХ-ийн 279.6/;

9.Талуудын мэтгэлцэх ур чадвар шаардлагын түвшинд хүрээгүй

- Шүүхийн хэлэлцүүлгийн үед илэрхий зөрүүтэй асуудал байсаар атал нэмэлт асуулт, санал тавихгүй байх;
- Хөтөлсөн, тулгасан асуулт асууж ЭБШХ-ийн 144.6 дугаар зүйлийг зөрчиж байгаа бөгөөд талууд ийнхүү асуулт асуухыг эсэргүүцэхгүй байх. Энэ нь талуудын хөтөлсөн болон тулгасан асуултын шинж чанарыг мэдэхгүй байгаа байдлыг харуулж байв;
- Зарим тал хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтад найдаж, шүүх хуралдааны явцад мэтгэлцэн өөрийн давуу байдлаа харуулах асуудалд хайнга хандах;
- Талууд шүүхэд өөр өөрийн байр суурыа илэрхийлэхдээ чиг үүргээ барихгүй байх. Шүүхийн хэлэлцүүлгийн үед яллагч илт шүүгдэгчийн үйлдлийг хөнгөрүүлэх шинж чанартай асуултыг хөтлөн асуух;
- *Талууд өөр өөрсдийн байр суурийг нотлох биш, аль аль нь яллах болон цагаатгах шинжтэй асуултуудыг тодорхой зорилгогүй хольж асуух;*
- *Нотлох баримтыг шинжлэн судлах шатанд талууд нотлох баримтыг шинжлэхдээ ур чадвар нь дутагддаг.*

10.Мэтгэлцээний чухал хэсэг болох шүүмжлэлийн үг нь үндэслэл муутай, тухайлбал, яллагч гэм буруутай, зүйл анги тохирсон, ял халдаах үндэслэлтэй байна, өмгөөлөгч шүүгдэгчийн хувийн байдлыг ярихаас

хэтрэхгүй тухайлбал, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэндээ гэмшиж байгаа, өвчтэй зовлонтой, эцэг эх нь өндөр настай, нялх нойтон хүүхэдтэй тул хуульд заасан хөнгөн ял оногдуулж өгнө үү гэх мэт нэг загварын цөөн үгээр шүүмжлэл явуулж байна. Талууд эрх зүйн үндэслэлтэй шүүмжлэл хэлэх чадвар муутай байв;

11.Шүүгдэгчийн эцсийн үг мэтгэлцээний нэмэлт механизм болох ач холбогдолтой зүйл атал энэ талаар шүүгч, шүүгдэгчийн өмгөөлөгч нар тодорхой тайлбарлаж өгөөгүйгээс шүүгдэгч бүр хэвшил болсон, ахуйн чанартай хэдэн үг хэлэхээс биш хэрэг маргааны талаар эрх зүйн үндэслэлтэй үг хэлж чадахгүй байгаа явдал нийтлэг байв;

Мэтгэлцээний хэрэгжилтийг сайжруулахын тулд авах арга хэмжээ:

Шүүх хуралдаанд мэтгэлцээний хэлбэрийг баримтлахын тулд дараах чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

- *Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:*

1.ЭБШХ-ийн 279.6 дугаар зүйлд шүүх хуралдааны шүүмжлэлд оролцогчид үг хэлж дууссаны дараа тэд шүүмжлэлд яригдсан зүйлийн талаар тус бүр нэг удаа тайлбар хэлж болох ба хамгийн эцэст үг хэлэх эрх шүүгдэгч, түүний өмгөөлөгчид олгогдоно гэсний "тус бүр нэг удаа" гэдгийг хасаж өөрчлөх ба харин талууд урьдах саналаа дахин давтах байдлаар тайлбар хийсэн тохиолдолд хуралдаан даргалагч шүүмжлэлийг зогсоох эрхтэй байхаар хуульчлах нь зүйтэй.

2.Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ-д иргэдийн төлөөлөгч саналаа хэдийд гаргах, дүгнэлтийг танилцуулах эсэх талаар зохицуулалт байхгүй байгаа бөгөөд энэ талаар хуульд тусгах шаардлагатай.

3.ИХШХШХ-д талуудын мэтгэлцэх боломжийг төдийлөн хангаагүй байна. ИХШХШХ-д заасан шүүх хуралдаан явуулах ерөнхий журамд нотлох баримтыг шинжлэн судалсны дараа талуудад өөрсдийн байр суурыа дүгнэн илэрхийлэх боломжийг олголгүй шууд иргэдийн төлөөлөгчдийн саналыг сонсож, шүүх хуралдааныг завсарлуулахаар заажээ. Иймд ИХШХШХ-д иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргахын өмнө талууд өөрсдийн байр суурыа дүгнэн илэрхийлэх боломж олгосон /ЭБШХ-д заасан шүүмжлэлийн шаттай адил/ заалт нэмж оруулах нь зүйтэй.

4.ИХШХШХ-ийн 108.2 дугаар зүйлд гэрч, зохигчийн тайлбар, шинжээчийн дүгнэлтээс шүүх хуралдаанд оролцогч дараах дарааллаар асуулт тавина:

- шүүх хуралдаан даргалагч;
- шүүгч, иргэдийн төлөөлөгч;
- нотлох баримт гаргаж буй этгээд;
- нотлох баримтыг эсэргүүцэж буй этгээд гэсэн дараалал тогтоосон нь байцаан шүүдэг тогтолцооны нэг хэлбэр бөгөөд шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд хөндлөнгийн байр суурьтайгаар оролцох, мэтгэлцүүлэн шүүх зарчмыг зөрчиж байгаа тул талууд эхний ээлжинд асуулт тавих боломжтой байхаар өөрчлөх шардлагатай гэж үзэж байна.

- **Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс авах арга хэмжээ:**

1.Мэтгэлцээн явагдахад тохиромжтой байрлалаар шүүх хуралдаан явагдах байрны зохион байгуулалтыг улсын хэмжээнд жигдрүүлэх;

2.УДШ, нийслэлийн шүүх зэрэг дээд шатны шүүхийнхэнтэй зарим эргэлзээтэй, нэг мөр бус ойлгогдож хэрэгжиж байгаа асуудлаар зөвлөлдөж тохиролцох, шаардлагатай бол албан ёсоор тайлбар гаргах.

- **Сургалтын явцад анхаарах зүйлс**

1.Мэтгэлцэх ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулахдаа сургалтанд хамрагдаж байгаагүй хүмүүсийг түлхүү хамруулах;

2.Сургалтад дадлагажуулах хэлбэрийг илүү баримталж явуулах;

3.Сургалтын үр дүнгээ эргэн хянаж тооцдог тогтолцоонд шилжих нь зүйтэй гэж үзэж байна.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

ХОРИХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨ

НЭГ. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурал 2002 онд Эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн батлагдсан билээ.

Нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягийн өөрчлөлттэй уялдан Монголын нийгмийн амьдралд эерэг, сөрөг олон шинэ үзэгдэл бий болж үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг үйлдэж байгаа нөхцөл байдал, арга хэрэгсэл, хэв маягт ч өөрчлөлт гарсан. Монгол Улсын төрөөс эрүүгийн ял шийтгэлийн талаар баримтлах бодлого, хорих ял эдлүүлэх ажиллагаа, түүний Эрүүгийн хуульд заасан зорилгоо хэрхэн хангаж буй байдал, хорих ялын үр нөлөөг хэрхэн сайжруулах талаар судлан, үр дүнг шийдвэр гаргах эрх бүхий субьектэд танилцуулж санал, зөвлөмж гаргах асуудал нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Хууль зүйн үндэсний төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газрын ажилтан, эрдэмтэн судлаачдын баг "Хорих ялын үр нөлөө" сэдэвт энэхүү судалгааг эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар ангид 2007 оны 4 сарын 1-нээс 2007 оны 5 дугаар сарын 20 хүртэл хугацаанд явуулсан болно.

1.1.Судалгааны зорилго, зорилт

Эрүүгийн хуульд заасан хорих ялын (буюу шүүхээс оногдуулсан хорих ялын) хэмжээ үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэрэгтний гэм бурууд тохирсон эсэх, хорих ял эдлүүлэх нөхцөл байдал нь хорих ялын урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх, хүмүүжүүлэх зорилгыг хэрхэн хангаж буй, өөрөөр хэлбэл хорих ял үр нөлөөгөө өгч буй эсэхийг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

1.2. Судалгаа явуулсан байдал

Судалгааг хууль зүйн ухааны доктор, профессор Д.Зүмбэрэллхам ахлагчтай баг явуулж байгаа ба судалгааны багт Улсын ерөнхий прокурорын газрын Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Ц.Батцэнгэл, ХБНГУ-ын Макс Планкийн институтын докторант Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Тогтоол гүйцэтгэх газрын Тусгай газрын дарга, хурандаа Б.Амардорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 407 дугаар ангийн дарга, хурандаа Р.Оюунбадам, ХЗҮТ-ийн КСС-ын ЭША Г.Оюунболд нар орж ажилласан юм. Судалгааг анкетын буюу асуулгын, ярилцлагын, бичиг баримт судалгааны аргаар явуулж хорих 407 дугаар ангид ял эдэлж буй эмэгтэй ялтнуудын шийтгүүлсэн хугацаа, ял шийтгэлийн давтамж, хорих ял эдэлж байгаа нөхцөл, хорих байгууллагын зүгээс авч буй арга хэмжээ зэргийг судлав. Судалгааны мэдээллийг Баянзүрх дүүрэг дэх эмэгтэйчүүдийн 407-р хорих

ангид хорих ял эдлэж буй хоригдлууд, тус хорих ангиас "Буян" ХХК-д болон Буян ХХК-ний охин компани болох "Алтан жимс" ХХК-д гэрээгээр ажиллаж байгаа ялтнуудаас асуулгын болон ярилцлагын аргаар цуглуулсан болно.

1.3. Судалгаа явуулсан арга, хэлбэр

Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага авах, санал асуух, сурвалжлах зэрэг аргаар явуулав.

ХОЁР. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

Хууль тогтоомжийн судалгаа: Хууль тогтоомжуудын хүрээнд дараах байдлууд тогтоогдож байна. Үүнд:

1.Монгол Улсын Эрүүгийн хуулийн 52-зүйлийн 52-ийн 11 дэх хэсэгт "Шүүх нь хорих ял шийтгүүлсэн ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхийг тогтоож болох-"-ыг хуульчилсан боловч гяндангийн дэглэмийг, тухайлбал чанга алин болохыг заагаагүй орхигдуулсан байна. Хууль нэгэнт тодорхой заагаагүй болохоор шүүхээс хорих ял шийтгүүлсэн ялтныг гянданд ял эдлүүлэхдээ дэглэмийн талаар шийтгэх тогтоолд тусгадаггүй байна.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 109-р зүйлд гяндангийн жирийн ба чанга дэглэмтэй бусадтай хийх уулзалт, захидал явуулах тоо хэмжээ, хоорондын ялгааг зааж өгсөн ч шүүхийн шийтгэх тогтоолд ялтны эдлэх дэглэмийг заагаагүй учраас практикт хэрэгжих боломжгүй юм. Хууль жинхэнэ утгаараа биелэгдэхгүй байгаа нэг шалтгаан манай оронд хууль хэрэгжүүлэх нийгэм эдийн засгийн нөхцөл бүрдээгүй байхад өндөр хөгжсөн гадаад орнуудын журам зааврыг хуульчлан мөрдүүлж байгаатай холбоотой юм. Жишээ нь: Жирийн, чанга , онцгой дэглэмтэй хорих ангид тус тус ял эдлэх ёстой насанд хүрээгүй хүүхэд, болон эмэгтэйчүүдийг нэг хорих ангид бөөгнөрүүлэн хорьж, тэдгээрийг зөвхөн амьдрах байраар нь тусгаарлах, бусадтай уулзах тоонд хязгаарлалт тавих хэлбэрийн төдийгөөр дэглэмийн ялгаа илэрч байна.

3.Гяндангийн ялтныг өдөрт нэг цагаас доошгүй хугацаагаар салхилуулах тухай ШШГТХ-ийн 109-р зүйлд заасан заалт хэрэгждэггүй , хэрэгжих нөхцөл ч алга байна. Энэ нөхцөлд гяндангийн ялтны өрөөг байгалийн гэрлийг илүүтэй тусгах болон байнгын агааржуулалттай байлгах нь үр дүнтэй юм.

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ял эдлэж байгаа ялтныг хугацаанаас нь өмнө суллах болзол шаардлагын нэг нь учруулсан хохирол нөхөн төлсөн байх явдал юм. Өнөөгийн байдлаар хорих ангиуд нь ажлын хүчээр дутмаг ба албан бус эх сурвалжаас зарим ялтны ердөө

50-60 хувь нь л ажил хийдэг байна. Хорих ялтны хөдөлмөрийн орлогоос учруулсан хохирлоо нөхөн төлсөн нь дунджаар 4 хувийг эзэлж байгаа нь тун бага үзүүлэлт юм. 2002 оноос хойш тэнсэн суллагдсан байдлыг судлаж үзэхэд үндсэндээ ялтны ар гэрийнхэн нь хохирлыг барагдуулсан байна.

5.Мөн ЭБШХ-ийн 332-р зүйлийн 332.2 дахь хэсэгт саасан "Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн , түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдийн талаар гарсан тогтоол биелүүлэх явдлыг хойшлуулж болохгүй" гэж заасан атал тус хуулийн 333-р зүйийн 33.2 дахь хэсэгт " ял эдэлж байгаа этгээд зөвхөн бие эрхтэндээ санаатай гэмтэд учруулснаас бусад тохиолдолд өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлж болохыг заасан нь логикийн хувьд авцалдаагүй, хуулийн энэ цоорхойг ашиглан 2004 онд хэвтэж эмчлүүлсэн ялтны хорих ялыг нэг ч удаа хойшлуулаагүй байтал 24 ялтныг /үүний дотор онц хүнд хэрэг үйлдсэн 9 ялтныг/ ялаас бүрмөсөн өвчний учир чөлөөлсөн байна.

6.ШШГТХ-ийн 8-р зүйлийн 8.2-т хорих байгууллагын баривчлах, хорих ял эдлүүлэх талаарх чиг үүргийг тодорхойлж өгөөгүйгээс тэдгээр нь зарчмын хувьд ялгаагүй болж баривчлах ба хорих ял нь адилхан нэг төрлийн ял болон хувирчээ. Тухайлбал уг зүйлд баривчлах ялтай ялтныг хорих ангид ял эдэлж байгаа ялтантай нийтийн адил албадан хөдөлмөрлүүлэхээр заасан нь ЭХ-ийн ялтныг ганцаарчлан хорих заалттай зөрчилдөж байгаа юм.

7.ШШГТХ-ийн 66-р зүйлийн 66.2-д Хорих ял эдэлж байгаа ялтны төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр ялтны ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд гүйцэтгэх баримт бичиг явуулна. Түүнчлэн 66-р зүйлийн 66.3-т "Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан хорих ангийн захиргаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ" гэж зааж өгснөөс гадна 126-р зүйлийн 126.2-т Ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана. гэж хуульд шинэ зохицуулалт оруулж өгсөн байна. Тэгэхээр Эрүүгийн Байцаан Шийтгэх Тухай Хууль, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн хуульд хохирол барагдуулах талаар заасан заалтыг илүү нарийн тусгаж өгөх, хорих ялын хэрэгжилтийн явцад тулгамдсан хүндрэл бэрхшээлтэй олон асуудлын талаар хууль хяналтын байгууллага дорвитой ажил зохиох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд саналаа нэмэрлэх хэрэгтэй байна.

8.ШШГТХ-ийн 66-р зүйлийн 66.2-д Хорих ял эдэлж байгаа ялтны төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр ялтны ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд гүйцэтгэх баримт бичиг явуулна. Түүнчлэн 66-р зүйлийн 66.3-т "Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан хорих ангийн захиргаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ" гэж зааж өгсөнөөс гадна 126-р зүйлийн 126.2-т Ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг ялаас

хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана. гэж хуульд шинэ зохицуулалт оруулж өгсөн.

Өнөөгийн байдлаар хууль хорих ял эдлүүлэх ажиллагаанд МУ-ын Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас гадна дараах журмууд үйлчилж байгаа юм. Үүнд:

- 2002 оны 10 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Дугаар № 242 "Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам"
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны № 215 дугаар тушаалаар "Хорих ангийн дотоод журам"-ыг баталсан бөгөөд энэхүү журам дээр үндэслэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ангиуд өөрсдийн дотоод журмыг боловсруулдаг юм.
- 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан дугаар № 02 "Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журам"
- 2003 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр дугаар № 294/74 "Шүүхийн хуягийг ажиллуулах журам "
- 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Дугаар № 313/316 "Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журам"
- 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан д у г а а р № 1 4 "Цагдан хорих байрны дотоод журам"
- 2005 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дугаар № 37/64 "Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам"

гэсэн журмууд дагаж мөрдөгдөж байгаа бөгөөд ШШГЕГ, УЕПГ, түүнчлэн хорих байгууллагаас гаргасан тушаал , зааврууд үйлчилж байгаа юм. Хууль тогтоомжийн хүрээнд дутагдсан зүйл үгүй боловч тэдгээрийг нэг мөр дагаж хэрэгжүүлэх, биелүүлэх талаар үр дүнтэй ажил зохиовол хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх нэг алхам болох юм.

Анкетийн асуулгаар авсан мэдээллийг нэгтгэн дүгнэсэн байдал

Анкетын судалгаанд эмэгтэйчүүдийн хорих 407-р ангийн нийт 260 /2007 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар/ ялтнаас хорих анги дээр чанга дэглэмд ял эдэлж буй 20 ялтан, жирийн дэглэмд ял эдэлж буй 50 ялтан, "Буян" ХХК дээр ажиллаж буй 30 ялтан, "Буян" ХХК-ийн охин компани болох "Алтан жимс" ХХК дээр ажиллаж буй 19 ялтан, нийт 119 ялтан хамрагдсан. Энэ нь нийт ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 45.7 хувийг эзэлнэ.

Хавсралт№1 /Санал асуулгын хуудас/

Хавсралт№2 үзэх /анкетийн асуулгын дүн хүснэгтээр/

Анкетийн асуулгаар авсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ:

1. Таны шийтгүүлсэн зүйл анги ? гэсэн асуултанд



- "Бусдын эд хөрөнгийг хулгайлах" гэмт хэрэгт асуулгад хамрагдсан ялтнуудын 19.8 хувь буюу 15 ялтан шийтгүүлсэн байна. Үүнээс 145.4-т заасан зүйл хэсгээр 9 ялтан буюу 7.6 хувь, 145.3-т заасан зүйл хэсгээр 1 буюу 0.8 хувь, 145.2-т зааснаар 5 буюу 4.2 хувь нь шийтгүүлсэн байна,
- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт асуулгад хамрагдсан ялтнуудын 6.7 хувь буюу 8 ялтан шийтгэгдсэнээс 147.2-т заасан зүйл хэсгээр 5 буюу 4.2 хувь, 147.3-т заасан зүйл хэсгээр 3 буюу 2.5 хувь нь тус тус шийтгэгдсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн хувьд дийлэнх нь бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг тэр дундаа бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх, хулгайлах гэмт хэргүүд болон бусдыг санаатай алах гэмт хэргийг үйлдсэн бөгөөд ял эдлэж байгаа эмэгтэйчүүд гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хорих ял эдлэж байгаа эмэгтэй ялтнуудын 1/3% нь залилан, 1/3 % нь хулгай, үлдэх 1/3% нь бусдыг санаатай алах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн байна. Энэ нь тухайн эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь бага, эдийн засгийн хувьд хараат, боломж тааруу, гэр бүлийн хувьд хүчирхийлэл дарамтанд байнга байдаг эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэрэг илүү үйлдэж байгаагаас харагдаж байна.

2.Та хэдэн жилийн хорих ялаар шийтгүүлсэн бэ ?гэсэн асуултанд:



Санал асуулгын судалгаанд хамрагдсан ялтнуудын :

- 51 буюу 42.8 хувь нь 10 дээш 25 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн,
- 59 ялтан буюу 49.5 хувь нь 5 дээш 10 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бол
- 8 ялтан буюу 6.7 хувь нь 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэгджээ.

Энэ нь 2006 оны 6-р сарын 23-нд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулж "Өршөөлийн тухай хууль" батлагдан гарч, хөнгөн хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн ялтангууд суллагдсантай холбоотойгоор гарч байгаа тоон үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл Өршөөлийн тухай хууль батлагдан гараагүй бол үүнээс илүү хэмжээний ялтан ял эдэлж байсан юм.

3.Судалгаанд хамрагдсан 119 ялтны 86 буюу 72.3 хувь нь анхны удаа ял шийтгүүлсэн, 30 ялтан буюу 25.2 хувь нь 2-3 удаа ял шийтгүүлсэн, 2 ялтан буюу 1.7 хувь нь 4-өөс дээш удаа ял шийтгүүлсэн байв.



4. Санал асуулгад оролцсон ялтнуудаас 53 буюу ***44.5 хувь*** нь 2 хүртэл жилийн ялыг биечлэн эдэлсэн, 38 ялтан буюу ***31.9 хувь*** нь 3-5 жилийн ялыг биечлэн эдэлсэн, 6-8 жилийн ялыг 10 ялтан буюу 8.4 хувь нь биечлэн эдэлсэн бол 3-аас доош жил 6 ялтан буюу 5.0 хувь нь биечлэн эдэлсэн байна.



5.Санал асуулгад хамрагдсан 119 ялтны 99 буюу 83.2 хувь нь жирийн дэглэмд ял эдэлж байгаа бол 20 ялтан буюу 16.8 хувь нь чанга дэглэмд ял эдэлж байлаа.

6.Санал асуулганд оролцогч ялтангуудаас "Шүүхээс оногдуулсан хорих ял үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон эсэх" талаар судлахад

- 85 ялтан буюу 71.4 хувь нь тэдэнд оноосон хорих ял ихэдсэн буюу үйлдсэн гэмт хэрэгт тохироогүй
- 18 ялтан буюу 15.1 хувь нь тэдэнд шүүхээс оноосон хорих ял тохирсон гэж үзсэн бол
- зөвхөн 1 ялтан буюу 0.8 хувь нь шүүхээс оноосон хорих ял багадсан гэж байлаа.



Анкетийн асуулгад хариулсан эмэгтэй ялтангуудын дийлэнх нь оногдуулсан хорих ялыг ихэдсэн гэсэн ба шинээр батлагдан гарсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн ялын бодлого чанга гэдэгтэй бүгд санал нийлж байсан юм. Энэхүү хариулсан байдлаас үзэхэд хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь тэдний үйлдсэн гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан хорих ялын хэмжээ ихэдсэн байна гэж үздэг юм байна гэсэн дүгнэлтэнд хүргэлээ.

7. Хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн ар гэрт ямар өөрчлөлт гарсныг судлахад /давхардсан тоогоор/

- 58 ялтан буюу 48.7 хувь нь тэднээс найз нөхөд нь нүүр буруулсан
- 55 ялтан буюу 46.2 хувь нь ах дүү хамаатан садны хүмүүс нүүр буруулсан,
- 43 ялтан буюу 36.1 хувь нь орон гэрээ алдсан, 42 ялтан буюу 35.3 хувь нь гэр бүл салсан,
- 33 ялтан буюу 27.7 хувь нь хүүхэд сургуулиас завсардсан, 33 ялтан буюу 27.7 хувь нь эд хөрөнгөө алдсан,
- 28 ялтан буюу 23.5 хувь нь гэр бүлийн хэн нэг нь нас барсан,
- 20 ялтан буюу 16.8 хувь нь хүүхэд гэр оронгүй тэнэмэл амьдралтай болсон гэж хариулжээ.



Үүнээс үзэхэд хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдээс ах дүү, хамаатан садны хүмүүс нь нүүр буруулж, эд хөрөнгө, орон гэрээ алдах, хүүхэд нь сургуулиас завсардах, тэнэмэл болох, гэр бүлийн хэн нэгэн нас барах, гэр бүл салах зэргээр тэдний ар гэр нь хорих ялын цээрлэлийг давхар амсаж байна. Өөрөөр эмэгтэйчүүдийг эх хүн гэдэг талаас нь төрийн бодлого уян хатан байж болох эсэх талаар эрдэмтэн судлаачдын үзэл бодол янз бүр байдаг боловч энэ нь хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг зөрчсөн хэрэг болох юм.

Жишээ нь: Д гэгч эмэгтэй 10 жилийн чанга дэглэмтэй хорих ялаар шийтгүүлжээ. Тэрээр хорих ангид 5 сартай хүүхдийн хамт ирсэн байна.. Хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэж ШШГТХ-ийн дагуу 0-1 хүртэл насны хүүхэдтэй ялтнуудыг тусгайлан зассан нөхцөл сайтай байранд оруулах учиртай гэтэл Д чанга дэглэмд ял эдлэх шийдвэртэй, жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдтэй хамт хоригдох ёсгүй. Тэгээд яах вэ? Хуулийн зохицуулалт байдаггүй. Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд бодолцож, түүнийг хүүхэдтэй эхчүүдийн байранд оруулсанаар дэглэм, харуул хамгаалалт, хүмүүжил хөдөлмөр гэхчилэн олон асуудалд сөргөөр нөлөөлнө. Өөр нэг бодох асуудал бол төрөөс нярай хүүхдэд эхэд нэмж зарцуулахаар тусөвлөсөн хөрөнгө мөнгө байхгүй. Гэтэл цаана нь хүүхдийн хүмүүжил хувь заяа, гэр бүлийн асуудал гээд өчнөөн зүйл урган гарна.

Мөн хорих ял эдэлж байгаад гарч ирсэн л бол "олигтой хүн биш" тогтсон сэтгэлгээ нөгөө талаас хорихоос суллагдаж буй хүмүүст өмнө нь нийгэмшихэд нь тус дөхөм болох сургалт, ярилцлага, нийгэмд ямар амьдрал, юу хүлээж байгаа талаар бодитой, зөв төсөөлөл өгөх, ажлын байр, буцаад очих газар, жирийн иргэний нэгэн адил амьдрах боломж, нөхцлийн талаар тусламж, зөвлөгөө өгдөг үйлчилгээ байдаг болгох хэрэгтэй байгаа юм.

Ялтнууд ял эдэлж байх хугацаандаа бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн эсэх талаарх асуулганд оролцогчдын

Анкетийн судалгаандоролцсон нийт 119 ялтнуудаас

1.Ялтнууд ял эдэлж байх хугацаандаа бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн эсэх талаарх асуулганд оролцогчдын



- 50 ялтан хохирлоо огт төлөөгүй
- 28 ялтан зарим хэсгийг төлсөн
- 22 ялтан хохирлоо бүрэн төлсөн гэж байв

2. Хохирлоо огт төлөөгүй буюу хагас төлсөн шалтгааныг асуухад



Огт төлөөгүй буюу хагас төлсөн шалтгааныг судлахад

- 43 ялтан буюу 36.1 хувь нь төлбөрийн чадваргүй,
- 23 ялтан буюу 19.3 хувь нь хорих ялаа биечлэн эдэлж байгаа учраас төлөхгүй,
- төлөх хүсэлгүй гэсэн 8 ялтан буюу 6.7 хувь байна.

Энэ байдлаас үзэхэд хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүд төлбөрийн чадваргүй, хорих ялаа биеэр эдэлж байгаа учраас хохирол барагдуулах хүсэлгүй, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлоо барагдуулах явдал хангалтгүй байна.

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.lli.gov.mn

3.Санал асуулганд оролцогч ялтнуудаас гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын талаар ямар бодолтой байгааг асуухад:



Санал асуулганд оролцогч ялтан эмэгтэйчүүдээс гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын талаарх санал бодлыг судлахад

- 57 ялтан буюу 47.9 хувь нь тэр хохирогчдыг өрөвдөж өөрийн бурууг хүлээн зөвшөөрсөн байхад
- 42 ялтан буюу 35.3 хувь нь хохирогчдоос болж өөрийгөө ял эдэлж байна гэжээ.

Ялангуяа иргэдийн эрх зүйн мэдлэг хомс байдгаас болж гэмт хэрэг үйлдэх, бусадтай хамтран үйлдсэн хэргийн хариуцлагыг ганц өөр дээрээ үүрч гарах, хүний өмнөөс хэрэг хүлээх явдал, мөн хохирогчийн удаа дараагийн тэсвэрлэшгүй зан авир, үйлдлээс болж хэрэг хийх явдал ялангуяа нөхрөө болон хамтран амьдрагчийнхаа амь насыг санаатайгаар хөнөөсөн эмэгтэй ялтангуудад их гардаг нийтлэг зүйл ажиглагдсан юм.

2006 оны байдлаар хорих ял эдэлж буй ялтнаас иргэд байгууллагад олгох 2123 гүйцэтгэх баримт бичгийн 1.7 тэрбум төгрөгийн төлбөр барагдуулахаас 1317 гүйцэтгэх баримт бичгийн 1.4 тэрбум төгрөгийн төлбөрт хуульд заасны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж, иргэдэд олгох 701 гүйцэтгэх баримт бичгийн 302.5 сая төгрөгийн төлбөрөөс 241 гүйцэтгэх баримт бичгийн 102.8 сая төгрөгийг биелүүлж бодит биелэлт 34.0 хувьтай, байгууллага аж ахуйн нэгжид олгох 105 гүйцэтгэх баримт бичгийн 76.0 сая төгрөгийн төлбөр биелүүлэхээс 10 гүйцэтгэх баримт бичгийн 4.1 сая төгрөгийг барагдуулж 5.3 хувийн бодит биелэлттэй байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хамгийн их хувьтай байгаа ба өнгөрсөн онд 40 гаран хувь биелэгдэж үлдсэн хувь нь он дамжсан төлбөр болж байна. Гэтэл хорих ял эдэлж байгаа төлбөр төлөгчөөс гаргуулан иргэд байгууллагад олгох төлбөрийн гүйцэтгэл дөнгөж 28.2 хувьтай байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм. Хохирогчид заримдаа "хорих ангийн хийлгэж байгаа хөлснөөс төлбөрөө авна гэсэн бодолтой байдаг. Хорих анги ялтны нэрийн дансанд сард дунджаар 5-10 мянган төгрөг бичиж, шүүхийн хуудсын дагуу шилжүүлдэг боловч хэдэн арван сая төгрөгний хохирол барагдахгүй нь тодорхой. Шүүхийн практикаас харахад хохирол төлөгдөөгүй л бол хорих ял оноох хандлага газар авсан байна. Ялтан болсоноор улс нийгэмд үзүүлэх эдийн засгийн хор хохирлыг тооцоолж үзэхгүй байна.

Хорих ял эдэлж байх хугацаанд тухайн ялтнуудын эрх зөрчигдөж байгаа эсэхийг судлахад:



- 55 ялтан буюу 46.2 хувь нь эрх зөрчигдөөгүй
- 31 ялтан буюу 26.1 хувь нь хорих ял эрхийг нь зөрчсөн хэлбэр гэж үзсэн
- 15 ялтан буюу 12.6 хувь нь бусад ялтнууд өөрсдийнх нь эрхийг байнга зөрчдөг,
- 14 ялтан буюу 11.8 хувь нь хорих байгууллагын ажилтнууд өөрсдийнх нь эрхийг зөрчдөг гэж хариулснаас үзэхэд дийлэнх ялтнуудын эрх зөрчигдөх явдал бага байгаа боловч хорих байгууллагын ажилтнууд болон бусад ял эдэлж байгаа ялтнуудын зүгээс тэдний эрхэнд тодорхой хэмжээгээр халдаж байгаа нь ажиглагдаж байна. Түүнчлэн ялтнуудын зүгээс нь хорих ял оноож байгаа нь өөрөө төр тэдний эрхийг зөрчиж байна гэж үздэг ялтангууд ч байсан юм.

Судалгаанд хамрагдсан ялтнуудаас ял эдэлж буй орчин нөхцөл, хүндрэл бэрхшээлийн талаарх асуулганд:

- давхардсан тоогоор 48 ялтан буюу 40.3 хувь нь хорих ангийн орчин нөхцөл муу,
- 37 ялтан буюу 31.1 хувь нь өөрийн хүссэн зүйлээ хийх боломж байхгүй
- 32 ялтан буюу 26.9 хувь нь хорих ангийн байршил хол учраас ар гэрээсээ эргэлт авах боломж муу
- 27 ялтан буюу 22.7 хувь нь хоол унд тааруу, ном хэвлэл захиалах, усанд орох, эмнэлгийн тусламж авах боломж багатай,
- 17 ялтан буюу 14.3 хувь нь сэтгэл зүйн хувьд зовиуртай, 11 ялтан буюу 9.2 хувь нь хорих ял эдэлж байгаа болон хорих байгууллагын ажилтнуудын зүгээс эрхэнд нь хууль бусаар халдаад байдаг гэжээ.



Энэ байдлаас дүгнэхэд хорих ял эдлүүлэх ахуй дэглэм, орчин нөхцөл муу, ар гэрээсээ хол ял эдэлж байгаа учраас эргэлт авах боломж тааруу, хоол унд болон ариун цэвэр сахих гэх мэтийн наад захын хэрэгцээний хангамж багатай байна.

Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн нэг л хорих анги байдаг тул 21 аймгаас хорих ялтай эмэгтэй хоригдлууд тэнд ирдэг. Эргэлт ирэхэд уулзалтын байр сав, уулзах нөхцөл боломжоор хангаж өгөх талаар л төрөөс илүү сайн анхаарах нь чухал. Эмэгтэйчүүдийн хорих байранд түр болон хоногоор эргэх эргэлтийн хэд хэдэн өрөө тасалгаатай. Уулзахаар өргөдөл хүсэлтээ гаргасан ар гэрийнхэнтэй нь журманд заасан хугацаа, нөхцөлөөр чөлөөтэй уулзуулдаг талаар хорих ангийн удирдлага, хоригдлууд ярьж байсан.

Асуулганд оролцогч ялтнуудаас хорихоос суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар судлахад:

- давхардсан тоогоор 79 ялтан буюу 66.4 хувь нь хүмүүсийн үл ойлгох байдал
- 74 ялтан буюу 62.2 хувь нь ажил олдохгүй байх
- 49 ялтан буюу 41.2 хувь нь орон гэргүй байдал
- 41 ялтан 34.5 хувь нь бичиг баримтын асуудалтай тулгарна гэж хариулжээ.

Үүнээс үзэхэд ял эдэлж буй эмэгтэйчүүд хорихоос суллагдаад гарахад тэдэнд учрах бэрхшээл ихтэй, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно гэсэн айдастай байдаг юм байна. Энэхүү айдсыг давах талаар хорих байгууллагын сэтгэл зүйч бэлтгэн, 260 гаруй хоригдолтой дээрх ангийн хувьд дор хаяж 2-3 сэтгэл зүйч авч ажиллуулах шаардлагатай юм.



Түүнчлэн "хорих ял эдлээд суллагдсаныхаа дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүйгээр амьдарч чадах эсэх"-ийг асуухад:

- 91.6 хувь нь чадна гэсэн байхад
- 0.8 хувь буюу нэгхэн хүн тэгж амьдарч чадахгүй гэж хариулжээ.

Хорих ял эдэлж байгаа ялтнуудаас хорих ял өөрийн цээрлүүлэх зорилгоо хангаж байгаа эсэхийг асуухад асуулганд оролцогчдын

- ***61.3%*** буюу 73 ялтан тийм
- ***12.6 %*** буюу 15 ялтан нь үгүй гэж хариулсан байна.

Үүнээс үзэхэд хорих ял цээрлүүлэх зорилгоо хангаж байна гэж үзэж болох юм. Гэхдээ энэхүү цээрлүүлэх зорилго нь ихэнхдээ ялтангуудыг залхаах, цөхрөх, амьдрах итгэлийг бууруулах байдалд хүргэдэг нь харагдаж байсан.

Ялтнуудын зүгээс "Та хэний бүрүүгаас болж хорих ял эдэлж байна вэ?" гэсэн асуултанд:

Давхардсан тоогоор ***97*** ялтан буюу ***89.9 хувь*** нь хуулийн байгууллагын бүрүүгаас тухайлбал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажилтнуудын бүрүүгаас болж ял эдэлж байна гэж хариулсан байх юм.

Та хорих ангиас суллагдаад хамгийн түрүүнд юу хийх эсэхийг асуухад:

Нийт санал асуулганд оролцсон 100 ялтан буюу ***84.0 хувь*** нь ажилд орно гэсэн ба үлдэх цөөн хувь нь хариулаагүй, ямар ч аргаар хамаагүй мөнгөтэй болно, өөрийн дураар амьдарна гэж хариулсанаас үзэхэд ихэнх ялтнууд хорих ялаа эдэлж дуусгаад цаашид нийгэмд ажил хийж амьдрах дур сонирхолтой байгааг харуулж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд ямар ял шийтгэл оноовол өөрийн бүрүүг ойлгож засарч хүмүүжих эсэх, түүнчлэн ямар дэглэмд хорих ял эдлүүлбэл засрал хүмүүжилд эерэг нөлөө үзүүлэх эсэхийг судлахад:

Давхардсан тоогоор:

- 73 ялтан буюу 61.3 хувь нь ялын хэмжээ нь үйлдсэн гэмт хэргийн гэм буруу, учруулсан хор хохиролд тохирсон байвал зохино гэж үзсэн байхад
- 40 ялтан буюу 33.6 хувь нь аль болох хөнгөн ял оноовол засарна гэсэн ба

- 46 ялтан буюу 38.7 хувь нь ялын хүнд, хөнгөнөөр ялгаж тусад нь хорьвол,
- 35 буюу 29.4 хувь ял шийтгэлийн давтамжаар хорьвол,
- 34 буюу 28.6 хувь нь хорих дэглэм ялгаагүй засрал хүмүүжилд нөлөөлнө гэж үзсэн байна.



Эндээс дүгнэхэд хорих ял шийтгүүлсэн ялтнууд оногдуулсан хорих ялыг тэдний үйлдсэн гэмт хэргийн гэм бурууд тохирсон байх ёстой гэж үздэг нь харагдаж байгаа ба зарим хэсгийн зүгээс аль болох хөнгөн ял оноохыг илүүд үзэж хорих ялын дэглэм нь үйлдсэн хэргийн хүнд хөнгөн, давтан үйлдсэн зэрэг байдлаас ялгаатай байх нь засрал хүмүүжилд нөлөөлдөг юм байна гэж үзэж болохоор байна. Судлаачын зүгээс ажиглаж байхад хорих ял эдэлж байгаа ялтангууд аль болохоор хөнгөн дэглэмтэй, цөөн жилээр хоригдох сонирхолтой, хурдхан суллагдах хүсэл нь тэдний ингэж хариулахад хүргэсэн юм болов уу гэж бодоход хүргэж байсан юм.

Төр засаг холбогдох байгууллагуудын зүгээс ямар арга хэмжээ авбал ялтны засрал хүмүүжилд сайнаар нөлөөлөх вэ гэдгийг асуулгад оролцогч ялтнуудаас судлахад:

- давхардсан тоогоор хорих ял эдэлж байгаа нийт ялтнуудын 89 буюу 74.8 хувь нь хорих ялын хэмжээг багасгаж,
- 53 ялтан буюу 44.5 хувь нь ялтныг аль болох хугацаа дуусахаас өмнө суллах, ялтнуудын дунд сургалт хүмүүжлийн ажил байнга зохиох нь засрал хүмүүжилд нь сайнаар нөлөөлнө гэж үзжээ.



Тэгэхээр ялтнуудын зүгээс хорих ялыг багасгах, хугацаанаас өмнө суллаж байх нь засралд хүмүүжилд сайнаар нөлөөлдөг гэж үзэж болохоор байгаа ч хорих ял эдэлж байгаа ялтнууд нь хорих ялын цээрлэлийн үр нөлөөг ямар нэг хэмжээгээр амсаж байгаа болохоор аль болох хурдан суллагдах гэснээс энэ хариултыг сонгосон болов уу гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэг буюу "бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх авах" гэмт хэрэгт үйлдэж ял шийтгүүлсэн нэг эмэгтэй ялтан "би хүнд мөнгө зээлж өгснийхөө төлөө энд ял эдэлж байна, би эндээс гараад дахиад залилан хийнэ надад 70-80 сая төгрөг залилах боломж байгаа, насаараа идэх юм залилчихвал 5-6 жил шоронд суугаад гарсан ч яах вэ дэ" гэж ярьж байсан нь сонирхол татаж байсан юм.

Санал асуулганд оролцсон ялтнуудын гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг судлаж үзэхэд /давхардсан тоогоор/ :

- 27 буюу 22.7 хувь нь амьжиргааны эх үүсвэргүйн улмаас,
- 23 ялтан буюу 19.3 хувь нь бусдад дарамтлуулаад ,
- 22 ялтан буюу 18.5 хувь нь бусдад уруу татагдаад,
- 21 ялтан буюу 17.6 хувь нь мөнгөний шаардлагаар ,
- 19 ялтан буюу 16 хувь нь өрөнд ороод ,
- 15 ялтан буюу 12.6 хувь нь ажилгүй болохоор гэмт хэрэг үйлдсэн гэж хариулжээ.



Гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нь харилцан адилгүй байгаа боловч ихэнхдээ мөнгө төгрөг санхүүгийн асуудлаас болоод гэмт хэрэг үйлдэж байгаа нь илэрхий байна. Түүнчлэн бусдад уруу татагдах, дарамтлуулах байдлууд, нийгэмд байгаа ядуурал, ажилгүйдэл, архидалт, гэр бүл дэх дарамт, хүмүүсийн амьдрал, сэтгэлгээнд ороод байгаа өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.

Мөн санал асуулгад оролцсон 119 ялтанаас засарч хүмүүжиж байгаа эсэхийг судлахад /давхардсан тоогоор/:

- 83 ялтан буюу 69.7 хувь нь "шоронгоос залхаж айж байна"
- 47 ялтан буюу 39.5 хувь нь "би засарч байна"
- 16 ялтан буюу оролцогчдын 13.4 хувь нь "надад ямар ч нөлөө үзүүлэхгүй байна"

35 ялтан буюу 29.4 хувь нь "миний зан араншин улам эвдэрч байна" гэсэн хариулт



Энэ бүгдээс үзэхэд хорих ялаар шийтгэгдсэн эмэгтэй ялтнууд нь гэр бүлийн хүчирхийлэл, дарамт шахалт, санхүү эдийн засгийн байдал, ар гэрээ тэжээх асуудал, мөнгөний бэрхшээлд орсон, өрх гэр толгойлдог, амьжиргааны эх үүсвэргүй нь тэдний нуруун дээр дарамт учруулдаг, өөрийн гэнэн итгэмтгий, хууль эрх зүйн мэдлэггүй байдал, бусдад уруу татагдсан, нийгэмдэх хар тал болох ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийтлэг шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.

www.legal.mn

"Танд хорихоос өөр төрлийн ямар ял оноож болох байсан гэж та үзэж байна вэ" гэсэн асуултанд : /119 ялтанаас/

- 41 ялтан буюу 34.5 хувь нь хорих ялыг тэнсэх
- 13 ялтан буюу 10.9 хувь нь торгох,
- 12 ялтан буюу 10.1 хувь нь баривчлах
- 11 ялтан буюу 9.2 хувь нь албадан ажил хийлгэх
- 41 ялтан уг асуултанд хариулаагүй байна



Асуулгад оролцогч ялтнууд тэдэнд оноосон хорих ялын хэмжээ тэдний үйлдсэн гэмт хэргийн гэм буруугийн хэмжээнд тохироогүй, өөрөөр хэлбэл тэдэнд оногдуулсан ялын хэмжээ ихэдсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч нар хэргийн үнэн зөв байдлыг тогтоож чадаагүй, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож өгөөгүй, хорихоос өөр төрлийн ял оногдуулж болох байсан. Түүнчлэн тэдгээр ял эдэлж байгаа хүмүүст хорих ял оноосноороо төр өөрөө тэдний эрх ашгийг зөрчиж , ар гэр нь давхар яллагдаж байна, гэж үздэг болох нь санал асуулгын дүнгээс харагдаж байсан юм.

Ялтнуудын зүгээс хорих ялын бодлогыг зөөлрүүлж, бусдад учруулсан хохиролд тохируулсан ялыг оногдуулж байх, эмэгтэй хүнийг аль болох олон жилээр биш цөөн жилээр хорих ял шийтгэж байх, ялангуяа эх хүн, гэдэг үүднээс энэрэнгүй хандаж байх, хорих байгууллагын зүгээс хүүмүүжил спорт, урлагийн арга хэмжээг дэмжиж байнга явуулж байх нь зүйтэй , хорих ангийн ахуй дэглэмийг сайжруулах хэрэгтэй гэж дийлэнх хувь нь хариулсан байна.

Түүнчлэн дээрх ялтнуудын зүгээс хорих ял эдлэж суллагдаж гараад нийгэмд ажиллаж, амьдрах дур сонирхолтой, ахин гэмт хэрэг үйлдэхгүй гэж үздэг хорих ялаас залхаж цөхөрсөн, тэднийг хорих ял эдлээд суллагдаад гарахад нийгэм, хүлээн авахгүй байх гэсэн айдастай байдаг нь судалгаагаар тогтоогдож байна.

Ярилцлагын аргаар цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн байдал, товч дүгнэлт

Хорих ялын үр нөлөө судалгааны ажлын хэсэгт орж ажиллаж байгаа УЕПГ-ын ХЯЭАХТХ-ийн хяналтын прокурор Ц.Батцэнгэл, ХБНГУ-ын Макс Планкийн институтын докторант Х.Эрдэм-Ундрах, ХЗҮТ-ийн КСС-ын ЭШДА Д.Батхуяг нар хорих 407 дугаар ангид ял эдэлж буй 29 ялтан, мөн "Буян" ХХК-д гэрээгээр ажиллаж буй хорих 407 дугаар ангийн 29 ялтан, нийт 58 эмэгтэй ялтантай судалгааны ажилд ач холбогдолтой мэдээлэл цуглуулах зорилгоор ярилцлага явуулав.

Ярилцлагыг өдрийн цагаар хорих 407 дугаар анги болон Буян ХХК-ийн байранд ялтан тус бүртэй ганцаарчлан уулзаж явуулсан болно. Ярилцлаганд орох ялтнуудыг үйлдсэн хэргийн зүйл анги, хорих ял эдэлсэн хугацаанаас нь хамааруулан түүвэрлэн сонгож авсан болно. Ярилцлаганд орсон ялтнуудын:



Түүнчлэн:

- ЭХ-ийн 146.3 дах хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж 1 ялтан буюу 1.7 хувь нь,
- 113.3-р /хүн худалдах, худалдан авах/ хэсэгт зааснаар 1 ялтан буюу 1.7 хувь
- 124.2 дахь /биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, зохион байгуулах/ хэсэгт заагдсанаар 1 ялтан буюу 1.7 хувь нь,
- ЭХ-ийн 181.2 /танхайрах/, 146.3 / бусдын эд хөрөнгийг булаах/, 261.1-р зүйлүүдэд /хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх, цагдан хорих байр, хорих ангиас оргон зайлах/ заагдсан зүйл ангиудаар давхар зүйлчлэгдсэн 1 ялтан буюу 1.7 хувь нь тус тус хорих ялаар шийтгэгдсэн байлаа.

Ярилцлаганд оролцогч ялтнуудын боловсролын байдлыг авч үзвэл:

- дээд боловсролтой 12 буюу 20.6 хувь,
- тусгай дунд боловсролтой 8 буюу 13.7 хувь,
- бүрэн дунд боловсролтой 16 буюу 27.5 хувь,
- бүрэн бус дунд боловсролтой 18 буюу 31.0 хувь,
- боловсролгүй 4 буюу 6.8 хувь тус тус байв.



Судалгаагаар өмч хөрөнгө ашиглах, хулгайлах, залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн олонх нь амьдарлын хувьд тарчиг өлөн зэлмүүн нөхцөлд амьдрагсад байна. Өнөөгийн нөхцөлд олонх үйлдвэр албан газарт эмэгтэйчүүдийн ажлын нөхцөл, хөдөлмөр хамгаалалд тун тааруу анхаарал тавьж байгаа юм. Энэ байдал нь эмэгтэйчүүдийг тэсвэр тэвчээр алдагдахад хүргээд зогсохгүй "буруу зам"-аар явах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Дээрх төрлийн гэмт хэрэг үйлдсэн ялтнууд". Иргэний хэрэг байсан. Тухайн үедээ жаахан алдаа гаргаад, хойд хормойгоороо урд хормойгоо нөхөх гээд ...Би өөрөө хохирогч, найз нөхөддөө итгэсэн учраас... ар гэрийн байдал тааруу амьдрах гэж хэдэн хүүхдээ тэжээх гэж зүтгэж байгаад гэмт хэрэг үйлдсэн, надаас өөр манай гэрийнхнийг тэжээх хүн байхгүй. Түүнчлэн амьдарлын боломж тааруу, сэтгэл санааны дарамт, мөнгөний гачаалыг тэсвэрлэж чадаагүй учраас хулгай хийсэн гэж 145.145.4 заасан хэсгээр 10 жил хорих ял шийтгүүлсэн 350 мянган төгрөгний хохирол учруулсан ялтан Ч ярьж байснаас харж болох юм.

Түүнчлэн хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд ихэвчлэн нөхөр, болон танил хүн тэдгээрийн хүчирхийлэлд хүндээр дарлагдаж байсны улмаас болон , нийгэмд газар авсан хэт их архидалтаас , хардалтаас шалтгаалж бусдын амийг хөнөөсөн ар гэрийн дарамт шахалт үүнд нөлөөлсөн байх юм. Зөвхөн 2006 оны 05 сарын байдлаар л гэхэд улсын хэмжээнд нийт 335 эмэгтэй жирийн болон чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байсаны 107 буюу 31.9 хувь нь бусдыг санаатай алсан ба үүнээс 61 эмэгтэй ялтан нь нөхөр буюу хамтран амьдрагчийнхаа амь насыг хохироосон, 12 эмэгтэй нь нөхөр болон хамтран амьдрагчийнхаа биед хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн байжээ. Дээрх эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг тодруулахад 86 % нь эр нөхрийн байнгын дарамт, шахалт, айлган сүрдүүлэлт, байнгын архидалт, үндэслэлгүй хардалт, зодуур, нүдүүр хэрээс хэтэрч тэвчихийн аргагүй байдалд орсноос гэмт хэрэг үйлдсэн гэж байсан байна.

Эхний зорилго болох оногдуулсан ял, гэм буруугийн хэмжээ хоорондоо тохирч байгаа эсэхийг тогтоохоор ярилцлага явуулахад оролцогч нийт 58 ялтны

- 52 буюу 89.6 хувь нь оноосон ял гэм буруу хоорондоо тохироогүй, ял хүндэдсэн
- 5 ялтан буюу 8.6 хувь нь оноосон ял үйлдсэн хэрэгт тохирсон,
- 1 ялтан буюу 1.7 хувь нь оноосон ял шийтгэл миний үйлдсэн хэрэгт хөнгөдсөн гэж байлаа.



Үйлдсэн хэрэг, оноосон ял тохирсон гэсэн 5 ялтны 3 нь бусдыг санаатай алах гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байна. Үүнээс 1 нь хүндрүүлэх нөхцөл байдалтай бусдыг санаатай алах гэмт хэрэгт 15 жил чанга дэглэмтэй хорих ангид хоригдох, нөгөө хоёр нь 10 жилийн хорих ялаар тус тус шийтгүүлсэн байна, 1 ялтан ЭХ-ийн 113.3-р зүйлд зааснаар буюу хүн худалдах, хүн худалдан авах гэмт хэрэгт 11 жил чанга дэглэмтэй хорих ангид хоригдох, 1 ялтан ЭХ-ийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар буюу бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт жирийн дэглэмтэй хорих ангид 2.5 жил хоригдох ялаар шийтгүүлжээ.

Надад оногдуулсан хорих ял миний үйлдсэн хэрэгт хөнгөдсөн гэсэн 1 ялтан 1996 оны ЭХ-ийн 86 дугаар зүйлийн 86.2-т /бусдыг санаатай алах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй/ заагдсанаар 22 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна, энэ ялтан "би хүний сайхан үрийг алчихаад ямар нүүрээрээ надад өгсөн ял ихэдсэн байна гэж ярихав дээ, надад оноосон ял миний үйлдсэн хэрэгт багадаж байгаа" гэж ярьж байлаа.

Үлдэх хэсэг буюу ярилцлаганд оролцсон 58 ялтны 52 нь буюу 89.6 хувь нь тэдэнд оноосон хорих ял, гэм буруугийн хэмжээ хоорондоо тохироогүй, оноосон ял гэм буруугийн хэмжээнээс хамаагүй өндөр байна гэж байв, ялангуяа Эрүүгийн хуулийн 148.3-р зүйлд /бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах/ зааснаар шийтгэгдсэн ялтнууд бүгд тэдэнд шүүхээс оногдуулсан ял ихэдсэн, зарим нэг нь иргэний хэрэгт хорих ял оногдуулсан гэж ярьж байлаа, мөн олон ялтнууд намайг гэмт хэрэг үйлдээгүй байхад хилсээр хорьсон гэж үздэг юм байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Ярилцлагын явцад ярилцлаганд оролцсон ялтан эмэгтэйчүүд өөрсдийнхөө бусдад, нийгэмд учруулсан хор хохирлыг сайтар ойлгоогүй, эсхүл биеэ өмөөрөх, эсвэл өрөвдүүлэх, зарим нь худлаа ярих хандлагатай байсан нь үйлдсэн гэмт хэрэг /ялангуяа залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн/ болон эмэгтэй хүний бие сэтгэл зүйн онцлогтой холбоотой байж болох юм. Жишээ нь: Г гэгч эмэгтэй

"ганцхан гар утас, 10 гаруйхан мянган төгрөг хулгайлсны төлөө ийм олон жилийн хорих ял оноосон" гэхчилэн ярьж байсан юм.

- Хүн амины хэрэгтэй хүмүүсийн хувьд маш ихээр гэмшиж буй ч "ингэж олон жил хорьсноор хүний ааш араншин улам эвдэрч, догшин болж буцаад нийгэмшихэд бэрхшээлтэй тулгардаг", Мөн хүн амины хэрэгтэй хүмүүсийн дунд ахин ийм гэмт хэрэг хийх санаа бодол мэдээж байхгүй, ийм аймшигтай хэргийг хүн тэр бүр дахиж хийдэггүйг харгалзаад хорих ялын хэмжээ дуусахаас өмнө магадлангаар оруулж сулладаг нөхцлийг бий болгох талаар судлах хэрэгтэй юм.
- Нөхрийнхөө амь насыг хөнөөсний улмаас ял эдэлж байгаа эмэгтэй ялтан болох Н хэлэхдээ "...нөхрийн дарамт хүчирхийлэл дор 20 жил байсан үүнийг шүүх харгалзаж үзээгүй" гэж ярьж байсан бөгөөд үүнийг хүний амины эсрэг гэмт хэрэг үйлдсэн дийлэнх эмэгтэй ялтнууд гэр бүлийн хүчирхийлэл, шахалтыг гэмт хэрэг үйлдэх болсон гол шалтгаанаа гэж ярьж байсан. Гэхдээ нийгмийн хар тал болох архи хэтрүүлэн хэрэглэх, ядуурал, ухамсрын доройтол зэрэг байдлаас шалтгаалан хүний амь нас хөнөөсөн ч байсан юм. Тэрээр " Архи уугаад л байж байсан. Нэг мэдсэн хүн ийм хэрэг гарсан байсан.Тасарсан байсан.Үнэхээр хүн алсан гэдэгтээ одоо болтол итгэхгүй байна.Би энэ хэргийг үйлдээгүй." гэж байлаа.
- "...Төр олон жил үр ашиггүй тэжээж зардал гаргаж байна, эмэгтэй хүний хувьд онцлогийг нь харгалзах хэрэгтэй, ядаж ажлаар хангаж өгвөл цаг хурдан өнгөрнө, үр бүтээлтэй өнгөрнө, бас хүн ажил хийж сурна, хүмүүжинэ, учруулсан хохирлоо ажил хийж хагасыг нь ч гэсэн барагдуулна" олонх хоригдлууд гэх мэтээр ярьж байсан.

Жишээ авья л даа : 20 настай ялтан Д нь 2001 онд хулгайн гэмт хэрэг үйлдэж 3 жилийн хорих ялаар шийтгүүлж, ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан байна. 2004 онд хулгайн гэмт хэрэг давтан үйлдсэн тул МУЭХ-ийн 145-р зүйлийн 145.4-өөр 10 жилийн хорих ялаар шийтгүүлжээ. Энэ нь хуульд нийцэж байгаа боловч 62300 төгрөгний хохирол бусдад учруулсан энэ эмэгтэй 10 жил хорих ял эдлэхдээ төрөөс дулаан хувцас хунар, хоол , орон байр, гэрэл дулаан , харуул хамгаалалтын, сургалтын гэхчилэн жилд 605200 төгрөгний, 10 жил ял эдлэхэд 6 сая 5210 зардал гаргаж ял эдлэх юм. Хорих ял шийтгүүлээд хорих ангид ирсэн ялтны сэтгэл зүйд нэгэнт ял эдэлж байгаа учраас төлбөр хамаагүй гэсэн бичигдээгүй хууль үйлчилдэг. Тэд зөвхөн хорих ангийн дотоод журмыг сайн биелүүлж яаж ийгээд ялаас чөлөөлөгдөхийг чухалчилдаг нь харагдаж байсан.

Та ЭХ-ийн талаар ямар бодолтой явдаг вэ, хуульд заасан ялын хэмжээ их байна уу, эсвэл бага байна уу? гэсэн асуултанд

Эрилцлагад оролцсон нийт 47 ялтны нэгээс бусад нь хорих ялын хэмжээ маш өндөр байна, эмэгтэй хүнийг ингэж олон жилээр хорих шаардлагагүй гэж үзэцгээж байв. Мөн залилангийн хэрэгт хохирол нь 5.000.000 сая ч байсан 1 тэрбум ч байсан ялгаагүй ижил хугацаагаар хоригдож байна. "Хулгайн хэрэгт ч ялгаагүй хохирол харгалзахгүйгээр давтан гэдгээр өндөр

ял оноож байна" гэж байлаа. Зарим ялтан "Эмэгтэй хүнийг дээд тал нь 2-3 жил хориход хангалттай, манай ЭХ-ийн ялын бодлого маш хатуу чанга байна, хүнд гэм бурууд нь тохирсон ял оногдуулж чадахгүй байна, ямар ч эмэгтэй хүн шоронд 2-3 жил суухад л засарна, үүнээс илүү суух юм бол эвдрэх болно" гэж ярьж байсан юм. 14 жил хорих ял эдэлж буй ялтан Ж ярихдаа "Шоронд удаан сууснаар засарна гэж бол байхгүй ээ. Би энд ирээд 14 жил болж байна. Жил хагасын дараа суллагдана. Олон жил хорих ял эдэлж байгаа хүн амьдрах итгэл буурч сүүлдээ цөхөрдөг" гэж ярьсаныг анхаармаар мэт санагдана.

Цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүх байгууллагуудад ажилладаг хүмүүс хэрэгт холбогдсон хүмүүст яаж ханддаг вэ, тэд хэргийн үнэн зөвийг олж чаддаг эсэх, тухайлбал таны хувьд танд өгсөн ял, таны үйлдсэн хэрэгт чинь тохирч байна уу? гэсэн асуултад дээрх байгууллагад ажилладаг хүмүүс хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж чаддаг гэж цөөн тооны ялтан л хариулж байхад ихэнх нь энэ хүмүүс ажлаа хийж чаддаггүй, хийгээгүй хэрэгт хүн ялладаг, өөрсдөөсөө хурдан холдуулахын тулд хилсээр тасалдаг, тэр хүн хэрэг хийсэн үгүйг хангалттай сайн нягталж шалгадаггүй гэж байв. Ярилцлаганд оролцсон 47 ялтнаас дээр дурдсан хүн амины хэрэгтэй нэг л ялтан миний ял үйлдсэн хэрэгт тохирсон гэж байсан бол бусад нь ял, үйлдсэн хэрэг тохирохгүй байна, буруу зүйлчилж өндөр ял оноосон, хэрэг хийгээгүй байхад хилсээр ял оноосон, 145.4-өөр шийтгэгдсэн ялтнууд хохиролгүй байхад эсвэл маш бага хохиролтой тухайлбал "нэг муу эвдэрхий гар утасны" төлөө давтан гэдгээр өндөр ял оноосон гэх мэтээр ярьж байв.

Зарим ялтны хувьд хууль, эрх зүйн мэдлэг дутуугаас өөрийнхөө гэм буруугүйг эсхүл хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлаа нотлож чадаагүй, өмгөөлөгч энэ талаар хууль зүйн зөвлөгөө өгөөгүй, мөнгө аваад оронд нь хангалттай эрх зүйн туслалцаа үзүүлээгүй, өмгөөлөгч шүүх хурал дээр л нэг ирж харагдаад өнгөрсөн, эсхүл шүүх, цагдаагийн байгууллага хэргийг үнэн мөнөөр нь шийдэхэд өгнө гэж итгэсэндээ танил талаасаа тусламж хайгаагүй гэх зэргээр тайлбарлаж байлаа. Төв аймгаас залилангийн хэргээр таслагдсан нэгэн ялтан эмэгтэй шүүх хурал дээр гэм буруугүйгээ нотлох гэж үг хэлэхээр "олон юм яриад, яах аргагүй залилагч" гэж загнуулах, үг ч хэлэх эрхгүйдээ бухимдаад уйлахаар "баашилахаа боль" гэх , огт үг дуугарахгүй зогсохоор "их зантай" гэх зэргээр шүүгчид загнуулсанаа ярьсан юм.

Нэг талаас хоригдож залхсан хүмүүсийн үг ч, нөгөө талаас хууль тогтоогчийн зүгээс хорих ял үнэхээр урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх, цээрлүүлэх зорилгоо хангаж чадаж буй эсэхийг, зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулах нь илүү ач холбогдолтой эсэхийг эргэн харах, хорих ялын хэмжээний хувьд гэмт хэрэгтний хувийн байдал, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн нөхцөл байдал, учруулсан гэм хор, хохирлын хэмжээг харгалзан ялгавартай байдлаар тогтоох тал дээр анхаарах шаардлагатай байна.

Ярилцлагын хоёрдугаар зорилго болох хорих ял хувь хүнд ямар нөлөө үзүүлж байгаа болохыг тогтоохоор ярилцахад

- Хорих ял надад сайн нөлөө үзүүлж байгаа би засарч байна гэх ялтан 18 буюу 31.0 хувь байлаа.
- Хорих ял надад ямар ч нөлөө үзүүлэхгүй байна гэх ялтан 7 буюу 12.0 хувь
- Биеийн эрүүл мэнд сэтгэл санаагаар хохирч байна гэх 4 буюу 6.8 хувь
- Улам эвдэрч муу санаатай болж байна гэх 19 буюу 32.7 хувь,
- Залхаж байна, ар гэрийн хүмүүс үр хүүхэд давхар яллагдаж байна гэх ялтан 10 буюу 17.2 хувь байлаа.



Ял эдэлж байгаа эмэгтэй хүмүүсийн хувьд тэдний хэрэгцээ, ашиг сонирхол зэрэг нь тэдгээр эмэгтэйчүүдийн гэр бүл, хамт олон, нийгэмд эзэлж байсан байр суурьтай ихэвчлэн холбоотой байдаг. Эдгээр эмэгтэй ялтнуудын итгэл үнэмшил, хорих газар биеэ авч яваа байдал зэрэг нь тэдний гэр бүл, амьдралынх нь асуудалтай нягт холбоотой байдаг байна. Гэр бүл гэдэг эмэгтэй хүний хувьд гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэхээс сэргийлж байдаг гол үндэс, нөхцөл нь юм. Харин гэр бүл доторх зөрчилтэй байдал, асуудлууд нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэхэд хүргэдэг нэг нөхцөл нь болдог.

Гэр бүл, үр хүүхэдтэй эмэгтэйчүүд гэр бүл, үр хүүхэдгүй эмэгтэйчүүдийг бодвол эрх чөлөөгөө хасуулж ял эдлэх болсон явдлаа илүү хүндээр тусгаж авдаг. Энэ тохиолдолд ийм эмэгтэйчүүдийн нийгмийн холбоо харилцааг нь таслахгүй байх нь маш чухал юм, тухайлбал гэр бүл, хамаатан садны хүмүүстэй нь байнга уулзуулж байх, гэр бүл, ах дүү нараас нь илгээмж, мөнгөн шилжүүлэг зэргийг байнга авахуулдаг байх зэргээр. Эмэгтэй хүнийг гэр бүлээс нь ангид ойлгож болохгүй, гэр бүлээсээ салсан эмэгтэй хүн өөрийгөө зовлон шаналалд учруулдаг байна. Хорих ял эдлэх болсон эмэгтэй хүний хувьд хамгийн чухал, хамгийн хэцүү байдал нь өөрийнхөө гэр бүлийг алдахгүй байх, өөрийн үр хүүхэд, эцэг эх, эр нөхөртөө хүний хүн болохгүй байх явдал, хэрэв ийм явдал тохиолдчихсон бол энэ хүнд хэцүү байдлыг даван туулах явдал юм.

Таны бодлоор ямар зан араншинтай, ямар амьдралтай хүмүүс ихэвчлэн хэрэгт холбогдож байна вэ? гэсэн асуултанд

Асуулганд оролцогч ялтан нарын хулгай, дээрэм, танхай, булаалтын хэрэгт амьдрал ядуу, боловсрол мэргэжилгүй, танхай балмад зан авиртай, хөнгөн аргаар мөнгө олох гэсэн, орон гэргүй, шуналтай хүмүүс холбогдож байхад хүн амины гэмт хэрэгт ял шийтгэгдсэн эмэгтэй хүмүүсийн хувьд ихэнх нь олон жил гэр бүлийн хүчирхийлэлд байсан, цочмог ууртай, архи уудаг хүмүүс нийлдэг, нөхөрлөдөг байсан, залилангийн хэрэгт боловсрол харьцангуй өндөр, шуналтай, амар хялбар аргаар амьдрах гэсэн, хүнд тус болох, эсхүл бусдын нэгэн адил бизнес хийх гэзэг туршлага, мэдлэг дутсанаасаа болж хэрэгт холбогдсон хүмүүс ирж байна гэсэн хариултууд зонхилж байв.

Ялтнуудын зүгээс гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааны талаар дурдахдаа амьжиргааны эх үүсвэргүйн улмаас, ажил төрөлгүй байдал, хөнгөн аргаар амьдрах гэсэн бодол, шуналтай, орон гэргүй, өрөнд орсон, бусдад дарамтлуулсан, түр зуурын болчимгүй авираасаа болж хүмүүс ихэвчлэн хэрэг үйлддэг гэж эмэгтэй ялтнууд үзэж байв.

Таны бодлоор ямар хэрэг үйлдсэн хүмүүсийг хорьж шийтгэдэг байх хэрэгтэй юу? гэсэн асуултад

Нийт ярилцлаганд орсон дийлэнх ялтан хүнд, онц хүнд хэрэг үйлдсэн хүмүүсийг одоогийнхоос бага хугацаагаар хорьж байх хэрэгтэй гэж үзэж байв. Тодорхой гэмт хэрэг үйлдэж бусдад хохирол учруулсан тул зохих шийтгэл хүлээх нь зөв ч хэтэрхий урт хугацаагаар хорих нь тухайн хүний засрал хүмүүжил, дахин гэмт хэрэг хийхгүй байх баталгаа болохгүй бөгөөд гэмт хэрэгтнүүдэд хэрэг хийсэн тухай бүрт нь тохирох ялыг нь оноох нь чухал гэж судлаачын зүгээс үзэж байна.

Хохирлын хэмжээг огт харгалзалгүй, хэдэн удаа хулгай хийснээр нь олон жилийн хорих ял оноох нь оновчгүй байна. Тухайлбал Хэнтий аймгийн харьяат Ариунцэцэгтэй адилтгах хэргээр 10 жилийн ялтай хүмүүс маш их байна. Хөөцөлдөх хүнтэй, хэл амтай нь ингээд суллагдаад гарч байна. Гэтэл тийм хүнгүй бол энд ялын хугацаагаа дуустал л сууна. Энэ нь төр иргэддээ шударга бус хандаж буйгийн тод жишээ гэж хэлж болно.

Хорих ялын дээд талын хугацаа нь хэдэн жил байвал тохиромжтой гэж та үзэж байна вэ гэсэн асуултанд

Ихэнх ялтнууд олон жил хориод үр дүн байхгүй, дээд тал нь 10 жил гэж байхад, 5 жил байхад хангалттай гэж үзэх ялтнууд цөөнгүй байв. Ярилцлагад оролцогчид эмэгтэй хүнийг 2-3 жил хориход л өөрийн бүх бурууг ойлгож засарч хүмүүжиж чадна. Олон жил хорьсноор илүү засарч хүмүүжихгүй, төрд ч, хохирогчид ч, хоригдож буй хүнд, тэдгээрийн ар гэрийнхэнд ямар ч ашиггүй гэж байсан юм.

Төрөөс гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ял оноосноор хэнд ямар өөрчлөлт гарах вэ, ингэж хорих ял оноох нь хэн нэгэн хүнд ашигтай ч юм уу эсвэл хохиролтой байх уу?гэдгийг ярилцлагаар судлахад

Хүнийг хорьсноор тухайн хүн улам эвдэрч байна, олон жил хоригдоод ирэхээр хүмүүс улам л цөхөрч шантарч залхаж байна, хүнийг хорьсноор хэн нэгэнд ашиг байхгүй, харин ч хоригдож байгаа хүмүүст болон тэдний ар гэрт дарамт учруулах болно, төрд ч гэсэн тэр олон хүнийг зүгээр тэжээх нь дарамт л болно гэж гэж ярьцгааж байв. "Гэмт хэрэгтний зүгээс хоригдоогүй бол бусдад учруулсан хохирлоо нөхөн төлчих байсан, төрийн зүгээс хорих ял оноосноороо хохирол төлөх боломжийг үгүй болгосон . Өөрөөр хэлбэл хохирогчийг давхар хохироож байна. Эмэгтэй хүнийг хорьсноор түүний ард үлдэж байгаа ар гэр, үр хүүхдүүд нь давхар ял эдэлдэг, хүүхдүүд хараа хяналтгүй болж буруу замд ихээр ордог" гэж ярьж байлаа.

Хорих ял эдлэж буй хүмүүсийн хувьд амьдралын утга учир, өөрийгөө болон бусдыг үнэлэх үнэлэмж, сэтгэл зүйн үнэт зүйлд хандах хандлага нь эрс өөрчлөгдсөн байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна. Олон жил ял эдэлсэн эмэгтэй хоригдлуудын дунд ялангуяа гутранги үзэлтэй, амьдралд, хүнд үл итгэсэн байдал цөөнгүй харагдаж байна. Гурав хүртэлх жил ял эдлээд байгаа ялтнуудын ихэнх нь, мөн хувь хүний боловсрол, ухамсрын түвшин, урьд нь амьдарч байсан амьдралын түвшин, хэв маяг зэргээс шалтгаалж зарим ялтнуудын хувьд маш ихээр гэмшиж харууссан, ажил хөдөлмөр сайн хийж, "шагналын хоног" авч нэг өдрийн өмнө ч гэсэн "эндээс" гарч, үр хүүхэд, гэр бүлдээ очих, ердийн амьдралаараа амьдрах хүсэлтэйгээ илэрхийлж байлаа. Эмэгтэй хоригдлуудтай ярилцлага хийх явцад ажиглагдсан нийтлэг нэг зүйл нь эх хүнийхээ хувьд өөрийн санаатай, санаагүй хийсэн үйлдлийнхээ төлөө үр хүүхдээ давхар шийтгэж буйдаа харууссан, тэднийхээ одоогийн болон ирээдүйн амьдралынх нь төлөө санаа зовсон байдал байсан.

Хорих газар ял эдэлж байх хугацаандаа эргэлт авдаггүй эмэгтэйчүүдэд ял эдлэх хугацаанд гэр бүл нь салсан эмэгтэйчүүд олноор ордог байх юм. Ял эдлэх хугацаандаа гэр бүл, ойр дотныхоо хүмүүстэй байнгын холбоотой байсан эмэгтэй ялтнууд хорихоос суллагдсаны дараа эргээд нийгэмшихдээ амархан байдаг байна.

Ярилцлагын гурав дахь зорилго болох хорих ял эдлүүлэх байгууллага хуульд заасан хорих ялын зорилгыг биелүүлэхийн төлөө яаж ажиллаж байгаа болохыг тогтоохоор ярилцахад оролцогч ялтнуудын 19 буюу 32.7 хувь нь хорих ангиас зохион явуулдаг арга хэмжээ үр дүн муутай байдаг. 9 ялтан буюу 15.5 хувь нь үр дүн сайтай байдаг. 17 ялтан буюу 29.3 хувь нь зарим нааштай үр дүн гардаг. 13 ялтан буюу 22.4 хувь нь мэдэхгүй гэж ярьж байв. Ярилцлаганд оролцсон ялтнууд хорих ангийн зүгээс төрөл бүрийн арга хэмжээ авагддаг, гадны шашны байгууллагын хүмүүс ирж яриа таниулга, сургалт зохион явуулдаг тухайлбал Есүс Христийн шашны, мөн бясалгалын дасгал, ярилцлага зохион явуулдаг, ийм ярилцлага маш үр дүнтэй болдог, ангийн зүгээс сургалт хүмүүжлийн ажлууд тухайлбал тэмцээн уралдаан, урлагийн үзлэг гэх мэт арга хэмжээнүүдийг зохион явуулдаг, иймэрхүү тэмцээнд оролцсон хүмүүсийн сэтгэл санаа хэсэгтээ л өөдрөг байдаг гэж ярьж байв.

Ялтнуудын хэлсэн зүйл ийнхүү ялгаатай байгаа нь тэдгээрийн насны онцлог, боловсролын болон хувь хүний хүмүүжлийн онцлог, шоронд хоригдсон хугацаа, дээрх арга хэмжээний ач холбогдлыг ойлгох, хүлээн авах чадвар, хүсэл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Ярилцлагын 3 дахь зорилго болох хорих ял эдлүүлэх байгууллага хуульд заасан хорих ялын зорилгыг биелүүлэхийн төлөө яаж ажиллаж байгаа талаар ялтнуудтай доорх асуултын хүрээнд ярилцав.

Төрөөс хорих ялыг яг ямар зорилготой оноодог гэж та бодож байна вэ?гэсэн асуултанд

Энэ асуултанд ихэнх эмэгтэйчүүд залхааж цээрлүүлэх, хүмүүжүүлэх зорилготой хорьдог гэж байв, мөн цөөнгүй тооны ялтнууд энэ асуултанд мэдэхгүй гэж хариулж байлаа Эмэгтэй ялтнууд эрэгтэй ялтнуудыг бодвол нийгмээс тусгаарлагдах болсон байдлаа илүү хүндээр тусгаж авдаг. Тэдний сэтгэл зүйд маш их өөрчлөлт гарч орчин тойрныхоо сөрөг нөлөөг эмзэгээр хүлээн авах, уур уцаартай болох, уйланхай болох зэргээр өөрчлөгддөг. Эмэгтэй ялтныг хүмүүжүүлэхийн тулд түүний үйлдсэн гэмт хэргийн шинж байдал, ялтны зан авир, өөрийнх нь хувийн онцлог байдал зэргийг нь олон талаас гүн гүнзгий судлаж үр дүнд нь тулгуурлан хүмүүжлийн ажлаа явуулах шаардлагатай" юм.

Ял шийтгэлийн цээрлүүлэх зорилгын хувьд санал асуулгад оролцсон нийт 119 ялтнуудаас:

- 73 буюу 61.3 хувь нь цээрлүүлэх зорилго хангагдаж байна,
- 15 буюу 12.6 хувь нь хангагдахгүй байна
- 8 буюу 6.7 хувь нь мэдэхгүй
- 8 буюу 6.7 хувь нь хагас дутуу хангаж байна гэж хариулжээ.

Үүнээс үзэхэд хорих ялын цээрлүүлэх зорилго нь хорих ялын хүмүүжүүлэх болон урьдчилан сэргийлэх зорилгуудыг бодвол илүү хангагдаж байна гэж үзэж болохоор байна.

Төр засаг, холбогдох байгууллагуудын зүгээс ямар арга хэмжээ авбал хорих ялын үр нөлөө дээшилнэ гэж боддог вэ? гэсэн асуултад

Асуулгад оролцогч ялтнууд хорих хугацаанд аль болох нийгэмшүүлэх талын сургалт зохион байгуулж байх, одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн хорих дээр урлаг, спортын болон шашны тухайлбал Христийн сургалтууд их зохиогддог, мөн бясалгалын сургалтууд зохион байгуулагддаг нь үр дүнтэй байдаг. Бясалгалын сургалтад сууснаараа хүмүүс сэтгэл санаа нь тайвшрах үр дүнтэй байдаг гэж зарим нь ярьцгааж байв.

Цөөн тооны ялтнууд сургалт хүмүүжлийн ажлууд төдийлөн тогтмол зохион байгуулагдаад байдаггүй гэж байсан, ангийн алба хаагчид заримдаа яриа хийдэг, зохиогддог ажлуудаас нь төдийлөн үр дүн гардаггүй, ялтнуудаас өөрсдөөс нь их шалтгаалдаг гэж байв. "Буян" ХХК-д ажиллаж байгаа ялтнууд сургалт хүмүүжлийн ажилд хамрагдаж чаддаггүй гэдгээ хэлж байсан болно. Ярилцлаганд оролцсон ялтнууд хууль эрх зүйн талаар мэдлэг муутай байдаг, энэ талын сургалт төдийлөн зохион байгуулагддаггүйг хэлж байв.

Ялтнууд өөрсдийн өргөдөл, хүсэлтээ хаана, ямар албан тушаалтанд гаргах талаар ойлголт муу байв.

Ихэнх ялтнууд мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд бидэнд эрх үүргийг сайн тайлбарлаж ойлгуулж өгдөггүй, өмгөөлөгч нар ч үүнд огт анхаардаггүй, зарим ялтнуудын зүгээс өмгөөлөгчийг хуулийн зөвшөөрөлтэй луйварчид гэж хэлэх хүмүүс ч байв. Олон ялтан эмэгтэй хүнийг ингэж олон жил хорьсноос цөөн жил хатуу чанга дэглэмд, байнгын ажил хөдөлмөртэй байлгавал засрах, гэмших, цээрлэл амсах тал дээр илүү ач холбогдолтой гэдгээ хэлж байсан. Олон жил хоригдсоны дараа нийгэмших, энгийн иргэдийн нэгэн адилаар амьдрахад улам л төвөгтэй болдог, ажил мэргэжлээсээ хэт хөндийрөх, найз нөхөд цөөрөх, гэр бүлийн амьдрал бүр ч хүнд хэцүү байдалтай болох зэрэг нь шоронд орсон эхний өдрөөс л сэтгэл зүйн хүнд дарамт болдог тухай ярих хүн цөөнгүй байлаа.

Хорих байгууллагууд ялтныг хорих ялаа эдлэх хэвийн нөхцлийг хангаж чадаж байгаа эсэх талаар ярилцлагад оролцогч нийт ялтнуудын ихэнх хувь нь хорих анги аль болох нөхцөл боломжийг дээшлүүлэх тал дээр өөрийн хүч анхаарлаа хандуулдаг боловч дан өөрсдийн бололцоогоор үүнийг биелүүлэх боломжгүй, үүнд төр засгаас хөрөнгө мөнгөний асуудал дээр нь анхаарах хэрэгтэй гэж байв. Ялангуяа эмэгтэй хүний онцлог байдлыг харгалзан үзэж зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэглэл гэх мэт зүйлд мөнгө төсөвлөдөг баймаар байна. Ялтан бүр ар гэрээсээ эргэлт, мөнгөн тусламж авах боломжгүй, улсын хэмжээнд нэг л эмэгтэйчүүдийн хорих анги байдгаас бүх аймаг, сумдаас ялтан ирдэг, газрын хол, амьдралын бололцоо, ар гэрт үлдэгсэдийн байдал янз бүр тул ар гэрээсээ тэр бүр тусламж авах бололцоогүй хоригдлууд их бий.

Дээрх байдлуудаас үзэхэд хорих байгууллага хорих ялын зорилгыг хангахын тулд төрөл бүрийн арга хэмжээг зохион явуулдаг боловч төдийлөн наштай үр дүн гардаггүй, зохион явуулдаг арга хэмжээ нь тогтмол байж чаддаггүй, хуучирсан, нэгэн хэвийн байдалтай явагддаг, ял эдлэх нөхцөлийг сайжруулахын тулд өөрийн боломжийн хирээр анхаардаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Энэ бүгдээс дүгнэж үзэхэд хорих ял нь өөрийн хүмүүжүүлэх, цээрлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоо биелүүлэхэд төдийлөн сайн нөлөө үзүүлж чадахгүй байна гэж дүгнэв. Ялтнууд хорих ялаас залхсан, зөвхөн шоронгоос л хурдан суллагдах хүсэлтэй, ажил хийж шагналын хоног авахын төлөө л хүмүүс байлаа.

Судалгааны эцсийн дүгнэлт, санал, зөвлөмж.
Нэг . Хууль тогтоомжийн хүрээнд:

2002 оны Эрүүгийн хууль батлагдан гарсанаас хойш 5 жилийн хугацаа өнгөрөөд байгаа бөгөөд энэхүү хугацаанд улсын хэмжээнд дунджаар өдөр тутам 6648 ялтан ял эдэлж, хорих ялтны тоо хурдацтай өсөж байгаа нь анхаарал татаж байна. Нэг жилийн байдлаар л гэхэд нийт 6000 ялтан ял эдэлж байна. 2000 онд онцгой дэглэмтэй хорих ангид дунджаар 126 ялтан ял эдэлж байсан бол 2006 онд 496 болтлоо нэмэгдсэн байна. Өршөөлийн тухай хууль батлагдан гарсанаар энэ тоо буурсан боловч ахин өсөх хандлагатай байгаа юм. Үүнээс дүгнэхэд 2002 оны энэхүү Эрүүгийн хууль нь хуульд зааснаас хөнгөн ял шүүхээс оногдуулах боломжийг үндсэндээ хаасан, хорих ял оногдуулах нь давамгайлсан, ял шийтгэлийн бодлогын хувьд хэт хатуу хууль болсон гэж үзэж болохоор байна.

Нэн ялангуяа бусдын өмчийн эсрэг гэмт хэргүүд, танхайрах зэрэг эрүүгийн хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд ихэвчлэн 8 ба түүнээс дээш жилийн хорих ял оноохоор заасан байгаа нь шоронд ял эдэлж байгаа ялтнуудын тоог ихэсгэх, улмаар хорих ялын үр нөлөөг багасгахад хүргэж болзошгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл шинэ Эрүүгийн хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнээс хойш жилдээ дунджаар 12000 ялтан ял эдэлж байна. Иймээс эрүүгийн хуулийн ялын бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт хийж хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах заалтыг оруулж өгөх /1996 оны Эрүүгийн хуулийн 39-р зүйл "Хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах, 50-р зүйл" Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих гэх мэт заалтууд байсан юм./ шаардлагыг бий болгож байна.

Хоёр.Санал асуулга, ярилцлагын хүрээнд:

"Хорих ялын үр нөлөө" судалгааны ажлын явцад цуглуулсан мэдээлэлд дүгнэлт хийхэд хорих 407 дугаар ангид хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдэд хорих ял тодийлөн сайнаар нөлөөлөхгүй байна. Тус ангид 2001 оноос 2007 оны нэгдүгээр улирал хүртэлх хугацаанд нийт 1147 ялтан хорих ял эдэлжээ, үүнээс 524 ялтан буюу 45.6 хувь нь 2-3 удаа ял шийтгүүлсэн, 147 ялтан буюу 12.8 хувь нь 4-7 удаа ял шийтгүүлсэн, 7 буюу 0.6 хувь нь 8-10 удаа ял шийтгүүлсэн байна. Үүнээс үзэхэд энэ хугацаанд хорих ял эдэлсэн 1147 ялтны 678 ялтан буюу 59.1 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгджээ.

Санал асуулгад оролцсон эмэгтэйчүүдийн 32 буюу 27.7 хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байгаагаас үзэхэд хорих ялын хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгууд тодийлөн хангагдахгүй байгаа нь харагдаж байна. Залхаж байна, цээрлэл болж чадаж байна гэх хирнээ давтан гэмт хэрэг хийж удаа дараа хорих ял эдлэж буйгаас харахад эрүүгийн хуулинд заасан ялын цээрлүүлэх зорилгын агуулга, ач холбогдол,

давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцлийг судалж, хорих байгууллагын үйл ажиллагаа, хоригдлын хоригдож буй нөхцөл байдал, засарч хүмүүжих талаар авч буй арга хэмжээ, түүний үр нөлөө, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлж буй боловсон хүчний мэдлэг, туршлагыг дээшлүүлэх хэрэгтэй байгаа юм.

Гурав.Зохион байгуулалтын хүрээнд:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон харьяа хорих ангиудын хамтын ажиллагаа, зохион байгуулалт, ажлын үр дүнг дүгнэх аргачлалаа өөрчлөх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл хорих ялын үр нөлөөг сайжруулах тэр дундаа хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Гадаадын зарим орны эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалт янз бүр байдаг байна. Тухайлбал АНУ-д орон нутгийн шоронд аюул багатайд тооцогдох хоригдлуудыг хорьж ялыг нь эдлүүлдэг байна. Насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулан байгуулсан газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндхийн дэглэм, харуул хамгаалалтын систем нь насанд хүрэгчдийнхтэй харьцуулахад харьцангуй зөөлөн ба насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах боломж нь гэртээ очиж хонож болдог. Энэ нь хоригдлын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг юм байна. Энэ мэт шинэлэг байдлыг анхаарч хуулиндаа оруулж өгмөөр мэт санагдана.

2.Хорих ял эдлүүлэхэд нааД захын стандартын шаардлага эрүүл ахуйг хангасан дэглэм эдлүүлэх хэрэгтэй юм. Жишээлэхэд л ОХУ-ын Эрүүгийн Ял эдлүүлэх Хуульд Засан хүмүүжүүлэх колонид ял эдлэгсдийн орон байрны талбайг ялгавартайгаар тогтоож хуульчилсан .Тухайлбал засан хүмүүжүүлэх колонид 2, гэнданд 2.5, хүүхдийн колонид 3.5, эмэгттэйчүүд 3м квадрат талбай нэг хоригдолд оногдохоор тогтоожээ.

3.Түүнчлэн хорих ял эдэлж байгаа ажилтныг ажлын байраар хангаж, хөдөлмөр хийлгэх нөхцөлийг бий болгох нь тулгамдсан асуудлын нэг болоод байгаа ба хуульд зааснаар ялтныг гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэд байгууллагад учирсан хохирлыг ажил хийлгэж олсон орлогоноос нь нөхөн төлүүлэх ёстой. Нийт хорих ял эдэлж байгаа ялтнуудын 40-50 хувь нь ажил хийж байгаа гэх хэдий ч үнэн хэрэгтээ бусад аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрийн хөлсийг багаар үнэлсэн ажил, эсхүл хорих ангийн өөрийн бүсэд ажил хийж байгаа ялтнуудыг хамааруулсан тоо юм.

Одоогийн байдлаар ял эдэлж байгаа нийт ялтнуудын төлвөл зохих хохирлын дөнгөж 8.1 хувь нь төлөгдсөн байгаа нь маш бага үзүүлэлт бөгөөд шалтгааныг судлахад улсын хэмжээнд жилд дунджаар 12000 ялтан ял эдэлж байгаагийн дөнгөж 50 хувийг ял эдлүүлэхэд хүрэлцэхүйц мөнгийг төрөөс санхүүжүүлж, ялтны хөдөлмөрийн хөлсний орлогын зонхилох хувийг хорих ангиудын үйл ажиллагаанд зарцуулж ирсэн байна. Байдал ийм байхад ялтны хөдөлмөрөөс олсон орлогоос иргэд, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа ямар түвшинд байгаа нь ойлгомжтой.

Дөрөв.Сургалт, үйл ажиллагааны хүрээнд:

1.Хорих байгуулага бүр өөрийн гэсэн мэргэжлийн сэтгэл зүйчтэй байх шаардлагатай. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн хувьд амьдралын ердийн хэв маяг нь өөрчлөгдөж, хийж дадсан ажил, мэргэжлээ орхиход хүрч, ойр дотны хүмүүсээ алдах, оюун санаа хямрах, үзэл санаа, эрүүл мэнд нь доройтох зэргээр биеийн болоод сэтгэл зүйн маш их өөрчлөлтөд ордог. Олон нийтээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал нөхцөлд ял эдлэж буй эдгээр хүмүүсийн сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт, дасан зохицол, айдас түгшүүр, залхсан, хэн нэгэнд өширхсөн, гомдсон зэрэг зан араншингийн өөрчлөлт зэргийг судлаж, тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай байна. Ялангуяа насанд хүрээгүй, жирэмсэн, бага насны хүүхэдтэй, өндөр настай, олон жилээр хоригдож буй, эрүүл мэнд муу хоригдлуудын хувьд онцгой шаардлагатай байна. Энэ нь хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх, хоригдлыг нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой.

2.Төрийн зүгээс гэмт хэрэгтэнд хэрэглэж буй ял шийтгэлийн зорилгод хүрэхийн тулд ялтнуудтай ажиллах сэтгэл зүйчдэд, хорих байгууллагын ажилтан алба хаагчдад зориулж сэтгэл зүйн шинэ арга хэрэгсэл, нөлөөллийн арга хэмжээ зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах сэтгэл зүйн лабораториудыг бий болгох хэрэгтэй байна. Мөн энэ лабораторийн үүрэгт ялтны хувийн байдал, сэтгэл зүйн онцлогийг судлах шинэ арга хэрэгсэл боловсруулах, хорих газруудад бий болдог сөрөг үзэгдлүүдийг судлах түүнээс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлууд хамаарах учиртай.

3.Хорих ангийн зүгээс гэр бүл ялтнуудын нийгмийн холбоо харилцааг нь таслахгүй байх нь маш чухал юм. Тухайлбал гэр бүл, хамаатан садны хүмүүстэй нь байнга уулзуулж байх, гэр бүл, ах дүү нараас нь илгээмж, мөнгөн шилжүүлэг зэргийг байнга авахуулдаг байх зэргээр нийгэмд ойр байлгах талаар анхаарах хэрэгтэй байна. Ял эдлэх хугацаандаа гэр бүл, ойр дотныхоо хүмүүстэй байнгын холбоотой байсан эмэгтэй ялтнууд хорихоос суллагдсаны дараа эргэд нийгэмд дасан зохицохдоо амархан байдаг учраас үүнийг анхаарч ажиллах хэрэгтэй юм болов уу?

4.Эмэгтэй хүний онцлог байдлыг харгалзан үзэж тус хорих ангид эмэгтэйчүүдийн эмчийн болон нярай хүүхэдтэй эмэгтэйчүүд ял эдэлдэг тул хүүхдийн эмчийн орон тоог бий болгох, эмэгтэй ялтнуудад зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэглэл гэх мэт зүйлд мөнгө төсөвлөдөг баймаар байна. Ялтан бүр ар гэрээсээ эргэлт, мөнгөн тусламж авах боломжгүй, улсын хэмжээнд нэг л эмэгтэйчүүдийн хорих анги байдгаас бүх аймаг, сумдаас ялтан ирдэг, газрын хол, амьдралын бололцоо, ар гэрт үлдэгсэдийн байдал янз бүр тул ар гэрээсээ тэр бүр тусламж авах бололцоогүй хоригдлууд их байна.

5.Мөн нийгмийн болон техникийн хурдацтай хөгжлийн энэ эрин зуунд хоригдлуудыг ч түүнээс хол дутахаргүй байдлаар хөгжих боломжоор хангах нь зүйтэй. Жишээлбэл гадаад хэл, компьютерийн анхан шатны мэдлэг олгох, хорих байгууллагад олон жил амжилттай сайн ажиллаж буй чиглэлээр

(тухайлбал нарийн боов, оёдол, барилгын болон нэхмэл, сүлжмэлийн ажил хийж буй, эдгээр мэргэжлийг сайн эзэмшсэн хоригдлуудад) мэргэжлийн үнэмлэх олгох талаар төрөөс нэгдсэн байдлаар арга хэмжээ авах, анх удаа санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдсэн ялтнуудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах. Тухайлбал 1996 онд батлагдсан ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд Хоригдлуудын засан хүмүүжүүлэх колонийн үйлдвэрлэд ажилласан хугацааг улсад ажилласан хугацаанд оруулан тооцох, хөдөлмөрт хамрагдаж байгаа хоригдолд жилд ажлын 12-18 хоногийн амралт олгох, 30 хүртэл насны хоригдол ерөнхий боловсролын сургалтанд заавал хамрагдахыг хуульчилсан байна. Энэ стандартад нийцүүлэх, үгүй дээ гэхэд ядаж ойртуулах хэрэгтэй байгаа юм.

6. Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, ял эдлэж буй ч төрийн хууль цаазын бодлогын гол зорилго нь тэднийг зөвхөн цээрлүүлэхдээ бус харин хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхийг урьдач болгож буй тул хоригдлыг нийгэмшүүлэх, шоронгоос гараад ажил, хөдөлмөр эрхэлж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй амьдрах боломжийг олгоход илүү анхаардаг байх нь зөв зүйтэй болов уу.!

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН www.mli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БОЛОН ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

НЭГ.УДИРТГАЛ

1992 онд батлагдан хүчин төгөлдөр болсон "Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль" нь өнөөдөр захиргааны зөрчил, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа ганц хууль бөгөөд энэхүү хууль нь эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд дорвитой өөрчлөлт ороогүй. 1995,1997,2004,2006 онуудад нийт 20 гаран удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй байсан юм. Өнөөгийн байдлаар ЗХТХ-нь зохицуулах хүчин чадлаараа Эрүүгийн хуулийн дараа орохоор захиргааны эрх зүйн хэм хэмжээ нилээдгүй олон хуулиар тарсан байгаа ба тэдгээрийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар тодорхой хэмжээний сургалт явагдаагүй иржээ.

Энэхүү хуулийг хэрэглэх явцад зарим хэм хэмжээг эргэж харах, өөрчлөх боловсронгуй болгох шинээр Захиргааны Хариуцлагын Тухай Хуулийг батлан гаргах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх нь захиргааны эрх зүйн салбарын өнөөгийн тулгамдсан асуудал болжээ. Энэхүү асуудалд эрүүгийн хууль тогтоомжтой уялдах, харилцан бие биеэ нөхөх асуудал нэлээд байр суурийг эзэлж байгаа юм.

Эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулж чадаагүй хэрэг зөрчилтэй холбоотой асуудлыг захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон зэрэг нь ард иргэдийн дунд хууль тогтоох байгууллагын ажилтнуудыг хардах, гаргасан шийдвэрийг хууль бус гэж үзэхэд хүргэж байгаа юм.

Энэхүү хүрээнд захиргааны хариуцлагын хууль тогтоомжийн үйлчлэх үр нөлөөг дээшлүүлж Монгол Улсын Эрүүгийн бодлогын хүрээнд цоо шинэ үзэл баримтлалаар хөгжүүлэх, шинээр батлан гаргах шаардлагатай байна уу гэдгийг судлан дүгнэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэхүү шаардлага нь судалгаа хийх үндэслэл болсон юм.

"Монгол Улсын эрүүгийн болон захиргааны хууль тогтоомжийг харьцуулан судлах нь" сэдэвт судалгааны ажлыг 2007 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 6 сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд судаллаа.

Судалгааны календарчилсан төлөвлөгөөний дагуу судалгааг явуулсан болно.

1.1. Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь Эрүүгийн хууль тогтоомж ба Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг харьцуулан судалж эрүүгийн ба захиргааны хариуцлага хүлээлгэхэд учирч буй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлон, хууль зүйн хариуцлагын уялдаа үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулах явдал байв.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажиллалаа. Үүнд:

- Эрүүгийн гэмт хэрэг, Захиргааны зөрчил, Монгол Улсын Эрүүгийн бодлого, хууль зүйн хариуцлагын талаарх онолын сүүлийн үеийн үзэл санаа, ойлголтыг судлах
- Эрүүгийн хууль болон Захиргааны Хариуцлагын тухай хуульд давхардсан болон зөрчилдөж байгаа хэм хэмжээ бий эсэхийг судлах;
- Эрүүгийн хуулийг Захиргааны Хариуцлагын тухай хуультай харьцуулан судална. Энэ нь ерөнхий ба тусгай ангийн хүрээнд байх бөгөөд зөвхөн зөрчилдөж байгаа болон давхардаж байгаа хэмжээтэй холбоотой байна. / хүснэгтээр гаргана/
- Гадаадын зарим орны хууль тогтоомжид заасан захиргааны зөрчил захиргааны хариуцлагын тогтолцоог судлах /ижил төстэй эрх зүйн тогтолцоотой орны/
- Санал, зөвлөмж боловсруулах.

1.2. Судалгаа явуулсан арга, хэлбэр

Судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага авах, санал асуух, сурвалжлах, түүхчлэх зэрэг аргаар судалгааг явуулав.

Санал асуулгын судалгааны үр дүнгийн магадлалыг тандах, зарим асуудлыг тодруулах, илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авах, шүүхээс захиргааны зөрчилд оногдуулж буй шийдвэр мөн захиргааны зөрчилтэй ижил төстэй эрүүгийн хэрэгт оногдуулж байгаа шүүхийн шийтгэх тогтоолтой танилцах, Шүүх хуралдаанд суух, хавтаст хэргийн материалтай танилцах, шүүх прокурор, хэсгийн байцаагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нартай ярилцлага хийх, шүүх болон бусад байгууллагын статистик мэдээнд дүн шинжилгээ хийх ЗХТХ-ийн хэрэгжилтийн талаар судлав.

Мөн онолын хүрээнд Эрүүгийн эрх зүйн болон Захиргааны эрх зүйн шинжлэх ухаантай холбогдолтой ном, сурах бичиг, эрдэмтдийн бүтээлийг уншиж судаллаа.

ХОЁР. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

2.1.Онолын хүрээнд хийсэн судалгааны дүгнэлт

Захиргааны эрх зүйн шинжлэх ухааны судлах зүйл нь өөртөө төрийн удирдлагын өргөн явцуу утга, захиргааны эрх мэдлийн мөн чанар, тэдгээрийн харьцаа, эрх зүйн зохицуулалтын механизм, эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж, төрөл харилцан холбоо бүхий тогтолцоо, захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцаа, захиргааны эрх зүйн субьектын эрх зүйн байдал, хүрээ хязгаар, үйл ажиллагааны хэлбэр арга, захиргааны хариуцлагын үндэслэл болон хууль ёсыг хангах үйлдэл, арга

хэрэгсэл, түүнчлэн ерөнхий, мөн салбар салбар хоорондын удирдлагын захиргааны зохион байгуулалтыг багтаадаг байна.

Үүнээс гадна захиргааны эрх зүйн хамгийн түгээмэл ойлголт, тухайлбал захиргааны үйлдэл ба акт, үйл ажиллагааны хэлбэр, агуулга, захиргааны эрх зүйн албадлага болон шийтгэл гэх мэт ухагдахууныг тодорхойлж байдаг.

Захиргааны эрх зүйн чиглэлээр хийсэн судалгааны ажил, диссертацийн талаар авч үзэхэд доктор, профессор И.Дашням 1921-1940 оны үеийн захиргааны хууль тогтоомжид хэсэгчилсэн судалгаа хийснийг эс тооцвол, хуульч судлаачдын анхаарлын гадна байгаа нь бодит зүйл юм. Доктор профессор МУ-ын гавьяат хуульч Б.Чимид "Захиргааны хариуцлага захиргааны эрх зүй эрх зүйн салбар болох нь", "БНМАУ-ын захиргааны байгууллагын тогтоолцооны үүсэл, хөгжил" зэрэг 20 гаран өгүүлэл нийтлэл бичиж: "БНМАУ-ын Захиргааны эрх зүйн ерөнхий анги, тусгай анги " хэмээх сурах бичиг, / 1970-1975 онд/ гаргаж Захиргааны эрх зүйн үндэс суурийг тавьсан байна. Захиргааны эрх зүйн судлаач Д.Дашцэдэн "Заавал биелүүлэх шийдвэрийн тухайд", "Орон нутгийн захиргааны АДХ-ын захиргааны тогтоол түүний шинж", /1976/, "Орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны тогтоол", түүний шинж", /1978/ "Захиргааны байгууллагын эрх зүйн актыг боловсронгуй болгох зарим асуудал" хэмээх ганц сэдэвт зохиол туурвиж, /1976/ "БНМАУ-ын орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны эрх зүйн актыг боловсронгуй болгох нь " сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Доктор профессор Ж.Долгорсүрэн "Соёгтууралтай холбогдон гарсан захиргааны эрх зүйн зөрчлийг ангилан шийдвэрлэх асуудалд" /1982/, "БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагаас соёгтуугаар үйлдэгдсэн нийгмийн хэв журмын зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт" /орос хэл дээр 1987/, "Соёгтууралтай тэмцэх ажлын арга хэлбэрийг сайжруулъя" /1989/, зэрэг арваад өгүүлэл , хэд хэдэн гарын авлага, нэг сэдэвт зохиол, "БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагаас соёгтууралтай хийх захиргааны эрх зүйн тэмцэл" сэдвээр /1989/ дэд эрдэмтэн , Улмаар 1993-1999 онд "Захиргааны хариуцлага", "Захиргааны албадлага", "Захиргааны процесс" зэрэг цуврал бүтээлүүд, гаргаж "Монгол улсад захиргааны эрх зүйн албадлага хэрэглэх буй өнөөгийн байдал, түүнийг хууль тогтоомжийн хүрээнд судалсан нь" сэдвээр докторын зэрэг хамгаалжээ.

"Байгаль хамгаалах хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагын асуудал" /1986/, АДХ-ын байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа" сэдэвт өгүүллүүд гарч, "Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал , уламжлал шинэчлэл" сэдвээр Т.Сэнгэдорж докторын зэрэг хамгаалжээ.

Ном сурах бичиг: Одоогийн байдлаар манай улсад Захиргааны хариуцлага түүнтэй холбогдох онолын тодорхойлолтыг эрдэмтэн доктор Б.Чимидийн "БНМАУ-ын Захиргааны эрх зүй" ерөнхий ангийн сурах бичиг, Ж.Долгорсүрэн "МУ-ын Захиргааны эрх зүй", "Захиргааны албадлага", "Монгол Улсын Захиргааны эрх зүй ба захиргааны процессын ажиллагаа", "Монгол Улсын цагдаагийн эрх зүй" сурах бичиг, Ж.Сүхбаатар "МУ-ын

Захиргааны эрх зүй", Д.Ганзориг "Захиргааны эрх зүй", зэрэг сурах бичгүүд, Т.Сэнгэдорж "Экологийн эрх зүй" , Ш.Батсүх " Захиргааны шинжлэх ухааны ерөний онолын зарим асуудал", цуврал гарын авлагуудад онолын хүрээнд тодорхойлж өгчээ.

Сүүлийн үеийн эрдэмтэн судлаачдын дүгнэж байгаагаар Захиргааны хариуцлагын тухай хуульд онолын болон зарчмын шинжтэй өөрчлөлт хийх шаардлага бий болсон ба үүнийг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанаас тусдаа бие даасан шинэ үзэл баримтлалаар хөгжүүлэх хэрэгтэй байгаа гэж үзэж байгаа юм. Тухайлбал захиргааны зөрчлийн тухай ойлголтыг шинээр тодорхойлох , /хууль тогтоомжинд заасан зарчмуудаар/ шаардлага бий болж байна. Үүнд:

- Захиргааны зөрчил, захиргааны деликтологи, түүний хөгжлийн хандлага буюу захиргааны зөрчлийн гаралт , түүний бүтэц , хууль тогтоомж зарчим, чиг үүрэг, хөгжлийн хөдөлгөөн зэргийг хамааруулсан ойлголт бөгөөд гэмт хэргийн шинжгүй эрх зөрчлийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудлыг судалдаг. Иймээс захиргааны деликтологийн судалгааг хөгжүүлэх талаар анхаарах хэрэгтэй байна. Захиргааны зөрчлийн тухай ойлголт, мөн чанар, нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон журмыг зөрчсөн, нийгэмд хор уршигтай, гэм буруутай, захиргааны шийтгэл хүлээлгэх үйлдэл, эс үйлдэхүй, ЗХТХ-иар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа болох хүний эрх эрх чөлөө, эрүүл мэнд, хүн амын аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, байгаль орчин , түүнчлэн захиргааны журам зөрчсөн талаас нь онолын шинжтэй шинэ ойлголт өгч хуульд тусгах.

- Захиргааны хариуцлага гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын төрөл бөгөөд эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчил гаргасан этгээдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хуульд заасан албадлага хэрэглэх замаар зохих хэмжээгээр хязгаарлах явдал юм. Тэгэхээр одоо хэрэгжиж буй МУ-ын ЗХТХ-ийн нэр томьёо нь хуулийн зорилго зохицуулж буй харилцаандаа тохирохгүй байгаа юм.

- Эрүүгийн бодлогыг гэмт явдалтай тэмцэхэд төрөөс баримтлах чиглэл гэдэг агуулгаар эрүүгийн бодлогыг "kriminalpolitik" гэсэн нэр томьёогоор илэрхийлдэг бөгөөд хүн, төр, нийгэм, байгууллага , аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашиг , сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд ноулталт ямар үйлдэл эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээ, тэдгээрийг оногдуулах, эсвэл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах , хэрэгжүүлэх шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл , удирдамж бөгөөд Захиргааны Хариуцлагын Тухай Хуулиар захиргааны зөрчилд хамаарагдаж байсан үйлдэл, эс үйлдэхүй иргэн нийгэмд илүү их

хохирол учруулах болсон/ зам тээврийн осол гарсан газрыг орхих, албан тушаалтны нэр барих гэх мэт/ Түүнчлэн тодорхой үйлдэл эс үйлдэхүйг эрүүгийн хуульд тусгахдаа хууль тогтоогчийн зүгээс нийгмийн хор аюул ихтэй байх, тэдгээрт ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх замаар тэмцэх нь зайлшгүй байх, эрүүжүүлж буй үйлдэл нь түгээмэл байх, тэдгээртэй эрүүгийн эрх зүйн арга хэрэгслээр тэмцэх нь үр өгөөжтэй байх, нийгмийн хор аюул багатай үйлдэл эс үйлдэхүйг эрүүгийн хуулинд заахгүй байх зэргээр захиргааны эрх зүйн хэм хэмжээнд нөлөөлж байна.

2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгааны дүгнэлт

1. Ерөнхий ангийн хүрээнд

№	Захиргааны Хариуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** Энэ хуулийн зорилт нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.	**1 дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт** 1.1.Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.
2	**2 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж** Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	**2 дугаар зүйл. Эрүүгийн хууль тогтоомж** 2.1.Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ. 2.2. Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага тогтоосон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно.
3	**3 дугаар зүйл.Захиргааны зөрчил** Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил / цаашид "зөрчил" гэх/ гэж үзнэ.	**16 дугаар зүйл. Гэмт хэргийн тухай ойлголт** 16.1.Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. 16.2.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүй учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.

4	**4 дүгээр зүйл.Захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ** Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болно: 1.торгох; 2.тусгайлан олгосон эрх хасах / тээврийн хэрэгсэл жолоодох /; 3.хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах 4.баривчлах.	**46 дугаар зүйл. Ялын төрөл** 46.1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна: 46.1.1. торгох; 46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; 46.1.3. эд хөрөнгө хураах; 46.1.4. албадан ажил хийлгэх; 46.1.5. баривчлах; 46.1.6. хорих; 46.1.7. цаазаар авах.

Эрүүгийн хууль болон ЗХТХ-ийн тусгай ангид заасан заалтуудыг харьцуулан авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нэлээд зөрчилтэй зүйл байсан болно. Үүнд:

2. Гэмт хэргийн бүрэлдэхүүн болон захиргааны зөрчил заасан хэсэг нь хоорондоо зөрчилтэй зүйл, хэсгүүд

№	МУ-ын ЗХТХ	МУ-ын ЭХ
1.	**21 дүгээр зүйл.Танхайрах** Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр, үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дараллын журам зөрчсөн бол	**181 дүгээр зүйл.Танхайрах** 181.1.Олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн бол
2.	**23 дугаар зүйл. Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах** Галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодисыг хууль бусаар олж авсан, авч явсан, хадгалсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх,хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх** 185.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хийж бэлтгэсэн, хадгалсан, авч явсан, борлуулсан бол **186 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах** 186.1.Галт зэвсэг /ангийн буунаас бусад/, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар олж авсан бол

3.	**25[1] дүгээр зүйл.Гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, журам зөрчих** Гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, биелүүлэхээс зайлсхийсэн, гал түймрээс урьдчилан сэргийлэх зориулалттай барилгын хийц, бүтээц болон орон сууцны агааржуулах төхөөрөмжийг дур мэдэн өөрчилсөн, галын автомат дохиолол, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг санаатайгаар гэмтээсэн, тоносон, түүнчлэн шатах тослох материал, тэсэрч дэлбэрэх бодисыг зориулалтын бус газар хадгалах, ой, хээрийн түймэр тавих зэргээр гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**189 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих** 189.1.Аж ахуйн нэгж, байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг хүлээсэн этгээд галын аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөнөөс их хэмжээний хохирол учирсан бол **213 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих** 213.1.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан нь энэ хуулийн 84, 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол
4.	**26[1] дүгээр зүйл.Нислэгийн аюулгүй байдлыг хангах журам зөрчих** 1.Агаарын хөлгөөр тасалбаргүй зорчих, түүнчлэн нислэгийн хэвийн ажиллагааг хангах үүднээс тавьж буй агаарын хөлгийн даргын хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх зэргээр агаарын хөлгөөр зорчих журам болон олон улсын нислэгийн журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих** 224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисэж ирэх буюу Монгол Улсаас нисэж гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шаптгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол
5.	**30[2] дугаар зүйл.Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх** 3.Гэмт хэрэг, захиргааны зөрчил, гал түймэр гарсан тухай худал мэдээлэл цагдаагийн байгууллагад санаатайгаар өгсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол.	**252 дугаар зүйл. Зориуд худал мэдээлэх** 252.1.Хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж зориуд худал мэдээлсэн бол
6.	**34[1] дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих** Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчсөн бол	**235 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих** 235.1. Төрийн архивын сан хөмрөгт орсон архивын баримт бичгийг хууль бусаар худалдсан, шилжүүлсэн, дамжуулсан бол

7.	**36 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгө ашиглан шамшигдуулах** Бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол **37 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах** Бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор хувьдаа ашигласан буюу бусдад ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**145 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг хулгайлах**145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол **150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх** 150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсэн, эсхүл албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж бусдын эд хөрөнгийг авсан бол **151 дүгээр зүйл. Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших** 151.1.Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгийг завшсан бол **152 дугаар зүйл. Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших** 152.1.Бусдын хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгө, малыг завшсан буюу үрэгдүүлсэн бол
8.	**38 дугаар зүйл.Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх** Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдсэн, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх** 153.1.Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол
9.	**43[1] дүгээр зүйл.Төсвийн тухай хууль тогтоомж зөрчих** Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах** 273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:.зориулалтын бусаар зарцуулсан; зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан; .нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан; зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн; төрийн өмчийн болон төсөвт байгуллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан; улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол

10.	**52 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчих** 1.Зохих зөвшөөрөлгүйгээр эмчилгээ явуулсан, эмнэлгийн байгууллага байгуулж ажиллуулсан бол 3.Хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хорт нөлөө үзүүлэх химби, биологи, физикийн хүчин зүйл, бодисыг зохих шинжилгээгүйгээр хэрэглэсэн, худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрүй бол 4. Байгалийн болон гоц халдварт өвчин гарсан хориотой бүсэд нэвтрэх, ан агнах зэргээр хорио, цээрийн дэглэм зөрчсөн, байгалийн болон гоц халдварт өвчин үүсгэгч, нян тээгч зүйлсийг хот, суурин газар зохих шинжилгээгүй оруулсан, оруулахыг завдсан бол	**197 дугаар зүйл. Хууль бусаар эмчлэх** 197.1.Эмчийн мэргэжлийн бус этгээд эмчилгээ эрхэлсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол **200 дугаар зүйл. Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах** 200.1.Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, олгох, буртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн бол **199 дүгээр зүйл. Тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих** 199.1.Ариун цэвэр-эрүүл ахуй, дархлаажуулалтын талаар тогтоосон болон тахалтай тэмцэх журам зөрчсөнөөс, эсхүл дархлаажуулалтаас хүндэтгэх шалтгаангүйгээр зайлсхийснээс тахал болон гоц халдварт бусад өвчин тархсан буюу тархаж болох байсан бол

3. Эрүүгийн хууль тогтоомжид болон захиргааны хариуцлагын тухай хуульд давхардсан байдлаар тусгагдсан

№	Захиргааны Хариуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1.	**28 дугаар зүйл. Гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих** 1.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух эрхийн бичиггүй, эсхүл хүчингүй болсон баримт бичиг ашиглаж буюу зохих зөвшөөрөлгүй оршин суусан бол 2. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр зорчих, түүнчлэн шилжин суурьших болон буртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 8.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчиход зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн бол	**240 дүгээр зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих** 240.1.Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад байх эрхийн баримт бичиггүй буюу хүчингүй баримт бичгээр оршин суусан, буртгүүлэх, хаягийн буртгэл хийлгэх, шилжин суурьших, оршин суух газраа сонгох талаар тогтоосон журам зөрчсөн, эсхүл оршин суух, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх журам зөрчсөн бол

2.	**29 дүгээр зүйл.Улсын хилийн дэглэм, журам зөрчих** 1..Улсын хилийн дэглэм зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2.Улсын хил арчлан хамгаалах, хилийн ус болон шугам оптлон гарсан зам, холбооны байгууламж ашиглах,хил орчмын нутагт ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 3.Улсын хилийн бүс, зурваст болон хилийн гарц, боомтод тогтоосон журам зөрчсөн бол	**89 дүгээр зүйл.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх** 89.1.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол **90 дүгээр зүйл.Улсын хилийн дэглэм зөрчих** 90.1.Монгол Улсын хилийн багана, тэмдгийг санаатай устгасан, гэмтээсэн, хилийн шугамыг оптлон гарсан ус, зам, гүүр, холбооны байгууламжийг ашиглах журам болон улсын хилийн дэглэмийг бусад хэлбэрээр ноцтой зөрчсөн бол
3.	**30 дугаар зүйл.Шүүхийг үл хүндэтгэх** 3.Шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол	**258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх** 258.1.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол
4.	**30[1] дүгээр зүйл.Прокурорыг үл хүндэтгэх** **30[2] дугаар зүйл.Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх** **30[3] дугаар зүйл.Хорих байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх** **30[5] дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх** **30[6] дугаар зүйл.Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх** **30[4] дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх**	**230 дугаар зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх** 230.1 . Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь буюу олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь эсэргүүцсэн бол 230.2.Энэ хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, түүнчлэн хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол **231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох** 231.1. Төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол
5.	**30[4] дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх**3. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол	**258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх** 258.2.Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн бол

6.	**33 дугаар зүйл.Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах** Төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас түр хугацаагаар битүүмжилсэн эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол	**244 дүгээр зүйл. Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах** 244.1.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас битүүмжилсэн эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол **260 дугаар зүйл. Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух** 260.1.Хуулийн байгууллагаас дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд санаатай үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн бол
7.	**34[2] дугаар зүйл. Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчих, компьютер, мэдээллийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх** Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчсөн, компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас мэдээллийг болгоомжгүйгээр өөрчлөх, устгах, хаахад хүргэсэн буюу компьютер түүний төхөөрөмжийг ашиглах боломжгүй болгон эвдсэн, түүнчлэн компьютер мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээллийг хууль бусаар хуулбарласан, мэдээллийн сүлжээгээр дамжуулж байгаа мэдээллийг замаас нь авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**226 дугаар зүйл. Компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх** 226.1.Компьютер, компьютерийн программ, түүний төхөөрөмжийг санаатайгаар өөрчилсөн, эвдсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, мэдээллийн сүлжээг сүйтгэсний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол **227 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авах** 227.1.Компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа болон дамжуулж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хуулбарласан, бусад аргаар олж авсан буюу авахыг завдсан бол
8.	**41 дүгээр зүйл.Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх** Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**123 дугаар зүйл.Садар самууныг сурталчлах** 123.1 Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол
9.	**44 дүгээр зүйл.Албан татварын тухай хууль тогтоомж зөрчих** Албан татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, албан татварын мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, албан татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт сэлт гаргаж өгөөгүй зэргээр албан татварын тухай хууль тогтоомж зөрчсөн бол	**167 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчих** 167.1.Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих хууль тогтоомжид заасан журмыг зөрчсөн, татварын хяналт шалгалтад саад учруулсан бол

10.	**45 дугаар зүйл.** **Албан дайчилгааныаас зайлсхийх** Байгалийн гэнэтийн аюул, хүн, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, гал түймэр эсэргүүцэх, улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон хүн хүч, тээвэр, холбооны хэрэгслийн дайчилгааныаас санаатайгаар зайлсхийсэн, саад учруулсан бол	**239 дүгээр зүйл .** **Төрийн дайчилгааныаас зайлсхийх** 239.1 Байгалийн гэнэтийн аюул, хүн, малын гоц халдварт өвчин, гал түймрээс эсэргүүцэх, улсын аюулгүй байдал хангахтай холбогдсон дайчилгааныаас санаатайгаар зайлсхийсэн, саад учруулсан бол
11.	**47 дугаар зүйл.** **Аюулгүй ажиллагааны журам зөрчих** 2.Тэсэрч дэлбэрэх болон радио идэвхит, түүнчлэн хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**184 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах** 184.1.Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явсан бол **190 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах,тээвэрлэх, илгээх журам зөрчих** 190.1.Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журмыг зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл учирсан бол

4. Эрүүгийн хууль болон ЗХТХ-д давхардсан байдлаар орсон боловч хор уршиг шаардсанаараа ялгаатай зүйл, хэсгүүд

№	Захиргааны Харьуцлагын Тухай Хууль	Эрүүгийн Хууль
1.	**26 дугаар зүйл.Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих** 1.Галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулж болох зүйлсийг төмөр зам дээр тавих, мал, ердийн хөсөг болон тээврийн хэрэгслийг төмөр зам дээгүүр гарцгүй газраар гаргах, төмөр замын хориотой бусад эвшөөрөлгүй нэвтрэх, мал бүхий иргэд малаа хариулгагүй орхисноос төмөр замын хориг хашаанд оруулах, түүнчлэн галт тэргийг дур мэдэн зогсоох, дээвэр, гишгүүр дээр зорчих, хөдөлгөөн дунд буух, суух зэргээр төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2.Төмөр замын төхөөрөмж, хамгаалалтын тор, хаалт, галт тэрэгний болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, суудлын галт тэрэгний тоноглолыг эвдэж, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**217 дугаар зүйл. Төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих** 217.1.Төмөр зам, усан болон агаарын тээврийн байгууллагын ажилтан тухайн төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөний улмаас хүний бие махбодид хүндэвтэр буюу хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол **219 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх** 219.1.Тээврийн хэрэгслийн холбоо, дохиоллын болон бусад тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол

2.	**31 дүгээр зүйл.Төрийн байгууллагын ажилтны нэр барих** Төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууран мэхлэх үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих** 267.1.Албан тушаалтан бус этгээд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр барьж үйл ажиллагаа явуулсан нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжгүй, энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний ашиг олсон, эсхүл бусдад их хэмжээний хохирол учирсан бол
3.	**38[1] дүгээр зүйл. Барилга, хот байгуулалтын журам зөрчих** 1.Зохих зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын болон барилгын зураг, төсөл зохиох ажил гүйцэтгэх, барилгын хийц, эдлэл, материал үйлдвэрлэх явцад барилга, байгууламжийн бат, бэх, тогтвортой буюу найдвартай чанарыг алдагдуулах зэргээр барилга, хот байгуулалтын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**174 дүгээр зүйл. Чанар муутай барилга бариулах, ашиглалтад оруулах** 174.1.Барилга барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, эрх бариг, түүнчлэн барилгын чанарт хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан чанар муутай, дутуу болон батлагдсан зураг төсөлд тохироогүй барилга бариулсан буюу ашиглалтад хүлээлгэн өгсний улмаас их хэмжээний хохирол учирсан бол
4.	**42 дугаар зүйл.Худалдаа, үйлчилгээний журам зөрчих** 1.Хориглосон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**161 дүгээр зүйл. Хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх** 161.1.Хууль тогтоомжоор хориглосон, тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дур мэдэн их хэмжээтэйгээр эрхэлсэн бол
5.	**46[1] дүгээр зүйл.Ургамлын өвчин, хортонтой тэмцэх журам зөрчих** Ургамлын өвчин, хортонтой тэмцэх технологи зөрчсөн, түүнчлэн ургамлын өвчин, хортон устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулах зэргээр ургамал, хорио цээрийн дэглэм зөрчсөн бол	**209 дүгээр зүйл. Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих** 209.1.Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчсөний улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол
6.	**47 дугаар зүйл.Аюулгүй ажиллагааны журам зөрчих** 1.Түлш, эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх, ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах, зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах; уул уурхай, барилга болон тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**183 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны журам зөрчих** 183.1.Уул, уурхай, барилга, түүнчлэн тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй үйлдвэр бусад аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны журам зөрчсөний улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор урших учирсан бол

7.	**47[1] дүгээр зүйл.Хөдөлмөр хамгааллын журам зөрчих** Аж ахуйн нэгж, байгууллага, хувираа эрхлэх аж ахуйд хөдөлмөр хамгааллын журмыг сахин хангуулах эрх бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүй буюу хөдөлмөр хамгааллын журам зөрчигдөж буйг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ авааагүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	**138 дугаар зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчих** 138.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүйгээс хүний бие мэхбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол

Монгол Улсын "Захиргааны хариуцлагын тухай хууль" нь 3 бүлэг , 56 зүйл заалттай, 1992 оны 12 сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн, 20 гаран удаагийн нэмэлтээр уг хуулийн тавны нэгд өөрчлөлт орсон. Захиргааны хариуцлагын тухай хуулийн "соггуурах" /22-р зүйл/ гэсэн зөрчлөөс бусад нийт 44 зүйл, 86 хэсэгт торгууль оногдуулахаар заасан байгаа нь "Захиргааний торгууль оногдуулах хууль" гэмээр харагдаж байгаа юм. Хэрэв тийм бол гадаадын орнуудын жишгээр зөвхөн торгууль оногдуулах шийтгэлийг тусгаж бусад эрх хасах , баривчлах, хууль бусаар олсон орлого зд зүйлийг хураах захиргааны шийтгэлүүдийг оруулахгүй байх нь зүйтэй юм.

Нөгөөтэйгүүр захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн хөдөлмөр эрхлэх, хамт олонд хүмүүжүүлэхээр өгөх гэх мэт шийтгэлийг оруулж өгвөл урьдчилан сэргийлэх үүргийг биелүүлэх нэг нөхцөл болно.

ЗХТХ-ийн 39-р зүйлд "Энгийн харуул манааны дүрэм зөрчих" зөрчилд 3000 төгрөгийн торгууль оногдуулахаар заасан байгаа нь торгуулийн хамгийн бага заалт юм. Иймэрхүү байдалд нэг бүрчлэн судалбал 5000 хүртэл төгрөгөөр торгох "ЗХТХ-ийн 24-р зүйл " Хүйтэн.зэвсэг хууль бусаар биедээ авч явах" , 8000 төгрөг хүртэл торгох "замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих", мөн 10000 төгрөг хүртэл торгох ЗХТХ-ийн 41-р зүйл "Садар самууныг сурталчилах, өнгөний өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх" зөрчил гэх мэт байна.1000 хүртэл төгрөгөөр торгох заалт бүхий заалт нь хуулийн 13,8 хувь байна. Мөн тус хуулийн 28-р зүйл "Гадаадын иргэн харьяалалгүй хүн хөдөлмөр эрхлэх талаар хууль тогтоомжинд заасан журам зөрчих, 42-р зүйл " Хориглосон үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, 37-р зүйл "Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах", 48-р зүйл " Гэрээний тухай хууль тогтоомж зөрчих" зөрчлүүдэд 10000 төгрөгнөөс дээш 15000-20000 хүртэл төгрөгөөр торгохоор зааж өгсөн байна. Энэ хуулинд гадаадын иргэн , байгууллага аж ахуйн нэгж захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хэрхэхийг тодорхой зааж өгөөгүй байна.

- ЗХТХ-ийн Ерөнхий ангийн заалтанд тус хуулийн зорилт хэсэгт олон улсын нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ болон , баримтлах зарчмууд ялангуяа гэм буруугүйн презумци, эрх тэгш байх зарчим, захиргааны хуулиар хамгаалагдах харилцаа, хуулийн үйлчлэх хэмжээ хязгаар, орон зай, цаг хугацаа зэргийг тусгаагүй байна. Хойшлуулшгүй ажиллагаа , гадаадын иргэд , харьяалалгүй этгээд, гадаадын хуулийн

этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэх, мансуурсан үед хүлээлгэх захиргааны хариуцлагыг хэрхэн авч үзэх, Захиргааны шийтгэлийн зорилго, төрөл хэлбэрийг боловсронгуй болгох талаар оруулж өгөх зайлшгүй шаардлагатай байна.

- ЗХТХ-ийн нийт 38 зүйл, хэсэг нь эрүүгийн хууль тогтоомжтой давхардаж, эрх зүйн хэм хэмжээний давхардал, зөрчилдөөн бий болгож байна. Захиргааны Хариуцлагын Тухай Хуулийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор эрүүгийн хууль тогтоомжинд тусгагдсан зарим заалтыг хасах , эсвэл ялгаж ойлгох талаар хуульд тусгаж өгөх, 1993 онд гарсан УДШ-ийн "ЗХТХ-ийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" №38 тогтоол нь өнөөгийн шаардлага хангахгүй болсон учир хүчингүй болгож ахин тайлбар гаргуулах зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй байна. Түүнчлэн дээр дурдагдсан ерөнхий ангийн 4 зүйл, эрх хэм хэмжээ хоорондоо зөрчилтэй 10 зүйл, эрх зүйн хэм хэмжээний давхардал буюу нэг харилцааг хамгаалсан 11 зүйл хэсэг, эрүүгийн гэмт хэргээс хор уршиг шаардсанаараа ялгаатай 7 зүйл хэсэгт заагдсан заалтууд нь ЗХТХ-ийг шинээр батлан гаргах шаардлагатай гэдгийг харуулж байна.
- Захиргааны зөрчилтэй холбоотой хэм хэмжээ нилээдгүй олон хуулинд тусгагдсан байна. 240 гаран хуулиас захиргааны зөрчилтэй холбоотой хэсгийг төрөлжүүлэн нэгтгэж ЗХТХ-д ямар нэг байдлаар тусгах уу эсвэл ЗХТХ-иар зөвхөн нийтлэг хэм хэмжээ, ерөнхий анги зааж уг харилцааны эрх зүйн үндэсийг тусгаж, захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг тусгаж өгөх үү гэдэг асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн захиргааны зөрчилийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан заалтуудыг ч оруулж өгөх, хууль гаргах талаар бодох хэрэгтэй байгаа юм.
- Бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнчлэн шунахай зорилгоор хувьдаа ашигласан буюу бусдад ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэж зааж өгчээ. **Бага хэмжээгээр ашиглан шамшигдуулах** гэдгийг нарийн тодорхойлох, УДШ-ийн тайлбарт тодорхой оруулж өгөх ялангуяа **ашиглан шамшигдуулах** гэдгийг тодорхойлж хулгайлах, залилан мэхэлж авах, ашиглах, үрэгдүүлэх зэргийн алин болохыг зааж өгөх, бага хэмжээтэй гэдгийг эрүүгийн хуулинд заасан байдлаар ойлгож, хэрэв бага хэмжээтэйгээр бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг үйлдсэн бол ЗХТХ-иар ашиглан шамшигдуулах гэмт хэргэгт тооцож, давтан үйлдсэн, бага хэмжээнээс дээш буюу үлэмж хэмжээтэйгээр үйлдсэн бол эрүүгийн гэмт хэрэгт үзэж байхаар Эрүүгийн хуулинд тусгаж өгөх саналтай байгаа юм.
- Эрүүгийн хэрэгтэй ижил төрлийн харилцааг хамгаалсан хэм хэмжээ захиргааны хариуцлагын тухай хуульд байгаа нь хуулийн байгууллагын ажилтнуудын дунд хардлага бий болгох, хэргийг өөрт ашигтай

байдлаар шийдэх, улмаар эрүүгийн хариуцлагаас зайлсхийж, ял завших боломжийг олгож байна. Жишээлбэл: Танхайрах зөрчил /ЗХТХ-ийн 21-р зүйл /-ийг танхайрах гэмт хэргээс /ЭХ-ийн 181--р зүйл/, мөн Галт зэвсгийг хууль бусаар олж авах , эзэмших хадгалах , борлуулах гэмт хэргийг / ЭХ-ийн 185-р зүйл/ энэ төрлийн захиргааны зөрчлөөс / ЗХТХ-ийн 23-р зүйл / ялгах , нэг мөр зөв ойлгож хэрэглэх талаар тайлбар гаргуулах, зөвхөн нэг хууль тогтоомжинд тусгаж өгөх хэрэгтэй юм. "Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах" / ЗХТХ-ийн 33-р зүйл болон ЭХ-ийн 244 дүгээр зүйл. "Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах" 260 дугаар зүйл. "Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, нуух" гэмт хэргээс ялгагдах ямар нэг ялгаа байхгүй байгаа юм.

- Шинэ эрүүгийн хууль тогтоомжинд танхайрсан зөрчил гаргасны дараа ахин дээрх зөрчил гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан байсан хэм хэмжээ байхгүй болсон нь бэрхшээл учруулж байгаа бөгөөд эрүүгийн хууль тогтоомжинд ахин тусгаж өгөх шаардлагатай байна.
- Огт хэрэгждэггүй , арга хэмжээ авагддаггүй захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хэм хэмжээнүүд байсаар байна. Тухайлбал "Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэх гэмтээх /ЗХТХ-ийн 38-р зүйл/ нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эрүүгийн хуулиар хамгаалсан бусдын эд хөрөнгөнөөс ямар шалтгааны улмаас доогуур авч үзэж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

2.3 Практик үйл ажиллагааны хүрээнд хийсэн судалгааны дүгнэлт

Өнөөгийн байдлаар нийт 240 гаран хууль тогтоомжинд захиргааны зөрчил тусгагдсан бөгөөд 60 гаран эрх бүхий субьект захиргааны шийтгэл оногдуулж байна. /хууль тогтоомжинд заасанаас үзэхэд 10 гаран эрх бүхий байгууллага, ажилтан/ Үүнд :

- Татварын байгууллага
- Мэргэжлийн хяналтын байгууллага
- Цагдаагийн байгууллага, цагдаагийн ажилтан
- Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага
- Онцгой байдлын алба
- Аудитын байгууллага
- Иргэний бүртгэл мэдээллийн байгууллага
- Гоц халдвартын байгууллага
- Стандарт хэмжил зүйн байгууллага
- Газрын албаны байгууллага.
- Мал эмнэлэг,эрүүл ахуйн улсын байцаагч
- Татварын улсын байцаагч
- Байгаль орчны улсын байцаагч

Судалгааны ажлын хүрээнд ЦЕГ-ын мэдээлэл дүн шинжилгээний төв, Замын Цагдаагийн газрын тоо бүртгэлийн алба, Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн

захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэж буй албан тушаалтнуудтай уулзаж захиргааны зөрчилд хүлээлгэж буй захиргааны хариуцлагын үр нөлөө, өнөөгийн байдал, цаашид тулгараад буй бэрхшээлийн талаар судлахад дараах байдлууд тогтоогдож байна. Үүнд:

- ЗХТХ-ийн 21, 22, 25-р зүйлд заасан зөрчилд авч буй захиргааны шийтгэл нь зөрчил гаргагчид үзүүлэх цээрлэлийн нөлөөлөл багатай, захиргааны арга хэмжээ авагдсан этгээд ахин энэ төрлийн захиргааны зөрчил гаргах явдал олонтаа байдаг. Жишээ нь: согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдал улсын хэмжээнд буурахгүй байна.
- ЗХТХ-ийн 25-р зүйлд заасан зам тээврийн зөрчилд оногдуулж байгаа шийтгэл торгуулийн хэмжээ бага байна. Тухайн үед батлагдсан торгуулийн хэмжээний заалт нь зөрчил гаргагчид нөлөөлөх эдийн засгийн нөлөөлөл болж чадахгүй байна. ЗХТХ-ийн "удаа дараа" гэж заасан заалт нь хэдэн удаа зөрчил гаргасныг хэлэх вэ? гэдэг асуудал тодорхойгүй байна. Иймээс захиргааны шийтгэвэрээр торгууль хүлээлгэх асуудлыг нэг мөр цэгцлэх, тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хамааралтай заалт оруулах, хуулинд заасан "удаа дараа гэдгийг 2 ба түүнээс дээш" гэж тодорхойлж өгвөл үр дүнтэй байх болов уу.
- Социализмын үед 209 төрлийн торгууль байсан бол эдүгээ 2000-3000 гаруй болж нэмэгджээ. Торгуулийн орлогыг бүрдүүлж байгаа субьектуудын үйл ажиллагаанд хяналт тавих механизм тодорхойгүй байна. Орон нутгийн төсвийн хүү торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагууд нь ихэвчлэн босоо тогтолцоотой байгаагаас тэдний ажлыг дүгнэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, хариуцлага тооцох механизм орон нутагт байхгүй байна. Торгуулийн орлого оруулж байгаа байгууллагуудын хэрэглэж байгаа үнэт цаасанд тавих орон нутгийн хяналт байхгүй учраас хүү торгуулиар орон нутгийн орлогод орж буй орлого үнэт цаасны зарцуулалттай тохирч буй эсэхийг ч мэдэх аргагүй байна. Захиргааны шийтгэл хүлээлгэж байгаа торгуулийн тасалбар янз бүр байгаа нь түүнийг хуурамчаар үйлдэх, буруугаар ашиглах явдал гарахад хүргэж байгаа юм. Тиймээс захиргааны шийтгэл хүлээлгэж байгаа торгуулийн тасалбар, захиргааны шийтгэврийн хуудсыг нэгдсэн нэг стандартад оруулах шаардлага бий болж байна.
- Согтуурсан тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ байгаа боловч мансуурсан үед захиргааны зөрчил үйлдсэн бол хүлээлгэх хариуцлагыг зааж өгөөгүй нь практикт бэрхшээл учруулж байна. Жишээлбэл: Мансуурсан этгээд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчил гаргасан бол хэрхэх вэ гэдэг асуудал тодорхойгүй байна.
- Манай улсад зам тээврийн зөрчилтэй холбоотойгоор Замын Цагдаагийн газрын тоо бүртгэлийн тасаг, гудамж талбайд гарч байгаа хэрэг захиргааны зөрчилтэй холбоотойгоор ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төв тоо мэдээ, бүртгэл судалгаа хийгдэж байна.

Бусад байдлаар байгаль хамгаалах журмын эсрэг , компьютерийн мэдээллийн зөрчил , гэх мэт зөрчлийн нэгдсэн тоо мэдээлэл бүртгэл судалгаа байхгүй байна. Цагдаагийн байгууллагын ажилтан ЗХТХ-ийн 27 зүйл заалтанд заасан захиргааны зөрчилд арга хэмжээ авдаг. Энэ 27 захиргааны зөрчилд нэгдсэн тоо бүртгэл байхгүй байгаагаас нэг этгээд өөр газар нутаг дэвсгэрт хэдэн ч удаа захиргааны зөрчил гаргаж түүндээ хэдэн удаа захиргааны хариуцлага хүлээж удаа захиргааны арга хэмжээ авагдсаныг тогтоох боломжгүй байна. Өөрөөр хэлбэл захиргааны зөрчлийн нэгдсэн сан тоо бүртгэл байхгүй байгаа. Жишээ нь Иргэний бүртгэл мэдээллийн байгууллагаас гаргасан 2005 оны тайланд ЗХТХ-иар бичиг баримтын зөрчил гаргасан 10630 хүнд 96837716 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна. Тэгвэл энэ зөрчилд арга хэмжээ авагдсан этгээд ахин өөр төрлийн захиргааны зөрчил үйлдсэн бол түүнийг тогтоох боломж байхгүй гэсэн үг.

- Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн эрх бүхий албан хаагчаас торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр оногдуулж байгаа практикийг судалж, торгуулийг бэлэн бус хэлбэрээр хийдэг асуудлыг судлан санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Торгуулийг бэлэн бусаар ногдуулж байгаа улс орнуудын иргэд нь хувийн хадгаламж болон картын систем, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрэн шийдвэрлэгдэж төлбөрийн тооцоо бэлэн бусаар хийгдэж хэвшсэн байдаг байна. Иймд манай орны хувьд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим монгол" хөтөлбөр хэрэгжсэний дараа энэ ажил үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой юм. Одоогийн байдлаар зарим дүүргийн байгнын постууд дээр кассын машин туршин ажиллуулж байгаа бөгөөд цаашдаа торгуулийг бэлэн бусаар тооцож байх аргыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Захиргааны зөрчилд хийгдэх процессын ажиллагаа заагдсан зүйл хэсгүүд учир дутагдалтай байгаагаас хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, өөр байдлаар захиргааны зөрчлийн тэмдэглэл үйлдэх, нотлох баримтыг бүрдүүлэх зэрэг байдлууд гарсаар байна. Түүнчлэн захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй бэрхшээлийг харгалзан захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх процессын хууль гаргах, эсвэл ЗХТХ-ийн хэсэгт тусгай бүлэг болгон тусгаж өгөх нь зүйтэй юм.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Иймээс дээрх бэрхшээлийг арилгаж, ял шийтгэлийн тохиромжтой байдлыг хангах зорилгоор дараах чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

- Захиргааны хариуцлагын тухай хуулийг шинэ үзэл баримтлалаар хөгжүүлэн ажлын хэсэг гаргаж шинэ хуулийн төсөл боловсруулах,
- Судалгааны ажлын хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн дүгнэлтэнд үндэслэн захиргааны зөрчлийн тухай тодорхойлолт өгөх, зарчим, хуулийн зорилтыг шинээр тодорхойлох ялангуяа захиргааны зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгыг оруулж өгөх,
- ЗХТХ-ийн тусгай ангид оруулж өгөх захиргааны зөрчлүүдийг эрүүгийн хууль тогтоомжтой давхардуулахгүй байх, эрүүгийн гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан, нийгмийн хор аюул багатай хэргүүдийг захиргааны зөрчилд оруулж болохоор тодорхой зааж өгөх, Эрүүгийн хууль, ЗХТХ- нь харилцан бие биеэ нөхөж байхаар зохицуулалт хийх
- Гадаадын Захиргааны хариуцлагын хууль тогтоомж тэр дундаа ижил төстэй эрх зүйн тогтолцоотой ОХУ гэх мэт орнуудын хууль тогтоомжийг судалж шинэ үзэл баримтлалыг хуульд тусгах, нэвтрүүлэх

Практик үйл ажиллагааны хүрээнд

- Захиргааны зөрчлийн нэгдсэн сан байгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын саналыг авч, энэ төрлийн мэдээллийн бааз, судалгааны байгууллагыг байгуулах чиглэлийг баримталж ажиллах.
- Монгол улсын эрүүгийн бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт хийж зарим төрлийн хэргийн захиргааны зөрчилд тооцох тухайлбал ашиглан шамшигдуулах зөрчилд эрүүгийн хуулийн бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг ашиглах, үрэгдүүлэх зэрэг зарим төрлийн хэргийг бага хэмжээтэйгээр үйлдсэн байвал захиргааны зөрчил гэж үзэж байхаар оруулж өгвөл захиргааны хариуцлагын үр нөлөө дээшлэх нэг алхам болох юм.
- Захиргааны зөрчилд шинэ төрлийн зөрчлүүдийг оруулж өгөх
- Захиргааны шийтгэвэр, торгуулийн хуудсыг улсын хэмжээнд нэг стандартад оруулж, хянах системийг боловсронгуй болгох, улмаар бэлэн бус хэлбэрээр торгууль төлөх системд шилжихэд бэлтгэх.
- Захиргааны зөрчилтэй холбоотой нийт 240 гаран хуулийн холбогдох хэсэгт судалгаа хийж, тэдгээрийг эмх журамд оруулж, захиргааны хариуцлагын тухай хуульд тусгах ажлын хэсэг байгуулах, давхардсан зөрчилдсөн хэм хэмжээг хүчингүй болгох, зөрчилдөөнийг арилгах зэрэг ажиллагааг хийх.

__oOo__

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

НЭГ. УДИРТГАЛ

Эрх зүйт төр нь хуулийг дээдлэх, төр, иргэний харилцан үүрэг хүлээх, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хангах зэрэг үндсэн зарчмуудаар биелэлээ олдог билээ. Ийнхүү төр, иргэн хоёр харилцан үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага өндөрсөж, төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудал эрх зүйн болоод нийгмийн өнөөгийн тулгамдсан асуудал болоод байна.

Өнөөдөр гэмт хэргийн улмаас иргэд олноороо хохирох, хохирлоо нөхөн төлүүлэх боломжгүйд хүрч, төр засгийн байгууллага, албан тушаалтанд бухимдлаа илэрхийлэх явдал нэлээд газар аваад байна.

Тэгвэл ийнхүү гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадахгүйд хүрч буй байдал нь эрх зүйн зохицуулалттай холбоотой юу, аль эсвэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага болон прокурор, шүүхээс хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэж буй бодлоготой холбоотой юу, мөн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой юу гэдгийг судлан дүгнэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэхүү шаардлага нь судалгаа хийх үндэслэл болсон юм.

1.1.Судалгааны зорилго, зорилт

Судалгааг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор хийсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;

2.Хуулийн байгууллагууд хохирол нөхөн төлүүлэх тухай үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцийг практикт хэрхэн хэрэглэж байгаад дүн шинжилгээ хийх;

3.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;

4.Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;

5.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг гаргуулах тухай шийдвэрийн бодит биелэлтэд дүн шинжилгээ хийх;

6.Хорих ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хөлс, үнэлгээ, хөдөлмөрийн хөлснөөс төлбөрийг төлүүлж буй байдалд дүн шинжилгээ хийх;

7.Хохирол нөхөн төлүүлэлтийн талаар гадаадын зарим орны хууль

тогтоомж, туршлага, жишгийг харьцуулан судлах;

8.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зүйг шинэчлэн боловсруулах;

9.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх иж бүрэн арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах.

1.2. Судалгаа явуулсан байдал

ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны сектор нь НҮБХХ-ийн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын институцийн чадавхийг бэхжүүлэх" төслөөс зарласан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах үндэсний чуулган уггаж "Хохирогчийн эрхийн хэрэгжилт" сэдвээр судалгаа хийх судлаачдын багийг сонгон шалгаруулах шалгаруулалтад оролцож, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт" судалгааны ажлыг 2007 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд судалгааны удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь гарган хэд хэдэн чиглэлээр судалгааг явуулсан болно.

Судалгааны зорилго, зорилтыг хангахын тулд дараах үндсэн чиглэлийн дагуу судалгааг явуулсан. Үүнд:

1.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл. хэмжээг тогтоох, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх талаархи эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн байдлыг тогтоох;

2.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс болох хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдлыг тогтоох;

3.Хуулийн байгууллагууд буюу байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид хохирол нөхөн төлүүлэх талаарх хууль тогтоомжийг практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа, хохирол нөхөн төлүүлэхэд хэрхэн анхаарч буй өнөөгийн байдлыг тогтоох;

4.Хорих ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийн үнэлгээ буюу хөлс, хөдөлмөрийн хөлснөөс төлбөрийг төлүүлж буй өнөөгийн байдлыг тогтоох;

5.Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүмүүсээр хохирол нөхөн төлүүлж буй байдал, хохирол нөхөн төлүүлэлтэд учирч буй бэрхшээлийг судлан тогтоох;

6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаархи гадаадын зарим орны туршлага, олон улсын чиг хандлагыг судлан тогтоох.

1.3. Судалгаа явуулсан арга, хэлбэр

Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага авах,

санал асуух, сурвалжлах зэрэг аргаар явуулав.

Судалгааны 1-3 дахь чиглэлийн хүрээнд буюу үг чиглэлүүдэд дүрдсан байдлыг тогтоохын тулд дор дурдсан ажлыг хийсэн болно. Үүнд:

*1.*Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоох, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх талаархи эрх зүйн зохицуулалтыг судлах ажлын хүрээнд үндэсний 7 хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын 23 гэрээний зохицуулалтыг судалж, дүн шинжилгээ хийсэн болно.

2.Харин хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг тогтоохын тулд 2006 онд дүүргүүдийн шүүхийн шийдвэрлэсэн 242 эрүүгийн хэргийн материалыг уншиж судалсан болно. Хавтаст хэргийн материал судалсны үр дүнд дараах байдлыг тогтоосон болно:

- Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд ЭБША-ны явцад иргэний нэхэмжлэл гаргаж буй эсэх;
- ЭБША-ны явцад хохиролтой холбогдуулан тогтоовол зохих байдлуудыг тогтоож буй эсэх;
- ЭБША-ны явцад иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох, хөрөнгө хамгаалах зэрэг байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчээс хийж гүйцэтгэвэл зохих ажиллагаа хийгдэж буй эсэх;
- Хохирлын хэмжээг хэрхэн тогтоож, үнэлж буй практикийг тогтоох;
- Байцаан шийтгэх ажиллагааны аль шатанд хохирол ямар журмаар нөхөн төлөгдөж буй эсэх;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нотлох баримтыг шүүх үнэлэн шийдвэрлэж буй өнөөгийн байдал.

3. Мөн шүүх, прокурор, цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирол нөхөн төлүүлэлттэй холбогдуулж гаргасан тайлбар, журам, заавар, зөвлөмжийн чанартай баримт бичгүүдийг хуулийн эх заалтынх нь утга агуулгатай тулган судалж, дүн шинжилгээ хийлээ.

4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлтэд хохирогч болон хохирол нөхөн төлүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан хэрхэн хандаж буй хандлагыг тодорхойлох зорилгоор Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны 300 өрхөд асуулгын хуудас тарааж, 280 өрх буюу иргэнээс санал асуулгаар судалгаа авч, саналыг нэгтгэн төрөлжүүлж авч үзлээ.

5. Мөн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, ярилцах замаар хохирол нөхөн төлүүлэлтийн талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг тогтоосон бөгөөд энэхүү судалгаанд давхардсан тоогоор 35 шүүгч, 18 прокурор, 21 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, 43 хохирогч, 70 ялтныг хамруулсан болно.

6. Иргэд олноор хохирсон гэх хэргийг онцлон авч үзэж, хэргийн материал, шүүхийн шийдвэртэй танилцахын хамт энэ төрлийн хэргийг мөрдсөн мөрдөн байцаагчтай ярилцах замаар мөрдөн байцаах ажиллагааны явцад хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх болон хөрөнгө хамгаалах ажиллагаа явуулахад учирсан бэрхшээлийг тодорхойлохыг хичээсэн болно.

Судалгааны 4 дэх чиглэлийн хүрээнд[150] буюу үг чиглэлд дурдсан байдлыг тогтоохын тулд дор дурдсан ажлыг хийсэн болно. Үүнд:

1.Хоригдлоор хөдөлмөр эрхлүүлэх, тэдний хөдөлмөрийг үнэлэх, хөдөлмөрийн хөлс тооцох талаархи эрх зүйн зохицуулалт, мөн холбогдох журам, дүрмийг хууль тогтоомжтой харьцуулан дүн шинжилгээ хийсэн.

2.ШШГЕГ-ын харьяа хорих 407, 409, 421 дүгээр ангиудад ял эдэлж буй 70 ялтантай ганцаарчлан уулзаж, ярилцлага хийсэн бөгөөд энэхүү ярилцлагын судалгаагаар хоригдууд өдөрт ямар хугацаагаар хөдөлмөр эрхэлдэг, ийнхүү хөдөлмөрлөсний хөлс олгох журмын талаарх мэдлэг, хөдөлмөрийг үнэлж буй байдлыг тогтоож, дүн шинжилгээ хийсэн.

3.Ийнхүү ярилцлагын судалгааны үр дүнгээс шалтгаалан ШШГЕГ-аас авсан статистик үзүүлэлтийг дахин нарийвчлан судлах шаардлага тавигдсан бөгөөд хоригдлуудын нэрийн дансны орлого, зарлага, зарцуулалтыг судлах гэсэн боловч үүнийг баримтаар судлах боломжгүй байлаа /ШШГЕГ-аас энэ талаарх мэдээлэл гарсангүй/.

Судалгааны 5 дахь чиглэлийн хүрээнд[151] буюу үг чиглэлд дурдсан байдлыг тогтоохын тулд дор дурдсан ажлыг хийсэн болно. Үүнд:

Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүмүүсээр хохирол нөхөн төлүүлж буй байдал, түүнд учирч буй бэрхшээлийг судлах зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн бөгөөд энэхүү судалгаанд давхардсан тоогоор 13 шийдвэр гүйцэтгэгчийг хамруулсан болно.

Судалгааны 6 дахь чиглэлийн хүрээнд[152] буюу үг чиглэлд дурдсан байдлыг тогтоохын тулд дор дурдсан ажлыг хийсэн болно. Үүнд:

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлтийн талаархи АНУ, Англи, ХБНГУ, Япон, ОХУ-ын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан.

2.Олон улсын эрх зүйн баримт бичгийн зохицуулалт, үзэл баримтлалыг судалсан.

[150]Судалгааны тайлангийн 1.3 дахь хэсэгт дурдсан чиглэлийн 1-3-ыг харна уу.
[151] Судалгааны тайлангийн 1.3 дахь хэсэгт дурдсан чиглэлийн 1-3-ыг харна уу.
[152]Судалгааны тайлангийн 1.3 дахь хэсэгт дурдсан чиглэлийн 1-3-ыг харна уу.

ХОЁР. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

2.1. ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

а/ Хохирогчийн эрхийн талаархи эрх зүйн зохицуулалт

1. Монгол Улсын Үндсэн хууль[153]

▪*16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг.* Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй.

▪*17 дугаар зүйл.* Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

▪*19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.* Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2.Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль[154]

▪*42 дугаар зүйлийн 42.1.* Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ.

▪*42 дугаар зүйлийн 42.3.* Хохирогч, түүний төлөөлөгч нь дараах эрх эдэлнэ:

42.3.1.өмгөөлөгч авах /энэ заалт нь төлөөлөгч өмгөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй/;

42.3.2.баримт сэлт гаргаж өгөх;

42.3.3.нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;

42.3.4.шүүх хуралдаанд оролцох;

42.3.5.шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;

42.3.6.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

42.3.7.эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

42.3.8.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах;

---

[153]Энэ хууль 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 1992 он. №1

[154] Энэ хууль 2001 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №6

42.3.9.гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
42.3.10.цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах;

42.3.11.бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах;

42.3.12. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах.

- *43 дугаар зүйлийн 43.1.*Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.
- *43 дугаар зүйлийн 43.3.* Иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгч нь дараахь эрх эдэлнэ:

43.3.1.хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт гаргаж өгөх;

43.3.2.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд өөрийн нэхэмжлэлийг хангах талаар арга хэмжээ авахыг хүсэх;

43.3.3.шүүх хуралдаанд оролцох;

43.3.4.гаргасан нэхэмжлэлээ дэмжих, татгалзах;

43.3.5.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах;

43.3.6.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

43.3.7.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

43.3.8.шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.

- *43 дугаар зүйлийн 43.4.* Иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлтэй холбогдсон өөрт байгаа баримт сэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шаардсанаар гаргаж өгөх үүрэгтэй.
- *115 дугаар зүйлийн 115.1.*Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.
- *115 дугаар зүйлийн 115.2.* Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- *115 дугаар зүйлийн 115.3.* Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.
- *116 дугаар зүйлийн 116.1.* Иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг үүсгэснээс эхлэн шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд гаргаж болно.
- *116 дугаар зүйлийн 116.2.* Энэ хуулийн 116.1-д заасан хугацаанд

эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргаагүй, эсхүл гаргасан нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол түүнийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй.

3. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[155]

▪ *3 дугаар зүйлийн 3.1.* Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх буюу сэргээлгэх эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрхтэй" хэмээн тусгалаа олжээ.

Монгол Улсад 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдийг хохирогч, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эд хөрөнгийн хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан агуулга бүхий шинэлэг зохицуулалт болсон юм. Иймхүү гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь эрх зүйн, тэр дундаа эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн чухал шинэтгэл болжээ.

Гэмт хэргийн хохирогчид хуулиар олгосон эрх нь тэдний ашиг сонирхлыг хөндөхөөргүй харин ч хэрэгжүүлбэл эрхээ хангахуйц байдлаар зохицуулсан байна. Харин ЭБШХ-ийн 115 дугаар зүйлийн 115.1-ийн "гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй..." гэсэн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалт болон ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1-ийн заалттай зөрчилдөж буйг авч үзэх шаардлагатай байна.

б/ Хохирогчийн эрхийн хэрэгжилтийн байдал

Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд хууль ёсаар эрхээ хэрхэн хэрэгжүүлж буй байдлыг судалж, дүн шинжилгээ хийлээ.

1. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс 2001-2006 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн талаархи тоон мэдээг авч үзвэл:

[155] Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №7

Зураг 1



Цагдаагийн байгууллагын хохирол нөхөн төлүүлэлтийн тоон мэдээнээс харахад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад зөвхөн эд хөрөнгийн хохирлыг л тооцдог байдал харагдаж байна.

Мөн Цагдаагийн байгууллагын тоон мэдээ буюу улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ судалгаа гаргаж буй "Гэмт хэргийн улмаас учирсан хохирол"-ын статистик дүнг харуулах хүснэгт-11[156]-ээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мэдээг:

- Эд хөрөнгөд учирсан хохирол;
- Нас барсан хүн;
- Гэмтсэн хүн гэх үзүүлэлтээр гаргадаг байна.

Энэ байдлаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад эд хөрөнгийн хохирлын төрөл, хэмжээ, мөн хүний амь нас хохирсон болон биед учирсан гэмтлийн зэргийг л тогтоодог бөгөөд харин хохирогчийн эдийн бус хохирол нэхэмжлэх эрх хэрэгждэггүй болох нь тодорхойлогдож байна.

2. Хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нэхэмжилж буй байдал, түүний нэхэмжлэлийн шаардлагын дагуу хохирлын төрөл, хэмжээг тогтоож буй байдлыг эрүүгийн хэргийн материал судалж дүн шинжилгээ хийлээ.

- *Судалсан хэргийг төрөл*

Зураг 2



- *Иргэний нэхэмжлэл гаргасан хэлбэр:*

[156] Үндэсний статистикийн газрын зөвшөөрснөөр ЦЕГ-ын 2007 оны 4 тоот тушаалаар батлагдсан улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээний хавсралт хүснэгт-11.



Зураг 3

Судалсан хэргийн 81%-д нь хохирогч хохирлоо нэхэмжилсэн байх ба

- Иргэний нэхэмжлэл гаргах хэлбэрээр 5.1% нь;
- Байцаалтад дурдах хэлбэрээр 71.4% нь;
- Зөвхөн хохирлын баримт бүрдүүлэх хэлбэрээр 11.7% нь нэхэмжлэл гаргажээ /ийнхүү баримт бүрдүүлсэн тохиолдолд хохирлыг баримтаар тооцож гаргуулдаг практик байна/.

Энэ нь хохирол нэхэмжилсэн хохирогчдын 83.1% нь нэхэмжлэлийг ямар хэлбэрээр гаргахаа мэдэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

- *Гаргасан нэхэмжлэлийн шаардлага:*

Зураг 4



Судлагдсан хэргийн 86.7%-д нь хохирогч эдийн хохирол, 13.3%-д нь эдийн бус хохирол нэхэмжилсэн байх ба эдийн хохиролд эмчилгээний зардал, оршуулгын зардал, алдагдсан эд хөрөнгийн үнэ зэргийг багтаан нэхэмжилсэн бол эдийн бус хохиролд сэтгэл санаанд учирсан хохирлыг багтаан нэхэмжилжээ.

3. Хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлж буй байдлыг тогтоох зорилгоор хохирогч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нараас ярилцлагын аргаар судалгаа авсан.

Судалгаанд оролцсон хохирогчид:

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо ямар журмаар нэхэмжлэхээ мэддэггүй;
- Цагдаагийн байгууллагад эд зүйлээ алдсан тухай гомдол гаргахаар өөрийнхөө хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хохирсон хэмээн анхаарч үздэггүй;
- Санхүүгийн боломж муугаас тэмдэгтийн хураамж төлж чадахгүйгээс

www.ii.gov.mn

нэхэмжлэл гаргаж чаддаггүй;
- Хохирсон боловч хохирол учруулсан этгээдийг танихгүй, мэдэхгүйн улмаас хохирлоо нэхэмжилж чаддаггүй;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хохирогчийн талд биш харин гэмт этгээдүүдийн талд ажилладагаас хохирлоо нөхөн төлүүлж чаддаггүй;
- Хохирол учруулсан этгээд төлбөрийн чадваргүйгээс хохирлоо нэхэмжлээгүй;
- Гэмт хэргийн улмаас хохирсон тохиолдолд юу нэхэмжлэхээ мэддэггүй гэж ярьж байсан юм.

Судалгаанд оролцсон хуульчид:
- Хохирогчид шүүхийн шатанд, тэр бүү шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд ч юу нэхэмжлэх, ямар журмаар нэхэмжлэл гаргах, хохирлоо хэрхэн төлүүлэхээ мэддэггүй;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хохирогчид эрхийг нь сайн тайлбарлаж өгдөггүйгээс тэд хохирол нэхэмжлэх мэдлэг хомс байдаг;
- Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуульчилж өгөөгүйгээс бэрхшээл учирдаг. Тухайлбал, гэмт хэргийн улмаас хохирсон этгээд Монгол Улсад байхгүй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгч оролцуулах тохиолдолд энэхүү төлөөлөгчийг ямар журмаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах тухай хуульчлаагүй учраас хэрэг хэрэгсэхгүй болгогдох, түдгэлзүүлэгдэх зэргээр хохирогчийн эрх хангагдахгүй удааширдаг;
- Хохирогч нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргадаггүй, энэ ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч л хийвэл хийдэг;
- Хохирогч иргэний нэхэмжлэлээ хуульд заасан хэлбэрээр гаргадаггүй;
- Иргэн байтугай төр ч иргэний нэхэмжлэл гаргах эрхээ мэддэггүй;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар хохирлын асуудалд бус гэм бурууг нотлох асуудалд анхаарлаа чиглүүлдгээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийн хохирол нөхөн төлүүлэх эрх төдийлөн хэрэгжихгүй, иргэний журмаар хохирлын нэхэмжлэлээ шийдвэрлүүлж чирэгдэхэд хүрдэг гэж ярьж байлаа.

Ийнхүү хохирогчид болон хуульчдаас ярилцлагын аргаар авсан судалгаагаар хохирогч иргэний нэхэмжлэл гаргах эрхээ тэр бүр мэддэггүй, бүрэн хэрэгжүүлдэггүй, мөн аль байцаан шийтгэх ажиллагааны аль шатанд ямар эрх эдлэхээ бүрэн мэддэггүй, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч гэж ямар этгээд байх, тэрээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо ямар эрх эдэлж, үүрэг хүлээх талаар хуульд тодорхой тусгагдаагүй болох нь тогтоогдсон болно.

4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлтэд хохирогч хэрхэн хандаж буй хандлагыг тодорхойлох зорилгоор санал асуулгын аргаар судалгаа авсан.

Санал асуулгад оролцогчдын 75.3% нь гэмт хэргийн улмаас хохирч



байсан байх бөгөөд түүний 48.5% нь л хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас хохирсон этгээдүүдийн 51.5% нь гэмт хэргийн улмаас хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй ажээ.

Хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллад мэдэгдээгүй шалтгааныг судлахад "мэдэгдээгүй" гэж хариулсан хохирогчдын:

- 22.6% нь Цагдаагийн байгууллагад итгэдэггүй;
- 21.3% нь хохирол ялимгүй байсан;
- 25.3% нь төвөгтэй бөгөөд бэрхшээлтэй байдаг;
- 18.6% нь Цагдаагийн байгууллага хүнд сурталтай;
- 9.3% нь өмнө нь ийм тохиолдолд надад туслаагүй;
- 2.6% нь бусад шалтгаанаар Цагдаагийн байгууллагад хандаагүй гэжээ.

Дээрх дүнгээс харахад гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдүүд буюу хохирогч нарын 50 хүрэхгүй хувь нь хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллагад мэдэгдсэн байх бөгөөд ийнхүү хохирогчийн эрхийг хангах чиг үүрэг бүхий байгууллагад хандахгүй байгаа шалтгаан нь төвөг, чирэгдэл ихтэй, хуулийн байгууллагад итгэдэггүй, өмнө нь хандсан ч туслаагүй явдал гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хувь үзсэнийг анхаарах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагад мэдэгдсэнээр <u>хохирол төлөгдсөн эсэхийг</u> судлахад асуулгад оролцогчид /Цагдаагийн байгууллагад хохирсон тухайгаа мэдэгдсэн/-ын:

- 12.5% нь хохирлоо бүрэн нөхөн төлүүлсэн;
- 19.8% нь хохирлынхоо заримыг нөхөн төлүүлсэн;
- 67.6% нь хохирлоо огт нөхөн төлүүлээгүй гэж хариулжээ.

Хохирлоо бүрэн болон заримыг нөхөн төлүүлсэн бол аль шатанд нөхөн төлүүлсэн болохыг судлахад уг хохирогчдын /давхардсан тоогоор/:

- 54.5% нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд;
- 15.9% нь прокурорын хяналтын шатанд;
- 22.7% нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шатанд;
- 31.8% нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хохирлоо нөхөн төлүүлсэн байна.

Хохирлоо төлүүлж чадаагүйн шалтгаан, үүнд хэн буруутай болохыг судлахад уг хохирогчид:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээд ядуу байдаг;
- Хохирлын хэмжээ бага хэргийг Цагдаагийн байгууллага анхаарч үздэггүй;
- Эрхээ мэддэггүй учраас гэм буруутай этгээдээс эмчилгээний зардал гэх багахан мөнгийг аваад л салсан;
- Шүүх гэм буруутай хүний талд асуудлыг шийдсэнээс хохирлоо төлүүлж чадаагүй;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд олдоогүй;
- Цагдаагийн байгууллагын хүнд суртлаас болж хохирлоо нөхөн төлүүлж

чадаагүй;
- Шүүх, цагдаагийн байгууллагаар явахад цаг зав их зарцуулна, чирэгдэл ихтэй байсан учраас хохирлоо төлүүлэлгүй орхисон;
- Гэм буруутай этгээд хорих ял шийтгүүлээд явсан учир хохирлоо нөхөн төлүүлээгүй;
- Гомдол гаргаагүй учир хэргийг хаалаа гэсний би зөвшөөрсөн;
- Сэтгэл санааны хохирлыг тооцон үздэггүйгээс хохирлоо төлүүлж чадаагүй;
- Гэм буруутай этгээдийг бариад өгөхөд тавиад явуулсан хуулийн байгууллагын буруугаас хохирлоо төлүүлж чадаагүй;
- Хуулийн байгууллага жирийн иргэдэд үйлчилдэггүйгээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлж чаддаггүй гэж үзжээ.

Дээрх байдлаас хохирогч эрхээ хэрэгжүүлэхэд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байдал харагдаж байна.

в/ Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс хохирогчийн эрхийг хангаж буй байдал

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс хохирогчийн эрхийг эдлүүлэх, хангахад хэрхэн хандаж буйд дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Иргэний нэхэмжлэлийг хангах буюу гэмт этгээдийн хөрөнгийг хамгаалах ажиллагаа хийсэн талаархи тоон мэдээнд дүгнэлт хийхэд Улсын Мөрдөн байцаах газар 2005 оны 1 дүгээр улиралд 3 миллиард 766 сая төгрөгийн хохирлын 1 миллиард 836 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 622.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан нь нийт хохирлын 70.3% болж байна хэмээн дүгнэжээ[157].

Гэвч Мөрдөн байцаах газрын энэхүү дүгнэлт битүүмжилсэн хөрөнгийн хэмжээг нийт хохиролтой харьцуулахад 16.5%, харин нөхөн төлүүлсэн хохиролтой харьцуулахад 39.9% болж байгаа юм.

Харин хэрэг бүртгэх албаны 2002-2006 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн байдлыг авч үзэхэд жилд дунджаар нийт хохиролтой харьцуулахад 2.7%, нөхөн төлүүлсэн хохиролтой харьцуулахад 3.2%-тай тэнцэхүйц хэмжээний хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг зургаар харуулбал:

[157]ЦЕГ-ын иж бүрэн шалгалтыг үгтаж, МБА-аас хийсэн ажлын талаар хийсэн танилцуулга. 2005 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр.

Зураг 5



Иймхүү хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нөхөн төлүүлэх баталгаа болох *"Иргэний нэхэмжлэлийг хангах"* ажиллагаа хийхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хариуцлагагүй ханддаг буюу энэ ажиллагаа маш хангалтгүй түвшинд хийгддэг болох нь харагдаж байна.

2.Эрүүгийн хэргээс байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс хохирогчийн эрхийг эдлүүлэх. хангах талаар хэрхэн хандсан байдлыг судлахад:

Зураг 6



Иймхүү судалсан хэргийн дөнгөж 1.6%-д нь л иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авсан байх бөгөөд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас гаргасан тоо хэрэг судлах явцад давхар нотлогдсон нь энэ ажиллагаа ямар түвшинд хийгдэж байгааг тодорхойлж байна.

3. Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс хохирогчийн эрхийг эдлүүлэх, хангах талаар хэрхэн хандсан байдлын талаар ярилцлагын аргаар судлахад:

С*удалгаанд оролисон хүүльчид:*

- Зарим хэрэг дээр хохирогч буюу иргэний нэхэмжлэгч олддоггүй.

Тухайлбал, байгалийн ховор олдвор, алт, үнэт зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэх мэт гэмт хэргийн хохирогч хэн бэ гэдэг асуудал бүрхэг, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хохирогчийн эрэл хайгуул хийхэд хүрдэг;

- Хохирогчид хохирол нэхэмжлэх эрхээ шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хүртэл мэдэхгүй байсаар байдаг тул эрхийг нь тайлбарлаж, ойлгуулах ажиллагааг эхний шатанд буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хийж байх шаардлагатай;
- Хохирогчид эрхийг нь хэлбэр төдий биш маш тодорхой, тухайлбал улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх, эдийн болон эдийн бус хохирол нэхэмжлэх эрхийг болон эдийн, эдийн бус хохиролд ямар хохирол хамаарах тухай тайлбарлах шаардлагатай;
- Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нар эдийн бус хохирлын талаар ойлголтгүйгээс ийм шаардлага бүхий нэхэмжлэлийг авч үздэггүй;
- Иргэний хариуцагчийг тогтоох ажиллагаа учир дутагдалтай байдаг. Тухайлбал, насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, хуулийн этгээдийн албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдний төлөөлөгчийг иргэний хариуцагчаар татдаггүй;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар иргэний нэхэмжлэлийн талаар ойлголтгүйгээс иргэний нэхэмжлэл гаргахаар гайхах, хүлээж авахгүй байх, авсан ч хэрэгт хавсаргахгүй байх тохиолдол байдаг гэж хариулсан байна.

Хохирогч хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа нь нэг талаас хохирогчийн хууль, эрх зүйн мэдлэг, ухамсартай холбоотой боловч нөгөө талаас байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хохирогчийн эрхийг бүрэн, ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөлгүй, харин тайлбарлаж өгсөн мэтээр гарын тэмдэглэлд гарын үсэг зурууллах төдийгөөр хохирогчид хууль ёсны эрхийг нь тайлбарлах үүргээ хэрэгжүүлж байна.

Мөн нөгөө талаас практик дээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар иргэний нэхэмжлэлийн талаар төдийлөн сайн ойлголттой биш байгаагаас хохирогчид иргэний нэхэмжлэл гаргах эрхийг нь тайлбарлахгүй, улмаар иргэний нэхэмжлэл гаргахыг шаардахгүй, нөгөө талаас хохирлын асуудалд тэр бүр анхаарлаа хандуулахгүй, эрүүгийн хэргийг шалгах буюу гэм бурууг нотлох, хэргийг зүйлчлэх асуудалд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байгааг анхаарах цаг болжээ.

УЕП-ын 2007 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 269 тоот тушаалаар батлагдсан "Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос тавих хяналтын ажилд ЭБШХ-ийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан заавар"-ын 10 дугаар зүйлд "Эрүүгийн хэргийн хохирол нөхөн төлүүлэхэд тавих хяналт"-ын талаар заасан байх бөгөөд дээрх дүнгээс харахад прокурор хууль болон уг зааварт заасны дагуу хяналт тавих үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж байна гэж дүгнэх боломжгүй байна.

2.2. ХОХИРЛЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭГ ТОГТООЖ, ҮНЭЛЖ БУЙ БАЙДАЛ

а/ Хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх талаархи эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан "Хохирол нөхөн төлүүлэх эрх"-ийг хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх асуудал юм. Учир нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирлын төрөл, шинж, чанар, хэр хэмжээг зөв тогтоосноор, түүнийг зөв үнэлснээр хохирогчийн "гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх" хангагдах учиртай. Тиймээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирол нөхөн төлүүлэлтийн үндэс болох энэхүү ажиллагаа ямар түвшинд явагддаг болохыг судлахын тулд эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль[158]

- *80 дугаар зүйлийн 80.1.*Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад дор дурдсан асуудлуудыг нотолно:

80.1.5. гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ;

- *79 дүгээр зүйлийн 79.1.*Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэнэ.
- *79 дүгээр зүйлийн 79.2.* Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно.
- *79 дүгээр зүйлийн 79.4.* Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.
- *155 дугаар зүйлийн 155.1*. Шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэр тухай тогтоол гаргаж, түүндээ шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжээчийн нэр, шинжилгээ хийх хугацаа, шинжээчид тавих асуулт, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн эд зүйлийг тодорхойлон бичнэ.
- *123 дугаар зүйлийн 123.1*. Шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно.

[158]Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №6

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дээрх зохицуулалтаар дараах шаардлагыг хуульчилсан байгаа юм. Үүнд:

- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг заавал нотолсон байхыг;
- гэмт хэргийн нөхцөл байдлын талаар ЭБШХ-д заасан үндэслэл журмын дагуу олж авсан баримт, сэлт мэдээллийг нотлох баримт гэх ба энэ нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэлээр тогтоогдох болохыг;
- шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэр тухай тогтоол гаргаж, шинжээч томилон дүгнэлт гаргуулах эрхтэй болохыг;
- шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болохыг тус тус заажээ.

Хуульд заасан эдгээр шаардлага буюу хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийн түвшинг тогтоох зорилгоор нийслэлийн дүүргүүдийн шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн материалыг судалснаас гадна байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс ярилцлагын аргаар судалгаа авсан бөгөөд энэ байдлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд заасан хохирлын төрөл тус бүрээр судалж, дүн шинжилгээ хийлээ.

• *Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын тухайд:*

а/ Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Иргэний хууль[159]

▪ *510 дугаар зүйлийн 510.1.*Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.

б/ Хохирлын хэмжээг тогтоож, үнэлж буй байдал

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлдөг, мөн өмнө үйлчилж байсан болон одоо үйлчилж буй хуулиудад эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх асуудал тодорхой тусгагдсан тул харьцангуй нэг мөр шийдвэрлэгддэг гэж үзэх үндэстэй. Гэвч бодит байдалд буюу манай өнөөгийн практикт эд хөрөнгийн хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдал буюу хуулийн хэм хэмжээ ямар түвшинд хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж үзвэл:

[159]Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №7

1. Эд хөрөнгийн хохирлын хэмжээг хэрхэн тогтоож буйг эрүүгийн хэргийн материалаас судлахад ихэвчлэн "Үнэлгээний комисс" гэх этгээд үнэлгээ тогтоодог байна.

Үнэлгээний комисс дараахь хүснэгтийг ашиглан үнэлгээ тогтоодог.

Батлав..... МБА-ны дарга.....

№	Эд зүйлийн нэр	Чанар байдлын тодорхойлолт	Үнэлгээ			Тайлбар
			Хохирогчийн	Шалгаж буй газрын	Үнэлгээний комиссын	

Ийнхүү эрүүгийн хэргийн материал уншиж судалж байх явцад дээрх хүснэгтийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх үнэлгээний комисс үнэлгээг тогтоодог бөгөөд энэхүү комиссын бүрэлдэхүүн үндсэн ажил үүргийнхээ зэрэгцээ энэ ажлыг гүйцэтгэдэг, эд зүйл үнэлэх мэргэшил, мэддлэггүй хүмүүсээс бүрддэг байдал харагдаж буйгаас гадна ийнхүү үнэлгээ тогтоож буй этгээдүүд эд хөрөнгийн шинж чанарыг тогтоолгүйгээр үнэлж буй нь хохирлын үнэлгээг бодитой, зөв хийж буй гэдэгт эргэлзээ төрүүлж байгаа юм. Тухайлбал, нэгэн аж ахуйн нэгжийн агуулахаас алдагдсан гал тогооны шинэ тавилгыг үнэлэхдээ хохирогчийн санхүүгийн баримтад тусгасан үнэлгээнээс 30.000-50.000 төгрөгөөр бууруулж үнэлсэн байх атлаа яагаад ийнхүү бууруулан үнэлэх болсноо тайлбарлаагүй байна.

Ийнхүү эд зүйлийг үнэлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу хийгдэхгүй буюу үнэлгээ хийж буй комиссын гишүүд өөрийн үзэмжээр үнэлгээ хийж, хохирогчийн үнийн саналаас ихэнхдээ бууруулан үнэлж хэвшсэн, ийнхүү бууруулан үнэлсэн талаараа тайлбар хийхгүй байгаа байдал нь хохирлын хэмжээ бодит бусаар тогтох, улмаар хохирогчийг улам хохироохоод хүргэж байна.

Эд зүйлийн үнэлгээ хийхдээ эд зүйлийн шинж чанар, хэлбэр, эдэлгээ, зах зээлийн ханш зэргийг тооцож үзэлгүй үнэлж буй нь учир дутагдалтай байх бөгөөд зарим тохиолдолд үнэлгээний комиссын бүрэлдэхүүн ч харилцан адилгүй байна /2; 3; 4; 5 хүний бүрэлдэхүүнтэй байх гэх мэтээр/.

Энэхүү журмаар, дээрх хүснэгтээр үнэлгээ тогтоосон нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дор дурдсан хэм хэмжээнд нийцэхгүй байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Үүнд:

1.Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт нь .... шинжээчийн дүгнэлтээр тогтоогдох;

2.Шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулах;

3.Нотлох баримтыг цуглуулах талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах зарчим зөрчигдөж байна.

Ийнхүү үнэлгээний комиссоор үнэлүүлэхээс гадна дор дурдсан баримтыг үндэслэн эд хөрөнгийн хохирлыг тогтоож буй практик байна. Үүнд:

- Татвар, гаалийн байцаагчийн акт;
- Мэргэжлийн хяналтын байцаагчийн акт;
- Зардлын баримтаар тогтоох;
- Байгууллагын дансанд тусгасан үнэлгээ гэх мэт.

Эдгээр үнэлгээ нь мөн л дээрх зарчим, журмыг зөрчиж байгаа бөгөөд цаашид хуульд заасан журмын дагуу шинжээчийн дүгнэлтээр эд зүйлийн үнэлгээг тогтоолгох шаардлага зүй ёсоор тавигдаж буйг анхааруштай.

***2.** Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын хэмжээг хэрхэн тогтоож буйг ярилцлагын аргаар судлахад:*

Судалгаанд оролцсон хуульчид:

- Гэмт халдлагад өртсөн эд зүйл байхгүй тохиолдолд үнэлгээ тогтоох ажиллагаа бэрхшээлтэй;
- Үнэлгээний компаниуд үнэгүйг үнэтэй болгож, үнэтэйг үнэгүй болгож үнэлдэг;
- Археологийн ховор олдворыг үнэлэх үнэлгээ байхгүй;
- Мөн бугын чив, хүдрийн заар гэх мэт амьтны гаралтай, эрэлт хэрэгцээтэй зүйлийг үнэлэх үнэлгээ байхгүй учраас тухайн амьтны амьд үеийн үнэлгээгээр үнэлдэг;
- Алмаз гэх мэт эрдэнийн зүйлийг үнэлэх үнэлгээ байхгүй;
- Экологийн үнэлгээ хийдэг байгууллага болон үнэлгээ хийх аргачлал байхгүйгээс байгаль хамгаалах журмын эсрэг зарим төрлийн хэргүүд "үнэлгээ тогтоох боломжгүй" гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болох гэх мэтээр үнэлгээ тогтооход бэрхшээлтэй зүйл нэлээд байдаг тухай ярив.

Хохирлын үнэлгээг тогтоож буй дээрх журам, тогтолцооноос гадна хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар үнэлгээ хийлгэх эд зүйлийн шинж, чанар, эдэлгээ, элэгдлийн байдлыг тогтоох ажиллагаа хийдэггүй нь хохирлын хэмжээг бодитой, зөв тогтооход нөлөөлж буй хүчин зүйл болдог, мөн ховор, үнэт зүйлс гэх мэтийг үнэлэх аргачлал, үнэлгээ хийх эрх, үүрэг бүхий байгууллага байхгүйгээс зарим төрлийн гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоож чадахгүйд хүрч буй нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тулгамдсан асуудал болж байна.

***3.** Эд хөрөнгийн хохирлыг үнэлж, шийдвэрлэж буй практиктай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн "Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийг тайлбарлах тухай" 27 тоот тогтоолын хохирогчийн хохирол нэхэмжлэх эрхтэй холбоотой заалтад дүгнэлт хийвэл*:

• Тогтоолын 5 дахь хэсэгт "Тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэл гэмтлийн хэмжээг тодорхойлохдоо түүний эд ангийн хорогдлыг хасч, эвдэрч гэмтсэнийг засаж, сэргээхэд шаардагдах эд анги, бусад материалын үнийг

оруулан тооцно. Харин тэзврийн хэрэгслийн эвдэрч гэмтсэнийг засаж сэргээхэд гарсан ажлын хөлсийг тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг хэлэлцэх хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд үүнтэй холбоотой зардлыг ИХШХША-ны журмаар шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болох"-ыг заасан байна. Энэ нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөх хохирлыг ЭБША-ны явцад, харин тухайн хохирлыг дагаж учирсан шууд бус хохирлыг иргэний журмаар шийдвэрүүлэх агуулгыг илэрхийлсэн байх агаад энэ нь хохирогчийн хохирлоо нэг мөр шийдвэрлүүлэх эрхийг зөрчиж, чирэгдүүлсэн тайлбар болжээ.

4. *Мөн сүүлийн үед нэлээд олноор гарч, иргэдийг олноор хохироож буй "Банкны", "Хадгаламж зээлийн хоршооны" гэх тодотголтой хэргүүд дээр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх, хөрөнгө хамгаалах ажиллагаа хийхтэй холбоотой бэрхшээлтэй асуудлыг тогтоох зорилгоор мөрдөн байцаагч нараас ярилцлагын аргаар судалгаа авахад:*

- Маш олон хохирогчтой, хохирогч бүр хохирлоо өөр өөрөөр тооцож нэхэмжилдэг;
- Зарим хохирогч олддоггүй;
- Хүүтэй хадгаламжид мөнгөө хадгалуулсан байдгаас хохирлын хэмжээг тогтооход бэрхшээл учирдаг;
- Иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор эд хөрөнгийг битүүмжилж, үнэлүүлэхэд үнэлгээний байгууллагууд өөр өөрөөр үнэлгээ тогтоосноос эд хөрөнгийг бодитой үнэлэх боломжгүйд хүрдэг;
- Гэм буруутай этгээдүүд хөрөнгөө бусдын нэр дээр болгох зэргээр хөрөнгөө нуух явдал элбэг байдаг тул нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажил бэрхшээлтэй байдаг;
- Гэмт этгээдийн хөрөнгийг хураах, битүүмжлэх болоход тухайн хөрөнгө аль нэг банкны барьцаанд байх тохиолдол элбэг байдаг ба ихэвчлэн давхар битүүмжлэх ажиллагаа хийдэг;
- Хохирогч нар олноор хохирсноос бухимдах, төрөл бүрийн байдлаар эсэргүүцэх явдал их байдаг хэмээн бэрхшээл тооцож байсан юм.

Энэхүү олноор хохирсон хэргийн тухайд нуугдмал хөрөнгийг илрүүлэх, улмаар битүүмжлэх, мөн барьцаа авч, түүнийг иргэний нэхэмжлэлийг хангахад ашиглах шаардлагатай байна.

- *Гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд учирсан хохирлын тухайд:*

а/ *<u>Эрх зүйн зохицуулалт:</u>*

Монгол Улсын Иргэний хууль[160]

- <u>505 дугаар зүйлийн 505.1.</u>Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх,

[160]Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №7

хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй.

- *505 дугаар зүйлийн 505.2*. Гэм хор учруулах үед хохирогч цалин хөлс, орлогогүй байсан бол тэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах эрхтэй.
- *506 дугаар зүйлийн 506.1.*Арван зургаан нас хүрээгүй бөгөөд цалин, хөлс, орлогогүй иргэний эрүүл мэндэд гэм хор учруулсан бол гэм хор учруулсан этгээд нь ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан зардлыг энэ хуулийн 505.1-д зааснаар нөхөн төлнө.
- *506 дугаар зүйлийн 506.2.*Энэ хуулийн 506.1-д заасан хохирогч арван зургаан нас хүрсэн боловч эрүүл мэнд нь сайжраагүй бол хөдөлмөрийн чадвар алдсанаас учирсан хохирлыг хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр тооцож төлүүлэхээр түүний эцэг, эх, харгалзан дэмжигч шаардах эрхтэй.
- *506 дугаар зүйлийн 506.2.*Арван зургаан нас хүрээгүй иргэн эрүүл мэндэд нь гэм хор учруулах үед байнгын цалин, хөлс, орлоготой байсан бол хохирлыг дутуу авсан цалин, хөлс, орлогын хэмжээгээр төлүүлнэ.
- *507 дугаар зүйлийн 507.1.*Эрүүл мэндэд нь гэм хор учирснаас болж, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан иргэний хөдөлмөрийн чадвар нь цаашид дордох буюу авч байгаа тэтгэврийн хэмжээ багасвал гэм хор учруулсны төлбөрийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг хариуцагчаас шаардах эрхтэй.
- *507 дугаар зүйлийн 507.2.*Хохирогчийн хөдөлмөрийн чадвар сайжирсантай холбоотойгоор авч байгаа цалин, хөлс, орлого болон тэтгэврийн хэмжээ нэмэгдвэл хариуцагч нь гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг багасгахыг шаардах эрхтэй.

б/ Хохирлын хэмжээг тогтоож, үнэлж буй байдал:

1. Гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу гэмтлийн зэргийг тогтоох ажиллагаа зохих түвшинд хийгдэж байна гэж үзэх үндэслэлтэй. Өөрөөр хэлбэл, гэмтлийн зэргийг гагцхүү шинжээчийн дүгнэлтээр тогтоож буй нь хуульд нийцэж байгаа бөгөөд энэ нь зөвхөн гэмт хэргийг зүйлчлэх шалгуур болдог. Харин гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтооход ямар гэмтэл учирсан эсэхээс үл шалтгаалан зөвхөн эмчилгээ, асаргааны зардал, мөн хөдөлмөрийн чадвар алдсан хугацааны цалин хөлс гаргуулах зохицуулалт байдаг боловч практикт ихэвчлэн эмчилгээний зардал, цөөн тохиолдолд цалин хөлсний зөрүү нэхэмжилдэг байх агаад энэ нь хохирогч эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд ямар зардал нэхэмжлэх эрхээ мэддэггүйтэй холбоотой.

Мөн хуульчдын дунд ч, хохирогчдод ч ажилгүй буюу цалин орлогогүй



хүн эрүүл мэндийн хохирол хүлээснээс хөдөлмөрийн чадвараа алдсан бол нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэйг төдийлөн сайн мэддэггүй ажээ[161].

Хохирогч эрүүл мэндэд учирсан хохирлын үр дагавар болох эмчилгээний зардлаа эм, тарианы зардагын баримт, эмчилгээ, оношлогоо хийсэн баримтаар нотолдог бөгөөд хуулийн байгууллага ч энэ баримтыг үндэслэн хэргийг шийдвэрлэдэг байна. Ийнхүү шийдвэрлэж буй нь нэг талаас хохирогчид чирэгдэл учруулахгүй байгаа боловч нөгөө талаас хохирогч зарлагын баримт дээр дуртай эм, тарианы нэрийг бичиж, дуртай хэмжээгээрээ үнэ тавьдаг практик мэр сэр байдаг, шүүх эдгээр эм, тариаг хэрэглэсэн гэх эмчийн жор болон эмийн үнэлгээг төдийлөн харгалзалгүй шийдвэрлэдэг байна.

2.*Эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээг хэрхэн тогтоож, шийдвэрлэж буй талаар ярилцлагын аргаар судалгаа авахад:*

Судалгаанд оролцсон хүүльчид:

- Эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд эмчилгээний зардал гэх багахан зүйл гаргуулснаар хохирол барагдаж буй нь учир дутагдалтай;
- Гэмт хэргийн улмаас хохирогчийн аль нэг эрхтэн ажиллагаагүй болсон, эсвэл эрхтнээсээ хагацсан тохиолдолд хохирогчийн хохь болоод үлдэж буй нь зүйд нийцэхгүй байна;
- Машины эд анги бүр үнэлгээтэй байхад хүний эд эрхтэн үнэлгээгүй байна;
- Эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд нөхөн сэргээхэд гарсан зардлыг бодитой зардлаар тооцдог бүрүү практик, тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж үзжээ.

Судалгаанд оролцсон хохирогчид:

- Эрүүл мэндээрээ хохирчихоод байгааг харсаар байж хуулийн байгууллага нотолгоо, баримт шаардан хохирлыг шийддэггүй;
- Хохирлыг заавал бодитой гарсан зардлаар тооцдог;
- Байцаан шийтгэх ажиллагааны эцсийн шат хүртэл хохирол нөхөн төлөгдөхгүй чирэгдсэнээс эрүүл мэнд улам мууддаг;
- Хууль хохирсон хүмүүст уян хатан биш байна;
- Гэмт хэргийн улмаас эрхтнээсээ хагацаад хичнээн эмчилгээ хийлгээд ч засал авааг үй тохиолдолд зөвхөн эмчилгээний зардал л гаргадаг;
- Бие эрүүл байсан бол хичнээн их зүйл бүтээж, ямар орлого олох байсныг шүүх анхаарч үздэггүй гэж үзсэн байна.

Дээрх байдлаас гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд бодитой гарсан эмчилгээ, асаргааны зардал болон хөдөлмөрийн чадвар алдсаны зардлыг гаргуулснаар хохирол нөхөн төлүүлэлтийг хязгаарлан хуульчилсан нь хүний эрхийг бүрэн хангадаггүй бөгөөд хүний эд эрхтнийг үнэлэн хохиролд тооцон гаргуулж байх шаардлага байна.

Гадаад орнуудын туршлагыг судалж үзэхэд эрүүл мэндийн хохирлыг гэмт хэргийн улмаас учирсан хохирол /өвчний онош/-оор төрөлжүүлсэн тарифын үнэлгээнд суурилан олгодог ажээ.

[161] Энэ тухай Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 505.2-т заасан.

Тэгэхээр хохирогчийн бие, эрхтний гоо үзэмжийг алдагдуулсан, нөхөн сэргээгдэхгүй болгосон, бие эрхтэнээс нь салгасан зэрэг тохиолдолд тухайн эрхтнийг үнэлэх аргачлал, үнэлгээ байх, ийнхүү хохирол учруулсан тохиолдолд шүүх хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэдэг практик тогтоох шаардлагатай байна.

• *Гэмт хэргийн улмаас амь насанд учирсан хохирлын тухайд:*

а/ Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Иргэний хууль[162]

- *508 дугаар зүйлийн 508.1.*Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй.
- *508 дугаар зүйлийн 508.2.*Гэм хор учруулсны төлбөрийг нас барсан хохирогчийн асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах эрхтэй байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд, хохирогчийг нас барсны дараа төрсөн хүүхэд тус тус, түүнчлэн нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байгныг цалин хөлс орлогогүй эцэг, эх, нөхөр /эхнэр/-ийн аль нэг нь авах эрхтэй.
- *508 дугаар зүйлийн 508.3.* Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджаар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдсаны тэтгэврийг хасна.
- *508 дугаар зүйлийн 508.4.*Гэм хор учруулсны төлбөрийг дор дурдсан хугацаанд нөхөн төлнө:

508.4.1.бага насны буюу насанд хүрээгүй иргэнд арван зургаан нас хүртэл, харин сураліцаж байгаа бол арван найман нас хүртэл;

508.4.2.тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд бүх насаар нь;

508.4.3.тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдсон хугацаанд;

508.4.4.нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байгныг цалин, хөлс, орлогогүй нас барагчийн эцэг, эх, нөхөр /эхнэр/-ийн аль нэгэнд түүний нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр уг хүүхдийг найман нас хүртэл.

- *509 дүгээр зүйлийн 509.1.*Хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдсон төлбөрийг сар тутам төлнө.

б/ Хохирлын хэмжээг тогтоож, үнэлж буй байдал:

Амь нас хохирох гэдэг бол хамгийн хүнд төрлийн хохирол бөгөөд ийнхүү хохирсноор Үндсэн хуулиар олгосон "амьд явах эрх зөрчигдөж", улмаар тухайн этгээдийн ирээдүй, хүсэл, мөрөөдөл, амьдралын зорилго, итгэл найдвар тасрахын зэрэгцээ гэр бүл, ойр дотнынхонд нь туйлын их хохирол учирдаг онцлогтой.

[162]Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №7

1. Гэмт хэргийн улмаас амь нас хохирсны хохирлын хэмжээг тогтоож, шийдвэрлэж буй байдлыг хэргийн материалаас судаллаа.

Хүний амь хохирсон тохиолдолд практикт хохирогч нарс барснаар оршуулгын үйлдэл хийхэд гарсан зардал, мөн нас барагчийн авч байсан дундаж цалингаас өөрт нь болон түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсэг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг хассан хэмжээгээр олгодог байна.

Харин шашны зан үйлтэй холбоотой зардал буюу ном уншуулсны зардал, хоног хураахад гарсан зэргийг нэхэмжилсэнийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэдэг практик үндсэндээ хэвшжээ.

2. Гэмт хэргийн улмаас амь нас хохирсны хохирлын хэмжээг хэрхэн тогтоож буй талаар ярилцлагын аргаар судалгаа хийхэд:

Судалгаанд оролцсон хуульчид болон хохирогчид санал нэгтэйгээр "хүний амь нас гэх үнэ цэнэтэй зүйл"-ийн үнэлгээ байх шаардлагатай гэж үзжээ.

Тэгэхээр манай практикт хүний амь хохирсон тохиолдолд гаргах зардал хязгаартай хуульчлагдсан, хохирогчид хохирол нөхөн төлүүлэлтийн асуудалд сэтгэл дундуур үлдсээр байгааг бодит байдал харуулж байна.

АНУ-ын Канзас мужийн туршлагыг судалж үзэхэд нас барсан хохирогчид нөхөн төлбөр олгодог жишиг байдаг бөгөөд ийнхүү олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээг тогтоож өгдөг байна.

- *Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлын тухайд:*

а/ Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Иргэний хууль[153]

- *511 дүгээр зүйлийн 511.1.* Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.
- *511 дүгээр зүйлийн 511.2.* Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

б/ Хохирлын хэмжээг тогтоож, үнэлж буй байдал:

Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг арилгах, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй байгаа бөгөөд энэ нь хүний эрхийг хангах асуудал болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй байна.

***1.** Эдийн бус хохирлын төрөл, хэмжээг тогтоож буй байдлыг хэргийн материалаас судлахад:*

Эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоож буй практикийг

[153] АНУ-ын Канзас мужийн жишиг болон хохирогчийн нөхөн төлбөр авах тухай өргөдлийг хэрхэн шийдвэрлэсэн тухай дүнг Хавсралт7-оос харна уу.

судлахын тулд судалсан хэргийн хүрээнд байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатан дахь байцаалтын тэмдэглэлийг уншиж судлахад энэ талаар асуулт асуудаггүй, мөн шинжилгээ хийлгэх замаар хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох ажиллагаа нэг ч хийгдээгүй байлаа. Өөрөөр хэлбэл, хэргийн талаар *нотолбол зохих асуудлын нэг болох* гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг нотлоход чиглэгдсэн ажиллагаа огт хийгддэггүй байна.

Эдийн бус хохирол /сэтгэл зүй, бие махбодийн болон амь нас, эрхтний/-ыг хохирогчид нэхэмжилдэг боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд энэхүү хохирлыг нотлох ажиллагаа хийдэггүй, улмаар шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байсан бол сүүлийн үед хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд "сэтгэл санааны" хохирлыг тооцон гаргуулж эхэлсэн боловч хохирлыг үнэлэх аргачлал, журам байхгүй тул хохирогчийн нэхэмжлэлийн шаардлагын ихэнхийг тодорхой үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Жишээ: *Орхон аймгийн Сум дундын шүүх 2007 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 178 тоот шийтгэх тогтоолтой, насанд хүрээгүй хүнийг бүлэглэн хүчиндэх гэмт хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 497; 511 дүгээр зүйлд заасныг бариментлан хохирогчийн сэтгэл санааны хохиролд 1500000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэснийг түс аймгийн шүүх "...гэмт хэргийн үр дагавар, хэрэг гарснаас хойшхи хугацааны хохирогчийн сэтгэл зүйн байдал, сургууль, анги хамт олны хандлага, оршин суугаа газраа өөрчилсөн зэрэг байдал нь сэтгэл санааны хохирол бодитой би болсныг нотолж байна..." хэмээн дүгнэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.*

2. *Эдийн бус хохирлын төрөл, хэмжээг тогтоож буй байдлын талаар хуульчдаас ярилцлагын аргаар судалгаа авахад <u>судалгаанд оролцсон хуульчид:</u>*

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэтгэл санааны хохирол нэхэмжилдэг боловч энэхүү хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүйгээс байцаалт авахаас өөр ажиллагаа хийдэггүй;
- Эдийн бус хохирол гэдэгт юуг ойлгох талаар онол, практикийн түвшинд тайлбар байхгүйгээс энэ төрлийн хохирлыг шийдвэрлэх боломжгүй;
- ЭБШХ-д "эдийн бус хохирлыг нэхэмжлэх" эрхийг хуульчилсан боловч Иргэний хуульд хохирлын хэмжээг хэрхэн тогтоох, үнэлэх арга замыг хуульчлаагүй учир шийдвэрлэж болдоггүй;
- Хуульд эдийн бус хохирол гаргуулах зохицуулалт байхгүй учир гэмт хэргийн хохирогч, иргэний нэхэмжлэгч нарт эрхийг нь тайлбарлахдаа "эдийн бус хохирол нэхэмжлэх эрх"-ийг нь тайлбарлалгүй орхидог;
- Эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэхэд шүүгчдийн зориг дутдаг гэж хариулжээ.

Гадаад улсын туршлагыг судалж үзэхэд гэмт хэрэгт өртсөн хэнд боловч сэтгэл санааны хохирол учирдаг гэж үзэж, сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэдэг бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ гэмт хэргийн төрөл бүрээр тооцсон тарифын үнэлгээг үндэслэдэг байна. Жишээлбэл,

ОХУ-ын шүүхийн практикт сүүлийн үед А.М.Эрдевскийн зохиосон хүснэгтэд[164] үндэслэн сэтгэл зүйн хохирлыг тооцож байна.

Мөн гэмт хэргийн улмаас бие эрхтэндээ гэмтэл авч хохирсон этгээдэд өвдөж, шаналсных төлөө нөхөн төлбөр олгох зохицуулалт, мөн нэр төр, алдар хүндийн хохирол хүлээсэн этгээд ч мөн тариф-д суурилсан нөхөн төлбөр авах зохицуулалт байх шардлага байна.

Судалгааны явцад АНУ-ын хөгжлийн агентлагийн ШЭМШХ төслөөс 2007 оны 3 дугаар улиралд орон нутгийн сургагч багш нарт болон тэднээр дамжуулж, орон нутгийн бүх хуульч /шүүгч, прокурор, өмгөөлөгч/ нарт зориулж, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхойлох" сэдэвт сургалт зохион байгуулсан байх агаад энэ сургалтад хамрагдсан шүүгч нар гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэж эхэлж буй нь сургалтын үр дүнг харуулсан үзүүлэлт гэж дүгнэж байна.

2.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ШАТАНД ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

2.3.1. Хорих ял эдэлж буй хоригдлын хохирол нөхөн төлүүлэлт

а/ Эрх зүйн зохицуулалт:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

- *66 дугаар зүйлийн 66.2*. Хорих ял эдэлж байгаа ялтны төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр ялтны ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд гүйцэтгэх баримт бичиг явуулна.
- *66 дугаар зүйлийн 66.2*. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан хорих ангийн захиргаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.
- *121 дүгээр зүйлийн 121.1.* Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.
- *121 дүгээр зүйлийн 121.2.* Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ.
- *121 дүгээр зүйлийн 121.3.* Хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон энэ хуулийн 121.2-т заасны дагуу шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ.
- *121 дүгээр зүйлийн 121.4.* Энэ хуулийн 121.3-т заасны дагуу төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгоно.
- *121 дүгээр зүйлийн 121.5.*Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг

[164]Энэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл". 2002 он. №7

хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.

- *121 дүгээр зүйлийн 121.6*. Хорих анги, эсхүл ажил олгогч нь ялтны хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн үнэлгээ, ханшаар тооцно.
- *126[1]-дүгаар зүйлийн 126.1.* Ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, *гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол* түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга прокурорт гаргана...

2. НХХЯ-тай зөвшилцөж ШШГЕГ-ын даргын 2006 оны А/53 тоот тушаалаар батална "Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тооцох журам"[165]

• 2. Бусад байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хорих ангиас байгуулсан гэрээгээр ажиллах ялтны хөдөлмөр эрхэлсэн нэг өдрийн цалин хөлсийг:

- Хот суурин газарт 2400 төгрөг;

- Хөдөө орон нутагт 2000 төгрөгнөөс доошгүй байхаар тогтоож, цагийн үнэлгээнд шилжүүлэн тооцно.

• 3. Хорих ангид ял эдэлж байгаа ялтны ахуй үйлчилгээ, аж ахуй, үндсэн үйлдвэрлэлийн туслах чанарын ажилд нийт ялын 8-10% байхаар тогтоож, тэдгээрийн хөдөлмөрийн хөлсөнд хуулийн дагуу ногдох шагналын хоног олгож байх.

• 5. Хорих анги, байгууллагын өөрийн үйлдвэрлэл, байгууллагын хувь нийлүүлсэн болон хамтарсан аж ахуйн нэгж дээр ажиллаж байгаа ялтны хөдөлмөрийн хөлсийг энэ журмын 2 дугаар зүйлд заасан жишгээр тогтоож, дараах тохиолдолд суутгал хийсний дараа үлдэх цалинг нэрийн дансанд бичилт хийнэ. Үүнд:

1.Улсын төвлөрсөн төсвөөс дутуу санхүүжигдсэн ялтантай холбогдож гарах зардал болох /цахилгаан , дулаан, хоол хүнс, хувцас , ус ялтны эрүүл мэндийн даатгал, эм гэх мэт/ шууд зардал;

2.Ялтны шүүхийн тогтоолд заасан хохирол;

3.Ял эдэлж байхдаа анги байгууллагад учруулсан материаллаг хохирол.

• 6. Ялтны нэрийн дансанд төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг нь суллагдах үед өөрт нь олгоно.

[165] Хавсралт10-аас харна уу.

б/ *Хорих ял эдэлж буй хоригдлын хохирол нөхөн төлсөн байдал:*

Зураг 7

Хохирол төлсөн ялтны тоон үзүүлэлт



Хохирол төлсөн хэмжээний үзүүлэлт /мянган төгрөгөөр/



Хорих ял эдэлж буй ялтнуудын хохирол барагдуулалтын хувь хэмжээг харахад 2006 онд хамгийн өндөр буюу 22.9%-тай байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт бөгөөд ийнхүү маш бага хувиар барагдуулсан хохирлыг хөдөлмөр эрэлсний орлогооос уу, ар гэр нь нөхөн төлснөөс үү гэх мэт ямар эх сурвалжаас нөхөн төлөгддөг талаар судалгаа гаргах боломжгүй байлаа.

2. *Хоригдлын хохирол нөхөн төлөлтийн талаар ярилцлагын аргаар судлахад:*

Судалгаанд оролцсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд:

"Ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдах шаардлагыг хангахын тулд хохирлоо нөхөн төлдөг" хууль зүйн хөшүүрэг[166] байдаг тулдаа л хохирлыг нөхөн төлдөг, хэрэв хуульд ийм зохицуулалт байгаагүй бол хорих ял эдэлж буй этгээдийн хохирол нөхөн төлүүлэлтийн хувь ямар түвшинд байх вэ гэдгийг бодох хэрэгтэй гэж үздэг байна.

Судалгаанд оролцсон хоригдлууд бусдад учруулсан хохирлоо төлөхгүй байгаа шалтгаанаа:

[166]Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйл, ШШГТХ-ийн 126[1] дугаар зүйлийн 126[1].1

- Төлбөрийн чадваргүй, хорих ангид хөдөлмөр эрхлээд төлөх боломжгүй;
- Нэгэнт хорих ял эдэлж байгаа учраас хохирлыг нөхөн төлөхгүй;
- Хохирогч хохирлоо шаардахгүй байгаа;
- Суллагдаад ажил хөдөлмөр эрхэлж л төлөхгүй бол боломжгүй;
- Хохирогч өөрөө буруутай байсан учраас хохирлыг нөхөн төлөхгүй гэж тайлбарлаж байна.

3. Хоригдлоос хохирол нөхөн төлүүлэлтийн талаар санал асуулгын аргаар судлахад[167]:

Ялтнууд ял эдэлж байх хугацаандаа бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн эсэх талаар судлахад асуулганд оролцогчдын:

- 42 % нь хохирлоо огт төлөөгүй;
- 23.5% нь зарим хэсгийг төлсөн;
- 18.5% нь хохирлоо бүрэн төлсөн гэж хариулжээ.

Хохирлоо огт төлөөгүй буюу хагас төлсөн шалтгааныг судлахад асуулгад хариулагчдын:

- 36.1% нь төлбөрийн чадваргүйгээс;
- 19.3%нь хорих ялаа биечлэн эдэлж байгаа учраас төлөхгүй;
- 6.7% нь хохирлоо нөхөн төлөх хүсэлгүй гэжээ.

Энэ байдлаас ялтан болон хохирогч нарын дунд хорих ял эдэлсэн бол, мөн хохирогч буруутай, төлбөрийн чадваргүй бол хохирлыг нөхөн төлөхгүй гэх ташаа ойлголт байдаг агаад тэдний энэхүү ойлголтыг залруулах талаар зохих этгээд /өмгөөлөгч, хорих ангийн нийгмийн ажилтан, байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид гэх мэт/-үүд арга хэмжээ авдаггүй байна.

в/ Хоригдлын хөдөлмөр эрхэлж буй байдал:

Өнөөдөр хорих ангиуд өөрийн үйлдвэрлэл эрхэлж[168], уг үйлдвэрлэл дээр ялтныг ажилуулах замаар хөдөлмөр эрхлүүлж байгаа бөгөөд харин ийнхүү өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсан тохиололд хөлс биш харин тухайн ажлын төрлөөс хамааран ажлын хоногоор урамшуулдаг байна[169].

Ялтны хөдөлмөр эрхэлж буй байдлын талаар ярилцлагын аргаар судалгаа авахад:

Судалгаанд хамрагдсан хоригдлууд:

- Ажил бага байдаг, ихэвчлэн хорих ангийн үйлдвэрлэл болон хашаан дотор ажилладаг;
- Хоригдлууд 100 хувь ажил хийж чаддагүй, өдөрт цөөн тооны хоригдол л гадуур /гэрээт/ ажил хийдэг;
- Гэрээгээр ажилласан тохиолдолд хувцас, хоол хүнсээр хангадаг, харин хөлс өгдөггүй;
- Ажил сайн хийвэл шагналын хоног сайн өгдөг тул шагналын хоног өгөх гол хэрэглүүр нь хөдөлмөр эрхлэх явдал;

[167]ХЗҮТ-ийн КСС-оос 2007 онд явуулсан "Хорих ялын үр нөлөө" судалгааны санал асуулгын судалгааны дүгнээс хэсэгчлэн авав.

[168]Хорих ангиудын өөрийн эрхэлж буй үйлдвэрлэлийн чиглэлийг Хавсралт11-ээс харна уу.

[169]Хавсралт12-ыг харна уу.

- Хувь хүн болон компануудад ажил хийдэг, үүний төлөө шагналын хоног өгдөг;
- Хөдөлмөр эрхэлсний төлөө хөлс авдаг гэдгийг огт мэдэхгүй гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд:

- Өнөөдөр хорих ангийн ачаалал хэт ихэссэнээс батлагдсан төсөв нь үйл ажиллагааны зардалдаа хүрэхгүй, улмаар ялтны хөдөлмөрийн хөлс хорих ангийн үйл ажиллагаанд зарцуулагддаг;
- Хөдөлмөрийн хөлсийг ажлын хоногоор үнэлдэг гэхэд хилсдэхгүй, энэ нь ч хоригдлуудад ашигтай байдаг;
- Хөдөлмөрийн хөлс нэрийн дансанд орж, түүнээс хохирол нөхөн төлүүлж байх хуультай боловч хуульд заасан дараалаараа эхний ээлжинд хорих анги зардлаа суутгаж авдаг. Үүнээс хохиролд төлөх мөнгө үлддэггүй;
- Хөдөлмөрийн хөлснөөс хохирол төлсөн маш цөөн тохиолдол байдаг, бараг байхгүй гэж үзэж болно;
- Ялтнаар хийлгэх ажил олддоггүй, олдлоо гэхэд үнэлгээ нь маш бага учир үүнээс хохирол төлөх боломжгүй байдаг;
- Жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж буй ялтнууд хугацаанаас өмнө тэнсэн суллагдахын тулд ар гэрээс нь хохирлыг төлдөг гэж ярилаа.

Харин эмэгтэйчүүдийн хорих ангийн хувьд "Алтан жимс" ХХК, "Буян" ХХК-тай гэрээ байгуулан хоригдлуудыг ажиллуулдаг, хөдөлмөрийн хөлсийг өдөрт 2000 төгрөгөөр үнэлдэг бөгөөд уг компаниуд хоригдлын хөдөлмөр хөлсний 50%-ийг хорих ангийн дансанд шилжүүлж, 50%-ийг нь эмэгтэй ялтнуудын өдөр тутмын хэрэгцээнд зарцуулдаг гэх бөгөөд хорих ангийн дансанд шилжиж ирсэн гэх 50%-ийг хэрхэн зарцуулдаг болохыг судлах боломжгүй байлаа.

Энэ байдлаас харахад хоригдлуудад хөдөлмөр эрхлүүлэх боломж сайн биш, хөдөлмөрийн хөлсний үнэлгээ бага, мөн хорих байгууллагын төсөв хүрдэггүйгээс хоригдлын хөдөлмөр эрхэлсний хөлсийг дотоодын хэрэгцээнд, мөн ажлын хэрэгцээнд буюу бээлий гэх мэтэд зарцуулж, хохирол нөхөн төлүүлэлтэд зарцуулдаггүй гэж дүгнэхэд хүргэж байна.

Үүнтэй холбоотойгоор хорих ял эдэлж байгаа ажилтныг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бий болгох нь тулгамдсан асуудлын нэг болоод байгаа бөгөөд ялтныг гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэд байгууллагад учирсан хохирлыг ажил хийлгэж олсон орлогоос нөхөн төлүүлэх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.3.2.Хорихоос өөр төрлийн ял эдлэгсдийн хохирол нөхөн төлүүлэлт

а/ Эрх зүйн зохицуулалт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

▪ *77 дугаар зүйлийн 77.1.*Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй бол төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн олгоно.

▪ *77 дугаар зүйлийн 77.2.*Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжинд олгоно.

б/ Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүмүүсийн хохирол нөхөн төлсөн байдал:

Зураг 8



Энэхүү судалгаанаас харахад 2001-2004 онд хохирол нөхөн төлүүлэлт нэлээд өндөр хувьтай байсан бол 2005 оноос эхлэн хохирол нөхөн төлүүлэлтийн хувь буурч эхэлсэн байна.

Торгуулийн ял эдэлж буй төлбөр төлөгч, ААХЯ эдэлж буй төлбөр төлөгчийн хохирол нөхөн төлөлтийн байдлыг харьцуулж үзвэл: *Зураг 9*



Торгох ялтай төлбөр төлөгч нь ААХЯ-тай төлбөр төлөгчтэй харьцуулахад хохирол төлүүлэлтийн хувь харьцангуй бага байгаа бөгөөд энэ талаар

шийдвэр гүйцэтгэгч нартай ярилцаж, дүгнэлт хийх зорилго тавьсан болно.

Судалгаанд оролцсон шийдвэр гүйцэтгэгч нар:

- Торгох болон ААХЯ болон хохирол нөхөн төлөх гүйцэтгэх хуудас нэлээд олон байдаг боловч шүүх "Шийтгэх тогтоол"-доо ялтны хаягийг бичдэггүйгээс хохирол төлөгддөггүй;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд төлбөр төлөгчийн хөрөнгийг нь битүүмжлэх ажиллагаа хийгээгүйгээс төлбөр төлөгч нар хөрөнгөө нуух гэх мэтээр ШШГА-нд саад учруулдаг;
- Төлбөр төлөгчийн хаягийг бодитой тогтоодоггүй, өөрсдийнх нь амаар тогтоодогоос хаяг тогтоогдохгүй гэх шалтгаанаар шийдвэр биелэгдэхгүй удааширдаг;
- Шүүхийн шийтгэх тогтоолд гэм буруутай этгээд эд хөрөнгөгүй, эрхэлсэн ажилгүй гэж дурдсан атлаа торгох ял оногдуулж, хохирол гаргуулахаар шийдвэрлэдэг;
- Торгуулийн ялын хэмжээ өндөр учир ял, хохирлыг хувилан төлбөрт өгсөн мөнгийг хуваарилахад хохиролд маш бага хувь нь хийгддэг;
- Торгох ялаар шийтгүүлсэн этгээд хохирол төлөх тохиолдолд тэргүүн ээлжинд ялыг гүйцэтгэх шаардлагатай. Хохирогч хэл ам хийх цөөн тохиолдолд хувь тэнцүүлэх замаар ял, хохирлыг хуваан гүйцэтгэдэг;
- Прокуророос ялыг тэргүүн ээлжинд гүйцэтгэх шаардлага тавьж, гүйцэтгэхгүй бол шийдвэр гүйцэтгэгчид арга хэмжээ төлөхдөг зохисгүй механизм үйлчилдэг гэсэн байр суурийг илэрхийлсэн болно.

Судалгаанаас торгуулийн ял маш өндөр болсон, мөн торгох ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн төлөх төлбөр өндөр /Эрүүгийн хуулийн 148; 215 гэх мэт зүйлүүдэд заасан гэмт хэргийн хувьд/ байдаг тул аль аль нь биелэгдэхгүйд хүрдэг. Торгох ял дагасан хохиролтой гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэхдээ дараах журмаар ажилладаг. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ялыг тэргүүн ээлжинд гүйцэтгэх, хохирлыг дараагийн ээлжинд гүйцэтгэх;
- ШШГТХ-д заасны дагуу төлбөр авагч нэг бүрт төлөх төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн олгох.

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-ийн "хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч 1 жил өнгөрсөн бол ялтны ялыг эдлүүлж болохгүй" гэсэн заалтын дагуу торгуулийн ялыг хохирлоос тэргүүн ээлжинд гүйцэтгэхгүй бол "ялтан ял завших" боломжтой болдог учир шийдвэр гүйцэтгэгч нарын энэхүү үйл ажиллагааг буруутгах буюу үгүйсгэх боломжгүй юм.

Судалгаагаар энэ асуудлыг зохицуулсан журам, заавар байхгүй тул ШШГТХ-ийн 77 дугаар зүйлийг баримтлан зохицуулдаг болох нь тогтоогдсон бөгөөд харин энэ нь ШШГТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.2-ыг практикт зөрчиж хэрэгжүүлж байна гэх дүгнэлтэд хүргэлээ.

2.4. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ ТӨРӨӨС НӨХӨН БАРАГДУУЛАХ АСУУДАЛ

Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй учраас хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх талаархи гадаад улсын туршлага, олон улсын чиг хандлагыг судалсан юм.

а/ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх хууль тогтоомж

❖ **АНУ**

АНУ-ын Холбооны хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль (Victims of Crime Act (VOCA) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуульд 1988, 1993-1997, 1999-2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Уг хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зардал, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна.

Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан ажилладаг ажээ.

АНУ-ын 50 мужид гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд муж бүр тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Гэмт хэргийн хохирогчийн тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн хохирогчийн сангаас мужуудын хөтөлбөрийг санхүүгийн эх үүсвэрээр хангаж байна. 1884 онд батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд АНУ-ын хэмжээнд гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн дагуу муж бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн хамт уг асуудалтай холбогдсон зүйлтэй нийтлэг дараах эрх зүйн зохицуулалт байна.

АНУ-ын муж бүрт гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн дагуу *хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд* санхүүгийн тусламж үзүүлж байна. АНУ-ын Хууль зүйн яам нь Гэмт хэргийн хохирогчийн албаар дамжуулан дээрх хуулийн дагуу хөтөлбөрийн санхүүжилт болон техникийн туслалцааг муж бүрт үзүүлж байдаг байна.

❖ **ХБНГУ**

ХБНГУ-ын Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийг[170] 1976 онд батлан гаргаж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа

[170] 1984 онд батлагдсан гэмт хэргийн хохирогчийн тухай хууль нь Victim compensation and assistant act of 1984, Pub. L. 98-473, Title II, Chapter XIV, as amended, Title 42 – The Public Health and Welfare, Chapter 112 – Victim Compensation and Assistance. Уг хууль нь нийт 7 зүйл, заалтаас бүрдэх бөгөөд хуулийн 10601 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчийн сан

бөгөөд нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид н өхөн төлбөр олгох тухай хуулиар[171] нөхөн төлбөр авахад тавигдах хууль зүйн үндэслэл, гомдол гаргах, шийдвэрлэх журам, нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл, нөхөн төлбөр олгох зардал, гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, санхүүжүүлэх зэрэг нийтлэг асуудлыг зохицуулсан байна.

❖ АНГЛИ

Англид гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хуулийг (Criminal Injuries Compensation Act 1995) 1995 онд батлан гаргасан бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Уг хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

*Нөхөн төлбөр олгох хөтөлбөр.*Английн хуульд заасны дагуу нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг төрийн бие даасан байгууллага хэрэгжүүлдэг, хөтөлбөрийн зорилго нь хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгоход оршино. Хөтөлбөрт заасснаар хохирогч нь эрүүл мэндийн талаасаа өвчтэй байх, гэмтлийн нөхцлийг анагаах ухааны хувьд тодорхойлсон байх ёстой.

❖ ЯПОН

Япон улсын гэмт хэргийн хохирогчид төлбөр олгох тухай хууль[172] нь 1980 онд батлагдсан бөгөөд харин одоо уг хуулийг Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх тухай хууль гэж нэрлэх болсон байна. Япон улс нь гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөртэй бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог.

Японд Үндэсний нийтийн хамгаалах газрын Гэмт хэргийн хохирогчийн алба гэх байгууллага гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох ажлыг эрхлэн явуулдаг байна. Мөн Үндэсний цагдаагийн байгууллага нь уг ажлыг хариуцан ажиллаж байна.

❖ ОХУ

байгуулах, сан бүрдүүлэх эх үүсвэр, мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагаа, 10602 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох үндэслэл, хөтөлбөр, нөхөн төлбөр олгох зардал, 10603 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх, 10604 дүгээр зүйлд захиргааны үйл ажиллагаа явуулахтай холбогдсон заалт, 10605-р зүйлд гэмт хэргийн хохирогчийн албыг байгуулах, 10606-р зүйлийг хүчингүй болгосон, 10607-р хохирогчид туслалцаа үзүүлэх, 10608-р зүйлд гэмт хэргийн хохирогчийн шүүх хуралдаанд оролцуулахтай холбогдсон заалт.

[171] Гэмт хэргийн хохирогчийн тухай хуульд зааснаар гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох болон туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тэтгэлэгт хөтөлбөрийг зөвхөн төрийн болон ашгийн бус байгуулагаа хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийг сонгон шалгаруулалт хийх замаар хэрэгжүүлж байна.

[172] 1993 оны 7 дугаар сарын 21-ний өдөр уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

ОХУ 2004 онд хохирогч, гэрч болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай хуулийг[173] батлан гаргаж 2005 оны 1 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. 2006 оноос эхлэн Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Судалсан орнуудын хувьд "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах" бие даасан хууль батлан мөрддөг. Мөн үүний зэрэгцээ Хохирлыг нөхөн барагдуулах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ажээ.

Эдгээр орнуудын хувьд "Хохирол нөхөн барагдуулах тухай" бие даасан хуультай боловч энэхүү хууль нь зөвхөн "Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд"-д үйлчилдэг онцлогтой байна.

б/ Хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэр

❖ **АНУ**

Гэмт хэргийн хохирогчийн тухай хуульд зааснаар гэмт хэргийн хохирогчийн сангийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлдэг байна. Үүнд:

- гэмт хэрэгтэнд оногдуулсан торгууль, гэмт хэрэгт холбогдсоны торгууль[174];
- хураагдсан орлогын эх үүсвэр, хураамж зэрэг үүсвэрээс бүрдүүлдэг байна.

Зарим мужууд тодорхой орлогоос санхүүжилт хийдэг. Мужууд гэмт хэргийн хохирогчийн албанаас санхүүжилт авдаг бөгөөд уг санхүүжилт нь Холбооны Эрүүгийн хуулийн дагуу хийдэг байгаа торгууль болон шийтгэлээс бүрддэг байна.

❖ **ХБНГУ**

Хөтөлбөрийг ХБНГУ-ын төсвөөс санхүүжүүлдэг байна.

❖ **АНГЛИ**

Хөтөлбөр нь Засгийн газраас санхүүжилт болон татвар төлөгчийн орлогоор санхүүждэг.

❖ **ЯПОН**

Гэмт хэргийн хохирогчийн алба нь үндэсний төсвөөс санхүүждэг бөгөөд гэмт хэргийн улмаас өнчирсөн хүүхдэд болон гэмт хэргийн хохирогч нарт дэмжлэг үзүүлэх туслах сангаар дамжуулан тэтгэлэг олгоно.

❖ **ОХУ**

Хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хөтөлбөр зааасан байна.

---

[173] Уг хууль нь 13 зүйл, заалт бүхий хууль юм. Хуульд нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг Парламентаар оруулж батлуулахаар заасан байна.

[174] Япон улсын хуулийг англи хэл дээр хэсэгчлэн орчуулсан интернет эх сурвалжаас авсныг хавсаргав.

в/ Хохирогч нөхөн төлбөр авах эрх үүсэх шалгуур

❖ **АНУ**

Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллага болон хууль хяналтын байгууллагад 72 цагийн дотор мэдэгдэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад мөрдөн шалгах болон прокурорын байгууллагатай хамтран ажиллах, ямар ч гэмт хэрэгт холбоогүй байх, хуульд заасан хугацаанд өргөдлийг гаргасан байх[175].

❖ **ХБНГУ**

Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэж, хуульд заасан хугацаанд өргөдлийг гаргаж цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн байх, хохирогч цагдаагийн болон прокурорын байгууллагатай хамтран ажилласан байх.

❖ **АНГЛИ**

Цагдаагийн байгууллагад аль болох хурдан мэдэгдэх, гэмтэл авсан хохирогчид хүнд гэмтэл, сэтгэл санааны хохирол бодитой учирсан байх, нөхөн төлбөр авах гомдлыг хугацаандаа гаргасан байх.

Англи болон Умарт Ирландад гэмт хэргийн улмаас хохирсон гадаад улсын иргэн нөхөн төлбөр авах өргөдөл гаргах эрхтэй байдаг.

❖ **ЯПОН**

Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэх / хэзээ ч мэдэгдэж болно/, Өргөдөл гаргагч 2 жилийн дотор гэмт хэрэг гэж үзсэн буюу гэмт хэрэг гарснаас 7 жилийн дотор өргөдөл гаргасан байх ба гомдлыг Цагдаагийн байгууллагад гаргасан байх.

❖ **ОХУ**

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаагийн улмаас хамгаалалтад байгаа этгээд нас барсан, гэмтэл учруулсан болон бусад эрүүл мэндэд хохирол учруулсан бол нийгмийн хамгааллын арга хэмжээ хэрэглэх үндэслэл болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаагийн улмаас хамгаалалтад байгаа этгээдийн амь насыг хөнөөх, хүч хэрэглэхээр заналхийсэн, болон эд хөрөнгийг устгах үндэслэл бүхий мэдээ байгаа, нас барсан, гэмтэл учруулсан болон бусад эрүүл мэндэд хохирол учруулсан байх. Дээрхи хуулиар тодорхой нөхөн төлбөрийн хэмжээг[176] заагаагүй бөгөөд бусад хуульд заасан нөхөн төлбөр олгох хэмжээгээр олгохоор заасан байна.

[175]АНУ-ын эрүүгийн хуулиар хөнгөн гэмт хэрэгт холбогдсон бол 5 ам.доллараас 125 ам.долларын торгууль оногдуулдаг; хүнд гэмт хэрэгт 100 ам.доллараас 400 ам.долларын торгууль, байгууллагыг хөнгөн болон хүнд гэмт хэрэг хийсэн, хүн алсан бол 500,000 ам.доллар, хөнгөн гэмт хэрэгт 200,000 ам.доллараар торгох ял оногдуулж байна.

[176]Хөтөлбөрт 64,86 сая рублийг нөхөн төлбөрт олгохоор заасан байна.

г/ Гомдол гаргах эрх бүхий этгээд

❖ **АНУ**

Ихэнх мужид нөхөн төлбөр авах шаардлагага хангасан дараах этгээд гомдол гаргана.

• Хүч хэрэглэсэн гэмт хэрэг, хүний эрүүл мэндийг эсрэг гэмт хэрэг, хүн амины эсрэг гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүд;

• Гэмт хэргийн хохирогчийн төрөл садан, гадаад улсын иргэн

❖ **ХБНГУ**

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч, хүн амины эсрэг гэмт хэргийн гэр бүлийн гишүүд байна[177].

❖ **АНГЛИ**

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч, хүн амины эсрэг гэмт хэргийн гэр бүлийн гишүүд болон төрөл садангийн хүмүүс байна.

❖ **ЯПОН**

Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл учирсан бөгөөд хууль ёсоор Япон улсад амьдарч байгаа гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлийн гишүүд, гадаад улсын иргэн нь гэмт хэрэг гарах үед Японд хууль ёсоор байсан иргэн нөхөн төлбөр авах өргөдлийг гаргаж болно.

д/ Гомдол гаргах журам

❖ **АНУ**

Хохирогч гомдлыг 1 жилийн хугацаанд гаргах ёстой /зарим тохиололд хүндэтгэн үзэх шалтгааны харгалзан үзнэ/. Өргөдөл гаргагч гэмт хэрэг гарсан муж улсын нөхөн төлбөр олгох агентлагт хандаж өргөдөл гаргана. Хохирогчийн гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэн өргөдөл гаргагч хуулийн шаардлага хангаж байгаа эсэх, мөн санхүүгийн алдагдал бий болсон байдлыг агентлаг тодорхойлох болно. Ихэнх мужид хохирогч нь агентлагаас нөхөн төлбөрийн хэмжээг багасгах болон татгалзсан шийдвэр гаргасан бол уг шийдвэрийг давж заалдаж болохоор хуульчилсан байна.

❖ **ХБНГУ**

Гомдол гаргах хугацааг тогтоогоогүй боловч 1 жилийн дотор гомдол гаргах хугацааг баримталдаг. Хэрвээ нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэгдвэл гэмт хэрэг гарсан өдрөөс биш өргөдөл гаргасан өдрөөр нөхөн төлбөрийг олгоно. Гадаад улсын иргэний хувьд Европын Холбооны улсуудын хооронд харилцан тохиролцсон холбооны иргэд нөхөн төлбөр авах эрхтэй байна. Мөн гадаадын иргэн ХБНГУ-тай хоёр талын хэлэлцээртэй улсын иргэн бол нөхөн төлбөр авах эрхтэй байх бөгөөд мөн ХБНГУ-д албан ёсоор 3 жилийн хугацаанд амьдарч байгаа гадаадын иргэн нөхөн төлбөр авах эрхтэй

[177]Өргөдөл гаргах хугацаа 1 жил байна.

байдаг байна. Хохирогч гэмт хэрэг гарсан өдөр, байршил, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмтлийн талаар цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэх ёстой байдаг. Өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авсаас хойш 6 сарын дотор гаргасан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

❖ **АНГЛИ**

Гомдол гаргах хугацаа 2 жил байх бөгөөд Англид гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох байгууллага-Criminal Injuries Compensation Authority (CICA), цагдаа, орон нутгийн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх хөтөлбөр болон орон нутгийн иргэдэд зөвлөгөө өгөх албанаас өргөдлийг авч, гомдлыг хууль болон хөтөлбөрийн дагуу гаргана. Шаардлага хангасан өргөдлийг гэмт хэргийн улмаас хохирсон этгээд нөхөн төлбөр олгох байгууллагад буюу Criminal Injuries Compensation Authority (CICA) нөхөн төлбөр олгох тухай өргөдөл гаргаж хүргүүлсэн байна. Хөтөлбөрөөс эхний удаагийн шийдвэр нь 12 сарын дотор гарах бөгөөд өргөдлийг хянах, хэлэлцэхэд дахин хэсэг хугацааны дараа шийдвэрийг эцэслэн гаргана.

Өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн талаар түүнд мэдэгдэл хүргүүлэх ба нөхөн төлбөр олгох хөтөлбөрөөс 28 хоногийн дотор нөхөн төлбөрийг олгоно.

❖ **ЯПОН**

Цагдаагийн газарт заавал гомдол гаргана. Цагдаагийн байгууллага нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг тогтоосон байна. Гомдол гаргагч өргөдлийг маягтыг цагдаагийн байгууллагаас авч, гомдол гаргагч өргөлдөө харьяа нийтийн хамгаалах байгууллга руу тухайн өргөдөл гаргагчийн оршин суугаа цагдаагийн байгууллагаар дамжуулан хүргүүлсэн байна. Өргөдлийг хүлээн авсан байгууллага нь ойролцоогоор 5 сарын дараа шийдвэр гаргах бөгөөд мөн 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагч зохих хэмжээний төлбөрийг олгоно.

д/ Нөхөн төлбөрийн хэмжээ ба олгох хязгаар

❖ **АНУ**

АНУ-д муж улсын хөтөлбөрийн дагуу гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн доод хэмжээ нь 10.000 ам.доллар болон дээд хэмжээ нь 25.000 ам.доллар байх бөгөөд зарим мужид[178] нөхөн төлбөр олгох дээд болон доод хэмжээг харилцан адилгүй тогтоосон байна.

❖ **ХБНГУ**

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох дээд хязгаар байхгүй байна[179].

❖ **АНГЛИ**

Англид хөтөлбөрт заасны дагуу гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн

[178]АНУ-ын Канзас муж улсын нөхөн төлбөр олгох хэмжээг харуулсан баримтыг хавсаргав.

[179]Нөхөн төлбөр олгох хэмжээг хуульд заагаагүй бөгөөд төлбөрийн тухай хуульд тодорхой заасан байдаг байна.

төлбөрийн дээд хэмжээ 250.000 фунт стерлинг байх бөгөөд нөхөн төлбөр олгох доод хэмжээ 1000 фунт стерлинг байна. Умарт Ирландад нөхөн төлбөр олгох дээд хэмжээг тогтоогоогүй байна. Хэрвээ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүний гэр бүл, ойрын төрөл саданд нөхөн төлбөр олгож болно.

Англид нөхөн төлбөр олгохоор шаардлага хангасан өргөдөл гаргагч 11000 фунт стерлинг нөхөн төлбөрт авах эрхтэй байдаг. Харин өргөдөл гаргагч нэгээс дээш байвал тус бүр 5500 фунт стерлинг нөхөн төлбөр авна. Умарт Ирландад шаардлага хангасан өргөдөл гаргагч бүрт 12000 фунт стерлингийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх төлбөр авах эрхтэй байна. Английн хуульд зааснаар нөхөн төлбөрийн хэмжээг тарифт суурилсан үнэлгээгээр тогтоодог ба гэмт хэргийн хохирогчийн амьжиргааны алдагдал, бусад нэмэгдэл зардал, хүнд гэмт хэргийн хохирол зэрэг нэмэгдэл зардал олгох ба гэмт хэргийн хохирол нөхөн төлөх тариф[180] нь 1-25 түвшинтэй байна.

❖ **ЯПОН**

Хохирогчийн гэр бүлд 10179000 иений болон боломжит олговорт 12730000 иен олгоно.

Нас барахын өмнөх гаргасан эмчилгээний зардлын нөхөн төлбөрт 10790000 /2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид 15730000 иен/ олгоно. Хөдөлмөрийн чадваргүй болсоны нөхөн төлбөрт 12730000 иен /2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид 18492000 иен/ олгоно.

<u>е/ Нөхөн төлбөрт олгох зардал</u>

❖ **АНУ**

Мужууд дараах зардлыг нөхөн төлбөрт олгохоор заасан байна. Үүнд:

- Эмчилгээний зардал;
- Тахир дутуу болсон хохирогчийн цалин хөлс;
- Сэтгэл зүйн зөвлөгөө авсан зардал;
- Хүн амины гэмт хэргийн хохирогчийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх зардал;
- Оршуулгын зардал.

Мужууд дараах нэмэгдэл зардлыг нөхөн олгоно. Үүнд:

- Эмчилгээ хийлгэсэн;
- Хохирогчийн урьд өмнө хийж байсан ажлыг өөрчлөх талаар үйлчилгээ;
- Гэмт хэргийн газрыг цэвэрлэх;
- Нүүлгэн шилжүүлэх;
- Зайлшгүй хувийн хэрэглээний эд зүйлс;
- Нөхөн сэргээх;
- Хуульчийн хөлс.

[180] Дээрхи хуулийн 2.2 дугаар зүйлд тарифийн үнэлгээг үндэслэн нөхөн төлбөр олгох заасан байна.

❖ **ХБНГУ**

Хууль[181] болон хөтөлбөрийн дагуу эмчилгээ, асрах, нөхөн сэргээх, гэмт хэргийн хохирогч тахир дутуу иргэний амьдрах боломж буурсан бол тэтгэвэр олгох, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүл, физик эмчилгээ, оршуулгын зардал, гэр бүлийн гишүүдэд олгох нөхөн төлбөр, хохирогчийн урьд өмнө хийж байсан ажлыг өөрчлөхөд олгох төлбөр, туслалцаа зэрэг зардлыг нөхөн олгоно.

❖ **АНГЛИ**

Хөтөлбөрийн дагуу гэмт хэргийн хохирогчид дараах зардлыг нөхөн төлбөр хийх журмаар олгоно. Үүнд:

- Өвдөлт болон шаналалын төлбөр;
- Тахир дутуу болсон хохирогчийн цалин хөлс;
- Эмчилгээний зардал /хэрвээ үндэсний эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх буюу бусад эх үүсвэрээс үйлчилгээ авах боломжгүй бол/;
- Сэтгэл зүйн зардал /хэрвээ үндэсний эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх буюу бусад эх үүсвэрээс үйлчилгээ авах боломжгүй бол/;
- Оршуулгын зардал;
- Хүч хэрэглэсний улмаас эд хөрөнгө болон тоног төхөөрөмжид хохирол учруулсан бол;
- Орон сууцны нөхцлийг өөрчлөх;
- Аялалын зардал;
- Тахир дутуу хохирогчийн нөхөн сэргээлтийн зардал /хэрвээ үндэсний эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх буюу бусад эх үүсвэрээс үйлчилгээ авах боломжгүй бол/;
- Гэр бүлд олгох нөхөн олговор;
- Хүн амины эсрэг гэмт хэргийн улмаас хохирогчийн гэр бүлийн санхүүгийн алдагдлын дэмжлэг;
- 18 наснаас доош шаардлага хангасан өргөдөл гаргагчид эцэг эхээ алдсаны төлбөр

❖ **ЯПОН**

Хөтөлбөрийн дагуу эмчилгээний зардал, цалин хөлс, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговрыг бүхэлд нь олгодог байна.

❖ **ОХУ**

Нөхөн төлбөрт дараах зардлыг хамааруулдаг. Үүнд:

- Эмчилгээний зардал;
- Тахир дутуугийн нөхөн төлбөр;
- Оршуулгын зардал;
- Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас эд хөрөнгө болон тоног төхөөрөмжид учирсан хохирол.

[181] Дээрхи хуулийн 7 дугаар зүйлд нөхөн төлбөрт олгох зардлын талаар заасан байна.

е/ Яаралтай олгох нөхөн төлбөр

❖ **АНУ**

Зарим мужууд нөхөн төлбөрийг яаралтай олгодог бөгөөд хохирогчид санхүүгийн яаралтай хэрэгцээ тулгарсан тохиолдолд хохирлыг шуурхай барагдуулна.

❖ **ХБНГУ**

Хөтөлбөрт яаралтай нөхөн төлбөр олгох талаар тусгагдаагүй байна.

❖ **АНГЛИ**

Хөтөлбөрт эцсийн шийдвэр гаргахад хүртэлх хугацаанд нөхөн төлбөр олгох асуудал тодорхой бус байвал явцын нөхөн төлбөр олгож болно. Тухайлбал, хохирогчийн өвчний эдгэрэлт тодорхой бус байгаа нөхцөл гэх мэт.

❖ **ЯПОН**

Хэрвээ нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийг яаралтай гаргах боломжгүй бол, мөн гэмт хэрэгтэн болон гэмт хэргийн хохирол тодорхой бус байвал өргөдөл гаргагчид урьдчилсан нөхөн олговрыг хөтөлбөрийн дагуу олгоно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д заасанчлан төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүргийнхээ дагуу гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хэрхэн хангаж буйг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийв.

1.Хохирогчийн эрхийн хэрэгжилтийн талаар

Судалгаанаас гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт нь хуулиар олгосон иргэний нэхэмжлэл гаргах, гаргасан нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх, иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах эрхээ бүрэн хэрэгжүүлдэггүйгээс гадна нэхэмжлэлээ ямар хэлбэрээр гаргахаа ч мэдэхгүй байгаа нь иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсартай холбоотой тул тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

Хохирогчийн эрх бүрэн хэрэгжихгүй байгаа нь нөгөө талаас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болох нь санал асуулгын аргаар авсан судалгаанд оролцогчдын 75.8% нь Цагдаагийн байгууллагад итгэх итгэл, уг байгууллагын хүнд суртал, өмнө нь хохирогчид хандаж байсан хандлага зэргээс шалтгаалан хохирсон тухайгаа мэдэгдээгүй гэсэн хариулт өгснөөр тодорхойлогдож байх тул цаашид Цагдаагийн байгууллага гэмт хэргийн хохирогчийн эрхийг аль болох хангаж байхад анхаарч ажиллах шаардлагыг бий болгож байна.

Иргэний нэхэмжлэлийг хуулийн дагуу зөв шийдвэрлэж, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн үндэс нь иргэний нэхэмжлэлийг хангах ажиллагаа байдаг боловч байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид уг ажиллагаанд төдийлөн анхаарал хандуулдаггүй, харин гэм бурууг нотлох ажиллагаанд голчлон анхаарч ажилладаг, мөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэрээр гаргуулж авдаггүй, иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох ажиллагааг зохих түвшинд хийдэггүй нь тэднийг ЭБША дахь иргэний нэхэмжлэлийн талаар хангалттай мэдлэггүй, прокурорын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд тавих хяналт сул байна гэх дүгнэлтэд хүргэлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг гэмт этгээдийн эд хөрөнгийг хамгаалах ажиллагаагаар баталгаажуулахаар заасан боловч уг ажиллагаа нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үзэмжийн дагуу хийгдэх боломжтойгоор зохицуулагджээ. Хуулийн энэхүү зохицуулалт учир дутагдалтай байгаагаас шалтгаалан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийг хангах /нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах/ ажиллагаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хангалтгүй хийгдэж энэ нь шүүхийн шийдвэрийн зарим хэсэг буюу хохирол нөхөн төлүүлэх тухай шийдвэрийг биелэгдэхгүйд хүргэж байна. Иймээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах, хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх баталгааг хангах арга хэмжээний талаархи заалтыг боловсронгуй болгох санал боловсруулах шаардлага тавигдаж байна.

ЭБША-ны явцад иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох ажиллагаа хууль зүйн шаардлагын түвшинд хийгдэхгүй байна. Тухайлбал, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрийг байцаан шийтгэх ажиллагаанд иргэний хариуцагчаар хууль ёсны төлөөлөгчийг нь татах, хуулийн этгээдийн удирдлага үйл ажиллагааныхаа хүрээнд зохих үүргээ биелүүлээгүйгээс иргэнд хохирол учирсан хэрэг /Эрүүгийн хуулийн 183 (Аюулгүй үйл ажиллагааны журам зөрчих гэмт хэрэг) гэх мэт/-ийг байцаан шийтгэх ажиллагаанд хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар татах тухай хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь судалгаагаар тогтоогдлоо.

Мөн зарим төрлийн хэрэгт, тухайлбал хориглосон буюу хязгаарласан эд зүйл, ховор амьтан, эрдэнэс, эрдэс, байгалийн төрцийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд иргэний нэхэмжлэгчээр хэн оролцох нь тодохойгүй, өөрөөр хэлбэл, дээрх эд зүйлсийг нэхэмжилж авах этгээд тодорхойгүй байдаг нь байцаан шийтгэх ажиллагаанд тодорхой бэрхшээлийг учруулдаг байна.

2.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх талаар

Судалгаагаар байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх ажиллагаа зохих журмын дагуу хийгддэгүй, хамгийн төлөвшсөн гэж үзэх боломжтой эд

хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоох асуудалд, цаашлаад эрүүл мэнд, амь насанд учирсан хохирол болоод сэтгэл зүй, бие махбод, нэр төр алдар хүндэд учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх аргачлал, журам байдаггүй, эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй биш учраас хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх ажиллагаа бэрхшээлтэй, шийдвэрлэхэд төвөгтэй тулгамдсан асуудлын нэг болох нь тодорхойлогдсон.

Ялангуяа хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, бие махбод, нэр төр, алдар хүндэд учирсан хохирлын хэмжээний үнэлгээ тогтоогүй байгаад зохих түвшинд анхаарч, хохирогчид учирсан хохирлыг арилгах, эрхийг нь нөхөн сэргээхэд зориуд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал байна. Өнөөдөр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүй, зарим зүйлийн үнэлгээ ч тогтоогүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд тэр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Шүүхийн практик судалгаанаас харахад эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэдэг ажээ. Мөн ЭБША-ны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг нотлох, нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах ажиллагаа төдийлөн хийгддэггүй нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны практикаас харагдсан юм.

Иргэний хууль, бусад хууль тогтоомжоос харвал зөвхөн эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг хуульчилжээ. Харин сэтгэл зүй, бие эрхтэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжид тусгагдаагүй байна. Бусдыг санаатай алсан хэрэгт оршуулгын явцад гарсан шууд зардлыг л төлүүлдэг төдийгүй зан үйл шашны холбогдолтой зардлыг ч шүүхээс нөхөн төлүүлэлгүй орхидог байна. Энэ нь иргэд өөрийн өөрийн үзэл бодол итгэл үнэмшилтэй байх, Үндсэн хуулиар олгосон шашин шүтэх эс шүтэх эрхийн тухай асуудлыг үл хүндэтгэсэн хэрэг гэж үзэж болохоор байна. Нөгөө талаас ийнхүү шашны зан үйл үйлдэж буй нь хохирогч сэтгэл санааны тайвшрал авч буй хэрэг учир үүнийг хохиролд тооцохгүйгээр шийдвэрлэж буй шүүхийн практикийг өөрчлөх шаардлагатай. Тэгэхээр гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж, хүний юугаар ч нөхөж болшгүй эмзэг нандин эрхийг сэргээх ажиллагааны өнөөгийн практикийг сайшаан дүгнэх боломжгүй байлаа. Эрдэмтэн судлаачид эдийн бус хохирлын үнэлгээг хуулиар тогтоох, улмаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд дүйцүүлэн үнэлэх санал дэвшүүлсэн байдаг боловч судалгааны явцад сэтгэл зүй, бие эрхтний хохирол нь хүн бүрт харилцан адилгүй байдлаар учирдаг нь харагдсан учраас уг хохирлын жишиг үнэлгээг нэг мөр тогтоох нь учир дутагдалтай гэх дүгнэлтэд хүрлээ. Харин нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, бие эрхтэнд нь хэдий хэмжээний гэмтэл учирсныг шатлал /зэрэг/-аар шинжилгээ хийлгэх замаар тогтоож, шатлал бүрт хохирлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд

үндэслэсэн тодорхой тарифыг баримтлан хохирлыг тооцож байх нь зүйтэй гэх дүгнэлтийг хийж, тодорхой санал боловсруулсан болно.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатан дахь хохирол нөхөн төлүүлэлтийн талаар

Хорих ял эдэлж буй хоригдлуудын хувьд хугацаанаас өмнө тэнсэн суллагдах тохиолдолд хуульд заасан шаардлагын дагуу хохирлыг нөхөн төлөхөөс бусад тохиолдолд хохирлыг нөхөн төлдөггүй, хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх ажлын байргүйгээс хөдөлмөр эрхлүүлэх боломж муу байдаг, хөдөлмөрийн үнэлгээ нь зах зээлийн үнэлгээнээс бага байдаг, хорих ангийн ачаалал буюу хоригдлын тоо хэвийн буюу байх ёстой хэмжээнээс 50 орчим хувь илүү байгаагаас хоригдлын хөдөлмөр эрхэлсний хөлсийг хоригдлын хэрэгцээний төсөвт зарцуулдаг, үүнээс хохирол нөхөн төлөх боломж байдаггүй гэх шалтгаанаар бусдад учруулсан хохирлоо төлдөггүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ч хохирол нөхөн төлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авдаггүй байна. Иймд хоригдлын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх талаар зохистой арга хэмжээ авах, хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс хохирол нөхөн төлүүлэлтэд зарцуулах хувь хэмжээг журамлах; хөдөлмөрийн хөлсний үнэлгээ, зарцуулалтыг хоригдлуудад тайлбарлах, тайлагнах асуудлыг журамлах шаардлагатай байна гэж үзэж санал боловсруулаа.

Харин хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтнуудын хувьд, ялангуяа торгох ял эдэлж буй этгээдүүдийн хувьд ял болон хохирлын аль алиных нь хэмжээ өндөр байгаа тул ял, хохирлын алийг эхний ээлжинд гүйцэтгэх вэ гэдэг асуудал анхаарал татсан бөгөөд үүнийг шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Хорихоос өөр төрлийн ялыг биелүүлэхгүй 1 жилийн хугацаа өнгөрвөл ял эдлүүлж болохгүй гэх Эрүүгийн хуулийн зохицуулалтаас шалтгаалан шийдвэр гүйцэтгэгч нар ялаа эхлээд гүйцэтгэх бодлого барин ажиллаж буйг бууртгах аргагүй боловч энэ нь нөгөө талаасаа хохирогчийн эрхэд хэрхэн нөлөөлж буйг анхаарах, энэ асуудлыг журамлах цаг болжээ гэж дүгнэв.

4.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаар

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудал хуульчлагдан зохицуулагдаагүй, энэ талын практик байхгүй тул гадаад улсын хууль тогтоомж, практик болон олон улсын чиг хандлагыг тодорхойлсны үндсэн дээр Монгол Улс Үндсэн хуулийнхаа 19 дүгээр зүйлийн 1-д заасан "төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах" үүргээ хэрэгжүүлэх үүднээс гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулах эрх зүйн зохицуулалт хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрөөс хохирлын зарим хэсгийг ч болов барагдуулдаг шинэ тогтолцоо бий болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч, үүнийг хэрэгжүүлэх саналыг боловсруулаа.

ДӨРӨВ. САНАЛ

Судалгааны дүгнэлтэд үндэслэн хохирогчийн эрхийн баталгааг хангах, түүний хэрэгжилтийн түвшинг нэмэгдүүлэх талаар дараах чиглэлээр санал боловсруулаа. Үүнд:

Нэг. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

Арга зам:

1.ЭБШХ-ийн 115 дугаар зүйлийн 115.1-ийн "гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь .... иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн "... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй...", ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1-ийн "гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ", 43 дугаар зүйлийн 43.1-ийн "гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ" гэсэн заалтуудтай зөрчилдөж байх тул ЭБШХ-д зохих өөрчлөлт оруулж нийцүүлэн хуульчлах;

2.ЭБШХ-ийн 156 дугаар зүйл /шинжилгээ заавал хийлгэх/-д "эдийн болон эдийн бус хохирол нэхэмжилсэн этгээдийн эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, бие махбодид учирсан хохирол /зовиур, шаналал, өвчин буюу өвдөлт/-ын зэрэг, шинж байдал, үнэлгээг тогтоох" гэсэн агуулгыг нэмж оруулах;

3.ЭБШХ-ийн 123 дугаар зүйлийн заалтыг гэмт хэргийн улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан тохиолдолд заавал иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч байхыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгосон агуулгаар өөрчлөх;

4.Иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээнд "хөрөнгө барьцаалах арга хэмжээ авах" асуудал багтах агуулга бүхий зохицуулалт нэмж оруулах /ЭБШХ-д/. Өөрөөр хэлбэл, барьцааны хөрөнгөөр хохирол нөхөн төлүүлэх боломж бүхий заалт нэмж оруулах;

5."Хүний амь нас, эд эрхтнийг үнэлэх" агуулга бүхий зохицуулалтыг Иргэний хуулийн 505; 506 дугаар зүйлд тусгах замаар хуульд өөрчлөлт оруулах;

6.Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд бодит хохирлоор бус гарах шаардлагатай хохирлоор тооцон хохирлыг гаргуулах агуулга бүхий зохицуулалтыг Иргэний хуульд нэмж оруулах;

7.Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд "сэтгэл санаа, бие махбодийн хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцон гаргуулах" агуулга бүхий зохицуулалт нэмж оруулах;

8.ШШГТХ-ийн 121 дүгээр зүйлийн 121.1-ийн "...цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж ..." гэснийг тодорхой болгож буюу ямар төрлийн суутгал хамаарахыг нэрлэн зааж хуульчлах замаар өөрчлөх.

9. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах эрх зүйн тогтолцоо бий болгох



Арга зам:

- *Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тухай бие даасан хууль батлан мөрдөх. Хууль батлан гаргасантай холбогдуулан уг хуульд дараах агуулгыг тусгах:*

- Хохирлын сан бий болгох;

- Хохирлын сангийн санхүүгийн эх үүсвэрийг гэмт хэргийн хохирлын даатгалд иргэдийг хамруулах замаар, мөн торгох, эд хөрөнгө хураах ялын орлого болон бусад захиргааны торгууль, ААХЯ-ыг хөлстэй гүйцэтгэж, хөлсийг санд оруулах замаар, мөн төсвөөс тодорхой хэмжээгээр санхүүжүүлэх гэх мэт аргаар эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг хуульчлах;

- Гадаад улсын хууль тогтоомжид хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулахаар зохицуулсан байдаг боловч тус хуульд хүч хэрэглэсэн гэмт хэргээс өөр төрлийн гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн барагдуулах онцгой шаардлагыг хуульчлах;

- Гэм буруутай этгээд цаазаар авах ял шийтгүүлсэн ихэнхи тохиолдолд хохирол нөхөн төлүүлэлт хийгддэггүй учир энэ тохиолдолд хохирлыг төрөөс зайлшгүй барагдуулахаар зохицуулах;

- Төрөөс хохирол нөхөн гаргуулах журам, шаардлагыг хуульчлах гэх мэт.

Хоёр. Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх хүрээнд:

1.Иргэдэд гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах.

Арга зам:

- *Иргэдийг соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;*
- *Энэхүү үйл ажиллагаанд байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийг идэвхи, санаачилгатай оролцуулах;*
- *Эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулах чиг үүрэг төрийн болон төрийн бус байгууллагыг иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулж, төрөөс уг үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжих.*

2. Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх талаархи идэвхи, санаачилга, мэдлэг чадвар, хандлагыг сайжхуулах.

Арга зам:

- *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хохирогчийн эрх ба иргэний нэхэмжлэл" сэдэвт сургалт, хичээлд хамруулах;*
- *Хуульчдад "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тодорхойлох" сэдвээр сургалт явуулах;*
- *Хэрэг бүр дээр иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг авч хэвшүүлэх, энэ талаар зөвлөмж, чиглэл өгөх;*

- *Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоож, тэдэнд эрх, үүргийг нь тодорхой, дэлгэрэнгүй тайлбарлаж байх үүргийг хэрэгжүүлж хэвшүүлэх;*
- *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч зөвхөн эдийн хохирлоор хязгаарлахгүйгээр хэрэг болгонд эдийн бус хохирол учирсан эсэх болон түүний хэмжээг тогтоох ажиллагаа заавал явуулдаг болгож хэвшүүлэх, энэ талаар байнгын давтамж бүхий сургалт явуулах;*
- *Хохирогчийн иргэний нэхэмжлэл гаргах эрх буюу хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн талаархи прокурорын хяналтыг сайжруулах;*

3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэмжээг тогтоох аргачлал, журам, заавар боловсруулж мөрдүүлэх.

Арга зам:

- *Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал боловсруулах. Аргачлалын ерөнхий агуулгад дараах зүйлийг тусгах:*
  - *Эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоохдоо эд зүйлийн элэгдэл, хорогдлыг тооцон, нарийн мэргэшлийн шинжээчээр, мөн тухайн эд зүйлийн өмчлөгч, эзэмшигчдээ үнэ, цэнэтэй байх зэрэг шалгуурыг харгалзан үнэлэх;*
  - *Хүний биед гэмтэл учирсан тохиолдолд эрхтэн нэг бүрийн үнэлгээ байх шаардлагыг харгалзах;*
  - *Хүний амийг үнэлэх тариф бий болгох;*
  - *Сэтгэл санааны болон бие махбодийн хохирлыг сэтгэл санааны сөрөг хөдлөл, өвчний төрлөөс шалтгаалан зэрэглэж, зэрэглэл тус бүрт тариф тогтоох замаар үнэлэх;*
  - *Нэр төрийн хохирлыг тооцох тодорхой тариф бий болгох.*
- *Зарим төрлийн эд зүйл, тухайлбал эрдэнэсийн зүйл, түүхийн ховор нандин дурсгалт зүйл, амьтны гаралтай түүхий эд гэх мэтийг үнэлэх аргачлал, үнэлгээний тарифыг тогтоох;*
- *Төрийн эрх, ашиг сонирхолд хохирол учирсан хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд иргэний нэхэмжлэгчээр төрийг төлөөлж оролцох тухай заавар, журам боловсруулах.*

4. Хохирлын хэмжээ, үнэлгээг шинжээч томилон дүгнэлт гаргуулах шаардлагатай холбогдуулан хууль сахиулах байгууллагын төсөвдэх байцаан шийтгэх ажиллагааны зардлын төсвийг тодорхой хувиар нэмэгдүүлэх.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны журмыг боловсронгуй болгох.

Арга зам:

- *Хорих ял эдэлж буй этгээдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн норм, түүний орлогоос хохирол нөхөн төлүүлэх журмыг "хоригдлын нэрийн дансанд хөдөлмөрийн хөлсийг шилжүүлсний дараа хууль тогтоомжид заасан хувиар суутгал хийх, ялангуяа хохиролд заавал тодорхой хувийг суутган шилжүүлж байх" агуулгаар журамлах;*
- *Хоригдлын хөдөлмөрийн хөлсний норм, үнэлгээг ердийн ажлын үнэлгээтэй адил байх олон улсын зарчимд тулгуурлан шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;*

- *Торгох ялаар шийтгүүлсэн этгээдээс гаргуулсан төлбөр, ялыг биелүүлэх зарчим, дараалал, хувь хэмжээг тогтоосон журам боловсруулж, мөрдүүлэх;*
- *Дээрх журамтай холбогдуулан гэм буруутай этгээдэд торгох ял оногдуулахдаа хохирлын хэмжээг харгалзан бодитой биелэгдэх боломжтой ял оногдуулах тухай зөвлөмж гаргах талаар УДШ-д санал хүргүүлэх;*

Гурав. Зохион байгуулалтын хүрээнд:

1.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын зэрэг, шинж байдлыг иж бүрэн тогтоох шинжилгээний байгууллага бий болгох, энэ чиг үүргийг Шүүхийн шинжилгээний үндэсний төвд хариуцуулах;

2.Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх эмчилгээгээр засах гэх мэт замаар арилгах аргыг судалж, нэвүүлэх;

3.Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар "хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд бус иргэний нэхэмжлэлийн талаар гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах /иргэний нэхэмжлэлийг хангах/ ажиллагаанд ач холбогдол өгч ажиллах"-ыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт даалгах;

4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хэрэглэж буй "Иргэний нэхэмжлэгчээр тогтоох" тухай хэвшсэн бланкийг хуульд заасны дагуу өөрчлөх;

5.Иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэр /иргэний нэхэмжлэлийг бичгээр гаргах ИХШХШХ-ийн заалт бий/-ээр гаргуулж хэвшүүлэх, энэ талаар байцаан шийтгэх ажиллагааны үе шат бүрт анхаарч ажиллахыг зохих байгууллага, албан тушаалтанд даалгах;

6.Иргэний нэхэмжлэлийг хангах ажиллагаа хийсэн байдлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт болгох;

7.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлүүлэхэд тавих прокурорын хяналтыг сайжруулах, энэ чиглэлээр хэрхэн хяналт тавьсаныг прокурорын ажил дүгнэх үзүүлэлт болгох;

8.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг баримтжуулах, нотлох хуулийн шаардлагыг хангах үүднээс үйлчилгээний бүх төрлийн байгууллагуудад баримтаар үйлчлэх шаардлага тавих;

9.ШШГЕГ-т хоригдлын хөдөлмөр эрхэлсний орлогын зарцуулалтыг хуулийн дагуу хийх, мөн энэ талаар тодорхой судалгаатай байхыг даалгах;

10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг сайжруулах үүднээс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.

Арга зам:

- *Хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор барилга, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжтэй харилцан холбоотой ажиллах;*
- *Хоригдлыг хөдөлмөр эрхлүүлсэн аж ахуйн нэгжид татварын болон бусад зохих хөнгөлөлт үзүүлэх замаар урамшуулал үзүүлэх.*

__oOo__

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ХАВТАСТ ХЭРГИЙН СУДАЛГАА

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол Улсад 2002-2007 онд шүүхээр шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болгосон ЭХ-ийн 113 дугаар зүйл, 124 зүйлд заасан эрүүгийн хавтаст хэргийн судалгааг 2009 оны 3 дугаар сарын 9-ны өдрөөс 2005 оны 3 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл Улсын Ерөнхий Прокурорын газрын төв архив, нийслэлийн Прокурорын газрын архивын материалд түшиглэн явуулаа.

Судалгаанд сүүлийн 3 жилд буюу 2004-2007 онд нийслэлийн дүүргүүдийн шүүхээр нийтлэг шийдвэрлэгдсэн дараах төрлийн хэргийг багтаан судалсан болно. Үүнд:

- Хүн худалдах худалдан авах гэмт хэрэг;
- Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, бие үнэлэхийг зохион байгуулах;

Судлаачдын бүрэлдэхүүн: ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд, Д.Тамир, Б.Одонгэрэл

1.2 Судалгааны зорилго

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу "Хүн худалдах худалдан авах"; 124 дүгээр зүйл буюу "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, бие үнэлэхийг зохион байгуулах" гэмт хэрэг шийдвэрлэгдсэн байдлыг судлах.

Энэ хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаа:

- Хохирогч хамгаалал
- Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт
- Нотлох баримт
- Зүйлчлэл
- Прокурорын хяналт
- Шүүн таслах ажиллагаа

1.3 Судалгааны хамрах хүрээ

Судалгааны хүрээнд нийт 17 эрүүгийн хэргийг тодорхой аргачлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэргийн төрөл тус бүрт /эрүүгийн хэргийн архивт байгаа/ судалгаа хийсэн болно. Зөвхөн судалгаанд хамрагдсан буюу уншиж судалсан хэргийн хүрээнд судалгааны дүнг тодорхойлсон болно. Судалгааны ажлын урьдчилсан тайланг энэ чиглэлээр дагнан бие даан судалгаа хийдэг таван экспертүүдээр хянуулав. Экспертүүдээс ирүүлсэн санал, дүгнэлт зөвлөмж, тоон статистик үзүүлэлтүүдийг нэмж тусгалаа.

P.s: 2008 оноос хойшхи хэргүүд нь эцэслэн шийдвэрлэгдээгүй, эрүүгийн хэргийн төв болон нийслэлийн архивт ирээгүй, ажиллагаанд буцсан зэргээс

шалтгаалж судалгаанд хамруулах боломжгүй байсан болно. Цаашид дээрх судалгааг үргэлжлүүлж хийх шаардлагатай болно.

1.4 Судалгааны ерөнхий зарчим

- Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах
- Хохирогч хамгааллын зарчмуудыг удирдлага болгов.
- Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс болох хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдлыг тогтоох;
- Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлтэд хохирогч болон хохирол нөхөн төлүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан хэрхэн хандаж буй хандлагыг тодорхойлох

1.6 Судалгааны түүвэрлэлт

Судлагдсан хэрэг бүрт түүвэрлэлтийн аргыг хэрэглэхдээ тухайн хэргийн онцлогийг харгалзан мэдүүлгэн нотлох баримтыг голчлон авч үзэв. Тухайлбал гэрч, хохирогчийн мэдүүлэг, байцаалтын тэмдэглэл, шүүхийн шийтгэх тогтоолыг түүвэрлэн авав.

1.7 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг удирдамжид заагдсан чиглэлийн дагуу тусгайлан гаргасан хүснэгтийг ашиглан боловсруулав.

ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН

2.1 *ЭРҮҮГИЙН ХЭРЭГ*



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
WWW.ITC.GOV.MN

Судлагдсан эрүүгийн хэргийн зүйл, хэсэг



Шинжээчдээс ирүүлсэн нэмэлт мэдээлэл:

• УДШ-ийн Судалгааны төвөөс 2002-2008 онд хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах талаар хийсэн судалгаанаас үзэхэд энэ таван жилд эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 4 хэрэгт 4 хүн ял шийтгүүлсэн бол 124 зүйлээр 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлсэн байна. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 2006 онд-1хэрэгт 1 хүн, 2007 онд-1хэрэгт 1 хүн, харин 2008 онд-2 хэрэгт 2 хүн ял шийтгүүлжээ. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр 2005 онд - 2 хэрэгт 5 хүн, 2006 онд - 2 хэрэгт 1 хүн, 2007 онд – 8 хэрэг 8 хүн ял шийтгүүлсэн бол 2008 онд 20 хэрэгт - 39 хүн ял шийтгүүлжээ. Гэтэл ЦЕГ-ын МДШТ-ийн мэдээгээр 2007 онд хүн худалдаалах гэмт хэрэг огт бүртгэгдээгүй бол 2008 онд 9 хэрэг бүртгэгджээ. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2007 онд огт бүргэгдээгүй бол 2008 онд 27 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

• Нийслэлийн дүүргүүдийн 2008 оны бүтэн жилийн мэдээнээс харахад "Хүн худалдаалах" гэмт хэрээр зүйлчлэгдсэн нийт 4 хэрэг хүлээн авч, 2 хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, 2 хэрэгт 2 хүн ял шийтгэсэн бол, ЭХ-ийн 124 дүгээр зүйлд зааснаар зүйлчлэгдсэн нийт 19 хэргийн 37 хүнд ял шийтгэсэн байна.

Энэ тоон үзүүлэлтээс харахад хүн худалдаалах гэмт хэрэг өмнөх оныхоос өсөөгүй боловч ЭХ-ийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг өмнөх оныхоос /өмнөх онд 6 хэрэгт 6 хүн шийтгүүлсэн/ хэрэг 68 хувиар, хүн 83.7%-иар тус тус өсчээ. Энэ тоон судалгаанаас харахад 124 дүгээр зүйлд заасан ял шийтгүүлэгчдийн 65 хувь нь эмэгтэйчүүд, нийт ял шийтгүүлсэн 37 ялтны насны байдлыг судлахад 19-30 насны 9, 31-35 насны 18, 36 –аас дээш настай хүн 18 байна. Боловсролын хувьд дээд мэргэжилтэй 8, тусгай дунд 4, бүрэн дунд 16, суурь боловсролтой 7, бага боловсролтой 2 байна. Нийт ажил сургуульгүй хүн 19, гадаадын ирэн 3 хүн байна.

2.2.ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

Нийт уншиж судалсан 17 хэргээс "хохирогч хамгаалал"-ын асуудлыг шийдвэрлэсэн өөрөөр хэлбэл түүнийг ашуулгүй байдлыг хангаж тусгаарласан, эмнэлэг, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулсан, хувийн байдлыг тогтоосон баримт огт байгаагүй нь манай улсад гэрч, хохирогчийн хамгаалал байхгүй байгааг харуулж байна.

Шинжээчдийн зүгээс: Хүн худалдах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн эсэхээс үл хамааран гэмт хэргийн эмзэг хохирогчид учирсан эдийн болон эдийн бус гэм хорын хохирлыг төрөөс нөхөн төлөх тухай хуулийг батлан гаргах шаардлагатай гэж үзэж байна. Мөн хохирогч хамгаалллын асуудалд хүүхдийг онцлон үзэж, хүн худалдах гэмт хэргээс салгаж тусгайлан хуульчлах, Эрүүгийн хуульд бие даасан төрөл болгон оруулах бодлогыг явуулах хэрэгтэй талаар дурджээ.

2.2.1 Дарамт

Судалсан эрүүгийн хэргийн хохирогч нарын дийлэнх нь буюу 70 гаруй хувь нь хуурташгдсан, хүчинд автсан зэрэг аргагүй нөхцөл байдлын улмаас байнгын биеэ үнэлсэн буюу бэлгийн мөлжлөгөд өртжээ. Сонирхол татаж байсан нэг асуудал бол БНХАУ болон Эрээн, Макаод байгаа хүн худалдах гэмт хэргийг гардан үйлдэж байгаа этгээдүүд нь хохирогчид учруулах бие, сэтгэл зүйн дарамтыг тун сайн ашиглаж сурсан байна. Жишээлбэл хохирогч нарыг хооронд тусгаарлах, бичиг баримтыг нь хураан авах, хуурамч өр үүсгэх, элдэв эм тариаг дарамтлах замаар албадан хэрэглүүлж эрүүл мэндийн хувьд хохироосон байдлууд гарсан байна.

Мөн анхаарал татахгүй байхын аргагүй нэг асуудал бол иргэний бичиг баримтыг нь эзэнд өгөх зэргээр хараа хяналтанд нь байлгаж эрхшээлдээ оруулсан, өр төлөөс төлөх маягаар дарамталж биеэ үнэлэхээс аргагүй нөхцөл байдалд оруулж бэлгийн мөлжлөгөд өртүүлжээ.

Жишээ №1: БНХАУ-ын "Магисс" бааранд биеэ үнэлдэг байсан гэх хохирогч нарын мэдүүлгээс үзэхэд бусдын эрхшээлд биеэ үнэлж байгаа Монгол эмэгтэйчүүд Бээжинд их байдаг /№1 хэргээс/

Жишээ №2: Хохирогч Х нь: *...массажист хийж байгаад оргон, баригдаж зодуулж байсан, хүчээр биеэ үнэлэхийг шаардаж хүний эрхшээлд байсан. Хөхөнд маань мэс засал хийлгэж, өр нэхэх, бэлгийн харьцаанд хүчээр оруулах, дүүгээс минь тусгаарлах, бичиг баримтыг нь хураан авах, өгөхгүй байх, зэргээр элдэв дарамтанд байлгаж байсан".*

Жишээ №3 .Хохирогч Б–гийн мэдүүлэгт *"..биеийг маань хүчээр үнэлүүлсэн, хууран мэхэлж хил давуулан гарган, байнгын зоддог, дарамталдаг, хяналтан доор харгалзан харж байсан ба гар утсаар ярихад нь төхөөрөмж суурилуулсан тул хамаагүй юм ярьж болохгүй гэдэг байсан"*

"..Гадаад паспортыг нь барьцаалснаас зугтах боломжгүй байсан, ... зарим охидтой өөрсдөө *бэлгийн харьцаанд ордог байсан ...ажилд гарах боломжгүйгээс болж мөнгө олоогүй өдөр нь 500 юань гэж тооцон хуурамч*

өр үүсгэдэг байсан ба сарын тэмдэг ирсэн үед нь хүртэл биеэ үнэлэхийг нь шаарддаг гэх мэт зүй бусаар харьцдаг зүйлүүд байсан" гэж мэдүүлжээ.

Гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүд нь утсан болон цахим харилцааны хэлбэрт байнгын хяналт тавьж зориудаар төөрөгдүүлэн ар гэрийнхэнд нь өөрсдөөр худал яриулдаг байжээ. Жишээ аваад үзэхэд О нарт холбогдох хэрэгт гэмт хэрэг гардан үйлдэж этгээдүүд нь хохирогчдыг хажуудаа байлгаж, утсаар *"энд сайхан байна, санаа зовох хэрэггүй ээ , мөнгө олоод явж байна"* гэхчилэн яриулдаг, эсвэл худал мэдээлэл агуулсан захиаг зуучлагчаар болон хэн нэгэн этгээдээр хүргүүлдэг байсан байна.

2.2.2 Хохирогч:

Хохирогч нарын тухайд судалгаа хийхдээ урьд энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудад дурдагдсан нийтлэг дүгнэлтүүдээс зайлсхийхийг хичээсэн болно.



Судлагдсан эрүүгийн хэргүүдээс үзэхэд 30 хувь нь 18-21 насны, 20 хувь нь 21-26 насны эмэгтэйчүүд байгаагаас үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь залуу хүмүүс байна. Түүнчлэн хувь хүний төлөвшил бүрдээгүй, хувийн байдал нь тогтворгүй, бусдад амархан хууртдаг, биеэ үнэлдэг байсан зэрэг нь энэ гэмт хэргийн хохирогчид болоход гол хүчин зүйл болжээ.

Дурдахгүй байхын аргагүй нэг зүйл бол хохирогчид тэдний ар гэр, иргэний бичиг баримтгүй, иргэний бүртгэлд хамрагдаагүй, хаягийн бүртгэл буруу, шилжилт хөдөлгөөн хийлгээгүй зэрэг нь хохирогч түүний хууль ёсны төлөөлөгчийг олж тогтооход хүндрэл учруулах, улмаар мөрдөн байцаалтын хугацааг сунжруулах, хохирогч тогтоогдохгүй байх зэрэг байдлыг бий болгож байсан нь харагддаг.

Тухайлбал: Д нарын хэрэгт Макао гарсан 10 гаран охидын хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй, мөрдөн байцаалтын явцад 5 эмэгтэйн сургийг гаргаж байцааж чадсан боловч үлдсэн 5 эмэгтэйн хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй үлдсэн байна.Энэ хэрэг эцэслэн шийдэгдэхэд нийт 18 хохирогчоос 5 хохирогч тогтоогдоогүй байжээ.

Судлагдсан хэргүүдээс сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн хохирогч



цөөнгүй байсан боловч үүнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад бүхэлдээ хэрэгсэж үзээгүй байна.Мөн прокурорын шатанд хохирогчдын мэдүүлэгт ач холбогдол өгөлгүйгээр нотлох баримтын эх сурвалжаа зааж чадаагүй, хөндлөнгөөс нотлогдоогүй гэдэг үндэслэлээр хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх дурдах төдийгөөр орхигдуулсан. Энэ нь хохирогчдыг хохирсон дээр нь ахин хохироодог өөрөөр хэлбэл тэдний хувь хүний нууц болох нэр төр, бэлгийн амьдралтай холбоотой мэдээллийг агуулсан нэхэмжлэл гаргах нь сэтгэл зүйн хүнд дарамт учруулдаг, боломжгүй болгодог байна. Ийм учраас энэ төрлийн гэмт хэрэгт эдийн болон эдийн бус хохирлыг үнэлэх, нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлэлийг хангаж, хэвшүүлэх хэрэгтэй байгааг харуулж байна.

Жишээ нь хохирогч Д "..7 хоногт дунджаар 12, 11 хоногт 25 хүнтэй бэлгийн харьцаанд орж тогтмол бэлгийн мөлжлөгөд өртсөн, сэтгэл санааны хувьд хохирол хүлээсэн" гэсэн байтал үүнийг харгалзаж үзээгүй, эмнэлгийн шинжилгээнд хамруулаагүй байна. Мөн цаашид хэрхсэн нь тодорхойгүй 2 охины тухай баримт эрүүгийн хэрэгт байсаар атал үүнийг эцэслэн шалгаагүй. Шүүх хурлын тэмдэглэл, мөрдөн байцаалтын явцад бэхжүүлэн авсан мэдүүлгүүдтэй танилцахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын зүгээс хохирогчийг "биеэ үнэлэгч", "хөнгөн явдалтай охид" гэдэг "нүд"-ээр харсан байдаг.

Жишээ нь: Мөрдөн байцаалт, шүүх хурлын явцад асуулт тавихдаа *"Та биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан уу? Ямар шалтгаанаар эргэж явсан бэ? Та өөрөө зөвшөөрсөн гэдэг чинь биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан юм биш үү?" Та урьд нь мэдүүлэхдээ үхлээ хаттлаа гээд байсан яасан?". "Та нар явахдаа биеэ үнэлнэ гэж мэдэж байсан юм биш үү?"*гэх зэргээр асуусан нь хэт нэг талыг барьсан нь харагддаг. *"Та өөрөө зөвшөөрөөд яваад байсан байна, таныг яг зодсон уу? Хүч хэрэглэсэн үү? Тийм юм бол зугтаад хүрээд ирэхгүй яасан юм бэ?* гэхчилэн асуусан нь хуульчийн ёс зүй, хохирогчийн эрхийг зөрчсөн байна.

2.2.3 Хохирол:



Судалгааны ажлын явцад хохирогчдийн мэдүүлэгт бие махбодийн хохирол амссан, хохирол хүлээсэн байсаар байтал хохирол барагдуулах талаар ажиллагаа хийгээгүй, тогтоогоогүй, удаа дараа мэдүүлэг авсанаас хохирогч нар залхсан, улмаар гомдолгүй гэж цөөнгүй мэдүүлжээ. Үүний улмаас хохирогч Б өрөөл татуу болох , сэтгэл санааны хүнд хохирол хүлээх зэрэг байдлууд гарсан байхад үүнийг үнэлээгүй

Мөрдөн байцаалтын явцад хохирогчийг БНХАУ болон гадаад улсаас ирэхийг хүлээх, Монгол улсад ирүүлэх талаар явуулсан ажиллагаа нь үр дүнгүй болсон нь хохирогчдыг улам хохирооход хүргэсэн нь нэг биш хэрэг дээр харагдаж байлаа.

Түүнчлэн хохирогч нараас ганцхан удаа мэдүүлэг авах, хохирогчийн хувийн байдал, ар гэрт үүнээс шалтгаалж гарсан хохирол зэргийг ч асууж тодруулахгүй, хохирогчийн хохирол нэхэмжилсэн асуудлыг огтхон ч анхааран үзээгүй төдийгүй, "биеэ үнэлээд тэгээд байгаад байсан нь та нарын буруу" мэтээр хандсан зүйл ч ажиглагдаж байна.

Жишээлбэл: Ян Фений холбогдсон эрүүгийн хэрэгт хохирогч 9 охин тус бүр өөрсдийн биеэ үнэлээд олсон мөнгөө шүүгдэгчээс нэхэмжилсэн боловч нэг ч төгрөгний хохирлыг олгоогүй төдийгүй шүүхийн шийтгэх тогтоолд ***"хохирогчдод төлөх нөхөн төлбөргүй болохыг дурдсугай"*** гэж заасан байна. Мөн түүнчлэн шийтгэх тогтоолыг хохирогчдод танилцуулаагүй, гарын үсэг зуруулаагүй, биеийг нь үнэлүүлэн бүх мөнгийг нь хураан авч байсан талаар прокурор, шүүхийн шатанд дурдагдаагүй орхижээ.

Жишээ аваад үзэхэд О нарт холбогдох эрүүгийн хэрэгт хохирогч Д "сэтгэл санааны хохирол 300.000 төгрөг нэхэмжилнэ." гэснийг шүүх авч хэлэлцээгүй, хохирогч Э нь "бие, махбодийн хувьд хохирол хүлээж эмнэлэгт хэвтсэн" гэсээр атал үүнийг шалгаагүй орхигдуулсан байна.

Зарим хохирогч нарын анхны мэдүүлэг тайлбарт "гомдолтой, хохирол нэхэмжилнэ" гэсэн боловч дараагийн мэдүүлгүүдэд "гомдол, саналгүй, нэхэмжлэх зүйлгүй" гэсэн нь анхаарал татаж байлаа. Мэдүүлэг, тайлбар нь яваандаа өөрчлөгдөж хохиролгүй, гомдолгүй, шүүх хуралд суухгүй гэхчилэн мэдүүлсэн нь энэ бүхний ард хохирогчид учирч байгаа аюул занал, эд хөрөнгө болон далайлган сүрдүүллийн нөлөө байгаа юм биш биз гэсэн судлаачдын дүгнэлтэнд хүргэлээ. Мөрдөн байцаалт. шүүхийн шатанд хохирогчыг энэхүү нөлөөллөөс хамгаалах арга хэрэгсэл, огт байхгүй, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар нь ийм асуудалд "хуулиар хүлээсэн үүрэгт ажил биш", ажил дүгнэх үзүүлэлтэнд нь ордоггүй зэрэг дээрхи байдалд нөлөөлөх магадлалтай юм.

Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Хүн худалдах, худалдан авах болон түүнтэй төсөөтэй гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ дээрх нөхцөл байдлуудыг анхаарч "хэвшмэл арга барил"-аас ангижирч, шинэ туршлагыг нэвтрүүлэх хэлбэрээр ажиллах хэрэгтэй байгааг харуулж байна.

2.2.ЗҮЙЛЧЛЭЛ

2002 онд шинээр батлагдсан МУ-ын Эрүүгийн хуулиар Хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг анх удаа хуульчилж 113 дугаар зүйлд "Хүн худалдсан буюу худалдан авсан бол ..." гэж оруулсан тухайн үедээ нилээд дэвшилттэй алхам болж байсан. Гэвч энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх явцад хуулийн зүйл, хэсэг, үг үсгээс хамаарсан бэрхшээл гарч, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад нэг мөр ойлголт, тайлбар байхгүйгээс сэжигтэн этгээд ял завших, хохирогч хохирч үлдэх, түүнээс шалтгаалсан хуульчдын дунд зүйлчлэлийн маргаантай асуудлууд гарсаар байжээ. Судалгааны ажлын явцад МУ-ын ЭХ-д 2008 оны 2 дугаар сард орсон нэмэлт өөрчлөлт ороогүй байхад шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргүүдэд судалгаа хийсэн учир дээрх байдлууд илүү ихээр ажиглагдаж байлаа.

Жишээ нь: Р-д холбогдох эрүүгийн хэрэгт анх хохирогчдыг "караокед дуулуулна" хэмээн авч явсан ч бэлгийн мөлжлөгөд ашиглах зорилгоор бусдын эрхэнд шилжүүлсэн, байнгын шинжтэйгээр бусдыг хил давуулан худалдаж байсан Р-ийн үйлдэлийг нарийвчлан шалгаагүй, БНХАУ-д эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, тодорхой ажиллагаа хийх боломж байхгүй учир сэжигтнийг мэдүүлгийг үндэслэн хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд гэмт этгээдүүд хохирогчдыг өөрсдийн эрхшээлд байлган биеийг нь үнэлүүлэн тодорхой ашиг авдаг байсан төдийгүй "хамгаалж байна, байрны мөнгө" гэх элдэв "зохиомол" өр нэхэж, бэлгийн мөлжлөгөд ашигласан нь илэрхий байсан боловч үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд хохирогчийн мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлээгүй, худалдан авагч, худалдагч тал байхыг шаарддаг, ЭБШХ-ийн 83 дугаар зүйл/ хохирогч нь тухайн мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй зэрэг заалтыг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ашигтайгаар шийдвэрлэсэн нь ажиглагдаж байлаа.

Судалсан тодорхой эрүүгийн хэрэг дээр бэлгийн мөлжлөгөд ашигладаг байсан нь хохирогч нарын мэдүүлгээс харагддаг. Мөрдөн байцаалтын шатанд "хүч хэрэглэсэн үү" гэж асууж яг хүч хэрэглээгүй гэдгийг анхаарч ЭХ-ийн 124 дүгээр зүйл зүйл, хэсгээр зүйлчилсэн нь учир дутагдалтай байна. Цагийн 100 үүнээс 70 юань, хоногоор 300 үүнээс 150 юанийг нь авдаг, Бичиг баримтыг нь барьцаалж хүнтэй унтахыг шаардаж байсан. Хуурч мэхлэх замаар аваачсан гэдгийг бүр хохирогч нар хэлсээр байтал анхаарч үзээгүй. Жишээ нь хохирогч Ц–ийн биеэ үнэлж олсон бүх мөнгийг авдаг байсан, хохирогч Б "Намайг Макаод аваачиж 7000 патакаар зарсан" гэх зэрэг нь хүн худалдах гэмт хэргийн шинжтэй мэдүүлгүүдэд ач холбогдол өгөөгүй байна.

Судлагдсан хэргүүдээс Б, Г нарт холбогдох хэрэгт хохирогчид нь насанд хүрээгүй онцлог нөхцөлийг харгалзаагүй, хууртсан гэх байдал нь биеэ үнэлэхийг зохион байгуулах, татан оролцуулах хэлбэр болохгүй гэдгийг анхааралгүй байна. Хүн худалдах гэмт хэргийг прокурорын шатанд өөрчилж ЭХ-ийн 124 дүгээр зүйлийн 124.3 бүр сүүлдээ ЭХ-ийн 124 дүгээр

зүйлийн 124.2-оор 3 сар баривчлах ял шийтгэсэн нь ял завшуулсан гэж үзэхэд хүргэж байна.

Судлан буй хэргүүдэд зүйлчлэлийн үүднээс дүгнэлт хийхэд ЭХ-ийн 113 дугаар зүйл, ЭХ-ийн 124 зүйлийг нэг мөр ойлгон хэрэглэх талаар онол-аргазүйн зөвлөмж гаргах, урьд шийдэгдсэн эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сургалт явуулах байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээс "....Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан.. " гэдэг хэсгийн агуулгыг өөрчлөх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл энэ нь ЭХ-ийн тухайн заалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд томъёоллын хувьд эргэлзээ, маргаан үүсгэх нэг хүчин зүйл болж байгаа юм. Үүнд биеэ үнэлж байгаа этгээдийн хүсэл зориг, үйлдэлдээ хандах харьцааг буруу илэрхийлсэн мэт санагддаг. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх арга хэлбэр нь өөрөө хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэх нэг хэлбэр гэж үзвэл зохино.

Шинжээчдийн зүгээс:

- 101 дүгээр зүйл. Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах
- 108 дугаар зүйл. Хүн хулгайлах
- 109 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар хорих
- 115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах
- 116 дугаар зүйл.Хүүхэд солих, хууль бусаар үрчлэх
- 233 дугаар зүйл. Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах
- 182 дугаар зүйл. Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах, түүнд оролцох зэрэг хэргүүдийг давхар үйлдсэн байгааг анзаардаггүй.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх бэлтгэл, завдалтын болон үйлдэгдэх */үргэлжилсэн үйлдлийн/* явцад бусад олон төрлийн гэмт хэрэг */авилга, албан тушаалын, хуурамч бичиг баримт үйлдэх, хууль бусаар хил нэвтрэх/* үйлдэгдэх магадлал өндөртэй. Хүн худалдах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх талаах УДШ-ийн тайлбар гарсан боловч практик туршлага, тайлбарыг хэрэглэх нэг мөр ойлголт байхгүй байна. Дурдах бас энэ асуудал бол гадаад орнуудын энэ төрлийн гэмт хэргийн ойлголтыг харьцуулан судлах шаардлагатайг дурджээ.

2.3. НОТЛОХ БАРИМТ

Судалгааны явцад шалган шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн нотлох баримт үүн дотроо хэргийн талаар нотолвол зохих асуудлууд, нотлох ажиллагаа, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлж, үнэлж байгаа байдлыг судалгааны объектоо болголоо.



Тодорхой эрүүгийн хэрэг нэг бүрт дүн шинжилгээ хийхэд нотлох баримтыг хохирогчийн мэдүүлэгт түшиглэн шалгасан эсвэл хохирогчийн мэдүүлгийг гүйцэд шалгаж тогтоогоогүй, гэмт хэрэг гарах болсон нөхцөл байдлыг сайтар судлаагүй, мэдүүлгэн нотлох баримтыг "шүтдэг", шууд бус нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэхээс төвөгшөөдөг нь судалгааны явцад тодорхой харагдаж байлаа.

Гадаад улсад бусдын эрхшээлд автан биеэ үнэлсэн гэх нотлоход хүндрэлтэй. Тухайн гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах боломж хягаарлагдмал өөрөөр хэлбэл хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг үнэхээр биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах зорилготой байсныг ЭБША-г хилийн чанадад явуулж байж тогтоох хэрэгтэй болдог.

Үүнийг тогтоохгүйгээр эдийн болон эдийн бус бодит хохирлыг тогтоох, гэмт хэрэгт сэжиглэн шалгах, ял сонсгох хууль зүйн үндэслэл байдаггүй. Энэ тал дээр анхаарах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь өөрөө энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх болон таслан зогсооход маш том хүчин зүйл */фактор/* болно. Үүнд тухайн гадаад улсад Монгол улсаас суугаа элчин сайдын яамны консул болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нэн чухал. Учир нь тухайн газрын консулын асуудал эрхэлсэн ажилтан нь ЭБШХ-ийн 172 дугаар зүйлийн 172.4.2-т заасны дагуу ЭБША явуулах эрх бүхий субьект байдаг.

Жишээ нь С, Ү нарт холбогдох хэрэгт мөрдөн байцаагч болон прокурор хэрэгт авагдсан нотлох баримтуудыг дутуу үнэлсэн байдаг. Хохирогчийн *"над руу байнга яриад залуугаараа шоронд ормооргүй байна. Гомдолгүй гэвд хэлчихээч гэвд байдаг гэдэг"* гэдэг хэсэгт ямар ч ач холбогдол өгөөгүй. Энэ тухай сэжигтнийг байцаахдаа шалгаагүй.

Мөн түүнчлэн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурор хохирогчийн мэдүүлгүүдийг үнэлэхдээ харьцуулж судлаагүй. Энэ нь хохирогчид паспортоо гадаад хүнээс мөнгө төлж авсан тухай хохирогчийн мэдүүлэг болон хохирогчийн насанд хүрээгүй дүүг гэрчээр байцаасан байцаалтаас харагдаж байна. Уг паспортоо мөнгө өгч авсан үйлдэл нь бие даасан гэмт хэрэг /ЭХ-ийн 113 дугаар зүйлийн 113.2.2 113.2.4/ байхад үүнийг хангалттай нотлогдоогүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон. Мөрдөн байцаагч

гэрч, хохирогч, сэжигтэнгүүдийг байцааж авахдаа хэрэгт ач холбогдол болохуйц асуултыг /хөтөлсөн бус/ тавиагүй. Жишээ нь: Танд яг тийм үйлдэл болсныг ямар нэг хэмжээгээр нотлох боломж байна уу? гэх мэт. Мөн түүнчлэн хохирогчдыг эмчийн үзлэг, шинжилгээнд /БЗХӨ, ДОХ-ын шинжилгээ/ хамруулаагүй.

Прокурор мөрдөн байцаагчийн сонсгосон ялыг хэрэгсэхгүй болгохдоо нотлох бариментыг үнэлээгүй. Яагаад ийм үндэслэл гаргах болсноо тайлбарлаагүй. Хэдийгээр прокурор эрх зүйн ухамсрыг удирдлага болгон нотлох баримтыг дотоод итгэл үнэмшлээрээ үнэлдэг боловч үүнийгээ тайлбарладаг болох нь чухал ач холбогдолтой төдийгүй тухайн факт /үйл баримт/ нь өөрөө нотлох баримт болж болох юм.

Хүн худалдах, худалдан авах болон түүнтэй төсөөтэй үйлддэгддэг эрүүгийн хэрэг нь нотлох баримтыг бүрдүүлэх үйл ажиллагааны хувьд хангалттай болж чаддаггүй.

Шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт сэжиглэн шалгагдвал зохих субъектыг шалгалгүй орхигдуулсан байдлууд гарсан байсан.

Жишээ: Гэрч А: "би охидуудыг биеийг нь үнэлүүлэх гэж байгааг мэдээгүй" гэж хэлсэн байдаг. Гэтэл охидын зарим нь" биеэ үнэлэхээ явахаасаа өмнө мэдсэн" гэж байдаг, мөн А нь гудамжинд явж байгаа охидуудыг харж байгаад өдөж танилцаад утсаа өгөөд, дараа нь өөрийн хамтран амьдрагч А-д танилцуулсан байдаг нь хавтаст хэрэгт байгаа хохирогч охидуудын мэдүүлгээс харагддаг. Иймд гэрчээр татсан А нь мөн энэхүү хэрэгт бүлэглэн хамтран оролцсон нотлох баримт байсаар байтал нотлоогүй орхигдуулсан.

Д-д холбогдох эрүүгийн хэрэгт БНХАУ-ын Эрээн хотод байдаг Гейтингд /биеэ үнэлэх газар/ аваачсан, худалдсан, зарсан гэх асуудлыг эцэслэн шалгаагүй. Танил талын сүлжээ гэхээсээ илүү бүлэг зохион байгуулалттай гэмт хэргийн шинжийг анх шалгасан боловч мэдүүлгэн нотлох баримтанд ач холбогдол илүү өгчээ.

Нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх нь энэ төрлийн хэрэгт хамгийн хамгийн их ур чадвар болон ажиллагаа шаардаж байдаг. Дээрх хэргийн нотлох баримтаар эдгээр хохирогч охидын Бээжингийн чиглэлд ирсэн, явсан галт тэрэгний тасалбар, мөн сэжигтэн Ян Фенг, Ван Чин Фей, Гуо Ннь Жүй нарын галт тэрэгний тасалбар, сонинд өгсөн зар төдийхнөөр дуусан байна. Гэтэл энд тухайн Холливуд бааранд дээрх охидуудыг 800 юанаар биеийг нь үнэлүүлж байсан тухай мөн тэрхүү мөнгийг нь Ян Фенг хураан авч байсан зэргийг нь нотлох боломжгүй байсан байна.

Шинжээчдийн зүгээс: Шүүхийн шийдвэрийн гол цөм нь хэргийн үйл баримтыг нотолсон нотлох баримтуудыг шүүх яагаад үнэн зөв гэж үзэн шүүхийн шийдвэрийнхээ үндэслэл болгосон талаар бичсэн "дүгнэлтийн хэсэг" байдаг. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн талаар шүүхийн тогтоосон үйл баримтыг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдтэй харьцуулан дүгнэж бичих, түүнийг нотлож буй гол нотлох баримтуудын агуулгыг хамтад нь тусгах шаардлагатай.

2.4. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Судалгааны баг нь судалсан эрүүгийн хэргүүдийн үйлдэгдсэн шалтгаан нөхцлийг тогтоохдоо "байнга дурдагддаг" нийтлэг нөхцөл байдал болох ажилгүйдэл, ядуурал, нийгмийн байдал гэх мэт "тодорхой бус" хүчин зүйлсийг дурдахаас татгалзсан болно.



ЭБША-ны явцад дараах онцлог шалтгаан нөхцлүүд тогтоогдож байлаа.

1.1.1 Иргэний бүртгэлийн алба нь бичиг баримт олгох асуудал дээр хувь хүнд биш хэн нэгэн танихгүй хөндлөнгийн этгээдэд, эсвэл танил талаар дамжуулан иргэний бичиг баримт олгодог, хяналтгүй.

Жишээ нь судлагдсан дөрвөн ч эрүүгийн хэрэгт хохирогчдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад пасспортыг эзэмшигчээс нь өөр этгээдэд олгосон байдаг. Энэ нь танил талын сүлжээ, Иргэний бүртгэлийн байгууллагын хууль бус ажиллагаанаас шууд шалтгаалсан байна. Хүн худалдах гэмт хэргийн зуучлагч, дамжуулагч этгээд нь хохирогчдын бичиг баримтгүй байдлыг овжиноор ашигласан, цаашдаа хил давуулан гаргах гол арга хэрэгсэл нь болсон байдлууд ажиглагдаж байсан.

2.2.2. Монгол Улсын хилээр гарахад гадаад паспортийн хавсралт гаргаж өгөх нь Замын Үүдийн гаалийн боомт дээр ямар нэгэн хяналтгүй мөн л танил тал, хэн нэгнээр дамжуулан авдаг. Энэ нь хохирогч нарыг хил давуулан гаргахад гол түлхэц болдог.

Жишээлбэл О нарт холбогдох хэрэгт 17 настай 3 охиныг Замын Үүдийн хилийн боомтоор нэвтрүүлэхдээ хавсралтыг тухайн газар ажилладаг танилаараа дамжуулан авсан, хуурамч гадаад пасспорт ашигласан гэмт хэрэг үйлдсэн байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

3.3.3 Зар сурталчилгаа: Судлагдсан эрүүгийн хэргүүдийн гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл нь зар сурталчилгааны хяналтгүй байдлыг давуу талаа болгосон, хохирогч нарын сул талыг /ажил хайж байгаа гэх мэт/ ашигласан. "Гадаад өндөр цалинтай ажил хийлгэнэ" гэдэг нь хохирогч нар сэдэл төрүүлэх, хууртагдах гол нөхцлийг бүрдүүлж байсан байна.

Тухайлбал С, О нарт холбогдох эрүүгийн хэрэгт "18-22 насны охидыг өндөр цалинтай ажилд авна. Намхан байж болно " гэсэн зар нь хохирогчийг анх гэмт хэрэгт өртөх "гүүр" болж өгсөн байдаг. Түүнчлэн зар нийтлүүлсэн этгээд нь ихэвчлэн хуурамч нэрээр зар өгдөг, уг гэмт хэрэгт шууд бус хамааралтай, эсвэл гэмт хэргийн зуучлагч байх нь элбэг байжээ.

***3.3.4* Хохирогчийн эрсдэл бүхий байдал**: Судалгааны ажлын явцад уншиж судалсан эрүүгийн хэргүүд нэг бүр өөр өөрийн онцлог шалтгаан нөхцөлд үйлдэгдсэн байх бөгөөд тэр тусмаа хохирогчийн эрсдэл бүхий байдалтай холбоотойгоор үйлдэгдсэн хэргүүд нилээдгүй байлаа. Гол нь хохирогчийн эрсдэл бүхий байдал гэдэгт хохирогчдын "эрсдэл" бүхий шинж болох хамаатан садны дэмжлэг туслалцаа байхгүй, танил нөхдийн холбоо найдваргүй, хэт итгэмтгий /найздаа итгэснээс гэмт хэргийн хохирогч болох/ , түүнчлэн эцэг эхийн хайр, халамж дутсанаас орон гэрээсээ дайжсан, хараа хяналтгүй гудамжны тэнэмэл амьдралыг орууллаа.

Жишээ нь: Б. Г нарт холбогдох эрүүгийн хэрэгт насанд хүрээгүй, орон гэрээсээ дайжсан 2 охины бие хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан хүчиндэж, улмаар хүчээр биеийг нь үнэлүүлсэн байна.

3.3.5 Бусдад хууртсан, хүчинд автсан : Шалгаж шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт хүн худалдах гэмт хэрэг нь үйлдэгдэх арга нь хүчинд автах , хууртах байдлууд түгээмэл байлаа. Эрүүгийн хэргийн ихэнхид нь гэмт хэрэг үйлдэж байгаа сэжигтнүүд нь урьд нь өөрөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж байсан. Тодорхой нэг эрүүгийн хэрэгт гадаад улсад хүчээр бэлгийн мөлжлөгд өртөж байсан хохирогч "эзэд"-ээсээ мултрахийн тулд хохирогчдыг хууран мэхэлж аваачдаг, улмаар тэд хүчинд автан биеэ үнэлэхэд хүрдэг байсан нь хохирогч, гэрч нарын мэдүүлэг , хавтаст хэрэгт авагдсан бусад баримтаар тогтоогддог .

3.3.6 Биеэ үнэлдэг байдал : Хэдийгээр хохирогч нарын зарим хэсэг нь биеэ үнэлдэг боловч тухайн гэмт хэрэгт өртөх хамгийн гол хүчин зүйл гэдгийг дурдах нь зүйтэй. Судлаачид бид хэдийгээр тогтооход хэцүү боловч тухайн тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүчээр биеийг нь үнэлүүлж, бэлгийн мөлжлөгөд ашиглаж байсныг харахыг хичээсэн. Судлагдсан хэргүүдээс аваад үзэхэд "хөнгөн явдалтай" хэмээн дурдагдсан. хэрэгсэхгүй болгон шийдвэрлэгдсэн хэргийн хохирогч нарын мэдүүлэг нь судлаачдыг "энэ өнцгөөс" харахад хүргэлээ.

Судлаачдын зүгээс дурдахгүй байж боломгүй нэг асуудал бол гадаад улсад байдаг хүн худалдах сүлжээтэй нэгдсэн арга хэрэгслээр тэмцэх хэрэгтэй байгаа нь цаг үеийн тулгамдсан асуудал мөн гэж үзлээ. Эрүүгийн хэргүүдэд охидыг гадаад улсад хүлээн авдаг, орогнуулдаг, худалдаалдаг Монгол Анна гэх эмэгтэй /хоёр ч эрүүгийн хэргийн ард энэ эмэгтэй нэр

гарч байсан/, Бээжинд байдаг өвөрмонголчууд, Эрээнд байдаг Гейтингийн эзэдтэй тэмцэхгүйгээр гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, түүнээс урьдчилан сэргийлж чадахгүй. Энэ нь өөрөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хамгаллын асуудлыг "эцэс төгсгөлгүй" болгож, зөвхөн хохирсон хойно нь хамгаалах байдалд хүргэж байна.

ЭБША-ны явцад хохирогч нарыг мэдүүлэгт дурдсан буудал, хил гарсан нэрсээр нь эрэн сурвалжлуулахаар Интерполоор дамжуулан мэдэгдэл бичиж байсан боловч манай улсад эдгээр иргэд хил нэвтэрсэн гэсэн мэдээлэл байхгүй гэсэн мэдээлэл ирж байсан нь хүний наймааны энэхүү хэлбэр зохион байгуулалт, нууц байдалд орсон гэдгийг харуулж байна.

Мэдэгдэл

ЭБШ хуульд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар мэдэгдэл бичдэг. Мэдэгдэл бичих үндэслэл нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд прокурор эрүүгийн хэргийг хянах явцад болон хуулийн биелэлтийг шалгасан судалсан хийгээд хууль зөрчсөн шалтгаан, гэмт явдлын учир шалтгааныг судалсан дүн зэрэг бодит байдлыг нотолсон баримт, мэдээлэл байж болно. Хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг илрүүлж, тогтоох эсэх нь тухайн прокурорын үзэмжийн асуудал биш бөгөөд эрүүгийн хэрэг бүрд нотолбол зохих асуудлын жагсаалтад орсон заавал хийх ажиллагаа юм.



Судалсан эрүүгийн хэргүүдээс аваад үзэхэд энэхүү шалтгаан нөхцлийг арилгах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдэгдэл бичсэн нэг л хэрэг байсан бөгөөд тодорхой байгууллага, албан тушаалтны бууруулай үйлдэлд арга хэмжээ авбал зохих захиргааны шийтгэл, бусад хариуцлагыг хүлээлгээгүй байлаа.

Мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нь мэдэгдэлд дурьдсан шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авч, мэдэгдэлд заасан хугацаанд албан ёсоор хариу өгөх ёстой байдаг. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авахуулах мэдэгдлийн нийтлэг хугацаа 1 сар боловч тодорхой хэргийн нөхцөл байдлаас хамаарч прокурор мэдэгдэлд хариу өгөх хугацааг өөрөөр тогтоож болох бөгөөд мэдэгдлийн хариуг заавал бичгээр албан ёсоор өгөх ёстойг анхаарах

хэрэгтэй юм. Албан ёсны хариу өгсөн эсэхээс үл хамааран бичсэн мэдэгдлийнхээ биелэлтэд хяналт тавьж мэдэгдлийн заалтыг биелүүлээгүй, тогтоосон хугацаанд хариу өгөөгүй этгээдэд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д зааснаар шүүх торгох шийтгэл ногдуулах үндэслэл бийг анхаарч мэдэгдэл бичиж, хэрэгжилтийг нь шалгаж байх нь цаашид хүн худалдах, худалдан авах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх нэг алхам болно.

Энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого /санкц/ алдагдсанаас гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших, эрүүгийн хариуцлагаас захйлсхийх боломжийг олгож, улмаар ялын гэмт хэргээс,урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх, цээрлүүлэх зорилго хангагдахгүй байна.

Жишээ 1: О нарт холбогдох эрүүгийн хэргийг прокуророос ЭХТА-н 124 дүгээр зүйлийн 124.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч шүүхээс уг хэрэгт нь нэг жилийн хорих ял оногдуулж тэнсэн харгалзсан байна..

Жишээ 2: Д нарт холбогдох эрүүгийн хэрэгт улсын яллагч нь шүүх хурал дээр өөрийн байр сууриа яллах дүгнэлтээ /ЭХ-ийн 113 дугаар зүйлээр яллах дүгнэлт үйлдсэн/ шүүх хурал дээр дэмжээгүй, түүнчлэн яллах дүгнэлтээсээ татгалзсан[182] төдийгүй энэ үндэслэлээ тайлбарлаагүй байна. Анхан шатны шүүхээс шүүгдэгчид 3 жилийн хорих ял оногдуулж, түүнийг хойшлуулж шийдвэрлэсэн байна.

Шинжээчдийн зүгээс: Монгол Улсын иргэд гадаад улс оронд шилжих хөдөлгөөн нэмэгдэж, гэр бүлийн хямрал, хүчирхийлэл ихсэж, хууль тогтоомжийн хийдэл, боловсронгуй бус байдал болон бусад олон хүчин зүйл нөлөөлж байна. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний дотор гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгт хохирох эрсдэл бүхий этгээдүүдтэй харилцах талаарх төрийн бодлого, бодит ажил үгүйлэгдэж байна.

2.3.ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

Прокурор нь эрүүгийн хэрэгт дугаар олгосон үеэс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын ажил эхлэх бөгөөд эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор байнгын тасралтгүй хяналт тавих бөгөөд аль болох богино буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаанд нь хэргийг нотолж шийдвэрлүүлэхэд хяналтаа чиглүүлнэ.

Эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ерөнхий нөхцөл, шаардлагыг ЭБШХ-аар тогтоосон үндэслэл, журмын дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Прокурор нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа ХХГХ-т хяналт тавихдаа дараах зүйлийг анхаарах хэрэгтэй байна:

[182]СБД-ийн 2007 оны 353 дугаартай шийтгэх тогтоолд дээрхи байдлыг дурдсан байна

- ХХГХ-ийн улмаас хохирсон хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалж байгаа эсэх;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны нууц, хохирогч болон түүнтэй холбоотой этгээдийн хувийн нууцыг задруулахгүй байх арга хэмжээ авсан эсэх;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эрүүгийн хэргийг тусгаарлах, нэгтгэх ажиллагаа үндэслэлтэй эсэх; нэн ялангуяа ХХГХ-ийг үйлдэхдээ тусдаа үйлдэгдсэн хэргүүдийг нэгтгэж тусгаарласан ажиллагааг анхаарах
- Байцаан шийтгэх ажиллагааны хугацааг үндэслэлтэй тогтоож, хуульд заасан журмаар хугацааг сунгаж, хэтэрсэн хугацааг сэргээж байгаа эсэх; Шийдэгдсэн ХХГХ-үүд нь мөрдөн байцаалтын хугацаа сунгасан, нэмэлт мөрдөн байцаалтанд хэд хэдэн удаа буцсан байсан. Прокурор дээрх бүх хугацааг нарийн тооцож, үндэслэл журмын дагуу сунгаж байх
- Тухайн эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг тогтоосон байдал, хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэлийг тогтоож байгаа болонтухайн гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцлийг тогтоосон байдалд хяналт тавина. ХХГХ –т ялангуяа хохирогчид нь бие болон сэтгэл санааны хохирол ихээр хүлээдэг тул үүнийг аль болох бодитой тогтоох, хохирогч нь гадны нөлөөнд автах, бусдад хуурталд мэдүүлгээсээ буцах зэрэг байдлуудыг сайтар анхаарч шаардлагатай бол тодорхой ажиллагааг явуулахад байлцах, хохирогчтой биечлэн уулзаж байх хэрэгтэй байна.

2.5.1 Зөвшөөрөл

Прокурорын байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д *"**Шүүхээс зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгнө. Прокурорын зөвшөөрөл энэ хуулийн 29.1-д заасан ажиллагааг явуулах албан тушаалтны шийдвэрийг батламжлах хэлбэрээр үйлдэгдэнэ"*** гэжээ.

Иймхүү дээр дурьдсан бусдын эрх, эрх чөлөөг хөндсөн ажиллагааг эрх бүхий албан тушаалтан зөвхөн прокурор зөвшөөрсөн тохиолдолд явуулахаар хуульчлагдсан тул прокурорууд хүн худалдах, худалдан авах гэмт хэргийн материалыг заавал нягтлан хянаж үзэж, хуульд заасан үндэслэл, журмыг чанд сахиж, зөвшөөрлийн хууль эрх зүйн үр дагаварыг урьдчилан тооцож үзэх шаардлагатай.

а/ Хураан авах, нэгжлэг хийх;

Судлагдсан эрүүгийн хэргүүдийн 9-д нь эд зүйл, баримт бичиг хураан авах, нэгжлэг хийх ажиллагааг хийж гүйцэтгэсэн байлаа. Нэн ялангуяа нэгжлэг хийх ажиллагаанд зөвшөөрөл өгсөн боловч энэ ажиллагаанд прокурор биеэр оролцоогүйгээс нотлох баримтыг үнэлэхэд эргэлзээ төрсөн, шүүх хурал дээр маргаан гарсан зэрэг байдлууд гарч байжээ.

Энэ төрлийн эрүүгийн хэрэгт нотлох баримт нь ихэвчлэн мэдүүлгэн нотлох баримт байдаг боловч тодорхой онцлог хэрэгт нэгжлэг хийх тохиолдол гардаг. Тухайлбал хэргийн ач холбогдол бүхий бичиг баримтыг /хуурамч иргэний үнэмлэх гэх мэт/ олж илрүүлэх, хураан авах зорилгоор нэгжлэг хийх, түүний үр дүнг бэхжүүлэхэд прокурор заавал байлцах хэрэгтэй байна.

б/ Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, үзлэг хийх;

Эрүүгийн хавтаст хэргүүдэд судалгаа хийх явцад энэхүү ажиллагааг ердөө нэг удаа л хийж гүйцэтгэсэн байлаа. Шуудан цахилгаанаар явуулсан эд зүйлийг хураан авахдаа бусдаар дамжуулан авчруулах, битүүмжлэхгүйгээр зөвхөн хураан авах, үзлэгийн үр дүнг буруу бэхжүүлснээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын, хувь хүний нууцлалыг задруулах аюултай юм. Цаашлаад энэхүү ажиллагаар ирүүлсэн баримт бичигт өрчуулга хийлгэхдээ эх баримтыг дурдах, баталгаажуулалт хийлгэх нь тун чухал.

в/ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг нийтэд мэдээлэх;

Хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг шалгах явцад гэмт хэрэг үйлдсэн нотлогдоогүй байхад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эсвэл тодорхой байгууллага, албан тушаалтан. Төрийн бүс байгууллага нь эрүүгийн хэргийн талаар нийтэд мэдээлэл өгөх, зураггаар гаргах, хохирогчийн нэрийг дурдах, хувь хүний нууцлалыг задруулах байдлууд нилээд гарч, ямар нэгэн хяналтгүй болсон байгаа нь ажиглагдаж байлаа. Нэн ялангуяа биеэ үнэлэхийг зохион байгуулах, татан оруулах гэмт хэргийн ард хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг байж болзошгүйг онцгой анхаарч энэ тухай материалыг нийтэд мэдээлэхэд байнга хяналт тавих нь зүйтэй байна.

Хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг нь хохирогчийн хувьд заавал нууцлах шаардлагатай, тодорхой хамгаалалт шаардаж байдаг учир прокурор нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дээр дурдсан үйлдэлд шаардлага бичих болон хяналт тавьж байх, зөвшөөрөл авахуулж хэвшүүлэх хэрэгтэй юм. Прокурор нь зөвхөн зөвшөөрөл өгөх бус, тухайн зөвшөөрлийн дагуу хийгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа, үр дүнг нэгэн адил хянана.

2.5.2 Прокурорын эсэргүүцэл

Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргах хамгийн хүчтэй эрх зүйн хэлбэрийн нэг нь прокурорын эсэргүүцэл юм.Монгол Улсын ЭБШХ-ийн 193 дугаар зүйлийн 193.1.24-д "Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, хууль зөрчсөн тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих" бүрэн эрхтэйг заасан.

Хүн худалдах, худалдан авах гэмт хэргээр яллах дүгнэлт үйлдэгдсэн хэргүүдээс 3 хэрэг нь шүүх ажиллагааны явцад буруу зүйлчилсэн байна хэмээн үзэж ЭХ-ийн 124 дүгээр зүйлээр ял ногдуулсан байна. Эдгээр хэргүүдэд тус бүрд эсэргүүцэл бичигдсэн боловч эсэргүүцлийг хэлэлцээд үндэслэлгүй хэмээн шүүх үзсэн байна. Энэ нь 2008 оны 2 дугаар сард Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй УДШ-ийн тайлбар гараагүй байхад шийдэгдсэнтэй холбоотой.

- Түүнчлэн шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүх нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаасан бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан прокурор эсэргүүцэл бичих эрхтэй. Нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан 2 хэргийн тухайд эсэргүүцэл бичигдээгүй байна.
- Хяналт тавьсан прокурорууд тодорхой шалтгаанаар өөрчлөгдөг, энэ нь хэргийн шийдвэрлэлт, хугацаанд нөлөөлдөг нь ажиглагдаж байсан. Хүн худалдах, худалдан авах гэмт хэргийн тухайд энэ хэрэгт хяналт тавьж байгаа прокурор шүүхийн шатаар эцэслэн шийдвэрлэгдтэл оролцож байх нь ач холбогдолтой юм.

2.5.3 Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт

Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт нь төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх талаар явуулж байгаа ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх,Захиргааны хариуцлагын талаархи хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангуулахад хяналтын зорилго оршдог. Судалгааны ажлын хүрээнд танилцсан эрүүгийн хэргүүд дотор захиргааны хариуцлага хүлээлгэх үйлдлүүд байсан боловч тухай бүрд нь мөрдөн байцаагч, прокурор арга хэмжээ авааг үй, эсвэл анзаарахгүй орхих, хугацаа алдсанаас шалтгаалж /Хөөн хэлэлцэх хугацаа дуусч/ захиргааны хариуцлага хүлээлгэх боломжгүй болох зэрэг байдлууд гарч байсан байна.

Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан материалыг хянахдаа дараах нөхцөл байдлыг анхаарвал зохино:

1.Захиргааны зөрчил нэрийн дор гэмт хэргийн шинжтэй үйлдэлд захиргааны хариуцлага ногдуулж, ял завшуулахгүй байхад прокурорын хяналт чиглэгдэх

2.Шалгагдаж байгаа эрүүгийн хэрэгт захиргааны хариуцлага хүлээлгэх үйлдэл байгаа бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид даалгавар бичиж, зохих захиргааны хариуцлага хүлээлгэх, түүнийг хянах

3.ХХГХ-ийн шалгах явцад ЗХТХ-ийн 28 дугаар зүйл Гадаад улсын иргэн Монгол улсад оршин суух журам зөрчих, 29 дүгээр зүйл.Улсын хилийн дэглэм, журам зөрчих, 41 дүгээр зүйл .Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх зэрэг захиргааны зөрчил үйлдэгддэг болохыг анхаарах,

4.Бусад хууль тогоомж зөрчсөн эсэхийг ч анхаарах. Гадаад ажиллах хүч

илгээх, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай, Зар сурталчилгааны тухай, Хөдөлмөрийн тухай, Садар самуунтай тэмцэх тухай хуулиудыг зөрчсөн үйлдүүд хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон байна. Иймээс хууль зөрчсөн үйлдэл бүрт холбогдох албан тушаалтнаар арга хэмжээг нь авахуулж, эрүүгийн хэрэгт хавсаргаж байх нь зүйтэй.

2.6. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГАА

Шүүхийн шийдвэрийн гол цөм нь хэргийн үйл баримтыг нотолсон нотлох баримтуудыг шүүх яагаад үнэн зөв гэж үзэн шүүхийн шийдвэрийнхээ үндэслэл болгосон талаар бичсэн дүгнэлтийн хэсэг буюу үндэслэл хэсэг байдаг. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн талаар шүүхийн тогтоосон үйл баримтыг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдтэй харьцуулан дүгнэж бичих, түүнийг нотлож буй гол нотлох баримтуудын агуулгыг хамтад нь тусгах шаардлагатай

Шүүхийн шийтгэх тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлээс үзэхэд нийтлэг ажиглагдлаж байгаа дутагдал нь ямар үндэслэлээр нотлох баримтыг үнэлсэн, эс үнэлсэн тухайгаа дурдаггүй, прокуророос үйлдэж ирүүлсэн яллах дүгнэлтийн хүрээнд эсвэл түүнээс хөнгөрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн гэж хэргийг шийдвэрлэсэн явдал нилээдгүй байлаа.Шат шатны шүүх хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэл дээр маргаж оновчтой зөв зүйлчилж чадахгүй, хэргийг буруу зүйлчлэх, үндэслэлгүй шалтгаанаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах зэргээр чирэгдүүлдэг явдал судлагдсан эрүүгийн хэргүүдээс харагдаж байна. Шүүхийн практикт Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үндсэнд нь зөв зүйлчилж байгаа боловч насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэн авч явж, зодож хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчлэхгүй Эрүүгийн хуулийн 124 “биеэ үнэлэхэд татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэсэн хөнгөн зүйлээр зүйлчилж ноцтой гэмт хэрэгтнийг ял завшуулж байгаа буруу хандлага байгааг таслан зогсоох шаардлагатай юм.

Жишээ нь: Судлагдсан хэргүүдээс Б, Г нарт холбогдох хэрэгт хохирогчид нь насанд хүрээгүй онцлог нөхцөлийг харгалзаагүй, хууртсан гэх байдал нь биеэ үнэлэхийг зохион байгуулах, татан оролцуулах хэлбэр болохгүй гэдгийг анхааraагүй байна. Энэхүү хүн худалдах гэмт хэргийг прокурорын шатанд ЭХ-ийн 124 дүгээр зүйлийн 124.3-аар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлсэн боловч анхан шатны шүүх ЭХ-ийн 124 дүгээр зүйлийн 124.2-оор 3 сар баривчлах ял шийтгэжээ. Энэ нь шүүх энэ төрлийн гэмт хэргийн бүрэлдхүүний талаар нэг мөр ойлголтгүйг байгааг харуулж байна.

Мөн зарим судлагдсан эрүүгийн хэрэгт биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэхдээ зарим эмэгтэйг худалдсан, хууль бусаар хорьсон байхад үйлдэл тус бүрийг нарийн шалгаж тогтоолгүй хүн худалдаалах хэргийг нь орхигдуулж хавтгайруулан хөнгөн зүйл болох 124 дүгээр зүйлээр зүйлчилжээ. Жишээ нь: хохирогч А-ийн мэдүүлэгт “найз Э-тэй тааралдаж ажил олдохгүй байгаа тухайгаа

ярихад Хятад улсад зочид буудалд цэвэрлэгч, тогоочоор ажиллуулахаар ярьж тохирон авч яваад тэнд очсоныхоо дараа намайг биеэ үнэл гэж хятадуудад зарж, паспортыг минь хураан авсан" гэж мэдүүлсээр байтал энэ мэдүүлгийг огт шалгалгүйгээр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг "бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан" гэж үзэн Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр зүйлчилж ирүүлсэнийг хэвээр шийдвэрлэсэн байна.

7.7.ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАХ ГЭРЭЭ

Гадаад улсад биеийг нь үнэлүүлэх зорилгоор хил давуулан худалдсан, биеэ үнэлэхийг зохион байгуулсан дээрх хэргүүдэд судалгаа хийх явцад гадаад улсад байцаан шийтгэх ажиллагаа явуулах боломжгүйгээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, хүн худалдах гэмт хэргийг нотлох ажиллагаа явуулж чадаагүй, нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх боломжгүй зэрэг байдлууд түгээмэл ажиглагдаж байлаа.

Биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэрэг нь БНХАУ-ын эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэрэг /240-242 дугаар зүйл/, 8 дугаар хэсэгт зохион байгуулж, албадаж, өдөөн татаж, үлдээн авч, танилцуулж байгаад биеийг нь үнэлүүлсэн гэсэн нийт 358-362 дугаар зүйлд заасан гэмт хэргийн нотлох баримтыг БНХАУ-д шилжүүлж өгөх, шалгуулах хүсэлт гаргаж болно. Монгол Улс дангаараа хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь үр дүнгүй. Харин Хүн худалдаж авдаг гол улсуудын хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, эрх зүйн харилцан туслалцах гэрээ болон бусад олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулах боломжийг судлан дүгнэлт, саналаа гаргаж, тухайн асуудлыг шийдвэрлэх төрийн захиргааны төв байгууллагад зөвлөмж хүргүүлж болно.

- *Хүүлийн байгууллага дээрх гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаад орноос ирүүлсэн даалгавар, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байна. Судалгаанаас үзэхэд дээр нэр дурьдагдсан улс орнуудындотроос зөвхөн ОХУ, Польш, Чех улсаас ирүүлж буй даалгавар хүсэлт ньзонхилох хувийг эзэлж байдаг. Түүнчлэн Монгол Улсын ерөнхий прокурорын газар нь бусад орны Ерөнхий прокурорын газруудтай тухайлбал, ОХУ, Герман, Польш, Казахстан, БНХАУ, Украйн, БНСУ-ын Ерөнхий прокурорын газруудтай байгуулсан хамтын ажиллагааны тухай гэрээ хэлэлцээрийн хүрээнд эрх зүйн зарим туслалцааг харилцан үзүүлж байна. Энэ нь улс хооронд байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнээс ялгаатай тал нь тухайн гэрээнд шүүд заасан хязгаарлагдмал асуудлын хүрээнд харилцдаг. Тодруулбал хоёр улсын хооронд байгуулсан гэрээнд гэмт хэргийн тухай харилцан мэдээлэл солилцох, гэрч, шинжээч байцаалгах, баримт бичиг гардуулах зэрэг эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ гэж заасан бол зөвхөн эдгээр асуудлаар л хязгаарлагдана гэж ойлгож болох юм. Эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:*

  - *Гадаад улсаас манай улсын нутаг дэвсгэрт тодорхой байцаан*

шийтгэх ажиллагаа хийлгэхээр ирүүлсэн хүсэлт, даалгаврыг хүлээн авч, холбогдох байгууллагаар гүйцэтгүүлэх;

- *Гадаадаас шилжүүлж ирүүлсэн хэргийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн улс оронд эргэж хариу мэдэгдэх;*
- *Гадаадаас ирүүлсэн тогтоол, шийдвэр, бичиг баримтыг холбогдох иргэн, байгууллагад гардүүлж, энэ тухайгаа хариу мэдэгдэх;*
- *Монгол Улсын хүүль тогтоомжийн талаархи сонирхсон мэдээллийг гадаадын холбогдох байгууллагад гаргаж өгөх;*
- *Гадаад улс оронд байцаан шийтгэх ажиллагаа хийлгэхээр Монгол Улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн даалгавар, хүсэлтийг тухайн улс оронд уламжилж, даалгаврын гүйцэтгэлийг хангүүлах;*
- *Гадаадад гарсан хэргийн асуудлаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авах;*

Дээрх гэрээ, хэлэлцээрийн хүрээнд тус улсад суугаа гадаад орны дипломат төлөөлөгчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай харилцах зэрэг үйл ажиллагааны хэлбэрийг дурьдаж болно (Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, хэлэлцээрийн хүрээнд тус улсад суугаа гадаад орны Дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөгчдийг хүлээн авч үүлзан, санал хүсэлтийг нь зохих журмын дагуу шийдвэрлэх, зарим даалгавар, хүсэлтийг Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан холбогдох газруудад уламжлах).

ГУРАВ.САНАЛ, ЗӨВЛӨМЖ[183]

Хүн худалдаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрийн шинэ цогц бодлого хэрэгтэй байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх төрийн шинэ бодлого нь хүн худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдүүдийг илрүүлэх, хэргийг нь хянан шийдвэрлэх, энэ гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах талаарх механизмын бий болгох зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга, хэрэгслийг өөртөө багтаасан, мөн өөр хоорондоо уялдаа холбоо бүхий иж бүрэн арга хэмжээг багтаасан цоо шинэ үзэл баримтлал, цогц хөтөлбөрт үндэслэгдэх ёстой. Энэхүү үйлявц нь хүний эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн стандартад бүрэн нийцэх шаардлагатай юм.

Цагдаагийн байгууллага, прокурор, шүүхийн шатанд шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэргүүдийн тоог албан ёсоор авч архивт байгаа хэргүүдийн тоотой харьцуулах, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан мөрдөн байцаагч, хяналт тавьсан прокурор, хэргийг шийдвэрлэсэн шүүгчтэй биечлэн уулзаж, тэдний энэ төрлийн гэмт хэрэгт болон хохирогч, яллагдагч нарт хандах сэтгэлзүйн хандлага ямар байгаад үнэлэлт өгвөл илүү үр өгөөжтэй юм. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ярилцлага хийж мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд хэргээ шийдүүлэхээр явж байхад учирсан хүндрэл, мөн сайшаалтай талуудын талаар дурьдах хэрэгтэй.

[183] Шинжээчдээс ирүүлсэн санал, зөвлөмж

- Судалгааны тайлангаас харахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорууд нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар нэгдсэн нэг ойлголт муу байгаа нь харагдаж байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг илрүүлж арилгах талаар Монгол Улсын ЭБШ хуулийн 22 дугаар зүйлийг хэрхэн нэг мөр хэрэгжүүлэх талаар УДШ-ээс холбогдох тайлбар гаргуулах буюу бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй байна. Мэдүүлгийн тэмдэглэлд Монгол Улсын ЭБШ хуулийн 144 дүгээр зүйлийн 144.6. "Байцаагдаж байгаа этгээдийг хөтөлж буюу тулгаж асуухыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.
- Охид эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэрэгт татагдан ороход гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчилах ажил шаардлагын түвшинд хийгдэхгүй байгаа, мөн хэвлэл мэдээллийн байгууллага, хувь хүмүүсийн буруутай үйл ажиллагаа ихээхэн нөлөөж байгаа тул тэдэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлагыг чангатгах

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд зөвхөн биеэ үнэлэгчидэд захиргааны хариуцлага ногдуулдаг явдлыг өөрчилж, мөнгөөр биеэ үнэлэгч нарыг худалдан авдаг, садар самуун явдлыг өөгшүүлдэг этгээдэд хариуцлага хүлээлгэдэг байх нь шударга ёсонд нийцнэ

Үүнээс үзэхэд сүүлийн үед энэ гэмт хэрэгтэй тэмцэх хандлага өссөн гэж дүгнэж болох ч хууль тогтоомж боловсронгуй бус, энэ гэмт хэргийн талаарх мэдлэг мэдээлэл хомс байгаагаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүх прокурорын байгууллагын ажилтнууд дээрх хэргүүдийг төдийлөн ялгаж салгаж зүйлчилж чадахгүй байгаа нь хэргийн судалгаанаас харагдаж байна. Тайланд дурдсан нөхцөл байдлаас үзэхэд хүн худалдаалах үзэгдэлд социо-криминологийн шинжлэх ухааны үндэстэй шинжилгээ судалгаа хийх, хүн худалдаалахын эсрэг эрүүгийн болон эрх зүйн бусад хэм хэмжээнд задлан шинжилгээ хийх, гадаад улс орнуудын хууль тогтоох болон хэрэглэх практик, туршлагыг судлах, хилийн чандад хүмүүсийг хууль бусаар зөөвөрлөхийн эсрэг арга хэмжээний тогтолцоог боловсруулах болон бусад хандлагуудыг цаашид цогцоор нь дэлгэрүүлэн судлах шаардлагатай. Энэ бүхэн нь хүн худалдаалах асуудлыг гүн гүнзгий ойлгох, хүний эрх эрх чөлөөг хамгаалах үр нөлөөг дээшлүүлэх боломж олгох юм.

Хүн худалдаалах үзэгдлийг эрүүгийн эрх зүй болон криминологи, виктимологийн байр сууриас нарийвчлан судалж, эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, түүнтэй тэмцэх хэтийн зорилтуудын талаар зөвлөмж боловсруулахын үүднээс түүнтэй тэмцэх арга хэрэгслийг тодорхойлох хэрэгтэй юм. Энэ талаар эрдэмтэн судлаачдын болон практик ажилтнуудын хүчин чармайлтыг нэгтгэх, энэ гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахад тэдний судалгаа шинжилгээний ажлын үр дүнг ашиглах нь энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хувь нэмэр болох нь дамжиггүй. Энэ хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай:

- Эрдэмтэд, практик судлаачид болон олон улсын шинжээчдийн тодорхойлолтуудыг харьцуулан судлах үндсэн дээр "хүн худалдаалах" болон түүний илрэх үндсэн хэлбэрүүдийг шинээр тодорхойлох;

- Хүн худалдаалах явдалд криминологийн болон социологийн судалгаа, шинжилгээ хийж, хүн худалдаалах болон биеэ үнэлэхийг зохион байгуулах механизмыг тодорхойлох;
- Зохион байгуулалттай гэмт хэрэг болон хүн худалдаалахын уялдаа холбоог судалж, хүн худалдаалах үзэгдэл амь бөхтэй оршин байх нөхцлийг бүрдүүлж байгаа учир шалтгааныг илрүүлэх;
- Гадаадын зарим улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжид харьцуулсан судалгаа явуулж, эрх зүйн зохицуулалт, хамгаалалтыг боловсронгуй болгох талаар тодорхой санал, зөвлөмж боловсруулах хэрэгтэй. Тухайлбал Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах бие даасан хууль, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх сан байгуулах шаардлагатай байгааг судалгаа харуулж байна.
- Монгол Улсын эрүүгийн хуульд хүүхэд худалдаалахыг гэмт хэргийн нэг төрөл болгон зүйлчлэх шаардлага бий болжээ. Хуулийн нэр томъёо, болон түүний ойлголтуудыг нарийн тодорхойлж, шинэ зүйлд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хүн худалдаалахтай (human trafficking) тэмцэх нь Монгол улсад тулгамдсан асуудлын нэг болжээ. Ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг улс дотор болон хил дамнуулан худалдах, биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөлмөрлүүлэх, хүчээр гэр бүл болгох болон гэмт хэрэгтэй холбоотой бусад үйлдэлд татан оролцуулах явдал өссөөр байгааг гэрчилж байна. Монгол улсын охид эмэгтэйчүүдийг албадан ажил хийлгэх болон бэлгийн мөлжлөгийн зориулалтаар хөршзэргэлдээх орнуудад худалдаалжбуйталаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон үндэсний төрийн бус байгууллагууд их хэмжээгээр мэдээлэгдэж байгаа боловч, хуулийн байгууллагын зүгээс тэдэнтэй хийх тэмцэл өнөөгийн шаардлагаас хоцорч байна. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний дотор гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгт хохирох эрсдэл бүхий этгээдүүдтэй харилцах талаарх төрийн бодлого, бодит ажил үгүйлэгдэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд хамгийн бага судлагдсан энэхүү аюултай үзэгдлийг онолын болон практикийн түвшинд цогцоор нь авч үзэж, хүн худалдаалахын эсрэг олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний хөдөлмөрийг мөлжих болон хүн худалдаалахыг хориглосон, эрүүгийн хуулийн зүйл, заалтуудад харьцуулалт хийж, хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний тогтолцоо болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох практик дүгнэлт, санал, зөвлөмжийг боловсруулах, цаашид хүн худалдаалахтай хийх тэмцлийг эрчимжүүлэх, энэ хүрээнд олон улсын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх талаарх практик алхам хийж эхлэх хэрэгтэй юм.

__oOo__



ХҮҮХДИЙН АСУУДАЛ ХАРИУЦАХ ХОРООНЫ ДҮРМИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Нэг. Судалгаа явуулсан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл болон Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасан "... Эрүүгийн хууль зөрчсөн хэмээн сэжиглэгдсэн, яллагдсан, гэм буруутай нь тогтоогдогдсон хүүхдэд хамаарах хууль, журам, тусгай байгууллага, алба байгуулахад дөхөм үзүүлбэл зохино: ... шаардлагатай бөгөөд зохистой тохиолдолд эдгээр хүүхдийн хүний эрх, эрх зүйн баталгааг бүрэн хүндэтгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албан ёсны тогтолцооноос гадуур харьцах ... " гэснийг үндэслэн Монгол Улсад Хүүхдийн асуудал хариуцах хороо гэхийг байгуулах, түүний эрх зүйн үндсийг тодорхойлох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн "Хүүхэд хамгаалал" хөтөлбөрөөс Хүүхдийн хариуцах хорооны дүрмийг боловсруулсан байна.

Монгол Улсад захиргааны зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл, дарангуйлал, мөлжлөг гэх зэрэг хүүхэд, гэр бүлд сөргөөр нөлөөлж болох нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, найз нөхөд, сургууль зэрэг орчинд хууль зөрчих явдлыг таргуулахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах, хүүхдэд учирч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх, хүүхдийг соён гэгээрүүлэх, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх буюу тэднийг хохирогчтой эвлэрүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлох, бий болгох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн "Хүүхэд хамгаалал" хөтөлбөрийн захиалгаар Хууль зүйн үндэснийн хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор энэхүү ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Ажлыг 2007 оны 12 дугаар сараас эхлэн 2009 оны 4 дүгээр сарыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд Хүүхдийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох, зохих хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тогтоох зорилгоор дараах байдлыг дор дурдсан арга, хэлбэрээр судалсан болно. Үүнд:

- Хэнтий аймаг, Баганаар, Баянгол дүүрэгт загварын журмаар ажиллаж буй хороодын үйл ажиллагаа болон Дархан-Уул, Орхон, Төв аймаг дахь Хүүхдийн байгууллагын үйл ажиллагаанд ажиглалт хийж, харьцуулах;
- Хэнтий аймаг, Баганаар, Баянгол дүүрэгт хороо ажиллаж эхэлснээс хойшхи хүүхэд үйлдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтын статитстик, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймагт хүүхэд үйлдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтын статистикийг судлан харьцуулалт хийх;
- Хүүхдийн асуудал хариуцах загвар хорооны үйл ажиллагаа, уг хороог байгуулах хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааны чиглэл, бүтцийн талаар ярилцлага хийх;
- Олон улсын туршлага, чиг хандлагыг харьцуулах.

Хоёр. Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар хорооны үйл ажиллагааны үр нөлөө

Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хорооны үйл ажиллагааны үр нөлөөг судлах зорилгоор Хэнтий аймаг, Багануур, Баянгол дүүрэгт загварын журмаар ажиллаж буй хороодын үйл ажиллагааг ажиглалтын аргаар судлахын зэрэгцээ уг хороо ажилладаггүй оронд нутаг дахь хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг хэн хариуцдаг, тэр нь ямар үр нөлөөтэй болохыг харьцуулж үзэх зорилгоор Төв, Орхон, Дархан-Уул аймагт мөн ажиглалтын аргаар судалгаа хийсэн юм.

2.1.Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар хорооны явуулж буй үйл ажиллагаа

Багануур дүүрэг дэх Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо нь 2007 онд гэмт хэрэгт холбогдсон 24 хүүхэд, хохирогч 3 хүүхэд болон зан үйлийн зөрчилтэй 30 хүүхэд нийт 57 хүүхэдтэй ажиллаж, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд хяналт тавин ажиллахаас гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу хүүхдийн талаар нэмж тогтоовол зохих байдлуудыг тогтоход дүүргийн Цагдаагийн хэлтэс болон Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Хэнтий аймаг дахь Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо нь 2007 онд гэмт хэрэгт холбогдсон 7 хүүхэдтэй ажилласан төдийгүй хүүхдэд зориулсан сургалт, ухуулга сурталчилгаа, мэдээлэл хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэжээ.

Дээрх хороодын хийсэн ажил тооны хувьд харилцан адилгүй боловч чиглэл, зорилгын хувьд ижил үйл ажиллагаа явуулдаг байна. Тухайлбал,

1.Гэмт хэрэг үйлдсэн хүүхэд бүртэй ажиллах хүрээнд дараах төрлийн үйл ажиллагаа явуулсан байна:

- ЭБШХ-д заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн талаар нэмж тогтоовол зохих байдлыг тогтооход хамтран ажиллах;
- Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд оногдуулсан ялыг хойшлуулсан тохиолдолд дахин хууль зөрчиж болохгүйг сануулах, ном уншуулах, тэмдэглэл хөтлүүлэх, хохирогчоос амаар болон бичгээр уучлал хүсүүлэх, өөрийн нь үйлдсэн гэмт хэрэг, түүний хор уршгийн талаар зохион бичлэг бичүүлэх, шөнийн цагаар гэрээс гарахгүй байхыг даалгах, бусад хүүхдэд бичиг үсэг сурахад нь туслуулах зэргээр тухайн хүүхдийн засрал, хүмүүжилд нөлөөлөхүйц арга хэмжээ авах;
- Мөн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, сэтгэл зүйчийн зөвлөгөө өгүүлэх зэргээр туслалцаа үзүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор гагнуурчин дагалдуулан усны тэрэг гэх мэт боломжит ахуйн хэрэглээний эд зүйл хийж сурахад нь туслах, дэмжих;
- Цагдан хоригдож буй хүүхдийг эмчийн үзлэгт тогтмол хамруулах, тэдэнд тэмдэглэлт баяраар бэлэг өгөх зэргээр сэтгэл зүйн дэм өгөх;
- Хуулийн зохих байгууллагад тухайн хүүхдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлүүлэх санал өгөх гэх мэт.

2.Хүүхдэд зориулсан хүмүүжлийн ажил, сургалт зохион байгуулах хүрээнд дараах төрлийн үйл ажиллагаа явуулдаг байна:

- Хүүхдийн буруу зан үйл, хүсэл сонирхлыг хэрхэн өөр зүйлд хандуулах, эрсдэлд буй хүүхдүүдтэй цаашид хэрхэн ажиллах, цаашид аливаа зүйлд итгэл үнэмшилтэй, идэвхитэй оролцох оролцоог нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэлд байгаа болон тэнэмэл, бүтэн болон хагас өнчин хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, бусадтай чөлөөтэй харилцах, үзэл бодлоо илэрхийлэх, сэтгэл зүйн дарамтаас гарахад нь туслах;
- Баг, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, ахлагч, олон нийтийн байцаагч нарыг зан үйлийн зөрчилтэй хүүхдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх ажилд татан оролцуулж, хамтран ажиллах;
- Хууль зөрчсөн хүүхдийн эцэг, эхэд зориулсан сургалт зохион байгуулах;
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг зусланд амруулж, тэнд болсон сургалтад хамруулах гэх мэт.

Хорооноос явуулж буй үйл ажиллагаа хир үр нөлөөтэй байгааг магадлах буюу тандах, хороо цаашид ямар чиглэл, хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжийг тогтоох зорилгоор ярилцлагын аргаар судалгаа явуулсан бөгөөд уг судалгаанд дор дурдсан 60 хүн хамрагдсан болно:

Ажиглалтын болон ажлын байрны зураг авалтын аргаар тогтоогдсон зүйл:

Судагааны явцад хүүхдийн хорооны өдөр тутмын үйл ажиллагаа, ачаалал, хүндрэл бэрхшээл зэргийг судлав.

Хүүхдийн хорооны нарийн бичгийн даргын хувьд ачааалал ихтэй, зохицуулах зүйл, өдөр тутам хийх ажил харьцах албан тушаалтнууд их байдаг юм байна. Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй сэжигтэн яллагдагчийн хувьд хүүхдийн хэрэг эрхлэх хорооныхоо байранд өдөр тутам ирж сургалтанд хамрагддаг байцаан шийтгэх ажиллагаа гэхээсээ илүүтэй энгийн амьдралд байж хэргээ шийдүүлдэг сайн туршлага тогтжээ.

Судалгаанд хамрагдагсад	Тоо
Иргэдийн хурлын дарга. Засаг дарга болон засаг даргын тамгын газрын дарга, түүний орлогч, бусад ажилтнууд /хорооны гишүүд/	17
Хорооны нарийн бичгийн дарга	3
Цагдаагийн хүүхдийн байцаагч, цагдаагийн байгууллагын ажилтан	10
Шүүгч , прокурор, ШШГБ-ын ажилтан	12
Хүүхдийн байгууллагын ажилтнууд	8
Бусад	10
Бүгд	**60**

Ярилцлага хийх аргаар авсан судалгаанд оролцогчдоос Хүүхдийн гэмт хэрэг хариуцах хорооны үйл ажиллагааны өнөөгийн байдал, үр нөлөө, цаашид хэрхэн ямар хэлбэрээр ажиллаж болох, хорооны үйл ажиллагаа

бусад төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай хэрхэн уялдаж байгаа талаар дараахь асуулгаар судалгаа авсан бөгөөд судалгаанд оролцогчид дор дурдсан байдлаар хариулжээ.

1.Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хорооны хийж буй ажиллагаа, өнөөгийн байдал ямар байгаа талаар асуухад судалгаанд оролцогчдын:

- 51 нь буюу 82.5% нь Хороо байгуулагдсан цагаасаа хойш үр дүнтэй, сайн ажиллаж байгаа, цаашид ажиллах шаардлагатай байгаа гэж;
- 9 нь буюу 17.5% нь Хороо байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа нь жигдрээгүй, чиг үүрэг нь тодорхой бус гэж хариулжээ.

2. Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо цаашид үйл ажиллагаагаа хэрхэн чиглүүлбэл зүйтэй талаар асуухад судалгаанд оролцогчдын:

- 9 нь буюу 31.6% нь одоо явуулж буй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах нь зүйтэй гэж;
- 18 нь буюу 30% нь үйл ажиллагааны хүрээгээ өргөсгөж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэж, холбогч хэлбэрээр ажиллах нь зүйтэй гэж;
- 8 нь буюу 13.4% нь хуулийн байгууллагын бүтцэд ажиллах нь зүйтэй гэж;
- 15 нь буюу 25% нь Хүүхдийн төлөө үндэсний төв болон орон нутгийн хүүхдийн байгууллагын бүтцэд орж ажиллах нь зүйтэй гэж хариулжээ.

3. Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хорооны үйл ажиллагаа бусад байгууллагын үйл ажиллагаатай хэрхэн уялдаж, нийцэж байгаа талаар асуухад судалгаанд оролцогчдын:

- 13 нь буюу 21.6% нь зарим байгууллагын болон нэгжийн үйл ажиллагаатай давхцаж байгаа ба тодорхой нэг үйл ажиллагаанд чиглүүлэх хэрэгтэй гэж;
- 21 нь буюу 35% нь Хорооны үйл ажиллагаа бусад байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй давхардахгүй байна. Иймээс үйл ажиллагаагаа энэ хэвээр нь цааш үргэлжлүүлэх хэрэгтэй гэж;
- 17 нь буюу 28.4% нь зөвхөн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон гэрч хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байх хэрэгтэй гэж;
- 9 нь буюу 15% нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон эрсдэлтэй нөхцөлд байгаа насанд хүрээгүй хүмүүст үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах нь зүйтэй гэж үзжээ.

Ярилцлагын судалгааг зөвхөн дээрх асуултын хүрээнд явуулаагүй гэдгийг ойлговол зохино. Судлаачид тусгайлан боловсруулсан 10 асуултын хүрээнд явуулсан бөгөөд дүнг ерөнхий байдлаар нэгтгэж дүгнэсэн болно. Өөрөөр хэлбэл судалгааны энэхүү тайланд төрийн албан хаагчийн эсвэл хэн нэг хүний нэр дурдах, үзэл бодлыг шууд тусгахаас зайлсхийсэн болно.

Хуульчид, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний газрын төлөөлөгчид, Хороо нь насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ болох "Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага" Монгол Улсад байгуулагдаагүй тул уг байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг Хороонд хариуцуулах, Хороог Хүүхдийн төлөө үндэсний газрын бүтцэд ажиллуулах санал гаргаж байлаа.

ХЗХДХЯ-ны Ажлын хэсэгтэй хийсэн хэд хэдэн уулзалтанд оролцогчид тодорхой албан тушаалтнууд харилцан адилгүй байр суурьтай байснаас судалгааны ажилд нилээдгүй хүндрэл бэрхшээл учирч байв. Тухайбал судалгааны ажлын явцад илэрч гарсан зүйлсийг үгүйсгэж өөр өөрсдийн байр суурийг тулгаж байсныг дурдух хэрэгтэй болов уу.

Харин НҮБ-ын Хүүхдийн сангийн "Хүүхэд хамгаалал" хөтөлбөрөөс Хороонд захиргааны зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл, дарангуйлал, мөлжлөг гэх зэрэг хүүхэд, гэр бүлд сөргөөр нөлөөлж болох нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, найз нөхөд, сургууль зэрэг орчинд хууль зөрчих явдлыг гаргуулахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах, хүүхдэд учирч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх, хүүхдийг соён гэгээрүүлэх, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх буюу тэдгээрийг хохирогчтой эвлэрүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, хохирогч, гэрч хүүхдийг хамгаалах, ер нь эрсдэлтэй нөхцөлд байгаа бүх хүүхдэд үйлчлэх чиг үүргийг хариуцуулж, Хороог тухайн орон нутгийн Засаг даргын дэргэд байгуулах, Хороо энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зохих байгууллага, албан тушаалтныг татан оролцуулах буюу зохион байгуулах замаар үйл ажиллагаг нь нэгтгэн уялдуулах хэлбэрээр ажиллах нь зүйтэй гэх саналтай болно.

Гэтэл энэхүү байр суурийг арай өөр өнцгөөс буюу "НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй ажиллаж байгаа Хүүхдийн хэрэг эрхлэх хорооны зарим үйл ажилагааг төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага эрхлэн гүйцэтгэдэг. Тийм учраас чиг үүргийн болоод үйл ажиллагааны давхардал үүснэ. Энэ хороо нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүст үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах ёстой" гэсэн байр суурийг ХЗХДЯ-ны зүгээс баримталж байна.

Ярилцлагын судалгааны дүнгээс үзэхэд хүүхдийн хороо сайн үр дүнтэй ажиллаж байгаа, цаашид энэхүү хороог заавал байгуулах шаардлагатай гэдэг дээр ярилцлагын судалгаанд оролцогсод санал нэгдэж байсан боловч харин ямар хэлбэрээр байгуулах вэ гэдэг дээр өөр өөр саналтай байлаа. Магадгүй энэ нь тухайн төрийн албан тушаал хашиж буй хүмүүсийн мэргэжлийн онцлогтой холбоотой байж болох юм. Тодруулбал орон нутгийн хүүхдийн албадууд өөртөө энэ чиглэлийг авах эсвэл цагдаагийн байгууллагын албан хаагчид "divertion" хийх нь манайд үр дүнгүй зүйл гэж үздэгтэй холбоотой байв.

2.2. Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа

Орон нутгийн хүүхдийн байгууллага нь хуучин манай улсад байсан пеонерийн байгууллагын суурин дээр түшиглэн үүсчээ. Өөрөөр хэлбэл энэ байгуулагын бааз суурин дээр орон нутаг дахь хүүхдийн төвүүдийг байгуулсан юм байна. Энэхүү төвүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж, тодорхой үр дүнд хүрч ажиллаж байгаа илт мэдрэгдэж байсан боловч гэмт хэрэг зөрчилтэй холбоотой насанд хүрээгүй хүмүүсийн асуудал үндсэндээ орхигдсон энэ нь цагдаагийн байгууллагын ажил гэж үздэгтэй холбоотой байв.

Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар хороо байгуулагдаагүй буюу ажиллаагүй орон нутагт гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхэдтэй хэрхэн ажиллаж байгаа, өөрөөр хэлбэл, загвар хорооны хийж буй үйл ажиллагаа тухайн орон нутагт ямар түвшинд байгааг тогтоох зорилгоор Дархан-Уул, Орхон, Төв аймагт ажиглалтын аргаар судалгаа явуулсан болно. Энэхүү судалгаагаар дараах байдал ажиглагдсан болно.

Орхон аймагт Засаг даргын Тамгын газрын дэргэд ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хүүхдийн үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг, Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага /Хүүхдийн төлөө төв/ нь хүүхдийн сурч боловсрох гэх мэт нийгмийн бүхий л үйлчилгээнд хамрагдах эрхийг нь хамгаалах талаар анхаарч ажилладаг байна.

Төв аймагт гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийн эрхийг хамгаалах талаар тодорхой ажил хийгдэхгүй байна гэж үзэж, Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар хороог байгуулан ажиллаж байна. Өөрөөр хэлбэл Төв аймгийн холбогдох албан тушаалтнууд загвар Хорооны үйл ажиллагааг үр нөлөөтэй гэж үзэж, өөрийн орон нутагт уг хороог байгуулсан байна.

Иймээс насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэх гэмт хэрэг эрс буурч гэмт хэрэг эрх зүйн зөрчилд хүүхдүүд холбогдох явдал тоо болоод бодит байдал дээр илт буурсан байлаа.

Дархан-Уул аймагт ГХУСАЗСЗ-ийн бүтцэд Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл ажиллаж байгаад мөн Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар хорооны туршлагад үндэслэн уг хорооны хэрэгжүүлж буй чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хороог байгуулах асуудлыг шийдвэрлэх шатанд байна.

Ийнхүү Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хорооны явуулж буй үйл ажиллагааг Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага хэрэгжүүлдэггүй, өөрөөр хэлбэл, орон нутагт гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдэд хандсан үйл ажиллагаа дутагдалтай байдаг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага бий болгох хэрэгцээ, шаардлага байгааг ажиглалаа.

2.3. Хүүхдийн гэмт хэргийг хариуцах загвар

хорооны үйл ажиллагааны үр нөлөө

Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хорооны үйл ажиллагаа хир үр нөлөөтэй байгааг тогтоох зорилгоор Хэнтий аймаг, Багануур, Баянгол дүүрэгт загвар Хороо байгуулагдахаас өмнө хүүхэд үйлдэж байсан гэмт хэргийн тоог, уг хороо байгуулагдснаас хойш хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо /хороо байгуулагдснаас өмнөх 2 жил, хойшхи 2 жилийн байдлаар/-той харьцуулан судлахын зэрэгцээ загвар хороо ажиллаагүй Орхон, Дархан-Уул, Төв аймагт хүүхэд үйлдсэн гэмт хэргийг статистикийг мөн 4 жилээр харьцуулан дүгнэлт хийлээ.

Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо ажиллаж буй аймаг, дүүрэгт хүүхэд үйлдсэн гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлийн тоог[184] *харьцуулж үзвэл:*

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо:



Хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо:



Энэхүү статистикаас харахад Баганууур дүүрэгт Хороо байгуулагдсанаас хойш хүүхэд гэмт хэрэгт холбогдох явдал бараг 50 хувиар буурч, Хэнтий аймагт 2007 онд эдгээр тоо өсч, 2008 онд буурсан байна.

Харин Баянгол дүүрэгт хүүхэд гэмт хэрэгт холбогдох явдал болон хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо өссөн дүнтэй байна.

Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо ажиллаагүй буюу

[184]ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээний төвийн мэдээ

байгуулагдаагүй орон нутагт хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоог харьцуулж үзвэл:

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо



Хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо.



Төв болон Орхон аймагт хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт холбогдох явдал нэлээд буурсан бол Дархан-Уул аймагт хүүхэд гэмт хэрэгт холбогдох явдал өсөх хандлагатай байна.

Ярилцлагын судалгаагаар хорооны үйл ажиллагаа нэлээд үр нөлөөтэй байгаа гэх дүн гарсан боловч Хороо байгуулагдсанаас хойш хүүхэд үйлдсэн гэмт хэргийн тоо болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо тодийлөн буураагүй байгаа нь, мөн Хороо ажиллаагүй буюу байгуулагдаагүй орон нутагт хүүхэд гэмт хэрэгт холбогдох явдал дээрхээс тодийлөн ялгаагүй байгаа нь хорооны хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны үр нөлөө тодийлөн төлөвшөөгүй байгааг харуулж байна.

Бодит байдал дээр тоон үзүүлэлтэд ач холбогдол өгөх нь утгагүй юм.Үүнийг ерөнхий чиг хандлага болгон авч үзэж, цаашид боловсруулах прогноз гаргахад ашигладаг.

Хүүхдийн хэрэг эрхлэх хороо байгуулагдаад шууд гэмт хэргийн тоон үзүүлэлт, статистикт нөлөөлөхгүй нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл хүүхдийн хэрэг эрхлэх хорооны үйл ажиллагааны үр дүн бүр хэдэн жилийн дараа ч гарч болох юм. Яг өнөөдрийн тухайд гэмт хэрэг хэзээ гарах яаж үйлдэгдэх нь тодорхойгүй. Дархан ул аймагт гэхэд нэг дор

ангийнхаа охиныг хүчиндсэн гэх хэрэгт 8 хүүхэд холбогдоход гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо эрс өссөн дүнтэй гарч байна.

Гурав. Олон улсын туршлага, чиг хандлага

Монгол Улсад загварын журмаар ажиллаж эхэлж буй Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороотой адил зорилго бүхий байгууллага гадаадын улсуудад байдаг эсэх, байдаг бол ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ямар бүтэц, зохион байгуулалтаар ажилладаг байгууллага болохыг харьцуулан судаллаа.

3.1. Канадын туршлага

Канад улсад энэ чиглэлээр "Канадын 2 дахь боломж хөтөлбөр" нэртэй хөтөлбөр хэрэгжиж байсан байна.

Тус улсад энэхүү хөтөлбөрийн дагуу хүүхдийн гэмт хэргийн асуудлыг Төрийн бус байгууллага хариуцдаг байна. Прокурор гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, эсхүл шүүхээс хүүхдэд оногдуулсан ялыг хойшлуулж, хүүхдийг дээрх хөтөлбөрт хамруулдаг ажээ. Уг хөтөлбөрийн дагуу дээр дурдсан хүүхдийг дор дурдсан 2 үе шатаар амьдралын ухаанд сургах буюу амьдралд чиглүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

I үе шат: 12 долоо хоногийн сургалтанд хамруулж амьдрах ухаан, техник мэдлэг, гар урлал, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд хамруулах, сургууль нь буцаан оруулахад бэлтгэх;

II үе шат: "9 долоо хоногийн ажлын байр" нэртэй үе шат. Энэ үе шатанд төрийн байгууллагатай хамтран хүүхдийг ажлын байраар хангах, сайн дурын этгээдийн тусламжтайгаар олон нийтийн ажил, тэр дундаа олон нийтийн цэвэрлэгээний ажилд хамруулах үйл ажиллагаа явуулдаг байна.

3.2. Өмнөд Африкийн туршлага

Өмнөд Африк-д "Өсвөрчдийг чадваржуулах бүдүүвч" нэртэй хөтөлбөр хэрэгжиж байсан байна. Энэ бүдүүвчийн дагуу дараах үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Хүүхдийг байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлж, амьдрах ухааны хөтөлбөрт хамруулах;
- Ял хойшлуулагдсан хүүхэдтэй ажиллах ажилтныг томилох, түүнд зориулан 8 долоо хоногийн сургалтыг 7 хоногт нэг удаа хагас өдрөөр хийх ба энэхүү сургалтаар дараах сэдэв бүхий хичээлийг заадаг байна:
- Дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор нийгмийн үнэлэмж, дэг журам;
- Гэмт хэргийн хор уршиг, учир холбогдол, ухамсар, хувийн хариуцлага, шийдвэр гаргалт гэх зэрэг;
- Эцсийн 7 хоногт хүүхэд, эцэг, эхийг хамтад нь сургалтад оролцуулж, эцэг эх, хүүхдийн хамтын харилцааны талаар сургадаг байна.

3.3. Тайландын туршлага

Тайланд улс олон улсын хэмжээнд нэлээд шинэ хандлага загварыг бий болгосон бөгөөд хүч хэрэглэсэн гэмт хэргээс бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн асуудлыг хариуцаж ажилладаг.

Шүүгч хорих ял оногдуулалгүй, олон нийтийн хяналтад тодорхой хугацаагаар байлгахаар шийдвэрлэсэн тохиолдолд хүүхдийг эцэг, эх хариуцна. Мөн хүүхдийг олон нийтэд тустай ажил хийлгэх, мэргэжил олгох сургалт, ажлын байраар хангах, хүүхдийн оролцооны хөтөлбөр, хүүхдийн суслан гэх мэтэд хамруулах замаар хүүхдийг засарч хүмүүжүүлэх зорилго бүхий байгууллага байдаг байна. Үүний эцэст шүүгч хүүхэд, эцэг, эхтэй ярилцаж, хүүхдийн зан үйлийн өөрчлөлтийг хянадаг. Хэрэв хүүхэд засарсан гэж үзвэл ялыг хүчингүй болгох тогтолцоо, эрх зүйн зохицуулалт байдаг ажээ.

3.3. АНУ-ын туршлага

АНУ-д хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоосны үндсэн дээр хэргийг шиддэг бөгөөд хүүхдийн хэргийг "Холимог салбар" хариуцдаг байна. Холимог салбар нь хувийн төлөвшлийн эрсдэлтэй, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Холимог салбараас сургагдсан нийгмийн ажилтан хүүхдийн гэр бүлтэй нягт ажилладаг ба нэг бүрчилсэн болон бүлгийн зөвлөгөө өгөх арга хэмжээ авдаг байна. Өөр хүний байр сууринаас асуудалд хандах, итгэл үнэмшлийг өөрчлөх, хүсэл сонирхлыг өөрчлөх, хүсэл сонирхол, тэмүүллийг өөрчлөн сайжруулна. Нийгмийн ажилтан нь хүүхдийг таагүй орчноос хөндийрүүлэх, сөрөг нөлөөгүй арга хэмжээнд хамруулах, сургууль, олон нийтийн арга хэмжээнд хамруулах, нийгэм, хамт олны дунд байлгах зэрэгт анхаарна.

Эцэг, эх нь хүүхдээ харааа хяналтандаа байлгах, дэмжих, туслах, таатай нийгмийн бүлэглэл, үйл ажиллагаанд хамруулдаг байна.

3.3. Босния Герцеговинын туршлага

Босния Герцеговинд Чука сурган хүмүүжүүлэх төв ажилладаг.

Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, Төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг.

Уг төвд хүүхэд 6 болон 12 сарын хугацааны туршид 7 хоногт 4 өдөр төвд хүрэлцэн ирдэг.

Орон нутгийн ял хойшлуулахыг хариуцах байгууллага нь өөрийн нэгжээ дээрх төвд байгуулдаг ба 2 ажилтан нь хөтөлбөрт хяналт тавьдаг.

8 сайн дурын ажилтан \сургуулийн оюутан\ ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг.

Хүүхдийн шүүх нь Чукагийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад явуулдаг болсон.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хүүхэд хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгуулагууд хүүхдийн нийгмийн асуудалд чиглэсэн үйл ажиллагаа явуулдагаас бус хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүүхэд болон гэрч хүүхдийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.

Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах загвар Хороог нэг аймаг, гурван дүүрэгт байгуулсан ба энэхүү хорооны үйл ажиллагааны талаар судлахад судалгаанд оролцогчдын 82.5% нь Хороо байгуулагдсан цагаасаа хойш үр дүнтэй, сайн ажиллаж байгаа, цаашид ажиллах шаардлагатай гэж үзсэнээс харахад Хорооны явуулж буй үйл ажиллагаа дутагдалтай, цаашид хороог байгуулан ажиллуулах шаардлагатай байна гэж дүгнэхэд хүргэлээ.

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь хороо одоо явуулж буй үйл ажиллагаагаа цаашид үргэлжүүлэх шаардлагатай, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болон гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, гэрч хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байх хэрэгтэй гэж үзсэнээс харахад Монгол Улсад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн болон уг хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа дутагдалтай байна. Мөн хуульчид болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, захиалагч байгууллагын зүгээс Хороонд Эрүүгийн хуульд заасан насанд хүрээгүй этгээдэд хэрэглэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ болох Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг Хороонд хариуцуулах, Хороо захиргааны зөрчил, гэмт хэрэг, хүчирхийллэл, дарангуйлал, мөлжлөг гэх зэрэг хүүхэд, гэр бүлд сөргөөр нөлөөлж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхэд хууль зөрчих явдлыг гаргуулахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах, хүүхдийн хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бус журмаар шийдвэрлэх, хүүхдэд учирч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх, хүүхдийг соён гэгээрүүлэх, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх буюу тэдний хохирогчтой эвлэрүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, хохирогч, гэрч хүүхдийг хамгаалах, ер нь эрсдэлтэй нөхцөлд байгаа бүх хүүхдэд үйлчлэх чиг үүргийг хариуцуулах нь зүйтэй гэх саналтай байсан болно.

Монгол Улсад хүүхдэд чиглэсэн дээр дурдсан үйл ажиллагаа дутагдалтай байгаа бол гадаадын зарим улсуудад энэ чиглэлээр хөтөлбөр боловсруулан мөрдөж, энэ дагуугаа тодорхой байгууллага байгуулах, эсвэл тодорхой байгууллагад түшиглэн буюу хариуцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр ахицтай, дэвшилттэй туршлагууд байна.

Иймд дээрх туршлагыг харгалзан Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцах хорооны дүрэмтэй нийцүүлэн зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санал хэлбэрээр, Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалахад дор дурдсан ажиллагаа хийгдэхгүй байна гэх дүгнэлтэд үндэслэн боловсруулла. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэргийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бус журмаар шийдвэрлэх;
- Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүүхдийн эрхийг хамгаалах;
- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ авах;
- Хүүхдийн хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээ авах;
- Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон хохирогч хүүхэд болон гэрч хүүхдийг хамгаалах;
- Хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр боломжит орчин, нөхцөлд саатуулах, хүмүүжүүлэх;
- Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдүүлэхгүй байх зорилгоор соён гэгээрүүлэх.

Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцсан хороог цаашид ямар хэлбэрээр байгуулвал үр дүнтэй вэ?

Нэгэнт энэхүү үр дүнтэй ажиллаж байгаа байгууллагаа ямар хэлбэрээр байгуулах вэ? Цаашид энэ байгуулага байх ёстой юу үгүй юу.? Үүнд хэд хэдэн товч бөгөөд тодорхой хариулт өгье.

1.Үйл ажиллагааны хүрээнд:

Хүүхдийн хэрэг эрхлэх хороо байх шаардлагатай нь тодорхой зүйл. Гэхдээ үйл ажиллагааны чиглэл ойлгомжтой, бусад байгууллагуудын чиг үүрэгтэй давхардахгүй байх ёстой юм. Цагдаагийн байгууллага, Орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхдийн төлөө газар, орон нутаг дахь хүүхдийн төлөө төвүүдийн үйл ажиллагааны чиглэл хуулиар тодорхой заагдсан байгаа. Хүүхдийн хэрэг эрхлэх хороо эдгээр байгуулагуудтай уян хатан холбоотой ажиллахаас гадна "координатор"- ийн үүргийг гүйцэтгэх хэрэгтэй. Товч хэлэхэд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд сайн зохицуулагч, зангидагч байх нь хамгийн үр дүнтэй хэлбэр. ***Хүүхдийн хэрэг эрхлэх хорооны үйл ажиллагааны "гол цөм" нь гэмт хэрэгт холбогдсон хүүхэд, хохирогч хүүхэд, ял шийтгэгдсэн хүүхдэд чиглэх ёстой.***

Ажлын хэсэг болон ХЗДХЯ-ны баримталж байгаа чиглэл, бодлого, Судалгааны ажлын зөвлөх, удирдагч нарын байр суурь, зөвлөмжөөс аваад үзэхэд "эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхэд" бүхий гэсэн тодорхойгүй байдлыг оруулах шаардлага яг өнөөгийн байдлаар байхгүй байна. Ийм ойлголтыг оруулахад нилээдгүй хүндрэл бэрхшээл үүсэх бөгөөд хорооны нарийн бичиг гэсэн байнгын нэг орон тоотой нэгжийн тухайд бүтэшгүй зүйл. Хуулийн байгуулагуудын чиг хандлага ч эрсдэл бүхий хүүхдэд үйл ажиллагаагаа хороо чиглүүлвэл үйл ажиллагааны давхардал үүснэ гэсэн төсөөлөлтэй байна. Тийм учраас хорооны баримтлах үйл ажиллагааны чиглэл бол дээр дурдсан насанд хүрээгүй хүмүүст чиглэгдсэн байх хэрэгтэй.

2.Зохион байгуулалтын хүрээнд

Одоо ажиллаж байгаа ажлын зохион байгуулалт хамгийн үр дүнтэйд тооцогдож байгаа. Өөрөөр хэлбэл орон тооны бус гишүүдтэй, тэдгээр нь

орон нутгийн төрийн үйлчилгээ үзүүлэх байгуулагуудын төлөөлөл байх энэ хувилбар ашигтай юм.

Судалгааны ажлын нэг зорилт нь энэ байгууллага хаана харъяалагдах вэ гэсэн асуултанд хариулт өгөх явдал байлаа. Судалгааны ажлын явцад судалгаанд оролцогчдоос санал болгосон эсвэл тулгасан, дэмжсэн хэд хэдэн хувилбар дэвшүүлсэн байна. Үүнийг дурдвал:

• ***Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага болгох хувилбар:***

Энэ хувилбар төрийн байгуулагуудын зүгээс хамгийн их санал болгож байгаа хувилбар байлаа. Судалгааны ажлын зөвлөх ч энэхүү байгууллага хэлбэрээр байвал үр дүнтэй гэсэн чиглэлийг өгч байсан. Үүний эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн **69 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх" гэсэн заалт юм.**

ЭХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2 –т "Насанд хүрээгүй этгээд энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээ авагдсаны дараа засарч хүмүүжихгүй байвал шүүх уг арга хэмжээг насанд хүрээгүй хүмүүсийн ***сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага***д явуулах арга хэмжээгээр сольж болно."

ЭХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.3-т "Насанд хүрээгүй этгээдийг ***сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад*** явуулах хугацааг уг этгээдийнзан төлөв, ахуй амьдралын байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулыншинж чанар, хэр хэмжээг харгалзан шүүхээс тухай бүр тогтоох эрхтэй боловч арван зургаан наснаас хэтрүүлж болохгүй."

ЭХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.4-т "Насанд хүрээгүй этгээдийг тогтоосон хугацааны өмнө ***сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас*** чөлөөлөх асуудлыг тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ." гэжээ. Өнөөдөр манай улсад Эрүүгийн хуулинд ийм байгууллага ***"байгаа"*** боловч практикт байхгүй. Хэрэгцээ шаардлага байна уу гэвэл байна. Судалгааны ажлын явцад ХДЗХЯамны "ажлын хэсэгт" байгаа гишүүнээс *"Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага гэсэн нэртэй нэг сургууль байх нь байгаа. Гэхдээ тэр нь Улиастайд бидэнтэй гэрээлэх хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч эрх зүйн хэлбэрийн хувьд баталгаажаагүй байна"* гэсэн мэдээллийг бидэнд өгсөн юм.

Төсөөлөл:

Хэрэв ийм байгууллага хэлбэрээр хүүхдийн хороог байгуулвал хэд хэдэн үр дүнд хүрч болох юм.

1)Монгол Улсын Эрүүгийн хуулиар эрх зүйн үндсийг нь тодорхойлсон учраас дэмжигдэх магадлал өндөр

2)Санхүүгийн нийгэм эдийн засгийн тооцоо гаргах шаардлагатай. Дурдвал боловсон хүчин, төсөв, бүтэц, хамрах хүрээ гэвд олон асуудлууд байна. Энэ нь саад бэрхшээл болж болох юм. Өөрөөр хэлбэл төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага олон байх нь үр дүнгүй, ийм байгууллага

байгуулах санхүүгийн боломж байхгүй гэдэг байр суурийг баримталдаг субьектууд байна.

3)Нийслэлд нэг, бүсийн хэмжээнд тус бүр нэг сургалт хүмүүжлийн тусгай байгууллага байвал хөрөнгө бага зарцуулах юм.

4)ХЗДХЯ-ны тодорхой алба, нэгжийн харъяанд энэхүү төвийг байгуулах бололцоотой

5)Хэрэв ийм байгууллага байгуулвал зөвхөн ял шийтгэгдсэн хүүхдүүдэд үйл ажиллагаа чиглэгдэх болно. Тэгэхээр нөгөө хүүхдийг "эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас хөндийрүүлэх" бодлого маань хэрэгжих боломжгүй болох юм. Үүнийг Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар засч болох юм. Өөрөөр хэлбэл сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад шалгагдаж байгаа хүүхдүүдэд хамааралтай байх утга агуулга бүхий заалт оруулах хэрэгтэй болно.

6)Сөрөг гэмээр нэг байдал нь ял шийтгэгдсэн хүүхэд, эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа хүүхэд энэ байгууллагад хамт байгаа тохиолдолд нэгэндээ нөлөөлөх гэх мэт харш зан үйлүүд гарч болзошгүй. Тэгэхээр ийм байгуулагад хамрагдах хүүхдүүдийг ангилах тус тусад байлгах хөтөлбөр, сургалт нь хүртэл өөр болно. Үүнд нилээдгүй зохион байгуулалтын болон санхүүгийн бэрхшээл шаардагдах учраас нарийвчилсан судалгаа хийж байж /зөвхөн сургалт хүмүүжлийн тусгай байгууллага байгуулах боломжыг судлах/ шийдэгдэнэ.

- ***Хүүхдийн төлөө үндэсний газарт харъяалуулах***:

Судалгааны ажлын явцад ийм санал нилээд гарч байсан. Ялангуяа хүүхдийн төлөө байгуулагуудаас их ирж байсан болно. Энэ нь мөн л ажил үүргийн онцлогоос шалтгаалсан эсвэл хүүхдийн байгуулагын чиг үүргийг олон салгах нь үр дүнгүй хий хоосон зардал гардаг гэсэн төсөөлөлтэй субьектээс гарсан. Ялангуяа орон нутгийн хүүхдийн төлөө төвүүдэд ажиллаж байгаа албан хаагчдын дийлэнх хувь нь ингэж үзэж байлаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд "Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төв байгууллагын эрх"-д

1/ хүүхдийн талаар явуулах төрийн бодлого,хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах зорилго бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөлгөө өгөх, арга зүйгээр хангах;

3/хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, санал боловсруулах;

Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүүхдийн төлөө байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

<u>1/төрөөс хүүхдийн эрхийг хамгаалах талаар орон нутагт</u>

хэрэгжүүлэх бодлого,үйл ажиллагааг зохион байгуулах;

2/эрх нь зөрчигдсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

3/хүүхдийн эрхийг хангах ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах гэжээ.

Эндээс аваад үзэхэд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагад харъяалуулах эрх зүйн үндэс байхгүй байна. Хэрэв Хүүхдийн хэрэг эрхлэх хорооны үйл ажиллагааг Хүүхдийн төлөө үндэсний газарт харъяалуулбал Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд гарцаагүй нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл тусгайлсан бүтэг нэмж оруулах замаар энэ асуудлыг шийдэж болно.

Одоогийн байдлаар Хүүхдийн төлөө үндэсний газарт энэ чиг үүргийг хариуцсан нэг орон тоо байна. Энэ нь гэмт хэрэг хариуцсан мэргэжилтэн гэсэн орон тоо юм байна. Орон нутагт хийсэн судалгаанаас харахад гэмт хэрэг хариуцсан дээрхи мэргэжилтний орон тоо байхгүй ихэвчлэн хүүхдийн хамгаалал талаар бэлтгэгдсэн мэргэжилтнүүд байдаг тэдгээр нь өөр өөрсдийн чиглэлээр хүүхдийн төлөө үндэсний газрын чиг үүргийг хэрэгжүүлж байдаг. Харин гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн асуудлыг ихэвчлэн "цагдаагийн байгууллагын ажил" гэсэн нүдээр хардаг, тийм хүүхдүүд чиглэсэн ажиллагаа явуулдаг боловч гагц дээрхи асуудал орхигддог байна.

Төсөөлөл:

Хүүхдийн хэрэг эрхлэх хорооог Хүүхдийн төлөө Үндэсний газрын харъяанд байвал хэд хэдэн үр дагавар бий болох төсөөлөл судалгаар тогтоогдсон. Үүнийг дурдвал

1) Эрх зүйн орчинг өөрчлөх. Тэр тусмаа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх гэх мэт хуулиудад хуульд тодорхой оруулж өгөх хэрэгтэй байна. Үүний агуулга гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хамгаалах, ял шийтгэгдсэн, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдүүдэд чиглэгдэх үйл ажиллагааг тодорхой зааж, томъёолох

2) Орон тооны асуудлыг шийдвэрлэх. Энэ нь гэмт хэргийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог орон нутгийн хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагад бий болгох

3) Нийгэм эдийн засгийн өртгийн тооцоо гаргавал хавьгүй бага зардал гарна. *Өөрөөр хэлбэл хүүхдийн асуудал хариуцсан байгууллага нэмж байгуулах нь дэмжигдэх магадлал багатай.* ***Тиймээс судлаачдын зүгээс энэхүү хувилбарыг хэрэгжих бололцоотой гэж үзэж байгаа болно. Хэрэв цаг хугацааны хувьд хүүхдийн хороо байгуулах эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа бол энэ***

хүвилбар хамгийн тохиромжтой бөгөөд тодорхой үр дүнд хүрсний дараа үе шаттайгаар зөвхөн гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн асуудал хариуцсан нэгж байгууллж болох юм.

4) Практикт ажиллаж байгаа хүүльч, хүүхдийн байгууллагын алба хаагч нар дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд 80 гаран хувь нь хороог дээрхи байдлаар хүүхдийн төлөө үндэсний агентлагт харъяалуулж, орон тоо болон бусад асуудлыг шийдвэрлэх бололцоотой гэж үзэж байна.

- **Тусгайлсан нэгж байгуулах**

1980 аад оны үед байсан "Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх хороо" нь одоогийн шүүхийн байгууллагын нэгэн адил эрх мэдэлтэй байж, тодорхой үр дүнд хүрч ажиллаж байсан байна.

Хүүхдийн хэрэг эрхлэх хороо нь НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэг, санаачлагаар 2006 онд байгуулагдаж, үйл ажиллагаагаа албан ёсоор эрхлэн явуулж байна. Зохион байгуулалтын хувьд дүүргийн хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо нь дарга/дүүргийн засаг дарга/, нарийн бичгийн дарга, 20-30 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хорооны нарийн бичгийн дарга нь хорооны өдөр тутмын ажлыг эрхлэн явуулдаг. Одоогийн байдлаар гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу хүүхдийн талаар нэмж тогтоовол зохих байдлуудыг тогтооход дүүргийн Цагдаагийн хэлтэс болон Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж, хууль зөрчсөн хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж байгаа бөгөөд хууль зөрчсөн хүүхдүүд болон түүний эцэг эхэд амьдрах ухааны болон хууль зүйн мэдлэг олгох сургалтыг явуулж байна.

Бодит байдал дээр хорооны нарийн бичгийн дарга ачаалал ихтэй ажилладаг. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэх хүүхдүүдийг өдөр тутам дагаад яваад чадахгүй нь мэдээж учраас тэднийг засаг даргын тамгын газраас олгосон өрөөндөө дуудаж уулзах, сургалтуудад зуучлах хэлбэрээр ажиллаж байна.

Орон нутагт байгаа хүүхдийн хэрэг эрхлэх хороонд нутгийн өөрийн удирдлагын байгууллагын засаг дарга, удирдах албан тушаалтнууд ам сайтай байсан. Гол нь ийм байгууллага байгуулахад төр засгийн зүгээс үзүүлэх дэмжлэг бага байгаа явдал юм. Зохион байгуулалтын хүрээнд ч тэр үйл ажиллагааны хүрээнд ч тэр одоо байгаа боломжоороо ажиллах бүрэн бололцоотой байна.

Бас нэг дүрдах зүйл бол манай улсад ***"juvenile justice system"*** бүрэн утгаараа бүрдэж тогтоогүйд байгаа юм. Хүүхдийн асуудал хариуцсан шүүх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа бүрдэж тогтоогүй байгаа энэ үед хороог байгуулах нь үүний ***"хөрс, суурь"*** болно.

Төсөөлөл:

Хүүхдийн гэмт хэргийг хариуцсан хороо нь хорооны дүрэмд заасан

үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа боловч өнөөдрийн байдлаар зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүүхэдтэй ажиллаж байна.

*1)*Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах дагнасан хяналтын прокурор, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хүүхдийн хэргийг шийдвэрлэхэд дагнасан шүүгч ажиллуулж байгаа нь хорооны үйл ажиллагаанд нэлээд дэмжиж ажиллаж байгаа байдал харагдаж байна.

*2)*Засгийн газар, УИХ-д танилцуулга, судалгааны дүнг лобби бүлгээр хүргүүлж батлуулж болох хувилбар байна. Ингэвэл 21 аймаг тус бүрд Хүүхдийн гэмт хэргийн асуудал харуцсан хороодтой болох бөгөөд Засаг даргын тамгын газар эсвэл Иргэдийн хурлын дэргэдэх хороо хэлбэрээр байгуулагдах бололцоотой байна.

*3)*Анхаарах хэд хэдэн зүйлийн дотор хорооны дүрэм байна. Хорооны дүрмийг заавал нарийвчлан боловсруулж түүнд ач холбогдол өгөх нь бодит байдал дээр гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх ажилд садаа, тотгор учруулдаг. Иймээс хорооны дүрэм товч бөгөөд тодорхой, хамрах хүрээ, үйл ажиллагааны чиглэлийг тусгаж байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад болохооргүй байх хэрэгтэй. НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан хорооны дүрэм нь хэт нуршуу дээрээс нь хуулийг түүнд нийцүүлэх шаардлагатай мэтээр харагдаж байгааг анхаарах.

*4)*Хороог тусгайлсан байгууллага гэдэг шууд утгаар байгуулах гэвэл нилээд эсэргүүцэлтэй тулгарахаар байна. Тийм болохоор иргэдийн хурлын дэргэд байгуулагдах орон тооны хорооны тухайд дэмжүүлэх, тийм утгаар ойлгох нь үр дүнтэй.

3.Хууль тогтоомжийн хүрээнд

Насанд хүрээгүй этгээд ял оногдуулах хуульд заасан эрүүгийн хариуцлага нь хүүхдэд тохирохгүй байгаа тэдийгүй эрүүгийн ялын бодлого нь хатуу, чанга хэвээр байна. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргийг хариуцах хороо өндөр хөгжилтэй улс гүрнүүдэд байдаг жишгийг харьцуулан уг хороог байгуулах ажлыг хийх хэрэгтэй байгааг харгалзан:

- Өнөөдөр гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд туслалцаа үзүүлэх, дэмжих, эрхийг нь хангуулах, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, нөхөн сэргээх зайлшгүй шаардлагатай байна. Энэ үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэдийн уялдаа холбоог хангах, хууль зөрчсөн насанд хүрээгүй хүмүүсийн асуудлыг шийдэх, олон нийтийг татан оролцуулах, хүүхдийг ЭБША-наас хөндийрүүлэх ангид байлгах.
- Цаашид насанд хүрээгүй хүмүүсийн асуудал хариуцсан хороо нь гэмт хэрэгт холбогдсон болон ял шийтгэгдсэн, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн асуудлыг шиддэг тогтолцоо, хууль эрх зүйн орчинг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргийг хариуцах хорооны сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, аймаг болгонд олон нийтэд түшиглэсэн

ийм байгууллагыг байгуулах. Ингэхийн тулд Насанд хүрээгүй хүмүүсийн асуудал хариуцах хорооны дүрэм, ***Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах явдал юм.***

<u>Хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлт</u>

Зорилт нь Монгол Улсад гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг олон нийтийн жүрмаар шүүх эрх мэдлийн тогтолцооноос өмнө шийдвэрлэдэг тогтолцоог төлөвшүүлэх, хүүхдэд учирч байгаа бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бүрэн гүйцэд тогтоож, хариу арга хэмжээ авах, туслаж дэмжих, хүүхдийн асуудлыг шийдвэрлэдэг бүтэц, тогтолцоог сайжруулахад оршино. Хуулийн төсөлд Насанд хүрээгүй хүмүүсийн асуудал хариуцсан хорооны талаар баримталвал зохих зүйл, үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг зэрэг зохицуулалтыг тусгана.

<u>Үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар:</u>

Хуулийн төсөл батлагдсаны дараа нийгэм, эдийн засгийн дараах үр дагавар гарна гэж тооцож байна.Үүнд:

- Нийслэлийн дүүрэг, аймгийн хэмжээнд хүүхэд хамгаалах тогтолцоо бий болсноор хууль зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг сурган хүмүүжүүлэх, хүмүүжиж буй байдалд нь хяналт тавих, тэдгээрт төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүүхдийг аль болох цагдан хорихгүй, хорих ял эдлүүлэхгүй байлгахын тулд ажиллаж цагдаа, прокурор, шүүхийн байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хүнд нөхцөлд байгаа хүүхэд буюу бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдэд туслах, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх боломжтой болох бөгөөд хүүхдийн үйлдэж буй гэмт хэрэг буурна гэж үзэж байна.

- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилган сэргийлэх, сурган хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх асуудал эрхэлсэн байгууллага, уг байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан журам гаргана. Энэ нь практикт хэрэгжих боломжтой, хуулийн байгууллагын нэн ялангуяа Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, хууль хяналтын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулахааргүй байна.

А/Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд орох зүйл, хэсгийн агуулга:

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд тусгайлсан бүлэг нэмэх шаардлагатай юм байна гэсэн дүгнэлтэнд судалгааны баг хүрсэн ба энэ дараах агуулгатай байвал зохино.

Энэ нь Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд гэсэн нэртэй бүлэг байх бөгөөд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэг болж нэмэгдэх юм.

Энэ бүлэгт Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцах хорооны зорилго, зохион байгуулалт , хорооны хуралдаан, хамтарсан баг, гэмт хэрэг үйлдсэн, түүний улмаас хохирсон , ял шийтгэгдсэн хүүхэдтэй холбоотой ажиллагаанууд, түүний төрөл, шүүх, цагдаа, прокурорын байгуулагын оролцооны талаар тусгах юм. Агуулга нь ерөөс хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулалгүйгээр тусгайд нь шийдэх тэр процедурыг оруулсан байна. Өөрөөр хэлбэл хүүхэд гэмт хэрэг үйлдээд сэжиглэгдэн шалгах явцад хүүхдийн байгууллагад заавал мэдэгдэх үүргийг цагдаагийн ажилтан хүлээх бөгөөд прокурорын зөвшөөрлийн үндсэн дээр хүүхдийн гэмт хэрэг хариуцсан хороонд шилжүүлэх ажиллагааг хуульчилсан байна. Дээрээс нь ял шийтгэгдсэн, хойшлуулсан, тэнсэн харгалзсан хүүхдүүд, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэдтэй холбоотой ажиллагааг тусгаж өгсөн болно. Гол нь энэ бүлэг нэмэгдэж орсноор гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдтэй ажиллах ажилтан, хуулийн байгууллагаас гадуур шийдэгдэх эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх юм.

Б/ Эрүүгийн хууль

Эрүүгийн хуулинд орох өөрчлөлтийн агуулга нь дараах байна. Үүнд

1) ***Шүүхээс гэм буруутай тогтоогдсон насанд хүрээгүй хүмүүст ял ногдуулах бодлогоос аль болох татгалзаж,*** эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ авах, сургах, хүмүүжүүлэх мэргэжлийн чиг баримжаатай болгох, нийгмээс хөндийрүүлэхгүй байх бодлого баримтлах бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бус журмаар шийдвэрлэхийг урьтал болгох

2) **Эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаар:** Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрсэн боловч 21 насанд хүрээгүй иргэнийг түүний сэтгэц, оюун санаа, бие бялдарын байдлыг харгалзан насанд хүрээгүй иргэнд шүүгч тооцож болох, "Анх удаа хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийг нийгэмшүүлэн, хүмүүжүүлэх ***сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад байлгах насны дээд хязгаар 21 нас хүртэл байна." гэж оруулах.***

3) ***Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагыг ангилах***

4) **Т*одорхой нийгэм хүмүүжлийн арга хэмжээг эрүүгийн хуулинд нэмж оруулах өөрөөр хэлбэл хуулиар төрлийг нь нэмэгдүүлэх***

5) ***Насанд хүрээгүй хүмүүсийг*** сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад явуулахгүй байх боломжтой гэж шүүх үзвэл ***дурдсан хүмүүжлийн арга хэмжээний төрөл болон олон нийтэд тустай хөдөлмөрийг эрхлүүлэхээр*** хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх агуулга бүхий заалтууд байх хэрэгтэй.

Ингэснээр хүүхдэд насанд хүрсэн хүнээс эрс ялгаатай эрх зүйн байдал үүсэх юм.

В/Эрүүгийн байцаан шийтгэх хууль:

Энэ хуулинд орох нэмэлт өөрчлөлт нь нилээд процессын шинжтэй байх хэрэгтэй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг гагцхүү эрүүгийн

байцаан шийтгэх хуулиар явуулах ёстой. Гэтэл гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас гадуур шийдэж болохгүй эрх зүйн зохицуулалттай байдаг. Иймд Эрүүгийн процессийн хуульд орох нэмэлт нь насанд хүрээгүй хүнийг насанд хүрсэн хүнээс ялган үзэж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас гадуур шийдэх эрх зүйн боломжийг олгосон байх нь зөв.

Агуулга: Анх удаа хөнгөн, хүндэвтэр, хүнд[185] гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд холбогдох хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэхгүй бөгөөд энэ тухай прокурор шийдвэр гаргана. Прокурор шийдвэрээ гэмт хэрэг үйлдсэн гэх хүүхдийн хамт Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагад шилжүүлнэ. Тэрний дараа хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн дагуу "divertion" хийх юм. Хэрэв хүүхэд засарч хүмүүжихгүй итгэл даахгүй, гэмт хэрэг давтан үйлдвэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны журмаар шийдэх нь зүйтэй. Энэ хуульд үүнийг дагаад прокурорын бүрэн эрхэд нэмэх, мөрдөн байцаагч хэрэг бүртгэгчээс авах таслан сэргийлэх арга хэмжээг хүүхдэд тохирсныг нэмэх, төрөлжүүлэх, цагдан хорих үндэслэлийг хүүхдийн хувьд багасгах, цагдан хорих хоногийг цөөрүүлэх агуулга бүхий заалтууд орвол зохино.

Г/Бусад хуулиуд

Гэмт хэргээс урьдчлан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хувилбар нь тус хуулийн */9' дүгээр зүйлд/ **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд Хүүхдийн хорооны үүрэг"** гэсэн нэртэй байх бөгөөд* Хүүхдийн асуудал хариуцах хороо нь гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ авах, гэмт хэргийн хор уршгийг түүнд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгон ажиллана гэсэн агуулгатай байна.

Түүнчлэн гэмт халдлагаас гэмт хэрэгт өртөж болзошгүй хүүхдийг өөрийн хүрээнд хамгаалах арга хэмжээ авах; хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг халдлагаас хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах чиглэлээр холбогдох заалтууд орох хэрэгтэй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагын үүрэг" гэсэн хэсэг оруулах. Энэ хүүхдийг гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртүүлэхгүй байхад чиглэгдсэн байх хэрэгтэй бөгөөд одоогийн хуулин дээр хүүхэдтэй холбогдолтой заалт байхгүй байна.

__oOo__

[185] Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн асуудлыг Хүүхдийн асуудал хариуцах хороонд шилжүүлэх нь захиалагч байгууллагын санал бөгөөд хүүхэд хүнд ангиллын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ЭБША явуулах эсэх талаар судлаачид нэгдсэн саналд хүрээгүй боловч захиалагч байгуулагын саналаар төслийг ийнхүү боловсруулсан болно.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙГ ЦАГДАН ХОРИХ БАЙР, ХОРИХ АНГИЙН ДОТООД ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ

Нэг. Судалгаа явуулсан байдал

Өсвөр үеийнхнийг нийгэмдээ утга учиртай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, тэднийг амьдралыг зан үйлийн гажуудалд орж болзошгүй үед нь, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэхээс эртнээс урьдчилан сэргийлж, бие хүний хөгжил, боловсрол олгох үйл явцыг дэмжих, цагдан хорих болон хорих ангиас суллагдсан насанд хүрээгүй этгээдээс давтан гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, нэн ялангуяа хохироос суллагдсан хүүхэд эргэзд гэр бүлдээ очих, олон нийтийн дунд байх, сургуульд суралцах, мэргэжлийн чиг баримжаа эзэмших нйигэмд эргэн орох бэлтгэлээ хангахад хорих байгууллагаас туслалцаа ихээхэн шаардагддаг учраас насанд хүрээгүй хүмүүс цагдан хорих, хорих ангийн нөхцлийг тусгайлан анхаарах хэрэгтэй.

Одоогийн байдлаар насанд хүрсэн хүмүүст зориулан гаргасан Хорих ангийн дотоод журам, Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиар зохицуулсан эрх зүйн орчинд цагдан хоригдож, ял эдэлж байна.

Цагдан хорих байр, хорих ангид байгаа насанд хүрээгүй хүмүүсийг сургаж хүмүүжүүлэх ажлын зорилго нь нийгэмд ашигтай, үр бүтээлтэй байр суурьтай байхад нь тус болох үүднээс асрамж хамгаалалтаар хангах, боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэх ёстой.

Хорих анги, цагдан хорих байранд байгаа насанд хүрээгүй хүний ашиг сонирхлыг хангах явдлыг баталгаажуулж тэдний эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нийгмийн гишүүн болгох боломжийг хөгжүүлэхэд туслахуйц тийм үзэл бодол, дадал зуршлыг төлөвшүүлэх явдлыг урамшуулах, тэднийг хариуцлагаа мэдэрдэг болгон хүмүүжүүлэхэд тус дөхөм болсон үр нөлөөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

- ***Хоёр. Нөхцөл байдал, судалгаа шинжилгээ***[186]

Судалгааны ажлын хүрээнд Нийслэлийн Багануур дүүрэг, Дархан-уул, Хэнтий, Төв, Орхон аймгуудын цагдан хорих байр, ШШГЕГ-ын харъяа эмэгтэйчүүдийн 0407 дугаар, Насанд хүрээгүй хүмүүсийн 0411 дүгээр ангиудын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцсан байна.

Орон нутагт байгаа ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих байруудын зарим нь 2002 онд цагдаагийн байгуулагаас хүлээж авсанаас хойш зарим нь шинэчлэгдээгүй бөгөөд нийт 40-60 хүний багтаамжтай, нийтдээ 172м/квадрат талбайтай, нэг цагдан хорих өрөө нь дунджаар 2.5 метр квадрат талбайтай. Насанд хүрээгүй хүмүүсийг цагдан хорих байрны өрөө нь 2.4х2.7 м/квадрат талбайтай, заримдаа 2 хүний багтаамжтай өрөө боловч дээд тал нь 5-6 хүүхэд хийх тохиолдол байдаг, олон улсын жишиг стандартанд дурдсан

[186]Судалгааны ажлын хүрээнд нийт 6 цагдан хорих байр, 2 хорих ангийн үйл ажиллагаатай танилцсан.

нөхцөл байтугай жорлон, угаалтуур ч байхгүй нийтийн угаалтуурт очиж угаадаг, бие засдаг. Цагдан хорих байр нь насанд хүрэгчдийнхээс ялгагдах, хүүхдийн онцлогт тохирсон өрөө гэж байхгүй ижил нөхцөлд хоригддог. **"Хүүхэд"** гэсэн бичгээрээ л ялгаатай, ор болон цагаан хэрэглэл байхгүй бөгөөд зөвхөн нэг наар буюу банзан хавтантай, агааржуулагч, байгалийн гэрэл тусах боломжгүй байна.

Одоогийн байдлаар эмчгүй, орон тоо бий боловч хүн аваагүй, гэрээгээр аймгийн эмнэлэгээс хааяа эмч ирж ихэнхидээ хүн өвдсөн үздэг. Тэрнээс ямар нэг байдлаар тогтмол үзлэг хийж чадахгүй байгаа. Олон Улсын байгуулагаас хааяа бэлэг сэлт, ариун цэврийн хэрэгсэл өгдөг. Цэвэр усны асуудал, цагаан хэрэглэлийн асуудал хүнд, цагдан хорих байрны зүгээс өөрсдийнхөө дотоод хүч бололцоогоор аль болох гэж шийдэх гэж хичээдэг байна. Насанд хүрээгүй хүмүүс олноор хоригдох үед эмэгтэйчүүдийн камерт хийдэг байдлууд гарч байсан. Сүүлийн үед аймгуудийн хэмжээнд насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг давтан үйлдэж байгаагаас цагдан хоригдох явдал их гарч байгаа хэмээн нэгэн аймгийн хяналтын прокурор ярьж байсан. Энэ нь :

1.Ялтны болон цагдан хоригдож байгаа сэжигтэн яллагдагчтай холбоотой зардал, цагдан хорих байрны тохижилтийн санхүүжилт

2.Гэрэл /байгалийн болон үүсмэл/

3.Цэвэр ус

4.Тусгайлсан өрөө /НХХ-т/ байхгүй зэргээс шалтгаалаад стандарт шаардлагад нийцдэггүй юм.

Орон нутагт ажиллажбайгаа хууль сахиулах байгууллагын ажилтнуудаас ярихдаа: *"Насанд хүрээгүй сэжигтэн яллагдагчид зориулсан тусгайлсан нөхцөл байх хэрэгтэй боловч заавал тусад нь журам гаргах шаардалага байхгүй юм болов уу.. Нэг их олон журам гаргаад байдаг хэрэгжиж байгаа нь хэд билээ. Эхлээд энэ хүүхдийн цагдан хорих байрны санхүүжилт, тохижилтийн асуудлын эрх зүйн болон санхүүгийн үндсийг шийдвэрлэсний дараа журам гаргаж болох юм. Одоо хэрэгжиж байгаа журам дээрээ болон ШШГТХ-д хэдэн зүйлд тодорхой нэмэлт оруулаад заачихвал болох. Олон улсын наад захын стандартыг дагаж мөрдөх боломж орон нутагт үнэхээр байхгүй. Одоогийн байдлаар хүүхдийн эргэлт уулзалт авахыг хязгаарлаж байгаа ба заавал тэгэх шаардалагүй. Хүүхэд өөрөө эрх зүйн хувьд шийдвэр гаргах боломж хязгаарлагдмал байдапд ингэж хязгаарлах нь хортой байж мэдэх юм. Энд хоригдож байгаа хүүхдүүд өдөрт 1 удаа 10 минутын зайтай салхилж байгаа. Хэвлэл мэдээллээр хангагдах болон бусад хангамжийн талаар яриад ч хэрэггүй биз. Эцэг эхэд нь ч гэсэн хүүхэд ямар нөхцөлд яаж хоригдож байгаа талаархи мэдээллийг өгч байх хэрэгтэй."* гэж бодож байна гэж байсан юм. [187] Дархан аймаг, Орхон-уул аймгийн цагдан хорих байрууд нь ижил нөхцөлтэй байсан бөгөөд насанд хүрсэн хүмүүсээс ялгагдах өрөө байхгүй, хүүхдийн өрөө нь заримдаа дүүрчихдэг,[188] Энэ нь санхүүжилттэй

[187] Ярилцлагын судалгаанаас

[188] Нэг эрүүгийн хэрэгт холбогдож ирсэн 12 хүүхдийг тусгайлан хорих өрөө байхгүйгээс насанд хүрэгчдээс тусгаарлаж чадахгүй байгаа гэсэн бэрхшээлийг хорих байгуулагын ажилтан ярьж

холбоотой аймгийн ЗДТГ-аас ШШБ-ын санхүүжилтийг тодорхой хэмжээгээр хариуцах заалт байдаг боловч тэр нь хэрэгждэггүй, анхаарч үздэггүй гэсэн шалтгаан ч хэлж байв. Түүнчлэн энэ зөвхөн санхүүгийн асуудлаас шалтгаалсан хүндрэл биш байсан. Ялангуяа Багануур дүүрэг, Төв аймгийн цагдан хорих байрны дарга нарын идэвхи санаачилгаар насанд хүрээгүй хүмүүсийн өрөөг жишиг стандартад нийцүүлж, насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих өрөө шинэ байранд орсноор жорлон, угаалтуурын асуудлыг бүрэн шийдвэрлэж чадсан, агааржуулагч, байгалийн гэрэл нэвтрэлттэй, модон шалтай болгож тохижуулсан нь анхаарал татаж байлаа.[189]

Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн хувьд ШШГЕГ-ын харъяа 407 ангид судалгааны ажлаар очиход 5 эмэгтэй хүүхэд, ШШГЕГ-ын харъяа 411 дүгээр ангид 87 эрэгтэй хүүхэд ял эдэлж байсан. 2008 оны байдлаар хорих болон баривчлах ял эдэлж байгаа ялтны тоо 970 буюу 15.7%-иар, үүнээс хорих ялтай ялтны тоо 871 буюу 14.6%-иар, жирийн дэглэмтэй ялтны тоо 609-өөр буюу 23.6%-иар өссөн байгаагаас үзэхэд эрүүгийн ялын бодлоготой уялдан цаашид хорих ял эдлэгсдийн тоо өсөх хандлагатай байна.[190]

Ярилцлагын судалгаанд оролцогчдын 85 хувь нь насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байрны журам, хорих ангийн дотоод журмыг шинээр боловсруулах шаардлагатай гэж үзэж байсан ба 12.5 хувь нь шинэчилсэн журам гаргалгүйгээр нэмэлт тусгах замаар энэ харилцааг зохицуулж болно хэмээн хариулсан юм. Үлдэх 2.5 хувь нь тусгайлсан журам гаргах шаардалагагүй гэсэн хариултыг өгч байлаа. [191]

ШШГЕГ-ын харъяа цагдан хорих 0461-р анги

1. Уг байр нь:[192]

- Нийт 14 хорих өрөө бүхий 215.46 м² талбайтай, 70 хүний багтаамжтай.
- Өрөө тус бүр 5 хүний ортой, 1 хувцасны шүүгээтэй, байгалийн гэрэлтүүлэг шуудтусдаг 110х90см-ын харьцаатай цонхтой, хяналтын шагайвар бүхий модон хаалгатай, модон шалтай, хаалганы дээд талд агааржуулах цонхтой.
- Цагдан хорих өрөө болон коридор нь хяналтын телекамертай.
- Хичээл сургалт явуулах ширээ, сандал, самбар, номын сан бүхий зориулалтын танхимтай боловч хоригдогч хүүхдүүдэд зориулсан сургалтууд бага явагддаг, тогтмол бус. Номын сангийн нөөц хангалттай бус, шинэ ном, сонин, сэтгүүлээр хангагддаггүй.

байсан.

[189] Цагдан хоригдож байгаа нэг хүүхэд байсан, мөрдөн байцаалтын явцад хэрэг нь шийдвэрлэгдээгүй байхад ахин хулгайн гэмт хэрэг үйлдсэн учраас цагдан хоригдсон, 3х3 м/кадврат талбайтай. Дээд тал нь 3 хүүхэд нэг дор хоригдож байсан.

[190] *"Эрх зүйт төр - хууль ёсны хэрэгжилт" Үндэсний зөвлөгөөний эмхэтгэл, "Шүүхийн шийдвэр түүний хэрэгжилт" , ШШГЕГ-ын дэд дарга , хурандаа Д.Дамдинцэрэн, 2008 он, 162 дахь тал*

[191] Ярилцлагын судалгаанаас

[192] *2008 оны 6 сарын байдлаар*

2. Цагдан хоригдогсдын талаар:

Цагдан хорих 461-р ангийн насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих байранд өнөөдрийн байдлаар 42 хүүхэд хоригдож байна. Үүнээс

- шүүхээр таслагдаж, тогтоол хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа - 8
- ангийн нэгдсэн эмнэлэгт өвчний учир хэвтэн эмчлүүлж байгаа - 3
- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа - 31 хоригдогч тус тус байна.

Өнөөдрийн байдлаар насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих байранд хоригдогсдыг насны байдлаар нь ангилан үзвэл:

- 14 настай - 1 буюу 2,3%
- 15 настай - 3 буюу 7,1 %
- 16 настай - 14 буюу 36%
- 17 настай - 24 буюу 57,1 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн ангиллаар хубааж үзвэл:

- хүндэвтэр гэмт хэрэгт - 19 буюу 45,2%
- хүнд гэмт хэрэгт - 17 буюу 40,6%
- онц хүнд гэмт хэрэгт - 6 буюу 14,2% тус тус шалгагдаж байна.

Эрүүгийн гэмт хэрэгт хэдэн удаа холбогдсон байдлаар авч үзвэл:

- 32 буюу 76,1 % нь - анх удаа шалгагдаж байгаа
- 8 буюу 19% нь - 2 дахь удаа шалгагдаж байгаа бол 2 буюу 4,7% нь - 3 дахь удаа шалгагдаж байгаа хоригдогч байна.

Хоригдсон хугацаагаар авч үзвэл:

- 1 сар хүртэл - 18 буюу 52,9%
- 1 сараас дээш - 7 буюу 20,5%
- 4 сараас дээш - 6 буюу 17,6%
- 8 сараас дээш - 3 буюу 8,6% байна. Үүнд:

Өмгөөлүүлэх эрхээр хангагдсан байдлаар авч үзвэл:

- Өөрөө өмгөөлөгч хөлсөлж авсан - 12 буюу 35,2%
- Томилолтын өмгөөлөгчтэй - 14 буюу 41,1%
- Өмгөөлөгчгүй - 8 буюу 23,5%
- Цагдан хоригдсоноос хойш өмгөөлөгч нь ирж уулзсан – 22, цагдан хоригдсоноос хойш өмгөөлөгч нь ирж уулзаагүй-12 хоригдогч байна.

2007 оны байдлаар 1 хоногоос 18 хоногийн хугацаагаар 8 хүүхэд өлсгөлөн зарласан. Өлсгөлөн зарласан шалтгааныг үзвэл:

- хэргээ хурдан шийдүүлэх зорилготой - 4
- даалтанд гарах - 2
- Хилс хэрэгт гутгэгдэн хорьж байна"гэсэн үндэслэлээр 1 хүүхэд өлсгөлөн зарласан

Цагдан хоригдсоноос хойш хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ирж уулзаагүй:

- 14 хоногоос дээш ирээгүй - 2
- 1 сараас дээш ирж уулзаагүй - 2

Цагдан хоригдож буй хүүхдүүдээс авсан судалгаанаас үзэхэд тэдэнд:

- Гадаад хэлний мэдлэг олгох сургалт
- Хууль эрх зүйн мэдлэг /Хүүхдийн эрхийн тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаарх хууль тогтоомжийн тухай/
- Танин мэдэхүй
- Нийгмийн харилцааны тухай мэдлэг, чадвар олгох хичээл сургалтууд шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Насанд хүрээгүй хүүхэд шүүхээр ял шийтгүүлсэн байдал 2006-2008 он[193]

Он	Шүүхээр ял шийтгүүлсэн
2006 он	663
2007 он	635
2008 он	447

Насанд хүрээгүй хүмүүсийг цагдан хорих байр, хорих ангийн дотоод журмын зорилго нь ямар нэгэн хэлбэрээр хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахад хүний үндсэн эрх, эрх чөлөөнд нийцүүлэн бүх төрлийн хорих ялын сөрөг үр дагаварыг саармагжуулах ба нийгмийн ба амьдралд буцаан татан оруулахад тус дөхөм үзүүлэх. ингэхийн тулд хүүхдийг төрөл садантай нь хамт олонтой нь тогтмол уулзуулж байх, харилцаа холбоотой байлгаж байх, захидал харилцааны эрхийг нь хязгаарлахгүй байх, мэдээлэл авах эрхийг нь хязгаарлахгүй байхаар зохицуулах ёстой юм.

Насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байр, хорих ангийн дотоод журам батлагдан гарсны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсаны дараа нийгэм, эдийн засгийн дараах үр дагавар гарна гэж тооцож байна.Үүнд:

1.Насанд хүрээгүй хүмүүсийг олон улсын наад захын жишиг стандартад нийцүүлэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх шинэлэг эрх зүйн зохицуулалт бий болно

2.Тусгайлсан журам гаргана. Энэ нь практикт хэрэгжих боломжтой, хуулийн байгууллагын нэн ялангуяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын өдөр тутмын үйл ажиллагааны хүндрэл учруулахааргүй байна.

Уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах, насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байр, хорих ангийн дотоод журам боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,

[193]УДШ-ийн Судалгааны Төв

Боловролын тухай хууль, Хүүхдийн эрхийн хамгаалах тухай хууль, ХЗДХЯ-ны сайдын 2002 оны 215 дугаар тушаалаар батлагдсан хорих ангийн дотоод журам.

Хуулийн төсөлд хорих байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүмүүсийн талаар баримталвал зохих зүйл, насан хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байрны үйл ажилагаа, дэглэм, өдөр тутмын үйл ажиллагаа зэрэг асуудлыг тусгана. Одоо үйлчилж буй "Цагдан хорих байрны дотоод журам" дээр "насанд хүрээгүй сэжигтэн яллагдагчийг цагдан хорих" гэсэн хэсэг нэмэгдэж, "Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн дотоод журмын төслийг шинээр боловсруулагдах юм.

Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн дотоод журмыг үндэслэл, зорилго

Энэхүү журмын зорилго нь насанд хүрээгүй хоригдлыг хамгаалахын тулд тэдний эрх эрх чөлөөнд нийцүүлэн хорих ялын сөрөг үр дагаварыг саармагжуулах, тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор Монгол улсын хууль тогтоомж болон Нэгдсэн үндэсний байгуулагаас баталсан наад захын жишиг стандартыг хэрэгжүүлэхэд оршино.

1.Хорих байгууллагын ажилтны зүгээс насанд хүрээгүй хоригдолд байнга туслалцаа үзүүлэх ажилтныг мэргэжлийн удирдамжаар хангахад зориулагдана.

2.Насанд хүрээгүй хоригдолд анхаарал халамж тавих, тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулахад бэлтгэхэд хорих ангийн зүгээс орон нутгийн засаг захиргаа оршин суугчидтай чөлөөтэй харилцах хэлхээ холбоог байнга хийж байх ба энэ ажилд идэвхи чармайлт гаргасан байгууллага хүмүүсийг урамшуулан дэмжиж байвал зохино.

3.Хүүхдийн хүний сайн сайхан байдал, эрх ашгийн үүднээс эцэг эх, асран хамгаалагчид нь түүнтэй уулзах эрхтэй байна. Үүнийг хэт богино цаг, хугацаагаар, цөөхөн удаагаар хязгаарлаж болохгүй. Уулзуулахгүй бол хүүхэд гэр бүл, хамт олноосоо хөндийрөх, улмаар нийгэмшихэд нь саад учрах нэг нөхцлийг бүрдүүлдэг.

4.Хориход байгаа насанд хүрээгүй хүний мэргэжлийн сургалт нь боломжтой бол түүнийг суллагдсаны дараа нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, түүний цаашдын амьдралд хэрэгтэй байх хэрэгтэй бөгөөд зохих хэвийн байдлыг хангах зорилгоор яам, газар хоорондын хамтын ажиллагааг урамшуулан дэмжих нь зайлшгүй чухал юм.

5.Олон нийтийн хяналт буюу төрийн бус байгууллага, төрийн байгууллага, хүүхдийн байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс гэх зэрэг байгууллага, иргэдийг хяналтанд татан оролцуулах хэрэгтэй байгаа билээ.

6.Насанд хүрээгүй хүнийг хорих нь хамгийн эцсийн арга хэмжээ байх, нэгэнт хорихоос өөр аргагүйд хүрэх нь хорих аль болох богино хугацаатай байх зарчмыг баталгаажуулахын тулд хүүхэдтэй холбоотой хэрэг, хувийн

болон бусад нөхцөл байдлыг хорих байгууллагаас байнга судалж байх, холбогдох байгууллагад нь уламжилж байх, тэрхүү байгууллага нь арга хэмжээ ач байх, ялангуяа цагдаа, прокурор, шүүх өөрсдийн шийдвэрээ байнга хянаж байх, үндэслэл арилсан бол хүүхдийг нэн даруй суллах, хориход төрийн болон хөндлөнгийн, олон нийтийн хяналтыг татан оруулах гэх зэргээр уг зарчмын хэрэгжилтийг баталгаажуулж байгаа юм.

Үүний зэрэгцээ хүүхэд эрүүгийн хэргийг шийдвэрлэх явцад 18 насанд хүрсэн гэсэн үндэслэлээр насанд хүрэгчдийн нэгэн адил зарим хэргийг шийдэж байгаа нь мөн хууль зөрчсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Учир нь гэмт хэрэг үйлдэх үеийн насаар нь тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх нэг зармыг Эрүүгийн хуулийн 21-р зүйлд заасан байдаг.

ДҮГНЭЛТ

Цаашид анх удаа хууль зөрчиж амьдралдаа алдсан хүүхдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр орон нутагт үлдээж нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх боломжийг олгосон хуулийн зохицуулалтыг бий болгох нь гарцаагүй хэрэгтэй байгаа юм. Орон нутагт нь байгаа бүх төрийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүд хамтран гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцлийг арилгах, сургууль завсардалт, гэр бүлийн хүчирхийлэл, асран хамгаалалт, гэр бүлийн ядуурал гэх зэрэг олон эрсдэлтэй нөхцөл байдлуудыг хамтран шийдэх, үүний зэрэгцээ хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд, гэр бүлд нь туслаж дэмжиснээр, хууль зөрчих, өөрөө хохирогч болохоос нь урьдчилан сэргийлэх, улмаар Хүүхэд хамгаалллын тогтолцоог Монгол улсад бий болгох, тогтворжуулах, шаардлагатай байна.

Нөгөө талаар гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүүхдийг сүүлчийн арга хэмжээний хувьд нэгэнтээ цагдан хорихоос өөр аргагүй болсон бол цагдан хорих дээд талын хугацааг 3 хоногоор хязгаарлах, энэ үед хүүхдийг хүмүүжүүлэх, цагдан хорихыг олон нийт, төр захиргааны хараа хяналт, батлан даалтанд өгөх. Хүүхдийн хорих байгууллагыг нээлттэй сургалт хүмүүжлийн тусгай байгууллага болгож өөрчлөх, хүүхэд орой нь, эсхүл 7 хоногийн сүүлээр, эсхүл сарын сүүлээр гэртээ харьж болохыг зөвшөөрөх, хүүхдийг амьдрах ухаан, хаьцааны соёл, мэргэжлийн чиг баримжаа, монгол хэлний мэдлэг, суурь боловсрол гэх зэрэг төрөл бүрийн сургалтаар хангах гэх зэрэг бодлого, зохицуулалт туйлын их үгүйлэгдэж байна. Тэгэхгүйгээр хүүхдийг хориод байвал нэг талаас “гэмт хэрэгтнүүдийг” эртнээс нь бэлтгэж байна гэсэн үг, нөгөө талаар хорих нь нийгэм, гэр бүл, иргэн хэнд нь үр ашиггүй, зардал ч ихтэй. Иймхүү Хүүхдийг хорихоос татгалзаж олон нийтийн дунд нийгэмшүүлэх хүмүүжүүлэх бодлогыг баримтлах нь зүйтэй, үүний зэрэгцээ хүнд нөхцөлд байгаа хүүхдэд туслаж дэмжиж эхлэх хэрэгтэй. Ингэснээр бид нар бүгдээрээ үр хүүхдүүддээ амьдралыг аюулгүй орчныг нь бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна гэсэн үндэслэл бүхий асуудлуудыг зохицуулахаар хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй юм.

Мөн ХЗҮХ-ийн Криминологийн сектороос эрхлэн хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн, хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлаар нийслэл, орон нутагт ажиллаж байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч нийт 100 гаруй албан тушаалтныг хамруулсан судалгааны дүн, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын зөвлөмж ч дээрх дүгнэлтэд хүргэсэн юм.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ЦАГДАН ХОРИХ БАЙР, ХОРИХ АНГИЙН ДОТООД ЖУРМЫН ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

I.Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, дотоод журмын төсөл боловсруулах болсон үндэслэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах, насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байр, хорих ангийн дотоод журам боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

1)Хүүхдийн эрхийн тухай конвенцидхүүхдийн эрх чөлөөг хууль бусаар бүүю дур мэдэн хязгаарлаж болохгүй.

Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх; эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрд насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана. Дээд ашиг сонирхолд нь харшилна гэж үзээгүй бол эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрийг насанд хүрэгчдээс тусгаарлах, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд гэр бүлтэйгээ харилцаатай байх, уулзах боломжоор хангах талаар заасан.

2)Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбоотой НҮБ-аас гаргасан журамд заахдаа Насанд хүрээгүй хүмүүст холбогдох шүүн таслах ажиллагааг явуулахтай холбогдсон НҮБ-ын наад захын стандартын Журам (Бээжингийн Журам)-аар тогтоосон зарчим, процедурт нийцүүлэн насанд хүрээгүй хүмүүсийг хорих ёстой. Насанд хүрээгүй хүмүүст ногдуулсан хорих ял нь хамгийн зайлшгүй наад захын хугацаатай нөлөөллийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэгдэх ёстой. Энэ нь ял шийтгүүлсний дараа улам илүү аюултай төрлийн гэмт хэрэг үйлдсэн онцгой тохиолдолд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр хязгаарлагдах ёстой бөгөөд бусад нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой.

3)Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж , Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль

тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. гэж заасан.

4)Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд "Төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан хорих ял эдэлж байгаа хүүхдийн нэр төрийг хүндэтгэн хамгаалж, сурч боловсрох, авьяас чадвараа хөгжүүлэх, хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт албадан саатуулах, цагдан хорихыг хориглоно. Хүүхдийг албадан саатуулах, цагдан хорих болон насанд хүрээгүйчүүдийн хорих байгууллагын дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн.

II. Төсөл боловсруулах шаардлага, баримтлах зарчим:

Шаардлага:

- Өсвөр үеийнхнийг нийгэмдээ утга учиртай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, тэднийг амьдралыг зан үйлийн гажуудалд орж болзошгүй үед нь дэзд зэргээр гэмт хэргээс ангид байлгаж, бие хүний хөгжил, боловсрол олох үйл явцыг дэмжих нь тулгарсан асуудал болоод байна. Цагдан хорих болон хорихоос суллагдсан хүүхэд давтан гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас сэтгэл санаа болон бие эрхтэнээрээ хохирох явдал жил ирэх тусам буурахгүй байна.

  Нэн ялангуяа хорихоос суллагдсан хүүхэд эргээд гэр бүлдээ очих, олон нийтийн дунд байх, сургуульд суралцах, мэргэжлийн чиг баримжаа эзэмших бэлтгэлээ хангахад хорих байгууллагаас туслалцаа шаардагдаг, энэ бүхэн байхгүй учраас насанд хүрээгүй хүмүүсийн зүгээс гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байна.
- Цагдан хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийн нас, хүйс, хувийн байдлыг харгалзан нийгэм, боловсрол, мэргэжил, сэтгэл зүй, эмнэлэг, бие махбодийн шаардлагатай бүх туслалцаа, анхаарал халамж, хамгаалал бүхий тогтолцоо манай улсад байхгүй байна.
- Хориход байгаа насанд хүрээгүй хүний ашиг сонирхлыг хангах явдлыг баталгаажуулж тэдний эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нийгмийн гишүүн болгох боломжийг хөгжүүлэхэд туслахуйц тийм үзэл бодол, дадал зуршлыг төлөвшүүлэх явдлыг урамшуулах, тэднийг хариуцлагаа мэдэрдэг болгон хүмүүжүүлэхэд тус дөхөм болсон үр нөлөөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Хорих байгууллагад байгаа насанд хүрээгүй хүмүүсийг сургаж хүмүүжүүлэх ажлын зорилго нь нийгэмд ашигтай, үр бүтээлтэй байр суурьтай байхад нь тус болох үүднээс асрамж хамгаалалтаар хангах, боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэх ёстой. Ийнхүү хүүхдэд асрамж хамгаалал, тэдний нас, хүйс, хувийн байдал. түүнчлэн тэдгээрийн хөгжлийг бүрэн хангахад шаардлагатай нийгэм, сэтгэл зүй, эмнэлэг, бие махбодийн түүнчлэн боловсрол, мэргэжлийн сургалтын салбарт бүх талын туслалцаа үзүүлбэл хүүхдүүд ахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн улмаас хохирох явдал гарахгүй байх нэг нөхцөл бүрдэнэ.

Зарчим: Бусад улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзэхэд насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг тусгайлан шийддэг шүүх, хуулийн зохицуулалт, цагдан хорих, хорих ял эдлүүлэхэд тусгайлан гаргасан журам байдаг байна. Дээрх хууль зүйн болон практик шаардлага, олон улсын чиг хандлагад үндэслэн насанд хүрээгүй хүмүүсийн цагдаг хорих байр, хорих ангийн журмыг тусгайлан гаргах шаардлагатай гэсэн чиг баримталлаа.

Түүнчлэн насанд хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байрны, хорих ангийн журмыг бололвсруулахдаа үндэсний хууль тогтоомжид харшлахгүй байх, хуулийн байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүй байх, манай улсын эрх зүйн онцлогт нийцсэн байх нөхцөлд хэрэгжих ёстой гэсэн зорилго баримталлаа.

Журмын гол зарчим нь ***ямар нэгэн хэлбэрээр хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахад хүний үндсэн эрх, эрх чөлөөнд нийцүүлэн бүх төрлийн хорих ялын сөрөг үр дагаварыг саармагжуулах ба нийгмийн ба амьдралд буцаан татан оруулахад тус дөхөм үзүүлэх, ингэхийн тулд хүүхдийг төрөл садантай нь хамт олонтой нь тогтмол уулзуулж байх, харилцаа холбоотой байлгаж байх, захидал харилцааны эрхийг нь хязгаарлахгүй байх, мэдээлэл авах эрхийг нь хязгаарлахгүй байхаар зохицуулах ёстой*** юм.

III.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай", "Эрүүгийн хууль" нэмэлт өөрчлөлт, "Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай" хуульд "Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх" гэсэн зүйл, хэсэг, заалт нэмэхээр хуулийн төсөл боловсруулна.

Хуулийн төсөлд хорих байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүмүүсийн талаар баримталвал зохих зүйл, насан хүрээгүй хүмүүсийн цагдан хорих байрны үйл ажиллагаа, дэглэм, өдөр тутмын үйл ажиллагаа зэрэг асуудлыг тусгана.

IV.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Журмын төсөл батлагдсаны дараа нийгэм, эдийн засгийн дараах үр дагавар гарна гэж тооцож байна.Үүнд:

1. Насанд хүрээгүй хүмүүсийг олон улсын наад захын жишиг стандартад нийцүүлэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх шинэлэг эрх зүйн зохицуулалт бий болно.

3.Тусгайлсан журам гаргана. Энэ нь практикт хэрэгжих боломжтой, хуулийн байгууллагын нэн ялангуяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулахааргүй байна.

V. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр

боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй бөгөөд одоо үйлчилж буй "Цагдан хорих байрны дотоод журам" дээр "насанд хүрээгүй сэжигтэн яллагдагчийг цагдан хорих" гэсэн хэсэг нэмэгдэж, "Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн дотоод журмын төслийг шинээр боловсруулна.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ХОРИХ АНГИЙН ДОТООД ЖУРАМ

Үндсэн зорилго

1.1.Энэхүү Журмын зорилго нь ямар нэгэн хэлбэрээр хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүний үндсэн эрх,эрх чөлөөнд нийцүүлэн бүх төрлийн хорих ялын сөрөг үр дагаврыг, саармагжуулах ба нийгмийн амьдралд буцаан татан оруулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор наад захын стандартыг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Дотоод журмын үйлчлэх хүрээ ба түүнийг хэрэглэх

2.1 Хорих ял нь насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн байх ёстой. Насанд хүрээгүй хүний ашиг сонирхлыг хангах явдлыг баталгаажуулж тэдний эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нийгмийн гишүүн болгох боломжийг хөгжүүлэх, элдэв муу дадал зуршлыг арилгахад тус дөхөм болсон үр нөлөөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2. Энэхүү журмыг хорих ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүмүүс байгаа бүх төрөл хэлбэрийн хорих ангид хэрэглэнэ.

3 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүмүүсийг хорих ангид бүртгэх баримт, бичиг

3.1. Хэргийн тэмдэглэл, эмнэлгийн үзлэгийн үр дүн, сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэсэн протокол, түүнчлэн хүмүүжлийн хэлбэр, агуулгад хамаарах бусад бүх баримт бичгийг оруулсан бүх мэдээлэл нь шинэ мэдээ сэлтээр байнга баяжигдсан, нууцлал бүхий хувийн хэрэгт хадгалагдах ёстой бөгөөд тэдгээртэй зөвхөн эрх бүхий албан тушаалтан танилцах бөгөөд тэдгээрийг ойлгоход хялбар дөхөм нөхцлийг хангасан байдлаар ангилагдсан байна.

3.2 Насанд хүрээгүй хүн бүр хувийн хэрэгтээ орсон аливаа баримт буюу саналтай маргах эрхтэй байх бөгөөд нарийн тодорхой бус, үндэслэлгүй, шударга бус тодорхойлолтыг залруулах боломжтой байна.

4 дүгээр зүйл. Хорих ангид хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх

4.1.Насанд хүрээгүй хүнийг байлгаж байгаа байгууллага бүр хүлээн авсан насанд хүрээгүй хүн бүрийн хувьд дараах мэдээллийг агуулсан бүрэн, нарийн тэмдэглэлийг хөтлөх ёстой.

а)Насанд хүрээгүй хүний хувийн байдлын тухай мэдээлэл;

б)Түүнийг хорих болсон баримт, шалтгаан, үндэслэл;

в)Хүлээн авсан, шилжүүлсэн, сулласан өдөр, цаг;

г)Насанд хүрээгүй хүнийг байлгах, шилжүүлэх буюу суллах тохиолдол бүрд эх, эцэг буюу асран хамгаалагчид мэдэгдсэн тухай баримт;

д)Мансууруулах болон согтууруулах ундааг байнга хэрэглэдэг эсэх талаарх болон бие махбодийн ба сэтгэцийн эрүүл мэндийн тодорхой асуудлын тухай мэдээ сэлт;

4.2.Насанд хүрээгүй хүнийг хүлээн авсан, байгаа газар, шилжүүлсэн ба сулласантай холбогдсон мэдээллийг насанд хүрээгүй хүний эцэг эх, асран хамгаалагч буюу ойрын төрөл саданд нь нэн даруй хүргэнэ

4.3.Хүлээн авсны дараа богино хугацаанд захиргаа нь насанд хүрээгүй хүн бүрийг байлгах байдал, нөхцлийн тухай холбогдох бүрэн мэдээллийг бэлтгэж танилцуулах ёстой.

4.4.Бүх насанд хүрээгүй хүмүүс нь хорих ангид байрласны дараа тус байгууллагад байх журам, тэдний эрх үүргийн бичмэл танилцуулгыг сайн мэдэх хэл дээрээ гомдол гаргах бүрэн эрх бүхий байгууллагын хаягийн хамт авах, түүнчлэн хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн буюу хувийн байгууллагын хаягийг авах ёстой. Бичиг үсэг үл мэдэх буюу зохих хэлээр уншиж чадахгүй насанд хүрээгүй хүмүүсийн хувьд түүнд эдгээр мэдээллийг бүрэн ойлгох боломжийг хангасан хэлбэрээр өгнө.

4.5.Бүх насанд хүрээгүй хүмүүст хорих ангийн дотоод дэг журмыг зохицуулдаг дүрэм тэдэнд тавих анхаарал, халамжийн зорилго, арга, сахилгын шаардлага, мэдээлэл олж авах ба гомдол гаргах бусад зөвшөөрөгдсөн арга, түүнчлэн хорих ангид байх үеийн эрх, үүргийг бүрэн хэмжээгээр ойлгох боломжийг олгохуйц зайлшгүй чухал бусад бүх асуудлыг тайлбарлаж өгнө.

5 дугаар зүйл. Ангилалт ба хуваарилалт

5.1. Насанд хүрээгүй хүн бүрийг хүрэлцэн ирсэн даруйд богино хугацаанд тэдэнтэй ярилцлага хийж тэднийг сэтгэл зүйн болон нийгмийн хувьд бэлтгэх, тодорхой хөтөлбөрт хамаарах аливаа хүчин зүйлийг тодорхойлох ёстой. Хорих ангид байх хугацаанд зан төлөвийг нь өөрчлөх тусгай арга хэмжээг хорих ангийн мэргэшсэн ажилтан сайтар боловсруулсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

5.2. Насанд хүрээгүй хүнийг гагцхүү түүний нас, хувийн онцлог шинж, хүйс, эрх зүйн зөрчлийн төрөл, сэтгэцийн болон бие махбодийн байдлыг хортой нөлөөлөл ба аюултай нөхцөл байдалд оруулахаас хамгаалагдсан тэдгээрийн хэрэгцээ, эрх зүйн байдал, онцлог шаардлагыг хангасан нөхцөлд байлгах ёстой. Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хуваарилах үндсэн шалгуур нь янз бүрийн хэрэгтнийг бие махбод сэтгэл зүй, ёс суртахууны төлөвшил, сайн сайхан байдлыг хамгаалах явдлыг хангах, зарим тодорхой этгээдийн онцлог эрэлт хэрэгцээнд дээд зэргээр нийцсэн тийм төрлийн анхаарал халамжаар хангахад орших ёстой.

5.3 Насанд хүрээгүй хүнийг насанд хүрэгчдээс тусад нь байлгах ёстой.



6 дугаар зүйл. Хорих нөхцөл, байр сууц

6.1.Хорих ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүмүүс нь эрүүл ахуй, хүний нэр төрийг хүндэтгэх бүхий л шаардлагад нийцсэн нөхцөл, үйлчилгээтэй байх ёстой.

6.2.Насанд хүрээгүй хүмүүсийн хорих анги, түүний нөхцөл нь насанд хүрээгүй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, сэтгэл хөөрлийн урамшуулал, бусадтайгаа харилцах, спорт, биеийн тамирын арга хэмжээнд оролцох, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангагдсан байх ёстой.

6.3.Насанд хүрээгүй хүмүүст зориулсан орон байрыг төлөвлөх, барихдаа гал түймэр гарах боломжийг дээд зэргээр багасгаж орон байрнаас аюулгүйгээр гарган аврах нөхцлийг бүрдүүлсэн, гал түймрийн аюулаас сэрэмжлэх үр нөлөөтэй дохиоллыг тавьж, гал түймэр гарсан тохиолдолд аюулгүй байлгах зааварчилгааг боловсруулсан байна.

6.4.Насанд хүрээгүй хүн бүр унтлагын ор, цэвэр хэрэглэлээр хангах бөгөөд тэдгээрийг цэвэр байлгахын тулд зохих журмын дагуу байнга сольж байх ёстой.

6.5.Ариун цэврийн өрөөний тоноглол нь насанд хүрээгүй хүн ямар ч үед өөрийн жам ёсны хэрэгцээ, цэвэр, тохитой нөхцлийг хангах ёстой.

6.6.Насанд хүрээгүй хүн бүр хувийн эд зүйлстэй байх, зохих нөхцөлд хадгалах, өөртөө байлгахыг хүсэхгүй байгаа буюу хураан авсан эд зүйлийг найдвартай газар хадгалуулах ёстой. Ийм зүйлсийн жагсаалтад насанд хүрээгүй хүн гарын үсгээ зурсан байна. Эд зүйлсийг хорих ангиас гадагш илгээх, мөнгө өөрөө зарцуулахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд эдгээр эд зүйлс, мөнгийг насанд хүрээгүй хүнийг суллагдах үед нь буцаан олгоно.

6.7.Хорих анги насанд хүрээгүй хүн бүрийг зохих цаг уурын болон ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд тохирсон хувцаар хангах ёстой бөгөөд энэ хувцас нь ямар ч тохиолдолд тэдний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй. Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүмүүс хувийнхаа хувцыг хэрэглэх эрхтэй бөгөөд хорих ангиас суллагдсан буюу өөр ямар нэгэн ажил хэргээр түр гарч байгаа тохиолдолд хувийн хувцаа өмсөхийг зөвшөөрөх ёстой.

6.8.Насанд хүрээгүй хүмүүсийг хоолны дэглэм, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардалагад нийцсэн, амт чанар, хэмжээтэй хоол хүнсээр хангах ёстой. Насанд хүрээгүй хүн бүр ямар ч үед ундны цэвэр усаар хангагдсан байх ёстой.

7 дугаар зүйл. Боловсрол, мэргэжлийн бэлтгэл, хөдөлмөрийн үйл ажиллагаа

7.1.Насанд хүрээгүй хүн бүр эрэлт хэрэгцээ, авьяас чадвартаа тохирсон, нийгмийн амьдралд бүцан ороход нь бэлтгэх зорилготой боловсрол эзэмших эрхтэй. Ийм боловсролыг боломжтой бол засан хүмүүжүүлэх газраас гадуур ердийн сургуулиар олгох бөгөөд ямар ч тохиолдолд суллагдсаныхаа дараа үргэлжлүүлэн боловсрол эзэмшихэд ямар нэгэн хүндрэл гархааргүй хөтөлбөрийн дагуу олгох ёстой. Хорих ангийн захиргаа нь гадаадын болон угсаа соёлын өвөрмөц эрэлт хэрэгцээтэй насанд хүрээгүй хүмүүсийн

боловсролд онцгой анхаарвал зохино. Бичиг үсэг мэдэхгүй буюу суралцахад онцгой хүндрэл бүхий насанд хүрээгүй хүн тусгай боловсрол олж авах эрхтэй.

7.2.Албан боловсрол эзэмших наснаас хэтэрсэн насанд хүрээгүй хүн үргэлжлүүлэн боловсрол эзэмшихийг хүсвэл түүнийг зөвшөөрч дэмжлэг үзүүлэх бөгөөд тэднийг боловсролын зохих хөтөлбөрт хамруулахад шаардлагатай бүх зүйлийг хийвэл зохино.

7.3.Хорих ангид байгаа насанд хүрээгүй хүнд олгосон боловсролын диплом, гэрчилгээнд тухайн хүнийг хорих ангид хоригдож байсныг нь мэдэгдэх ямар нэгэн тэмдэглэл хийж болохгүй.

7.4.Хорих анги нь насанд хүрээгүй хүнд зориулсан сургалтын болон танин мэдэхүйн ном, сэтгүүл, тогтмол хэвлэл бүхий номын сантай байх бөгөөд насанд хүрээгүй хүмүүс түүнийг ашиглах боломжоор бүрэн хангагдсан ийнхүү ашиглахыг нь дэмждэг байх ёстой.

7.5.Насанд хүрээгүй хүн бүр ирээдүйн хөдөлмөрийн үйл ажиллагаанд нь хэрэг болох мэргэжлийн тусгай боловсрол эзэмших эрхтэй.

7.6.Хорих ангийн захиргааны шаардлагыг харгалзан зохих мэргэжлийг сонгосон хязгаарын хүрээнд өөрийнхөө хүсэж байгаа ажлын төрлийг сонгох боломжийг насанд хүрээгүй хүнд олгох ёстой.

7.7.Хорих анги нь насанд хүрээгүй хүмүүсийг мэргэжлийн сургалттай нь холбоотойгоор цалин хөлстэй ажил хийх бололцоог олгож нийгмийн амьдралд буцан ороход хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөвийг нь сайжруулах боломжийг нэмэгдүүлэх ёстой. Ийм төрлийн ажил нь насанд хүрээгүй хүнийг суллагдсаны дараа мэргэжлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд нь зохих бэлтгэл болох ёстой. Хорих анги дахь хөдөлмөрийн зохион байгуулалт, арга нь хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүнийг хөдөлмөрийн хэвийн үйл ажиллагааны нөхцөлд бэлтгэж чадахуйц зохион байгуулалт, арга адил төрөлтэй нийцсэн байх ёстой.

7.8.Цалин хөлсний зарим хэсгийг насанд хүрээгүй хүнийг суллагдах үед нь олгох зорилгоор нэрийн дансанд нь хадгалах ёстой. Цалин хөлсний бусад хэсгийг насанд хүрээгүй хүн өөртөө зарцуулах эд бараа худалдан авах, үйлдсэн гэмт хэргийнхээ хохирлыг нөхөн төлөх, хорих байгууллагаас гадна байгаа гэр бүлийнхэн болон бусад хүмүүст илгээх эрхтэй байна.

8 дугаар зүйл. Амралт, чөлөөт цаг

8.1.Насанд хүрээгүй хүн бүр хэрэв цаг агаарын нөхцөл боломжтой байгаа бол биеийн тамирын дасгал хийх хангалттай хэмжээний чөлөөт цагтай байх эрхтэй бөгөөд энэ хугацаанд эрүүлжүүлэх буюу биеийн тамирын зохих дасгал хийх боломжоор хангагдана. Эдгээр арга хэмжээнд зориулж зохих байр, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана. Насанд хүрээгүй хүн бүрт өдөр бүр чөлөөт цагаа өнгөрөөх нэмэгдэл цаг олгох бөгөөд энэ үед насанд хүрээгүй хүний хүсэлтээр урлаг, гар урлал эрхэлж болно.

9 дүгээр зүйл. Шашин шүтлэг

9.1.Насанд хүрээгүй хүн бүрт шашин шүтлэгийн болон оюун санааны

амьдралтай холбогдсон өөрийн эрэлт хэрэгцээгээ хангах, тухайлбал, хорих ангид явагдаж байгаа хурал мөргөлд суух өөрийн шашны зан үйлд нийцүүлсэн мөргөлд оролцох түүнчлэн шашны ёслолын зайлшгүй шаардлагатай ном, бусад эд зүйлийг ашиглах, өөрийн шашин шүтлэгт нийцсэн сургалт хийхийг зөвшөөрөх ёстой.

Насанд хүрээгүй хүн бүр өөрийн сонгосон аливаа шашны мэргэжлийн төлөөлөгчтэй уулзах эрхтэй байхын зэрэгцээ шашны зан үйлд оролцохгүй байх, шашны сургалт, номлолоос татгалзах эрх чөлөөтэй байна.

10 дугаар. Эмнэлгийн үйлчилгээ авах

10.1.Насанд хүрээгүй хүн бүрт эмнэлгийн зохих үйлчилгээ урьдчилан сэргийлэх болон шүд, нүд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, эмчийн зааврааар эм хэрэглэх, хоолны дэглэм баримтлах зэрэг эмчилгээ хийнэ. Эдгээр эмчилгээ, үйлчилгээг хорих ангид байгаа насанд хүрээгүй хүмүүст тухайн байгууллага байрлаж байгаа газрын зохих байгууллага, эрүүл мэндийн алба нийгмийн амьдралд буцаж ороход нь тус дөхөм болохуйцаар үзүүлнэ.

10.2.Насанд хүрээгүй хүн бүр хорих ангид ирмэгцээ өмнө нь харгис хэрцгий харьцаж байсан аливаа шинж тэмдгийг бүртгүүлэх эмчийн хяналт шаардагдах бие махбодийн болон сэтгэцийн гаж согогийг тодорхойлуулах зорилгоор эмчийн үзлэгт орох эрхтэй.

10.3.Насанд хүрээгүй хүмүүст үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ нь бие махбодын буюу сэтгэцийн аливаа өвчин, мансууруулах бодис хэрэглэх буюу нийгмийн амьдралд насанд хүрээгүй хүнийг буцаан оруулахад саад учруулж болзошгүй бусад гажуудлыг илрүүлэх эмчлэн эдгэрүүлэх зорилготой байх ёстой. Хорих анги бүр хоригдож байгаа хүмүүсийнхээ тоо, хэрэгцээнд нийцсэн эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж түүнчлэн урьдчилан сэргийлэх, сувилах буюу эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх чадвар бүхий ажилтантай байх ёстой. Өвчтэй, өвчний зовиуртай, бие махбодийн болон сэтгэцийн хүндрэлтэй байдал илэрсэн насанд хүрээгүй хүнд эмнэлгийн ажилтан нэн даруй үзлэг хийх ёстой.

10.4.Сэтгэцийн өвчтэй насанд хүрээгүй хүн хараат бус эмнэлгийн хяналт бүхий тусгай байгууллага эмчилгээ хийх ёстой. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагатай тохиролцсоны дагуу суллагдсаны дараа сэтгэцийн өвчнийг үргэлжлүүлэн эмчлэх арга хэмжээг авбал зохино.

10.5. Эм, тариаг эмнэлгийн зайлшгүй эмчилгээний үед хэрэглэх ёстой бөгөөд хэрэв боломжтой бол ийм нөхцөл байдлыг насанд хүрээгүй хүнд танилцуулж зөвшөөрлийг авсны дараа хэрэглэнэ. Ялангуяа, мэдээллийг хууль бусаар авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэх, насанд хүрээгүй хүнийг бие махбодийн хөдөлгөөнийг хориглох хэрэгсэл болгох зорилгоор эм тариаг ашиглах ёсгүй. Насанд хүрээгүй хүмүүсийг хэзээ ч эм, эмчилгээний туршилт болгох ёсгүй. Аливаа эм тариаг зөвхөн эмнэлгийн ажилтны зөвшөөрөлтэйгөөр хэрэглүүлнэ.

11 дүгээр зүйл. Өвдсөн, гэмтсэн, нас барсныг мэдээлэх

11.1. Насанд хүрээгүй хүний гэр бул, асран хамгаалагч, насанд хүрээгүй хүний нэрлэсэн бусад хүмүүс нь тэдний хүсэлтээр насанд хүрээгүй хүний эрүүл мэндийн байдлын тухай, эрүүл мэндэд нь гарсан ноцтой өөрчлөлтийн талаар мэдээлэл авах эрхтэй. Хорих ангийн дарга нь нас барсан тухай болон насанд хүрээгүй хүнийг хорих анги байрлаж байгаа газраас өөр эмнэлгийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай өвчний тухай буюу хорих ангийн эмнэлэг 48 цагаас дээш хугацаагаар сэхээн амьдруулах эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлага үүссэн талаар холбогдох насанд хүрээгүй хүний гэр бүл, асран хамгаалагч болон нэр заасан бусад хүмүүст нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв насанд хүрээгүй гэмт хэрэгтэн гадаад улсын иргэн бол харьяалах улсын консулын газарт мөн мэдэгдэнэ.

11.2. Хорих ял эдлэх үедээ нас барсан насанд хүрээгүй хүний ойрын төрөл садны хүмүүс нь нас барсан тухай нотолгоо, цогцсыг үзэх, хэрхэн оршуулахыг тодорхойлох эрхтэй байна. Хоригдох үед нас барсан насанд хүрээгүй хүний нас барсан шалтгааныг хараат бусаар мөрдөн шалгах ёстой бөгөөд үр дүнг ойрын төрөл садны хүмүүст нь танилцуулна. Ийм мөрдөн шалгалтыг суллагдсанаас хойш 6 сарын дараа нас барсан нь хоригдох үетэй холбоотой гэж үзэх үндэслэл байвал мөн явуулна.

11.3 Насанд хүрээгүй хүнд түүний гэр бүлийн ойрын төрлийн аливаа гишүүн нас барсан, хүндээр өвчилсөн, гэмтсэн талаар богино хугацаанд мэдэгдэж, оршуулгад оролцох, хүнд өвчтэй төрөл садантайгаа уулзах эрхтэй байх ёстой.

12 дугаар зүйл. Харилцах хүрээг өргөтгөх

12.1.Насанд хүрээгүй хүн бүр түүний эрэлт хэрэгцээг харгалзсан орчинд гэр бүлийнхэн, өмгөөлөгчтэйгөө харьцахад нь саад хязгаарлалтгүй нөхцөлд сард нэгээс доошгүй удаа буюу ерөнхийдөө долоо хоногт нэг удаа тогтмол хувийн, ганцаарчилсан уулзалт хийх эрхтэй.

12.2.Насанд хүрээгүй хүн бүр өөрийн сонголтоор хэнтэй ч утсаар ярих, захидал харилцаагаар харилцах эрхтэй бөгөөд энэ эрхээ бодитойгоор хэрэгжүүлэхэд шаардагдах тусламжийг авах ёстой. Насанд хүрээгүй хүн бүр захидал харилцаа хүлээн авах эрхтэй.

12.3.Насанд хүрээгүй хүмүүст сонин, сэтгүүл, бусад хэвлэл нийтлэл унших, радио, телевизийн хөтөлбөр, киногоор дамжуулан, дэлхий дахины үйл явдлын талаар мэдээллийг байнга олж авах, өөрсдийн сонирхсон хууль ёсны аливаа клуб, байгууллагын төлөөлөгчидтэй уулзах боломжийг олгож байх ёстой.

13 дугаар зүйл. Бие махбодийн хөдөлгөөнийг хязгаарлах ба хүч хэрэглэх

13.1. Бие махбодийн хөдөлгөөнийг хязгаарлах хэрэгсэл болон хүч хэрэглэхийг хяналтын бусад арга хэмжээг хэрэглэж дууссан буюу үр дүнгээ өгөөгүй онцгой тохиолдолд зөвхөн хууль тогтоомжид заасан буюу зөвшөөрсөн хэлбэрээр хэрэглэнэ. Эдгээрийг доромжлох буюу тохуурхан даажигнах шинжгүйгээр гагцхүү шаардлагатай хамгийн богино хугацаанд,



хязгаарлагдмал хүрээнд хэрэглэх ёстой. Захиргааны удирдлагын шийдвэрээр ийм арга хэрэгслийг зөвхөн насанд хүрээгүй хүн өөртөө болон бусдад буюу, эд хөрөнгийн ноцтой хохирол учруулахгүй байхын тулд хэрэглэнэ. Энэ тохиолдолд байгууллагын дарга эмнэлгийн болон бусад холбогдох албан тушаалтнуудтай зөвлөлдөн нэн даруй дээд шатны байгууллагад мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл. Сахилгын дэглэм

14.1.Сахилгын бүх арга хэмжээ, түүнийг хэрэглэх үндэслэл журам нь аюулгүй байдлын ашиг сонирхлыг хангах, дэг журмыг сахиулахад чиглэгдэх ёстой бөгөөд насанд хүрээгүй хүмүүсийн жам ёсны нэр төр, алдар хүнд эрхэм чанарыг нь хамгаалах зорилт, хүний үндсэн эрхийг хүндэтгэх, өөрийгөө хүндэтгэх болон шударга ёсыг мэдрэхэд хэвшүүлэх хорих байгууллагын зорилт, агуулгад нийцэх ёстой.

14.1.Харгис хэрцгий, хүнлэг бус, бие махбодийг тарчлаан зовоох ял шийтгэл, ганцаарчлан хорих байр, насанд хүрээгүй хүний бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учруулах, хүний нэр төр алдар хүндийг гутаан доромжилж харьцах бусад аливаа шийтгэлийг тогтоосон сахилгын бүх арга хэмжээг хэрэглэхийг хориглоно.

14.2.Ямар ч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүдтэйгээ уулзахыг хязгаарлах буюу хориглох явдал байж болохгүй. Хөдөлмөр эрхлэх нь насанд хүрээгүй хүмүүсийг нийгмийн амьдралд бүцан ороход бэлтгэх, өөрийгөө хүндэтгэж сургах арга хэрэгсэл, хүмүүжлийн арга байх ёстой бөгөөд сахилгын арга хэмжээ болгон хэрэглэж болохгүй. Насанд хүрээгүй хүнийг нэг удаагийн сахилгын зөрчилд нэгээс дээш удаа шийтгэл оногдуулж болохгүй. Хамт олноор нь шийтгэхийг хориглоно.

14.3.Эрх бүхий захиргааны байгууллагаас гаргасан журам, заавар нь насанд хүрээгүй хүмүүсийн эрх, эрэлт хэрэгцээ, шаардлага, үндсэн онцлогыг бүрэн харгалзсан дараах хэм хэмжээ тогтооно.

а) Сахилгын зөрчилд тооцогдох зан үйл;

б) Ногдуулах сахилгын шийтгэлийн төрөл, үргэлжлэх хугацаа;

в) Ийм шийтгэлийг оногдуулах эрх бүхий этгээд;

г) Гомдол хянан хэлэлцэх эрх бүхий этгээд.

14.4. Насанд хүрээгүй хүмүүст гаргасан зөрчлийнх нь талаар ойлгомжтой хэлбэрээр мэдэгдэж, эрх бүхий шударга байгууллагад өөрийгөө өмгөөлөх, давж заалдах боломжийг зохих ёсоор олгосны эцэст шийтгэл оногдуулна. Сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэсэн бүх арга хэмжээний тэмдэглэлийг хадгална.

14.5.Насанд хүрээгүй хүмүүс боловсрол, спортын салбарт, буюу биеэ авч хөтөлбөрийн хүрээнд болон нийгмийн салбарт тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой үйл ажиллагаанаас бусад тохиолдолд сахилга хангуулах чиг үүргийг гүйцэтгэх ёсгүй.

15 дугаар зүйл. Гомдлыг хянан үзэх

15.1.Насанд хүрээгүй хүн бүр хорих ангийн дарга, түүний эрх олгосон

төлөөлөгчид хүсэлт, гомдол гаргах боломжтой байх ёстой.

15.2.Насанд хүрээгүй хүн тогтоосон журмын дагуу, агуулгыг хянуулж өөрчлүүлэхгүйгээр захиргааны төв байгууллага, шүүх буюу холбогдох бусад байгууллагад гомдол, хүсэлт гаргах эрхтэй ба ирсэн хариуг нь тэдэнд саадгүй мэдэгдэх ёстой.

15.3.Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүн бүр гомдол гаргахдаа гэр бүлийн гишүүд, хуулийн зөвлөх, хүмүүнлэгийн тусламжийн алба, бусад этгээдээс туслалцаа хүсэх эрхтэй байна. Бичиг үсэг мэдэхгүй насанд хүрээгүй хүмүүс шаардлагатай үед улсын болон хувийн байгууллага, хуулийн зөвлөгөө өгөх газар буюу гомдол хүлээн авах эрх бүхий байгууллагуудын үйлчилгээ, холбогдох тусламжийг авах ёстой.

16 дугаар зүйл. Нийгмийн амьдралд буцаан оруулах

16.1. Насанд хүрээгүй хүн бүр хорих ангиас суллагдан нийгэм, гэр бүлийн амьдралд эргэн орох, боловсрол эзэмших, ажил эрхлэхэд нь туслахад чиглэгдсэн арга хэмжээнд хамрагдах ёстой. Энэ зорилгоор хугацаанаас нь өмнө суллах болон тусгай сургалт зохион байгуулах ёстой.

16.2.Насанд хүрээгүй хүмүүс нийгмийн амьдралд буцан ороход нь дэмжлэг үзүүлэх, тэдний эсрэг шударга бус хандлагатай тэмцэх ажил, үйлчилгээг эрх бүхий байгууллагууд зохион байгуулах ёстой. Энэхүү ажил, үйлчилгээний хүрээнд суллагдсан насанд хүрээгүй хүмүүс нийгмийн амьдралд амжилттай дасан зохицоход тус болох тохиромжтой орон байр, ажил, хувцас, амьдрах хангалттай хэрэгслээр боломжийн хэрээр хангавал зохино. Ийм үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын төлөөлөгчид насанд хүрээгүй хүмүүсийг нийгмийн амьдралд буцан ороход нь туслах зорилгоор зөвлөгөө өгөх, хоригдож байгаа хүүхдүүдтэй уулзах боломжоор хангагдана.

17 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн ажилтан

17.1.Хорих ангийн ажилтан ял эдлүүлэхээр шалтаглах буюу бусад ямар ч нөхцөл, тохиолдолд ямар нэгэн байдлаар эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус харьцах буюу бусдын нэр төрийг гутаах хандлага, өдөөн турхирах явдлыг гаргаж болохгүй.

17.2.Бүх ажилтнууд насанд хүрээгүй хүмүүсийн бие махбодийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч, тухайлбал, бие махбодийг буюу хурьцал үйлдэхэд албан ажлын байдлаа урвуулан ашиглах, сэтгэл санаанд дарамтад оруулахаас хамгаалж, шаардлагатай үед эмнэлгийн хяналтад оруулах шуурхай арга хэмжээ авах ёстой.

17.3.Бүх ажилтнууд насанд хүрээгүй хүмүүсийн хувийн амьдралын эрхийг хүндэтгэх, түүний дотроос мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн гэр бүл болон өөртэй нь холбогдох мэдээллийн нууцыг хадгалах ёстой.

17.4.Бүх ажилтнууд насанд хүрээгүй хүнийг хүн болохын нь хувьд нэр төр, алдар хүндийг зохих ёсоор хүндэтгэж хандахын тулд хорих ангийн дотоод ба түүний гаднах амьдралын ялгааг аль болохоор бууруулахыг эрмэлзэх ёстой.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

/өөрчлөх/

51.3. "арван зургаан насанд хүрээгүй этгээд" гэснийг *"арван найман насанд хүрээгүй этгээд"* гэж өөрчлөх

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ"

/нэмж өөрчлөлт оруулах/

31 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдийг хорих

31.1.Хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийг ахуй нөхцөлийн хувьд сайжруулсан байранд байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

31.2.Насанд хүрээгүй этгээдийн өдөр тутмын салхинд гарах хугацаа нэг цаг ба түүнээс дээш байна.

31.3.Насанд хүрээгүй хүмүүсийг нийгмийн амьдралаас нь хөндийрүүлэхгүй байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ

/нэмж өөрчлөлт оруулах/.

110 дугаар зүйл. Насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх

110.1.Насанд хүрээгүй ялтны ялыг зөвхөн насанд хүрээгүйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.

110.2.Насанд хүрээгүй ялтныг хөдөлмөрийн дадлага олгох зорилгоор хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй нөхцөлөөр ажиллуулж болно.

110.3.Насанд хүрээгүй ялтан 18 нас хүрмэгц ялыг нь эдлүүлэхээр насанд хүрэгсдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг хорих ангийн даргын тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

110.4.Энэ хуулийн 110.3-т заасан ялтны хувийн байдал, ял эдэлсэн хугацааг харгалзан хорих ангийн даргын шийдвэрээр түүнийг насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 2 жил хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

110.5.Насанд хүрээгүй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд жилд 8-аас дээшгүй удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

110.6.Насанд хүрээгүй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.

1.Насанд хүрээгүй хоригдолд хорих ял эдлэх хугацаанд мэргэжлийн сургалтыг ерөнхий боловсролын сургалтын нэгэн адил эзэмшүүлнэ.

2.Насанд хүрээгүй хоригдол хугацаанаас өмнө тэнсэн суллагдахад бусдад учруулсан өр төлбөр хамаарахгүй байна.

3.Хорих газраас суллагдсан насанд хүрээгүйчүүдийг хөдөлмөр заавал эрхлүүлдэг байх, үүнийг өөрсдийх нь санал хүсэлт, мэргэжил, авъяас чадварыг харгалзан хөдөлмөрт зохион байгуулалттай оруулах, орон

байраар хангахыг орон нутгийн захиргаа хариуцах.

4.Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийн журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ
/НЭМЖ ОРУУЛАХ/

1.Баривчлагдсан буюу шүүх хурлыг хүлээж байгаа (хэрэг нь хянан шийдвэрлэгдээгүй) насанд хүрээгүй хүнийг гэм буруугүй гэж үзэж харьцах ёстой. Хэрэв боломжтой байвал шүүх хурлаас өмнө цагдан хорихоос аль болохоор зайлсхийх нь чухал бөгөөд гагцхүү онцгой тохиолдолд ингэж болно. Үүнтэй холбогдуулан сонгох арга хэмжээ хэрэглэхийг аль болохоор эрмэлзэнэ.

2.Цагдан хорих арга хэмжээг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэж байгаа тохиолдолд насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхэлсэн шүүх бамөрдөн байцаах байгууллага баривчлагдсан хугацааг аль болохоор богиносгохын тулд хэргийг дээд зэргээр түргэн шуурхай хянан шийдвэрлэхэд тэргүүн ээлжинд анхаарал тавих ёстой. Шүүхээр хэрэг нь хянан шийдвэрлэгдээгүй байгаа насанд хүрээгүй хүнийг ял шийтгэгдээд байгаа насанд хүрээгүй хүнээс тусад нь байлгах ёстой.

ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ
/НЭМЖ ОРУУЛАХ/

1.Хэрэг нь шүүхээр хянан шийдвэрлэгдээгүй байгаа насанд хүрээгүй хүмүүсийг цагдан хорих нөхцөл нь дор дурьдсан хэм хэмжээнд нийцсэн байх ёстой бөгөөд түүнчлэн нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмыг харгалзсан бусад тодорхой байдал, цагдан хорих хугацааны үргэлжлэл, насанд хүрээгүй хүний эрх зүйн байдал, хэргийн онцлог зэргийг харгалзан үзвэл зохино.

2.Насанд хүрээгүй хүн нь хууль зүйн зөвлөгөө авах эрхтэй бөгөөд тийм туслалцаа авах тохиолдолд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах тухай хүсэлт гаргах боломжтой байна. Түүнчлэн өөрийнхөө өмгөөлөгчтэй тогтмол уулзана. Ийнхүү уулзах явцад түүний хувийн амьдралд хөндлөнгөөс үл оролцох ба өмгөөллийн нууцыг хадгалах явдлыг хангана.

3.Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүмүүст өөрийн боловсрол, сургалтаа үргэлжлүүлэх боломжийг олгох ёстой. Тэдний хөдөлмөр, сургалт буюу мэргэжлийн бэлтгэл нь цагдан хорих хугацааг сунгахад хүргэх ёсгүй.

4.Хэрэв энэ нь шүүн таслах ажиллагаа явуулах ашиг сонирхолтой зөрчилдөхгүй бол насанд хүрээгүй хүн нь чөлөөт цаг, амрахад нь зориулагдсан зүйлсийг авах буюу өөртөө байлгахыг зөвшөөрөх ёстой.

__oOo__

Батлав: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа,
Цагдан хорих төвийн 461 дүгээр ангийн дарга

.....

НАСАНД ХҮРЭЭГҮЙЧҮҮДИЙН БАЙРНЫ 7 ХОНОГИЙН ХУВААРЬ					
№	Үйл ажиллагаа, явц, ажил	Хэрэгжих газар	Цаг	Үргэжлэх хугацаа	Хариуцах этэн, албан тушаалтан
Даваа					
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	07:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	07.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	08:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	08:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Сагсан бөмбөг тоглох	Гадаа	09:10	2 цаг	Ээлжийн ахлагч
6.	Хичээлээ давтах	С.Танхимд	11:10	1 цаг 20	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
7.	Үдийн хоол	Танхимд	12:30	1 цаг 30	Ээлжийн ахлагч
8.	Хичээл / дундаа 4 удаа 10 минутаар завсарлана /17 цагт цай ууна/	Танхимд	14:00	4 цаг 40	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	18:40	1 цаг	Ээлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Ээлжийн ахлагч
11.	Телевиз үзэх	Танхимд	20:00	2 цаг	Ээлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Ээлжийн ахлагч
13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд
Мягмар					
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	07:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	07.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	08:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	08:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Биеийн тамирын дасгал	Гадаа	09:10	1 цаг	Ээлжийн ахлагч

хууль зүйн үндэсний хүрээлэн www.mn.gov.mn

6.	Усанд орох	Ариун цэврийн өрөөнд	10:10	1 цаг	Ээлжийн ахлагч
7.	Хичээлээ давтах	С.Танхимд	11:10	1 цаг 20	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
8.	Үдийн хоол	Танхимд	12:30	1 цаг 30	Ээлжийн ахлагч
9.	Хичээл / дундаа 4 удаа 10 минутаар завсарлана /17 цагт цай ууна/	Танхимд	14:00	4 цаг 40	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
10.	Оройн хоол	Танхимд	18:40	1 цаг	Ээлжийн ахлагч
11.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Ээлжийн ахлагч
12.	Телевиз үзэх	Танхимд	20:00	2 цаг	Ээлжийн ахлагч
13.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Ээлжийн ахлагч
14.	Өрөөндөө орох, цэвэрлэх, оройо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
15.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд
		Лхагва			
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	07:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	07.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	08:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	08:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Хөл бөмбөг тоглох	Гадаа	09:10	2 цаг	Ээлжийн ахлагч
6.	Хичээлээ давтах	С.Танхимд	11:10	1 цаг 20	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
7.	Үдийн хоол	Танхимд	12:30	1 цаг 30	Ээлжийн ахлагч
8.	Хичээл / дундаа 4 удаа 10 минутаар завсарлана /17 цагт цай ууна/	Танхимд	14:00	4 цаг 40	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	18:40	1 цаг	Ээлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Ээлжийн ахлагч
11.	Телевиз үзэх	Танхимд	20:00	2 цаг	Ээлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Ээлжийн ахлагч

ХҮҮЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nhrc.gov.mn



13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд
	Пүрэв				
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	07:00	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	07.20	30 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	08:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	08:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Хөгжөөнт тоглоом	Гадаа	09:10	2 цаг	Ээлжийн ахлагч
6.	Хичээлээ давтах	С.Танхимд	11:10	1 цаг 20	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
7.	Үдийн хоол	Танхимд	12:30	1 цаг 30	Ээлжийн ахлагч
8.	Хичээл / дундаа 4 удаа 10 минутаар завсарлана /17 цагт цай ууна/	Танхимд	14:00	4 цаг 40	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	18:40	1 цаг	Ээлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Ээлжийн ахлагч
11.	Телевиз үзэх	Танхимд	20:00	2 цаг	Ээлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Ээлжийн ахлагч
13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд
	Баасан				
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	07:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	07.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	08:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	08:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Гаднах орчны сургалт	Гадаа	09:10	2 цаг	Ээлжийн ахлагч
6.	Хичээлээ давтах	С.Танхимд	11:10	1 цаг 20	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
7.	Үдийн хоол	Танхимд	12:30	1 цаг 30	Ээлжийн ахлагч

хууль зүйн үндэсний хүрээлэн www.legalinstitute.gov.mn

8.	Хичээл / дундаа 4 удаа 10 минутаар завсарлана /17 цагт цай ууна/	Танхимд	14:00	4 цаг 40	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	18:40	1 цаг	Эзлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Эзлжийн ахлагч
11.	Телевиз үзэх	Танхимд	20:00	2 цаг	Эзлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Эзлжийн ахлагч
13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд
		Бямба			
1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	08:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	08.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	09:00	40 минут	Эзлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	09:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Гар урлалын зүйл хийх	Өрөөнд	10:10	2 цаг	Хүүхдүүд өөрсдөө
6.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	12.10	50 минут	
7.	Үдийн хоол	Танхимд	13:00	1 цаг 30	Эзлжийн ахлагч
8.	Чөлөөт цаг - Хүүхдүүд хоорондоо харицан ярилцах, ном унших, компьютер үзэх, ТВ үзэх	Танхимд	14:30	4 цаг 30	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	19:00	1 цаг	Эзлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Эзлжийн ахлагч
11.	Их угаалга - Усанд орох	Ариун цэврийн өрөөнд	20:00	2 цаг	Эзлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минт	Эзлжийн ахлагч
13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	9 цаг	Хүүхдүүд
		Ням			

ХҮҮЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН www.mn.edu.mn



1.	Ороо засах, өрөөгөө цэвэрлэх	Өрөөнд	08:00	20 минут	Хүүхдүүд өөрсдөө
2.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	08.20	40 минут	
3.	Өглөөний цай	Өрөөнд	09:00	40 минут	Ээлжийн ахлагч
4.	Амралт	Өрөөнд	09:40	30 минут	Хүүхдүүд өөрсдөө
5.	Гар урлалын зүйл хийх	Өрөөнд	10:10	2 цаг	Хүүхдүүд өөрсдөө
6.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	12.10	50 минут	
7.	Үдийн хоол	Танхимд	13:00	1 цаг 30	Ээлжийн ахлагч
8.	Чөлөөт цаг - Хүүхдүүд хоорондоо харицан ярилцах, ном унших, компьютер, ТВ үзэх, хөгжим сонсох	Танхимд	14:30	4 цаг 30	Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч
9.	Оройн хоол	Танхимд	19:00	1 цаг	Ээлжийн ахлагч
10.	Танхимын цэвэрлэгээ	Танхимд	19:40	20 минут	Ээлжийн ахлагч
11.	Гар урлалын зүйл хийх	Танхимд	20:00	2 цаг	Ээлжийн ахлагч
12.	Бие засах	Ариун цэврийн өрөөнд	22:00	30 минут	Ээлжийн ахлагч
13.	Өрөөндөө орох, цэвэрлэх, ороо засах	Өрөөнд	22:30	30 минут	Хүүхдүүд
14.	Унтлагын цаг	Өрөөнд	23:00	8 цаг	Хүүхдүүд

Жич:

a.Ээлжит эмчийн үзлэгийг сард 2 удаа хийнэ. Шаардлагатай бол эмчийн үзлэгийг тухайн үед нь хийнэ

b.Хүүхэд цагдан хорих өрөөнд түүнээс гадна байгаа бол бие засах боломжийг саадгүйгээр хангах бөгөөд боломжгүй бол хүүхэд хувиндаа бие засна. Бохир байгаа хувинг хүүхэд өөрөө цэвэрлэнэ. Захиргаанаас сар болгон хувинг нь ариутгаж өгнө.

c.Хүйтний улиралд өөр хуваариар хүүхдийн байрны үйл ажиллагаа явагдах бөгөөд гаднах орчны үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг богиносгоно.

d.Энэ хуваарьт дурьдсан болон дурьдаагүй бусад асуудлыг Насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих байрны дотоод журмаар зохицуулна.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn



IV БҮЛЭГ

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.legal.gov.mn

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

ОРШИЛ

Хятад Улс бол дэлхийн эртний түүх, соёлт улсуудын нэг. Өнөөдрийн өөрчлөн байгуулалтын энэ үедээ ч их түүх, соёлыг бүтээсээр байна.

Хүн амын тоогоороо дэлхийд тэргүүлж, 56 үндэстнийг багтаан оршдог их гүрний хувьд хүний хөгжил, хүний эрх, эрх чөлөө зэрэг хүн гэдэг үнэт зүйлтэй холбоотой бүхий л асуудлаар дэлхий нийтэд эн тэргүүний сонирхлыг татах нь дамжиггүй.

Хагас колонийн, хагас феодалын хуучин Хятад орны ард түмэн урт удаан хугацаанд хүнд суртал, хүнд хүчир аж амьдралын дор байх үед эрх чөлөө гэдэг үг оргүй хоосон байлаа.

Аливаа улс орон, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг жинхэнэ утгаар ханган хэрэгжүүлэх явдал нь хүний эрхийн хөгжилд зайлшгүй нөлөөлөх, орхигдуулж боломгүй нөхцөл байдал юм. Хуучин Хятад орон гадаад орны эрхшээл, ноёрхолд гүн автаж, улсын бүрэн эрхт байдал алдагдсанаар ард түмний эрх, эрх чөлөөнд нөлөөлж, хүний эрхийн хамгийн үндсэн хамгаалалт алдагдсан юм.

Хятад оронд XX зууны эхэн үеэс эрх зүйн шинэчлэл хийгдэж эхэлсэн. Ялангуяа 1911 оны хувьсгалын үзэл санаа, БНХАУ-ын анхны ерөнхийлөгч Сун Ят Сэний Хятадын эрх зүйн хөгжилд оруулсан хувь нэмэр их.

1949 онд шинэ Хятад Улс байгуулагдсаны дараа Хятадын ард түмэн өргөн хүрээтэй хөдөлгөөн өрнүүлж, хүүчин нийгмийн бүдүүлэг ёсыг халан, хүний эрхийг тунхаглаж хамгаалсан нийгэм улс төрийн үндсэн тогтолцоог бүрдүүлснээр улс нийгмийнхээ нүүр царайг өөрчилж, хүний эрхийн хөгжлийн шинэ үе эхэлсэн.

БНХАУ Үндсэн хуульдаа иргэдийнхээ эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсныг ард түмнийхээ он удаан жилийн хувьсгалт тэмцлийн ололт амжилтын үр дүн гэж бахархдаг. Шинэ Хятад Улс байгуулагдсанаас хойшх Үндсэн хуулийн хөгжлийн үр дүнд хүний эрхийн дэвшил тусгалаа олсон байна.

I ХЭСЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

БНХАУ Зүүн Азид 9 сая 600 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийг хамран оршдогоороо ОХУ, Канад Улсын дараа дэлхийд гуравдугаар байр, Ази тивд эхний байранд ордог том гүрэн юм.

Шанхай, /Циндао,Тяньжин/ Далянь, Фужоу зэрэг олон боомт, эдийн засгийн нээлттэй 11 хотоор дэлхийн зах зээлтэй холбогдоно. БНХАУ нь Тажик, Киргиз, Казакстан, ОХУ, Монгол, БНАСАУ, Вьетнам, Лаос, Мьянмар, Бутан, Балба, Энэтхэг, Афганистантай хуурай газраар, БНСУ, Япон, Зүүн өмнөд Азийн орнуудтай усан хилээр хиллэдэг нь хил орчмын чөлөөт бүс байгуулж хамтарсан үйлдвэр, аж ахуйн газрыг хөгжүүлэх, хилийн худалдаа хийх аятай нөхцлийг бүрдүүлдэг. Хятад нь Европыг зүүн өмнөд Азитай олон улсын төмөр зам, өмнөд, Зүүн өмнөд Азийг Зүүн Ази, Япон, АНУ-тай

холбосон усан замын түшиц газар байрласнаараа дэлхийн эдийн засгийн харилцаанд чухал байр эзэлнэ.

Нутаг дэвсгэрийн байгууламжаар автономит хуваариудтай нэгдмэл улс бөгөөд, засаг захиргааны хувьд өөртөө засах 5 орон */Шинжан-Уйгар, Өвөр Монгол, Нинся-Хуэй, Түвд, Гуанси-Жуан/*, төвийн захиргаатай 4 хот */Бээжин, Шанхай, Тянжин, Чунчин/*, 23 муж, 30 өөртөө засах тойрог, 124 тойрог, 1893 засаг захиргааны анхан шатны нэгжид хуваагдана.

Хүн ам зүй, холбогдох бодлого

Хятад Улсын хүний эрхийн асуудал, түүний бодлого зохицуулалтад нөлөөлөх хүчин зүйлүүдийн хамгийн гол гогцоо нь хүн ам зүйн асуудал юм.

Хятадын хүн ам зүйн асуудал хэд хэдэн онцлогтой.

1. Хүн амын тоо олон тул жилд төрөх хүний тоо их. Жилд дунджаар 12 саяар өсөж байна.

2. Хүн ам их залуужсан бөгөөд гэрлэлтийн дундаж нас 24-25 болсон.

0-14 насны хүн нийт хүн амын 34%, 15-64 насны хүн нийт хүн амын 62%, 65-аас дээш насны хүн 5%-ийг эзэлж байна.

3. Нийт хүн амын дундаж наслалт урт болж 3 сая 800 мянга гаруй хүн 100-гаас дээш настай, эмэгтэйчүүдийн дундаж нас 74, эрэгтэйчүүдийнх 72 болсон юм.

4. Нийт хүн амын 79.0% нь хөдөөгийн хүн ам бөгөөд энэ үзүүлэлтээр дэлхийн дунджаас 26%-иар давж байна.

5. Хятадын хүн амын соёлын төвшин харьцангуй доогуур байна. 12 жилийн сургалттай боловч хүн амын маш бага хувь нь бүрэн дунд боловсролтой юм.

6. Хүн амын нутагшилт нутаг дэвсгэрээр жигд бус хуваарилагдсан юм. Нийт нутгийн 57%-ийг эзлэх баруун, баруун хойд хэсэгт хүн амын 6%, нутгийн 43%-ийг эзлэх зүүн, зүүн хойд, зүүн өмнөд хэсэгт хүн амын 94% нь ногдож байна.

7. Хятадын хүн амын төрөлт буурч байгаа нь *Төлөвлөгөөт төрөлт*-ийн бодлоготой холбоотой бөгөөд жилийн дундаж өсөлт 2.2-1.7% болж буурсан. НҮБ-ын хүн ам зүйн фонд, хөгжлийн хөтөлбөрийн тусламжаар Хятадад хүн ам зүйн судалгааны 30 гаруй төвийг байгуулсан байна.

Хятадын хүн ам зүйн бодлого 3 үндсэн зорилтоос бүрддэг[194] байна.

1. Хүн амын тоог хязгаарлах *төлөвлөгөөт төрөлтийн* бодлого

2. Боловсролын төвшинг өндөржүүлэх, мэдлэг эзэмшүүлэх, эрүүлжүүлэх *чанарын* бодлого

3. Хүн амын аж амьдралын төвшинг дээшлүүлэх *Эдийн засгийн* бодлогыг дэвшүүлжээ.

Эдийн засгийн байдал

Сүүлийн арваад жил тэрбум гаруй хүн амтай Хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац жилд 10 хувиас давж байна. Саяхан болтол дэлхий

[194]Хятадын тойм, Бээжин, 2004

нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүний 23 орчим хувийг АНУ, 16 хувийг Япон эзэлж байсан бол энэ зууны эхний хагаст Хятад улс эдийн засгийн үнэмлэхүй хэмжээгээрээ дэлхийн хамгийн том гүрэн болох нь гарцаагүй байна.

Одоогоор Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт хамгийн өндөр хурдацтай байгаа. Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1.2 триллион ам.долларааp 2002 онд дэлхийд тав, гадаад худалдааны эргэлт 500 тэрбум доллар, валютын нөөц 286 тэрбум долларааp гуравдугаар байранд орсон. Өөрөөр хэлбэл БНХАУ дундаж чинээлэг хүмүүсийн нийгэм байгуулах, өөрөөр хэлбэл нийгмийн асуудлыг шийдвэрлэх тухай яригдаж байна.

2003 онд Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжлийн үр дүнд Хятадын ард түмний амьдралд, түүнчлэн хүний хөгжлийн эрхийн хүрээнд ахиц дэвшил гарчээ. 2003 онд, Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүн 116694 сая юанд хүрсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 91%-иар нэмэгдэж, тухайн үеийн ам.долларын ханшид шилжүүлэхэд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн анх удаагаа 1000 ам.долларт хүрсэн нь шинэ тавцанд гарч ирсэн амжилт юм.

Ард түмний амьдрал зохих төвшинд дээшилсэн байна. "БНХАУ-ын хүний эрхийн үйл ажиллагаа" цагаан номонд 2003 онд, нийт улсын хотод оршин суугчдын дундаж орлого 8472 юань, хэрэглээний зүйлийн үнийн өсөлтийг тооцвол, энэ нь өмнө оныхоос 9%-иар өсч, хөдөө тосгоны оршин суугчдын дундаж цэвэр орлого 2622 юан, энэ нь өмнөх оныхоос 4,3%-иар нэмэгджээ.

Нийгмийн ахуйн хэрэглээний бүтэц нь амьдралын үндсэн хэлбэрээс орчин үеийн амьдралын хэв маягт шилжиж өрчлөгджээ. 2003 онд нийгмийн хэрэглээний бүтээгдэхүүн борлуулалтын дүн 45842 сая юанд хүрсэн нь өмнөх оныхоос 91%-иар өссөн байна. Хот хөдөөгийн оршин суугчдын хоол хүнс, хувцас болон амьдралын бусад үндсэн хэрэглээний бүтээгдэхүүний зарлага тасралтгүй буурч, орчин үеийн амьдралын тансаг хэрэглээ болох автомашин, байр сууц, эрүүл мэндээ хамгаалах болон соёл амралт, зугаа цэнгээний шинжтэй зардлууд ихээхэн өсөн нэмэгдэж байна.

БНХАУ-ын эрх зүйн тогтолцоо

БНХАУ-ын эрх зүйн тогтолцоо өвөрмөц онцлогтой бөгөөд уламжлалт эрх зүйн үзэл санаа ба эрх зүйн тогтолцоо, эрх зүйн барууншил болон Марксизмын нийлэмж бүтээгдэхүүн боловч мөн тэдгээрийг нэг бүрчлэн бүрэн тусгаагүй юм. Өөрөөр хэлбэл "Хятадын эзэнт гүрний үеийн эрх зүйтэй адилгүй ба барууны эрх зүйн тогтолцооноос мөн ялгаатай"[195].

Эрх зүйн уламжлалт сэтгэлгээ

Күнзийн/Confucianism/ ба Хуулийн дэгийн /Legalism/ гэсэн хоёр үзэл санаа Хятадын уламжлалт эрх зүйн сэтгэлгээнд онцгой байр эзэлдэг. Күнзийн эрх зүйн сэтгэлгээ нь ёс суртахууныг эрхэмлэж, ёс суртахуун, шударга, хүнлэг ёс нь эрх зүйн хэм хэмжээнээс илүү гэдгийг сургасан бол Хуулийн дэгийн үзэл санаа үүнтэй эсрэгээр, хатуу шийтгэл бүхий хуулиар

[195]Хятадын эрх зүйн хөгжил, Жу Зэн Вэн нар, Бээжин, 2004

нийгмийг журамлана гэж үздэг. Хятадад бие хүн нийгмийн нэг хэсэг байж л хөгжиж чадна гэж үзэх агаад хувь хүн бүр нэг бүхэл цулын дотор өөрт ноогдсон дүрд тоглож, нийгмийн олон зүйл харьцаанд агуулагдаж буй харилцан нөхцөлдсөн үүргээс өөрийн хэсгийг биелүүлж л гэмээнэ нийгэм ба төр дэг журамтай, зөвшил зохицолтой байна гэж үздэг Күнзийн сургаал илүү ноёрхсон. Ийм үзлээр нийгмийг тайван, эмх журамтай байдлаар зохицуулахыг хичээдэг бөгөөд харин үүнтэй эвлэрч чадаагүй нэгэнд хууль хатуу үйлчилдэг гэж яривал оновчтой болно. Ийнхүү орчин үеийн Хятадын эрх зүйд эртний эрх зүйн сэтгэлгээ уламжлагдан үлдэж логик уялдаа, үнэт зүйл болж чадсан.

Хятадын эрх зүйн барууншлын эхлэл

Түүхэнд Чингийн үеийн сүүлчээс Европын эрх зүйг баримтлан Хятадын эрх зүйн тогтолцоонд өөрчлөлт хийх хөдөлгөөн өрнөж эхэлсэн гэж үздэг. Түүнээс хойш Хятадын эрх зүйн барууншил /Westernization of Chinese Law/ явагдаж 1911-1949 оны Дундад Иргэн Улсын үед ч. Бүгд Найрамдах Улс байгуулагдсанаас хойш ч агуулга, хэлбэрийн хувьд барууны эрх зүйн тогтолцоо, үзэл баримтлал, нэр томъёог судлан нэвтрүүлж ирсэн. Бүгд Найрамдах Улсыг тунхагласны дараа Европын жишээн дээр үндэслэн орчин цагийн төрөлжсөн хууль боловсруулж гаргах ажил өрнөжээ. Түүний үр дүнд Хятадын эрх зүй европжиж, Ромын эрх зүйд үндэслэсэн эрх зүйн бүлд хамрагдах болсон. Хятад орон анх Марксизмыг Октябрын хувьсгалын дараа Зөвлөлтөөр дамжуулж авсан.

Зөвлөлтийн эрх зүйн нөлөө

"БНХАУ байгуулагдсанаас хойшхи эрх зүйн салбарын онцлог үйл явдлын судалгаа" сэдэвт томоохон судалгааны тайландаа судлаач Ча Дин Жэн "Хятадууд Октябрын хувьсгалын нөлөөгөөр, Маркс, Энгельсээс шууд бус Зөвлөлтийн онол, практикаар дамжуулан Марксизмыг хүлээж авсан. Үндсэн хууль болон төрийн байгууллын тухайд Зөвлөлтийн загварыг авсан" гэж бичжээ.

Тухайн үед Мао Зэ Дун Хятадын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд хандан Зөвлөлтийн Үндсэн хуулийг хүн бүр нэг бүрчлэн уншиж судлахыг даалгасан байна. Иймдээ ч БНХАУ-ын 1954 оны анхны Үндсэн хууль Зөвлөлтийн 1936 оны үндсэн хуультай харьцуулахад бүтцийн хувьд болон үндсэн хуульд тусгасан төрийн эрх мэдлийн тогтолцоо бүгд адилхан байдаг. Энэхүү үйл явц 1950-иад онд бүхэлдээ өрнөсөн боловч богино хугацаанд загварлаж чадсан. Тухайлбал, хууль зүйн сургалт, судалгааны ажилд гоц нөлөөлсөн байна. Хууль зүйн сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, ашиглах сурах бичиг төдийгүй сургалт явуулах хичээлийн байр танхим хүртэл зөвлөлтийн жишгийг дагаж байсан. Зөвлөлтийн мэргэжилтэн Хятадын Ардын их сургуульд хууль зүйн сургагч багш бэлтгэх анги нээж ажиллуулж байжээ. Зөвхөн 1952-1956 оны хооронд гэхэд хууль зүйн 115 сурах бичгийг орос хэлнээс хятад хэл дээр орчуулж гаргажээ. Энэхүү харахад Хятадын хууль зүйн шинжлэх ухаан Зөвлөлтийн нөлөөгөөр нэлээд хөгжсөн нь батлагдана гэж дүгнэсэн байдаг.

"Хятадын онцлогтой социализм", "Хятадын онцлогтой социалист эрх зүй" гэсэн ойлголтууд

Зөвлөлтийн эрх зүйн нөлөөгөөр олж авсан социализмыг Хятадууд хэрхэн хөгжүүлсэн нь хамгийн чухал асуудал. 1979 оноос эхлэн улс төрийн бодлогоо өөрчилж, ангийн тэмцэл хурцдах үзэл санаа болон эдийн засгийг төрийн бүрэн хараат болгохоос татгалзаж чадсан юм. Энэ бол Хятадууд социализмын үзэл суртлаас гээсэн хэсэг төдийгүй Хятад оронд хөгжил нээсэн алхам гэж хэлж болно. 1978 оноос Дэн Сяо Пиний прагматик бодлого дэлгэрч, энэ нь "муур хар байх цагаан байх нь хамаагүй хулгана барьдаг байх ёстой" зарчмын үндсэн дээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж зах зээлийг сонгосон. Гэхдээ энэ бол хятад социализмаас ангижирсан хэрэг бус харин социализм дээр зах зээлийн тогтолцоог нэмж, үүнийгээ "Хятадын онцлогтой социализм" гэж томъёолдог.

Дэн Сяо Пиний "Хятадын онцлогтой социализм" байгуулах онолын чухал хэсэг нь "нэг улс, хоёр систем" юм. Дэн Сяо Пин хэлэхдээ "Манай социалист тогтолцоо бол Хятадын онцлогтой социалист тогтолцоо, энэхүү онцлогийн нэгэн чухал агуулга нь Гонконг, Макао, Тайваний асуудлыг шийдвэрлэх "нэг улс, хоёр систем" юм. Энэ бол шинэ зүйл. Үүнийг Америк гаргаж ирээгүй, Япон гаргаж ирээгүй, Европ ч мөн гаргаж ирээгүй, түүнчлэн Зөвлөлт Улс гаргаж ирээгүй, харин Хятад Улс гаргаж тавьснаараа энэ бол Хятадын онцлог" хэмээсэн байдаг.[196] Нэгэн социалист улсад социалист болон капиталист гэсэн хоёр өөр нийгмийн тогтолцоо оршиж, харилцан ашигтай, хамтран хөгжих болсон. "Нэг улс, хоёр систем" дэх эрх зүйн хөгжил, өөрчлөлтүүд мөн онцлог болно.

Хятад ДХБ-д элссэн явдлын хууль зүйн ач холбогдол

Арван зургаан жилийн турш уйгагүй хэлэлцээ явуулсны эцэст 2001 оны 12 дугаар сарын 11-нд Хятад Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсон. Энэ явдал бол хятадын эрх зүйн барууныхаас үйл явцын ололттой талыг тод томруун харуулсан юм. Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсноор тус улсын худалдааны бодлого либеральчлагдан, бусад улс гүрэнтэй харилцах таатай нөхцлийг бүрдүүлсэн хууль тогтоомжтой болох хөгжлийн үе эхэлсэн гэж үздэг. Олон талт худалдааны тогтолцоонд Хятадын элссэн баримт бичиг нь 900 орчим хуудас бөгөөд хамгийн чухал хэсэг нь Элсэх тухай протокол ба Хятад ДХБ-д элссэн тухай ажлын хэсгийн тайлан юм. Нарийн төвөгтэй шинж, тусгай амлалтын хүрээ, элсэх үед зөвшөөрсөн гажилтын тоо зэргээр ДХБ-ын түүхэнд урьд өмнө гарч байгаагүй элсэлт болсон. БНХАУ-ын эдийн засаг, худалдааны тогтолцоог ДХБ-ын гишүүн улс орнуудын тогтолцоотой нийцүүлэхийн тулд уг баримт бичигт шийдвэрлэх ёстой асар олон асуудлыг тусгах шаардлагатай болсон. Нөгөө талаар тус байгууллагад элсэхдээ өөрсдөдөө харилцан ашигтай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нягт нямбай ажилласан нь мэдээж.

[196] "Дэн Сяо Пиний түүвэр зохиол" 3 дугаар боть, 218 дахь тал

БНХАУ-ын Үндсэн хуулийн хөгжлийн онцлог

Хятад Улс 1954 онд анхны үндсэн хуулиа баталснаас хойш 1975, 1978, 1982 онуудад Үндсэн хууль батлан гаргасан бөгөөд өнөөгийн үндсэн хууль буюу 1982 оны үндсэн хуульд 1988, 1993, 1999, 2004 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан.

1954 оны анхны үндсэн хуулийг батлахаас өмнө хуулийн төслийг бүх ард түмнээр 3 сар хэлэлцүүлж, нийт 1 сая 380 мянган ширхэг санал хүлээж авсан бөгөөд саналын дагуу өөрчлөлт оруулсан учраас Хятадын эрх зүйн хөгжилд энэ хуулийн үзүүлсэн үр нөлөө сайн байх нь гарцаагүй гэж үздэг. Хятадад хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, хуулийг тодорхой хугацаанд туршилтын журмаар хэрэглэх үйл ажиллагаа нэлээд боловсронгуй байдаг. "Эд хөрөнгийн тухай хууль"-ийг 8 удаа хэлэлцсэн бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээгээр дамжуулан иргэдийн саналыг авч тусгасан. Үүнээс жишээлэн хэлэхэд Хятад социалист орон учраас бүх зүйл дээрээс заасан зааврааар байдаг учраас хүний эрх хэрэгждэггүй гэж үзэх ёсгүй болно.

1988, 1993, 1999, 2004 онд БНХАУ-ын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг судлахад дараах агуулгатай байна. Үүнд:

- Социалист ардчиллыг хөгжүүлж, социалист эрх зүйг бий болгох
- Коммунист намын удирдлага дор олон намын хамтын ажиллагаа ба улс төрийн зөвшилцөх тогтолцооны оршин тогтнол ба хөгжил
- Зах зээлийн эдийн засгийн чөлөөт хөгжил, түүн дэх хүний эрх
- Аж ахуй эрхлэлтийн ардчилсан, чөлөөт, шударга өрсөлдөөнт тогтолцоо
- Эрх зүйг дээдэлсэн, социалист эрх зүйт төрийг бүтээн байгуулахыг зорилго болгосон
- Нийтийн өмч ба хувийн өмчит эдийн засгийн хамтын хөгжил
- Хувийн аж ахуй, хувийн аж ахуй эрхлэлтийг дэмжих, хөгжүүлэхийн зэрэгцээ удирдан чиглүүлэх, хянах
- Газар, хувийн өмчийг төр иргэдээс авч ашиглах, эсвэл хураан авахдаа нөхөн төлбөр төлөх

Улс төр, эдийн засгийн шинэчлэлдээ тохируулсан нэмэлт өөрчлөлтүүд гол байр суурьтай байна. Жишээлбэл, 1999 онд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр Оршил хэсгийн *"Манай улс өнөөгийн байдлаар социализмын эхний шатанд байгаа болно."* гэсэн заалтыг *"Манай улс урт удаан хугацааны турш социализмын эхний шатанд байх болно." гэж өөрчлөн найруулсан байна.*

Түүнчлэн агуулга, мөн чанарын хувьд өөрчилсөн, нэмэлт оруулсан, хэлбэрийн хувьд агуулга ойролцоо боловч нэр томъёоны хувьд өөрчлөн найруулсан, иргэдэд эрх олгож, төрд үүрэг хариуцлага ноогдуулсан, эрх олгохын сацуу үүрэг болгосон заалтууд, урамшуулан дэмжсэн, ухуулан тунхагласан шинж бүхий заалтууд юм.

1999 онд Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд "***БНХАУ хуулийг дээдлэн улсаа засаглаж, социалист эрх зүйт төрийг бүтээн байгуулна***" гэсэн заалт эрх зүйн орчин үеийн хөгжилд дэвшил дагуулсан байна.

Онцлох заалтуудаас эш татахад, 2004 онд Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд 4 дэх хэсэг болгон "төрөөс эдийн засгийн хөгжлийн төвшинд тохирсон нийгэм хамгааллын тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлнэ", 33 дугаар зүйлд 3 дахь хэсэг болгож төрөөс хүний эрхийг дээдлэн баталгаажуулна" гэсэн заалтуудыг тус тус нэмж оруулсан байна. Агуулга, үйлийн цаг хугацааны хувьд өөрчлөлт оруулан ҮХ-ийн Оршил хэсгийн 7 дугаар догол мөр дэх "Хятадын онцлогтой социализм байгуулах замаар" гэснийг **"Хятадын онцлогтой социализмын замаар"** болгон өөрчилсөн нь нэг ёсондоо өмнөх заалтаар ирээдүйд болох үйлийг тодорхойлж байсан бол 2004 оны өөрчлөлтөөр аль хэдийн бүтээж бий болгосон утга санааг оруулан "**Хятадын онцлогтой социализмын замаар"** гэж өөрчилсөн.

Хятадын эрх зүйн хөгжлийн чиг хандлага

Хятадын эрх зүйн талаар судлахад нэгдүгээрт, "Хууль зүйт тогтолцоо"-ноос "Хууль дээдлэх ёс" руу шилжсэн байдал, хоёрдугаарт эх газрын эрх зүйн бүлд суурилсан боловч "холимог систем" рүү хурдацтай өөрчлөгдөж буй үйл явц гэсэн хөгжлийн хоёр чиг хандлага ажиглагдаж байгаа юм.

Хятад Улс эх газрын эрх зүйн бүлд багтдаг гэж албан ёсоор тэмдэглэгдсэн ч орчин үед холимог эрх зүйн системтэй гэж үзэх судлаачид нэлээд байна. Хятадын тухайд Япон, Германы эрх зүйгээс эх газрын эрх зүйн бүлийн үндсэн онцлогийг авсан боловч өөрчлөлт, шинэчлэл, нээлттэй бодлогын 30 гаруй жилд Англи Саксоны эрх зүйн бүлийн элементүүдийг санаатай болон санамсаргүй байдлаар хүлээж авсан. Ялангуяа худалдааны эрх зүйн хүрээнд, тухайлбал Хятадын "Гэрээний тухай хууль" нь эх газрын болон Англи Саксоны эрх зүйн бүлийн нийтлэг ойлголт, зарчмуудын нийлэмж юм. Хятадын компанийн эрх зүй, үнэт цаасны эрх зүй нь үндсэн тодорхойлолтоос авахуулаад гол удирдлага, хяналтын зарчим нь бүгд Англи, Америк болон Гонконгийн холбогдох эрх зүйн зохицуулалтыг авч хэрэгжүүлсэн байна. Жишээлэхэд шүүхэд хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй ч "Хэргийн удирдамж", "Түгээмэл хэргүүдийн эмхтгэл" зэргийг нийтлүүлэн гаргаж байгаа нь доод шатны шүүхүүдийн шүүн таслах ажиллагаанд хэрэглээ бий болгож өгч байгаа ба тэдгээр тайлбар Хятадын эрх зүйн тогтолцоонд чухал эх сурвалжийн нэг болж байгаа. Энэ нь Хятадад холимог эрх зүй бий болсны илрэл юм.

Хятадын эрх зүйн тогтолцооны үндсэн бүтцийн тухайд эрх зүйн 7 салбар бий. Үүнд: Үндсэн хуулийн ба түүнтэй холбоотой эрх зүй, иргэн, худалдааны эрх зүй, захиргааны эрх зүй, эдийн засгийн эрх зүй, нийгмийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, процессын ба процессын бус эрх зүй ордог.

Эрх зүйн салбарын ангиллын хувьд маргаантай, саналын төвшинд яригддаг зүйл байгаа. Тухайлбал, цэргийн эрх зүй, байгалийн баялгийн эрх зүйг тус тус бие даасан эрх зүйн салбар болгох хэрэгтэй гэсэн бол гэрлэлтийн болон өв залгамжлалын эрх зүйг иргэн, худалдааны эрх зүйгээс салган авч гэр бүлийн тусгай салбар эрх зүй болгох, үнэт цаас, санхүү, татвар, банкны эрх зүйг эдийн засгийн эрх зүйгээс салгаж санхүүгийн эрх зүй болгон бие даасан эрх зүйн салбарт ангилах шаардлагатай гэж үзсэн

хандлага байдаг.[197]

1979 онд Дэн Сяо Пин "Хууль ёсны" гэсэн шинэ нэр томъёог хэрэглэж, "ард түмний ардчиллыг баталгаажуулахын тулд хууль ёсыг чангатгах ёстой" гэж хэлжээ. Энэ үзэл санаа нь "хэн нэгэн удирдагчийн үг" солигдмогц солигдож байсан өмнөх үеийн тогтолцоог өөрчлөх шинэчлэл болж чадсан ба энэ нь одоогийн хууль дээдлэх ёсны чиг хандлага болж өгсөн гэж үздэг. Ийнхүү хятадын эрх зүй 1990 оны 2 дугаар хагасаас эхлэн нэр томъёо, агуулгын хувьд шинэчлэгдэх болж, 1996 онд Хятадын Засгийн газрын харьяа Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Эрх зүй судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд БНХАУ-ын Улс төрийн төв зөвлөлийн даргад хандаж өргөн барьсан илтгэлдээ "хуулийн дагуу төрөө засаглаж, социалист эрх зүйт төрийг бүтээн байгуулах" ухагдахууныг санал болгож, тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ли Бү Юн хятадад хамгийн нөлөө бүхий сэтгүүл болох "Хятадын эрх зүй судлал" сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ. Үүний дүнд 1999 оны БХАТИХ-аар "хууль дээдлэх ёс" гэсэн үзэл баримтлал "БНХАУ-ын Үндсэн хууль"-д нэмэлтээр орсноор "эрх зүйт төр", "хууль дээдлэх ёс" –ыг албан ёсоор хэрэгжүүлэх болсон.

БНХАУ-ын хүний эрхийн талаархи үйл ажиллагаа

БНХАУ нь социалист улс бөгөөд хүний эрхийн асуудалд баримтлах байр сууриа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хүний үндсэн эрхийг дээдэлж, үндэстний өөрөө удирдах байдлыг хязгаарлах болон үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах бодлогыг эсэргүүцэн тэмцэх;

2. Аль нэгэн улс орон хүний эрхийн асуудлыг ашиглан өөрийн орны эрх ашиг, үзэл бодол, соёл, ухамсрын байдал , улс төрийн үзэл баримтлал болон хөгжлийн хэв загварыг тулгах ба хүний эрхийн асуудлаар түрүү барьж бусад орны дотоод үйл хэрэгт оролцох явдалтай тэмцэх;

3. Олон улсын хүний эрхтэй холбогдол бүхий үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хүний эрхийн хүрээн дэх олон улсын хамтын ажиллагааг өргөтгөх.

Хятадын хүний эрхийн үйл ажиллагааны байгууллагууд[198]**:**

1. Хятадын хүний эрхийг хангах төрийн байгууллага:

- Бүх улсын Ардын төлөөлөгчдийн их хурал, түүний тогтолцоо
- Хятадын коммунист намаар толгойлуулсан олон намын хамтын ажиллагаа ба улс төрийн зөвшилцөх тогтолцоо, олон нийтийн улс төрийн байгууллага
- Ардын дээд шүүх
- Ардын прокурорын газар
- Олон нийтийн аюулгүйн байгууллага
- Хууль зүйн яам

[197] "Хятадын онцлогтой социалист эрх зүйн тогтоцоон дахь онолын зарим асуудал" , Хятадын Ардын их сургуулийн профессор Жу Зэн Вэн.,"Синхуа хэвлэлийн газар. Бээжин., 2001

[198] Хятад Улс хүний эрхийн талаар засгийн хяналтаас ангид, бие даан үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулахыг хориглодог ба олон улсын хүний эрхийн байгууллага Хятадад орохыг бас хүлээн зөвшөөрдөггүй гэж олон улсын зүгээс буруутгагддаг.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Боловсролын яам
- Соёлын яам
- Ардын хэргийн яам
- Улсын төлөвлөгөөт төрөлтийг хянах хороо
- Төрийн зөвлөлийн Хүүхэд, эмэгтэйчүүдийн ажлын хороо
- Үндэстний хэрэг эрхлэх хороо
- Улсын шашны үйл хэргийн хэлтэс

2. Засгийн газрын бус байгууллага:

- Бүх Хятадын Ажилчдын эвлэлийн хороо
- Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Зөвлөл
- Бүх Хятадын Залуучуудын Зөвлөл
- Бүх Хятадын Тахир дутуу иргэдийн Зөвлөл
- Бүх Хятадын Хуульчдын Зөвлөл
- Бүх Хятадын Хэвлэл, мэдээллийн ажилтны Нэгдсэн зөвлөл
- Бүх Хятадын Эх орондоо буцаж ирсэн цагаач иргэдийн хороо

Судалгаа шинжилгээний байгууллага:

- Хятадын хүний эрхийн судалгааны хороо
- Хятадын хүний эрхийн хөгжлийн сан
- Бээжингийн их сургуулийн Хүний эрхийн судалгааны төв
- Бүх Хятадын Ардын их сургуулийн Хүний эрхийн судалгааны төв
- Шандуны их сургуулийн Хүний эрхийн судалгааны төв
- Ухайны их сургуулийн Хүний эрхийн судалгааны төв
- Хятадын Улс төр, хуулийн их сургуулийн Хүний эрхийн судалгааны сектор

БНХАУ-ын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн конвенцууд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Эдийн засаг, нийгэм, соёлын тухай олон улсын пакт
- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц
- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1967 оны зөвлөмж
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
- Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж , шийтгэхийн эсрэг конвенц
- Тэгш шан хөлс олгох тухай конвенц зэрэг болно.

Хятад Улс олон улсын хүний эрхийн эдгээр гэрээнд нэгдэн орсон боловч тэдгээрийн хэрэгжилтэд зөрчил оршсоор байгаа билээ.

II ХЭСЭГ. ХҮНИЙ ЭРХИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ БА ДҮГНЭЛТ

Хятад Улс дахь хүний эрхийн өнөөгийн нөхцөл байдалд дэвшилттэй тал болон зөрчилтэй байдлын аль аль нь оршиж байна. Тэдгээрийг судалж, жишээ баримтаар дурдахын зэрэгцээ дүгнэлт өгөхийг зорилоо.

2004 оны сүүлээр, Хятадын Төрийн зөвлөлөөс коммунист намын эрх барих эрх мэдлийг хүчирхэгжүүлэх зорилгоор, нам дотроо улс төрийн өөрчлөлт хийхийг уриалсан. Хятадын коммунист намын дарга Хятадад нэг намын удирдлага хэвээр байх бөгөөд энэ нь тасралтгүй хүчирхэгжих хуульт ёсны үндсэнд суурилан бүтээгдэх юм гэж тодорхой заажээ. Хэдийгээр хэдэн жилийн туршид Хятадын аль ч салбарт хөгжил дэвшил гарч байгаа, тухайлбал хууль сахиулах тогтолцоог чангатгаж, бие даасан мэдээ, мэдээллийг зөвшөөрсөн зэрэг ямар нэгэн бодлого, төлөвлөгөөг боловсруулахдаа ард түмний хүсэл зоригийг ойртуулахыг зорьж байгаа боловч Хятад улс урьдын адил ард түмнээ барьдаг улс хэвээр байна гэж олон улсын ажиглагчид үздэг.

Хэдийгээр 2004 онд Хятадын төр засгаас хуульт ёсыг баримталж улс орноо удирдахыг амласан боловч төрийн албан тушаалтны хээл хахууль, авлига газар авсан байдал, коммунист намаас хуулийн байгууллагуудад үзүүлж буй нөлөө, төрийн албан тушаалтан болон тэдний гэр бүлийнхэн хуулийн хүрээнээс гадуур оршиж байгаа зэрэг үзэгдэл нь тэрхүү амлалтыг эвдэхэд хүргэж байгаа гэжээ.

2004 оны 10 дугаар сарын сүүл, 11 дүгээр сарын эхээр Хөнан, Сычуан мужуудад хэдэн түмэн хүн оролцсон томоохон үймээн дэгдсэн юм. Хэдийгээр үймээн гарсан эдгээр газрууд хоорондоо маш хол зайтай, үймээн гарсан шалтгаан бас өөр ч гэсэн эдгээр үймээн ба засгийн газраас үймээнд хандах хандлага нь тасралтгүй үргэлжилж буй хөдөө тосгоны тогтворгүй байдал ба хятадын эрх мэдэлтнүүийн нийгмийн тогтвортой байдлыг хангах гэсэн анхаарлыг илчлэн харуулж байна. Хятадын эрх мэдэлтнүүд сэтгэл хангалуун бус байдлын тархалтыг зогсоохыг үргэлжлүүлэн, нийгмийн асуудлуудтай холбоотой мэдээ, мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэхийг хичээдэг байна.

Дэвшилттэй талууд

Хууль эрх зүйн орчинг тулхүү анхаарч байгаа байдал

Улс орондоо ардчилсан төрийг хөгжүүлэхийг ихэд анхаарч, улс төрийн соёлыг төлөвшүүлж, улс төрд иргэний эмх дэглэмтэй оролцоог нэмэгдүүлэн, иргэний болон улс төрийн эрхийг хуулийн дагуу хангаж, хамгаалах зорилтыг хэрэгжүүлж байна. Хятадын Үндсэн хуульд "БНХАУ-ын төрийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэж заажээ. Ард түмний төрийн эрх барих эрх бүхий байгууллага нь Бүх улсын Ардын төлөөлөгчдийн их хурал ба орон нутгийн бүх шатны Ардын төлөөлөгчдийн их хурал юм. Бүх улсын Ардын төлөөлөгчдийн их хурал нь төрийн эрх бүхий дээд байгууллага бөгөөд улсын нийт бодлого, төлөвлөгөөг боловсруулж, хууль тогтоох эрхийг хэрэгжүүлдэг. 1979 оноос одоог хүртэл Бүх улсын Ардын төлөөлөгчдийн их хурал, түүний Байнгын хороо нийт 451 салбар хууль, хуулийн тайлбар болон бусад хууль, эрх зүйн

...уудлыг тогтоон шийдвэрлэж, Төрийн зөвлөлөөс нийт 966 захиргааны ...тыг боловсруулжээ. Орон нутгийн Ардын төлөөлөгчдийн их хурал, түүний ...айнгын хороо 8000 гаруй орон нутгийн шинжтэй актыг гаргаж, Үндэстний ...утгийн өөрөө удирдах байгууллагаас 480 гаруй нутгийн өөрийн удирдлагын ...урам, нэг талт журмыг тогтоон баталжээ. Ингэснээрээ Үндсэн хууль ...өвтэй харьцангуй бүрэн эрх зүйн тогтолцоог эхний ээлжинд бий болгож, нийгмийн амьдралын бүхий л салбарт эрх зүйн орчин үндсэндээ тавигдсан гэж үздэг. Тухайлбал, 1996 онд батлагдсан шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар:

- Ардын шүүх хорооноос шүүн таслаагүй бол хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй зарчмыг шинээр тогтоов.

- Өмгөөлөгч эрүүгийн хэрэгт оролцох цагийг өөрчилж, сэжигтэн, холбогдогчдын хууль ёсны эрх ашгийг баталгаажуулав. 1979 оны Эрүүгийн байцаан шийтгэх төрөлжсөн хуульд байсан "Шүүх тэнхим нээж шүүхээс 7 хоногийн өмнө өмгөөлөгч авч болно гэдгийг хэлж өгөх ёстой" гэж байсныг өөрчлөөд "мөрдөн байцаах байгууллагаас сэжигтнийг анх удаа байцаасан өдөр буюу таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан өдрөөс эхлэн өмгөөлөгчийг авч хууль зүйн дэмжлэг авч болно. Мөрдөн байцаах байгууллага мөрдөн байцаалтаа дуусгаад байцаах хороонд хянан шалгуулахаар хэргийг шилжүүлсэн өдрөөс эхлэн өмгөөлөгч хэрэгт оролцож өмгөөлөл хийж болно" болгожээ.

- Прокурор болон өмгөөлөгчийн шүүх тэнхим дээр мэтгэлцэх дүрмийг нарийвчлан тогтоов.

Үндэстний тэгш эрхийг хангахад гарч буй дэвшил

Бага үндэстнүүд оршин суудаг бүс нутгуудын эдийн засаг хурдацтай хөгжиж байна. 2003 онд улсын хэмжээнд үндэстний орон нутгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 11000 сая юанд хүрсэн нь өмнө оныхоос 11.1%-иар өсч, улсын дундаж өмнөх үзүүлэлтээс өндөр гарсан байна. Түүний дотор Төвд, Нинся 11.5%-иар өсгөсөн бол Өвөр Монголын нийт бүтээгдэхүүний өсөлт 16.3%-иар ахисан нь улсын хэмжээнд тэргүүлсэн үзүүлэлт гарчээ.

2004 оноос эхлэн улсын сангаас ядуурлыг бууруулах хөрөнгө оруулалт 60 сая юанд хүрсэн нь хязгаар нутгийн ард түмний аж амьдралыг дээшлүүлж, тухайн бүл нутгийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа юм. Бүс нутгуудын ядуу амьдралтай хүүхдүүдийг сургахад ихээхэн мөнгө санхүү зарцуулж байгаа гэдэг. Тэднийг их дээд сургуульд элсэх шалгалтын суурь оноон дээр тодорхой оноо нэмж өгдөг дэмжлэг нь бага үндэстний хүүхдүүдийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч буйн илрэл билээ.

БНХАУ-ын Үндэстний нутгийн өөрийн удирдлага бол төрийн нэгдмэл удирдлаган дор, БНХАУ-ын Үндсэн хуулинд заасны дагуу, үндэстний цөөнх төвлөрч суудаг орон нутагт орон нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлж, тухайн нутагт үндэстний өөрөө удирдах байгууллагыг байгуулан, өөрөө удирдах эрхийг хэрэгжүүлж, тухайн үндэстэн доторх орон нутгийн шинжтэй үйл ажиллагааг эрхлэн явуулна.

БНХАУ-ын Үндсэн хуулийн Ерөнхий үндэслэл хэсэг болон Төрийн бүтэц гэсэн бүлэгт тодорхойлсон заалтуудаас харахад Үндэстний нутгийн өөрийн удирдлагын гол агуулга, мөн чанар нь дараах байдлаар илэрч байна. Үүнд :



1."Үндэстний өөртөө засах орон бол БНХАУ-ын салшгүй хэсэг мөн." Үндэстний нутгийн өөрөө удирдах байгууллага нь төвийн төвлөрсөн удирдлагын дор ажилладаг нэг шатны орон нутгийн төрийн байгууллага бөгөөд дээд шатныхаа төрийн байгууллагын удирдлаган дор ажилллана.

2.Үндэстний нутгийн өөрөө удирдах байгууллага нь Ардын төлөөлөгчдийн Их хурал болон бүх шатны Ардын Засгийн газар юм. Тэдгээр нь улсын хууль болон төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ тухайн нутгийн бодит байдлыг харгалзан үзэх эрхтэй. Үндэстний өөртөө засах орны Ардын төлөөлөгчдийн Их хурал нь тухайн нутгийн үндэстний улс төр, эдийн засаг, соёлын онцлогт тохирсон өөрийн удирдлагын тухай журам болон тусгайлан үйлчлэх дүрэм журам батлах эрхтэй./Дээд шатны эрх бүхий байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна./

3.Үндэстний нутгийн өөрөө удирдах байгууллага нь Үндсэн хууль, Үндэстний өөрийн удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу өөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ.Өөртөө засах орон, өөртөө засах тойрог болон өөртөө засах хошууны Ардын төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны дарга болон орлогч даргаар өөрийн удирдлагыг хэрэгжүүлж буй үндэстний иргэн томилогдож ажиллана. Өөртөө засах орны дарга, өөртөө засах тойрог болон өөртөө засах хошууны даргаар өөрийн удирдлагыг хэрэгжүүлж буй үндэстний иргэн томилогдож ажиллана.

4. Бүх үндэстэн тэгш эрхтэй. Бүх үндэстний нэгдмэл байдал, тэдгээрийн харилцан туслалцах, харилцан суралцах, хамтран ажиллах талын харилцааг хангаж ажиллана. Ямар ч үндэстнийг ялгаварлан гадуурхах, дарлан мөлжихийг хориглож, их үндэстний үзэл, ялангуяа их хан үндэстний үзэл гаргах, түүнчлэн нутгийн үндэстний үзэл гаргахыг бас хориглоно. Үндэстний нутгийн өөрөө удирдах байгууллагад үндэстэн бүр зохих тооны төлөөлөл байна.

5.Үндэстэн бүр өөрийн хэл бичгийг хэрэглэх эрхтэй бөгөөд бас өөрийн уламжлалт ёсыг хадгалах эсвэл өөрчлөлт оруулах эрхтэй.

Үндэстний нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн орон нутгийн санхүү, эдийн засгийг удирдан явуулж, бүх талын бүтээн байгуулалтын хөгжлийг төлөвлөн удирдах зэргээр тухайн нутгийн соёлын бүтээн байгуулалтыг хөгжүүлнэ. Үүнд төрөөс их хэмжээний тусламж, дэмжлэг үзүүлнэ гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого зохицуулалт

Хятад Улсад 60 сая орчим тахир дутуу хүн байгаа нь нийт хүн амын 5%-ийг эзэлдэг. Одоогоор хэлгүй, дүлий, хараагүй, оюуны хомсдолтой хүүхдүүдэд зориулсан 1655 сургууль байна. Энгийн сургуулиудын дэргэд байгуулсан тусгай сургалттай анги 3154 байна. Соёлын төв, номын сан, спортын талбай зэрэг олон нийтийн соёл, хүмүүжлийн газруудыг олноор байгуулж, одоогоор тэдгээрийн тоо 1618-д хүрсэн гэсэн мэдээлэл байдаг.

2003 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Улсын 6 дугаар спартикиадыг зохион явуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй тамирчид олон улсын тэмцээнүүдээс 177 алтан медалийг авсан үзүүлэлт нь тэдэнд үзүүлдэг нийгэм, соёлын анхаарал халамжийг илтгэж байгаа юм.

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулахыг гойд анхаарч байна.

Хятадад эмэгтэйчүүдийн боловсролын төвшин дээшилж байна. Тэдний эрүүл мэндийг онцгой анхаарч, эрх ашиг нь хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомж, холбогдох арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлж байна. Хүүхдийн боловсрол, хүмүүжилд түлхүү анхаарч, сурч боловсроход хүндрэлтэй хүүхдүүдийн *"Инженер болох хуслэн"* халамжийн сангийн үйл ажиллагаа маш үр дүнд хүрч олон нийтийн талархлыг хүртдэг юм. Гэсэн ч эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн мэдээллүүд байгааг бас дурдах хэрэгтэй.

Хүний эрхийн үйл ажиллагаа дахь хэвлэл мэдээллийн оролцоо

Эрүү шүүлтийг хэвлэл мэдээллээр илчлэх нь түүнтэй тэмцэх үр дүнтэй үйл ажиллагааны нэг гэж хэлж болно. Жишээлбэл, Хятадад хорих болон саатуулахтай холбоотойгоор албаны хүмүүсийн хүчирхийллийг илчлэхэд сүүлийн жилд хэвлэл мэдээллийнхний үүрэг нэмэгдэж байна. Хэдийгээр улс төрийн ноцтой хэргүүдийн талаар мэдээлэгдэхгүй байгаа боловч бусад хэргүүдийн хувьд зарим сонин эрүү шүүлт эсхүл зүй бус харьцааны хэргийн талаар албан ёсны мөрдөн байцаалт явуулахыг нь хүлээлгүй мэдээлдэг байна. Олон жилийн байдлаас харахад, хохирогчид болон тэдний гэр бүлийнхэн албаны хүмүүсийн хүнд суртал, хайхрамжгүй байдлын эсрэг шударга ёсыг эрэлхийлэн тэмцсэн хэргүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэнийхээ дараа шийдвэрлэгдэж байсан байна.

Олон улсын үйл ажиллагааны оролцоо

Хятад Улс хүний эрхийг эрхэмлэж, тэгш байдал, харилцан хүндэтгэх байдлыг хангаж олон оронтой хүний эрхийн хүрээнд хэлэлцээр хийж, хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. 2003 онд гэхэд Хятад Улсын Засгийн газар Европын холбоо болон Австрали, Канад, Англи, Герман, Голланд, Норвеги зэрэг орнуудтай хүний эрхийн асуудлаар хэлэлцээр хийж, харилцан зөвшилцсөн. Түүнчлэн Хятад – Канад – Норвегийн 5 дахь удаагийн хүний эрхийн сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, Европын холбоотой хамтарч Хятад ба Европын орнуудын эрх зүйн эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион явуулсан байна. Эдгээр болон бусад улс, холбогдох байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагаагараа дамжуулан хүний эрхийн асуудлаарх ойлголт, мэдлэг туршлагаа харилцан солилцдог.

Хүний эрхийг зөрчиж байгаа талаарх мэдээлэл[199] ба дүгнэлт

"6-4"түүхэн үйл явдал ба түүнд хандах хандлага

2004 оны 6 дугаар сарын 4-ний өдөр бол "6-4" үйл явдлын 15 жилийн ойн өдөр. Хятадын эрх мэдэлтнүүд тэр жил цэргийн анги нэгтгэлдээ тушааснаар Тиэнанминий талбайд нэвтрэн орж, эсэргүүцэл үзүүлсэн энгийн ард иргэд рүү гал нээсэн билээ. 15 жилийн дараа Хятадын Засгийн

[199]Хятадад хүний эрхийг хангах, хамгаалах асуудлыг ихэд анхаарч дэвшилттэй талыг илтгэсэн судалгааны тайлан, илтгэл олон байгаа боловч зөрчилтэй талуудыг сайтад тавигдсан гадаад улс, олон улсын байгууллагын зүгээс гаргасан тайлан, илтгэлээс ишлэж оруулсан болно.

газар уг хэргийн талаар ямар нэгэн олон нийтэд нээлттэй дурсгалын үйл ажиллагааг хориглосоор байна. Хохирогчидтой тэмцэхийг эсэргүүцэж, тэдний хохирлыг барагдуулахын зэрэгцээ үйл явдлын талаарх үнэлэлт, дүгнэлтээ албан ёсоор өөрчлөх тухай гаргасан шаардлагыг няцааж, тэр ч байтугай баривчлан хорьдог байна.

Хятадын хууль сахиулах тогтолцоо

2004 оны 3 дугаар сард Хятад улс Үндсэн хуулинд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хүний эрхийг хамгаалах талаар амласан билээ. Хэдийгээр энэхүү Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь шууд хэрэгжих боломжгүй боловч Хятад улс хүний эрхийг хүлээн зөвшөөрдөг гэдгийг нотлон харуулж байна. Хуульт ёсыг бататгахыг хичээж байгаа боловч хуулийг хэрэгжүүлэх тогтолцоо нь хүний эрхийг зөрчих гол үндэс суурь болсоор байгаа гэж ажиглагчид үздэг. Хуулийн арга ажиллагаа тодорхой бус, шүүх, цагдаагийн ажилтнууд улс төрийн зорилгыг баримталж ажилладаг; шүүхийн системийн бие даасан шинж алдагдсанаас эрх баригч намын албан тушаалтнууд садан төрөл, танилынхаа эрх ашигт нийцүүлэн бүх шатны шүүхийн байгууллагын ажиллагаанд оролцдог; хэдийгээр олон шүүгч нэхэмжлэлийг хүлээн авдаг ч хэзээ хахуульд автсан байдал газар авсан; эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд аман өчгөөр нотолгоо хийх явдал урьдын адил оршиж байгаа бөгөөд мөрдөн байцаагчид нь зодох зэрэг хэрцгий эрүү шүүлт хэрэглэн ам өчгийг авдаг; хууль эрх зүйн мэргэжилтэн, хууль зүйн туслах ажилтнууд нийт хүн амын 4/1-ийн хэрэгцээг хангахуйц; хэрвээ өмгөөлөгч хүн үйлчлүүлэгчийнхээ эрхийг хэтэрхий сайн хамгаалах аваас өмгөөллийн эрхээ хасуулах эсвэл шоронд хоригдох аюул нүүрлэдэг зэрэг хүний эрхийн зөрчлүүд байсаар байгаа гэж шүүмжлэгдэж байна. Саяхнаас Хятадад шүүгч нар сонгон шалгаруулалтанд ордог болоод байгаа нь эрх зүйн тогтолцоог өөрчлөх замаар гэмт хэрэгт холбогдогчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авч байгаагийн илрэл юм.

Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөн дээх хязгаарлагдмал байдал

Хятадын интернет сүлжээ ба дотоодын мэдээллийн хэрэгслүүдийн хурдацтай хөгжил нь түүнийг хянан зохицуулж байх хуулийг 2004 онд батлан гаргахад хүргэсэн байна. Төрийн эрх мэдэлтнүүдээс мэдээллийн агуулгыг хянах хяналтын хүрээг өргөтгөж, хяналтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна. 2004 оны 10 дугаар сард Хятадын Засгийн газраас хөдөө тосгоны газрын талаарх бүх мэдээллийг түгээх явдлыг хориглосон.

9 дүгээр сард *"Нью-Йоркийн цаг үеийн мэдээ"*-ний эрдэм шинжилгээний туслах ажилтан Жао Ен гадаадад улсын нууцыг задруулсан хэргээр баривчлагдсан ба эрх мэдэлтнүүд түүнийг гадаадад коммунист намын удирдлагын давхаргад өөрчлөлт орсон талаар мэдээлсэн гэж үзэж байгаа юм. 2004 оны эхээр, "Хятадын тариачдын судалгаа" нэртэй, бодит байдлыг өгүүлсэн ном борлуулалт сайтай байсан ч цаашид худалдахыг хориглосон байна. Энэхүү номонд Ан Хуй тосгоны даргын хэзээ хахуулийн хэрэг болон цагдаа нарын хэрцгий байдлаар хүч хэрэглэдэг тухай зэрэг олон хэрэг явдлын талаар бичсэн байжээ.

ДОХ-ын халдвар авсан иргэдийн талаар

Хятад Улс дэлхий дээрх хамгийн олон ДОХ-ын халдвар авагсадтай улс болох аюул нүүрлээд байна. Эрх мэдэлтнүүдийн мэдээлснээр, Хятадад 840 мянган хүн ДОХ-ын халдвар авсан байна гэсэн боловч үнэн хэрэгтээ үүнээс илүү тоон үзүүлэлт гарч магадгүй гэнэ. Олон хятад иргэд ДОХ-ын талаарх мэдээлэл хомс ба ДОХ-ын халдвар авсан хүмүүс эрх мэдэлтнүүдийн арга явуулга, олноороо баривчлагдаж хоригдох явдалтай тулгардаг. Хятадын удирдлагаас ДОХ-ын талаар дорвитой арга хэмжээ авсаар байна. 2003 оны сүүлээр, улсын төв удирдлагаас ДОХ-ын халдвар авсан бүх ядуусыг эмчлэх болно гэж амласан билээ. Хятадын Төрийн зөвлөлийн 2004 оны 5 дугаар сард гаргасан мэдэгдлээр орон нутгийн бүх шатны дарга нарыг ДОХ-оос урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэхийг шаардсан юм. 2004 оны 8 дугаар сард Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, халдварт өвчтнийг алагчлах явдлыг хориглосон. Гэвч хүний эрхийн ажиглалтын 2003 оны 9 дүгээр сард нийтэлсэн "*Тулгээтэй хаалга*" тайлангаас харахад хүний үндсэн эрх, эрх чөлөөний хязгаарлагдмал байдал болон орон нутгийн засаг захиргааны хүний эрхийг зөрчсөн үйлдлүүд нь Хятадын ДОХ-ын халдвар авсан иргэдэд туслах зорилготой үйл ажиллагаанд саад болж байна гэж үзсэн байна.

Хөдөлмөр эрхлэгчдийн эрхийн талаар

Хятадад жирийн ажилчин хүмүүс улс орныхоо эдийн засгийн асар хурдацтай хөгжлөөс төдий хэмжээний ашиг хүртэж чадахгүй байна гэж дүгнэсэн байдаг. Ажил хийх зорилгоор хотод орж ирсэн хэдэн зуун мянган тариачдын асуудал маш хүнд байна.

Захиргаанаас оршин суух зөвшөөрөлгүй учраас тэдгээр хүмүүс хотын үндсэн үйлчилгээнд хамрагдах аргагүйн дээр цагдаагийн байгууллагад баригдаж хохирдог тал байдаг.

Засгийн газраас ажилчдын бие даасан зөвлөл байгуулахыг хориглодог учраас ажилчин хүний эрх ашиг хохирох явдал ихэсч, тэдний эрх хязгаарлагдмал байдалд ордог байж болно гэж ажиглагч бичжээ. Хятадын төрийн хяналтын дор ажилладаг "БНХАУ-ын Ажилчдын төв зөвлөл"-ийн үйл ажиллагааг л зөвхөн хүлээн зөвшөөрдөг. Жө Зяны Сан Зяо Жоу нуттийн олон нийтийн байгууллага ажилчдын хууль ёсны эрхийн ойлголт сэдвээр сургалт явуулж, тэдэнд эзэдтэйгээ хэрхэн зарга үүсгэх талаар тусалдаг байснаас болж бас л үйл ажиллагааг нь хориглож, ажилчдын бие даасан зөвлөл байгуулах аргагүй болжээ.

Хувийн нууц, гэр бул, орон байр, захидал харилцаанд хөндлөнгөөс оролцох

Хэдийгээр Үндсэн хуульд хувь хүн, түүний орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууцыг хадгална гэж заасан хэдий ч амьдрал дээр Хятадын Засгийн газраас дээрх заалтуудыг хэрэгжүүлэхэд зөрчил байсаар байна.

Хүний эрхийн ажиглагчдаас 2004 оны 3 сард нийтэлсэн "Их нүүлгэлт" нэртэй судалгааны тайлан нь Хятадын орон нутгийн захиргаа болон Өөрчлөн байгуулалтын хорооноос хэдэн сая оршин суугчдыг шинэ барилга байгууламж барих зорилгоор оршин суугаа байрнаас нь хүчээр нүүлгэж байгаа тухай өгүүлжээ.

Хууль эрх зүйн ямар ч арга зам байхгүй учир хөөгдсөн хүмүүс гудамжинд гарч бослого хөдөлгөөн өрнүүлдэг боловч цагдаа нарын хэрцгий авираар дарагдаж, саатуулан хоригддог байна. Хүний эрхийн нэрт хамгаалагч Е Гуо Жу захиргааны удирлагад "хөдөлгөөн гаргах жагсаалыг нэг удаа зөвшөөрөөч" гэсэн өргөдөл гаргасны улмаас баривчлагджээ. Хөөгдөн нүүсэн олон ерх айлуудыг өмгөөлсөн хуульч Дэн Ен Эн Шанхайн нэгэн шүүхээр 3 жил хоригдох ял сонссон. Түүний ялын төрөл нь "Улсын хуулийг задруулсан" хэрэг гэгдсэн бөгөөд тэрээр өмнө нь Олон улсын хүний эрхийн нэгэн байгууллагад өөрийн хөдөлгөөний байдлын талаар факс явуулжээ.

Хууль судлаач, мэргэжилтэн болон зарим удирдах ажилтнууд, Засгийн газраас иргэдийн оршин суух эрхийг хамгаалж чадахгүй байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэйгээр шүүмжилж байна. Иймээс Засгийн газраас Үндсэн хуулийн зарим заалт ба зарим нэгэн бодлого төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан юм. Гэвч энэхүү хуульчилсан заалтууд хэрэгжихэд хэзээ хахуулийн газар авсан байдал ба хууль хэрэгжүүлэх тогтолцооны сул дорой байдлууд саад учруулж байна гэж гадны ажиглагч үзжээ.

Хонконг

2004 оны 4-р сард Хятадын Засгийн газраас Хонконгод хамгийн наад зах нь 2012, 2013 оноос өмнө бүх нийтийн сонгууль явуулахгүй гэж дангаараа шийдвэр гаргасан билээ. Гэвч Хонконгийн хуулиудыг дахин хянаж үзсэний дараа Бээжин сонгуулийн тогтолцоог өөрчлөх талаар дэвшүүлсэн ямар ч саналыг шийдвэрлэх эрхтэй хэвээр үлдсэн юм.

Гонконгийн Хууль тогтоох хурал өмнө нь улс төрийн өөрчлөлт хийх эрхтэй байсан ба одоогоор Сонгуулийн онцгой хорооны олон тооны гишүүд Бээжингээс дэвшин сонгогдсон байна. Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын Байнгын хороо Хонконгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хариуцаж байгаа бөгөөд Хонконгоос сонгогдсон төлөөлөгчид ард түмний санал асуулга явуулахыг олон удаа шаардсан боловч хүлээн аваагүй юм.

1997 онд гэрээний дагуу Хонконг нь Өөрөө удирдах онцгой бүс гэсэн байр суурьтайгаар Хятадад эргэн орсон ба Хятадын Засгийн газраас тухайн үед Хонконгод "Дэзд зэргийн өөрийн удирдлага" хэрэгжих болно гэж хүлээн зөвшөөрч байсан. Гэсэн хэдий ч Бээжингээс ойрын үед Хонконгийг хянаж, захирах эрх мэдлээ чангатгасаар байсан тул хүний үндсэн эрх, эрх чөлөөг доройтуулах байдал газар авч байна гэж Хонконгчууд үзсэн учир 2003 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, 2004 оны 1 дүгээр сар, 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Хонконгод том хэмжээний жагсаал цуглаан болсон юм. Энэ нь *"Нэг улс хоёр нийгмийн байгуулал"*-ын зарчмын үндсэн агуулга алдагдсаны илрэл гэжээ.

Шинжаан ба "терроризмыг эсэргүүцсэн дайн"

АНУ-аар толгойлуулсан "Терроризмыг эсэргүүцэх дайн"-ыг дэмжих нэрийдлээр Шинжаан-Уйгарт үзүүлж байгаа дарангуйллаа БНХАУ олон улсын байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэх болон дэмжихэд хүргэж байна гэж ажиглагчид үзэж байна. Зарим Уйгар үндэстний бүлэглэлүүд энх тайвны замаар жинхэнэ автономит эрх эсвэл тусгаар тогнолоо олохоор тэмцэж байхад харин нөгөө хэсэг бүлэглэлүүд хүч хэрэглэж байгаа билээ. Энхийн замаар эсэргүүцэх ба хүч хэрэглэсэн эсэргүүцэл, салан тусгаарлах үзэл ба олон улсын терроризмыг Хятадын эрх мэдэлтнүүд ямар ч ялгаатайгаар авч үзэхгүй байна.

Шинжааны бүс нутагт үзүүлж байгаа дарангуйлал нь *шалтгаангүй баривчилгаа, нууцаар хаалттай шүүн таслах болон цаазаар авах ялыг ихээр хэрэглэх* зэргээр хүний эрхийг санаатай зөрчих явдлаар илэрч байна. Тус бүс нутгийн намын хорооны баримт бичигт 2004 оны 9 сард үндэглэгдсэнээр, тус оны эхний 8 сард 50 хүн цаазын ял хүлээж, 22 хүн салан тусгаарлах үзэл ба терроризмын бүлгүүдэд оролцсон шалтгаанаар баривчлагджээ. Засаг захиргаа ял хүлээсэн 50 хүн бүгд цаазлагдаагүй гэж мэдээлж байгаа ч тэдгээр хүмүүсийн одоогийн байдлын талаар ямар ч мэдээлэл өгөхгүй байна.

Хятад Улсын зах хязгаарын бусад үндэстний адилаар уйгар үндэстний уламжлалт соёлыг хадгалж үлдэх нь маш хүнд хэцүү хэвээр байна. Засаг захиргаа уйгар үндэстнүүдийг уламжлалт баяр ёслол хийх, уйгар хэлийг яриандаа хэрэглэхийг хязгаарлаж, шашны сургалт явуулах ба үзэл санаагаа илэрхийлэхийг хатуу хяналтын дор оруулж байна. Мөн 18 нас хүрээгүй хүнийг мусульман сүмд элсэх ба гэрээрээ шашны сургалтанд орохыг хориглон, бүх ахуныг (мусульман сүмийн номлогч) төрөөс сонгон шигших ба улс орноо хайрлах үзлийг сурталчилахыг үүрэг болгодог. Шүтлэгтнүүдийн залбирал үйлдэхийг хязгаарлаж, коран судрыг коммунист үзэл суртлын дагуу тайлбарлахыг хичээх тухай тушаал гаргасан байна.

Түвд

Хятад Улсад Түвд гэдэг нэрээр зөвхөн Түвдийн өөртөө засах орныг нэрлэдэг. Харин түвд үндэстнүүдийн 50 гаруй хувь нь "Их Түвд" гэж нэрлэгдэх Чинхай, Юннан ба Сычуан мужуудын нутагт амьдардаг.

Хятадын төрийн эрх мэдэлтнүүд Түвдийн шашин шүтлэг ба соёл уламжлалыг үргэлжлүүлэн хязгаарлахын сацуу Түвдийн бүх нутагт Далай ламын улс төрийн бодлого ба шашны нөлөөллийг сулруулах оролдлого хийж байна. Хатуу дарангуйлах арга хэмжээ авснаар Түвдийн тусгаар тогнолын үйл ажиллагааг ил тодоор дэмжихийг хориглон хязгаарласан. 2002 онд Сычуан мужийн шүүх тус нутгийн нэртэй лам Данзандэлренбучид цаазаар авах ял оноож, ялын гүйцэтгэлийг 2 жилээр сунгасан. Түүнд "Тэсрэх бөмбөг тавьсан ба Хятадаас салан тусгаарлахыг уриалсан" гэсэн ялыг хуурамчаар зүүсэн байна. Түүнтэй хамтрагч гэж засгийн эрх мэдэлтнүүдийн нэрлэсэн Лувсандүнжү 2003 оны 1 дүгээр сард цаазаар авахуулсан юм.

Сүүлийн арав гаруй жил Хятадын төрийн эрх мэдэлтнүүд Данзандэлийг Түвдийн уламжлалт шашин ба түвд үндэстний нийгмийн бүтцийг хөгжүүлэхийг тасралтгүй хязгаарлахыг оролдож байсан ба эцсийн үр дүн

нь түүнийг цаазаар авахад хүргэжээ. 2004 оны 3 дугаар сард нийтэлсэн "Нэгэн Түвдийн санваартныг шүүн таслах үйл ажиллагаа"-ны тайланд тус хэргийг тэмдэглэсэн байна. Энэ хэрэг үндэстнийхээ соёл уламжлалаа хадгалж үлдэхийн төлөө тэмцэж байгаа Түвд үндэстнүүдийн анхаарлын төвд байгаа.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаар:

Хэдийгээр шашин шүтэх явдал зөвшөөрөгддөг ч Хятадын төр засгийн эрх баригчдын онолоор шашин шүтлэг бол нэгэн төрлийн итгэл үзлийн систем болон нийгмийн байгууллагад тооцогддог ба эцсийн дүнд мөхөж үгүй болно гэж үзэж байна. Үүнээс өмнө Хятадын засгийн газар шашин шүтлэгийг хатуу хяналтанд авах шаардлагатай гэж үзэж байжээ. Үүний учир нь шашин шүтлэг ард түмний засаг төрд итгэх үзлийг урвуулан булаах чадвартай улс төрийн хүч эсвэл байгууллага болон хүчирхэгжихээс урьдчилан сэргийлэхэд оршин байжээ.

Хятадын төр засгийн бодлого шашны номлогчдыг өөрсдөөсөө хөндийрүүлэх ба тэднийг далд үйл ажиллагаа явуулахад хүргэхээс зайлсхийж, тэдний хүч хөдөлмөрийг коммунист намын төлөвлөсөн улс орныхоо хөгжилд зориулахад чиглэж байна.

Хятадын төр засгийн эрх баригчид багц хууль тогтоомжуудаар шашин шүтлэг ба шашны үйл ажиллагааны хөгжлийг хязгаарласан байдаг. Хуулийн дагуу эрх авахын тулд шашны байгууллагууд холбогдох төр засгийн байгууллагуудад заавал бүртгүүлж, тэдний хатуу хяналтан дор ордог байна. Буддын шашин, Даосизм, Мусульман шашин, Католик шашин ба Протестант гэсэн 5 шашныг төрийн засгийн зүгээс хүлээн зөвшөөрдөг. Бусад шашин шүтлэг нь мөн л хязгаарлагдмал ажээ. Бүртгүүлж эрх авсны дараа ч шашны номлогчид, шашны цуглаан, санхүүжилт ба хэвлэн нийтлэл нь бүгд хяналт шалгалт ба шилэлт сонголтонд ордог. Хэдийгээр хууль бус, бүртгэлд ороогүй ч шашин шүтлэгийн зарим үйл ажиллагаа Хятад улсад асар хурдацтай хөгжиж байна гэжээ. Дээрх байдлуудаас харахад Хятад Улсад шашин шүтэх эрх, эрх чөлөө хязгаарлагдмал байдалд байна.

Эмэгтэйчүүдийн эрхийн талаар

Хятадад, улс төрийн дээд давхарга ба бизнесийн дээд өндөрлөг дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь хангалтгүй бага хэвээр байна.

Эрчүүдийг дээдэлж, эмэгтэйчүүдийг дорд үздэг уламжлалт үзэл болон улсаас хэрэгжүүлж буй төлөвлөгөөт төрөлтийн бодлого, хөдөө тосгодод эмэгтэйчүүд ба эмэгтэй хүүхдийн тоо бага байгаа зэрэг нь хүн худалдах бизнесийг бий болгодог ажээ. Хэдийгээр хүн наймаалдаг хэсэг бүлэг этгээдийг илрүүлсэн ч хүүхэд, эмэгтэйчүүдийг барьцаалж, бусдад эхнэр болгох эсвэл биеийг нь үнэлэх зорилгоор худалдах явдал гарсаар байна. Ийм тохиолдлууд хөдөөд, үндэстний цөөнх оршин суудаг нутгуудад илүү хурцадмал байдаг. 2004 онд, биеэ үнэлдэг гэж сэжиглэгдэн баригдсан эмэгтэйчүүдэд цагдаагийн ажилтнуудаас хүч хэрэглэсэн явдал гарчээ хэмээн Хятадын дотоодын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Иймээс эмэгтэйчүүдийн эрхийн тухайд дэвшилттэй тал байхын зэрэгцээ зөрчилтэй тал бас байсаар байна.

Олон улсын үйл ажиллагааны оролцоонд гарч буй зөрчил

Хятад Улс, НҮБ-ын Хүний эрхийн байгууллага хоорондын хамтын ажиллагаанд үр дүн муутай тал бас байна. Сүүлийн 10 жил хэлэлцсэний дараа, Хятад улс НҮБ-ын эрүүгийн ажилтныг өөрийн орондоо айлчлахыг урьсан ба хугацааг 2004 оны 6 дугаар сард гэж урьдчилан тогтоосон боловч Хятадын Засгийн газар энэхүү хугацаанаас 2 долоо хоногийн өмнө тодорхой хугацаагүйгээр уг айлчлалыг хойшлуулсан. Энэхүү айлчлалын нөхцөл нь урьдчилан мэдэгдэхгүйгээр шоронд очиж байдалтай танилцах, хэрэгтнүүдтэй ганцаарчлан уулзах тухай бөгөөд үүнийг Хятадын тал хүлээн зөвшөөрөхгүй байсаар ирсэн юм. 2004 оны 9 сард НҮБ-ээс хорих газрын асуудлаар ажиглалт, судалгаа хийх ажлын хэсэг Хятадад айлчилсан юм. 1997 онд анх Хятадад ирсэний нэгэн адил энэхүү ажлын хэсэг Хятад улсын хууль тогтоомжийг Олон улсын Хүний эрхийн загварт нийцэж байна гэж үзсэн. Хэдийгээр ажлын хэсэг анх 1997 онд Хятадад айлчилж байсантай гол хамтын ажиллагааг харьцуулахыг анхаарсан ч Хятад улс ажлын хэсгийн Түвд дэх нэгдүгээр шоронгийн аж байдалтай танилцах айлчлалын хугацааг багасгаж, ажлын хэсгийн 1997 оны айлчлалын хугацаанд хүнд шархадсан байсан хэрэгтэнтэй уулзах шаардлагыг хүлээж аваагүй байна. Хятад Улс *"Эдийн засаг, нийгэм, соёлын хүний эрхийн олон улсын конвенц"*, *"Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц"* болон *"Хүүхдийн эрхийн конвенц"* зэрэг олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орсон боловч тэдгээрийн хэрэгжилтэнд зөрчил оршсоор.

БНХАУ Нэгдсэн Үндэстний Байгууллагын *Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц* болон *Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1967 оны зөвлөмжид* нэгдэн орсон хэдий ч тэдгээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж шүүмжлэгдэж байна. БНАСАУ-аас дүрвэгсдийг өөрийн улсын аюулгүй байдал, тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх нэрийдлээр хүлээн авахгүй байгаа, түүнчлэн өөрийн улсын улс төрийн бодлогоос шалтгаалан БНАСАУ-д хүний эрхийг хамгаалахгүй байгаа байдлыг өөгшүүлэн, тойруу замаар дэмжиж байна хэмээн дэлхий нийтээр үзэж байна. Тухайлал, БНХАУ-ын Засгийн газраас тус улсын хилээр Хойд Солонгосын хичнээн иргэн дамжин гарсан, тэдгээрээс хичнээнийг нь буцаасан болон өөр улс руу гаргасан болон өөрийн улсад үлдэхийг зөвшөөрсөн талаар мэдээлэл өгдөггүй ажээ.

III ХЭСЭГ - ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1989 оны Тэнаньмэний талбайд болсон явдлаас хойш одоо БНХАУ дипломат ганцаардлаас гарсан төдийгүй Ази-Номхон далай, дэлхий нийтэд байр суурыа бэхжүүлж чадлаа. Эхний шатанд Азийн орнуудтайгаа харилцаагаа хэвийн болгосон төдийгүй зарим орнуудтай дипломат харилцаагаа сэргээсэн. Тайвань болон Хонконгд буй хятад үндэстнээрээ дамжуулан асар их хөрөнгө оруулалт хийж байна. Хоёр дахь алхам буюу АНУ болон Европын орнуудтай харилцаагаа сэргээхдээ асар их хэрэглэгчтэй зах зээлээ овжин ашиглаж ирлээ.[200]

[200] Ш.Үнэнтөгс. Олон улсын харилцаа- Ази, Номхон далайн орнуудын хэтийн төлөв, Монгол Улсын эзлэх байр суурь

Мөн БНХАУ-ын дарга удаа дараа АНУ-д айлчилж харилцаагаа хэвийн болгосон нь, мөн АНУ-ын шинэ ерөнхийлөгч Ж.Буш БНХАУ-ын талаарх АНУ-ын шинэ бодлогыг тодорхойлохдоо: *"БНХАУ нь АНУ-ын стратегийн гол өрсөлдөгч"* хэмээн зарласан зэрэг нь дэлхий нийтэд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн их гүрний зиндаанд очих бололцоо олгосон юм. Хэдий тийм ч Хятадын дотоодын улс төрийн хэт нам гүм байдал ихээхэн түгшүүр төрүүлдэг. Өөрөөр хэлбэл саяхан сэлгээ хийсэн нам, төр ямархуу байр суурь баримтлах, улс төрийн тогтвортой байдлын номлолоо шаргуу баримтлах эсэх нь хамаг зүйлийн гогцоо болж байна. Энэ орны бүх зүйлийн хөдөлгөгч хүчин зүйл нь эдийн засаг байсан, байсаар ирсэн, байх ч болно. Сүүлийн арваад жил тэрбум гаруй хүн амтай Хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац жилд 10 хувиас давж, энэ зууны эхний хагаст Хятад улс эдийн засгийн үнэмлэхүй хэмжээгээрээ дэлхийн хамгийн том гүрэн болох нь гарцаагүй байна. Гэвч боловсролтой, чинээлэг хүн амын давхарга бий болохын сацуу улс төрийн ардчиллыг шаарддаг нь тодорхой билээ. Түүний нэг илрэл буюу тус улсад хэээнээс оршсоор ирсэн, дэлхий нийтийн шүүмжлэлд байнга өртдөг сэдэв бол хүний эрхийн асуудал юм. Хятад Улсын хүний эрхийн асуудал, түүний бодлого зохицуулалтанд нөлөөлөх хүчин зүйлүүдийн хамгийн гол гогцоо нь тус улсын хүн ам зүйн онцлог юм байна. Тэдгээрийг **дүгнэн үзвэл**:

- Хүн амын тоо ***их*** төдийгүй их ***залуужсан***, түүний зэрэгцээ дундаж ***наслалт урт*** болж 3 сая 800 мянга гаруй хүн 100-гаас дээш настай, эмэгтэйчүүдийн дундаж нас 74, эрэгтэйчүүдийнх 72 болсон өвөрмөц бүтэцтэй учир хүний эрхийн асуудалд **болгоомжтой хандах** аргагүй байдалд хүргэдэг. Өөрөөр хэлбэл олон тооны их залуу ба олон тооны өндөр настай хүмүүсийг удирдан залах асуудал хурцаар хөндөгдөн гарч ирнэ.
- Хүн амын ***соёлын төвшин харьцангуй доогуур***, түүнд нийт хүн амын ***79.0% -ийг хөдөөгийн хүн ам*** эзэлдэг, энэ үзүүлэлтээр дэлхийн дунджаас ***26%-иар давж*** байгаа байдал нь их нөлөөлдгийг анзаарах хэрэгтэй байх. Иймээс боловсрол нимгэн хүн амын тоо асар их байхын хэрээр нийгэмд эмх замбараагүй байдал үүсэх нь хялбар бөгөөд үүссэн тохиолдолд тун аюултай.
- 56 үндэстнээс бүрддэг, хүн ам газар нутгаар жигд бус тархан суусан байдал бас онцгой нөлөөтэйн зэрэгцээ тэдгээр үндэстнүүдийн заримаас ***"хүний хүү хурэн бөөртэй"***-н жишээ тод илэрдэг. Тэд хөгжих дэвшихийн хэрээр, эрх, эрх чөлөөгөөр хангагдахын хэрээр нийгэмд эмх дэглэмгүй байдал, түүгээр зогсохгүй улс орны аюулгүй байдалд цаашилбал дэлхий нийтийн энхийн асуудалд онц хор учруулахаар өнгө аяс олонтаа ажиглагддаг.
- Хятадын хүн амын төрөлт бууруй байгаа нь ***Төлөвлөгөөт төрөлт***-ийн бодлоготой холбоотой бөгөөд жилийн дундаж өсөлт 2.2-1.7% болж буурсан.

  Гэтэл энэхүү бодит байдалд хөнгөн гоомой хандагчид, Хятадын хүний эрхийн асуудлыг гуйвуулагчид *Төлөвлөгөөт төрөлт*-ийн бодлогыг хүний эрхийг зөрчиж байгаа тод томруун жишээ гэж үздэгээрээ *"Төлөвлөгөөт төрөлт"*-ийг үгүйсгэх аваас ирээдүйд Хятад Улс төдийгүй дэлхий нийтэд Хятадын хүн амын их өсөлт ямар ур нөлөөтэй, ямар ур дагаварт хүргэж болохыг санаатайгаар үл мэдэгч, үл тооцоологчийн царайгаа харуулж байна.

Хятадын хүн ам зүйн бодлогын 3 үндсэн зорилт (Хүн амын тоог хязгаарлах ***төлөвлөгөөт төрөлт***-ийн бодлого, Боловсролын төвшинг өндөржүүлэх, мэдлэг эзэмшүүлэх, эрүүлжүүлэх чанарын бодлого, Хүн амын аж амьдралын төвшинг дээшлүүлэх ***Эдийн засгийн*** бодлого) нь дээрх байдлуудыг сайн харгалзсан бөгөөд бодитоор хэрэгжиж байна гэж дүгнэхэд хүргэлээ.

Хятад Улсын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн амжилтыг дагаад тус улсад ***нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хүрээнд*** ихээхэн ололт гарч байгаа гэдэгтэй маргах аргагүй юм. Хүний эрхийг хангах, баталгаажуулах туйлын зорилготой бөгөөд түүнийгээ зохих төвшинд зарлан тунхагласан улс орнууд хэдий байгаа ч эдийн засаг нь тогтворгүй, дорой байдлаасаа шалтгаалаад хэрэгжүүлж чадахгүйд хүрэх явдал олонтаа ажиглагддаг билээ.

Хятад Улсын хүний эрхийн хөгжил бусад салбаруудын хөгжил дэвшлийн нэгэн адил хурдацтай хөгжиж байгаа гэж үзэхийн зэрэгцээ тэдгээр дэвшилттэй талууд нь зөрчиж буй дутагдалтай талуудаасаа илүү өндөр үзүүлэлттэй байна гэж онцлон тэмдэглэмээр байна.

Гэвч Хятадын хүний эрхийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлангуудад хүний эрхийн хүрээн дэх дутагдалтай бөгөөд шийдвэрлэгдээгүй, зөрчилтэй байгаа талуудыг дурдалгүй өнгөрөөдөг байдал ажиглагдлаа.

Хятад улс хүний эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллага, түүнчлэн эрдэм шинжилгээний байгууллага гэсэн бүтцийн ангилалтайгаар хүний эрхийг ханган баталгаажуулах цогц системийг бүрдүүлсэн харагдах боловч эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны хүрээ, хязгаарлагдмал эрх үүрэг нь төр засгийн удирдлага, хараа хяналтаас шууд хамааралтай байгааг илтгэж, хүний эрхийг ханган, баталгаажуулахад оролцох үндсэн үүрэг, нөлөөллөө хэрэгжүүлж чадахгүйд хүргэж байгаа нь мэдээж юм. Хятад Улс хүний эрхийн талаар засгийн хяналтаас ангид, бие даан үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулахыг хориглодог ба олон улсын хүний эрхийн байгууллага Хятадад орохыг бас зөвшөөрдөггүй гэж шүүмжлэгддэг. Энэ нь Хятад Улс хүний эрхийн олон асуудлуудаа дангаар хянан зохицуулж байх зорилгыг агуулж байна гэж судлаач үзэж байна. Хүний эрхийн олон улсын байгууллагатай холбоо тогтоосон иргэдийг баривчлан хорьдог гэсэн мэдээ байдаг. Хятадад хүний эрхийг зөрчиж байгаа талаарх дээр дурдсан мэдээллүүдийг нэгтгэн үзэхэд:

Хүний салшгүй эрхийн тухайд хүний амь насыг үндэслэлгүйгээр болон хууль бусаар хөнөөх, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, эсхүл шийтгэх, дурааран баривчлах, хорих, эсхүл цөлөх, шударга, нээлттэй шүүх хуралдааныг үгүйсгэх, хувийн нууц, гэр бүл, орон байр, эсхүл захидал харилцаанд хөндлөнгөөс оролцох,

Иргэний эрх чөлөөний тухайд үг хэлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний хувьд зөрчил илэрч байна. Эдгээр зөрчлүүд нь тодорхой бүс нутаг /*Хонконг, Тайвань, Түвд, Шинжаан-Уйгар* гэх мэт/, тодорхой хүрээг хамран улс төрийн ашиг сонирхлоос урган гарч байгаа нь тодорхой харагдаж байна. Хятадын төдийгүй дэлхийн бусад орны жишээн

дээр харахад хүний эрхийг улс төрийн ашиг сонирхлын үүднээс зөрчих явдал түгээмэл байгаа нь нотлогддог.

2004 оноос БНХАУ-ын олон улсын төвшинд үзүүлэх нөлөө нь улам гүнзгийрч байна. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2004 оны ээлжит хуралдаанд Хятад Улс санал дэвшүүлснээр, Хятадын хүний эрхийн түүхэн замналыг хэлэлцэх ажиллагаанд саад болж чадсан. АНУ-ын энэхүү асуудлыг хэлэлцэхийг чармайн дэмжиж буй явдлыг дарах үүднээс. Хятад улс АНУ-тай хийх хүний эрхийн талаарх хэлэлцээрээ 2004 онд дахин тасалдуулсан юм. Өнгөрсөн оны 10,11 дүгээр сард болсон Бээжингийн хэлэлцээрт хоёр улс тогтмол явуулдаг хүний эрхийн талаарх хэлэлцээрээ дахин сэргээхийг зөвшөөрсөн байна. Хятад улсад хүний эрхийг хангахад шаардлагатай загвар гарган өгч, тэрхүү загварыг бүрдүүлэх хугацааг нарийн тодорхойлж, гүйцэтгэх явцыг нийтэд тодорхой байлгахыг баталгаажуулах хэрэгтэй гэж Хятадын хоёр талын хэлэлцээрийн хамтрагчдад хүний эрхийн зарим ажиглагчаас уриалжээ.

Түүнчлэн АНУ тэргүүтэй орнууд Хятад Улсад хүний эрхийн асуудлаар дарамт учруулж, дэлхий нийтийн Хятад Улс дахь хүний эрхийн нөхцөл байдалд хандах хандлагыг төөрөгдүүлэх явдал цөөнгүй байна. Энэхүү байдалд Хятад Улсын хүн ам зүйн онцлог, түүнд тохирсон бодлого зохицуулалт, хүний эрхийн талаар баримтлах байр суурь зэргийг дүгнэн харьцуулалт хийвээс **дэлхий дээрх олон орны түүх, соёл, ард түмний ёс заншил, зан суртахуун, тухайн орны хөгжлийн түүхэн замнал, одоогийн хүрсэн төвшин зэрэг маш олон, нарийн хүчин зүйлүүд өөр өөрийн онцлогтой байсаар атал тухайн орны хүний эрхийн хөгжлийг нэгэн хэв загварт багтаан оруулахыг хичээх, харьцуулан үнэлж дүгнэх, түүнийгээ үндэслэн түрүү барьж тухайн улсын дотоод үйл хэрэгт хөндлөнгөөс оролцох нь нэн тохиромжгүй гэсэн байр суурийг баримтлах нь зүйд нийцэж байна.** Ялангуяа тэрбум гаруй хүнтэй энэ их гүрний хүний эрхийн асуудал ярвигтай бөгөөд гаднын ямар нэгэн шахалт, нөлөөллөөр шууд шийдвэрлэж болохгүй асуудал гэж үзэж байна. Ийнхүү Хятад Улсын хүний эрхийн хөгжлийн асуудал, төлөв байдлыг дэвшилттэй ба зөрчил дутагдалтай асуудлуудыг эш татаж дүгнэлт өгөх замаар тайланд тусгасан болно.

__oOo__

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/-ын төсөлд хийх хавсрага судалгаа

ОРШИЛ

Судалгааны зорилго[201]

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг (1993) Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй (2008) харьцуулан онолын судалгаа хийж хуулийг цаашид боловсронгуй болгох, зөв хэрэглэхэд тус дөхөм үзүүлэхүйц санал, дүгнэлт гаргах явдал энэ судалгааны гол зорилго болно.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох арга зүйг хангахад судалгааны зорилго оршиж байна.

Судалгааны зорилт

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг (1993), Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй (2008) харьцуулан судлах;
2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн онолын үндэс, бүтцийг судлах;
3. Гадаадын иргэд, тэдгээрийн эрх зүйн байдалтай холбоотой хууль тогтоомжийг хэрэглэж байгаа практикийг судлах;
4. Хуулийн төслийг боловсронгуй болгох, нэмэх боломжтой зүйлийн талаар санал гаргах зэрэг болно.

Судалгааны арга

Энэхүү ажлыг хийхдээ судалгааны дараах аргуудыг хэрэглэлээ. Үүнд:

- Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
- Харьцуулалт хийх;
- Түүхчлэх зэрэг арга орно.

Судалгааны агуулга

Уг судалгааны ажлыг үндсэн хоёр бүлэгт хуваан авч үзлээ. Эхний бүлэгт Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг онолын үүднээс авч үзсэн. Уг бүлгийг гурав, дөрвөн дэд бүлэгт хуваав. Эхний дэд бүлэг нь гадаадын иргэдийн ангилал, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон нэр томъёог авч үзсэн бөгөөд энэ нь хуулийн төслийн нэгдүгээр бүлгийг бүхэлд нь хамарна. Хоёр, гуравдахь дэд бүлэгт хуулийн төслийн үзэл бариитлал болон хуулийн төсөл холбогдох шаардлага хэр хангаж байгаа талаарх судалгааг багтаасан.

[201]Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэв.

Сэдвийн хоёрдугаар бүлэгт судалгааны гол үндсэн хэсэг болох гадаадын иргэд, тэдний эрх зүйн байдалтай холбоотой практик судалгааг багтаасан. Уг бүлэг үндсэн дөрвөн дэд бүлгээс бүрдэж байгаа юм. Нэгдүгээр дэд бүлэгт гадаадын иргэдийн бүртгэлийн асуудлыг авч үзсэн. Тус дэд бүлгийг гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим, гадаадын иргэн, цагаачлалын талаарх бодлого, гадаадын иргэдийн асуудал хариуцсан төрийн байгууллагуудын дотоод уялдаа холбоо гэсэн гурван хэсэг асуудал болгон ангилсан. Энэ хэсгүүдэд хуулийн төслийн хоёр, гурав, тав, зургаа, долоо, аравдугаар бүлгийн асуудлыг тусгасан юм. Хоёр дахь дэд бүлэгт хуулийн төслийн найм, есдүгээр бүлгээр зохицуулсан асуудал буюу цагаачлалын байгууллагын тогтолцоог авч үзсэн бөгөөд ямар чиг үүрэгтэй байгууллага байдаг, хэнд үйл ажиллагаагаа тайлагнадаг талаарх асуудлыг тодруулахад чиглэгдсэн. Харин гуравдугаар дэд бүлэгт виз олгох асуудлыг тусгасан бөгөөд визийн журам, виз олгох чиг үүрэг бүхий байгууллагын талаар тусгайлан авч үзэж, хавсралтаар баяжуулав. Тус дэд бүлэгт хуулийн төслийн дөрөвдүгээр бүлгээр зохицуулах асуудлыг тусгасан болно. Судалгааны хэсгийн сүүлийн дэд бүлэг нь Монгол улс дахь гадаад иргэдтэй холбоотой шүүхийн практикийг авч үзсэн болно.

Дүгнэлт хэсэг буюу судалгааны ажлын үр дүн, зөвлөмжийг төгсгөл хэсэгт оруулж өгсөн.

Уг нэг сэдэвт судалгаа нь бүлэг, дэд бүлэгт хамаарах хүснэгт, дүрслэл зураг бүхий хавсралт хэсгээс бүрдэж байгаа юм. Үүний дараа уг судалгааг хийхэд ашигласан ном, сурах бичиг, хууль тогтоомж, сонин сэтгүүлийн өгүүллэг, интернэт хаяг зэргийг жагсаан бичсэн ном зүйг оруулсан болно.

II. ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ОНОЛЫН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

А. Гадаадын иргэдийн ангилал, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон нэр томъёо

Эх хэлний хууль зүйн нэр томъёог гадаад /орос, англи/ нэр томъёотой харьцуулж монгол хэлний оновч, гадаад нэр томъёоны оноолтыг нягтлахдаа харьцуулан судлах арга хэрэглэлээ.

Definition – нэр томъёоны тодорхойлолт. Энэ нь дотроо *Legal definition* буюу хуулийн тодорхойлолт, *Eigene definition* буюу өөрийн шууд утгыг илэрхийлсэн хэл зүйн тодорхойлолт гэж ангилагддаг.

Нэр томъёоны тодорхойлолтыг авч үзэхдээ:

– Тухайн хууль даасан тодорхойлолт байгаа эсэх

– Шүүхээс тайлбарлан гаргасан тодорхойлолт байгаа эсэх

–Өөр хууль тогтоомжид заасан тодорхойлолт байгаа эсэхийг нягтална.

Хэрэв энэ дараалллын дагуу тухайн ойлголтыг тайлбарласан тодорхойлолт байхгүй бол бусад салбар шинжлэх ухааны тодорхойлолт байгаа эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн "Нэгдүгээр бүлэг" нь тус хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойлолт, уг хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийн талаар тусгана гэж заажээ. Хуулийн төслийн текстийг үзэхэд "гадаадын иргэн", "уригч", "түр ирэгч", "хувийн хэргээр оршин суугч", "Монгол Улсад албан хэргээр оршин суугч", "харьяалалгүй хүн", "паспорт", "виз", "визийн зөвшөөрөл" зэрэг нийт 9 нэр томъёог онцгойлж авч үзсэн байна.

Харин 1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлд "Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид энэ хуульд "гадаадын иргэн" гэх/-д хамаарна" гэсэн. Энэ зүйлд заасан нэр томъёогоо тус хуулийн 22 дугаар зүйлд тодорхойлж өгчээ. "Түр оршин суугч", "албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч", "цагаач", "байнга оршин суугч", "хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч", "дамжин өнгөрөгч" зэрэг нийт 6 нэр томъёог онцгойлж тодорхойлсон байна. Гэхдээ хууль анх батлагдах үед эдгээр нэр томъёоноос 4 нэр томъёог тодорхойлсон байсан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явцад буюу 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар зарим нэр томъёог өөрчлөн найруулж, заримыг шинээр нэмж, 2000 оны 12 дугаар сарын 7-ны хуулийн нэмэлтээр зарим нэр томъёог шинээр оруулсан байна.

Эдгээр нэр томъёог тайлбарласан эсвэл 1993 онд батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн талаар Монгол улсын Дээд шүүхээс аливаа нэг тайлбар гараагүй байна.

Гадаадын зарим улс орны хууль тогтоомжийг үзэхэд "харьяалалгүй хүн" хэмээх нэр томъёог "Харьяатын тухай хууль"-даа тодорхойлсон байна. Үүний нэг жишээ бол 2002 оны ОХУ-ын Харьяатын тухай хууль, түүний 3 дугаар зүйл болно. Гэтэл Монгол Улсын бусад хууль тэр дундаа Харьяатын тухай хуульд энэ нэр томъёог өнөөг хүртэл тодорхойлоогүй байна. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд энэ нэр томъёог анх удаа тодорхойлсон гэж үзэж байна.

1993 онд батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон хуулийн төслийн текстэд тодорхойлсон нэр томъёоноос эрх зүйн харилцааны субъектийг тодорхойлох зарим нэр томъёог түүвэрлэн харьцуулан авч үзье.

Хүснэгт №1

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2008 он	Бусад эрх зүйн эх сурвалж

22.3.Монгол Улсад Засгийн газар хоорондын гэрээгээр сураллцах, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон тэдэнтэй адилтгах албан тушаал эрхлэн 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнийг албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ.	4.1.5. "Монгол Улсад албан хэргээр оршин суугч" гэж Монгол Улсад төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар ирсэн буюу Засгийн газар хоорондын, гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг	
22.1.Энэхуульдзаасанүндэслэлээр Монгол Улсад 30 хоног хүртэл хугацаагаар албан болон хувийн хэргээр ирсэн гадаадын иргэнийг зорчигч гэнэ. 22.7. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг орноос нөгөөд зорчиж байгаа этгээдийг дамжин өнгөрөгч гэнэ.	4.1.3."түр ирэгч" гэж Монгол Улсад 30 хоног хүртэлх хугацаагаар Монгол Улсад ирсэн гадаадын иргэнийг	
22.2. Монгол Улсад хувийн хэргээр 90 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг түр оршин суугч гэнэ. 22.5. Монгол Улсын харьяат иргэнтэй гэр бүл болсон бөгөөд 90 хоногоос дээш хугацаагаар Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнийг байнга оршин суугч гэнэ. 22.6. Монгол Улсад хувийн хэргээр 90 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ.	4.1.4. "хувийн хэргээр оршин суугч" гэж Монгол Улсад сураллцах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүл болох болон бусад хувийн зорилгоор Монгол Улсад ирсэн гадаадын иргэнийг	
22.4.Хувийн хэргээр Монгол Улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг цагаач гэнэ.		"цагаач[1]" гэж оршин суух газар нутаг хайж ирсэн хүнийг хэлнэ
	4.1.6. "харьяалалгүй хүн" гэж аль ч улсын харъяат биш хүнийг	"харьяалалгүй хүн"[2] гэж ОХУ-ын иргэний харьяалалгүй, өөр улсын иргэн гэдгийг нь нотлох баримт бичиггүй этгээдийг хэлнэ
	4.1.1."Гадаадын иргэн" гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй хүнийг	Энэхүү тунхаглал[3] болон холбогдох зүйлүүдэд заасан утгаар нь "гадаад хүн" гэж өөрийн амьдарч буй улсынхаа иргэн биш аливаа этгээдийг хэлнэ.

ХҮНДЭСНИЙ ХЯЗГААР ЗӨРЧЛИЙН ЯАМ

Дээрх хүснэгтээс харахад хуулийн төсөлд зарим нэр томъёог, жишээ нь "зорчигч", "дамжин өнгөрөгч" гэсэн нэр томъёог нэгтгэж "түр ирэгч" гэсэн нэг нэр томъёо хэрэглэсэн байна. Мөн "түр оршин суугч", "байнга оршин суугч", "хувийн хэргээр оршин суугч" гэсэн нэр томъёог нэгтгэн "хувийн хэргээр оршин суугч" гэсэн нэр томъёог хэрэглэжээ.

1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтооход цаг хугацааны хүчин зүйлс нөлөөлсөн. Харин хуулийн төсөлд цаг хугацааны хүчин зүйлийг нэр томъёог тодорхойлохдоо харьцангуй бага буюу зөвхөн "түр ирэгч"-ийг тодорхойлоход 30 хоног гэсэн хугацаа ашиглажээ. Харамсалтай нь зарим шаардлагатай, тухайлбал "цагаач" гэх мэт нэр томъёог хуулийн төсөлд орхигдуулсан байна. Дараах зургаас нэр томъёог тодорхойлоход цаг хугацааны хүчин зүйл хэрхэн нөлөөлснийг харж болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон хуулийн төсөлд хуулийн хамаарах этгээд гэсэн заалтад уг хуулиар болон хуулийн төсөлд тодорхойлсон бүх субъектуудыг "цаашид *"гадаадын иргэн* гэх болно" гэж хаалтанд бичиж заасан нь хуульд тодорхойлсон субъектуудын хувьд тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа цаг хугацааны нөлөө нь тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох гол хүчин зүйл биш гэдгийг харуулах бөгөөд тэдний эдлэх эрх, хүлээх үүрэг тийм ч ялгаатай биш гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл ийнхүү ангилан заагласан нь тус улсын нутаг дэвсгэрт орж ирэн бүртгүүлэхээс бусад буюу яг ямар эрх, үүргийн хувьд ач холбогдолтой болох нь тодорхойгүй болжээ. Иймд энэ заалтыг тийм ч оновчтой заалт болж чадаагүй гэж үзэж байна.

Хүснэгт №2

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2008 он
4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамаарах этгээд Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харъяалалгүй хүн /цаашид энэ хуульд "гадаадын иргэн" гэх/-д хамаарна.	5 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамаарах этгээд 5.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн /цаашид "гадаадын иргэн" гэх/-д;

Хуулийн төслийн үзэл баримтлалд "Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэний ангилал, статусыг тодорхой болгож цэгцлэх шаардлагатай байна" гэж дурьдаад одоо мөрдөж байгаа хуулиар гадаадын иргэдийг 7 ангилалд хувааж байгаа нь хэт олон, ойлгомжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа нь гадаадын иргэдэд тавих хяналтад сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байгаатай санал нэг байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд гадаадын иргэн, цагаачлалын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг улам боловсронгуй болгоход уг хуулийн шинэчилсэн найруулгыг хийж байгаа ач холбогдол

оршиж байгаа тухай бичсэн. Цагаачлалын тухай ярихад "цагаач" гэсэн нэр томъёог тодорхойлохгүйгээр уг субъектийн эрх зүйн байдлыг тогтоож чадахгүй. Хувь хүн гадаадад амьдрахаар сайн дурараа өөрийн эх орноо орхин явахыг цагаачлах гэнэ[202]. Цагаачид[203] (эдийн засгийн) – зөвхөн эдийн засгийн шалтгаанаар буюу материаллаг аж байдлаа дээшлүүлэх зорилгоор уугуул орноо орхин гарч байгаа хүмүүс. Эдийн засгийн цагаачид нь дүрвэгчийн эрх зүйн шалгуурт багтдаггүй, тийм учраас дүрвэгсэд мэт олон улсын хамгаалалт эдэлдэггүй.

Цагаачлалын эрх зүйн субъект нь гадаадын тодорхой улсын иргэдээс гадна хоёрдмол харъяалалтай болон харъяалалгүй хүмүүс байдаг учир "гадаадын иргэн" гэж нэрлэх нь учир дутагдалтай[204]. Аливаа улсын цагаачлалын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа тухайн улсын иргэн бус аливаа хүнийг "гадаадын хүн" гэдэг. Энэ талаар "Амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдийн хүний эрхийн асуудлаархи тунхаглал" НҮБ-ийн А/40/53 (1985) баримт бичигт ч заасан байдаг. Хууль зүйн толь бичиг сөхөж үзвэл *Extraneus est subditus qui extra terram, i.e., potestatem regis natus est* - харь хүн, гадаад хүн гэдэг бол улсын хилээс гадна, эсхүл хааны эрх мэдлээс гадна төрсөн хүнийг хэлнэ гэж тэмдэглэжээ (Extraneus[205]-харь хүн, гадаад хүн, гадны хүн). Хууль нь нэр томъёогоор амьсгалдаг, нэр томъёо зөрвөл наанадаж гажуудал, цааш хууль ёсонд хямрал үүсдэг. "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль" (1993 он)-ийн 21 дүгээр зүйлийн гарчиг "Гадаадын хүн Монгол Улсад оршин суух" гэсэн байдгийг анхаарвал "гадаадын хүн" гэсэн нэр томъёог хуульд огт хэрэглээгүй биш, цоо шинэ нэр томъёо биш байна гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 14.2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэж заасан. Эндээс үзвэл аливаа хүн тухайн улсын иргэн байна уу, гадаадын иргэн байна уу, давхар харъяалалтай этгээд байна уу, харъяалалгүй хүн байна уу гэдгээс үл шалтгаалан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Гэвч гадаадын иргэн нь өөрийн улсын болон оршин суугаа улсын гэсэн хоёр эрх зүйн дэглэмд захирагддаг. Уг хоёрдмол байдал нь гадаадын иргэдийн эрх зүйн өөрмөц байдлын илэрхийлэл болдог юм.

Аливаа улсад байгаа гадаадын иргэний эрх зүйн байдлыг тодорхойлоход хүний эрх, эрх чөлөөний талаарх олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ба хэм хэмжээ нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим ба хэм хэмжээ нь Хүний эрхийн тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн пакт, Эдийн засаг, нийгэм

[202] О.Пунцагдаш, Иргэний харъяалал (Олон улсын эрх зүйн асуудал), УБ, 2002, ху 98

[203] Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №2-2001, Дүрвэгсдийн асуудлаарх олон улсын эрх зүйн лавлах, УБ, 2007, ху131

[204] Г.Сэсээр "АНУ-ын цагаачлалын эрх зүйн зарим аудал", Вашингтон хот, 2006 он, ху 97

[205] Ж.Амарсанаа – Латин нэр томъёоны толь, 2008, ху 74

соёлын эрхийн тухай пакт, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын Конвенц зэрэгт агуулагддаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал[206]-ын 6 дугаар зүйлд "Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[207]-ын 13 дугаар зүйлд "Энэхүү Пактад оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэнийг гагцхүү хуулийн дагуу гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс албадан гаргаж болох бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин хянуулах түүнчлэн энэ зорилгоор ийнхүү эрх бүхий байгууллага, этгээд буюу этгээдүүдэд өөрийгөө төлөөлүүлж хандах эрхтэй" гэж тус тус заажээ.

Олон улсын эрх зүйгээр тогтоосон хүний эрх тухайлбал, өөрийн улсыг чөлөөтэй орхин явах, эх орондоо буцаж ирэх эрхийг хангах, хэрэгжүүлэхэд аль улсын иргэн байх, харьяалалгүй этгээд байх зэрэг үл хамаарна. Энэ талаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал[208]-ын 13 дугаар зүйлд "Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[209]-ын 12 дугаар зүйлд "Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй", "Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй", "Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй" гэж тус тус заажээ. Мөн НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр хуралдаанаар Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенц батлан гаргасан юм.[210]. Уг конвенцид цагаачид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрх зүйн харьцаанд ялгаварлан гадуурхахгүй байх, тэд ямар ч үед аливаа улс, түүний дотор харьяалах нутаг дэвсгэрээс гарч явах, зорчин очих, тэдний амь нас хуулиар хамгаалагдах зэрэг өргөн эрх, эрх чөлөөг тодорхой зааж оруулсан. Монгол Улсын хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд заасан. 2008 оны байдлаар Монгол Улс гадаадын 74 улстай 1055 гэрээ байгуулснаас Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг.[211]

[206]Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть1 , хуу 6-7
[207] Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть1 , хуу 16
[208]Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть1 , хуу 6-7
[209] Төрийн мэдээлэл, ОУГ, тусгай дугаар, 2005 он, боть1 , хуу 16
[210] Монголын төр эрх зүй сэтгүүл, 2002/4, О.Пунцагдаш "Цагаачдын эрх зүйн байдал", хуу 10
[211]Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгэ тайлан, УБ,

- эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх - 19
- иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх - 18
- гэр бүлийн хэргээр - 11
- аж ахуйн асуудлаар - 2
- хөдөлмөрийн асуудлаар - 1
- гэмт хэргээдийг шилжүүлэн өгөх тухай - 4
- ялтан шилжүүлэн өгөх тухай - 1

тус тус байгуулжээ.

Гадаадын иргэн, гадаадын хүний эрх зүйн байдлыг бусад улс оронд хэрхэн авч үзсэн байдаг талаар товч авч үзье.

1981 оны гадаадын иргэдийн эрх зүйн бэйдлын тухай ЗХУ-ын хууль гадаадын иргэдийг хоёр бүлэгт хуваасан байдаг: байнгын оршин суугч болон ОХУ-д түр хугацаагаар оршин суугч. Гадаадын иргэдийг аль нэг бүлэгт оруулахдаа хугацааны нөхцөл байдыг /оршин байх хугацаа/ нь харгалзахаас гадна түүний ОХУ-тай тогтоосон эрх зүйн холбооны тогтвортой байдлыг болон ОХУ-д байх зорилго бэ шинж чанарыг нь харгалзаж үздэг. ОХУ-ын хуулиар тухайн улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гэсэн бодит байдал нь түүний эрх зүйн байдлыг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Иймд хөдөлмөрийн үйл ажиллагаа явуулах, орон сууцаар хангагдах, эмнэлгийн туслалцаа авах, боловсрол олж авах зэрэг асуудлаар ОХУ-д байнга оршин суугч ОХУ-ын иргэдийн адил эрх эдэлдэг. Иймд байнга оршин суугч иргэдийн статус нь түр хугацаагаар хүрэлцэн ирсэн гадаадын иргэдийн статусаас ялгаатай.

ОХУ, ТУХН-ийн болон Зүүн Европын улс гүрнүүд болон БНХАУ «гадаадын иргэдийн эрх зүйг» эрх зүйн тогтолцоон дахь бие даасан салбар гэж үздэггүй. Учир нь зохицуулах зүйлээрээ хамаарах хэм хэмжээ нь эрх зүйн тогтолцооны төрөл бүрийн салбарт багтдаг: төрийн, захиргааны, иргэний, хөдөлмөрийн. гэр бүлийн, эрүүгийн, процессийн г.м. Гэхдээ энэ нь нийлбэр цогц шинжтэй тусгай хууль тогтоомжийн зохицуулалтын практик ач холбогдлыг (зүй ёсны) үгүйсгэж байгаа гэж үзэж болохгүй юм. Ийм зохицуулалт зүй ёсны гэдгийг хүлээн зөвшөөрсний улмаас ЗХУ 1981 онд «ЗХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуулийг батлан гаргасан билээ. ОХУ-ын хувьд «Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуулийн төсөл боловсруулагдаад байна. Белорусс болон Казахстан зэрэг улс «Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай» хуультай.

Харьяалалгүй хүн гэдэг нь ОХУ-ын харьяалалд хамаарагдахгүй бөгөөд өөр аль нэг улсын харьяат гэдгийг нотлох баримтгүй хүнийг ойлгоно.

Дүрвэгч гэдэг нь ОХУ-ын харьяалалгүй бөгөөд түүний эсрэг үйлдсэн хүчирхийллийн болон бусад хэлбэрийн мөрдөн мөшгөлтийн улмаас эсхүл арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл мөн ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддаг байдлаасаа болон улс төрийн үзэл бодлоос нь хамааран мөрдөн мөшгилтөд өртөх аюулаас зугтан өөрийн улсын нутаг дэвсгэрийг орхин гарах хүсэлттэй эсхүл шаардлагатай болсон улмаас ОХУ-ын нутаг дэвсгэрт хүрэлцэн ирсэн буюу тийм хүсэлттэй байгаа хувь этгээдийг ойлгоно.

2008 он, хуу 409-410

Шилжин суурьшигч гэдэг нь сайн дурын үндсэн дээр болон өөрийн хүсэлтээр өөрийн улсын нутаг дэвсгэрийг орхин өөр улсын нутаг дэвсгэрт шилжин суурьшиж байгаа хувь этгээдийг ойлгоно. ОХУ нь Армени, Белорусс, Казахстан, Киргиз, Туркменистан, Латви зэрэг улстай шилжин суурьших асуудлаар хэлэлцээр хийсэн бөгөөд уг гэрээгээр шилжин суурьшуулах ажиллагааг зохицуулахаас гадна шилжин суурьшигчдын эрхийг, тэр тусмаа өмчийн эрхийг нь хамгаалж өгсөн юм. Жишээлбэл, 1999 онд хүчин төгөлдөр болсон Казахстан Улстай байгуулсан гэрээнд соёлын үнэт зүйлд тогтоосон хязгаарлалтыг харгалзан бусад хөдлөх эд хөрөнгө хилээр гаргах эрхийг шилжин суурьшигчид олгосон байна.

АНУ-д гадаадын хүмүүсийг эрх зүйн байдлаас нь шалтгаалан 3 хуваадаг.

1. АНУ-ын нутаг дэвсгэр дээр түр оршин суух зөвшөөрөлтэй хүмүүс (цагаачлалын бус визтэй хүмүүс)

2. АНУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суух зөвшөөрөлтэй хүмүүс (цагаачлалын визтэй хүмүүс)

3. Хууль бусаар оршин суугаа хүмүүс

Цагаачлалын болон цагаачлалын бус визтэй гадаадын хүний эрх зүйн байдал нь АНУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлөөрөө ялгаатай. Нэг нь байнга оршин суух, нөгөө нь түр оршин суух зөвшөөрөлтэй байдаг. Зөвшөөрлийн төрөл нь тухайн хүний АНУ-д байнга буюу түр оршин суух мэдүүлэгт дурдсан хүсэл эрмэлзэлтэй холбоотой бөгөөд нийцсэн байх ёстой. *Хууль бусаар оршин суугаа хүмүүс* гэж цагаачлалын хууль тогтоомжийг зөрчин АНУ-ын нутаг дэвсгэрт суугаа хүнийг хэлнэ. Энэ ангилалд хууль бусаар хил нэвтэрсэн буюу хилийн хяналтаар ороогүй, хууль ёсоор орсон боловч тухайн улсын нутаг дэвсгэрт байх зөвшөөрөгдсөн хугацаагаа хэтрүүлэн үлдсэн, тухайн улсын нутаг дэвсгэрт хуурамч бичиг баримтаар буюу өөр хүний нэрээр орж ирсэн, эсхүл хууран мэхлэх замаар орж ирсэн, тухайн улсад орох эрхгүй мөртлөө шаардлагатай мэдээлэл нуун дарагдуулах замаар орж ирсэн (өмнө нь албадан гаргагдсан, зөвшөөрсөн хугацааныасаа өмнө буцаж ирсэн г.м) гадаадын хүмүүсийг хамруулна.

Б. Хуулийн үзэл баримтлал

Одоогийн үйлчилж буй Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн найруулан хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулахдаа дараах зүйлсийг гол зорилгоо болгожээ. Үүнд:

– Гадаадын иргэн, цагаачлалын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг улам боловсронгуй болгох;

– Гадаадын иргэнтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулах;

– Гадаадын иргэнтэй холбоотой албаны тогтолцоог олон улсын жишигт тохирсон бүтэц, зохион байгуулалттай болгон бэхжүүлэх;

– Гадаадын иргэний статусыг зөв тогтоох гэж томъёолжээ.

Ийнхүү томъёолохдоо хууль зүйн үндэслэлийг хангалттай гаргаж тавьсан байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурлын 2005 оны 26 дугаар



тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 116-д "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тогтолцоог боловсронгуй болгох, түүнчлэн уг хуульд олон дахин өөрчлөлт орсныг харгалзан нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх зэргээр хуулийг бүхэлд нь өөрчлөн найруулах" гэж, мөн Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 8.1.13-д "Иргэний бүртгэл, мэдээлэл, шилжих хөдөлгөөн, гадаадын иргэн, харьяатын асуудал, иргэний бүртгэл, мэдээллийн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх тогтолцоог боловсронгуй болгох", Засгийн газрын 2004 оны 245 дугаар тогтоолын 8.1.13.8-д "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албыг олон улсын жишигт тохирсон бүтэц, зохион байгуулалттай болгон бэхжүүлэх", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө батлах тухай" 40 дүгээр тушаалд "Уг албаны үйлчилгээг түргэн, шуурхай, нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр бүтэц, зохион байгуулалтын асуудлыг судалж, санал боловсруулж холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлнэ" гэдгийг дурджээ.

Мөн практик үндэслэл, шаардлагыг тус хуулийн үзэл баримтлалд дурдсан байна. Гэхдээ ямар судалгаан дээр үндэслэж гаргаж ирсэн нь тодорхойгүй. Хуулийн үзэл баримтлал нь өөрөө эрх зүйн баримт бичиг болохоор судалгааны асуудлыг магадгүй шууд тусгаагүй байж болох юм.

Хуулийн үзэл баримтлалыг тодорхойлохдоо "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг авч үзье.

Хүснэгт №3

	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл-Шинэчилсэн найруулга (2008)
9.3.1.хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага	– Хуульд заасан тодорхой нэр томъёоны тайлбарыг хуульчлаагүйгээс – Засгийн газрын агентлагийн статустай цагаачлалын байгууллагыг бий болгох, чиг үүргийг тогтоох – Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны бүрэн эрхийн асуудлыг нарийвчлан хуульчлах – Энгийн зэргийн виз олгохдоо цагаачлалын байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн олгож байх тогтолцоог хуульчлах – Гадаадын иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон хяналтын байцаагчдын бүрэн эрхийг тодруулан хуульчлах – Захиргааны хариуцлага ногдуулах эрхийг давхардуулахгүй байх – Хяналтын журмыг хуульчлан тогтоох, хуульд буй давхардлыг арилгах – Гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, хаягийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох – Гадаадын иргэнийг урих, ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, хаягийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох

9.3.2. хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Нийт 10 бүлэг 65 зүйл. Хүснэгт №3-аас дэлгэрэнгүй үзнэ үү.
9.3.3. хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;	*Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн найруулснаар дараах зөрэг үр дүн бий болно. Үүнд:* *1/ Гадаадын иргэн, цагаачлалын талаар төрийн институтын харилцаа, бүрэн эрх тодорхой болж, гадаадын иргэний талаар иргэн, аж ахуйн нэж байгууллагын хүлээх үүрэг, түүнд уялдсан хариуцлагын нэгдсэн тогтолцоо тус улсад бий болно.* *2/ Гадаадын иргэн Монгол Улсад орох, оршин суух, гарах хөдөлгөөнөөр буртгэн бүхэлд нь хяналт тавих чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн гадаадын иргэдийн зорчих, оршин суух хөдөлгөөнд нэгдсэн байдлаар хяналт тавих нөхцөл бүрдэх юм. Ингэснээр гадаадын иргэд хууль бусаар оршин суух явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрчимжиж, нэгдсэн тоо, буртгэл судалгаатай болно.* *3/ Гадаадын иргэнд захиргааны харицуулага хүлээлгэх харьяалал тодорхой болж, гадаадын иргэдэд олон субьект хяналт тавих нэрийдлээр чирэгдэл учруулах, цаашлаад хяналтыг тарамдуулдаг тогтолцоо байхгүй болно.* *4/ Албадан саатуулах, албадан гаргах үйл ажиллагаа олон улсын жишигт нийцсэн, өөрийн улсын онцлогт тохирсон байдлаар хэрэгжих хууль эрх зүйн үндэслэл бий болно. Түүнчлэн үригч, тээвэрлэгчийн харицуулага хүлээх зарчмыг бий болгосноор гадаадын иргэнийг албадан саатуулах. гаргах үйл ажиллагаг улсын төсөөт хүндрэлгүй байдлаар шийдвэрлэх, цаашлаад эдийн засгийн аргаар гадаадын иргэдийн урсгал хөдөлгөөнийг хянах боломж бүрдэнэ.*
	5/ Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, суралцах, Монгол Улсын иргэнтэй гэр бул болсон болон 5 жилээс дээш хугацаагаар цагаачлан амьдарч байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний талаарх хувийн мэдээлэл, гарын хурууны хээг бүртгасан гадаадын иргэний үнэмлэх бий болгосноор үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах. аливаа гэмт халдлагад өртсөн тохиолдолд гадаадын иргэнийг олж тогтоохоод чухал ач холбогдолтой. 6/ Цагаачлалын байгууллагын тогтолцоог бий болгосноор нутаг дэвсгэр дэх гадаадын иргэний шилжилт хөдөлгөөнийг хянах, бүртгэх Монгол Улсад хууль бусаар оршин суух явдлыг багасгах, урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой.
9.3.4.хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал.	1/ Захиргааны хариуцлагын тухай хуулийн захиргааны хяналтын давхардлыг арилгах чиглэлээр; 2/ Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд уг хуулийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын давхардлыг арилгах, энэ хуульд нийцүүлэн нэг мөр болгох чиглэлээр. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргах холбогдох шийдвэрийн төслийг боловсруулна.



В. Хуулийн төсөл холбогдох шаардлагыг хангасан байдал

Энэхүү төсөл нь Хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 11.3-д зааснаар "Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл" гэсэн төрөлд багтана. Тус хуульд хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тавигдаж буй шаардлагыг "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2008)"-ын төсөл хэрхэн хангаж байгааг доорх хүснэгтээр харъя.

Хүснэгт №4

Эрх зүйн шаардлага	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл-Шинэчилсэн найруулга (2008)
Хуулийн үзэл баримтлалыг тодорхойлсон эсэх[4]	Нийт 4 асуудлаар үзэл баримтлалыг тодорхойлсон байна. –Хуулийн төсөл боловсруулах үндсэн шаардлага –Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, харах хүрээ –Хуулийн төслийн дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар –Хуулийн төсөл бусад хууль тай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаар
12.1.1. Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх[5]	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6, 14, 16, 18 зүйлтэй нийцсэн. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын нэгдэн орсон 1055 гэрээний заалтыг зөрчөөгүй. Хүний эрхийн тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн пакт, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай пактад заасан заалтуудтай уялдсан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
www.legalinstitute.mn

12.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг аль болох бүрэн тусгасан байх	1. *Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойолт, уг хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийн талаар* 2. *Хоёрдугаар бүлэг бүлэгт гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух, цагаачлах эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим, хориглох үйл ажиллагааг* *3. Гуравдугаар бүлэгт гадаадын иргэн, цагаачлалын талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын бүрэн эрхийн талаар болон, гадаадын иргэнийг урих, ажиллуулах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүргийн талаар* 4. *Дөрөвдүгээр бүлэгт Монгол Улсын визийн ангилал, зэрэг, виз олгох байгууллага, тэдгээрийн чиг үүрэг, виз, визийн зөвшөөрөл, түүний хугацаа, сунгах зэрэг асуудлыг* 5. Тавдугаар бүлэгт гадаадын иргэн Монгол Улсад орох, орохыг үл зөвшөөрөх үндэслэл, дамжин өнгөрөх журмын талаар 6. *Зургадугаар бүлэгт гадаадын иргэний бүртгэл. Монгол Улсад хувийн хэрэгээр болон байнга оршин суух, цагаачлах гадаадын иргэдийн тоо, бүтцийн тухай, мөн гадаадын иргэн Монгол Улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх журам, гадаадын иргэнд үнэмлэх олгох, түүний мэдээллийн сан бүрдүүлэх талаарх зохицуулалтыг*
	7. Долдугаар бүлэгт гадаадын иргэн Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх, албадан саатуулах, албадан гаргах үндэслэл, журам, түүнчлэн албадан гаргах улсын талаар 8. *Наймдугаар бүлэгт Цагаачлалын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны үндсэн зарчим, санхүүжилт, цагаачлалын байгууллагын болон ажилтны эрх, үүргийн талаар* 9. *Есдүгээр бүлэгт Цагаачлалын байгууллагын ажилтны нийгэм, эдийн засгийн баталгааны талаар* 10. *Аравдугаар бүлэгт гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух, цагаачлах тухай хуулийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо, хариуцлага хүлээлгэх субъектын талаар тус тус тусгасан.*
12.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох тухай заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөлд ийм заалт тусгаагүй

12.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Нийт 10 бүлэг, 65 зүйлтэй. Хуулийн төсөл дээр хоорондоо утгын болон агуулгын зөрчилтэй зүйл, хэсэг, заалт байхгүй байна
12.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх гэсэн шаардлагыг энэ хуулийн төсөл хангаж байна.
12.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	– Бусад хуулийн заалтыг давхардуулан заасан тохиолдол хуулийн төсөлд байхгүй байна. – Хуулийн төслийн 2.1-д "...Монгол Улсын Үндсэн хууль..." гэж оруулсан түл түс хуулийг хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг иш татан зааж өгөөгүй байна
12.1.8. хуулийн зорилт, түхайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хамрах хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчоос удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл /гипотези/, тэдгээрийг биелүүлэх журам, эрх, үүрэг /диспозици/, онцгойлон үзэх нөхцөл байдал, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тодорхой заасан байх;	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 7 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх, үүрэг 8 дугаар зүйл. Гадаадын иргэнд хориглох үйл ажиллагаа 10 дугаар бүлэг, 56-62 дугаар зүйл – Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
12.1.9. шаардлагатай тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хэм хэмжээ, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгох, хасах санал;	– Хуулийн төслийн 65 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацаа гэсэн заалт оруулсан боловч огноог тодорхой тавиагүй байна. – 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг мөн бэлтгэсэн байна.
12.1.10. шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулсан байх.	*Дараахь хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахаар санал бэлтгэсэн байна. Үүнд:* 1. Захиргааны хариуцлагын тухай хуулийн захиргааны хяналтын давхардлыг арилгах чиглэлээр; 2. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд уг хуулийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын давхардлыг арилгах, энэ хуульд нийцүүлэн нэг мөр болгох чиглэлээр. 3. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргах холбогдох шийдвэрийн төсөл

Хууль зүйн нэр томъёонд тавигдах хэл зүйн шаардлага

Хүснэгт №5

Хэл зүйн шаардлага[6]	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл-Шинэчилсэн найруулга (2008)
13.1.1. Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Үндсэн хуульд "гадаадын иргэн", "харьяалалгүй хүн" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Үүнийг тус хуулийн төсөлд хэрэглэсэн. Гэвч олон улсын жишиг "гадаад хүн" гэсэн нэр томъёог хэрэглэсээр ирсэн.
13.1.2. нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлсэн байдал тус хуулийн төсөлд байхгүй байна.
13.1.3. нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;	"гадаадын иргэн" гэсэн нэр томъёог "гадаад хүн" эсвэл "монгол улсын иргэн биш этгээд" гэсэн нэр томъёогоор солих. Учир нь олон улсын хэмжээнд "alien", "etranger" (гадаад хүн, харь хүн) гэсэн нэр томъёог нэгэнт хэрэглэж заншсан. "гадаадын иргэн" гэдэг нэр томъёог хуучин ЗХУ-ын нөлөөн дор байсан улсууд хэрэглэдэг. Тухайлбал Эстони, Латви зэрэг улсуудыг нэрлэж болно.
13.1.4. монгол хэлэнд тохирох үг нь байвал гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй байх;	гадаад хэлний нэр томъёо хэрэглээгүй. Монгол хэлэнд нэгэнт хэвшин тогтсон "виз" гэсэн үгийг хэрэглэсэн.
13.1.5. үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	хоёрдмол утгатай, тодорхой биш, ойлгоход төвөгтэй үг хэллэг тус хуулийн төсөлд байхгүй байна
13.1.6. хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх	хүч оруулсан нэр томъёог хуулийн төсөлд хэрэглээгүй
13.1.7. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	жинхэнэ нэрэнд олон тооны нөхцөл залгаж хэрэглэсэн тохиолдолд хуулийн төсөлд байхгүй байна

"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хуульд заасан шаардлагыг "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2008)" бүтцийн хувьд бүрэн хангажээ. Зарим төрлийн нийгмийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн төсөл хэр оновчтой зөв болсон талаар тогтсон аргачлал байдаг. Тухайлбайл байгаль орчинтой холбоотой нийгмийн харилцааг зохицуулсан хуулиуд заавал агуулсан байх ёстой элементүүдийг Австралийн хуульч, эрдэмтэн Ян Ханнамын "Байгаль орчинд холбогдолтой Монголын хууль тогтоомжид хийсэн анхан шатны судалгаа" сэдэвт бүтээлдээ тодорхойлжээ. Үүнээс зарим элементийг хасан бидний авч үзэж байгаа "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-д хамааралтай байх ёстой гэж үзсэн 12 элементийг сонгон авч анализ хийснийг дараах хүснэгтээс тодруулан харъя.



Хүснэгт №6

Хуульд зайлшгүй байх ёстой элемент[9]	**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (1993)**		**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл-Шинэчилсэн найруулга (2008)**	
1. Ерөнхий зорилго	байгаа	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	байгаа	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
2. Хууль тогтоомж	байгаа	2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ	байгаа	2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ
3. Нэр томъёоны тодорхойлолт	байгаа	22 дугаар зүйл. Монгол Улсад зорчигч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн	байгаа	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4. Хариуцлагын тогтолцоо	байгаа	9 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийг хүндэтгэх, хууль тогтоомжийг сахин биелүүлэх 31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	байгаа	Аравдугаар бүлэг. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
5. Институцийн асуудал	байгаа	7 дугаар зүйл. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх байгууллага	байгаа	Наймдугаар бүлэг. Цагаачлалын байгууллага
6. Бодлогын асуудал	байгаа	8 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим 10 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх, үүргийн онцлог 24 дүгээр зүйл. Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц	байгаа	6 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим 7 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх, үүрэг 8 дугаар зүйл. Гадаадын иргэнд хориглох үйл ажиллагаа 27 дугаар зүйл. Монгол Улсад хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдийн тоо, бүтэц
7. Боловсролын асуудал	байхгүй		байхгүй	Монгол Улсад цагаачлахаар ирсэн гадаад хүн, түүний үр хүүхэд Монгол Улсад боловсрол эзэмших талаарх асуудлыг дурьдаагүй

8. Судалгаа, шинжилгээ	байхгүй		байхгүй	Монгол Улсад байгаа гадаадын иргэдийн эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийх, хууль тогтоомж зөрчигдийн талаарх судалгаа шинжилгээ асуудлыг хэн хариуцах талаар дурдаагүй байна.
9. Олон нийтийн оролцоо	байгаа	29 дүгээр зүйл. Гадаадын иргэнийг урих, ажиллуулах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хүлээх үүрэг	байгаа	Гуравдугаар бүлэг. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний оролцоо
10. Санхүүжилт	байхгүй		байгаа	48 дугаар зүйл. Цагаачлалын байгууллагын санхүүжилт
11. Бүрэн төгс байдал & хүчин төгөлдөр болох асуудал	байгаа	32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох	байгаа	65 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох
12. Маргаан шийдвэрлэх асуудал	байхгүй		байхгүй	Цагаачлалын асуудлаарх маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүй байна.
БҮГД	Байгаа элемент- 8 , байхгүй элемент- 4		Байгаа элемент - 9, байхгүй элемент - 3	

Дээрх хүснэгтээс үзвэл хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиас илт ялгараагүй зарим зохицуулах зайлшгүй шаардлагатай асуудлыг агуулаагүй байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсын хилээр орж гарч байгаа гадаадын иргэдийн хөдөлгөөнийг судлах, гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг хэрхэн өөрчлөх, сайжруулах, дордуулахгүй байх арга хэмжээ авахад шаардагдах судалгаа хийх асуудлыг хуулиар зохицуулж өгөх, түүнтэй холбогдон гарах санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөх, мөн цагаач иргэдийн болон тэдний үр хүүхдийн боловсролын асуудлыг хэрхэн зохицуулж байгааг тодруулах, өөр хуульд заасан бол эшлэх асуудлыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

III. ПРАКТИК СУДАЛГАА

А. Гадаадын иргэдийн бүртгэлийн асуудал

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 1993 онд батлагдсанаас хойш 1999 онд гадаадын иргэдийг бүртгэх чиг үүрэг Цагдаагийн байгууллагаас иргэний бүртгэлд шилжихтэй холбогдсон асуудлаар, 2000 онд гадаадын иргэдийн бүртгэл, хяналт тавих чиг үүрэг Гадаадын иргэн,

харьяатын асуудал эрхлэх албанд шилжихтэй холбогдсон асуудлаар, 2001 онд 30 хүртэл хоногоор зорчигч гадаадын иргэдийг бүртгэлд хамруулахгүй болох зэрэг асуудлаар нийтдээ 5 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Монгол Улсад төрийн болон засаг захиргааны нэгж, хот тосгоны өөрөө удирдах байгууллагын урилгаар ирсэн болон "зорчигч"-оос бусад гадаадын иргэн ирсэн өдрөөсөө хойш 10 хоногийн дотор нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, орон нутагт Цагдаагийн газар, хэлтэст бүртгүүлнэ. Монгол Улсад иж үйл ажиллагаагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж компанид ажиллахаар ирсэн гадаадын иргэнийг зөвшөөрөл олгосон байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд 10 хоногийн дотор бүртгэнэ. Монгол Улсад түр оршин суух гадаадын иргэнийг хүлээн авсан, урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тус тус түүнийг ирснээс хойш долоо хоногийн дотор Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд бүртгүүлэн, буцахаас нь өмнө бүртгэлээс хасуулна.[212]

Гэвч бодит байдал дээр бүртгэл хийж буй байгууллагуудын ажлын уялдаа холбоо муутайгаас гадаадын иргэдэд хүндрэл бэрхшээл тулгардаг байсан. Тухайлбал, Улаанбаатар хотод тодорхой хугацаанд оршин сууж байгаад орон нутагт очиход орон нутгийн цагдаагийн хэлтэст дахин бүртгүүлэх шаардлагатай тулгардаг[213] гэх мэтийг дурдаж болно. 2007 оны байдлаар Гадаадын иргэн харьяатын албанаас захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэдийн тоог гаргасан байна. Үүнийг дараах зургаас үзье.

Зураг №1



Хүснэгт № 7

ГИХАЭА-аас захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэд

Зөрчлийн төрөл	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
Оршин суух журам зөрчсөн	48	38	30		31	52			71	89			359

[212]Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн Монгол улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах журам. 2003 оны 7 дугаар сарын 7-ний өдөр. 168 дугаар тогтоол

[213]2006 оны 6 сарын 2-нд монгол улсад энх тайвны корпусын шугамаар сайн дурын ажилтаны статустай 2 жилийн ажиллах гэрээтэй, АНУ-аас Ховд аймагт багшаар ажиллаж байгаа хатагтай Стэйсигийн гомдолтой танилцав. Гомдолыг бүртгэлийн байгууллагад биш, харин Монгол дахь Энхтайвны корпусын төвд хандан гаргасан байсан.

Дамжин өнгөрөх журам зөрчсөн					2	1			4	4			11
Бүртгэлийн журам зөрчсөн	18	20	9		27	38			81	84			277
Хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн	34	9	4		81	94			160	318			700
Визийн хугацаа хэтэрсэн	254	220	65		95	179			332	463			1608
Нуун далдалсан, орон байраар хангасан													
Зөвшөөрөл олгох журам зөрчсөн	5	33	1						4	1			44
БОС үнэмлэх үрэгдүүлсэн													
Нийт	359	320	109	0	236	364	377	374	652	959			3750

Түүнчлэн гадаадын иргэнийг урьсан дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдөө хууль зөрчиж хуулийн хугацаанд гадаадын иргэдийг бүртгүүлэх үүргээ гүйцэтгэхгүй байна.[213] Иймд хуульд заасны дагуу хууль зөрчигчдөд захиргааны арга хэмжээ авдаг байна. 2007 оны байдлаар Гадаадын иргэн харьяатын албанаас захиргааны арга хэмжээ авагдсан аж ахуйн нэгж, уригч иргэдийн тоог гаргасан байна. Үүнийг дараах зургаас үзье.

Зураг №2



Хүснэгт № 8

ГИХАЭА-аас захиргааны арга хэмжээ авагдсан ААН, уригч иргэн

Зөрчил гаргагч	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
А А Н байгууллага	34	22	14	0	33	38	48	77	84	90			440
Уригч иргэн	6	2	1	0	1	1	1	0	1	0			13
Нийт	40	24	15	0	34	39	49	77	85	90			453

[214]Гадаадын иргэн, харьяатын албанд гаргасан өргөдөл, хүсэлтээс авав.

Хуулийн төслийн зургадугаар бүлэгт гадаадын иргэний бүртгэл, Монгол Улсад хувийн хэргээр болон байнга оршин суух, цагаачлах гадаадын иргэдийн тоо, бүтцийн тухай, мөн гадаадын иргэн Монгол Улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх журам, гадаадын иргэнд үнэмлэх олгох, түүний мэдээллийн сан бүрдүүлэх талаархи зохицуулалтыг тусгажээ. Хуулийн төслийн дагуу гадаадын иргэний бүртгэлийг үндсэндээ засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд хийж, улмаар дээд шатны байгууллагад бүртгэлийг хүргүүлэхээр болсон байна. Тодруулбал сум, хорооны засаг дарга нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэлийг хөтлөх[215] бөгөөд аймаг, дүүргийн засаг дарга харьяалах сум, хороонд оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэлийн мэдээг цагаачлалын байгууллагад нэгтгэн гарган өгөх[216] бүрэн эрхтэй болсон.

Хэрэв гадаадын иргэн Монгол Улсад оршин суух хаягийн бүртгэл хийлгээгүй бол 30000 төгрөгөөр торгохоор[217] одоогийн хуульд тусгасан байсан бол 100000-150000 төгрөгөөр, Гадаадын иргэнийг Монгол Улсад тодорхой хугацаагаар урьсан, байгууллага, аж ахуйн нэгж нь түүнийг хууль тогтоомжийн дагуу зохих байгууллагад бүртгүүлэхгүй бол 600000-1000000[218] төгрөгөөр торгох шийтгэл ногдуулахаар хуулийн төсөлд тусгасан байна. Торгуулийн хэмжээний өсөлт нь цаг үеийн нөхцөл байдал, эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой бөгөөд хууль зөрчсөн гадаадын иргэдийн хувьд эдийн засгийн дарамт учруулахуйц байж чадахаар хэмжээ болно. Гадаадын иргэдийн бүртгэлийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, орон нутагт Цагдаагийн газар, хэлтэст бүртгүүлэх байсныг тухайн сум, хорооны засаг дарга бүртгэхээр болсон нь олон улсын жишигт нийцсэн бүртгүүлэхээр очиж буй гадаадын иргэнд хүндрэл багатай байх болно. Гадаадын иргэнтэй гэрлэх холимог гэрлэлтийн тоо өссөнөөр Монгол Улсад оршин суух гадаад иргэдийн тоо нэмэгдэж байна. 1993 оны "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль", түүнд орсон 2000 оны 12 дугаар сарын 7-ны хуулийн өөрчлөлтөөр "Гадаадын иргэдийн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, аймагт аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба эрхлэн явуулж, холбогдох мэдээллийг тухай бүр Албанд ирүүлж[219]" байхаар болсон. Харин хуулийн төсөлд гадаадын иргэний гэр бүлийн бүртгэл хийх субъект өөрчлөгдөөгүй бөгөөд холбогдох мэдээллийг тухай бүр цагаачлалын байгууллагад[220] ирүүлж байхаар болсон.

[215] Хуулийн төслийн 14 дүгээр зүйл, 14.1.1 хэсэг
[216] Хуулийн төслийн 13 дугаар зүйл, 13.1.1 хэсэг
[217] Хуулийн төслийн 62 дугаар зүйл, 62.1 хэсэг
[218] Хуулийн төслийн 58 дугаар зүйл, 58.1 хэсэг
[219] 1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11[1] дүгээр зүйл
[220] Хуулийн төслийн 25 дугаар зүйл, 25.1 хэсэг

I. ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРГИЙН ОНЦЛОГ, ҮНДСЭН ЗАРЧИМ

Гадаадын иргэдийн эрх зүй нь тухайн улсын иргэн бус этгээдийн эрх үүргийг тодорхойлсон онцгой журам, эрх зүйн зохицуулалтыг шаарддаг. Өөрөөр хэлбэл оршин суух зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах зэрэг тэдгээрийн эрхийг хязгаарласан хэм хэмжээний нийлбэр цогц юм.[221]

Гадаадын иргэд болон харьяалалгүй хүн амьдарч буй улсынхаа иргэний адил эрх зүйн чадвартай байна. Энэ нь олон улсын хэмжээнд тогтсон зарчим. Хууль тогтоомжид тусгагдсан үндэсний дэглэм нь гадаадын иргэдийн иргэний эрх зүйн чадварын хувьд ямар нэгэн болзол агуулаагүй шинж чанартай, өөрөөр хэлбэл, тодорхой нөхцөлд гадаадын иргэнд харилцан адил байх шаардлага тавихгүйгээр үндэсний дэглэм олгогдоно. Уг зарчмаас төрөл бүрийн харилцаан дахь гадаадын иргэдийн эрхийг зохицуулдаг бусад хууль тогтоомж үндэслэн гардаг. Гадаадын иргэдийн хувьд зарим эрх эдлэхийг хуулиар хориглодог. Тухайлбал хуулийн төслийн 8 дугаар зүйлд энэ талаар зохицуулсан байна.

Аливаа улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө тэр тусмаа газар өмчлөх эрхийг нь хязгаарладаг. Зарим улс оронд гадаадын иргэн газар худалдаж авахын тулд төв болон орон нутгийн засаг захиргаанаас тодорхой зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Канадын зарим мужид гадаадын иргэдийн газар худалдаж авах эрхийг хязгаарладаг (Жишээ нь, Альберте мужид гадаадын иргэд болон гадаадын хяналттай компани газар худалдан авах ба эзэмших эрхгүй байдаг, Саскачеван мужид гадаадын иргэдэд худалдах хөдөө аж ахуйн газрын хэмжээг хязгаарладаг, г.м). Кипрт гадаадын иргэн нь Сайд нарын Зөвлөлийн зөвшөөрлөөр газар түрээсэлж болдог боловч газрыг 99 жилээр л худалдаж авч болдог. Финлянд улсад гадаадын компани болон компанийн салбар хэрвээ түүний акцийн 20% (зарим тохиолдолд 40%) гадаадын иргэн эзэмшдэг бол Төрийн Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр хоёр жилээс илүү хугацаагаар газар худалдан авах ба худалдах эрхгүй байдаг. АНУ-ын дийлэнх мужийн хуулиудын үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгө тэр тусмаа газар худалдан авах гадаадын иргэдийн эрхийг хязгаарладаг.

II. ГАДААДЫН ИРГЭН, ЦАГААЧЛАЛЫН ТАЛААРХ БОДЛОГО

Цагаачлалын бодлого нь улс гүрнүүд хүн амаа өсгөх бодлогын нэг хэсэгт тооцогддог. Цагаачлал, түүний дотор хөдөлмөр эрхлэх цагаачлалын хязгаарлалт тогтоосон цагаачлалын бодлого явуулдаг.[222] Цөөн хүн амтай, эдийн засгийн буурай хөгжилтэй, санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал манай улсын хувьд цагаачлал, дүрвэгсдийн асуудалд хандахдаа үндэсний

[221] М.М.Богуславский, Олон улсын хувийн эрх зүй, УБ, 2008 он, хуу 101

[222] Хууль дээдлэх ёс, 2006№1(12), О.Пунцагдаш "Дэлхийн улс гүрнүүдийн хүн ам зүйн бодлого", хуу 87-88

аюулгүй байдлын эрх ашгийг эш үндэс болгон туйлын болгомжтой хандах учиртай.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 1 хувь, үүний дотор нэг улсын иргэн О, 33 хувь хүртэл байж болно[223]" гэж заажээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын О,8 хувиас доош байгаа нөхцөлд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тус улсад оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суух цагаачийн тоог улс орноор нь бүрэн эрхийнхээ хугацаанд нэг удаа, О,8 хувиас дээш гарсан нөхцөлд жил тутам тогтоодог.[224]

Албан ёсны мэдээгээр гадаадын иргэдийн тоо үндэсний аюулгүй байдалд нөлөөлөөгүй байна.[225] Монгол улсын хүн амын тооллогын дүнгээс үзвэл 2007 онд Үндэсний статистикийн газрын гаргасан мэдээгээр Монгол улсын харьяат нийт 2,635,200 хүн байгаа судалгаа гарч байна. Өнөөдөр манай улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэдийн тоо 26352 үүний дотор нэг улсаас 8696-аас илүүгүй хүн байгаа тооцоо гарч байна. Өөрөөр хэлбэл 2008 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын харьяат хүн амын 0,091 хувьтай тэнцэж байна. 30 хоногийн хугацаанд жуулчны виззээр зорчигчид ГИХАЭА[226]-нд бүртгүүлдэггүй, хэрэв хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авахуулж нутаг буцдаг байна. Олноороо ирж буцдаг жуулчид оршин суугчдад хамаардаггүй. Монгол улсад цагаачлах иргэдийн тоо нэг жилд 100 байхаар УИХ-аас зөвшөөрсөн ч энэ тоонд хүрдэггүй өнгөрсөн жил гэхэд л гадаадын 26 иргэнд ГИХАЭА-наас цагаачлах зөвшөөрөл олгосон байна. Хуульд зааснаар "хувийн хэргээр Монгол улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг цагаач" гэнэ.

Өнгөрсөн жилийн хугацаанд ГИХАЭА-ныхан бичиг баримтын зөрчилтөй, ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй, 1058 гадаадын иргэнийг хил дээрээс буцааж, 2550 иргэнийг Монгол улсад эргэн орохыг тодорхой хугацаагаар хориглосон байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад Хятад иргэдийн тоо арваад мянгаар цөөрсөн байна.

Барилгын ажил ид эрхэлдэг энэ цагт хятадуудын тоо эрс өсдөг, одоогоор 17 мянга орчим хятад иргэн бүртгэгдсэн бол өнгөрсөн жилийн мөн үед 27 мянган хятад иргэн оршин сууж байсан тоо гарсан талаар ГИХАЭА-наас мэдээлж байна.

Гэтэл Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 3 хувь,

[223] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 он, 24 дүгээр зүйл

[224] Энэ зүйлийг дээрхи хуульд 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

[225] Хууль зүйн мэдээ сонин, 2008 он, Дугаар 12(126), 2 дахь тал

[226] Гадаад иргэн, харьяатын асуудал эрхлэх алба

үүний дотор нэг улсын иргэн 1 хувь хүртэл байж болно[227]" гэж заажээ. Харин Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 3 хувиас доош байгаа нөхцөлд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тус улсад оруулж болох хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо, бүтэц болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суух цагаачийн тоог улс орноор нь бүрэн эрхийнхээ хугацаанд нэг удаа, 2 хувиас дээш гарсан нөхцөлд жил тутам тогтооно гэж өөрчилжээ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоог нэмэгдүүлсэн бодлого баримталж байгаа нь харагдаж байна. Энэ зохицуулалтын цаана улс төрийн ямар зорилго агуулж байгаа нь тодорхойгүй байна. Хүн ам олонтой том гүрнүүдтэй хиллэдэг жижиг улсын хувьд Монгол Улс өөрийн гэсэн бодлогоо тодорхойлох нь чухал. Магадгүй эдийн засгийн учир шалтгаанаар ирж суурьшиж буй цагаачдын тоог нэмэгдүүлж байж болох юм.

Эдийн засгийн цагаачид[228] – Зөвхөн эдийн засгийн шалтгаанаар буюу материаллаг аж байдлаа дээшлүүлэх зорилгоор уугуул орноо орхин гарч байгаа хүмүүс. Эдийн засгийн цагаачид нь дүрвэгчийн эрх зүйн шалгуурт багтдаггүй, тийм учраас дүрвэгсэд мэт олон улсын хамгаалалт эдэлдэггүй. Эдийн засгийн цагаачид нь уугуул орноо зөвхөн эдийн засгийн учир шалтгаанаар материаллаг аж байдлаа сайжруулах зорилгоор орхин явж байгаа хүмүүс юм. Цагаачид эх орныхоо хамгаалалтыг эдэлдэг."[229]

НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр хуралдаанаар Цагаач-ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенц батлан гаргасан юм.[230] Уг конвенцид цагаачид, тэдний гэр бүлийн гишүүдийг эрх зүйн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх, тэд ямар ч үед аливаа улс, түүний дотор харьяалах нутаг дэвсгэрээс гарч явах, зорчин очих, тэдний амь нас хуулиар хамгаалагдах зэрэг өргөн эрх, эрх чөлөөг тодорхой зааж оруулсан.

2008 оны 1 дүгээр сард УИХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалтаас[231] үзэхэд Цагаачлалын олон улсын байгууллагын дүрэмд нэгдэж орох тухай асуудлыг эхний ээлжинд хэлэлцэхээр байсан. Түүнчлэн Монгол Улсын Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах 2008-2010 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлд "Цагаачлалын хөдөлгөөнд хүүхдүүд хэрхэн оролцож байгаа, тэдний амьдралын нөхцөл байдал ямар байгаа талаар хамтарсан судалгаа явуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд цагаач, харьяалалгүй болон хараа хяналтгүй зорчиж байгаа хүүхдийн талаар мэдээлэл, туршлага солилцох сүлжээнд нэгдэн, мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх" арга хэмжээ авна гэж заажээ.

[227] Хуулийн төслийн 27.1 хэсэг

[228] Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №2-2001, Дүрвэгсдийн асуудлаарх олон улсын эрх зүйн лавлах, УБ, 2007, хуудас 131

[229] Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №2-2001, Дүрвэгсдийн асуудлаарх олон улсын эрх зүйн лавлах, УБ, 2007, хуудас 40

[230] Монголын төр эрх зүй сэтгүүл, 2002/4, О.Пунцагдаш "Цагаачдын эрх зүйн байдал", хуудас 10

[231] http://www.pmis.gov.mn/cabinet/Document/plan01%20month1.doc

III. ГАДААДЫН ИРГЭДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН БАЙГУУЛАГУУДЫН ДОТООД УЯЛДАА ХОЛБОО

Гадаадын иргэнд виз олгох талаарх эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох үүднээс энгийн зэргийн виз олгох асуудлыг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн цагаачлалын байгууллагад хариуцуулах, дипломат төлөөлөгчийн газраас болон өргөмжит консулаас энгийн зэргийн виз олгохдоо Монголд байгаа уригчийн баталгаа, тодорхой тохиолдолд барьцааг үндэслэн цагаачлалын байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн олгож байхаар хуулийн төсөлд тусгасан байна.

Мөн захиргааны хариуцлага ногдуулах эрхийг хэт олон субьектэд давхардуулан олгосноор нэг талаас хяналт давхардах буюу зөрчил гаргагч олон дахин торгууль төлөх, хоёр өөр хуульд нэг төрлийн зөрчилд өөр өөр санкц тогтоосон байдал нь хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагуудын хооронд үл ойлголцох байдлыг бий болгож, хууль хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа тул гадаадын иргэний эрх зүйн байдлын талаарх хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагын хэм хэмжээг нарийвчлан тогтоож өгсөн байна.

Б. Цагаачлалын байгууллагын тогтолцоо

Цагаачлалын байгууллага нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, гадаадын иргэний хуулиар олгогдсон халдашгүй эрхийг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах, гадаадын иргэний виз, бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоотой, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална. Шинээр байгуулах гэж байгаа цагаачлалын байгууллагыг байгуулахад гарах хөрөнгө, санхүүгийн асуудлыг хуулийн төслийн хамтаар УИХ-д өргөн барих нь илүү цогц бөгөөд хэрэгжихүйц арга хэмжээ байх болно гэж үзэж байна.

Цагаачлалын байгууллагын бүрэн эрх[232]

- цагаачлалын асуудлаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- цагаачлалын асуудлаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- цагаачлалын талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Монгол Улсад оруулж болох хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тоог оршин суух засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон харьяалах улс орноор нь тогтоох талаар санал оруулах;
- цагаачлалын асуудлаар Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг мэдээлэл болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- байгууллагын хэмжээнд мөрдөх дүрэм, заавар, журмыг Монгол Улсын хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн батлан мөрдүүлэх;
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын

[232] Хуулийн төслийн 50 дугаар зүйл

виз, иргэний харьяаллын асуудал хариуцсан консулын ажилтныг томилох, чөлөөлөхөд санал өгөх;
- Монгол Улсын энгийн зэргийн виз олгох, олгохоос татгалзах, ангиллыг өөрчлөх, хугацааг нь сунгах, богиносгох, хүчингүй болгох;
- гадаадын иргэнийг бүртгэх, Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хугацааг сунгах, хүчингүй болгох;
- Монгол Улсад оршин суух гадаадын иргэнд үнэмлэх олгох;
- уригч барьцаа гаргах, буцаан олгох, барьцааны гэрээний шаардлагыг хангуулах журмыг батлах;
- цагаачлалын байгууллагын ажилтны хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах;
- гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх;
- гадаадын иргэнийг түр саатуулах;
- Монгол Улсаас гадаадын иргэнийг албадан гаргах;
- хуулийн 15.1.2 дахь хэсэгт заасан барьцаанаас чөлөөлөх улсын жагсаалтыг батлав.
- гадаадын иргэний талаарх мэдээллийн улсын нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх.

Хуулийн төслийн үзэл баримтлаасс үзэхэд шинээр байгуулах гэж байгаа Цагаачлалын байгууллага нь засгийн газрын агентлагийн статустай байхаар санал болгосон байна. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаагаа Засгийн газрын тухайн асуудал хариуцсан чиглэлийн яамд тайлагнаж байхаар асуудлыг зохицуулжээ.

Гадаадын бусад оронд цагаачлалын асуудал хариуцсан ямар ямар байгууллага байдаг, тэдний эрх үүргийн талаар товч авч үзье. Гол төлөөлөл болгон АНУ-ыг сонгон авлаа. Учир нь цагаачлалын талаар идэвхитэй бодлого баримталдаг томоохон улсын нэг нь АНУ юм.

АНУ-ын цагаачлалын албаны удирдлага, зохион байгуулалт

АНУ-ын хувьд цагаачлалын асуудлаар хэд хэдэн хууль баталж байснаас хамгийн сүүлд баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гол хууль нь 1952 онд баталж хожим нь хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан Цагаачлалын болон харьяатын тухай хууль юм. Энэ нь "Immigration and nationality Act of 1952" болно. АНУ-ын цагаачлалын албаны удирдлага, зохион байгуулалтад чухал нөлөө бүхий өөр нэг хууль бол 2002 оны эхээр Дотоодын аюулгүй байдлын тухай хууль Homeland Security Act of 2002. Энэ хуулиар цагаачлалын асуудал эрхэлдэг 22 байгууллага шинээр байгуулагдсан. Дотоодыг хамгаалах департаментад харьяалуулаад цагаачлалын үйл ажиллагаатай холбоотой байгууллагуудын эрх, үүргийг зааглан тодорхойлж, бүтцийг баталж өгснөөрөө цагаачлалын эрх зүйн олон асуудлыг зохицуулсан.

Цагаачлалын асуудлаар улс орон даяар заавал дагаж мөрдөх эрхийн акт батлан гаргах эрхийг АНУ-ын Төрийн, Дотоодын Аюулгүй байдлын, Хууль зүйн, Хөдөлмөрийн болон эрх бүхий бусад департмент (яам), агентлагууд эдэлдэг.

Төрийн департмент (Department of state) - Америкийн гадаад явдлын яам. Хилийн чанадад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газрааралаа дамжуулан АНУ-д ирэх нутаг дэвсгэр дээр түр буюу байнга оршин суухыг хүссэн гадаадын хүмүүсийн асуудлыг хариуцан шийдвэрлэдэг.

Хилийн чанадад суугаа элчин сайдын яам, консулын газар гадаадын хүмүүст цагаачлалын болон цагаачлалын бус виз олгодог. Америкийн хуулиар виз олгох асуудлаар эцсийн шийдвэр гаргах талаар консул суугаа газартаа асар их эрх мэдэлтэй бөгөөд аливаа асуудлыг үзэмжээрээ шийдвэрлэх өрөн боломжтой. Тус департментын Консулын харилцааны товчоо нь визийн бодлого боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх замаар АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдал, хил хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Дотоодын аюулгүй байдлын департмент (Department of Homeland Security) – Тус байгууллага нь 2002 оны 1 дүгээр сард батлагдсан Дотоодын аюулгүй байдлын тухай хуулиар байгуулагдсан. Энэ департментын харьяанд цагаачлалын эрхзүйг хэрэгжүүлэх, хууль сахиулахад оролцдог 22 байгууллага шилжсэн бөгөөд шилжиж ирсэн эдгээр байгууллагууд хуучин гүйцэтгэж байсан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэхийн зэрэгцээ дээр дурдсан хуульд тусгагдсан олон шинэ үүрэг гүйцэтгэх болсон.

АНУ-ын харьяатын болон цагаачлалын алба (US Citizenship and Immigration Services) – Урд нь Хууль зүйн департаментын харьяанд байсан Цагаачлалын болон Харьяатын албыг өөрчлөн байгуулж улс орны аюулгүй байдлыг ханган үүднээс Дотоодын аюулгүй байдлын департаментын харъяанд шилжүүлэн шинэчлэн байгуулсан. Тус байгууллагын үндсэн үүрэг нь цагаачлалын эрх зүйг бүхэлд нь сахиулах, хууль бус цагаачлалыг зогсоох, хууль ёсны цагаачлалд тусламж дэмжлэг үзүүлэх явдал юм. Мөн цагаачлалын үйлчилгээ эрхлэх, гэр бүлийн хэлхээ холбооны үндсэн дээр болон ажил эрхлэхтэй холбогдсон цагаачлалын өргөдлийг шийдвэрлэх, ажил эрхлэх зөвшөөрөл олгох, орогнол хүсэгчид, дүрвэгсдийн баримт бүрдүүлэх, харьяат болгох болон тусгай эрх олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцна. АНУ-д нэгэнт ирчихээд байгаа гадаадын хүний АНУ-д байнга оршин суух эрх авах өргөдлийг авч хэлэлцэж, шийдвэрлэх асуудал тус байгууллагын үндсэн үүргийн нэг.

Цагаачлалын болон гаалийн хууль сахиулах агентлаг (US Immigration and Customs Enforcement) - Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэнийг хорьж саатуулах, албадан гаргах, контрабандын болон гадаадын хүмүүсийг худалдаалахтай холбогдсон үйлажиллагаагзогсоох, цагаачлалын давуу байдлыг бууруулах, хуурамч баримт бичиг ашиглах ажиллагааг мөрдөн шалгах, гүйцэтгэх ажил эрхлэх зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

Гаалийн болон хил хамгаалах агентлаг (US Customs and Border Protection) - Харьяатын болон цагаачлалын албаны байцаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Тодруулбал хууль сахиулах зорилгор цагаачдыг мөрдөн байцаах үүрэгтэй.

Харьяатын болон цагаачлалын албаны омбудсман - гол төлөв цагаачлалын эрх зүйн асуудлаар хэрэглэгчдэд үйлчлэхтэй холбогдсон асуудлыг хариуцаж, Харьяатын болон цагаачлалын албанаас асуудал шийдвэрлүүлэхэд хувь хүмүүс болон ажиллагчдын зүгээс Харьяатын болон цагаачлалын албаны үйл ажиллагаатай холбоотой хүндрэлтэй асуудлын хүрээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд тодорхойлсон хүрээнд багтаж байгаа хүндрэлтэй асуудлыг багасгахын тулд Харьяатын болон цагаачлалын албаны захиргааны үйл ажиллагааг өөрчлөх санал хүлээнэ.

Хөдөлмөрийн департмент (Department of Labor) – Үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэх үндэслэлээр АНУ-д ирэх, байнга оршин суух цагаачлалын болон цагаачлалын бус виз хүссэн өргөдлийг авч үзнэ. Мөн хөдөлмөр эрхлэх үндэслэлээр цагаачлах өргөдлийн ихэнхийг тус департмент шийдвэрлэх ёстой. Тус департментээс АНУ-д дутагдаж байгаа мэргэжлийн жагсаалт, Америкийн хөдөлмөрийн зах зээл дээр илүүдэж байгаа жагсаалтыг гаргаж хөдөлмөр эрхлэхтэй холбогдсон цагаачлалын өргөдлийг хянахдаа энэхүү жагсаалтыг гол үзүүлэлтээ болгодог.

Манай Улсын хувьд ийм жагсаалт байдаг эсэх нь тодорхойгүй. Гадаадаас ажиллах хүч авахдаа дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах талаар бодитой арга хэмжээ авдаггүй. Барилгын салбарт гадаадаас тэр дундаа урд хөршөөс ажиллах хүч авч байгаа өнөөгийн дүр төрх ямар байгааг хүн бүр мэднэ.

Нэг жишээ дурдахад: Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 125 дугаар тогтоолоор "бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу… нэр бүхий компаниудад[233] гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл олгосон бөгөөд зарим нэг ажилтныг[234] бүр ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна." Энэ тогтоолын дагуу бол 5640 ажлын байрыг гадаадаас авсан

[233] Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх "Голден Сий Петролиум" ХХК-ийн 510, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 1810, "Доншен" ХХК-ийн 570, Ховд аймгийн Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх БНХАУ-ын "Чи тай зам гүүрийн компани"-ийн 191, "40.000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэх "Мавангуй" Нөхөрлөлийн 100, "Хуанлу Хуантун" ХХК-ийн 350, "Их үйлсийн эрэлд" ХХК-ийн 800, "Богда холдинг" ХХК-ийн 300, "Гандирс" ХХК-ийн 450, "Вилмар" ХХК-ийн 250, "Шилмэл шилтгээн" ХХК-ийн 100, "Стар Эстэйтс" ХХК-ийн 400, "Гангар" ХХК-ийн 350, "Зүн Гуо Жизнь Жү Монгол" ХХК-ийн 450, "Номин конструкшн" ХХК-ийн 100, "Манс-Арт" ХХК-ийн 150, "МҮХ" ХХК-ийн 260, "Заг" ХХК-ийн 109 инженер техникийн болон мэргэжлийн ажилтанд 2008 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэлд даалгасугай.

[234] "Голден Сий Петролиум" ХХК-ийн 510, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 1810, "Доншен" ХХК-ийн 570, "Чи тай зам гүүрийн компани"-ийн 191, "Их үйлсийн эрэлд" ХХК-ийн 800, "Богда холдинг" ХХК-ийн 300, "Гандирс" ХХК-ийн 450, "Манс-Арт" ХХК-ийн 150, "Заг" ХХК-ийн 109 ажилтныг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй

гэх ажиллах хүчин эзэлсэн байна. Ажил хайж байгаа, ажилгүй гэх монгол хүмүүст энэ ажлын байр хүртээлгүй байх ёсгүй.

Визийн үндэсний төв (National Visa Center) – Төрийн департменттай гэрээтэй ажилладаг бөгөөд хувийн компанийн удирдлагаар тусгай үүрэг гүйцэтгэдэг. Гадаад улсад суугаа консулын газрууд болон Харьяатын болон цагаачлалын агентлагийн цагаачлалын визийн бүрдүүлэлт хийх ажлыг зохицуулдаг.

* Энэ нь төр өөрийн зарим үүргийг хувийн байгууллагад гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байгаа хэлбэр юм. Манай улсын хувьд энэ төрлийн эрх зүйн зохицуулалт байдаг боловч хөрөнгө санхүүгийн асуудалтай холбоотойгоор бодит байдал дээр огт хэрэгжиж байгаагүй.

Хууль зүйн департмент (Department of Justice) - тус департаментын харьяанд цагаачлалын асуудалд хяналт тавих газар нэртэй гүйцэтгэх байгууллага ажилладаг. Цагаачлалын асуудлаар давж заалдах асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг шалгах зааварлах, цагаачлалын хуульчдын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Тодруулбал цагаачлалын шүүхээс гаргасан шийдвэрийн талаар гаргасан гомдлыг хянан хэлэлцдэг захиргааны байгууллага юм. Учир нь АНУ-ын Үндсэн хуулийн дагуу Цагаачлалын асуудлаар хяналт тавих газар нь шүүхийн бус захиргааны байгууллага байхаар заасан байдаг.

Цагаачлалын асуудлаар өргөдөл гаргасан гадаадын иргэний асуудлыг ямар байгууллага яаж шийдвэрлэх асуудлыг тус хуулийн төсөлд огт тусгаагүй байна. Өнөөдрийн байдлаар иргэний харьяаллын болон Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах асуудлаар гаргасан албан бичиг, өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх журмыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны баримт бичгийн эргэлт, түүнд тавих дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 9 дэх хэсэгт заасан байдаг.

Холбооны мөрдөх товчоо (Federal Bureau of Investigation) - тус товчооны Гэмт хэргийн мэдээллийн үндэсний төвийн мэдээллийн санд 16-аас дээш насны цагаач хүн бүрийн нэр, хуруувы хээ, дижитал зургийг агуулдаг. Энэ нь цагаачлалын асуудлаар олон давхар хяналтын тогтолцоог бүрдүүлж байгаа нэг хэлбэр бөгөөд цагаачлалын бодлогыг хэрэгжүүлэхэд оролцож буй онцгой хэлбэр юм.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн 38 дугаар зүйлд гадаадын иргэдээс хуруувы хээ авах тохиолдлуудыг заасан байна. Үүнд:

- Монгол Улсад 6 сараас дээш хугацаагаар оршин суух албан болон хувийн хэргээр оршин суугч;
- Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөний улмаас холбогдох байгууллагад шалгагдаж байгаа;
- хэн болох нь тогтоогдохгүй байгаа;
- энэ хуульд заасан журмын дагуу Монгол Улсаас албадан гаргагдаж байгаа;

– Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үүднээс цагаачлалын байгууллага хурууны хээ нь шаардлагатай гэж үзсэн гадаадын иргэдийн хурууны хээг авна.

Хурууны хээний талаарх ямар мэдээллийн санд байрлуулах, ямар тохиолдолд ашиглах талаар ямар нэг зохицуулалт алга байна.

В. Виз олгох асуудал

i. Визийн журам

1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд "виз" гэсэн нэр томъёог тодорхойлоогүй харин хуулийн төсөлд 'виз'' гэж гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрэх зориулалт бүхий олгосон хэвлэмэл хуудсыг[235] хэлнэ гэж тодорхойлжээ. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 75 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол улсын виз олгох журам"-ыг батлсан. Монгол Улсын виз гэж тус улсын эрх бүхий байгууллагаас гадаадын иргэн, харьяалалгүй хүнд олгосон Монгол Улсын хилээр нэвтрэх зөвшөөрлийг хэлнэ. Виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй, "орох", "орох-гарах", "гарах", "гарах-орох", "дамжин өнгөрөх" зориулалттай, нэг, хоёр, олон удаагийн гэсэн ялгаатай, тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын хилээр нэвтрэх зорилгыг заасан ангилалтай, үйлчилж эхлэх хүртэл хүчинтэй байх болон үйлчлэх хугацаатай байдаг.

Монгол Улсын виз нь "D", "A", "OU", "T", "НМ", "O", "B", "S", "J", "HG", "SH", "TS", "H" гэсэн ангилалтай. Визийн нөхцөл хоёр улсын хоорондын харилцааны байдлаас шалтгаалан өөр өөр байдаг. Виз авахаас бүрэн хэмжээгээр болон тодорхой нөхцөлөөр хэсэгчлэн чөлөөлөх талаар улс орнууд янз янзаар тохирдог. Бүх төрлийн паспорттай Монгол Улсын иргэд визгүй зорчих хэлэлцээрийг 19 улстай, зөвхөн дипломат, албан паспорттай иргэд визгүй зорчих хэлэлцээрийг 15 улстай байгуулсан, харин АНУ-тай олон удаагийн визтэй зорчих хэлэлцээртэй (Монгол Улсын хувьд гадаадын ямар улсуудтай ийм төрлийн хэлэлцээр хийсэн талаар Хавсралт В-ээс үзнэ үү). Визийн талаар, тухайлбал виз олгох байгууллагын бүрэн эрхийн талаар цагаачлалын хууль тогтоомжид тусган оруулж зохицуулдаг жишиг олон улсад байдаг. Тухайлбал 1976 оны Канадын "Цагаачлалын хууль"-д заасан байдаг. Тус хуульд "виз" гэж виз олгогч албан хаагчийн олгосон баримт бичиг эсвэл тодорхой бичиг баримтад дарсан тамга тэмдэгийн дардас[236] болно гэж заажээ. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд виз болон визийн зөвшөөрөлтэй холбоотой хэм хэмжээг тусгасан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн актаас "Монгол улсын виз олгох журам" буюу Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 75 дугаар тогтоолын хавсралтад визийн тодорхойлолтыг өгсөн байна. Өөрөөр хэлбэл хуулиар биш, засгийн газрын тогтоолын хавсралтаар уг тодорхойлолтыг өгчээ.

[235] Хуулийн төслийн 4.1.8 хэсэг

[236] 1976 оны Канадын "Цагаачлалын хууль"-ийн 2 дугаар зүйл "нэр томъёоны тайлбар" хэсгийг үзнэ үү.

Гэхдээ визийн журмыг хуульд зааж өгдөггүй. Гагцхүү виз гэж юу болох, ямар төрлийн виз байх, ямар визийг ямар эрх, үүрэгтэй байгууллага байгууллага олгохыг хуульд зааж өгдөг. Тухайлбал АНУ-ын Цагаачлалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн III дэд бүлэгт виз олгох асуудлыг тусгасан байдаг. (Хавсралт Б-ийн Хүснэгт №2-ыг үзнэ үү).

Визийн журамд процессын асуудлыг тусгадаг. Ер нь бол процессын асуудлыг хуулиар зохицуулах шаардлага байдаггүй. Харин хуульд процессын журмыг тусгахаас илүүтэй бодлогын шинжтэй асуудлыг тусгадаг. Олон хүчин зүйлээс шалтгаалж процессын асуудал өөрчлөгдөхөд хүрдэг. Процессын асуудлыг журмаар зохицуулах нь илүү оновчтой харин журам ямар бүтэцтэй юуг тусгасан байх ёстойг хуульчилж болно. Өөрөөр хэлбэл журмаар ямар харилцааг зохицуулахыг зааж өгдөггүй. Ингэж заасан тохиолдолд хууль зөрчих, улмаар хуулийн хариуцлага хүлээх болно. Түүнчлэн хуулинд процессын хугацаа зааж өгөх нь асуудлыг заасан хугацаандаа биелүүлж чадахгүй байх зэрэг шалтгаанаас хууль зөрчихөд хүрнэ.

Виз болон оршин суух эрх зүйн байдлын ялгаа

Виз нь түүний тодорхой ангилалыг эзэмшигчид зохих хэмжээний эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэдэг. Виз нь гагцхүү визийн хүчинтэй байх хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрт орох эрхээ нэн даруй хэрэгжүүлэх эрх олгодог. Визээр олгогдож байгаа энэ эрх зайлшгүй бус шинжтэй, өөрөөр хэлбэл визтэй хүнийг тухайн улсын нутаг дэвсгэрт оруулах эсэхийг улсын хил дээр шалгалт хийж байгаа цагаачлалын албаны байцаагч эцэслэн шийдвэрлэх эрхтэй. Ихэнх тохиолдолд Монголчууд визтэй л бол тухайн оронд шууд орно гэж ойлгодог нь буруу бөгөөд тухайн улсын хилийн шалган нэвтрүүлэх албанд шалгуулахдаа виз мэдүүлж, ярилцлагад ордогтой ижил. Тухайн улсын нутаг дэвсгэрт эрх эдлэх, үүрэг хүлээх боломж гагцхүү тухайн улсын хилээр нэвтэрсний дараа л бүрдэнэ. Визийн хүчинтэй байх хугацаа нь виз эзэмшигч тухайн улсын нутаг дэвсгэрт орж тэнд байж болохыг зөвшөөрсөн хугацаа юм. АНУ-ын хувьд хилийн шалган нэвтрүүлэх албаны байцаагч тухайн гадаадын иргэний визийг шалгаж үзээд холбогдох бичиг баримт, нотлох баримт, тухайн хүний мэдүүлэг зэргийг үнэлж дүгнэснийхээ дараа АНУ-д байх тодорхой хугацаа заасан баримт бичиг буюу А94 олгоно. Энд заасан хугацаанд тухайн визээр АНУ-д байхыг зөвшөөрнө.

ii. Виз олгох чиг үүрэг бүхий байгууллага

Хуулийн төслийн 16-20 дугаар зүйлд визтэй холбоотой зохицуулалт тусгагдсан байна. Тухайлбал виз олгох байгууллага, түүний чиг үүрэг, виз болон визийн зөвшөөрөл, визийн хугацаа, түүнийг сунгах асуудал зэрэг болно. 1993 оны "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлд виз олгох эрх бүхий байгууллагууд гэж:

1/гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

2/Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

3/гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар;

4/Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосноор Монгол Улсын өргөмжит консул[237]

Харин хуулийн төслийн 17 дугаар зүйлд виз олгох байгууллагууд гэж:

1. гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

2. цагаачлалын байгууллага;

3. гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар.

4. гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосноор Монгол Улсын өргөмжит консул.

Дээрхээс үзэхэд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны оронд цагаачлалын байгууллага виз олгохоор болжээ.

1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй харьцуулан үзэхэд бүхэлдээ цагаачлалын байгууллага гэсэн шинэ бүтцийг бий болгож Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны чиг үүргийг бүхэлд нь гүйцэтгэх олон улсын жишиг нийцсэн бүтэц, зохион байгуулалттай, гадаадын иргэн, цагаачлалын талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх, бусад төрийн байгууллагуудыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн статустай байгууллага байгуулах эрх зүйн үндэсийг гаргаж өгсөн байх юм[238].

Энэ нь Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлан гаргасан олон тооны хуулиудтай агуулгын хувьд ижил төстэй болсон санагдана. Тодруулбал, хэм хэмжээ тогтоосон материаллаг хууль байх ёстой атал тухайн асуудал хариуцсан ямар нэг төрийн байгууллагын статус, бүрэн эрх, бүтэц зохион байгуулалтыг зохицуулсан хэм хэмжээг эдгээр хууль агуулсан байдаг. Угтаа бол ийм төрлийн байгууллагуудын эрх зүйн үндсийг бие даасан хуулиар зохицуулбал илүү зохимжтой.

Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу Гадаад хэргийн яамны зөвшөөрлөөр 30 хүртэл хоногийн хугацаатай энгийн зэргийн визийг ямар үндэслэл шалгуураар олгох нь тодорхойгүй, визийг хязгаарлалтгүй, хүсэлт гаргагч бүрт олгох боломжтойгоос гадна хяналт тавих үүргийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хэрэгжүүлж байгаа нь гадаадын иргэнд нэгдсэн хяналт тавих боломжгүйд хүргэж байна.

Г. Шүүхийн практик

Шүүхийн прецедентийг эрх зүйн эх сурвалж болгон авч үздэг улс орны хувьд цагаачлалын эрх зүйн эх сурвалж хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн

[237] 1993 оны "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлт.

[238] Хуулийн төслийн 45 дугаар зүйл



шүүхийн шийдвэрийг тусгайлан эмхтгэн боть болгон хэвлэдэг практик олон улсын жишигт байдаг. Манай улсын хувьд шүүхийн шийдвэрийг эрх зүйн эх сурвалж хэмээн авч үздэггүй боловч судлаачид болон олон нийтийн хүртээл болгон цөөнгүй тооны шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг гаргасан байна.

Гадаадын иргэдийн эд хөрөнгийн, эд хөрөнгийн бус хувийн, гэр бүлийн, хөдөлмөрийн зэрэг эх зүйн харилцааг иргэний эрх зүйн нэг хэсэг болох олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг. Иргэний хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн эмхтгэлээс гадаадын иргэдийн эрх зүйн асуудалтай холбоотой шийдвэрийг хайсан боловч тэдний эрх, үүргийг зөрчсөн эсвэл эрх зүйн байдлыг нь илт зөрчсөн талаар хэрэг маргаан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр байсангүй. Харин гадаадын иргэдийн оролцсон хөдөлмөрийн эрх зүйн болон иргэний эрх зүйн дараах маргааныг шийдвэрлэсэн байсныг жишээ болгон авч үзье.

1. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол дугаар 14[239] (2003 оны 5 дугаар сарын 8-ны өдөр) - "Е" гэгч гадаадын иргэний нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай: "Т" ХХК нь ерөнхий эдийн засагч Е-г түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний "Монгол улсын нутаг дэвсгэр дээр мэргэжилтнээр ажиллаж буй гадаадын иргэдийн баримтлах дүрмийг бүдүүлгээр зөрчсөн"- гэсэн үндэслэлээр ажлаас нь халжээ. Анхан шатны шүүх "Т" ХХК Е-г ажлаас үндэслэлгүй халсан гэж дүгнэн нэхэмжлэгчийг ажилд нь эргүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин 3.008.000 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэснийг хариуцагч эс зөвшөөрөн аймгийн шүүхэд давж заалдсан байна. Аймгийн шүүхийн магадлалын тодорхойлох хэсэгт "…Ажил олгогч 2001 оны 4 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд Е-г ажиллуулан түүнээс хойш хөдөлмөрийн гэрээ сунгагдахгүй тохиолдолд захиргааны санаачлагаар ажлаас халах боломжтой болсон байна. Гэвч "Т" ХХК нь өөрийн гэрээг сунгах санал тавьсан хугацааны дотор буюу 2001 оны 3 дугаар сарын 1-нд Е-ийг ажлаас халжээ. Энэхүү тушаал нь хөдөлмөрийн хуулийн зүйл, заалт баримтлаагүй, тушаалд заасан үндэслэл нь хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй байна. Иймд нэгэнт хөдөлмөрийн гэрээг сунгах ажил олгогчийн санал тавьсан хугацаа 2001 оны 4 дүгээр сарын 1-ээр дууссан тул түүнийг ажилд эргүүлэн тогтоох боломжгүй" гэсэн дүгнэлт хийсэн атлаа магадлалын тогтоох хэсэгт энэ талаар шийдвэрлээгүй орхигдуулсан нь буруу болжээ. Иймд аймгийн шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэлтэй болж чадаагүй тул холбогдох хэргийг аймгийн шүүхийн давж заалдах шатны шүүхээр дахин хянан хэлэлцүүлэхээр гаргасан Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хүлээн авах үндэслэлтэй гэж үзсэн байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 177.1, 178 дугаар зүйлийн 178.1.5-д заасныг удирдлага болгон Орхон аймгийн шүүхийн 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 5 дугаар магадлалыг хүчингүй болгож, уг хэргийг Орхон аймгийн шүүхийн Иргэний давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр буцаахаар тогтоосон байна.

[239]Шүүхийн шийдвэрийн эмхтгэл (иргэний хэрэг) – боть 2, ху 368

2. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 607[240] (2004 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр) - "Н" нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай: Нэхэмжлэлийн шаардлага нь нотариатчийн ажиллагаагаар хууль бусад тооцож, үйлдлийг хүчингүй болгуулах тухай байх ба тус бүртээ холбогдох үйлдэл хийсэн нотариатч О, Б нарыг нэхэмжлэгч энэ хэрэгт хариуцагчаар татсан байна. Нотариатч О нь хуульч Д-д Сингапур Улсын иргэн А-аас олгосон итгэмжлэлийн хуулбарын үнэн зөв болохыг (хавтаст хэргийн 4, 5, 13 дахь хуудас), нотариатч Б нь энэхүү итгэмжлэлийн орчуулгын үнэн зөвийг (хавтаст хэргийн 4, 5, 17 дахь хуудас) тус тус гэрчилсэн байна.

Эдгээр үйлдлүүдээ хариуцагч нар Нотариатын тухай хуульд заасан журмын дагуу явуулсан байна.

Дээрх нотариатчид тухайн итгэмжлэлийн үнэн зөвийг гэрчлээгүй тул хэн алиныг нь Консулын харилцааны тухай Венийн Конвенц, Дипломат албаны тухай хууль, Нотариатын тухай хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй. Итгэмжлэлийг хүчингүй болгуулах асуудал эдгээр хариуцагч нарт хамааралгүй тул энэ талаар гаргасан нэхэмжлэгчийн гомдол үндэслэлгүй юм. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 178 дугаар зүйлийн 178.1.1-ийг удирдлага болгон Чингэлтэй дүүргийн шүүхийн 2004 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 857 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхихоор тогтоосон байна.

ДҮГНЭЛТ

Дээрх асуудлуудыг судалж үзсэний эцэст дараах дүгнэлтийг хийж байна.

1. Цагаачлалын эрх зүйн субьект нь гадаадын тодорхой улсын иргэдээс гадна хоёрдмол харьяалалтай болон харьяалалгүй хүмүүс байдаг учир "гадаадын иргэн" гэж нэрлэх нь учир дутагдалтай. Аливаа улсын цагаачлалын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа тухайн улсын иргэн бус аливаа хүнийг "гадаад хүн" гэдэг. Иймд тус хуулийн төслийн нэрийг "Гадаад хүний эрх зүйн байдал" эсвэл "Монгол Улсын иргэн биш этгээдийн эрх зүйн байдал" гэж нэрлэх саналтай байна.

2.Цагаачлалын тухай ярихад "цагаач" гэсэн нэр томьёог тодорхойлохгүйгээр уг субьектийн эрх зүйн байдлыг тогтоож чадахгүй. Иймд "цагаач" гэсэн нэр томьёог тус хуулийн төсөлд оруулах, нэр томьёог олон улсын эрх зүйн үүднээс тодорхойлох нь зүйтэй.

3. Гадаадын иргэдтэй холбоотой эрх зүйн харилцааны эх сурвалж нь дараах зорилтуудыг хангадаг гэж үздэг[241]. Үүнд:

– Мэргэжилтэй боловсон хүчний урсгалыг хангах

– Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, ажлын байр нэмэгдүүлэх

[240] Шүүхийн шийдвэрийн эмхтгэл (иргэний хэрэг) – боть 1, ху 322

[241] Г.Сэсээр, "АНУ- ын Цагаачлалын эрх зүйн зарим асуудал", Вашингтон хот, 2006 он, ху 89



– Тухайн улсын ажиллах хүчний зах зээлийг хамгаалах

– Хүмүүнлэгийн зорилтыг хангах

– Хүмүүнлэгийн болон улс төрийн зорилтыг шийдвэрлэх - улс төр, итгэл үнэмшил, үндэс угсаа, шашин шүтлэгийн шалтгаанаар мөрдөн мөшгилтөд өртөж байгаа болон дайны болон байгалийн гамшгийн улмаас төрөлх орондоо байх боломжгүй болсон хүмүүст байнгын болон түр орогнол олгохтой холбоотой

– Үндэстэн хоорондын тэнцвэрийг хангах

– "Тааламжгүй" этгээдийг оруулахад хязгаарлалт тогтоох

Эдгээр зорилтыг хуулийн төсөл бүрэн хангасан гэж үзэж байна.

4. Цагаачлалын эрх зүйн эх сурвалж нь шударга, үл ялгаварлах байдлаар хэрэгжих ёстой боловч улс төрийн болон бусад шалтгаанаар улс орон бүрийн хувьд өөр өөр жишиг, шаардлага тогтоосон заалт олон байдаг. Гадаадын иргэд амьдарч байгаа тухайн улсын иргэдийн адил эрх, эрх чөлөөг эдэлж, үүрэг хүлээнэ. Гэхдээ хуулиар хориглосноос бусад эрхээ тус улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж болно. Тодруулбал гадаадын иргэд өөрийн эрхээ хэрэгжүүлэхдээ тус улсын нийгмийн болон төрийн ашиг сонирхолд болон Монгол Улсын иргэдийн болон бусад этгээдүүдийн эрх, ашигт хохирол учруулах ёсгүй.

Иргэний харилцаанд оролцогчдын хувьд гадаадын иргэд бусдын адил тус улсын хууль тогтоомжийг болон өөрсдийн иргэний эрхээ хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмыг сахин биелүүлнэ гэсэн агуулгыг тус хуулийн төсөл бүрэн агуулсан байна.

5.Баримт бичиггүй гадаадын иргэдийн асуудлыг зайлшгүй шийдэх ёстой. Учир нь улс орны аюулгүй байдал, хил хамгаалалт, гадаадын иргэдийн бүртгэл, биеийн байцаалт, баримт бичиг хуурамчаар үйлдэх асуудлыг цагаачлалын шинэчлэл байдлаар багцаар нь шийдэх нь гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулах алхам болох юм.

6. Бусад улс орны практикаас үзвэл гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүл болох, хүүхэд үрчлэх болон хувийн эрх зүйн асуудлыг хуульд цогц хэлбэрээр тусгасан практик байхгүй. Эдгээр асуудлыг тусгай журмаар зохицуулж, харин уг журам ямар бүтэцтэй байх талаар хуульд тусгах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл бүх асуудлыг нэг мөр тусгасан хууль байх нь бололцоогүй, заавал кодексчлон хуульчлах шаардлагагүй бөгөөд журам хэлбэрээр зохицуулах боломжтой.

7. Визийн журмыг хуульд тусгах нь оновчгүй бөгөөд харин уг журам ямар бүтэцтэй байх талаарх улс төрийн бодлого агуулсан зохицуулалтыг хуульд хийж өгөх. Түүнчлэн оршин суух ангилалтай уялдуулан визийн зэрэг, ангиллыг өөрчлөх шаардлагатай.

Амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдийн хүний эрхийн асуудлаархи тунхаглал, ЕА-н 40/144 зөвлөмж, НҮБ-ийн 252 дугаар 40 дэх нэмэлт баримт бичиг (#53), НҮБ-ийн А/40/53 (1985)[242]

Ерөнхий Ассамблей,

Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэм нь хүний арьс, хүйс, хэл, шашин шүтлэгийг үл харгалзан хүний эрх, үндсэн эрх чөлөөг авч үзэхийн зэрэгцээ бүх нийтээр хүндэтгэн үзэхийг дэмжиж байдгийг харгалзан үзэж,

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалд бүх хүн төрөхдөө адил эрх, эрхэмсэг оршихуйтай байж, уг тунхаглалд заасан бүх эрхийг хүн бүр гарал үүсэл, арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн болон үндэстний гарал, өмч хөрөнгө, төрөлт болон бусад байдлаас үл хамааран эдлэх эрхтэй гэж заасныг харгалзаж,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар хэн ч хаана ч хуулийн өмнө хүн гэдэг үүднээсээ тэгш эрхтэй байж, ямар нэгялгаварлан гадуурхалтгүйгээр хуулийн хамгаалалтыг адил хүртэж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг зөрчсөн аливаа ялгаварлан гадуурхалтаас хамгаалуулах тэгш эрхтэй байж, ялгаварлан гадуурхах аливаа шалтаг өдөн хатгалтаас хамгаалагдана гэдгийг харгалзан,

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг соёрхон батлсан гишүүн улсууд нь аливаа хүний арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч, төрсөн болон бусад байдлыг үл харгалзан эдгээр олон улсын баримт бичигт заасан эрхүүдийг баталгаажуулах үүднээс,

Улс орон, тухайн улсад амьдардаг боловч харьяат биш хувь хүмүүсийн энх тайван, найрсаг харилцааг улам хөгжүүлэн дэмжихийг ойлгон ухамсарлаж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд заасан зорилго, зарчмыг дахин баталгаажуулан,

Тухайн улс оронд амьдарч байгаа боловч уг улсын иргэн биш этгээдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг олон улсын баримт бичгүүдэд заасны дагуу хамгаалахыг хүлээн зөвшөөрч,

Энэхүү Тунхаглалыг зарлан тунхаглаж байна:

1 дүгээр зүйл

Энэхүү тунхаглал болон холбогдох зүйлүүдэд заасан утгаар нь "гадаад хүн" гэж өөрийн амьдарч буй улсынхаа иргэн биш аливаа этгээдийг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Энэхүү Тунхаглалд заасан аливаа зүйл нь тухайн улсад суугаа

[242]http://www1.umn.edu/humanrts/instree/w4dhri.htm вэб сайтаас англи эхийг авч орчуулав



гадаад иргэний эсрэг хэрэглэгдэх, хууль бус байдлаар тайлбарлагдах ёсгүй төдийгүй аливаа улс нь гадаад хүнийг нутагтаа нэвтрүүлэх, тэдгээрийг нутаг дэвсгэртэй байлгахыг хориглох, хязгаарлахад мөн өөрийн харъяат болон гадаад хүний хооронд ялгаатай байдал үүсгэсэн нөхцөл, болзол тавьсан эрх зүйн зохицуулалтыг бий болгоход энэхүү Тунхаглалыг хууль бусаар хэрэглэгдэх ёсгүй. Ийм төрлийн эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын хүний эрхийн салбарт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болох ёсгүй.

2. Энэхүү Тунхаглалд заасан зүйлс нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу олгосон эрхээ эдлэх, хэдийгээр энэ Тунхаглалаар уг эрхийг хүлээн зөвшөөрөх, хамгийн бага боломжоор хангасан ч гэсэн тухайн улс олон улсын эрх зүйн үүднээс хүлээсэн үүргийнхээ дагуу гадаад иргэдийг эрхээ эдлэхэд саад болох ёсгүй.

3 дугаар зүйл

Бүх улс гадаадын хүнтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг олон нийтэд нээлттэй байлгана.

4 дүгээр зүйл

Гадаад хүмүүс нь оршин сууж буй болон амьдарч байгаа улсын хууль тогтоомжийг даган биелүүлж, тухайн улсын хүмүүсийн зан заншил, уламжлалыг хүндэтгэх ёстой.

5 дугаар зүйл

1. Тухайн улсын дотоод хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн дагуу дараах эрхүүдийг аливаа гадаад хүн эдлэх:

(а) Амьд явах, аюулгүй амьдрах эрх; аливаа гадаад хүнд хүч хэрэглэн баривчлах, эрүү шүүлт тулгах ёсгүй; хууль заасан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд аливаа гадаад хүний эрхийг хязгаарлаж болохгүй;

(б) Хувь хүний, гэр бүлийн, гэр орны, шуудан харилцааны нууцад хууль бусаар, хүч түрэн халдахын эсрэг хамгаалуулах эрх;

(в) Шүүхийн болон шүүх эрх мэдэл хэрэгжүүлэгч бусад байгууллагын өмнө тэгш эрхтэй байх, шаардлагатай тохиолдолд хууль болон бусад байцаан шийтгэх эрх зүйн актад заасны дагуу эрүүгийн шүүх ажиллагаанд орчуулагч үнэ төлбөргүй авах эрх;

(г) Гэр бүл болох, эхнэр, нөхөрөө сонгох, гэр бүлээ хайх эрх;

(д) Үзэл бодол, шашин шүтлэгээ чөлөөтэй сонгох эрхтэй; өөрийн итгэл үнэмшил, шашны төлөө хуульд заасан үндэслэлийн хүрээнд бусад хүмүүсийн үндсэн эрх, эрх чөлөө, зан суртахуун, эрүүл мэнд, нийгмийн дэг журам, аюулгүй байдалд халдахгүйгээр тэмцэх эрх;

(е) Өөрийн төрөлх хэл, соёл, уламжлалыг хадгалан үлдэх эрх;

(ё) Тухайн улсын дотоодын валютын хууль тогтоомжоор зохицуулагдаж буй хувийн мөнгөн орлого, хадгаламж, цалин хөлсөө гадаад руу шилжүүлэх эрх.

2. Тухайн улсын ардчилсан нийгэмд зайлшгүй хэрэгтэй үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийтийн дэг журам, нигмийн эрүүл мэнд, зан суртахуун болон бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс хууль тогтоомжид заасан хязгаарлалтууд нь холбогдох олон улсын баримт бичгүүдээр хүлээн зөвшөөрөгдөж, энэхүү Тунхаглалд заагдсан дараах эрхүүдийг гадаад хүн эдэлнэ. Үүнд:

(a) Улс орноо орхин явах эрх;

(b) Үг чөлөөтэй хэлэх эрх;

(c) Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх;

(d) Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжийн дагуу ганцаараа болон бусад этгээдтэй хамтран эд хөрөнгө өмчлөх эрх.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээд буюу тухайн улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад хүн нь чөлөөтэй зорчих, тухайн улсын хилийн дотор оршин суух газраа сонгох эрх чөлөөг эдэлнэ.

4. Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу тухайн улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад хүний гэр бүлийн хүн, насанд хүрээгүй болон эцэг эхийн асрамжид байдаг хүүхдүүд уг гадаад хүнтэй хамт байх, хамт амьдрахыг зөвшөөрнө.

6 дугаар зүйл

Аливаа гадаад хүн харгис хэрцгий, хүн ёсны бус эрүү шүүлт амсах, зохисгүй ял шийтгэл амсах, тухайлбал уг гадаад хүнийг эрүүл мэнд, шинжлэх ухааны туршилтад түүний зөвшөөрөлгүй оруулах ёсгүй.

7 дугаар зүйл

Тухайн улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин суугаа гадаад хүнийг гагцхүү хуулийн дагуу гаргасан шийдвэрийн үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрээс хөөн гаргаж болох бөгөөд үндэсний аюулгүй байдалтай холбоотой албадлагын арга хэмжээ үүнд хамаарахгүй. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин суугаа гадаад хүн нь эрх бүхий байгууллага, албан тушаалтан, тусгайлсан асуудал эрхэлсэн байгууллагад хөөгдөн гарах ёсгүй талаарх шалтгаанаа гаргаж тавихыг зөвшөөрнө. Гадаад хүнийг арьс, өнгө, шашин, соёл, нийгмийн гарал, үндэс угсааг нь харгалзан хөөн гаргахыг хориглоно.

8 дугаар зүйл

1. Энэхүү Тунхаглалын 4 дүгээр зүйлд заасан үүргийнхээ дагуу хууль ёсоор нутаг дэвсгэрт нь оршин суугаа Улсын дотоодын хулуь тогтоомжийн дагуу гадаад хүн дараах эрхүүдийг мөн эдэлнэ.

(а) Эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрх, чөлөө аливаа нэг ялгаварлан гадуурхалгүй, ялангуяа эмэгтэй хүнийг эрэгтэй хүнээс дор гэж үзэхгүйгээр адил нөхцөлд ижил хэмжээнд ажилласны төлөө адилхан цалин хөлс авах эрхтэй;

(б) Өөрийн сонголтын үндсэн дээр үйлдвэрчний эвлэл, бусад байгууллага, холбоонд нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй.



Эдгээр эрхээ эдлэхэд тухайн улсын хууль тогтоомжид үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журам тогтоох, ардчилсан нийгмийн үнэт зүйлс, бусад хүмүүсийн эрх, эрх чөлөөнд саад болоход зайлшгүй хязгаарлана гэж зааснаас бусад төрлийн хязгаарлалт, хориглолт байх ёсгүй.

(в) Тухайн оролцож буй харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан болон тухайн улсын холбогдох хууль тогтоомжид байвал зохистой шаардлагуудыг хангахад шаардагдах эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлэгийн тусламж, нийгмийн үйлчилгээ авах, боловсрол олж авах, чөлөөт цагтай байх, амрах зэрэг эрхтэй.

2. Гадаад хүний байгаа улсад хууль ёсоор цалин хөлс авах эрхийг нь хангахдаа тухайн байгаа улсын нэгдэн орсон олон талт болон хоёр талт гэрээнд заасны дагуу тодорхойлно.

9 дүгээр зүйл

Аливаа гадаад хүний хууль ёсоор эзэмшиж буй хөрөнгийг дур мэдэн хууль бусаар хураах ёсгүй.

10 дугаар зүйл

Аливаа гадаад хүн нь өөрийн харьяат улсын дипломат, консулын албаны элч, төлөөлөгчтэй, хэрэв тухайн гадаад хүний харьяалсан улсын дипломат, консулын алба оршин сууж буй улсад нь байдаггүй бол уг гадаад хүний харьяалсан улсын иргэний эрх ашгийг хамгаалахаар итгэмжлэгдсэн аливаа бусад улсын элч төлөөлөгчтэй хэдийд ч чөлөөтэй уулзах эрхтэй.

Хавсралт 2

Хүснэгт №1

Их Британы хууль	28 зүйлтэй	Status of Aliens Act 1914
1 дүгээр хэсэг	Оноосон нэр байхгүй	
2 дугаар хэсэг	Оноосон нэр байхгүй	
3 дугаар хэсэг	Ерөнхий зүйл	General
	Гадаад хүний статус /эрх зүйн байдал/	Status of Aliens
	Нэмэлт зүйлс	Supplemental
Хавсралт хэсэг	Оноосон нэр байхгүй. Нийт 3 хавсралттай	

Хүснэгт №2

АНУ-ын хууль	1175 зүйлтэй	Immigration and Nationality Act (8 USC)
1 дүгээр бүлэг	Ерөнхий зүйл	GENERAL PROVISIONS
2 дугаар бүлэг	Сонгогдсон франчайз	ELECTIVE FRANCHISE
3 дугаар бүлэг	Иргэний эрх	CIVIL RIGHTS
4 дүгээр бүлэг	Чөлөөнд гарсан хүмүүс	FREEDMEN
5 дугаар бүлэг	Газар эзэмшигч гадаад хүн	ALIEN OWNERSHIP OF LAND
6 дугаар бүлэг	Цагаачлал	IMMIGRATION
Дэд бүлэг I	Цагаачлалын болон харьяатын агентлаг, албан хаагчид, ажиллах бөомт	IMMIGRATION AND NATURALIZATION AGENCIES, OFFICERS, AND STATIONS
Дэд бүлэг II	Цагаачлалын ерөнхий зохицуулалт, хөриглолт	REGULATION AND RESTRICTION OF IMMIGRATION IN GENERAL
Дэд бүлэг III	Цагаачлалд квот тогтоох болон квот тогтоохгүй байх	QUOTA AND NONQUOTA
Дэд бүлэг IV	Дэлхийн 1 дүгээр дайнд оролцсон ахмад дайчид	ALIEN VETERANS OF WORLD WAR I
7 дугаар бүлэг	Хятад иргэдийг онцгойлон авч үзэх	EXCLUSION OF CHINESE
8 дугаар бүлэг	Хууль бус худалдаа	THE COOLY TRADE
9 дүгээр бүлэг	Бусад заалт	MISCELLANEOUS PROVISIONS
10 дугаар бүлэг	Гадаад хүний бүртгэл	ALIEN REGISTRATION
11 дүгээр бүлэг	Харьяалал	NATIONALITY
Дэд бүлэг I	Нэр томьёоны тодорхойлолт	DEFINITIONS
Дэд бүлэг II	Төрснөөр харьяалал олж авах	NATIONALITY AT BIRTH
Дэд бүлэг III	Харьяат болсноор харьяалал олж авах	NATIONALITY THROUGH NATURALIZATION
Дэд бүлэг IV	Харьяаллаа алдах	LOSS OF NATIONALITY
Дэд бүлэг V	Бусад зүйлс	MISCELLANEOUS

www.li.gov.mn



Дэд бүлэг VI	Дэлхийн II дугаар дайны үед АНУ-ын цэргийн хүчинд алба хашиж байсан хүмүүст харъяалал олгох	NATURALIZATION OF PERSONS SERVING IN THE ARMED FORCES OF THE UNITED STATES DURING WORLD WAR II
12 дугаар бүлэг	Цагаачлал болон харьяалал	IMMIGRATION AND NATIONALITY
Дэд бүлэг I	Ерөнхий үндэслэл	GENERAL PROVISIONS
Дэд бүлэг II	Цагаачлал	IMMIGRATION
1 хэсэг	Сонгох систем	SELECTION SYSTEM
2 хэсэг	Гадаад хүнийг хүлээн зөвшөөрөх шалгуур, гадаад хүн болон иргэдийг зорчиход хяналт тавих	ADMISSION QUALIFICATIONS FOR ALIENS; TRAVEL CONTROL OF CITIZENS AND ALIENS
3 хэсэг	Хилээр нэвтрэх бичиг баримт олгох	ISSUANCE OF ENTRY DOCUMENTS
4 хэсэг	Хяналт шалгалт, түр саатуулах, үзлэг хийх, үл оруулах, гаргах, буцаах	INSPECTION, APPREHENSION, EXAMINATION, EXCLUSION, AND REMOVAL
5 хэсэг	Эрх зүйн байдлыг өөрчлөх, нийцүүлэн зохицуулах	ADJUSTMENT AND CHANGE OF STATUS
6 хэсэг	Гадаад хүмүүсийг тэргүүлэгч этгээдэд холбогдох тусгай журам	SPECIAL PROVISIONS RELATING TO ALIEN CREWMEN
7 хэсэг	Гадаад хүмүүсийн бүртгэл	REGISTRATION OF ALIENS
8 хэсэг	Хариуцлага хүлээлгэх ерөнхий нөхцөл	GENERAL PENALTY PROVISIONS
9 хэсэг	Бусад зүйл	MISCELLANEOUS
Дэд бүлэг III	Харьяалал болон иргэншил	NATIONALITY AND NATURALIZATION
1 хэсэг	Төрснөөр харьяалал олж авах, холимог иргэншил	NATIONALITY AT BIRTH AND COLLECTIVE NATURALIZATION
2 хэсэг	Иргэншилтэй болсноор харьяат болох	NATIONALITY THROUGH NATURALIZATION
3 хэсэг	Иргэншлээ алдах	LOSS OF NATIONALITY
4 хэсэг	Бусад зүйлс	MISCELLANEOUS
Дэд бүлэг IV	Дүрвэгсдэд тусламж үзүүлэх	REFUGEE ASSISTANCE
Дэд бүлэг V	Гадаадын террористуудыг хөөн гаргах ажиллагаа	ALIEN TERRORIST REMOVAL PROCEDURES
13 дугаар бүлэг	Цагаачлал ба иргэншил олгох үйлчилгээ	IMMIGRATION AND NATURALIZATION SERVICE
Дэд бүлэг I	Байгууллага	ORGANIZATION
Дэд бүлэг II	Цагаачлалын үйлчилгээ болон уг үйлчилгээг сайжруулах дэд бүтцийн асуудал	IMMIGRATION SERVICES AND INFRASTRUCTURE IMPROVEMENTS
14 дүгээр бүлэг	Гадаадын хүнд нийгмийн даатгал, тэтгэмж олгохыг хориглох тухай	RESTRICTING WELFARE AND PUBLIC BENEFITS FOR ALIENS

Дэд бүлэг I	Холбооны тэтгэмж авах бололцоо	ELIGIBILITY FOR FEDERAL BENEFITS
Дэд бүлэг II	Муж улсын болон орон нутгийн тэтгэмж авах боломжтой хөтөлбөрүүд	ELIGIBILITY FOR STATE AND LOCAL PUBLIC BENEFITS PROGRAMS
Дэд бүлэг III	Орлого тодорхойлох, гэрчийн мэдүүлэгийг урамшуулах	ATTRIBUTION OF INCOME AND AFFIDAVITS OF SUPPORT
Дэд бүлэг IV	Ерөнхий нөхцөл	GENERAL PROVISIONS
15 дугаар бүлэг	Хилийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, орох визийн шинэтгэлийн асуудал	ENHANCED BORDER SECURITY AND VISA ENTRY REFORM
Дэд бүлэг I	Санхүүжилт	FUNDING
Дэд бүлэг II	Агентлаг хооронд мэдээлэл солилцох	INTERAGENCY INFORMATION SHARING
Дэд бүлэг III	Виз олгох	VISA ISSUANCE
Дэд бүлэг IV	Гадаадын хүнийг шалгах, нэвтрүүлэх	INSPECTION AND ADMISSION OF ALIENS
Дэд бүлэг V	Гадаадын оюутан болон солилцооны зочид	FOREIGN STUDENTS AND EXCHANGE VISITORS
Дэд бүлэг VI	Бусад журам	MISCELLANEOUS PROVISIONS

Хүснэгт №3

Канадын хууль	110 зүйлтэй	Immigration Act, 1976
1 дүгээр бүлэг	Канадын цагаачлалын бодлого	CANADIAN IMMIGRATION POLICY
2 дугаар бүлэг	Канадад нэвтрэх	ADMISSION TO CANADA
3 дугаар бүлэг	Үл хамаарах нөхцөл болон гаргах	EXCLUSION AND REMOVAL
4 дүгээр бүлэг	Гомдол гаргах, даваж заалдах	CLAIMS AND APPEALS
5 дугаар бүлэг	Тээврийн байгууллагуудын үүрэг	OBLIGATIONS OF TRANSPORTATION COMPANIES
6 дугаар бүлэг	Хүчин төгөлдөр болох	ENFORCEMENT
7 дугаар бүлэг	Ерөнхий зүйл	GENERAL

Хүснэгт №4

Оросын хууль	45 зүйлтэй	Федеральный закон О гражданстве Российской Федерации
1 дүгээр бүлэг	Ерөнхий зүйл	Общие положения
2 дугаар бүлэг	ОХУ-ын харьяалалтай болох	Приобретение гражданства Российской Федерации
3 дугаар бүлэг	ОХУ-ын харьяалалаа алдах	Прекращение гражданства Российской Федерации
4 дүгээр бүлэг	ОХУ-ын харьяалалын асуудлаар татгалзсан шийдвэр гаргах	Отмена решений по вопросам гражданства Российской Федерации

5 дугаар бүлэг	Эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн иргэний харьяалал өөрчлөгдсөнөөр хүүхдүүдийн харьяалал өөрчлөгдөх. Эрх зүйн чадамжгүй этгээдийн харъяалал	Гражданство детей при изменении гражданства родителей, опекунов и попечителей. Гражданство недееспособных лиц
6 дугаар бүлэг	ОХУ-ын харьяатын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага	Полномочные органы, ведающие делами о гражданстве Российской Федерации
7 дугаар бүлэг	ОХУ-ын харьяатын асуудал шийдвэрлэх процесс	Производство по делам о гражданстве Российской Федерации
8 дугаар бүлэг	ОХУ-ын харьяатын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын болон албан хаагчдын шийдвэрт гомдол гаргах. ОХУ-ын харьяатын асуудалтай холбоотой маргаан шийдвэрлэх	Обжалование решений полномочных органов, ведающих делами о гражданстве Российской Федерации, и действий их должностных лиц. Разрешение споров по вопросам гражданства Российской Федерации
9 дүгээр бүлэг	Төгсгөлийн заалтууд	Заключительные положения

Хүснэгт №5

Францын хууль	34 зүйлтэй	LOI no 98-349 du 11 mai 1998 relative a l'entree et au sjour des trangers en France et au droit d'asile
Хэсэг I	Олон улсын эрх зүйн ерөнхий заалтууд	Dispositions generales de droit international
Хэсэг II	Олон улсын хувийн эрх зүйн ерөнхий заалтууд	Dispositions generales de droit international prive
1 дүгээр бүлэг	Гадаад хүний эрх зүйн байдал	De la condition des etrangers
Дэд бүлэг I	Хувь этгээдийн эрх зүйн байдал	Condition des personnes
Дэд бүлэг II	Хуулийн этгээдийн эрх зүйн байдал	Condition des personnes morales
2 дугаар бүлэг	Зөрчилдөөний хэм хэмжээ	Des conflits de lois

Хавсралт 3

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ХОЁР ТАЛТ ГЭРЭЭГЭЭР ИРГЭД ХАРИЛЦАН ВИЗТЭЙ БОЛОН ВИЗГҮЙ ЗОРЧИХ БОЛОМЖТОЙ УЛС ОРНЫ ЖАГСААЛТ

Д/д	Орон	Зорчих нөхцөл	Хэлэлцээр
Иргэд визгүй зорчих орнууд			
1.	Азербайжан	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
2.	Белорусь	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
3.	Гонконг	14 хүртэл хоногоор визгүй зорчино	1998.06.18
4.	Гүрж	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
5.	Израйль	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1996.03.12
6.	Казахстан	90 хүртэл хоногоор визгүй зорчино	1994.12.02
7.	Киргиз	90 хүртэл хоногоор визгүй зорчино	1999.12.04
8.	Куба	30 хүртэл хоногоор визгүй зорчино	2001.10.08
9.	Лаос	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1978.06.08[19]
10.	Макао	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2004.07.03
11.	Малайз	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1994.06.06
12.	Молдов	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
13.	Сингапур	14 хүртэл хоногоор визгүй зорчино	1990.03.09
14.	БНАСАУ	Д, А, албаны зориулалттай Е паспорттай иргэд 90 хүртэл хоногоор визгүй, хувийн зориулалттай Е паспорттай иргэд визтэй зорчино	1986.11.14
15.	Тажикистан	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
16.	Туркменистан	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
17.	Украин	90 хүртэл хоногоор визгүй зорчино	
18.	Филиппин	21 хүртэл хоногоор визгүй зорчино	1994.05.13
19.	Хятад	Д, А, албаны зориулалттай Е паспорттай иргэд 30 хүртэл хоногоор визгүй, хувийн зориулалттай Е паспорттай иргэд визтэй зорчино	1989.03.30
Дипломат, албан паспорттай иргэд визгүй зорчих орнууд			
1.	Болгар	30 хүртэл хоногоор визгүй зорчино	
2.	Бразиль	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2007.05.03
3.	Вьетнам	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2000.01.07
4.	Индонез	14 хүртэл хоногоор визгүй зорчино	2002.10.07
5.	Мексик	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2001.11.09
6.	Орос	90 хүртэл хоногоор визгүй зорчино	1995.04.05
7.	Румын	30 хүртэл хоногоор визгүй зорчино	
8.	Словак	90 хүртэл хоногоор визгүй зорчино	1992.06.26
9.	БНСУ	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1991.10.23
10.	Тайланд	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1994.05.13
11.	Турк	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1992.05.29
12.	Унгар	30 хүртэл хоногоор визгүй зорчино	1992.09.24
13.	Чех	90 хүртэл хоногоор визгүй зорчино	1992.06.26
14.	Чили	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2003.09.25



15.	Энэтхэг	90 хүртэл хоногоор визгүй зорчино	2005.12.23
Бусад хөнгөлөлт			
1.	АНУ	Манай иргэдэд 2-10 жилийн хугацаанд олон удаа зорчих виз олгоно. АНУ-ын иргэд 90 хүртэл хоногоор визгүй зорчино	2001.07.06
Бусад оронд визтэй зорчино			

Жич: НҮБ-ын паспорт бүхий НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын албан хаагчдыг визээс чөлөөлөхөөр манай 2007.04.30-ны К/07-566, НҮБ-ын 2007.06.11-ны төлөөний ноотоор тохиролцсон нь 2007.07.10-наас хүчин төгөлдөр болсон

__oOo__

ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙХ ХАВСРАГА СУДАЛГАА

ОРШИЛ[243]

Эрх зүйт төрд хувь хүн ба төрийн хоорондын харилцааны үндсэд үндсэн хуулийн хэмжээнд батлагаажилт, иргэний нийгмийн давуу байр суурь, хүний эрхийг тодорхойлох, түүний баталгаа зэрэг асуудал чухал ач холбогдолтой байдаг. Хувь хүн нь нийгмийн амьдралын ямарч салбарт түүний нийгмийн байр суурийг тодорхойлох хүний эрх, эрх чөлөө, үүргийн обьект байдаг. Харин хууль зүйн зохицуулалт бөгөөд төрийн зүгээс хамгаалагдахыг шаарддаг хувь этгээдийн энэхүү эрх, эрх чөлөө, үүргийн нийлбэрийг хувь этгээдийн эрх зүйн байдал (эрх зүйн статус) гэж тодорхойлдог. Энэ статус нь хувь этгээдийн нийгэм, улс дахь эзлэх байр суурийг илэрхийлнэ. Иймд энэ эрх зүйн статусд иргэний хувьд эдлэх эрх, хүлээх үүрэг голлох байр суурьтай. Учир нь иргэний хувьд эдлэх үндсэн эрх, эрх чөлөө, хүлээх үүргийг Үндсэн хуульд тунхагласан байдаг.

Монгол Улсын иргэний эрх зүйн байдлын үндэс гурван элементээс бүрдэнэ:

1. Харьяалалтай байх өөрөөр хэлбэл Монгол Улсад эрх зүйн хамааралтай байх. Аль нэг улсын харьяалалтай байх нь түүнд улсаас олгох эрх, эрх чөлөөний баталгааг тухайн улсад бөгөөд хилийн чандад эдлэх нөхцөл болно.

2. Эдлэх эрх, эрх чөлөө ба хүлээх үүрэг. Энэ нь иргэний эрх зүйн байдлын цөм нь болох бөгөөд үүнээс бусад салбарт үүсэх эрх үүрэг бий болдог.

3. Эдлэх эрх, эрх чөлөө болон хүлээх үүргийн үндэс болсон иргэний эрх зүйн байдлын үндсэн зарчим. Эдгээр зарчим нь Үндсэн хуульд тусгалаа олж бусад хууль тогтоомжид хуульчлагдсан байдаг.

Харьяалал нь хувь этгээдийн эрх зүйн байдлын анхдагч ба үндсэн элемент юм. Өөрөөр хэлбэл, харьяалал нь тодорхой этгээдэд тэр эрх, эрх чөлөөг ханган хамгаалж, үүргийг хүлээлгэдэг. Иргэний харьяалал нь Төр ба Иргэн хүн хоёрыг холбож буй улс төр, эрх зүйн тогтвортой холбоос юм. Харин энэхүү холбоосын агуулга болох төрийн зүгээс баталгаажуулж өгсөн иргэний эрх, эрх чөлөө, төрийн өмнө хүлээх үүргийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд уялдуулж байдаг үндэсний хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар зохицуулдаг байна. Ном зохиолд энэ холбоосыг тогтвортой гэдэг, өөрөөр хэлбэл хувь хүн ямар хугацаанд харьяалалтай байна тэр хугацаанд харьяалуулж буй улсаас хаана явж байгаагаас үл шалтгаалж эрхийнхээ баталгааг эдэлж, өмнө нь үүргээ хүлээнэ. Үүнийг тогтвортой гэж ойлгоно. Харин тогтвортой гэх ойлголт нь мөн харьцангуй байдаг. Учир нь хүнд харьяаллаа өөрийн хүсэлтээр солих эрх байдаг ба хуучин холбоогоо цуцлаж өөр нэгэн улстай тогтвортой харилцаанд орох нь үүний жишээ болно. Харин улс төрийн шинж нь хувь хүний төр, нийгмийн хэргийг удирдахад оролцож буйг илэрхийлнэ.

[243]Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэв.

Иргэний харьяаллийн асуудал онолын хувьд олон улсын эрх зүйд, практикийн хувьд үндэсний эрх зүйд чухал асуудал юм. Иргэний харьяалал нь улс гүрний бүрэн эрхийн гол шинжийн нэг нь болдог хэдий ч бүрэн эрх нь өөрөө харьяаллын оршин байх нөхцөл болдог.

Хүн бүрийн харьяалалтай байх баталгаагаар хангагдах эрхийг 1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамлейн тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл түнхаглалаар[244]тогтоожээ. Энэ эрхээр төрмөгц хангагдаж байх стандартыг мөн олон улсын эрх зүйн олон баримт бичигт туңхаглажээ[245]. Харьяалалтай байх эрх нь хүний салшгүй эрхийн нэг. Монгол Улсын иргэний харьяаллыг төр дур мэдэн хасаж болохгүй бөгөөд мөн харьяаллаа сонгох эрхийг боогдуулж болохгүй юм. Харьяаллаа яаж олж авсанаас үл хамааран Монгол Улсын иргэн мөн бол бүгд тэгш байдлаар үндсэн хуулиар баталгаажсан эрх эдлэн, хуулийн өмнө тэгш байна.

Монгол Улс өөрийн иргэн болгондоо үндсэн хуулийн эрхийг баталгаажуулж, хамгаалж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг нь хангуулна.

Монгол Улс нэгдмэл харьяалалтай. Энэ харьяаллыг олгох ба харьяаллаас гаргах асуудлыг хуулиар зохицуулдаг.

1995 оны Харьяатын тухай хуулиар болон шинэ төслөөр Монгол Улсын иргэн гэж энэ хууль хүчин төгөлдөр болоход Монгол Улсын иргэн байсан, мөн Ардын хувьсгалын үед манай улсын иргэн байсан ба дараа нь харьяатаас гараагүй хүн, тэгээд мэдээж энэ хуулийн дагуу харьяат болсон хүмүүсийг ойлгохоор байна. Харин Монгол Улс харьяатын асуудлаар олон улсын гэрээ байгуулсан ба тэр нь энэ хуулиас өөр журам тогтоосон байвал олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэнд дээрх хуулийн дагуу харьяат болсон хэсэг хүмүүсээс гадна олон улсын гэрээгээр харьяалал олж авсан хүнийг бас ойлгохоор байна.

Орчин цагийн олон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд хоёрдмол харьяалалын байдалтай холбоотой үүсэж буй асуудлыг шийдэх нэгдмэл шийдэлд хүрээгүй л байна. Ихэнхи улс энэ асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй байдлаар ханддаг. Анх хоёрдмол харьяаллаас үүсэх асуудлыг хоёр талын болон олон талт гэрээгээр шийдэх оролдлого 19 зуунд гарч байсан байна (*Банкрофтын гэрээ*).

Олон улсын түвшинд анх 1930 онд Гааг хотноо болсон олон улсын бага хурлын төгсгөлд Харьяатын тухай хуулийн зөрчилдөөнийг арилгах тухай конвенцийг баталжээ. Энэ онд мөн Олон харьяалалтай зарим тохиолдлын цэргийн үүргийн тухай Протоколыг баталсан.

Дэлхийн II Дайны дараа НҮБ-ийн Олон улсын эрх зүйн комисс энэ асуудлыг анхааралдаа авч давхар харьяаллыг багасгах хандлагыг баримтлан 1963 оны Олон харьяаллыг багасгах ба олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай Конвенцийн төслийг боловсруулсан байна.

[244]Арван тавдугаар зүйл. 1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй.

[245]1959 оны Хүүхдийн эрхийн тухай тунхаглалын гуравдугаар зарчим, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн пактын 24 дүгээр зүйл зэрэг

1. Хоёрдмол харьяалал, түүний шалтгаан

Ихэнхи хуульч, улс төрийн зүтгэлтэн давхар харьяаллыг устгах нь зүйтэй гэж үздэг. Энэ зорилгын хүрээнд хэд хэдэн олон улсын гэрээ, хэлэлцээр хийсэн байдаг. Харин сүүлийн хэдэн арван жил хоёр болон түүнээс их харьяалалтай иргэдийн тоо өссөн байх ба энэ тоо цаашид ч өсөх хандлагатай гэж үздэг. Энэ асуудал дэлхийн нийт улс орнуудыг хамарсан асуудал болж улс төржиж эхэлжээ. Энэ асуудал нь зөвхөн эрх зүйн бус мөн улс төрийн асуудлыг хөнддөг.

Олон улсын эрх зүйгээр энэ асуудлыг хязгаарлах хандлагатай байхад хоёрдмол харьяалал газар авч буй шалтгаан юунд байна? Баруун Европ ба Хойд Америкт сүүлийн хорин жил цагаач, дүрвэгчдын тоо асар хурдтай нэмэгдсэн. Хэдий цагаачдын байдал шууд харьяаллын статус бий болгох боломжгүй ч цагаач, эсхүл тэдгээрийн үр хүүхэд тухайн улсын энэ чиглэлдээ шинэчлэгдэж буй харьяаллын тухай хууль тогтоомжоор давхар харьяаллыг авах боломжтой болж байна. Цагаач их тусам тухайн улсад төрснөөр давхар харьяалалтай болох асуудал их байдаг. Мөн үүний адилаар холимог гэрлэлт ихээр нэмэгдэж байгаа нь нөлөөлдөг байна.

Дүрвэгсдийн хувьд тэдгээр нь харьяаллыг олж авах цагаачтай харьцуулахадихэнхулсадхялбаршуулсанжурамтайбайдаг.Натурализацийн шаардлагад өмнөх харьяаллаасаа татгалзах шаардлага тавьдаггүй байна.

Хоёрдмол харьяаллыг бий болгож буй бас нэг шалтгаан бол улс гүрнүүдийн энэ асуудалд хүлээцтэй ханддаг болсонтой холбоотой. Тухайлбал, 1963 онд Европын Зөвлөлийн 11 улс харьяаллын асуудлыг зохицуулах оролдлого хийсэн олон улсын гэрээг соёрхон баталсан. Энэ гэрээгээр хэлэлцэн тохирогч улсуудын иргэд сайн дураараа хэлэлцэн тохирогч нөгөө улсын харьяаллыг авч буй бол өөрийн харьяаллаас татгалзах үүрэгтэй байжээ. Гэвч Англи болон Ирланд энэ гэрээний хэсгийг нь л соёрхон баталсан бол зөвхөн Люксембург ба Норвеги улс уг гэрээний Харьяалал олгож буй талаар мэдээллийг харилцан солилцож байх тухай нэмэлт протоколыг хүлээн зөвшөөрч соёрхон баталсан байна. Судлаачид энэ нэмэлт протоколгүйгээр суурь гэрээ нь бага ач холбогдолтой гэж үздэг. Харин гишүүн улсууд үүнд нэгдэн орох асуудлыг хайхрахгүй байсаар байна.

Өнөөдөр харьяаллын талаар нэгдсэн бүртгэл хаана ч байдаггүй. Иймд хоёрдмол харьяалалтай иргэдийн бодит тоо байдаггүй. Харьяаллын талаар хатуу бодлого баримталдаг ХБНГУ, Швед зэрэг улсад хоёрдмол харьяалалтай иргэд бас цөөнгүй байдаг.

Герман, тухайлбал, натурализацаар харьяаллыг нь авч буй иргэдийн гуравны нэг нь хоёрдмол харьяалалтай болж байгаа гэж үздэг байна. Харин Швед улс нь давхар харьяалалтай 100 мянга гаруй шведийн иргэн байдаг гэж үздэг. Канад, АНУ, Англи, Франц зэрэг улсад ийм иргэдийн тоо асар их байдаг ба үүний шалтгаан нь эдгээр улсад төрснөөр харьяалалтай болох *jus soli* буюу хөрсний зарчим үйлчилдэг, мөн натурализацийн аргаар давхар харьяалалтай болох асуудалд төвийг сахих байдлаар ханддаг явдал юм.

Франц ба Алжирийн давхар харьяалалтай иргэд сая гаруй байдаг гэсэн тооцоо байдаг байна.

2. Ямар хүрээнд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг

Улс болгонд хоёрдмол харьяаллын асуудалд өөр өөрөөр ханддаг. Европт энэ асуудалд хандах нэгдсэн байр суурь бол байдаггүй. Ирланд, тухайлбал, хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн байхад Австри нь тодорхой тохиолдлоос бусад үед хүлээн зөвшөөрдөггүй. Харин Испани тодорхой улсын харьяаллыг хоёрдмол байдлаар зөвшөөрдөг. Голланд, Итали зэрэг улсад энэ асуудлыг аль болох анзаарахгүйгээр өнгөрөөдөг гэж үздэг. Түрк, Грек хоёрдмол харьяаллыг зөвшөөрдөг бол Норвеги, Швед болон Франц албан ёсоор зөвшөөрдөггүй. Швецарийн хувьд онцлог зохицуулалттай: Швецарийн иргэн өөр улсын харьяаллыг авах боломжтой бол гадаадын иргэн Швецарийн харьяаллыг авах бол өмнөх улсын харьяаллаас татгалзах ёстой байдаг байна.

Шведийн Үндсэн хуулиар[246] Шведийн өөр улстай байгуулсан олон улсын гэрээгээр төрснөөр өөр улсын иргэн болсон тохиолдолд 18 нас хүрснээр тухайн улсад удаан хугацаагаар оршин сууж буй бол Шведийн харьяаллыг алдах зохицуулалттай.

Испаний Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлээр Испани Улс нь түүнтэй онцгой холбоо бүхий ибероамерикийн орнуудтай[247] хоёрдмол харьяаллын тухай гэрээ хийж болно. Гэхдээ эдгээр улс нь харилцан хүлээн зөвшөөрөх зарчмыг баримтлахгүй бол төрснөөр Испанийн харьяаллыг алдалгүй эдгээр улсын харьяаллыг олж авах эрхтэй гэжээ.

АНУ болон Канадад цагаач иргэдээс төрсөн хүүхэд (Англи улсад бараг гадаадын иргэдээс төрсөн хүүхэд болгон) тухайн улсын харьяаллыг шууд авдаг. Францад цагаачаас төрсөн хүүхэд 18 нас хүрмэгц Францад хэвээр амьдарч буй бол францын иргэн болдог.

Өмнөд Америкийн хувьд байдал бас төсөөтэй. Боливи болон Уругвай улсад хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй бол Аргентин Улс испани болон италийн харьяаллыг л хоёрдогч харьяаллаар хүлээн зөвшөөрдөг. Ямайк болон Доминиканы Бүгд Найрамдах Улс хоёрдмол харьяаллыг зөвшөөрдөг бол Чили зөвхөн Испани улстай давхар харьяаллын тухай гэрээ байгуулсан байдаг ба түүгээрээ л харьяаллыг нь зөвшөөрдөг.

Олон улсын практикт бүс нутгийн чанартай олон улсын эрх зүйн баримт бичиг бол 1954 оны Араб Улсуудын холбооны давхар харьяаллыг устгах тухай олон улсын гэрээ юм.

[246]Шведийн Үндсэн хуулийн 7 дугаар зүйл (1979 оны 933 дугаар найруулагаар).

[247]Америкийн орнууд гэдэгт испани хэлээр ярьдаг Латин Америкийн улсуудыг ойлгоно. Мөн эдгээр улсын тоонд Андорр, Экваторын Гвиней, Португалийг багтаадаг.

3. Хоёрдмол харьяаллын тухай хууль тогтоомж

Хоёрдмол харьяаллын асуудлыг хүлээн зөвшөөрч буй бөгөөд үгүйсгэзгүй улсууд нь үндэсний хууль тогтоомжоороо зохицуулсан байх бөгөөд цөөхөн хэдэн улс нь тусгайлсан хуулиар зохицуулсан байдаг байна. Тухайлбал, Армени 2007 оны 2 дугаар сард Хоёрдмол харьяаллын тухай хууль баталсан байна. Армени нь 3 сая хүн амтай байх бөгөөд хилийн чандад дүрвэж гадаадын иргэн болсон 5 сая хүн байдаг ба эдгээрийг давхар харьяалалтай болгосноор Армени Улсын нэр хүнд өсөж, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж хууль тогтоогчид үзжээ.

Энэ хуулиар давхар харьяаллын журам нь армян гаралтай хүмүүс, эсхүл төрийн өмнө онц гавьяатай хүмүүст хялбарчилсан журам үйлчилдэг байна.

Белорусь, Латви, Молдав, ОХУ, Финлянд зэрэг улс давхар харьяаллын асуудлыг холбогдох Харьяатын хуульдаа зөвшөөрсөн заалт нэмэлт өөрчлөлтөөр оруулсан байна.

Харин эдгээрээс Латви: Сеймын (парламентын) гишүүд Латви улсдаа үнэнч байх төрийн тангараг өргөдөг нь давхар харьяалалтай гишүүдийн хувьд үүсэж буй асуудлыг шийдэх үүднээс 2004 онд төрийн болон улс төрийн албан тушаалтанд тавигдах шаардлагад зөвхөн Латвийн иргэн байх заалтыг холбогдох хуульд тусгажээ. Мөн Молдав 2007 оны 12 дугаар сард төрийн албан хаагчийн давхар харьяалалтай байхыг хориглосон хууль баталжээ. Давхар харьяалалтай Молдавын иргэн Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, парламентын гишүүн, орон нутгийн нэгжийн тэргүүлэгч, хотын захирагч, Сонгуулийн хороо, төлбөр тооцооны танхим, Үндэсний банк зэрэг байгууллагын гишүүн, шүүгч, парламентын ажлын хэсэг, гааль болон бусад албан тушаал хашихыг хоригложээ. Эдгээр албан тушаалтан 6 сарын хугацаанд өөр улсын харьяаллаас татгалзаж өөрийн албан тушаалаа хадгалах боломжтой.

ОХУ мөн давхар харьяаллыг тодорхой хэмжээгээр хязгаарласан байна. ОХУ-ын Ерөнхийлөгч 2006 оны 6 дугаар сарын 14-нд ОХУ-ын хууль тогтоомжийн Төрийн болон орон нутгийн албан тушаалд тавигдах шаардлагыг тодотгох хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэглэн хүчин төгөлдөр болгожээ. Энэ хуульд мөн холбогдох төрийн албаны тодорхой албыг хоёрдмол харьяалалтай ОХУ-ын иргэнд хашихыг хориглосон ба олон улсын гэрээгээр заасан бол тэдгээр нь орон нутгийн байгууллагад сонгогдох боломжтой болжээ. Энэ зохицуулалтаа Үндсэн хууль болон ОХУ-ын олон улсын гэрээтэй харшилдаагүй гэж хууль тогтоогчид үзжээ.

Армени төрийн албанд тавигдах дээрхи шаардлагыг Хоёрдмол харьяаллын тухай хуульдаа мөн тусгасан байдаг байна.

Харин бусад улсад холбогдох асуудлаар хууль тогтоомжийн нарийн зохицуулалт үгүй байна.

4. Хоёрдмол харьяалалтай иргэний эрх зүйн байдлын зохицуулалт хяналт, бүртгэл

Давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг, үгүйсгэдэггүй улсад хоёрдмол харьяалалтай иргэний эрх зүйн байдлыг тухайн улсын иргэний эрх зүйн байдлаас ялгамжтай байдлаар авч үздэггүй байна. Тухайлбал, Испанийн хуулиар тэдгээрийн эдлэх эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй гэдгийг тунхагласан байх бөгөөд эрх эдлэхийн зэрэгцээ үүргээ хүлээж холбогдох хууль тогтоомжийг зөрчсөнөөс үүсэх хариуцлага хүлээнэ гэдгийг нь хуульчилсан байна.

Харин амьдрал дээр иргэний үүргийн хувьд давхар харьяалалтай хүмүүст тодорхой бэрхшээл тулгардаг байна. Тухайлбал, иргэний үүрэг болох цэргийн алба хаах, татвар төлөх асуудал давхардаж иргэд хохирдог байна.

Бүртгэдэг бөгөөд хянадаг нарийн тогтолцоо хаана ч байдаггүй байна. Хяналтын асуудал нь зөвхөн төрийн албатай холбоотойгоор зарим улсад зохицуулагддаг байна.

Зарим улсад Иргэний бүртгэл, эсхүл Харьяатын болон цагаачийн асуудлаар бүртгэлийн товчоо, алба байх бөгөөд эдгээр нь тухайн улсад буй гадаадын иргэн болон тухайн улсын иргэний бүртгэл, мэдээллийг хөтөлдөг. Гэвч эдгээр байгууллагад давхар харьяаллын тухай мэдээлэл байдаггүй.

5. Хоёрдмол харьяалалтай иргэний татвар, өмчлөх эрх

Давхар харьяалалтай иргэдийн татвар төлөх асуудлыг шууд ба шууд бус байдлаар зохицуулдаг байна. Тухайлбал, холбогдох асуудлаар гэрээгээр зохицуулдаг, эсхүл татварын асуудлаар хийгдсэн бусад зохицуулалтад хамруулж шийддэг байна. Өмчлөх эрхийг тусгайлан зохицуулдаггүй байна.

6. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрснөөс үүсэн гарч болзошгүй сөрөг үр дагаварыг хэрхэн урьдчилан тооцоолж болох, шийдвэрлэх арга зам

Давхар харьяалал иргэн хүнд хил дамнан чөлөөтэй зорчих, нийгмийн халамжид хамрагдах, ажил хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг нь давуу тал болох болов ч сөрөг үр дагавар ихтэй байдаг байна. Тухайлбал, тэргүүн ээлжинд иргэний үүрэг байдаг.

Иргэн хүн байгаа улсын хууль тогтоомжид захирагдах ёстой байдаг. Байнгын оршин суугаа улсын хуулиар нь иргэд нь зөвхөн тухайн улсын паспортоор зорчих ёстой байх бөгөөд өөр улсын паспорт илрэх бол хураан авч торгодог тогтолцоо хөгжсөн байдаг байна. Хэрэв аль нэг улсын иргэн хилийн чанадад асуудалд орсон бол тухайн улсын элчин сайдын яам, консулын газар түүнд туслах үүрэгтэй. Харин нөгөө этгээд давхар

харьяалалтай тэгээд хоёрдогч улсын паспортоор зорчиж буй бол эхний улс нь оролцохоосоо татгалздаг. Учир нь өөр улсын дотоод хэрэгт оролцох сонирхолгүй байдаг. Харин хоёр дахь улс нь тухайн иргэнийг анхны улсын хувьд үүсэл гаралтай гэж үзэж дипломат хамгаалалт үзүүлэхээс татгалзах боломжтой. Энэ тохиолдолд иргэн хүн өөрөө хохирдог байна.

Мөн манай улсын иргэний өөр харьяаллын улс нь өөрийн иргэний хувьд эрхийг нь хязгаарлах боломжтой. Тухайлбал, хил дамнасан хөдөлгөөнийг нь хязгаарлах, цэргийн заавал хаших алба, тусгай татвар, эд хөрөнгийг нь нийгэмчлэн хураах, дайчилгаанд авах, өмнө авсан үйлчилгээний хөлс хэлбэрээр нөхөн төлбөр шаардах (тухайлбал, сургалтын төлбөр) зэрэг асуудалтай тулгарах нь мэдээжийн асуудал юм. Мөн эх орондоо байхад нь өөр харьяаллын улс нь иргэний үүргийг биелүүлэхийг хэзээ ч шаардаж болдог.

Эдгээр асуудлыг шийдэх цөөхөн аргын нэг бол тухайн хоёр улсын хооронд хоёрдмол харьяаллын асуудлаар гэрээ байгуулах явдал юм. Хоёрдмол харьяаллын асуудлаар гэрээг хоёр үндсэн зорилгоор хийдэг байна. Эхний зорилгын хувьд давхар харьяаллыг устгах талаар хийдэг бол хоёр дахь нь давхар харьяаллыг харилцан зөвшөөрч тулгарах асуудлыг шийдэх зорилгоор хийдэг байна. Тухайлбал, Хоёрдмол харьяаллаас урьдчилан сэргийлэх бөгөөд устгах тухай хоёр талын хэлэлцээрийг хийдэг байна. Хүлээн зөвшөөрөхийн хувьд давхар харьяалалтай цэргийн албын асуудлаар тусгайлан гэрээ байгуулдаг практик байдаг байна. Тухайлбал, АНУ нь Норвеги (1930 он), Швед (1933 он), Швейцарь (1937 он), Финлянд (1939 он) зэрэг улстай, Франц нь 1958 онд Швейцарьтай, 1959 онд Израилтай, 1970 онд Испанитай, Аргентин Финляндтай 1963 онд, мөн онд Англитай тийм гэрээ хийжээ. Эдгээр гэрээний хувьд хэлэлцэн тохирогч нэг улсад хаасан цэргийн албыг нөгөө улсад хүлээн зөвшөөрөн цэргийн алба хаасанд тооцдог байна. 1970 оны Испанитай, Аргентины хооронд байгуулсан гэрээгээр сүүлийн 12 сарын хугацаанд алба хаасан бол харилцан зөвшөөрөх зохицуулалттай.

Цэргийн алба хаах иргэний үүргийг давхар харьяаллын асуудлаархи бүхий л гэрээнд зохицуулдаг. Тухайлбал, түгээмэл чанартай олон улсын эрх зүйн баримт бичиг болох 1930 оны Олон харьяалалтай зарим тохиолдлын цэргийн үүргийн тухай Протокол, 1963 оны Олон харьяаллыг багасгах ба олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай Конвенц, 1997 оны Харьяаллын тухай Европын Конвенц, бусад хоёр талын гэрээ юм. 1963 оны Олон харьяаллыг багасгах ба олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай Конвенцийн 1977 оны Нэмэлт Протоколын 2 дугаар зүйл, Харьяаллын тухай Европын Конвенцийн 22 дугаар зүйл нь цэргийн албыг харилцан зөвшөөрөх тухай заалтууд нь олон улсын эрх зүйд хийгдсэн шинэ зохицуулалт болсон юм. Харин энэ асуудлыг зарим улс өөрийн үндэсний хууль тогтоомжоор мөн зохицуулдаг байна. Тухайлбал, давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөг ихэнхи улсын хуулиар зөвхөн байнгын оршин суугч иргэн цэргийн албыг хаших ёстой байдаг байна. ХБНГУ-ын хувьд тухайлбал, Францад байнгын оршин сууж байхдаа цэргийн, эсхүл дүйцүүлэх албыг

хашсан бөгөөд Германд буцаж ирсэн тохиолдолд францад Германд хаших хугацаанаас баг хугацаагаар алба хаасан бол дахин цэргэг татагдах боломжтойгоор зохицуулсан байна.

7. Үндэсний аюулгүй байдалд хэрхэн нийцэх

Жижиг улсын хувьд тусгаар тогтносон улс бүрэн эрхэт байдлынхаа хувьд хязгаарлалтанд өртсөөр байгаа. Энэ нь эдийн засаг, технологийн шинжтэй хөгжилтэй болон бүх салбар дахь олон улсын хамтын ажиллагаатай шууд холбоотой. Бүс нутгийн интеграчлал бол бүрэн эрхт байдлыг хязгаарладаг хүчин зүйлсийн нэг. Энэ хүчин зүйлс нь бусдаасаа илүү нөлөөтэй байдаг. Тухайлбал, Европын холбооны гишүүн улс үүнийг биеэрээ амсаж байна. Гишүүн улс хоорондоо цагаачлалын хяналтыг хялбаршуулж өөрийн нутаг дэвсгэр дээр хянах боломжгүй болсон. Аюулгүй байдлын асуудал эдгээр улсын хувьд бие даасан шинжээ алдаж хамтын хамгаалалтын нэгдсэн бодлогыг баримталж байна. Ийм интеграчлалын хүрээнд давхар харьяаллыг эсэргүүцэх бодлого утгаа алдаж гарцаагүй хүлээн зөвшөөрөхөд хүрч байна. Хоёрдмол харьяаллын асуудлыг аюулгүй байдалтай хэд хэдэн зүйлээр холбодог.

Зэвсэгт мөргөлдөөн, дайны байдлын болон бусад онц байдалд эх орондоо хандах үнэнч байдал эргэлзээтэй болдог. Учир нь тэдгээр нь өөр нэг улсад мөн үнэнч байх тангараг өргедөг. Харьяаллын гол нэг асуудал нь цэргийн алба хаших үүрэг байдаг. Харин энэ хоёр улсын хооронд асуудал үүсэх тохиолдол үндэсний аюулгүй байдал алдагдах өндөр магадлалтай байдаг гэж үздэг байна.

Энхийн цагт ч мөн адил үндэсний аюулгүй байдал гэх үүдэнээс давхар харьяалалтай иргэдийн эрхийг хязгаарлах зүйл бий. Эдгээр дээрх үндэслэлээр төрийн алба, эсхүл тодорхой төрийн бодлоготой холбоотой албан тушаал хаших, төрийн нууцын зэрэглэлтэй мэдээлэлд хүрэх боломжийг хязгаарлах зэрэг байдлаар эрхийг нь хязгаарладаг байна.

Улсын нэгдмэл, бүрэн бүтэн байдал, улсын хүчирхэг байдалд сөргөөр нөлөөлнө гэх болгоомжлол Хоёрдмол харьяаллыг эсэргүүцэх гол шалтгаан болсоор иржээ.

8. Харьяатын тухай хуулийг Хоёрдмол харьяаллын асуудлаас гадна сайжруулах нь

Монгол Улсын иргэн болох асуудлыг 1995 оны Харьяатын тухай хуулийн Хоёрдугаар бүлгээр зохицуулна.

Энэ хуулийн дагуу Монгол Улсын харьяат дараах аргаар[248] болно:

1. төрснөөр
2. (хүсэлтээр) харьяат болсноор
3. харьяаллаа сэргээснээр

[245] Шинэ төслийн мөн 6 дугаар зүйл

4. олон улсын гэрээгээр

Төрснөөр Монгол Улсын иргэн болох нь олон улсын эрх зүйн дагуу филиацийн арга бөгөөд энэ нь өөртөө мөн хоёр хэлбэрийг агуулдаг. Энэ нь "цусны" болон "хөрсний" зарчим юм. Филиацийн аргаар харьяат болгохдоо улс болгонд эдгээр зарчмын аль нэгийн давамгайлсан байдлаар зохицуулсан байдаг. Тухайлбал, англи-саксоны эрх зүйн бүлийн (АНУ, Канад), мөн Латин америкийн зарим улс оронд (Аргентин, Куба) хөрсний зарчим түгээмэл байх ба тодорхой тохиолдолд давамгайлах чанартай байдаг. Манай улсад *jus sangvinium* буюу "цусны зарчим" давамгайлах зохицуулалттай. Хэдий монгол гэр бүл (эцэг, эх)-ээс төрсөн хүүхэд Монгол Улсын иргэн байх тухай Харьяатын тухай хуулийн болон нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 1-д үндэслэн цусны зарчим ноёрхох шинжтэй гэж үзэж болох болов ч энэ зүйлийн 2, 4, 5-д үндэслэн хөрсний зарчим үйлчилж байна гэж мөн үзнэ. Эцэг, эхийн аль нэг нь монгол бол монголын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхэд хөрсний зарчмын дагуу Монгол Улсын иргэн байхаар, мөн эцэг, эх нь тогтоогдоогүй Монгол Улсын нутаг дэвсгэр дээр буй хүүхдийн харьяалал монгол байхаар, мөн манай улсад буй харьяалагүй хүмүүсээс төрсөн хүүхэд 16 нас хүрсний дараа эцэг, эх нь Монгол Улсад байнга оршин суугаа бол манай улсын харьяаллыг сонгож авах боломжтойгоор хуульчилсан. Энэ нь хөрсний зарчмыг баримтлан харьяалал олгох асуудал юм.

Зарим гадаад улсын практикаас харахад бас онцлог зохицуулалттай байдаг. Тухайлбал, Харьяатын тухай Казакстаны хуулиар (12 дугаар зүйл) эцэг тогтооход эх нь харьяалалгүй ба эцэг Казахстаны иргэн бол 14 нас хүрээгүй хүүхэд нь Казахстан улсын иргэн байхаар зохицуулжээ. Төсөөтэй зохицуулалт 2001 оны Харьяатын тухай Украин улсын хуулийн 14 дүгээр зүйлд агуулагджээ. Гэхдээ хүүхдийн насыг 16 нас тогтоожээ. Харин ОХУ-ын Харьяатын тухай хуулиар эцэг эхийн аль нэг нь оросын иргэн бол хүүхдийг нь тэдгээрийн бичмэл зөвшөөрөлд үндэслэн, бичмэл зөвшөөрөл үгүй бол шууд оросын иргэнд тооцхоор зохицуулжээ.

Монгол Улсад жилдээ дунджаар 50000 хүүхэд төрдөг ба цусны зарчмын дагуу Монгол Улсын иргэн болдог байна. Харин үүнээс холимог гэр бүлд төрсөн хүүхдийн тоо дунджаар 100[249] байдаг байна. 2000 оноос 2007 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 633 хүүхэд холимог гэр бүлд төрсөн байна. Эдгээрээс эцэг, эхийн харьяалал нь дийлэнх нь Хятад, Солонгос, ОХУ-ын байна.*Өөрийн хүсэлтээр Монгол Улсын харьяат болох* ("Монгол Улсын харьяат болсоноор Монгол Улсын харьяат болно"- хуулийн найрууллага) нь натурализацийн аргаар буюу хүсэлт гаргах замаар харьяалалтай болж буй асуудал юм. Улс болгон өөрийн харьяалалдаа "авах" нөхцөл, журмыг өөрөө тогтоодог.

Энэ нь гол төлөв тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суух тодорхой хугацаа, үндэсний хэл, соёл, хууль тогтоомжийн мэдлэг, хүндэтгэл гэх нөхцөл байдаг.

[249] ГИХАЭА-с авсан судалгааны материал

Тухайлбал, АНУ-ын хуулийн 1427 дугаар заалтын 8 дахь дэд заалтад "хүсэлт гаргагч нь АНУ-ад оршин суух зөвшөөрөл хууль ёсны дагуу авсанаас хойш 5 жилээс доошгүй хугацаанд амьдарсан ба харьяат болох хүсэлт гаргасан мужид 6 сарын хугацааанаас багагүй хугацаанд амьдарсан ... ёс зүйн өндөр чанартай, АНУ-ын Үндсэн Хуульд үнэнч, АНУ-ын хөгжил, цэцэглэлтэд болон үйлчилж буй дэг журамд найрсаг хандах..." этгээдэд харьяалал олгох нөхцлийг хуульчилжээ. 2002 оны шинэчлэн найруулсан Харьяатын тухай ОХУ-ын хуулийн 13 дугаар зүйл бүхэлдээ харьяалал олж авах асуудлыг зохицуулсан байна. Энэ зохицуулалтын дагуу үүсэл гарал, харьяалал, үндэс угсаа, хүйс, боловсрол, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзлээс үл шалтгаалан 18 нас хүрсэн, эрх зүйн чадамжтай ОХУ-ын харьяалалгүй этгээд тус улсын харьяалалтай болох хүсэлтийг гаргаж болно. Харьяалал олгох үндсэн нөхцөлийн анхдагчид ОХУ-д байнга оршин сууж буй асуудал юм байна. Таван жил байнга оршин суусан, эсхүл хүсэлт гаргахаас өмнө нь тасралтгүй гурван жил амьдарсан байх шаардлагыг дүрвэгчидын хувьд ОХУ-ын олон улсын гэрээний дагуу энэ хугацаа хоёр дахин бага байж болохоор зохицуулжээ. Харин тасралтгүй хугацаа гэдгийг шууд утгаар нь ойлгохоос гадна сургалт, эмчилгээний зорилгоор 3 сараас ихгүй хугацаагаар хилийн чанадад гарсан байж болох нөхцөлийг тусгажээ.

Манай улсын харьяат болохын тулд амьжиргааны зохих чадвар, эх үүсвэртэй байх; Монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн ба иргэний харьяатын асуудлаар өргөдөл гаргасан өдрөөс өмнө Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тавааc доошгүй жил байнга оршин суусан байх, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанаас тогтоосон бусад тодорхой шалгуурыг хангасан байх, мөн Монгол Улсад байнга оршин сууж байсан гэмт хэрэг санаатайгаар үйлдээгүй байх; Монгол Улсын иргэн болсноор тус иргэний гадаад улстай тогтоосон харилцаа нь Монгол Улсын нэр хүнд, ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх зэрэг нөхцөлийг хангасан байх ёстой байдаг.

Харин Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болно гэжээ.

ОХУ-ын хуулийн зохицуулалтыг манай хуультай харьцуулах бол илүү төстэй байна. Тухайлбал, хуучин ЗХУ-ын иргэн байсан бол, ОХУ-ын иргэнтэй гэр бүл болоод гурваас доошгүй жил амьдарсан, шинжлэх ухаан, техник, соёлын салбарт онцгой амжилт гаргасан, мөн түүнчлэн ОХУ-д онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн гэх зэрэг үндэслэлээр байнгын оршин суух хугацааг нэг жил хүртэл богиносгох тохиолдолыг хуульчилсан байдаг байна.

Монгол Улсын хуулийн дагуу хүсэлт гаргагчийн хувьд тавигдах дээрх шалгууруас гадна түүний хүрээнд төрийн бодлогыг үндэслэн Гадаадын

иргэн, харьяатын асуудал эрхлэх алба тодорхой шалгуурыг тогтоон нийт шалгуурыг хангасан эсэхийг шалгаж тогтоох байгууллага. Энэ шалгуурыг тогтоох журмыг Засгийн газрын тогтоолоор батлахаар хуульчилжээ. Үүний дагуу 2003 онд 62 дугаар Засгийн Газрын тогтоолын хавсралтаар Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам баталсан байна. Үүнд ГИХАЭА нь дараах тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгохоор Ерөнхий сайдад танилцуулан Ерөнхийлөгчид өргөн барьж болно:

1. Засгийн газраас 2003 оны 251 тоот тогтоолоор баталсан Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшлийн жагсаалтад тухайн хүсэлт гаргагчийн эзэмшсэн мэргэжил, мэргэшил хамрагдсан бол;

2. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудаас тухайн хүсэлт гаргагчийг Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсныг нотолж, түүний Монгол Улсын харьяат болох хүсэлтийг нь дэмжсэн бол;

3. Олон улсын нэр хүнд бүхий шагнал хүртсэн буюу шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан бол;

4. Монголд хоёр сая буюу түүнээс дээш америк доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бол. .

Хүсэлт гаргагч нь Монгол Улсад оршин суусан сүүлийн таван жилийн хугацаанд жилд 120 хүртэл хоногийн хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй байж болно.

Практик дээр натурализацийг гэрлэлтийн болон ердийн (гэрлэлтийн бус) журмаар харьяалал олж авах гэж ангилдаг.

Хоёр дахь нь ганцаарчилсан. биечилсэн журмаар харьяалал олж авах гэж ойлгогдох бол нэгдэх нь тухайн улсын иргэнтэй гэр бүл болох, эсхүл үрчлэхтэй холбоотой замаар харьяалалтай болох асуудлыг ойлгоно. Энэ салбарт эмэгтэй хүний гэр бүл болсонтой холбоотой харьяаллын асуудал гарч ирдэг. 1957 оны Нөхөрд гарсан эмэгтэйчүүдийн харьяаллын тухай конвенцийн 1 дүгээр зүйлд хэлэлцэн тохирогч улс болгон эмэгтэй хүний гэрлэлт нь түүний харьяаллын асуудалд нөлөөлөхгүй байх арга хэмжээ авахыг үүрэг болгосон байдаг. Эмэгтэй хүн хүнтэй суухдаа өөрийн харьяаллаа авч үлдэх эсэх сонголт нь хадгалагдаж байх ёстой байдаг. Харин манай хуульд энэ талаарх зохицуулалт тодорхой биш байна. Мөн үрчлэгдэж буй хүүхдийн харьяаллын асуудлыг шийдвэрлэхдээ зөвхөн монголын харьяалалтай хүүхдийг гадаадын гэр бүлд үрчлэхэд хүүхдийн харьяаллыг өөрчлөх боломжтойгоор хуульчилсан байна. Харин үрчилж авч буй эцэг, эх, эсхүл түүний аль нэг нь Монгол Улсын иргэн харин үрчлүүлж буй хүүхэд харьяалалгүй, эсхүл гадаадын иргэн байх тохиолдлыг огт тооцоогүй байна. Харгалзан дэмжигч, асран хамгаалагч нь Монгол Улсын харьяат бол харьяалалгүй, эсхүл гадаадын иргэн хүүхдийн харьяаллыг шийдвэрлэх асуудал мөн орхигдсон байна. Зарим улсын хууль зүйн практикаас үзэхэд дээрх тохиолдолд үрчлэх тухай шийдвэр гармагц гадаадын иргэн, эсхүл

харьяалалгүй хүүхэд нь "шинэ" эцэг, эхийн, эсхүл аль нэгийн харьяаллыг автоматаар авдаг байна[250]. Мөн харгалзан дэмжигч, асран хамгаалагч томилсон тухай шийдвэр гармагц харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн нэг нь л тухайн улсын иргэн байх, нөгөө нь харьяалалгүй иргэн байхад автоматаар холбогдох харьяалалтай болдог байна. Харин харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн нэг нь тухайн улсын иргэн байхад нөгөө нь гадаадын иргэн ба түүний харьяаллыг аваагүй бол хүүхэд автоматаар холбогдох улсын харьяалалтай болдог байна.

Монгол Улсын хуулиар 16-18 насны хүүхдийн харьяаллыг зөвхөн түүний бичгээр өгсөн зөвшөөрөлд үндэслэн харьяаллыг өөрчлөх шийдвэр гаргах бол зарим улсын, тухайлбал, Украин улсын хуулиар хүүхдийн тийм насыг 15-18 нас гэж тогтоожээ.

Хүсэлт гарган Монгол Улсын харьяат болсон байдлыг он, улсаар авч үзвэл дараах байдалтай байна.

Он	Хүний тоо
2001	5
2002	0
2003	0
2004	23
2005	11
2006	25
2007	18
нийт	82

Улс	Тоо
БНХАУ	71
ОХУ	7
Түвд	3
Ирак	1
нийт	82

Хэрэв 5-аас доошгүй жил байнга оршин суусан байх ёстой нь үндсэн шалгуурын нэг бол манай улсад албан болон хувийн хэргээр удаан хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэдийн тоо асар их байна. Өөрөөр хэлбэл жил тутам холбогдох шалгуурыг хангах гадаадын иргэдийн тоо олширсоор байх болно.

Монгол Улсад оршин суух зөвшөөрөл сүүлийн 3 жилд олгосон байдлаар авч үзвэл:

олгосон статус	2005 он	2006 он	2007 оны эхний 8 сарын байдлаар
Албан хэргээр удаан хугацаагаар оршин суух	10448	11512	12251
Бүртгэлээр	11122	16490	17765
Цагаачлах	55	51	51
байнга оршин суух	56	63	71
Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух	244	275	178
Нийт	21925	28391	30316

Гадаадын иргэдийг статусаар нь үзвэл:

[250] 2001 оны Харьяатын тухай Украин улсын хуулийн 11 дүгээр зүйл

оршин суугаа статус	2005 он	2006 он	2007 оны эхний 8 сарын байдлаар
ХХУХОС	533	654	804
АХУХОС	13754	20052	24154
байнга оршин суугч	1074	1094	1144
цагаач	2314	2330	2359
харьяалалгүй хүн	81	75	73
нийт	17756	24205	28534

Энэ тоог (түр оршин суугчийн тоог багтаасан) улсаар авч үзвэл:

Улс	2005 он	2006 он	2007 оны эхний 8 сарын байдлаар
АНУ	1131	1441	1284
БНСУ	1620	2210	2071
БНХАУ	7325	11547	17711
ОХУ	4062	4587	3717
УКРАИН	633	743	681
ЯПОН	427	652	694
БУСАД	3140	4194	5275
Нийт	18338	25374	30149

Харин энэ хугацаанд Монгол Улсын харьяатаас гарсан хүний тоо 300 - гаар их (Монголын харьяатаас гарч Казахстан улсын харьяат болсон 30608 хүнийг оруулаагүй болно) байна.

Он	Хүний тоо
2002	40
2003	12
2004	70
2005	77
2006	126
2007 оны эхний 8 сарын байдлаар	57
нийт	382

Улс	Тоо
Австри	39
БНСУ	148
БНПУ	14
БНЧУ	13
ХБНГУ	149
бусад	19
нийт	382

Энэ нь гадаадын иргэнтэй гэр бүл болж монголоос явж буйтай холбоотой байна. Тухайлбал, гэрлэлтээ бүртгүүлсэн судалгааг он, улсаар авч үзвэл:

Он	Тоо
2000 он	134

Улс	Тоо
БНСУ	



2001 он	186
2002 он	317
2003 он	524
2004 он	686
2005 он	704
2006 он	804
2007 оны I улирал	260
Нийт	3615

ХБНГУ	177
ЯПОН	199
БНХАУ	189
АНУ	114
ОХУ	84
ШВЕЙЦАРЬ	39
БУСАД	381
Нийт	1183

Харьяаллаа сэргээснээр мөн Монгол Улсын иргэн болно. Харьяатын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу хүсэлт гаргагч нь харьяаллыг сэргээн тогтоолгох тухай өргөдлийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаар уламжлан Монгол Улсын Ерөнхийлөгчид гаргана.

Дор дурдсан тохиолдолд Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтооно:

1/үрчлэгдсэнтэй холбогдож Монгол Улсын иргэн энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр иргэний харьяаллаа алдсан;

2/эцэг, эхийн нь харьяалал өөрчлөгдсөнтэй холбогдож Монгол Улсын иргэн иргэний харьяаллаа алдсан бол 18 нас хүрснээс хойш таван жилийн дотор;

3/1921 оны долдугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монгол Улсын харьяат байсан бөгөөд аль нэг гадаад улсын харьяат болсон хүмүүс.

Хэрэв гадаад улсын харьяат болох зорилгоор Монгол Улсын харьяатаас гарсан этгээд гадаад улсын харьяат болж чадаагүй бол өөрийн нь хүсэлтээр Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтооно.

Харин гадаад улсын иргэн болчихоод буцаад Монгол Улсын харьяаллаа сэргээх хүсэлт гаргах тохиолдолд ямар болзол, шалгуураар шийдвэрлэх талаар хууль тогтоомжийн зохицуулалтгүй байна. Зарим улсын практикт гадаад улсын харьяаллаасаа татгалзсанаа нотлохыг шаарддаг ба тийм тохиолдолд хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг байна.

Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэлээр мөн Монгол Улсын харьяат болно. Харьяалалтай холбоотой асуудлаар, тухайлбал, хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулсан олон улсын хоёр талт гэрээг Монгол Улс 1970-1983 оны хооронд нийт таван улстай байгуулсан ба эдгээр улс нь соцлагерийн улсууд юм. БНБАУ, БНАГУ, ЗСБНХУ, БНПАУ, БНУАУ-тай байгуулсан эдгээр гэрээ одоо болтол шинэчлэн байгуулагдаагүй. Мөн нэмж өөр улстай байгуулаагүй байна. Зөвхөн Казахстантай иргэний харьяалалтай холбоотой асуудлаар 1994 онд гэрээ байгуулсан.

Зөвхөн нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар болон Монгол Улсын харьяат болох асуудлаар ерөнхий зохицуулалтын хүрээнд (чиг үүргийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох зохицуулалтыг авч үзэхгүйгээр) онол, зарим гадаад улсын хууль зүйн практиктай харьцуулан дараах саналыг дэвшүүлж байна.

Хоёрдмол харьяаллын хувьд шинэчилсэн найруулагад зөвшөөрөх хандлагыг илэрхийлж хуульчилсан нь Олон улсын эрх зүйн хандлагад үл нийцэж байгаа бөгөөд үүнийг Үзэл баримтлалдаа гадаад зарим улсын жишээгээр баталгаажуулах нь зохимжгүй байна. Тухайлбал, АНУ-ыг ишлэн авчээ, АНУ-ын иргэн болохдоо тангараг өргөдөг ба энэ тангарагыг зөрчих, өөрөөр хэлбэл Америк улсад үнэнч байх үүргээ алдагдуулахад харьяаллаас хасах үндэслэл болдог. Үүнд, өөр улсын паспорт ашиглах, өөр улсад тухайн улсын иргэний үүргээ биелүүлэхэд Америкийн өмнө хүлээсэн үүргээс няцсан гэж үздэг. Мөн гадаад паспортын эхний нүүрт "Паспорт эзэмшигчийн гадаад улсын харьяалалыг хүлээн зөвшөөрөхгүй" гэсэн агуулга бүхий үгс нь цаад утгаараа хоёрдмол харьяаллыг багасгах бодлого баримталж байна гэж үзэх үндэслэлтэй. Харин хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрч буй улсын цөөнгүй нь түүхэн болон үндэс, угсааны хувьд холбоо бүхий улсуудад хоёрдмол харьяаллыг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээ байгуулах боломжтойгоор хуульчилсан байдаг. Тухайлбал, ЗХУ задарч гэр бүл, хамаатан садангаараа хил дамнан тархсантай холбоотойгоор ОХУ энэ асуудлыг зөвшөөрөхөд хүрсэн байдаг.

Хоёрдмол харьяаллыг дагаад сайн талаас гадна хүний эрхийн хувьд сөрөг үр дагавар бий болдог. Тухайлбал, эрхээс гадна давхардмал иргэний үүргүүд бий болно, холбогдох улсууд тохиролцож чадахгүй бол[251] иргэд хохироно. Мөн гуравдагч улсад байхад нь дипломат хамгаалалтаар хангах үүргээсээ аль аль улс нь нөгөөдөө найдан[252] татгалзах магадлал өндөр байдаг.

Нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хоёрдмол харьяаллыг зөвшөөрсөн хэдий ч олон улсын гэрээгээр харьяалалтай болох асуудлыг хассан нь эргээд хоёрдмол харьяаллыг үгүйсгэж буйг илэрхийлсэн болно. Учир нь хоёрдмол харьяаллыг харилцан хүлээн зөвшөөрсөн гэрээнд үндэслэн харьяалалын асуудлыг шийдвэрлэж болох талтай.

Харьяаллын асуудлаар олон улсын гэрээнд үндэслэн харьяаллыг олж авдаг практик дэлгэрсэн байдаг. Манай улс ийм гэрээ байгуулаагүй[253] ч ирээдүйгээ харах нь зохимжтой[254].

Хэдий олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээгээр хэнийг ч харьяаллаасаа хасаж болохгүй ч өнөөгийн зарим улсын практикт улс, үндэсний ашуулгүй байдал, нэр хүнд гэх зэрэг нөхцөлөөс шалтгаалан харьяаллаасаа хасах тохиолдол гарч байна. Үүнийг олон улсын эрх зүйг зөрчиж байна гэж үзэж бас болохгүй юм. Учир нь төрийн санаачлагаар харьяаллаасаа хасах боломж нь зөвхөн харьяаллаа хасуулах гэж буй этгээд нь тухай улсын харьяаллаа натурализацийн аргаар олж авсан ба цаана нь үүсэл гарал, үндэс угсаатай нь хамааралтай улсын харьяалал

[251] АНУ, тухайлбал, хоёрдмол харьяаллын асуудлаар гэрээ байгуулах бодлого баримталдаггүй.

[252]Асуудлын хурцадмал байдлаас шалтгаалан өөрөөсөө зайлуулах бодлого барих хандлагатай байдаг.

[253]Казахстантай байгуулсаныг үл тооцвол

[254]Төсөлд Олон улсын гэрээний үндсэн дээр харьяалал авах тухай хуучин заалтыг хассан байна.



автоматаар сэргэгдэж байх ёстой байдаг. Манай улс мөн цаг үетэйгээ хууль тогтоомжоо нийцүүлэн натурализацийн аргаар харьяалалтай болсон иргэдэд хяналт тавин үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн ямарваа үйлдэлийн төлөө харьяаллаасаа гаргах талаар зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

Натурализацийн аргаар харьяалалтай болох хүсэлт гаргагч нь Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гэдгээр нь ямар ч шалгуур тавилгүй харьяалал олгож болох асуудлыг нягталж үзэн хялбаршуулсан журмаар олгодог болгох нь зохистой болов уу. Мөн тавигдаж буй ерөнхий шалгуурыг тодорхой болгох. Тухайлбал, албаны, хувийн ямар ч хамаагүй зорилгоор 5-аас доошгүй жил Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж байсан бол энэ шалгуурыг хангах боломжтой мэт. Мөн дээд тал нь 140 хоног бас л зорилго тодорхой бус байдлаар хилийн чанадад оршин сууж байсан нь тасралтгүй байнга оршин суусан хугацаанд нөлөөлөхөөргүй байгаа. Зөвхөн сургалт, эмчилгээ гэх зэрэг зорилгоор бол зөвшөөрөгддөг үгүй бол хугацааны тоолуур тэглээд эхнээсээ эхэлдэг байх зэрэг зохицуулалтыг оруулж өгмөөр байна.

Үрчилж авч буй эцэг, эх, эсхүл түүний аль нэг нь Монгол Улсын иргэн харин үрчлүүлж буй хүүхэд харьяалалгүй, эсхүл гадаадын иргэн байх тохиолдолыг шийдвэрлэх зохицуулалтыг хуульчлах шаардлагатай. Харгалзан дэмжигч, асран хамгаалагч нь Монгол Улсын харьяат бол харьяалалгүй, эсхүл гадаадын иргэн хүүхдийн харьяаллыг шийдвэрлэх асуудал мөн орхигдсон байна.

Монгол Улсын харьяаллаа сэргээх хүсэлт гаргах тохиолдолд ямар болзол, шалгуур байх эсэх асуудлыг мөн судлах шаардлагатай байна.

__oOo__

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ СУДАЛГАА

Монгол Улс бол гадаад орчноос шууд хамааралтай, эмзэг эдийн засагтай жижиг улс. Хоёр их гүрний дунд, далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжтай бус нөхцөлд, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн бага эдийн засагтай, хүн ам цөөнтэй орон тул гадаад хүчин зүйлс, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөлд шийдвэрлэх үүрэгтэй. Энэ нь цаашид манай орны эдийн засгийн бүтцийг шинэчлэн хөгжүүлж, улмаар олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцоход чухал ач холбогдолтой хүчин зүйлийн нэг билээ.

Монгол орныг хөгжүүлэх гурван гол хүчин зүйл нь: а) байгалийн баялаг; б) хүн ам; в) гадаадын шууд хөрөнгө оруулалт. Мөн Монголын эдийн засгийн харьцангуй давуу тал нь байгалийн баялаг, хөдөө аж ахуй, юуны өмнө мал аж ахуйн бүтээгдэхүүн юм.

Монгол орны хөгжлийн гарц бол энэхүү давуу тал, онцлогтоо тулгуурлах явдал мөн. Гадаадын хөрөнгө оруулалт нь манай оронд бүхэлдээ хийгээд бүсчилсэн нутаг дэвсгэр, тодорхой аймаг, сум, компанийн хөгжил дэвшил, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг улс төр, эдийн засаг, эрх зүйн чухал хүчин зүйл билээ. Манай улс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр компаниуд бизнесийн үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлэх юм.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хуулиар зохицуулж төрийн бодлогоор дэмжсэнээр компани, орон нутгийн хүрээнд "хөрөнгө оруулалт" хийгдэх бол монгол улсын хэмжээнд тэргүүний технологи, ноу-хау, шинэ менежмент "хөрөнгө оруулалт" хийгдэх боломжтой юм. Гэхдээ сүүлийн жилүүдэд Засгийн газраас явуулж байгаа бодлогоо хэрэгжүүлэхэд "хөрөнгө оруулалт", "гадаадын иргэн" гэсэн хоёр хүчин зүйлийн онцлог, ашиг сонирхлыг сайтар уялдуулах, харгалзан үзэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах, төрийн эдийн засгийн бодлоготой хэрхэн хамааралтай болох, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг шууд хариуцаж байгаа байгууллагын эрх хэмжээ, бүтэц, зохион байгуулалт ямар байх, улсын болон орон нутгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих ажиллагаагаа хэрхэн зохион байгуулах зэрэг тулгамдсан асуудлыг эрх зүйн хувьд цаашид нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлаас гаргасан товхимолд гадаадын хөрөнгө оруулалтыг "хөрөнгө оруулалт хийсэн охин компанитай урт хугацааны туршид харилцаа холбоотой байж үйл ажиллагаанд нь тасралтгүй зохицуулалт хийх зорилготой хөрөнгө оруулалт" гэж тодорхойлжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгийн оролцоо (equitycapital), гадаадын хөрөнгө оруулагчид олсон ашгаараа дахин



хөрөнгө оруулалт хийх (reinvested earnings), толгой компани, охин компани хоорондын зээл (intra - company loans) –ээс бүрдэж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага, хэрэгцээ бий. Түүнчлэн Монгол Улс эдийн засгийн баялаг бий болгож нэмэгдүүлэх явцдаа өөрийн орны имиж бий болгох, сурталчлах зэрэг маркетингийн үйл ажиллагааг төрийн иж бүрэн бодлогын чанартай авч явуулах шаардлагатай бөгөөд энэ талаар Гадаадын хөрөнгө оруулалтын газрын эрх мэдэл ажлын цар хүрээг хуулиар тодорхойлж өргөтгөх бололцоо байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалт дандаа улс төр, эдийн засаг, эрх зүйн эерэг үр дагавар бий болгодоггүй байна. Эдийн засгийг гадаадаас хамааралтай болгох, байгаль орчныг сүйтгэх, импортыг хэт нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн сөрөг үр дагавар бий болгодгийг манай орны эдийн засгийн амьдрал бэлхэнээ харуулж байна.

Монгол Улс дэлхийн бусад орны нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж үр шимийг нь хүртэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж гаргах, гадаадын хөрөнгө оруулалт эрхэлсэн байгууллагыг бий болгон ажиллуулах, хөрөнгө оруулалтын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чухал арга хэмжээ авсаар ирсэн. Үүний үр дүнд 1990-ээд оноос хойш Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт жил бүр 2 сая ам.долларааp өсч 2007 он гэхэд 500 сая гаруй ам.долларт хүрснээс ихэнх нь ашигт малтмал, уул уурхайн салбарт ноогдож байна.

Монгол Улсад 90 орчим орны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийсэн байна. Монгол Улс 40 орчим улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талын хэлэлцээр байгуулжээ.

Социализмын үед нийгэм, эдийн засаг, улс төрийн талаар ихээхэн гажуудал байсан ч Зөвлөлт Холбоот Улс, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн хүрээнд цахилгаан эрчим хүч, барилга, төмөр зам, автозам, хөнгөн, хүнсний үйлдвэр, хөдөө аж ахуй, мал аж ахуйн зэрэг салбарт гадаадын шууд хөрөнгө оруулах замаар ихээхэн амжилт олсныг үгүйсгэж болохгүй юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн эхэн үед буюу 1990-1991 онд Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлт (нийтийн ба хувийн өмчийн тухай), Газрын тосны тухай, Өмч хувьчлах тухай, Аж ахуйн нэгжийн тухай, Банкны тухай, Албан татварын тухай, Гаалийн тухай, Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай зэрэг хууль батлагдсан нь гадаад хөрөнгө оруулалтыг дэмжихэд эрх зүйн чухал баталгаа болсон юм. Үүний нэг нь 1993 оны 3 дугаар сарын 23-нд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль юм.

Экспортыг нэмэгдүүлэх, импортын барааг орлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дэвшилт техник, технологи ашиглан шинжлэх ухааны өндөр түвшинд бүтээгдэхүүн үйлдвэрлэх; үйлчилгээ үзүүлэх; байгалийн баялаг, эрдсийн болон хөдөө аж ахуйн гаралтай төрөл бүрийн түүхий эдийн нөөцийг ашиглаж, гүнзгий боловсруулалттай эцсийн бэлэн бүтээгдэхүүн

үйлдвэрлэх; геологи хайгуулын ажил явуулах; эрчим хүч, зам тээвэр, холбоо зэрэг эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх, гадаадын жуулчдад үйлчлэх баазыг хөгжүүлэх, түүнтэй холбогдсон төрөл бүрийн үйлчилгээг өргөжүүлэх нь энэхүү шинэ хуулийн зорилт байв. Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага байгуулах асуудлыг Засгийн газар 60 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэсний дараа Сангийн яаманд бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулж эхлэхээр хуульд заажээ. Уг хуульд татварын хэмжээ нь ашгийн 40 хувиас хэтрэхгүй байх, эхний 3 жилд ашгийн татвараас чөлөөлөхөөр заасан нь хөрөнгө оруулалтыг төрөөс дэмжих чухал бодлого байв.

Үүний дараа 1990 оны 12 дугаар сарын 21-нд Засгийн газар тогтоол гаргаж тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, тэсрэх, дэлбэрэх, хорт бодисын үйлдвэрлэл, эрдэс, түүхий эдийн эрэл хайгуул, шинжилгээний ажил, олборлох үйл ажиллагааг Засгийн газрын зөвшөөрлөөр шийдвэрлэж байхаар тогтосны гадна улсыг батлан хамгаалах, иргэний хамгаалалттай холбогдсон үйлдвэрлэл, холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (төрийн сонин, радио, телевиз), алт мөнгөний орд газрыг эзэмшихэд гадаадын хөрөнгө оруулалтыг хориглохоор заажээ. Мөн гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагын дүрмийн сан гадаадын оролцогчдын хувь хэмжээний дээд хязгаарыг эрдсийн болон хөдөө аж ахуйн түүхий эд олборлох, үйлдвэрлэх салбарт 49 хувь, үндэсний соёл, урлагийн салбарт 30 хувь байхаар шийдвэрлэсэн байна.

Энэ үед мөн зах зээлийн эдийн засгийн суурь өөрчлөлт болох үнэ чөлөөлөх, төрийн өмчийг хувьчлах, мал хувьчлах, гадаад худалдаа, эдийн засгийг либеральчлах үйл явдлыг эхлүүлсэн нь хөрөнгө оруулах таламжтай орчин, хөрс суурь болсон юм.

Үүний дараа 1993 оны 5 дугаар сарын 10-нд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр баталсан бөгөөд энэ хуульд 1998, 2002, 2008 онд зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ хуульд "Гадаадын хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ" гэж хөрөнгө оруулалтын үндсэн ойлголтыг тодорхойлсон байна. Энэ хуулиар гадаадын хөрөнгө оруулагч, монголын хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын гэрээ, нэг цэгийн үйлчилгээний талаар шинэ зохицуулалт нэмсэн байна.

Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийж болохыг хуулиар тодорхойлсон байна. Аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийн тухай хуульд (2001) зааснаар хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах (эмнэлгийн зориулалтаар зэрэг тусгайлан зөвшөөрсөн бол үүнд хамаарахгүй), садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих, казиногийн үйл ажиллагаа эрхлэх (чөлөөт бүсэд хамаарахгүй), олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд хориотой юм.

Монгол Улсад оруулах гадаадын хөрөнгө оруулалт нь эрх зүйн хувьд: а/ чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнг тегрегөөр олсон орлого; б/ хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх; в/ оюуны өмчийн эрх гэсэн гурван үндсэн төрөлтэй байна.

Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтыг эрх зүйн хэлбэрийн хувьд: а/ аж ахуйн нэгж байгуулах; б/ монголын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах; в/ Монгол Улсын аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах замаар шууд бус хөрөнгө оруулалт хийх; г/ байгалийн баялгийг ашиглах, боловсруулах талаар хууль, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эрх олж авах; д/ маркетинг, менежментийн гэрээ байгуулах; е/ санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлбэрээр хэрэгжих боломжтой юм.

Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын хууль, олон улсын олон талт болон хоёр талын гэрээгээр эрх зүйн хувьд баталгаажсан байна. Юуны өмнө гадаадын хөрөнгө оруулалтыг хууль бусаар хураан авахыг хориглосон байна. Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс, зөвхөн хуульд заасан журмын дагуу, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан гаргуулж болно.

Эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, түүний дотор аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөд хувь хөрөнгө болгон оруулсан эд хөрөнгөө гадаадад буцаан гаргах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох, бусад этгээдэд эрх, үүргээ шилжүүлэх нь Монгол Улсын хуулиар гадаадын хөрөнгө оруулагчдад олгосон өргөн эрх юм.

Монгол Улсын хууль болон дүрэм, гэрээний заалтыг сахин биелүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах, монголын ард түмний үндэсний ёс заншлыг хүндэтгэх үүргийг гадаадын хөрөнгө оруулагчдад хуулиар оногдуулжээ.

Монгол Улсад аж ахуйн нэгж байгуулахын тулд өөрийн хөрөнгө нь 100 мянган ам.доллараас дээш байх, түүний 25-аас доошгүй хувь нь хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн байх шаардлагатай юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө хуулийн этгээдийн эрх эдэлнэ. Харин аж ахуй нэгж байгуулах, зөвшөөрлийг Гадаадын хөрөнгө оруулалтын газар мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан дүгнэлтийг (хуульд нийцэж байгаа эсэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэх, техник, технологийн түвшний үнэлгээ) үндэслэн олгоно.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид татварын хууль тогтоомжийг үндэслэн татвар ноогдуулахын зэрэгцээ Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Газрын тухай хуулийн дагуу зохих хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлэж байна.

Монгол Улсын зах зээлд хөрөнгө оруулагчийг татах эрх зүйн нэг чухал хэлбэр нь "Тогтвортой байдлын гэрээ" юм. Монгол Улсад 20 сая ам.доллараас доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг 20 жил, 50 сая ам.доллараас дээш бол 15 жилээр гэрээ байгуулна.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын нэг чухал асуудал бол газрын харилцаа юм. Гадаадын хөрөнгө оруулагчид газрыг төлбөртэйгээр, гэрээний үндсэн дээр ашиглуулах бөгөөд газар ашиглах гэрээний үндсэн хугацаа эхний ээлжинд 60 жил, дараагийн удаа 40 жилээр сунгаж болно.

Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиас гадна Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай (1993), Иргэний хууль (2002), Хөдөлмөрийн тухай (1999), Компанийн тухай (1999), Аудитын тухай (1997), Дампуурлын тухай (1997), Аялал, жуулчлалын тухай (2000), Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай (2000), Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (2001), Ажиллах хүч гадаадад гаргах, Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001), Үнэт цаасны зах зээлийн тухай (2002), Төв банкны тухай (1996), Валютын зохицуулалтын тухай (1994), Банкны тухай (1996), Гаалийн тухай (1996), Гаалийн тарифын тухай (1996), Газрын тухай (2002), Газрын төлбөрийн тухай (1997), Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай (2006), Хувь хүний орлогын албан татварын тухай (2006), Онцгой албан татварын тухай (2006), Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай (2006) зэрэг хуулиар зохицуулж байна.

Эдгээр хуулиар гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж болох бөгөөд цаашид тэдгээрийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах, мэдээлэл, технологи, татвар, үйлдвэрлэлийн чиглэлээр олон хууль шинээр батлан гаргах нь зүйтэй юм.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс Засгийн газраас бодлогын чанартай олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Засгийн газар 2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгох тухай шийдвэр гаргаж, уг ажлыг зохион байгуулах, зохицуулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн болон хөрөнгө оруулалтыг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, түүний дагуу олон төрлийн арга хэмжээ зохион байгуулжээ. Мөн 2007 оныг Монголд зочлох жил болгох тухай Засгийн газрын шийдвэр гарч аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулжээ.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн өөр нэг бүлэг хууль бол Чөлөөт бүсийн тухай (2002), Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай (2002), Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай (2003), Цагаannуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай (2003) хуулиуд юм. Хэдийгээр эдгээр хууль хөрөнгө

оруулалтын асуудлыг боломжийн хэмжээнд зохицуулсан боловч төрийн албаны хүнд суртал, гадаад сурталчилгаа, хөрөнгө оруулагчдыг татах бодлого, хөрөнгийн гачигдал, ажлын арга барил, зохион байгуулалтаас шалтгаалж тун хангалтгүй хэрэгжиж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

1. Нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл

№	Нийтлэлийн нэр	Нийтлэл бичсэн	Эх сурвалж
1	Чөлөөтбүсийнэрхзүйнзохицуулалтын зарим асуудал	А. Энх-Амгалан /Олон улсын эрх зүйч/	Хууль дээдлэх ёс сэтгүүл 2003 он №2/02/
2	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай олон улсын эрх зүй ба гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль	Ч. Нарантуяа /ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	Хууль дээдлэх ёс сэтгүүл 2004 он №2 /05/
3	Гадаад орнууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын төлөв байдал, эрх зүйн зохицуулалт	Ж. Соёлмаа /ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан/	Хууль дээдлэх ёс сэтгүүл 2008 он №1 /20/
4	Гадаад эдийн засгийн гэрээ хэлцэл, хэлцлээс үүсссэн маргааныг шийдвэрлэх нь	Б. Батбаяр	Эрх зүй сэтгүүл 2003 он №8-9
5	Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талт гэрээ	П. Цагаан	Эрх зүй сэтгүүл 2003 он №8-9
6	Монголын феодалын нэгдсэн улс үүсэх үеийн олон улсын эрх зүйн хөгжил	Ц. Сарантуяа, Ж. Бямбагарав	Ардын төр сэтгүүл 1989 он №2
7	Гадаад худалдааны хэлцлээс үүдсэн маргааныг шийдвэрлэх журам	Д. Уянга	Монголын төр, эрх зүй 2001 он №4
8	Арбитрын хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуулийг зөв хэрэглэх нь	Б. Цогнам	Монголын төр, эрх зүй 2004 он №1
9	Mongolian Foreign Investment Regulations	С.Должин	Asia Law Quarterly Vol. 1, No.2 October 2009

Ном, гарын авлага

№	Нэр	Зохиогч болон хянан тохиолдуулсан	Хэвлэгдсэн газар, он
1	Олон улсын эдийн засгийн харилцааны зарим асуудал	Х. Олзвой	УБ, 1983
2	Олон улсын эдийн засаг ба олон улсын худалдааны бодлого	Т. Цэнд-Аюуш	УБ, 2000
3	Олон улсын татварын тогтолцоо /тэргүүн дэвтэр/	Б. Ганхүлэг	УБ, 2002
4	Олон улсын татварын эрх зүйн тогтолцооны удиртгал	О. Чулуунцэцэг	УБ, 2003
5	Олон улсын эдийн засгийн эрх зүй	П. Амаржаргал, Ш. Оюунтунгалаг	УБ, 2004
6	Олон улсын иргэний эрх зүй	О. Өнөрцэцэг	УБ, 2005
7	Олон улсын худалдаа	Э. Гүргэмжав	УБ, 2000
8	Олон улсын хувийн эрх зүй	Богуславский	
9	Управление инвестициям	Фабоци	Москва, 2000

10	Правовая поддержка инвестиций	Пепеляев, Гольцбат и партнеры	Москва, 2006
11	Инвестиции	Шарп Уильям Ф, Александр Гордон Дж, Бейли В. Джеффри	Москва, 1999
12	Правовые отношение государства и инвесторов	Кирин А.В	Москва, 1998
13	Международное экономическое право	Шумилов В.М	Москва, 2001
14	Международное экономическое право	Карро Д, Жюайр П	Москва, 2002
15	Международное частное право	Ануфриева ЛвП	Москва, 2000
16	Международное частное право	Звеков В.П	Москва, 2000
17	Международное частное право	Милищенко	Москва,
18	Finance investments using the wall street journal	Peter R. Crabb	Boston, McGraw-Hill Companies, 2003
19	Investment	Bodie Zvi	Boston, McGraww-Hill Companies, 1999
20	The basics of investing		New-York, Jhon Wiley, Sons& Inc, 1989
21	Economic laws on foreign investment in Korea		Seoul, Hwimoon, 2003
22	Private capital flows to developing countries: the road to financial integration		Washington, Oxford University, 1997
23	The legal problems of investments in developing countries	Nwogugu E.I	Oceana publications, inc, 1965
24	Mongolian Foreign Investment Regulations	S.Doljin	KLRI, October 2009

II. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн хөрөнгийг эзэмшигч нь бүхэлд нь буюу хэсэгчлэн хяналтдаа байлгаж давуу талыг нь ашиглан хөрөнгө босгох зорилгоор нэг улсаас нөгөө улс руу бодитой ба бодитой бус эд хөрөнгийг шилжүүлэх тухай ойлголт юм. Нөгөө талаас, санхүүгийн хэрэгсэл болон эд хөрөнгийн зүйлсийг ирээдүйд ашиг олох зорилгоор урт хугацаагаар байршуулах явдал хэмээн тодорхойлж болно. Ямар объектыг хөрөнгө болгон оруулж байгаагаас нь хамааран санхүүгийн хөрөнгө оруулалт /хувьцаа худалдан авах гэх мэт/ ба эд юмсын хөрөнгө оруулалт хэмээн ангилдаг. Эд юмсын хөрөнгө оруулалт нь маш онцгой ач холбогдолтой, учир нь ирээдүйд хийж болохуйц үйл ажиллагаа болон өрсөлдөх чадварыг тодорхойлон, ингэснээрээ үндэсний эдийн засгийн өсөлтийг тодорхойлж байдаг.

Эдийн засаг хэр хурдан өсөх нь үйлдвэрлэлд хэрэгжүүлж болохуйц эд

хөрөнгийн /машин, үйлдвэрлэлийн байр, дэд бүтэц/ хувьцааны хэмжээнээс ихээхэн хамаардаг. Энэхүү хөрөнгө оруулалт нь эргээд тухайн улсын хөрөнгийн зах зээлийн хэмжээ, чанарыг тодорхойлж эхэлнэ. Хөрөнгө оруулалт нь үр дүнтэй тохиолдолд хөрөнгийн зах зээлд эзлэх байр суурийг томосгож, олон тооны ажлын байр бий болох, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх, шинэ техник технологийг дамжуулан авах, тодорхой салбарт чадварлаг боловсон хүчинтэй болох зэрэг олон давуу талыг хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсад бий болгодог. Иймээс ч учраас улс гүрнүүд, ялангуяа буурай хөгжилтэй болон хөгжиж буй улсууд гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхитэй татах бодлогыг явуулж, ингэснээр үндэсний эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилготой байдаг. Иймээс гадаадын хөрөнгө оруулалт гэж чухам ямар үйл ажиллагааг хэлдэг талаар эдийн засгийн болоод эрх зүйн нэгдсэн ойлголттой байх нь чухал юм.

Хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрүүд дэх гадаадын хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолт

Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх тусгайлсан хууль батлан мөрдөж буй улс гүрэн нилээдгүй бий. Тэдгээрийн тоонд Монгол Улс багтах бөгөөд өнөөдөр 1993 онд батлагдсан "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль" хүчин төгөлдөр үйлчилж байна.

Тус хуульд гадаадын хөрөнгө оруулалтыг "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлийг хэлнэ" хэмээн тодорхойлжээ.

Эндээс харахад хөрөнгө оруулалт гэдэгт:

1/ эд хөрөнгийн үнэт зүйлс.

2/ эд хөрөнгийн бус үнэт зүйлс нэгэн адил хамаардаг.

Энэ нь ч Монгол Улсаас бусад улстай байгуулсан Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээрүүд дэх тодорхойлолтоос илэрхий харагдана.

Тухайлбал, Бельги улс, Люксембургийн вант улстай байгуулсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр"-т "эдийн засгийн аливаа салбарт биетээр болон үйлчилгээгээр шууд ба шууд бусаар оруулсан үнэ өртөг бүхий зүйлсийг хэлнэ" хэмээн тодорхойлсон ба энэхүү үнэ өртөг бүхий зүйлс гэдэгт юу юуг хамруулахыг нарийвчлан заажээ. Үүнд, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө, тэрчлэн дэнчин, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх болон тэдгээртэй адилтгах бусад эрх, хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрт байгуулагдсан компанийн хувьцаа, өмчлөх эзэмших бусад эрх, түүнчлэн шууд бусаар эзэмших эрх, облигаци, мөнгөн төлбөр шаардах эрх болон эдийн засгийн холбогдолтой аливаа гэрээний дагуу төлбөр шаардах эрх, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрх, техникийн процесс, худалдааны нэр хүнд, хууль тогтоомж болон гэрээгээр олгосон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл /концесс/, тухайлбал, байгалийн нөөц баялгийг хайх, олборлох, боловсруулах ашиглах эрхийг тус

тус хамааруулжээ.

Гэхдээ энд дурдсан бүхнээр хөрөнгө оруулалт нь хязгаарлагдахгүй бөгөөд, хөрөнгө оруулалтыг хүлээн авч буй улсын хууль тогтоомжид харшлахгүй бол ямар ч төрлийн үнэ өртөг бүхий зүйлийг хөрөнгө оруулалт гэж үзэхээр тусгасан байна /Гэрээний 1.2/.

Дэлхийн худалдааны байгууллагын Уругвайн үе шатны үр дүнд батлагдсан хэлэлцээрүүд болох Үйлчилгээний худалдааны тухай хэлэлцээр, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр болон Санхүүгийн үйлчилгээний талаар хүлээх үүрэг амлалтын тухай харилцан ойлголцлын баримт бичиг зэрэгт гадаадын хөрөнгө оруулалтын талаар зарим нэг зохицуулалтыг тусгасан байдаг. Жишээ нь, Үйлчилгээний худалдааны тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2-д, нэг гишүүн орны нутаг дэвсгэр дээр бусад гишүүн орны иргэн, хуулийн этгээд ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгуулах нь үйлчилгээний худалдааны нэг төрөл болохыг заасан байна. Энэ нь агуулга, хэлбэрийн хувьд гадаадын хөрөнгө оруулалт гэдэгт бүрэн хамаарах төрөл юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх олон тооны хэлэлцээрүүд, ялангуяа АНУ болон бусад капитал экспортлогч улсуудын боловсруулсан загвар гэрээнд гадаадын хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолтын цар хүрээ ихээхэн өргөжиж байгаа. Үүний зэрэгцээ тавьж буй зорилго нь гадаадын шууд хөрөнгө оруулалттай нийцэх өргөн хүрээний хэд хэдэн үйл ажиллагааны хувьд байгуулж буй гэрээгээр хамгаалалт бий болгоход баталгаа өгөх явдал юм. Энэхүү зорилго нь арбитрын шүүх болон энэ салбар дахь зохиогчдын өргөн дэмжлэгийг авсан болно. Энэ нь түүнийг өргөжүүлэхээс гадна гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж буй этгээдэд ойлголт өгөхөд чухал ач холбогдолтой юм.[255]

Хөрөнгө оруулалт гэсэн ойлголтын томьёолол нь ГШХО-ыг татах, түүнээс олох ашгийг нэмэгдүүлэхэд шууд нөлөө үзүүлдэггүй. Гэхдээ ямар нэгэн актив эсвэл капиталын олон төрлийн хөдөлгөөнийг "хөрөнгө оруулалт" гэж тодорхойлох нь гадаадын хөрөнгө оруулагчдад тодорхой хэмжээний эрх олгож гадаадын хөрөнгө оруулалтыг хөнгөвчилдөг байна. Мөн талуудын сонирхол татсан харилцааг төрүүлдэг. "Хөрөнгө оруулалт" гэсэн хэллэг нь нэгдсэн утга илэрхийлдэггүй. Олон улсын практикт төлбөрийн балансын статистикийг хөтлөх үед гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг ангилж, бүртгэж байгаа аргаар бол хөрөнгө оруулалтыг шууд хөрөнгө оруулалт, портфелийн хөрөнгө оруулалт, санхүүгийн деривативууд, бусад хөрөнгө оруулалтууд гэж ангилж байна.

Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээрүүдэд "хөрөнгө оруулалт" гэсэн ойлголт нь тодорхой заалтуудын хамт уг гэрээ хэлэлцээрийн цар хэмжээ үйлчлэх хүрээг тодорхойлж байдаг учраас эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой. Хөгжиж буй орнуудын хувьд гэрээ, хэлэлцээрт зөвхөн ГШХО-нд төвлөрсөн хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал тодорхойлолт өгөгдөж байна уу, эсвэл гадаадын хөрөнгө

[255] M. Sornarajah. The international law on foreign investment. New York 2004., 9 дүгээр тал.

оруулагчидтай ямар нэгэн байдлаар холбоотой арай өргөн ямар ч активийг хамарсан тодорхойлолт өгөгдөж байна уу гэдэгт гол асуудал байдаг ажээ.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн үүсэл, үйлдвэрлэх хүчний хөгжил, улс гүрнүүд байгуулагдан хөгжсөнтэй уялдаж энгийн солилцоо арилжаанаас олон улсын худалдаа, олон улсын эдийн засгийн харилцааны хэлбэрүүд хөгжиж нэлээд хожим дэлхийн зах зээл бүрэлдсэн билээ. XIX зууны сонгодог эдийн засгийн, тухайлбал Адам Смит, Давид Рикардо нарын онолчид олон улсын худалдааг интернациональчлал болон дэлхийн эдийн засгийн интеграчлалын хөдөлгүүр гэж үзэж байжээ. Худалдааг хөгжүүлэх замаар интернациональчлах процессууд нь ялангуяа тухайн орон "харьцангуй давуу талдаа" тулгуурлан төрөлжвөл үндэсний аж байдлаа дээшлүүлэгч хурдасгагч мөн гэж үзэж байжээ. Францын "интервенционистууд"-ыг бодвол англи, хойд америкийн "чөлөөт худалдаачид зах зээлийн "үл үзэгдэгч" гарын үйлдэлд төрийн оролцоо хамгийн бага байж, эдийн засгийг өөрийнх нь явцаар хөгжүүлбэл тэнцвэрээ өөрөө үргэлж олно гэж онцгой ач холбогдол өгч байв. Олон улсын худалдааг анх англи, францын компаниуд өөрсдийн хянаж байсан далайн чанад дахь колониудад хөгжүүлж, шинэ үйлдвэрлэл нээн хөгжүүлж байсан ба энэ нь АНУ-д бүх дэлхийг хамарсан хөгжингүй сүлжээтэй үндэстэн дамнасан корпорациуд /УДК/ бий болсон 50-иад он хүртэл үргэлжилжээ. Эдгээр корпорациудын заримынх нь эзэлсэн тэргүүлэх байдал нь өөрсдийн хүн хүч, санхүүгийн нөөцийг өсөж байгаа Латин Америк, Европын зах зээлд хөрөнгө оруулалтын хэлбэрээр шилжүүлэн байрлуулах боломж олгож, энэ нь дайны дараахь жилүүдэд тэдгээр орнуудын эдийн засгийг өөрчлөх сайн үр дүнд хүргэжээ.

1990 онд анх баталж 1993, 1998, 2002, 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, гадаадын дагнасан аж ахуйн нэгж байгуулах зэрэг хөрөнгө оруулалтын чөлөөт горим, хамгаалалт эдлэх боломж олгодог бол, татварын багц хуулиудаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломж олгож байв.

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэх нь манай гадаад бодлогын эрхэм зорилт бөгөөд энэ чиглэлээр Монгол Улсын Засгийн газар тодорхой алхмууд хийж "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай" хэлэлцээрт 33 улстай "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр"-т 39 улстай тус тус гарын үсэг зурсан ба "Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" 1965 оны Вашингтоны конвенцид 1996 онд, "Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай" 1985 оны Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон. Хөрөнгийн нөөцийн дутагдалаас болж гадаад санхүүжилт болох ГШХО болон гадаадын зээл тусламж нь Монгол Улсын эдийн засгийг тэтгэх, өсгөхөд чухал үүрэг гүйцэтгэж байна.

"Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" Монгол Улсын хуульд "гадаадын хөрөнгө оруулалт" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ гэж томъёолжээ.

Мөн гадаадын хөрөнгө оруулалтын төрөлд:

Нэгдүгээрт, чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнд төгрөгөөр олсон орлого;

Хоёрдугаарт, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх;

Гуравдугаарт, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрхийг тус тус хөрөнгө оруулалт хийж болно гэж заасан байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Улс төр, үзэл суртлын догмаас болж одоогийн шилжилтийн эдийн засагтай орнуудын эдийн засагч, улс төрчид олон арван жилийн туршид үндсэндээ дэлхийн эдийн засгийн интеграци, үндэсний эдийн засагт ГШХО-ын үзүүлэх үр нөлөөг судлах, хэлэлцэхээс гадуур явж иржээ. Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ГШХО-ын бодлого, ГШХО-ын тэдний үндэсний эдийн засаг болон дэлхийн худалдаанд нөлөөлж буй байдлыг онол практикийн үүднээс түүхэн нөхцөл байдалтай нь уялдуулан судлах нь шилжилтийн эдийн засагтай орнууд, тухайлбал, манай оронд гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого боловсруулах, тааламжтай нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагчийн урт хугацааны эдийн засгийн сонирхол дээр үндэслэгддэг. Шууд хөрөнгө оруулалт нь аж ахуй эрхлэгч субьект болох аль нэг улсын төлөөлөгч /резидент/ нөгөө улсын төлөөлөгч /резидент/ болох үйлдвэр аж ахуйн газарт удаан хугацаагаар сонирхох олон улсын хөрөнгө оруулалтын категори юм. Удаан хугацааны сонирхол гэдэг нь шууд хөрөнгө оруулагч болон үйлдвэр аж ахуйн газрын урт хугацааны харилцаа болон хөрөнгө оруулагчийн зүгээс уг үйлдвэр аж ахуйн газрыг удирдах ихээхэн нөлөөг хэлнэ. Хөрөнгө оруулалтанд хувь нийлүүлсэн капитал /нийт капиталын 10-аас доошгүй хувь/ буцааж хөрөнгө оруулсан ашиг ба фирмийн доторх өрийн гэрээнүүд хамаарна. Өрийн гэрээнүүд нь зээлүүд, шууд хөрөнгө оруулагчид тэдгээрийн салбаруудын нийлүүлэгчийн өрийн бичгүүд ба зээл гэж хуваагдана.

Хорьдугаар зууны 50-иад онд классик болон неоклассик концепцийн /Рикардо, Хекшер- Олин- Самуэльсон/ дагуу эдийн засагчид, улс төрчид улс орны эдийн засгийн өсөлт нь тухайн улсын олон улсын худалдааны масштабыг тодорхойлж байдаг гэж үзэж байжээ. Энэ хандлагаар бол үндэсний эдийн засаг нь үйлдвэрлэлд харьцангуй давуу талтай таваарынхаа экспортыг өргөжүүлэх хэрэгтэй. Хөгжиж буй орнуудын хувьд ийм таваар нь түүхий эдийн салбарын, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд байв. Учир нь ихэнх хөгжиж буй орнуудын хувьд илүүдэл ресурс нь өргөн

уудам хөдөө аж ахуйн талбай, түүхий эд байжээ. Эдийн засгийн өсөлтийн энэ концепцийн хүрээнд тэр нь газар болон түүхий эдийн орд газрыг эзэмшиж, эдгээр орд газрын капитал багтаамжтай боловсруулалтыг эрхлэж, анхдагч бүтээгдэхүүнүүдийн экспортын дэд бүтцийг хангах ёстой байв. Ингэхдээ олон үндэстний томоохон компаниудын зүгээс эдийн засагт оролцох идэвхтэй оролцоог хангаж байсан байна. Учир нь төрөөс гадна эдгээр бүтэц нь анхдагч түүхий эдийн ресурсын экспортыг өргөжүүлэх анхан шатны зардлыг хангахад хүрэлцэхүйц капиталыг хангах чадвартай байв. Гэвч олон улсын худалдааны дэглэмийн төгс бус байдал, ихэнх дэлхийн зах зээл дэх олигополь байдал, хөгжингүй орнуудын зүгээс ялгаварласан үнийн байдал болон бусад хүчин зүйлүүд нь харьцангуй давуу талын үндсэн дээрх олон улсын чөлөөт худалдаа нь хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтийн "бүх өвчний эм" гэж үзэхийг болиулахад хүргэсэн байна.

Хорьдугаар зууны 60-аад оноос үндэсний материаллаг үйлдвэрлэлийн суурь салбаруудыг хөгжүүлж, өөрсдийн үйлдвэрлэлээр бэлэн бүтээгдэхүүний импортыг орлуулах замаар улс орны олон улсын худалдааны хамаарлыг багасгах нь эдийн засгийн өсөлтийн үндэс болно гэсэн концепци давамгайлах болсон байна. Импорт орлуулах бодлого нь хөгжиж буй орнуудын бүхэл бүтэн үеийн уриа болжээ. Энэ хөгжлийн загварын хүрээнд улсын секторт "үндсэн хөдөлгүүрийн" үүрэг оногдож, өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн гол суурь салбарыг хөгжүүлэх тэргүүлэгч хүч гэж үзэх болжээ. Хөгжиж буй орнуудын зах зээл дэх олон улсын монополийн үйл ажиллагааны нөхцөл хатуурч өмчийн зарим хэсэг болон үндэсний хувийн компаниудын өмчийн зарим хэсэг улсын өмчид очин нийгэмчлэгдэж, төрийн өмчийг удирдах, гадаадын хөрөнгө оруулалтыг хянах том хүнд суртлын систем тогтож эхэлжээ.

Жараад оноос ГШХО-ын онол, концепци тогтмол нэмэгдэж баяжиж ирсэн боловч энэ нь улс үүрнүүдийн удирдлагууд, улс төрчдөд тодорхой компанийн үйлдэлийг урьдчилан тодорхойлж харах, олон улсын капитал, технологи ноу хаугийн шилжилт хөдөлгөөнд үр ашигтай нөлөөлөхөд туслаж чадахгүй байгаа юм. Гэвч зарим үзэл баримтлал нь эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэлийг өсгөхөд ГШХО-ын талаарх баримтлах бодлого боловсруулахад ихээхэн тус нэмэр болсоор байна. Эдийн засгийн үндэстэн дамнах үйлявц, корпорацуудын хөрөнгө оруулах үйлажиллагааг тайлбарлах онолын үндэс, үзэл баримтлалыг К.Акамацу, Коджима, Озава, Р.Вернон, М.Портер, Дж.Даннинг, Нарула, Г.Хаймер, Киндльбергер, Грэм, Баккли, Кассон, П.Фишер нарын олон эрдэмтэд судлаачид судлан боловсруулжээ.

Хорьдугаар зууны 70-аад оноос макро эдийн засгийн тогтворгүй байдал өсөж, тухайлбал инфляци өсөж, уг системийн үр ашиггүй байдал илрэх үед янз бүрийн хөгжиж буй орнууд янз бүрийн цаг хугацаанд эдийн засгийн өсөлтийн өөр загварт шилжин орох болсон байна. Хөгжиж буй орнуудын импорт орлуулах бодлогын бүтэлгүйтлийн шалтгаан нь тэдгээрийн хаалттай байдал дахь зах зээлийн бага багтаамж, үйлдвэрлэлийн масштабаас эдийн засгийн эффектийг хэрэглээгүй, аж үйлдвэрлэлийн суурь салбаруудад

харьцангуй капитал багтаамжтай технологийг эрчимтэй нэвтрүүлсэнээс болж нэмэгдсэн ажилгүйдэл, протекционист хандлага нэмэгдсэнээс дотоод зах зээлд өрсөлдөөн багассанаас болсон байна. Эдийн засгийн өсөлтийн шинэ загвар нь олон улсын хөдөлмөрийн хуваарьт хөгжиж буй орнууд үйлдвэрлэлээ өсгөх, хөдөлмөр багтаамж ихтэй аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар оролцоогоо тэлэхэд үндэслэгджээ. Өөрөөр хэлбэл өөрсдийн үндэслэлдээ харьцангуй давуу талын концепцийг ашиглажээ. Энэ загварт хөгжиж буй орнуудын харьцангуй давуу тал нь мэргэшил багатай болон мэргэшилгүй ажиллах хүчний нийлүүлэлтийн илүүдлээр тодорхойлогдож байна. Тээврийн бага зардал, олон үндэстний компаниар дамжуулж хөгжингүй орнуудаас хангалттай хэмжээний капитал, технологийг импортлох нөхцөлд хөгжиж буй орнуудын хувьд хөдөлмөр багтаамжтай аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болох нэхмэл, гутал, спортын хэрэгслийн болон бусад үйлдвэрлэл нь дэлхийн худалдаан дахь төрөлжилтийн үүднээс үзвэл ашигтай болж байна. Эдийн засгийн өсөлтийн энэ загварын хүрээнд төрийн зүгээс аж үйлдвэрлэлийн томоохон хүрээнүүдийг хувьчилж, ГШХО-ыг урамшуулж, дэд бүтцийн салбаруудыг санхүүжүүлж, эдийн засгийг либералчилж байна.

Эдийн засгийн өсөлтийн энэхүү концепци нь хөгжиж буй орнуудад янз бүрийн ололттойгоор одоо хүртэл хэрэглэгдсээр байгаа ажээ. Эдийн засгийн транснациональчлал, ГШХО-ыг дамжуулагч корпорациудын хөрөнгө оруулалтын үйл хөдлөлийн онолын үндэсийг хангах эдийн засаг, бизнесийн олон улсын стратеги, маркетинг, мөн политологи, социологи зэрэг шинжлэх ухаан-практикийн салбарууд бий. Эдгээр салбар тус бүр гадаадын хөрөнгө оруулалтын үйл явцын урьдчилсан нөхцөл, шинжийн тухай ойлголтыг өөрийн онцлог үзэлийн үүднээс ойлгоход дэмжлэг болдог. Дэлхийн эдийн засгийг судалдаг тэргүүлэх эрдэмтэн-судлаачдын бүтээлүүд онолын томьёолол, парадигм нь зарим орнуудын улс төрчдөд ГШХО-тай холбоотой шийдвэр гаргахад нөлөөлсөөр байна.

ЗХУ задарснаар XX зууны 80-аад онд ЭЗХТЗ-д байсан социалист орнууд зах зээлийн эдийн засагт шилжихдээ "шилжилтийн эдийн засагтай орнууд" гэсэн бүлэг орнуудыг бий болгосон. Үүнээс өмнө тэд гадаадын хөрөнгө оруулалтаас бүрэн хаалттай байлаа. Үйлдвэрлэлийн зохион байгуулалт, удирдлагыг засгийн газрын төлөвлөгөөний байгууллагууд хэрэгжүүлж нөөцүүдийг хуваарилж, зорилтуудыг тодорхойлдог байв. Салбарын яамдууд эдгээр зорилтуудыг хэрэгжилтийг хянадаг байв. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ хатуу тогтоогдож, эрэлт нийлүүлэлтийн ямарч харилцан үйлчлэлгүй байлаа. Өөрчлөн байгуулалтын хэлбэр, хурдацараа ялгаатай боловч төвлөрсөн төлөвлөлт, үнийн зохицуулалтаас татгалзсанаар улсын төсвийн хомсдол нь огцом инфляцийн тэсрэлтийг бий болгож, ҮНБ болон аж үйлдвэрлэл нь огцом унаснаар эдгээр орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшин хойш ухарч ҮНБ-ний өсөлт, хэмжээгээрээ хөгжиж буй орнуудын дундаж түвшинд очсон байна. Энэ нөхцөлд шилжилтийн эдийн засагтай орнуудын эхний зорилт нь тогтворжуулалт байлаа. Зарим оронд инфляцийг тогтоон барьж, үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, зарим оронд үйлдвэрлэлээ

өсгөж эхэлж чадсан байна. Стратегийн зорилт болох төрийн өмчийн хувьчлал нь ихэнх оронд амжилттай хэрэгжиж байгаа боловч улс орнуудад янз бүрийн хурдацтайгаар хэрэгжиж байна. Зах зээлийн өөрчлөлтийн гол элемент нь нээлттэй эдийн засагт шилжих, тухайлбал гаалийн тариф болон бусад худалдааны саад хоригийг арилгах, валютийг хөрвөх чадвартай болгох, гадаад эдийн засгийн харилцааг өөрчлөх явдал байв. Эдийн засагтаа гадаадын хөрөнгө оруулалтыг татахад ихээхэн анхаарал тавьж байна. Унгар, Чех, Польш зэрэг орнууд нэлээд амжилт олоод байна.

2. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ, БАТАЛГААНЫ АСУУДАЛ

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудал хөгжингүй улс орнуудад төдийлэн хурц тавигддаггүй байхад хөгжиж буй орнуудад тухайн асуудлыг нухацтай авч үздэг байна. Хөгжингүй эдийн засагтай улс орон ихэнхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах салбар тусгайлсан эрх зүйн тогтолцоо байдаггүй байна. Тэдгээр улсад хөрөнгө оруулалтын хангалттай дотоод эх үүсвэртэй байдаг. Хөрөнгө оруулалтын харилцаанд, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд онцгой байр суурийг төр эзэлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон ашиглах асуудлыг төрөөс тогтоосон эрх зүйн актаар зохицуулна. Татварын тогтолцоо, хөнгөлт, чөлөөлөлтийн систем болон зээлийн аргаар төр гадаад хөрөнгө оруулалтыг татах нэгэн хөшүүргийг бий болгодог.

Гадаадын хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал, татварын тогтолцоо, эрх зүйн бусад холбогдолтой зохицуулалтыг улс орон бүхэн өөрийн онцлогийг харгалзан өөр өөр шийдвэрлэдэг. Хөрөнгө оруулалтыг татахын тулд улс орнууд янз бүрийн баталгаа гаргадаг. Тухайлбал гадаадын хөрөнгө оруулсан компанийг дотоодынх болгох боломжтой бол оруулсан хөрөнгийг нөхөн олгох, төлбөр тооцоонуудыг нь хийх, ашиг орлогыг төлөх, зээлийн хүүг нь төлөх, татварын тогтвортой орчинг амлах, дотоодын мөнгөний хөрвөх чадварыг хангах гэх мэт баталгааг улс орнууд гаргадаг байна. Өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа гадаадын өмчийг олон улсын эрх зүйн дагуу тухайн улс өөрийн болгох бүрэн эрхтэй байдаг. Хувийн өмчийг улсын өмч болгоход ямар зарчим баримтлах, хэрхэн нөхөн олгох талаар Үндсэн хуулиасаа эхлэн заасан байдаг. Өмчийг хураах нь гагцхүү хуульд заасан дагуу байх ёстой гэж Энэтхэгийн Үндсэн хуульд хуульчилсан бол ХБНГУ-ын Үндсэн хуульд гагцхүү хуульд үндэслэн, олон нийтийн эрх ашигт нийцэх тохиолдолд өмчийг хураахыг зөвшөөрсөн байна

Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой нарийвчилсан журмыг холбогдох хуулиудад заасан байдаг. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг олон нийтийн эрх ашгийн үүднээс болон өөр бусад шалтгаанаар хураасан тохиолдолд Засгийн газраас бүрэн нөхөн олговор олгохоор хуульчилсан байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиудад гадаадынхөрөнгөоруулагчийгдотоодынхоосдордүзэхгүйбайх,гадуурхахгүй байх зарчим, тогтвортой байх зарчим \татварыг өөрчлөхгүй, үйлчилж буй

хууль тэдий хугацаанд хэвээр үлдэнэ гэх мэт\ зэргийг тусгайлан хуулиндаа зааж өгдөг байна. Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулагчтай дотоодын хөрөнгө оруулагчийн адил тэгш харьцах эрх зүйн баталгаа байгаагаас гадна уул уурхай, дэд бүтэц зэрэг салбарт хөрөнгө оруулах бол татварыг тодорхой хугацаанд тогтвортой байлгах гэрээ байгуулж болдог байна. Хөрөнгө оруулалтын хэмжээнээс шалтгаалан уг гэрээний хүчинтэй байх хугацаа тогтоогдох аж.

Дэлхийд гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой олон улсын гэрээ байгуулах оролдлогыг 1995 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хийсэн. Гэвч энэхүү гэрээ хэлэлцээр нь амжилттай болж чадаагүй. Олон улсын хөдөлмөр, байгаль орчны байгууллагууд эсэргүүцэж тус гэрээ хүчин төгөлдөр болвол улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд дотоодынхоо эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, хөдөлмөрийн стандартуудаа аль болох багасгах бодлого барина гэж үзэж, ихэд шүүмжилж байжээ. Өнөөдрийн байдлаар улс орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг үндэсний, хоёр талын, эсвэл бүс нутгийн гэрээгээр зохицуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиуд нь гадаадын хөрөнгө оруулалтыг хянах, дэмжих, зохицуулах үүрэгтэй байдаг бөгөөд дараах гурван янз байна:

1. Хөрөнгө оруулалтыг ихээхэн дэмжсэн, хуулийн хязгаарлалтыг аль болох бага байлгахад чиглэсэн эрх зүйн орчин. /Алс Дорнодын орнуудад өргөн хэрэглэдэг/.

2. Хөрөнгө оруулалтыг янз бүрийн аргаар дэмждэг ч үүнд дотоодын оролцоог чухалчлан, квот тогтоосон эрх зүйн зохицуулалт. \Ойрхи Дорнодын орнуудад их дэлгэрсэн бодлого юм\.

3. Гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрч буй ч дотоодын зохицуулалт хяналтанд байлгах бодлого. /Латин Америкийн орнууд гол төлөв ийм хуультай байдаг аж/.

Дэлхийн ихэнх оронд аливаа гадаадын хөрөнгө оруулалт тухайн газар нутагт үйл ажиллагаагаа явуулахын тулд бүртгүүлэх, зөвшөөрөл авдаг байна. Ийм үйл ажиллагааг улс орнуудад бие даасан, тусгайлан байгуулсан байгууллага болох агентлагууд гүйцэтгэдэг ба тэдгээр нь зохион байгуулах, мөн түүнчлэн хянах ч үүрэгтэй байх нь элбэг байдаг. Тухайн хөрөнгө оруулалт Засгийн газраас олгож буй ямар нэг хөнгөлөлтийг эдлэх, эсвэл оруулах хөрөнгө нь заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн саналыг илүү нарийвчлан авч үзэх эсэх хамаардаг. Хөрөнгө оруулалтыг энгийн бичгээр зөвшөөрөхөөс гадна Засгийн газар болон хөрөнгө оруулагч нар хоорондын тусгай гэрээгээр тохирох нь бас бий. Өмнөд Солонгост хөрөнгө оруулалт $100.000 ам.доллараас багагүй байж хөрөнгө оруулах эрх олгодог. Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар бол 50.000 ам. долларын хөрөнгийн доод хэмжээтэй бөгөөд Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг нь гадаадын хөрөнгө оруулагчийг албан ёсоор бүртгэдэг байна. Гадаадын хөрөнгө оруулалт тухайн улсын хөгжлийн бодлогод нийцэж байх нь чухал. Ихэнх орнууд үүнд тухайн хөрөнгө

оруулалтын эдийн засгийн нөлөө, ажлын байрын хангамж, технологийн ноу-хау, дотоодын зах зээлд үзүүлэх нөлөө, хөгжил буурай орон нутагт оруулах хувь нэмэр, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, импортыг орлох чадвар, үйлдвэрлэлд ашиглах дотоодын нөөц, баялаг, үнэ ханшид үзүүлэх нөлөө зэргийг анхаарч байна. Бизнесийн төрлийн хувьд улс орнууд гадаадын хөрөнгө оруулагчийг нэг талаас дотоодын хувь нийлүүлэгчтэй хамтарсан бизнес эрхлэх нөгөө талаас олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулж байхыг хүсдэг. Дотоодын хөрөнгө оруулагчтай хувь нийлүүлэн нөхөрлөл, бүрэн бус хариуцлагатай компани, олон нийтийн хувьцаат компани зэргийг байгуулж болдог. Саудын Арабт тухайлбал дотоодын ямар нэгэн оролцоогүй компани байгуулж болох ч энэ нь дотоодын татварын хөнгөлөлтүүдийг эдлэх эрхгүй байдаг. Монголд 100% гадаадын өмчийн хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн байна. Хөрөнгө оруулалтын эрх зүйн боломжийн орчинтой хэмээн үнэлэн дүгнэдэг.

Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтын төрөлжсөн хуультай, төрийн захиргааны мэргэшсэн байгууллагатай улс орнуудын нэг. Энэ нь манай улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, төрийн зохицуулалтын бас нэгэн давуу тал юм.

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт нь үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдахаас гадна олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалттай.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд элсэж, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалахад чиглэсэн олон улсын түгээмэл гэрээ, конвенциудад нэгдэн орсон билээ. Тухайлбал, "Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" Вашингтоны конвенц, "Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай" Сөүлийн конвенци зэрэг болно. Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хоёр талын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газар дөчин хоёр оронтой, Давхар татварын хэлэлцээрийг гучин дөрвөн улстай тус тус байгуулаад байна. Монгол Улс хөрөнгө оруулалтын боломжийн орчин, хамгаалалттай гэдгийг олон улсын байгууллагуудын судалгаа ч давхар нотолж байна. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлаас жил бүр гаргадаг "Дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл"-д улс орнуудыг гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр дүнгийн болон чадавхийн индексээр нь байр эзлүүлэн, эдгээр үзүүлэлтийг хооронд харьцуулан ангилдаг билээ. Манай улс 1993-1995 онуудад хоцрогсодын ангилал, эгнээнд байсан бол 1999 оноос "чадавхаасаа илүү гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээсэн улс орнууд"-ын тоонд орох болсон байна. Дэлхийн банкнаас жил бүр уламжлал болгон явуулдаг "Бизнес эрхлэлт-2009" судалгаанд Монгол Улс ерөнхий үзүүлэлтээрээ дэлхийн 181 орноос 58-т жагссан бөгөөд "Хөрөнгө оруулагчдын хамгаалалт" гэсэн үзүүлэлтээр эхний 24-т бичигдсэн байна.

Түүнчлэн Дэлхийн эдийн засгийн чуулганаас 1979 оноос эрхлэн явуулж байгаа Өрсөлдөх чадварын индексийг тогтоох 2008-2009 оны судалгаанд ерөнхий үзүүлэлтээрээ хойгуур байгаа ч Хөрөнгө оруулагчдад үзүүлж буй

хамгаалалтын индексээр 19-т орсон байна. Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт гэхээсээ илүүтэй тогтвортой орчинг чухалчилдаг билээ. Монгол Улсад 20 сая америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж татварын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газар гишүүн уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг 10-15 жилийн хугацаатайгаар байгуулах зохицуулалт манай улсад үйлчилж байна.

Монгол Улс хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих идэвхитэй бодлого баримталж ажиллаж ирсэний дүнд манай улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний нийгэм, эдийн засгийн үр өгөөж тогтвортой өсөн нэмэгдэж байна. 2008 онд гэхэд л 708922.55 мянган ам. долларын шууд хөрөнгө оруулалт бүртгэгдсэн нь 1996 оныхтой харьцуулбал даруй 13 дахин нэмэгджээ. Түүнчилэн 2008 оны жилийн цэвэр өсөлт гэхэд 2003 онд бүртгэгдсэн нийт хөрөнгө оруулалтын хэмжээнээс давжээ. Зүүн бүсэд 1996 оноос хойш БНХАУ, ОХУ, Канад, БНСУ зэрэг орнуудын хөрөнгө оруулалттай 30-аад компани байгуулагдаж, 20 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын 70 орчим хувь нь геологи, уул уурхайн салбарт орсон байна.

Монгол Улсад бизнесийн харьцангуй чөлөөт горимыг мөрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, түүнийг хөхүилэн дэмжих, баталгаажуулах, хамгаалах бодлого баримталж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 болон 3-т зааснаар, "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" хэмээн тусгасан нь гадаадын болон дотоодын хуулийн этгээдийн хувийн эд хөрөнгийг хуулиар хамгаалж байна. Мөн 5 дугаар зүйлийн 3-т зааснаар, "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" хэмээн тусгажээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын Засгийн газар бусад Улсын Засгийн газруудтай байгуулсан "хөрөнгө оруулалтыг харилцан хөхүилэн дэмжих, хамгаалах тухай хэлэлцээр"-т мөн гадаадын хөрөнгө оруулагчийн өмчийн эрхийг хамгаалсан. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаар, гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглох бөгөөд гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс, хуульд заасан журмын дагуу ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан гаргуулж болно. Дайчлан гаргуулсан тохиолдолд тухайн үеийн үнэлгээгээр нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж, саадгүй гүйцэтгэнэ. Гадаадын хөрөнгө оруулагч нарт олгох нөхцөлийн талаар дотоодын хөрөнгө оруулагчдад олгогдогоос *"дутуугүй тааламжтай нөхцөл"*-өөр олгоно хэмээн заасан.

Монгол Улсын хувьд гадаадын улс орнуудын Засгийн газар хооронд хөрөнгө оруулалтыг хөхүилэн дэмжих, хамгаалах тухай 40 гаруй гэрээ,



хэлэлцээр байгуулсан. Уг хэлэлцээрүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хураан авах асуудлаар зохицуулалт бүхий заалтууд байгаа. Жишээ нь, Монгол Улсын Засгийн газар, Итали Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрт тусгаснаар, тухайн улсын аль аль тал өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч талын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулахыг хөхүүлэн дэмжих, тийнхүү хөрөнгө оруулахыг өөрийн хууль тогтоомжийн дагуу зөвшөөрнө хэмээн заажээ. Мөн хөрөнгө оруулагчаас хийсэн хөрөнгө оруулалтанд ямагт шударга хандаж, хөрөнгө оруулалт хийсэн аливаа пүүс, компани эрхлэн хөтлөх, хэвийн ажилуулах, ашиглах, шилжүүлэх, зогсоох болон татан буулгахад аливаа хэлбэрээр үндэслэлгүй буюу ялгаварлан гадуурхах арга хэмжээ авах ёсгүй байна.

Дээр дурдагдаж байсан "дутуугүй таатай нөхцөл" хэмээх нэр томьёо энд мөн тааралдаж байна. Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд, хөрөнгө оруулагч болон орлогод дутуугүй таатай нөхцөлөөр хандана хэмээн тусгасан байдаг. Ер нь хэд хэдэн ийм ижил төрлийн хэлэлцээрүүдийг авч үзэхэд, "үндэсний болон нэн тааламжтай нөхцөл", "дутуугүй тааламжтай нөхцөл", "ялгаварлан гадуурхахгүй нөхцөл", "үндэсний дэглэм" гэсэн нэр томьёо тааралдаж байна. ОХУ-д "үндэсний дэглэм" буюу "национальный режим"[256] хэмээх нэр томьёог, "олон улсын гэрээнд хэрэглэгдэх зарчим буюу тохиролцож буй нэг талын иргэн болон хуулийн этгээдэд тохиролцож буй нөгөө талын улсын нутаг дэвсгэр дээр өөрийн орны иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу адил тэнцүү хөнгөлөлт болон давуу байдлыг олгох" хэмээн байдлаар ойлгоно. Англи хэл дээр тухайн дэглэмийг "national treatment[257]" хэмээн авч үздэг бөгөөд утгын хувьд ижил төстэй уттатай байна.

Дээрх хоёр дэглэмийг нэгэн зэрэг хэрэглэх боломжтой юм. Гадаадын хөрөнгө оруулагчдад холбогдох дэглэмийг олгоно гэдэг нь алагчлахгүй байх гэсэн утгатай хэмээн ойлгож болно. Гадаадын хөрөнгө оруулалтын дэглэмтэй холбоотой олон улсын баримт бичигт адил нөхцөлд үйлчилж байгаа хөрөнгө оруулагчдад зориулсан ижил дэглэм, түүнчлэн тэдгээрийн хоорондын чөлөөт өрсөлдөөн нь хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх нөхцөл болдог бөгөөд харин эрх зүйн дэглэм нь шударга болон эрх тэгш байна гэж тодорхойлогддог.

Энэ нь юуны түрүүнд хөрөнгө оруулагчдын өмчийн эрхийг хамгаалах, хяналт болон материаллаг ашиг олох, ажиллах хүч авах зөвшөөрөл, экспорт, импортын зөвшөөрөл болон бусад хууль зүйн хүчин зүйл юм. Үүний зэрэгцээ үндэсний хөрөнгө оруулагчтай холбоогүй тухайн улсын хууль тогтоомжид тодорхойлсон дэглэмийн бусад асуудал болон зохицуулдаг тусдаа дүрэм нь өөр өөр улсын гадаадын хөрөнгө оруулагчдад алагчлах шинж агуулах ёсгүй, өөрөөр хэлбэл тэдгээрийн үндэсний харьяалалыг авч үзэж болохгүй.

Гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадны хөрөнгө оруулалттай худалдааны байгууллагын хөрөнгийг дайчлан хураасан тохиолдолд

[256]Словарь юридических терминов, 2002 год.
[257]www.wikipedia.org

дайчлан хураан авсан хөрөнгийг буцаан авна хэмээн хуульчилсан талаар дээр дурдсан. Дайчилгаа хийх болсон шалтгааны нөхцөл байдал дууссан тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагч дайчилгаанаас үлдсэн хөрөнгөө шүүхийн журмаар шаардах эрхтэй бөгөөд харин энэ тохиолдолд буцаан олгосон мөнгөний хэмжээг хөрөнгийг буурсан алдагдлыг тооцон буцаан өгөх үүрэгтэй.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хураан авахгүй баталгааг хуулиар баталгаажуулснаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадны хөрөнгө оруулагчдыг татах нэгэн хөшүүрэг болох юм. Хөрөнгө оруулалтыг татах зорилгоор үзүүлж буй татварын хөнгөлөлтүүдээс гадна хууль, эрх зүйн орчны баталгаа чухал байр суурь эзлэх болно.

Монгол Улсын хууль, эрх зүйн орчны хувьд иймэрхүү байна. Гэтэл энэ асуудал дээр гадаад орнуудын зохицуулалтыг мөн харгалзаж үзвэл зүгээр хэмээн бодож байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг хураан авахаас хамгаалах баталгааны асуудлаар ОХУ-ын хууль тогтоомжийг авч үзвэл, "гадаадын хуулийн этгээд, байгууллагуудын хувьд үндэсний дэглэмийг хэрэглэх нь Холбооны хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд өөрийн орны хуулийн этгээдүүдтэй нэгэн адилаар эрх эдэлж, үүрэг хүлээх болохыг хэлнэ[258]" хэмээн заасан.

ОХУ-ын 1999 оны "Гадаадын хөрөнгө оруулалтын тухайн ОХУ-ын Холбооныхуулиар"гадаадынхөрөнгөоруулагчдадолгожбуйбаталгаануудыг нилээдгүй дэлгэрэнгүй зохицуулсан байдаг бөгөөд 5-17 дугаар зүйлүүд нь бүгд хөрөнгө оруулагчид үзүүлэх баталгаануудын талаархи зохицуулалт бүхий байна. Энэхүү зохицуулалтаас авч үзэхэд, манай орны хуулинд "баталгаа" гэсэн нэр томьёог оруулах нь зөв зохистой хэмээн үзэж байна. "Баталгаа"-ны асуудлыг авч үзвэл тус хуулийн 8 дугаар зүйл гадаадын хөрөнгө оруулагч эсхүл гадаадын хөрөнгө оруулттай аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг төрөөс өөрийн өмчид буюу төрөөс өөр зорилгоор хураан авсан тохиолдолд үзүүлэх баталгааны талаар дурджээ.

Энэ тохиолдолд Монгол Улсын хуулинд "хураан авах" гэсэн нэг нэрээр тусгасан бол ОХУ-ын тус хуулинд "национализация", "реквизия" гэсэн хоёр нэрээр тусгагдаж, үүнээс эхнийх нь "төр цаашид өөрийн өмчид үлдээх зорилгоор хураан авах", нөгөө нь "төр өөр зорилгоор хураан авах " хэмээн ойлгогдож байна.

Гэхдээ үүнийг хууль бусаар хураан авдаг хэмээн ташаа ойлгож болохгүй. Холбооны хууль, олон улсын гэрээгээр зохицуулсан үндэслэл болон шалтгаанаар л зөвхөн төр хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авч, тэр дотроо өөрийн өмчид шилжүүлэх зорилгоор буюу бусад зорилгоор хураан авч болно. Төр өөр зорилгоор хураан авсан тохиолдолд хураан авсан хөрөнгийн хэмжээгээр нөхөн олговор олгогдох бөгөөд энэ үйлдлийг гадаадын хөрөнгө оруулагчид шүүхийн журмаар нэхэмжилж болно.

Бас нэгэн орны жишээг авч үзэхэд, БНСУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3-4 дүгээр зүйлд мөн хөрөнгө оруулалтыг хураан

[258]В.В.Гаврилов "Международное частное право" Москва, 2002 г.



авахаас хамгаалах баталгааны талаар тусгажээ. Үүнд, төр болон бусад хуулийн этгээд нь гадаадын хөрөнгө оруулагч хууль бусаар хураан авахыг хориглох бөгөөд үүнийг олон улсын хоёр талт гэрээ болон энэхүү хуулиар зохицуулж хуульчилсан болно.

3. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ

Орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалтыг хянах үүргийг гол төлөв захиргааны байгууллагууд гүйцэтгэнэ. Энэхүү захиргааны байгууллага нь тухайн хөрөнгө оруулалт дотоодын эдийн засагт ямар үр ашигтай байж болох талаарх судалгааг шаардах боломжтой. Үүний нэг илрэл нь улс гүрнүүд гадаадын хөрөнгө оруулалтыг бүртгэхдээ хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх үе шат хугацаа, хөрөнгө оруулалттай холбоотой техник эдийн засгийн үндэслэл, төсөл зэргийг өргөдөлдөө хавсаргасан байх талаар хууль тогтоомжид тусгасан байхыг шаарддаг. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн 12.2, 12.3-т гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах өргөдөлд "хөрөнгө оруулалтын төрөл хэмжээ, хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх хэлбэр, хугацаа" заажөгсөн байхыг шаарддаг бол уг өргөдөлдөө хөрөнгө оруулагчийн төлбөрийн чадварын талаархи үйлчлүүлэгч банкны тодорхойлолт, хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэлийг хавсаргасан байхаар тусгажээ. Түүнчлэн, БНХАУ-ын Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг байгуулахад зайлшгүй Хятад улсын улс, ардын аж ахуйн хөгжилд ашигтай байх хэрэгтэй. Бүтээгдэхүүнээ гадаадад гаргах буюу тэргүүний техник технологи бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг төрөөс дэмжинэ" хэмээн тусгаснаас харахад гадаадын хөрөнгө оруулалтыг татахын гол зорилго нь дотоодын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал ба энэхүү зорилгыг хангах үүднээс орж ирж буй хөрөнгө оруулалтын үр дүн, зорилгыг хянах үүргийг эрх бүхий байгууллагад олгодог байна.

Олон улс гүрнүүд гадаадын хөрөнгө оруулалтыг зөвхөн хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр оруулахыг хүлээн зөвшөөрч, хөрөнгө оруулалт нь бололцоотой эсэх талаарх судалгааг хийж эхэлсэн нь цэвэр хувь этгээд болон хамтарсан үйлдвэрийн хооронд урьдаас бэлтгэсэн шалгуур мэт харагдах бөгөөд энэхүү шаардлага нь ч төвөгтэй гэж харагддаггүй билээ. Харин хувийн шинжтэй гэрээ хэлэлцээрийн хувьд урьдчилсан шалгалт хийх явцад өгсөн мэдээллийн үнэн зөвийн талаар маргаан үүсэж магадгүй юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх асуудал эрхэлсэн захиргааны байгууллагын үндсэн зорилго нь гадаадын хөрөнгө оруулагч нь хүлээн авагч улсад бодитой үр дүн бий болгоно гэдгийг баталгаажуулах явдал байна. Уг байгууллага гадаадын хөрөнгө оруулалт нь дотоодын эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэх ёстой. Өөрөөр хэлбэл өргөн далайц бүхий гадаадын хөрөнгө оруулалтын улмаас аж үйлдвэрлэлийн салбар дахь дотоодын аж ахуй эрхлэгчдэд сөрөг үр дагавар бий болохгүй хэмээх баталгааг бий болгох зорилго юм. Гэхдээ ийм арга хэмжээг хөрөнгө оруулалтыг орж ирэхийн

өмнө болон дараа нь авсан ч улс үндэстнээр ялгаварлан гадуурхсан тухай асуудал үүснэ. Харин ийнхүү ялгаварлах асуудал нь бүрэн дүүрэн хууль ёсны байх ёстой. Зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг оруулахгүй байх эдийн засгийн шалтгаан байж болох юм. Жишээ нь, хөгжиж буй орнуудад гол тулгуур салбаруудыг эрхлэх эрхийг дотоодын аж ахуй эрхлэгчдэд олгох сонирхолтой байдаг бөгөөд энэ нь гадны аж ахуйн нэгжээс хэт хамааралтай байхаас урьдчилан сэргийлэх зорилготой. Өөр нэг шалтгаан нь, үлэмж хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт нь дотоодын аж үйлдвэрийг унагах магадлалтай. Иймээс авч болох арга хэмжээ нь, техник технологи хөгжөөгүй ч ажиллах хүчээр баялаг бүс нутаг дахь гадны тусламжгүйгээр үйл ажиллагаа явуулж үл чадах өндөр технологи шаардлагатай үйлдвэрүүдэд гадаадын үндэстэн дамнасан компаниуд орж ирэхэд нээлттэй байх бодлогыг баримтлах явдал болно. Хөгжингүй орнууд нь ялгаагүй зарим төрлийн үйлдвэрлэлийн салбараас гадаадын хөрөнгө оруулалтыг ангид байлгах бодлогыг баримтлах боломжтой. Ялангуяа цэрэг армийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрүүд нь маш ховор тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтыг авах боломжтой. Үүнийг гол төлөв үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар баталгаажуулсан байдаг.

Одоо бүс нутгийн болон хоёр талт хэлэлцээрүүд, тэрчлэн ДХБ-ын ТХЕХ зэрэг арга хэрэгсэл нь хязгаарлагдмал байдлаар ч хамаагүй үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулах эрх чөлөөг бий болгохыг дэмжиж байна. ТХЕХ-ийн гэрээ хэлэлцээрт заасны дагуу оролцогч улс нь өөрөө зааж өгсөн салбарт л гадаадын аж ахуйн нэгж байгуулах буюу түүний салбар төлөөлөгчийн газрыг байгуулахыг зөвшөөрдөг. Энэ нь гаднаас орж ирж буй хөрөнгө оруулалтыг хязгаарлах боломжтойг илэрхийлж байгаа хэрэг юм.

4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

Байгалийн эрдэс баялагтай хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй ихэнхи орон үндэстэн дамнасан компаний хөрөнгө мөнгө, техник технологи ба удирдлагын ур чадварыг сонирхож гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого явуулдаг[259]*.

Харин үндэстэн дамнасан компани нь хөрөнгө хүлээн авагч улс дахь ашигт малтмалын нөөцийг эзэмших эрх, өндөр ашиг олох боломж болон татвар, хууль тогтоомжийн тогтвортой, урьдчилан тооцож болох нөхцөлийг илүүтэй сонирхоно. Ашигт малтмал олзворлох салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн асуудал нь бий болох орлого ашгийг хэрхэн хуваарилах, олзворлолт, борлуулалтад хэн хяналт тавих вэ гэдэгт оршино. Нэг талаас хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улс, тус улсын оршин суугч иргэд, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол тулгарч, хөрөнгө оруулалтын олон эрсдэлийг бий болгоно. Ялангуяа олзворлох салбарын хувьд байгаль орчин, нийгмийн үр дагавар онцгой анхаарал татна. Эрчим хүчний гол түүхий эд, тухайлбал байгалийн хий, газрын тос, ураны орд

[259]World Investment report 2007: Transnational Corporations, Extractive Industries and Development, S. 157



газрыг ашиглахад улс төрийн хүчин зүйл чухал үүрэгтэй.

Хөрөнгө экспортлогч улсууд импортлогч улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих хоёр талт гэрээг түгээмэл ашиглаж байна. Гэхдээ ийм төрлийн гэрээ нь эрх зүйн нийтлэг үндсийг бүрдүүлэхээс тухайн хөрөнгө оруулагч компани, түүний явуулах гэж буй бизнесийн үйл ажиллагааны онцлог эрсдэлийг бууруулах сонирхолд тэр бүр нийцэж чадахгүй. Нөгөө талаар хөрөнгө хүлээн авагч улсын хувьд ч мөн тодорхой тохиолдолд ялангуяа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой, аюулгүй байдалд нөлөө үзүүлэхүйц томоохон төслийн хүрээнд илүү нарийвчилсан тохиролцоо хийх сонирхол бий. Үүний тод жишээ бол Монгол Улсын хувьд Оюу толгой, Таван толгойн орд газрын төслүүд юм.

Өмнө дурдсан нөхцөл байдлыг харгалзан хөрөнгө хүлээн авагч улс орнууд хөрөнгө оруулалтын тусгайлсан гэрээ байгуулах журмыг хуульчлан тогтоох эсхүл тодорхой төсөл дээр тухайлсан гэрээ байгуулах явдал түгээмэл болжээ.

Богд хаант Монгол Улсын үед Орос улсын "Монголор" алтны компанитай концессийн гэрээ анх байгуулж байжээ[260]. Социалист бүтээн байгуулалтын хүрээнд ЗХУ болон бусад социалист улстай хамтарсан үйлдвэр байгуулах гэрээ байгуулдаг практик өргөн дэлгэрсэн байлаа. Тухайлбал, Улаанбаатар төмөр зам, Эрдэнэт, Монголросцветмет үйлдвэрийг нэрлэж болно.

Манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1990-ээд оны эхэн үеэс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэмжих бодлого явуулж эхэлсэн. Энэ бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын зарим эрсдэлийг бууруулах зорилгоор эрх зүйн ба татварын тогтвортой орчныг баталгаажуулах нөхцөл боломжийг бүрдүүлж тогтвортой байдлын гэрээ байгуулах зохицуулалтыг анх удаа 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгасан билээ. Ашигт малтмалын салбарт хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор тус улсын нутаг дэвсгэр дээр ашигт малтмал хайх, ашиглах эрхийг аливаа этгээдэд өргөдлийн үндсэн дээр шууд олгодог журмыг 1997 оны Ашигт малтмалын тухай хуулиар бүрдүүлсэн юм. Тус хууль нь ашигт малтмал хайх, ашиглах эрхийг онцгой журмаар олгож концессийн гэрээний дагуу ашиглуулдаг олон улсад өргөн дэлгэрсэн аргыг хөнгөвчилсөн явдал болсон. Гэхдээ газрын тосны салбарт газрын тос хайх, олзворлох эрхийг онцгой журмын дагуу олгож, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олзворлолт явуулдаг журмыг 1991 оны Газрын тосны тухай хуулиар мөрдүүлж байна.

Ашигт малтмалын тухай хуульд 1997 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр "тогтвортой байдлын гэрээ", мөн тус хуулийн 2006 оны шинэчилсэн найруулгаар ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулагчтай "хөрөнгө оруулалтын гэрээ" байгуулах шинэ журам бий болгосон юм. Сүүлийн үед концесс буюу төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар өргөн хэлэлцэх болсон бөгөөд энэ харилцааг зохицуулсан хуулийн төслийг бэлтгэж УИХ-аар хэлэлцэхээр төлөвлөж байна. Хэрэв энэ хууль батлагдвал

[260] 1910 онд уг компани үйл ажиллагаагаа эхэлсэн ба 1913 онд гэрээ байгуулсан байна.

зам харилцаа, эрчим хүчний хангамж, эмнэлэг, боловсролын салбарт гадаадын төдийгүй дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах зохистой арга хэлбэр бий болно. Дүгнэж үзвэл, манай улс нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгах, түүнчлэн улс орны нийтлэг эрх ашигт нийцүүлэн тусгайлсан нөхцөл журмыг тухайн төслийн хувьд хөрөнгө оруулагчтай тохиролцох гэрээний арга хэлбэрийг өргөн ашиглахыг эрмэлзэн үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгож байна. Түүнчлэн Монгол Улс нь олон улсын хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих эрх зүйн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож олон тооны олон улсын гэрээ байгуулах, нэгдэн орох арга хэмжээ авсан юм.

Хөрөнгө оруулалтын гэрээний төрөл, хэлбэр

Гадаадын хөрөнгө оруулалтын практикаас үзэхэд хөрөнгө оруулалтын гэрээ нь дараах этгээдийн хооронд түгээмэл байгуулагдаж байна:

А. Хоёр улсын засгийн газар хооронд
- Засгийн газар хооронд байгуулах
- Улсын үйлдвэр хооронд байгуулах

Б. Засгийн газар ба хөрөнгө оруулагч хувь этгээд хооронд
- Засгийн газар ба хувь этгээдийн хооронд
- Улсын үйлдвэрийн газар ба хувь этгээдийн хооронд

В. Хувь этгээд ба хувь этгээд хооронд
- Дотоодын хувь этгээд ба гадаадын хувь этгээд
- Гадаадын хувь этгээд ба гадаадын хувь этгээд

Дээрх гурван төрлийн гэрээнээс хоёр дахь тэр дундаа Засгийн газар ба хувь этгээдийн хоорондынх нь илүү анхаарал татна. Учир нь, гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эрсдлээ бууруулах, тогтвортой байдлыг баталгаажуулахад хөрөнгө оруулалт хүлээн авагч улстай байгуулсан гэрээ чухал ач холбогдолтой. Улсын үйлдвэр болон хувь этгээд хоорондын гэрээ нь үндсэндээ Засгийн газар хоорондын хоёр талт гэрээ ба дотоодын хууль тогтоомж тухайлбал, Монгол Улсын хувьд Иргэний хууль, Компанийн тухай хуулийн хүрээнд байгуулагддаг хувийн эрх зүйн гэрээ байна. Ийм учраас номын энэхүү бүлэгт зөвхөн Засгийн газар ба хувь этгээдийн хоорондын гэрээг тодруулан үзнэ. Ийм гэрээ нь эдийн засгийн салбараас хамаарч олон төрөл хэлбэртэй байж болно. Тухайлбал, газрын тос, хийн салбарт гэрээний дараах хэлбэр түгээмэл дэлгэрсэн байна[261*]:

- Орчин үеийн концесс (modern concessions)
- Хамтарсан үйлдвэрийн гэрээ (joint-venture arrangement)
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ (production-sharing agreements)
- Үйлчилгээний гэрээ (risk technical/service contract and pure technical/service contract)

Эдгээр хэлбэрийг хооронд нь тэр бүр шууд ялгахад бэрхшээлтэй ба талууд ижил нөхцөл агуулгатай гэрээг янз бүрээр нэрлэх явдал элбэг тохиолдоно. Тухайн улс , ѣодорхой төслийн хувьд чухам ямар хэлбэрийн гэрээ зохимжтой вэ гэдэг нь олон хүчин зүйлээс хамаарна. Хөгжиж байгаа

[261]World Investment report 2007: Transnational Corporations, Extractive Industries and Development, S. 160



болон шилжилтийн эдийн засаг бүхий улсын дэд бүтцийн буюу эрчим хүч, тээвэр, холбоо, усан хангамжийн салбарт хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн хэлбэрийг 1996-2006 оны дүнгээр үзэхэд концесс (Concession), хувьчлал (Privatization FDI), менежмент ба түрээсийн гэрээ (Management and lease) голлон хэрэглэгджээ[262]. Харилцаа холбоо ба эрчим хүчний салбарт чөлөөт шууд хөрөнгө оруулалт (Greenfield FDI) хийх буюу шинээр бизнес эхлүүлэх явдал түгээмэл ажиглагдаж байна. Харин тээвэр, усан хангамж, эрчим хүчний салбарт хамгийн их хэрэглэгдсэн хэлбэр нь концессийн гэрээ болжээ.

Сүүлийн үед зарим улс орон, тухайлбал манай улсад эрх зүй, татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, хууль тогтоомжийн огцом өөрчлөлтөөс хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор хөрөнгө хүлээн авагч улсын Засгийн газар хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулдаг практик нэвтэрч байна.

Өмнө дурдсан, гадаадын хөрөнгө оруулалтын хүрээнд түгээмэл хэрэглэж буй зарим хэлбэрийн гэрээг дор илүү тодруулан үзье. Хөрөнгө оруулалтын гэрээний нийтлэг зүйл заалт:

Хөрөнгө оруулалтын гэрээнүүд урт хугацаанд үйлчлэх ба тэдгээрийн зарим зүйл заалт нийтлэг, ижил төстэй байдаг. Энд тогтвортой байдлын заалт, хууль сонгох заалт, маргаан шийдвэрлэх заалтыг юуны өмнө нэрлэж болно.

а)Тогтвортой байдлын заалт (stability clause\stability agreement).

Хөрөнгө оруулалт орох үеийн хууль тогтоомжийг хэвээр тогтвортой байлгах, хуульд хожим орсон өөрчлөлт гэрээний хувьд үйлчлэхгүй байх нөхцлийг хангах зорилгоор энэхүү заалтыг гэрээнд оруулна. Ингэснээр хөрөнгө хүлээн авагч улс дураараа нэг талын журмаар өөрчлөх боломжоос ангид байж чадах хуулийн тогтолцоог хэрэглэх баталгаа хангагдана. Учир нь хөрөнгө хүлээн авагч улс өөрийн нутаг дэвсгэрт болж буй үйл явдлыг өөрчлөх, гэрээний талуудын эрх, үүрэг болон нутаг дэвсгэртээ оршин байгаа эд зүйлийг өмчлөх эрхэд нөлөөлөх хууль тогтоох бүрэн эрхтэй. Энэ бүрэн эрх нь тусгаар улсын бүрэн эрхт байдлаас улбаатай. Гадаадын компани хөрөнгө оруулагч ийм бүрэн эрхээ хэрэгжүүлэх явдлаас эмээж, бүрэн эрхээсээ өөрөө татгалзах амлалтыг улсаар гаргуулж авах сонирхолтой. Тогтвортой байдлын заалтын агуулга нь хөрөнгө оруулалт хийсэн цаг үеийн хууль тогтоомжийг хэвээр нь царцаах буюу хэвээр үлдээх, хожим гарсан хууль, хуулийн өөрчлөлтийг тухайн гэрээний хувьд хэрэглэхгүй байх, гэрээний аливаа заалтыг хуулиар шууд хүчингүй болгохгүй, өөрчлөхгүй байх амлалт, үүргийг хөрөнгө хүлээн авагч улс авах явдалд оршино. Гэрээний хүчинтэй хугацаанд тогтвортой байх, эсхүл тогтвортой байх шаардлагагүй салбар, хүрээг гэрээгээр нарийвчлан тохиролцоно. Зарим үед зөвхөн татвар, байгаль орчны хяналт зэрэг тодорхой салбарын хуулийн зохицуулалтыг цаашаахаар тохирч байхад өөр тохиолдолд хууль тогтоомжийг бүхэлд нь

[262]World Investment report 2008: Transnational Corporation and the Infrastructure Challenge, S. 15

царцаах явдал байж болно.

Ашигт малтмалын тухай хууль 1997 онд шинэчлэгдэн гарснаас хойш манай улс хөрөнгө оруулагчидтай бие даасан тогтвортой байдлын гэрээг байгуулах болсон юм. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар 20 сая ам доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг Засгийн газрыг төлөөлөн Сангийн сайд байгуулж болно. 2009 оны эцсийн байдлаар 7 компанитай ийм төрлийн гэрээг байгуулсан байна. /Хавсралт хүснэгтийг үзнэ үү/ Тогтвортой байдлын гэрээний загварыг Засгийн газрын 2005 оны 24 дүгээр тогтоолоор батлажээ. Энэ загвар нь Засгийн газрын 2002 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан өмнөх загвартай харьцуулахад нилээд өөрчлөгдсөн бөгөөд татварын орчноос гадна газрын харилцаа, байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөр, ажиллах хүчинд холбогдсон хууль тогтоомжийг тодорхой хэмжээнд тогтворжуулах зарим боломжийг тусгасан байна.

b) Хэрэглэгдэх хууль сонгосон заалт (Applicable law clause).

Засгийн газар ба хувь этгээдийн хооронд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед уг гэрээнд ямар улсын хууль хэрэглэх асуудлыг заавал тодруулан тусгадаг. Хөрөнгө оруулалт, түүний үр дүнд бий болох хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь бүхэлдээ хөрөнгө хүлээн авагч улсын хуулиар зохицуулагдах шаардлагатай байдаг тул гэрээнд энэ улсын хуулийг хэрэглэхээр заахаас өөр хувилбар тун бага юм. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар ба"Айвенхоу майнз монголиа инк", Айвенхоу майнз лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс лимитед компани хоорондын хөрөнгө оруулалтын гэрээнд маргаан шийдвэрлэх дараах заалт тусгагдсан байна: "арбитрын шүүгчид Хөрөнгө оруулалтын гэрээг тайлбарлахдаа Монгол Улсын хуулийг хэрэглэх. Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулагдан тайлбарлагдана" гэжээ. Эндээс үзэхэд хөрөнгө оруулалтын гэрээнд Монголын хууль хэрэглэгдэх заалтыг оруулсан байна.

Гэхдээ хөрөнгө хүлээн авагч улсын үндэсний хуулийг хэрэглэхээс татгалзаад гэрээг тайлбарлах. маргааныг шийдвэрлэхдээ олон улсын стандарт буюу "хуулийн ерөнхий зарчим", олон улсын эрх зүй эсхүл аль нэг гадаад улсын хууль хэрэглэх агуулгатай заалт ашиглах явдал бий.

c) Маргаан шийдвэрлэх буюу арбитрын заалт (Dispute resolution or arbitration clause).

Хөрөнгө хүлээн авагч улсын шүүх эрх мэдлээс ангид байлгах, хөндлөнгийн арбитр, шүүхээр маргааныг шийдвэрлүүлэх зорилгын үүднээс маргаан шийдвэрлэх байгууллагаар ихэвчлэн олон улсын арилжааны арбитрыг сонгож гэрээндээ энэ тухай заалт оруулна. Жишээ нь, Монгол Улсын Засгийн газар ба "Айвенхоу майнз монголиа инк", Айвенхоу майнз лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс лимитед компани хоорондын хөрөнгө оруулалтын гэрээнд маргаан шийдвэрлэх дараах заалт тусгагдсан

байна: "... энэхүү гэрээнээс үүдсэн эсхүл түүнтэй холбогдон гарсан маргааныг уг маргаан гарсан өдөр мөрдөгдөж буй НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссийн Арбитрын дүрмээр тодорхойлсон журмын дагуу шийдвэрлэнэ. Арбитрын шийдвэрийг заавал биелүүлнэ. Арбитрын үйл ажиллагаа дараах журмаар явагдана: ... арбитрын ажиллагааг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хотод явуулах, ... Лондонгийн Олон улсын арбитрын шүүх удирдан явуулах". Эндээс үзэхэд маргааныг монголын шүүхээр бус гадаад улсад оршин байгаа арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон байна. Манай улсын байгуулсан тогтвортой байдлын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээнд ийм агуулга бүхий арбитрын заалтыг үзэж болно.

Концессийн гэрээ

Эрх бүхий этгээдээс бусад этгээдэд тодорхой нөхцөлөөр олгосон аж ахуйн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эсхүл ашигт малтмал олзворлох онцгой эрхийг "концесс" (concession[263*]) гэж нэрлэж болно. Хэрэв концессийн нөхцөлийг гэрээний үндсэн дээр тодорхойлохоор бол концессийн гэрээ байгуулна.

Концессийн гэрээтэй төстэй уул уурхайн регалийн гэрээг дундад зуунд Ариун Ромын Гогенштауфенын үед хэрэглэж байсан болон концессийн сонгодог хэлбэрийг XIY зууны хоёр дахь хагасаас ашиглаж эхэлсэн тухай судлаач М.Мөнхбат өөрийн илтгэлдээ дурдсан байдаг[264]. Энэ үед газар, газрын хэвлий, түүнд байгаа ашигт малтмал нь эзэн хаан, ноёны өмчлөлд байсан учраас орд газрыг ашиглах тусгай зөвшөөрөл олгож зохих татвар, хураамж авдаг явдал илүү зохимжтой байсан болов уу. Ингэхдээ олборлосон бүтээгдэхүүний хэмжээнд уялдуулан төлбөр авах, эсхүл олсон орлогод нь татвар ногдуулах аргыг хэрэглэж байв. Уурхай эрхлэгч нь хайгуул, олборлолтын бүх эрсдэл зардлыг хариуцах тул газар өмчлөгчийн хувьд зөвхөн орлого олох боломжтой байдаг.

20 дугаар зууны эхэн үеэс концессийн гэрээг газрын тосны салбарт өргөн хэрэглэж эхэлжээ. Тэр үед газрын тосны нөөц бүхий ихэнхи улс үндэстнүүд колонийн хараат байдалд байсан учраас тухайн улсын ашиг сонирхол бус колончлогч улс, түүний харьяат олборлогч компанийн ашиг сонирхолыг илүү хангасан гэрээг байгуулж байв. 1901 онд Персийн Шахтай байгуулсан Willam D'Arcy-ийн гэрээ нь Ойрхи дорнодын бүс нутаг дахь анхны концессийн гэрээ байсан юм. Тус гэрээгээр гэрээлэгч талд 60 жилийн хугацаанд Персийн 500000мкв тайлбайд газрын тосны үйл ажиллагаа явуулах онцгой эрх олгосон ба хариуд нь Персийн Шах 100000 ам долларын урамшуулал болон 16 хувийн роялти авах болжээ[265]. Энэ үеийн концессийн

[263] Black's law dictionary: concession, - A Government grant for specific privileges, - Int;l law. A contract in which a country transfers some rights to a foreign enterprise, which then engages in an activity (such as mining) contingent on state approval and subject to the terms of the contract.

[264]МУИС-ийн ХЗС-ийн багш М.Мөнхбатын "Уул уурхайн салбар дахь концессийн гэрээ" сэдэвт судалгааны илтгэл. Одоогоор нийтлэгдээгүй.

[265]Ernest E. SmithH & John S. Dzienkowski, A fifty year perspective on the world petroleum agreements, 1989., p. 5

гэрээнүүд нь их хэмжээний газар нутагт удаан хугацаагаар үйл ажиллагаа явуулах баталгааг олгож байсан ба гэрээлэгч компаниудад тухайн нутаг дэвсгэртээ хайгуул, өрөмдлөг хийхгүй бол нутаг дэвсгэрийг чөлөөлөх үүрэг ногдуулдаггүй байв. Түүнчлэн концесс олгогч Засгийн газар гэрээлэгч компанийн үйл ажиллагаанд оролцох эрхгүй ба түүний хүлээн авах орлого нь зөвхөн гэрээний төлбөр эсвэл роялти гэсэн зүйлээр хязгаарлагдаж, гэрээнд тусгаагүй өөр татвар ногдуулах эрхгүй байсан юм. Ийм байдлаар 1970-аад оноос өмнө арабын орнууд өөрийн нутаг дэвсгэр дээрх газрын тосны бүхий л нөөцөд хяналт тавих, өмчлөх эрхийг гадаадын компаниудад 75 хүртэл жилээр олгосон ба Засгийн газрын хяналт, нөлөө тун бага болсон байв. Гэвч ихэнхи улс концессийн гэрээний дагуу газрын тос олборлолт байсан гадаадын компанийг улсын болгох /нийгэмчлэх/ арга хэмжээ авч хэрэгжүүлсэн[266] ба дараа нь зөвхөн техникийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр гадаадын компанийг ажиллуулах болсон байна.

Концессийн гэрээ нилээд хувьсан өөрчлөгдөж, зарим тохиолдолд бүтээгдэхүүн хуваах гэрээтэй тун төстэй зохицуулалттай болж түүнээс ялгахад бэрхшээлтэй болсон байна. Сүүлийн үеийн концессийн загварыг заримдаа татвар ба нөөцийн төлбөрийн тогтолцоо гэж нэрлэдэг. Учир нь, улс буюу Засгийн газар гадаадын компанид тодорхой нэг орд газарт ашигт малтмал хайх, олзворлох тусгай зөвшөөрөл \лизенз\ олгож, олзворлогч компани олзворлосон зүйлийн өмчлөгч болох улмаар борлуулах, тээвэрлэх, боловсруулах эрхтэй байхыг хүлээн зөвшөөрч, харин компани нь лиценз эзэмшсэний төлбөр, мөн олзворлосон ашигт малтмалынхаа төлөө улсад татвар болон нөөцийн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ. Олзворлогч компанид олгодог онцгой эрхтэй холбоотойгоор энэхүү төрлийн гэрээг ялангуяа газрын тосны салбарт хэрэглэдэг орнуудын тоо буурч байгаа аж[267].

Орчин үед концессийн ойлголт нилээд өөрчлөгдсөн ба төрийн, нийтийн үйлчилгээ, дэд бүтэц, төр, орон нутгийн өмч ашиглалтын хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, менежментийг татан оруулах зорилгоор концессийг өргөн ашиглах болжээ. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон бусад олон улсын байгууллагаас концессийн эрх зүйн зохицуулалтын талаар олон баримт бичиг, зөвлөмжийг сүүлийн жилүүдэд гаргасан байна. Жишээ дурдвал[268]:

- "Байгуулах-Ажлуулах-Шилжүүлэх" аргаар дэд бүтцийг хөгжүүлэх талаарх ЮНИДО-ийн удирдамж \UNIDO Guidelines for Infrastructure Development through Build Operate Transfer (BOT) Projects, 1996 (UNIDO BOT Guidelines)\;
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Концессийн гэрээний талаарх хуулийн үндсэн бүрдүүлбэр хэсгүүд \OECD Basic Elements of a Law on Concession Agreements, 1999-2000\;
- Хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй дэд бүтцийн төслийн

[266]Жишээ нь, Ирак 1961, 1972 онд ийм арга хэмжээ хэрэгжүүлжээ.

[267]Газрын тосны тухай бичихүй, Нээлттэй нийгэм хүрээлэн. УБ хот, 2002 он, 101 дэх тал

[268]www.uncitral.org; www.unido.org; http://www.ebrd.com; www.europa.eu



талаарх ЮНСИТРАЛ-ын хууль тогтоох зөвлөмж \UNCITRAL Legislative Guide on Privately Financed Infrastructure Projects, 2000 (UNCITRAL Legislative Guide)\;

- Хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй дэд бүтцийн төслийн талаарх ЮНСИТРАЛ-ын хуулийн загвар заалтууд \UNCITRAL Model Legislative Provisions on Privately Financed Infrastructure Projects, 2003 (UNCITRAL Model Legislative Provisions)\;
- Орчин үеийн концессийн хуулийн талаарх Европын сэргээн босголт, хөгжлийн банкны суурь зарчмууд \The EBRD Core principles for a Modern Concession Law\;
- Төр ба хувийн хэвшлийн амжилттай хамтын ажиллагааны талаарх Европын Комиссийн удирдамж \European Commission Guidelines for Successful Public-Private Partnerships, 2003\;
- Төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаарх Европын Комиссийн Ногоон баримт бичиг ба Нийтийн гэрээ, Концессийн тухай Хамтын нийгэмлэгийн хууль \European Commission Green Paper on Public-Private Partnerships and Community Law on Public Contracts and Concessions, 2004\.

Монгол Улсын 1997 оны Ашигт малтмалын тухай хууль, мөн хуулийн 2007 оны шинэчилсэн найруулгын үзэл баримтлал ч гэсэн анх хүсэлт гаргасан этгээдэд хайгуул хийх тусгай зөвшөөрлийг чөлөөтэй олгох, улмаар ашиглалт явуулахад уг этгээд давуу эрх эдлэх, олзворлосон ашигт малтмалыг эзэмшилдээ авч худалдан борлуулах эрхтэй байх, гэхдээ ашигт малтмал олборлогч этгээд нь татвар, нөөцийн төлбөрийг зохих хуулийн дагуу төлөх нөхцөл бүхий концессийн энгийн аргыг нэвтрүүлэх явдал байсан юм.

Монгол Улсад газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмал нь төрийн өмч байх тул ашигт малтмалын ордыг хайж олох, ашиглах, олборлосон зүйлээ өмчлөх онцгой эрхийг зөвхөн төрийн байгууллагын шийдвэрээр тодорхой этгээдэд тусгайлан олгоно. Ингэхдээ зохих төлбөр, татвар төлүүлэх болзол, нөхцлийг хуулиар болон гэрээгээр тогтоох боломжтой юм.

Манай улсын 1993 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4-т 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулснаар концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ нь хөрөнгө оруулалтын гэрээний нэг төрөл болжээ. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлд төрийн өмчийн эд хөрөнгийг концессийн гэрээгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулах боломжийг тусгасан байдаг.

Улсын Их Хурлын 2009 оны намрын чуулганд Концессийн тухай хуулийн төсөл өргөн баригдсан байна. Уг хуулийн төслийн 4 дүгээр зүйлд концесс дараах төрөлтэй байхаар тусгажээ. Үүнд:

- тодорхой төрлийн ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх;
- тодорхой төрлийн эд хөрөнгө, үйл ажиллагааны удирдлага, менежментийг хэрэгжүүлэх;

- эд хөрөнгийг өөрийн хөрөнгөөр бий болгож төрийн болон орон нутгийн байгууллагад түрээслүүлэх, гэрээнд заасан хугацаанд өмчлөгчид шилжүүлэх;
- эд хөрөнгийг өөрийн хөрөнгөөр бий болгож тодорхой хугацаагаар эзэмшиж ашигласны дараа төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх.

Төслийн 6 дугаар зүйлд зааснаар төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтыг Засгийн газрын санал болгосноор Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батлана. Гэвч чухам юу концессийн зүйл байж болох талаар төсөлд нарийвчлан тодорхойлоогүй орхигдуулсан байна.

Уг нь концессийн зүйлд нэгд, төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ \иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийг хамгаалах, хууль журам сахиулах, аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих, тээвэр, зам харилцаа, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх\, хоёрт, нийтэд үйлчлэх зориулалтын төрийн болон орон нутгийн өмчлөлийн зүйлс \зам, гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн, үер усны хамгаалалт, далан шуудуу, байгууламж болон дэд бүтэц, нийтийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлийн төрийн ба орон нутгийн өмчит үйлдвэр, байгууллага, компани, тэдгээрийн хувьцаа\ зэргийг хамруулбал зохино. Өөрөөр хэлбэл, өмчлөлийн зүйлийн зэрэгцээ үйл ажиллагаа ч концессийн зүйл байж болно.

Хамтарсан үйлдвэр байгуулах гэрээ

Улс зарим үед бизнесийн түншийн хувиар хамтарсан аж ахуйн үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэл эрхлэх зорилгын үүднээс гадаад улс эсхүл гадаадын компанитай гэрээ байгуулдаг. Энэ тохиолдолд шаардлагатай хөрөнгө оруулалтын тодорхой хувийг улс өөрөө гаргах бөгөөд энэ хэмжээгээр тухайн аж ахуйн нэгжийн зохих хувьцааг эзэмшинэ. Социалист эдийн засгийн төгөлдөр



Компанийн тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах бөгөөд Монгол Улсын хуулийн этгээд болно. Компанийн үйл ажиллагааны гол чиглэл нь уран агуулсан хүдрийн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, дахин боловсруулалт, баяжуулалт болон эцсийн бүтээгдэхүүн борлуулалт, мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт уран олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах, дэд бүтцийг байгуулах, ашиглах явдал байна.

Улс ба хувь этгээд хамтарч байгуулсан хамтарсан үйлдвэрийн ойрын нэг жишээ бол Монгол Улсын Засгийн газар ба "Айвенхоу майнз монголиа инк", Айвенхоу майнз лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс лимитед компани хоорондын хөрөнгө оруулалтын гэрээ юм. Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн байгуулсан уг гэрээгээр хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны тогтвортой орчинг баталгаажуулж, мөн гэрээт талбайд ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, баяжуулах үйл ажиллагаа явуулах талаарх эрх, үүргийг тодорхойлсон байна. Гэрээ байгуулагч талууд "Айвенхоу Оюу толгой \БиВиАй\ лимитед" компанийн энгийн хувьцааны 34 хувийг өмчлөх, цаашид нэмж 16 хувийг өмчлөх талаархи Монгол Улсын Засгийн газрын эрхийг хүлээн зөвшөөрч зохих тохиролцоонд хүрчээ.

Дээр дурдсан хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд Монгол Улсын төрийн өмчит "Эрдэнэс МГЛ" ХХК, "Айвенхоу Оюу толгой \БиВиАй\ лимитед" компанийн хооронд Оюу толгой төслийн хувь нийлүүлэгчдийн гэрээ байгуулагдсан бөгөөд үүний үр дүнд "Айвенхоу майнз монголиа инк" ХХК нь үндсэндээ хамтарсан компани болжээ. Ийнхүү хамтарсан компани байгуулах, компанийн хувьцааны тодорхой хувийг төр эзэмших хуулийн үндэслэлийг Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалтад тусгасан байдаг. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлд мөн ийм агуулга бүхий зохицуулалт саяхан нэмэгдэж оржээ. Хэдийгээр өмнө дурдсан хуульд заасны дагуу манай улс ашигт малтмалын орд эзэмшигч компанийн тодорхой хувийг заавал өмчлөхөөр болж байгаа боловч цаашид шаардлагатай хөрөнгө оруулалтын өөрт ногдох хэсгийг гаргах, улмаар төслийн хэрэгжилтийн эрсдэлийг нэгэн адил хариуцах үүргийг хүлээнэ. Манай Засгийн газар ялангуяа хөрөнгө оруулалтын санхүүжилт хийх үүргийг тэр бүр хэрэгжүүлэх эдийн засгийн боломжгүй тохиолдолд хуулийн ийм зохицуулалт манай улсын хөгжил, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд саад тотгор болох магадлал ихтэй.

Оюу толгой төсөлтэй холбогдуулан манай улсын Засгийн газрын байгуулсан хөрөнгө оруулалтын болон хамтарсан компанийн хувь нийлүүлэгчийн гэрээ, түүний бүтэц, нөхцлүүд нь цаашдын ижил төстэй хэлэлцээр, гэрээнүүдэд жишиг, суурь нөхцөл болох нь дамжиггүй.

Хамтарсан компани үүсгэн байгуулах гэрээ буюу хувь нийлүүлэгчдийн гэрээнд дараах нөхцөлийг нарийвчлан тусгасан байдаг:

- хамтарсан компани байгуулах гэрээний талууд, түүний эрх зүйн байдал
- хувьцаа эзэмшилтийн харьцаа, хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх

журам
- Засгийн газраас олгох онцгой эрх, зөвшөөрөл, хөнгөлөлт, баталгаа
- талуудын хөрөнгө оруулалтын хэлбэр, хэмжээ, түүнийг үнэлэх нөхцөл, журам
- компанийн удирдлага, шийдвэр гаргах журам
- ногдол ашиг хуваарилах
- зарим үүрэг, эрсдэлийн хуваарилалт
- талуудын хүлээх хариуцлага
- гэрээний хугацаа, гэрээг цуцлах журам
- маргаан шийдвэрлэх арга.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Бүтээгдэхүүн хуваах үзэл баримтлалыг 1950-иад оны эхээр Боливи улсад анх турших эхэлжээ. Гэхдээ бүтээгдэхүүн хуваах гэрээний өнөөгийн эрх зүйн хэлбэрийг ашигт малтмалын салбар ялангуяа газрын тос олборлох үйл ажиллагаанд амжилттай ашигласан улс бол Индонези улс юм[269]. Тус улс нь 1945 онд тусгаар тогтнолоо зарласан боловч Данийн колонийн бодлогын дагуу гадаадын газрын тосны компаниуд үйл ажиллагаагаа явуулсаар байв.

Харин 1960-иад онд үндсэрхэг үзэл сэргэн лиценз, концессийг империалист, колонийн арга хэмээн үл итгэх байдал нэмэгдэж, Засгийн газраас шинээр концесс олгохоо зогсоож, харин нөөц баялагийг төр өмчилж, ашиг хуваах "Индонезийн дүрэм" гэгчийг нэвтрүүлсэн ба улмаар олон улсын газрын тос, хий олборлогч тэргүүлэх компаниуд үүнийг дэмжиж хүлээн зөвшөөрч эхэлсэн байна[270].

Өнөөдөр энэ төрлийн гэрээ олон улс оронд түгээмэл хэрэглэгдэж байна. Тухайлбал, Ангол, Вьетнам, Ливи, Египет, Малази, Перу, Сири, Филлипин, Казакстан, Азербайджан, ОХУ зэрэг улсыг нэрлэж болно.Ялангуяа газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээг голлон ашиглаж байна.

Онолын хувьд энэхүү гэрээгээр засгийн газар ашигт малтмалыг бүрэн хяналтдаа байлгах бөгөөд хөрөнгө оруулагч компани нь гэрээнд заасан нөхцлөөр ашигт малтмалыг олборлох үүрэг хүлээнэ. Гэхдээ практикт засгийн газрын эрх, ялангуяа нөөцөд хяналт тавих, хууль тогтоомжийг шинэчлэн өөрчлөх бүрэн эрхийг хязгаарлах, олборлох компани хайгуулийн эрсдлийг бүрэн хариуцаж, олзворлосон бүтээгдэхүүний тодорхой хувийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авах нөхцөлүүд БХГ-нд тусгагдсан байдаг.

БХГ-ний дагуу хөрөнгө оруулагч нь эхлээд хайгуулын ажлыг гүйцэтгэх, өрөмдлөг хийх, дэд бүтцийг бүрдүүлэх чиглэлээр хөрөнгө оруулах үүрэг хүлээж, хайгуулын эрсдэлийг бүрэн хариуцна. Олзворлосон ашигт малтмалын эхний хэсгийг хөрөнгө оруулагч компанийн гаргасан хөрөнгө оруулалт ба зардлыг эхлэж хаах зорилгоор уг компанид хуваарилах бөгөөд газрын тосны салбарт ийм хэсгийг "зардлын тос" (cost oil) гэж нэрлэдэг ажээ.

[269]Tahmud H. The Indonesian Product Sharing Contract, 1998, p. 37

[270]Dr. Irina Paliashvili (the President of the Russian-Ukrainian Legal Group), The Presentation at the Seminar on the Legislation on Production Sharing Agreements, September 14,1998

Нийт олзворлосон бүтээгдэхүүний хэдэн хувийг жил бүр зардалд зориулан тооцохыг зарим гэрээнд тусгайлан хязгаарлан тогтоох явдал бий. Зардал бүрэн нөхөн төлөгдсөн үеэс үлдэж буй "ашгийн бүтээгдэхүүн" Засгийн газар ба хөрөнгө оруулагчдын хооронд тохиролцсон харьцаагаар хуваагдана. Энэхүү харьцаа нь ойролцоогоор 40:60-аас 60:40 хооронд хэлбэлзэж байна. Компани өөрт ногдох бүтээгдэхүүний ашгаас татвар болон нөөцийн төлбөр төлөх эсхүл аливаа татвар, төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлөөр гэрээг байгуулж болно.

БХГ нь бусад гэрээ, тухайлбал, концессийн гэрээнээс төрийн хяналтын эрх хэмжээ, эрсдэл, ашиг хуваарилах аргаар илүүтэй ялгагдана. Гэхдээ гэрээний нөхцлөө хэрхэн тохирохоос хамаарч эдгээр гэрээ санхүүгийн өнцгөөс харахад ялгаа багатай байж болно гэж үздэг. Концессийн гэрээтэй харьцуулбал, БХГ нь төрийн хяналт, оролцоог илүү нэмэгдүүлэх боломжийг хангана. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хайгуул, олзворлолтын үйл ажиллагааг бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр явуулахаар 1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуульд анх удаа тусгаж, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн билээ[271].

Энэ үеэс хойш газрын тосны үйл ажиллагааг 25 гэрээт талбайд явуулахаар шийдвэрлэж зохих сонгон шалгаруулалтыг үе шаттайгаар явуулж байна. Үүний үр дүнд 2009 оны эцсийн байдлаар гадаадын болон дотоодын 16 компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан байна \ Хавсралт хүснэгтийг үзэх\.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ гэж гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар Газрын тосны хэрэг эрхлэх газар \ГТХЭГ\ болон Гэрээлэгчийн хооронд байгуулж, Монгол Улсын Засгийн газраар батлуулсан гэрээг ойлгоно. Уг гэрээг дараах үе шаттайгаар байгуулна. Үүнд:

1. ГТХЭГ газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах захиалга хүлээн авах тухай болон захиалга хүлээн авах эцсийн хугацааг Агентлагийн веб хуудсаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлнэ.

2. Зарласан хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий этгээд захиалгаа Монгол Улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу бүрдүүлж, ГТХЭГ-т өгнө.

3. Захиалгыг хүлээн авах хугацаа дууссаны дараа ГТХЭГ ирүүлсэн захиалгыг цаашид судлах, эсвэл хүлээн авах боломжгүй тухайгаа Захиалагчид 45 хоногийн дотор мэдэгдэнэ

[271]Газрын тосны тухай хууль \1991 он\, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль \2005 он\, Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан "Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам", ... "БХГ-ний Гэрээлэгч сонгон шалгаруулах журам", "БХГ-ний загвар", Засгийн газрын 2002 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын тосны салбарт 2010 он хүртэл баримтлах чиглэл", ... Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого, 2015 он хүртэлх үйл ажиллагааны үндсэн чиглэл"

4. ГТХЭГ-ын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг Захиалагчтай БХГ-ний хэлэлцээг хийнэ.

5. Ажлын хэсэг Захиалагчтай хэлэлцээ хийж холбогдох материалыг бүрдүүлэн битүүмжилж тогтоосон хугацаанд Үнэлгээний хэсэгт хүлээлгэн өгнө.

6. Үнэлгээний хэсэг нь захиалагчийн ирүүлсэн захиалга болон холбогдох материалыг хянан шалган, үнэлгээ хийж санал дүгнэлт гарган Сонгон шалгаруулах зөвлөлд /СШЗ/ танилцуулна.

7. СШЗ нь Ажлын хэсгийн Илтгэх хуудас, Үнэлгээний хэсгийн санал, дүгнэлтийг хуралдаанаараа авч хэлэлцэн БХГ байгуулах нөхцлийг хангасан Захиалагчийг сонгох буюу түүнд гэрээ байгуулах эрх олгох эсэх тухай шийдвэр гарган Үйлдвэр худалдааны сайдад танилцуулна. СШЗ-ийн шийдвэрийг баталгаажуулан Үйлдвэр, худалдааны сайд тушаал гаргана.

8. БХГ байгуулах эрх олгогдсон Захиалагчид гэрээ байгуулах тухай мэдэгдлийг ГТХЭГ-аас хүргүүлнэ.

9. ГТХЭГ-аас эрх олгогдсон төлөөлөгч Захиалагчтай БХГ-ний төслийг үзэглэнэ.

10. Үзэглэсэн БХГ-ний төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвлөмж гаргуулна.

11. БХГ-ний төслийг бусад яам, газрын саналыг авсаны үндсэн дээр Засгийн газраар хэлэлцүүлж гарын үсэг зурах зөвшөөрөл авна.

12. Засгийн газрын шийдвэрийг үндэслэн ГТХЭГ-аас томилогдсон эрх бүхий этгээд БХГ-нд гарын үсэг зурж, улмаар Засгийн газарт гэрээг өргөн мэдүүлж батлуулна.

13. Засгийн газар БХГ-г баталсан өдрөөс эхлэн Гэрээ хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Газрын тосны хэрэг эрхлэх газар БХГ-г байгуулахдаа Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ыг баримтлах бөгөөд нөхцлийг голлон тусгаж байна. Үүнд:

- Хайгуулын ажил явуулах хугацаа \5 хүртэл жил, 2 удаа 2 хүртэл жилээр сунгах\
- Олборлолтын хугацаа \20 хүртэл жил, 2 удаа тус бүр 5 жилээс илүүгүй хугацаагаар сунгах\
- Хайгуулын ажлын хөтөлбөр
- Талбай буцааж өгөх
- Олборлолтын үйл ажиллагаа \Гэрээлэгч нь Нээлтийн цооног болон Үр ашигтай нээлт бүрийн тухай мэдэгдэх, жилийн олборлолтын нарийвчилсан хөтөлбөр, төсвийг батлуулах\
- Газрын тосны үнэлэлт \Үнэ тогтоох арга, аргачлал\
- Төлбөр, Газрын түрээс, Татвар \Гэрээлэгч нь хууль тогтоомжийн дагуу төлбөр, газрын түрээс, орлогын болон бусад татвар төлөх\
- Зардал нөхөх \Гэрээлэгч нь үйл ажиллагааны зардлаа нөхөх зорилгоор

жилд олборлосон нийт газрын тосны 40 хүртэл хувийг "Өртөгт тос"-д авч зарцуулах\

- Бүтээгдэхүүн хуваах \олборлосон газрын тооноос Төлбөр болон Өртөгт тосыг хасаад үлдсэн хэсгийг Хэрэг эрхлэх байгууллага, Гэрээлэгчийн хооронд хуваах\
- Эд хөрөнгийг Монгол Улсад оруулах, тус улсаас гаргах \Гэрээлэгч нь өөрт ногдох газрын тосыг МУ-ын нутгаас авч гарах, түр хугацаагаар оруулсан тоног төхөөрөмжөө буцаан гаргах эрхтэй\
- Эд хөрөнгө өмчлөх, эрх шилжих \Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, барилга байгууламж, материал, түүхий эд нь Хэлэлцээрийн хугацаа дууссаны дараа нэмэгдэл төлбөргүйгээр МУ-ын төрийн өмчид шилжих\
- Гаалийн татвараас чөлөөлөх \Гэрээлэгч нь тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, материал, түүхий эдийг МУ-д оруулах, түр хугацаагаар оруулсан тоног төхөөрөмжийг буцаан гаргах, хуваарьт Газрын тосыг МУ-ын нутаг дэвсгэрээс гаргахад гаалийн татвараас чөлөөлөгдөх\
- Хэлэлцээр цуцлах \аль нэг тал нь Хэлэлцээрийг цуцлах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэснээр түүнийг цуцлах эсэх\
- Хэрэглэгдэх хууль тогтоомж \Хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх, тайлбарлахад МУ-ын хууль тогтоомжийг баримтлах бөгөөд холбогдох хуулийн заалт байхгүй тохиолдолд олон улсын эрх зүйн зарчмыг иш үндэс болгох\
- Маргааныг хянан шийдвэрлэх \Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүсэх эд хөрөнгийн болон бусад маргааныг Хэрэг эрхлэх байгууллага, Гэрээлэгч нь эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гомдлоо МУ-ын шүүхэд гаргах, Хэлэлцээрийн нөхцөлийг тайлбарлах болон Хэлэлцээрийг хүчингүй болгох зэрэг асуудаар үүссэн маргааныг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх эүйн байгууллагын дагаж мөрдөж буй дүрмийн дагуу холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх\
- Нууцлалт \Гэрээлэгчийн Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад олж авсан бүхий л баримт бичиг, мэдээлэл, материал, мэдээг нөгөө талтай урьдчилан тохиролцохгүйгээр гурав дахь этгээдэд үл шилжүүлэх\

5. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

Уул уурхайн салбарын үйл ажиллагаатай холбогдсон эрх зүйн зохицуулалтын онцлог нь эрх зүйн обьект бүхэлдээ эрх зүйн нэг субьектийн өмчлөлд байдагт оршино.

Монгол Улсын Үндсэн Хуулийн зургадугаар зүйлд:

1. "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад

байна"

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн" гэж заасан.

Өмчлөх эрх нь захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг агуулдаг бөгөөд эдгээрээс зөвхөн ашиглах эрхийг бусад этгээдэд шилжүүлэх эрх зүйн зохицуулалт бий.

Уул уурхайн салбарын хүрээнд үйлдвэрлэлийн харилцаанд оролцдог өмчийн хоёр хэлбэрийн нэг болох үйлдвэрлэлийн хэрэгсэл (газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ашигт малтмал) төрийн өмч, нөгөө хэсэг үйлдвэрлэлийн багаж зэвсэг (машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж) хувийн болон төрийн өмчийн аль нь ч байж болно.

Үйлдвэрлэлийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн багаж зэвсэг бүхэлдээ төрийн өмч байх тохиолдолд эрх зүйн хувьд харьцангуй хялбар зохицуулалттай байдаг.

Үйлдвэрлэлийн хэрэгсэл (ашигт малтмал) төрийн өмч, үйлдвэрлэлийн багаж зэвсэг хувийн өмч байх нөхцөлд өмчийн энэ хоёр хэлбэрийн харилцааг маш нарийн эрх зүйгээр зохицуулах шаардлагатай байна.

Эрх зүйн нэг объекттой (ашигт малтмалын орд) эрх зүйн хоёр субьект (үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч, үйлдвэрлэлийн багаж зэвсгийг өмчлөгч) харилцах үеийн эрх зүйн зохицуулалтыг "Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар үндсэнд нь зохицуулах боловч "Газрын хэвлийн тухай хууль" (1988), "Ашигт малтмалын тухай хууль" (2006), "Газрын тухай хууль" (2002), "Усны тухай хууль" (2004), "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль" (1998), "Байгаль орчныг хамгаалах тухай хууль" (1995) зэрэг хуулиуд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, бусад хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

Эрдэс баялгийн цогцолбортой холбоотой Алтны, Нефтийн, Цөмийн энергийн тухай зэрэг олон салбар хуулиуд байгаа боловч Уул уурхайн тухай хууль батлагдаж гараагүй байна.

Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог нь уул уурхайн салбарын өөрийнх нь онцлогтой шууд холбоотой байна. Уул уурхайн салбарын онцлог гэдэгт:

1. Ашигт малтмалын орд эрх зүйн обьект болохын хувьд орон зайн төрмөл байрлалтай.

2. Бүтэц, тогтоц, найрлага нь олон сая жилийн миграцын дүнд буй болсон төрмөл шинжтэй.

3. Эрх зүйн субьектын санаачлагаар байрлал, тогтцыг нь өөрчлөх боломжгүй.

4. Ашигт малтмалын нэгэн төрлийг нөгөөгөөр солих боломжгүй. (алтыг уран болгож болохгүй)

5. Уул уурхайн үйлдвэр нь байгалийн баялгийг үндэсний баялаг болгон

хувиргах үйлдвэрлэгч. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь түүний өмч болдог.

6. Ашигт малтмалын нөөц, чанар, газрын хэвлий дэх тогтоц, хүдрийн биеийн зузаан нимгэн, гүний хэмжээ, хэрэглэж буй технологи зэргээс шалтгаалан нэг төрлийн ашигт малтмалыг олборлох зардал харилцан адилгүй байх.

7. Ажлын байрны байршил ба нөхцөл байнга өөрчлөгдөж түүнийг дагаж уулын ажлын горим, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага өндөрсөх, зардал өсөх хандлагатай.

8. Уул уурхайн үйлдвэрлэл нь ажлын хүнд, аюултай нөхцөлтэй ангилалд хамаардаг.

9. Уул уурхайн үйлдвэрлэл нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх магадлал ихтэй зэрэг хүний хүчин зүйлээс бага хамааралтай олон онцлог бий. Уул уурхайн салбар нь Газар, түүний хэвлий, ашигт малтмал, байгаль орчинтой харьцдаг эдийн засаг- экологи технологийн нэгдэлд тулгуурласан нийгмийн үйлдвэрлэлийн өвөрмөц цогцолбор юм. Уул уурхайн салбарын бас нэг онцлог гэвэл үйлдвэрлэлийн харилцаанд өмчийн олон хэлбэр оролцдог (дагнасан болон холимог, хамтарсан) онцлогтой.

5.1. ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ОНЦЛОГ

Байгалийн баялгийн үлэмж их нөөцийн зэрэгцээгээр улс төрийн тогтвортой байдал, хууль эрх зүйн таатай нөхцөл нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах зайлшгүй нөхцөлийн нэг юм. Ер нь тогтвортой хөгжил гэдэг өөрөө аливаа үйл хэрэгт оролцогч талууд: Засгийн газар, компаниуд, хөдөлмөрийн хамт олон, төрийн бус байгууллагууд, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч бүгд тухайн улсын хууль, эрх зүйн байдал, тогтоомын дүрмийг мэдэж байх ёстой. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлого барьж буй улс орны хувьд хууль дүрэм нь олон улсын жишигт нийцсэн, ил тод, ойлгомжтой байх шаардлагатай.

Хууль дүрэм нь үндэсний эрх ашиг, нийгмийн сонирхол, байгаль орчныг хамгаалах асуудлыг зохицуулах удирдлагын гол хэрэгсэл байхын зэрэгцээ хамтран ажиллагч бусад оролцогчдын сонирхлыг харгалзан хамгаалж чадах чадвартай байвал шударга болно. Иймэрхүү үзэл баримтлалын үүднээс бид эрх зүйн шинэчлэл хийх ёстой.

Эрх зүйн шинэчлэл Монголд төдийгүй дэлхийн 100 гаруй оронд хийгдэж бодлого, хууль тогтоомжууд шинээр гарсан буюу шинэчлэгдсэн байна. Эрх зүйн эдгээр шинэчлэл нь голдуу гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, тогтвортой таатай санхүүгийн болон хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Уул уурхайн болон бусад хөрөнгө оруулалтад чөлөөт эдийн засгийн бодлогыг тусгаж олон улсын илүү өрсөлдөөнтэй талбар буй болгох бодлогыг агуулж байна.

Хуулийн болон бүтцийн энэхүү шинэчлэл нь салбарын эдийн засгийн нөхцөл сайжрахын зэрэгцээгээр хөрөнгө оруулалтын шинэ урсгал бий болж

улмаар тогтвортой хөгжлийн суурийг тавих зорилго агуулж буй нь мэдээж хэрэг. Эрх зүйт төрийн тогтолцоо бүхий ардчилсан нийгэмд хууль бол удирдлагын үндэс байх ёстой.

Уул уурхайн салбарын удирдлагад хууль голлох үүрэгтэй. Яагаад гэвэл газрын хэвлий түүний баялаг төрийн өмч байх тул түүнийг захиран зарцуулах, эзэмших, ашиглах харилцаа зөвхөн хуулиар зохицуулагдах ёстой.

Хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш байна. Хууль хүчтэй. Гэхдээ түүнийг чадварлаг зохицуулан удирдах байгууллагагүйгээр, эсвэл олгогдсон эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх ажиллагаа нь хөндлөнгийн хүчинд автдаггүй, бие даасан шүүхийн системгүйгээр дангаараа амжилтанд хүрэхгүй.

Төр нь хууль зүйн үндсэн нөхцлийг ашигт малтмалын салбарт бүрдүүлдэг ба улсын хууль бол компаниудыг тэдний харилцагч бусад талуудтай хуулийн эрх үүргийн хүрээнд холбож байдаг зам болдог. Хууль нь зохицуулагчдад ойлгомжтой, цэгцтэй, сахиулж болох үндсэн нөхцөл нь үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг үр өгөөжтэй хянахад зайлшгүй чухал хэрэгсэл. Иргэдийн хувьд, уг үндэс суурь нь амь нас, хөрөнгөө алдаж болох эрсдэлийн эсрэг, эсвэл шударга бус маргаантай шийдвэр, хандлагаас хамгаалдаг ба тэдэнд өөрийн байр суурийг олж дээшлүүлэх хууль эрх зүйн системтэй байх нь чухал.

Ихэнх орнуудад уул уурхайн тухай хууль нь ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэлийг удирдах, захирах гол хууль зүйн хэрэгсэл юм. Засгийн газрын хамгийн эхний үүрэг бол дотоодын хайгуул, олборлолт, ашиглалт, боловсруулалт зэрэг асуудлыг зохицуулахад оролцох явдал юм. Уул уурхайн хуулиуд холбогдох дүрэм журмуудад хайгуулын болон ашигт малтмалын ашиглалтын лицензэ эзэмшигч нь холбогдох бүх хууль дүрэмд захирагдах ба зарим тохиолдолд уул уурхайн хуулийн хүрээнээс хальсан байгаль орчны болон нийгмийн шаардлагын талаар уламжлалт нэмэлт нөхцөлийг ч дагах шаардлага гарна. Жишээ нь, байгаль орчин болон нийгэмд нөлөөлөх нөлөөллийн талаарх үнэлгээ, үндэслэл, байгаль орчны удирдлагын төлөвлөгөө, нөхөн сэргээх хөтөлбөр эсвэл нөхөн сэргээх буюу сэргээн засварлах сантай байхыг шаардаг. Уул уурхайн хууль дахь байгаль орчны талаарх олон заалтууд байгаль орчны хуультай давхцаж байдаг. Сүүлийн үед зарим улс зөвхөн уул уурхайн үйл ажиллагаанд зориулсан байгаль орчны тусгай журмыг гаргах хандлагатай болсон байна.

Зарим улс орон тусгай төслийн хувьд тогтвортой байдлын гэрээ байгуулах сонирхолтой болжээ. Энэ нь хөрөнгө оруулагчдыг дэмжиж байгаа боловч нийгмийн шаардлагын өөрчлөлт, цаашдын үйл ажиллагааны хөгжлийн нөхцөл байдлуудтай уялдуулан өөрчлөх боломжийг тодорхой хугацаанд хязгаарладаг.

Уул уурхайн өөр нэг хууль бол уурхайн хаалт төлөвлөлтийн хууль буюу нөхөн сэргээх хууль юм. Эдгээр нь Австрали, Канад, АНУ-ын хувьд хэдийн жишиг болжээ. Ерөнхийдөө эдгээр нь уурхайг хаагдах үед байгаль орчны ямар нөхцөл бүрдүүлэх талаар олон нийтийн оролцоотой үйл

ажиллагааны төлөвлөгөө ба компаниас уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах санхүүгийн баталгааг шаарддаг. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ) ч гэсэн ийм хуультай. Цөөн тооны бусад хөгжиж буй орнууд хаалтын хуультай. Монголд энэ харилцаа Ашигт малтмалын тухай хуулиар (45-р зүйл) зохицуулагддаг. Засгийн газрууд уул уурхайн хуулиа өөрчилж шинэчлэхэд дэлхийн банк чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн банк хууль зүйн ба институцийн хувьд хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх, нэмэгдсэн орлогоо өрийг буцаан төлөхөд ашиглагдах нөхцлийг бүрдүүлэхэд туслах зорилготой. Энэ нь хөрөнгө оруулагчид зээлдэгчдийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн гэж хэлж болно. Яагаад гэвэл гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ядуу орны эдийн засгийн хөгжлийнх нь капиталын маш чухал эх үүсвэр болдог.

УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ХЭЛЭЛЦЭЭР, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД

Гадаад орнуудын уул уурхайн өнөөгийн практик. Капитал импортлогч орнуудын эрдэс баялаг олборлох салбарт мөрдөгдөж байгаа уул уурхайн хууль тогтоомж нь сүүлийн 20 жилийн хугацаанд боловсронгуй болсон хэдий ч ихэнх орнуудад эрдэсийн баялаг олборлолтын үйл ажиллагааг үндэстэн дамнасан корпорациуд капитал импортлогч тухайн орны Засгийн газартай орчин үеийн концессийн хэлэлцээр буюу эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээр байгуулах замаар явуулж байна.

Гадаад орнуудын уул уурхайн өнөөгийн практикт орчин үеийн концессийн гэрээг янз бүрээр нэрлэж байна. Тухайлбал, концессийн хэлэлцээр (concession agreement), эдийн засгийн хөгжлийн хэлэлцээр (economic development agreement), аз турших хэлэлцээр (risk service agreement), үйлчилгээний хэлэлцээр (service agreement), ажил гүйцэтгэх гэрээ (work contract), хамтарсан үйлдвэрийн гэрээ (joint venture agreement), бүтээгдэхүүн хуваах хэлэлцээр (production sharing contract), оролцооны хэлэлцээр (participation agreement), ашигт малтмалын хэлэлцээр (minerals ad hoc agreement) гэсэн нэр томъёог өргөн хэрэглэж байсан бол саяхнаас эрдсийн баялаг боловсруулах хэлэлцээр (natural resource development agreement) гэсэн нэр томьёог өргөн хэрэглэж байна.

Концессийн хэлэлцээрийн нэр, хэлбэрийн сонголт нь улс төрийн агуулгатай байдаг учраас олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны өнөөгийн практикт эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээр (natural resource development agreement) гэсэн нэр томьёог гол төлөв сонгон хэрэглэх болжээ. Одоо гадаад орнуудын уул уурхайн практикт өргөн хэрэглэдэг концессийн хэлэлцээрийн ойлголт, бүтэц, агуулга, төрлүүдийн талаар тодорхой ойлголт өгөхийн тулд эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн үүсэл хөгжил, бүтэц, онцлог шинж болон төрлүүдийг авч үзье.

Эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн үүсэл, хөгжил. Уламжлалт концессийн гэрээнд капитал импортлогч орны Засгийн газрын зүгээс

концессийн эрх эзэмшигч компанийн уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих эрх тусгагддаггүй байв. Иймээс концессийн хэлэлцээрийн заалтууд нь роялтийн төлбөр тооцох аргачлал зэрэг санхүүгийн асуудлыг гол төлөв зохицуулдаг байжээ. Түүнчлэн, концессийн эрх эзэмшигч нь олборлосон ашигт малтмал буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өмчлөх эрхтэй байсан учраас уламжлалт концессийн гэрээнээс аль болох татгалзаж түүний оронд эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг байгуулах хандлага гарч түүний хөгжлийн үе эхэлжээ.

1960-аад оны дунд үед хөгжиж буй орнуудад эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг эдийн засгийн хөгжлийн хэлэлцээр (economic development agreement) гэсэн нэрээр байгуулах практик өргөн дэлгэрсэн бөгөөд энэ нэр томъёог хэрэглэх саналыг анх америкийн судлаач Н.Хид дэвшүүлсэн билээ. Хөгжиж буй зарим орнуудын практикт "эдийн засгийн концесс" (economic concession) гэх мэтийн нэр томьёог хэрэглэсэн боловч тэдгээрийг хууль зүйн үүднээс хэн ч тодорхойлж чадаагүй байна.[272] Харин яваандаа гадаад орнуудын уул уурхайн практикт гол төлөв "эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээр" гэсэн нэр томьёог хэрэглэж заншсан юм.

Эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн агуулга. бүтэц нь уламжлалт концессийн гэрээнийхээс өөр болсноос гадна капитал импортлогч орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны практикт төлөвшин хөгжсөнөөрөө онцлог юм.

Энэ шалтгаанаар одоо болтол концессийн гэрээний нэгдмэл стандарт нөхцөлүүд боловсруулагдаагүй байна. Гэхдээ, гадаад орнуудын уул уурхайн практикт эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн биеэ даасан төрлүүд бий болж, концессийн гэрээний агуулга, бүтэц ихээхэн өөрчлөгдсөн ба ийнхүү өөрчлөгдөхөд гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал нөлөө үзүүлсэн билээ. Учир нь эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээр нь гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлж санхүүжүүлэх хууль зүйн механизм болсон ба уг механизмын давуу тал нь ашигт малтмал өмчлөх эрхийг гадаадын хөрөнгө оруулагчид шилжүүлэхгүйгээр гадаадын хөрөнгө оруулалттай уулын үйлдвэрлэлийн олборлолтын болон аж ахуйн үйл ажиллагаа эсвэл уул уурхайн төслийн хэрэгжилтэнд капитал импортлогч орны засгийн газрын зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгосонд оршино. Гэхдээ, эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн бие даасан төрлүүдийн агуулга, зохицуулах зүйлийн хүрээ нь өөр хоорондоо ялгаатай юм.

Эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн бүтэц, агуулга

Капитал импортлогч орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын үндэсний бодлогын үр дүнд газрын тосны үйлдвэрлэлийн салбарт анх төлөвшин хөгжсөн орчин үеийн концессийн анхны гэрээ, хэлэлцээрт гадаадын хөрөнгө оруулагчийн хүлээх үүрэгтэй холбогдсон тодорхой асуудал тусгагдах болжээ.

Тухайлбал, гадаадын компанид дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг

[272] J N Hyde, "Permanent Sovereignty over Natural Wealth and Resources", 50 AJIL (1956), p 854, at p. 862.



худалдан авах, энэ тэргүүнд орон нутгийн иргэдийг хөлслөн ажиллуулах, сургах, түүнчлэн компанийн хөлслөн авсан ажилчдад зориулсан сургууль, эмнэлэг барих үүрэг хүлээлгэсэн байна.

Яваандаа гадаадын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа хөгжихийн хирээр капитал импортлогч орнууд нь орчин үеийн концессийн загвар гэрээг өргөн ашиглах болсоноос гадна загвар гэрээндээ ашигт малтмалын төрөлжсөн хуулийн зүйл заалтыг шууд тусган оруулах болсон байна. Мөн уурхайн ашиглалтын аюулгүй ажиллагаа, хүрээлэн байгаа орчны хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбогдсон зүйл, заалтууд тусгагдах болжээ.

Ийнхүү 1970-аад оноос эхлэн гадаад орнуудын уул уурхайн практикт эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрээр гадаадын уул уурхайн компанийн аж ахуйн болон маркетингийн үйл ажиллагаа ялангуяа, уурхайн ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа, татвар ногдуулалт, экспорт-импортын журам, хөдөлмөр эрхлэлт, удирдлагын бүтэц, валютын ханшийн зохицуулалт, хөрөнгө оруулагч компани болон капитал импортлогч орны эрх, үүрэг, дэд бүтэц, уурхайн барилга байгууламж зэрэг асуудлыг зохицуулах болсон бөгөөд одоо ч зохицуулсаар байна.

Концессийн гэрээний өнөөгийн практикаас харахад эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг гадаадын хөрөнгө оруулагч болон капитал импортлогч орны Засгийн газрын хооронд гол төлөв стандарт нөхцлөөр байгуулдаг учраас түүний агуулга, бүтэц, түүнд гарын үсэг зурах журам зэрэг асуудлыг капитал импортлогч орны захиргааны эрх зүйгээр зохицуулж байна.[273] Ялангуяа Дани, Их Британи, Герман, Аргентин, Бразил, Колумб зэрэг уул уурхайн практик нь төлөвшин тогтсон орнуудад концессийн гэрээний стандарт нөхцөлийг хэлэлцээ хийж өөрчлөх боломж байдаггүй аж. Ер нь концессийн гэрээний стандарт нөхцөлийг капитал импортлогч орны тухайн орны ашигт малтмалын төрөлжсөн хууль, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон дүрэм, журам зэрэг захиргааны хууль тогтоомжийн хүрээнд боловсруулдаг тул капитал импортлогч орны хуулийн императив хэм хэмжээг хэлэлцээрийн талууд зөрчих ёсгүй юм.

Концессийн гэрээний өнөөгийн практикаас үзэхэд эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээр нь ерөнхий хэлэлцээр болон бусад дагалдах хэлэлцээрүүдээс бүрдэнэ. Ерөнхий хэлэлцээрээр концессийн эрх эзэмшигч буюу гадаадын хөрөнгө оруулагчид олгох онцгой эрх, давуу тал, хөнгөлөлт (тухайлбал, татварын хөнгөлөлт), маргаан шийдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулагчид олгох эрх зүйн баталгаа, хэлэлцээрийг зөвшөөрөх, соёрхон батлах зэрэг асуудлыг зохицуулдаг. Харин дагалдах хэлэлцээрээр тухайлбал, концессийн эрхийн хүчинтэй хугацаа, уурхайн ашиглалт, бүтээгдэхүүн хуваах зарчим, уулын ажлын санхүүжилт,түүний зарчим, хамтарсан үйлдвэрийн барилга байгууламж зэрэг асуудлыг хэлэлцээрийн талууд тохиролцон шийдвэрлэж байна.

[273] S I Pogany, "Economic Development Agreements", 7 ICSID Rev-FILJ (No !, 1992), pp 1 ff.

Эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн төрлүүд

Олон улсын гадаадын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны өнөөгийн практикт өргөн хэрэглэдэг эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрүүдийг төрөлжүүлэн ангилах тодорхой шалгуур байхгүй боловч ихэнхи судлаачид эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг а) хамтарсан үйлдвэрийн хэлэлцээр (equity sharing), б) менежментийн хэлэлцээр (management contract), б) бүтээгдэхүүн хуваах хэлэлцээр (production sharing agreement), г) аз турших хэлэлцээр (risk service agreement) болон ажил гүйцэтгэх хэлэлцээр (works contract) гэж ангилж байна.*

Мөн зарим судлаачид техник туслалцааны хэлэлцээр (technical assistance contract)-ийг эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн бие даасан төрөл гэж үзэж байна.[274]* Одоо металл олборлох үйлдвэрлэлийн салбарт өргөн хэрэглэдэг эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн зарим төрлүүд, тэдгээрийн агуулгыг авч үзье.

Хамтарсан үйлдвэрийн хэлэлцээр. Хөгжиж буй орнуудын Засгийн газар нь уламжлалт концессийн гэрээнээс аль болохоор татгалзах бодлого явуулж эхэлсний улмаас 1960-иад оноос үндэстэн дамнасан корпорациуд ашигт малтмалыг хамтран олборлох хэд хэдэн шинэ механизмыг боловсруулж практикт нэвтрүүлэхэд хүрчээ.

Эдгээр шинэ механизмын нэг бол олон улсын хамтарсан үйлдвэрийн хэлэлцээр (international mining joint venture agreement) юм. Гадаад орнуудын уул уурхайн практикаас харахад хамтарсан үйлдвэрийн хэлэлцээрийг байгуулснаар ялангуяа капитал импортлогч орны Засгийн газар нь хамтарсан үйлдвэрийн хувьцаа, ногдол хувийг эзэмших эрх олж авчээ.

Капитал импортлогч орны Засгийн газрын хувьд шинээр байгуулагдах хамтарсан үйлдвэрийн дүрмийн санд хувь хөрөнгө нийлүүлэх шаардлагагүйгээс гадна түүний эзэмших хувьцаа, ногдол хувийн хэмжээг хамтарсан үйлдвэрийн үүсгэн байгуулагчид хэлэлцээ хийх замаар харилцан тохиролцох болсон бөгөөд одоо ч ийнхүү тохиролцсоор байна. Түүнчлэн, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих үүднээс капитал импортлогч орнууд хамтарсан үйлдвэрүүдэд татварын болон бусад хөнгөлөлт үзүүлэх болсон нь эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн энэ төрөл уул уурхайн салбарт хөгжиж төлөвшин тогтох үндсэн шалтгаан болсон байна.

Олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны өнөөгийн практикт олон улсын хамтарсан үйлдвэрийн хэлэлцээрийг а) equity joint venture agreement, б) contractual joint venture agreement гэж ангилдаг. Equity joint venture agreement хэлэлцээрийг олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны практикт заримдаа equity sharing agreement гэж нэрлэдэг бөгөөд энэ нь биеэ даасан хуулийн этгээдийн эрхтэй үйлдвэр эсвэл компани байгуулах тухай хэлэлцээр юм. Харин contractual joint venture agreement хэлэлцээрийг ашигт малтмалын том хэмжээний ордын нөөцийг тогтоох болон гадаадын хөрөнгө оруулалттай бусад төсөл хэрэгжүүлэх зорилгоор капитал эзэмшигч

[274]David N.Smith and Louis T. Wells, Jr.Дээр дурдсан бүтээл. х. 561.



орны Засгийн газар гадаадын компаниудтай байгуулдаг.

Equity joint venture agreement гэж нэрлэгдэх олон улсын хамтарсан үйлдвэрийн хэлэлцээрийг гол төлөв уурхайн нөөцийн хэмжээ тогтоогдож ашиглалтын үе шат эхлэх үед байгуулдаг ба тухайн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг капитал импортлогч орны Засгийн газрын оролцоотой компанийн нэр дээр шилжүүлэхээр хэлэлцээрийн талууд тохиролцдог. Ингэснээр капитал импортлогч орны Засгийн газар нь хамтарсан компанийн гишүүн болж түүнийг удирдахад оролцох, компанийн гүйцэтгэх байгууллагын гишүүдийг томилох эрхтэй болж байна. Түүнчлэн, хамтарсан компани нь уурхайн барилга байгууламжийн өмчлөгч болдог. Хамтарсан үйлдвэрийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үүсгэн байгуулагчид хоорондоо хуваан авч ногдол ашиг авдаг ба энэ нь хамтарсан уулын үйлдвэрийн онцлог шинж юм.

Ийнхүү, гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр нь капитал импортлогч тухайн улсын хувийн эрх зүйн хуулийн этгээд болж аж ахуйн үйл ажиллагаагаа иргэний болон худалдааны эрх зүйн хүрээнд явуулдаг. Гэвч уул уурхайн практикт хамтарсан үйлдвэрийн удирдлага, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдон үүсдэг асуудлыг эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн талууд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж байна. Одоо эдгээр асуудлын заримыг капитал импортлогч орнууд хэрхэн шийдвэрлэж байгааг товч авч үзье.

Гадаад орнуудын уул уурхайн өнөөгийн практикаас харахад, капитал импортлогч орны Засгийн газар нь хамтарсан компанийн эсвэл үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохыг тэр болгон чухалчлан үздэггүй байна. Гэхдээ, зарим тохиолдолд капитал импортлогч орны Засгийн газар нь өөрийн өмчийн оролцоо (size of shareholdings)-ны хэмжээнээс үл хамаарч хамтарсан үйлдвэрийн захирлуудын зөвлөлийн гишүүдийн олонхийг томилох эрхийг гадаадын хөрөнгө оруулагчтай хэлцэл хийсний үр дүнд олж авдаг.

Хамтарсан үйлдвэрийн олборлолтын болон экспортын үйл ажиллагаанд хяналт тавих үүднээс үйлдвэрийн захирлуудын зөвлөлөөс шийдвэр гаргах журам, ялангуяа зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэх ёстой асуудлын талаар капитал импортлогч орны Засгийн газар гадаадын уул уурхайн компанитай тодорхой тохиролцоонд хүрсэн байх нь чухал аж.

Тухайлбал, хамтарсан үйлдвэрийн уурхайн олборлолтын төлөвлөгөөг үйлдвэрийн зөвлөлөөр заавал батлуулж байх саналыг капитал импортлогч орны Засгийн газар гадаадын уул уурхайн компанид тавих нь олонтой. Яагаад гэвэл уурхайн олборлолтын төлөвлөгөөнд үйлдвэрлэх таваарын бүтээгдэхүүний хэмжээ, технологийн шинэчлэл болон үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, борлуулалтын төлөвлөгөө, уул уурхайн үйл ажиллагааны зардал, ажиллах хүчний тоо зэрэг хамтарсан компанийн аж ахуйн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд тусгагдсан байдаг.

Хамтарсан үйлдвэрийн гүйцэтгэх удирдлага нь олборлолтын болон бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаагаа явуулах учиртай. Хэрэв үйлдвэрийн зөвлөлөөс баталсан төлөвлөгөөг биелүүлж чадахгүйд хүрвэл тухайн үйлдвэрийн зөвлөл, түүнчлэн капитал импортлогч орны засгийн газрын эрх бүхий байгууллагатай зөвлөлдөж холбогдох зөвшөөрөл авах шаардлагатай болдог.

Энэ шалтгаанаар гадаадын компани нь эрдсийн баялаг олборлолтын ерөнхий хэлэлцээрийн төслийг капитал импортлогч орны Засгийн газартай тохиролцох явцад хамтарсан үйлдвэрийн зөвлөлийн эрх хэмжээнд хамаарах асуудлын хүрээ, түүнчлэн Засгийн газартай зөвлөлдөж шийдвэрлэх асуудлын хүрээг тохиролцохыг эрмэлздэг байна.

Ийнхүү капитал импортлогч орнуудын уул уурхайн өнөөгийн практикт хамтарсан үйлдвэр нь олон улсын гэрээ, түүний дагалдах хэлэлцээрийн хүрээнд байгуулагдан үйл ажиллагаагаа капитал импортлогч орны дотоодын хууль тогтоомжийн хүрээнд явуулдаг. Капитал импортлогч орнууд гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрүүдэд үндэсний эсвэл нэн тааламжтай үндэстний нөхцөл олгож байна. Мөн хөгжиж буй олон оронд хамтарсан үйлдвэр нь татварын болон бусад хөнгөлөлт эдлэдэг бөгөөд хамтарсан үйлдвэрт оруулсан гадаадын хөрөнгө оруулагчийн эд хөрөнгө, эрхийг гол төлөв хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрээр хамгаалж байна.

Менежментийн гэрээ. Хөгжиж буй орнуудын уул уурхайн практикт менежментийн гэрээг уул уурхайн салбарт шинэ технологи, барууны орнуудын үйлдвэрлэлийн менежментийн тэргүүний туршлага нэвтрүүлэх зорилгоор анх байгуулж эхэлжээ. Тухайлбал, Зайр улсад 1967 онд Белгийн Union Miniere du Haut Katanga нийгэмлэгийн зэсийн үйлдвэрийг нөхөн төлбөргүйгээр нийгэмчилсэн боловч 1969 онд Зайрийн Засгийн газар уг компанитай менежментийн гэрээ (management contract) байгуулж нөхөн төлбөр төлөхөөр тохиролцсон аж. Энэ гэрээгээр Зайрийн засгийн газар нь уул уурхайн үндэсний боловсон хүчинг сургах асуудлыг шийдвэрлэх зорилт тавьж зохих үр дүнд хүрсэн юм.

Яваандаа менежментийн гэрээг хөгжиж буй бусад орнууд үндэстэн дамнасан корпорациудтай байгуулах болсноос гадна гэрээний дагуу үзүүлэх үйчилгээний нэр төрөл, хүрээ өргөжжээ. Хөгжиж буй орнуудын орд, уурхайн олборлолтын модель боловсруулж өгөх, төрийн өмчлөлийн компанийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд борлуулах зэрэг үйлчилгээг гадаадын хөрөнгө оруулагчид менежментийн гэрээний дагуу үзүүлэх болсон байна. Ийнхүү менежментийн гэрээ нь аажмаар эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн биеэ даасан төрөл болон төлөвшжээ.

Ийнхүү менежментийн гэрээний дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь уулын үйлдвэрийн хувьцааг эзэмшиж түүний удирдлагад оролцохгүйгээр тодорхой төрлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлж байна. Менежментийн гэрээний энэ давуу тал нь түүний уламжлалт концессийн гэрээнээс ялгагдах үндсэн шинж юм.

Олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны практикт менежментийн гэрээний стандарт нөхцлүүд боловсруулагдаагүй аж. Гэхдээ, менежментийн гэрээний гол нөхцөл болох үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлал нь олон улсын практикт аль хэдийнээ бий болжээ. Ихэнх гэрээнд менежментийн үйлчилгээний хөлс(renumeration)-ний хэмжээг борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ эсвэл борлуулалтын орлогын хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр тогтоодог боловч мөн заримдаа гэрээний талууд ашиг хуваах тохиролцоонд хүрэх тохиолдол ч бас байдаг.

Капитал импортлогч орны засгийн газар нь менежментийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих боломж бараг байдаггүй. Менежментийн гэрээний энэ сул талыг ашиглан үндэстэн дамнасан корпорациуд өөрсдийн гэрээгээр хэрэгжүүлж байгаа уул уурхайн төслийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материал, тоног төхөөрөмжийг хараат болон охин компаниудаас өндөр үнээр худалдан авах замаар ашиг нэмэгдүүлэх явдал гардаг аж.

Гэсэн хэдий ч менежментийн гэрээг гадаад орнуудын уул уурхайн практикт ялангуяа, үндэстэн дамнасан корпорацийн уул уурхайн үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг зохицуулах үүднээс өргөн ашиглаж байна.

Эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн бусад төрлүүд. Эрдсийн баялаг олборлолтын зарим хэлэлцээрийн дагуу капитал импортлогч орны Засгийн газар нь гадаадын компанийн үйлчилгээг худалдан авдаг. Энэ тохиолдолд гадаадын компани нь тухайн уулын үйлдвэрийн хувьцаа, ногдол хувийг эзэмшдэггүй бөгөөд тодорхой төрлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр төлбөртэй үзүүлнэ. Энэ төрлийн хэлцэлд бүтээгдэхүүн хуваах, аз турших болон ажил гүйцэтгэх гэрээнүүдийг хамруулдаг бөгөөд 1970 он хүртэл ихэнхи судлаачид эдгээр гурван гэрээг эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн биеэ даасан төрөл гэж үздэггүй байжээ. Онолын үүднээс авч үзвэл эдгээр гэрээнд гадаадын компани нь концессийн эрх эзэмшигчийн эсвэл хамтарсан үйлдвэрийн гишүүний хувиар биш харин ажил гүйцэтгэгчийн хувиар л оролцож байна.

Бүтээгдэхүүн хуваах хэлэлцээр

Бүтээгдэхүүн хуваах хэлэлцээр уул уурхайн салбарт орчин үеийн концессийн гэрээний бие даасан төрөл болон хөгжиөд нь индонезийн уул уурхайн практик чухал нөлөө үзүүлсэн байна. 1960-1965 онуудад гадаадын хөрөнгө оруулалттай уулын үйлдвэрүүдийг Индонезийн засгийн газар улсын өмчлөлд шилжүүлэх арга хэмжээ авчээ. Үүний зэрэгцээ Индонезийн Засгийн газар нь бүтээгдэхүүн хуваах гэрээг гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх хамгийн ашигтай хэлбэр гэж үзэн ялангуяа Японы корпорациудтай байгуулжээ.

Бүтээгдэхүүн хуваах хэлэлцээрийн хүрээнд Индонезийн Засгийн газар нь Японы корпорациудаас зээл авч харин үндсэн өр, хүүгийн төлбөрт тухайн төслийг хэрэгжүүлсний үр дүнд олборлосон ашигт малтмалын тодорхой хэсгийг Японы корпорациудад өгч байлаа. Түүнчлэн, Японы корпорациудын

үзүүлсэн инжинерингийн болон маркетингийн үйлчилгээний хөлсийг Индонезийн Засгийн газар олборлосон ашигт малтмалаар төлж байв. Ийнхүү бүтээгдэхүүн хуваах гэрээг Индонезийн Засгийн газар газрын тос, никель зэрэг ашигт малтмал олборлох төслийг хэрэгжүүлэх, эдгээр төсөлд гадаадын хөрөнгө оруулагчийг татан оролцуулах зорилгоор байгуулж ихээхэн туршлага хуримтлуулсан байна.

Гэвч 1965 онд засгийн эрхэнд гарсан шинэ кабинет нь бүтээгдэхүүн хуваах гэрээг зөвхөн газрын тосны үйлдвэрийн салбарт байгуулж байхаар шийдвэрлэсэн байна. Индонезийн шинэ Засгийн газрын энэ шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Индонезийн төрийн өмчит Pertamina компани нь Shell, Compagnie Francaise de Petroles, Gulf, BP, Mobil зэрэг үндэстэн дамнасан корпорациудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг олноор байгуулжээ. Индонезийн Pertamina компанийн байгуулсан гэрээний дагуу гадаадын компани нь гэрээт талбайд газрын тос олборлох тухайн төслийг санхүүжүүлж ийнхүү санхүүжүүлсний төлбөрт нийт олборлосон түүхий газрын тосны 35 хүртэл хувийг биет байдлаар авахаар тохиролцжээ. Үүнээс гадна, ашгийн татварыг гадаадын компануд Индонезийн хуулийн дагуу төлж байхаар бүтээгдэхүүн хуваах хэлэлцээрийн талууд хэлэлцэн тохирчээ.

Бүтээгдэхүүн хуваах гэрээг хөгжиж буй бусад орнууд Индонезийн жишгээр байгуулж эхэлснээр энэ гэрээ нь капитал импортлогч орнуудын уул уурхайн практикт цаашид боловсронгуй болон төлөвшсөн билээ.

Мөн бүтээгдэхүүн хуваах гэрээг Зүүн Европын социалист орнуудын гадаад худалдааны нэгдлүүд 1970-иад оны дунд үеэс барууны фирмүүдтэй байгуулж байв. Энэ төрлийн хэлцлийн дагуу барууны фирмүүд тоног төхөөрөмж, машин механизм нийлүүлж төлбөрт нь үйлдвэрлэсэн ашигт малтмалын тодорхой хэсгийг биет байдлаар авч байлаа.

Индонезийн болон бусад орны концессийн гэрээний практикаас харахад бүтээгдэхүүн хуваах гэрээг газрын тосны олборлолтын салбарт гол төлөв байгуулдаг нь газрын тосны борлуулалтын онцлогтой холбоотой юм. Түүхий газрын тосыг капитал импортлогч орны Засгийн газар дотоодын болон гадаадын зах зээл дээр борлуулах боломжтой бол бусад төрлийн ашигт малтмалыг дэлхийн зах зээл дээр биржээр дамжуулан худалдахаас өөр зам бараг байдаггүй аж. Энэ шалтгаанаар бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд бүтээгдэхүүний борлуулалтыг гол төлөв гадаадын компани хийхээр гэрээний талууд тохиролцдог байна. Гэхдээ, сүүлийн үед газрын тос олборлогч орнууд нь газрын тосоо дэлхийн зах зээл дээр өөрсдөө эсвэл төрийн өмчит үйлдвэрийн газруудаараа дамжуулан худалдаж байна.

Олон улсын газрын тосны үйлдвэрийн салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлийг капитал импортлогч орнууд өөрсдийн уул уурхайн хууль тогтоомжийн императив хэм хэмжээний дагуу боловсруулдаг учраас гэрээний стандарт нөхцөлийг өөрчлөх боломж муу байдгийг энд хэлэх нь зохистой. Тухайлбал, ОХУ-д Бүтээгдэхүүн хуваах тухай хууль 1995 онд батлагдсан бөгөөд энэ хуулийн ихэнхи зүйл, заалтууд оросын компаниудын

байгуулдаг бүтээгдэхүүн хуваах гэрээний стандарт нөхцөл болж байна.

Олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны өнөөгийн практикаас харахад бүтээгдэхүүн хуваах гэрээнд гадаадын хөрөнгө оруулагч нь концессийн эрх эзэмшигч (concessionaire)-ийн хувиар биш газрын тосны хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувиар оролцдог тул газрын тосны өмчлөлийн асуудлыг гэрээгээр зохицуулах шаардлагагүй юм. Харин уул уурхайн үйл ажиллагааны санхүүжилтийн зарчим, хайгуулын зардлын нөхөн төлөлт, бүтээгдэхүүнийг хуваах зарчим, татвар зэрэг бүтээгдэхүүн хуваах гэрээний гол нөхцөлийг гэрээний талууд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж байна.

Ажил гүйцэтгэх гэрээ.

Гадаад орнуудын уул уурхайн өнөөгийн практикаас харахад үйлчилгээ үзүүлэх болон ажил гүйцэтгэх гэрээний хоорондын ялгааг олж тогтооход маш хүндрэлтэй байдаг. Тухайлбал, Индонезийн уул уурхайн практикт зөвхөн "ажил гүйцэтгэх гэрээ" гэсэн нэр томьёог хэрэглэж заншсан учраас "үйлчилгээ үзүүлэх гэрээ" гэсэн нэр томъёог никель, зэс болон хар тугалга зэрэг ашигт малтмал олборлохтой холбогдон байгуулах гэрээ, хэлцлийн хувьд хэрэглэдэггүй байна.[275]

Гэтэл үйлчилгээ үзүүлэх гэрээг Ойрхи Дорнодын болон Латин Америкийн орнуудын эрдсийн баялаг олборлох үйлдвэрлэлийн салбарт өргөн ашиглаж байна.[276]

Олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны өнөөгийн практикт ажил гүйцэтгэх гэрээний талуудын эрх, үүрэг, гүйцэтгэх ажлын нэр, төрөл, хэмжээ, төлбөрийн нөхцөл, ажлын гүйцэтгэлд тавих хяналт, инжинерингийн стандарт зэрэг нөхцлүүдийг капитал импортлогч орны засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчтай олон улсын зарим байгууллагын боловсруулсан иргэний барилга байгуулламж барих гэрээний стандарт нөхцөлүүдийг ашиглан байгуулж байна.[277] Ийнхүү ажил гүйцэтгэх гэрээний дагуу гадаадын компани нь капитал импортлогч орны хувьд ажил гүйцэтгэгчээр ажилладаг. Гэхдээ, гадаадын компани нь ашиглаж байгаа тухайн уурхайн барилга байгууламжийг дангаараа өмчлөх явдал байдгаас гадна орлогын татварыг бүтээгдэхүүний борлуулалтын орлогоосоо төлдөг аж. Үүнээс гадна капитал импортлогч орны засгийн газар нь гадаадын ажил гүйцэтгэгчийн уурхайн ашиглалтын явцад гарсан бодит зардлыг нөхөн төлдөг байна. Эцэст нь тэмдэглэхэд, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтын механизм нь хэлэлцээний үр дүнгээс хамаарч гэрээ бүрт өөр өөр байдаг.

[275]David N. Smith and Louis T.Wells, JR, Дээр дурдсан бүтээл. х. 583.

[276]A F M Maniruzzaman, Дээр дурдсан бүтээл. х. 215.

[277]Олон улсын уул уурхайн хамтын ажиллагааны өнөөгийн практикт НҮБ-ын төрөлжсөн байгууллагаас батлсан иргэний барилга байгууламж барих гэрээний стандарт нөхцлийг ялангуяа, уурхайн барилга байгууламжийг барих ажилд өргөн ажиглаж байна. Тухайлбал. UN Guide for Use in Drawing up Contracts relating to the International Transfer of Know-how in the Engineering Industry, UN Doc TRADE/222/Rev 1 (1970); Guide on Drawing up Contracts for Large Industrial Woks, UN Doc ECE/TRADE/117 (1973); UNCITRAL Legal Guide on Drawing up International Contracts for the Construction of Industrial Works (United Nations, New York, A/CN9/ SER B/12, 1988.

Аз турших гэрээ.

Гадаад орнуудын уул уурхайн хамтын ажиллагааны практикт аз турших гэрээ (risk service contract)-г ялангуяа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажил гүйцэтгэх төслийг хэрэгжүүлэхэд өргөн ашигласаар ирсэн бөгөөд уг гэрээний онцлог нь ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын зардлыг гадаадын компани даадагт оршино. Хэрэв эрэл, хайгуулын ажлын үр дүнд үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий орд нээгдэж ашигт малтмалын олборлолт эхэлбэл ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийг капитал импортлогч орны Засгийн газар гадаадын компанид нөхөн олгодог.

Гадаад орнуудын уул уурхайн практикт аз турших гэрээний талуудын эрх, үүрэг, ашигт малтмалын хайгуулын ажлын санхүүжилт, геологи-хайгуулын ажилд тавигдах экологийн шаардлага, инжинерингийн стандарт зэрэг нөхцөлүүдийг гэрээний талууд гол төлөв капитал импорлогч орны хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн тохиролцож байна.

Дээр дурдсанаас үзэхэд концессийн гэрээний өнөөгийн практикт эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг байгуулахад иргэний болон худалдааны эрх зүйн механизмыг өргөн хэрэглэж байгаа бөгөөд энэ нь эрдсийн баялаг олборлолтын гэрээний оролцогч талуудын тэгш эрхийн байдлыг хангахад чиглэгдэж байна.

Гэсэн хэдий ч уул уурхайн хамтын ажиллагааны практикт уг асуудлыг шийдвэрлэхэд байнга хүндрэл гардаг. Яагаад гэвэл нэгдүгээрт эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг концессийн эрх, лиценз болон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулдаг ба эдгээр тусгай зөвшөөрлийг капитал импортлогч орны Засгийн газар дангаараа хүчингүй болгох тохиолдол байдаг. Капитал импортлогч орны Засгийн газарт ийм эрх байгаа эсэх асуудлыг зохицуулсан олон улсын эрх зүйн ямар нэг баримт бичиг одоо болтол боловсруулагдаагүй байна. Хоёрдугаарт хэлэлцээрийн нэг тал болох катипал импортлогч улсын төр, нөгөө тал болох гадаадын хөрөнгө оруулагч нь өөр өөр эрх зүйн статустай субьектүүд байдаг учраас эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийг гадаадын хөрөнгө оруулагчид аль нэг улсын төр эсвэл засгийн газартай байгуулахыг чухалчлан үздэг байна.

Дээрх хоёр шалтгааны улмаас сүүлийн үед эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрийн хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа гадаадын хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдал, концессийн эрхийн агуулга, хүчинтэй байх хугацаа, татварын орчин зэрэг асуудлыг капитал эзэмшигч орны захиргааны эрх зүйн актаар, харин гадаадын хөрөнгө оруулагчийн уул уурхайн үйл ажиллагааны асуудлыг хувийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хандлага давамгайлах боллоо.

Хэдийгээр эрдсийн баялаг олборлолтын хэлэлцээрт хувийн эрх зүйн зарчмыг хэрэглэжбайгаа боловч түүний голнөхцөлүүдийг капитал импортлогч тухайн орны захиргааны эрх зүйгээр зохицуулж байна. Энэ үүднээс эрдсийн баялаг олборлолтын ерөнхий хэлэлцээрийг үндэстэн дамнасан корпорациуд капитал импортлогч орны төртэй байгуулж парламентаар

батлуулах замаар олон улсын гэрээний ангилалд хамааруулах явдлыг илүү практик ач холбогдолтой гэж үздэг. Олон улсын нийтийн эрх зүйн үүднээс энэ нь үндэстэн дамжсан корпорацийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах хууль зүйн механизм болж байна.

Иймээс капитал импортлогч орны уул уурхайн салбарт оруулсан гадаадын хөрөнгийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалах, ялангуяа үндэстэн дамнасан корпорациудын хөрөнгийг капитал импортлогч улс дайчлан гаргуулахаас хамгаалах асуудал үүсч байна.

5.2. УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ТАЛААР ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Өнөөгийн хуулиуд нь зах зээлийн нөхцөлд байгалийн нөөцийг ашиглах үйл явцыг зохицуулахад эерэг нөлөө үзүүлдэг. Байгалийн нөөцийн дотроос газрын хэвлийн баялгийг ашиглах хуулийн болон хэмжээ тогтоох эрх зүйн баазыг бүрдүүлэх үйл явц бүрэн дуусаагүй байна.

Монголын эрдэс баялгийн эрх зүйн салбарт газрын хэвлийн ашиглалтын хэм хэмжээ ба хууль эрх зүйн баазыг бүрдүүлэхэд хоёр гол чиглэлийг хослуулан шийдвэрлэх шаардлага гарсан. Түүний нэг нь үйлчилж байгаа хуулиудаа сайжруулж боловсронгуй болгох, хуулийн доторх болон хууль хоорондын зөрчлийг арилгах, уул уурхайн хуулиудыг боловсруулах, нөгөө нь үүнтэй зэрэгцүүлэн орчин үеийн шаардлага бодит нөхцөлтэй уялдсан эрдэс баялгийн цогцолборын эрх зүйн шинэ үзэл баримтлалыг өндөр хөгжилтэй орнуудын эрхийн жишгийг харгалзан олон улсын эрх зүйн түвшинд нийцүүлэн боловсруулах явдал чухал байна.

Эрдэс баялгийн цогцолборын эрх зүйн цаашдын хөгжлийн шаардлага буюу эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийн загварын тухай үндэслэлийг бид дээр хэлсэн. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг боловсруулахад дараах үндсэн зарчим, үзэл баримтлалыг удирдлага болгох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Газрын хэвлийн нөөц төрийн өмч байх Үндсэн хуулийн зарчим;

2. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг Уул уурхайн хэм хэмжээ, хуулийн системд тэргүүлэх байртай байлгаж газрын хэвлийн болон ашигт малтмалын салбарын эрх зүйн зохицуулалтын үндэс болгох;

3. Газрын хэвлийн ашиглалттай холбогдсон зөвшөөрлийн (лицензийн хэм хэмжээний) ба хэлцлийн журмууд;

4. Газрын хэвлийн ашиглалт нь төлбөртэй байх;

5. Газрын хэвлийн ашиглалтын талаар удирдлагын бүх шатанд төрийн зохицуулалттай байх;

6. Газрын хэвлийн хэсгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрх хэмжээг нарийн зааглан тогтоож түүний эрх, үүрэг, хариуцлагын салшгүй байх зарчмыг хангах;

7. Газрын хэвлийг түүний тогтоц, орших хэлбэр, хэмжээ хэрэглэгдэх боломж, аж ахуйн үйл ажиллагаанд хэрэглэгдэх зориулалт үүргээрээ улс орны байгалийн нөөцийн чадавхийг бүрдүүлэх зэрэг олон талаас нь үнэлэн

тодорхойлох;

8. Газрын хэвлийн ашиглалтыг материаллаг үйлдвэрлэлийн бие даасан салбарын хэмжээнд гаргах;

9. Газрын хэвлийг ашиглах зорилгоор геологийн ба уурхайн эдэлбэрт зориулан газрын хэсгийг олгохдоо тухайн газрын гадаргуу ба гүнд орших байгалийн бүх баялгийн үнэ цэнийг бүс нутгийн болон улс орны хэмжээнд эдийн засаг, экологи, нийгэм, түүхийн ач холбогдлоор нь иж бүрэн бодож ялгавартай хандах;

10. Газрын хэвлийг ашиглах стратегийн чухал шийдвэр гаргахдаа түүний хүрээлэн буй байгаль орчин болон экологийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөө ялангуяа хил дамжсан нөлөөлөл гарах эсэхийг бодолцох;

11. Улсын болон бүс нутгийн хэмжээнд эрдэс түүхий эдийн чадавхийн өөрчлөлтийг бүртгэж хянаж байх;

12. Удирдлагын бүх түвшинд газрын хэвлийн баялгийг үнэн зөв, иж бүрэн судалж, ашиглаж байгаад төрийн хяналт тавих хэмжээ, хязгаар тогтоох журам, шаардлагатай байх;

13. Өмчийн эзэмшлийн байдлаас хамаарахгүйгээр газрын хэвлийн баялгийн тухай улсын мэдээллийн нэгдсэн сантай байх; (Улсын геологийн сан, улсын нөөцийн кадастртай байх)

14. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг бусад хуулиудтай харилцан уялдуулах зэрэг болон бусад зарчмуудыг үндэс болгох ёстой гэж үзэж байна.

III. ШҮҮХИЙН ПРАКТИК

1. МАРГААН ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН БАТАЛГАА

Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг хөндлөнгийн шүүх болох арбитраар шийдвэрлэх талаарх олон талт баталгаа нь зарим улс орны гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Энэхүү баталгаа нь Засгийн газрын зүгээс оролцсон тохиолдолд түүнийг залруулах, багасгах боломжтой шударга арга бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт үлэмж нэмэгдэх итгэл найдварыг төрүүлж байдаг. Хожим нь тухайн баталгааг өгч байгаа Засгийн газар болон гадаадын хөрөнгө оруулагчдын хоорондын маргаан өссөн тохиолдолд хэлэлцэн тохирсны дагуу тухайн маргааныг гадаадын арбитрын шүүхээр шийдвэрлүүлдэг. Харин аль арбитрын шүүх харьяалан шийдвэрлэх талаарх онол нь гадаадын хөрөнгө оруулагч шүүхэд хандахаасаа өмнө арбитрын хэлэлцээр хийх боломжийг олгодог ба энэ нь хууль тогтоомжийн баталгаа болно. Хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь хувь нийлүүлэгчтэй гэрээ байгуулахдаа аль арбитрын шүүхэд хандахаа сонгох боломжтой бөгөөд энэхүү гэрээнд заасан арбитр нь тухайн хэргийг харьяалан шийдвэрлэдэг.

Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд, "гадаадын хөрөнгө оруулагч болон Монголын хөрөнгө оруулагчийн хооронд, түүнчлэн

гадаадын хөрөнгө оруулагч болон Монголын хуулийн этгээд, хувь хүний хооронд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх шийдвэрлэнэ" хэмээн заасан. Эндээс, юуны өмнө талуудад маргаанаа шийдвэрлэх улс, шүүх буюу арбитрыг өөрсдөө сонгох боломжийг олгосон нь тодорхой харагдаж байна. Харин ийнхүү сонгоогүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд харьяалагдах ёстой. Харин маргааны нэг тал нь аль нэг гадаад улсын төр, төрийн байгууллага байгаа тохиолдолд шүүхийн харьяаллыг тодорхойлохдоо төрийн дархан эрхийн зарчмыг харгалзан үзэх шаардлагатай болно.

Хууль тогтоомжоос гадна хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Засгийн газар хооронд хэлэлцээрт хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдсан байдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар БНЧУ-ын Засгийн газартай байгуулсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай" хэлэлцээрийн 8 дугаар зүйлд маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Энэхүү зохицуулалт нь юуны өмнө аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг урьтал болгосон /8.1 дүгээр заалт/ ба ийнхүү эв зүйгээр шийдвэрлэж чадалгүй 6 сарын хугацаа өнгөрсөн бол Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх олон улсын төвд хандах, эсхүл аль нэг арилжааны арбитрт хандах боломжийг олгосон байдаг.

Бизнесийг амжилттай явуулах, эдийн засгийн эргэлтийг түргэтгэх гол аргуудын нэг бол хөрөнгө оруулалт байдаг. "Black's law dictionary"-д тайлбарласнаар хөрөнгө оруулалт гэдэг нь эд хөрөнгийг байршуулах эсвэл орлогоо нэмэгдүүлэх зорилгоор мөнгөөр хөрөнгө оруулахыг хэлэх ба ингэхдээ тогтвортойгоор үнэт цаасыг худалдан авах, бизнест мөнгө, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөө оруулах гэх мэт аргыг хэрэглэдэг бөгөөд энэ нь ирээдүйд ашиг орлого авчрах болно гэжээ. Энэ бүлэгт яригдах хөрөнгө оруулагч нь дотоодын бус гадаадын хөрөнгө оруулагч болно. Учир нь дотоодын хөрөнгө оруулагч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг үндэсний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах боломжтой байдаг бол гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд гадаад улсын хуулийн хэм хэмжээг судлах, өөрийнх нь эрх ашиг нь хэр хамгаалагдсан зэргээс эхлээд асуудлууд ар араасаа урган гарч ирдэг. Иймд хөрөнгө оруулагч нь нэгэнт өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулж байгаа учраас аль болох эрсдэл багатай хөрөнгө оруулалтын орчинг сонгох нь тодорхой. Нөгөө талаар улс орнууд гадаадын хөрөнгө оруулагчдыг өөрийн оронд татахын тулд янз бүрийн баталгаагаар хангадаг. Доорх асуудлуудтай холбоотой баталгаа нь чухал баталгаанд тооцогддог.

Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг нийгэмчлэх тохиолдолд нөхөн төлбөр олгох;
- Эд хөрөнгөө буцааж гаргах;
- Орлого, ногдол ашгаа гуйвуулах;

- Бусад төрлийн урсгал орлогоо гуйвуулах; /технологийн онцгой төлбөр, лизингийн төлбөр, менежментийн шагнал гэх мэт/
- Үндсэн болон зээлийн хүүг гуйвуулах;
- Ялгаварлан гадуурхахгүй байх;
- Татвар болон бусад зохицуулалтыг тогтвортой байлгах зэрэг болно.

Гадаадын хөрөнгө оруулалт нь үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдахаас гадна хөрөнгө оруулалтын хоёр талын гэрээ, тухайн улсын нэгдэн орсон олон талт гэрээгээр давхар хамгаалагдах боломжтой. Гадаадын хөрөнгө оруулагчийн харьяаллаас хамаараад эрх зүйн давхар баталгаа ч эдэлж болдог.

Гэвч эдийн засаг, түүнийг зохицуулж байдаг эрх зүйн харилцаа нь өөрөө өргөн цар хүрээг хамарч байдаг учраас хөрөнгө оруулалтаас үүдэн гарах маргааныг шийдвэрлэх механизм нь орчин үед хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татаж байна. Соёлт хүн төрөлхтөн хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх хэд хэдэн гарцыг бодож олоод байна.

Ялангуяа улсууд хоорондын бизнесийн харилцаанд "найрсаг харилцааны, худалдааны" зэрэг харилцан ойлголцлын агуулгатай гэрээ байгуулдаг. Улсууд худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа явуулахдаа нөгөө талдаа өөрийн ашиг сонирхлын дагуу тодорхой хэхцлийг санал болгож, маргаан гарсан тохиолдолд арбитрын журмаар шийдвэрлүүлэхээр тохиролцох нь олонтой. Учир нь улс нь олон улсын эрх зүйн субъект болохын хувьд аль нэг улсын шүүхэд хариуцагчаар татагддаггүй. Иймд хувийн эрх зүйн холбогдолтой маргаан гарсан тохиолдолд хөндлөнгийн бие даасан шийдвэр гаргах эрх бүхий субъект болох арбитрт хандах, маргаан шийдвэрлэх сонголтот аргыг хэрэглэх нь эновчтой гэж үздэг. Мөн түүнчлэн орчин үед улс хоорондын хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах нь хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх нэгэн чухал алхам болоод байна. Эдгээр аргуудын ихэнхи нь хөрөнгө оруулсан, хөрөнгө оруулалтыг хүлээн авсан улсуудын хоорондын ирээдүйд гарч болох маргааныг шийдвэрлэх харьяаллыг тогтоож өгдгөөрөө ач холбогдолтой юм.

Хөрөнгө оруулагч гэсэн ойлголтод хөрөнгө оруулалтыг шингээгч орны үндэсний болон олон нийтийн байгууллагууд ч хамаарна. Сүүлийн жилүүдэд хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээний тоо огцом өсч байна.

Орчин үед хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж тэр хэрээрээ хөрөнгө оруулагч болон улс хооронд үүсэх маргаантай асуудлууд олноор бий болж байгаатай холбоотойгоор маргааныг шийдвэрлэх арга улам боловсронгуй болсоор байна. Олон улсын гэрээ байгуулахаасаа өмнө урьдчилан маргаан шийдвэрлэх талаар тохиролцох арга нилээд түгэн дэлгэрч байгаа ба мөн арбитрын шүүхэд хандахаас өмнө эвлэрэх зэрэг маргааныг шийдвэрлэх олон аргаас сонгох боломжтой болсон.

Урт хугацааны гэрээнд талууд маргаан гарсан тохиолдолд сайн санааны үүднээс эвлэрэхээр оролдох хэрэгтэй гэсэн нэр томьёо бүхий заалтыг хэрэглэдэг. Сайн санааны үүднээс эвлэрнэ гэдэг нь тодорхой бус үүрэг юм.

Хэн эвлэрлийг санаачлах вэ? Хэр удаан үргэлжлэх вэ? Талууд сайн санаагаа хэр удаан харуулах вэ? Талууд буулт хийж, зарчмын хувьд сайн санаагаа илэрхийлж батлах ёстой юу зэрэг нь тодорхойгүй юм. Хөрөнгө оруулагч болон улс хооронд үүссэн харилцаанд энэ асуудал бүр ч илүү хурцаар тавигддаг учраас хувийн эрх зүйн субъект, улс гүрэн (төр) хоёр хэргийн нэхэмжлэгч, хариуцагч болж шүүхэд хандах нь жинлүүрийн хоёр талын хүчний болоод хүндийн харьцааг хэзээ ч тэнцвэржүүлэхгүй. Иймд сонгох боломжтойгоор маргаан шийдвэрлэх арга (Alternative Dispute Resolution) нь одоогоор хамгийн зөв хувилбар гэж ихэнх хөрөнгө оруулалтын гэрээний талууд хүлээн зөвшөөрдөг. Тэдгээр нь гол төлөв эхлээд тодорхой зуучлал, эвлэрүүлэх арга хэрэглэх дараагийн шат нь шүүхэд нэхэмжлэл гаргах эсвэл арбитрт хандах зэрэг аргууд юм. Гэвч яагаад сонгох боломжтойгоор маргаан шийдвэрлэх арга нь маргааныг шийдвэрлэх арга болсныг ойлгох нь чухал. Маргаан шийдвэрлэхэд ADR нь сайн дурын шинжтэй, арбитр болон шүүхийн ажиллагаа нь албадлагын шинжтэй гэдгээрээ хоорондоо ялгаатай. Сонгох боломжтойгоор маргаан шийдвэрлэх аргад хэрэгт сонирхолгүй, гуравдагч этгээдийг оролцуулдаг нь шүүх, арбитртай төстэй. Түүнийг хамгийн товчоор төвийг сахисан эвлэрүүлэгч гэж нэрлэдэг. Тэрээр талуудад ямар нэгэн үүрэг өгдөггүй харин талуудыг өөрсдөө маргаанаа шийдвэрлэхэд нь тус болох үүрэгтэй. Мөн тэрээр маргааныг шийдвэрлэхэд санаа өгдөг ба эцсийн зорилго нь эвлэрүүлэн шийдвэрлэх юм.

Практикт улс хэдийгээр худалдааны үйл ажиллагаа явуулах эрх эдэлдэг ч өөрөө эсвэл төрийн хуулийн этгээдээр болон хувь хүнтэй бизнесийн харилцаанд орсон бол уг харилцаанаас үүссэн маргааныг холбогдох улсын шүүхэд хандаж эсвэл олон улсын худалдааны арбитрт хандаж шийдвэрлүүлдэг. Гэхдээ хувь этгээдийн тал нь маргаан бүхий улсын шүүхэд хандахаасаа илүү "төвийг сахисан" арбитрт хандаж маргаанаа шийдвэрлүүлэхийг илүүд үздэг.

Өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үндэстэн дамнасан корпораци, гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаанд төр хяналт тавих ноёлогч үүрэгтэй гэсэн хандлага ажиглагддаг.

Улс болон хөрөнгө оруулагчийн хоорондын маргааныг хэрхэн, хаагуур шийдвэрлэх вэ гэдгийг шийдэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд улс төрийн шалтгаан ч байдаг. Мөн улс гүрний нэр хүнд энд шууд хамааралтай. Энэ нь улс гүрний бие даасан байдал, дархан эрхэд хууль зүйн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаас халдашгүй дархлагдсан байдагтай холбоотой.

Хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, томоохон хуулийн этгээдүүдийн өрсөлдөөн, үндэстэн дамнасан корпорацийн хурдацтай хөгжил зэрэг нь хөрөнгө оруулалтаас үүдэн гарах маргааныг шийдвэрлэх дагнасан байгууллага бий болгоход хүргэсэн. Иймд зөвхөн талуудын аль нэг нь төр ба төрийн хуулийн этгээд байгаа тохиолдолд маргааныг шийдвэрлэдэг хоёр олон улсын байгууллага одоогоор үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр нь Хөрөнгө Оруулалтын Маргаан

Шийдвэрлэх Вашингтоны төв ба Гааг дахь байнгын арбитрын шүүх юм.

Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх хэм хэмжээг тогтоох нь бизнес, хөрөнгө оруулалтын орчинг хөгжүүлэх нэгэн гарц байсан бөгөөд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон Улсын Худалдааны Эрх Зүйн Комисс (ЮНСИТРАЛ), Олон Улсын Худалдааны Танхим (ICC), Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх Олон Улсын Төв зэрэг олон улсын байгууллагууд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх эвлэрлийн аргыг зохицуулах дүрмийг боловсруулсан.

1980 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Асамблейн зөвлөснөөр ЮНСИТРАЛ-ын "Эвлэрлийн дүрэм" батлагдсан. ICC-ын дүрэм ЮНСИТРАЛ-ын Эвлэрлийн дүрмийг бодвол бага зэрэг тодорхой бус бөгөөд эвлэрүүлэх ажиллагааг хэлбэрийн төдий зохицуулсан байдаг гэж зарим судлаачид дүгнэдэг. 2002 онд ЮНСИТРАЛ-аас "Олон улсын худалдааны эвлэрлийн ажиллагааны загвар хууль"-ийг батлсан. Энэ нь ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн нэгэн адил эвлэрлийн ажиллагааны явцад хууль зүйн зохицуулалт шаардлагатай талуудад нэгдсэн жишиг байдлаар хэрэглэгдэх боломжтой зохицуулалтын хэм хэмжээ болж чадсан.

Шүүхийн ажиллагаа

Хөрөнгө оруулагч болон улс хоорондын маргааныг шийдвэрлэх үндсэн арга бол шүүх, арбитр байдаг. Орчин үед хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх сонголтот аргууд бий болгож, хэрэглэж байгаа ч шүүх, арбитрын арга ч бас өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн хэвээр байна. Гэхдээ өмнө дурдсанчлан хөрөнгө оруулагч болон улс хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд дийлэнхдээ хөрөнгө оруулагчид төрийн шүүхээр шийдвэрлүүлэх сонирхолгүй байдаг. Учир нь хөрөнгө оруулагч нь хувийн эрх зүйн хуулийн этгээд бол улс нь олон улсын нийтийн эрх зүйн хувьд дархан эрхтэй субъект байдаг. Хэдийгээр хувийн эрх зүйн харилцаанд төр гэрээний тал болж нөгөө талтайгаа тэгш эрхтэйгээр оролцох зарчимтай ч бодит байдал дээр маргаан гарсан тохиолдолд түүнийг шүүхээр шийдвэрлүүлэх нь хууль, шүүхийн өмнө талууд тэгш эрхтэй байх нөхцөл хангагдахгүй байх боломжтой гэсэн болгоомжлол төрүүлдэг. Гэсэн хэдий хөрөнгө оруулагчийн эсвэл хөрөнгө оруулалтыг шингээгч улсын шүүхэд хөрөнгө оруулалтын маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдах нь тодорхой. Нөгөө талаар ийм төрлийн маргааныг шийдвэрлэхэд улс хоорондын байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрүүд ч зохицуулалтын хэм хэмжээ болон хэрэглэгддэг.

Шүүхээр хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх ажиллагаа явагдахын урьдач нөхцөл болгон анхаарах нэг зүйл бол шүүхийн харьяаллын тухай асуудал юм. Шүүхүүдийн хооронд өрсөлдөөн гэсэн ойлголт сүүлийн үед яригдах болсон. Энэ нь аль улсын хууль илүү оновчтой зохицуулалт агуулсан байна, мөн аль улсын шүүх илүү шударга, хараат



бусаар, мэргэжлийн өндөр түвшинд шийдвэр гаргаж байна, тэр хууль, шүүхийг хөрөнгө оруулалтын гэрээнд маргаан шийдвэрлэх заалтад оруулах хандлага байгаатай холбоотой. Хөрөнгө оруулалтын механизм нь сайн хөгжсөн дэлхийн ихэнх улс орны хувьд дотоодын иргэний холбоотой хууль тогтоомжоор маргаан шийдвэрлэх шүүхийг сонгож болохоор хуульчилсан байдаг. Үүнд ОХУ, БНХАУ зэрэг Монгол Улстай худалдааны өргөн харилцаатай улсуудыг нэрлэж болно. Манай улсын хувьд 2002 оны Иргэний хуулинд энэ талаар зохицуулсан хэм хэмжээ байхгүй. Гэхдээ хориглогдоогүй бүхэн зөвшөөрөгддөг иргэний эрх зүйн зарчмаараа гэрээндээ маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох боломжтой.

Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн тухайд өөр нэг анхаарал татсан зүйл бол хэрэглэгдэх хэм хэмжээ. Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа маргаан нь lex fori буюу шүүхийн улсын хуулиар шийдвэрлэгддэг зөрчилдөөний хэм хэмжээ байдаг. Гэхдээ талууд гэрээндээ тусгайлан тохиролцсон бол хэрэглэгдэх хэм хэмжээ түүгээр тодорхойлогдоно.

Шүүхээр хөрөнгө оруулалтын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулах, шүүх маргааныг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хэм хэмжээ хоёр нь тусдаа гэдгийг мөн анхаарах хэрэгтэй.

Хөрөнгө оруулагч болон улс хоорондын хөрөнгө оруулалтын талаар маргааныг шийдвэрлэхэд улс гэрээний нэг тал гэдэг утгаараа хөрөнгө оруулагчтай тэгш эрх, үүрэгтэйгээр оролцох бөгөөд дийлэнх тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээнд улсыг төлөөлж гарын үсэг зурсан субъект маргаанд улсыг төлөөлж оролцдог.

Хөрөнгө оруулагч болон улс хоорондын маргааныг шийдвэрлэхэд шүүх нэр хүндтэйгээр ажиллаж чадвал “country risk index” буюу эрсдлийн/өрсөлдөх чадварын шалгуурт эерэг байдлаар үзүүлэлтээ дээшлүүлэхэд ихээхэн түлхэц болдог.

Ерөнхийдөө товчоор дүгнэвэл хөрөнгө оруулалтын маргааныг шийдэх нэг арга болох шүүхийн нэр хүнд нь хөрөнгө оруулалтыг татах, түүнд таатай орчин бүрдсэн эсэхийг тодруулах нэгэн шалгуур үзүүлэлт болдог. Иймээс хөрөнгө оруулагч болон улс хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх шүүхийн арга өөрийн байр суурийг хэвээр хадгалж байгаа ч цаашдаа ADR энэ салбарт илүү хүч түрэн орж ирэх хандлагатай байна.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх орчин үед хамгийн ихээр хүлээн зөвшөөрөгдөөд байгаа маргаан шийдвэрлэх сонголтот аргын нэг бол арбитрын арга юм. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед талуудын журамд захирагдах байдал нь шүүхтэй харьцуулвал тийм ч хатуу биш. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх журмаа өөрсдөө тохирдог гэсэн үг. Гэхдээ ингэж тохирохдоо хамгийн гол нь арбитрын ажиллагаа явагдах улсын хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг заавал дагаж

мөрдөнө. Арбитрын ажиллагаатай холбоотой энэхүү зарчим нь арбитрын үйл ажиллагааг шударга ёсны дагуу явагдахад нөлөөлнө. Хэрэв уг журмыг баримтлахгүй бол магадгүй арбитрын шийдвэр хэрэгжих боломжгүй болж, бүр хүчин төгөлдөр буст тооцогдож ч болох юм. Хууль тогтоомжид заасан шаардлага болон талуудын тохиролцсон журмын дагуу талууд арбитрын ажиллагаанд эрх тэгш оролцоно. Хэдийгээр хууль, шүүхийн өмнө хөрөнгө оруулалтын гэрээний талууд эрх тэгш байх зарчимтай ч маргаан шийдвэрлэх асуудлын тухайд дийлэнхдээ хөрөнгө оруулагч тал гэрээнд арбитрын хэлэлцээр тусгахыг илүүд үздэг нь үүнтэй холбоотой.

Ингээд арбитрын ажиллагааны талаар товчхон авч үзье. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 25 дугаар зүйлээр арбитрын ажиллагаа эхлэх асуудлыг зохицуулсан байдаг. Уг зүйлийн дагуу талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хариуцагч тал хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлсэнд тооцдог. Гэхдээ арбитрын ажиллагаа эхлэх, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх гэсэн хоёр ойлголт нь цаг хугацааны хувьд ялгаатай юм. Арбитрын ажиллагаа эхлэх гэдэг нь тухайн маргааныг хянан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүн ба журмыг тогтоон тохиролцох сонголтын шинжтэй үе шат байна.

Арбитрын бүрэлдэхүүнд хуульд заасан эрх бүхий этгээд хуулиар хориглосноос бусад хэнийг ч арбитрчаар томилж болно. Байнгын зарим арбитрын хувьд арбитрчдын нэрсийн жагсаалттай байдаг. Маргааны талууд тухайн нэрсийн жагсаалтаас арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх арбитрчаа сонгож, сонгогдсон арбитрчид даргалагч буюу гурав дахь арбитраа сонгоно. Эсвэл талууд тохиролцон нэг арбитрчаар маргааныг шийдвэрлүүлэх ч боломжтой. Түр арбитрын тухайд талууд маргааныг шийдвэрлүүлэхээр итгэл үзүүлсэн хэнийг ч арбитрчаараа сонгож болдог. Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд арбитрчаар сонгогдож байгаа этгээд өндөр нэр хүндтэй, итгэл хүлээсэн, мэргэшсэн, талуудаас хараат бусаар ажиллаж чадах шударга хүн байх нь чухал. Арбитрыг хөрөнгө оруулагч болон улс хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдэх аргаар сонгож талууд гэрээндээ арбитрын хэлэлцээр тусгадаг нь арбитрын хөндлөнгийн хараат бус байх чадвартай шууд холбоотой.

Арбитрын бүрэлдэхүүн бүрдсэний дараа бүрэлдэхүүн болон талууд арбитрын ажиллагаа явагдах журмаа хамтран тогтоодог нь арбитраар хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх бас нэг хүчин зүйл нь юм. Нэгэнт арбитрын бүрэлдэхүүн бүрдсэн бол ажиллагаа эхэлснээс дуусах хүртэл бүхий л үйл явц талуудын тохиролцсон болоод сонгосон журмаар явагдана. Энэ нь олон улсын практикт "Procedural Order №1" буюу процессын журам гэж нэрлэгддэг бол манай улсын хувьд "Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам" гэсэн нэрээр талууд хүсвэл урьдчилсан хуралдааны хэлбэрээр уулзалт хийн тохиролцож эсвэл арбитрын бүрэлдэхүүн өөрөө Арбитрын тухай хууль, Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийнхээ хүрээнд тогтоодог. Ингэснээрээ арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг цаг тухайд нь, тогтоосон журмынхаа дагуу явуулах боломжтой болж байгаа юм. Журмыг талууд тохиролцсноор арбитрын хуралдааныг бүрэлдэхүүн удирдан явуулж, нэгэнт журмаараа тохиролцчихсон учраас талууд ч гэсэн арбитрын ажиллагаатай холбоотой аливаа асуудал дээр тохиролцох гэж цаг алдахгүй. Арбитрын ажиллагааны явцад бүрэлдэхүүн ямар нэг асуудлыг дангаараа шийдэх боломжгүй тохиолдолд (жишээ нь гэрч хуралдаанд оролцохоос татгалзсан тохиолдолд) үндэсний шүүхээс туслалцаа авдаг. Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд талуудаас гаргаж өгөх боломжгүй нотлох баримтууд байх нь бий. Нөгөө талаар арбитрын шийдвэрийг баталгаажуулах зэрэгт төрийн шүүхийн туслалцаа заавал шаардлагатай. Энэ тохиолдолд шүүхийн хуулийн дагуух оролцоо хэрэгтэй болдог. Талуудын өөрөө тогтоох эрх бол арбитрын ажиллагааны нэгэн чухал зарчим болдог. Энэ нь зөвхөн үндэсний хууль тогтоомжоор баталгаажхаас гадна олон улсын хэм хэмжээнд ч тусгалаа олсон байх нь бий. 1923 оны Женевийн протоколын 2-р зүйлд "арбитрын бүрэлдэхүүнийг томилохоос эхлээд хэрэг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагаа нь талуудын хүсэл зоригийн дагуу явагдана..." гэсэн байдаг бол Гадаад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Нью Йоркийн конвенцийн 5.1 (d)-д "арбитрын ажиллагаа нь талуудын тохиролцсон журмын дагуу явагдаагүй бол..." биелүүлэхээс татгалзах тухай зохицуулалт агуулсан байдаг. Энэ талаар олон улсын арбитрын институт, гадаад арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмуудад ч мөн ижил агуулгатайгаар зохицуулсан байдаг. Ер нь арбитрын ажиллагаан дахь талуудын өөрөө тогтоох эрх нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө талууд хуралдааны тов, хуралдаан хийх газар, хугацаа, арбитрын ажиллагаа явуулах хэл, хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээ гээд аливаа горимын шинжтэй асуудлуудаа тохирох боломжийг олгодог чухал зарчим юм. Уг зарчим нь мөн арбитрын үйн хатан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү боловсронгуй, бий болсон нөхцөл байдалд тохируулж, талуудын эрх тэгш хэлбэрээр илэрхийлсэн хүсэл зоригийн үндсэн дээр явуулах боломжийг бүрдүүлдэг тул хөрөнгө оруулагч нь улстай байгуулж байгаа хөрөнгө оруулалтын гэрээндээ арбитрын заалт оруулдаг.

Арбитрын ажиллагаа нь талуудын тохиролцоон дээр үндэслэн явагддаг учраас энд ямар нэг байдлаар хүч, эрх мэдлээр далайлгах гэсэн ойлголт байж болохгүй. Иймч учраас талуудын тэгш байдлын талаар яригдаж байгаа юм. Ерөнхийдөө арбитрын ажиллагааны явцад талууд аль аль нь бүрэн эрх эдэлдэг гэвэл тэд тэгш эрхтэйгээр уг эрхээ эдэлж хэрэгжүүлдэг гэж ойлгож болно. Гэхдээ энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Талууд урьдчилсан хуралдаанаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмаа хэрхэн тогтоносоос үл хамааран арбитрын ажиллагаа явагдаж байгаа газрын холбогдох хууль тогтоомжоор тогтоосон заавал мөрдөх журмыг баримтлах шаардлагатай болно. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, эсвэл талууд арбитрын хэлэлцээрээр хэрэглэх эрх зүйгээрээ юу гэж тогтоосон эсэхээс үл хамааран арбитрын ажиллагаанд уг ажиллагаа явагдаж байгаа газрын эрх зүйн хэм хэмжээ ямар нэг байдлаар хэрэглэгдэнэ гэсэн үг. Гэхдээ бодит байдал

дээр арбитрын тухай хэм хэмжээнүүдийн дийлэнх нь UNCITRAL-ийн Загвар хуулинд тулгуурласан байдаг тул тэдгээрийн зарчим, хэм хэмжээ онолын хувьд нэлээд ойролцоо байдаг.

Шүүхийн процессын хувьд хуулиар тогтоосон нарийн дэгтэй, олон жилийн турш хэрэглэгдэж ирсэн байнгын шинжтэй байдаг бол арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь уг ажиллагаа болж байгаа газрын шүүхээс тогтоосон ч юмуу ямарваа заавал дагаж мөрдөх процессын дагуу бус талуудын тохиролцсон журмаар ажиллагаагаа явуулдаг.

Арбитрынхэлэлцээрээрчүүнийгээзаавалтохиролцсонбайхшаардлагыг тавьдаггүй. Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улсуудын хувьд арбитрын ажиллагааны журмаа тогтоохдоо шүүхийн журамтай ойролцоо байхаар тохиролцох хандлага ажиглагддаг.

UNCITRAL-ын Загвар Хуулийн зарчмын дагуу хэн нэгнийг харьяалал, яс үндсээр нь ялгаварлаж арбитарчаар ажиллах эрхийг нь зөрчих ёсгүй. Иймд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх ажиллагаанд аль нэг улсын харьяалсан бус олон улсын арбитрын төвүүдийг маргаан шийдвэрлэх арбитраар сонгодог.

Арбитрын төвүүд болон институтуудыг бүс нутгийн хэмжээнд байгуулах нь чухал. Учир нь орчин үед үндэстэн дамнаж үйл ажиллагаагаа явуулах хандлага нэмэгдэж байгаагаас аль нэг талын арбитрыг сонгоход бэрхшээл үүсдэг. Тиймээс арбитрын ажиллагаа нь өөрөө уян хатан бөгөөд үндэстэн дамнан явагдах боломжтой байх хэрэгтэй. Арбитрын ажиллагаа явагдах газрыг тодорхойлно гэдэг нь арбитрын бүх ажиллагаа ганцхан тэр л газар явагдана гэсэн үг биш. Орчин үед үндэстэн дамнасан үйл ажиллагаа ялангуяа олон улсын худалдаа, барилгын төслийн хөрөнгө оруулалтаас үүдэлтэй маргааны арбитрын ажиллагаа нь талуудын мэтгэлцээн, нотлох баримтан дээр тулгуурлаж явагддаг учраас арбитрын хэрэг хянан шийдвэрлэх явцад талуудын процессын эрхийг дээд зэргээр хүндэтгэж, хангах хэрэгтэй.

Хөрөнгө оруулагч болон улс хоорондын маргааныг шийдвэрлэх арбитр ялангуяа арбитрын олон улсын төвүүд нь орчин үед тодорхой салбараар мэргэшин ажиллах төлөвтэй байгаа нь ихээхэн зөв шийдэл болоод байна.

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛОН УЛС ХООРОНДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Хөрөнгө оруулалтын харилцаа улам бүр өргөжих болсонтой холбоотойгоор XX зуунд түүнээс үүдэн гарах маргааныг шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх шаардлага урган гарсан.

Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх Вашингтоны Төв (ХОМШВТ) нь 1965 оны Вашингтоны конвенциор байгуулагдсан байгууллага юм. Уг конвенцыг тухайн улс болон бусад үндэстнүүдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх конвенц гэж нэрлэдэг ч товчлон Хөрөнгө Оруулалтын Маргааныг Шийдвэрлэх тухай конвенц гэдэг ба 1966 оны 10-р



сарын 14-нд хүчин төгөлдөр болсон. Уг конвенцийг Олон Улсын Сэргээн Босголт Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлууд нарийвчлан боловсруулж уг банкны гишүүн орнуудын засгийн газруудад 1965 онд өргөн барьж батлуулсан байна.

ХОМШВТөв нь Дэлхийн Банкны Ерөнхийлөгч даргалдаг Захиргааны зөвлөл, Нарийн бичгийн газар гэсэн бүтэцтэй. Захиргааны Зөвлөл нь конвенцид гарын үсэг зурсан улс бүрийн нэг төлөөллөөс бүрддэг.

ХОМШТөв нь бие даасан институт боловч үүсгэн байгуулсан түүх, одоогийн явуулж буй үйл ажиллагаа зэргээсээ хамааралтай Дэлхийн Банктай маш ойр хамтын ажиллагаатай бөгөөд тус Төвийн бүх гишүүд нь мөн Дэлхийн Банкны гишүүд байдаг.

1990-ээд оноос Аргентины эдийн засагт үүссэн хямралаас болоод одоо тус Төвөөр хянан шийдвэрлэгдэж байгаа 300 орчим хэргийн 30-аад хэрэгт Аргентин улс хариуцагчаар татагдаад байна.

Вашингтоны конвенци нь хөрөнгө оруулалтын салбарт шинэ нэлт хийсэн гэж үзэж болно. Эхэндээ хөрөнгө оруулагч нь хариуцагчаар улсыг татаж байгаа бол олон улсын арбитрт хандахаас өмнө улсын дотоодын шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагатай байсан. Энэ нь тухайн хөрөнгө оруулагч болон улс хоорондын харилцаанд "дипломат хамгаалалт" буюу улсын дархан эрхийн онол үйлчилж байсантай холбоотой. Гэвч энэ байдал нэг их удаан үргэлжлээгүй. Орчин үед хөрөнгө оруулалтын гэрээний аль ч тал гэрээнд заасан бол маргаанаа ХОМШВТ-д хандан шийдвэрлүүлэх эрхтэй болсон. Энэ нь ч бас ач холбогдолтой дэвшилттэй алхам болсон юм.

Конвенцийг бий болсон буюу олон улсын эрх зүйд дэвшлийг авчирсан, одоо нийтлэг болж байгаа нэгэн ойлголт бол төрийн бус хуулийн этгээд ба хувь хүн нь хөрөнгө оруулалтын гэрээний нэг тал болохдоо улсын халдашгүй дархан байдлыг бага зэрэг хязгаарлаж, өөрөөр хэлбэл маргаан шийдвэрлэх асуудлаар эрх тэгш оролцдог болсон явдал байлаа.

Вашингтоны конвенц нь хожим хувь хүн болон хуулийн этгээд эвлэрлийн болон арбитрын аргаар гадаадын улсын эсрэг нэхэмжлэл гаргах тогтолцоог бий болгоход чиглэсэн ач холбогдолтой дэвшил байсан. Конвенцийн үр ашиг нь улс ба хөрөнгө оруулагчийн маргаан хэмээх 11-р бүлэгт илүү нарийн тусгагдсан байдаг.

Вашингтоны конвенцийн дагуу ХОМШТөв нь гишүүн улс болон гишүүн улсын хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг эвлэрүүлэг, арбитрын журмаар шийдвэрлэдэг. Арбитрын болон эвлэрүүлэгтэй ажиллагаа нь бүхэлдээ сайн дурын үндсэн дээр явагддаг. Төвийн шийдвэр биелэгдэх улс нь гишүүн бус байсан ч шийдвэр хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөгдөж, биелэгддэг.

Вашингтоны конвенцийн шат дамжлага

Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх төв нь Вашингтон дахь Дэлхийн банкны төв албан байранд байрладаг. Энэ нь хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхдээ эвлэрлийн ба арбитрын гэсэн хоёр өөр шат дамжлагаар шийдвэрлэдэг. Эдгээр шат дамжлага нь 4 нөхцөлд хүчинтэй. Эдгээр нь:

1. Талууд тэдгээр маргааныг ХОМШТ-д хандаж шийдвэрлэхийг зөвшөөрсөн.

2. Уг маргаан нь гэрээ бүхий улс болон өөр гэрээтэй улсын үндэстэн хооронд байх ёстой.

3. Энэ нь хууль зүйн маргаан байна.

4. Мөн энэ нь хөрөнгө оруулалтаас шууд бий болсон маргаан байна.

"Хөрөнгө оруулалт" гэсэн нэр томъёог Вашингтоны конвенцоор тодорхойлоогүй ч практикт үйлчилгээ ба технологийн хөрөнгө оруулалт гэж байхаас гадна капиталын хөрөнгө оруулалт ч бас байж болно. ХОМШТ нь бүхэлдээ олон улсын эрх зүйн шинж чанартай бөгөөд үйл ажиллагаандаа хүндэтгэлтэйгээр хууль зүйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой халдашгүй эрх бүхий эвлэрүүлэгч болон арбитраар томилогдсон этгээд юм. Энэ халдашгүй байдал нь зөвхөн ХОМШТөвөөр л хязгаарлагддаг бөгөөд өөр салбарт байж болохгүй.

Вашингтоны конвенц

ХОМШТ-ийн шийдвэр нь тухайн улсын хуулийн дагуу шалгалт хийгдэж хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдолд хүчин төгөлдөр болохгүй. ХОМШТ нь олон улсын байгууллага. Учир нь энэ нь үндэсний хуулиас илүү олон улсын гэрээнд захирагддаг. Төрд харьяалагддагүй. ХОМШТ-ийн арбитрын үйл ажиллагааны үндэсний хуулинд хамаарахгүй зүйл нь ХОМШТ-ийн шийдвэр нь эцсийн байдлаар хүчин төгөлдөр байж, хүлээн зөвшөөрөгдөх маргаантай асуудлыг зохицуулдаг. Вашингтоны конвенцийн хэлэлцээрийн хүрээнд уг байгууллага нь ажилладаг.

Уг конвенцийн 56 дугаар зүйлийн дагуу ХОМШТ-ийн арбитрын шийдвэр нь аливаа бусад өөрчлөлт, давж заалдах боломжгүйгээр талуудад үйлчилдэг тэдийгүй энэ заалт конвенцод өөрт нь бас хамаарна. Гэхдээ эдгээрийг шийдвэрийн тайлбар болон агуулга утга санааны тайлбар ба байнгын бус хорооны шийдвэрээр хүчингүй болгох механизм бий. Энэ ажиллагаа жишээлбэл хэдэн жилийн өмнө болсон Камеруны БНУ-ын Клохрын болон СОКАМЕ компанийн хэргүүд юм. Энэ хэрэг нь Камеруны БНУ-д бордооны үйлдвэрлэл барьж, ажиллуулсан Клохр группын төслөөс үүссэн. Уг төсөл бүтэлгүй болж Клохр компани өөрийн оруулсан хөрөнгө оруулалтаа буцаан авахаар ХОМШТ-д маргаанаа шийдвэрлүүлэхээр хандсан. ХОМШТ-ийн эхний шийдвэр 1983 оны 10 дугаар сард гарсан. Үүнийг 1985 оны 5 дугаар сард байнгын бус хорооноос хүчингүй болгожээ. Уг маргаан 1988 онд шинэ арбитрын бүрэлдэхүүнээр дахин шийдвэрлэгдэж үүнийг талууд хоёулаа



хүчингүй болгохыг хүссэн ч 1990 оны 6 дугаар сард байнгын бус хорооноос татгалзсан. Уг маргаан бүхэлдээ арбитрт хандаж эхний хүсэлт гаргаснаас хойш 9 жилийн дараа шийдвэрлэгджээ. Түүнээс хойш гурван хэргийг хүчингүй болгосон. Энэ нь энэхүү арбитрын хувьд сайн муу түүх ээлжилж байсныг нотлож байна. Нөгөө талаар ХОМШТ-ийн шийдвэрийг хүчингүй болгох процедур хатуу шүүмжлэлд өртсөнийг ч хангалттай илтгэж байна.

Гэвч энэхүү хэцүү эхлэлийн дараа шийдвэрээ хүчингүй болгох тогтолцоо нь аяндаа тогтворжиж одоо маргааная шийдвэрлүүлэхээр хандсан талуудын хууль ёсны ашиг сонирхолд нийцэх болжээ.

ХОМШТөвийн нэмэлт үйлчилгээ

Төв өөрийн үндсэн үйл ажиллагаанаас гадна 1978 оноос ХОМШТ-ийн нарийн бичгийн газар үндэстэн хоорондын маргаан шийдвэрлэх арбитр ба эвлэрүүлэлтийн ажиллагааг Вашингтоны конвенцын дагуу бус арай өөр байдлаар хийдэг нэмэлт үйлчилгээг бий болгосон. Энэ нэмэлт нь талуудын аль нэг нь гэрээ байгуулаагүй тохиолдолд хэрэглэгддэг ба гишүүн бус улсуудад болон арбитрын ажиллагааг хийхэд хэрэглэгддэг. Нөгөө талаараа нэмэлт үйлчилгээ нь хөрөнгө оруулалтын бус худалдааны маргаанд ч хамаарна.

Нэмэлт үйлчилгээний дагуу маргаан шийдвэрлэх ажиллагааг явуулсан тохиолдолд Вашингтоны конвенциос гадна арбитрын ажиллагааны талуудын хувьд ашигтай улсын хуулинд үндэслэн маргааныг шийдвэрлэдэг. Гэхдээ энэ дүрэм зөвхөн "Гадаад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай" 1958 оны Нью Йоркийн конвенцод гарын үсэг зурсан орнуудын хувьд үйлчилнэ. Учир нь тухайн арбитрын шийдвэр нь Вашингтоны конвенц бус Нью Йоркийн конвенцийн дагуу хэрэгждэг.

Төвийн үзүүлдэг гурав дахь үйлчилгээ нь түр арбитрт ХОМШТөвийн Ерөнхий Нарийн Бичгийн Дарга эрх бүхий арбитрыг томилж өгөх юм.

Дээрх бүгдээс гадна ХОМШТөв нь зөвлөгөө өгөх, судалгаа явуулах, Дэлхийн улсуудын Хөрөнгө оруулалтын хуулийг хэвлэн нийтлэх, Дэлхийн Банкны тодорхой нэгжүүдтэй хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Төвийн үйл ажиллагаа нь АНУ-ын Вашингтон хотоос гадна Гаагийн Байнгын Арбитрын Шүүх, Кайро ба Куала Лампур дахь Ази-Африкын Эрх зүйн туслалцааны хорооны бүс нутгийн арбитрын төв, Мелбурн дахь Олон Улсын Арилжааны Арбитрын Австралийн төв, Сингапурын Олон Улсын Арбитрын Төв, Бахрайн дахь Арилжааны Арбитрын Төв, Германы Олон Улсын Арбитрын Төв, Франкфуртын Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимд явагддаг.

3. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ СУДЛАХ ПРАКТИК АЖИЛ-ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ ШАТАНД

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтолцоог судлах судалгааны ажлын хүрээнд ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн сектор Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг судлах практик ажил–хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэмээх дэд судалгааны тайлан бэлтгэсэн. Уг ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно:

Гүйцэтгэсэн ажил:

1. Тус судалгааны ажлын зорилгоор мэдээллийн эх сурвалжийг цуглуулах, баримт бичиг, мэдээлэл олж авч танилцахтай холбогдуулан ЦЕГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч, ЦЕГ-ын Мөрдөн байцаах газар /МБГ/ болон Хэрэг бүртгэх газрын /ХБГ/ дарга нарын нэр дээр албан бичиг /Хавсралт 1/ хүргүүлсэн.

2. Дээр дурдсан албан бичигт үндэслэн харьяалах газар, хэлтсийн дарга, ажилтнуудтай уулзаж, холбогдох мэдээллийг аман болон бичгээр өгсөн танилцуулгыг үндэслэн авсан болно.

3. ЦЕГ-ын сургалт хариуцсан газрын зүгээс тус газарт ГХО-тай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчтай холбоотой аливаа мэдээ, мэдээлэл байхгүй гэсэн бол ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс 2008 онд гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа авсан. /Хавсралт 2/

4. ЦЕГ-ын ХБГ-т хүргүүлсэн албан бичгийн хариуд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой хэрэг зөрчил нь мөрдөн байцаах харьяалалтай тул тус газарт сүүлийн 3 жилийн байдлаар шалгагдаагүй гэсэн хариу албан бичгийг /Хавсралт 3/ үндэслэн тус судалгааг хэрэг бүртгэх шатанд хийх боломжгүй болсон.

5. ЦЕГ-ын МБГ-ын дэд дарга Н. Арвинбуудайн цохолт хийсэнээр хавтаст хэрэгтэй танилцах боломжгүй боловч мэдээ, мэдээллээр хангах үүргийг тус газрын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх 5 дугаар хэлтэст хуваарилсан бөгөөд тус хэлтсийн ахлах мөрдөн байцаагч цагдаагийн ахмад Б. Цогтбаярын гаргаж өгсөн " Уул уурхайн олборлолт явуулахдаа газрын хэвлий ашиглах журам зөрчиж, нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийгээгүй мөн химийн онцгой хортой бодис ашигласнаас байгаль, хүн, малд хохирол учруулсан дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад холбогдох хэргүүдийн талаар судалгаа" /Хавсралт 4/, тус хэлтсийн ахлах мөрдөн байцаагч цагдаагийн хошууч Н. Доржсүрэнгийн амаар өгсөн тайлбарт үндэслэн санал, дүгнэлт бичсэн болно.

САНАЛ, ДҮГНЭЛТ

ЦЕГ-аас 2008 оны эхний 9 сард гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа, ЦЕГ-ын МБГ-аас хийсэн "Уул уурхайн олборлолт явуулахдаа газрын хэвлий ашиглах журам зөрчиж, нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийгээгүй мөн химийн онцгой хортой бодис ашигласнаас байгаль, хүн, малд хохирол учруулсан дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад холбогдох хэргүүдийн талаар судалгаа"-нд үндэслэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалгчийн нийтлэг үйлддэг гэмт зөрчлийг дараах байдлаар гаргаж байна. 2008 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчийн үйлдсэн 11 гэмт хэргийг үүсгэсэн байна. Үүнд дараах төрлийн гэмт хэргүүд давамгайлж байна.

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлд заасан Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, олгох, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн-1

2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 214 дүгээр зүйлд заасан Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулж үлэмж хэмжээний хохирол учруулсан -5

3. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авсан -5

4. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан Татвар төлөхөөс зайлсхийсэн-1

Гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар шалгагдсан ГХО-той аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчийг харьяалах улсаар нь доор жагсааж байна.

1.БНХАУ-9

2.БНСУ-2

3.Бангладеш-1

Дээрх тоон үзүүлэлт болон Татварын албаны байцаагчаас авсан судалгаанаас харахад ГХО-той аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагаанд тавих хяналт сул учраас Татварын алба өөрийн зүгээс арга хэмжээ авсаны үр дүнд Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн тоо харьцангуй буурсан.

Гэвч манай улсад газрын хэвлийн баялагийг дур зоргоор ашиглах явдалд тус салбарын хяналт дутмагаас үүдэн Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах /200 дугаар зүйл/ болон Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих /204 дүгээр зүйл/, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох /214 дүгээр зүйл/ гэмт хэргийн тоо өсч байна.

Түүнчлэн ГХО-той аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн хэмжээ болох 10.000 ам.доллар нь зах зээлийн түвшингээс хэт доогуур байгаа нь үүнийг буруугаар ашиглах тухайлбал, худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа

явуулах эрх авсан боловч хууль бусаар саун, массаж ажиллуулан, садар самууны болон биеэ үнэлүүлэх үйл ажиллагааг явуулан хууль зөрчдөг.

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл бол тус улсад үйл ажиллагаа явуулж буй ГХО-той аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч нь улсын бүртгэлд бүртгүүлсэн үндсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулдаг, газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх явдал газар авсан, ажилгүйдэл, ядуурал болж байна.

Цаашид дараах хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.

- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан ГХО-той аж ахуйн нэгж байгуулахад шаардагдах дүрмийн сангийн хэмжээ нь 10.000 ам.доллар байгаа нь гадаадын иргэн, аж ахуйн нэгжид гэмт хэрэг үйлдэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа учраас энэхүү босгыг яаралтай өндөрсгөх эсвэл өөрөөр зохицуулах хэрэгтэй.
- ГХО-той аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын зохих эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулж үл болохоор үр дүнтэйгээр зохицуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.
- Татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулан ГХО-той аж ахуйн нэгж бүр ерөнхий нягтлан бодогч, хуулийн зөвлөх нь Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх явдлыг хангана гэж үзэж байна. Уул уурхайн олборлолт явуулахдаа газрын хэвлий ашиглах журам зөрчиж нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийгээгүй мөн химийн онцгой хортой бодис ашигласнаас байгаль орчин, хүн, малд хохирол учруулсан гэмт хэрэг шийдвэрлэх шатны ажиллагаанаас харахад "Гэмт хэргийн улмаас учирсан бодит хохирлыг тогтоон илрүүлэх" гэсэн үндэслэлээр шүүхээс дийлэнх хэрэг мөрдөн байцаалтаас буцаж байх тул цаашид "байгаль экологид учирсан хохирлын эдийн засгийн үнэлгээг тогтоох тухай" хуулийг яаралтай боловсруулан УИХ-аар хэлэлцэн гаргавал энэ төрлийн гэмт хэргийг бүрэн шийдвэрлэж болохоор байгааг санал болгон дэвшүүлж байна.

IV. ӨӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Дэлхийн хөгжлийн орчин үеийн хандлагаар хэсэг улсын хооронд гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг татах өрсөлдөөн нэмэгдсээр байгааг хүн бүхэн мэднэ. Энэ нь хөрөнгө оруулагчдыг татах арга, хэрэгслийн ач холбогдлыг улам нэмэгдүүлж боловсронгуй болгосоор байдаг. Иймд гадаадын хөрөнгө оруулалтыг татах хамгаас үр дүнтэй арга бол эдийн засгийн чөлөөт бүс байгуулах явдал гэдэгт олон эрдэмтэд санал нэг байдаг.

Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах шалтгаан, зорилго, өөрөөр хэлбэл түүнийг ямар учраас, хөгжлийн аль шатанд буй улс, ямар бодлогоор байгуулж буй нь чухал байдаг. Тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн

түвшин болон улсын эдийн засаг, аж ахуйг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө, бодлого зэрэг нь чөлөөт бүс байгуулах гол шалтгаан болдог.[278]

Харилцан адилгүй хөгжлийн шат, өөр өөр эдийн засгийн болон улс төрийн үндэслэлээс шалтгаалаад эдийн засгийн чөлөөт бүс нь олон янзын нэршилтэй, адилгүй хэв шинжтэйгээр бий болсон байдаг байна. Ном зохиолуудад эдийн засгийн чөлөөт бүсийг маш олон янзаар нэрлэснийг харж болно. Зарим эрдэмтэд эдийн засгийн чөлөөт бүсийн нэршил 50 гаруй байдаг гэж үздэг. Тэдгээр нь Эдийн засгийн чөлөөт бүс гэх нэрийн дор чөлөөт бүсийн бүх төрлийг багтаан ойлгож болно гэж үздэг.

Нэгдсэн хэв шинжийг агуулсан эдийн засгийн чөлөөт бүсийн тухай нэгдсэн ухагдахуун гадаадын болон Монголын ном зохиолд хараахан төлөвшин тогтоогүй ба 1973 оны 5 дугаар сарын 18-ны Киотогийн Гаалийн байгууллагын үйл ажиллагааг хөнгөвчлөх, уялдуулах тухай Олон улсын конвенцид "чөлөөт бүс нь бараанд ногдуулах үндэсний татварын болон гаалийн ердийн журам үйлчилдэг нутаг дэвсгэрээс гадна оршиж, тийм гаалийн журам үйлчилдэггүй тухайн улсын нутаг дэвсгэрийн нэг хэсэг" хэмээн тодорхойлсон байна.

Харин зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн улсуудын туршлагад үндэслэн эрдэмтэд "гадаад худалдаа, эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, техник технологийн салбарт хөрөнгө оруулж буй дотоодын болон гадаадын бизнес эрхлэгч нарт эдийн засгийн онцгой хөнгөлөлт, урамшуулал үзүүлдэг тусгайлсан тогтоосон нутаг дэвсгэр, далайн болон агаарын боомтыг эдийн засгийн чөлөөт бүс" хэмээн тодорхойлсон байна.[279] Түүнчлэн эрдэмтдийн үзэж буйгаар эдийн засгийн чөлөөт бүс нь гаалийн чөлөөт дэглэм болон гадаад эдийн засгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг эдийн засгийн бусад аргаар урамшуулал үзүүлдэг нутаг дэвсгэр[280] юм.

Өнөөгийн олон улсын практикаас харахад эдийн засгийн чөлөөт бүс нь нутаг дэвсгэрийн хувьд тухайн улсын хил хязгаар дотор, эсхүл хэд хэдэн улсын хил дамнасан шинжтэй байх бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны хувьд тухайн газар нутагт бүхэлдээ онцгой дэглэм үйлчилдэг нийтлэг шинжтэй байна. Чөлөөт бүсийн нийтлэг шинжийг дэлхийн олон улс өөрийн хууль тогтоомжид тусгаж өгсөн байдаг байна. Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар Чөлөөт бүс нь "гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байдагт тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг хэлнэ". Эдийн засгийн чөлөөт бүс нь үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, бүтэц, зохион байгуулалт, байршил зэргээс шалтгаалаад

278Meng Guangwen, "The Theory and Practice of Free Economic Zones", Ruprecht-Karls University of Heidelberg, Germany, 2003, p.27

279Игнатов.В., Бутов.В. "Свободные экономические зоны. Методические и организационные основы. Правовой и налоговый режим", М., 1997.

280Nikolay Sberegaev, "Local Free Economic Zones: New Approach and New Opportunities", Kaliningrad State Technical University, Kaliningrad, 2005, p.2

маш олон янз байх бөгөөд дэлхийн эдийн засгийн харилцаа улам өргөжиж, хөгжихийн хэрээр түүний төрлүүд улам нэмэгдэж, төрөл бүрийн чиглэл зорилготойгоор шинэ шинэ чөлөөт бүс байгуулагдаж байгаа нь чөлөөт бүс гэх ойлголтын хамрах хүрээ улам өргөжүүлж байна. Эдийн засгийн чөлөөт бүсийн талаар нэгдмэл тодорхойлолт хараахан байхгүй ч ихэнх эрдэмтэн судлаачдын тодорхойлсноос харахад Эдийн засгийн чөлөөт бүс нь дараах онцлог шинжүүдээр тодорхойлогдож болох юм:

- Эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс
- Эдийн засгийн тодорхой үйл ажиллагаа явуулах зорилгоор
- Тухайн улсад мөрдөгддөгөөс өөр, онцгой дэглэм үйлчилдэг
- Тодорхой хэмжээний нутаг дэвсгэрт орших бүс.

Эдийн засгийн чөлөөт бүсийн нийтлэг онцлог бол тухайн улсын гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршдог. Өөрөөр хэлбэл, гаалийн нутаг дэвсгэр гэдэг нь тухайн орны гаалийн дэглэм үйлчилдэг газар нутаг байдаг бол уг гаалийн дэглэм үйлчлэхгүй бүс нутаг бол эдийн засгийн чөлөөт бүс юм. Ийм бүсэд тусгайлан тогтоосон гаалийн журам үйлчилдэг.

Гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршино гэдэг нь тухайн улсын Засгийн газрын удирдлага, хяналтаас бүрэн тусгаарлагдана гэсэн үг биш. Нэгэнт тухайн улсын нутаг дэвсгэрийн дотор, улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр эдийн засгийн чөлөөт бүс байгуулагддаг тул төрийн зүгээс түүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих явдал зайлшгүй юм. Иймд удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтан, түүний чиг үүрэг, бүрэн эрх, үүрэг хариуцлага зэргийг хууль тогтоомжоор нарийн тогтоосон байх шаардлагатай байдаг. Улс орон нь өөрийн эдийн засгийг хөгжүүлэх, их хэмжээний хөрөнгө татах, олон улсын эдийн засгийн харилцаанд оруулах хувь нэмэр, гүйцэтгэх үүргээ нэмэгдүүлэх үүднээс худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх тодорхой хэмжээний нутаг дэвсгэр дээр ийм эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулдаг. Ингэхдээ гадаадын хөрөнгө оруулагчдыг илүү ихээр татаж, тэдний сонирхлыг өөрийн орны онцлог, давуу тал, ашиг сонирхолтой нийцүүлэн удирдан зохион байгуулах бөгөөд хөрөнгө оруулагчдыг татахын тулд тэдэнд татварын, гаалийн, захиргааны шинжтэй тодорхой хөнгөлөлт, урамшуулал үзүүлэхээр амладаг байна. Ийм татварын, гаалийн болон бусад хөнгөлөлт, урамшууллыг улс орнууд хууль тогтоомжоороо тогтоодог.

Хамгийн гол нь эдгээр арга замуудыг хэрхэн зөв оновчтой зохицуулж, хөрөнгө оруулагчдад ч, өөрийн орны эдийн засагт ч харилцан ашигтай нөхцлийг бүрдүүлж чадах эсэхээс эдийн засгийн чөлөөт бүсийн хувь заяа шалтгаална. Үүнд эрх зүйн орчныг маш сайн, оновчтой, зөв бүрдүүлэх нь хамгийн чухал юм.

UNCTAD[281]-ийн хийсэн судалгаагаар өнөөдөр дэлхийд 2000 - 4000 чөлөөт бүс байх бөгөөд үүнээс 900 гаруй нь эдийн засгийн чөлөөт бүс байна. Эдгээрээс тун амжилттайгаар хэрэгжиж, улс орны эдийн засгийн хөгжилд голлох үүргийг гүйцэтгэж буй эдийн засгийн чөлөөт бүс олон

[281] Mongolian journal of International affairs., p.152

байхад тодорхой хэмжээгээр үйл ажиллагаа нь зогсонги байгаа, төдийлөн амжилттай хэрэгжиж чадаагүй ЭЗЧБ-үүд ч цөөнгүй бий. Үүний шалтгаан нь тухайн улсын ЭЗЧБ-ын эрх зүйн үндэс суурь, орчныг сайн бүрдүүлээгүй, удирдлага зохион байгуулалт сул, бодит байдалд нийцсэн, хэрэгжүүлэх боломжтой, нарийн боловсруулсан төлөвлөгөө байхгүй зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна.

Түүхэн хөгжлийн явцад шинээр олон янзын эдийн засгийн чөлөөт бүс бий болж, энэ олон янзын эдийн засгийн чөлөөт бүсийг тодорхой нийтлэг шинжээр нь төрөлжүүлэн ангилах шаардлага гарч ирсэн. Эдийн засгийн чөлөөт бүсийг ерөнхийдөө үйл ажиллагааных нь чиглэл, хамрах салбараар нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, технологи, эдгээр салбаруудын хэд хэдэн төрлийн нэгдэл буюу цогц хэлбэр, мөн хил дамнасан гэж ангилсан байдаг. Энэхүү хамрах салбараар нь төрөлжүүлэн ангилсан нь тухайн бүсийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл, худалдааны төрөлд багтах эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь худалдаа бөгөөд үүнд чөлөөт боомт, чөлөөт худалдааны бүс /"Алтанбулаг" болон "Цагааннуур" худалдааны бүс/, баталгаат агуулах зэрэг, үйлчилгээний төрөлд аялал жуулчлал-амралтын бүс, мөн банк даатгал зэрэг үйлчилгээ эрхлэн явуулдаг эдийн засгийн чөлөөт бүс хамаардаг байна[282].

Сингапурын Nanyang Технологийн Их Сургуулийн судлаач Chee Kian Leong эдийн засгийн чөлөөт бүсийн олон төрлүүдээс үл хамааран тэдгээрийг байгуулах болсон гол зорилго нь нийтлэг шинжтэй байдаг бөгөөд дараах 4 үндсэн зорилгоор эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулдаг гэж үзсэн. Үүнд:

1. Экспортыг дэмжих замаар эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх
2. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон гадаад валютын хэмжээг нэмэгдүүлэх
3. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх
4. Технологийн болон удирдлага зохион байгуулалтын шинэ аргуудыг олж авах.[283]

Ийнхүү эдийн засгийн чөлөөт бүсийн талаар нэгдмэл тодорхойлолт байдаггүй хэдий ч энэ талаар эрдэмтэн судлаачдын өгсөн тодорхойлолт ерөнхийдөө ойролцоо байх бөгөөд тухайн бүсийг байгуулах зорилго тус бүст эрхлэх үйл ажиллагааны онцлог, үйлчлэх дэглэм, нутаг дэвсгэр зэрэг нь Эдийн засгийн чөлөөт бүсийг тодорхойлох үндсэн шалгуур, онцлог шинж гэж үзэж болохоор байна.

Чөлөөт бүс нь Эдийн засгийн чөлөөт бүс, Чөлөөт боомт, Чөлөөт худалдааны бүс зэрэг олон төрөл байдаг нь түүнийг байгуулах болсон шалтгаан, зорилго, үйл ажиллагааны чиглэл болон газар зүйн байршил зэргийн хувьд тухайн тохиолдол бүрт, улс орон болгонд өөр өөр байдаттай

[282] Meng Guangwen, "The Theory and Practice of Free Economic Zones", Ruprecht-Karls University of Heidelberg, Germany, 2003, p.34

[283]Chee Kian Leong, "A tale of two countries: Openness and growth in China and India", Nanyang Technological University, 2004, p.6

холбоотой. Ийм олон янзын зорилго, зориулалт, нэршил, тодорхойлолт зэргээс шалтгаалан дэлхий нийтийн хэмжээнд чөлөөт бүсийн талаар нэгдсэн ойлголт бий болгоход хүндрэлтэй юм.

Гэтэл зарим улс орнууд ижил төрлийн эдийн засгийн чөлөөт бүсийг өөр өөрөөр нэрлэсэн, эсхүл өөр өөр төрлийн эдийн засгийн чөлөөт бүсийг ижил нэрээр нэрлэсэн байдаг нь энэ талаар маргаант байдлыг бий болгодог. Жишээлбэл, Хонконг, Сингапурын Чөлөөт боомтууд, Хятадын зарим эдийн засгийн онцгой бүс болон Эдийн засаг-технологийн хөгжлийн бүс, Худалдааны чөлөөт бүс, Хилийн худалдааны чөлөөт бүс зэрэг нь Экспортын бүс боловч Тайвань, Өмнөд Солонгосын Экспортын бүс, Шаннон, Каосиун дахь Худалдааны чөлөөт бүс нэртэй Экспортын бүсээс ялгаатай юм. Мөн зарим судалгааны ажлуудад Экспортын бүсийг Худалдааны чөлөөт бүс, Эдийн засгийн онцгой бүс хэмээн тайлбарласан байдаг. Иймд эдгээр маш олон Эдийн засгийн чөлөөт бүсийг тодорхой онцлог, нийтлэг шинж байдлаар нь төрөлжүүлэн ангилснаар дэлхий дээр орших олон тооны, олон төрлийн, олон янзын нэршил бүхий Эдийн засгийн чөлөөт бүсийг системтэй болгохоос гадна дээр дурдсан нэг төрлийн Эдийн засгийн чөлөөт бүсийг өөр өөр байдлаар нэрлэх, өөр өөр төрлийн Эдийн засгийн чөлөөт бүсийн ижил байдлаар нэрлэх явдлаас зайлсхийх ач холбогдолтой юм.

Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт

Эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай хэрэгжүүлэх, түүний үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулах, улс орны эдийн засагт гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, хөгжүүлэхийн тулд түүний эрх зүйн үндэс суурь, эрх зүйн орчныг бүрдүүлэн тогтвортой байх нөхцлийг тухайн улс нь бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг нь ойлгомжтой юм.

Монгол Улсын хувьд зах зээлийн тогтолцоонд шилжин эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрчээ. Олон улсын эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцож, түүнийгээ улам бүр өргөжүүлэх бодлого баримталж байна.

Энэ үүднээс Монгол Улсын Их Хурал 1995 оны 87 тоот тогтоолоор "Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал" баталж, түүнийг баримтлан 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр "Чөлөөт бүсийн тухай Монгол Улсын хууль" батлан гаргасан. Иймхүү Монгол Улсад Чөлөөт бүс байгуулагдах эрх зүйн үндэс суурь тавигдсан юм.

Энэхүү Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын дагуу эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үндэслэл нь:

1/ эдийн засгаа нээлттэй аргаар хөгжүүлэх зохион байгуулалтын нэг шинэ хэлбэр болсон эдийн засгийн чөлөөт бүсийг сонгон авч хэрэгжүүлж байгаа дэлхийн олон орны нийтлэг жишиг.

2/ манай орны тодорхой бүс нутагт хөрөнгө оруулах эрмэлзэл бүхий гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг өөрийн орны эрх ашигтай зөв



хослуулан тухайн бүс нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх явдал гэж үзнэ.

Чөлөөт бүс байгуулах энэхүү үзэл баримтлалын дагуу УИХ-ын 2002 оны 38 дугаар тогтоолоор манай орныг ОХУ, БНХАУ болон Европ Азийн орнуудтай холбосон тээвэр газар зүйн нэн тохиромжтой байрлал бүхий Монгол Улсын хойд хил дээр нийт 500 га талбай бүхий нутаг дэвсгэрт "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс, 900 га талбайд "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар шийдвэрлэжээ.

Одоогоор "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс нь хэсэгчилсэн менежментээр үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах гэрээгээр олгож байгаа юм. Эхний хөрөнгө оруулагчид нь бүтээн босголтын ажлаа эхэлжээ. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн хувьд хоёр ч удаа хөрөнгө оруулагчдад бүтэн менежментээр олгох гээд бүтэлгүйтсэн. Эдийн засгийн чөлөөт бүсийн гол санаа нь дэлхийн зах зээл дээр өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, шинэлэг, орчин үеийн барилга байгууламж байгуулах юм.

Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилго нь тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино.

Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай хуулиар чөлөөт бүс нь Худалдааны, Үйлдвэрлэлийн, Хөдөө аж ахуйн, Аялал жуулчлал-үйлчилгээний, Эдийн засгийн гэсэн хэлбэртэй байхаар заасан ба үүний дагуу "Алтанбулаг", "Цагаannуур" худалдааны чөлөөт бүс, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдсан. Түүнчлэн "Чойр" эдийн засаг, технологийн чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Эдгээрээс "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс 2008 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр албан ёсоор нээлтээ хийсэн байна.

Одоогоор дээрх "Алтанбулаг", "Цагаannуур" худалдааны чөлөөт бүс, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсүүдийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан. Харин "Чойр" эдийн засаг, технологийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль нь төслийн л хэмжээнд хэдэн жилийн нүүр үзэж байна. Эдгээр хуулиар холбогдох бүсийн эрх зүйн байдал, мөрдөгдөх тусгай журмыг хуульчилсан байна.

Чөлөөт бүс дэх хөрөнгө оруулалтыг татах таатай дэглэм

ЭЗЧБ-ийн хөгжилд түлхэц үзүүлэх хамгийн гол хүчин зүйл бол хөрөнгө оруулагч нарт хөнгөлөлт урамшуулал үзүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм.

Иймд аливаа улс хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж өгөг бөгөөд ингэхдээ мөн өөрийн орны үндэсний ашуулгүй байдал, эдийн засгийн гадаад бодлого зэргийг харгалзан үзэх шаардлагатай байдаг байна.

Дэлхийн томоохон чөлөөт бүсүүдийг авч үзэхэд маш олон төрлийн аргаар хөрөнгө оруулалтыг татдаг байна. БНХАУ гэхэд чөлөөт бүсийн дэд бүтцийн барилгыг бүрэн хийж дууссаны дараа хөрөнгө оруулагчддаа газар олгожээ. Энэ арга нь хөрөнгө оруулагчидад чөлөөт бүсийг бүтэн менежментээр олгоход нэн тохиромжтой. Хэсэгчилсэн менежмент - Засгийн газраас эхний ээлжинд чөлөөт бүсийн дэд бүтцийг байгуулна. Тухайн чөлөөт бүсэд хэрэгжих төслүүдийг бэлдэн нэгдсэн хот байгуулалтын бүрэн хэмжээний төлөвлөгөө, кадастрын зураг зэргийг гаргаж хөрөнгө оруулагч нарын сонирохсон үйл ажиллагааны чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэхээр өгдөг. Энэ нь хот байгуулалтын хувьд жигд барилга байшин баригдах ба жижиг дунд бизнес эрхлэгчдэд чөлөөт бүсийн үйл ажиллагаанд оролцох боломж олгож байгаа юм.

Орон бүр гадаадын хөрөнгө оруулалтыг татаж оруулахдаа тухайн орны газар зүйн онцлог, эдийн засгийн байдлыг харгалзаж хуулийн зохицуулалтыг хийдэг. Чөлөөт бүсэд оруулж байгаа хөрөнгийн хэмжээ, хэлбэрээс хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг шийдвэрлэх тал ч бас бий. Тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хүртэл газрын төлбөрийг 20%- ийн хөнгөлөлт түүнээс дээш 50%-ийн хөнгөлөлт үзүүлэх гэх мэт байдаг.

Манай улсын хувьд 1993 оны 5 дугаар сарын 10-ны өдөр "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль" батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалтыг өөрийн орондоо татах хууль зүйн орчин бүрдсэн. Мөн Чөлөөт бүсийн тухай хууль болон холбогдох чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиар уг чөлөөт бүсэд үзүүлэх чөлөөлөлт, хөнгөлөлт, урамшууллын талаар зохицуулсан байдаг. Түүнчлэн төрийн зүгээс хөрөнгө оруулалтыг татах, оруулж буй хөрөнгийг өөрийн улсын ашиг сонирхолд нийцүүлэн удирдан зохицуулах эрх зүйн үндсийг бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч байна. Тухайбал:

2008-2012 оны Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого баримталж, хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг хангана" гэжээ.

Түүнчлэн УИХ-ын тогтоолоор баталсан 2009 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 12.3-ийн дагуу Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсэд түшиглэн эдийн засаг, экспортын өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж эхлэх; 16.2-т Монгол Улсын хөгжлийг хангах худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын нэн тааламжтай орчинг бүрдүүлж, Европын Чөлөөт худалдааны нийгэмлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны тунхаглалаа хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээг төлөвлөсөн байна.

Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хөрөнгө оруулагч нарт хөнгөлөлт, урамшууллыг тодорхой хэмжээгээр үзүүлэхээр эрх зүйн хүрээнд тогтоож өгсөнийг дээрхээс харж болно.

Ийнхүү хууль зүйн орчин бүрдсэнээр гадаадын хөрөнгө оруулалт бодит байдал дээр хэрэгжих үндэс суурь нь болж байгааг манай улсад гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж буйгаа нотолж болно. Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлэх арга зам нь гол хөрөнгө оруулагч улс болох БНХАУ, БНСУ, ОХУ -тай эдийн засгийн харилцаагаа бэхжүүлэх явдал байхаас гадна тэргүүлэх салбаруудыг өргөжүүлэн хөгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалт улам бүр нэмэгдэх боломжтой юм.

Монгол Улсад хөрөнгө оруулалтыг татах давуу талууд:

- Монгол Улсын нээлттэй эдийн засаг
- Хөрш зэргэлдээ томоохон зах зээлтэй
- Хятад, Зүүн Өмнөд Азийн орнуудыг ОХУ-ын болон Европын зах зээлтэй холбох хамгийн дөт зам
- Хүн ам нутагшин амьдрах, аялан зорчих, байгаль газар зүй, түүх соёл иргэншлийн тааламжтай болон өвөрмөц нөхцөл бүхий өргөн уудам нутаг дэвсгэртэй
- Ашигт малтмал, түүхий эдийн арвин их нөөц.

Түүнчлэн хөрөнгө оруулагчдыг татах дараах таатай нөхцлүүдийг амладаг.

– чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хамгаалах ба улсын өмч болгохгүй байх

– чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэд аж ахуйн нэгжийн хөрөнгийг шүүхийн шийдвэр гараагүй байхад хураан авахгүй байх

– ногдол ашгаа гадаадад ямар ч хязгаарлалтгүйгээр гуйвуулах эрхтэй.

Төгсгөлд нь хэлэхэд, ЭЗЧБ-ийг амжилттай хэрэгжүүлж, эдийн засгаа хөгжүүлэн, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын тоонд багтаж чадсан улс орнуудаас суралцаж, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтаас дууриалал аван өөрийн орны хууль тогтоомжийг сайжруулахад анхаарах чухал шаардлагатай байна.

V. ГАДААД ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

1. ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ

Капитал нь бараа үйлдвэрлэхийн тулд зайлшгүй зарцуулагддаг үйлдвэрлэлийн гол нөөц хүчин зүйлийн нэг бөгөөд материаллаг баялгийг бүтээхэд гарцаагүй шаардагддаг үр бүтээлтэй бараа ба мөнгөн хэлбэрээр хуримтлагдсан нөөц болж илрэлээ олдог.

Олон улсын мөнгөний хөдөлгөөн нь үйлдвэрлэлийн хүчин зүйлийн олон улсын хуваарьт үндэслэгдэн түүхэн хугацаанд бий болсон буюу янз бүрийн орнуудад капиталыг төвлөрүүлэн эзэмшиж байгаа нь бусад орноос эдийн засгийн хувьд үр ашигтай тодорхой барааны үйлдвэрлэл

явуулах урьдчилсан нөхцлийг бүрдүүлсэн байдаг. Олон улсын капиталын хуваарь нь улс орнуудын бараа үйлдвэрлэхэд шаардагдах мөнгөний нөөц хуримтлалын ялгаа, зах зээлийн механизм болон барааны үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин, үйлдвэрлэлийн туршлага хийгээд түүхэн уламжлалын ялгаа, мөн түүнчлэн ердийн мөнгө болон бусад санхүүгийн нөөцөөр илэрч байдаг.

Бэлэн мөнгөний найдвартай нөөц нь хөрөнгө оруулалт болон нөхөн үйлдвэрлэл явуулах маш чухал урьдчилсан нөхцөл мөн.

Импортыг санхүүжүүлэх гол уг сурвалж бол барааны экспорт гарцаагүй мөн. Тухайн орон гадаадаас бараа худалдан авахын тулд гадаадад бараа экспортлох буюу үйлчилгээ үзүүлэх ёстой. Бодит амьдралд гадаадаас капитал оруулах, санхүүжилтийн нэг бодитой эх сурвалж бол зээл юм. Ямар ч орон олон улсын зээл авах буюу олгох боломжтой. Түүнчлэн гадаадад хөрөнгө гаргаж бизнес эрхлэн капиталын хуримтлалыг бий болгох боломж ч бий.

Олон улсын мөнгөний хөдөлгөөний хэлбэр

Олон улсын мөнгөний хөдөлгөөн нь үйлдвэрлэлийн хүчин зүйл болохын хувьд олон янзын тодорхой хэлбэртэй учир дэлхийн зах зээлд хөдөлгөөнд байгаа капиталын гарал үүслийн уг сурвалжийг улсын буюу хувийн гэх зэргээр ангилдаг:

- Албан ёсны буюу улсын хөрөнгө оруулалт
- Бизнес эрхлэх хөрөнгө оруулалт
- Зээлийн хөрөнгө оруулалт
- Хувийн хөрөнгө оруулалт
- Шууд хөрөнгө оруулалт
- Хувьцааны хөрөнгө оруулалт

Албан ёсны буюу улсын (Official capital) мөнгөн хөрөнгө нь Засгийн газар буюу Засгийн газар хоорондын байгууллагын шийдвэрээр гадаадад мөнгө байршуулах буюу гадаадаас мөнгө хүлээн авах, мөн түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөс бүрдэл болдог. Мөнгөний хөдөлгөөний энэхүү категорид зээл, зээллэг, бэлэглэлийн зүйлс, тусламж зэрэг хамаардаг бөгөөд эдгээр нь зөвхөн Засгийн газар хоорондын гэрээний дагуу олгогддог болно.

Дэлхийн банк болон Олон улсын валютын сан /ОУВС/ тэдгээрийн гишүүдийн нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын байгууллагууд захирамжлан гаргасан хөрөнгийг албан ёсны гэж хүлээн зөвшөөрдөг. Албан ёсны хөрөнгийн эх сурвалж нь улсын төсвийн хөрөнгө өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн төлсөн татварын дүн хэмээн үзэж болно.

Тиймээс ийм хөрөнгийг гадаадад байршуулах асуудлаар тухайн улсын парламент болон засгийн газар хамтарч шийдвэр гаргана.

Хувийн капитал /Private capital/ гэдэг нь хувийн компани, банк болон төрийн бус байгууллагын шийдвэрийн дагуу гадаадад мөнгө байршуулах буюу гадаадаас мөнгө хүлээн авахыг хэлнэ.

Мөнгөний хөдөлгөөний энэ категорид хувийн компаниас гадаадад хийж байгаа хөрөнгө оруулалт, мөн олгож байгаа худалдааны болон банк дундын зээл хамаарна. Эдгээр хөрөнгийг үүсгэх гол сурвалж бол улсын төсөвтэй холбоогүй зээллэг буюу хувийн компанийн өөрийнх нь хөрөнгө байдаг.

Хэдийгээр хувийн компани өөрийн мэдлийн хөрөнгийг олон улсын хүрээнд байршуулах асуудлаар шуурхай шийдвэр гаргадаг ч тухайн улсын засгийн газар мөнгөний хөдөлгөөний ерөнхий байдлыг хянаж зарцуулах үүргийг хүлээдэг.

Хөрөнгийг ашиглалтын шинж байдлаар нь ангилж болно. Үүнд:

- Бизнес эрхлэх хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг, орлого олох зорилгоор үйлдвэрлэлд шууд буюу шууд бусаар оруулж байгаа мөнгийг хэлнэ. Юуны өмнө бизнес эрхлэгч болгон хувийн капиталыг ашигладаг бөгөөд нэг бол улс өөрөө эсвэл улсын мэдлийн үйлдвэрийн газар, гадаадад хөрөнгө оруулах замаар ашиглаж болдог.

- Зээлийн хөрөнгө гэдэг нь хүүгийн хувь авах зорилгоор олгож байгаа зээллэгийг хэлнэ. Мөн чанартаа зээлийн хөрөнгийг олон улсын хүрээнд гол нь улсын мөнгөний албан ёсны эх сурвалжаас ашигладаг. Гэхдээ олон улсын зээлийг хувийн мөнгөний эх сурвалжаас хангаж байгаа нь олон улсын хөрөнгө оруулалтад чухал байр эзэлдэг юм.

- Дунд болон урт хугацаатай /Mid- term and Long-term capital/ хөрөнгө оруулалт гэдэг нь жилээс доошгүй хугацаатай оруулсан мөнгөн хөрөнгийг хэлнэ. Бизнес эрхлэх бүх хөрөнгө оруулалтад улсын мөнгөн зээлийн хувьд шууд болон хувьцааны хэлбэрээр гол төлөв урт хугацаатай олгогддог.

- Богино хугацаатай хөрөнгө оруулалт /Short - term capital/ нь ихэвчлэн жилээс бага хугацаатай байдаг бөгөөд төлөв худалдааны зээлийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийгддэг.

Олон улсын мөнгөний хөдөлгөөн нь практикийн ихээхэн ач холбогдолтой дараах төрөлд хуваагддаг. Үүнд:

- Шууд хөрөнгө оруулалт /Direct investment/ гэдэг нь хөрөнгө оруулсан объектод хөрөнгө оруулагч хяналт тавих боломжтой, хөрөнгийг хүлээн авч байгаа орны урт хугацааны эдийн засгийн сонирхлыг хангаж байгаа, ашиг орлого олох зорилгоор оруулсан хөрөнгийг хэлнэ.

- Хувьцааны хөрөнгө оруулалт /Portfolio Investment Position/ гэдэг нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан объектод шууд хяналт тавих боломжоор хангагдаагүй, гадаадын үнэт цаасыг худалдан авахаар оруулсан хөрөнгийг хэлнэ. Тийм хөрөнгө оруулалт ихэвчлэн хувийн бизнес эрхлэх капиталд үндэслэгддэг хэдий ч улс өөрийн үнэт цаасыг гаргахын зэрэгцээ, гадаадын үнэт цаасыг ч худалдан авдаг үйл ажиллагаа юм.

Олон улсын мөнгөний хөдөлгөөнийг улс орон бүр хүлээн зөвшөөрдөг бөгөөд түүнийг Хөрөнгө оруулалтын болон Банкны хуульд хуульчлан тусгаж оруулдаг. Мөнгөний хөдөлгөөний бүлэг бүр нь хагас бүлэгт хуваагддаг бөгөөд гадаадад мөнгө гаргаж хөрөнгө оруулалт хийж байгааг экспорт буюу "актив", өөрийн оронд хөрөнгө оруулж хүлээн авч байгааг импорт

буюу "пассив" хэмээн үздэг.

Олон улсын мөнгөний хөдөлгөөнийг үйл ажиллагааны чиглэлээр хуваах нь

1.Шууд хөрөнгө оруулалт	Гадаадад	Гадаадын ба гадаадын бус мөнгөний хөдөлгөөн нь урт хугацаатай эдийн засгийн харилцан ашиг сонирхол бий болгоход хүргэдэг
	Өөрийн оронд	
2.Хувьцааны хөрөнгө оруулалт	Экспорт /актив/	Үнэт цаас худалдаалах ба худалдан авахтай холбоотой мөнгөний хөдөлгөөн
	Импорт /пассив/	
3.Бусад хөрөнгө оруулалт	Экспорт /актив/	Банкны хадгаламж болон улс хоорондын зээлтэй холбоо бүхий мөнгөний хөдөлгөөн
	/Пассив/	
4.Нөөц актив	Алт	Төлбөрийн балансын алдагдлыг нөхөх зорилгоор гишүүн улсаас ашиглах боломжтой экспортын активтай холбоотой мөнгөний хөдөлгөөн
	Зээлжих тусгай эрх	
	ОУВС-гийн нөөцийн байдал	
	Гадаадын валют	

Мөнгөний хөдөлгөөн нь бүхэлдээ аль нэг бүлгийн хүрээнд дамжиж байдаг. Сүүлийн 10-аад жилд шууд хөрөнгө оруулалт ихээхэн ач холбогдолтой байсан бол 1990-ээд оноос хойш олон улсын мөнгөний хөдөлгөөний дотор хувьцааны хөрөнгө оруулалтын үүрэг ихээхэн өсчээ.

1993 оны байдлаар хувьцааны хөрөнгө оруулалтын 97 хувь ба шууд хөрөнгө оруулалтын 96 хувь нь өндөр хөгжилтэй орнуудад, нөгөөтэйгүүр шилжилтийн эдийн засагтай орнуудыг оролцуулан хөгжиж байгаа бүх орнуудад дээрх үзүүлэлт 4 ба 3 гэсэн харьцаатайгаар тус тус ногдож байна. Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээл эрчимтэй хөгжиж, хувьчлах үйл явц хурдассантай холбогдон олон улсын мөнгөний хөдөлгөөнд эдгээр орон тус бүрийн хувийн жин өсөх хандлагатай болж байна.

Хөрөнгө оруулалтын байдал /Investment Position/ гэдэг нь гадаадад оруулсан хөрөнгийн активтай орон ба тухайн оронд гадаадынхны эзэмшиж байгаа хөрөнгийн актив хоорондын харьцааг хэлнэ. Ийм активд хувьцааны болон шууд хөрөнгө оруулалт хамаарна. Улс орнуудын хооронд улсын, хувийн бизнес эрхлэх, зээлийн богино ба дунд, урт хугацаатай мөнгөний шилжилт хөдөлгөөн явагдаж байдаг.

2. ГАДААД ОРНУУД ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудал бүх улс орнуудад өөр өөр талаас авч үздэг бөгөөд өөрийн орны онцлогийг харгалзан зохицуулалт бүхий механизм ч өөр өөр байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн

зохицуулалт онцлог бүхий гадаадын элемент оролцсон хувийн эрх зүйн харилцааны хүрээгээр өргөн хэмжээнд ойлгоход ч олон улсын хувийн эрх зүйн хүрээнээс хол хальдаг, олон талтай асуудал юм. Улс орон бүр өөрийн эрх зүйн системийн онцлогоос хамаарч өөр өөр зохицуулалтыг хэрэглэдэг. Тухайн судалгааны ажилдаа дараах улс, орнуудын жишээг авч үзлээ.

1.Оросын Холбооны Улс

2.Казахстан Улс

3.АНУ

4.Япон

5.Европын Холбоо

6.БНХАУ

1. ОХУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

ОХУ-ын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт өөрийн гэсэн онцлогтой. Төр хөрөнгө оруулалтын харилцаанд, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд онцгой байр суурийг эзэлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон ашиглах асуудлуудыг төрөөс тогтоосон эрх зүйн актаар зохицуулна. Татварын тогтолцоо, хөнгөлт, чөлөөлөлтийн систем болон зээлийн аргаар гадаад хөрөнгө орулалтыг татах нэгэн хөшүүргийг бий болгодог. Гадаадын хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал, татварын тогтолцоо, эрх зүйн бусад холбогдолтой зохицуулалтыг улс орон бүхэн өөрийн улсын онцлогийг харгалзан өөр өөр шийдвэрлэдэг.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт тэр байтугай Оросын номлолд онцлог бүхий гадаадын элемент оролцсон хувийн эрх зүйн харилцааны хүрээгээр өргөн хэмжээнд ойлгоход ч олон улсын хувийн эрх зүйн хүрээнээс хол хальдаг. ОХУ-ын хувьд 1990 оны нийгэм, улс төрийн тогтворгүй байдал, эрх зүйн хувьд хангалтгүй зохицулалттай бөгөөд гэмт хэрэг дэлгэрэх шинжтэй байсан үед гадаадын хөрөнгө оруулагч нар ОХУ-д хөрөнгө оруулалт хийхээс эмээж байсан үе билээ. Сүүлийн жилүүдэд эрх зүйн шинэтгэл, төгөлдөржүүлэлт явагдаж, В.В. Путины улс төр, эдийн засгийн бодлого нь үр дүнгээ өгч улмаар гадаадын хөрөнгө оруулагч нарын анхаарлыг татах болсноор өнөө үед хөрөнгө оруулалтын салбар ихээхэн хөгжих болсон. Үүнд мэдээж хэрэг эрх зүйн уян хатан, тогтвортой зохицуулалт нөлөөлсөн буй за. ОХУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хуулиудыг дурдвал:

ОХУ-ын 1991 оны "Гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль"-иар гадаадын хөрөнгө оруулагч гэдэгт гадаад улсын хуулийн этгээд, гадаад улсын хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын байнга оршин суугч, олон улсын байгууллага болон гадаад улсын төрийг ойлгодог.

Хөрөнгө оруулалтын асуудлаарх ерөнхий хууль бол "ОХУ. дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг юм. Уг хууль нь 1999 онд батлагдаж, олон тооны нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хөрөнгө оруулагч нарт төрөөс

үзүүлэх гол баталгаанууд, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх журам, ОХУ дахь материаллаг болон санхүүгийн эх үүсвэр, дэвшилтэт техник, технологи, удирдахуйн ухааны туршлага, гадаадын хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг хангах, олон улсын эрх зүй болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны олон улсын практикийг хэм хэмжээнд үндэсний хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт зохицож байгаа эсэх асуудлуудыг зохицуулна.

ОХУ-ын дээрхи хуулинд гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх баталгаануудын талаар энэхүү хуулийн ихэнхи хэсэг буюу 5-17 дугаар зүйл дурджээ. Тухайлбал,

- 5 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээрх гадаадын хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалтын баталгаа
- 6 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг хэрэгжүүлэх эрхийн баталгаа
- 7 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүргээ өөр этгээдэд шилжүүлэх баталгаа
- 8 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагч эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн национализаци буюу реквизийн нөхөн олговор олгох баталгаа
- 9 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулагч эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд эерэг бусаар ОХУ-ын хууль тогтоомжинд өөрчлөлт орохоос сэргийлэх баталгаа
- 10 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт оруулах буюу аж ахуйн үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор үүсэх маргааныг зохих ёсоор шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх баталгаа
- 11 дүгээр зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр олсон орлого болон бусад хууль ёсоор олсон мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах буюу өөр улс руу шилжүүлэх баталгаа
- 12 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэрт анхлан гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэрээр зөөвөрлөн оруулсан эд хөрөнгө, баримт бичигт эсхүл цахим зөөврийн хэрэгсэлд агуулах мэдээлэлийг ОХУ-аас саадгүй зөөвөрлөх эрхийн баталгаа
- 13 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн үнэт цаас олж авах эрхийн баталгаа
- 14 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьчлалд оролцох эрх.
- 15 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчид газар талбай, бусад байгалийн баялаг, барилга байгууламж болон бусад үл хөдлөх эд хөрөнгө олж авах эрхийн баталгаа
- 16 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчид буюу гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх
- ОХУ-ын субъектууд буюу өөрөө удирдах орон нутгийн байгууллагуудын үзүүлэх хөнгөлөлт, баталгаа

Мөн 1999 оны уг хуулиар улс төрийн эрсдлээс хамгаалж гадаадын хөрөнгө оруулалтын олон улсын даатгалд хэрэглэдэг суброгацийн зарчим чухал ач холбогдолтой. Хөрөнгө оруулалтын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдад олгосон баталгааны /даатгалын гэрээ/ дагуу гадаадын хөрөнгө оруулагчийг төлөөлж гадаадын хөрөнгө оруулагчаас дурдсан хөрөнгө оруулалтын эрх нь шилжсэн бол тийм эрх шилжүүлэхийг ОХУ-д хууль ёсны гэж үзнэ.

Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд яригдах бусад асуудлууд болох шударга бус өрсөлдөөнийн асуудал, салбар, охин компани байгуулах үед тавигдах шаардлагын асуудал, гадаадын хөрөнгө оруулалтын хувьд улсаас явуулах бодлого боловсруулах буюу хэрэгжүүлэх асуудал, гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх гол байгууллага, түүний эрх үүрэг зэрэг асуудлуудыг тодорхойлжээ.

ОХУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг судлан авч үзэхэд, хөрөнгө оруулагч нарт төрөөс үзүүлэх баталгааны асуудлууд, гадаадын хөрөнгө оруулалт хийгдэж буй аж ахуйн нэгжийн төрлийн асуудлуудыг түлхүү авч үздэг байна. Олон хүн амтай, өргөн уудам нутаг дэвсгэртэй улсын хувьд ОХУ нь геологи, газар зүй, цаг агаар, байгалийн баялгийн онцлогуудаас хамаарч хот, суурин болгон хөрөнгө оруулалтыг татах "чадвар" нь янз бүр байдаг бөгөөд энэ онцлогийг харгалзаж хууль тогтоомжийн зохицуулалт хийнэ гэдэг хэцүү асуудал. Хэдий тийм ч хууль болон бусад хууль зүйн актуудын хүчээр гадаадын хөрөнгө оруулалтыг эрх зүйн уян хатан зохицуулалт бүхий таатай орчинд татаж байна.

2. БНСУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

Солонгосын гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой гол тулгуур хууль болох "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль": 1998 онд батлагдсан, 2009 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн: Foreign Investment Promotion Act, "KFIPA" хуулийг тус тус баталжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой Солонгосын хуулиуд нь Үндсэн хуулийг оролцуулаад 50 гаруй хууль байх бөгөөд, 2007 оны 4 дүгээр сард хэлэлцэн соёрхон батлуулахаар хүлээгдэж байгаа БНСУ-АНУ хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээр FTA-д Гадаадын хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөх хэсэг заалт байгаа учир Хөрөнгө оруулалтын тухай хуульд цаашид нэмэлт засвар, өөрчлөлт хийх шаардлагатай болох буй заа.

Олон улсын хөрөнгө оруулалт, ялангуяа Гадаадын шууд хөрөнгө оруулалт (FDI) ажлын байр, цалин хөлс нэмэгдүүлэх, технологийн шилжилт зэрэг арга замаар олон улсын эдийн засагт ихээхэн нөлөөлөх Гадаадын хөрөнгө оруулалт болон олон улсын гадаад худалдааны харилцан шүтэлцээ илэрхий биш ч хоорондоо салшгүй холбоотой зүйл гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч байгаа билээ. Энэ утгаараа аливаа улс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд олон төрлийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, олон улсын хэмжээнд ч нэлээд хуулийг баталж ирлээ. Олон улсын хэмжээнд

Олон талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр (MAI) үргэлжилсээр ирсэн хэдий ч 2003 онд Дэлхийн Худалдааны Байгууллага (WTO) нь Канкуны Сайд нарын уулзалтаас хэлэлцээрийг зогсоохоор шийдвэрлэж олон талт хөрөнгө оруулалтын тогтолцоо бүрэлдээгүй ийм нөхцөл байдлын дунд Хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр (BIT) ч явцгүй болсон. Хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр нь хамрах хүрээ, агуулгын хувьд ихээхэн ялгаатай ч голдуу хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө санхүүгийн шилжилт, шууд төлбөрийг чөлөөтэй болгох, ялгаварлахгүй байх, зарим хориг гэх мэтчилэн хөрөнгө оруулалтыг оруулсны дараах асуудлыг ерөнхийдөө зохицуулсан агуулгатай байдаг. Зарим нэг BIT нь цаашлаад үүсгэн байгуулах (establishment) болон эзэмших (acquisition) зэрэг хөрөнгө оруулалт оруулахаас өмнөх асуудлыг ч хамруулсан байдаг нь хөрөнгө оруулалтыг хүлээн авах, нөхөн төлбөр зэрэг асуудлын эрх зүйн үндэслэлийг тавьж өгдөг учир хөрөнгө оруулалтыг хамгаалах гэсэн утга агуулга илэрхий байдаг.

Солонгосын "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай" хууль ч дээр өгүүлсэнтэй адил олон улсын хандлагыг тусгасан байдаг учир олон улсын гэрээ хэлэлцээрийн ерөнхий зааltыг оруулж, түүнд нийцэх Солонгосын холбогдох хууль журам, тогтолцооны талаар тайлбарлах нь энэхүү илтгэлийн агуулгыг илүү ойлгомжтой болгоно.

Хөрөнгө оруулалтын талаарх олон улсын гэрээ хэлэлцээрийг томоохон 5 салбарт ангилж үзэж болно.

(1)Хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолт(definitions): Илүү үр өгөөжтэй байх хууль эрх зүйн тогтолцоотой болохын тулд сүүлийн үеийн олон улсын гэрээ хэлэлцээрт дэлгэрэнгүй заалтыг оруулахын өмнө хэрэглэж байгаа нэр томъёог тодорхойлж буй хэсгийг оруулдаг болсон. Ялангуяа НАФТА болон 2007 онд хэлэлцэн баталсан БНСУ-АНУ хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээр FTA зэрэгт нийтлэг харагддаг. Тодорхойлж буй нэр томъёогоо дагаад хамрах хүрээ нь өөр өөр байх тул холбогдох хөрөнгө оруулалтын тогтолцоог бүхэлд нь ойлгоход дөхөм чухал элемент нь болж байдаг. Солонгосын "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль"д дээрхи нэр томъёоны тодорхойлолт 2 дугаар бүлэгт тусгагдсан байдаг. Гэхдээ улс тус бүрээр хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр BIT-д харилцан тохиролцсон нэр томъёог хэрэглэх бөгөөд тухайн улс хоорондын тодорхой харилцааны явцад нэр томъёо өөр байх боломжтой юм. "Солонгосын Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 6-д энэхүү тохиолдлыг урьдчилан харж тусгасан байдаг ба дэлгэрэнгүй агуулга нь: Энэхүү хууль нь БНСУ-ын нэгдэн орсон, баталсан олон улсын гэрээ хэлэлцээрийн агуулгыг засварлах эсвэл хязгаарлах байдлаар тайлбарлахгүй" гэж тусгажээ.

(2)Хөрөнгө оруулалтыг татах (investment promotion): Хоорондын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх болон хөхиүлэн дэмжихтэй холбоотой арга зам, мэдээлэл солилцох, дүрэм журмын хувьд харилцан туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тодорхой аргууд болон техникийн туслалцаа зэргийн талаар өгүүлсэн байдаг. Солонгосын

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль”-ийн 9-17 дугаар зүйлүүдэд үүнийг тусган заасан байдаг.

“9 дүгээр зүйл Гадаадын хөрөнгө оруулалтын талаарх татварын хөнгөлөлт үзүүлэх тухай” заалтаар гадаадын хөрөнгө оруулагч “Татварын тусгай хөнгөлөлт эдлэхийг хязгаарлах тухай” хуулийн дагуу ААН-ийн албан татвар, Орлогын албан татвар, Эзэмшлийн татвар, Бүртгэлийн хураамж, Хөрөнгийн хураамж болон Газрын нэгдсэн татвар зэргээс хөнгөлөлт эдэлж болдог.

“14 дүгээр зүйл Орон нутгийн захиргаанаас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухайд: 1. Төр орон нутгийн засаг захиргаа 18 дугаар зүйлд заасны дагуу гадаадын хөрөнгө оруулагч объект газраа олох, гадаадын хөрөнгө оруулалттай ААН түрээслэх газрын түрээс, худалдааны хүү, газрын түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, байр худалдан авах үнийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудал дээр Еөрнхийлөгчийн зарлигт заасан холбогдох этгээд өөрийн эзэмшлийн газрыг түрээсээ бууруулан түрээслэсэн эсвэл хөрөнгө оруулагч объект худалдан авахдаа хямдруулсан үнээр худалдан авсан бол тэрхүү зөрүү үнэ, өртгийг орон нутгийн захиргаанаас нөхөн олгох тухай тусгасан байна. Боловсрол, сургалтыг дэмжих тэтгэлэг зэрэг төрөл бүрийн тэтгэмж олгох бусад Гадаадын хөрөнгө оруулалтыг татан нэмэгдүүлэхтэй холбоотой зардлын санхүүжилтийг хүсэх тохиолдолд хамгийн их боломжтой хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй” гэж заасан байна.

“14 дүгээр зүйлийн 2-т Гадаадын хөрөнгө оруулалтад бэлэн мөнгөөр дэмжлэг үзүүлэх нь: 1. Төр болон орон нутгийн удирдлага гадаадын хөрөнгө оруулагч дараахь аль нэгэн заалтын болзлыг хангаж хөрөнгө оруулалт хийж байвал уг хөрөнгө оруулагч өндөр технологи оруулж ирж байгаа эсэх, технологи шилжилтийн үр дүн, ач холбогдол, ажлын байр шинээр бий болгох цар хүрээ, дотоодын хөрөнгө оруулалттай давхцаж байгаа эсэх, тухайн байршлын зохимжтой эсэх зэргийг харгалзан уг хөрөнгө оруулагчид үйлдвэрийн газар шинээр барих гэх мэт Ерөнхийлөгчийн зарлигт заасан зориулалтаар ашиглаж байгаа хөрөнгийг бэлэн мөнгөөр дэмжиж болно” гэж заасан байна.

“14 дүгээр зүйлийн 3-т Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих урамшуулал: 1. Орон нутгийн удирдлага нь Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад ихээхэн хувь нэмэр оруулсан этгээдийн гавьяа зүтгэлийг нь үнэлж тухайн хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч урамшуулал олгож болно.”

“15 дугаар зүйлд Гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих төв байгуулах: 1. Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, танилцуулга, сурталчилгаа болон судалгаа хийх, өргөдөл гомдол хүлээн авах, шинээр ААН байгуулахад сургалт зохион явуулах болон эдгээрээс гадна гадаадын хөрөнгө оруулагч хувь хүн болон ААН-д дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг нэгдсэн журмаар явуулах зорилгоор БНСУ-ын Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих корпораци КОТРА-д Гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих төв байгуулна”

“15 дугаар бүлгийн 2-т Гадаадын хөрөнгө оруулагчийн зөвлөх:1.

Гадаадын хөрөнгө оруулагч ААН-ийн бэрхшээлтэй асуудлыг зохицуулан, туслах зорилгоор хөрөнгө оруулалтын асуудлаар мэргэшсэн, арвин туршлагатай хүнийг Гадаадын хөрөнгө оруулагчийн зөвлөхөөр ажиллуулж болно."

"16 дугаар зүйл Гадаадын хөрөнгө оруулагчийг туслан дэмжих газар: 1. Гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой зөвшөөрөл олгох, лиценз , бүртгэл хийлгэх, санал оруулах, зөвлөлдөх гэх мэт санал хүсэлттэй холбоотой ажлыг саадгүй явуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бий болгон гадаадын хөрөнгө оруулагчид үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулах бололцоо олгохоор төв захиргааны байгууллага, хот, муж, дүүрэг сумын гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн хэлтсийг Гадаадын хөрөнгө оруулагчийн туслан дэмжих газар болгон өргөтгөх буюу шинээр байгуулж ажиллаж болно."

"17 дугаар зүйл Гадаадын хөрөнгө оруулагчийн зөвшөөрөл олгох асуудлаар өргөдөл гомдол барагдуулах тусгай журам"

(3)Хөрөнгө оруулалтыг хамгаалах (investment protection): Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг чөлөөтэй захиран зарцуулах, гадаадад мөнгөн гуйвуулга хийх , хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, нөхөн төлбөр зэрэг асуудлаар маргаан үүссэн тохиолдолд зохицуулах заалт юм. БНСУ "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай" хуулийн 3-4 дүгээр зүйлийн 2 заалтад тусгасан байдаг бөгөөд нөхөн төлбөртэй холбоотой маргааныг шийдэхдээ улс тус бүрээр хийсэн хоёр талын гэрээ хэлэлцээрт тулгуурлан зохицуулдаг. Үүний агуулгыг товч танилцуулбал:

"3 дугаар зүйл Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай:

- Гадаадын хөрөнгө оруулагчийн худалдан авсан хувьцаанаас гарсан алдагдал, хувьцаа зэргийг худалдаалсан хөрөнгө, 2 дугаар зүйлийн 1-4-т заасан Зээлийн гэрээнд үндэслэн олгосон үндсэн төлбөр болон шимтгэл хураамж, техник технологи оруулах гэрээний дагуу хийсэн төлбөрийн хувьд мөнгөн гуйвуулга хийх тухайн үед гадаадын хөрөнгө оруулагч болон импортлогч хоорондын гэрээний агуулга, мэдэгдлийн хуудаст үндэслэн тухайн мөнгө гуйвуулсан шилжүүлэгт батлан даалт хийнэ.
- Гадаадын хөрөнгө оруулагч хувь хүн болон ААН хуульд тусгайлан заасан тохиолдлоос бусад тохиолдолд БНСУ-ын иргэн болоод ААН-тэй адил хууль журмыг дагаж мөрдөнө.
- БНСУ-ын иргэн, ААН-д ногдуулдаг албан татварын хуулиуд дотроос хөнгөлөлт үзүүлэх тухай хууль журамд тусгайлан заасан хуулийн заалт, болзлыг хангаснаас бусад тохиолдолд Гадаадын иргэн, ААН 2 дугаар зүйлийн 1-4т заасны дагуу зээлийн эзэн болоод 25 дугаар зүйлд заасан техник технологи импортлогчтой адил эрх үүрэгтэй."

"4 дүгээр зүйлийн 2-т Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого боловсруулах: 1. Мэдлэг, эдийн засгийн яамны сайд Гадаадын хөрөнгө оруулалтыг татан хөхиүлэн дэмжихийн тулд жил бүр 27 дугаар зүйлд заасны дагуу Гадаадын хөрөнгө оруулалтын хорооны хуралдааныг зохион явуулж, уг хурлаас хэлэлцэн Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг



боловсруулж гаргах ёстой."

(4)Хөрөнгө оруулалт хийгдэхээс өмнөх зохицуулалт (pre-admission provisions): Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан зах зээлийн судалгаа хийх зорилгоор хөрөнгө оруулалт хийх улс орон, тухайн салбарт нэвтрэн орон, шинээр компани үүсгэн байгуулахтай холбоотой Гадаадын хөрөнгө оруулагчийн эрхийг тусган оруулсан заалт юм. Энэ хэсэгт ДХБ (WTO) болон Чөлөөт худалдааны хэлэлцээр (FTA) зэрэгт тухайн улс бүрээр эсвэл ДХБ (WTO)-ын харилцан зөвшөөрсөн (commitments) агуулгын дагуу ялгаатай байх ба "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль"-д тусган оруулаагүй байдаг

(5)Хөрөнгө оруулалт хийсний дараах зохицуулалт (post-admission provisions):

Хөрөнгө оруулалт хийх улсаа сонгон нэгэнт тухайн оронд очин суурьшиж буй Гадаадын хөрөнгө оруулагчийг хамгаалах тухай заалт бөгөөд дотоодын хөрөнгө оруулагчтай харьцуулахад зохисгүй хандлагыг хориглох, дотоодын иргэнтэй ялгаварлан гадуурхахгүй байх асуудлыг зохицуулж байдаг. БНСУ-ын "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 2-т заасан 2. Гадаадын хөрөнгө оруулагч хувь хүн болон ААН хуульд онцгойлон зааснаас бусад тохиолдолд тухайн бизнесийн үйл ажиллагаг эрхлэн явуулахдаа БНСУ-ын иргэн, ААН-тэй адилхан эрх үүрэгтэй зохицуулагдана." гэжээ.

3. Казакстан Улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

Казакстан Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ өөрийн орны хөрөнгө оруулалтыг дэмжин эдийн засаг, эрх зүйн бодлогоо хэрэгжүүлдэг улс юм. Казак, Орос, Уйгар, Узбек зэрэг олон үндэстнүүдийн нэгдэл болсон уг улс нь нутаг дэвсгэрийн харьцаа, байгалийн баялаг, эрх зүйн тогтвортой орчин зэрэг нөхцөлүүдээрээ гадны хөрөнгө оруулагч нарыг багагүй татдаг.

1990 оны 12 дугаар сарын 7-нд Казакстан Улс "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хууль баталж, нэмэлт өөрчлөлт оруулсан.

Тус хуулийн дагуу хөрөнгө оруулалт гэдэг нь хуулийн этгээдийн дүрмийн сан, эсхүл үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах тогтсон активыг нэмэгдүүлэх зорилгоор оруулж буй бүх төрлийн /хувийн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүнээс бусад нь/ хөрөнгийг, үүнд лизингийн гэрээ байгуулсан үеэс эхлэн санхүүгийн лизингийн зүйл болон эдгээр бүх хөрөнгөд хамаарах эрхийг хэлнэ хэмээн тусгажээ.

Мөн хөрөнгө оруулалтын переференц гэсэн ойлголт байх бөгөөд үүнд Казакстан Улсад хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй хуулийн этгээдэд Казакстан Улсын хууль тогтоомжоор ойлгож буй хөнгөлөлтийг олгоно. Гадаадын хөрөнгө оруулагчдийн хувьд хориг, хязгаар байхгүй, аливаа хөрөнгө оруулагч нь хуульд тавьсан зарим шаардлагуудыг хангаснаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх боломжтой бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагаар тодорхой төрлийн

үйл ажиллагаа болон нутаг дэвсгэрийн хувьд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хязгаарлах буюу хориглож болно.

Мөн гадаадын хөрөнгө оруулагчид эрх зүйн баталгааг дээрхи хуулийн 4-5 дугаар зүйлээрээ олгодог. Төрийн байгууллагын зүгээс Казакстан Улсын хуультай харьшилдах эрх зүйн акт шинээр гаргасан, эсхүл тийм байгууллагын албан тушаалтан хууль бус үйлдэл хийснээс хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд Казақстан улсын Иргэний хуулиар зохицуулсаны дагуу хохирлоо барагдуулна гэсэн заалт байна.

Тогтвортой байдлын баталгаа хэмээн ойлголт үүсэж байгаа бөгөөд энэ нь хөрөнгө оруулагч, төрийн байгууллагын хооронд хийсэн гэрээний, талуудын харилцан тохиролцож хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс бусад нөхцлийг уг баталгаагаар хангаж өгнө.

Дээрхи баталгаа нь дараах тохиолдолд үйлчилнэ. Үүнд,

- Онцгой албан татварт барааны импорт, үйлдвэрлэл, борлуулах журам болон нөхцлийг өөрчилж байдаг Казакстан Улсын хууль тогтоомж өөрчлөгдсөн. Казакстан Улсын олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон ба өөрчлөгдсөн бол
- Үндэсний болон байгаль орчны аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс Казакстан улсын хууль тогтоомжид нэмэлт өөрлөлт хийж буй бол үйлчилнэ.

Казакстан Улсын хуульд мөн төрийн дайчилгаа болон нийгэмчлэлээс хөрөнгө оруулагчдын эрхийн баталгааны асуудал, хөрөнгө оруулагчдын хувьд төрийн байгууллагуудын нээлттэй байдал, мэдээллийн хүртээмжийг хангах зэрэг асуудлууд тусгагдсан.

Дээр яригдсан переференцийн ойлголт 13 дугаар зүйлд яригдаж байна. Хуулиар эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулснаар дараах хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг эдэлнэ:

- Татварын
- Гаалийн татвараас чөлөөлөх
- Төрийн натур грант.

Хөрөнгө оруулалтын преференцийг буюу хөнгөлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн ангилагчийн ангилалын түвшинд Засгийн газраас баталдаг жагсаалтаар тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд олгоно. Преференц буюу хөрөнгө оруулалтын хөнгөлөлтөд дараах шалгууруар орно. Үүнд:

- Хөрөнгө оруулалт нь тэргүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтын жагсаалтанд орсон
- Шинэ үйлдвэрлэл байгуулах, хуучныг шинэ технологи нэвтрүүлэн өргөтгөх, шинэчлэх зорилгоор Казакстан Улсын хуулийн этгээд тогтсон активд хөрөнгө оруулалт хийж буй бол
- Казакстан Улсын хуулийн этгээдийн санхүү, техник, зохион байгуулалтын боломжийг нотолсон, улсын бүртгэлд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлсэн тохиолдолд.

Харин татварын хөнгөлөлтийн хувьд ашигт малтмалын чиглэлээр



явуулж буй хөрөнгө оруулалтанд татварын хөнгөлөлт үзүүлэхгүй хэмээн заажээ.

Гаалийн татварын хувьд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүний бусад эд ангийг хилээр нэвтрүүлэхэд хөнгөлөлт үзүүлж, гэрээ байгуулснаас хойш 5 жилийн дотор хүчинтэй байна.

Төрийн натур грант /хөрөнгө оруулалтын төслийн урамшуулал/ гэдэг нь Казакстан Улсад хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй Казакстан Улсын хуулийн этгээдэд түүний өмчлөлд, эсхүл зэмшилд төлбөргүйгээр шилжих нөхцөлтэйгээр Казакстан Улсын өмчлөлд буй хөрөнгийг түр хугацаагаар төлбөргүйгээр, эсхүл тийм эрхтэйгээр шилжүүлэх хөрөнгийг хэлнэ хэмээн заажээ.

Мөн хуулиар переференци буюу хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргах, тус хүсэлтэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хөнгөлөлтийн асуудлыг хэлэлцэх журам, хугацаа, гэрээ байгуулах талаар тус тус зохицуулжээ.

4. АНУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

АНУ нь өөрийн нутаг дэвсгэрийн онцлогоос хамаарч хөрөнгө оруулалтыг дэмждэг бөгөөд үүнд шууд хөрөнгө оруулалт болон портфелийн хөрөнгө оруулалтыг дэмждэг байна. Энэ байр суурь нь бусад орныг бодвол хязгаарлалт харьцангуй бага тогтоодгоос харагдаж байна.

Гадаадын иргэд АНУ-ын нутаг дэвсгэр дээр холбооны, төрийн болон орон нутгийн байгууллагуудын онцгой хязгаарлалт буюу хориггүйгээр өөрийн салбар, нэгжээ нээдэг. Доор яригдах зарим нэг улс орнуудын хувьд болон бизнесийн үйл ажиллагааны төвшингээс хамаарч л тодорхой хязгаарууды тогтоодог.

АНУ-ын гадаадын хөрөнгө оруулагч нар АНУ-ын иргэдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

- АНУ-д компани байгуулахын тулд санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн дээд байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авах шаардлагагүй
- Гадаад валютын хяналт үгүй
- Гадаадын хөрөнгө оруулагч нар АНУ-ын хуулийн этгээдүүдэд хөрөнгө оруулалт оруулах бүрэн эрхтэй
- АНУ-ын хуулийн этгээдүүдтэй хамтын ажиллагааны үр дүнд олсон орлого хувь хэмжээг хоорондоо тохиролцсоны үндсэн дээр чөлөөтэй хуваарилана. АНУ-ын татварын албанд л мэдэгдэх үүргийг хүлээнэ. Технологи шилжүүлэх гэрээг бүртгүүлэх шаардлагагүй.
- АНУ дахь гадаадын хөрөнгө оруулагч АНУ-д олсон орлогоо АНУ-ын хилээр чөлөөтэй гаргах, шилжүүлэх эрхтэй.

АНУ-д гадаадын хөрөнгө оруулагч нарыг улсын бүртгэлд бүртгэх нэгдсэн систем үгүй бөгөөд муж бүр өөрсдийн хуулиар зохицуулна.

Гадаадын хөрөнгө оруулагч нарт холбооны, төрийн болон орон нутгийн хөгжлийн стратеги бүхий төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах эрхтэй. Холбооны төвшинд эдгээр төслүүдийн ихэнхи нь АНУ-ын эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн. Тухайлбал, АНУ-ын Экспорт-импортын банкны төслүүд, хувийн гадаад хөрөнгө оруулалтын Корпораци, олон улсын хөгжлийн Агентлаг зэрэг байгууллагуудын төслүүд юм. Холбооны гадаадын хөрөнгө оруулагч нарт зориулсан татварын тусгай хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй.

Гэвч зарим мужуудын засаг захиргаа өөрийн мужийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого явуулж, татварын уян хатан систем санал болгодог. Энэ уян хатан байдал нь татварын зарим нэг хөнгөлөлтүүд, шууд зээл, эдийн засгийн хувьд зогсонгуй салбарт хөрөнгө оруулалт хийхэд зээлийн баталгаа өгөх зэргээр илэрдэг.

1. Зарим салбар дахь хязгаарлалтууд

Холбооны хуулиар зарим салбар дахь гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааны түвшинг хязгаарлдаг. Тухайлбал, радио-, телевизийн нэвтрүүлгийн байгууллага, дотоодын агаарын болон усан тээвэрлэлт болон загас агнах зэрэг салбарт. Мөн зарим өндөр хөгжилтэй салбаруудад тухайлбал, банкны үйл ажиллагаа, даатгал, электроэнерги болон газ, харилцаа, холбоо зэрэг салбарт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд илүү өндөр шаардлага тавьж, хяналттай байдаг.

2. Үл хөдлөх хөрөнгийн асуудал

Хөдөө, аж ахуйн өндөр хөгжилтэй 30 гаруй мужуудын хуулиар гадаадын хөрөнгө оруулагчийн газар эзэмших эрх болон өв залгамжлах эрхийг хязгаарладаг. Эдгээр хуулиудын зарим нь хөдөө, аж ахуйн салбар дахь хөрөнгө оруулалтын хувьд тусгайлан зохицуулалт агуулсан байдаг.

3. АНУ-ын Үндэсний ауюлгүй байдлын үзэл бариmтлал

Холбооны "Exon-Florio" хуулиар АНУ-ын Ерөнхийлөгч нь үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй хэмээн үзвэл гадны хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтыг зогсоох эрхтэй. АНУ-ын Сангийн Яамны харъяа Гадаадын хөрөнгө оруулалтыг хариуцсан салбар дундын комисс нь /CFIUS/ нь дээрхи хөрөнгө оруулалтын асуудлыг мөрдөн шалгаж, цаашдын арга хэмжээг тодорхойлдог.

"Exon-Florio" хуульд "үндэсний аюулгүй байдал" гэсэн нэр томъёо байхгүй ч, үүнийг илэрхийлсэн дараах ойлголтуудыг багтаажээ:

- Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүний зөвхөн дотоодын үйлдвэрээр, дотооддоо үйлдвэрлэх;
- Үндэсний аюулгүй байдлыг хангахуйц хүний нөөц, бүтээгдэхүүн, технологи, материал болон бусад бараа үйлчилгээ үйлдвэрлэх дотоодын үйлдвэрийн боломж, бололцоо бууруулах хөрөнгө оруулалтыг хязгаарлах;
- Дээрхи дотоодын үйлдвэрүүдийг гадаадын этгээд эзэмших, хувь эзэмших явдлыг хянах;
- Терроризмыг дэмжих буй улсуудад борлуулахаар үйлдвэрлэгдсэн цэргийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

- Үндэсний аюулгүй байдлыг хөндөхүйц технологийн салбар дахь гэрээний үр дагавар.

4. USA PATRIOT хууль

2001 оны 10 дугаар сард USA PATRIOT Act буюу АНУ-ын Эх оронч хууль хэмээх хуулийг "Америкийг бэхжүүлэх болон нэгттэх замаар Террорист үйл ажиллагааг зогсоох буюу арилгахад чиглэгдсэн механизм бий болгох" уриан доор баталсан байна. Уг хуулиар зарим хууль хамгаалах байгууллагуудын эрх хэмжээний хүрээг тэлж, террорист үйл ажиллагааны хувьд эрүүгийн хариуцлагын хэмжээг тогтоожээ. Үүнээс гадна уг хуулиар "мөнгө угаах" гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр боловсруулах тухай, мөн санхүүгийн болон улсын бүртгэлийн байгууллагын гадаадын иргэдийн бүртгэлийн хувьд илүү нарийн хяналт, шалгалтыг явуулж байх үүргийг оноожээ. Үүний үр дүнд гадаадын хуулийн этгээдүүд санхүүгийн үйл ажиллагаанд оролцохдоо үндэсний аюулгүй байдалд нөлөөхүйц шалгууруудыг давахын тулд илүү дэлгэрэнгүй мэдээллийг өргөн барих үүрэг хүлээнэ.

2002 оны 11 сард АНУ-д Үндэсний ауюлгүй байдлын хороо байгуулагдаж, нэн тэргүүний зорилгоороо террорист үйл ажиллагааг зогсооход чиглэгдсэн үйл ажиллагаа эрхэлдэг байна. Үүнээс гадна, уг хороо нь АНУ-ын гадаадын иргэн, цагаачлалын албатай харилцан ажилладаг бөгөөд USA PATRIOT Act болон "Exon-Florio" хуулийн хэрэгжилтийг хангана.

5. Харилцан хамаарал

АНУ-ын зарим мужуудын хуулиар өөрийн орны нутаг дэвсгэр дээр эрх тэгш хүлээн зөвшөөрсөн орнуудын гадаадын хөрөнгө оруулагч нарыг дэмжих бодлого баримталдаг.

6. Зарим орнуудын бүртгэлийн асуудал

Зарим улс орнуудын гадаадын хөрөнгө оруулагч АНУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхлэхийн тулд АНУ-ын санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээнэ. Одоогийн байдлаар энэ орнуудын жагсаалтад Куба, Иран, Ирак, Ливия, Хойд Солонгос болон Судан байна. Уг жагсаалт заримдаа өөрчлөгддөг бөгөөд улс орнуудаас гадна террорист үйл ажиллагаатай ямар нэгэн байдлаар холбоотой байж болзошгүй хуулийн этгээдүүдийн хувьд ч дээрхи байдлаар бүртгүүлэх шаардлага бий болно.

7. Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд АНУ-д шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах эсхүл 10% буюу түүнээс дээш хувийг гадны хөрөнгө оруулагч эзэмшдэг хуулийн этгээд байгуулна. BE-13 хэмээх загварын дагуу барим бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн хяналт, шалгалтын хороонд өргөн барьж, 45 хоногийн дотор уг асуудал шийдэгдэнэ. Мөн гадаадын хөрөнгө оруулагч нь BE-15 загварын дагуу жил бүр тайлан гаргаж өгөх үүргийг хүлээдэг.

8. Портфелийн хөрөнгө оруулалт

Санхүүгийн тайлангуудыг хянан үзэж АНУ-ын Сангийн яам удаан хугацааны хөрөнгө оруулалтын мониторингийн асуудлыг шийддэг. Ийнхүү портфелийн хөрөнгө оруулагч нарын хувьд S загвараар санхүүгийн тайлан гаргаж, АНУ-ын Сангийн яаманд өргөн барих үүргийг хүлээнэ.

9. Хөдөө аж ахуйн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт

Хөдөө аж ахуйн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын хувьд 1972 онд батлагдсан "Хөдөө аж ахуйн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-иар энэ асуудлыг зохицуулна. Энэ хуулиар уг хуулийн этгээдүүдийн эрх, үүргийн асуудал тусгагдахаас гадна хөдөө, аж ахуйг хөгжүүлэхэд гадны хөрөнгө оруулагч нарын гүйцэтгэх үүргийн талаар зохицуулсан байна.

Дээрхи АНУ-ын эрх зүйн зохицуулалтаас харахад нэг талаас гадаадын хөрөнгө оруулагч нарт бусад орныг бодвол илүү эрх чөлөө олгож байгаа, нөгөө талаас үндэсний аюулгүй байдлын үүднээс зарим нэг хязгаарлалтуудыг хуульчилж өгсөн нь зөв зохицуулалт хэмээн үзэж байна.

5. БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

Аливаа улсад гадаадын хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй байдаг. Ялангуяа хөгжиж буй орнуудад эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Харин хөгжингүй улс орнуудын хувьд хөрөнгө оруулалтын ханглаттай дотоод эх үүсвэртэй байдаг.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх нь шууд болон дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлнэ гэж макро эдийн засгийн хувьд үздэг байна.

БНХАУ хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг бий болгон ашигласан нь үсрэнгүй хөгжлийн хөшүүрэг болж байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдүүлж, хуулийг уян хатан заалттай болгож, хөрөнгө оруулалтын төрлүүдийг нарийн зааглаасан. Тухайлбал, төвийн хөрөнгө оруулалт, нийгмийн буюу хувь хүмүүсийн, бусад муж орны, гадаадын, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт гэж задлаж, хувь хэмжээ, татварыг ялгаатай хуульчилжээ.

Сүүлийн 5 жилд гадаадын хөрөнгө оруулалт 527 сая 900 мянган ам. долларт хүрчээ. Гадаадад нээлттэй байх бодлого баримтлан, гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалтыг элдэв төрлийн татвараас чөлөөлж, "Хойд хэсгээсээ эхлэн нээнэ, хойд хэсгээрээ оруулна, хойд хэсгээрээ гаргана" гэсэн чиглэл баримталан ажилласан байна.

2008 онд нийгмийн үл хөдлөх хөрөнгөд 559 тэрбум 645 сая, хүнд аж үйлдвэрийн салбарт 25 тэрбум 150 сая, хөнгөн аж үйлдвэрт 291 тэрбум 690 сая, худалдаа үйлчилгээний салбарт 242 тэрбум 805 сая, орон сууц байрихад 73 тэрбум 608 сая, *аж ахуйн нэгжид 331 тэрбум 614 сая юанийн хөрөнгө оруулалт* хийсэн байна.



Эрх зүйн зохицуулалт:

Хятад Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг "БНХАУ-ын Хятад болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай" хууль, "БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай" хууль, "БНХАУ-ын Хятадын болон гадаадын хамтарсан аж ахуйн нэгжийн тухай" зэрэг хуулиар зохицуулсан байдаг байна.

1986 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр VI хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны IV хуралдаанаас батлагдсан "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай" хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу "*Хятад Улсын холбогдох хууль цаазын дагуу Хятад Улсын дотор байгуулсан бүх хөрөнгийг нь 100 хувь гадаадын бэл оруулагчаас оруулсан аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулагч дангаараа байгуулсан гадаадын оруулалттай аж ахуйн нэгж гэнэ.*"[284]

Мөн 1979 оны 7 дугаар сарын 1-ний өдөр V хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны II хуралдаанаас батлагдсан "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хятад болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай" хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу "*...гадаад улсын хөрөнгө оруулалтын хэмжээ 25-аас доошгүй байна.*" [285] гэж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг тодорхойлсон байна.

Гадаадын хөрөнгө оруулагч бэлэн мөнгө, эд хөрөнгө, аж үйлдвэрийн өмчийн эрх зэргээр хөрөнгө оруулалт хийж болдог юм байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зөвшөөрөл олгох асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын хэлэлцээр, гэрээ, дүрмийг 3 сарын хугацаанд хянан шалгана.

Хөрөнгө оруулалт нь Хятад улсын хэрэгцээнд нийцэх тэргүүний техник, технологи байх шаардлагыг гадаадын хөрөнгө оруулагчдад тавьдаг.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид БНХАУ-ын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулна. Ашиг орлогоороо Хятад Улсын дотор дахин хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд татварын буцаан олголт хийж болдог байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжүүлэгчид үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бусад хууль тогтоомжоор зохицуулж болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүтэгдэхүүнээ хилийн чанадад худалдан борлуулахыг улсаас хөхиүлэн дэмждэг бөгөөд төлөөлөгчийн газар байгуулж болно. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг хугацаатай ба хугацаагүй байгуулж болно. Хэрэв хугацаатай байгуулсан тохиолдолд хугацаа дуусахаас 6 сарын өмнө холбогдох төрийн захиргааны байгууллагад хугацааг сунгуулах хүсэлт гаргана. Энэхүү хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлэн 1 сарын дотор хянан хэлэлцэнэ.

[284] Ц.Баасанжав, Ч.Энхтуяа. Өрнөн хөгжиж буй Өвөрмонгол. Хөх хот., 2009 он.
[285] Ц.Түвшинзаяа. БНХАУ-ын хуулийн эмхтгэл. УБ., 2008 он

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь Хятад Улсын хууль тогтоомжийн дагуу дотоодын даатгалын байгууллагад даатгуулна.

БНХАУ-ын татварын тухай хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь татвар төлсний дараа ашиг орлогоо гуйвуулж болох бөгөөд гадаад гуйвуулгын данстай байж болно.

Гадаадын хөрөнгө оруулагч болон хятадын хөрөнгө оруулагчийн хооронд, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч болон Хятадын хуулийн этгээд, хувь хүний хооронд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг арбитраар, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Хятад Улсын шүүх шийдвэрлэнэ.

Монгол Улс нь Хятад улсын хойд хөрш болохын хувьд Хятадын гадаад дахь шууд хөрөнгө оруулалтын чухал газар болоод байна.

1990 оноос хойш Хятад нь Монгол Улсын хамгийн том хөрөнгө оруулагч улс болсон байна. Өөрөөр хэлбэл 1990 оноос 2009 оны III улирал хүртэл БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалттай компани нийт *4868 бүртгэгдсэн буюу 2,282,090.30 ам.долларын* хөрөнгө оруулсан нь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын *61.02 хувийг* эзэлж байна.

ГАДААД УЛСУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГООС ХАМААРЧ ӨӨРИЙН ОРНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Судалгааны ажлын хүрээнд бусад улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын судалгаа явуулж, гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтын судалгаан дээр үндэслэн тэдгээрийг үндэсний эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэхийг эрмэлзэв.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудал бүх улс орнуудад өөр өөр талаас авч үздэг бөгөөд өөрийн орны онцлогийг харгалзсан зохицуулалт бүхий механизм ч өөр өөр байдаг. ОХУ-ын хувьд ч гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт өөрийн гэсэн онцлогтой. Тэр хөрөнгө оруулалтын харилцаанд, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд онцгой байр суурийг эзэлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон ашиглах асуудлуудыг төрөөс тогтоосон эрх зүйн актаар зохицуулна. Татварын тогтолцоо, хөнгөлөлт, чөлөөлөлтийн систем болон зээлийн аргаар төр гадаад хөрөнгө оруулалтыг татах нэгэн хөшүүргийг бий болгодог. Гадаадын хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал, татварын тогтолцоо, эрх зүйн бусад холбогдолтой зохицуулалтыг улс орон бүхэн өөрийн улсын онцлогийг харгалзан өөр өөрөөр шийдвэрлэдэг.

Уг судалгааны тайланд манай ойрын хөрш болох Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, мөн Казакстан Улс, Бүгд Найрамдах Солонгос улс, АНУ зэрэг улсуудыг авч үзсэн. Мөн судалгааны ажлын хүрээнд "Гадаадын хөрөнгө оруулалт" /эрх зүйн асуудал/ номыг бэлтгэсэн



бөгөөд уг номын 9 дүгээр бүлэгт гадаад улсуудын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын талаар улс тус бүрээр дэлгэрэнгүй бичсэн.

Гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд дараах давуу болон дутагдалтай тал ажиглагдлаа. Үүнд:

1. 1991 оны Гадаадын хөрөнгө оруулалтын тухай ОХУ-ын хуульд эрх зүйн баталгааны асуудал нэлээдгүй хөндөгджээ. Тухайлбал, *5 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээрхи гадаадын хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалтын баталгаа; 6 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг хэрэгжүүлэх эрхийн баталгаа; 7 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүргээ өөр этгээдэд шилжүүлэх баталгаа; 8 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагч эсүүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн национализаци буюу реквизийн нөхөн олговор олгох баталгаа; 9 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулагч эсүүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд эерэг бусаар ОХУ-ын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах баталгаа; 10 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт оруулах буюу аж ахуйн үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор үүсэх маргааныг зохих ёсоор шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх баталгаа; 11 дүгээр зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэр дээр олсон орлого болон бусад хууль ёсоор олсон мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах буюу өөр улс руу шилжүүлэх баталгаа; 12 дугаар зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэрт анхлан гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэрээр зөөөрлөн оруулсан эд хөрөнгө, баримт бичигт эсүүл цахим зөөврийн хэрэгсэлд агуулах мэдээллийг ОХУ-аас саад, тотгоргүй зөөөрлөх эрхийн баталгаа; 13 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн үнэт цаас олж авах эрхийн баталгаа; 14 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьчлалд оролцох эрх; 15 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчид газар талбай, бусад байгалийн баялаг, барилга байгууламж болон бусад үл хөдлөх эд хөрөнгө олж авах эрхийн баталгаа; 16 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчид буюу гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх; 17 дугаар зүйл. ОХУ-ын субъектууд буюу өөрөө удирдах орон нутгийн байгууллагуудын үзүүлэх хөнгөлөлт, баталгаа зэрэг төрөөс гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлж байгаа олон төрлийн баталгааг дурьдаж болно.*

Эрх зүйн баталгааны асуудлыг ийнхүү дэлгэрүүлэн зохицуулсан нь гадаадын хөрөнгө оруулагч нарыг татах нэг талын давуу тал, нөгөө талаасаа нийгэмд гарч болзошгүй аливаа асуудлыг урьдчилан тооцоолж зохицуулсан нь бас нэг давуу тал болно хэмээн үзэж байна.

Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх эрх зүйн баталгааны асуудлаар, 8-10 дугаар зүйлд тусгасан бөгөөд үүнд, аливаа тохиолдлуудыг тухай бүр нь дэлгэрүүлэлгүйгээр ерөнхий байдлаар авч үзсэн.

2. 1991 оны ОХУ-ын "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль"-иар "суброгаци" хэмээх ойлголтыг авч үзсэн бөгөөд энэ нь "Хөрөнгө оруулалтын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдад олгосон баталгааны /даатгалын гэрээ/ дагуу гадаадын хөрөнгө оруулагчийг төлөөлж гадаадын хөрөнгө оруулагчаас дурдсан хөрөнгө оруулалтын эрх нь шилжсэн бол тийм эрх шилжүүлэхийг ОХУ-д хууль ёсны гэж үзнэ[286]" гэсэн утгатай ойлголт юм.

3. АНУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтаас авч үзэхэд, үндэсний аюулгүй байдлын талаар нарийн зохицуулалтыг агуулсан нь онцлог юм. АНУ-ын хувьд террорист халдлагад өртөх аюулыг харгалзан үзэж USA Patriot Law буюу "Exon-Florio Law" зэрэг хуулиудыг баталсан бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын асуудал дээрх хоёр хуультай холбоотойгоор зохицуулдаг гэж хэлж болно. Тухайлбал, "Exon-Florio Law" хуулиар АНУ-ын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үйлдэл, нөхцөл байдлыг таслан зогсоох үүднээс гадаадын хөрөнгө оруулагч нарын хувьд тодорхой шалгуурыг зааж өгсөн зохицуулалтыг агуулдаг. Мөн CFIUS буюу Гадаадын хөрөнгө оруулалтыг хариуцсан салбар дундын комисс нь дээрхи хөрөнгө оруулалтын асуудлыг мөрдөн шалгаж, цаашдын арга хэмжээг тодорхойлдог комиссын талаар зохицуулжээ.

4. АНУ-ын тодорхой салбарт хөрөнгө оруулалт хийхэд илүү өндөр шалгуурыг давах шаардлагыг хуулиар зохицуулжээ. Үүнд, банкны үйл ажиллагаа эрхлэх, радио, телевизийн нэвтрүүлэх салбар, цахилгаан, эрчим хүч болон хийн түлш, даатгал зэрэг салбаруудад хөрөнгө оруулалт хийхэд илүү өндөр шалгуурыг давах шаардлагыг тавьсан байна.

5. Казакстан Улсын хуулиар хөрөнгө оруулалтын переференц гэсэн ойлголт гарч ирж байна. Энэ нь Казакстан Улсад хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй хуулийн этгээдэд Казакстан Улсын хууль тогтоомжийг ойлгож буй хөнгөлөлтийг ойлгоно. Ер нь Казакстан Улсын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар, гурван төрлийн хөнгөлөлтийн асуудлыг зохицуулсан бөгөөд энэ нь:

- хөрөнгө оруулалтын переференцийн хөнгөлөлт
- гаалийн хөнгөлөлт
- төрийн натур грант
- татварын хөнгөлөлт хэмээх хөнгөлөлтүүдийг хөрөнгө оруулагч нарт үзүүлдэг байна.

6. БНСУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын тухай эрх зүйн зохицуулалтын хувьд 1998 онд батлагдсан "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль"-иар зохицуулдаг бөгөөд үүнд, хөрөнгө оруулалтыг хийхээс өмнөх зохицуулалт буюу "pre-admission provision", хөрөнгө оруулалт хийгдсэний дараах зохицуулалт буюу "post-admission provision" хэмээх зохицуулалт нь чухал үүрэг гүйцэтгэдэг болно.

7. БНХАУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд, дотоодын хөрөнгө оруулагч нь гадаадад хөрөнгө оруулалт хийж, улмаар бизнесийн үйл ажиллагаа хийхийг дэмждэг бөгөөд энэ нь дотоодын

[286]М.М.Богуславский "Олон Улсын хувийн эрх зүй" УБ хот, 2008 он.



хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч нарт дэмжлэг үзүүлэх нэг хэлбэрийг хуулиар зохицуулсны илэрхийлэл юм.

Дээрх гадаад улсуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлогоос хамаарч Монгол Улсын хувьд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтад эрх зүйн баталгааны асуудлыг илүү нарийвчлан зохицуулах. Энэхүү зохицуулалтыг хийснээр гадаадын хөрөнгө оруулагч нартай холбоотой маргаан бага гарна хэмээн үзэж байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагч нарын хувьд МУ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас үүдэн учирч болзошгүй хохирлын үед үзүүлэх баталгаа, хөрөнгө оруулагч нарт холбоотой гарсан маргааныг шийдвэрлэх баталгаа зэргийг хуульчлах шаардлагатай.

2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтад үндэсний аюулгүй байдлын асуудлыг оруулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Мэдээж хэрэг гадаадын хөрөнгө оруулагчийг улсын бүртгэлд бүртгэх явцад энэ асуудлыг шалгаж байгаа боловч үүнийг хуульчлах нь илүү үр дүнтэй болов уу хэмээн үзэж байна.

3. Гадаадын хөрөнгө оруулагч нарын зохицуулалтаас гадна дотоодын хөрөнгө оруулалтын зохицуулалтыг хийх хэрэгтэй. Монголын үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санаачлан 2005 онд Дотоодын хөрөнгө оруулагчдын чуулганыг зохион байгуулж, 360 гаруй аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид дунд санал асуулга явуулжээ. Санал асуулгын үр дүнд дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд хууль эрх зүйн орчин муу хэмээн үзсэн байна. Адил нөхцөлд, адил бизнес, үйлдвэрлэл явуулж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгаатай хууль, дүрэм үйлчилж гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй элдэв хөнгөлөлт, чөлөөлөлт дотоодын хөрөнгө оруулагчдад үл үйлчилж буйгаас шударгаар өрсөлдөх нөхцөлгүй болж байна. Иймээс хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоодын гэж ангилан ялгавартай хандах нь хэр зохистой талаар санал асуулганд оролцогчдоос асуусан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд нийт оролцогчдын 42,5 хувь нь хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоод гэж ялгаварлалгүй тэгш, шударгаар хандах хэрэгтэй гэсэн бол 20 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтад илүүтэй анхаарах нь зүйтэй гэж үзсэн байна. Энэ талаар БНХАУ-ын гадаад хөрөнгө оруулалтын тухай хуульд дэлгэрэнгүй зохицуулалтыг агуулдаг болно.

4. Гадаад орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтад "хөрөнгө оруулалтын төсөл" хэмээх ойлголтыг оруулсан байна. Манай улсын хувьд уг ойлголтыг зохицуулаагүй бөгөөд энэ нь алдаа хэмээн үзэж байна. Монгол Улсад оруулж буй хөрөнгө оруулалтын ихэнх нь төсөл хэлбэрээр оруулдаг бөгөөд уг ойлголтыг хуульдаа оруулж, эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай.

Судалгааны ажлын хүрээнд Солонгосын Хууль судлалын хүрээлэнгийн зочин багш С.Должин нь Asia Law Quarterly эрх зүйн сэтгүүлд "Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт" сэдэвтэй нийт 29 нүүр нийтлэл англи хэлээр бэлтгэн хэвлүүлсэн. Уг нийтлэл нь:

- Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог,
- Хөрөнгө оруулалтын гэрээ болон түүний төрлүүд,
- Гадаадын хөрөнгө оруулалтын хөхиүлэн дэмжих зохицуулалтын түүхэн асуудал
- Монгол Улс, Солонгос Улс хоорондын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог
- Монгол Улс дахь Солонгосын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдүүд, практик судалгаа
- Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн төлөвлөгөө зэрэг бүлгүүдээс бүрдэнэ.

Мөн судалгааны ажлын хүрээнд С.Должин Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй, эсхүл явуулахаар төлөвлөж байгаа Солонгосын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдүүдэд зориулж "Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, практик асуудал" нэртэй номыг 2009 оны 6 сард солонгос хэлээр бэлтгэн хэвлүүлсэн.
Дээр дурдсан нийтлэл болон номыг судалгааны тайлангийн хавсралт хэсэгт оруулсан болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ /САНАЛ, ЗӨВЛӨМЖ/

"Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтолцоог судлах" судалгааны ажил 2008 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжсэн болно.

Тус хугацаанд уг салбарт холбогдох дараах үндсэн чиглэлүүдийг авч судалж, холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг бэлтгэлээ. Үүнд,

- Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтолцооны өнөөгийн байдал
- Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлаарх шүүхийн практик ажиллагаа
- Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт
- Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог
- Гадаад орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, түүний онцлог
- Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог зэрэг чиглэлүүд юм.

Судалгааны ажлын хүрээнд Оросын Холбооны Улс, Монгол Улсын хамтарсан "Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт"-ын чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал Улаанбаатар хотноо нэг удаа, Улаан-Үүд



хотноо нэг удаа, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хамтарсан "Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт: тулгамдсан асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зэрэг хурлыг зохион байгуулж, тухай бүрт нь хурлаар хэлэлцэгдсэн илтгэлүүдийн эмхтгэлийг бэлтгэн гаргасан болно. Дээрх хурлуудын үр дүнд чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын сэдвээр гадаад улсуудтай санал солилцож, холбогдох санал, дүгнэлтэнд хүрсэн болно.

Мөн төслийн үр дүнгийн даалгавар болон төслийн каленьдарчилсан төлөвлөгөөний дагуу "МУ, ОХУ, БНХАУ-ын Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт" эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, "Гадаадын хөрөнгө оруулалт" гарын авлага, "Гадаадын хөрөнгө оруулалт" /эрх зүйн асуудал/ нэг сэдэвт бүтээл, "Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт" /эрх зүйн баримт бичгийн эмхтгэл/-ийг тус тус бэлтгэн хэвлүүлсэн болно.

"МУ, ОХУ, БНХАУ-ын Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт" эрх зүйн баримт бичгийн эмхтгэлийн хувьд холбогдох улсын чөлөөт бүстэй холбоотой эрх зүйн баримт бичгийг хятад, орос хэлнээс монгол хэл рүү тус тус орчуулан бэлтгэж, хэвлүүлсэн болно.

"Гадаадын хөрөнгө оруулалт" ном нь гадаадын хөрөнгө оруулагч нар, хуульчид, аж ахуй эрхлэгчдэд зориулсан 200 асуулт-хариулт, Монгол Улсын холбогдох хуулиудыг бүтнээр нь буюу хэсэгчилэн оруулж, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол багтаасан гарын авлага юм. 200 гаруй асуулт, хариулт нь Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалт хийх гэж буй хөрөнгө оруулагч нар, хуулийн этгээд байгуулах гэж буй гадаадын иргэд болон аж ахуй эрхлэгч нар, хуульчдад зориулж энгийн дөхөм хэллэг ашиглан бэлтгэсэн.

"Гадаадын хөрөнгө оруулалт" /эрх зүйн асуудал/ нэг сэдэвт бүтээл нь нийт 15 зохиогч оролцсон болно. Холбогдох бүлгийг бичихэд тухайн чиглэлээр ажил эрхэлж, судалгаа хийж байсан туршлагатай хүмүүсийг зохиогчоор оролцуулсан болно. Тухайн бүтээлдээ дээрх гадаадын хөрөнгө оруулалттай холбогдон гарч ирж буй хууль, эрх зүйн орчин дахь бүхий л зохицуулалтыг багтаан тайлбар өгөхийг эрмэлзэв. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын асуудлууд, чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын онцлог, хөрөнгө оруулалтын гэрээ, түүний төрөл, гадаад орнууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлуудыг хэлж болно.

"Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт" /эрх зүйн баримт бичгийн эмхтгэл/-д Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой Монгол Улсын хууль, олон улсын олон талт болон хоёр талт гэрээг тус тус эмхлэн бэлтгэв. Монгол Улсын Засгийн газар өөр улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт гэрээ болон Орлого ба хөрөнгийн тухай хоёр талт гэрээнүүдийг түүвэрлэн оруулсан нь урьд өмнө ийнхүү хэвлэгдсэн эх сурвалж ховор байдгийг харгалзсан болно.

Хийгдсэн ажлын хүрээнд Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах санал, зөвлөмжүүдийг дэвшүүлж байна.

1. Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо зах зээлд чиглэсэн (market-seeking), ашигт малтмалд чиглэсэн (resource - seeking), үйлдвэрлэлийн бүтээмжид чиглэсэн (efficiency -seeking), стратегийн нөөц баялаг болон чадварт чиглэсэн (strategic asset or capability-seeking) хөрөнгө оруулалтын алинд нь түлхүү анхаарал тавих, алийг нь илүү дэмжих, ямар хөнгөлөлт үзүүлэх бодлогыг сайтар тодорхойлох хэрэгтэй юм. Учир нь гадаадын хөрөнгө оруулалтын шийдвэрлэгч хүчин зүйлст эдийн засгийн хүчин зүйлсээс гадна манай орны гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын тогтолцоо (policy framework) болон бизнесийн тав тухтай орчин (business facilitation), эрх зүйн таатай орчин (favorable legal environment) хамаарах бөгөөд энд Улсын Их Хурал, Засгийн газрын идэвхитэй үйл ажиллагаа бодлого үгүйлэгдэж байна.

2. Гадаадын хөрөнгө оруулагч нарын зохицуулалтаас гадна дотоодын хөрөнгө оруулалтын зохицуулалтыг хийх хэрэгтэй. Монголын үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санаачлан 2005 онд Дотоодын хөрөнгө оруулагчдын чуулганыг зохион байгуулж, 360 гаруй аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид дүнд санал асуулга явуулжээ. Санал асуулгын үр дүнд дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд хууль эрх зүйн орчин муу хэмээн үзсэн байна. Адил нөхцөлд, адил бизнес, үйлдвэрлэл явуулж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгаатай хууль, дүрэм үйлчилж гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй элдэв хөнгөлөлт, чөлөөлөлт дотоодын хөрөнгө оруулагчдад үл үйлчилж буйгаас шударгаар өрсөлдөх нөхцөлгүй болж байна. Иймээс хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоодын гэж ангилан ялгавартай хандах нь хэр зохистой талаар санал асуулганд оролцогчдоос асуусан бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд нийт оролцогчдын 42,5 хувь нь хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоод гэж ялгаварлалгүй тэгш, шударгаар хандах хэрэгтэй гэсэн бол 20 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтанд илүүтэй анхаарах нь зүйтэй гэж үзсэн байна. Энэ талаар БНХАУ-ын гадаад хөрөнгө оруулалтын тухай хуульд дэлгэрэнгүй зохицуулалтыг агуулдаг болно.

3. Гадаад улсуудын тухайлбал, ОХУ, Казахстан улс зэрэг хэд хэдэн улсуудын хуулинд "хөрөнгө оруулалтын төсөл" хэмээх нэр томьёоны талаар зохицуулалт агуулж байна. Уг ойлголттой хамтатган "хөрөнгө оруулалтын давуу байдалтай төсөл", "хөрөнгө оруулалтын төслийн ашиг эргүүлэн төлөгдөх хугацаа" зэрэг ойлголтуудыг хуульчлан зохицуулсан байна.

Манай улсын хувьд "хөрөнгө оруулалтын гэрээ" гэж хуулийн этгээд байгуулахгүйгээр тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан концесс, бүтээгдэхүүн хуваах тухай, маркетинг, менежмент, санхүүгийн түрээсийн болон франчайзын хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлцлийг хэлнэ хэмээн тодорхойлсон боловч хөрөнгө оруулалтын төслийн талаар тодорхой дурдсан зүйл алга байна.

3.Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 8

дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгааны асуудлыг зохицуулсан байдаг. Мөн Монгол Улсын Засгийн газар болон бусад улс орнуудын Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай хоёр талт хэлэлцээрээс үзэхэд, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгааны асуудлыг дурдсан. Гэвч энэ зохицуулалт нь дутуу хэмээн үзэж байна. Гадаад улсуудын хувьд эрх зүйн баталгааны асуудлыг нилээдгүй дэлгэрүүлж авч үзжээ. Жишээ болгоход, ОХУ-ын 1991 оны "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулиар 12 төрлийн эрх зүйн баталгааны асуудал хуульчлагджээ. Тухайлбал, тухайн улсын хуулинд нэмэлт, өөрчлөлт орсноос болж гадаадын хөрөнгө оруулагчид үүсэж болзошгүй хохирлоос хамгаалах баталгаа, гадаадын хөрөнгө оруулагчид газар талбай,байгалийн баялаг, барилга байгууламж болон үл хөдлөх эд хөрөнгө олж авах баталгаа болон бусад баталгааны асуудлыг дурджээ. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх эрх зүйн баталгааны асуудлыг нарийвчлан хуульчлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

4. Эдийн засгийн ном зохиолд хөрөнгө оруулалтыг татах хөнгөлөлт, урамшууллыг дараах байдлаар бүлэглэн үзсэн байна.

1.Гадаад худалдааны хөнгөлөлт. Татвар-гаалийн онцгой дэглэм, гадаад худалдааны үйл ажиллагаанд үзүүлэх татварын хөнгөлөлт, валютын тарифын онцгой дэглэм зэрэг хамаарна.

2.Татварын хөнгөлөлт. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны хэлбэрээс хамааралд үзүүлэх татварын урамшуулал- стандартууд. Энэхүү хөнгөлөлт нь өөр өөр төрлийн татвар /ашгийн эсхүл орлогын, эд хөрөнгө худалдсаны зэрэг/, татвар ногдуулалтын түвшин, татвараас байнга болон түр хугацаагаар чөлөөлөх зэрэг хамаарна.

3.Санхүүгийн хөнгөлөлт. Нийтийн үйлчилгээний хямд үнийн тогтолцоо, газар болон үйлдвэрлэлийн талбайг хямд үнээр түрээслэх, урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох зэрэг арга хэмжээ.

4.Захиргааны арга хэмжээ. ЭЗЧБ-д үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх ажиллагаа болон гадаадын иргэд, хөрөнгө оруулагчид орох, нэвтрэх журмыг хялбаршуулах, зах зээлийн талаарх мэдээллээр хангах, бизнесийн төлөвлөгөө бэлтгэх зэрэг олон төрлийн бизнесийн туслалцаа үзүүлэх зэрэг хамаарна. Дэлхийн практикаас харахад, гадаадын хөрөнгийг татах дээрх төрлийн хөнгөлөлт урамшууллуудыг олон янзаар хослуулан хэрэглэсэн байдаг байна. Эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжилд дээрх хөнгөлөлт урамшуулалтын тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын баталгаа, дэд бүтэц, мэргэжилтэн, ажиллах хүчний чадвар зэрэг хүчин зүйлс хамгаас чухал нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчид хаана илүү таатай нөхцөл санал болгож байна гэдгээс илүү уг олгож буй хөнгөлөлт нь хэр тогтвортой, хөрөнгө оруулалт хийх салбар, тухайн улсын зах зээл, дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, улс төрийн тогтвортой байдал зэргийг харгалзан үздэг. Уг практикийг хэрэгжүүлэх шаардлагатай.

5. Чөлөөт бүс байгуулах, үйл ажиллагааг нь идэвхтэй явуулах эрх зүйн үндэс суурь нэлээн хэдэн жилийн өмнө тавигдсан, эдийн засгийн нөхцөл

хангалттай байгаа боловч тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэх асуудал манай улсын хувьд тулгамдсан хэвээр байна. Иймд Чөлөөт бүсийн эрх зүйн орчинг хоорондоо уялдаа холбоо сайтай, нарийн зохицуулалттайгаар сайжруулах нь чухал байна.

Тухайлбал, "Чөлөөт бүсийн тухай хууль" болон "Чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль"-иудаар хөрөнгө оруулагчид, удирдлагын болон хяналтын байгууллага, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн чиг үүрэг, бүрэн эрхийн хэмжээ, үүрэг хариуцлага болон Чөлөөт бүсэд эрхлэх үйл ажиллагааны талаар нарийн тогтоож өгөөгүй, түүнчлэн Чөлөөт бүсэд зорчих, оршин суух, тухайн бүс дэх оршин суугчдын эрх үүрэг гэх зэрэг олон асуудлыг зохицуулалгүй орхигдуулсан, эсхүл тодорхой бус гэх зэрэг дутагдалтай тал олон байна.

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх нарийн зохицуулалт байхгүй. Гагцхүү ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэх, мөн аж ахуйн нэгжийг бүртгэх журмыг өнгөцхөн тусгасан байна.

Монголд Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй этгээд хууль тогтоомжийн дагуу, тухайн чөлөөт бүсийн төрөл, онцлогт нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих талаар зохицуулалтыг боловсронгүй болгох хэрэгтэй. Хуулиар гагцхүү Чөлөөт бүсийн захирагч нь аж ахуйн нэгжийг бүртгэх үед шалгалт хийж, аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс хойш үйл ажиллагаагаа явуулалгүй 1 жил болсон тохиолдолд бүртгэлээс хасах эрхтэй болохыг л заасан байна. Харин бүртгэсний дараагаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт ойлгомжгүй байна.

Хэдийгээр Чөлөөт бүсэд Хяналтын алба байхаар заасан боловч түүний чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрх, үүрэг хариуцлага, үйл ажиллагааны журам зэргийг заагаагүй, зөвхөн мэргэжлийн хяналтын алба ажиллах бөгөөд түүний орон тоо, зохион байгуулалтыг Засгийн газар тогтооно гэсэн ерөнхий л заалт байна. Иймд байдлаар манай улсын Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй эсэхэд Мэргэжлийн хяналтын алба хяналт тавих талаар заалт оруулж болох юм.

6. Чөлөөт бүсийн тухай хуулиар удирдлагыг Чөлөөт бүсийн захирагч хэрэгжүүлэх ба тэрээр ажлаа Ерөнхий сайдын өмнө хариуцна. Мөн Засгийн газрын тухай хуулиар Чөлөөт бүсийн асуудлаар бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг ажлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд эрхлэхээр заасан. Энэ нь дээрх хоёр хуулиуд дахь Чөлөөт бүсийн талаарх зохицуулалт нь хоорондоо уялдаа холбоогүй, эргэлзээтэй байдлыг бий болгож байна.

Түүнчлэн Чөлөөт бүсийн ерөнхий менежер, мэргэжлийн хяналтын алба, хөрөнгө оруулагчдын зөвлөл нь зөвхөн Чөлөөт бүсэд ажиллана гэснээс өөрөөр ямар нэгэн бүрэн эрх, чиг үүрэг үйл ажиллагааны журам, үүрэг хариуцлага тодорхой биш байна.

Засгийн газрын 2009 оны 2 дугаар сард Засгийн газрын тогтоолоор Тэргүүн шадар сайдын удирдлага дор Чөлөөт бүсийн Зөвлөл байгуулагдсан



боловч уг Зөвлөлийн эрх зүйн байдал, бүрэн эрхийн хүрээ, үүрэг хариуцлага, үйл ажиллагааны журам зэргийг тогтоосон хууль тогтоомж алга байна.

Чөлөөт бүсэд нэвтрэх, зорчих, оршин суух журмын асуудал өнөөдрийг хүртэл тодорхойгүй байсан билээ. Харин 2009 оны 2 дугаар сард "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсэд зорчих, оршин суух журмыг Засгийн газрын тогтоолоор баталжээ. Бусад чөлөөт бүсүүдийн хувьд энэ талаар ямарваа журам байхгүй байгаа тул цаашид эдгээр чөлөөт бүсүүдэд мөрдөгдөх журмыг мөн боловсруулан батлах шаардлагатай.

"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журмаар иргэний үнэмлэх, ажлын үнэмлэх зэрэг Монгол Улсын иргэний бичиг баримттай бол нэвтрэн орох боломжтой бөгөөд гадаадын иргэний хувьд виз авах шаардлагатай. Харин орох, орох-гарах визтэй бол дахин виз авах шаардлагагүй, оршин суух зөвшөөрөлтэй бол мөн виз авах шаардлагагүй зэрэг харьцангуй хялбаршуулсан журмыг тогтоосон байна.

Энэ нь чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдыг татах нэгэн чухал хүчин зүйл болох бөгөөд ийм таатай нөхцөлийг бусад чөлөөт бүсүүдэд мөрдөх журмыг батлан гаргах хэрэгтэй.

Гадаадын улс орнууд энэ талаар өөр өөрийн гэсэн журамтай байдаг. Зарим улс орны Эдийн засгийн чөлөөт бүсэд виз авахыг шаарддаггүй бол зарим газар тодорхой хугацаа заах тохиолдол ч байдаг. Иймхүү ямар журам тогтоон мөрдүүлэх нь тухайн улс орны асуудал бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдад харьцангуй чирэгдэл багатай, боломжийн нөхцөл олгох нь хөрөнгө оруулалтыг татах чухал зүйлсийн нэг юм.

Хуулиар эдийн засгийн чөлөөт бүсэд гаалийн хяналтыг Гаалийн удирдах төв байгууллагын тогтоосон журмаар явуулахаар хуульчилсан боловч гаалийн байгууллагын энэ бүс дэх эрх хэмжээ тодорхойгүй байна. Иймд Киотогийн конвенцийн эдийн засгийн чөлөөт бүсэд гаалийн хяналтыг зохицуулсан Хавсралт F1-ийг харгалзан тооцох шаардлагатай.

7. "Чойр" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулсан нэртэй боловч эрх зүйн байдлын тухайн хууль нь хэдэн жилийн турш төсөл хэлбэртэй л явж байна. Энэ чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлахдаа өмнө батлагдсан Чөлөөт бүсийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжтой харилцан уялдаатай, илүү нарийвчлан зохицуулсан хууль байхаас гадна дээр дурдсанаар зохицуулаагүй орхигдуулсан, тодорхой бус, дутуу дулимаг заалтуудыг боловсронгуй болгон тусгах нь чухал.

Мөн чөлөөт бүсүүд өөрийн тодорхой төлөвлөгөөтэй боловч эдгээрийн дотор үндэслэл сайтай, нарийн тооцоотой, бодитой хэрэгжихүйц хангалттай сайн боловсруулсан төлөвлөгөө алга байна. Тухайлбал, "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг харахад нэлээн хэдэн жилийн өмнө буюу 2003 онд боловсруулагдсан учраас өнөөгийн хурдацтай хөгжиж, хамрах хүрээ нь улам бүр өргөжин тэлж буй эдийн засгийн харилцаанд төдийгүй саяхан нээлтээ хийсэн чөлөөт бүсийн хувьд хуучирсан, одоогийн

бодит байдалд үл нийцэх нь тодорхой байна.

8. Өнөөгийн хуулиуд нь зах зээлийн нөхцөлд байгалийн нөөцийг ашиглах үйл явцыг зохицуулахад эерэг нөлөө үзүүлж байна. Байгалийн нөөцийн дотроос газрын хэвлийн баялгийг ашиглах хуулийн болон хэмжээ тогтоох эрх зүйн баазыг бүрдүүлэх үйл явц бүрэн дуусаагүй байна. Монголын эрдэс баялгийн эрх зүйн салбарт газрын хэвлийн ашиглалтын хэм хэмжээ ба хууль эрх зүйн баазыг бүрдүүлэхэд хоёр гол чиглэлийг хослуулан шийдвэрлэх шаардлага гарч байна. Түүний нэг нь үйлчилж байгаа хуулиудаа сайжруулж боловсронгуй болгох, хуулийн доторх болон хууль хоорондын зөрчлийг арилгах, уул уурхайн хуулиудыг боловсруулах, нөгөө нь үүнтэй зэрэгцүүлэн орчин үеийн шаардлага бодит нөхцөлтэй уялдсан эрдэс баялгийн цогцолборын эрх зүйн шинэ үзэл баримтлалыг өндөр хөгжилтэй орнуудын эрхийн жишгийг харгалзан олон улсын эрх зүйн түвшинд нийцүүлэн боловсруулах явдал чухал байна.

Эрдэс баялгийн цогцолборын эрх зүйн цаашдын хөгжлийн шаардлага буюу эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийн загварын тухай үндэслэлийг бид дээр хэлсэн. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг боловсруулахад дараахь үндсэн зарчим, үзэл баримтлалыг удирдлага болгох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Газрын хэвлийн нөөц төрийн өмч байх Үндсэн хуулийн зарчим

2. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг Уул уурхайн хэм хэмжээ, хуулийн системд тэргүүлэх байртай байлгаж газрын хэвлийн болон ашигт малтмалын салбарын эрх зүйн зохицуулалтын үндэс болгох

3. Газрын хэвлийн ашиглалттай холбогдсон зөвшөөрлийн (лицензийн хэм хэмжээний) ба хэлцлийн журмууд

4. Газрын хэвлийн ашиглалт нь төлбөртэй байх

5. Газрын хэвлийн ашиглалтын талаар удирдлагын бүх шатанд төрийн зохицуулалттай байх

6. Газрын хэвлийн хэсгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрх хэмжээг нарийн зааглан тогтоож түүний эрх, үүрэг, хариуцлагын салшгүй байх зарчмыг хангах

7. Газрын хэвлийг түүний тогтоц, орших хэлбэр, хэмжээ хэрэглэгдэх боломж, аж ахуйн үйл ажиллагаанд хэрэглэгдэх зориулалт үүргээрээ улс орны байгалийн нөөцийн чадавхийг бүрдүүлэх зэрэг олон талаас нь үнэлэн тодорхойлох,

8. Газрын хэвлийн ашиглалтыг материаллаг үйлдвэрлэлийн бие даасан салбарын хэмжээнд гаргах,

9. Газрын хэвлийг ашиглах зорилгоор геологийн ба уурхайн эдэлбэрт зориулан газрын хэсгийг олгохдоо тухайн газрын гадаргуу ба гүнд орших байгалийн бүх баялгийн үнэ цэнийг бүс нутгийн болон улс орны хэмжээнд эдийн засаг, экологи, нийгэм, түүхийн ач холбогдлоор нь иж бүрэн бодож ялгавартай хандах,

10. Газрын хэвлийг ашиглах стратегийн чухал шийдвэр гаргахдаа түүний хүрээлэн байгаа байгаль орчин болон экологийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөө ялангуяа хил дамжсан нөлөөлөл гарах эсэхийг бодолцох

11. Улсын болон бүс нутгийн хэмжээнд эрдэс түүхий эдийн чадавхийн өөрчлөлтийг бүртгэж хянаж байх,

12. Удирдлагын бүх түвшинд газрын хэвлийн баялгийг үнэн зөв, иж бүрэн судалж, ашиглаж байгаад төрийн хяналт тавих хэмжээ, хязгаар тогтоох журам, шаардлагатай байх,

13. Өмчийн эзэмшлийн байдлаас хамаарахгүйгээр газрын хэвлийн баялгийн тухай улсын мэдээллийн нэгдсэн сантай байх (Улсын геологийн сан, улсын нөөцийн кадастртай байх)

14. Эрдэс баялгийн цогцолборын төрөлжсөн хуулийг бусад хуулиудтай харилцан уялдуулах зэрэг болон бусад зарчмуудыг үндэс болгох ёстой гэж үзэж байна.

Сүүлийн 10 жилд ГШХО-ын дийлэнх нь буюу 32,9-94,5 хувь нь уул уурхай, худалдаа, нийтийн хоол, хөнгөн үйлдвэрийн салбаруудад орсон байна. Цаашилбал, судалгаанаас үзэхэд ГШХО-ын харьцаа 1 хувиар өсөхөд урт хугацаанд ажилгүйдлийн төвшинг 0,58 хувиар бууруулж, харин дундаж цалингийн хэмжээг 0.65 хувиар нэмэгдүүлэхээр байна.

Иймээс дээрх санал, зөвлөмжүүдийг харгалзан үзэж эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох арга хэмжээ авах нь зүйтэй хэмээн санал дэвшүүлж байна.

__oOo__

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ БА ХОЛБОГДОХ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨНИЙ ТАЛААР СУДАЛЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛОХ

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРЭМ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ерөнхийдөө олон улсын эрүүгийн шүүх болон түүний шүүх эрх мэдэл нь үндэсний шүүх эрх мэдлийг нэмэгдүүлэн, нөхөх зарчимтай. Уг зарчмын дагуу Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) нь Ромын дүрэмд (ОУЭШ-ийн үүсгэн байгуулах гэрээ - цашид Дүрэм) нэгдэн орсон улс гүрнээс хүн төрөлхтөний энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг харьяалан шийдвэрлэхийг, эсхүл холбогдох гэмт хэргийг шийдвэрлэх (шүүн шийдвэрлэх ажиллагааг зохих төвшинд явуулах) хүсэл зориг, боломж, чадвар хомсдох үед харьяалан шийдвэрлэх эрхээсээ татгалзахыг шаардаж, хянаж байх тогтолцоо мөн. Тус дүрэмд нэгдэн орсон ямар ч гишүүн улс ОУЭШ-ийн шүүн шийдвэрлэх ажиллагаанд тус, дөхөм үзүүлэх үүрэг хүлээдэг. Иймд ОУЭШ-ийн ажиллагаа бүхэлдээ гишүүн улсын дүрэмд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас шууд шалтгаалж байна. Гишүүн улсын үүргийн чухал нь гэмт этгээдийг албадан саатуулж ОУЭШ хүлээлгэн өгөх асуудал юм. Энэ асуудал нь төрийн дээд албан тушаалтны дархан эрхийн асуудалтай холбоотой байдаг.

Монгол Улсын Үндсэн хууль болон түүний нэгдэн орсон Ромын дүрэм хэрхэн хоорондоо уялдаж буй байдал, үндэсний хууль тогтоомжийг хэрхэн нийцүүлэх зэрэг асуудалд практик зарим зөвлөмж гаргахыг зорилоо.

1.Үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх асуудал

Ромын дүрэмд нэгдэн орсноор гишүүн улс дотоодын хууль тогтоомжоо заавал өөрчлөх ёстой болж байна гэж үзэх нь дутагдалтай. Учир нь ОУЭШ-ийн нөхөх зарчим нь үндэсний эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг яг таг Ромын дүрмийн журмаар явуулахыг шаардана гэж ойлгож болохгүй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон ял шитгэлийн хэмжээ нь Дүрэмд тогтоосноос ялгаатай (эрх зүйн тогтолцооноос шалтгаалан) байж болно. Харин үндэсний шүүн шийдвэрлэх ажиллагааг "зохих төвшинд" л явуулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийг халхавчлах, зөвтгөх зорилгоор шүүн шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй гэсэн үг.

Ромын дүрмийн гишүүн ихэнх улс нөхөх зарчмыг хангах үүднээс ОУЭШ-ийн харьяалах гэмт хэргийг үндэсний хууль тогтоомждоо тусгаж өгч байна. Харин цаашид Дүрэмтэй зөрчилдөх байдал гаргахгүйн үүднээс, тухайлбал гэмт этгээдийг "халхавчлах" зорилгоор өөрийн хууль тогтоомждох ялаас чөлөөлөх, хөнгөвчлөх нөхцөлийг тус Дүрэм эсхүл бусад олон улсын эрх зүйн баримт бичигтэй нийцүүлж байна. Хэдий ийм өөрчлөлт хийх зохистой боловч Ромын дүрэм нь үүнийг заавал хийхийг шаарддагүй байна. Ромын

дүрэм нь үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх үүргийг гишүүн улсад тулгадаггүй боловч ийм өөрчлөлт хийхэд хүргэх нь ойлгомжтой. Тухайлбал, ОУЭШ нөхөх зарчмын дагуу шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх явцад заавал хамтран ажиллах үүргийнхээ хувьд үндэсний шүүхийн тогтолцоо байцаан шийтгэх ажиллагааг Дүрмээр тогтоосон журмын дагуу явуулахад асуудал гарах нь ойлгомжтой.

2. Хамтран ажиллах үүргийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх.

Аливаа улс үндэсний хэмжээнд хууль тогтоомжоо Дүрэмд нийцүүлэхгүйгээр тус гэрээг соёрхон батлах ажиллаагаа явуулж болох болов ч дараагийн шатанд нь нийцүүлэх ажлыг зохион байгуулах нь зохимжтой. Учир нь тэгээгүйгээс практик дээр асуудалтай тулгарч олон улсын гэрээг зөрчсөн хэрэгт унах магадлалтай. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байдлаа үндэсний хууль тогтоомжоор зөвтгөхийг олон улсын эрх зүйгээр хориглосон байдаг[287]. Харин энэ заалтыг үл тоон Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэж үзсэн ч ОУЭШ-ээс шаардсаны дагуу үүргээ гишүүн улс биелүүлэхгүй бол шүүх нь Гишүүн улсуудын ассамлейд, эсхүл НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлд шийдвэрлүүлэхээр хандах хүртэл арга хэмжээ авна гэдгийг тооцож анхааралдаа авах шаардлагатай[288].

Гишүүн улс бүр хамтран ажиллах нөхцөлийг (Дүрмийн 9 дүгээр хэсэг) хууль тогтоомждоо тусгах үүрэг 88 дугаар зүйлийн дагуу хүлээх нь хамгийн чухал бөгөөд энэ нь ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ба шүүхийн туслалцааг үзүүлэх явдал юм. Уг үүрэг нь ОУЭШ-ийн дүрмийн 86 дугаар зүйлд тодорхойлогдсон[289]. Мөн бусад зүйлд хамтран ажиллах хэлбэрийг заасан байдаг. Тухайлбал, албадан саатуулах, шүүхэд хүлээлгэн өгөх, нотлох баримт шилжүүлэх, эд мөрийн баримт, эд хөрөнгө битүүмжлэх, хохирогч ба гэрчийг хамгаалах гэх зэрэг. Шүүхийн даалгавар гүйцэтгэх, торгууль тавих, эд хөрөнгө хураах, шүүхтэй тусгай гэрээ хийсэн бол хорих ялыг хэрэгжүүлэх зэрэг хамтын ажиллагааг хангана. Үүнээс гадна гишүүн улс болгон ОУЭШ-ийн удирдах, санхүүжүүлэх зэрэг ажилд оролцохоос гадна шүүн шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй.

Гадаад зарим улсын практикаас үзвэл тухайн хамтын ажиллагааг хангах үүднээс тусгайлан ОУЭШ-тэй хамтран ажиллах хууль тогтоосон байдаг байна. Тухайлбал, 2006 оны 9 дүгээр сарын байдлаар 18 улс[290] ОУЭШ–тэй хамтран ажиллах кодексыг баталсан байна.

[287] 1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002 оны 4 дүгээр сарын 5-нд соёрхон баталсан.

[288] 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн Вений конвецийн 27 дугаар зүйл. (Монгол Улс 1988 оны 4 дүгээр сарын 11-нд нэгдэн орсон)

[289] 87 дугаар зүйлийн 5.b заалт, 7 дугаар зүйл

[290] 86 дугаар зүйл. *Хамтран ажиллах нийтлэг үүрэг.* Оролцогч улсууд энэхүү дүрмийн заалтуудын дагуу хэрэг шүүн шийдвэлэхэд нь хамаарах гэмт хэргийн эрүүгийн мөрдөн байцаалт болон эрүүгийн мөрдөн мөшгөлт явуулахад Шүүхтэй бүх талаар хамтран ажиллана. ("Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийнТусгай дугаар II боть).

Хууль тогтоомжийг нийцүүлэх ажиллагааг зөвхөн хууль тогтоох техниктэй холбож үзэж болохгүй юм. Эдгээр хууль тогтоомж нь хууль тогтоох процессоос гадна улс төрийн болон санхүүгийн бэрхшээл, хязгаарлалтай тулгарах нь зайлшгүй байдаг, тэр тусмаа үндсэн хуулийн заалттай харшилдах бол дээрхи саадтай улам хурц тулгарна. Үндсэн хууль бусад эрх зүйн актаас харьцангуй халдашгүй, тогтвортой байдаг учир түүнтэй харшилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг нийцүүлэх ажиллагаа асуудалтай тулгардаг. Иймд энэхүү Үндсэн хуультай харшилдах байдлын талаархи судалгаа хийх нь зайлшгүй юм.

3. Албан тушаалтны дархан эрх болон баривчлах, шилжүүлэн өгөх асуудалтай холбоотой үндсэн хуулийн асуудал

Үндсэн хуулийн асуудал өнөөдөр дэлхийд хэдэн янзын үндсэн хууль байна төдий чинээ ялгаатай байна. Эдгээрээс хамгийн шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал бол ОУЭШ-ийн шаардлагаар гэмт этгээдийг баривчлах ба шүүхэд шилжүүлэн өгөх асуудал юм. Харин энэ асуудлаар үндсэн хууль Ромын дүрэмтэй нийцэж буй байдлыг ОУЭШ-ийн дүрмийн гурван заалтаар шалгуур болгож үздэг.

1. Албан тушаалтныг эрүүгийн хариуцлагад татахад саад болох аливаа бэрхшээлийг ОУЭШ нь эс хүлээн зөвшөөрөх ба гишүүн улсаас тийм этгээдийг Үндсэн хуулиар дархан эрх олгосон эсхээс үл шалтгаалан баривчилж шилжүүлэн өгөхийг шаардана.

2. ОУЭШ сэжигтэнг түүний ямар харьяалалтай байгаагаас үл шалтгаалан шилжүүлэн өгөхийг шаардана. Тиймд ОУЭШ нь гишүүн улсаас үндсэн хуулиараа шилжүүлэн өгөхгүй байсан ч өөрийн иргэнийг баривчлах ба ОУЭШ-д шилжүүлэн өгөхийг шаардана.

3. Үндэсний хууль тогтоомжоор тодорхой хугацаанаас хэтрүүлэхгүйгээр хорих ялын хэмжээтэй байсан ч ОУЭШ-ээс бүх насаар нь хорих ял ногдуулж болно.

Ромын дүрэм нь бүх этгээдэд түүний албан тушаалыг харгалзахгүйгээр үйлчлэх бөгөөд энэхүү албан тушаалын байдал нь ялаас чөлөөлөх, эсхүл хөнгөрүүлэх үндэслэл болохгүй[291].

Олон улсын эрүүгийн шүүх нь үндэсний хууль тогтоомжоор дархан эрх эдлэх этгээдүүдийг харьяалан шийдвэрлэх бүрэн эрхтэй[292] нь төрийн болон дипломат эрх дархын асуудлаар гуравдагч улсын хувьд эдлэхэд нь саад болохгүй. Өөрөөр хэлбэл үндсэн хууль болон олон улсын гэрээгээр олгогдсон дархан эрх нь ОУЭШ-д шүүн шийтгэх ажиллагаа явуулахад саад болохгүй байна.

[291] Австрали, Аргентин, Бразил, Белги, Голланд, Испани, Их Британи, Канад, Нигер, Норвег, Өмнөд Африк, Пэру, Словени Улс, Тринидад ба Тобаго, Уругвай, ХБНГУ, Франц Улс, Швед (http://www.iccnow.org/?mod=romeimplementation)

[292] Ромын дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дүгээрт



Үндсэн хуулийн дагуу дархан эрхийг олгож буй байдал нь үүргээ гүйцэтгэж дуусан, эсхүл гүйцэтгэж буй төрийн тэргүүн, засгийн газар болон парламентын гишүүн, шүүгч зэрэг төлөөлөх болон гүйцэтгэх эрх мэдлийн ямар ч түвшний албан тушаалтанг улс төрийн асуудлаар болон аливаа гүтгэлэг, мөрдөн мөшгилтөөс ангид байлгах үүднээс олгодог. Ийм хамгаалалт нь тухайн албан тушаалтанг өөрийн ажил үүргээ зохих түвшинд хийхэд нь баталгаа болдог. Харин үндсэн хуулийн дагуу дархан эрхийг эдэлнэ гэхийг түрэмгийлэл, дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэрэгт буруутгагдахгүй гэж тайлбарлаж ойлгох бол ОУЭШ-ийн харьяалах хэргээр шүүх ажиллагаа тэдгээрийн эсрэг явуулж болохгүй мэт. Энэ байдал нь, *нэгдүгээрт,* ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ажиллагаанд бэрхшээл учруулах ба *хоёрдугаарт,* ийм гэмт хэрэг үйлдсэн ч шийтгэлгүй үлдэж болно гэх итгэл үнэмшилтэйгээр хүний эрх, эрх чөлөөнд халдах боломжтой нөхцөл байдлыг бий болгоно. Хэдий хэмжээнд ийм байр суурьтай хандах нь төдий чинээ 88 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөнө.

Энэхүү асуудлыг шийдэх гурван гарц л байна. Нэгдүгээрт, Үндсэн хуульдаа Ромын дүрэмд нийцүүлэх үүднээс өөрчлөлт оруулах. Хоёрдугаарт, холбогдох үндсэн хуулийн заалтыг Ромын дүрэмд нийцүүлэн тайлбарлах. Эсхүл, эцэст нь ОУЭШ-ийн харьяалагдах хэрэг манайд гарахгүй ч юм билүү гэж үзэн ямар ч арга хэмжээ авахгүй байх. Харин гарах тохиолдолд НҮБ-ээс хариуцлага тооцно гэдгийг мартаж үл болно.

Эхний ээлжинд ОУЭШ-ийн харьяаллын гэмт хэрэгт дархан эрхийн асуудал үйлчлэхгүй гэх байдлаар үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах нь чухал. Ийм өөрчлөлт оруулсан нь ОУЭШ-д шилжүүлэхгүйгээр үндэсний шүүх эрх мэдлийн байгууллагаар дархан эрхтэй этгээдийг харьяалан шийдвэрлэх боломжтой болох бөгөөд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Монгол Улсын хууль тогтоомжоор ерөнхийлөгчөөс бусад төрийн дээд албан тушаалтны эрх дархыг зохих журмын дагуу түтгэлзүүлж болох ба эрүүгийн хариуцлагад татаж болох нөхцөлтэй. Харин ерөнхийлөгчийн хувьд түүнийг зохих журмын дагуу огцруулах нөхцөлтэй ч хариуцлагад татах боломж нь тодорхой бус байдаг.

Дархан эрхийг дээрх гэмт хэргийн хувьд хамаарахгүй гэж Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар, эсхүл Дүрэмд нийцүүлэн тайлбарласнаар албадан саатуулах, ОУЭШ-д шилжүүлэн өгөх асуудлыг хөндөхгүйгээр үлдээх боломжтой. Учир нь гэмт хэрэг үйлдсэн дархан эрхтэй этгээдийг дотоодын хуулиар тухайн хариуцлага тооцох механизм нь бүрэлдэнэ.

Тухайн шүүхийн шийдвэр нь шударга бол ОУЭШ-д шилжүүлэн өгөх шаардлага гарахгүй.

Энэ асуудалд Франц улс арай өөрөөр хандсан практиктай. Франц улс Ромын дүрэмд нэгдэн ороходоо төрийн тэргүүний дархан эрхийн талаархи Үндсэн хуулийн заалт нь тухайн Дүрэмтэй нийцэхгүй байна гэж Үндсэн хуулийн Зөвлөл нь дүгнэлт гаргаж байв. Уг асуудлыг парламентын хоёр танхимаар хэлэлцүүлэн 1999 онд Бүгд Найрамдах Улс нь Олон улсын

эрүүгийн шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрнө гэсэн үндсэн хуулийн өөрчлөлтийг[293] баталсан байна. Франц Улсын тус өөрчлөлтийг шинжилж үзвэл ОУЭШ-тэй хамтран ажиллах нөхцөлийг бүрэлдүүлж өгсөн хэдий ч төрийн тэргүүн холбогдох гэмт хэргийг үйлдвэл дотоодын шүүхээр харьяалан шийдвэрлэх бус харин дархан эрхийг нь үл харгалзан ОУЭШ-д шилжүүлэхийг сонгосон байна. Өөрөөр хэлбэл Франц улс өөрийн тэргүүнээ эрүүгийн хариуцлагад өөрөө татах "хүсэлгүй" улсын тоонд хэвээр багтан үлдсэн гэж хэлж болно. Гэхдээ энэ байдал нь олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ зөрчиж байгаа илрэл огт биш.

Дараагийн чухал асуудал нь түрэмгийлэл, дайны гэмт хэрэг, хүмүүнлэгийн болон төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн хэнийг ч харьяаллаас нь үл хамааран ОУЭШ-д хүлээлгэн өгөх асуудал юм.

Манай Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтаар Монгол Улсын иргэнийг өөр *улсад* шилжүүлэн өгөхийг хориглосон. Харин Дүрэм нь гэмт этгээдийг "хүлээлгэн өгөх", "шилжүүлэн өгөх" гэсэн хоёр ойлголтыг ялгаж үзсэн байна[294]. "Хүлээлгэн өгөх"-ийг Ромын дүрмээр ОУЭШ-ийн харьяалалд тухайн этгээдийг шилжүүлэн өгөхийг ойлгох бол "шилжүүлэн өгөх"-ийг өөр улсын үндэсний шүүхийн харьяалалд шилжүүлэхийг ойлгоно. Энэ нэр томъёог дүрэмд ялгаж тусгаж өгсөн нь ОУЭШ-ийн харьяалал ямар ч улсын өөрийн иргэнийг өөр улсад шилжүүлэн өгөхгүй байх үндсэн хуулийн заалтад харшилах зүйлийг арилгах зорилготой юм. Мэдээжийн хэрэг хууль тогтоогчид Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. дахь заалтыг томъёолохдоо Монгол Улсын иргэнийг гагцхүү Монгол Улсын шүүхээр харьяалан шийдвэрлэх үзэл баримтлалтайгаар хандсан байх. Үүний гол үндэслэл нь тухайн этгээдийн асуудлаар гадаад улсын шүүхээс илүүд үндэсний шүүх нь шударга шийдвэр гаргах магадлалтай. Мөн хэл, соёлын асуудлаас гадна тодорхой хэмжээгээр ял эдэлж буй этгээдийг нийгэмшүүлэх, үндэсний хэмжээнд гарч болох бусад ийм төрлийн гэмт хэргээс сэргийлэх нөхцөлийг гадаад улсын практик биш зөвхөн үндэсний шүүхийн үйл ажиллагаа л бий болгодог. Хэрэв энэ үзэл баримтлалыг хөдлөшгүйгээр хамгаалах бол хүн төрөлхтөний эсрэг аливаа гэмт хэргийг шийдвэрлэх, эсхүл төрийн дээд албан тушаалтанг тухайн хэрэгт буруутган шийтгэх шударга механизмтай байх шаарлагатай болж байна.

Нөгөөтэйгүүр Ромын дүрмийг хүлээн зөвшөөрсөн, ОУЭШ-ийн байгуулцсан улсын хувьд хүлээсэн үүргээ дахиад л санах шаардлагатай. Ромын дүрэм нь "хүлээлгэн өгөх", "шилжүүлэн өгөх" гэсэн хоёр ойлголтыг ялгаж үзсэн нь уг асуудлыг хялбарчлах зорилго агуулж байгаа гэж үзэж болох юм. Учир нь өөрийн улсын иргэнийг гадаад шүүхэд шилжүүлэн өгөхгүй байх дээрх үзлийг хөндөхгүйгээр ОУЭШ үйл ажиллагаагаа явуулна гэж ойлгож болох юм. ОУЭШ бол нэгдүгээрт, гадаад бүрэн эрхт улсын шүүх биш, хоёрдугаарт, ОУЭШ нь шударга ёсны батаалгааг гадаад улсын

[293] Ромын дүрмийн 27 дугаар зүйлийн 2 дугаарт

[294] Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хуулийн 53-2 дугаар зүйл (өөрчлөлт N 99-1568, 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр).

шүүхээс илүү хангаж өгнө. Өөрөөр хэлбэл Дүрэм нь ямар ч улсын хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хангах олон улсын стандартыг тусгаж өгсөн. Нөгөөтэйгүүр, ОУЭШ нь олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэл зоригоор, зөвшилцлөөр бий болсон, энд хэн нэгэн улсын эрх ашиг, бүрэн эрхийн ноёрхол байхгүй. Манайх шиг тус шүүхийг байгуулсан улс болгон ОУЭШ-ийн үйл ажиллагаанд тэгшээр оролцдог. Өөрөөр хэлбэл ОУЭШ нь улс биш юм.

Иймд нэн тэргүүнд Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг "эрх бүхий байгууллагаас" Ромын дүрмийн 102 зүйлтэй нийцүүлэн тайлбарлах шаардлагатай байна. Энэ заалтыг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үндэсний шүүх нь хэрэг гарах бүрт ОУЭШ-д шилжүүлж ажилгүй болно гэж ойлгож болохгүй, учир нь, нэгдүгээрт, ОУЭШ нь нэмэлт хөшүүргийн зарчмаар ажиллана, хоёрдугаарт, нэмэлт хөшүүргийн нөхцөл бүрэлдсэн ч ОУЭШ нь тухайн хэргийг шийдвэрлүүлэхээр үндэсний шүүхэд даалгаж болно. Энд дахиад л хамтран ажиллах талаарх үндэсний зохицуулалт шаардаж эхэлнэ.

Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтарч ажиллах тухай тусгайлан хууль гаргасан улсын жагсаалт

	Улс	Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтрч ажиллах тухай хууль тогтоомж
1.	Тринидад ба Тобаго	24 Feb 2006 International Criminal Court Act 2006
2.	Аргентин	01 July 2005 S-2078/06 Proyecto de Ley de Implementaction del Estatuto de Roma de la Corte Penal Internacional
3.	Уругвай	01 July 2005 Proyecto de ley Sutitutivo de la Comisiyn
4.	Нигер	19 May 2005 ICC Ratification and Jurisdiction Bill 2005
5.	Пэру	29 July 2004 ICC Cooperation Bill - Code of Criminal Procedure - Legislative Decree (Spanish)
6.	Австрали	27 June 2002 International Criminal Court (Consequential Amendments) Act 2002 (inserting the relevant crimes into the Criminal Code)
		27 June 2002 International Criminal Court Act 2002 (cooperation provisions)
		May 2002 Report 45, The Statute of the International Criminal Court; Joint Standing Committee on Treaties
		2002 International Criminal Court Bill 2002, Explanatory Memorandum
		2002 International Criminal Court (Consequential Amendments) Bill 2002, Explanatory Memorandum

7.	Франц Улс	26 Feb 2002 LOI no 2002-268 du 26 fйvrier 2002 relative a la coopйration avec la Cour pйnale internationale (1)
8.	ХБНГУ	26 Feb 2002 Act to Introduce The Code Of Crimes Against International Law Of 26 June 2002
9.	Их Британи	05 Nov 2001 International Criminal Court Act 2001 - Summary
10.		05 Nov 2001 International Criminal Court Act 2001 (Elements of Crimes) Regulations 2001
11.		05 Nov 2001 International Criminal Court Act 2001 (Enforcement of Fines, Forfeiture and Reparation Orders) Regulations 2001
12.		04 Apr 2001 ICC (Scotland) Bill
13.	Словени Улс	17 July 2001 Law on Nomination of Judges to International Tribunals/Courts
		25 Oct 2002 Implementing Law: Predlog Zakona O Sodelovanju Med Republiko Slovenijo In Mednarodnim Kazenskim Sodi_em (Slovenian)
14.	Өмнөд Африк	04 July 2001 International Criminal Court Bill
15.	Швед	22 June 2001 Federal Law on Cooperation with the ICC
16.	Норвег	15 June 2001 Act on Implementation of the Rome Statute
17.	Канад	29 June 2000 Crimes Against Humanity and War Crimes Act
18.	Голланд	NA Bill on International Crimes (Rules concerning serious violations of international humanitarian law)
19.	Испани	NA ICC Implementing Legislation
20.	Белги	
21.	Бразил	

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРЭМ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

I.Монгол Улсад Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалах гэмт хэрэг, үйлдсэнд тооцох, мөн энэ талаар шүүн таслах ажиллагаа явуулах нөхцөлийн талаар Монгол Улсын хууль тогтоомж зохицуулалтгүй байдлыг засварлах санал

№	Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ)-ийн Дүрэм	Монгол Улсын хууль тогтоомж	Тайлбар	Санал
1.	*5 дугаар зүйл* Шүүхээс хэрэг шийдвэрлэхэд хамаарууллах гэмт хэрэг 1. Шүүхээс шүүн шийдвэрлэх хэрэг нь олон улсын нийт хамтын нийгэмлэгийн сэтгэлийг түгшээсэн хамгийн ноцтой гэмт хэргээр хязгаарлагдана. Энэхүү дүрмийн дагуу Шүүх дараах гэмт хэргийг шүүн шийдвэрлэнэ: (b) *хүн төрөлхтөний эсрэх* гэмт хэрэг; *31 дүгээр зүйл* *Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл* *1. Энэхүү дүрмэд дурдсан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бусад үндэслэлээс гадна тухайн этгээд хэрэв үйлдэх үед дараах нөхцөл байдал байвал эрүүгийн хариуцлагаа хүлээхгүй:* *(c) цэргийн азмат хэрэгийн нөхцөлд тухайн этгээд өөрийгөө буюу бусад этгээдийг мөн тухайн этгээд буюу бусад этгээдийн амьд үлдэхэд онцгой чухал ...*	Монгол Улсын Эрүүгийн хууль Арван нэгдүгээр хэсэг Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг Гучдугаар бүлэг	Цэргийн гэмт хэрэг гэхийг Дайны гэх, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэхийг хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг гэж өөрчлөх саналтай байна. Учир нь, нэгдүгээрт, олон улсын эрүүгийн эрх зүйд 1949 оны Женевийн дөрвөн конвенц болон дайн, зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой дүрэм, журмыг хуульчилсан бусад олон улсын гэрээг зөрчсөн гэмт хэргийг дайны (War crimes-военные преступления) гэдэг бол хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг (crime against humanity – преступления против человечности 1, humanity гэж нэр томьёог толь бичиг хүн төрөлхтөн, хүмүүнлэг гэж орчуулдаг ба хүмүүнлэг гэж нэр томьёо нь оновчтой болно) нь энгийн хүн амыг ерөнхий хүрээтэй, байнга (систематический) алах, устгах, эрүү шүүлт тулгах, тарчлаан зовоох, сураггүй алга болгох зэрэг хэргийг аргаар үйлдэх санаатай үйлдлийг ойлгодог. Хоёрдугаарт, олон улсын эрх зүйд дайны гэмт хэрэг, түрэмгийлэл, төрөвөр устгах, хүмүүнлэгийнийн эсрэг гэмт, олон улсын хамгаалалтад буй эгэзэдийн эсрэг гэмт хэрэг, экоцид, биоцид зэрэг олон улсын гэмт хэргийг хүн төрөлхтөний эсрэг буюу хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэж ойлгодог.	Олон улсын эрүүгийн шүүхийн Дүрмийн 5.1. b хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг гэхийг хүмүүнлэгийн гэж орчуулгыг зөв болгох 31.1. (c) Дайны гэмт хэргийн нөхцөлд гэж өөрчлөх Монгол Улсын Эрүүгийн Хууль Арван нэгдүгээр хэсэг Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг Гучдугаар бүлэг Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг нэмэх 306. энгийн хүн амыг ерөнхий хүрээтэй, байнга алах, устгах, эрүү шүүлт тулгах, тарчлаан зовоох, сураггүй алга болгох, арьсны өнгөөр алагчлах гэмт хэрэг, хүнд хэлбэрийн бэлгийн аливаа хүчирхийлэл, санаа сэтгэлийн буюу бие махбодийн эрүүл мэндийн хувьд ноцтой хохирол санаатай учруулсан шинж чанартай хүмүүнлэг бус үйлдэл зэрэг хэргүй аргаар санаатай үйлдсэн бусад хүмүүнлэг бус *үйлдэл үйлдсэн* бол хориос хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

www.nli.gov.mn

	27 дугаар зүйл: 1. Энэхүү Дүрмийг албан тушаалын байдлын үндсэн дээр ямар нэг өлгөвөр гаргагүйгээр бүх эгээдэд нэгэн адил байдлаар хэрэглэнэ. Түүнчлэн төрийн буюу засгийн газрын тэргүүн, Засгийн газрын буюу парламентын гишүүн, сонгогдсон төлөөлөгч буюу засгийн газрын албан хаагч зэрэг албан тушаалын байдал нь ямар ч тохиолдолд энэхүү Дүрмийн дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгч биеэвд энэ нь шийтгэх тогтоолыг хенгеруулэх үндэслэл болохгүй. *2. Үндэсний буюу олон улсын эрх зүйн дээгүү байлва ч газсн алиеэа этгэдийн албан тушаалын байдалтай холбоотой байж болох дарган эрх буюу байцаан шийтгэх акилпааганы тусгай хэм хэмжээ нь тухайн этгэдийн хувьд Шүүх шүүн таслах акилпаагаага хэрэгжүүлэхэд саад учруулах ёсгүй*	Эрүүгийн хууль 13 дугаар зүйл. Монгол Улсын нутаг дээсэгт гэмт хэрэг үйлдсэн этгэдэд Эрүүгийн хууль үйлчлэх үндэслэл. 13.1.Монгол Улсын нутаг дээсэгт гэмт хэрэг үйлдсэн этгэдэд энэ хуулийг зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулья заасан журмыг баримтлан эрүүгийн байцаан шийтгэх акилпагаа явуулж болно.	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 4.2. Дипломат дархан эрх, эрх ямба эдэлэх байгаа гадаадын иргэн еөеөе хүссэн, эсүүл зөвшөөрсөн тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх акилпагаа явуулж болно.	Үндэсний хууль тогтоомжийг үндэслэн төрөөс дарган эрхэлэ этгэдийг үндэсний шүүх эрх мэдлээс зангид байлгах хүсэлтэй байсан ч Улсын эрүүгийн шүүх Дүрмийнхээ 27 дугаар зүйлийн дагуу хэрэгий нь харьяалан шийдвэрлэнэ. Тиим учир бид үндэсний этгэдийг ОУЭШ-д хүлээлгэн өгөхгүйгээр шийдвэрлэх боломжтой болно.	Эрүүгийн хуулья 13.1-т "Монгол Улсын нутаг дээсэгт Монгол Улсын Эрүүгийн хууль заасан Хүн төрөлтөөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэний төлөө харицлага нөгдулахад түүний төөрөн дарган эрх саад болох ёсгүй. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулья 4.4. Дипломат дархан эрх ямба эдэлэх байгаа гадаадын иргэн хүн төрөлтөөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол олон улсын гэрээнд заасан журмын дагуу энэ хуулья заасан журмыг баримтлан эрүүгийн байцаан шийтгэх акилпаага явуулж болно

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

II. Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах, тухайлбал

№	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэм	Монгол Улсын хууль тогтоомж	Тайлбар	Нэмэлт өөрчлөлт
3.	86 дугаар зүйл. *Хатуран ажиллах нийтлэг үүрэг.* Оролцогч улсууд энэхүү дүрмийн заалтуудын дагуу хэрэг шүүн шийдвэлэхэд нь хамаарах гэмт хэргийн эрүүгийн мөрдөн байцаалт болон эрүүгийн мөрдөн мөшгөлт явуулахад Шүүхтэй бүх талаар хамтран ажиллана. 27 дугаар зүйл 1. Энэхүү дүрмийг албан туршаалын байдлын үндэсэн дээр ямар нэг ялгавар гаргахгүйгээр бүх этгээдэд нэгэн адил байдлаар хэрэглэнэ. Түүнчлэн төрийн буюу засгийн газрын тэргүүн, засгийн газрын буюу парламентын гишүүн, сонгогдсон төлөөлөгч буюу засгийн газрын албан хаагч зэрэг албан туршаалын байдал нь ямар ч тохиолдолд энэхүү дүрмийн дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхүй бөгөөд энэ нь шийтгэх тогтоолыг көнгөрүүлэх үндэслэл болохгүй. 2. Үндэсний буюу олон улсын эрх зүйн дагуу байлаа ч гэсэн аливаа этгээдийн албан туршаалын байдалтай холбоотой байж болох дархан эрх буюу байцаан шийтгэх ажиллагааны тусгай хэм хэмжээ нь тухайн этгээдийн хувьд Шүүх шүүн таслах ажиллагаагаа хэрэгжүүлэхэд саад учруулах ёсгүй. *87 дугаар зүйл* 7. Оролцогч улс энэхүү дүрмийн заалтыг зөрчин хамтран ажиллах тухай хүсэлтийг биелүүлээгүй бөгөөд ингэснээрээ Шүүхэд энэхүү дүрмийн дагуу үүрэг болон эрхээ биелүүлэх боломж олгоогүй бол Шүүх энэ асуудлаар дүгнэлт гаргаж болох бөгөөд асуудлыг оролцогч улсуудын Ассамблейд, хэрэв тухайн асуудлыг Шүүхэд Аюулгүйн Зөвлөл шилжүүлсэн бол Аюулгүйн Зөвлөлд шилжүүлж болно хэмээн заасан байна.	Эрүүгийн Хууль 15 дугаар зүйл 1. "Монгол улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй. 2. Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно. *404 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт* 404.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад тавина.	Гишүүн улс бүр <u>хамтран ажиллах нөхцөлийг</u> (Дүрмийн 9 дүгээр хэсэг) хууль тогтоомждоо тусгах үүрэг 88 дугаар зүйлийн дагуу хүлээх нь хамгийн чухал бөгөөд энэ нь ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ба шүүхийн тусламцаар үзүүлэх явдал юм. Үг үүрэг нь ОУЭШ-ийн дүрмийн 86 дугаар зүйлд тодорхойлогдсон. Мөн бусад зүйлд хамтран ажиллах хэлбэрийг заасан байдаг. Тухайлбал, албадан саатуулах, шүүхэд хүлээлгэн өгөх, нотлох баримт шилжүүлэх, эд мөрийн баримт, эд хөрөнгө битүүмжлэх, хохирогч ба гэрчийг хамгаалах гэх зэрэг. Шүүхийн даалгавар гүйцэтгэх, торгууль тавих, эд хөрөнгө хураах, шүүхтэй түсгай гэрээ хийсэн бол хорих ялыг хэрэгжүүлэх зэрэг хамтын ажиллагааг хамгана. Дүрмийн 102 дугаар зүйлээр "хүлээлгэн өгөх", "шилжүүлэн өгөх" ойлголтыг ялгаатайгаар тайлбарласан. "Хүлээлгэн өгөх"-ийг Ромын дүрмээр ОУЭШ-ийн харьяалалд тухайн этгээдийг шилжүүлэн өгөхийг ойлгох бол "шилжүүлэн өгөх"-ийг өөр улсын үндэсний шүүхийн харьяалалд шилжүүлэхийг ойлгоно. Энэ нэр томьёог дүрэмд ялгаж тусгаж өгсөн нь ОУЭШ-ийн харьяалал ямар ч улсын өөрийн иргэнийг өөр улсад шилжүүлэн өгөхүй байх үндэсэн хуулийн заалтад харшлах зүйлийг арилгах зорилготой юм.	Эрүүгийн хуулийн 15-д 15.1.Монгол Улсын иргэнийг Хүн терелхтний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэний төлөө Монгол Улсын олон улсын гэрээний дагуу түүнийг олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөх ба үүнийг гадаад улсын шүүхэд шилжүүлэн өгсөн гэж үзэхгүй. 15.2.Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлэн өгч буюу Олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэж өгч болно. *404 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт* 404.1.Монгол Улсын иргэнийг Хүн терелхтний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэний төлөө Монгол Улсын олон улсын гэрээний дагуу түүнийг олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгч болно. *405 дугаар зүйл. Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай шаардлагыг биелүүлэх*

4.	102 дугаар зүйл Нэр томъёо хэрэглэх Энэхүү дүрмийн зорилгоор: (a) "хүлээлгэн өгөх" гэж энэхүү дүрмийн дагуу аливаа улс тухайн этгээдийг Шүүхэд хүргэж өгөхийг хэлнэ. (b) "шилжүүлэн өгөх" гэж нэг улс тухайн этгээдийг олон улсын гэрээ, конвенц буюу үндэсний хууль тогтоомжийн заалтын дагуу өөр улсад хүргэж өгөхийг хэлнэ. 9 ДҮГЭЭР ХЭСЭГ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН ШҮҮХИЙН ТУСЛАЛЦАА 92 дугаар зүйл 3. Хэрэв хүсэлт хүлээн авсан улс 91 дүгээр зүйлд дурдсан хүлээлгэн өгөх тухай хүсэлт болон энэ хүсэлтийг баталгаажуулсан баримт бичгийг Дэгийн болон нотолгооны журамд заасан тодорхой хугацаанд хүлээж аваагүй бол урьдчилан баривчлагдсан этгээдийг урьдчилан хорихоос чөлөөлж болно. Гэхдээ хүсэлт хүлээн авсан улсын хууль тогтоомж үүнийг зөвшөөрч байгаа бол энэ хугацаа дуусахаас өмнө тухайн этгээдийг хүлээлгэн өгөхийг зөвшөөрч болно. Энэ тохиолдолд хүсэлт хүлээж авсан улс тухайн этгээдийг аль болох богино хугацаанд Шүүхэд хүлээлгэн өгнө.	*405 дугаар зүйл. Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай шаардлагыг биелүүлэх* 405.1. Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ. *406 дугаар зүйл. Шилжүүлэн өгөхөөс татгалзах* 406.1. Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй: 406.1.1. Монгол Улсын иргэн; Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн *61 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх* 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад *улсын иргэн бол энэ хуулийн 61.1-*д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.	Учир нь өөрийн улсын иргэнийг гадаадын шүүхэд шилжүүлэн өгөхгүй байх дээрх үзлийг хөндөхгүйгээр ОУЭШ үйл ажиллагаагаа явуулна гэж ойлгож болох юм. ОУЭШ бол нэгдүгээрт, гадаад бүрэн эрхт улсын шүүх биш, хоёрдугаарт, ОУЭШ нь шударга ёсны батаалгаат гадаад улсын шүүхээс илүү хангаж өгнө. Өөрөөр хэлбэл Дүрэм нь ямар ч улсын хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хангах олон улсын стандартыг тусгаж өгсөн. Нөгөөтэйгүүр, ОУЭШ нь олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэл зоригоор, зөвшилцөлөөр бий болсон, энд хэн нэгэн улсын эрх ашиг, бүрэн эрхийн ноёрхол байхгүй. Манайх шиг *тус шүүхийг байгуулсан улс болгон* ОУЭШ-ийн үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцдог. ОУЭШ-тэй хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ийм нөхцлийг оруулах шаардлагатай.	405.1. Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг болон хүлээлгэн өгөх тухай Олон улсын эрүүгийн шүүхийн хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ. *406 дугаар зүйл. Шилжүүлэн өгөхөөс татгалзах* 406.1. Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй: 406.1.1. Монгол Улсын иргэнийг Олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөхөөс бусад тохиолдолд; Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмж өөрчлөн найруулах 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын консулын буюу Дипломат төлөөлөгчийн газарт, эсхүл олон улсын гэрээнд заагдсан журмын дагуу олон улсын байгууллагад мэдэгдэнэ.

ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.tuv.gov.mn

	9 ДҮГЭЭР ХЭСЭГ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН ШҮҮХИЙН ТУСЛАЛЦАА	*408 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх зорилгоор цаадан хорих* 408.1. Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчилж шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ. 408.2. Энэ хуулийн 408.1-д заасны дагуу цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол прокурорын тогтоолоор суллана. *409 дүгээр зүйл. Эд зүйл, бусад нотлох баримтыг шилжүүлэх* 409.1. Энэ хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ. 409.3. Гадаад улсын холбогдох байгууллага хэргийг шийдвэрлэж дуусмагц энэ хуулийн 409.1-д дурдсан эд зүйлийг буцааж өгөх тухай баталгаа гаргасан үед шилжүүлнэ.		*408 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх, эсхүл хүлээлгэн өгөх зорилгоор цаадан хорих* 408.1.Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхийн эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт этгээдийг хүлээлгэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчилж шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ. 408.2. Энэ хуулийн 408.1-д заасны дагуу цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж болон Олон улсын эрүүгийн шүүхийн Дэгийн болон нотолгооны журамд заасан тодорхой хугацаанд хүлээн аваагүй бол прокурорын тогтоолоор суллана. *409 дүгээр зүйл.Эд зүйл, бусад нотлох баримтыг шилжүүлэх* 409.1. Энэ хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн мөн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг Олон улсын шүүхэд хүлээлгэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ. 409.3. Гадаад улс, олон улсын байнууллагын холбогдох байгууллага хэргийг шийдвэрлэж дуусмагц энэ хуулийн 409.1-д дурдсан эд зүйлийг буцааж өгөх тухай баталгаа гаргасан үед шилжүүлнэ.

ЦЕНТРАЛЬНЫЙ ХУРЕЭЛЕНГИЙ ИНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.tuv.mn

		410 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх үндэслэл 410.1. Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх, түүнчлэн гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг Монгол Улсад шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гүйцэтгэнэ. *412 дугаар зүйл. Ял эдлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх* 412.1. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг тухайн ялтан, түүний хууль ёсны төлөөлөгч буюу төрөл, садангийн хүн, түүнчлэн ялтны зөвшөөрснөөр тухайн улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллага Монгол Улсын ерөнхий прокурорт уламжилна. 412.3.Монгол Улсын ерөнхий прокурор хүсэлтийг хангасан бол ялтныг тухайн улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу шилжүүлж авна.		*410 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх үндэслэл* 410.1. Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөх, түүнчлэн гадаад улсын шүүхээр, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг Монгол Улсад шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ болон Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм болон тухайн шүүхтэй байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гүйцэтгэнэ. *412 дугаар зүйл. Ял эдлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх* 412.1. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын шүүхээр болон олон улсын эрүүгийн шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг тухайн ялтан, түүний хууль ёсны төлөөлөгч буюу төрөл, садангийн хүн, түүнчлэн ялтны зөвшөөрснөөр тухайн улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл тухайн улс, олон улсын эрүүгийн шүүхийн эрх бүхий байгууллага Монгол Улсын ерөнхий прокурорт уламжилна. 412.3.Монгол Улсын ерөнхий прокурор хүсэлтийг хангасан бол ялтныг тухайн улстай байгуулсан болон Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм болон тухайн шүүхтэй байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу шилжүүлж авна.

ЭРҮҮГИЙН ХҮРЭЭЛЭН ТАЙЛАН
www.tuzgoo.mn

		413 дугаар зүйл. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон асуудлыг шүүхээр шийдвэрлэх журам *413.2. Шүүгчийн захирамжид даравх зүйлийг заасан байна:* *413.2.1. гадаад улсын шүүхийн нэр, шийдвэр гаргасан газар, он, сар, өдөр;* *413.2.3. ялтны үйлдсэн гэмт хэрэг, гадаад улсын шүүхээс түүнд хэрэглэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт;* *413.2.5. гадаад улсын шүүхээс ялтанд оногдуулсан ялын хугацаа, хорих ангийн төрөл, Монгол Улсад эдэлбэл зохих ялын хугацаа, хорих ангийн төрөл, хохирол нөхөн төлөх журам.* *413.3. Гадаад улсын шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа нь Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох ялын дээд хэмжээнээс их байвал Монгол Улсад ял эдлэх хугацааг Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээгээр тогтооно.* *413.4. Гадаад улсын шүүх хорих ял оногдуулсан боловч Монгол Улсын хуулиар уг хэрэгт хорих ял оногдуулж болохооргүй байвал шүүгч уг этгээдэд гадаад улсын шүүхээс оногдуулсан ялтай дүйцэхүйц төрөл, хугацааны өөр төрлийн ял эдлүүлэхээр шийдвэрлэнэ.*		*413 дугаар зүйл. Гадаад улсын болон* Олон улсын эрүүгийн *шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон асуудлыг шүүхээр шийдвэрлэх журам* 413.2. Шүүгчийн захирамжид дараахь зүйлийг заасан байна: 413.2.1. гадаад улс, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхийн нэр, шийдвэр гаргасан газар, он, сар, өдөр; 413.2.3. ялтны үйлдсэн гэмт хэрэг, гадаад улсын, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхээс түүнд хэрэглэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт; 413.2.5. гадаад улсын, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхээс ялтанд оногдуулсан ялын хугацаа, хорих ангийн төрөл, Монгол Улсад эдэлбэл зохих ялын хугацаа, хорих ангийн төрөл, хохирол нөхөн төлөх журам. 413.3. Гадаад улсын, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа нь Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох ялын дээд хэмжээнээс их байвал Монгол Улсад ял эдлэх хугацааг Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээгээр тогтооно. 413.4. Гадаад улсын шүүх, эсхүл Олон улсын эрүүгийн шүүх хорих ял оногдуулсан боловч Монгол Улсын хуулиар уг хэрэгт хорих ял оногдуулж болохооргүй байвал шүүгч уг этгээдэд гадаад улсын, эсхүл Олон улсын эрүүгийн шүүхээс оногдуулсан ялтай дүйцэхүйц төрөл, хугацааны өөр төрлийн ял эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.tuv.gov.mn

Дараах зохицуулалтыг эрүүгийн хууль тогтоомжид нэмж оруулах

- Гэрчийн дархан эрхийн баталгааг олгох талаар зохицуулалт оруулах
- Хүн төрөлхтөний энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт сэжиглэгдэж буй дипломат дархан эрх, эрх ямба эдэлж буй этгээдийн орон байрт нэвтрэх ба нэгжлэг хийх, баривчлах, битүүмжлэх ажиллагааг Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл түүнийг оролж буй этгээдийн зөвшөөрөлтэйгөөр явуулах ба үл зөвшөөрөх тохиолдолд Олон улсын эрүүгийн шүүхэд мэдэгдэнэ. Тухайн зөвшөөрлийг тухайн улсын гадаад хэргийн ямнаас Прокурор хүснэ. Дээрх ажиллагааг явуулахад прокурор болон тухайн улсын гадаад хэргийн ямны төлөөлөгч заавал байлцана.
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд “бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцлийг санаатайгаар бий болгосон” үйлдлийг конвенцийн заалтын агуулгаар гэмт хэрэг болгон хуульчлах
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Хүн төрөлхтөний аюулгүй байдал. энх тайвны эсрэг гэмт хэрэг”-ийн бүлэгт Дүрэмд заасан “Боолчлох, Хүн амыг албадан гаргах буюу хүчээр нүүлгэн шилжүүлэх”, “Эрүүдэн шүүх”, “Хүчиндэх, бэлгийн боолчолд оруулах, биеэ үнэлэхэд тулган хавчих, *албадан жирэмслүүлэх*, хүчээр засаж хөнгөлөх”, “Мөрдөн мөшгих”, “Хүнийг сураггүй алга болгох” гэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор Дүрмийн заалтын агуулгаар хуульчлах
- Зэвсэгт мөргөлдөөн гаргах гэмт хэрэг үйлдэхдээ “Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон эдгээр үйлдлийг хийснийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 297 дугаар зүйлд заасан “Зэвсэгт мөргөлдөөн гаргах” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон конвенцийн заалтын агуулгаар хуульчлах
- Зэвсэгт мөргөлдөөн гаргах гэмт хэрэг үйлдэхдээ “Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон эдгээр үйлдлийг хийснийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 297 дугаар зүйлд заасан “Зэвсэгт мөргөлдөөн гаргах” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон конвенцийн заалтын агуулгаар хуульчлах
- Зэвсэгт мөргөлдөөн гаргах гэмт хэрэг үйлдэхдээ “Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон эдгээр (Дүрэмд заасан) үйлдлийг хийснийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 297 дугаар зүйлд заасан “Зэвсэгт мөргөлдөөн гаргах” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон конвенцийн заалтын агуулгаар хуульчлах
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд “Төрлөөр устгах гэмт хэргийг сурталчлах, өдөөн хатгах” үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх тухай заах
- Монгол Улсын ЭБШХ-ийн 313.4 дүгээр зүйлийн заалтад Дүрмийн болон ЭБШХ-ийн 288.5; 349.5 дугаар зүйлийн заалтуудтай нийцүүлэн өөрчлөлт оруулах
- Монгол Улсын ЭБШХ-ийн “Эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөх” гэсэн бүлэгт “Гэмт этгээдийг дамжуулан өнгөрүүлэх шаардлагыг биелүүлэх” гэсэн зүйл нэмж оруулах
- Монгол Улсын ЭБШХ-ийн “Эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөх” гэсэн бүлэгт “Шилжүүлэн өгөхийг хойшлуулах” гэсэн зүйл нэмж оруулах

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 1973 оны 1 дүгээр сарын 26-нд хүчин төгөлдөр болсон[295]/

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* Хэрэв аливаа этгээд дараахь үйлдлийг хууль бусаар болон санаатайгаар үйлдсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ: (a) нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүч хэрэглэсэн бөгөөд энэ нь агаарын тухайн хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахаар байвал; (b) нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар ашиглалтанд байгаа агаарын хөлгийг бүрмөсөн эвдсэн, эсхүл түүнд гэмтэл учруулсан; *(c) ашиглалтанд байгаа агаарын хөлгийг эвдэх, эсхүл түүнийг бүрмөсөн эвдэх буюу нислэг үйлдэх боломжгүй болохуйц хохирол учруулахаар гэмтээх чадалтай төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан;* *(d) агаарын навигацын тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн, эсхүл түүний ашиглалтад саад учруулсан бөгөөд аливаа иймэрхүү үйл ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан;* *(e) худал гэдгийг нь мэдсээр байж агаарын хөлгийн нислэгт аюул учруулж болохуйц мэдээлэл өгснийг тус тус гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.*	*Эрүүгийн хууль* *224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих* 224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисэж ирэх буюу Монгол Улсаас нисэж гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шаптгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 224.2.Энэ хэргийн улмаас агаарын хөлөг осолдсон, сүйрсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. *225 дугаар зүйл. Агаарын хөлөг авч зугтаах* *225.1.Нислэгт буюу газарт байгаа агаарын хөлгийг авч зугтаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *225.2.Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл хөлгийг авч зугтаах зорилгоор эзэлж авсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *225.3.Энэ хэргийг давтан, эсхүл олон хүний амь насанд аюултай арга, зэвсэг хэрэглэж буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	Монгол Улсын Эрүүгийн хуульд иргэний агаарын тээврийн нислэг, агаарын хөлгийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг 224; 225 дугаар зүйлээр зохицуулсан байх боловч эдгээр нь энэхүү конвенцийн заалтын агуулгатай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, конвенцийн заалтын агуулга Эрүүгийн хуульд тусгагдаагүй ажээ. Ийнхүү Монгол Улс Олон улсын гэрээний хэм хэмжээг хууль тогтоомждоо тусгалгүй Үндсэн хуульд заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зөрчиж байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд *"Иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдалд саад учруулах"* гэсэн зүйлийг энэхүү конвенцийн заалт нэг бүрээр "Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг" гэсэн бүлэгт нэмж хуульчлах

Дараах зохицуулалт эрүүгийн хууль тогтоомжид нэмж оруулах

- Монгол Улсын Эрүүгийн хуульд *"Иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдалд саад учруулах"* гэсэн зүйлийг энэхүү конвенцийн заалт нэг бүрээр "Тээврийн.хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг" гэсэн бүлэгт нэмж хуульчлах

[295]Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 870-876 дахь тал.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛЬ ХОТНОО 1971 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР ҮЙЛДСЭН КОНВЕНЦИЙН ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХЭД ҮЙЛЧИЛДЭГ НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ[296]

/1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	2 дугаар зүйл 1. Конвенцийн 1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 1bis хэсэг шинээр нэмнэ: "1bis. Дараахь үйлдлийг хууль бусаар санаатайгаар аливаа төхөөрөмж, бодис буюу зэвсэг хэрэглэн хийснийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ: (а) олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүний эсрэг түүнд хүнд гэмтэл учруулах буюу амь насыг нь хохироох, эсхүл хүнд гэмтэл учруулж буюу амь насыг нь хохироож болзошгүй үйлдлийг хүч хэрэглэн хийсэн; эсхүл	*Эрүүгийн хууль* *224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих* 224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисэж ирэх буюу Монгол Улсаас нисэж гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шалтгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 224.2.Энэ хэргийн улмаас агаарын хөлөг осолдсон, сүйрсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд иргэний агаарын тээврийн нислэг, агаарын хөлгийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг 224; 225 дугаар зүйлээр зохицуулсан байх боловч эдгээр нь конвенцийн энэ заалтын агуулгатай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, конвенцийн заалтын агуулга Эрүүгийн хуульд тусгагдаагүй ажээ. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүрэг биелэгдэхгүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцийн энэхүү заалтын агуулгыг дараах байдлаар тусгах - Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүн алсан хэргийг "Хүнийг санаатай алах" гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож; - Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүний биед гэмтэл учруулсан үйлдлийг хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож;

[296] Монгол Улс 1999.10.22–нд нэгдэн орсон

	(b) олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудлын төхөөрөмж буюу уг нисэх буудал дахь ашиглалтад бус байгаа агаарын хөлгийг эвдсэн буюу ноцтой хохирол учруулсан, эсхүл нисэх буудлын ажиллагааг тасалдуулсан нь тухайн нисэх буудлын аюулгүй байдалд заналхийлсэн буюу заналхийлж болзошгүй байвал".	*225 дугаар зүйл. Агаарын хөлөг авч зугтаах* 225.1.Нислэгт буюу газарт байгаа агаарын хөлгийг авч зугтаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 225.2.Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл хөлгийг авч зугтаах зорилгоор ээлж авсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 225.3.Энэ хэргийг давтан, эсхүл олон хүний амь насанд аюултай арга, зэвсэг хэрэглэж буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.		- "Агаарын хөлөг, иргэний нисэхийн төхөөрөмжийг эвдэх, гэмтээх" гэсэн зүйлийг "Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт нэмж тус тус хуульчлах

БҮРЭН ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

/1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталж, 1969 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон[297]/

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* 1. Энэхүү конвенцийг дараах тохиолдолд хэрэглэнэ: (a) эрүүгийн хуулийг зөрчсөн гэмт хэрэг; (b) гэмт хэрэг мөн эсэхээс үл шалтгаалан агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан хийгээд учруулж болзошгүй үйлдэл. 2. III дугаар бүлэгт зааснаас бусад тохиолдолд агаарын хөлөг нислэгт буюу их далайн гадаргуу дээр байх үед, эсхүл аливаа улсын нутаг дэвсгэрээс гадна байгаа оролцогч улсад бүртгүүлсэн аливаа агаарын хөлгийн бүхээгт хэн нэг этгээд гэмт хэрэг буюу бусад үйлдэл үйлдсэн тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэнэ. *3. Энэхүү конвенцийн зорилгод хөвргөхөөр хөдөлгүүрээ асаасан мөчөөс эхлэн буух гүйлт нь дуусах мөч хүртэл агаарын хөлгийг нислэгт байгаа гэж үзнэ.* *4. Энэхүү конвенцийг цэрэг, гааль, цагдаагийн албанд ашиглаж байгаа агаарын хөлгийн тухайд хэрэглэхгүй*	*Эрүүгийн хууль* *224 дүгээр зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих* 224.1.Олон улсын нислэг үйлдэж байгаа нисэх багийн бүрэлдэхүүн зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад нисч ирэх буюу Монгол Улсаас нисч гарах, зөвшөөрөгдсөн агаарын зам, хаалга, буух газрыг хүндэтгэх шалтгаангүйгээр дур мэдэн өөрчлөх зэргээр олон улсын нислэгийн журмыг зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 224.2.Энэ хэргийн улмаас агаарын хөлөг осолдсон, сүйрсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. *225 дугаар зүйл. Агаарын хөлөг авч зугтаах* *225.1.Нислэгт буюу газарт байгаа агаарын хөлгийг авч зугтаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *225.2.Энэ хэрийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл хөлгийг авч зугтаах зорилгоор эзэлж авсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *225.3.Энэ хэргийг давтан, эсхүл олон хүний амь насанд аюултай арга, зэвсэг хэрэглэж буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	Монгол Улсын Эрүүгийн хуульд олон улсын нислэг үйлдэж буй нисэх багийн бүрэлдэхүүн нислэгийн журам зөрчих болон агаарын хөлгийг авч зугтаах үйлдлийг гэмт хэрэг болгон хуульчилсанаас биш агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн аливаа зөрчлийг гэмт хэрэгт тооцох тухай хуульчлаагүй. Иймээс Монгол Улс конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.	- Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Агаарын хөлгийн бүхээгт гэмт хэрэг үйлдэх" гэх зүйл нэмж оруулан уг зүйлд агаарын хөлгийг хөвргөхөөр хөдөлгүүрээ асаасан мөчөөс эхлэн буух гүйлт дуусах мөч хүртэлх хугацаанд хөлгийн бүхээгт Эрүүгийн хуулийг зөрчсөн гэмт хэрэг үйлдсэнийг уг гэмт хэрэг гэж үзэж, ял шийтгэл оногдуулахаар заах. - Мөн хуульд энэ зүйлийг цэрэг, гааль, цагдаагийн албанд ашиглаж байгаа агаарын хөлгийн тухайд хэрэглэхгүй гэсэн тайлбар оруулах.

[297] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 895-903 дахь тал.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТАД ОРОХ ХҮМҮҮС, ТҮҮНИЙ ДОТОР ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН ШИЙТГЭХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1973 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталж, 1977 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон[298]/*

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*2 дугаар зүйл* 1. Санаатайгаар: (a) олон улсын хамгаалалтад байдаг хүний амийг хөнөөх, хулгайлах, түүнд болон түүний эрх чөлөөнд халдах; (b) олон улсын хамгаалалтад байдаг хүн, түүний эрх чөлөөнд аюул учруулах магадлалтайгаар түүний албан байр, орон сууц, тээврийн хэрэгсэлд хүч хэрэглэн халдах; (c) ийм аливаа халдлага хийхийг заналхийх; *(d) ийм аливаа халдлага хийхийг заедах;* *(e) ийм аливаа халдлага үйлдэхэд хамтран оролцсон үйлдлийг оролцогч улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж үзвэл зохино.* *2. Оролцогч улс бүр эдгээр гэмт хэрэгт тэдгээрийн ноцтой шинжийг харгалзсан зохих шийтгэл оногдуулахаар тогтоно.*	*Эрүүгийн хууль* *301 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох* 301.1. Дайн өдөөх, улс хоорондын харилцааг хурцатгах зорилгоор олон улсын хамгаалалтад байдаг гадаад улсын төлөөлөгч, олон улсын байгууллагын ажилтан, түүнчлэн тэдний албан өрөө, орон байр, тээврийн хэрэгсэлд халдан довтолсон бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 301.2.Энэ хэргийг үйлдэхдээ олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийг алсан, барьцаалсан, эд хөрөнгийг нь их хэмжээгээр гэмтээсэн, устгасан бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. *Тайлбар: Энэ зүйлд дурдсан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс гэдэгт гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн аазар, гадаад улсын гадаад худалдааны байгууллагын ажилтнууд, дипломат элч, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад өөрийн улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хамаарна. Дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан өрөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна.* *60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу заедсан үйлдэлд ял оногдуулах* *37 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага*	Конвенцид олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдсан бол ямар зорилгоор халдсанаас үл хамааран уг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхийг үүрэг болгосон байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох гэмт хэргийг хуульчилсан боловч "дайн өдөөх, улс хоорондын харилцааг хурцатгах" зорилгоор уг гэмт хэргийг үйлдсэн бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна. Конвенцоор олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст аливаа халдлага хийхийг заналхийлсэн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж буй боловч Монгол Улсын Эрүүгийн хуульд "халдлага хийхээр заналхийлэх"-ийг гэмт хэрэг гэж үзэх тухай зохицуулалт байхгүй. Эдгээр нь конвенцийн заалтын агуулгатай нийцэхгүй байна.	- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 301 дүгээр зүйлийн "Дайн өдөөх, улс хоорондын харилцааг хурцатгах зорилгоор" гэдгийг хасч өөрчлөх; - Монгол Улсын Эрүүгийн хуулийн холбогдох заалт буюу 301 дүгээр зүйлийг "Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийг <u>заналхийлэх</u> буюу хүч хэрэглэх" гэж өөрчлөх

[298] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 877-882 дахь тал.

ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР БӨМБӨГ ХЭРЭГЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/1998 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталж, 2001 оны 5 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон[299]/

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*2 дугаар зүйл* 1. Хэрэв аливаа этгээд: (а) хүний амь нас хөнөөх буюу бие махбодид хүнд гэмтэл учруулахыг зорин; эсхүл (b) эдийн засгийн томоохон алдагдалд оруулах, эсхүл оруулж болзошгүй их хэмжээний сүйрлийг тухайн газар, объект, тогтолцоонд учруулахыг зорин тэрэх бодис буюу амь насанд аюултай бусад төхөөрөмжийг нийтийн хэрэглээний газар, төрийн буюу засгийн газрын объект, нийтийн тээврийн тогтолцоо, эсхүл дээ бүтцийн объект, тэдгээрийн эсрэг хууль бусаар, эсхүл санаатайгаар хүргүүлсэн, байрлуулсан, тэсэлсэн, дэлбэлсэн бол уг этгээдийг энэхүү конвенцийн үзэл санааны хүрээнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.	*Эрүүгийн хууль* *1781 дүгээр зүйл. Терроризм* 781.1.Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэхээр заналхийлсэн, энэхүү үйлдлээрээ гоц халдварт өвчин, гал түймэр болон гамшгийн нөхцөлийг бүрдүүлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих яп шийтгэнэ. 1781.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах яп шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд терроризмын гэмт хэргийг хуульчлахдаа түүний эрүүгийн эрх зүйн шинж, гэмт хэргийн субъектив тал (гэмт хэрэг үйлдэх зорилго), объектив тал (гэмт хэрэг үйлдэх арга, хэрэглэх зэвсэг хэрэгсэл)-ийн шинжийг зарим талыг орхигдуулан хуульчилжээ. Хуулийн энэхүү заалт нь конвенцийн энэ заалтын агуулгыг бүрэн тусгаагүй учир Монгол Улс Олон улсын гэрээний хэм хэмжээг хууль тогтоомждоо бүрэн тусгалгүй "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүрэг биелээгдэгүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд терроризмын гэмт хэргийн объектив талын шинж болох гэмт хэрэг үйлдэх арга, хэрэгслэх болон объектив талын шинж болох гэмт хэрэг үйлдэх аргыг конвенцийн заалтын агуулгатайнийцүүлэн тодорхой, нарийвчилж өөрчлөх

[299] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 922-932 дахь тал.

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж, 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон[300]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*2 дугаар зүйл* 1. Аливаа этгээд дараахь хэргийг үйлдэхэд бүрэн буюу хэсэгчлэн ашиглуулах зорилготойгоор, эсхүл тийнхүү ашиглагдахыг мэдсээр байж, мөнгөн хуримтлалыг аливаа байдлаар, шууд буюу шууд бус, хууль бусаар болон санаатайгаар олгосон буюу хуримтлуулсныг энэхүү конвенцийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ: (а) Хавсралтад дурдсан гэрээний аль нэгний үйлчлэлд хамаарах бөгөөд түүний дагуу гэмт хэрэг хэмээн тодорхойлогдсон үйлдлийг хийсэн бол; *(b) Өөрийн шинж чанар, агуулгын хувьд аль нэг зэвсгийн газар, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахыг тулган шаардах болон олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн, эсхүл зэвсэгт мөргөлдөөний үед байлдааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоогүй энгийн иргэд болон аливаа бусад хүний амь насыг нь хөнөөх буюу бие махбодид нь ноцтой гэмтэл учруулах зорилготой аливаа бусад үйлдэл.* *3. Аливаа үйлдийг энэ зүйлийн 1 дэх хэсгээр заасан гэмт хэрэг хэмээн тодорхойлоход 1 дэх хэсгийн (а), (b) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд мөнгөн хуримтлалыг бодитойгоор ашигласан байхыг шаардахгүй.*	177 дугаар зүйл. Зандалчлах 177.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахад шууд буюу шууд бус нөлөөлөх зорилгоор, олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн нийтэд аюултай хүч хэрэглэсэн буюу хэрэглэхээр заналхийлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 177.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулагтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ. Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэлтгэхэд идэвхтэй оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсхүл энэ үйлдлийг таслан зогсооход идэвхтэй оролцсон бөгөөд түүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно 178[2] дугаар зүйл. Терроризмыг санхүүжүүлэх 178[2].1.Террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол эд хөрөнгийг хурааж, *таваас дээш* арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид "Терроризмыг санхүүжүүлэх" гэмт хэргийг нэмж тусгажээ.	

[300] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 933-946 дахь тал.

		178[2] .2.Энэ гэмт хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, эсхүл их хэмжээгээр террорист байгууллага, террорист ажиллагааг санхүүжүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 178[2] .3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээгээр террорист байгууллага, террорист ажиллагааг санхүүжүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.		
2	*5 дугаар зүйл* 1. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр байрладаг буюу түүний хууль тогтоомжийн дагуу байгуулсан хуулийн этгээдийг удирдаж байгаа буюу хяналтдаа байлгадаг этгээд албан ажиллагааныхаа хүрээнд нь 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн бол тухайн хуулийн этгээдэд хуулийн хариуцлага ногдуулах талаар шаардлагатай арга хэмжээг оролцогч улс бүр авна. Тэр нь эрүүгийн, иргэний, эсхүл захиргааны хариуцлага байж болно. *2. Уг хариуцлага нь тухайн гэмт хэрэг үйлдсэн хувь этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс ангид байна.* *3. Оролцогч улс бүр ялангуяа 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэл хүлээлгэсэн хуулийн зохих этгээдэд үр нөлөөтэй, гэм бурууд нь тохирсон, цээрлүүлэх зорилгоо хангахуйц, иргэний болон захиргааны хариуцлагыг тогтооно. Ийм хариуцлага нь мөнгөн хэлбэртэй байж болно.*	*Эрүүгийн хууль* *8 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим* 8.1.Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ. 8.2.Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэх буюу гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчмыг хуульчилсан. Гэвч энэхүү конвенцоор оролцогчулсуудыг хууль тогтоомждоо хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай заахыг үүрэг болгосон байх тул конвенцийн заалтыг харгалзан үзэх шаардлагатай.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай" зохицуулалт нэмж оруулах
3	*14 дүгээр зүйл* Гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зорилгын хүрээнд энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алийг ч улс төрийн гэмт хэрэг, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэж авч үзэж үл болно.	*Эрүүгийн хууль* Эрүүгийн хуулийн тусгай ангийн Нийгмийн Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт авч үзсэн.		

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mnlegov.mn

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1979 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталж, 1987 оны 2 дугаар сарын 8-нд хүчин төгөлдөр болсон[301]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*7 дугаар зүйл* 1. Санаатайгаар: (a) хүний амь насыг хороох буюу хүнд ноцтой гэмтэл учруулж болох, өмч хөрөнгөд ноцтой хохирол учруулж болох цөмийн материалыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хүлээн авах, ээмших, ашиглах, дамжуулах, хэлбэрийг нь өөрчлөх, байрлуулах болон цацаж сарниулах үйлдэл хийсэн; (b) цөмийн материалыг хулгайлах буюу дээрэмдэх замаар булаан авсан; (c) залилан мэхлэх, эсхүл төөрөгдүүлэх замаар цөмийн материалыг олж авсан; (d) хүч хэрэглэх, түүнийг хэрэглэхээр заналхийлэх буюу айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр цөмийн материал өгөхийг шаардсан үйлдэл хийсэн; *(e) дор дурдсанаар заналхийлсэн:* *i) хүний амь насыг хороох, түүнд хүнд гэмтэл учруулах буюу өмч хөрөнгөд нь ноцтой хохирол учруулах зорилгоор цөмийн материалыг ашиглахаар, эсхүл* *(ii) ямарваа үйлдэл хийх буюу түүнээс түдгэлзэхийг хувь хүн болон хуулийн этгээд, олон улсын байгууллага буюу улсад тулган хүлээлгэх зорилгоор* *(b) дэд хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэхээр;*	*Эрүүгийн хууль* 185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх *186 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах* *187 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хамгаалах үүрэгт ажилдаа хайнга хандах* *188 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх* *190 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх болон цацраг идэвхт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх журам зөрчих* *191 дүгээр зүйл.Түргэн шатамхай болон идэмхий бодисыг хууль бусаар илгээх* *300 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг бүтээх, олж авах, тараах*	Конвенцоор хүч хэрэглэх, түүнийг хэрэглэхээр заналхийлэх буюу айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр цөмийн материал өгөхийг шаардсан үйлдэл хийсэн, мөн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээр заналхийлсэн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж буй боловч Монгол Улсын Эрүүгийн хуульд "халдлага хийхээр заналхийлэх"-ийг гэмт хэрэг гэж үзэх тухай зохицуулалт байхгүй. Энэ нь конвенцийн заалттай нийцэхгүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 186 дугаар зүйлд "хүч хэрэглэх, түүнийг хэрэглэхээр заналхийлэх буюу айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр цөмийн материал өгөхийг шаардсан үйлдэл"-ийг гэмт хэрэг гэж үзэх тухай, мөн хуулийн "Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт конвенцийн 7 дугаар зүйлийн "е" –ийн "i, ii"-д заасан үйлдлийг хийхээр заналхийлсэнийг гэмт хэрэг гэж тооцох тухай заалтыг оруулах

[301] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 2006. 883-895 дахь тал

ДАЛАЙН НАВИГАЦЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*3 дугаар зүйл* 1. Хэрэв аливаа этгээд дараах үйлдлийг хууль бусаар, санаатайгаар хийсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ: (a) хөлөг онгоцыг хүчээр булаан авах буюу хянаптандаа оруулсан; (b) хөлөг онгоцны навигацад аюул учруулахуйцаар түүн дээр байгаа этгээдийн эсрэг хүч хэрэглэсэн; (c) хөлөг онгоцыг устасан, эсүүл хөлөг онгоцны навигацад аюул учруулахуйцаар үг хөлөг онгоц буюу түүний ачаанд гэмтэл учруулсан; *(d) хөлөг онгоц устаг, эсүүл хөлөг онгоцны навигацад аюул учруулахуйцаар түүнд буюу түүний ачаанд гэмтэл учруулах тогтөвөрмөж зэ зүйлийг уг хөлөг онгоцонд аливаа арга хэлбэрээр байрлуулсан буюу суурилуулсан;* *(e) хөлөг онгоцны навигацад аюул учруулахуйцаар далайн навигацын төхөөрөмжийг устасан, нөлөөг гэмтээсэн, эсүүл үйл ажиллагаанд нь нөлөөлөх саад учруулсан;* *(f) хөлөг онгоцны навигацад аюул учруулах хүсэл мэдэгдлийг мэдэж байж дамжуулсан* *(g) (a)-аас (f)-д заасан гэмт хэрэгтэй үйлдэхэр заводдоо аливаа этгээдийн бие махбодоо гэмтэл учруулсан, эсүүл түүнийг амиас хөнөөсөн*	Эрүүгийн хуулийн холбогдох заалт Монгол Улсын Эрүүгийн хуульд холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хууль зохицуулалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцид заасан гэмт хэргийг хуульчлагдаагүй нь конвенцийн шаардлагыг хангахгүй байна. Конвенцийн энэ зүйлийн "g" хэсэгт заасан үйлдлийг хийсэн тохиолдолд түүнийг гэмт хэргийг үйлдэхээр завдсанаар болон Эрүүгийн хуулийн тохирох зүйл хэсгээр зүйлчлэх боломжтой.	- Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг"-ийн бүлэгт "Хөлөг онгоц авч зугтаах гэмт хэргийг;
2	(c) 1 дэх хэсгийн (b), (c), (e)-д заасан гэмт хэргийг үйлдэхийн гүлд хүчээ хүч, хүчийн эргэдээр ямарваа нэг үйлдэл хийлгэх, эсүүл эс хийлгэх нөхцөлтэгээр буюу нөхцөлгүйгээр хөлөг онгоцны навигацад аюул учруулахуйцаар заналхийлсэн.	Монгол Улсын Эрүүгийн хуульд холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "хөлөг онгоцны навигацад хандлага,жижээр заналхийлэх"-ийг гэмт хэрэг гэж үзэх тухай зохицуулалт байхгүй. Эдгээр нь конвенцийн заалтын агуулгатай нийцэхгүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн холбогдох заалт /дээрх санаын дагуу орох/-д "хөлөг онгоцны навигацад аюул учруулахаар заналхийлэх" тухай нэмж оруулах

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ЭХ ГАЗРЫН ХОРМОЙД БАЙРЛУУЛСАН СУУРИЛУУЛАХ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ПРОТОКОЛ

/1988 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батлаж, 1992 оны 3 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* 1. Хэрэв аливаа этгээд хууль бусаар болон санаатайгаар дараах үйлдлийг гүйцэтгэсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ: (a) суурилуулах төхөөрөмжийг хүчээр буюу түүнийг заналхийлэх замаар, эсвэл сүрдүүлэх бусад хэлбэрээр булаан авсан буюу хяналтандаа оруулсан; (b) суурилуулах төхөөрөмжид аюул учруулахуйцаар түүн дээр байгаа аливаа этгээдийн эсрэг хүч хэрэглэсэн; (c) суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хохирол учруулахуйцаар түүнийг эвдлэх; (d) суурилуулах төхөөрөмжийг эвдрэлд хүргэх буюу түүний аюулгүй байдалд аюул учруулахуйц тоног төхөөрөмж буюу эд зүйлсийг суурилуулах төхөөрөмжид аливаа арга хэлбэрээр байрлуулах буюу угсрах; (e) энэ зүйлийн (a)-аас (d) хүртэлх дэд хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх буюу үйлдэхээр завдахдаа аливаа этгээдийн бие махбодид гэмтэл учруулсан, эсхүл түүний амийг хөнөөсөн.	Монгол Улсын *Эрүүгийн хуульд* холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцид заасан "Суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг"-ийг хуульчлаагүй байх ба Монгол Улсыг олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд гэмт үзэх бүрэн үндэслэлтэй.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлыг алдагдуулах" гэмт хэргийг конвенцийн заалтын агуулгаар хуульчлах

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

АВИЛГАЛЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*15 дугаар зүйл. Үндэсний төрийн албан тушаалтныг хахуульдах* Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээ авна: (a) төрийн албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь аливаа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг ампах, санал болгох буюу олгох; (b) төрийн албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад аливаа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах. *16 дугаар зүйл. Гадаадын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах* *1. Оролцогч улс бүр гадаадын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь олон улсын үйл ажиллагаа явуулахад хамаарууллан безнесийн буюу зүй бус бусад давуу тал олж авах буюу тийм давуу талаа хадгалах зорилгоор ямарваа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг ампах, санал болгох эсхүл олгох үйлдлийг санаатай үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээ авна.*	*Эрүүгийн хууль* 268 дугаар зүйл. Хээл хахууль авах 268.1.Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан ампах буюу ампахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. *Тайлбар: Хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.* *268.2.Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл даатан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хахууль авсан бол эд хөрөнгийг хураах, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	Авилгалын үйлдэлд хамаарах хээл хахууль өгөх, авах гэмт хэргийг дотор нь үндэсний төрийн албан хаагчийг хахуульдах /15 дугаар зүйл/, гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийг хахуулдах /16 дугаар зүйл/, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ажилтныг хахуульдах /21 дүгээр зүйл/ хэмээн тус Конвенцид ангилан заасан байна. Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд хээл хахууль авах, өгөх гэмт хэргийг хуульчилсан боловч үндэсний болон гадаадын төрийн албан хаагч хахууль авсан, егснийг субъектээр нь ялгаж хуульчлаагүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн үндэсний төрийн албан хаагч хээл хахууль авах, түүнд хээл хахууль өгөх тухай зүйлийн "албан тушаалтан" гэсэн субъектын хүрээг тодоттож, үүнд гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийг хамруулах шаардлагатай. Ингэхдээ гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчид хэнийг хамаарууллахыг нарийвчлан тодорхойлох. Түүнчлэн бусдад давуу байдал олгож байгаа үйлдлийн шинжийг тодорхойлох

ЦЫНТЭЛ ХУРЭЭЛЭН

	2. Оролцоч улс бүр авдаадын төрийн албан тушаалтан эсүл олон улсын байгууллагын албан тушаалтан еврийн албан үүрэлэ хэрэжүүлэх явцад ямарвэа үлдэл хий эсүл хилгээхаүдн түлэ өөртөө эсүл өөр этгээд буюу бадаүүлпаавд шүүх шүүх бусаар зүй бус давуу тал олгохыг шаардаж хаган боодүүлах эсүл давуу тал авах үүлдлэд саһаатайгаар үлдэсэнилэ гэмт хэрэг гаж тоатооход шаардлагатай байх болох хууль болон бусад арга хэмжээ авах асуудлыг анч үзнэ.	269 Дүгээр зүйл. Хээл хахууль авах 269.1.Албан тушаалтанд еврев буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол хөдөлмөрийн хөнсний доод хэмжээ тавин хүүгээс хор тэнь дахин нэмэгдүүлсэнээс таншх хэмжээний төгрөгөөр торгох, эсүл дүрвэх жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 269.2.Энэ хэрэгийг бөөтөн, эсүл хээл хахууллын хэмжээ түрэ ял шийтгүүлсэн этгээд, түүнээн зохион бадуүлалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол тээвэс дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.			
2	18 дугаар зүйл. Эрх мэдэлээ нь урвуулан ашиглуулах Оролцоч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогооход шаардлагатай байж болох хууль тогоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ. (а) ямх үйлдлийг анхлан эхлүүлэх буюу аливаа бусад этгээдэд зорүүлж оролцоч улсын захиргаа буюу төрийн эрх бүхий байгууллагаас зүй бус давуу тал олж авах үүнээс төрийн албан тушаалтан буюу аливаа бусад этгээдийн еөрийн бодит буюу байгаа гэх эрх мэдлээс урвуулан ашиглуулахын туд тухайн албан тушаалтанд еөрт нь эсүл өөр этгээдэд шүүх буюу шүүх бусаар зүй бус давуу тал олгохыг ямлах, санаал болгох буюу олгох; (b) оролцоч улсын заигдсэв буюу төрийн эрх бүхий байгууллагаас зүй бус давуу тал олж авах үүднээс төрийн албан тушаалтан буюу аливаа бусад этгээдийн еөрийн бодит буюу байгаа гэх эрх мэдлээс урвуулан ашиглуулахын туд тухайн албан тушаалтанд еөрт нь эсүл өөр этгээдэд шүүх буюу шүүх бусаар зүй бус давуу тал олгохыг шаардаж хаган боодүүлэх эсүл давуу тал авах.	Монгол Улсын Эрүүгийн хуулиэд конвенцийн энэ заалтын агуулгыг тусгагдүй.	Монгол Улсын Эрүүгийн хуулиэд төрийн албан тушаалтны хэрэгжүүлэх үүрэгтэй хэрэгцээтэй эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт байхгүй ньМонгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн хэрэг болмоз.	Монгол Улсын Эрүүгийн хуулиэд конвенцийн заалтыг албаны түшаалтны эрх мэдэл буюу албан тушаалтай холбоотой гэмт хэрэг"-ийн бүлэгт "Албан албаны эрх ашгийн эсрэг гэмт хэрэг" гэсэн нэрийг өөрчлөх	

ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

3	*20 дугаар зүйл. Хууль бусаар баяжих* Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол иинхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нйицүүлэн авч үзнэ.	Монгол Улсын *Эрүүгийн хуульд* конвенцийн заалтын агуулгатай нийцэх заалт байхгүй.	Монгол Улс Олон улсын гэрээний энэхүү хэм хэмжээг Эрүүгийн хуульдаа тусгалгүй Үндсэн хуульд заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зөрчиж байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Албан тушаалын гэмт хэрэг"-ийн бүлэгт конвенцийн энэ заалтын агуулгаар "Хууль бусаар баяжих" гэмт хэргийг нэмж хуульчлах
4	*23 дугаар зүйл. Гэмт хэргээс олсон орлогыг угаах* 1. Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ: (а) (i) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний хууль бус гарлыг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах эсхүл суурь гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд үйлдсэн хэргийнхээ хууль зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх; *(ii) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулалт, хөдөлгөөн буюу өмчлөл эсхүл түүн дэх эрхийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах;*	*Эрүүгийн хууль* 163 дугаар зүйл. Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах 163.1.Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. *163.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хураах, зуреан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *163.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хураах, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	Монгол Улсын Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийг ерөнхий байдлаар тодорхойлсон байх бөгөөд Конвенцийн энэхүү заалтаар мөнгө угаах гэмт хэрэгт чухам ямар үйлдлүүд хамаарахыг тодорхой заасан байх тул Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийг Конвенцийн заалтад нийцүүлэн өөрчлөх шаардлага тавигдана.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйл "Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах" гэмт хэргийн объектив болон субъектив талын шинжийг Конвенцийн заалтын агуулгаар нарийвчлан зааж өөрчлөх

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

5	*26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн хариуцлага* 1. Оролцогч улс бүр эрх зүйн зарчимтай нийцүүлэн энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хуулийн этгээдэд хариуцлагыг тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна. 2. Оролцогч улсын эрх зүйн зарчмуудаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага эрүүгийн, иргэний буюу захиргааны байж болно. 3. Ийм хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүний эрүүгийн хариуцлагатай хөндөхгүй. 4. Оролцогч улс бүр ялангуяа энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд үр ашигтай, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг хийхгүй байлгах эрүүгийн буюу эрүүгийн бус шийтгэл, түүний дотор мөнгөн торгуулийн шийтгэл ногдуулна.	Эрүүгийн хууль *8 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим* 8.1.Эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ. 8.2.Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэх буюу гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчмыг хуульчилсан. Гэвч конвенцоор оролцогч улсуудад хууль тогтоомждоо хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай заалт оруулах талаар шаардлагатай арга хэмжээ авахыг үүрэг болгосон байх агаад Монгол Улс Олон улсын гэрээгээр хүлээсэн энэхүү үүргээ биелүүлээгүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай" нэмж зохицуулах
6	*32 дугаар зүйл. Гэрч, шинжээч болон хохирогчийг хамгаалах* 1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг ес хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна.	Монгол Улсын *Эрүүгийн хуульд* конвенцийн энэ заалттай холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд гэрч (шинжээч, хохирогч болон тэдний гэр бүлийн гишүүн)-г ес хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах тухай зохицуулалт байхгүй бөгөөд энэ нь тус улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн явдал болжээ.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Гэрч, хохирогч, шинжээч, тэдний гэр бүлийн гишүүдэд дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, эрх, эрх чөлөөнд нь халдах" гэмт хэргийг нэмж хуульчлах

Хууль зүйн ундэсний хүрээлэн www.nli.gov.mn

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

АРЬС ҮНДСЭЭР АЛАГЧИЛАХ ҮЗЛИЙН БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ[302]

/Ерөнхий Ассамблейн 2106 (XX) тоот тогтоолоор 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталж, 1969 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	4 дүгээр зүйл (b) арьс үндэсний дээрэнгүй буюу үзэн ядах санаар дэлгэрүүлэх, арьс үндсээр алагчлах үзэлд элдвээр өдөөн турхирах, мөн аливаа арьс үндэстэн буюу өөр угсаатны гаралтай бүлэг хүмүүсийн эсрэг чиглэсэн хүчирхийлэх буюу тийн үйлдэхэд өдөөн турхирах, түүнчлэн санхүүжүүлэх зэрэг арьс үндсээр алагчлахад туслалцаа үзүүлэхийг хуулиар шийтгэх гэмт хэрэг мөн гэж зарлан мэдэгдэнэ. (c) Арьс үндсээр алагчлах үзлийг өөгшүүлэн дэмжиж, өдөөн турхирч байгаа байгууллагууд, түүнчлэн иймэ зорилгоор зохион байгуулсан хийгээд бусад сурталчилгаа хууль бус хэмээн зарлан мэдэгдэж, үйл ажиллагааг нь хориглож, иймэ байгууллага буюу үйл ажиллагаанд оролцохыг хуулиар шийтгэх гэмт хэрэг хэмээн үзнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцийн энэ заалтын агуулга бүхий заалт байхгүй. .	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Арьс үндсээр алагчлах үйлдлийг гэмт хэрэг" гэж тооцох тухай заагаагүй нь олон улсын гэрээний хэм хэмжээг хууль тогтоомжоо тусгалгүй Үндсэн хуульд заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зөрчсөн хэрэг болсон байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт *"Арьс үндсээр алагчлах"* гэмт хэрэгийг энэхүү конвенцийн заалт нэг бүрээр "нэмж хуульчлах

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

[302] Монгол Улс 1969.03.31-нд соёрхон баталсан.

АПАРТЕИДЫН ГЭМТ ХЭРГИЙГ ТАСЛАН ЗОГСООХ, ТИЙМ ГЭМТ ХЭРГИЙГ ҮЙЛДЭГЧДИЙГ ШИЙТГЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/Ерөнхий Ассамблейн 1973 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3068 (XXVIII) дугаар тогтоолоор батлагдсан, 1976 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон[303]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*2 дугаар зүйл* ... "апартеидын гэмт хэрэг" гэсэн нэр томъёонь нэг арьс үндэстэн нөгөөгөө эрхшээлдээ оруулан ноёрхох, байнга дарлан мөлжих зорилгоор хийсэн хүмүүнлэг бус дараахь үйлдлийг хэлнэ. 2.дор дурдсан аргаар арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүн буюу гишүүдийн амьд явах эрх хийгээд хувийн эрх чөлөөг хасах; I/ арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн амь насыг хороох; II/ арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн бие махбодид ноцтой гэмтэл учруулах буюу сэтгэцэд согог суулгах, тэдний эрх чөлөө, нэр төрд халдах, эрүү шүүлт тулгах болон хэрцгий, хүмүүнлэг бусаар хандаж харьцах, нэр төрийг нь доромжлох, шийтгэх; III/ арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийг дур мэдэн баривчлах, хууль бусаар шоронд хорих; (b) арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгахад чиглэсэн амьдрал ахуйн нөхцлийг санаатайгаар бий болгох;	Эрүүгийн хууль 91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах 96 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах 110 дугаар зүйл. Доромжлох 111 дүгээр зүйл. Гүтгэх 248 дугаар зүйл. Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх 249 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар баривчлах	Монгол Улсын Эрүүгийн хуульд хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, нэр төрд халдан гүтгэх, доромжлох, хууль бусаар ял шийтгэх, хууль бусаар хорих, баривчлах гэмт хэргийг хуульчилсан боловч конвенцид заасан зорилгоор дээрх гэмт хэргийг үйлдэхийг хэрэхэх тухай заагаагүй байна.	- "Арьс үндэстэн нөгөөгөө эрхшээлдээ оруулан ноёрхох, байнга дарлан мөлжих зорилгоор" Монгол Улсын Эрүүгийн хуулийн 91, 96, 110, 111, 248, 249 дүгээр зүйлүүдэд заасан гэмт хэрэг үйлдэсний дээрх гэмт хэргүүдийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож хуульчлах. - "Арьс үндэстэн нөгөөгөө эрхшээлдээ оруулах буюу ноёрхох зорилгоор тэдний нэг буюу хэд хэдэн бүлгийг .. устгахад чиглэсэн амьдралын өөр нөхцөл бий болгох" үйлдлийг хохирол шаардахгүйгээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн *"Арьс үндсэзр алагчлах"* гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүн болгон хуульчлах

[303] "Төрийн мэдээлэл" тусгай дугаар I боть, 2004, 145-151 дахь тал

Эрүүгийн хууль нэмэлт өөрчлөлт оруулах санал

БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДААГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1926 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр батлаж, 1927 оны 3 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон, 1953 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн протоколоор өөрчлөлт оруулж, уг протокол нь 1955 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон[304]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* Энэхүү конвенцийн зорилгод дараах нэр томьёог хэлэлцэн тохиров: 1. Боолчлол гэдэгт өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг ойлгоно.	*Эрүүгийн хууль* 113 дугаар зүйл. Хүн худалдаалах 113.1.Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмэгз байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 113.2.Энэ хэргийг: 113.2.1.насанд хүрээгүй хүнийг; 113.2.2.хоёр буюу түүнээс олон хүнийг; 113.2.3.хүлгайлах; 113.2.4 эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг; 113.2.5.давтан; 113.2.6.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд хүнийг боол болгох зорилгоор олж авах, эрхэндээ оруулах үйлдлийг гэмт хэрэг болгон хуульчлаагүй.	- Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүний эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Хүнийг боолчлох" гэсэн зүйлийг энэ конвенцийн заалтын агуулгаар нэмэх.

[304]Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар IV боть. 2006 он. 947-951 дахь тал

	2. Боолын худалдаа гэдэгт хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл; боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл; худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна.	*113.3.Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *Тайлбар:* *1. Энэ хуулийн 113.1-д заасан "мөлжих" гэдгийг худалдагдсан хүний биеийг нь үнэлүүлэх ээргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.* *2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.*	Харин хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг хуульчилсан боловч уг гэмт хэргийг "хүнийг боол болгох зорилго"-оор худалдсан, худалдан авсныг гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон хуульчлаагүй байна.	- Хүнийг боол болгох зорилгоор худалдсан, худалдан авсаныг "Хүн, худалдах, худалдан авах" гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчлах.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

БООЛЧЛОЛ, БООЛЫН ХУДАЛДАА БОЛОН БООЛЧЛОЛТОЙ АДИЛТГАХ ЁС, ЗАНШЛЫГ УСТГАХ ТУХАЙ НЭМЭЛТ КОНВЕНЦ

/1956 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1957 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон[305]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүү. ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* Энэхүү конвенцид оролцогч улс гүрэн бүр Женев хотноо 1926 оны 9 дүгээр сарын 25-нд гарын үсэг зурсан Боолчлолын тухай конвенцийн 1 дүгээр зүйлд заасан боолчлолын тухай тодорхойлолтод туссан эсэхийг нь харгалзалгүйгээр хараахан устаагүй байгаа дараахь ёс болон заншлыг бүрэн халах буюу устгахыг аль болох богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд бүхий л хэрэгжихүйц болон шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээ авна: *(с) Дараахь үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс. заншил:* *(i) эмэгтэй хүнийг өөрөө болон биет эд зүйлийн орлогч төлөө болзолтойгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр түүнийг эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өөвхийг амласан эсхүл өгсөн;* *(ii) эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйг өөр хүнд үнэтэй эд зүйлсийн орлогч буюу бусад хэлбэрээр шилжүүлэн өгөх эрх эдэлдэг байх;*	*Эрүүгийн хууль* 124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 124.1.Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хүүрч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. *124.2.Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан жижүүрлэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *124.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүтэлгэлт үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гүйланчлалд татан оруулах* *115.1.Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гүйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорироос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан жижүүрлэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.*	Монгол Улсын Эрүүгийн хуульд бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах, зохион байгуулах, насанд хүрээгүй этгээдийг биеэ үнэлэхэд татан оруулах, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх үйлдлийг гэмт хэрэг гэж заасан байна. Харин конвенцид заасан зорилгоор буюу "менгө болон биет эд зүйлийн орлогч төлөө зорилгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр хүнийг бусдад өгсөн, уг үйлдлийг хийхээр амласан"-ыг гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон хуульчлаагүй. Мөн дээрх зорилгоор эмэгтэй хүнийг бусдад эхнэр болгож өгсөн, түүнийг амласан үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх тухай заалт байхгүй байна.	- "Менгө болон биет эд зүйлийн орлогч төлөө зорилго"-оор эмэгтэй болон насанд хүрээгүй хүний биеийг нь үнэлүүлсэн, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэнийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 124, 115, 121 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хүнд рүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчлах; - Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүний эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт нэмж оруулах "Хүнийг боолчлох" гэсэн зүйлд дээр дурдсан зорилгоор эмэгтэй хүнийг бусдад эхнэр болгож өгсөн, түүнийг амласан үйлдлийг гэмт хэрэг болгож хуульчлах.

[305] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар IV боть. 2006. 951-957 дахь тал

	(iii) хөвгүүд нь нас барахдаа хүлээсэн хэрэгсэл буюу хасагдсан хөдлөмрийн хэсэгт доод хэмжээ тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зуравнаас дээш зураагаар сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. *(d) 18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдэд ашиглах буюу төлөөлөгчийн хөдлөмрийг зөвшөөрөлгүйгээр зарах, эсхүл хүчээр хөдлөмрийг хөдлөмрийг зориулалтын бусаар ашиглуулах зэрэг үйлдэл нь энэхүү хуулийн 115.3.2-т заасан гэмт хэрэгт тооцох бөгөөд хэрэгслийг хөдлөмрийн хэсэгт доод хэмжээ тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зуравнаас дээш зураагаар сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.* *115.3.3.Энэ хэрэгцээ дагтан, эсхүл хүч хэрэлэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хөдлөмрийн хэсэгт доод хэмжээ нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зуравнаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *121 дүгээр зүйл. Хүүхдийг албадан болон хууль бусаар хөдлөмрүүлэх* *121.1.Хүүхдийг албадан болон хууль бусаар хөдлөмрүүлсэн бол хөдлөмрийн хэсэгт доод хэмжээ нэг зуугаас тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*			
2	3 дугаар зүйл 1.Бөөлөн нэг улсаас нөгөө улсад төрөлийн аль нэг хэрэгсэлээр буюу төвөрөлтэхний завсаж, эсхүл түүнд ороолсон үйлдлийг энэхүү конвенцид ороолсон улсууд хуулийн дагуу гэмт төөдөн нийгэмд хэрэг үйлдэгчдэд наш хүчд ял оногдуулна. 2. (а) Энэхүү конвенцид ороолсон улсууд түүний төрийн дайбаар хэрэглэх эвлэрөлт буюй хөлөг онгоц болон агаарын хөлөөр бөөн төвөөрлэх, улсынхаа төрийн дайбаар тийм зорилгоор ашиглахаас урьчилан сэргийлэх, иймэрхэг гэмт бүрүтгай эгээдлийг шийтгэх тайлар ур нөлөөтэй арга хэмжээ авна. (b) Энэхүү конвенцид ороолсон улсууд бөөн төвөөрлэхэд хэрэглэх эвлэрөлт буюй эргэз ашиглуулахтүй байх наслыг хангах ур нөлөөтэй бүхий л арга хэмжээ авна.	*113 дугаар зүйл. Хүн хулгайлах* *113.1.Ашиг олох буюу мөнгөн зорилгоор хүн хулгайлахадаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хуурай мэхлэсэн, эмэгт бандлын нь дагинэдүүлсэн, түүнчлэн бусдыг эрсүүлсэн, төвөөрлэсэн, дамжуулсан, ороолуулсан, хүлээн авсан бол* *хөдлөмрийн хэсэгт доод хэмжээ тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл* *тавин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *113.2.Энэ хэрэгт:* *113.2.1.насанд хүрээгүй хүнийг;* *113.2.2.хоёр буюу түүнээс олон хүнийг;* *113.2.3.хулгайлах;* *113.2.4.эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээдэг байгаа хүнийг;* *113.2.5.дагтан;* *113.2.6.бүлэглэн буюу урьчилан үгсэж тохироцсон бүлэг үйлдсэн бол хөдлөмрийн хэсэгт доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	Монгол Улс Олон улсын гэрээний үүргээ биелүүлэх зорилгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд "Хүний эрх чөлөө, ятдар хүнд, нэр төрийн эрэгт гэмт хэрэг-ийн бүлэгт "Хүнийг болохлох зорилгоор олж авах, бөөлөхлох, тээвэрлэх" гэсэн зүйл нэмж, үүг улсаас нөгөө улсад тээвэрлэх", "Монгол Улсын төрийн дайбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлгөөр бөөл тээвэрлэх" зэргийг уг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуулыпах

	3. Энэхүү конвенцид оролцох үндэслэл болсон хүндэтгэлээ зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас зөрчлийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөрчлийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэнтэй адилтган шийтгэнэ.	*113.3.Хүчийг хэлбэлзэлгүй, эсхүл зохимжтой байнгын хэрэглэлээр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн 113.1-д заасан ялыг оногдуулахдаа тухайн гэмт хэрэгтэй адилтган шийтгэнэ.* *Тайлбар:* *1. Энэ хуулийн 113.1-д заасан "мэлхий" гэдэгт хүндэтгэлээс хүний биеийг нь үнэлүүлэх зорилгоор болгосон хүчирхийлэлд өртсөн, эсхүл тэрслэх, эсэргүүцэх чадваргүй болсон этгээдийг ойлгоно.* *2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч хүндэтгэлээс зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан энэ бүрэлдэхүүнийг үүсгэнэ гэж үзнэ.*			
3	*5 дугаар зүйл* Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан бөгөлчлөл болон түүнтэй адилтгах ёс, заншлыг бүрэн халж устаагүй улсад боол буюу эрх мэдэлгүй байдалд байгаа хүн жен гэдгийг нь тэмдэглэх, эсхүл цээрлүүлэх буюу өөр ямар нэгэн зорилгоор тэдгийг зэрэмдэглэх, тамгалах үйлдэл түүнчлэн үүний үйлдэхэд оролцсоныг энэхүү конвенцид оролцоч улсын хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж үйлдэгчидийг шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцийн заалтын агуулгатай холбогдох заалт байхгүй.	Энэхүү конвенцоор энэ үйлдлийг хуулиар гэмт хэрэг гэжүзэж, ийм хэрэгүйлдэгчидиг шийтгэхийг үүрэг болгосон байх тул конвенцийн заалтын агуулгыг хууль тогтоомждоо тусгах нь зүйтэй.		Конвенцийн энэхүү заалтын агуулгыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүний эрх чөлөө, алдар хүнд нэр төрийн эсрэг гэмт хэрэг-ийн бүлэгт нэмж оруулах "Хүнийг боолчлох" гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуулчлах

www.nli.gov.mn
хүн зүйн үндэсний хүрээлэн

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ТУХАЙ КОНВЕНЦ[306]

/1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр батлав, 1976 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*22 дугаар зүйл* Шийтгэлийн тухай заалт 1. а) Тал бүр энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс баталсан хууль буюу журамд харш санаатайгаар үйлдсэн аливаа үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх бөгөөд ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан хангана.	Эрүүгийн хууль 192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах 192.1.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дөрөв зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 192.2.Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дөрөв найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих, тэдгээрийг хууль бусаар авах" гэмт хэргийг хуульчилсан боловч уг бодисыг хэрэглэсэн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх тухай заагаагүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд "Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэх" үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор нэмж хуульчлах

[306] Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

	b) Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэгчид тийм гэмт хэрэг үйлдсэн бол талууд дээрх хэсгийг үл харгалзан шийтгэл буюу ялын оронд, эсүүл нэмэлт болгож тэдний эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдрэлд эргүүлэн оруулах эрга хэмжээнд 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн хамруулахаар заажболно.	193 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих 193.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээрийг үйлдвэрлэхэд хэрэглэгдэг бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, бүртгэх, худалдах, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, устгах журмыг зөрчсөн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаатаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 194 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах 194.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 194.2.Энэ хэрэгийг: 194.2.1. их буюу онц их хэмжээгээр; 194.2.2.мэргэжлийнболон албан тушаалын байдлаа ашиглаж; 194.2.3.урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд; 194.2.4.давтан; 194.2.5.бүлэглэж үйлдсэн бол тавааснаас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Мен Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцийн заалтын дагуулыг бүрэн тусгасан "мансууруулах донтой этгээдэд ял онооруулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх" тухай зохицуулалт байна.		

Үндэсний хүрээлэн

		68 дугаар зүйл. Архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэдэнд харгалзан дэмжигч тогтоох 68.1.Архаг архичин буюу мансуурах донтой этгээд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх уг этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. 68.2.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд шаардлагатай гэж шүүх үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. 68.3.Хорих ял шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдийг ял эдлэх хугацаанд нь шаардлагатай гэж үзвэл албадан эмчилж болно.		
2	2. Аль нэг талын үндсэн хуулийн хязгаарлалт, эрх зүйн тогтолцоо, дотоодын хуулийг харгалзан: i) 1 дэх хэсгийн дагуу гэмт хэрэгт тооцогдох өөр хоорондоо холбоотой үйлдлийг хэд хэдэн оронд үйлдсэн бол үйлдэл бүрийг тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно;	Эрүүгийн хууль 19 дүгээр зүйл. Нийлмэл гэмт хэрэг 19.1.Энэ хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байхыг нийлмэл гэмт хэрэг гэнэ. Нийлмэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг бүрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 19.2.Энэ хуулийн тусгай ангийн хоёр буюу түүнээс дээш зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулсан нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхүйг нийлмэл гэмт хэрэгт тооцно.	- Монгол Улсын Эрүүгийн хуульд нийлмэл гэмт хэргийн тухай ойлголт болон гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, гэмт хэрэгт хамтран оролцсон үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн ял оногдуулах тухай зохицуулалт байгаа бөгөөд эдгээр нь агуулгын хувьд конвенцийн заалтын агуулгатай нийцэж байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих, тэдгээрийг хууль бусаар авах" гэмт хэрэгт гадаад улсад шийтгүүлж байсныг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход харгалзах тухай заалт нэмж оруулах

	iii) тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецедив байдлыг тогтоох зорилгоор харгалзан үзнэ;	60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэл ял онодуулах 37 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага 24 дүгээр зүйл. Онц аюултай гэмт хэрэгтэн 24.1. Дараах этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтэнд тооцно: 24.2.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэг болон энэ хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсон гэмт хэрэг хамаарахгүй.	-Монхуульдонцаюултай гэмт хэрэгтнээр тооцох үндэслэлийг заасан болонконвенцидзаасан үндэслэл буюу сэтгэцэд нөлөөлөх бодис ....' гэмт хэрэгт гадаад улсад шийтгүүлснийг харгалзан үзэх тухай заагаагүй байна.	

ХЭЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

МАНСУУРУУЛАХ ЭМИЙН ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ

/1961 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт өөрчлөлт оруулж, уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон[307]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	2. Аль нэг талын үндсэн хуулийн хязгаарлалт, эрх зүйн тогтолцоо, дотоодын хуулийг харгалзан: i) 1 дэх хэсэгт жагсаасан гэмт хэрэг бүрийг хэд хэдэн оронд үйлдсэн бол тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно; iii) тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив гэмт хэрэгтнээр тогтоох зорилгоор харгалзан үзнэ;	Эрүүгийн хууль 19 дүгээр зүйл. Нийлмэл гэмт хэрэг 19.1.Энэ хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байхыг нийлмэл гэмт хэрэг гэнэ. Нийлмэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг бүрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 19.2.Энэ хуулийн тусгай ангийн хоёр буюу түүнээс дээш зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулсан нэг үдаагийн үйлдэл, эс үйлдэхүйг нийлмэл гэмт хэрэгт тооцно. 60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулах 37 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага 24 дүгээр зүйл. Онц аюултай гэмт хэрэгтэн 24.1. Дараахь эгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтэнд тооцно: 24.2.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэг болон энэ хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсон гэмт хэрэг хамаарахгүй.	- Монгол Улсын Эрүүгийн хуульд нийлмэл гэмт хэргийн тухай ойлголт болон гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, гэмт хэрэгт хамтран оролцсон үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн ял оногдуулах тухай зохицуулалт байгаа бөгөөд эдгээр нь агуулгын хувьд конвенцийн заалтын агуулгатай нийцэж байна. - Мөн хуульд онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох үндэслэлийг заасан боловч конвенцид заасан үндэслэл буюу "мансуурууллах эм ...." гэмт хэрэгт гадаад улсад шийтгүүлсэнийг харгалзан үзэх тухай заагаагүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Мансуурууллах эм хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих, тэдгээрийг хууль бусаар авах" гэмт хэрэгт гадаад улсад шийтгүүлж байсныг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход харгалзах тухай заалт нэмж оруулах

[307] Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон. Төрийн мэдээлэл тусгай дугаар IV боть, 2006, 957-996 дахь тал

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

/1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон[308]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*3 дугаар зүйл* (с) Үндэсний хууль тогтоомжийнхоо заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо гол зарчмуудыг баримтлан: i) энэ хэсгийн (а) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг болон гэмт хэргүүд, эсхүл тухайн гэмт хэрэг болон гэмт хэргүүдэд оролцсон үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийг хүлээж авахдаа энэ тухай мэдсээр байж олж авсан, эзэмшсэн, хэрэглэсэн; ii) I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;	*Эрүүгийн хууль* 155 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах 155.1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан ампалгүйгээр авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 155.2.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан ампалгүйгээр борлуулах зорилгоор авсан буюу борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах үйлдлийг гэмт хэрэг хэмээн хуульчилсан, мөн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, гэмт хэрэгт хамтран оролцсон үйлдлийг төгсөөгүй гэмт хэрэг гэж үзэн ял оногдуулах тухай заасан нь конвенцийн заалтын агуулгатай нийцэж байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэхийг сурталчилах" гэх зүйлийг конвенцийн агуулгаар нэмж хуульчлах

[308]"Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 2006. 1033-1063 дахь тал

	2.Энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах; iv) энэ зүйлээр тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр зорилго тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх гэж хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн.	60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд яп оногдуулах 37 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага	Харин олон нийтийг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар хэрэглэхийг уриалсан, хатгасан, сурталчилсан үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх тухай заагаагүй нь түүнийг конвенцийн заалтын агуулгыг хууль тогтоомжоос бүрэн тусгаагүй хэрэг болсон байна.	
2	5. Талуудаас нөхцөл байдлыг тэдгээрийн шууд болон хэрийн харьяалал тогтоосон эрх мэдэл бүхий байгууллагуудаас 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн хүндүүлэх нөхцөл байдал гэж үзэх явдлыг хангана: а) гэмт этгээд өөрийн харьяалагдах зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон; b) гэмт этгээд олон улсын чанартай бусад төрлийн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагаанд оролцсон;	Эрүүгийн хууль 188 дугаар зүйл. Галт зэвсэг, байдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт. тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх 188.3.Энэ хэргийг давтан буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, хэмжээгээр, түүнчлэн албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих яп шийтгэнэ. 188.4.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэгт үйлдсэн бол хорио дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих яп шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хууль нь хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийг албан тушаалтан, зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэгт үйлдсэн бол, 188, 192-196 дугаар зүйлд мөн тэдгээрийг хууль зөрчин бусаар бэлтгэх, олж авах, хүчирхийлэх бүрэлдэхүүн бүрэлдэхүүн болгон хуульчлах	Конвенцид заасан Монгол Улсын Эрүүгийн хуульд заримхэсэгчилэн мөн хуулийн хүрээнд заасан гэмт хэргийн

	c) гэмт этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон; d) гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн; e) гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэг нь түүний албан тушаалтай холбоотой; f) гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулсан, эсхүл тэднийг ашигласан; g) гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар эсхүл тэдгээрийн ойр орчинд, эсхүл сурагч, оюутны сургалт, спорт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн; h) холбогдох талын дотоодын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн.	192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах 192.3.5.урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 182 дугаар зүйл. Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах, түүнд оролцох 182.1.Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлд элссэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 182.2.Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэх зорилгоор зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулсан, түүнийг удирдсан, үйл ажиллагаанд нь оролцсон бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 182.3.Энэ хуулийн 182.2-д заасан хэргийг албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн бол эд хөрөнгийг хураах арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Мөн Эрүүгийн хуульд зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэл байгуулах, түүнд оролцох гэмт хэргийг хуульчилсан байна. Харин Эрүүгийн хуулийн 188, 192-196 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт конвенцийн энэ заалтад дурдсан хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлаагүй байна. Иймээс Монгол Улс Эрүүгийн хуульдаа конвенцийн заалтыг бүрэн тусгаагүй байна гэж үзэх үндэслэлтэй.	

ЭРҮҮГИЙН ХУРЭЭЛЭН
www.gov.mn

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ[309]

/Ерөнхий Ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор батлав, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*8 дугаар зүйл* 1.Хэнийг ч боол болгож болохгүй: аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно. 2.Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй.	*Эрүүгийн хууль* 113 дугаар зүйл.Хүн худалдах, худалдан авах 113.1.Хүн худалдсан буюу худалдан авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. *113.2.Энэ хэргийг:* *113.2.1.хүний цус, эд, эрхтэнг ашиглах зорилгоор;* *113.2.2.биеийг нь үнэлүүлэх зорилгоор;* *113.2.3.давтан;* *113.2.4.хөөр буюу түүнээс олон хүнийг;* *113.2.5.насанд хүрээгүй хүнийг;* *113.2.6.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.* *113.3.Энэ хэргийг байнга үйлдсэн, хүнийг хил давуулан худалдсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.*	*Монгол Улсын Эрүүгийн хуульд* хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг хуульчилсан боловч уг гэмт хэргийг "хүнийг боол болгох зорилго"-оор худалдсан, худалдан авсаныг гэмт хэргийн бүрэлдэхүүн болгон хуульчлаагүй, мөн хүнийг боолчлох гэмт хэргийг хуульчлаагүй.	- Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүний эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Хүнийг боолчлох" гэсэн зүйлийг энэ конвенцийн заалтын агуулгаар нэмэх. - Хүнийг боол болгох зорилгоор худалдсан, худалдан авсаныг "Хүн худалдах, худалдан авах" гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчлах.

[309] Монгол Улс 1974.11.18-нд соёрхон батлагдсан.

2	*20 дугаар зүйл* 1.Дайныг аливаа хэлбэрээр хуулиар суртачлахыг хориглоно. 2.Алагчлан дайсагнацах болон ялгаварлан гадуурхах, үндэс угсаа, арьс өнгө, хэл, шашин шүтлэг, үзэл бодол, эд хөрөнгө, гарал, албан тушаал, нас, хүйс, оршин суугаа газар, эрүүл мэндийн байдал, бусад шалтгаанаар хүн амын дунд үндэсний, арьсны, шашны, ангийн ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийлэл үйлдэхийг уриалах, сурталчлах, үзэл суртлыг хориглоно.	*Эрүүгийн хууль* *298 дугаар зүйл. Дайныг сурталчлах, уриалах* 298.1.Олон нийтийн дунд дайн явуулахыг сурталчилсан, дайнд уриалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл ялтныг гурван сар хүртэл хугацаагаар нэгээс баривчлах ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд конвенцийн заалтын агуулга бүхий "Дайныг сурталчилах, уриалах" гэмт хэргийг хуульчилсан байна. Харин "Алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн түрхирах, арьс үндэсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа үйлдэлд суртачилгаа явуулах" гэмт хэргийг хуульчлаагүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Хүчирхийллийг сурталчлах, уриалах" гэмт хэргийг, "Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Арьс үндэс, шашин шүтлэгээр алагчлах байдлыг сурталчлах, уриалах" гэмт хэргийг тус тус хуульчлах

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ХҮҮХДИЙГ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ОРОЛЦУУЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ОРУУЛАХ НЭМЭЛТ ПРОТОКОЛ[310]

/Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор батлаж, 2002 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*4 дүгээр зүйл* 1.Төрийн зэвсэгт хүчнээс ангид зэвсэгт бүлэглэлүүд ямар ч нөхцөлд 18 нас хүрээгүй хүмүүсийг байлдааны ажиллагаанд татан оролцуулж , ашиглах ёсгүй. 2.Оролцогч улсууд тийнхүү татан оролцуулах болон ашиглахаас сэргийлэх зорилгоор боломжтой бүх арга хэмжээ, тухайлбал уг үйлдлийг хориглох болон гэмт хэрэг гэж үзэх талаар хууль эрх зүйн шаардлагатай арга хэмжээ авна. 3.Протоколын энэ зүйлийг хэрэглэх нь зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа аливаа улсын эрх зүйн байдалд нөлөөлөхгүй.	Монгол Улсын *Эрүүгийн хуульд* холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүүгийн хуульд хүүхдийг гэмт хэрэг, садар самуун гэх мэтэд татан оролцуулахыг гэмт хэрэг гэж үзэхээр заасан боловч насанд хүрээгүй этгээдийг байлдааны буюу дайны ажиллагаанд татан оролцуулсан үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх тухай заагаагүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг"-ийн бүлэгт "Насанд хүрээгүй хүнийг дайн буюу байлдааны ажиллагаанд татан оролцуулах" гэсэн зүйлийг конвенцийн заалтын агуулгаар нэмж хуульчлах

[310] Монгол Улс 2002.10.11-нд нэгдэн орсон.

Хуульзүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧИЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ОРУУЛАХ НЭМЭЛТ ПРОТОКОЛ[311]

/Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/ 263 тогтоолоор батлав, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	3 дугаар зүйл 1.Оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хууль дор хаяж дараах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамаарулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүй хариуцлага хүлээлгэх талаар: a.хүүхдийг аливаа арга хэрэгслээр дараах зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах: a.бэлгийн хүчирхийлэлд ашиглах b.шан харамж авч хүүхдийн эрхтэн шилжүүлэх c.хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэд ашиглах	Эрүүгийн хууль 113 дугаар зүйл. Хүн худалдаалах 113.1.Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмэгт байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тэзвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэмт бүрүүтай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	- Монгол Улсын Эрүүгийн хуульд "Хүн худалдах" гэмт хэргийг хуульчилсан бөгөөд үүнд хүүхэд худалдаалах үйлдэл хамаарна.	Энэ гэмт хэргийг үйлдэхдээ "Зуучлах" гэсэн үйлдэлийг орхигдуулсан байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ зуучилсан эүйлдлийг гэмт хэрэгт тооцох тухай оруулах хэрэгтэй.

[311] Монгол Улс 2002.10.11нд нэгдэн орсон.

	113.2.Энэ хэргийг: *113.2.1.насанд хүрээгүй хүнийг;* *113.2.2.хөөр буюу түүнээс олон хүнийг;* *113.2.3.хулгайлах;* *113.2.4 эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхиэлдэх байгаа хүнийг;* *113.2.5 даатан;* *113.2.6 бүлэглэж буюу урьдчилан үзэсж тохиролцон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хоёр зуун таван мянга зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэгнэ.* *113.3.Хүнийг хил давуулан хүдэлдаалсан, эсхүл зохион байгуулагчтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, үе хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтэгнэ.* *Тайлбар:* *1. Энэ хуулийн 113.1-д заасан "мелжих" гэдэгийг хүдэлдаадсан хүнийг бүлэг нь үнэлүүлэх зорилгоор бэлэгийн хүнийг хүлээлэгч, борлуулах болон тушаагч ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.*		
	2.Хүүхэд урвлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалт зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх. *Мен* *a.хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өөрт:* *b.хүүхэд оролцон садар самуун суртачилгааг үйлдэх, түгээх, тарааж, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалах*	- Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан "Хүүхэд, сопих, хууль бусаар урчлэх", "Садар самууныг суртачлах" гэсэн зүйлд конвенцийн заалтын агуулга бүрэн тусссан байна.		

ТӨРЛӨӨР УСТГАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТИЙМ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧДИЙГ ШИЙТГЭХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1948 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж, 1951 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон[312]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* Хэлэлцэн тохирогч улс төрөөр устгах нь тайван буюу дайны цагт үйлдэгдсэнээс үл хамаарч олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн гэмт хэрэг болохыг баталж, тийм хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх үүрэг хүлээнэ. *2 дугаар зүйл* Энэхүү Конвенцид төрөөр устгах гэдэгт нь үндэс, угсаа, арьс үндэс буюу хэсгийг нь устгах зорилгоор үйлдсэн дараах үйлдлийг ойлгоно: a.бүлгийн гишүүдийн амь насыг хороох; b.бүлгийн гишүүдийн бие махбод, сэтгэцэд ноцтой гэмтэл учруулах; c.бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцлийг санаатайгаар бий болгох; d.бүлгийн дотор төрөлт зогсооход чиглэсэн арга хэмжээ авах; e.хүүхдүүдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх.	*Эрүүгийн хууль* 302 дугаар зүйл.Төрөөр устгах 302.1.Үндэс, угсаа, арьсны өнгө болон хүн ам, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, бие махбодид нь хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг нь бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн бол хориос хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн заалтын агуулга конвенцийн заалтын агуулгатай үндсэндээ нийцэж байна. Гэхдээ конвенцоор "бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцлийг санаатайгаар бий болгох" (хэлбэрийн бүрэлдэхүүн)-г гэмт хэрэг гэж үзсэн бол Монгол Улсын Эрүүгийн хуульд "амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн" (материаллаг бүрэлдэхүүн)-ийг гэмт хэрэг гэж үзэхээр заасан.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйлд конвенцийн заалтын агуулгаар "бүлгийг бүхэлд нь буюу түүний хэсгийг бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал, ахуйн нөхцлийг санаатайгаар бий болгосон" үйлдлийг гэмт хэрэг болгон хуульчлах

[312] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004. 120-124 дахь тал

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ

/1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон[313]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*1 дүгээр зүйл* 1.Энэхүү конвенцийн зорилгын дагуу "эрүүдэн шүүх" гэж хэн нэгэн хүн буюу гуравдах этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүргээ гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалга, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй.	*Эрүүгийн хууль* 251 дүгээр зүйл. Мэдүүлэг өгөхийг албадах *248 дугаар зүйл. Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх* *249 дүгээр зүйл. Хүнийг хууль бусаар баривчлах* *250 дугаар зүйл. Шүүхээс хууль бус шийдвэр гаргах*	Монгол Улсын Эрүүгийн хуульд "эрүүдэн шүүх" хэлбэрийг агуулсан эдгээр гэмт хэргийг хуульчилсан боловч конвенцийн заалтын агуулгыг бүрэн тусгаагүй байна.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн эдгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэх зорилго, аргыг конвенцийн заалтын агуулгаар нэмж хуульчлах
2	*2 дугаар зүйл* 1.Дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй.	*Эрүүгийн хууль* 44 дүгээр зүйл. Тушаал, захирамж биелүүлэх 44.1.Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй. Харин хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	Монгол Улсын Эрүүгийн хуульд илт хууль бус тушаал, захирамж биелүүлж хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт бий.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн "Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал" гэсэн бүлэгт конвенцийн заалтын агуулгаар "дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал,

[313]Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004. 109-120 дахь тал

Хуульзүйн Үндэсний хүрээлэн www.mli.gov.mn

	2.Өгөд шатны албан тушаалтны бүрэн эрх бүхий байгууллагаас авсан туршаал нь эрүүдэн шүүхийг зөвтөөх үндэслэл болохгүй.	*44.2.Илт хууль бус туршаал, захирамж биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан аливаг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн харуцлага хулээлгэнэ. Илт хууль бус туршаал, захирамжийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн харуцлага хүлээлгэхгүй.*	Харин мөн хууль дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтсон шаптаганаар "эрүүдэн шүүх," ажиллагаа явуулсан бол эрүүгийн харуцлага хүлээлгэх эсэх талаар зохицуулалт байхгүй байна.	нийтийг хамарсан онц байдал тогтсон шаптаганаар эдгээр гэмт хэргийг үйлдсэн нь эрүүгийн харуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" гэсэн заалт нэмж оруулах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 1973 оны 1 дүгээр сарын 26-нд хүчин төгөлдөр болсон[314]/*

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*5 дугаар зүйл* 1. Хэлэлцэн тохирогч улс бүр дор дурдсан тохиолдолд гэмт хэргийн харьяаллаа тогтоох шаардлагатай байж болох арга хэмжээ авна: (a) гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн; (b) гэмт хэрэг тухайн улсад бүртгэгдсэн агаарын хөлгийн эсрэг, эсхүл бүхээгт нь үйлдэгдсэн; (c) бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн агаарын хөлөг сэжигтэн этгээд бүхээгт нь байхад тус улсын нутаг дэвсгэр дээр буусан; (d) үйл ажиллагаа явуулдаг үндсэн газар нь, эсхүл тийм газар байхгүй бол байнга оршин суудаг газар нь тухайн улсад байдаг түрээслэгчид агаарын хөлгийг багийн гишүүдгүйгээр түрээсэлсэн байхад түүний бүхээгт гэмт хэрэг үйлдэгдсэн бол.	3 дугаар зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар* 3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ. 4 дүгээр зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хууль гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үйлчлэх* 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаг явуулахдаа энэ хуульд заасан журмыг баримтална.	Уг конвенцийн 5 дугаар зүйлийн 1-ийн (b) "тухайн улсад бүртгэгдсэн агаарын хөлөг...." гэдгийг ЭБШХ-ийн "Монгол Улсын төрийн далбаа мандуулсан агаарын хөлөг" гэж ойлгож хэрэглэх нь зүйтэй бөгөөд конвенц, хуулийн заалтууд харшлахгүй байна. Харин *бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн гадаад улсын төрийн далбаа мандуулсан агаарын хөлөгт сэжигтэн этгээд байхад Монгол Улсын нутаг дэвсгэрт буусан тохиополд Монгол Улсын ЭБШХ үйлчлэх эсэх талаар зохицуулалт байхгүй байна.* Иймд Монгол Улс гэрээгээр хүлээсэн гэмт хэрэгт "хэргийн харьяаллаа тогтоох шаардлагатай байж болох арга хэмжээ авах" үүргээ биелүүлээгүй байна.	ЭБШХ-ийн 3 дугаар зүйлд "бүхээгт нь гэмт хэрэг үйлдэгдсэн гадаад улсын төрийн далбаа мандуулсан агаарын хөлөг бүхээгт нь сэжигтэн этгээд байхад Монгол Улсын нутаг дэвсгэрт буусан бол уг хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчлэх" тухай заалт нэмж оруулах

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

[314] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 870-876 дахь тал.

АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

/1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталж,1969 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон[315]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*13 дугаар зүйл* 3. Өмнөх хэсэгт дурдсаны дагуу цагдан хорьсон аливаа этгээдэд өөрийгнь харьяалах улсын хамгийн ойр орших зохих ёсны төлөөлөгчтэй яаралтай холбоо барихад нь туслалцаа үзүүлнэ.	68 дугаар зүйл. Цагдан хорих 68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ. 61 дүгээр зүйл. *Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх* 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.	ЭБШХ-д гадаад улсын иргэн баривчлагдсан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх тухай заасан атлаа цагдан хоригдсон бол энэ тухай хэнд, ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх тухай зохицуулаагүй ажээ. Мөн харьяалалгүй хүнийг баривчилсан, цагдан хорьсон тухай мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.	Гадаад аль ч улсын иргэний халдашгүй байх эрх болон бусад эрхийг хангах үүднээс тэд цагдан хоригдсон бол зохих ёсны ойрын төлөөлөгчид мэдэгдэх, мөн харьяалалгүй хүн баривчлагдсан, цагдан хоригдсон тухай байнга оршин суудаг улсынх нь төлөөлөгчид мэдэгдэх журмыг, ЭБШХ-д тусгах нь зүйтэй /Эсхүл "Гадаадын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт ЭБША явуулах тусгай журам"-ыг хуульчлах/.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

[315] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 895-903 дахь тал.

АГААРЫН ХӨЛГИЙГ ХУУЛЬ БУСААР БУЛААН АВАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталж, 1971 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон[316]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*6 дугаар зүйл* 3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар цагдан хоригдсон аливаа этгээдэд өөрийн улсын хамгийн ойр байгаа зохих төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтоох бололцоо олгоно.	68 дугаар зүйл. Цагдан хорих 68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ. 61 дүгээр зүйл. *Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх* 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.	ЭБШХ-д гадаад улсын иргэн баривчлагдсан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх тухай заасан атлаа цагдан хоригдсон бол энэ тухай хэнд, ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх тухай зохицуулаагүй ажээ. Мөн харъяалалгүй хүнийг баривчилсан, цагдан хорьсон тухай мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.	

[316] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 865-870 дахь тал

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.mni.gov.mn

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

ХҮН БАРЬЦААНД АВАХЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1983 оны 6 дугаар сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон[317]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*3 дугаар зүйл* 1.Гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан бол оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх талаар зохистой гэж үзсэн бүх арга хэмжээг авна. 2.Гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч улс түүнийг аль болох түргэн хугацаанд барьцааны хүн буюу тухайн тохиолдлоос хамаарч 1 дүгээр зүйлд заасан гурав дахь этгээдэд, эсхүл тэдгээрийн эрх бүхий холбогдох байгууллагад буцааж өгнө.	117 дугаар зүйл. *Иргэний нэхэмжлэгчээр тогтоох* 117.1. Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэдэнд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг нь тайлбарлана. 117.2. Нэхэмжлэл гаргасан этгээдийг энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан журмын дагуу иргэний нэхэмжлэгчээр тогтоох тухай шийдвэр гаргаж, энэ хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлана.	Монгол Улсын ЭБШХ-д гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эд хөрөнгийн хохирлыг арилгахаас бусад эрхийг хамгаалах, туслах талаар зохицуулалт байхгүй.	Монгол Улсын ЭБШХ-д "Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх" тухай зохицуулалт нэмж оруулахын хамт тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалахад төлсөн зардлыг шүүхийн зардалд оруулан хуульчлах

[317] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 904-910 дахь тал.

Хүн бүрдэсний хүрээлэн www.nli.gov.mn

		115 дугаар зүйл. *Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл* 115.1. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. 115.2. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө. 409 дүгээр зүйл. *Эд зүйл, бусад нотлох баримтыг шилжүүлэх* 409.1. Энэ хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ.	Монгол Улсын ЭБШХ-д гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэх тухай, хэрэв гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх бол түүний гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад баримтыг гадаад улсын холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх тухай заажээ.	
2	*5 дугаар зүйл* 1. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн алийг ч дор дурдсан байдлаар үйлдсэн бол оролцогч улс бүр тухайн хэрэгт харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна: (a)нутаг дэвсгэрт нь, эсхүл тухайн улсад бүртгэлтэй хөлөг онгоц буюу агаарын хөлөгт үйлдсэн; (b)харьяат нь, эсхүл тухайн улс зохистой гэж үзвэл нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн; (c)тухайн улсаар аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор үйлдсэн; эсхүл (d)тухайн улс зохистой гэж үзвэл, тухайн улсын харьяат болох хүнийг барьцаалж үйлдсэн.	3 дугаар зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар* 3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ. 4 дүгээр зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хууль гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үйлчлэх* 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа энэ хуульд заасан журмыг баримтална.	Монгол Улсын ЭБШХ-д нутаг дэвсгэрт нь, мөн тухайн улсад бүртгэлтэй буюу тухайн улсын далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчлэх тухай заасан. Харин уг хуульд Монгол Улсаар аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор үйлдсэн, мөн Монгол Улсын харьяат болох хүнийг барьцаалж үйлдсэн хэрэгт Монгол Улсын ЭБШХ үйлчлэх талаар заагаагүй [illegible]	Монгол Улсын ЭБШХ-ийн 4 дүгээр зүйлд "Монгол Улсаар аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор, мөн тус улсын харьяат болох хүнийг барьцаалж гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан журмыг баримтлан ЭБША явуулж болно" гэсэн заалт нэмж оруулах

3	*6 дугаар зүйл* 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан цагдан хорих арга хэмжээний талаар дараахь этгээдэд шууд буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан хойшлуулахгүй мэдэгдэнэ: (a)нутаг дэвсгэрт нь тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн улс; (b)тулган шаардалт өөрийнх нь эсрэг чиглэсэн буюу чингэхийг завдсан улс; (c)өөрийн нь харьяат хувь хүн буюу хуулийн этгээдийнх нь эсрэг тулган шаардалт чиглэсэн буюу чингэхийг завдсан улс; (d)барьцаанд байгаа хүн харьяат нь буюу нутаг дэвсгэрт нь байнга оршин суудаг улс; (e)сэжигтэн этгээд харьяат нь буюу тэрбээр харьяалалгүй этгээд бол түүний байнга оршин суудаг улс; (f)тулган шаардалт өөрийнх нь эсрэг чиглэсэн буюу чингэхийг завдсан засгийн газар хоорондын олон улсын байгууллага; (g)холбогдох бусад улс. *2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараахь эрх эдэлнэ:* *(a)харьяат нь болох улсынхаа хамгийн ойр байгаа буюу ийм холбоо тогтоох эрх бүхий зохих төлөөлөгчтэй, эсхүл хэрэв тэрбээр харьяалалгүй этгээд бол байнга оршин суудаг улсынхаа төлөөлөгчтэй хойшлуулалгүй холбоо тогтоох;* *тухайн улсын төлөөлөгчтэй уулзах.*	68 дугаар зүйл. Цагдан хорих 68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ. 61 дүгээр зүйл. *Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх* 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.	ЭБШХ-д гадаад улсын иргэн баривчлагдсан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх тухай заасан атлаа цагдан хоригдсон бол энэ тухай хэнд, ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх тухай зохицуулаагүй ажээ. Мөн харьяалалгүй хүнийг баривчилсан, цагдан хорьсон тухай мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.	

Хэрэглэгчийн хүрээлэн
mgov.mn

4	8 дугаар зүйл 1. Оролцогч улс нь нутаг дэвсгэрт нь олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч уг хэрэгт тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх үүргийг аливаа нөхцөлгүйгээр хүлээнэ. Эдгээр байгууллага шийдвэрээ тухайн улсын хууль тогтоомжийн дагуу ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргана.	3 дугаар зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар* 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана. 3.2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баримтална. 3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.	Монгол Улсын ЭБШХ-ийг хэрэглэх хэмжээ хязгаарыг хуулиар тогтоохдоо "Монгол Улс нутаг дэвсгэртээ олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч тус улсын ЭБШХ -ийн дагуу ЭБША явуулах" тухай заагаагүй байна. Иймд хуульд конвенцийн заалтын агуулга бүрэн тусгагдаагүй байна гэж үзэх үндэслэлтэй.	Монгол Улсын ЭБШХ-ийн 3 дугаар зүйлд "Монгол Улс нутаг дэвсгэртээ олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч, уг хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчилнэ" гэсэн заалт нэмж оруулах
5	9 дүгээр зүйл 1. Шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авсан оролцогч улс дор дурдсан хангалттай үндэслэл байна гэж үзвэл сэжигтэн этгээдийг энэхүү конвенцийн дагуу шилжүүлэх тухай хүсэлтийг биелүүлэхгүй байж болно: (a) аль нэг этгээдийг 1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэргийг үйлдсэн хэмээн түүнийг шилжүүлэн өгөхийг арьс үндэс, шашин шүтлэг, үндэс, угсаа эсхүл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалан яллах буюу шийтгэх зорилгоор хүсвэл; (b) шилжүүлэх нь тухайн этгээдийн байдалд дараахь байдлаар хохирол учруулж болох бол: (i) энэ хэсгийн (a) дэд хэсэгт дурдсан аль нэг шалтгаанаар, түүнийг хамгаалах эрх бүхий улсын зохих байгууллагууд түүнтэй холбоо барих боломжгүй болох бол.	406 дугаар зүйл. *Шилжүүлэн өгөхөөс татгалзах* 406.1. Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй: 406.1.1. Монгол Улсын иргэн; 406.1.2. гэмт этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгосон; 406.1.3. шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэслэл нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол; 406.1.4. шилжүүлбэл зохих этгээд тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол; 406.1.5. Монгол Улсын хууль тогтоомжоор тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх буюу ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол.	Монгол Улсын ЭБШХ-д гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлийг заасан боловч конвенцид заасан "арьс үндэс, шашин шүтлэг, үндэс, угсаа эсхүл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалан яллах буюу шийтгэх зорилгоор шилжүүлэн өгөхийг хүсвэл" гэсэн үндэслэлийг заагаагүй.	Монгол Улсын ЭБШХ-ийн 406 дугаар зүйлд "гэмт хэрэг үйлдсэн хэмээн түүнийг шилжүүлэн өгөхийг арьс үндэс, шашин шүтлэг, үндэс, угсаа эсхүл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалан яллах буюу шийтгэх зорилгоор хүсвэл" гэсэн хэсэг нэмж оруулах

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР БӨМБӨГ ХЭРЭГЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/1998 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталж, 2001 оны 5 дугаар сарын 23-нд хүчин төгөлдөр болсон[318]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*6 дугаар зүйл* 1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг дараах байдлаар үйлдсэн бол хэргийн харьяаллаа тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна: (a) тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдсэн; (b) гэмт хэргийг үйлдэх үед тухайн улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцны тавцан дээр буюу тухайн улсын хуулийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн; (c) тухайн улсын харьяат үйлдсэн. 2. Оролцогч улс аливаа ийм гэмт хэргийг дараахь байдлаар үйлдсэн бол хэргийн харьяаллаа мөн тогтоож болно: (a) тухайн улсын харьяатын эсрэг үйлдсэн; (b) тухайн улсын төрийн буюу засгийн газрын хилийн чанад дахь объект, түүний дотор тухайн улсын элчин сайдын яам эсхүл дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдсэн; эсхүл (c) тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн; (d) уг гэмт хэрэг нь тухайн улсаас ямарваа нэгэн арга хэмжээ авахуулах, эсхүл авахаас татгалзахыг тулган шаардах оролдлогын дагуу үйлдсэн; эсхүл (e) гэмт хэргийг тухайн улсын засгийн газрын ээмшлийн агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн.	3 дугаар зүйл. *Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар* 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана. 3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ээмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.	Монгол Улсын ЭБШХ-д нутаг дэвсгэрт нь, мөн тухайн улсад бүртгэлтэй буюу тухайн улсын далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчлэх тухай заасан. Харин уг хуульд Монгол Улсын харьяат болон тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй этгээд уг гэмт хэргийг үйлдсэн, мөн Монгол Улсын харьяат болон төрийн буюу засгийн газрын хилийн чанад дахь объект, түүний дотор тухайн улсын элчин сайдын яам эсхүл дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдсэн тохиолдолд харьяалал хэрэгжүүлэх талаар заагаагүй байна.	Дараах конвенцуудын шаардлагаар Монгол Улсын ЭБШХ үйлчлэх хэмжээ хязгаарыг өргөсгөж хуульчлах

[318] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 922-932 дахь тал.

Хуулийн мэдээлэл
mnli.gov.mn

2	*7 дугаар зүйл* 1. 2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгийг үйлдсэн буюу үйлдэгдсэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байж болох тухай мэдэгэлийг хүлээн авмагц оролцоч холбогдох улс тэрхүү мэдэгэлэлд дурдсан баримтыг мөрдөн байцаах тапаар өөрийн дотоодын хуулийн дагуу зохих арга хэмжээ авна. 2. Хэрэв оролцоч улс нөхцөл байдал тийнхүү шаардаж байна гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэгдэн гэж сэжиглэгдсэн этгээд нь түүний нутаг дэвсгэрт байгаа бол оролцоч тухайн улс уг этгэдийг шилжүүлэх, эсхүл яллагданд байцаулах явдлыг хангах зорилгоор өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээ авна. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараах эрхийг эдэлнэ: *(a) тухайн этгээдийг харьяалах, эсхүл тухайн эрхийг ямар нэг хэлбэрээр хамгаалах эрх бүхий улсын камгийн ойр байх холбогдох төлөөлөгчтэй;* *хэрэв тухайн этгээд харьяалагүй бол нутаг дэвсгэрт нь байгаа орших суугаа газар нь байрлах улсын төлөөлөгчтэй саадгүйгээр холбоо барих;* *(b) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах;* *(c) (a) болон (b) дэд хэсгийн дагуу эдлэх тухайн этгээдийн эрхийн талаар мэдээлэл авах.* *Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг гэмт хэрэгтэн буюу этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд уг хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.*	*61 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчилсан тухай мэдээх* 61.1. Хэрэг бүртгэч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгаагаа 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгоно. 61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацаны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ. *68 дугаар зүйл. Цагдан хорих* *68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацаны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн аливүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ.*	ЭБШХ-д гадаад улсын иргэн баривчлагдсан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх тухай заасан атлаа цагдан хоригдсон бол энэ тухай хэнд, ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх тухай зохицуулаагүй ажээ. Мөн харьяалагүй хүнийг баривчилсан, цагдан хорьсон тухай мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.	

www.legalinfo.gov.mn

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

/1999 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж, 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон[319]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*7 дугаар зүйл* 2. Оролцогч улс мөн дараахь тохиолдолд тэдгээр гэмт хэргийн тухайд хэргийн харьяаллаа тогтоож болно: (a) уг гэмт хэрэг нь 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) буюу (b) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт буюу түүний харьяат иргэдийн эсрэг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол; (b) уг гэмт хэрэг нь 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) буюу (b) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг тухайн улсын хилийн чанад дахь төрийн буюу засгийн газрын объект, түүний дотор тухайн улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол; *(c) уг гэмт хэрэг нь тухайн улсаас ямарваа нэгэн арга хэмжээ авахуулах, эсхүл авахаас татгалзахыг тулган шаардахыг оролдсон 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) буюу (b) дэд хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд чиглэсэн буюу эдгээр гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн бол;* *(d) уг гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харъяалалгүй этгээд үйлдсэн бол;* *(e) гэмт хэргийг тухайн улсын засгийн газрын ээмшдэг агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн бол.*	*3 дугаар зүйл.* Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана. *3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ээмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.*	Монгол Улсын ЭБШХ-д нутаг дэвсгэрт нь, мөн тухайн улсад бүртгэлтэй буюу тухайн улсын далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчлэх тухай заасан. Харин уг хуульд Монгол Улсын харьяат болон тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй этгээд уг гэмт хэргийг үйлдсэн, мөн Монгол Улсын харьяат болон төрийн буюу засгийн газрын хилийн чанад дахь объект, түүний дотор тухайн улсын элчин сайдын яам эсхүл дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын байрны эсрэг үйлдсэн тохиолдолд харьяалал хэрэгжүүлэх талаар заагаагүй байна.	

[319] Төрийн мэдээлэл эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 933-946 дахь тал.

2	*9 дүгээр зүйл* 1. 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн этгээд нь тухайн улсын нутаг дэвсгэрт байж болох тухай мэдээллийг хүлээн авмагц оролцогч холбогдох улс тэрхүү мэдээлэлд дурдсан баримтыг мөрдөн байцаах талаар өөрийн дотоодын хуулийн дагуу зохих арга хэмжээ авна. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авахуулж буй аливаа этгээд дараахь эрхийг эдэлнэ: (a) тухайн этгээдийг харъяалах, эсхүл түүний эрхийг ямар нэг хэлбэрээр хамгаалах эрх бүхий улсын хамгийн ойр байх холбогдох төлөөлөгчтэй, хэрэв тухайн этгээд харьяалалгүй бол нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа газар нь байрлах улсын төлөөлөгчтэй саадгүйгээр холбоо барих; (b) тухайн улсын төлөөлөгчтэй уулзах; (c) (a) болон (b) дэд хэсэгт заасан өөрийн эрхийн талаар мэдээлэл авах.	*403 дугаар зүйл.* Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх буюу эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлтийг биелүүлэх 403.1.Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг шалгах хүсэлт ирүүлсэн бол байцаан шийтгэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулна. 403.2. Энэ хуулийн 403.1-д заасан этгээдийн хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.	Монгол Улсын ЭБШХ-д тус улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бол гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтээр ЭБША явуулах ба уг ажиллагааг дотоодын хуульд заасан журмаар явуулахаар заасан боловч гадаадын иргэн буюу харьяалалгүй хүн гадаад улсад гэмт хэрэг үйлдсэний дараа Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа тохиолдолд хэрхэх талаар зохицуулаагүй байна. Иймхүү хуульд конвенцийн заалтын агуулга бүрэн тусгагдаагүй байна.	Монгол Улсын ЭБШХ-ийн "Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх буюу эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлтийг биелүүлэх" гэсэн зүйлд "гэмт хэрэгүйлдсэнбуюу үйлдсэн гэж сэжиглэгдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байж болох тухай мэдээллийг хүлээн авмагц тэрхүү мэдээллийг шалгах ажиллагааг Монгол Улсын ЭБШХ-д заасан журмын дагуу явуулах" тухай заалт нэмж оруулах

Хууль зүйн яамны Хууль зүйн хүрээлэн

	4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд уг хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.	*61 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх* *61.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгоно.* *61.2. Баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол энэ хуулийн 61.1-д заасан хугацааны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.* *68 дугаар зүйл. Цагдан хорих* *68.7. Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ.*	ЭБШХ-д гадаад улсын иргэн баривчлагдсан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх тухай заасан атлаа цагдан хоригдсон бол энэ тухай хэнд, ямар хугацаанд, хэрхэн мэдэгдэх тухай зохицуулаагүй ажээ. Мөн харьяалалгүй хүнийг баривчилсан, цагдан хорьсон тухай мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.	

НЭЛЭЭЛЭН ЗАЛУЧЛАЛ ЭРХЭЛЭЭ ЗАЛУЧЛАЛ ЭРХЭЛЭЭ

3	*13 дугаар зүйл* Гэмт этгээдийг шилжүүлэх эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх зорилгын хүрээнд энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алийг нь татвартай холбогдсон гэмт хэрэг хэмээн авч үзэхгүй. Үүнтэй холбогдуулан, оролцоч үлсүүд нь гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг татвартай холбогдсон гэмт хэргийн талаар хүсэлт байна гэсэн ганц үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж болохгүй. Үүнтэй холбогдуулан, оролцоч үлсүүд нь гэмт этгээдийг шилжүүлэх, эсхүл эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг үлс төрийн гэмт хэрэг, эсхүл үлс төрийн гэмт хэрэгтэй холбогдол бүхий гэмт хэрэг, эсхүл үлс төрийн сэдэлтэй үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдсон хүсэлт байна гэсэн ганц үндэслэл заваж хүлээн авахаас татгалзаж болохгүй.	45 дугаар зүйл. Монгол Улсын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүхийн байгууллага болон гадаад улсын холбогдох байгууллагын хэргийн талаар зүй харилцаа туслалцаа үзүүлэх ажиллагаа	Монгол Улсын ЭБШХ-д эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааны талаар зохицуулсан боловч эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзаж болох тухай, татгалзаж болох тохиолдол бүрэн үндэслэлийг заагаагүй байна. Хуульд заасан шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл конвенцид заасан татгалзаж болохүй үндэслэл орохгүй учир үг заалтууд агуулгын хувьд нийцэж байна гэж үзэх боломжтой.	Монгол Улсын ЭБШХ-ийн 45 дугаар булэгт "Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзах" гэсэн зүйлийг конвенцийн агуулгаар нэмж хуульчлах
4	*16 дугаар зүйл* 1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг мөрдөн байцаах, яллахтай холбогдуулан хэн болохыг тогтоох, мэдүүлэг авах бүрэн эрхийг бүрдүүлэх, эсхүл өөрийн нутаг дэвсгэрт байгаа, эсхүл хорих ял эдлэх бүрэн эрхийг бүрдүүлэх зорилгоор гэмт этгээдийг Талбарын нутаг дэвсгэрт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ Талбарын дотоодын хууль тогтоомжийн дагуу болон одоо мөрдөгдөж буй олон улсын гэрээ, конвенцийн дагуу хүлээсэн үүргээ харгалзан үзнэ.	*403 дугаар зүйл.* Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаат үргэжүүлэх 403.1. Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллагаас уг хэргийг шалгах хүсэлт ирүүлсэн бол байцаан шийтгэх ажиллагаат энэ хуулиар заасан журмын дагуу эрүүлэн материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.	Монгол Улсын ЭБШХ-ийн 45 дугаар булэгт "Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх" гэсэн бүлэгт эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа явуулах үндэслэл, журам, хэлбэр, хэрэгжүүлэх байгууллагын талаар тодорхой заалт оруулах шаардлагатай.	Монгол Улсын ЭБШХ-ийн 45 дугаар булэгт эрүүгийн байцаан шийтгэх зарим тодорхой ажиллагаа хийх зорилгоор тухайн улсад цагдан хоригдож байгаа буюу хорих ял эдлэж буй этгээдийг шилжүүлэх үндэслэл, журмыг конвенцийн заалтын агуулгаар хуульчлах

	2. Энэ зүйлийн зорилгод: *(a) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсын зүгээс өөрөөр хүсэлт гаргасан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдийг цагдан хорьж байх эрх болон үүрэгтэй.* *(b) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь урьдчилан тохиролцсон ёсоор буюу өөр ямарваа нэгэн аргаар хоёр улсын эрх бүхий байгууллагуудын хооронд тохиролцсоны дагуу тухайн этгээдийг хүлээлгэн өгсөн улсад хойшлуулалгүйгээр буцааж өгөх үүргээ биелүүлэх ёстой.* *(c) тухайн этгээдийг хүлээн авсан улс нь хүлээлгэн өгсөн улсаас түүнийг буцааж авахын тулд шилжүүлэн өгөх ажиллагаа эхлүүлэхийг шаардаж болохгүй.* *(d) хүлээлгэн өгсөн улсад цагдан хоригдсон хугацааг хүлээн авсан улсад хорих ялаа биеэр эдэлж буй этгээдийн эдэлсэн ялын нийт хугацаанд оролцуулан тооцно.*	*Эрүүгийн хууль* *59 дүгээр зүйл. Цагдан хоригдсон хугацааг тооцох* *59.1.Шүүх цагдан хоригдсон хугацааг шүүгдэгчийн ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно. Гэхдээ гянданд ял эдлэх хугацаанд цагдан хоригдсон хугацааг оруулж тооцохгүй.* *4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг гэмт хэрэгтэн буюу сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа улсын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэх бөгөөд уг хууль тогтоомж нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эрх олгож буй зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн байвал зохино.*	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлд цагдан хоригдсон хугацааг хэрхэн тооцох талаар заасан бөгөөд энэ заалтын дагуу гадаад улсад цагдан хоригдсон хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох боломжтой.	

Хүрээлэн

КОНСУЛЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦ[320]

/1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр баталж, 1967 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон/

	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*63 дугаар зүйл* Эрүүгийн хэрэг Хэрэв өргөмжит консулын албан тушаалтны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэвэл тэрбээр эрх бүхий байгууллагад хүрэлцэн очих ёстой. Чингэхдээ шүүх ажиллагааны үед түүний албан байдлыг харгалзан хүндэтгэж, түүнийг баривчилсан буюу албадан саатуулснаас бусад тохиолдолд консулын чиг үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахаас аль болохоор зайлсхийнэ. Өргөмжит консулын албан тушаалтныг албадан саатуулах шаардлага гарвал хэргийг аль болох богино хугацаанд үүсгэнэ.	4 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хууль гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үйлчлэх 4.2. Дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа гадаадын иргэн өөрөө хүссэн, эсхүл зөвшөөрсөн тохиолдолд энэ хуульд заасан журмыг баримтлан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болно. 4.3.Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээдэд холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан хүснэ.	Монгол Улсын ЭБШХ-д тус хууль дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа гадаадын иргэнд үйлчлэх талаар заасан боловч консулын чиг үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахаас зайлсхийх, албадан саатуулах буюу баривчилсан тохиолдолд хэрэг үүсгэх хугацаа анхаарч үзэх талаар тодорхой заалт байхгүй. Ийнхүү Монгол Улс энэхүү конвенцийн дагуу дархан эрх, эрх ямба эдэлж байгаа гадаадын иргэнд холбогдох хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг нарийвчлан тогтоогоогүй буюу хууль тогтоомждоо конвенцийн заалтын агуулгыг бүрэн тусгаагүй байна.	

Хууль зүйн үндэсний хүрээлэн

320 Монгол Улс 1988 оны 6 сарын 20-нд нэгдэн орсон.

АВИЛГАЛЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*32 дугаар зүйл. Гэрч, шинжээч болон хохирогчийг хамгаалах* 1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна.	Монгол Улсын *ЭБШХ*-д конвенцийн энэ заалттай холбогдох заалт байхгүй.	Монгол Улсын Эрүү, ЭБШХ-д гэрч (шинжээч, хохирогч болон тэдний гэр бүлийн гишүүн)-г өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах тухай зохицуулалт байхгүй бөгөөд энэ нь тус улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн явдал болжээ.	
2	*46 дугаар зүйл* 11. Энэ зүйлийн 10 дахь хэсгийн зорилгыг хэрэгжүүлэхдээ: (a) хэрэгтэнг шилжүүлэн өгсөн оролцогч улс онцгойлон хүсэлт гаргаагүй бол шилжүүлэн авсан оролцогч улс хэрэгтэн этгээдийг хорионд байлгах эрхтэй буюу үүрэгтэй; (b) хоёр оролцогч улсын эрх бүхий байгууллагууд урьдаас буюу бусад хэлбэрээр хоорондоо тохиролцсон ёсоор хэрэгтэнг шилжүүлэн авсан оролцогч улс түүнийг шилжүүлэн өгсөн оролцогч улсын мэдэлд даруй буцаан өгөх үүрэг хүлээнэ; (c) этгээдийг шилжүүлэн авсан оролцогч улс түүнийг буцаахтай холбогдуулан шилжүүлэх ажиллагааг шинээр эхлүүлэхийг шилжүүлж өгсөн Оролцогч улсаас шаардаж болохгүй; (d) этгээдийг шилжүүлэн авсан оролцогч улсад хоригдсон хугацаа нь түүний шилжүүлж өгсөн оролцогч улсад эдлэх ялын хугацаанд орж тооцогдоно.	46 дугаар бүлэг. Эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөх	Монгол Улсын ЭБШХ-ийн 46 дугаар зүйлд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай зохицуулсан ба харин гэмт этгээдийг шилжүүлэн авах тухай, улмаар шилжүүлэн авсаны дараа явуулах ажиллагааны тухай заагаагүй. Ийнхүү Монгол Улсын ЭБШХ-д конвенцийн заалтын агуулгыг тусгаагүй байна.	Монгол Улсын ЭБШХ-д "Гэмт этгээдийг шилжүүлэн авах ажиллагаа" гэсэн бүлгийг конвенцийн заалтын агуулгаар нэмж оруулах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

	12. Энэ зүйлийн 10, 11 дэх хэсгийн дагуу оролцоч улс нэг эпизодыг шийдвэл өөрөө тус улсын эвлэрүүлэгчээр уг эпизод аль улсын харьяат гэдгээс үл хамааран, шийдвэлээ оролцоч улсын нутаг дэвсгэрээс гаргаасаа өмнө үеийн үйлдэл, эс үйлдэл болон шийтгэлээ нь хэлбэлзүүлэн түүнд эрүүгийн мөрдөн байцаалт явуулах, хорих, ял шийтэл хүлээлэх буюу бусад ямар нэг хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлах арга хэмжээ шийдвэлэн авсан оролцоч улсын нутаг дэвсгэрт ял болохгүй.			
3	*46 дугаар зүйл* 18. Тухайн хүн оролцоч улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд гэрч эсүүл шинжээчийн хувьд оролцоч нөгөө улсын шүүхийн байгуулагуудын ажиллагаанд оролцож асуулдах ёстой болон нутаг дэвсгэрт нь биеэр хүрэлцэн очих болоогүй эсүүл зохимжүй байвал оролцоч улс нь нөгөө талын хүсэлтийн дагуу боломжоороо буюу дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмитай нь нийцэж байвал видео үзүүлэлтэн хэлбэрээр асуулт харилцтыг явуулахыг зөвшөөрч болно. Хүсэлт гаргасан оролцоч улсын шүүхийн байгуулагаар асуулгыг явуулж, хүсэлт хүлээн авсан оролцоч улсын шүүхийн байгуулагын төлөөлөгчийг энэ ажиллагаанд байлцуулах талаар оролцоч улсууд тохиролцож болно.	*400 дугаар зүйл.* Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг дуудах, байцаах 400.1. Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дуудаж болно. 400.2. Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг дуудах, хэрэв тэдгээр нь Монгол Улсад байгаа бол Монгол Улсын ЭБШХ-ийн Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг дуудах журмыг хууль тогтоомжоор тогтоосон байна.	Монгол Улсын ЭБШХ-ийн Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг дуудах, байцаах" гэсэн зүйлд дээр дурдсан эгээдүүд хүрэлцэн ирэх, очих боломжгүй тохиолдолд байцаалт явуулах журмыг конвенцийн заалтын агуулгаар хуульчлах	Монгол Улсын ЭБШХ-ийн Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг дуудах, байцаах" гэсэн зүйлд дээр дурдсан эгээдүүд хүрэлцэн ирэх, очих боломжгүй тохиолдолд байцаалт явуулах журмыг конвенцийн заалтын агуулгаар хуульчлах

хууль зүйн үндэсний хүрээлэн

		400.3.Энэ хуулийн 400.1-д дурдсан эзэн, хохирогч болон бусад оролцогчийн хүчээ дор дурдснаас бусад байцаан шийтгэх ажиллагаагаа энэхүүльдзасансанжурмыгбаримтлан явуулна: *400.3.1. албадан иргүүлэх;* *400.3.2. тогтоуль оноодуулах;* *400.3.3. мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэх, дуенэлт гаргахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх.*			
4	*46 дугаар зүйл* 21. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс дараах тохиолдолд татгалзаж болно: (а) энэ зүйлийн заалтуудтай нийцүүлж хүсэлтэз гаргаагүй; (b) хүсэлт хүлээн авсан оролцоч улс хүсэлтийг биелүүлснээр түүний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нийгмийн дэг журам, ашиг сонирхолд хохирол учирна гэж үзвэл; (с) хүсэлтэд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан авах арга хэмжээг хүсэлт хүлээн авсан оролцоч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу адилтгах гэмт хэргийг шалгах, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бол; (d) хүсэлтийг биелүүлэх нь хүлээн авач оролцоч улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхтэй холбогдсон хууль зүйн тогтолцоотой нь зөрчилдөж байвал. 22. Оролцоч улс тухайн үйлдэл нь татварын асуудалтай холбоотой гэдэг үндэслэлээр л эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзаж болохгүй	*ЭБШХ* 45 дугаар бүлэг. Монгол Улсын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүхийн байгууллага болон гадаад улсын холбогдох байгууллагын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн хэрэгцээ, үндэслэлийг тодорхойлох, Монгол Улсын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа	Монгол Улсын ЭБШХ-д эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан үзүүлэх ажиллагааны талаар дэлхийн улс орнуудын зохицуулсан болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхэд татгалзаж болох тухай, татгалзаж болох тохиолдол буюу үндэслэлийг заагаагүй байна.	

5	*49 дүгээр зүйл. Хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа* Нэг эсвэл хэдэн улсад, шалгах, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулах, оролцогч улсуудын эрх бүхий холбогдох байгууллагууд хамтарсан мөрдөн байцаах нэгж байгуулах боломжийг зохицуулсан хөрөнгө болон олон талын хэлэлцээр, тохиролцоо байгуулахыг оролцогч улсууд судалж үзнэ. Иймэрхүү тохиролцоо байгуй бол тухайн үед хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа жич тохиролцож явуулна. Иймэрхүү хамтарсан мөрдөн байцаах ажиллагаа оролцогч улсын нутаг дэвсгэрт явуулахдаа холбогдох оролцогч улсууд тухайн улсын бүрэн эрхт байдлыг бүрэн хүндэтгэнэ.	*183 дугаар зүйл.* Мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах 183.1. Энэхүү төвөгтэй болон ихээхэн хэмжээний ажиллагаа бүхий хэргийн мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулж болох ба түүний мөрдөн байцаах албаны дарга томилж тогтоол гаргана. 183.2. Тогтоолд бүх мөрдөн байцаагчид, түүний дотор хэсгийн ахлагч-мөрдөн байцаагчийг томилсон тухай заана. 183.3. Тогтоолыг сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах ба тэдгээр нь аль ч мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй.	Монгол Улсын ЭБШХ-д мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах тухай заасан боловч нэг эсвэл хэд хэдэн улсад шалгах хэрэгт мөрдөн байцаах нэгж байгуулан ажиллах тухай заагаагүй байна. Энэ нь конвенцийн заалтыг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий асуудал гэж үзэхээр байна.	Монгол Улсын ЭБШХ-ийн "Мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах" гэсэн зүйлд "улс хооронд хамтарсан мөрдөн байцаах нэгж байгуулан ажиллах болох" тухай зохицуулалтыг конвенцийн заалтын агуулгаар нэмж хуульчлах

www.nli.gov.mn ХҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах санал

ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧИЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ОРУУЛАХ НЭМЭЛТ ПРОТОКОЛ[321]

/Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/ 263 тогтоолоор батлаж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*8 дугаар зүйл* 1.Оролцогч улсууд энэхүү Протоколоор хориглосон гэмт хэрэгт өртөж, хохирогч болсон хүүхдийн эрх ашиг сонирхлыг зрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед дор дурдсан арга замаар хамгаалах талаар зохих арга хэмжээ авна: a.гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлага, ялангуяа гэрч болохынх нь хувьд тэдгээрийн онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах: b.хохирогч болсон хүүхдэд тэдний эрх, үүрэг болон шүүн таслах ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаархи шийдвэрийн тухай мэдээлэх: c.шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх: d.шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх:	42 дугаар зүйл. Хохирогч 42.1. Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ. 42.2. Иргэн, хуулийн этгээдийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана. 42.3. Хохирогч, түүний төлөөлөгч нь дараах эрх эдэлнэ: 42.3.1. өмгөөлөгч авах /энэ заалт нь төлөөлөгч өмгөөлөгчөөр оролцож байгаа тохиолдолд хамаарахгүй/; 42.3.2. баримт сэлт гаргаж өгөх; 42.3.3. нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах; 42.3.4. шүүх хуралдаанд оролцох; 42.3.5. шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих; 42.3.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах; 42.3.7. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;	Монгол Улсын ЭБШХ-ийн 42 дугаар зүйлд ЭБША-ны явцад хохирогчийн эдлэх эрхийг тодорхойлсон. Гэвч Монгол Улс хууль тогтоомждоо энэхүү конвенцоор үүрэг болгосон "хохирогч, тэр дундаа *хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах*" тухай зохицуулалт оруулаагүй буюу конвенцоор хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй байна.	

[321] Монгол Улс 2002.10.11нд нэгдэн орсон.

е.шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үнэлэхий хүүхдийн тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах; *ё.хохирогч хүүхэд, түүнчлэн түүний эцэг буюу ижил төрөл, ойрын хамаатан, өөрт эзэлдэгч эсвэл асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгч, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, шүүгч зэрэг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг байгуулах, багийн гишүүдийн нэрсийг мэдээлэх, багийн гишүүдийг солих, багийн гишүүдэд шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх, багийн гишүүдийг сургах, багийн гишүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, багийн гишүүдийг хариуцлагад татах, багийн гишүүдэд урамшуулал олгох, багийн гишүүдийг чөлөөлөх, багийг татан буулгах асуудлыг шийдвэрлэх;* *ж.хохирогч хүүхэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн тогтоол болон шийдвэр гүйцэтгэлийг онцын шаардлагагүйгээр хойшлуулахаас зайлсхийх.* *2.Оролцоч этсүүд хохирогчийн насны талаар эргэлзээ гарвал үүнээс болж эрүүгийн мэрдэн байцаалт, тухайлбал, хохирогчийн насыг тогтоох зорилгоор мэрдэн байцаалт эхлүүлэхээ өмнө үүсэхүү байх нөхцлийг хангана.* *4. Оролцоч этсүүд энэхүү Протоколоор хориглосон үйлдэл хэгийн хохирогч хүүхэдтэй ажиллаж буй этгээдэд зохих сургалт, ялангуяа хүүхэд эрх зүйн болон сэтгэл зүйн сургалтад хамруулах талаар арга хэмжээ авна.*	42.3.8. хэрэг бүртгэлт; мэрдэн байцаалтын ажиллагаа дуусаны дараа хэргийн бүх материалтай танилцах; 42.3.9. гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх; 42.3.10. цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах; 42.3.11. бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах; 42.3.12. хэрэг бүртгэгч, мэрдэн байцаагч, прокурор, өмгөөлөгч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга татагдан гаргах тухай хүсэлт гаргах. 42.4. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол энэ зүйлд заасан эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүн эдлэнэ.		

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*19 дүгээр зүйл. Хамтарсан мөрдөн байцаалт* Оролцогч улсууд нэг буюу түүнээс олон улсад мөрдөн байцаалт, мөрдөн мөшгөлт буюу шүүхийн ажиллагаа явуулах, холбогдох эрх бүхий байгууллагууд хамтарсан мөрдөн байцаах байгууллага байгуулж болох асуудлаар хоёр буюу олон талт хэлэлцээр эсхүл тохиролцоо байгуулах талаар авч үзнэ. Тийм хэлэлцээр эсхүл тохиролцоо байхгүй тохиолдолд тухайн хэрэг тус бүрээрхэлэлцээрбайгуулан хамтарсан мөрдөнбайцаалтыг явуулж болно. Холбогдох Оролцогч улсууд нутаг дэвсгэрт нь тийм мөрдөн байцаалт явагдах Оролцогч улсын бүрэн эрхт байдлыг бүрэн дүүрэн хүндэтгэх нөхцлөөр хангана.	*ЭБШХ* *183 дугаар зүйл.* Мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах 183.1. Эдгээр төвөгтэй болон ихээхэн хэмжээний ажиллагаа бүхий хэргийн мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулж болох ба түүнийг мөрдөн байцаах албаны дарга томилж тогтоол гаргана. 183.2. Тогтоолд бүх мөрдөн байцаагчид, түүний дотор хэсгийн ахлагч-мөрдөн байцаагчийг томилсон тухай заана. 183.3. Тогтоолыг сэжигтэн, яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах ба тэдгээр нь аль ч мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй.	Монгол Улсын ЭБШХ-д мөрдөн байцаалтыг мөрдөн байцаагчдын хэсэг явуулах тухай заасан боловч нэг, эсвэл хэд хэдэн улсад шалгах хэрэгт мөрдөн байцаах нэгж байгуулан ажиллах тухай заагаагүй бөгөөд үүнийг конвенцийн зохицуулалт шаардаж байна.	
2	*25 дугаар зүйл. Хохирогчийг хамгаалах болон туслах* *1. Оролцогч улс бүр энэхүү Конвенцид хамаарах гэмт хэргийн хохирогчийг тухайлбал, өвөө авах буюу сүрдүүлэх заналхийлэлээс хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх хүрээнд зохих арга хэмжээнүүдийг авна.* *2. Оролцогч улс бүр энэхүү Конвенцид хамаарах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах талаар зохих журмыг батална.* *3. Оролцогч улс бүр гэмт хэрэгтний эсрэг эрүүгийн шүүн таслах ажиллагааны зохих шатанд хохирогчийн үзэл санааг өмгөөлөх эрхэд хохирол учруулахгүй байх хэлбэрээр илэрхийлүүлэх болон авч үзэх боломжийг өөрийн дотоодын хуулийн дагуу бүрдүүлнэ.*	*Монгол Улсын ЭБШХ-д гэрч, хохирогчийг хамгаалах тухай зохицуулалт байхгүй.*	Монгол Улсын ЭБШХ-д гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эд хөрөнгийн хохирлыг арилгахаас бусад эрхийг хамгаалах, туслах талаар зохицуулалт байхгүй.	

Энэхүү зүйл заалт дээр саналгүй.

ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

/1979 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлан, 1987 оны 2 дугаар сарын 8-нд хүчин төгөлдөр болсон[322]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	Эрүүгийн хуулийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*8 дугаар зүйл* 1. Оролцогч улс бүр 7 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллаа тогтооход шаардагдах арга хэмжээг дараахь тохиолдолд авна: (a) гэмт хэргийг тухайн улсын нутаг дэвсгэрт буюу тэр улсад бүртгэсэн хөлөг онгоцны тавцан буюу агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн үед; (b) сэжигтэн этгээд тухайн улсын харьяат бол.	*3 дугаар зүйл.* Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх хэмжээ хязгаар 3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана. 3.3. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.	Монгол Улсын ЭБШХ-д нутаг дэвсгэрт нь, мөн тухайн улсад бүртгэлтэй буюу тухайн улсын далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэгт ЭБША явуулахад Монгол Улсын ЭБШХ үйлчлэх тухай заасан. Харин уг хуульд Монгол Улсын харьяат этгээд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд харьяалал хэрэгжүүлэх талаар заагаагүй байна.	

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

[322] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 2006. 883-895 дахь тал

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ

/1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон[323]/

№	Монгол Улсын олон улсын гэрээний заалт	ЭБШХ-ийн холбогдох заалт	Тайлбар	Санал
1	*3 дугаар зүйл* 1.Эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл байвал оролцогч улс уг этгээдийг өөр улсад албадан гаргах, буцаах буюу шилжүүлэн өгөхгүй. 2.Тийм үндэслэл байгаа эсэхийг тогтоох эрх бүхий байгууллага уг асуудалд холбогдох бүх нөхцөл байдлыг, тэр дундаа тус улсад балмадаар, үй олныг хамруулан хүний эрхийг байнга зөрчдөг эсэхийг харгалзан үзнэ.	*406 дугаар зүйл.* Шилжүүлэн өгөхөөс татгалзах 406.1. Дараахь тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй: 406.1.1. Монгол Улсын иргэн; 406.1.2. гэмт этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгосон; 406.1.3. шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэслэл нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол; 406.1.4. шилжүүлбэл зохих этгээд тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол; 406.1.5. Монгол Улсын хууль тогтоомжоор тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх буюу ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол.	Монгол Улсын ЭБШХ-д гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлийг заасан боловч конвенцид заасан "эрүүдэн шүүх аюул тулгарна гэсэн хангалттай үндэслэл байвал" гэсэн конвенцийн заалтын агуулгаар нэмж оруулах	Монгол Улсын ЭБШХ-ийн 406 дугаар зүйлд "эрүүдэн шүүх аюул тулгарна гэсэн хангалттай үндэслэл байвал" гэсэн конвенцийн заалтын агуулгаар нэмж оруулах

[323] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004. 109-120 дахь тал

2	*13 дугаар зүйл* Оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээшүүрхэй,шударгаарханан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна.	20 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах эрх 20.1. Хэрэг буруутгагч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.	Монгол Улсын ЭБШХ-д оролцогчдоос БША, шийдвэрт гомдол гаргах эрхийг хуульчилж өгсөн ба харин хохирогч, гэрч нарыг хамгаалах тухай зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, ЭБШХ-д конвенцийн заалтын агуулга тусгагдаагүй байна.	ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
3	*14 дүгээр зүйл* 1.Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцооноо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хэнгэлттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдэхийг үлмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй. 2.Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй.	44 дүгээр. ЭБША-ны явцад хэрэг буруутгагч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны үлмаас иргэнд учирсан хохирлыг арилгах	Монгол Улсын ЭБШХ-ийн 44 дүгээр бүлэгт хэрэг буруутгагч, мөрдөнбайцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэгэхээр, тэгэхээр хууль зөрчсөн албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс болж иргэнд хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөр авах эрхийг хуульчилсан. Гэвч материалдаг хууль буюу Иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг хэрхэн арилгах тухай, мөн асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхийг хуульчлаагүйгээс хуулийн энэ заалт хэрэгждэггүй.	Монгол Улсын Иргэний хууль дэх конвенц болон ЭБШХ-ийн заалтын агуулгатай нийцэхүйц өөрчлөлт оруулах	

www.nuls.edu.mn хууль зүйн үндэсний

4	*15 дугаар зүйл* Оролцогч улсууд эрүү шүүлтийн улмаас хийсэн гэж тогтоогдсон мэдэгдлийг шүүн таслах аливаа ажилпагаанд нотлох баримт болгохгүй, харин эрүү шүүлт тулгасан хэмээн буруутгасан хүний эсрэг мэдэгдэл хийдсэн тухай нотлох баримт болгон ашиглаж болно.	*92 дугаар зүйл.* Нотлох баримтыг цуглуулах 92.4. Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хүчирх мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно. 79 дүгээр зүйл. *Нотлох баримт* 79.4. Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хүлээд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.	Монгол Улсын ЭБШХ-ийн заалтын конвенцийн агуулгатай нийцэж байх боловч конвенцын заалт илүү тодорхой байна.	Монгол Улсын ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлд заалтын агуулгыг нэмж хуульчлах

Хүний эрхийн үндэсний хүрээлэн
www.nhri.gov.mn

Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Тэмдэгтийн хураамжийн тухай хууль

Д/д	Гэрээний нэр, зүйл заалт	Хуулийн нэр, зүйл заалт	Тайлбар	Санал
1.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/АIII/ тоотоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.*	-Шүүхийн тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Прокурорын байгуулагын тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/ -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль /1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр	1948 онд баталсан. Хүний иргэний, улс төрийн ба нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг анх удаа нэгтгэн оруулсан.	
2.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай ОУ-ын пакт *Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Прокурорын байгуулагын тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/ -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль /1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр	Улс бүр нутаг дэвсгэртээ болоодэрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, УТ-ийн бусад үзэл үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал эд хөрөнгийн хийгээд бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.	
3.	Боловсролын талаар алагчлах явдалтай тэмцэх тухай конвенц *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгуулагын Ерөнхий бага хурлаас 1960 оны 12 дугаар сарын 14-нд баталж, 1962 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Прокурорын байгуулагын тухай хууль /2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/ -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/ -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль /1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна. Зөрчилдсөн зүйл заалт илрээгүй болно.	

4.	Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенц *Конвенцийг 1948 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталж,* *1951 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд здгээр хуулиудтай ямарч хамааралгүй байна.	
5.	Аж үйлдвэрт хүүхдийг ажилд авах насны доод хязгаарын тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц *1937 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж,* *1941 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд здгээр хуулиудтай ямарч хамааралгүй байна.	
6.	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийн тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын тухай 87 дугаар конвенц *1948 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж.* *1950 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд здгээр хуулиудтай ямарч хамааралгүй байна.	
7.	Зохион байгуулах эрх ба хамтын хэлэлцээний тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц *1949 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталж.* *1951 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд здгээр хуулиудтай ямарч хамааралгүй байна.	

www.legalinfo.mn

8.	Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц *1951 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталж,* *1953 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна.	
9.	Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, зөвлөмж	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна.	
10.	Эхчүүдийг хамгаалах тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц *1952 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж.* *1955 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна.	
11.	Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц *1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж,* *1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна.	

12.	Арьс өнгөөр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц *Ерөнхий Ассамблейн 2106 (XX) тоот тогтоолоор 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлаж, 1969 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль /*2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, эрх чөлөөг адил тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхийг үгүйсгэх зорилгоор арьс үндэс, арьсны өнгө,ураг төрөл, үндэстний буюу угсаатны үүслийн үндсэн дээр ялгаварлах, хязгаарлах, онцлох буюу дээрд үзэх тухай.	
13.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт *Нэмэлт өөрчлөлтийг 1995 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталж, 2002 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль /*2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр/*	Конвенцийн гол агуулга нь уг конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурьдсан "арав" гэсэн үгийг "арван найм" болгон батална. "2. Хороо нь ёс суртахууны эрхэм дээд чанарыг ээмшсэн, энэхүү Конвенцид хамаарах асуудлаар өндөр мэдлэг, чадвар хуримтлуулсан арван мэргэжилтнээс бүрдэнэ. Хорооны гишүүдийг оролцогч улсууд өөрийн иргэдээс сонгох бөгөөд тэдгээр нь өөрсдийн нэрийн өмнөөс ажиллана. Чингэхдээ газар зүйн тэгш хуваарилалт болон эрх зүйн гол тогтолцооны төлөөллийг харгалзана".	
14.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц *1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж,* *2000 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль /*2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Энэ конвенциор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт юу юу хамаарах, конвенцийг хэрэгжүүлэх арга механизмыг зааж өгсөн. Энэ конвенц здгээр 4 хуультай утга агуулгын хувьд тохирохгүй байна.	

15.	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол *1999 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлаж,* *2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах хороо ажиллах бөгөөд аливаа эрхийг зөрчсөний улмаас хохирсон тухай мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх процессын талаар бичсэн.	
16.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц *1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж,* *1987 оны оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор "эрүүдэн шүүх" гэдгийг тодорхойлсон. Оролцогч улсуудын авах арга хэмжээ, эрүүдэн шүүхийн үндэслэл, "Эрүү шүүлтийн эсрэг хороо"-ны ажиллах горим, мэдээлэл хүлээж авах, шийдвэрлэх процессыг заасан.	
17.	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц *1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж,* *1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол болон түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх зорилгоор улс хооронд хүүхэд үрчлэхэд тавигдах шаардлага, эрх бүхий байгууллага болон итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа, улс хооронд үрчлэх явцад тавигдах шаардлага, үрчлэн авахыг хүлээн зөвшөөрөх, түүний үр дагавар зэрэг асуудлыг зохицуулсан.	
18.	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол *Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталж,* *2002 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор 18 нас хүрээгүй этгээд сайн дурын үндсэн дээр үндэсний зэвсэгт хүчинд элсэж орж болно гэхдээ тодорхой шаардлага хангаж тодорхой баталгаа гаргана.	

19.	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол *Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор батлаж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах гэдэгт юуг ойлгохыг тодорхойлсон. Оролцогч улсуудын авах арга хэмжээг мөн тодорхойлж өгсөн.	
20.	Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц *1973 оны 6 дугаар сарын 26-ны өдөр батлаж, 1976 оны 6 дугаар 19-нд хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар, ажиллах хүрээг тогтоож өгсөн.	
21.	Хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Үндэсний бодлого, насны доод хязгаар, хөлсний болон өөр төрлийн хөдөлмөрийн аюултай хэлбэрүүд, ажлын нөхцөл зэргийг зохицуулсан.	
22.	Олонулсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурванталтзөвлөлдөөний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 144 дүгээр конвенц *1976 оны 6 дугаар сарын 22-ны өдөр батлаж, 1978 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Энэхүү конвенцийг соёрхон батлалсан улсууд хэрхэн дагаж мөрдөхийг зохицуулсан.	

23.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц *1981 оны 6 дугаар сарын 22-нд баталж, 1983 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор хамрах хүрээг тодорхойлж, тодорхойлолт гаргасан. Мөн үндэсний бодлогын зарчмууд, үндэсний түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан.	
24.	Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц *1983 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1985 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон*	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор нэр томьёо, хамрах хүрээ, тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлтийн зарчим, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан	
25.	Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, ажил эрхлэлтийн тухай 168 дугаар зөвлөмж	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Уг конвенциор тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээх, хөдөлмөр эрхлэх боломж, орон нутгийн оролцоо, хөдөө нутаг дахь мэргэжлийн нөхөн сэргээлт, боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн нөхөн сэргээлтийн үйлчилгээнд ажил олгогчдын ба ажилчдын байгууллага хувь нэмэр оруулах, мэргэжлийн нөхөн сэргээлтийн үйлчилгээнд тахир дутуу хүмүүс, тэдний байгууллага хувь нэмэр оруулах, уялдан зохицуулах зэргийг зохицуулсан	

26.	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт *Нэгдсэн Үндэстний Байгуулагын Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж,* *1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Зохицуулах зүйл, утга агуулгын хувьд шүүхийн тухай хууль, ЗХШХШТХ, Прокурорын байгууллагын тухай хууль, Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудтай нийцэхгүй байгаа тул зөрчилдсөн хэм хэмжээ байхгүй байна.	
27.	Апартейдын гэмт хэргийг таслан зогсоох, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай олон улсын конвенц *Ерөнхий Ассамблейн 1973 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3068 (XXVIII) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 7 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Апартейдын гэмт хэргийг таслан зогсоох, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай олон улсын конвенц нь эдгээр хуулиудаас зохицуулах зүйлээрээ эрс ялгаатай байна.	
28.	Хөдөлмөр эрхлэх бодлогын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122-р конвенц, зөвлөмж *1964 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж.* *1966 оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон*	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Энэхүү конвенцийн зорилт нь бүх нийтийг хөдөлмөр эрхлэх боломж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн, ямар нэг ялгаварлан гадуурхах зөрчлийг арилгахад улс орнуудыг уриалсан байдаг.	
29.	Газар доор буюу уурхайд ажиллагсадын насны доод хязгаарыг тогтоох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын тухай 123-р конвенц, 124-р зөвлөмж *1965 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж,* *1967 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хүчин төгөлдөр болсон*	- Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* - Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Энэ конвенц нь олон улсад хөдөлмөрийн хүнд нөхцөлд буюу газар доор насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглосон агуулгатай байна. Монгол Улсын эдгээр хуулиудын зохицуулах зүйлтэй уялдахгүй байна. Мөн зөрчилдсөн зүйл заалт илрээгүй болно.	

30.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенцийн агуулга нь хүйсийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засаг, улс төр соёлын эрхийг ялгаваргүйгээр эдүүлэхэд чиглэсэн байдаг. Монгол Улсын хууль тогтомжид хүйсээр ялгаварлан үзсэн ямар нэг зүйл заалт байхгүй. Монгол Улсын эдгээр хуулиудын зохицуулах зүйлтэй уялдахгүй байна. Мөн зөрчилдсөн зүйл заалт илрээгүй болно	
31.	Спортод апартейд явуулахын эсрэг олон улсын конвенц *Конвенцийг 1985 оны 12 дугаар сарын 10-ны батлав,* 1988 оны 4 дүгээр сарын 3-ний өдөр хүчин төгөлдөр болсон	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Спортод арьс өнгөөр ялгаварлахын эсрэг энэхүү конвенцийн зохицуулах зүйлтэй нь Монгол Улсын эдгээр хуулиудийн зохицуулах зүйл нь ямарч хамааралгүй байна.	
32.	Ажилчдын төлөөлөгчдийн тухай Олонулсын хөдөлмөрийн байгууллагын 135-р конвенц, 143-р зөвлөмж	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Ажилчдын төлөөлөгчдийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 135-р конвенц, 143-р зөвлөмж нь хөдөлмөр эрхлэлт түүний удирдах үйл ажиллагаанд ажилтнуудын төлөөллийг оролцуулахад чиглэсэн байна.	
33.	Хүүхдийн эрхийн тухай конвенц *1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлав, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамаарлгүй байна.	

34.	Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц *1962 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон.*	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамаарлгүй байна.	
35.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*		
36.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 20-р зүйлийн 1-р хэсэг дэх нэмэлт өөрчлөлт	-Шүүхийн тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Прокурорын байгууллагын тухай хууль */2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр/* -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль */2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр/* -Тэмдэгтийн хураамжийн тухай хууль */1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр*	Конвенц нь утга агуулгын хувьд эдгээр хуулиудтай ямар ч хамааралгүй байна.	

Эдгээр Монгол Улсын хууль тогтоомж болон холбогдох олон улсын гэрээнүүд дээр саналгүй болно.

—oOo—



Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Иргэн эдийн засгийн эрх зүйн сектор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай дараах олон улсын гэрээг харьцуулан судлав. Үүнд:

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А /XXI/ тоот тогтоолоор батлаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан/.

2. Зохион байгуулах, хамтын хэлэлцээ'хийх эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц /1949 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталж, Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон/.

3. Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц (хянаж өөрчилсөн) 1937 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж, 1941 оны 2 дугаар сарын 21-ий өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон.

4. "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/А/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан.

5. "Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц 1948 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж, Монгол Улс 1969 .05.10-нд нэгдэн орсон.

6. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол Ерөнхий Ассамблейн 2200А (XXI) тогтоолоор 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улсын Бага Хурлын 1991.01.14-ний өдрийн 3 дугаар тогтоолоор нэгдэж орсон.

7. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц 1973 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталж1976 оны 6 дугаар 19-нд хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002.10.31-нд соёрхон баталсан.

8. Хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны конвенцид нэмэлт зөвлөмжийн хэлбэрт оруулж, 1973 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны конвенцийн зөвлөмжийг баталсан.

9. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966.12.16-ны 2200А /XXI/ дугаар тогтоолоор НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталж, 1976.01.03-нд хүчин төгөлдөр болсон.

10.Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989.11.20-нд баталж, 1990.9.2-нд хүчин төгөлдөр болсон. Эдгээр олон улсын гэрээ нь судалсан дээрх хуулиудтай зөрчилдсөн зүйл байгаагүй болно.

2.ДҮГНЭЛТ

3.1.Судалгааг хийсний ач холбогдол

Энэхүү судалгааг хийснээр Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж болон холбогдох олон улсын гэрээний хоорондох зөрчилдөөнийг илрүүлэх, улмаар илрүүлсэн зөрчилдөөнийг арилгах талаар санал зөвлөмж боловсруулж цаашид Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэх арга хэмжээ авахад дөхөм болгож байгаа явдал юм.

3.2.Энэ судалгааг хийснээр хүрэх үр дүн

Судалгааны хийх хүрээ маш өргөн байсан ба хүний эрхтэй холбогдолтой гэрээнүүд болон гэмт хэргийн эсрэг тэмцэх гэрээнүүдийг судлахаар нэр заасан найман хуультай харьцуулан үзлээ.

Судалгааг ерөнхийдөө иргэний эрх зүйн, захиргааны эрх зүйн, эрүүгийн эрх зүй, олон улсын эрх зүйн гэсэн үндсэн бүлэг болгож хийсэн бөгөөд эдгээрээс хамгийн их зөрчилтэй байгаа хэсэг нь эрүүгийн эрх зүйн хэсэг байлаа. Тус бүрт нь тодорхойлж үзвэл:

- Олон улсын эрх зүйн сектор: Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж, "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм болон 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг судаллаа.

- Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг Монгол Улсын

Эрүүгийн хуулийн зүйл заалтуудтай харьцуулан судалж, олон улсын гэрээний хэм хэмжээг үндэсний хууль, тогтоомжид хэрхэн, ямар байдлаар тусгаж, нийцүүлэх талаар тайлбарлан дүгнэж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар нийт 24 санал боловсруулсан.

- 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "Монгол Улсын олон улсын

гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг судалж олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх эрх зүйн орчин бүрдсэн байдалд зохих судалгаа хийж дүгнэлт өгөв (энэхүү тогтоол нь Хууль зүйн үндэсний төвийн (хуучин нэрээр) Олон улсын эрх зүйн секторын 2008 оны 1 дүгээр сард УДШ-ийн тогтоолын төсөлд өгсөн саналыг бүрэн тусгасан нь тогтоолын төслийн ноцтой дутагдал засагдсан байгааг тэмдэглэж байна).

1. "Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн

нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон

улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан байх хэдий ч Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх асуудлаас зөвхөн олон улсын гэрээг хэрэглэх асуудлыг тусгаж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, тогтоолын нэрд агуулагдаж буй олон улсын гэрээнээс гадна олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэх нь огт тайлбаргүй үлдсэн байна.

1.1."Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолын 2 дугаар хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болно гэсэн нь оновчтой бус байна. Тухайлбал, Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болгон олон улсын гэрээний хэлбэртэй байдаггүй бөгөөд тэдгээрийн хувьд соёрхон батлах, түүнд нэгдэн орох асуудал байдаггүй.

2.Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх арга зүйн асуудал нь хэт ерөнхий болсон байх боловч тогтоолын 13 дахь хэсэгт энэ асуудлыг сургалт, арга зүйн материал, гарын авлага төлөвлөснөөр шийдэж болохоор зохицуулсан байна.

2.1.Арга зүйн асуудал хэт ерөнхий, тухайлбал, шүүх олон улсын гэрээг хэрэглэх дараалсан алхам, хэрхэн хэрэглэх аргачлал, шүүхийн шийдвэрийн хаана нь хэрхэн тусгах гэх зэрэг асуудал тодорхой биш байна. Энэ тогтоол гарснаас хойш 2 жил өнгөрсөн боловч тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ хийгдээгүй байна. Олон улсын гэрээг хэрэглэх аргачлал, сургалт, сургалтын гарын авлага одоо болтол боловсруулаагүй байна.

3.Тогтоолын 2-т Олон улсын гэрээг тодорхойлохдоо 1993 оны Олон улсын гэрээний тухай хуулийн өөр хоорондоо зөрчилтэй заалтыг үндэс болгосон нь Улсын Дээд шүүх албан ёсоор энэ зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байна.

Олон улсын гэрээний тодорхойлолтыг Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулиас авахдаа болгоомжтой хандах ёстой байсан. Учир нь онолын хувьд Парламентын байгуулсан гэрээг олон улсын гэрээнд багтаан тооцдоггүй ба Парламент улсын нэрийн өмнөөс гэрээ байгуулах эрхгүй байдаг. Мөн үүний адилаар агентлаг, тусгай газрын байгуулж буй гэрээг ялган авч үзэх шаардлагатай.

Үүнтэй холбогдуулж олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд болон Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд тус тус ялгаатай байдлаар тодорхойлсныг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, Үндсэн хуульд Монгол Улсын олон улсын гэрээ гэхийг зөвхөн соёрхон баталсан, эсхүл соёрхон батлах замаар нэгдэн орсон олон улсын гэрээг ойлгохоор бол Олон улсын гэрээний тухай хуульд олон улсын гэрээг өргөн хүрээгээр томъёолсон

байна. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т хоёрдмол санаа агуулаагүй зөвхөн соёрхон батална, эсхүл соёрхон батлах замаар нэгдэн орсон олон улсын гэрээ холбогдох хууль гармагц дотоодын хуулийн адил хүчинтэй болохоор заажээ. Иймд шүүх зөвхөн Үндсэн хуулиар тодорхойлсон Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэх нь зохистой.

4. Монгол Улсын Дээд шүүх анх удаа шүүхэд хэрэглэх олон улсын гэрээний шинжийг тодорхойлжээ. Тухайлбал: Монгол Улсын олон улсын гэрээ нь дараах шинжийг агуулсан бол шүүх хэрэглэнэ.

- Үндсэн хуульд харшлаагүй;
- хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан,
- албан ёсоор нийтлэгдсэн;
- дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй;
- үндэсний эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай.

Энэхүү шинж онол, практикийн үндэслэл бүхий бөгөөд эрдэмтдийн анхаарал татсан тулгамдсан асуудлын нэг болоод байна. Тухайлбал, НҮБ-ын Олон улсын шүүхийн 2001 оны La Grand-ийн (ХБНГУ vs. АНУ)[324] хэргийн шийдвэрт өөрөө биелэгдэх олон улсын гэрээний шинжийг тодорхойлсон байна. Олон улсын гэрээний заалт үндэсний эрх зүйн субъект хэрэглэхэд чиглэгдсэн агуулгатай байх, дотоодын хуульчилсан акт шаардахгүйгээр тухайн улсын нутаг дэвсгэр дээр шууд үйлчлэх чадвартай байх ёстой[325].

Харин зарим олон улсын гэрээ оролцогч улсад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх тодорхой арга хэмжээ авахыг үүрэг болгодог хэдий ч зарим гэрээ нь "шаардлагатай бол" тийм арга хэмжээ авна гэж уян хатан томъёолсон байдаг. Тиймд 27 дугаар зүйлийн дагуу "шаардлагатай талаар заасан" бол шууд хэрэглэх боломжгүй гэж ойлгох нь дутагдалтай. Тухайлбал; Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай 1997 оны конвенцийн 18 дугаар зүйлд "шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах" гэх заалтыг оролцогч улс өөрийн үндэслэлээр шаардлагатай эсэхээ тогтооно.

ОХУ-ынДээдшүүхийнтогтоолдгэрээнийдээрхшинжийгтодорхойлохдоо ОХУ-ын олон улсын гэрээний тухай Холбооны хуулийн 5 дугаар зүйлийн 3-аар тогтоосон нь агуулгын хувьд ч манай хуулийн 27 дугаар зүйлтэй таарахгүй байна.

5. Энэ хэсэгт "Олон улсын гэрээ хүчинтэй болсон хэдий ч албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэхгүй" гэсэн байна. Энэ асуудалд маш болгоомжтой хандмаар байна. Учир нь өнөөдөр санхүүгийн бэрхшээлээс болж төдийлөн олон улсын гэрээг нийтэлж чадахгүй байгаа.

---

[324] La Grand case. (2001) 40 ILM 1069.

[325] Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн 36 дугаар зүйл өөрөө биелэгдэх шинжийг агуулсан. Үүний дагуу АНУ-ад тухайн улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээсэн ХБНГУ-ийн иргэн Карл Лагранд нь конвенцийн заалтаар эрхээ хамгаалуулах бүрэн эрхтэй байсан гэж үзсэн байна.

Мөн хоёр талт олон улсын гэрээ огт нийтлэгдээгүй байна. Дээрх байдлаар шүүх нь нийтлэгдээгүй хуулийг хэрэглэж болохгүй боловч нөхцөл байдлыг дүгнэж энэ асуудалд болгоомжтой хандахгүй бол хүний эрхийг ноцтой зөрчих магадлалтай.

Нэгдсэн дүгнэлт

1."Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоол нь Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэх суурь эрх зүйн үндэс болсон. Шууд хэрэглэх Монгол Улсын олон улсын гэрээний шинжийг оновчтой тодорхойлсон байна.

2.Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн 9 дүгээр тогтоолыг сайжруулах замаар, эсхүл түүний хэрэгжилтийг хангах үүднээс зохих арга хэмжээ авч олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх аргачлал боловсруулах шаардлагатай байна.

3. Шүүгчийн сургалтын сэдэв, төлөвлөгөөг эргэн харж олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх аргачлалтай уялдуулж чанарыг сайжруулах шаадлагатай байна.

4. Нийтлэгдээгүй Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэхгүй байх асуудлыг түр заалт, эсхүл түр хугацааны арга хэмжээгээр шийдэх бололцоог судлах шаадлагатай байна.

- Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор: Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 10 гэрээг хамруулж судалсан.

Харьцуулсан хууль болон гэрээний нэрс: Монгол улсын Иргэний хууль,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол, Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц, Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц, хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц.

Эдгээр 10 гэрээг уншиж судлан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл заалттай зөрчилдөж байгаа эсэхийг судалсаны эцэст нэр бүхий 10 гэрээ нь тухайн 2 хуультай зөрчилдсөн зүйл заалт байхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

- Захиргаа хүмүүнлэгийн эрх зүйн сектор: Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 36 гэрээг хамруулж судалсан.

Харьцуулсан хууль болон гэрээний нэрс: Шүүхийн тухай хууль,

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, боловсролын талаар алагчлах явдалтайй тэмцэх тухай конвенц, Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенц, Аж үйлдвэрт хүүхдийг ажилд авах насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц, Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц, Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, зөвлөмж, Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц зөвлөмж, Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, зөвлөмж, Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц, Арьс өнгөөр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Хүүхдийг худалдах, хүүхдийг биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц, хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн туай олон улсын пакт, Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 144 дүгээр конвенц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, ажил эрхлэлтийн тухай 168 дугаар зөвлөмж, Апартейдын гэмт хэргийг таслан зогсоох, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай олон улсын конвенц, Хөдөлмөр эрхлэх бодлогын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенц, зөвлөмж, Газар доор буюу уурхайд ажиллагсадын насны доод хязгаарыг тогтоох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 123 дугаар конвенц, 124 дүгээр зөвлөмж, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах

тухай конвенц, Спортод апартейд явуулахын эсрэг олон улсын конвенц, Ажилчдын төлөөлөгчдийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 135 дугаар конвенц, 143 дугаар зөвлөмж, Сайн дурын үндсэн дээр гэрлэх болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1-р хэсэг дэх нэмэлт өөрчлөлт, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол.

Эдгээр хуулиуд нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын дээрх гэрээнүүдтэй зөрчидөж байгаа эсэх тухай харьцуулан, тулгаж уншсан бөгөөд ямар нэг зөрчилдсөн зүйл илрээгүй болно.

- Эрүүгийн эрх зүй, криминолгийн судалгааны сектор: Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж төрийн мэдээлэл сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 30 гэрээг хамруулж судалсан.

Харьцуулсан хууль болон гэрээний нэрс: Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол, Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц, Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц, олон улсын хамгаалалтад орох хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц, Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол,Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц, Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Апартейдын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэргийг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц, Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц, Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм.

Судалгаанд хамрагдсан 30 гэрээний харьцуулан судлагдсан 308 хэм хэмжээний:

- 209 буюу 67.8% нь үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан;
- 29 буюу 9.4% нь бүрэн бус тусгагдсан;
- 41 буюу 13.3% нь огт тусгагдаагүй байна.

Энэ нь Монгол Улс Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан" олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Үндсэн тайланд сектор тус бүрийн судалгааны ажлын дүгнэлтийг хавсаргалаа.

"ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ БА МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨН" СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ

Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор "Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль ба Монгол Улсын олон улсын гэрээний зөрчилдөөн"-ийг 2009 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд судаллаа.

Судалгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүваарь гарган, Монгол Улс нэгдэн орж, "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 30 гэрээг хамруулан судлав.Эдгээр 30 гэрээг судлан 308 хэм хэмжээг түүвэрлэн, тэдгээрт Монгол Улсын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох хэм хэмжээг харьцуулан тайлбарлан дүгнэж, зохих саналыг боловсруулсан болно.

Судалгаанд хамрагдсан 30 гэрээний харьцуулан судлагдсан 308 хэм хэмжээний:

- 209 буюу 67.8% нь үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан;
- 29 буюу 9.4% нь бүрэн бус тусгагдсан;
- 41 буюу 13.3% нь огт тусгагдаагүй байна.

Энэ нь Монгол Улс Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Ийм учраас дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгын дор Монгол Улсын Эрүүгийн хууль, ЭБШХ-д бүрэн тусгагдаагүй, эсвэл огт тусгагдаагүй байгаа олон улсын гэрээний хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн, ямар байдлаар тусгаж, нийцүүлэх талаар тайлбарлан дүгнэж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар 52, ЭБШХ-д өөрчлөлт оруулах талаар 23 санал, бүтд 75 санал боловсруулсан.

Санал боловсруулахдаа хуулийн хэм хэмжээг олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөх өөрчлөлтийн агуулга, төслийг томъёолсон болно.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:
ЭЭЗКС-ЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН
Ц.ОДОНЧИМЭГ

"ИРГЭНИЙ ХУУЛЬ, ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ БА МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨН" СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ

Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор "Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль ба монгол Улсын олон улсын гэрээний зөрчилдөөн"-ийг 2009 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд судаллаа.

Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 10 гэрээг хамруулан судлав. Эдгээр 10 гэрээг уншиж судлан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох зүйл заалттай зөрчилдөж байгаа эсэхийг судалсаны эцэст нэр бүхий 10 гэрээ нь тухайн хоёр хуультай зөрчилдсөн зүйл заалт байхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

Судалсан гэрээ:

1.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А /XXI/ тоот тогтоолоор батлаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон батлсан./

2.Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 98 дугаар конвенц /1949 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталж, Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон./

3.Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц (хянаж өөрчилсөн) 1937 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталж, 1941 оны 2 дугаар сарын 21-ий өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1969.05.10-нд нэгдэн орсон.

4."Хүний эрхийн түгээмэл тунхаглал" Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/А/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан.

5."Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц 1948 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталж, Монгол Улс 1969 .05.10-нд нэгдэн орсон.

6.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол Ерөнхий Ассамблейн 2200А (XXI) тогтоолоор 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.Монгол Улсын Бага Хурлын 1991.01.14-ний өдрийн 3 дугаар тогтоолоор нэгдэж орсон.

7.Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц 1973 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталж1976 оны 6 дугаар 19-нд хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002.10.31-нд соёрхон батласан.

8.Хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоох 146 дугаар зөвлөмж

Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны конвенцид нэмэлт зөвлөмжийн хэлбэрт оруулж, 1973 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны конвенцийн зөвлөмжийг баталсан.

9.Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966.12.16-ны 2200А /XXI/ дугаар тогтоолоор НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталж, 1976.01.03-нд хүчин төгөлдөр болсон.

10.Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989.11.20-нд баталж, 1990.9.2-нд хүчин төгөлдөр болсон.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:
ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОРЫН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТАМИР

"ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬ, ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ БА МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨН" СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ

Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн сектор "Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын иухай хууль, Тэмдэгтийн хураамжийн хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ба монгол улсын олон улсын гэрээний зөрчилдөөн"-ийг 2009 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд судаллаа.

Судалгааны явцад Монгол Улсын нэгдэн орж "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 36 гэрээг хамруулан судлав. Эдгээр 36 гэрээг уншиж судлан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох зүйл заалттай зөрчилдөж байгаа эсэхийг судалсаны эцэст нэр бүхий 36 гэрээ нь тухайн хуулиудтай зөрчилдсөн зүйл заалт байхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:

ЗАХИРГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОРЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

.....
Х. НАРАНЦАЦРАЛ



3.1.Саналын хэсэг

Энэхүү судалгааг хийснээр цаашид хэрэгжүүлж болох шинэ санал зөвлөмж байгаа эсэх

- Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиуд нь холбогдох олон улсын гэрээнүүдийн зарим зүйл заалттай зөрчилдөж байгаа нь Монгол Улс Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байдалд хүргэж байна. Ийм учраас дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгын үүднээс Монгол Улсын Эрүүгийн хууль, ЭБШХ-д бүрэн тусгагдаагүй, эсвэл огт тусгагдаагүй байгаа олон улсын гэрээний хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн, ямар байдлаар тусгаж, нийцүүлэх талаар тайлбарлан дүгнэж, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар 76 санал, ЭБШХ-д өөрчлөлт оруулах талаар 23 санал, нийт 99 санал боловсруулсан.

Санал боловсруулахдаа хуулийн хэм хэмжээг олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөх өөрчлөлтийн агуулга, төслийг томъёолсон болно.

- Цаашид энэхүү судалгааны хүрээг улам өргөтгөн судлах. Тухайлбал, Авилгын эсрэг хууль, Арбитрын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль Соггуруулах, мансууруулах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. Цагдаагийн байгууллагын тухай хууль зэрэг хуулиудыг олон улсын гэрээтэй хэр нийцэж, зөрчилдөж байгааг судлах шаардлагатай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn